

# Тунгалаг тамир

## Тунгалаг тамир

I

Олноо өргөгдсөний дөтгөөр оны зуны эхэн сарын нэгэн өдөр Их тамирын хойгуур гарсан замаар гуч орчим насны хар хүн нилээд ачаатай морин тэрэг хөтлөөд явж байв. Нар салхинд гандаж, хир хөлсөнд нэвтэрч урагдсан дээлээ есөн өнгийн юмаар нөхсөн болохоор ямар эдээр хийсэн нь мэдэгдэх аргагүй ажээ. Ханхар дөрвөлжин мөрөндөө утаа болсон цахиур буу хөндлөн үүрч, даахирсан бүдүүн хар гээгээ дарайсан хуучин хөх ямбуу алчуураар шуужээ. Шороонд буурал болсон өтгөн хар хөмсгөн доорхи том гэгчийн дүрлэгэр нүд нь удаан цавчилж, хөлс дааварласан хүрэн нүүрэнд нь урт замын алжаал илэрч, гүн бодолд автагдан хүрлийхийг харвал ядарсан буюу уурласан алин болох нь мэдэгдэмгүй ажээ. Энэ хүн дахин дахин эргэж харан, заримдаа зогсон, ачаагаа засан явсаар оройн нар уулын толгой шүргэх үед замаас гарч голын эрэг чиглэв. Ингээд ногоон зүлгэн дээр очоод буугаа эвтэйхэн гэгч нь авч шийрлэн тавиад, тэргээ буулгаж, морио чөдөрлөн тавив. Тэрэгнийхээ сүүдэрт тавтай завилан суугаад өврөөсөө мод толгой гаргаж тамхиа татаж утаагийг нь алгуурхан үлээн гаргах зуур ногооны үзүүр имрэн оролдоно. Энэ хүнийг Эрдэнэ гэдэг. Засагт ханы хошууны Олгонууд отгийн хүн. Уулаас эцгээс ах дүү хоёул бөгөөд багадаа өнчрөн айл дамжин зарагдаж бор хоног өнгөрүүлэн явжээ. Дүү нь Төмөр гэгч хүн бий. Арван зургаан насандаа шилийн сайн эрчүүдтэй нийлж удалгүй эрмэг зориг, эр чадал ухаан санаагаар гайхагдсан «Засагт ханы цахиур Төмөр» гэж алдаршин халх дөрвөн аймаг, шавь тавд домог мэт яригддаг болжээ. Өнөөгөөс гурван жилийн өмнө Төмөр ахындаа гүн шөнө үл таних хоёр хүний хамт ирж уулзаад үр шөнө салахын үед явжээ. Тэгэхдээ цоохор ембүү, оросын цагаан хааны цөлхөөв гучаадын хамт өгчээ. Түүнээс хойш ах дүү хоёр учраагүй зөвхөн л сургаар амьд мэндээ мэдэлцэж байжээ. Харин сүүлийн жил гаруйн дотор Эрдэнэ дүүгийнхээ тухай ямар ч сураг сонссонгүй.

Эрдэнийн өөрийн нь хувьд гэвэл багадаа Доной тайжийн хонь хариулж, хурдан морий нь унаж байхдаа хүү Чулууны нь бичиг заалгахын далимаар бичиг сурч, уулаас ухаан сэргэлэн болохоор «Оюун түлхүүр», «Цаасан шувуу», «Гурван улсын бичиг», «Алтан товч»-оос эхлэн олдсон юм бүхнийг уншин гуйсан хүнд өргөдөл, захиа бичиж удалгүй «Бичээч Эрдэнэ» гэж нутагтаа алдаршжээ.

Арван найман насандаа нутгийн Долгор гэдэг бүсгүйтэй дэр нийлүүлэн гэр барьж амьдрал. Бас арваад сарлаг, хоёр гурван унах морь, хэдэн хоньтой болжээ. Эрдэнэ бусад хүн шиг зовоходоо зовж, өлсөхдөө өлсөж, баярлахдаа баярлаад, хорсоходоо хорсоод амьдарч болох байжээ. Гэтэл шинээр ширээ залгасан засаг хаан Гомбожавын зан авир ширүүн, ард олныг зовоох нь хир хэмжээнээс хэтрэхэд чуулган дарга, монгол манж зургааныг дамжин заргалдав.

Гэвч ноёнтон өшөөтэй бол хонгогүй, нохойтой өшөөтэй бол хормойгүй гэдэг дэмий үг биш болохоор Гомбожав хошууны хөрөнгөөр хөлөө хүрэх газар бүхэнд хээл хахууль цутгаж байгаад эзэн ноёнтонгоо харгалдсан тэрсүүд албатыг Улиастайн бат гүнд орхив. Тэнд үс, бөөсөндөө баригдан жил гаруй болж байтал монгол улс манжаас тусгаарлан богд Жавзандамба хутагт төр шашныг хослуулан баригч нарангэрэлт

түмэн наст эзэн болоод өршөөл түгээж Эрдэнэ гяндангаас гарчээ. Бат гүнд сууж байхдаа дүүтэй нь хамт Говь мэргэн Вангийн ноён сүргээс таслан хөөж, Цэцэн Сартуулын хошуунд дамжуулж байсан нэг эртэй дайралдаж Төмөрийн тухай өдий төдий домог шиг яриа сонсжээ.

«Морины сайныг харуут таньдаг, санаа нь сүү шиг чадал нь хархул шиг эр дээ. Долоо хоногийн өлийг дуулж байгаад давдаг хүн, далан өртөө газрыг дөрөөн дээрээ туулдаг эр» гэх зэргээр Төмөрийг шагшин магтжээ.

Эрдэнийг нутагтаа очиход нь хорссон хааны хавчлага байж суухын аргагүй болоход нь албан татвар, аль нэгд өчүүхэн хөрөнгө хамж өгөөд ганц морин тэргэнд юмаа ачиж Богдод мөргөхөөр эхнэр хүүхдээ дагуулан хүрээний зүг зам хөөжээ.

Эрдэнэ тамхиа хэд дахин шунаг сороод, ирсэн зам руугаа харлаа. Тэртээ хөтлийн наад руу орсон замаар хүүхэд эхнэр хоёр нь гэлдрэн алхсаар ирж явааг хараад, мод толгойгоо галтай нь түрийлэн босож ачаагаа буулган яг л дээл шиг нь түмэн нөхөөс болж утаанд шарлан дарайсан жижиг майхнаа босгоод аргал хормойлж түүн, гурван том чулуу тулан галлаж цай чанав.

Жалавчин тогоотой цай цайран буцлах үед эхнэр хүүхэд нь ч ирлээ. Долгор замдаа түүсэн аргалаа асгаж хормойгоо сэгсрээд хөлөө жийн суув. Алсын аян, замын шороо, хурц наранд борлосон энэ эмэгтэйн царайнд алжаалын тэмдэг тодорхой авч эхийнхээ дууг сонссон ботгоны нүд шиг тормолзсон болох хар нүдэнд нь залуугийн гал, хөдөө талын бүсгүйн гоо жавхлан тодорхой ажээ.

- Хүү маань явж өгдөггүй шүү гээд инээмсэглэхэд нь жигдхэн бөгөөд дун цагаан шүд яралзав.
- Чи минь амарч үз. Би домбоо зайлаад цайгаа уудалж орхиё гээд Эрдэнэ тэргэн дээлээс гуулин домбо аваад жаргаж байгаа нарны гэрэлд гялтганан мяралзах голын зүг явлаа.

Доторхоо огт нуухгүй гэсэн мэт тунгалаг голын эргэн дээр явган суугаад домбоо зайлах зуур «Ус харсан хүн уйддаггүй» гэж сонссон нь Эрдэнийн сэтгэлд орж нүүрээ угаагаад дотоод хормойгоороо арчив. Босож шууд явсаар галын дэргэд ирээд оволзон буцалж байгаа цайнаас жижиг төмөр шанагаар хутгаж «Тайшир хан минь» гэж шивэгнэн баруун зүг өргөснөө дахин хутгалж «Хангай дэлхий минь» гээд өмнөх түнхгэр ногоон уул өөд өргөв.

Хол замд ядарсан гурван хүн ногоон зүлгэн дээр чандмалан суугаад үнэр нь ханхалсан замбай аяга дүүрэн зуурч бөөрөнхийлөн базаж хормой дээрээ тавиад аягандаа хар цай дүүргэж аваад идэж ууж байхдаа хорвоогийн бүх зовлонг умартаж, өнгөрсөн ирээдүйн гунигт явдлын тухай огтхон ч бодолгүй хөгжилдөн инээлдэж, хөхрөлдөн ярилцав.

- Аваа, Богдын хүрээ хэзээ орох вэ? гэж Батын асуухад Эрдэнэ зажилж байсан гурилаа залгиж, хойноос нь цайгаа балгаснаа
- Удахгүй. Харин чи өнөөдрийнх шигээ хашигнаад байвал хүрээ улам холдоно шүү гэлээ.
- Би явъя гээд л байхад энэ хөл чинь ядраад болохгүй юм гэж Бат гомдолтой хэлэхэд эцэг эх хоёр нь хүүгээ өхөөрдөн инээв.
- Баруун гарт өнгөрдөг том чулуу, нөгөө Тайхар чулуу гэдэг мөн үү? гэж Долгор асуув.
- Мөн. Аварга эд шүү.

Эгийн давааны цаана байдаг могойн зам гэгч харагдсанаас эхлэн Тайхар чулууны тухай домгийг эхнэр, хүүхдэдээ Эрдэнэ ярьж өгсөн билээ. Гайхамшигт гэгээний ид шидэнд биширсэн Долгор тэр мундаг чулууны хойгоор гарахдаа гурван халуун амиа даатган хэдэн удаа сунаж мөргөжээ.

- Ээжээ, та хэнд мөргөж байгаа юм бэ? гэж дэргэд нь зогсож байсан Бат асуув.
- Зая гэгээнд мөргөж байна хүү минь гэж эх нь шивэгнэн хариулав
- Юу гэж мөргөж байгаа юм бэ?
- Бид гуравд буян заяа хайрлаач гэж мөргөж байна ээж нь
- Надад мөсөн чихэр гуйгаарай ээжээ
- Миний хүү өөрөө мөргө

Бат сөхрөн сууж хэд дахин мөргөхдөө амандаа «Гэгээн минь надад мөсөн чихэр хайрлаач» гэж торжигнууллаа.

Өнгөрсөн жил Доной тайжийн хурдан хээрийг наадамд унаж түрүүлээд ирэхэд нь тайжийн авгай жижигхэн мөсөн чихэр өгчээ. Түүнээс хойш ертөнцийн хамгийн сайхан юм бол мөсөн чихэр гэж Бат боддог болсон ажээ.

Ингэж эх хүү хоёр талын дунд байгалийн гайхамшигт хүчээр сүндэрлэн боссон Тайхар чулууг бишрэн өнгөрсөн юм.

- Аав аа, та тэр чулууг орхимжоороо оосорлож үүрээд явж чадах уу? гэж Батын асуухад эцэг нь өхөөрдөн инээмсэглэснээ толгойг нь илж:
- Аав нь төрийн хар хүн болохоор орхимж байхгүй. Бас тэгээд Зая бандид шиг тийм ид шид ч байхгүй гэлээ.

Бат бодолхийлэн баахан сууснаа «Аав аа ид шид гэж юу байдаг юм бэ?» гэж асуугаад эцгийнхээ нүүр рүү нүдээ цавчлан харлаа.

- Ид шид гэж үү? үлэмж чадалтай юм байдаг. Ид шидтэй хүн бол гээд нүдээ аньснаа ингэх зуур л бид гурвыг Богдын хүрээ хүргэж орхино гэж Эрдэнэ хэлэв.
- Та ид шидтэй болохгүй яасан юм бэ? Ид шидтэйсэн бол ядрахгүй нүдээ ингээд л гээд Бат нүдээ тас аньж үнэхээр нисэж яваа юм шиг гараа сарвалзуулан хэсэг байснаа хөл ядрахгүй хүрээ орчихно шүү дээ. Тийм ээ ээж ээ гээд гомдолтой инээмсэглэв.
- Аавд нь зав болоогүй юм гээд Эрдэнэ хүүгийнхээ нар тоос үнэртсэн толгойг үнсэв. Бат байн байн «яагаад?» гэж асуугаад эцэг эх нь хүүгийнхээ гэнэн цагаан ярианд баясан инээж утаа болсон уранхай майхны дэргэдээс баяр цэнгэлийн хөгжилтэй дуу цууриатан, шуугиан урсаж байгаа Тамирын голын чимээнд өчүүхэн ч гэсэн хандив болж байв. Хүн жаргалын төлөө төрдөг болохоор ямар ч хэцүү бэрх амьдрал гашуун зовлон, баясах сэтгэл, жаргалын эрмэлзлийг нь ширгээн хатааж чаддаггүй. Энэ ч учраас хатуу амьдрал, нүсэр зам, энэ гурвын баясан цэнгэх сэтгэл, хомс хүнсээ идээд залуугийн цаг, хайрын галаар ядралаа умартан амарч байхад нь оргилон гарах бяцхан зовлон авчирч өгөхийг мэдэхгүй дүнгэр дүнгэр ярилцан хөгжиж байтал үдшийн бүрэнхий дуусаж үнэгэн харанхуй эхлэхэд тэнгэрт түг түмэн од гялалзан, Тамирын хөндий дагаж яруухан үнэр анхилсан сэрүүн салхи сэвэлзэнэ.

Эрдэнэ морио авчирч, урт дээсээр аргамжаад нутгийн зүг харж зогссоноо: «Тайшир хан минь, Тарлан хайрхан минь, Атаа таван тэнгэр минь, ачит Гомбо минь» гэж алгаа элгэндээ хавсран шивгэнэн залбираад майхандаа орж удалгүй гурван цагаачин гүн нойрондоо цохигдон унтжээ.

Үүр шөнийн завсраар Эрдэнэ босож, дээлээ нөмгөн нөмөрч гараад харвал аргамжаатай морио алга болсон байхад гүйн очвол чөдөр нь аргамжаатайгаа байв. Эрдэнэ цааш харах гэтэл өмнөх хар уул томорсоор ойртоод ирэх шиг болоход гэдрэгээ хоёр алхав. Хэсэг гөлрөн зогссоноо хүндээр шархадсан хүн эцсийн хүчээ шавхан алхаж байгаа юм шиг хэд алхаж хар чийгэнд нэвт норсон гурамсан чөдрийг атгаж, тэртээ баруунаа бараантан харагдах уулсын дээгүүр ширтэн «Тайшир хан минь, Атаа таван тэнгэр минь, Гомбо минь харахгүй яагаав дээ» гэж шивэгнэв. Эрдэнийг босоод гарахад сэрсэн Долгор орж ирэхэд нь өндийж:

- Тэнгэр сайхан байна уу? гэж асуув.

Эрдэнэ майхны үүдэнд дуугүй зогсож байснаа аргамж, чөдрөө майхны хаяа руу шидэж «хулгай аваад явчихжээ» гэж хэлэв.

— Юу. Морийг минь уу? гэж хашгираад Долгор босон харайв.

— Тийм гээд Эрдэнэ дэвсэж унтсан өнгөгүй гудсан дээрээ суув.

— Одоо яадаг билээ. Хүний газар гүний нутагт гахай явган хаачих билээ хэмээн Долгор уйлахад нулимс хацрыг нь даган урсав.

Энэ майханд орсон зовлон надад падгүй гэсэн юм шиг Тамирын гол жигдхэн шуугиж, дорно зүгээс улам тодорч байгаа үүрийн гэгээ нойрссон ертөнцөд шинэ өдөр мэндэлснийг баяртай тунхаглаж байв.

-- Уйлаад юу хийхэв дээ, хэрэггүй... за даа гээд Долгор руу харж инээмсэглэх гээд чадсангүй. Ам нь мурилзан өтгөн хар хөмсөг нь таталдсанаа мод толгойгоо авч тамхи нэрээд хэд дахин угсарч татлаа.

«Одоо яах вэ» гэдэг мухар сохор асуудал Эрдэнийн сэтгэлд орж хоолойд нь тээглэн нүд нь байн байн харанхуйлж байв. Тэгээд уйлж байгаа Долгор руу нүдний булангаар харснаа бүсээ бүслээд, дахин эндээс босохгүй гэсэн бололтой тавтай завилж суув.

-- За хөө явгарсан болохоос үхсэн биш. Цай чанаж ууцгаая. Амьд хүн аргатай, аргалын гал цогтой доо гэж зуусан шүднийхээ завсраар шивэгнэн хэлэв.

Эрдэнийн шанаа зангиран тавирч, нүд нь өмнөх газраас салалгүй ширтэн, үе үе хамар амаар нь цэнхэр утаа бургилан байхад Долгор хэд дахин юм хэлэх гэснээ больж гадагш гарлаа.

Дорнод уулын оройгоос цацарч байгаа нарны гэрэлд ивгээгдсэн Тамирын хөндийн бөөн бөөн гялалзсан хар толбо намрын хамхуул шиг өнхрөн тоглож байв.

Гал түлж байхдаа Долгор «Гомбо минь, Тайшир минь» гэж дахин дахин шивэгнэвч «Гомбо, Тайшир» хоёроос чухам юуг гуйж байгаагаа өөрөө мэдэхгүй байлаа.

II

Эрдэнэ харь нутагт явгарсан гунигт шөнийн урьдах өглөө Тамирын хөндийд өөр нэгэн хэрэг гарчээ.

Өмнүүрээ гарсан ялааг үмхэх гээд чадалгүй ангайж хоцорсон шувууны ам шиг голын баруун тал руу хойноос шааж орсон урт амны адаг, өргөн дэнж дээр дундаа хонины хашаатай чандмалан буусан гурван гэр хот айл харагдана.

Баруун өмнөх том гэрээс хөх даалимбан дээлтэй хуучивтар луучин гутал өмссөн сийлмэл төмөр хэт билтэй, вйсэн иштэй хутга зүүсэн, гялалзсан дугуй бор царайтай, тогтож ядсан давхраа алаг хурц нүдтэй, бүдүүн хар гээгэтэй хүн гарч ирээд дөнгөж тэмдэг орж байгаа үүрийн гэгээнд дөрвөн зүг найман зовхисыг ажиглан зогсов.

Энэ хүнийг Итгэлт гэдэг. Одоо гучин хоёр настай. Итгэлт ямар ч язгуур угсаагүй. Эцгээс уламжилсан өв хөрөнгө бага боловч хайрга чулуу мэрэхээс бусдыг хийж байгаад Луу гүний хошууны тэргүүн баяны нэг болжээ. Арван есөн насандаа Далай чойнхор вангийн Лувсан тайжийн охиныг ёслол авч өмчинд нь овоо мал авсан нь хөрөнгөжихийн эх сурвалж болжээ. Гаднаа цөөн мал байлгаж бусдыг хэдэн хошуун ядуучуудад суурилан өгч хариулгадаг ажээ. Итгэлтийн бүл гэвэл эхнэр Должин, арван настай хүү Хонгор, долоон настай охин Солонго ийм дөрвөн халуун амь билээ. Итгэлт үүрийн гэгээ цайхаас эхлээд үдшийн бүрэнхий болтол борви бохисхийхгүй юм хийж байдаг. Хавь ойрын хүмүүсээ ч яг тийм байлгахыг хичээдэг. Энэ ч учраас эхнэр Должин нь бусдаас түрүүнд босоод, бусдаас түрүүнд үнээгээ сааж билчээдэг заншилтай. Хэрэв аль нэгэн айлаас хожимдвол төд өдөртөө дуу шуугий уурлан явдаг. Энэ зангий нь мэддэг зарц нар нь ч гэрийн цайны уур дуугарахаас нааш босдоггүй. Итгэлт хэсэг зогсож хэд дахин суниав.

- Должин оо. Хүүг босгоод үнээнд явуул. Сайхан өдөр болох нь гэж нарийхан царгиа дуугаар хэлээд хойт гэр рүү гүйн очиж өрхийг татаад

- Дулмаа, босвол дээр байхаа гээд зүүн гэр рүү алхтал гэрээс ахимаг насны авгай гарч ирээд өрхөө татлаа.

- Хойт жижиг гэрт Итгэлтийн адуучин Галсан, эхнэр Дулмаагийн хамт байдаг. Зүүн гэрт хоньчин Ням, эхнэр Хишигт зургаан настай охин Сүрэнгийн хамт байдаг.

Итгэлтийн нуруу намхан, туранхай боловч булчин шөрмөс болсон бие нь гүйж, үсэрч явахаар зориуд заяагдсан мэт бөгөөд нутгийнхан «дэвхрэг Итгэлт» гэж хочилдог. Итгэлт шогшсоор гэрийнхээ гадна очиход хүү Хонгор нь нүдээ нухлан гарч ирэв.

- Муу хүний нойр, мулгуу хүний шүлс гэгчээр нойрмоглоод, заяа нь орхисон тархи.

Бушуухан үнээгээ хураагаад ир гэж тэртээ хойт энгэрт идэх нь идэж, хэвтэх нь хэвтэж байгаа сарлаг хайнаг голдуу үхэр рүү заав. Хонгор бургасан шилбүүр авч мордон гүйх гэхэд нь «Мод битгий уна, заяа нь орхисон тархи» гэж эцэг нь зэмлэн зогсов.

Итгэлт Тамирын нөгөө талын модтой уулын ард идэж байгаа хоёр морийг ажиглан харснаа шууд явж хонины хашаагаа нээв. Энэ үед Ням бүсээ бүсэлсээр ирээд «Сайхан унтав уу? Улс бид хоёрын хэн нь баян Итгэлт, хэн нь хоньчин Ням гэдгийг тааж олох гэж зүдэрдэг бололтой» гэж бүдүүн паргиа дуугаар хэлэв.

- Тааж л байг гээд Итгэлт хоолойдоо зальтай инээснээ Ням гуай, Пүрэв тайжийн адуучны сураглаж явсан хоёр тэр байна гэж нөгөө хоёр морийг заав.

- Барьж аваад, ирж автал нь хонинд талхиж орхих юмсан гэж Итгэлтийн бодлыг нь таасан мэт Ням хэлэв

- Адуу ирэхээр та мордоод хөөгөөд ир л дээ, орж айраг ууя гээд Итгэлт гэрийнхээ зүг явахад Ням дагав

- Хонгор хүү гүйсээр гүн жалганы эхээр гарах гэтэл ёроолд ямар нэгэн дуу гарахад зог тусан зогсож харлаа.

- Дүү минь гүйгээд ир гэж тэртээ дороос бүдүүн дуутай хүн дуугарав.

- Ажиглавал тэр дор хүн гэхэд ч бэрх биш ч гэхэд бэрх нэг юм хөдөлж байв.

- Дүү минь битгий ай. Ах нь нэг ядарсан хүн байна гэж паргисан дуугаар хэлэхэд Хонгор жалга руу орж ойртон очив.

- Ах аа, та хүн үү? гэж толгойгоо далжийлган нүдээ жартайлган ширтэж байгаад асуув.

- Би хүн. Дүү минь хүрээд ир

Тэр бол аргагүй л хүн байлаа. Чингэхдээ хоёр гаргүй хүн хэвтэж байв. Хир хөлсөнд баригдаж үс сахал нь ургаад эрэг мөргөж байгаад гарсан сарлагийн бух шиг болсон тэр хүний нүүрэнд

хоёр нүд гялалзах ажээ.

- Эр хvн, эр хvнээсээ айх хэрэггvй гээд тэр хvн инээмсэглэв.

- Би айгаагvй гээд хvв эвгvй юм гарвал буцаад зугтахад бэлхэн алгуурхан ойртов.

Хатсан ширэн хөнжил дотор зөвхөн толгойгоо гаргаад хэвтэж байгаа тэр хvний нүд гялалзан, цэлмэг хөх тэнгэр өөд цавчилгvй ширтэж байв.

- Ах аа, та бос л доо

- Ах нь босож чадахгvй

- Яагаад босож чадахгvй байгаа юм бэ?

Тэр хvн хэсэг дуугvй болж, нүднийхээ булангаар Хонгорыг ширтэв.

- Ах нь ширлэгдсэн хvн. Луу гvний тамган дээрээс оргоод энд ирлээ. Хvн мэдвэл намайг барьж аваад ална. Гэвч эрх хvн эр хvндээ хайртай байдаг болохоор ахдаа тус болох байх гэж итгэж байна гэлээ. «Эр хvн эр хvндээ хайртай» гэдэг vг Хонгорын сэтгэлд харван орж, баяртай инээмсэглэн, ихэмсгээр хоолойгоо түрж засаад:

- Би танд яаж тус болох вэ? гэж хиймэл бvдvvн дуугаар асуугаад хажууд нь тулж очив.

- Дvв минь хурц хутга, чадвал дээл хувцас, хазаар, идэх юм авчир. Харин ахыгаа хэнд ч хэлж болохгvй гээд тэр хvн инээмсэглэж том хар нүдээ ирмэлээ.

- Би ч эр хvн. Та ч эр хvн. Зодсон ч хэлэхгvй. Бvгдийг аваад ирнэ гээд Хонгор явах гэснээ

- Ах аа. Би урьдаар vнээгээ аваачиж өгнө. Та хvlээж байгаарай. Би заавал ирнэ гээд гvйн одлоо.

Ширтэй хэвтэж байгаа энэ хvнийг цахиур Төмөр гэдэг. Өнгөрсөн намар Луу Гvний ноён сvргээс тасалж хөөгөөд гэнэт верлэсэн Тамирын голд мориноосоо салж vхэхийн даваан дээр аврагдахын хамт баригдаж хэд хоног жанчигдан байцаагдсан боловч нутаг ус, нэр алдраа хэлсэнгvй. Хэд хэдэн хvн таньж гэрчлэхэд нь «Та андууран нvгэл хурааж байна» гээд хэв нэг инээмсэглэж байжээ.

Хулгайч хvн хошуу нутгаа хэлбэл уг хошуу чирэгдэж төлбөр төлж олонд зовлон тариад жигшигддэг болохоор шилийн сайн эр баригдахдаа нэр ус, нутаг хошуугаа хэлэхгvйг хичээдэг.

Төмөр эр зааж, эрvv шvvлтийг шvд зуун давж, vг дуугараагvй боловч адуу хөөсөн хэрэг нь даанч ил болохоор ширлэгдэж жил шахам болоод хоёр хоногийн өмнө оргож бөмбөрсөөр урд шөнө энд иржээ.

Төмөр хэдий чадалтай боловч биенд нь баригдаж хатсан шир, өл хоолгvй амь тавьсан тэнцэл хамаг хvчий нь шавхаж ухаан бодол нь уймарч туйлдсан ведээ Хонгортой дайралджээ. Хvв vнээгээ гэртээ ойртож очиход адуу манаад уургаа чирэн гэлдэрсээр гэрийн зvг явж байсан Галсантай уулзав.

- Хонгор хvв сайн хонов уу?

Хонгор хариу дуугарсангvй, дэргэдvвр нь өнгөрөв. Жалганд байгаа хvнд ямар аргаар хэнд ч мэдэгдэлгvй тус хvргэх билээ гэхээс өөр бодол байгаагvй болохоор Галсантай яриа дэлгэх зав ч хvсэл ч vгvй байжээ.

- Юунд дуугаа хураачихаа вэ? Ахаас гаваг хvрдээ юв гэж Галсан асуугаад инээв.

Галсанг гэртээ ороход Дулмаа хувингаа бариад vнээндээ гарах гэж байв.

- Дулмаа чи задарч байна шvv

- Яагаав вэ?

- Үргэлж ахаар өрхөө татуулж байх юм. Илжиртлээ унтаад буянтай хvнийг зарж байж заяа буянаа гөвчихнө шvv золиг минь. Чи буянгий нь даахгvй шvv

- Гөвчихнө байгаа гэж айх заяа буян надад байхгvй гэж Дулмаа хөгжvvн инээмсэглэн хэлээд

хаалгаа тас хийтэл хаяад гарлаа.

- Тэнэг гичий гэж Галсан хойноос нь хашгираад барьж ирсэн цардмал цуваа ор руу ууртай чулуудав.

Хонгор үнээ саах, унага барихыг далимдуулан аавынхаа хурц хутга, одончуу цув, хазаар, гүзээний булан тос зэрэг юм цуглуулан гэрээсээ нилээд зайтай газар нууж амжив. Ингээд сувай адуу гилэх замдаа юмаа аваад явж байтал билчээсэн хонины хойноос дагаж явсан Дулмаатай дайралдав.

- Наадах шуудайтай чинь юу вэ? гэж Дулмаагийн асуухад хvv хөмхийгөө зуун, ташуураар чимээгvй гэж дохио өгөөд ойртон очив.

- Эр хvн эр хvндээ хайртай

- Юу, эр хvн, эр хvндээ хайртай гэнээ гээд Дулмаа тачигнатал инээх зуур юмы нь ажиглан харснаа чи хээр эрхлэх гэж явуу юм уу хэмээн асуув

- Эгч ээ хэнд ч битгий хэлээрэй

- Хэлэхгvй

Сувай адуугаа билчээрт гаргаж орхиод буцах замдаа Төмөр дээр очив. Гэтэл хуучин байрандаа алга байв.

- Ах аа, та хаа байна гэж аяархан дуудав.

- Хажуу талын эрэгнээс «би энд байна хvрээд ир» гэж дуудав. Хонгор хурц хутгаар удаан ноцолдож байж ширлэсэн ширийг салгав. Тэр хvнд дээл хувцастай боловч дээгvүр нь билчиж байгаа бөөсийг харах аргагvй ажээ.

- Ах аа ямар их бөөс вэ? Хонгорын асуухад босох гээд чадалгvй буцаж хэвтсэн Төмөр «Тайшир минь» гэж шивэгнээд нvдээ аньж алгуураар дөрвөн мөчөө хөдөлгөж эхлэв.

- Ахын нь толгой эргэж байна гэж шивэгнэв. Биеэ ийм хатуу ширэнд боолгож vдvvлсэн боловч өдий хол газар явж ирсэн энэ хvнийг харах тусам Хонгорын сэтгэл хөөрөн богино амьдралдаа олонтой сонссон «гэрт орж, гэгээнд мөргөдөггvй» сайн эрийн тухай ярианууд сэтгэлд ургаж байлаа.

- Та шилийн сайн эр vү? гэж Хонгор тэвчилгvй асуув. Төмөр нvдээ алгуур нээж, хvүг удтал ширтэж байснаа инээмсэглэх мэт болов.

- Чи Засагт ханы цахиур Төмөр гэж сонссон уу.

Өнгөрсөн жил тамгын жасаан дээр халх даяар цууд гарсан Засагт ханы цахиур Төмөр гэгч сайн эр баригдаад байцагдаж байна гэсэн яриаг сонсож билээ.

- Сонссон ах аа. Та цахиур Төмөр vү?

- Тийм. Би цахиур Төмөр.

Тvмэнд алдаршсан мундаг эрд тус болоод зэрэгцэн ярьж байгаадаа баярлан, нvдээ дvрлийлгэн марсайн инээв.

- Дvүгийн нэр хэн билээ?

- Хонгор. Луу гvний баян Итгэлтийн хvү гэж нарийхан дуугаар цовоо гэгч нь хариулав. Удалгvй Төмөр босож дээл хувцсаа тайлан, заримы нь газар булж, зарим нь гvүж сэгсрэн өмсөв. Гадуур нь Хонгорын авчирсан одончvү цувыг өмсөөд бvслэв. Энэ гайхамшигт эрийн хөдөлгөөн бvхэн хvүд ер бусын юм шиг санагдаж байв. Ялангуяа гvзээний булан тосыг хэдхэн vмхээд алга болгож, ханцуйгаараа амаа шудран арчаад хоосон гvзээгий нь тэр хол шидэж орхих нь хэн ч хийж чадахгvй гайхамшигт юм мэт бодогдов.

- За дvү минь урт насалж удаан жаргаарай. Ах нь эр хvний ачийг хариулж чадна. Замын хvзvv урт, зааны хvзvv богино болохоор уулзана даа. Одоо дvү минь харь гэж Төмөр хэлэв. Хонгор хутгаа авч мордоод гэрийн зvг сажлан явж байхдаа «эр хvн эр хvндээ хайртай» гэж

давтан дахин дахин эргэж харсаар ирвэл зэлэн уяан дээр нь үл таних хоёр морь байлаа.

«Манайд хэн ирээ юм бол» гэж бодоод гэртээ орвол ижилхэн хуучин шар чисчүү хантаазтай хоёр хvн том хултай айраг уун аавтай нь ярьж байв.

- Итгэлт гуай та шvvгдэж байхыг нь харсан бол яана. Хонгоны цус нvvр рvv урсаад байхад шvд нь хяхтнахаас өөр чимээ гардаггvй нохой доо. Цахиур Төмөр ч эрийн хувьд эр ээ. Барьж аваад ах нь мөч мөчөөр нь жиргэж байгаад мөлжиж орхино доо гэж нvvр нь батганд идэгдэж нvх болсон өргөн цээжтэй том хар хvн хэлээд паржигнан инээхэд нь их гэр доргих шиг болов.

Энэ хvнийг Бадарч гэдэг. Арван долоон наснаасаа Луу Гvний тамгын тахар хийсэн бөгөөд одоо гуч хvрчээ. Хэрэгтэнд хатуу харгис, бас тэгээд чадал хvч ихтэй долоон хошууны заан цолтой хvн. Тахар хийснээс хойш хээл, хахууль авч овоо хөрөнгөтэй болоод сvvлийн вед хvнийг «муу гуйлгачин» гэж дайрах нь улам олон болж байгаа билээ.

Бадарч өнгөрсөн жил Төмөрийг усанд хөвж явахад нь бариад тамган дээр аваачиж өөрөө банздан, ширлэжээ. Тахар хийсэн ведээ олон хvнийг ширлэсэн бөгөөд тэд нараас оргож байсан хvнгvй. Гэтэл цахиур Төмөр оргожээ. Үvнийг бодох тутам хорсож байв.

Өнгөрсөн жил Төмөрийг банздаж байхдаа тvvний ган зориг тэсвэрт нь бахархаж байсан. Чоныг барьж авсан хvн эр чадалд нь бахархаж байгаад зовоох удаа байдаг. Төмөрийг банздаж байхад Бадарч яг л тийм байсан.

Бадарчийн хорин банзыг давж байсан эргvй. Гэтэл Төмөрийг дөч банздаад харахад нvд нь гөлөлзөн шvд нь тачигнаж байжээ. Ингээд Төмөрийг гяндан руу чирээд явж байхдаа «бузгай эр юм даа. Маргааш ах нь дvvгээ дуугаргаж чадна» гэж бардам хэлжээ. Маргааш нь хорь цохиод тvр зогсоход Төмөр амандаа хорь гээд хөлөө хөдөлгөж хэвтрээ засжээ. Бадарч улам хорсож нэг банз хугалсан боловч Төмөр бахь байдгаараа нvдээ гөлийлгөн шvдээ хяхтнуулан хавирч байв.

- Чи чинь чулуу юмуу, хvн юмуу? гэж уурласан тахар асуухад Төмөр

- Жа би хоёр хөлтэй хохимой толгойтой хvн билээ гэж ёжлон хариулав.

Эцэст нь Төмөрийг Бадарч ширлэж байхад Төмөр нvдээ гялалзуулан шvдээ зууж байгаад «Оргоно шvv» гэхэд нь Бадарч ихэмсгээр инээмсэглэж:

- Муу гуйлгачин чи сачий чинь хvрвэл тэгээрэй гэжээ. Цагаан сарын шинийн нэгэнд Бадарч тарган хонины гуяа чанаж очоод том том огтлон өгөхөд нь Төмөр шир, шир зажлан идэх зуур «чи вс, сахлыг минь салгаж өгөхгvй юу» гэхэд

- Оргож гараад салахгvй юу гэж Бадарч тавлажээ. Гэтэл цахиур Төмөр оргожээ. Энэ нь Бадарчийн нэрийг нэгмөсөн хорлосон шившигтэй юм шиг бодогдоод яаж ийж байгаад Төмөрийг заавал барьж, алдсан нэрээ олж авах, ташрамд нь халх даяар цууриатсан сайн эрийг хоёр дахь удаагаа барьсан алдар зvvнэ? гэж бодож байв.

Бадарчийн дор сууж байгаа намхан бvдvvн хvнийг Дамдин гэдэг. Өнгөрсөн жилээс эхлэн тамганы тахар хийж байгаа ажээ. Дамдинд Төмөрийг барих шунал байсангvй. Харин гэнэгvй явж байгаад цохиулчихаж магад гэж зурам давхисан ч цочиж, цогчиг дуугарсан ч сэрвэлзэн явжээ.

- Миний хvv малд явж байхад чинь ганц нэг явган нvцгэн хvн харагдаагvй биз? гэж Итгэлд хөхvvрийн өмнө зогсож байсан Хонгороос асуув.

- Үгvй, ажаагvй гээд Хонгор толгой сэгсрэв.

Хонгорын амьсгаа давхцан, зvрх нь цээжиндээ багтан ядан цохилж «эр хvн эр хvндээ хайртай» гэж сэтгэлдээ шивэгнэн байв. Хөдлөх гэтэл хөхvvрийн өмнө байсан саамын хувинд торж бvдрээд Бадарчийг мөргөж орхив.



- Ямар дүрсгүй хvv вэ. Тархигvйтээд байвал хөнгөлж орхино шvv гэж Бадарч хөмсгөө сvртэй зангидан бvдvvн дуугаар хvнгэнvвлэн хэлэв.

Хонгор Бадарчаас зайлан зогсож нохойд шахуулсан муурын нvдээр ширтэн биеэ хураав.

«Энэ лав намайг Төмөр гуайтай уулзсаныг мэдэж байх шиг. Би хэлэхгvй. Хөнгөлсөн ч хэлэхгvй. Ишиг шиг чарлахгvй, хурга шиг дуугvй байж байгаад л босоод явчихна. Эр хvн, эр хvндээ хайртай» гэж бодов.

- Чи муу хөнгөл дөө. Би ёо гэхгvй гэж Хонгорын хашгирахад нvдэнд нь доголон нулимс тунарав.

- Бэлтэй хvний ганц хvv гэсэндээ шөрмөстэй байна гээд Бадарч нvдээ жартайлган инээв.

- Миний хvv, том хvнтэй ингэж болохгvй гэж Итгэлт хvvгээ зэмлэсэн боловч дотроо «миний хvv ч яггvй эр болно доо» гэж бахдав.

- Ширтэй мөртлөө оргочихдог, аргагvй л сайн эр юм даа гэж Итгэлт толгойгоо алгуур сэжлэв.

- Үчнээс өмнө баригдаж байгаагvй юм шvv гэж Бадарчийн хэлэх дуунд ч «Гэвч би барьсан юм даа» гэсэн бардам өнгө тодорхой байлаа.

Итгэлт өнгөрсөн жил хошуу тамгын жасааны гянданд Төмөртэй дайралджээ. Эр хvн хэзээ нэгэн цагт эндэгдэл болж гянданд заавал ордог гэж урьдын хvmvvc ярьдаг болохоор «Юмыг яаж мэдэх вэ?» гэж бодсон Итгэлт ээлжээ өнгөрvүлэх гэж гяндангийн хуяг нарт хахууль өгч хагас өдөр тамгын жасааны гянданд сууж тэнд байгаа хоригдлуудыг хооллуулж байхдаа ширлvүлсэн Төмөртэй тохиолдож хоол өгөх зуур хэдэн vг ч сольжээ.

Төмөрийн тухай яриаг сонсох тусам Хонгорын сэтгэл хэмжээлшгvй бахархал оволзон хөөрч «Төмөр гуай намайг эр хvн гэсэн шvv дээ» гэж бодогдож байжээ. Гаднаас Нямаа ааруул бувтнан хvлхсээр орж ирлээ.

- Та бvхний амгаланг айлтгая. Тарган тавтай зусаж байна уу?

- Сайн, сайн байна уу? сайхан бороо хур элбэгтэй сайхан зун болж байна. Бадарч тахар хаа хvрч явна даа?

- Цахиур Төмөрийг алдчихаад эрж явна. Нямаа гуай vзээд өгөхгvй юв гэж Бадарчийн хэлэхэд «Манай Нямаа гуай ч шарсан мах андахгvй шар зурхай ч даа» гээд Итгэлт ёжлон инээв.

- Хөгширсөн юм уу мэдэхээ болиод төөрөх нь их болсон байна билээ гэж Нямаа өврөөсөө нандигнан хэлхсэн есөн зоосоо гаргаж шившин vлээхдээ заримдаа нvдээ аньж, заримдаа хошуугаа цорвойлгон их л дvвчин дvр vзvvлэв.

- За даа хачин юм даа. Өөрөө л чиний гарт орох юм шиг буугаад байна. Хөл нь мухардаж, хар арслангийн аманд нар жаргахын өмнө орох бололтой гээд Нямаа зоосоо хэлхэж өвөртлөв.

Бадарч том хул айргийг нэг амьсгаагаар залгилж орхиод Дамдингаа дагуулан явжээ. Хонгор хэдийгээр Төмөрийг энэ муу хоёр барьж чадахгvй. Төмөр гуай эднийг далан дээрээс нь барьж далан гурав, гуян дээрээс нь барьж гучин гурав эргvүлээд шидэж орхино гэж итгэвч, сэтгэл нь зовон байн байн хойт жалга руу харж байлаа.

Итгэлт адуучин нараа цуглуулж «тамган дээрээс цахиур Төмөрийг алдаж гэнэ. Адуугаа шөнө бvр хоёр хvн манаж бай. Хэдэн адуу ч яамай. Харин ганц нэгээрээ Төмөртэй дайралдвал осолтой гэжээ.

Итгэлтийнхээс гараад явж байхдаа «хөөрхий ах манийхаа аав шиг л бидний төлөө зовж байх ю» гэж Галсан хэлэв. Мань Итгэлт хоёр бодолтой хvн дээ. Алтаа бодоход авдраа бодно гэгчээр адуугаа бодоход манийгаа бодож байгаа юм гэж Нямаа ажиггvй хэлэв.

### III

Зуны бvгчим халуун өдөр Богдын хvрээний махны зах дээр хvн тэсэж ч байхын аргагvй

байдаг. Хар батгана амьсгаа давхцуулж, золбин нохой хөлд тээглэн гасална. Цус тос хоёр нэвтэрсэн дээлтэй яргачид багил хар ваадангаар байн байн хөлсөө арчин «өөх идье гэвэл энд байна. Таван цулын шөл уух дуртай хүнд шинэхэн цувдай хямдхан өгнө», «Бүгчим байна бороо орж магад. Эрхтэн өвчүү, хошного авбал дээр биш үү» гэх зэрэг бүдүүн нарийн хоолойгоор хашгирах нь дулдуйчны нэг хөгтэй унжирсан уншлага, гуйлгачны уянгалсан дуу, омогтой хүнд өшиглүүлсэн нохдын гаслахтай холилдон дасаагүй хүнд энд чухам юу болж байгаа нь ойлгогдохгүй ажээ.

Урт сур барьсан мах хүргэгчдийн зарим нь махны бандан түвшин сураа шувтран хааяа нэг эвшээнэ. Зарим нь махны үнэ асуусан хүний хойноос бие биеэ түлхэлцэн хошуурна. Энэ ер бусын шуугиантай захын зүүн талд өрөөсөн суга таягтай, хатанги цонхигор царайтай, уранхай хөх дээлтэй ерийн гуйлгачин залуу эр «олон түмэн ах дүү нар аа, нигүүлсэн үзэж юм хайрлана уу?» гэж уянгалсан намуухан дуугаар хашгирч байв. Зарим хүмүүс түүнээс сэжиглэн зайлж гарна. Зарим нь нэг хоёр улаан мөнгө гар дээр нь шидэж өгнө. Зарим нь өөх тос, боовны хэлтэрхий өгөхөд хар хүвдийнийхээ амыг тосож хийлгэнэ. Зарим нь юу ч өгөхгүй мөртлөө сонирхон харж зогсоно.

Богдод есөн цагаан тэмээ өргөж бэйсийн зэрэг шагнуулсан дотоод яамны түшмэл Довчин саяхан авсан залуу эхнэрээ нүдийг нь бүлтэртэл гоёод эзэн ч андуурмаар ижилхэн хоёр гал зээрд морь унан махан захын хажуугаар өнгөрөв.

- Хөөрхий энэ ядарсан амьтанд юм өгөх юмсан. Өгчихмөөр юм байна уу? гэж залуу эхнэр хэлэв.

- Хонгор минь ялихгүй зусар баяжихад саад. Хүрээний гуйлгачинг бид тэжээж барах биш гэж Довчин хэлээд эргэн тойрныг ихэмсгээр ширвэв.

Гэрэл өврөө уудалж урт аюуш хадаг гаргаад гуйланчин өөд хаяхад морь нь үргэж ухасхийхэд Довчин сандарч эргэн цулбуурдан тогтоож,

- Буян хишиггүй юманд гар сунгаж байж үхэх нь. Бас багшид барих гэсэн хайран хадгийг өгч орхих юм гэж зэмлэв.

- Битгий дэмий ярь, өгөхөд яадаг юм бэ? гээд Гэрэл ширвэв.

- Тийм, тийм гэж Довчин хошуугаа цорвойлгон сандран хэлэв.

Довчин хөрөнгө түрж байж л Богдын засгийн ихсийн эгнээд орсон бөгөөд жилийн өмнө залуу эхнэр Гэрэлээгээ авчээ. Гэрэлийг хүчээр уйлуулж байгаад богтлон авсан боловч удалгүй Гэрэл хүвхэн байдалдаа дасаж, цаг өнгөрөх тусам Довчингийн хөрөнгөний бүрх эрхт эзэн болж, зан нь ширүүсэн хөгшин Довчин залуу эхнэрийн гарт атгагдав. Ингээд нэг мэдэхэд Гэрэлийн үг Довчинд Богдын зарлигтай адил болов.

Гэтэл морин давиран хөдлөхөд Довчин дагаж хөдлөв.

«Арван цагаан буян чинь дэлгэрч яв» гээд гуйлгачин хадгийг авч нандигнан өвөртлөв, өндөр хээр морьтой орос ланчуу буу үүрсэн хөх дээлтэй залуу эр захын өмнүүр гараад зүүн тийш явж байснаа гуйланчинг хараад зогсож, Хуяг уу даа гэж шивэгнэв.

Гайхан бодож нилээд ширтсэнээ ойртон очоод «Хуяг минь чи амьд уу?» гэж дуу алдав.

Гуйлгачин тэр дуунд цочин хараад таньж «Амьдаар барах уу даа амьдрах гэж юм гуйгаад зогсож байна» гэхэд нүднээс нь нулимс дуславал ханцуйгаараа арчаад чичирсэн хоолойгоор «Чи сайн явж байна уу» гэлээ. Хоёр нөхөд элэгсэг дотноор золгов. Ядарч яваа хүн, таньдаг хүнтэйгээ уулзахдаа давхар баяр болдог. Хэцүү амьдралд хамт зовж танилцсан нөхөртэйгээ уулзаад сэтгэлд нь хур бууж, цэцэг ургасан. Хуяг юу ярьж, юу асуухаа мэдэхгүй балмагдан дэмий л «аа өө, тэгээд» гэж давтана.

- Чамайг чинь үхсэн гээд цэргийн лам бодийг чинь хөтөлсөн гэж ирсэн хүн хэлэв.

- Бvр тийм vv... ингэхэд нөгөө дайн юу болсон билээ?

- Тэр тухай яривал бөөн тvvх... өвгөн минь ингэж зогсоод яахав дээ. Энэ шуугиан, vнэр хоёроос зайлья.

Морио хөтлөн зэрэгцэн явж жижигхэн хятад дэлгvврийн vвдний довжоон дээр сvвдэрт тавтай суув. Хуяг бол Сайд вангийн хошууны хvн. Олноо өргөгдсөний хоёрдугаар онд Богд Жавзандамба хааны цэрэгт дайчлагдаж хар цэргийн түрэмгийллийг эсэргvвцсэн өмнө зvгийн тулалдаанд хатан баатар ван Магсаржавын даргалж явсан цэрэгт явжээ.

Арга самбаа, зориг төгөлдөр энэ эр, дайнд сайн оролцож шилдэг цэргийн нэг болов. Хуяг анх Богд хааны цэрэгт дайчлагдан ирэхдээ чухам яах гэж яваагаа мэдээгvй, өөгий нь тааруулж байгаад оргож харих бодолтой байсан. Гэтэл сvвлдээ их монголын тулгуур төрийг байгуулах, өөрийн эзэн хаантай тусгаар улс тогтоох, харийн хvн монгол хvнийг захирах ёсыг vгvй болгох их vйлд оролцож байна гэж ойлгоод сэтгэл санаа нь сэргэж дайрах цэргийн өмнө давхиж, цог жавхлан нь бадарсан билээ.

Ялангуяа хэдэн удаа ялсны дараа дайсан олон боловч «Богд Жавзандамбын аврал, монгол дахины хувь заяагаар сvр хvчин нь бадран ялна» гэж итгэж байлаа. Цахарын нэгэн гацаанд байсан хар цэрэг рvв уухай хашгиран дайрч сандран зугтсан цэргvвдийг мөрдөх хөөх вед гай болж зэрлэг суманд зузаан гуяараа шархдаад мориноос унаж ухаан алдаад хожим сэргэвэл харчин айлд байжээ. Тэнд сар гаруй хэвтэж эдгэрээд зэвсэг хvргээд буцаж явсан жинчинтэй тааралдан дайгдаж Богдын хvрээнд ирээд цэргийн яамны нэгэн тvшмэлтэй уулзаж учир явдлаа хэлж тусламж гуйсан чинь цэргээс оргосон ялтан гээд золтой л шоронд хийчихсэнгvй. Ингээд Богдын хvрээний гуйланчны тоо нэгээр өсөж баатар зоригт гэгдэж байсан Хуяг таяг тулсан гуйлгачин болов.

Ирсэн хvнийг Дорж гэдэг. Луу Гvнийхээс цэрэгт дайчлагдан ирээд ойр зэрэглээ хошууны улс гэж Хуягтай дотно танилцсан бөгөөд Хуягийн олзолсон сумнаас нэлээдийг хvртсэн билээ.

За ингээд чамаас хойш бид гэгээний авралаар хар цэргийг хиартал цохиод зарим газраар хэрмэнд ойрхон очсон. Ер нь Бээжингийн нохойн дуу бараг сонсогдож байсан шvv. Бид номхон хонь биш, эзэн Чингисийн угсаа эрэлхэг зоригт монгол гэдгээ vзvvлсэн дээ.

- Одоо манай цэрэг хаа хvрээд байна?

- Нутагтаа буцаад ирсэн гэж Дорж урамгvй хэлэв.

- Яагаад тэр билээ

- Хэн мэдэх вэ. Энэ хавар л татаж орхисон.

1941 онд монгол өөрийн цэргийг хаант орон улсын шахалтаар Дотоод монголын нутгаас татсан юм. Доржийн байсан анги хар цэрэгтэй гурван өдөр vргэлжлэн тулалдаж бут цохиод цахарын нэгэн гацааны дэргэд буудаллаад байж билээ. Утаа болсон уранхай майхнуудаа зэрэгцvвлэн шааж туг хиураа босгон агт морьдоо тавьж, манаа харуулаа гаргасан нь ялсан цэргийн vр жавхаатай нийлж цог хийморьтой харагдаж байв.

Майхнуудын гадна ил гал тvлж зарим нь хоол ундаа хийж, зарим нь хувцас хунараа оёж, зарим нь бөөс хуурсаа арилгаж эхлэв. Ил галын утаа хамар руу цоргин, нялх ногоо амсаж эхэлсэн морьд нь тургилдан урагштай яваа цэргийн сэтгэл ханагар сайхан байв.

Дорж майхны хажууд сууж дуу аялан, дээлийн уранхайг оёж байтал Дархан бэйсийн хошуун нэг ахимаг насны цэрэг ирж дэргэд нь суугаад шууд цамцаа тайлж бөөсий нь тvvн газар амьдаар нь хаялав.

«Алж идэхээр таргалуулах гэж байгаа биш дээ. Ил гал дээр барьж байгаад шатааж орхихгvй юу тун амархан салдаг юм» гэж Доржийг хэлэхэд ахимаг насны цэрэг ёжтой

инээмсэглэсэнээ:

«Монгол нутгийн минь бөөс» гээд тvvх ажлаа ажиггvй vргэлжлvвлэв. Эгнэсэн майхны аль нэгэнд нь тас хийсэн шингэн хоолойгоор «Зуун лангийн жороо луусыг» гэтэл паргисан бvдvvн хоолой «жаазан дундаа хөлөглөө» гэж дуултал янз бvрийн хоолойгоор «зураг болсон Богд ламыг Зонховын ширээнд залья даа хө» гээд vргэлжлvвлэн дуулав.

Дорж, ахимаг насны цэрэг хоёр ч намуухнаар олныг аялдан дуулжээ.

- Энэ дайн хэзээ дуусах бол? гэж ахимаг насны цэрэг дууны хоёр бадгийн дундуур асуув.

- Далдыг мэддэг далай лам далан хоёр жалгыг нэвт хардаг хар хэрээ биш, би яаж мэддэг юм бэ? гэж Дорж хариулав

- Тvvх яривал эзэн Чингис байна. Дааж байгаа сахиусыг хэлэлцвэл амьтныг жаргуулагч очир дарийн хувилгаан богд гэгээн, оройлж яваа жанжныг яривал хатан баатар хойно болох л байх даа. Саяны дайныг удирдаж байхад нь жанжны нvvр нь малгайнхаа сагалдарганд багтахгvй болоод амнаас нь улаан хөөс цахарч байсан гэдэг шvv.

- Аргагvй шvv дээ. Биеэрээ улаан сахиус юм чинь гэж Дорж мэдэмхий хариулав.

Мань хоёрын яриа тvр зогсов. Дуу солигдож цээлхэн сайхан хоолойтой хvн «эр бор харцагыг» сэтгэл догдлон дуулав.

- Гэртээ хариад, халаасан арз тагшийг уучихаад, эхнэрийнхээ дээлийг нөмөрчихөөд хотныхоо захад зогсож байх юмсан гэж нөгөө цэрэг нvдээ гялалзуулан нvvр дvvрэн баяр тодруулж байгаад ярилаа.

- Мань эр эхнэрээ санаж дээ гээд Дорж хөгжилтэй инээв

- Айхгvй ч гэсэн аягvй гэгчээр муу золиг чинь сэтгэлд ороод л байх юм гэж цэрэг гэнэн цагаан сэтгэлээр хэлэв.

- Би ч гэсэн ганц муу эхээ орхиод ирсэн юмсан. Яаж явдаг бол доо гээд Дорж утсаа шvдээрээ тас хийтэл таслаад газар руу чиглэсэн юмгvй ширтэв.

- За тэр ч яахав. Эхэлсэн хойно дуусах л байх гээд цэрэг санаа алдсанаа, чамд шvvр байна уу. Энэ хэдэн хялгасны сvрэг газар сайгvй vрлэчихээд билчиж явдаг боллоо гэлээ.

- Дорж нарийн хулсан шvvрээ гаргаж өглөө. Цэрэг авч всээ самнах зуур Доржийн зөв талын урьдах ганзаганаас ягштал уясан бор хvvдийтэй юмыг харлаа.

- Тэр юу вэ?

- Аль?

- Чиний ганзаганд байгаа бор хvvдийтэй

- Аа тэр vv, цагаан мөөг

- Тvvгээр яах нь вэ

- Чамд байхгvй гэж vv? гээд Дорж нөхрийгөө урьд өмнө vзээгvй сонин юм харж байгаа нvдээр гайхан харснаа «халууны газар ганц хэрэг болдог юм чинь энэ байхгvй юу. Худалдвал мөнгө, уувал эм шvv дээ» гэж их мэдэмхий хэллээ.

- Тийм хэрэгтэй юм бол надад жаахан өгөөч

- Бага бол болно. Гэхдээ сумаар солино

- Ахимаг насны цэрэг бодол болон дуугvй болов.

Гэтэл ямаан бvрээ жингэнэн дуугарав. Мань хоёр огло всрэн босож, тус тусынхаа майхан руу гvйн орж буу зэвсгээ зvvн аравтынхаа жагсаалд оров. Бvх цэрэг хэдэн эгнээ болон жагсаж, занги захирагч нар өмнө нь зогссоныг харвал ямар нэгэн их хvн ирэхийг хvlээжээ.

Жагссан цэргийн баруун гараас таван морьтой хvн хатируулан давхиж ирлээ. Тэдний тvрvvнд улаан хэлтэй хударга хөмөлдрөгтэй өдөр бор морь унасан хатанбаатар Магсаржав явах бөгөөд морин дээр бvдvvн хар гэзэг нь хоёр тийшээ цацлан хаяж, отог нь сагсалзан

сүртэйгээ харагдана.

Түүхийн цаг нь хэрэгтэй хүнээ бойжуулдаг. Монголын ард түмэн манжийн ноёрхлыг эсэргүүцсэн олон зуун жилийн тэмцлийн сүүлчийн шийдвэрлэх үед төрж гарсан их хүмүүсийн нэг бол хатанбаатар Магсаржав байж билээ. Цутгамал хүрэл шиг гялалзсан хүрэн царайтай, өргөн цээж, тод магнайтай энэ хүн манжаас тусгаарлах тэмцлийн тэргүүнд явж, явсан газар бүхэн нь ялалтаар туяарч байжээ. Вангийн зэрэг залгаж, хошуу ноён болсон бөгөөд монголын ард түмнийг боолчлон суух нь дууссаныг ойлгож, эвээр нутагтаа буцах шаардлагыг хүлээж авалгүй эсэргүүцсэн Ховдын амбаныг зэвсгийн хүчээр тонилгох тэмцлийг хатанбаатар ван Магсаржав удирдсан билээ.

Дайсныг цохиж тулалдааныг хожиход зэвсэг барьсан цэрэг гол хүч гэж бат итгэсэн энэ хүн цэргийн сэтгэлийг ямагт засаж, цэргийг өөртөө татахын тулд бүхнийг хийдэг. Цэрэгтээ үргэлж анхаарч, тэдэнд унасан газар, угаасан ус нь юу юм бэ, яах гэж байгааг ярьж тэдний сүсэг бишрэлийг ашиглан, өөрөө чойжин болох зэрэг олон аргыг хэрэглэн цэргийн дотор үлэмж алдаг хүндийг олоод, тэдний гүн хайр, бат итгэлийг татжээ. Магсаржавыг цэргүүд нь багш гэж нэрлэх бөгөөд түүний ер бусын хүчинд итгээд эргэлзээгүй сүсэглэн итгэсэнээ: Баатар багштай явсан цагт заяа орхиж, од харван, шоо цайгаагүй юм бол алзахгүй. Ирсэн сум, далайсан сэлмээс зайлуулж чадах улаан сахиусны хувилгаан хүн гэж цэргүүд ярилцдаг байв. Ховдын сангийн хотыг байлдсан тулалдаанд зугтаасан нэг цэргийг барин авчирч өгөхөд «Хүү минь даанч дээ. Би чамайг шийтгэхгүй, төрсөн нутагтаа хар буруу санасан болохоор заяа чинь орхиж гүйсэн» гээд явуулсан бөгөөд дэргэдээ байсан хүмүүст «энэ цэрэг дараагийн тулалдаанд үхнэ шүү, хөөрхий» гэж хэлсэн ажээ.

Хоёр өдрийн дараа болсон тулалдаанд тэр хүн үнэхээр алагдсан бөгөөд хүүрийг нь үзээд «Та нар харж байна уу? Шилээрээ шарх аваад газар мөргөж үхсэн байна шүү. дайсны сум биш, орон нутгийн сахиусны сум бололтой» гэжээ. Цэргүүд энэ явдлын тухай сонсоод Хатанбаатарын мэргэн чадлыг хэт өсгөн ярьж байснаас биш тэр цэргийн араас нь чухам хэн буудсан тухай ярих нь битгий хэл санасан хүн үгүй билээ.

Хатанбаатар Магсаржав хар цэргийн довтолгооныг эсэргүүцсэн монголын гол замын цэргийг захирч байлдаад, түргэн зуур дайсны давшилтыг зогсоон эсрэг довтолж үлэмж газрыг эзэлжээ. Бидэнд хүний нутаг хэрэггүй. Харин манжийн хар тамхинд унтсан монгол сэргэж боссон цагт зангасан гараа дальдрахын оронд хацар дунд нь таван салаа боов хүртээж чадна гэдгийг үзүүлэх ёстой юм шүү гэж хэлдэг байв. Хатанбаатар гурван улсын гэрээг зөвшөөрөөгүй. Гэхдээ нэгэнт орос хятад хоёрыг салгаж чадаагүй болохоор өөр зам харагдаагүй билээ. Энэ учраас аргагүй цагийг хүлээж их хэргийг бүтээх нь чухал гэж бодож байлаа. Монгол улс тусгаар улс болтол бид морь буу хоёроосоо салахгүй. Бид хүч нимгэн, хүн цөөхөн, гэвч биднийг эзлэх гэвэл чадлаараа тэмцэнэ. Ингээд монгол нутаг дээр нэг ч эр хүн унах ганц морьгүй болсон цагт тэмцэл дуусаж магад гэж дахин давтан хэлдэг байлаа.

Хар цэргийн төлөөлөгч, бууж өгвөл их мөнгө, өндөр хэргэм өгнө гэж хэлэхэд Манжийн өгсөн мөнгө хоолой дээр тээглэхчээ дахин мөнгө орох зай алга. Харин монгол хярамцаг идвэл бие сайжирна гэж оточ хэлсэн гэж хариулжээ. Хатанбаатарыг жагсаалын өмнө ирээд зогсоход олон цэргүүд хурай гэж нижигнүүлэн хашгирав.

Занги, хүнд нар яавал хатанбаатарын нүдэнд тусах бол гэсэн бололтой зарим нь толгойгоо шилэн дээрээ тавин, цээжээ түрэн зогсоно. Зарим нь амаа жимийлгэн, хамраа сартайлган хэв дүрсээ алдан байна. Хатанбаатарын морь нь тогтон ядан, газар цавчилж хазаар дарна. «Олон цэргүүд ээ, Монгол орос хятад гурван улсын хооронд гэрээ байгуулагдаж, манай улс өөрийн цэргийг гэдрэг нь татах болжээ. Би нийслэл хүрээ рүү өнөөдөр явна. Та бүхэн ойрын

өдрүүдэд буцах билээ. Бид хийх бүхнээ хийсэн болохоор хойч үе талархан дурсаж түүх дэвтэртээ бичнэ. Тусгаар тогтносон монгол улс бат оршиг» гэхэд олон цэрэг нэгэн зэрэг хурай гэж хашгирав.

Хатанбаатар Магсаржав жагссан цэргүүдийг захаас нь зах хүртэл хоёр дахин харснаа морины амыг эргүүлж явахад дагалдагсад нь бас явлаа. Хатанбаатарын өлмий бат оршиг гэж нэг цэрэг хашгирахад бүх цэрэг хурай гэж нижигнүүлэн хашгирав. Цэргүүд тарж майхан, майхны зүг явлаа. Дорж майхны хаяанд очоод зогстол нэгэн цэрэг дэргэд нь ирж «Өвгөөн, ингээд эндээс явах хэрэг үү?» гэж асуув.

- Тийм л болж дээ. Богд Жавзандамба хутагт нэгийг мэдэж байгаа байх даа гэж гомдолтой хэлэв.

- Монгол хүн амны билгээр гэж энэ дээ. Саяхан л ярьж байсан. Одоо ч нутагтаа харина даа гэж нөгөө ахимаг насны цэрэг хэлэв.

Дорж хариу дуугарсангүй. Ялж байсан дайнаа зогсоод, эзэлж авсан газраа хаяад буцах нь шившигтэй хэрэг шиг бодогдож байсан боловч нэгэнт энэ бол Богдын зарлиг болохоор буруу юу гэж хэлэх хүсэл байсангүй. Богд Жавзандамба надаас илүү мэдэж байгаа болохоор ингэх л ёстой байсан юм байх гэж хүчлэн бодовч харамсах, хайрлах, сэтгэл нь уул явдлыг дахин дахин бодогдуулна.

Хэдэн өдрийн дараа монголын цэрэг нутгийн зүг хөдлөхөд байран дээр нь жижиг боодолтой хатсан цагаан мөөг энд тэндгүй түгдийн хэвтэж байлаа. Ирэхэд нь тахил өргөж, баярлалдан, хүүхэд багачууд нь хэрэлдэн гүйж байсан айлуудаас гарсан нэг хоёр хүн дуу шуу ч үгүй харж зогсоно. Энэ бүхнийг хараад «Ах дүү нар минь Богд Жавзандамба хутагт нэг юм болгоож байгаа» хашгирмаар санагдаж байв. Арын эгнээнд нь гэртээ харьж, эхнэр хүүхэдтэйгээ амьд мэнд уулзсаны баяр хийх тухай ярьж явсан нэгэн цэргийн дуу олон жил суусан үглээ эхнэрийнхээ дууг, өлсөж ирээд хоол идэж байхдаа, сонсож байгаа хүний сэтгэлийг Доржид төрүүлж байв. Дорж урьд ганзагаа өөрөө мэдэлгүй оролдож яваад тайлсанд хүүдийтэй мөөг пад хийн унахад морь нь бусган ухасхийсэн боловч төдий л юм болсонгүй. Олон морины хөлд босон хуурай тоос хамар ам руу орж, хөлстэй зууралдан, үдийн нар дээрээс шарж зуны цагт том тогоо боов чанаж байгаа жижигхэн гэрт байгаа мэт бөгчим байжээ.

Дорж энэ бүхнээ Хуягт ярьж, гунигтайгаар урт санаа алдаад: «Баатар цагаан хааны баруун гарын түшмэл Коростай ноён гэгч Даа лам, чин сүшигт чин ван Цэрэнчимидийг ёс журам үгүй, муухай харааж, өгсөн бичгий нь базаад нүүр рүү нь шидсэн гэнэ. Ер нь биднийг хятад орос хоёр хавсайдах санаатай даг шүү гэв.

- Хоёуланг нь барилдуулчих арга байдаггүй юм байх даа гэж Хуяг хэлбэл

- Байхгүй бололтой... Ар хиагтад манай улсыг хятадын нэгэн хэсэг газар гэж бичиг хийгээд гарын үсэг зур гэхэд нь манлай ван Дамдинсүрэн өвгөд дээдсийн төрж өссөн нутгаа харь улсад өгсөн бузар бичигт гарын хуаюур зурж түмэн үе жигшигдэх нэртэй болохгүй гээд сэлмээ агссан чинь буцаагаад явуулсан гэнэ. Манлай ван ч аргагүй л эр хүн юм даа хөөрхий гэж төрийн явдлын тухай сонссон яриагаа Дорж дуусгав.

Хуяг хүрээнд таних айлгүй тэнүүлэн гуйланчилж яваа амьдралаа нөхөртөө ярихад «Чамайг би таньдаг айлдаа хүргэж өгье. Бас үүнийг ав» гээд тос болсон алчуурт боосон арван мөнгөн янчаанаа өгөв. Ер нь чи богд эзэнд гавьяа айлтгавал лав зүгээр өнгөрөхгүй. Нөгөө манай зуутын Яринпэл баатар болсон, би ч бас горьдож байгаа гэж Дорж цээжээ хөдөлгөн хэлэв. Хуяг хариу дуугарсангүй босов. Ингээд тэр хоёр Доржийн таньдаг айлд очихоор явлаа. Хүрээний халуун улам их болж үмхий шавар хамар хорсгон бие хувцас хоёр цавуугаар

наалдуулсан мэт зууралдана.

#### IV

Шөнийн харанхуйд Тамирын голын хөндийг өгсөж нуруугаа үүрсэн явган хүн алхална. Пад харанхуй шөнө тэнгэрт од гялалзавч гутлын үзүүр ч харагдахгүй ажээ. Хөндий дагаж шөнийн сэрүүн салхи бүхнийг ариутган үлээнэ. Тэр хүн хэсэг явж зогсож, зүг бүр чих тавин чагнаж байснаа харанхуйн дунд шуугиан урсаж байгаа голын эрэг дээр очиж түрүү урагшаа харан хэвтээд хүд хүд хийтэл баахан залгилав. Дараа нь нүүр гараа угааж, өмссөн цувын хормойгоор арчив. Энэ бол Төмөр байжээ. Ус уугаад босож хэд дахин алдлан суниагаад, түмэн зүйлийн үнэр ханхалсан хөндийн салхи залгин цээж дүүрэн амьсгалж «Орох нэг өдөр байхад, оргох нэгэн өдөр бий» гэж зөөлөн хоолойгоор аялаад хэсэг явснаа зогсож ногоон зүлгэн дээр хэвтэж тал бүхнийг ажиглан чагнаснаа ямар нэгэн чимээ сонссон бололтой түргэн түргэн алхлав. Ингээд удалгүй Эрдэнийн аргамжаатай морины дэргэд очив. «Ядарсан хүний ганц унаа болов уу» гэж бодоод хэсэг зогсов. Гэтэл энэ бодлын хажуугаар Бадарч тахрын царай, жил гаруй ширтэй хэвтсэн зовуурьт хатуу амьдрал сэтгэлд нь орж дахиад түвний гарт орвол амьд гарахгүй шүү дээ гэж бодогдов.

Авах, авахгүй гэсэн ац сэтгэлд дарагдан ямар ч шийдвэргүй хэсэг зогсов. «За гайгүй эр хүний замын хүзүү урт, зааны хүзүү богино» гэж шивэгнээд морийг шийдэмгий хазаарлан авч майхнаас нилээд холдоод мордож Тамирыг гатлан давхилаа. Ингэж дүү нь ахынхаа ганц морийг авч хүний нутаг, гүний газар гахай явган болгожээ. Төмөр маргааш нь өдөр турш модонд бүгж байгаад шөнө цааш хөдөлж айлын гадна эмээлтэй нь уяж хоносон морь авч хос морьтой болоод нутгийн зүг тэмүүлэв. Уулаас өлсгөлөн байсан Төмөр оргосноос хойш Хонгорын өгсөн тосноос өөр юм идээгүй болохоор дотор байн байн харанхуйлан нүд эрээлжилнэ. Өглөө эрт нэгэн уул дээр гарч ирвэл тэр дор аманд ганц бор гэр харагдахад нь шууд очив.

- Нохой хорио гэж Төмөр бүдүүн дуугаар хэлэхэд гэрээс хорь гаруй насны залуу гэээгт гарч ирээд нарийн суран хүзүүвчтэй бүдүүн хар нохойг зандран барив. Гэрт ахимаг насны хар хүн сур элдэж, зүүн талын орон дээр 3-4 настай хүвхэд унтаж байлаа.

- Сайн байна уу?

- Сайн, сайн байна уу?

- Тарган тавтай зусаж байна уу?

- Сайхан зусаж байна. сайхан зусаж байна уу?

Төмөр зүүн орны өмнө сууж байгаа хар хүнтэй нутаг ус, алдар нэрээ асуулцав. Өөрийгөө Дашдоо гүний хошууны анчин Жаргал гэдэг хүн. Олон хоног уулаар ан гөрөө хийж яваад мориноосоо унаж буу зэвсэг, хоол хүнснээсээ салж үхэхийн даваан дээр ирлээ гэж зохион ярилаа. Гэвч хүвхэн сорьж үзэхээр шийдэж гэрээсээ гараад буцаж орж ирмэгц «Энэ хойноос хэдэн морьтой хүн давхилдан айсуй» гээд Төмөр рүү харлаа.

Хүвхний гэнэн нүднээс бүх санаагий нь ажиж мэдсэн Төмөр тавтай завилан суух зуур «Явуулын улс байлгүй. Сохор газар нутгийн хүнтэй уулзаж, төөрч төөрч төрөлдөө гэгчээр гялайх юм биш байгаа даа» гээд инээмсэглэв. Цай буцалж хүвхэн данх дүүрэн цай, хүрэн модон таваг овоолон шинэ ааруул, өрөм тавьж өгөв.

Монголчууд явуулын хүнд «царай алдсан газар» гэж хошуу нутгаа хэлүүлэхгүй харин «Тэр хошууныхан цайтай, царайтай» гэж магтуулж байхыг хичээдэг. Энэ учраас ирсэн зочинд байгаа юмныхаа олигтойг барьж дайлдаг заншилтай. Зочинд харамлах шиг шившигтэй юм байдаггүй болохоор харамласан хүний нутаг усныхан нэрийг бузарлав гэж жишин хочилдог. Гэрийн эзэн нэр хичээж харь хошууны хүнд борц нүдэж хоол хийж өглөө. Төмөр энэ айлд

нар ханын элэг өнгөртөл байв. Хvvхнээр гэзгээ самнуулж, сахлаасаа саллаа. Хар хvний нэрийг Өлзий гэдэг. Хvvхний нэрийг Цэнд гэдэг ажээ. Өлзийн хvv, Цэндийн нөхөр Хуяг Богд хааны цэрэгт татагдаж яваад сураггvй болжээ. Эцгээсээ хоёр настай хоцорсон хvv Хврэл нь Төмөрийг гэзгээ самнуулж байхад энд тэнд нь гарч сонирхон байлаа. Гэдэс гарч хvч орсон Төмөр явах гэж байтал Сайд вангийн догшин сахиус гэж алдаршсан Пvрэв тайж ирлээ. Өлзий сандарч «Тайж ахайтан минь миний бор гэрийг гийгvvлсэн их завшааныг өчvvхэн боол бишрэвч барахгvй» гэж олбог дэвсэж алга хавсран бөхөлзөв.

Үлэмж халамцаг тайж архи нэхээд байхгvй болохоор нь «Царай алдсан гуйланчин», «Нутаг бузарласан новш» гэж агсганав. Согтуу тайжийн тачаангуй нvд Цэнд хvvхнээс салахаа больж Төмөрийг байн байн өлөн чонын хурц нvдээр ширвэж байлаа.

- Миний бие баахан согтуу байгаа учир энэ бvсгvйгээр хvргvvлнэ. Даруй морио эмээллээд намайг бараа болж яв гэж тайж Цэндэд хандаж хэлээд шууд гарлаа. Өнгө зvстэй залуу бvсгvйчvvдийг бузарлаж нэр гарсан тачаангуй тайжийн далд санааг ойлгосон Өлзий сандран дагаж гарлаа.

- Тэнгэр язгуурт тайж ахайтныг өчvvхэн боол өөрийн биеэр хvргэж өгье гэсэнд тайж уурлан догширч «гуя чинь загатнаагvй юм бол хэлснээр явуул» гэж хашгирахад нь Өлзий өмнө нь сөхрөн унаж байв.

Тайжийн нvд нь таталдан уурлаж бvдvvн тэнзэн ташуураар балбав. Энэ бvхнийг харсан Төмөр тэсэж чадсангvй шуугин очиж «хамжлагаа хазсан тайж, хаяагаа хадарсан луйварчин гэгчээр энэ хvн өчvvхэн ч гэм хийгээгvй байхад та дэндvv хэрцгий байна» гэсэн чинь тайжийн уур омог галд орсон дарь шиг оволзон асаж «чи хаа газрын гуйланчин бэ? Сайд вангийн Пvрэв тайж авгаа танихгvй байна уу?» гээд ташуураа далайн ирлээ.

Төмөр ташуурыг нь булааж аваад тvlхэн орхисон чинь омогтой тайж ардаа байсан шээзгий дээгvvр давж всрэн унав. Тайж босоод Өлзий рvv «Өчvvхэн боол чи цадиггvй амьтныг орогнуулж эзэн Чингис хааны угсааг аймшиггvй доромжилно гэнээ. Хойт өдөр хонгон дээр чинь хулсан банз буусан цагт ямар ял хийсэндээ гэмшинэ» гээд гэрийн бvслvvрээс мориныхоо цулбуурыг тайлах гэтэл Төмөр шилэн дээрээс нь базан авч сарвалзуулан өргөв.

- Уул харах нvдгvй, уушиг даах шvдгvй болсон байж яасан сэхvvн золиг вэ? муу зөнөг чи эднийг оролдож өшөө, хонзон өвөрлөвөл багалзуурыг чинь шахаж бодийг чинь хөтөлнө мэдэх vv? гэхэд Өлзийн дөрвөн ханатай гэр доргих шиг болов.

Тайжийн уусан архи, уурласан уур ор сураггvй алга болж бvх бие нь чичрэн, амь эвлэж ядан байхыг харсан Цэнд өөрийн эрхгvй инээд алдав. Харин хэрцгий тайжийн хойт өдрийн балгаас ухаан алдан айсан Өлзий «Дvv минь болиоч. Ядарсан намайг хэрэгт хийлээ» гэж vглэв. Төмөр хоёр дахин хvчтэй сэгсрээд газар тавихад тайж бөгсөөрөө лагхийтэл суув.

- Өчvvхэн амь өршөө. Их эрийн алдрыг хэн гэдэг бол гэж тайж бачимдан тасалдсан дуугаар асуув.

- Засагт ханы цахиур Төмөр гэгчийг сонссон уу гэж зуусан шvднийхээ завсраар асуув. Энэ алдаршсан шилийн оргодлын нэрийг Пvрэв тайж олонтой сонссоноор барахгvй Луу гvний тамганаас оргосон тухай өнөө өглөө дуулжээ. Энэ нэрийг сонсмогц тайж өвдөг дээрээ сөхрөн нvvр нь vрчийн уйлах, инээх хосолсон нvдээр Төмөрийн доороос нь гөлөлзөн харж «Өчvvхэн би их эрийг таньсангvй. Амь өршөө» гэж дахин давтан гуйхад магнайд нь хvйтэн хөлс бурзайн байлаа.

Өлзий ч энэ алдарт эрийн тухай яриаг бишгvй сонсож байсан болохоор vг ч дуугарч чадалгvй дэмий л амаа ангайн гайхав. Төмөр өтгөн хар хөмсөгтэй, том алаг нvдээ эргэлдvvлэн инээмсэглэж «Өлзий гуай сайн сууж байгаарай. Би эргэж байна» гээд царай нь хувирч,



хөмсөг нь атиран шүдээ зууж, тайжийг долоовор хуруугаараа чичилж, «тэгээд харин уу... Төмөр хэлсэндээ хүрнэ шүү» гэхэд нь тайжийн царай галд хийсэн шар тосны гүзээ шиг хуниран «жа» гээд алгаа хавсрав.

Төмөр мориндоо мордон дөрөөн дээрээ босоод баруун зүг хатируулан холдоход бахдан харж байсан Өлзий гэнэт ухаан орсон бололтой эргэж Цэнд минь тахил өргө гэхэд нүдний өмнө нь болж өнгөрсөн үлгэр шиг юмны учрыг олж ядан гайхаж байсан хvvхэн гэрт орж хувинтай сvv цацлаа авчраад есөнтөө тахил өргөв.

Доод хvчтэнтэй тохиолдохдоо ямар ч бузар хэрэг хийхээс буцдагвй боловч хvчтэнтэй уулзсан цагтаа ямар ч доромжлолыг тэсвэрлэн хvlээж чаддаг хvmvvсийн нэг бол Пvрэв тайж байжээ. Халх даяар нэр гарсан цахиур Төмөр хэлсэндээ эрх биш хүрнэ гэж бодсон Пvрэв тайж босож Өлзий өөд ихэнх нь унасан vүдэн шүдээ ярзайлган инээмсэглэсэн болоод мордож ум хумгvй давхилаа.

## V

Тэрэгний ганц морио алдаж харь нутагт явгарсан Эрдэнэ Долгорыг харахад төрсөн эхээ хөдөөлvvлж ирээд бие биеэ уруу татахгvйг хичээн сууж байгаа ах дvv хоёр шиг л байв. Бат морио алдсаныг сэрмэгц мэдэж эцэг эхийн гуниг сэтгэлд нь дамжин, ямар нэгэн хэцvv хар юм орогшиж байв.

- Аав аа бид морьгvй яана аа?

- Зvгээр миний хvv, болно гээд эцэг нь хvvгээ харснаа хөлс шороо анхилсан толгойг нь vнсэв.

- Ээж та уйлж байна уу даа? гэхэд нь Долгор хvvгээ тэвэрч элгэндээ наагаад «Миний хvv, бид гурав яасан азгvй улс вэ дээ?» гээд шивэгнэхэд хацры нь дагаж халуун нулимс урсав.

Тэр гурвыг ингэж байхад майхан руу морьтой хоёр хvн хатируулан ирлээ. Энэ бол Бадарч, Дамдин хоёр ажээ. Төмөрийг олох нь битгий хэл, мөр сураг гаргаж чадаагvйдээ Бадарч хорсон бухимдаж дайралдсан гэмгvй хvнийг хvртэл бvдvvн тэнзэн ташуураар ухаан алдтал нь занчиж явлаа. Чийгтэй зөөлөн хөрсөн дээр хатирч яваа морины төвөргөөнд пэд пад дуугарсаар морьтой хvн майханд ойртож ирснийг Эрдэнэ мэдсэн авч гарсангvй.

Юун улс вэ? бушуу гараад ир гэж Бадарч өндөр дуугаар зандран хашгирав.

Хантаазаар нь тамганы тахар байна гэж таньсан Эрдэнэ хvний нутагт ямар нэгэн будлианд орохоос болгоомжлон бушуухан босоод гарлаа.

- Танай vүгээр ганц нэг сэжигтэй хvн яваагvй биз? гэж Бадарч бvдvvн тэнзэн ташуураа мориныхоо шилэн дээгvvр хөндлөн барьж сvр бадруулан асуув.

- Явсан байхаа. Урьд шөнө тэрэгний ганц морийг минь мулталчихсан гэж Эрдэнэ намуухан дуугаар өчив.

- Юу гэнээ. Морио харж чадахгvй оргодолд хөл залгаж өгнө гэнээ гэж хэлэхэд Бадарчийн нvvрний бvх арьс нь хянган хамар дээр нь бөөгнөрөв. «Морио алдсан хvн бурууддаг бол хулгайчаа алдаж, замын ядарсан над шиг амьтныг явгалсан та давхар буруутай байх даа» гэж хэлмээр Эрдэнэд санагдсан боловч дахин ямар ч зовлонд орж болно гэж болгоомжлоод тэгж хэлсэнгvй.

- Хаанаас даа. Бид хол газраас Богдод мөргөх гэж яваа цагаачин байна гэж Эрдэнэ тайван хэлжээ.

- Урьд шөнө хэдийд морио алдав гэж Бадарчийг асуухад Эрдэнэ тэсэж чадсангvй.

- Хэдийд ирж авсныг мэдсэн бол би хаанаас адах билээ дээ. Дор нь барьж аваад та бvхэнд тушаачихгvй юу гэж хариулахад Бадарч бvдvvн дуугаар пар пар инээв.

Дамдин руугаа харж «барина гэнэ шvv. Энэ зэргийн жулдрай хvv барих юм гэнэ. Мөн бордог

эр ээ» гэснээ гэнэт инээхээ больж хөмсгөө зангидан «Гуйлгачин минь чам шиг юманд баригдах эр биш. Будааныхаа савтай хоцорсноо их аз гэж мэд. Засагт ханы цахиур Төмөрт морио алдсанаа мэдэж байна уу. Барина гэнэ шvv» гэж дахин инээв. Жил гаруй сургийг нь сонсоогүй ганц дvvгээ амьд мэнд явааг гэнэт сонсоод Эрдэнийн царай хувиран баярын туяа тодров. Эрдэнийн энэ байдлыг хашир Бадарч ажиж амжив.

- Муу нохой чи Төмөрийн нэрийг сонсоод өөр болдог чинь юу билээ? Хавсаа нь уу? гэж асуух зуур Төмөрийг алдаж хугарсан нэрээ бvтэн болгох нэг арга бодов.

Ширтэй Төмөрийг барьж чадаагүй хойно морьтой Төмөрийг барина гэдэг нь алганы хонхорхойг хазахтай адил хэрэг байлаа. Энэ учраас ямар нэгэн хvнийг оргуулсан хэрэгт тулгаж, банзны хvчээр хvlлээлгэвэл нэр нь цэвэршиж болох мэт санагдав. Гэтэл хэргийн учир буруудаж байгааг ойлгосон Эрдэнэ «будааныхаа савтай vлдсэн минь бурхны аврал гэж бодоод баярлаж байна» гэж ажиггүй хариулав.

Бадарч хөмсгөө зангидав. Эрдэнийг ажиглав. Өмнө нь зогсож байгаа энэ хvний хувцас нь муу боловч гялалзаж байгаа нvд, өргөн ханхар мөр, хэлж байгаа vг яриа нь тийм ч амар эр биш байлаа. Инээд Бадарчийн санаанд орсон бодол гэнэт замхран алга болов.

- Муу оргодол гуйлгачныг хаа байгаа гэж эрдэг билээ гэж Дамдинд хэлснээ За юу ч гэсэн гол өгсөө гэлээ.

- Ээ дээ, Бааяа минь олдох нь өнгөрсөн байх аа гэж Дамдин хэлэв

Ингээд хоёр тахар морио ташуурдан явахад Эрдэнэ ширтэн хоцров.

«Аваа яасан аймаар хvн бэ?» гэж хажууд нь наалдан зогсож байсан Батыг хэлэхэд Эрдэнэ хvвгийнхээ толгойг энхрийлэн илээд Долгорт хандаж «Явуулын хvний ганцыг авсныг бодоход дvv минь ядарч дээ. Морины учир ч ийм байжээ, харин...» гээд vгээ тасалж бодол болов. Морь худалдаж авъя гэхэд бэлхэн тоолох бэлгүй болохоор юу ч гэсэн энд тэнд хонож хvнтэй уулзан арга зай хайхаас өөр зам байсангүй.

За хө. Би тэр гурван гэрт очиж унаа гуйя. Айл бараадвал дээр. Ядаж аяга тараг cvv олдох байх гээд Эрдэнэ тэртээ харагдаж байгаа Итгэлтийн хот руу алхав.

Тэнгэрт өчvvхэн ч vvлгүй бөгөөд хурц нар хайр найргүй шарж, өнтэй зуны урт ногоо хөлд нь орооцолдож байлаа. Эрдэнэ хэдийгээр нуруугаа vvрэн, нилээд бөхийн хvчлэн алхавч газар нь дөхөхгүй ажээ. Дээгvvр нь хоёр ангир дэвэн ниссээр өнгөрөхөд атаархсан нvдээр ширтэж баахан зогсоод далд ороход нь санаа алдсанаа ханцуйгаар хөлсөө арчаад алхав. Явсан хvн зогссон юманд хvрдэг болохоор Эрдэнэ Итгэлтийн том гэрт орж амар мэндийг асуулцан суугаад хийж өгсөн том хул айргийг уух зуур Богдод мөргөхөөр явж байгаад ганц морио хулгайд алдсан тухай яриад айл бараадах унаа гуйв.

Тамган дээрээс цахиур Төмөрийг алдсан гэнэ билээ. Морийг чинь тэр л авчихсан байх даа. Та аль хошууны хvн бэ? Гэж Итгэлт асуув. Эрдэнэ хэсэгт тvгдрээд худал хэлж чадсангүй хошуу нутгаа vнэн зөв хэлэв. Итгэлт нvдээ тvргэн тvргэн цавчилж хулгай нvдээр Эрдэнийг ажиглана.

«Тайшир, тарлан бух, таваг хар, ноцдог дэгээ гэж Засагт ханы хөх харцууд хэцvv гэдэг дээ.

Та намайг танихгүй би таныг танихгүй. Бие биедээ балаггүй салбал дээр байх аа» гэж Итгэлт босов.

Энэ вед гаднаас Галсан орж ирээд өврөөсөө дугтуйтай бичиг гаргаж «ахаа өртөөний занги энэ бичгийг танд бариарай гэсэн юм гэнэ билээ» гээд Итгэлт өглөө. Итгэлт дугтуйтай бичгийг авч баахан эргvvлж харснаа «энэ золигийг чинь хэнээр дуудуулдаг билээ» гэжээ.

- Би уншиж өгвөл болох сон болов уу гэж Эрдэнэ царайчлан нам дуугаар хэлэв. Итгэлт Эрдэнийг гайхан ажиласнаа тоомжиргүй ёжтой инээмсэглээд «уншиж өгье гэв vv, та юу

даа?» гэв.

- Тийм ээ, би халт мулт гаргадаг юм гэж Эрдэнэ тайван хариулав.

- Тэгвэл гялайлаа гэсэн үг.

Эрдэнэ бичгийг авч задлан өндөр дуугаар «Ахай бээсийн хошууны захирагч Жамсрангийн бичиг...» гээд үргэлжлүүлэн уншив. Тэр бичигт ахай бээсийн хошуунаас Дарьборын өртөөнд хийх албыг ацаглан залгаж байгаа Итгэлтийн авлагыг хошуунаас гаргуулж төлөх болсон тухай дурджээ. Улаан шугамтай муутуу цаасан дээр бичсэн бичгийг нэг ч удаа түгдрэлгүй дуржигнуулан уншиж байгаа Эрдэнийг хараад Итгэлт ихэд гайхав.

Торгон дээлтэй, нарийхан цагаан хуруутай ноён түвшмэл нарын уншдаг бичгийг уранхай дээлтэй, туранхай царайтай хатуу ажилд эвэртэж борлосон гартай цагаачин уншиж байгаа нь Итгэлтэд үлэмж сонин хэрэг байв.

Итгэлт багадаа бичиг заалгах гэж оролдсон боловч сурааггүй. Тэгээд одоо малынхаа дансыг хээлтэй малыг дотроо дугуйтай дөрвөлжин хүрээ, сувай малыг дөрвөлжин хүрээ хийх мэтийн тэмдгээр зурж тоолдог юм. Энэ учраас бичигтэй зарц өөрөө хүрээд ирнэ гэдэг бол зүүдлээгүй баяр байлаа. Танай хошууныхан хэцүү гэлцдэг. Гэвч олон мод өндөртэй, намтай олон хүн сайнтай, муутай байдаг бас тэгээд монгол ах дүү байна ядарсан хүнд туслахгүй яахав. Ер нь шууд манай хаяанд ирээд бууж орхи гэж өрөвдсөн элэгсэг дуугаар хэлэв. Гачигдаж ядарсан хүн итгэхдээ амархан байдаг болохоор Итгэлтийн энэ үгэнд Эрдэнийн сэтгэл баяр найдвараар дүүрэв.

Эрдэнэ Итгэлтийнхээс заан шиг хоёр хайнаг хөллөсөн тэрэг аваад явахад гэрийн эзэн Галсанг дуудаж «дүү минь энэ ядарсан хүнд тусалж үз. Хэн маань ч ялгаа юу байх вэ» гэжээ.

Эрдэнэ замдаа Галсантай танилцав.

- Ах хэдий ширүүн зантай боловч нуруу сайтай, тусархаг хүн шүү. Харин тэгэхдээ хүнийг өөр шигээ л ажилтай болгохыг хичээдэг юм даа гэж Галсан ярив.

Хорь гаруй настай энэ эр бол Итгэлтийн төлөө илжиг мэт зүтгэгч найдвартай зарц нь билээ.

Тэр орой Эрдэнийн муу майхан Итгэлтийн хотын баруун хойно босож амьдралын хатуу хууль Эрдэнийг эхнэр хүүхдийн нь хамт хүний нутагт айлын зарц болгожээ.

За Эрдэнэ минь тэнхэртлээ манай хэдэн малаас харалцаж өгөөд байж үз. Би чамайг гомдоохгүй. Хоёр үнээ сааж цайгаа сүл. Хэн хэндээ тус больё гэж Итгэлтийн хэлснийг Эрдэнэ дуртай зөвшөөрчээ.

Амьдралын ширүүн урсгалыг сөрж хаантай хүртэл заргалдаад сүүлд нь өвөг дээдсийн нутгаас хавчигдан зайлж нэг зовлонгоос нөгөө зовлон руу дамжин орсон Эрдэнийн сэтгэл зориг аяндаа мохож, яаж эхнэр хүүхдээ тэжээх вэ? Яаж өлсөхгүй байх вэ? гэдэг түмэн шижмээр улам бүр нягт хүлэгдэж байлаа. Эрдэнэ, Долгор хоёр ч харь нутагт ядарч байхад нь царай өгч, гар сунган тусалсан Итгэлтэд баярлаж хий гэсний нь битгий хэл хэлээгүй ажлыг нь хичээн бүтээж байлаа.

Эрдэнэ минь, хошуу наадмаас хойш суурилсан малаа тоолно. Чи л нэг тус болж, ягштал дансалж аль гээд Итгэлт авдраасаа өнгөрсөн жил өөрийн хийсэн дансаа гаргаж өвгөн минь чам шиг эрдэмтэй хүн харвал элэг хөших эд дээ. Бас тэгээд надаас өөр хэн ч уншиж чадахгүй. Хоёул хэд хоног сууж чамд учрыг нь олж өгье гэж нэг өдөр хэлжээ.

Итгэлт бол үнэндээ хэрсүү хүн байж билээ. Өөрт нь тус болж, ажилд нь хэрэгтэй хүнд гэж тэжээмэл бяруу шиг, хүслээ биелүүлэхэд саад болсон хүд хорт могой шиг, ажил хийвэл энэ гэрийн хамгийн үнэнч зарц юм. Итгэлтэд хамгийн хайртай, хамгийн дотно юм гэвэл өөрийн нь хүсэл, эрмэлзэл бөгөөд үүнээ хангахад хэрэгтэй бүхнийг юунаас ч буцахгүй хийдэг байлаа. Хэрэгтэй вед юугаа ч өгөхөөс буцахгүй өглөгч, хэрэггүй бол сэтэрхий зүү ч хүнд өгөхгүй

цэвдэг сэтгэлтэй ажээ. Эрдэнэ үлэмж хэрэгтэй хvн болохоор Итгэлт тvvнд тэжээвэр бяруу шиг номхон байв. Эрдэнэ бол ухаантай, чадалтай гэхдээ амархан итгэмтгий, шударга хvн гэж бодсон Итгэлт тvvнийг өөртөө vнэнч байлгахын тул хvндэтгэн нөхөрлөж, тvvний дээр нь биш, дэргэд нь байхыг хичээдэг байв.

Энэ учраас хэрэв Галсанг доромжлон загнаж, Нямааг шоолж егөж зардаг бол Эрдэнэд vргэлж хvндэтгэсэн нөхөрсөг дvр vзvvлж байдаг байлаа. Yvнээс гадна Итгэлтэд өөр нэг бодол байв. Хатуу амьдрал ч дарж чадаагvй vзэсгэлэн гоо Долгорын өнгө жавхлан тvvний тачаангуй сэтгэлийг нь маажиж Долгорыг харах бvхэндээ өөрийн эрхгvй инээмсэглэн явдаг ба ажлаар Заяын хvрээ ороод ирэхдээ Долгор, Дулмаа, эхнэр Должин нартаа гарын бэлэг авчирч өгсний хамгийн чансаатай нь Долгорынх байв.

- Чи ч Долгорт хөл алдаж байх шив дээ. Би ч яахав. Дарлагдаж сурсан хvн. Харин Дулмаа чинь хардаж сvйд болох байх даа гэж сайхан бэлэг авсандаа магнай дvврэн баярласан Долгорыг гvйн гарахад Должин хэлэв.

- Чамд падгvй гэж Итгэлт хvйтэн бөгөөд тоомжиргvй хэлэв

- Чам шиг зарц нартайгаа эхнэрийг нь хуваадаг шившигтэй амьтан байхгvй даг шvv.

- Эрдэнэ бол Галсан чинь биш болохоор...

- Гичий минь дуугvй бай. Төрхөмд чинь залж орхино шvv гээд Итгэлт хялайн ширвэхэд Должин дуугvй болж, мах амтархан идэж байгаа том нохойн дэргэд шvлсээ залгин зогсож байгаа гөлгөн нохойн арчаагvй бөгөөд атаархсан нvдээр ширтэж байснаа урт гэгч нь санаа алдав.

Тэмээчин хvн буурынхаа занг андахгvй гэгчээр Должин нөхрийнхөө завхайг сайн мэддэг боловч яаж ч чаддагvй. Хардах сэтгэл нь оволзсон вeдээ ганц нэг ширvvн vг хэлчихдэг боловч Итгэлтийг уурламагц дуугvй бодог ба ялангуяа «Төрхөмд чинь хvргэж өгнө» гэхэд хөмсөг нь бууж аргадан эхэлдэг.

Ингээд өдөр өнгөрөх тутам нөхрөөсөө айх нь их болж далайсан газар нь далд орж, далласан газар нь ил гарч байдаг ба бас тайлбарлаж болшгvй хайр сэтгэлээр Итгэлтийн хийснийг цагаатгаж, амьдрал таван хуруу тэгш биш гэж сэтгэлээ засаж явдаг болжээ.

Эдлэнэ гэхэд хуучин, хаяна гэхэд ямар нэгэн дурсгал буюу сvсэг бишрэлтэй холбоотой юм зарим хvнд байдаг. Тэр хvн уул зvйлд онцын хайртай биш учраас авдрын аль нэгэн буланд хаяад мартаж орхидог бөгөөд заримдаа нvдэнд нь тусахад хаяхгvй хадгалж байгаа учир явдал нь санагддаг. Итгэлтийн хувьд Должин чухам ингэж хэрэглэж болдоггvй хаяж болдоггvй хуучин эд байлаа.

- Өвгөн минь хоолоо идэх vv? гэж Должин нам бөгөөд царайчилсан дуугаар асуухад нөхөр нь ихэмсэг ширvvн дуугаар аваад ир гэж хөмсөг зангидан хэлээд хутгаа авч завилан суув.

## VI

Булган уулын оройгоор гарч ирсэн бөөн бөөн хар vvл Зая Бандидын хvрээн дээгvvр сvvдэр татуулан нvсвээр vдийн хирд тэнгэр бvр бvрхэж ширvvн бороо орлоо. Хvрээний гудамжинд хөл тасран, гаднаас нь харахад бороонд шалба цохиулсан хэдэн нохойноос өөр амьд амьтангvй мэт боловч vнэндээ тийм биш, амьдрал өөрийн хуулиар урсаж байжээ. Том хашааны хойт талд бузгай тохилог барьсан зуны модон байшинд хоёр лам дундаа том ваартай шуугисан айраг тавиад хятад нарийн шаазан дvврэн дvврэн хийж ууна.

Өндөр гоолиг биетэй, тунгалаг цагаан царайтай шинэ хvрэн тэрмэн дээл дээр шар гяраг ороосон дэгжин ламыг Цамба гэдэг бөгөөд энэ жил хорин гурван нас хvрчээ. Нөгөө нь газар шагайсан хурц нvдтэй туранхай хантингар биетэй, нэр Жамбал гэдэг, насаар Цамбын ve ажээ.

Энэ хоёр Заяын хүрээний унаган шавь биш. Цамба луу гүний хүрээн дээр багаасаа сууж байгаа Заяын хүрээнд байсан нагац ах лам нь үхэж түүний хөрөнгө дээр иржээ. Эцэг Гомбо тайж нь Луу Гүний хошуу туслагч байгаад дээд ноён үхэж агь ноён ширээнд суухад огцорчээ. Гэхдээ одоо ч гэсэн хошууны хэрэгт нөлөөтэй хүний нэг юм.

Жамбал бол уул нь Далай Чойнхор вангийн хошууны хүн бөгөөд Тариатын хүрээн дээр арван настайгаасаа эхэлж суугаад арван найман насандаа Богдын хүрээ орж гандан дээр суужээ. Жамбал Сан амбаны жууз руу чулуу нүүлгэн дайрсан лам нарын хэрэг, амбаныг хүрээнээс хөөхөд оролцож яваад хоёр жилийн өмнө Заяын хүрээнд иржээ. Заяын хүрээний сангийн нярав Далан Чойнхор вангийн хошуунд явж байхдаа нэг залуу бүсгвйтэй холбоотой болж Жамбал гэдэг хүн ертөнцөд төржээ. Үлэмж хөрөнгөтэй нярав нас хөгшрөхдөө махны тасархай болсон Жамбалыг татаж ирүүлжээ.

- Манай энэ олноо өргөгдсөн төр, олноо идэгдсэн сэг болно шүү гэж Жамбал айраг уух зуур хэлэв.

- Тийм гэж үү? Орой дээр Богд гэгээн заларч байсан цагт гайгвй байхаа.

- Би мэдэлтэй сан бол доо. Халхын эр сүвтэн бүхнийг цөмийг цэрэгт дайчилж хөдөлбөл хоорондоо мэрэлцэж хүч нь суларсан хятадыг сандруулж болох л байсан даа.

- Чи ч далай шиг юм бодож явдаг гайхал байна.

- Далай шиг мөртлөө зэрэглээ шиг хоосон... за төрийн төлөө оготно гэгчээр тэр ч яамай.

Харин удахгвй Луу гүний хошуу наадам болох гэнэ билээ. Явна шүү.

- Явна. Би унаа гэж хэл өгсөн.

Жамбал нээлттэй гэгээвч рүү ажиглан, нүдээ цавчлан суув. Хэрэв би богдын оронд байсан бол Шамбалын дайн болов гэж лүндэн буулгаад монголын эр хүн, морь бүхнийг дайчилж аварга том монгол улсыг байгуулах байсан сан гэж бодож байхад их цэрэг захиран эрдэнэсийн дээдийг эдэлж, архины дээдийг ууж эхнэрийн сайхантай жаргаж байгаа бүдэг манан толгойд орон гаран байлаа.

- За явъя гээд Жамбалыг босоход Цамба зовомтгой инээмсэглэснээ «өвгөн чинь ичээд байна. Бүрэнхий болгож байгаад явъя. Лам нар мэдвэл баларлаа шүү» гэхэд нь Жамбал хөгжүүн инээмсэглэв

- Хар хэрээ бие биеийн харыг гайхав гэгчээр хэн нь хэнийгээ шоолох билээ дээ. Явъя гэлээ.

Ингээд Жамбал түрүүлэн гарч байшин хашаагаа том хар цоожны мэдэлд үлдээгээд хүрээний өмнө борчуулын хороо руу явжээ. Том хүрээний дэргэд хороочид гэж байдгийн ихэнх нь эмэгтэйчүүд байж билээ. Шарын шашин монголд дэлгэрэхэд бүх эр хүний дөч шахам хувь нь лам болж хүрээнд сууснаас эр нөхөргвй эмэгтэйчүүд олон болж хүрээ хийдийн ойролцоо амьдран лам нарын буюу худалдааны хятадын зугаа болж байжээ.

Өнөөдөр Жамбал, Цамба яг энэ мэтээр Заяын хүрээний дэргэд бий болсон хороонд суудаг Чимэг, Цэцэг гэдэг хоёр хүүхнийд очиж найрлан самуурахаар яваа ажээ. Энэ замаар анх удаа явж байгаа Цамбын сэтгэлд ичих хүсэх хослон эргэн тойрныг ажиглан, үргэсэн зээр шиг сэрвэлзэн, хүн харагдвал нүүрээ буруулан явжээ. Харин Жамбал бол эгэл амьдралын амтыг аль эрт мэдсэн бөгөөд энэ замд гутлынхаа улыг элээсэн хүн болохоор ичих зовохыг мэдэхгвй байжээ. Хүрэн хаалгатай хашааны үүдэнд ирээд Жамбал оньсны урт сурыг татах зуур Цамбыг харвал цагаан царай нь улаан болоод бүх бие тогтон ядан чичирч байлаа.

- Далай байвал ч намайг хармагц зовхи нь буугаад түргэн зайлна. Мядагийнд дайралдаж таван салаа боов хүртснээс хойш сүүлээ хавчдаг болсон. Харин Буянт байвал цор цор гээд байж магадгвй илжиг шүү. Шууд л барьж аваад дэлсэж орхино шүү. Үгвй чи айгаад байна уу даа? гэж Жамбал асуув.

- Айх ч юу байхав дээ

- Та түрүүлээд ор гээд хаалга нээхэд Цамба инээмсэглэх мэт болж, шилээ маажсанаа урт санаа алдан дотогшоо орлоо.

Хашааны баруун талд шавхарсан зээрд морь уяатай байв. Толгойгоороо тоглож байгаа тэр морины эмээл шуулттай байгааг харахад эзэн нь борооноос өмнө буюу борооны үеэр иржээ.

- Морь байна гэж Цамба шивэгнэв.

Жамбал явдал дундаа морийг ажиглан харснаа «хамаагвй» гээд хятад маягийн банзан байшин руу явж ороход инээж байсан хүмүүс нам гүм болов. Эздээс гадна үл таних нэг хүн байлаа. Зах нь задгай, хүрэн торгон дээлтэй, түрийд нь дөрөөний сурыг хэв гарсан луучинтай, бор царайтай тогтож ядсан хурц нүд бүхий цогтой эр ханзан дээрээ зүүн өвдгөө нугалан суугаад өмнөө тавьсан тарган махнаас том, том огтлон идэж байгаа. Хоёр хүвхний нэг нь орон дээр сандайлан, нөгөө нь үл таниг хүний хажууд суужээ. Саяхан инээж байсан байсан тэмдэг нүүрнээс нь салаагүй учир уруул нь жуумалзан байв.

- Бүгд мэнд амгалан уу гэж Жамбал мэндлэв. Жамбалыг харсан хоёр хүвхний царай хувирч төв болоод бие биеэ харалцав.

- Мэндээ, гэлэн гуай нар сайн уу? гэж нөгөө хүн мах зажлах зуур ёжтой хэлээд лам нарын толгойноос улыг хүртэл харж амжив.

Баруун ханзан дээрх цэмбэн гудас дээр Жамбалыг очоод суухад Цамба доод талд нь суулаа.

Нөгөө хүн үйсэн иштэй хутгаа арчиж мөнгөн тоногтой хуйнд хийгээд, түрийнээсээ бүдүүн цагаан соруултай гаанс, бүснээсээ мөнгөн соёо цохилууртай сав авч тамхи татлаа. Энэ бүхнийг хараад «Овоо л бэлтэй хүн бололтой» гэж Жамбал дотроо бодов. Тасалгаанд хэсэг зуур огт чимээ аниргвй байв. Үл танигчийг Түгжил гэдэг. Далай Чойнхор вангийн хошууны хүн. Хийдэг ажил гэвэл хулгайч, гэхдээ Төмөр шиг аймаг давж сүргээр адуу хөөдөгвй. Хавь ойроосоо хонь, хурга, бяруу шүдлэнгээс эхлээд хавьтсан бүхнийг авч хамар давуулан борлуулж явдаг ажээ. Жижиг хулгайн хэрэгт хэдэн удаа баригдсан боловч хээл хахуулийн хүчээр суллагджээ. Энэ удаа бас олз хайж ламын гэгээний шавь буюу ойр зэргэлдээ хошуунаас амбан шар хэдийг авч Тариатын оросуудад худалдах бодолтой яваа аж.

Хэрүүл зодоон болоход энэ хоёр асман ламыг дийлнэ гэж бат итгэсэн Түгжил, буулгасан нударгадаа соруулаа арчих зуур «Гэлхай нар сан тавьж өгөх гэж морилон ирэв үү?» гээд хажуудаа сууж байгаа Чимэг рүү нүд ирмэснээ өврөөсөө бүдүүн түрийвч гаргаж нүхтэй улаан зоос хоёрыг гаргаж, барьцыг нь урьдаад барьчихья гэлээ. Доромжилж байгаагий нь мэдсэн Жамбалын уур багтаж ядахдаа нүд нь гялалзаж, шанааны булчин нь татганан чичрэв. Жамбал зодоонд ягвй болохоор олон, үгтэй сагсуу хар хүвгийн намалдгийг чихэж, аагий нь дарж өгье гэж шийдэв. Цамба уурласан ч үгвй, баярласан ч үгвй. Амьсгаа нь давхцан, тасалгаанд байгаа юм бүхнээс хараа буруулж, ямар нэгэн юм болбол эргэж харалгвй Булган уулыг давж зугтахад бэлхэн байжээ. Хэрэв аль нэгэн нь хөдлөхгвй бол Жамбал Түгжил хоёр хэдий болтол ингээд л хэрсэн бух шиг хялалзан суухыг хэн мэдэх вэ. Гэтэл хэн урьтсан нь хожно гэж бодсон энэ хоёр яаж тэсэх билээ. цор цор гээд байвал хянган хамрыг чинь цааш хийж орхино шүү гээд Жамбал өндөлзөн, босоход бэлтгэв.

Гэтэл Түгжил ажигвй дүр үзүүлэн «Гэлхай нар миний өчүүхэн барьцыг өглөгийн эзний үнэн санаа, диваажинд төрөх гэсэн хүсэл хэмээн болгооно уу» гээд гараа сунгахад Цамба өөрөө мэдэлгвй гараа тосов. Жамбал гарыг нь цохиод авлаа.

- Нусгай хар хүв чи аяд. Нутгий чинь цогчин дуганыг мөргөтөл алгадаж орхино шүү мэдэв үү гэхэд Түгжил хоолойдоо хүд хүд хийтэл хүйтэн инээв.

- Сан тавьдаг гэлхай гэсэн чинь хийстэл алгаддаг гайхлууд байх нь уу гээд улам ч хөгжилтэй

инээснээ гэнэт царай нь хувирч шалдан банди нар минь гавжийн дугуйнхаа савтай явъя гэж байгаа бол олон таван үггүй тонилбол дээр гэж сүртэй ширүүн дуугаар хэлэв.

- Сүрхий эд байх нь ээ гээд Жамбал нудрагаа дотогш чихээд босов.

Хэрүүл зодоон болоход Жамбал хэгжүүн хар хүүгийн загатнасан хамар руу нударгаа чиглүүлэн дайрав. Гэтэл Түгжил зайлж гаансныхаа толгойгоор улаан суга руу нь хвчтэй ёворсонд лам гэдрэгээ алдлан унажээ.

Цамба аль хэдийн гүйн гарч хашаа даван ум хумгуй алга болов. Хоёр хүүхэн «та минь болиоч» гэхээс өөр гавьтай үг хэлж амжаагүй байхад Түгжил Жамбалыг хашааны хаалгаар гаргах зуур «Ахын чинь ёвролтыг халхын овоо эр тэсэж байгаагүй юм» гээд хаалга хааж ягштал түгжив.

Юу болж өнгөрснийг хоёр хүүхэн ойлгон ядаж байхад Түгжил бардам инээсээр орж ирлээ. Түгжилийн ёвролт хэцүү. Жижиг ташуур буюу гаансны толгойгоор хвний улаан суга руу ёворч унагаадаг сургуулийг олон жилийн өмнө залуу морио өгч баймааж сурч билээ.

Тариатын хүрээний дөрвөн ламд боорлуулаад байхдаа гурвыг нь нэг нэг ёвролтоор унагааж байсан удаа буй. Ер нь л ташуур буюу гаанстай цагт хэн ч ирсэн дарлуулахгүй гэж бардам бөгөөд итгэлтэй бодож явдаг байжээ.

Чимэг хүүхэнтэй хвсэл ханган наргиж хоносон Түгжил өглөө эрт урд Тамирын голыг өгсөн хатируулж явлаа.

## VI

Үүрийн гэгээ цайран дорнод уулын орой, дэл сүүлээ босгосон азарга шиг сүртэй харагдаж сэрүүн салхи баруун хойноос үлээв. Итгэлтийн адуу манасан Галсан мориноосоо бууж дахин нэг шөнө энх амгалан өнгөрсөнд баярлан тамхиа хэт угсран татаад мордох гэтэл морин төвөргөөн сонсогдож бүрэн харанхуйн дундаас морьтой хвний бараа тодорлоо. Галсан арван наснаас хорин таван нас хүртлээ Итгэлтийнд зарагдсан хвн. Анх түүний Заяын хүрээн дээр гуйлга гуйж явахад нь олж авчээ. Ингээд Итгэлтийн юу хэлснийг хичээнгүйлэн биелүүлж, юу өгснийг баярлан хүртэж, хорвоо дээр Итгэлтийн хвчээр амьдарч явна гэж боддог ажээ. Хоёр жилийн өмнө Итгэлт өөрөө хөөцөлдөж бага сага хөрөнгө зарж байгаад нутгийн нэгэн ядуу авгайн охин Дулмаатай суулгаад тов хийсэн дөрвөн ханатай гэр барьж өгчээ. Өнгөрсөн намар Галсангийн идшинд хөл нь хугарч хатсан туранхай сарлаг өгөхөд нь Дулмаа «энэ дэвхрэг Итгэлт, хоёулыг минь зарж байгаа мөртлөө үзэх өөхгүй хатингар зовлого өгнө гэнээ» гэсэнд Галсан уурлаж «хар эм чи, буянгий нь гударч байгаад эзний нь муу хэлнэ гэнээ. Задарсан өлөгчин» гэж хэлээд эр эм хоёр хэрэлдэж, эцэст нь Дулмаагийн нүдийг золтсоор хөхөртөл цохижээ.

Галсан туранхай бөгөөд нам нуруутай боловч адуунд эртэй ялангуяа эмнэг унахдаа гарамгай. Олон таван үггүй, хэлсэн бүхнийг нь хичээнгүйлэн хийдэг болохоор Итгэлт өөрийн үнэнч зарц гэдэг боловч өр шир нэхэх зэрэг чухал ажилдаа итгэж явуулдаггүй байв. Нэгэн удаа Итгэлт өр нэхэхээр явах гэж байхад нь Должин «энэ хар хвйтэнд өөрөө яваад яах нь вэ? Галсанг явуулчих» гэхэд «нэг бол хвний зэвүү хүргэчих, эсвэл хвнд маллагдах амьтныг явуулаад юу бодож суух билээ дээ. Адуугаа хариулж л байвал болох нь тэр» гэжээ.

- За хө адуугаа сайн манав уу? гэж эрт уях ёстой морь барихаар ирсэн Эрдэнийг асуухад Галсан нарийхан дуугаар хөгжилтэй инээснээ

- Эзэн нь буянтай болохоор, адуу нь тогтвортой байдаг юм гэв.

Эрдэнийг анх ирэхэд нь Галсан түүнтэй атаархаж дургүй байжээ. Үхэр тэрэг хөллөж чадахгүй юм. Морь уургалахдаа толгойг муу олох юм гэх зэргээр хэдэн удаа Эрдэнийг Итгэлтэд муулж ярьсан билээ.

- Юунд чавганц шиг бvвтнэж байдаг юм бэ. Би өөрөө мэдэж байна гэж Итгэлт аашилснаас хойш Эрдэнийн тухай ярихаа больжээ. Тvvгээр ч барахгvй, хоног өнгөрөх тутам Итгэлт Эрдэнэт итгэж, ойрын бага өр нэхэх ажлаар нэг удаа явуулсныг хараад буянтай юм мэддэг хvн ингэж байхыг бодоход энэ Эрдэнэ лав сvрхий хvн гэж тvvний хэлснийг Итгэлтийн хэлснээс бараг л өөрцгvй vнэлж байдаг болжээ.

- За би барилцъя гэж нойргvй хоносноос зовхи нь улайсан нvдээ анивчин Галсангийн хэлэхэд Эрдэнэ ганзагаасаа хазаар авах зуур

- Чи өлгөөд бай, би хазаарлаж авъя гэж хэлэв.

Морьдоо барилж холбоод хөтлөн гэрийн зvг хатируулан явжээ. Анхны вед Галсан Итгэлтэд арчаагvй загнуулан мэдэгдэхvйц зусардаж байгааг хараад Эрдэнэ дургvй нь хvрч байлаа.

Гэвч сvүлдээ «би ч бас л энэ хvнтэй яг л адилхан. Итгэлтийг аяыг харж явна шvү дээ» гэж бодоод Галсанг өрөвддөг болжээ.

Эрдэнийг уян дээр ирэхэд аль хэдий нь боссон Итгэлт хvлээж байлаа. Эрдэнийн дөнгөж сая уясан өндөр хээр морины хондлойг нь урт ханцуйгаар арчих зуур

- Хээр морь минь энэ жил намайг баярлуулах байх гэж итгэж байна. Дамшиг чинь нэг л өнгөтэй байна гэхэд нь Эрдэнэ морьдоо уяж дуусаад Итгэлтийн дэргэд ирж

- Эндхийн тvмний эхvүдийг мэдэх биш дээ. Харин хээр морины уяа зэхий таарч байх шиг санагдах юм гэлээ

Морьдоо уячихаад Итгэлт, Эрдэнэ хоёр тавлан сууж удахгvй болох их сунгалтын тухай ярилцаж байтал Нямаа ирлээ.

- Уясан морьд чинь хурдан болтугай, хурсан наадамд тvрvүлэх болтугай

- Тэр ерөөл бат оршиг. Таны санаанд морьдын уян ямар шvү байна даа? гэж Эрдэнийн асуусанд

- Миний бодоход сойлт нь таарч, далавч нь ургах нь л дутуу байх шиг гэж Нямаа хэлээд Эрдэнийн хажууд өвдөглөн сууж тамхи татлаа.

- Нямаа гуай ер нь морь сойход ядахдаа хошуу ч нэмэх vгvй юм аа даа гэж Итгэлт хэлэв.

- Бурхан мал маллах авьяас хуваарилахад та нар шиг овтой нь тvрvүлж очоод сайн морь сойх, уралдах, явалтай морь унах авьяасыг нь авч орхиод, над шиг нь айраг гvзээлж аяга шордож байгаад хожимдож, адуу манах, хонь хариулах авьяас арай хийж олж авсан болохоор оролцдогvй юм хэмээн Нямаа тамхи татах зуур амьдралдаа болсон юмаа дурсаж байгаа мэтээр төв бөгөөд тайван ярив.

Нямаа арваад жил Итгэлтийнд зарагдаж байгаа хvн. Эхнэр нь vнээ хонь саадаг. Өөрөө Дулмаатай тулж хонь хариулдаг. Нямаа томоотой цагаан сэтгэлтэй, хошин цэцэн vгтэй хvн. Итгэлт тvvнийг гэмгvй, тэнэг хvн гэж бодож явдаг юм.

- Нямаа гуай өнөөдөр яасан орой босов оо?

- Өглөө өрх татахад чинь аньсан нvдээ нээгээд хонины хишиг биш гэж бодохтойгоо зэрэг л дахиад тас аньж орхисон гэв.

Тэр гурав гэрт орж айраг уув. Хултай айраг ууж байгаа Эрдэнийн өвөр дээр Солонго очиж суугаад модон тоглоом хийж өгөхийг гуйв. Итгэлтийн хоёр хvүхэд Эрдэнэд дасаж, тvvнийг өндөр ах гэж нэрлэжээ.

- Чи хvнийг аяга айраг тавтай уулгахгvй юу болоод байна даа. Бас гарч тэр эхдээ тугал татаж өг гэж Итгэлтийн ширvүн хэлэхэд Солонго урамгvй босох гэхэд нь Эрдэнэ инээмсэглэн:

- Яахав дээ, сууж л байг гэсэн боловч эцгийнхээ ширvүн харцнаас эмээсэн Солонго гадагш гvйн гарлаа.

Тэр өдөр Долгортой зэрэгцэн vнээ сааж байсан Должин «та нар хэдий болтол энэ өмгөр



майханд байх юм. Манай суурин дээр дөрвөн ханатай овоо гэр буй. Тvvнийг авч барь» гэхэд нь олон давхар зовлонд нэрвэгдсэн Долгорын сэтгэл хөдлөн баярлаж, нүднээс нь нулимс дуслахад тvvнээ нуун үнээнийхээ гуянд нvvрээ нууж, нам бөгөөд догдлон чичирсэн дуугаар - За гээд дуугүй болов

Амьдралдаа ингэж баярлаж байгаагүй Долгорт бодогдов. Уранхай майхантай хvний газар яаж амьдарна даа гэж үргэлж сэтгэл нь шаналж байсан хvн дөрвөн ханатай овоо гэртэй болоход яахин баярлахгүй байх билээ.

Айраг ууж байх зуур суурин дээр дөрвөн ханатай гэр бий. Эрдэнэ минь тvvнийг авч барь. Сvvлд хөлжиж байгаад үнэ өртгийг нь өгнө биз гэж Итгэлт бас хэлжээ. Удалгүй Итгэлтийн хот дөрвөн гэр болсноор барахгүй хотоороо гэр мялаахад

Урт цагаан туургатай

Уран тагнай хаяавчтай

Далан цагаан дээвэртэй

Дархан ширмэл vүдтэй

Энэ сайхан өргөөнд

Yүрдийн жаргал бадарч

Сайн бvхэн орогнож

Саар бvхэн зайлж

Yүрд мөнх жаргахын

Өлзийтэй ерөөл дэвшvvлье

гэж Нямаа ерөөв.

Уранхай майхантай байхад нь тов хийсэн гэрээ өгсөн Итгэлтэд баярласан эр эм хоёр явал тvvнд сайн хvн болох бол гэж хичээдэг болов.

Эрдэнэ морь уяж, завандаа мал тоолж данс гаргаж байв. Долгор их гэрийн /Итгэлтийн зарц нар, Итгэлтийн гэрийг их гэр гэж нэрлэдэг бөгөөд таслан авч гаднаа маллаж байдаг малыг нь их гэрийн мал, бусад айл дээр байдаг малыг нь суурь гэж нэрлэдэг/ аар саар ажлыг борви бохис хийхгүй хийж шөнө орой л гэртээ орж ирдэг байв.

Морь унах өдөр болж Итгэлт Эрдэнэ хоёр Бат, Хонгор, Сvrэн гурвыг дагуулан /энэ гурав морь унаж байв/ явах гэхэд нь Солонго дагаж улайв. Эцэг нь уурлан загнахад Эрдэнэ авч явахыг гуйжээ.

За яахав өндөр ах чинь гуйж байгаа болохоор авч явъя. Усан нүдлээд дамшиг минь бушуу ач гэж Итгэлт хэлжээ. Сунгалтад олон хvн цугларчээ. Эрдэнийг морины сvvл шууж байхад дэргэд нь зогсож байсан Итгэлт дээр Бадарч ирэв. Морь хурдан гэж мэндлээд, хээр морины нь мундааг барьж үзсэнээ танай хээрийн уяа зэхий таараад шижир шиг л гялалзаж байна гэлээ.

Манай Эрдэнэ л гардаж уясан хvн дээ гэж Итгэлт баяртай инээмсэглэн хэлэв.

Бадарч, Эрдэнэ рvv ихэмсгээр ажиглан харснаа тоомжиргүй инээмсэглэх мэт болоод бvдvvн дуугаар бид хоёр танил байхаа гэлээ. Тийм байхаа. Та тэгээд нөгөө оргодлоо барьсан уу? гэж Эрдэнэ ерийн нэг асуух ёстой зvйлийг асууж байгаа юм шиг ажиггүй асуув.

Нэг л удаа тэнгэр өршөөж муу гуйлгачин миний гараас мултарсан. Гэвч уулзах байлгүй дээ. Халх өргөн боловч Бадарчийн гарт урт даа гээд маг маг инээв.

Сунгалтанд Итгэлтийн хоёр морь тvrvvлж хэдэн морь нь айргийн тавд орж хагартал баярлан ямаа авчруулан боодог хийлээ. Бас бөхийн барилдаан эхлэхэд Эрдэнэ барилдав.

Өндөр ахаа чанга хаяарай гэж Хонгор чихэнд нь шивэгнэн захив.

Эрдэнэ Бадарчийг сvrхий барилддагийг харж мэдсэн болохоор хянамгай ноцолдох гэж өрөөд

өө харан ажиглаж байв. Энэ цагаачин чинь овоо шөрмөстэй хvv бололтой. Гэвч Бадарчид юу болох вэ дээ. Аятайхан тонгорч байдаг шvv гэж наадам эхлэхийн өмнө ирээд байсан Цамба, Жамбал хоёрын ярилцах нь Эрдэнэд сонсогдов. Энэ ярианд Эрдэнийн зэвvv хүрч ухасхийн барьж автал чухам vvнийг хвлээж байсан Бадарч сээрэн дунгуй хийж дээр өргөөд хvчтэй шидэв. Эрдэнийн цээжнээс цус амтагдан нvд нь харанхуйлсан боловч шvд зуун босож хvчлэн инээмсэглэв. Бадарчийн дунгуйнд орсон хойно яаж тэсэх вэ?

Дархан мэх нь дээ гэж хvmvvc хоорондоо ярилцаж байлаа. Өндөр ах халтирч орхилоо. Тvvнээс дийлэх л байсан гэж Солонго нарийхан дуугаар гомдолтой хашгирав. На жаргахын вед сунгалт тарж, Итгэлтийнхэн гэрийн зvг явцгаав. Гэтэл Итгэлт «йлаар орох чухал ажилтай»гээд салж Эрдэнэ дөрвөн хvvхдийн хамт морьдоо хөтлөн явжээ.

Итгэлт явсаар Тамирын голын бургасанд оров. Чийгтэй сэрvvхэн салхи vлээн өдөр улиасны навч vл мэдэг шажигнан байв. Тамир нэгэн аяар шаагин урсаж, тvvний мандал дээр дугариг саран холбилзон гялтганаж тольдон байв. Итгэлт орой бvхэн том ган тавьсан тэргээр хотынхон нь ирж ус авдаг гармын ойролцоо очоод морио бургаснаа уяж, тамхи татлаа. Удалгvй модон голтой тэрэгний хяхтнах дуу гарч, Дулмаа сэлмэн эвэртэй бvдvvн хайнаг хөллөсөн тэргээ хөтлөн ирэхэд Итгэлт бургаснаас гарлаа. Чамайг усаа аваад явчихсан юм болов уу гэж бодлоо шvv гээд шууд очиж хайнагийн нь дөрийг гараас нь авч хажуугийн том улиаснаас уяв. Бургасанд уясан Итгэлтийн морины тургих дуу орчны нам гvmийг цочоон сэргээж байлаа. Дулмаа хөдлөлгvй зогсох байхад нь Итгэлт цээжээ хөдөлгөн инээмсэглэж гараас нь хөтлөн бургас руу орлоо. Гурван жилийн өмнө арван зургаатай охин Дулмааг хонь хариулж явахад Итгэлт очоод шууд барьж авч билээ. Буян хөрөнгө, арга ухаан нь хэдэн хошуунд алдаршсан энэ хvнийг бариад авахад Дулмаа эсэргvvцэж чадаагvй билээ. Тvvнээс хойш Дулмааг хонь хариулж явахад нь Итгэлт vргэлж очдог болсон бөгөөд Дулмаа гэнэн цагаан сэтгэлээр Итгэлт өөртэй нь сууна гэж хvртэл боддог байжээ. Гэтэл Итгэлтийн хvvхэд Дулмаагийн хэвлийд бий болжээ.

Итгэлтийг ирээд явахад нь хvvхэдтэй болсноо ичих баярлах хослуулан байж хэлэв.

Итгэлтийн нvд алсад яваа чоно харсан морины нvд шиг сэрвэс хийснээ vнэн vv гэж огцом асуув Тийм гэж царай нь vл мэдэг улайсан Дулмаа газар шагайж нам дуугаар хариулав.

Итгэлтийн царай барзайн бодол болон зогссоноо уг дуугvй мордон явжээ. Маргааш орой нь хонь хариулаад ирэхэд нь ижий нь уйлан хайлан байж vнсээд «Өнөөдөр Нямаа ирж миний охиныг Галсанд гуйж байна. Ижий нь өгнө гэсэн. Нэгэнт л эм хvн болж төрсөн хойно хадамд гарах нь ёс» гэлээ. Дулмаа дур хайргvй хvнд битгий өгөөч гэж элдвээр гуйвч тус болсонгvй. Арга нь барагдаж vхмээр бодогдсон боловч чухам vхье гэх дээр арга ч олдохгvй, зориг ч хүрэхгvй дэмий л усан нvдлэн явдаг болжээ. Итгэлттэй уулзаж уул явдлаа хэлэхэд нь Одоогоор надад ёсолж авсан эхнэр байгаа болохоор чи юу ч гэсэн Галсантай суу. Эм хvн гэртээ хvvхэд гаргах шиг шившигтэй юм байхгvй гэж зөвлөжээ.

Энэ vгийг сонсоод Итгэлтэд хязгааргvй гомдон тvvнийг элдвээр хараан зvхжээ. Гэвч болзоод өдөр болж бэр мордуулах хvmvvc ирээд Дулмааг төрсөн гэрээс нь салган авч явлаа. Төдий л их ёс болсонгvй. Харин найрыг ор нэр болгон ёслоод Галсангийн эхнэр болжээ. Гэтэл Дулмааг Итгэлт орхисонгvй. Үнэн хэрэг дээрээ Дулмаа Итгэлтийн хоёрдугаар эхнэр болж, адуу манах, ажилд явах зэргээр гэртээ ховорхон байдаг Галсан Дулмаагийн хоёрдугаар нөхөр болжээ. Энэ вед Дулмаа өөрийн жаргалд нь саад бологч бул хар чулуу бол Должин гэж бодоод тvvнийг жишин зааж, яавал тvvнд хор хүргэх вэ? гэж явдаг боллоо. Энэ учраас Итгэлт хоёр цэнгийн алтан бөгж, цэнгийн гархин зэмэг бэлэглэж өгөхөд нь хамгийн тvрvvнд Должинд vзvvлэн гайхуулж Итгэлттэй хэрэлдvvлээд «Төрхөмд чинь хүргэж өгнө» гэсэн

Итгэлтийн ширвүн үгэнд ачаа нь хүндэдсэн тэмээ шиг шургачин бууж өгч байгаа Должинг шоолон, хорслын баяр бахдалаар сэтгэл нь дүүрч байлаа.

Должинд Дулмаа шиг жигшил заналтай дайсан анхандаа байдаггүй байжээ. Гэвч сүүлдээ дасаж «юу ч л гэсэн би эхнэр нь Дулмаа бол талхиж талхиж хаядаг хонины морь» гэж сэтгэлээ хуурч явдаг болов. Дулмаагаас хvvхэд гараад арваад хонолгүй осолдов. Эх болсон Дулмаагаас өөр гашуудсан хүн үгүй бөгөөд Должин хязгааргүй баярлаж. Итгэлт ертөнцийн жирийн нэг явдал болж байгаа юм шиг өнгөрүүлэв. Дулмаа үүнээс эхлэн цаг өнгөрөх тутам хонины морь жол яваагаа ойлгосон бөгөөд чадалтай нь чадалгүйгээ жаргалдаа хэрэглэж байдаг энэрэлгүй хорвоогийн ёсыг танимагц залуу нас үзэсгэлэнт царайгаараа сэтгэлээ тохирсон бүхнийг татаж хүслээ хангах замд оржээ. Дулмаагийн завхайрлыг мэдвэл Итгэлт учир тоймгүй хардаж, заримдаа зодно. Би чиний ёсолж авсан эм чинь биш гэж Дулмаа хэрэлддэг. Итгэлт хардаж уурлаж байхад нь Дулмаа нэг талаар түүнийг чадаж байна гэж баярладаг боловч бас айж энэ хүний гараас нь сайнаар гарч чадахгүй гэж боддог байлаа. Муу янхан чамайг дал гарсан ламын тогооны хүн болгож орхино шvv гэж Итгэлт заналхийлэн загнахад дэмий үг биш гэж сэтгэлдээ үргэлж айн явна.

Галсан бол Итгэлт Дулмаагийн явдлыг сайн мэдэвч нүд балай, чих дүлий мэт явдаг байжээ. Итгэлт босож ийш тийш харснаа Дулмааг гараас нь татаж босгов.

За түргэн яв. Нөхөр чинь хүлээж байгаа шvv. Наадах үсээ зас гэж захирангуй шивэгнэв.

Цадсанаараа өөрөө л харь. Надад яарах нөхөр байхгүй.

Муу ч гэсэн төрийн ёсоор хар үсийг чинь хагалж авсан эр чинь шvv гэж Итгэлт хоолойдоо худал инээгээд бургасанд уясан морь руугаа цаггалан тэмээ шиг аажим бөгөөд намбатай алхлав.

Саяхан мэлтэлээж байсан мөнгөн сар ертөнцийн явдлыг харахгүй гэсэн юм шиг том хар үүлний цаагуур нуугдаад бүх юм бүрэг харанхуйд хучигдан, зөвхөн Тамирын голын мандал хүйтэн өнгөөр гялалзаж байлаа.

### VIII

Өглөөний нар дээр мандаж, зуны цагийн гоёлоо өмссөн ертөнцийг соёрхон, түмэн зүйлийн өнгө энд тэндгүй гялалзан байгаа цагт гуулингийн талын зүүн хойноос хор морьтой Төмөр «Эрдэнэ засгийн унага» гэдэг нутгийн дуугаа баргил хоолойгоор хүч мэдэн аялсаар хатируулан орж ирээд морины амыг татаж зогсов. Төмөр, баяр жаргал бадарсан хурц нүдээр эргэн тойрныг ажиглан харахад тэртээ өмнө суунагласан хөх манангийн дунд Тарлан хайрхан жирэлзэн харагдав. Төмөрийн нүднээс нулимсны доголлон дусал гарч хамрын нь хажууд ширхэг сувд шигтгэсэн юм шиг тогтов. Нутаг минь. Тайшир хан минь гэж тасалдсан нам дуугаар сэтгэлдээ хэлээд мориноосоо бууж, нялх ургасан таанаас таслан авч амтархан идэхэд хоёр завьжаар нь ногоон шүлс цахарч байв.

Төмөрөөс үргэсэн сүрэн зээр дээр дээр үсрэн давхиж зугтсанаа гэнэт эргэж алсаас ирсэн энэ хүнийг таних гэсэн юм шиг баахан харж зогссоноо налайн идээшилжээ. Төмөр нүдээ тас анин аажим бөгөөд жил гаруй ширлүүлж эвхэгдсэн биеэ нэгмөсөн тэнийлгэх гэсэн юм шиг суниагаад түрүүлгээ харан хэвтэж суунагласан манангийн дунд нүүгэлтэж байгаа Тайширын нурууг ширтэв. Төмөрийн сэтгэлд ахтайгаа уулзахаас өөр бодол байсангүй.

Эрдэнийх зуны цагт Сүхийн голоор нутаглаж байдаг болохоор шууд очихоор шийдэв.

-- Сайн байна уу? гэж хvvхдийн нарийхан хоолой дуугарахад Төмөр цочиж харвал хэд хэдэн нөхөөстэй хуучин хөх шандан өмд цамцтай хөл нүцгэн арав орчим насны борхvv богинохон шилбүүр барин зогсож байлаа. Төмөр тэр хvvг инээмсэглэн ажиглаж байснаа

--Сайн, дүүгийн лагшин тунгалаг уу? гэж асуув.

-- Миний бие тунгалаг гэж хvv цовоо дуугаар хариулав Дvvгийн алдар хэн гэдэг билээ Төмөр гэдэг

-- Төмөр өө?

-- Тийм манай ээж намайг гаргах гээд аав маань эх барих хvнд явах унаагvй сандарч байхад Цахиур Төмөр гэгч мундаг ах адуу хөөж ирээд дөрвөн сайн морь зvгээр өгч их тус болсон. Тэгээд л надад Төмөр нэг өгсөн юм шvv дээ. Би том болоод Цахиур Төмөр болно. Ах аа та Цахиур Төмөр гуайн тухай сонссон уу? Сонсож байсан гээд Төмөр инээмсэглэв.

-- Бас нэг ахыг нь танина. Эртvvд Богдод мөргөх гээд морин тэрэгтэй явсан -- Юу? Эрдэнэ vv?

-- Тийм, манайд хоноод явсан. Хvv нь их айхавтар тонгордог. Гэхдээ би илvv олон хаясан юм дээ Аавын чинь нэрийг хэн гэдэг вэ?

-- Намбар гэдэг. Та таних уу? Үгvй юм байна. Танайх хаана вэ? Энэ толгойн өмнө.

Юу ч гэсэн газар дээрх ганц ахтайгаа уулзах нь зөв. Хvрээ орсон бол хойноос нь явдаг хэрэг гэж сэтгэл шулуудсан боловч юуны өмнө амарч, тэнхрэх нь чухал. Ингэхлээр нутгийн айлаар хэсэг тараг, цайгаа эргvvлэн хэд хоноод хvрээ рvv явахаар шийдэв. Тийнхvv арав гаруй хоног амраад хос хөтөлгөө морьтой хvрээний зvг хөдлөв. Сайн ван, Луу Гvний нутгийг дайрч болохгvй болохоор хамгийн хангайн өмнө талаар явж билээ. Ширvvхэн довтолж ламын гэгээний нутгийг өнгөрөв. Морьд нь баахан сульдаж, газар хороох нь улам бага болж явтал гадна нь өдий төдий хvн бужигнасан хоёр эрэн майхан харагдав. Майхныг тойрон чөдөртэй, тушаатай морь тэмээ энд тэндгvй идэж байв.

Очихоор шийдээд олон морь уяатай зэл уяан дээр бууж майхныг чиглэн явтал тэртээ идэж байгаа ижилхэн хоёр хар морь нvдэнд нь тусав. Ямар сайхан морь вэ гэж бодоод бага эрэн майханд оров. Өдий төдий хvн хоол идэж, айраг ууж байжээ. Төмөр бvгдийн амрыг эрж, баганын орчим суув. Нутаг ус нэр алдраа асуулцсаны дараа Төмөрт хоол, айраг өгөв. Идэж уух юм нуур далай шиг бялхсан энэ майханд сууж байхдаа даян дээрхийн нэртэй бөө Санжаа зайран гэдэг явж байгааг мэдлээ. Манай зайран багшийн ид шид хязгааргvй болохоор амьтанд тусалж явна. Нутгаас бид хоёр, гурван морьтой гарсан юмсан. Одоо юмаа ч авч явж чадахгvй болох нь. Зайран нь чадалтай болохоор барьц нь их байх гэж нэлээд согтуу нэг хар хvн хэлэв. Хvmvvc энэ зайраны ид шидийг шагшин байж ярих зуур Төмөр гэдэс гаран цадаж аваад хормойгоороо тосоо арчих зуур майхны амаар харвал зэрэгцэн идэж байгаа хоёр хилэн хар морь наранд гялтганан улам ч сайхан харагдав. Оройн нар тvмэн алтан утсаараа цэлмэг тэнгэрийн өрнө хаяаг нэвтлэн шагайсаар жаргаж эхлэв. Тэр шөнө Төмөр хоёр хар морийг хулгайлж аваад модонд уяж, vд өнгөрөхийн вед майханд эргэж ирвэл бөөн вймээн болж байв. Орой од тvгэхийн вед хоёр хар морио авсан хулгайчийн зvрхийг суга татан иднэ, авсан муу хулгайн морьд авчирч өгвөл зайран багш ивгээж нохойн амийг өршөөн нигvvлсэнэ. Өнөө орой зайран багш хулгайчийн зvрх сугалахад ирцгээгээрэй гэж нэг хvн өндөр дуугар зарлаж байв.

Ид чадал нь багтаж ядсан сvрхий бөө нарын тухай сvртэй яриа олныг сонссон Төмөрт энэ vг баяртай сэтгэл төрvvлсэнгvй. Энэ чинь зvрхий минь vнэхээр идчих юм биш байгаа даа. Бөө нар сvрхий арга чаргатай гэж ярьдаг гэж бодогдоно. Гэтэл «Засагт ханы цахиур Төмөр бөөгөөс айгаад явсан хоёр морио авчирч өгсөн гэнэ билээ» гэж шуугин ярих шившигтэй яриа сэтгэлд нь орж ирлээ.

Том эрэн майхнаас Санжаа зайран гарч ирлээ. Шувтан мөртэй туранхай нам биетэй, тогтож явсан хурц нvдтэй, vзvvрт нь цагаан сур сvлжсэн алаг цоо бууралтаж яваа гээгтэй, дөч орчим насны хар хvн ажээ. Хөх дээл дээр хvрэн бvс ороогоод мөнгөн хэт билтэй хутга

зvvжээ.

Энэ хvн хорин насандаа бөө болж, ан хийгээд буцаж явахад нь модны цоорхойд идэж байсан хоёр vхрийг хараад эрсэн эзэн нь мэргэлvүлснийг олж өгснөөр алдаршжээ. Гэхдээ тэр хоёр vхрийг урьтаж vзээд дараа нь олж өгснөө аль хэдий нь мартсанаар барахгvй харин ид шидээр олж өгсөн юм шиг бодож явдаг ажээ. Одоо бол хvнийг буудах, сэлэмдэх зэрэг тvмэн зvйлийн ид шид vзvүлдэг болжээ. Ингээд хаа заль хэрэглэж, хаа ид шид хэрэглэж байгаагаа өөрөө ойлгохоо больсон хvн юм. Хvмvvc тvүний хойноос хуйлран дээлийн хормой, гутлын өлмий зэрэг хvрсэн газар бvхнээс адис авч байв. Хvрэн жинстэй нэг хvн зайрантай уулзаж юм хэлэв.

- Бор зvрхий нь булгилуулж байгаад хvртэж орхино гэж зайран чанга дуугаар хэлээд их л бардам инээв.

«Чадалтай юм бол чи миний зvрхийг эсвэл би чиний морийг» гэж Төмөр сэтгэлдээ шивэгнэв. Тэгээд орой болж ертөнцийг хар бvрээс таглан харанхуйлах вед зайран их майхандаа тvмэн уулын савдаг дуудан хулгайчийг сvртэй хараалаар зvхэн занаж дөвчирхөж гарлаа. Холбоогоо шажигнуулсан тал хэнгэрэг нь эхлээд жигд дуугарч байснаа сvүлдээ vргэлжилсэн хоёр цохилтоор дvжигнэж эхлэв. Бөө хэнгэргээ хаяж босоод майхны орой руу vсрэв. Тэгээд буцаж суудалдаа суухдаа ямар нэгэн юм гартаа барин шал шал хийтэл идлээ. Том гэгчийн тосон дэнгийн гэрэлд харвал зайрны завьжаар цус цувж, цус болсон хоёр гар нь чичирч байлаа.

- Хулгайч цаашаа харлаа, бурхан минь

- Уушги зvрх хоёрыг нь зооглож орхилоо шvv

- Ийм чадалтай хvн байх гэж

- Муу хулгайчийн хохь нь доо

- Хэлээд яахав. Үхэл нь ирж дээ гэх зэрэг хvмvvcийн шивнэлдэн ярих дуу сонсогдов.

Төмөрийн цээж нь хөнгөн болчихсон ч юм шиг, хатган өвдөж байгаа ч юм шиг санагдав.

Төмөр амьсгаа давчдан дотор нь эвгvй болоход майхнаас гарвал дорнод уулын оройгоос том гэгчийн сар салж ядан мандаж байв. Шөнийн жихvүн хvйтэн салхи хацар руу нь vлээж бие нь жирс жирс гэлээ.

- Үхсэн хvнд сvүдэр байдаггvй юм гэнэ билээ гэж бодоод сvүдрээ харвал хэвээрээ байв.

Шууд уяан дээр очив. Чөтгөр болсон юм боль морь vргэх байх гэж бодоод мориндоо хянамгай ойртовол морь нь огт хөдөлсөнгvй. Мордоод явахдаа дахин дахин сvүдрээ харж байв. Хvйтэн хөлс нь чийхран, дахин дахин хэнхдэгээ барилан явсаар майхнаас нилээд холдоод «vхсэн хvнд мөр байдаггvй юм гэдэг» гэж бодоод бууж шавар дээр гишгэвэл бас л байлаа. Гутлаа тайлж байгаад хvртэл vзсэн боловч мөртэй байлаа.

Магнайнхаа хөлсийг ханцуйгаар арчин, мордоод цааш явсаар хоёр морио уясан газар ирвэл бат бэх уяатай хэвээрээ хамраа тачигнуулан зогсож байв. Ам нь цангаж хоолой нь хатсаныг сая мэдэж ойролцоо байгаа жижигхэн горхиос тvрvv урагш харан хэвтэж байгаад баахан залгилав. Тэгээд нэг хар морийг нь эмээллэж унаад гурван морио холбон хөтлөөд дорно зvгийг барин хатируулж явахдаа байн байн тачигнатал инээн нойронд дарагдсан харанхуй ертөнцийг сэрээж байв. Шөнийн турш цас будран оров. Өглөө нь нилээд хөвчирхөг ууланд ирээд бууж морио чөдөрлөн хэрж тавиад хуурай хvнс устай холин идэж, тvр дуг хийхээр хэвтлээ. Нойрон дотор нь дөрөө хангинах нь сонсогдоход нь босож харвал модны завсраар хээр морьтой хvн ирж явлаа. Тэр хvн шууд ирээд мориноосоо бууж ихэмсэг бvдvүн дуугаар мэндлээд модноос морио уяв.

Зах нь задгай хvрэн торгон дээлтэй, ногоон дурдан бvстэй тогтож ядсан хурц нvдтэй хорь гаруй насны энэ хархvв бол нөгөө Заяын хvрэн дээр Жамбал, Цамба хоёрыг балласан

Түгжил байлаа.

Түгжил олз хайж яваад энэ хөвчид шинэ орсон цасан дээр дөрвөн морины мөртэй тохиолдож, юу ч гэсэн энгийн хүний мөр биш гэж мэдээд мушгин иржээ. Хулгайч хүний сэрэмж их боловч сэтгэл гэнэн байдгийг сайн мэддэг Түгжил энэ хулгайчийн морьдыг сүрдүүлж байгаад салгаж орхиё гэж боджээ. Хэрээтэй идэж байгаа хоёр хар морийг хараад шунал нь оргилж уг бодлыг нь улам ч лавшруулав.

- За хө хоёр хар морио өгөхгвй бол чамайг барьж явна даа. Би арван тавны цагдаа байна гэж нүдээ солбилзуулан сүртэй хэлээд босож дайрвал ёврохоор ташуураа бэлтгэв.

Төмөр хөдлөлгвй хэвтэж байснаа хүйтэн инээмсэглэж:

- Хэн нь хэнийгээ барих юм бэ? гэж асуув

Үүнтэй олон яриад хэрэггвй. Өдөж байгаад олон эрийг унагасан нэртэй ёвролтоороо унагааж орхиё гэж бодоод Түгжид ухасхийн дайрав. Юу болсныг Түгжил мэдсэнгвй. Нэг л мэдэхэд нарийхан сураар дангинатал хоньчлон хүлэгдээд хэвтэж байв.

- Одоо ах нь чамд миний хоёр морийг авах арга зааж өгнө дөө гээд Төмөр цааш явж хуурай гишүү цуглуулав. Хүчтэй хүн уурандаа нарийхан сураар янгинатал хүлсэн дөрвөн мөч бадайран, сур маханд нь улам бүр шигдэж байхад хор шар буцалсан Түгжил хөмхийгөө зуун үг дуугвй хэвтэж байлаа. Түгжилд халт ёвруулж зайлж амжсан сүвээ нь амьсгалахад янгинан өвдөхөд «муу ч эр биш байна» гэж Төмөр бодов. Түгжилийг хүлээсээр нь тохойлдон өргөж том хар модны бүдүүн мөчрөөс дүүжлээд дор нь овоолсон гишүүний дэргэд сууж хэт цохиж эхлэв.

- Чи яах гэж байна?

- Чамайг дулаацуулах гэж байна

- Алдар нэрийг чинь сонсьё

- Засагт ханы цахиур Төмөр гэж сонссон уу?

- Сонссон

- Тэгвэл тэр чинь би байна гээд хэтээ чанга цохисонд уул нь авалцав.

Ноцсон уулаа өмх модон дээр тавиад, нударгаараа хэд дэвсэнд утаа багшран суунаглаж байснаа гал ноцлоо. Энэ олонтой дуулсан эрийг сонсоод Түгжил эсэргүүцэж чадалгвй, арчаагвй хүлэгдсэндээ оволзож байсан хорсол нь салхинд замхрах утаа адил үлээгдэн алга болоод амьд байгаадаа баярлав.

- Таныг мэдсэнгвй. Энэ хүлээсээ тайлаад өгөөч гэж гэмшилтэй бөгөөд аргадаж буруугаа хүлээсэн дорой дуугаар гуйв. Түгжилийн нүүрнээс хөлс дуслан, уруулаа хэлээрээ долоов.

- Миний морийг авах арга олов уу? гэж Төмөр бүдүүн дуугаар ой доргиулан инээв. Тэгээд захаасаа тачигнаж асаж байгаа галыг дэвслэн унтраав.

- Та намайг өршөө

Түгжилийг мөрчөөс авч, газар тавиад хүлээсийг нь тайлав.

- Би ч бас л тан шиг олз хайсан хүн. Та болгоовол би таны номхон морины ногт, догшин морины чөдөр чинь больё гэж Түгжил шанаагаа газар нааж байгаад хэлэв.

Төмөр олзны төлөө хэзээ ч яваагвй. Баяд ноёдын адууг сүрэг, сүргээр нь таслан хөөхдөө тэдний хэмжээгвй эрх ямбыг доромжилж, эр чадлаа гайхуулж явна. Тэдэнтэй өрсөлдөж байна гэж боддог байсан. Энэ ч учраас хөөсөн адуунаасаа ядуу зүдүү хүмүүст үнэ өртөггвй өгдөг юм. Гэтэл «би ч бас л тан шиг олз хайсан хүн» гэж хэлж байх юм. «Би олз хайгаагвй» гэж Төмөр бас л хэлж чадахгвй байв. Хулгайч биш гэж бүр ч чадахгвй байв.

Аа тийм үү?.. надад морины ногт чөдөр хэрэггвй гэж хэсэг дуугвй байсны дараа намуухан хэлээд эргэж шууд морьдоо барилан мордоод явахад нь Түгжил мордож хойноос нь эцэгтээ

загнуулсан хvvхэд шиг дагаж явлаа. Хэсэг явсны дараа Төмөр дуулж хоёул зэрэгцэн дорно vt хатируулав. Төмөр нам бөгөөд дургисан бvдvvн хоолойгоор:

Эрдэнэ засгийн унага юу даа

Эрвэлзэж хийсэн жороо доо хө

Элсэн манхан нутагтай даа хө

Эмгэн буурал ээжтэй дээ хө

Тов засгийн унага юу даа

Тонолзож хийсэн жороо доо хө

Тонж хоёр сэтгэлийг хө

Сална гэж л санасангvй дээ

Гэж шуранхайлан дуулж явахад задгай энгэрээр vлээсэн салхи дээлийг нь хөөргөж нисэх гэж дэгдэж байгаа бvргэд шиг харагдаж байлаа. Харин Тvгжил «Төмөрийг бариад Луу Гvний тамганд аваачиж өгвөл илvv юм олох болов уу? Аль дагаж яваад баригдаж мэдэгдэхгvй алс газраас сvрэг сvргээр адуу хөөвөл илvv олз олох болов уу? » гэсэн ац бодолд дарагдан алиныг ч сонгон авч чадахгvй явжээ.

## IX

Зуны өглөө Итгэлтийн хойноос хоосон морин тэрэг хөтөлсөн хоёр морьтой хvн Луу Гvний хошуу хүрээ рvv гарлаа. Энэ бол Итгэлт, Эрдэнэ хоёр байлаа. Тэр хоёрыг зэрэгцэн явж байтал Итгэлтээс хэдэн жилийн өмнө хөлсөнд авсан хөгшин цагаагч гvvгээ унасан Нямаа гvйцэж ирлээ.

- Цай гvзээлж байгаад та хоёроос хоцорч орхилоо. Одоо хамт шогшоод байдаг хэрэг ээ

- Та хаачих нь вэ? гэж Эрдэнэ асуув

- Асуух юм байх вэ дээ. Нямаа гуай хошуу сахиулсанд мөргөх гэж яваа биз гээд Итгэлт ёжтой инээмсэглэв.

- Чухамдаа залбирч байвал буян, өлзий засаж байвал эд өлзий гэж аз хийморьт сайн байдаг юм гээд Нямаа ажиггvй тамхиа асааж татлаа. «Хошуу сахиусанд олон мөргөснөөр аз хийморь дэлгэрдэг бол энэ хvн өдийд хагартлаа баяжих болсон доо» гэж Итгэлт бодов.

- Нямаа гуай аз хийморь ч арван зvгтээ л дэлгэрч байдаг юм даа гэж Итгэлт хэлээд Эрдэнэ рvv нvдээ ирмэлээ

- Ер нь овоо шvv. Ээ жил морь ч бvдэрсэнгvй. Хамрын ханиад ч хүрсэнгvй гэж Нямаа баяртай хэлэв.

Хонины хишиггvй зарим өдрөө Нямаа хүрээ орж хошуу сахиусанд мөргөдөг заншилтай.

Харин баахан халмаг буцаж ирээд чихэр хийж шар тосонд зуурсан балингийн амттай гурил авчирч «Дамшиг минь идэх гээд эрхийгээ, долоох гээд долоовроо идчих вэ дээ» гээд хотынхондоо өгдөг заншилтай билээ.

Хэрэв Нямаа сахиусанд мөргөх гэж хүрээ рvv яваа бол нөгөө хоёр нь Итгэлтийн хашаанаас наадмаар хэрэглэх майхан ширээ, айраг сөгнөх ваар, хул авчрахаар яваа ажээ.

-- Бадарчийн тооноор утаа багшраад байх чинь тогоогоо нэрж байгаа бололтой. Аяга халуун архи уугаад мордох уу гэж Итгэлтийн хэлэхэд тэд замын урд талд харагдаж байгаа хоёр гэр рvv жолоогоо залав. Бадарчийнх Итгэлтийг хvндэтгэн шинэ олбог дэвсэн зочлон суулгав.

Итгэлтэд архины охь сөгнөв.

«За vvнийг чинь тогтоогоод байдаг хэрэг vв» гээд Итгэлт хоёр зарц руугаа харж инээмсэглэв.

«Танд хадгалсан юм. Та л тогтоож орхи. Аль тэр хоёрт архи хийж өг» гэж Бадарч хэлэв.

Итгэлт том мөнгөн аяга дүүрэн архиийг мэлтэлзүүлэн хэд балгаад «чанга гарсан дамшиг байна» гэж мишээн хэлэв.

«Манай архи гоц гарч байгаа шvv» гэж Бадарч бардам хариулав. Өөдөлж байгаагийн шинж гэж шар модон аягтай архи шимэн ууж байсан нэг лам мэдэмхий хэлэв. Нямаа өгсөн архиийг авч, ядам хурууныхаа өндгийг өнгөц хүргэж дээш няслан өргөөд «Усаар хөллөж, угсарч нэрээд, уран цоргоор урсгаж авсан, архи нэртэй, ариун чанартай, сархад нэртэй сайн чанартай рашаан юугаа, алтан мөнгөн хундаганд амсар дүүргэж суухын ашдын сайхан ерөөлийг дэвшүүлье» гээд том гэгч нь балгаж ууснаа, хэсэг тамшаагаад «нохой долоож vx. Тарган цийдэм шиг л юм байна» гээд хоосон аягаа дахиж хийлгүүлэхээр өгөв.

Буянтай айлын цагаа хатгахаар архи хүртэл цийдэм болдог юм байна шvv гээд Бадарч бүдvvн хоолойгоор пар пар инээж Итгэлт өөд харах харцанд «мөн догь хариу өгөв өө» гэсэн бардам бодол, Итгэлтийг догиосон зусарч сэтгэл холилдон байлаа. Итгэлт ихэмсгээр инээв. Гэвч энэ инээдэм нь Нямааг зэмлэсэн Бадарчийг дэмжиж талархсан тэмдгийн аль нь ч байсангvй.

Эрдэнэ исгэлэн ус өгсөн Бадарчид зэvvv нь хүрч Нямаагийн vнэн vгийг талархаж байсан боловч дуугарсангvй харин билээр бинчин тавгаа тавьдаг хар хорвоогийн ёсны тухай бодлоо. Нэгэнт л дээд доод баян хоосон гэж байх нь хорвоогийн ёс болохоор vvнээс өөр яах вэ дээ гэж бодогдов. Нямаа голсон архинаасаа дахин нэг аягыг уугаад ажиггvй босож Итгэлтийн өмнөх архинаас дүүрэн хийж том балгаж залгиснаа «энэ ч аргагvй гоц эд байна» гээд Бадарч руу хандаж талархан инээв.

- Луу гvний баян Итгэлтэд сул юм амсуулж нvvрээ баасдая гэж хэн бодох вэ дээ гээд Бадарч хөгжилтэй инээв. Тэр гурав тэндээс мордож явсаар хошуу хүрээний зах руу ороход Нямаа салах болж

- Та нар намайг битгий хвлээгээрэй гээд шогшив. Нямаа хошуу сахиусны лаврангийн өмнө бууж гvvгээ цулбуурыг нь унжуулан орхиод сvмийн vvдэнд гурвантаа сунаж мөргөв.

- Нямаа гуай сайн байна уу гэж дэргэдvvр нь өнгөрсөн тахилч ламыг хэлэхэд Нямаа алгаа хавсран «жаа сайн» гэж шивэгнэн хэлсэн боловч хэн ч тvvнийг сонссонгvй.

Тасралтгvй орж гарсаар байгаа мөргөлчин нарын заримтай нам дуугаар мэндлэлцэн явж лавранд орлоо. Ганцхан мөнгөн зулын гэрэл анивчин хvж арцны vнэр анхилж, хаашаа л харвал хадаг яндаг болсон энэ сvмийн юм бvхэн нь ер бусын нууц, эрхэмсэг бөгөөд мөргөлчдийн сэтгэлд vзvvргvй бишрэлийн оосрыг vxлvvт зангидна. Нямаа залбиран хошуу сахиусны өмнө очоод наминчлав. Агуу хvчит өндөр сахиус минь, нvгэлт надад сархдаа хайрла. Танаас өөр намайг өршөөн соёрхох хэн байх билээ. Бадарчийнх Итгэлтэд арз өгөөд надад тарган цийдэм өгч байна гээд ширээний ирмэгээс адис авах зуур хулгай нvдээр орчин тойрноо ажиглав. Өндийж толгой дээрээ наминчлаад дахин бөхийж мөнгөн цөгцтэй хар архин нанчидыг ууж орхилоо. Луу гvний хошуу сахиусанд өдөр бvхэн хар архиар нанчид тавьдаг билээ. Нямаа цааш явж хэдэн том балингийн араар гарахдаа хэд дахин базан авч өвөртлөөд сvмийн хаалгаар гарахад цагаагч гvvгий нь нэг лам хөтлөөд явж байснаа зогсож «таныг морио энд орхиж болохгvй гэж хэд хэлбэл болох юм бэ» гээд зогсов.

- Наадах чинь морь биш, гvv хvv минь гэж хэлээд Нямаа ажиггvй очиж цулбуураа авлаа.

- Эндээс зайл. Ноён залраад ирж байхыг харахгvй байна уу гээд лам эргэж явлаа.

Нямаа харвал саяхан ширээ залгамжилсан залуу ноён жороо хар морь унаад хойноосоо хэдэн хиа дагуулан ирлээ. Нямаа сөхрөн сууж залбирлаа.

Алтан нар шиг гялалзаж, мөнгөн сар шиг мэлтэлзэж байна даа. Эзэн минь, төрийн сvлд минь гэж шивэгнэн хэлээд магнайгаараа газар мөргөв. Ноён морины амыг татаж зогсоход хиа



очиж түвшин буулгав. Тэгээд лавран руу ороход Нямаа суусаар байлаа. Эзэн сүлд минь гээд Нямаа бостол хөл нь дайвж гүвнийхээ хэвээрээ тэврэн авч толгойгоо даланд нь наав. Буцаж суугаад мод толгойгоо гаргаж хэд дахин угсран тамхи татлаа. Ноён лаврангаас гарч эргэж залбираад хиагийн барьсан отготой малгайгаа өмсөөд морь руугаа явахад нь Нямаа мод толгойгоо бушуухан өвөртөл цагаагч гүүгээ орхиж навсайн гүйж очоод сөхөрмөгц ноёны луутай магнаг дээлийн хормойноос адис аваад «эзэн сүлд минь» гэж залбирав. Гэвч Нямаа юу гэж хэлснийг хэн ч ойлгосонгүй ойлгохыг ч хэссэнгүй. Харин залуу ноён ихэмсгээр хялайн хараад хиагаар сугадуулан мордож явлаа. Эзнийхээ хормойд хүрсэн их завшаандаа баярласан Нямаа бахдалын оч гялалзсан нүдээр ноёныг далд ортол үджээ. Мөргөлчид дэргэдүүр нь сүлжин өнгөрч, зарим нь Нямаагийн мэндийг асуувч, анхааралгүй хэсэг зогсоод цагаагч гүүрүү явлаа. Нямаа мордож гэрийн зүг шогшин явах зуур дотроос нь архи халааж, гаднаас хэвийж байгаа зуны нар шаран хааяа өврөөсөө балингийн бор гурил гарган зажилж «навсан цагаагч гүүр шогших тусмаа янзтай, нанчид уусан ходоод халах тусмаа баяртай, цэлдэн цагаагч гүүр хатирах тусмаа янзтай, чихэр бурамтай балин зажлах тусмаа амттай» гэж өөрт нь тод боловч хажууд нь анхааран сонсовч үг үл мэдэгдэх гуншаа дуугаар аялж явлаа. Бадарчийн хотын хойгуур гарахдаа танай хар усных биш, хошуу сахиусны хайрласан нанчдынх гэж бүвтнэн хэлээд өндийж хатируулав. Удалгүй Итгэлт, Эрдэнэ хоёрыг гүйцэв.

- За сахиусанд мөргөөд ирэв үү?

- Тийм

- Мөргөлчин олон байна уу?

- Ноён бид хоёроос эхлээд олон байлаа хөөрхий гээд лаврангийн үүдэнд ноёнтой дайралдсан, яаж эзний баринтгийн хормойноос адис авснаа ярилаа.

- Та ч тэнгэрийн умдаг атгажээ гэж Итгэлт хэлээд Эрдэнэ рүү нүд ирмэн инээв.

- Тэгэлгүй яахав гээд өврөөсөө балингийн хэсэг гурил гаргаж хуваагаад «идэх гээд эрхийгээ, долоох гээд долоовроо идчих вэ дээ» гээд өгөв.

- Хүн чинь сахиусанд мөргөхдөө өргөл барьж гарзтай явдаг. Тар чинь үргэлж олзтой явах юм гээд Итгэлт гурилыг амтархан зажлав.

- Сайхан л юм байна гэж Эрдэнэ хэлэв

- Тахилч нь надад хишиг өгсөн. Бас нэг тагш хар архи хайрласан гэж Нямаа ажиггүй хэлэв. Тэднийг гэртээ ойртоход нь Хонгор түрүүтэй Сүрэн сүүлтэй хүүхдүүд угтан гүйлдэж ирлээ. Нямаа мориноос бууж өврөөсөө гурил гаргаж хуваан өгөх зуур «идэх гээд эрхийгээ, долоох гээд долоовроо идчих вэ дамшгууд» гэлээ.

- Батаа, энэ хоёрынхыг булаая гэж Хонгорын хэлэхэд чухам юу идсэнээ мэдэх гэсэн бодолтой уруулаа долоож байсан Бат ойлгосонгүй.

- Ээж ээ үүнийг хараач гээд Солонго ухаасхийсэн боловч тугалын зэлний дэргэд хонгорт баригдав. Ул нь гялалзан гүйж явсан Сүрэн Солонгод тусалж гурвалжин зодоон болов. Хонгорын хэлсэн үгний учрыг хожим ухаарсан Бат бас л гүйж очиж ноцолдов. Сүрэн Хонгорын гар, Батын булчинг хөхөртөл хазсан боловч тус болсонгүй.

- Дандаа хүүхдийн юм булааж байдаг золиг шүү гээд Должин Хонгорын чихнээс татан босгоод хоёр дахин алгадаж түлхэв.

- Чи бас тэгээд Бат руу ухаасхийхэд тэр зугтан арилав. Хонгор уйлсан ч үгүй. Батыг гүйцэж очоод гараа үзсэнээ «муу эм шулмын хазсаныг хараач» гэв.

- Намайг бас хазсан гээд Бат гарын хөхөрсөн булчинг үзүүлэв.

- Юунд хүний юм булаах гэдэг юм гэж? Эрдэнэ хоёр хүүг зэмлэв.

- Тэднээс булаагаад идчихэж чадахгүй муу дамшгууд гээд Итгэлт шоолон инээв.

- Идэх гээд эрхийгээ, долоох гээд долоовроо гэж эс хэлсэн билүү гэж Нямаа гэрийн үг явав.
- Хоовон хөхийг алж орхих юмсан гэж Должин үглэсээр уйлсан Солонго, Сүрэн хоёрыг хөтлөн ирж явлаа.

Нар жаргаж унагаа дагуулан билчиж байгаа гүү зэлээ орхиж билчээр чиглэн явахад том хувин сүү дамжлан барьсан Долгор, Дулмаа хоёр инээлдэн ярилцсаар их гэрийн үг явж байв.

## Х

Жирэлзэн чавхдан урсаж байгаа нарийхан голын зүүн дэнж дээр Өлзийн ганц гэр торойно. Эрхлүүлснээс гэр тэрэг шөргөөдөг болсноор барахгүй олс, даавуу үлдээдэггүй иддэг хэдэн сарлагаасаа болоод Өлзийнх ингэж ганц гэр явдаг болжээ. Өлзий өчигдөр яваад, өглөө бор гөрөөс алж ирснээр гурван халуун амь, тургийн шөл ууж хар гэр хагартал баяр болов. Жин үдийн хирд тэднийд гурван морьтой хүн ирсэн нь Пүрэв тайж хошууны бичээч, хиа хоёрын хамт байлаа. Хэрцгий тайж хариугаа авахаар ирлээ гэж сандарсан Өлзий үүдээ сөхөж тайжийг дагалдагсдын хамт оруулан модон тэвштэй халуун мах, хадгалж байсан ганц галуун хүзүүт архиа барилаа.

Бичээч бүсэлж явсан шар ваадангаа задалж улаан шугамтай бичиг гарган «Сайд вангийн хошуу тамгын бичиг. Албат ардууд мэдтүгэй гэж илгээхийн учир...» гэж эхлэн нэг хөгтэй унжирсан дуугаар уншив. Энэ бичигт Өлзийнх Богд хааны цэргийн хүнсэнд амбан шар нэг, уналганд агт морь хоёрыг нийлүүлэхээр зарлигджээ. Бичээчийг уншиж дуусахад Пүрэв тайж зориуд шахсан бүдүүн дуугаар «Энэ бүхнийг арав хоногийн дотор нийлүүлэхгүй бол өчүүхэн боол чи, хойчийн өдөр хожмын цагт гомдовч барахгүй гэж мэдвэл зохино» хэмээн сүржин нэмж хэллээ. Гаднаас орж ирээ юу болж байгааг нэгд нэггүй мэдсэн Цэнд тайжийн өмнө хормой дэвсэн сөхөрч намбатай бөгөөд зөөлөн дуугаар:

- Засагт ханы «Тө» туслагч гуай урьд шөнө манайд алжаан нойрсоод морилохдоо эрхэм тайж танд мэнд айлтгаарай гэж хэлсэн юмсан гэлээ.

Өмнө нь үзэсгэлэнтэй залуу хүүхэн сөхрөхөд тайжийн нүдэнд үзэгдэж байсан шунал тачаалын гал салхинд үлээлгэсэн зул шиг унтарч, царай нь зэвхий цагаан болоод, хоолой нь чичрэвч, хуурмаг инээмсэглэн шүдээ ярзайлгав.

- Эрхэм туслагч гуай алжааж ирэхэд нь өчүүхэн хүн аймшиггүйгээр хариу мэнд айлтгасан гэж дамжуулаарай гэж намсхийн бөхөлзсөнөө эдний хүү наран гэрэлд түмэн наст богд эзний торгон зэрэгт байгаа болохоор дээрхи зүйлийг авахгүй гэлээ.

Пүрэв тайж Төмөртэй тохиолдож аянга мэт айхтар үгийг нь сонссоноос хойш хэдэн хоног унтаж чадахгүй хар дарж Төмөрийн хүчтэй гарт хоолойгоо шахуулан хашгиран босож байлаа. Тэр муу ёрын зүүднээс салах гэж гүрэм ч уншуулжээ. Сүүлийн вед Төмөрийн догшин дүрийг мартаж эхлэв. Гэтэл Цэндийн үгийг сонсоод сэтгэлд нь дахин нөгөө гайхал Төмөрийн дүр босож өөрийн эрхгүй чичрэн, үг хэлэх гэхээр хоолой нь зангираад байв.

Ингээд бараг л дохиогоор бичээч, хиа хоёроо дагуулан явахдаа олон нохойд хөөгдсөн чоно шиг байн байн эргэн хялайн харж, харах бүрдээ морио давиран гуядна.

Өлзий бэрийнхээ ухаан, Төмөрийн ачийг магтан, хадам бэр хоёр Төмөрийн нэрийг сонсоод шалай буусан тайжийг шоолон элгээ хөштөл инээлдэв. Энэ явдлаас хойш хоёр хоногийн дараа Цэнд үнээгээ сааж байхад дорноос баруун морьтой хүн хатируулан ирж яваа харагдахад манай руу шууд ирж явах чинь юун хүн юм бол доо гэж бодов. Өлзий тэргэнд мөөр шаах зуур ирж яваа хүнийг ажиглан харж байснаа сүхээ тавиад босож «Цэнд минь хүү ирэв бололтой, суудал нь мөн байна» гэлээ. Энэ үгэнд Цэнд босож улам бүр ойртож байгаа хүнийг ажиглав. Өндөр хар морьтой хүн эмээл дээр үл мэдэг ташуу суугаад урагш бөхийн

хатируулна.

- Аав аа, мөн байна гээд Цэнд гvйх гэснээ яг дороо зогсоход нvднээс нь баярын бvлээн нулимс өөрийн эрхгvй асгарав.

Ирсэн шувуу буцдаг. Явсан хvн ирдэг гэж энэ дээ гээд Өлзий тунаран гарсан нулимсаа ханцуйгаараа шудран арчиж инээмсэглэх мэт болсноо:

- Би цай чаная, чи буулгаж ав гээд тvлээ хормойлон орлоо.

Хуягийг гэрийн гадаа ирэхэд Цэнд морины нь цулбуураас барьж буулгав.

- Та нар минь сайн уу? гээд Хуяг эхнэрийнхээ толгойг тэврэн элгэндээ наав. Цэндэд хариу дуугарах чадал байсангvй, уйлсаар байлаа.

Элэг бvтэн уулзсан хойно уйлаад яахав гээд Хуяг инээмсэглэн Цэндийн нулимсыг алгаараа арчив. Энэ вед гэрийн цаана тоглож байсан хvвг гарч ирээд ээжтэй нь зогсож байгаа танихгvй хvнийг гайхан харж байв.

- Миний хvв аав нь ирээд байна гэж Цэнд хэлэв

Хуяг хvвгээ өргөн учир тоймгvй vнсэв. Цэндийн нvврэнд алгуурхнаар инээмсэглэл тодров.

- Бэр ээ, морийг нь чөдөрлөөд тавьж орхи гэж Өлзий гэрээс хэлэв.

Цэнд алсын замд сvрхий гундсан сайхан хар морины тохсон янгиаг авч чөдөрлөн тавиад орлоо. Хvвгээ ороход Өлзий малгайгаа өмсөж золгоод баруун хацар дээрээс нь vнсэж «сайн явж ирэв vв?» гэлээ

- Сайн явж ирлээ. Та нар сайн сууж байв уу?

- Амьд явбал алтан аяганаас ус ууна гэдэг vнэн юм шvв гээд Өлзий хичээвч тогтохгvй гарч байгаа нулимсаа арчиж энэ муу хар нулимс чинь ширгэх болоогvй юм байх даа гэлээ.

Ертөнц зовлонгийн хажуугаар жаргалаар дvврэн байдаг бөгөөд баяр жавхлангийн дундаас салж сарнисан ах дvв, амраг садан амьд мэнд уулзахаар баяр гоц сайхан байдаг билээ.

Өлзийн бор гэр амьд уулзсаны баяраар дvврч, хvн бvхний хөл хөнгөрөн нvд сэргэж хэлсэн vгээ дахин дахин давтаж байлаа.

Цай ууж, хоол идэх зуур Хуягт цэрэгт мордсоноос хойш өнгөрvүлсэн амьдралаа нэгд нэггvй ярилаа. Хатанбаатар Магсаржавын цэрэгт явж байсныг сонсоод Өлзий босож бурхандаа зул барьж «Хатанбаатар улаан сахиусны хувилгаан юм гэдэг шvв хөөрхий» гэлээ.

-- Тийм байхаа. Багш ч мөн лут чойжин доо. Сахиусаа залсны маргааш хар цэрэг бидний уухайн сонсоод сvр сvлд vгvй болж, сvнс нь зайлдаг юм гэж Хуягийн хэлэхэд:

- Тэгэлгvй яахав. Ард нь богд гэгээн, дэргэд нь улаан сахиусны хувилгаан харж яваа цэргийн сvрд юу тэсэх вэ гэж Өлзий мэдэмхай бөгөөд итгэлтэй хэлээд тамхиа татлаа. Хуяг шархдаж өвөр монголд жил хэвтсэн. Жинчинд дайгдаж хvрээнд ирснээ ярилаа.

- Хvвд минь сvрхий барцадтай байснаас сум дийлжээ. Амьд гарсан хойно ухаан бий.

- Нөхрийнхөө хэлснээр нэг бичээч хvнд хэдэн янчаан хадагтайгаа барьж бичиг хийлгээд дээдэст гавьяа мэдvүлсэн. Би муу vгvй дайтсан. Над шиг хvн баатар болсон ч буй, гэтэл хэд хоногийн дараа хоёр боов, нэг аюуш хадаг хайрласан байна билээ. Миний заяа дутсан юм байлгvй дээ гэж Хуяг гомдолтой ярив.

- Иш хvв минь. Ямар томоогvй юм ярина вэ. Бид нар шиг эгэл хvн хаанаас баатар болох вэ. Бас тэгээд манай хошууныхныг монгол даяар итгэхээ байсан юм гэдэг шvв.

- Яагаад тэр билээ гэж бэр нь сонирхон асуув

- Манай ноён Өөлдийн Амарсанаа, Шадар бэйс Цэнгvнжавтай нам нийлж, сэм сvлбэлдэж монголоо манжаас салгаж авья гэж тангараглан ярилцаад адаг сvүлд нь болохоор манжийн хаанд ховлочихсон юм гэнэ билээ. Тэгээд шагналд нь хааны гvнжийг авч Сайд ван болоод Бээжинд суудаг болсон. Yвнээс болж монголчууд манайхныг урвамтгай гэдэг болчихсон

хэрэг гэнэ билээ.

- Аль дивангарын элий балай ноёны хэрэг бидэнд ямар хамаа байх вэ... Яг л над шиг хvн баатар болсон юм даа гэж Хуяг гомдолтой давтлаа.

- Бурхан яаж хувиран явахыг хэн мэдэх билээ дээ. Бид нар шиг усан нvдтэй цусан зvрхтэй хvмvвст эгэл юм шиг харагдаж байвч цаад талд нь бурхан байна шvв дээ гээд Өлзий залбирав.

Хуяг Доржийн хэлснээр Богд эзэнд гавьяа мэдvвлэн бичиг өргөөд юу ч олоогvй билээ.

Тэгээд хvрээнд гуйлга гуйх, тvлээ хөрөөдөх зэргээр амьдарч байлаа. Засагт ханы хошууны нэг айлд тvлээ хөрөөдөж байгаад Төмөр Тvгжил хоёртой дайралдаж зовлон зvдvврээ ярьсанд Төмөр нэг хар морио өгчээ. Нөхдөөсөө янгиа олж тохоод нутаг руугаа гарахад «миний ах Эрдэнэ гэдэг хvн, Сайд вангийн юмуу, Луу гvний нутагт байгаа бололтой. Зав гарвал олж сураг гаргаад байвал зvгээр байна. За тэгээд Өлзий гуайд мэнд хvргээрэй» гэж Төмөр хэлжээ.

- Надад хөл залгуулж өгсөн тэр хvн та нарыг таньдаг бололтой. Аав танд мэнд хvргээрэй гэсэн гэж Хуяг хэлэв

- Алдрыг нь хэн гэдэг бол?

- Засагт ханы цахиур Төмөр цуутай эр дээ гэж Хуяг хэлсэн чинь аавын нvврэнд тvмэн баярын оч гялалзан «Цэнд минь сонсож байна уу. Тэр эгэл хvн биш шvв» гээд Төмөр яаж ирсэн, яаж тусалсан зэрэг бvх явдлыг яриад «тэр гайхамшигт хvний хишгийг хvртэх буяныг бид урьд насандаа хийсэн юм байх даа» хэмээн vгээ төгсгөв.

Тэр шөнө Өлзий, Хуяг, Цэнд гурав Төмөрийг магтан, тvвний тухай бусдаас нэмvвр, хачиртай сонссон домог шиг юмаа давслан нэмж ярилаа. Маргааш өглөө нь Өлзий өвгөн анд унадаг хvрэн морио унаад Сайд ван Далайчойнхор ван, Заяын гэгээн, Луу гvний хил нийлсэн сав нутгаар Эрдэнийн сургийг гаргахаар мордов.

## XI

Мянга есөн зуун долоон он Хатгалаар дамжиж Ангарын хотоос Павлов гэдэг орос, vхрийн наймаагаар энд иржээ. Тvрvвчийн наймаагаа Итгэлтэй хийж эхэлснээс хойш олз омог ашиг хонжоо их олж, жил бvр хэдэн зуун vхэр худалдан авч, Тvнхэнээр дамжуулан гаргадаг болов. Анхандаа Итгэлт нутгийн ардуудаас хямд vнээр vхэр авч Павловт дамжуулан өгдөг байсан бол сvүлдээ олзоо хуваадаг хань хоршоо нь болжээ. Энэ хоёрын аль аль нь ч анх наймаа хийснээ дурсан ярих дуртай. Итгэлтийг даваан дээр бугаад тамхи татаж суухад морин тэрэгтэй орос ирээд зогсов. Богино тааран дээлтэй хууз сахалтай Павлов бууж, Тvнхээний буриад аялгуугаар мэндлээд vхэр худалдан авах тухайгаа яриу.

- Орос чамд мөнгө байвал надад vхэр байна гэж Итгэлт хэлжээ.

- Баатар цагаан хааны буянаар чамайг хошуу нутагтай чинь худалдан авсан ч мөнгө байна. Хоёр зуун амбан шар байнаа? гэж Павлов асуув

- Ердөө нь vв. Тав хоногийн дараа хоёр зуун шар энэ даваан дээр туугаад ирье. Байдаг мөнгөө дэнслээ сууж байгаарай гэж Итгэлт хэлээд тэр хоёр салжээ. Тэр вед Итгэлтэд хоёр зуун шар байгаагvй, гэвч болзсон тав хоногийн дотор өдөр шөнөгvй давхиж байгаад ойр орчмын айлуудын шилдэг шаруудыг хямд vнээр салгаж хөөж ирсэн бөлгөө.

Павлов овооны өмнөх хавтгай чулуун дээр оросын гулдмай гэж нэртэй урт цагаан мөнгө гаргаж тавиад хангинуур сvхээр тас цавчлан цэгнэж өгөхдөө vсэрсэн хэлтэрхийнvвдийг авах нь битгий хэл харах ч vгvй байжээ. Энэ нь Итгэлтийн сэтгэлд vлэмж таалагдаж «их гарын панз бололтой» гэж бодож байсан билээ. Ингэж наймаа хийхдээ Павлов бодож ирснээсээ дөрвөн зуун лан хожсон бол Итгэлт хvнээс авсан зуун жар гаруй vхэр бvхнээс хоёр лан хожжээ. Тэр цагаас хойш энэ хоёр дотно нөхөрлөж хэдэн мянган vхрийн наймаа хамт

хийжээ. Нөхөрт итгэдэг. Том наймаа хийхээс буцдаггүй зүрхтэй, ховор монгол шvv гэж Итгэлтийг Павлов үргэлж магтаж байдаг аж. Манай Павлов нvнжигтэй орос доо. Жаахан онгиргон болохоос биш, ёстой нэг их гарын панзчин даа гэж Итгэлт Павловын тухай ярьдаг байв. Павлов сvvлийн жилvvдэд vxрийн наймаанаас их баяжиж Ангарын хотонд хоёр давхар чулуун байшинтай банкинд өдий төдий хөрөнгөтэй болсон бөгөөд хэдийгээр энэ хоёр хоршоо боловч, монголоос худалдаж авсан vxрээс Итгэлт нууц шомбодож орост худалдсан vxрээс Павлов хожоо гарган завшиж бусад орлогоо тэгшхэн хувааж сэтгэл ханамжтай явдаг ажээ. Павлов зуны сvvл сард ирж, намар vxрийн сvvлийн хэсэгтэй буцдаг. Хэдэн жилийн өмөн Луу гvний нутагт гурван том өрөөтэй модон байшин, том хашаа барьж авснаас хойш эхнэртэйгээ ирдэг болжээ. Нутгийнхан оросын суурин гэж нэрлэдэг тэр хашаа байшинг өвөл нэг орос сахиж vлддэг бөгөөд сvvлийн хоёр жил алиа Петр гэдэг хочтой болсон ханхар орос сахидаг болжээ.

Хошуу наадам эхлэхийн урьд өдөр Итгэлт морьд, хvvхдээ авч наадмын байранд гурван майхан шааж буув. Дунд талын том эрээн майханд битvv хивс дэвсэн архи айраг сөгнөж, хоёр талаар нь хашин өртэй суман ширээ тавьж дээр нь ижилхэн хятад шаазан, мөнгөн аяга өржээ. Хоёр талын хөх майхны нэгэнд хоолны газар, нөгөөд ажлын хvmvсийн унтах газар засжээ.

Орой нар жаргахаас нилээд өмнө хонх жингэнvвлсэн гурвалсан морин тэрэг ирж голын майхны өмнө зогсож тvvнээс Павлов эхнэрийн хамт буухад Итгэлт vлэмж элэгсгээр угтан очиж мэндлээд урьж оруулав. Уяан дээр морь арчиж байсан Эрдэнэ Павловын бие барьсан хар хувцас, эхнэрийн салбалзсан элбэг дээлийг хараад «ертөнцийн амьтад мөн янзын юм өмсөнө дөө» гэж дотроо бодов. Орос эхнэрийн хувцасны хөдөлж байх нь шархадсан элээ шиг санагдаж, инээд хүрэхийн хамт сонирхон харах хvсэл төрлөө. Эрдэнийг тэрэгний дэргэд очиход өмнөх өндөр суудал дээрээс ширэвгэр шар сахалтай хонин бор нvдтэй толгой нvцгэн орос бууж ирээд тойрон байгаа хvvхдийг харж арзайн инээмсэглэснээ монгол хэлээр Эрдэнэтэй мэндлэв.

- Морь тавина. Та тусална гэж тэр оросын хэлэхэд Эрдэнэ инээмсэглэж

- Морьдоо тавьж өгөөч гэж байгаа юмуу аа. Би наадах дөнгөнөөс чинь яаж салгадгийг мэдэхгүй гэлээ.

Энэ вед зvvн талын майхнаас хоол хийж байсан Галсан гарч ирэхэд орос угтан очиж гарыг нь атган «сайн байна уу? » гэхэд нь Галсан инээмсэглэх мэт болоод «Алиа Петр гуай сайн байна уу? Ойрдоо vзэгдэхгүй яагаа вэ? » гэлээ.

- Эзэн ирэх болоод зав ч байхгүй гээд орос Галсангийн мөрийг алгадахад нь Галсан золтой л уначихсангvйг хараад «энэ орос барилдвал овоо бяртай байх шvv. Харин мань эрд мэх ч байхгүй даг аа» гэж Эрдэнэ бодов.

Энэ вед майхнаас нөгөө салбагар хувцастай орос авгай гарч ирээд «Хонгор Солонго» гэж дуудав. Тэрэг сонирхон vзэж байсан Хонгорыг гvйн очиход Бат дагаж очлоо. Эхнэр Хонгорыг vнсээд хайрцагтай юм өгөв. Солонго бишvврхэн Сvрэнтэй зэрэгцэн нилээд зайдуу зогсож байхад нь орос эхнэр инээмсэглэн очиж тэврэн vнсээд бас л хайрцагтай юм өгөв. Бат, Сvрэн хоёр эхнэрийг майхандаа буцаж ортол нь горьдон ширтэж байв. «Дөрвөн хvvхэд байхад хоёрыг нь ялгаж орхилоо шvv. Нэг нэг танзуур ч өгчихгүй дээ» гэж Эрдэнэ бодоод эхнэрт дургүй нь хүрлээ. Эрдэнийн энэ бодлыг мэдсэн юм шиг нөгөө алиа Петр гэгч өмднийхөө гуя руу ухаж байгаад хятад мөсөн чихэр гаргаж тэрэгний арал руу цохиж хуваагаад Бат, Сvрэн хоёрт өгөхөд нь Эрдэнэ талархан инээмсэглэв.

Ингээд Эрдэнэ, оростой хамжиж морьдыг тэрэгнээс нь салгаад уяа руу хөтлөн явжээ.

Орос оо, чамд намайг согтоох архи байна уу? гээд Итгэлт царгил нарийхан дуугаар инээхэд Павлов бүдүүн дуугаар хөгжилтэй инээснээ баатар цагаан хааны буян манай байна. Харин манай согтох архи танай бана гэлээ. Энэ хоёр уулзах бүрдээ үүнийг ярьдаг. Анх тамирын хойт эрэг дээр үхрийн наймаа хийгээд Итгэлтийн ингэж хэлэхэд Павлов яг л энэ үгээ хэлж, орос цагаан архи нэг шилийг гаргаж ирэхэд Итгэлт жижиг ваартай хорз авчруулан сольж уусан билээ. Павлов, эхнэр хоёрыг майхны хоймор зассан мөнгөн цартай тарган ууцны ард суулгаж айраг архи сөгнөж гарлаа.

- За тэгээд наймаа сайн олз омог их биз дээ? гэж Итгэлтийн асуухад Павлов бардам инээмсэглэж «бид хоёр олз олохгүй бол ямар аавын хүү болох билээ дээ?» гээд хоёул чанга инээв.

Эрдэнэ морьдыг уяж орхиод баруун майханд орлоо.

- Танай шинэ байх аа? Би танихгүй байна гэж алиа Петр ажиглаж байснаа Эрдэнээс асуув.

- Тийм. Би саяхан ирсэн гэж Эрдэнэ хариулаад сууж айраг хийж авлаа.

Петр босож давхарласан хулнаас авч өөрөө айраг хийж хүд хүд хийтэл залгилаад хулаа тавьж сахлаа гарын алгаар арчив.

- Танай нэр хэн?

- Эрдэнэ гэдэг

- Миний нэр алиа Петр. Павловын зарц байна гээд нүдээ ирмэж, зальтайгаар инээмсэглэснээ «Танай эхнэр байна?» гэж асуув

Ямар олон үгтэй орос вэ? гэж Эрдэнэ бодсон боловч уцаарласангүй.

- Эхнэртэй. Та эхнэртэй юу?

Петрийн нүдэнд тодорхой байсан хөгжил нь хурц хутгаар хуссан юм шиг үгүй болж, нүдэнд нь гүн бодол нууц гашуудал илрэв. «Зайлуул үхэж үрэгдсэн юм болов уу даа. Хэрэггүй асуув» гэж Эрдэнэ бодов.

- Байна. Бас хоёр хүүхэд байна. Олон мянган өртөө хол байна гээд орос гунигтайяа санаа алдав.

Хаа газар хэний хүү ингэж эхнэр хүүхдээ олон мянган өртөөний цаана орхичихоод ганцаараа тэнэж яваа юм бол доо гэж бодоод Эрдэнэ энэ үүнийг өрөвдөх сэтгэл төржээ.

Петр бол 1905 онд орос оронд болсон хувьсгалд идэвхтэй оролцсон хэргээр Сибирьт цөлөгдсөн большевик намын гишүүдийн нэг билээ. Уг нь Морозовын фабрикт слесарь хийж байсан бөгөөд тэнд нь эхнэр хүүхэд нь үлдсэн. «Александр хааны төв гэж нэрлэгдсэн хатуу гянданд гурван жил гаруй хоригдож байгаа Байгалын орчим ажилд гараад тэндээс оргож Түнхэнд Павлонтой дайралдан энд ирж сууринг нь хардаг болжээ. Петр цөллөгний оргодол, гэхдээ бүр улс төрийн хэрэгтэн гэдгийг Павлов мэдэж байсан боловч хямд хөлсөнд нь болж хэрэглэсэн ба Петр хатуу шорон хүнд ажилд ядарсан биеэ засаж цагийг хүлээх бодолтой байжээ. Анх ирсэн жилдээ монголчуудын зан заншил, хэл амыг мэдэхгүй учраас тулгамдан хүмүүсийн аж амьдралыг холоос ажин харж байсан бол сүүл сүүлдээ юуны өмнө хэл сурах гэж буруу хазгай сонссон үг, хүмүүсийн тоглож заасан яриаг амьтны инээд хүргэж явсаар алиа Петр хочтой болжээ. Павлов монголчуудыг ихэмсгээр доромжлон харж, жигшиж байгааг Петр зэмлэдэг.

Монголчууд эрт нэгэн цагт дэлхий дахиныг эзэлж байсан гэдгийг би огт үнэмшихгүй юм.

Ингээд харахад сарлагаасаа дээр гэх юм алга. Эд яваандаа санаж үгүй болоод энэ өргөн баялаг нутгийг азтай, чадалтай, улс хүртэж орхино доо гэж Павловыг хэлэхэд Петр зад эсэргүүцэж «тийм биш. Монгол бол хор уугаад үхэлгүй муужран унасан баатар. Зүй нь эднийг цочоож сэргээх хэрэгтэй. Тэгвэл зөвхөн суниахад нь тоншиж байгаа хар хэрээнүүд

чөтгөр шулам руугаа тонилох юм шvv» гэж хэлдэг байлаа.

Монголын ард түмний бүдүүлэг харанхуй хатуу амьдралыг хараад Петрийн сэтгэл өрөвдөвч монгол хүний өргөн дэлгэр сэтгэл, түвний гэнэн цагаан санаа, чөлөөт амьдралын эрмэлзлийг ойлгож байжээ. Жил гаруй болоод Петр овоо хэлтэй болж амьтантай танилцан архи дарс ууж байхдаа зарим хүмүүст улс төрийн юм ярихад «галзуу орос минь чи ингэж дэмий юм чалчиж байж бөндгөрөөсөө хагацна. Урт хормой хөл ороодог, урт хошуу хүзүү ороодог юм гэдэг юм шvv» гэж урдаас нь хариулдаг байлаа. Монголын ард түмний хатуу амьдралын тухай зарим хүнд ярихад «манай орон баян, манайд ажил хийхгүй хэдэн жил цатгалан амьдарч болно» гэж хариулдаг байв.

Нэгэн удаа Нямаатай ярьж байгаад оросын цагаан хааныг муу хэлж орхисон чинь «бурхан хааныг тэгж хэлээд, нүглийг даахгүй шvv» гэж зэмлэсэн. Бас Галсантай ярьж Итгэлтийг зальтай хүн гэсэн чинь зад эсэргүүцэж «наддаа л бурхан» гэсэн билээ.

Павловын сууринг сахиж байхдаа Луу гүний хүрээний гуйлагчинтай хүртэл ярьж үзсэн. Гэтэл ярьсныг нь ойлгохын оронд өгсний нь аваад зайлдаг байжээ. Петр энэ мэт бухимдаж байсан боловч, цөхөрсөнгүй. Хүмүүстэй уулзах бүрдээ тоглоом, шоглоомын дундуур улс төрийн юм ярьж байдаг байлаа.

- Та Итгэлтийнд зарагдаж байна? гэж Петр Эрдэнээс асуув.

- Тийм ээ

- Энэ нутгийн хүн үү?

- Үгүй миний нутаг хол. Засагт ханы хошууг мэдэх үү?

- Мэдэхгүй сонссон

- Би тэр хошууны хүн. Богдод мөргөх гэж яваад явгарч Итгэлийн хүчээр амьдарч байна.

- Итгэлт хир хөлс өгч байна?

- Тодорхой хөлс яриагүй. Гэхдээ овоо юм өгч байна. Ер нь сайн хүн байна гэж Эрдэнийн хэлэхэд Петр тоомжиргүй инээмсэглэв.

Майхнаас «Петя» гэж хашгирсан Павловын бүдүүн дуу Петрийг босгов.

- Зарц хүн өөрийн эрхгүй байдаг болохоор явж үзье дээ хөгжилтэйгээр нүдээ ирмэн гарч эрээн майханд орлоо. Галсан ширээн дээр тавагтай бууз, луйм пүнтүүвтэй шөлнөөс аягалан тавьж байв. Павлов юм оруулж ирэх тушаал оросоор өгөхөд Петр толгой дохин гарч тэргэн дээрээс хоёр хар авдартай юм авчирч Павловын ард тавихад эхнэр нь уудалж том цагаан боодолтой юм гаргаж нөхөртөө өгөв.

- Наадмын өчүүхэн бэлэг чамд авчирсан юм гээд Итгэлтэд өгөв. Итгэлт өгвөл зохих зүйлийг авч байгаа юм шиг ажиггүй аваад ардаа тавилаа.

Энэ хооронд Павловын авгай хэдэн шил архи гаргаж ширээн дээр тавьжээ.

- Нөгөө Эрдэнийг дуудаач гэж Итгэлтийн хэлэхэд Галсан ухасхийн гарлаа.

Хоршоо хоёр харилцан найр тавин, бие биеэ харж бүр мишээн, мөнгөн аягатай арз ууж, халуун бууз, тарган махаар даруулна.

-- Арз толгойд гарах нь айхтар болохоос биш сайхан архи шvv гэж Павловын хэлэхэд Итгэлт сэтгэл ханамжтай инээмсэглэснээ «чиний нөгөө надад өгдөг нөхөр шилэн савтай чинь ясны хөлс гаргадаг хатуу дамшиг байдаг шvv» гэж найр тавин хэлэв.

Энэ вед Эрдэнэ орж ирээд баганын хажууд зогсож «намайг дуудсан уу?» гэж асуув.

Тийм, суу. Энэ бол манай анд Павлов гэдэг панзчин. Энэ бол гэргий нь Павлов, би нэг баруун гарын хүнтэй болсон. Бичиг унших гэдэг нь уяа таарсан түмний эх давхиж байгаа юм шиг. За Павлов наадах архианаасаа задлаач гэж Итгэлтийн хэлэхэд Павлов нэг шилийг авч алиа Петрт өгөв. Петр шилний бөгс рvv ганцхан цохиход бөглөө нь тэр хаяа руу үсрэн алга

болжээ. Бүгд инээлдэн Петрийн сурмагийг гайхав. Итгэлт ширээн дээр тавьсан архиийг авч нарийвчлан үзэв.

-- Энэ чинь овоо чанга билvv? гээд аягануудад хийж нэгийг аваад Эрдэнэд өгөв. Эрдэнэ сөхрөн сууж, дотогшоо шамласан нударгаа сэгсрэн, аягатай архиийг авч дээш өргөн:

Архи нэртэй амттын дээж юугаа

Алтан амтай мөнгөн хундаганд

Амсар дvvрэн хийж өгсөн

Ах дvv олон та нарын

Аз жаргал далай шиг бялхаж

Урт наслан удаан жаргахын

Өлзийт сайхан ерөөлийг

Уламжлан дэвшvvлье

Гэхэд нь «тэр ерөөл бат орших болтугай» гэж хэлэх зуур Итгэлт бас нэг аягыг авч Петрт өгөв. Эрдэнэ ядам хуруугаар мэлтэлзсэн архины мандалд хүргэн тахил өргөөд шимэн уужээ. Петр Эрдэнэ шиг сөхрөн суугаад, архиийг хоёр гардан авч юу хэлэхээ олж ядан хэсэг твгдэрснээ «сайхан ерөөлийг уламжлан дэвшvvлье» гээд хөгжилтэйгөөр нүдээ ирмэн инээмсэглэснээ ганцхан хөнтөрч орхиод ханцуйгаа үнэртэв.

Тэр орой Итгэлтийн майханд олон зочид цугларч найр болоход Бадарч, Цамба, Жамбал нар байжээ.

Петя, хөгжим гэж үлэмж согтсон Павлов өндөр дуугаар хэлсэнд алиа Петр баян хуур авчирч алд, алд сунган татаад бvжиглэхэд нь газар доргиж, всрэхдээ майхны шувуу модонд бараг л хүрч байлаа. Эрдэнэ Петрийн энэ байдал их л таалагдаж, тvvний гунигтvй, хөгжилтэй алиа занд талархах сэтгэл батжив.

Аль вэ, Эрдэнэ минь дуу бариач гэж Итгэлт хэлээд мөнгөн аяга дvvрэн архи барив. Энэ майханд цугларсан бvхэн өөрт нь сайн хvн болохыг хичээж байгааг ойлгосон Итгэлтэд бардам сэтгэлийн их баяр оволзон, хvсвэл хорвоогийн уулыг тал болгож, талыг уул болгох чадал биенд нь байх шиг санагдаж байв. Эрдэнэ «эр бор харцага»-ыг дуулсанд Итгэлт хоолой нь цээлхнийг магтаж таван түрлэг дахиулав. Хуруу гаргах, хуалах зэрэг зэрэг болж үргэлжилсэн шуугиан, эх захгvй яриа эхлэв. Тvнхэний буриад тосгонд өссөн Павловт энэ бvхэн нь ердийн дассан юм байсан болохоор олны урсгалд орон хашгирах газар нь хашгирч, инээх газар нь инээж суув. Харин эхнэрт нь ойн олон баавгайн дунд орчихсон юм шиг санагдавч Итгэлтийг хvндлэх хэрэгтэй. Энэ хvн бидний жаргалд их тус болно шvv гэсэн нөхрийн нь vг санагдан заримдаа эвшээж, заримдаа худал инээж суув. Сврхий согтсон Петр хуруу гаргаж ч үзэв. Хошууны олон тамир гээд хашгирч ч үзэв. Бvр сvvлд нь Эрдэнийг тэвэрч аваад үнсэв.

Эрээн майханд ийм юм болж байхад тvvний гадна өөр нэг зvйл болж байв. Нар салхинд борлосон хөрслөг царайнд нь тормолзсон хар нvд, яралзсан цагаан шvд, цэцэг эрвээхэй хоёр шиг дvйж, тавагтай юм бариад орж ирэх бvрдээ зvрх рvv харван инээмсэглээд, буцаж гарахдаа ташаагаараа үл мэдэг дайван яваа Дулмаа хvvхэн, Жамбалыг дагаж ертөнцийн амьдралын сониныг мэдсэн Цамбыг өөрийн эрхгvй таваг, таваг тарган мах, хөөсрөн шуугиж байгаа айраг, орос архи, шуугианаас салгаж майхнаас гаргажээ. Галын майхны ард очоод зогсож байтал савтай угаадас асгахаар Дулмаа зvvн тийш явлаа. Лам сэмхэн алхсаар бараг тулж очоод хоолойгоо засав. Хvvхэн цочин эргэв. Өөртөө талархсан нvдийг хvvхэн олж харахгvй хэрхэн өнгөрөх билээ. Оройноос эхлэн сээтэн хаясан өндөр цагаан залуу лам, Итгэлт Галсан хоёроос уйдаx нь байтугай жигшдэг болсон Дулмаагийн сэтгэлийг гижигдэж



байжээ.

- Хэн бэ?

- Би байна. Битгий ай гээд Цамба дахин юм хэлэх гэсэн боловч зүрх нь хөөрч амаар нь гарах гээд тагжрав.

- Юунаас айдаг юм бэ? харин очлоо шvv

- Хvvхэн чамд юу хэрэгтэй вэ?

- Юу, юу ч хэрэггүй гээд Дулмаа хvйтэн инээмсэглэв.

- Чамтай.. гээд Цамба vгээ тасалснаа Дулмаагийн гараас барьж авлаа. Хvvхнээс хувцсанд нь нэвт шингэсэн vнээний сvvний гашилмал vнэр ханхлав.

- Лам хvн ингэж болдог юм уу? тавиач гэхэд Цамба юм дуугаралгvй тэврэн авч цааш явахад нь «тавиач яасан ичдэггvй юм бэ?» гэж гарыг нь хумслан тийчлэв. Гэвч хашгирсангvй.

Лам явсаар жалганд орж Дулмааг тавихад «ичихгvй яасан юм бэ» гээд хөдлөлгvй зогсож байлаа..

«дахин уулзаж байна шvv» гэж шивэгнээд лам хvvхний хацрыг хурууны vзvvрээр эв хавгvй илснээ эргэж тvргэн явжээ. Дулмаа далаа хавчин хоолойдоо тоомжиргvй «хэ» гэжээ. Цамба майхны ойр очвол харанхуйн дунд нэг хvн зогсож байхдаа нь зог тусан зогсов.

«Яваад өнгөрөх нь зөв байх. Морь хараад л явж байгаа хvн биз» гэж бодоод нvvрээ буруулан өнгөрөх гэтэл хvчтэй гар мөрөн дээрээс нь шvvрч аваад гуд татан эргvvлж «асман банди, хvнийг барагтай доромжил» гээд цохисонд Цамба сөхрөн унав.

Тvргэн босож «юу болоод чи хvн зоддог билээ?» гээд давшлан очвол дахиад хvнд гар цээжинд нь бууж ухаан нь балартан унав. Ингэж цохисон хvн бол Эрдэнэ бөгөөд энэ хоёрын хооронд өшөөний хар оосор эрчлэн зангирч явсаар арав гаруй жилийн дараа тэр зангилааг Цамбын хатуу зарлиг тайлж билээ.

## ХII

Луу гvний хошуу наадам эхлээд хоёр дахь өдрөө vргэлжилж байлаа. Голын улаан эрээн асарт ноён, туслагч, тэдний хатан болон ойр шадар хvmvvc, баруун талын шар асарт мяндаг, тушаалтай лам нар зvvн талын хөх эрээн асарт тайж угсаатан морилон суужээ.

Хvн бvхэн олигтой дээл хувцсаа өмсөж энд тэндгvй бvснээсээ зодог шуудаг хавчуулсан бөхчvvд, хусуур сойз хавчуулсан уяачид сvlжилдэнэ. Гурвын даваа эхлээд хошууны нэр цолтой бөхчvvд хоорондоо уралдаж байлаа. Хэзээнээс бөх сайтай, Луу гvний хошуу, наадмаа бусад хошуунд алдахгvйг бараг хvн бvхэн хичээн, гаднын бөх унахад шуугилдан инээлдэж, өөрийн хошууны бөх унахад гаслалдан харамсана.

Эрдэнэ. Заяын шавийг нэг ламтай тунаран vлдэж барилдах болов. За хө Эрдэнэ минь. Би захыг чинь тасартал мушгия, гэгээнийхэн шөрмөстэй шvv гээд Нямаа дээлийг нь авч захыг нь мушгив

- Ноднин манай хоёр заан нэг начинг хаяж балаг тарьсан дамшиг. Вандан арслан л авч баймааж хаясан юм. Эрдэнэ минь хичээж vзээрэй гэж Итгэлт хэлээд vl таних нэг хvнтэй явлаа.

- Өндөр ахаа надад боорцог авчирч өгөөрэй гэж Солонго чихэнд нь шивэгнэхэд Эрдэнэ тааламжтай инээмсэглэв.

Эрдэнэ ламтай хоёр дахин тавилцаж, удаан барилдав. Ингээд хоёр биеэ хяналцан өө харж баахан хөшилдөв. Гэнэт лам шуугин барьж авахад нь Эрдэнэ ольж аваад тонгоров. Лам ар зоогоороо пад хийтэл унав.

- Аюултай тонгордог хvн байна шvv

- Аль хошууны хvн бэ?

- Мэдэхгvй, дэвхрэг Итгэлтийн шинэ зарц гэж Эрдэний тухай ярилцаж байлаа.

Эрдэнэ зодгоо тайлаад, дээлээ өмсөж байхад нилээд согтуу Итгэлт ирлээ.

- Сайхан тонгорлоо шvv

- Арай гэж л давсан боллоо

- Шөрмөстэй банди байгаа юм. за Эрдэнэ минь их насаа мордуулж орхи. Өнөөдөр бид хоёр нэг магнай тэнийх байх аа.

Өчигдөр азарга давхихад ноён Сүрэнгийн азаргууд замаас угтан нийлж уралдаад, түрvvлж, Итгэлтийн хээр азарга гуравдугаар иржээ. Харин өнөөдөр Итгэлт хээр морио түрvvлж ирнэ гэж итгэж байгаа юм.

- Урамгvй юм. Сүрэнгийнх хагас замаас нийлээд түрvvлж орших юм гэж Эрдэнийн хэлэхэд Итгэлт зэvvхэн инээмсэглэж гол асар руу хялайн харснаа

- Юу гавьдаг юм бэ? луйвардаж л байг. Миний хээрийн өмнө гишгэхийг нь vзье гэлээ.

- Зам хагаслана гэдэг чинь ядахдаа морь тэлж орхино...

- Олигтойхон цогчин дуган бариулж чадахгvй байж луйвардахдаа уургын морь шиг...

Хянамгай бөгөөд ухаантай Итгэлт архины халуунд нандин сэтгэлийн нууц бодлоо дэлгэчих шахжээ. Итгэлт, ноёд, тайж нартай атаархаж явдаг. Ялангуяа тайж нар албанд өнчин ишиг ч өгөхгvй байхад өөрөө өдий төдий юм өгч байгааг бодох бvр сэтгэл нь хорсон, атаархлаар дvүрч «Хошуу тонож хагартлаа идэж, илжиртлээ унтахаас өөр юу ч чадахгvй дамшгууд. Ядахдаа хэдэн хамжлагаа ч зарж чадахгvй арчаагvй мөртлөө хортой, мунхаг мөртлөө шунамгай амьтан» гэж жигшин бухимдаж хэрэв би хошуу толгойлж байсан сан бол эд нар шиг хөдлөх бvрдээ хятадын пvvсэнд нялх хvvхэд шиг мэхлvvлэн өр тавьж албан татвараар мань мэтийнхнийг чирэгдvvлж байхын оронд хошууны тоогоо алдсан гуйлагчныг цуглуулж авчраад уяагийг нь уртхан уяж, угаадсы нь өтгөхөн шиг өгч байгаад цэмбэ нэхvvлэхгvй юв» гэж хvртэл бодож байсан билээ.

Гэвч энэ тухайгаа хэнд ч хэлээгvй. Гэтэл өнөөдөр хундага архи хэтрvvлж ууснаас болж эрvvлдээ бодсоныг согтуудаа гэгчээр Эрдэнэт сэжvvрийг нь цухуйлгажээ. Гэвч согтуу хvн сохор ухаантай байдаг болохоор ам алдсанаа мэдээд:

- Эрдэнэ минь архины яриа хэрэггvй. Харин их насаа түргэн мордуулчих гээд vlэмж согтсоноо мэдэгдэх гэсэн бололтой найгав.

- Таны хэлдэг vнэн юм шvv гээд Эрдэнэ цааш явжээ. Эрдэнийн хойноос нvдээ цавчлан харж байхдаа «таны хэлдэг vнэн юм шvv гэнэ vv. Бас л яггvй дамшиг байна. Ер нь энэ Эрдэнэ амаргvй эр шvv» гэж бодлоо. Ингээд алгуур эргэж хэд алхтал ноён сvргийн морьд асар эргэж байгаа нь нvднээ тусахад гэнэт эргэж: «Эрдэнэ хvвэ Эрдэнэ минь» гэж хашгираад шогшин очив.

-- Өвгөн минь, хэрхэвч түрvvлж болохгvй. Нөгөө ноён чинь таалж орхино. Батад унуулаад сайн захиж өгөөрэй. Цаад Хонгор галзуу бол түрvvлvvлээд хээр мориноос минь салгаж орхино гэж хэлэв.

Эрдэнэ Итгэлтийн хэлснээр түрvvлж болохгvйг Батад захиж өгөөд хээр морь аман хvзvvнд нь иржээ. Харин түрvvлж ирсэн морийг Луу гvн таалж, эзэн нь урт авид хадагтай хоцорчээ. Замаас нь амдуулж тавьсан ноён Сүрэнгийн морьдоос айргийн тавд давхисан морьгvй байв. Yvнийг хараад Итгэлт цаглашгvй баярлаж, «амьтны аль шилдэг морьдыг таалах нэрээр дээрэмдэж аваад, дургvйд хvчгvй гэгчээр хvн албадаж сохор зоосны хөлсгvй уяулсан морьд хомоол хамаас өөр яах билээ дээ» гэж дотроо боджээ.

Тэр орой Итгэлтийн хамт Павловынд очих замдаа Эрдэнэ Итгэлтэд орон нутгаасаа гарсан

үнэн учрыг ярьжээ.

- Тийм байхаа. Би чамайг ягтгүй эр гэж бодоод байсан юм. Эрдэнэ минь манай хошууны бузар хэргийг уудлах юм бол далай л гэсэн үг... гэвч тийм зоригтой аавын хув байхгүй гэж хэлэв.

- Итгэлт гуай минь бяргай хвнийг хаяхад бярг хэрэгтэй. Ноён бол бяргай, бас бэлтэй болохоор, тэдэнтэй заргалдах гэвэл бузар хэргийг нь мэдэхээс гадна, хахууль өгөх бэлтэй байх хэрэгтэй юм шүү. Над шиг унах морьгүй унагаах ямаагүй хүн бол өөрөө л хохирохоос өөр олз олохгүй сална. Харин тан шиг бэл хөрөнгөтэй хүн бол... гэж Эрдэнэ нам дуугаар үгээ аажмаар сунжруулан хэлэхэд Итгэлт таслан «өдөр шөнөгүй шогшиж, өлбөрч үхэхээс бусдыг үзэж баймааж хуримтлуулсан хөрөнгийг нэгийг гаргаад арвыг олохгүй юман зарцуулж бас л болохгүй байна шүү» гэв.

Итгэлт ноёд, тайж нартай атаархаж явдаг боловч тэдэнтэй ил тэмцэхийг огт бодохгүй. Тэмцэл ч хэрэггүй мэт байдаг байлаа. Тэд хэдийгээр эрх ямбатай боловч над шиг чадалтай биш, хэдхэн жилийн өмнө солих мориор ховорхон байсан Итгэлт одоо хошууны тэргүүн баяны нэг болжээ. Түүнээс тайж нар хүртэл мөнгө зоос зээлж, айлчлан очиход нь хөл алдаж, архи айргаа барьж байхыг хараад өөртөө бахархан, чадалдаа бишрэн итгэх сэтгэл овозож явдаг билээ. Энэ учраас сүүлийн вед атаархлын хажуугаар тэдний арчаагүйг доромжлон шоолох сэтгэл төрдөг бөгөөд түүндээ ханаж тэдний дээрээс ширвэн харж явдаг болжээ. Луу гүний хүрээний баруун дэнд дээр Павловын барьсан саруул том гэгээвчтэй хэдэн өрөөтэй заамал дүвзэн байшин Эрдэнийн сэтгэлд их л таалагдав.

- Сайхан байшин байна шүү гэж Эрдэнийн хэлэхэд Итгэлт байшинг анх удаа үзэж байгаа юм шиг ажиглаж харснаа, ийм юм л бариад сууцгааж чадахгүй байгаа юм даа. Мөн ч болоогүй байна даа гэж толгой сэгсрэн хэлэв.

Хашаанд ороход түлээ хагалж байсан алиа Петр угтаж ирээд Эрдэнийн гарыг чанга атгаж:

- Барилдаж байхыг чинь харсан. Чи лав түрүүлэх байх аа гэж хөгжилтэй инээмсэглэн хэлээд Эрдэнийг ажиглан харлаа

- Сайхан бэлэгтэй үг байна хө. Барилдаж байгаа болохоор түрүүлэх хүсэлгүй яаж байх вэ дээ гээд Эрдэнэ тачигнатал инээв.

Ингээд байшинд орж зочлуулав. Гэтэл морьтны хишиг явганд гэгчээр найзындаа ирсэн Итгэлийг бараадан Бадарч, Жамбал хоёр ирэв. Харин Цамба Дулмаатай жаргах гэж Итгэлтийн эрээн майхан руу явжээ. Алиа Петр ч баян хуураа алдлан татаж өргөн банзан шалыг нахилзуулан бүжиглэв. Эрдэнэ ч «эр бор харцага»-аа эрдүүхэн дуулжээ.

Маргааш чинь Эрдэнийг амлаж аваад хүртэж орхино доо гэж уулаас их омог нь орос архинд улам бадарсан Бадарчийн хэлэхэд Эрдэнийн царай уласхийж хор нь даринд гал оруулсан мэт шатсан авч энэ байдлаа нуух гэж худал инээмсэглэж:

- Барилдаад л харъя даа. Ямар шороон дээр ойчихоос шорон дээр ойчих биш гэв.

- Бардам амтын гуя шалдан гэж монгол хүн хэлдэг шүү гэж алиа Петр хэлэхэд ямар утгатай юм ярьж байгааг ойлгож чадаагүй эзэгтэй, Бадарч хоёроос бусад нь инээв.

Муу орос чи ч сачий байвал үзэхгүй юу гэж хэлээд Бадарч босож бардмаар ханхалзав.

Ингээд Петр Бадарч хоёр барилдах болов. Дээр мандсан сар, дотроос олон лаа гэрэлтүүлсэн гэгээвч хоёрын гэрэлд тэд өрж хэсэг зогссоноо орос Бадарчийн мөрөн дээрээс барьж аваад учир дүрсгүй эргүүлэв. Тэгээд тавих гэтэл Бадарч намс хиймэгц тонгорч орхисон чинь барьцгүй байсан Петр харуулдан унав.

- За шалдан байна уу? гээд Бадарч бүдүүн дуугаар тавлан инээв.

Тэр шөнө Эрдэнэ бараг л унтаж чадсангүй. Бадарчийг хаях арга сүвэгчлэн хийдэг мэх бүхнээ бодов. Өглөө наадам руу зэрэгцэн явж байхдаа Итгэлт дуугүй бодол болон яваа Эрдэнэд

«Бадарч өнөөдөр чамайг авна даа Эрдэнэ минь эр хvн байна даа. Хичээж л vз» гэж хэлэв. Эрдэнэ хошуугаа мурилзуулан инээмсэглэхээс өөр хариу өгсөнгvй. Үнэхээр ч тавын даваанд Бадарч Эрдэнийг амлан авчээ. Эрдэнэ өрөөд зогсож байхдаа «Тайшир хан минь» гэж дотроо хэд дахин хэлэв. Эрдэнэ барьцаа гvйцээж аваад тонгорьё гэж шийджээ. Харин Бадарч Эрдэнийн хөдөлсөн шарыг улам буцалгаж байгаад хийсэн мэхэнд нь хариу хийе гэж бодож байв.

Чоно өтлөвч хургандаа, цорж өтлөвч балиндаа гэж Бадарч Эрдэнэд сонсогдохоор хэлээд шороо авч алгаа vрээд ханхалзан өрөх вeд нь Эрдэнэ дайран орж, зодогны нь ар далавчинд гар нь хvрэхийн хамт эргэж тонгортол барьцаа тавьж биеэ сул орхисон боловч Бадарч ард нь vлдэж Эрдэнийн бvслэхээр тэвэрч дээр өргөөд урьдахаас чанга хаяжээ.

Сvрхий барилддаг цагаачин бөхийг зоригтой авч хаясан Бадарчид луу гvнийхэн их л талархав. Харин Итгэлт тvвний хоёр хvvxэд, бас энэ хоёрын барилдахыг харах гэж зориуд ирсэн Петр Эрдэнийн ойчиход нvдээ анин далдирчээ. Эрдэнэ зодгийнхоо хөвчийг тайлаад урамгvй буцаж явахад нь Цамба тосож очоод ёстой тавласан харцаар гөлийн ширтэж байгаад:

- Хvзvv толгой чинь vргэлж vлдсэндээ баярлаж байна уу гэхэд нь
- Юу ч болсон чамдаа л зөв дөө гээд өнгөрөв. Тэр орой Эрдэнэ Петр хоёр Итгэлтийн тогооны майханд нэрмэл архи хуваан ууж нилээд юм ярилаа.
- Намайг энд ирэхэд манайхан, монголчуудын амьдрал нь ч, ухаан санаа нь ч уулын зэрлэг баавгай шиг гэдэг. Гэтэл та нартай танилцаад ирэхэд яг л бидэн шиг л зовох цагтаа зовж, баярлах цагтаа баярласан улс байх юм. Би ч монголд ирээд гурван жил болж болоход их юм мэдлээ гэхэд
- Манай улс сайхан улс шvv. Монгол хvн цагаан санаатай, нөхөрсөг гэвэл
- Монгол хvн ч олон янз. Сайн ч бий, муу ч бий гээд Петр зальтай нvдээр Эрдэнийг харж инээмсэглэв
- Олон хvн сайнтай муутай гэдэг болохоор аргагvй л тийм дээ гэж Эрдэнэ хэлэв
- Эрдэнэ чи бид хоёр сайхан танилцлаа
- Тэглээ шvv
- Чи таван онд орос оронд болсон явдлыг мэдэх vv?
- Морин жил vv?
- Яг тийм
- Баатар цагаан хааны ширээг булааж авах гэж вймээн гаргаад налам дарагдсан юм гэдэг, тэр vv?
- Би тэр хэрэгт оролцоод цөлөгдсөн хvн шvv дээ. Эрдэнэ гайхан Петрийг хэсэг харлаа. Петр инээмсэглэж байснаа «тийм шvv Эрдэнэ минь» гэлээ
- Чи бид хоёр шиг модоо барьсан гуйланчин хаад ноёдтой өрсөлдөөд сайнаа vзэхгvй. Муур барсын зан гаргавал vхэхийн цондон гэсэн vг гээд Эрдэнийн царайд гуниг хорсол хослон өтгөн хар хөмсөг нь заналаар эрчлэв.
- Сайныг vзэж болно шvv
- Бид хоёр шиг л хvн хvний нутаг, гvний газар цагаачилж явахыг сайхан гэх vv?
- Чи бас цөлөгдсөн хvн гэж vv? гээд Петр Эрдэнийг харлаа. Эрдэнэ Засагт хантай заргалдаад орон нутгаасаа хөөгдөх шахаж гарсныг Итгэлтээс өөр хvн яриагvй билээ. Яриад уршиг болохоос олз болохгvй гэж бодож байсан. Гэтэл энэ орост яримаар бодогдов.
- Бараг тийм. Би засагт хантай заргалдаад орон нутгаас хөөгдөж гарсан хvн гэж эхлээд өөрийн амьдралыг ярьж, ингээд нохойтой өшөөтэй хvн хормойгvй, ноёнттой өшөөтэй хvн

хонгогвй гэдэг болсон хэрэг дээ гээд гомдолтой инээмсэглэн яриагаа дуусгажээ.

Эрж явсан хвнтэйгээ уулзсан хвний сэтгэл баяр, сандралаар дүрдэг билээ. Эрэл нь хичнээн удаан, хэцүү байсан бол энэ сэтгэл төдий чинээн их байдаг. Эрдэнийг яриаг сонсоод Петр олон жилийн турш эрж явсан хвнтэйгээ уулзсан юм шиг болов. Тvvний томрон гайхсан хонин бор нүдэнд нь их барын оч гялалзан монголчуудыг өмгөөлөн Павловтой маргаж байхдаа ярьж байсан баатар өөртэй нь учирсан шиг бодогджээ. Гэхдээ Эрдэнэ бол нам унтсан баатар биш, харин гэнэт сэрээд буруу тийшээ ухасхийгээд хад мөргөөд гайхан зогссон баатар гэж бодогдов. Эрдэнийн тэнцэл буруу байсныг Петр бvрэн ойлгож байсан боловч тvvнийг нь зэмлэсэнгvй.

Бид хаант засгийг бvрмөсөн устгана. Тэгэхгvй бол тvvний балгийг арилгаж чадахгvй.

Үндсээр нь тасална. Үvнийг нэг хоёр хvн хийж чадахгvй. Тvм буман хvний хvчийг нэгтгэн зангидаж баймааж хийнэ... гэтэл Дулмаа дуу аялан орж ирээд энэ хоёрын яриаг таслав. Ямар ч удаан ярьдаг улс вэ дээ гэж байдаг гоёлоо өмсөөд, гээгээ гялалзтал самнасан Дулмаа ер бусын хөгжилтэй хэлээд жижигхэн ногоон модон хайрцгаас толь авч нvврнийхээ тал бvрээс тольдон өвөртлөөд гарахад нь Эрдэнэ:

- Дулмаа хаачих нь вэ гэлээ

- Холдохгvй гэж эргэж харалгvй хариулан нам хоолойгоор дуу аялан алга болов.

Эрдэнэ Петрийн яриаг сонсоод баймаар байлаа. Өндөр их хvчтэй орос улсын цагаан хааныг устгана гэх нь дэмий vг мэт санагдав. Чуулган дарга Богд эзэн дээр байдаг Засагт хан тийм хvчтэй байхад дээрээ эзэнгvй баатар цагаан хааны хvч хэмжээгvй байх ёстой. Гэтэл энэ оросын ярианд ямар нэгэн их итгэл байх шиг санагдав.

- За тэгээд чи яаж баатар цагаан хааныг дийлэх хvн бэ дээ?

- Би ганцаараа дийлэхгvй. Харин бид бvгдээрээ нэгдвэл дийлнэ

- Баатар цагаан хаан гэдэг чинь хэдэн бум цэрэгтэй асар их хөрөнгөтэй хvн шvv дээ. Гэтэл та нарт юу байгаа юм бэ?

- Бидэнд юм бvхэн бий. Тэр олон буман цэрэг чинь бидний өрөөсөн дугуй, бас тэр их хөрөнгийг чинь баатар цагаан хаан хийгээгvй, бид хийж тэр дээрэмдсэн юм. Ингэхлээр хэрэг дээрээ бидний хvч илvv гэхэд нь Эрдэнэ тоомжиргvй инээмсэглэж

- Тэр чинь өрөөсөн дугуй чинь чамайг барьж аваад Ангарын хот руу цөлсөн биз дээ гэсэнд Петр босож Эрдэнийн өмнө нь очиж явган суугаад, толгойгоо урагш сунган

- Тиймээ, барьсан. Гэвч маргааш надтай нийлээд цагаан хааныг барьж авна гэхэд Эрдэнийн нүдэнд нь цагаан сэтгэлийн хошигнол тодорч Петрийг ширтэж байснаа

- Тэмээ туйлаад тэнгэрт хvрэхгvй, ямаа туйлаад янгиа эвдэхгvй гэдэг vгийг чи сонссон уу? гэв

- Чи хятадад манжийн төр унасныг сонссон биз дээ

- Сонссон

- Манжийн хаан олон буман цэрэгтэй ч байсан. Арвин их хөрөнгөтэй ч байсан шvv дээ. тийм vv?

Эрдэнэ хэсэг дуугvй бодол болон суув. Петр мэхээр гаансандаа тамхи нэрж аваад татах зуур Эрдэнийг ажиглав. Эрдэнэ зууж байсан гаансыг амнаас нь авч хэд сороод буцааж аманд нь хийгээд цааш татсан утаагаа алгуур vлээх зуур

-- За тэгээд та нар баатар цагаан хааныг дийлчихээд дараа нь яах улс вэ? гэж асуув. Петр босож байрандаа суугаад хул айраг хийж шимэн ууж гарынхаа алгаар шар сахлаа арчсанаа «тэр бол өөр зvйл» гээд эхлэх гэтэл нөгөө майхнаас «Петя» гэж дуудах Павловын аргил дуу тод сонсогдов. Петр ухасхийн босоод «хоёулаа дараа тавтай ярина» гээд гарлаа. Эрдэнэ

нүдээ, цавчлан хэсэг сууснаа «Павловыг дуудахад сандран, огло үсэрч байж баатар цагаан хааныг ширээнээс нь халиулна гэнэ шvv. Аавын хvvгийн санаа арвин гэж, яахав дээ хөөрхий» гээд ганцаараа инээмсэглэв.

Наадмын дараа Эрдэнэ суурь тоолж эхлэв. Нэг өдөр Доржийн эх Буян чавганцынд ирлээ. Буян чавганцад ганц хvvгээс өөр тулах мод тоолох ямаа үгvй билээ. Хvv нь байхдаа айлан ажил хийж амь зууж байжээ. Гэтэл цэрэгт явсан учир амьдрахын эрхээр Итгэлтээс хоёр зуун хонь авч өдөр шөнөгvй майжигнан дагаж хөлсөнд авсан юмаар цаддагvй боловч хоосон хонохгvй амьдарч байв. Өнгөрсөн хавар сураггvй болсон хvvгийнхээ тухай ламаас асуусан чинь өдий төдий гvрэм буулгасан учир тvvнийг уншуулах гэж Итгэлтийн хониноос нэг эм хонь барьцаанд өгчээ.

Эрдэнэ мал тоолж вээд тэр хонийг үгvйлж асуухад чавганц бултаж вээд болохгvй болохоор нь идчихсэн гэж хэлэв. Мал тоололт дуусгаад өнгө зvс, нас им тамгыг нарийн ялгасан данс хийж Итгэлтэд өгөхдөө Буян чавганц нэг эм хонь идчихээд анхандаа бултаж вээд дараа нь внэнээ хэлснийг сонин болгож яриад «намар хөлснөөсөө нөхөж тавина гэсэн» гээд үгээ дуусгав. Тосыг усаар, толийг шилээр гэгч болж байгаа нь тэр дээ гэж Итгэлт тайван хэлээд дансыг авч том шар вааданд боож авдартаа хийжээ. Эрдэнийг тэр орой Итгэлт сайхан үг олж ядан магтаж орос газрын сайн архиар дайлжээ. Маргааш нь Галсанг явуулж Буян чавганцаас хонио авч өөр айлд өгсөн. Хэдэн хонь хариулж хөлсөөр нь амь зууж байсан чавганц уг малыг үлдээх өгөхийг уйлан, мөлхөн гуйсан боловч тус болсонгvй. Ядарсан чавганцыг ямар зовлонд унагааснаа Эрдэнэ мэдээгvй билээ. Гэтэл нэг өдөр хошуу хvрээний гудамжаар явж байтал хар сав вvрээд айлын вvдэн дээр юм гуйж байсан Буян чавганцтай тааралдав. Чавганц Эрдэнийг танимагц, таягаараа занаж «муу цагаач чи ядарсан чавганцын мууг вээж ханав уу? Чамайг над шиг л эх төрvүлсэн байх даа. За яахав. Итгэлтийн угаадсыг идээд үргэлж цатгалан явахыг чинь би эс боловч, миний хvv харах байх» гэж хараав.

Эрдэнэ «авгай минь, авгай минь» гэхээс өөр юу ч хэлж чадахгvй ангалзаж байхад чавганц хэлэх үгээ хэлж аваад майжигнан явжээ. Эрдэнэ санамсаргvй юу хийснээ ойлгож чавганцыг внэн сэтгэлээсээ өрөвдсөн учир Итгэлтээс Буян чавганцад малаа эргvүлж өгөхийг гуйхад:

- Эрдэнэ минь, хэрэггvй нинжин сэтгэлээ орхи. Чи бодооч дээ. Буян чавганцад би гэм хийгээгvй. Харин өөрөө өөрийгөө толгой руу ус хийсэн хvн. Тvvнд дахиж мал өгч би л чадахгvй гэж хатуу хэлжээ.

Намар Эрдэнэ Петртэй хамт Итгэлт Павловын худалдаж авсан вхрийг цуглуулж сvрэглэн туулгах ажилд явах гэж бэлтгэж байтал гэрт нь Өлзий ирж уулзахад газар дээрх ганц дvүгээ амьд мэнд явааг сонсож тэсгэлгvй баярлав.

- Та Төмөртэй уулзвал намайг амьд мэнд явна гэж хэлээрэй. Бас надтай уулзах гэж энд ирсний хэрэггvй. Луу гvний нохой нь хvртэл Төмөрийг занаж хуцдаг бололтой гэж Эрдэнийн хэлэхэд Өлзий

- Би мэдээд, чам балаг болохгvйг хичээж чиний сургийг битvv гаргах гэсээр олох хоног тэнэж орхилоо гээд инээмсэглэв.

### XIII

Төмөр Тvгжилийг дагуулан хvрээ орж Эрдэнээг сураглаад олсонгvй. Харин Сайд вангийн нутаг, Луу гvний нутгийн зах билчээрт Засаг ханы Эрдэнэ гэдэг хvн ирж суурьшсан тухай олон хvн дамжин там тус сураг гаргажээ. Ингэж явтал туйлдаж ядарсан Хуягтай дайралдаж нэг морио өгч, хөл залгуулаад, явахад нь эцэг Өлзйдөө ахын минь тодорхой сураг гаргаж өгөхийг захиарай гэж хэлээд зам шуударч Тvгжилийг дагуулан хос морь хөлөглөн зvүн өмнө зvг барьж довтлов. Гурав хоног хэлэн дээрээ юу ч тавилгvй, зөвхөн нэг удаа морьдоо

услахдаа ус уугаад явсанд Түгжилийн гол харанхуйлан, морины хатиралтад гэдэс дотор нь тасрах мэт болж байв. Харин Төмөр дөрөөн дээрээ босож зогсоод «Эрдэнэ засгийн унага»-аа шуранхайлан дуулж явахад Түгжилийн уур хүрч, бачимдавч яах ч аргагүй байлаа. Гуравдахь өдрийн орой жижигхэн задгай булаг дээр очиж морьдоо услав.

Төмөр захаараа мөстсөн жижигхэн горхины хоёр талд гишгэж, бөхийн ус залгихад хоёр шанааны нь булчин байн байн зангирч, төвөнхий нь нэг том болж, нэг агшиж байв. Тэгээд өндийж нүүрээ угаагаад дээлийнхээ хормойгоор арчив. Түгжил горхины захад элэглэн хэвтээд чанга чанга сороход харьсан ус эрүүгийн нь дагаж урсан дээлийн энгэр нэвтэлж байв. Одоо ч хүрэх газартаа ойртож байна даа гэж Төмөр хэлээд морьдоо сайн услах гэж исгэрэв. Хичнээн өртөө үлдээд байна гэж усны эрэг дээр хэвтэж байсан Түгжил найрын эхнээс аваад хундага алгасаагүй уусан хүн найр төгсөхийн вед бусдыг хардаг нүдээр Төмөрийг харж асуув.

- Хоёрхон хоногийн явдал үлдээд байв

- Төмөр гуай би тэсэхгүй нь, гэдэс тасарч байх шиг байна. Амарч юм идье гээд хацраа нойтон шаварт нааж нүдээ анив.

- Х.. хэ цис чамайг чинь овоо эр гэж бодсон юмсан огт хэрэггүй амьтан юмаа гээд Төмөр үгний хариу ч үгүй хэвтэж байгаа Түгжилийг баахан ажиглаж байснаа морьдоо чөдөрлөн тавиад богцоо авчирч давслан чанасан мах гаргаж

- За ид. Ямар найрлах гэж яваа биш гэж хэлэв.

Түгжил мөлхөж ирээд дал авч том үмхэн залгиад зогисов. Төмөр борцноосоо хатсан гүзээ гаргаж дэвтээх гэж усанд хийлээ. Мах үмхлэн зогисож байгаа Түгжилийн дэргэд ирээд:

- Арван тавны цагдаа ирлээ гэсэн чинь Түгжил цочин өндийж харвал юу ч байсангүй

- Хаа?

- Зогисоогий чинь зогсох гэж хуурсан юм гээд Төмөр бүдүүн дуугаар хөгжилтэй инээв.

Төмөр дунд чөмөг авч яралзсан цагаан шүдээрээ шир, шир хийтэл тасчин идээд ясы нь «Тайшир хан минь» гээд баруун зүг шидэж орхив. Дараа нь дөрвөн өндөр, сүүж хоёрыг дараалан идэж ясыг нь урьдах ёсоор «Шилийн богд минь» гэж зүүн урд зүг шидээд хүйтэн ус баахан ууж, хайрга хөрсөн дээр эмээлээ дэрлэж унтав. Түгжил ч гэдэс гарч ухаангүй унтав. Шөнө дундын вед Төмөр Түгжилийг сэрээв. Харвал морьдоо барилж ирээд эмээллэчихсэн байв. Нөгөө дэвтээсэн гүзээндээ ус хийгээд Түгжилд ганзгалуулав.

- Үүгээр юу хийх юм бэ?

- Говь огтолж гарахдаа булаад эргэж ирэхдээ ууна гээд мордоход Түгжил дуртай дургүй мордлоо. Тэр бүх бие нь няцран өвдөж «Юунд энэ золигтой нийлэв дээ» гэж бодон дотроо бухимдана. Ингэж хэнхэг туссан юм шиг давхиж байхын оронд зоволгүй олз олж болох л байсан шүү дээ. Хар тэнэг толгой энэ мангарын гарт үрэгдэх нь бололтой гэж бодож явлаа. Дээш харвал үүл бүрхсэн тэнгэр дарж, урагш харвал битүү харанхуй манаран, шөнийн хүйтэн салхи нэвт үлээн дутуу нойртой Түгжилийн эрүү толгой нь өөрийн эрхгүй зодолдон, үмхийгээр хэхэрч чухам аль зүг явж байгааг үл мэднэ. Төмөр урьдах хэвээр дөрөөн дээрээ босож үл мэдэг урагшаа бөхийгөөд «Эрдэнэ засгийн унага»-аа үгийг нь хэлэлгүй аялан давхина. Хоёр дахь өдрийн өглөө жижигхэн гүвээний орой дээр гарч мориноос буув.

Энд амарч, орой хүргэнэ. Бидний туулж ирсэн тэр говийг хар говь гэдэг юм. тэр харагдаж байгаа уулыг Зотол гэдэг гэж Төмөрийн ярьж байхад Түгжилд сонсох чадал байсангүй.

Төмөр морьдоо чөдөрлөж тавиад унтахаар хэвтэхэд нь эмээлээ түшиж суугаад хөдлөх бүрд нь ажиж байсан Түгжил «Төмөр гуай, мах идье» гэв. Битгий дэмий ярь. Битүүлэх гэж ирсэн биш, буцах зам гэж бий. Адуу хөөхдөө үлдсэнийг нь орхидог юм шүү гээд өөр яриагүй гэсэн

бололтой унтав. Түгжил богцтой махнаас хулгайлж аваад идье гэхэд Төмөрөөс айгаад чадсангвй болохоор аргагвй хэвтэв. Гэвч унтаж чадсангвй зүүрмэглэгчээ болоход элдэв янзын юм зүүдлэн хар дарна. Оройн нар шингэхийн вед Төмөр сэрээд бослоо. Зотол хааны орой дорно талдаа бараантай өрнө талдаа алтан шар дуулгаа гялалзуулан хар говийн дунд велсэн зэрэглээ далайн давалгаат дүрслэн тоглож байв. Түгжил бэрд болж төрөөд өмнөө тавьсан таваг махнаас ганц огтлом ч идэж чадахгвй ядран зүүдэлж байтал Төмөр угз татан сэрээжээ. Үдшийн бүрэнхий болоход мордоод цааш хэсэг явснаа: «тасдаж хөөгөөд, явдал дундаа морьдоо солино. Би барьж өгөхөд чи морин дээрээсээ хазаарлаж аваад зайдан унана. Эмээлтэй морьдоо дөрөөгий нь зөрүүлж тавиад хамт тууна. Манаатай адуу болохоор хойноос хөөнө шүү. Сандарч огт болохгвй» гэж Төмөр хэлжээ.

Түгжил толгой дохихоос өөр хариу хэлсэнгвй. Хэлэх чадал ч түвнд байсангвй. Төмөр богцноосоо эвхмэл уургаа гаргаж бариад урагш гэлдрэн явахад хойноос нь Түгжил дагасаар таран идэж байгаа олон адуун дунд орж ирэв. Явсаар нөгөө захад нь гараад буцаж эргэхэд Төмөрийг зогсоход Түгжил дэргэд нь очив.

За энд сайхан морьдтой хоёр азарга адуу байна. Дотор нь шавхарсан морьд ч байна. Зэрэгцээд яв гэж шивэгнэн хэлээд хөдлөв. Ингээд тавь гаруй адуу таслан хөөв. Төмөр исгэрэн адууг хайр найргвй шилбүүрдэн явахад Түгжил ч бүдүүн тэнзэн ташуураа зогсоо жолоогвй даллан хөөж байв. Адуу хөөх баярт автагдан өлсөл, ядрал нь түр мартагдаж Түгжилд ч ертөнц дээр үүнээс илүү сайхан юм байхгвй мэт бодогдож байв. Хөөгдсөн адууны чимээ бараг тасарч байхад сэхээ орж юу болсныг ойлгосон дөрвөн адуучин хойноос нь нэхэж эхлэв. Гэвч морио сольж амжсан Төмөр Түгжил хоёр улам ширүүн хөөж явтал морьд бүдрэхэд Түгжил зайдан мориноосоо салж тонгорцоглон унав.

Адуу хөөж явсан Төмөр мэдсэнгвйд Түгжил босож «Төмөр гуай аваарай» гэж хар тэнхээгээрээ хашгиран гвйв. Энэ вед адуучны хашгиралдах дуу улам ойртов. Төмөр морины амыг эргүүлж, Түгжилийн дэргэд очоод явуут сундалдууж адууны хойноос ирж морий нь барьж унуулав. Ингэсээр байтал нэхэгчид бүр ойрхон боллоо.

-- Одоо болохоо байлаа шүү. Чи ингээд алтан гадас чиглэн явж бай. Би гээд адуунаас хэсгийг таслан үлдэв. Юуны ч учрыг олоогвй Түгжил үлдсэн адууг хөөсөөр юу руу, хаашаа явж байгаагаа үл мэдэн давхив. Төмөр хэсэг адуугаа хойноос нь алгуурхан хөөж явтал «Энэ явж байна, гвйцлээ. Бариад аваарай» гэж хашгирсаар адуучид ирлээ. Төмөр хөөж явсан хэсэг адуугаа орхиж өөр зүг зугтав. Нэг нь адуун дээрээ үлдэж, гурав нь хөөсөн боловч Төмөрийн бараа тасарч алдав. Адуу хөөсөн хулгайчийг барьж чадагвй боловч хөөлгөсөн адуугаа бүрэн авлаа гэж баярласан адуучид эргэв. Өглөө нар мандахын вед Төмөр Түгжилийг гвйцэж ирлээ. Согоо шиг хорь гаруй морьдтой гуч шахам адуу ажээ. Үүнийг хараад ганц хоёр чөдрийн морь, идэшний шараас хэтэрч яваагвй Түгжил ядралаа мартаж сэтгэл нь олзны баяраар бялхав.

Адуу хөөн үргэлж холхин өргөн говийг огтлох тийм амар хэрэг биш. Аажмаар Түгжилийн баяр үгвй болж өлсөх, цангах, ядрахын туйлд хүрч, зогсож амрах тухай Төмөрт хэлсэнд «балаг болж адууны хагасыг орхиулчихаад бас амрах санаатай, ямар дүүрчихсэн эр вэ?» гэж хөмсгөө зангидан уурлажээ. Түгжилд дахиад хэлэх зүрх байсангвй. Үхсэн амьдаа бараг л өөрөө мэдэхээ больж унасан мориндоо бүрэн захирагдан заримдаа адууны дунд орон туугдаж явжээ. Нар шингэхийн вед Төмөр адуугаа зогсоов.

- Бууж булсан усаа ол гэж Төмөрийн хэлэхэд Түгжил арай чарай мориноосоо бууж, гүзээтэй усаа эржээ. Түгжилийн нүдэнд өргөн говьд цангаж үхэх аюул тодрон бүх бие нь сулран, цог нь буурсан харцаар Төмөр өөд гөлрөн.



- Өнгөрсөн бололтой. Газар маань биш шиг байна. Яадаг билээ? гэтэл Төмөр өргөн говийг цочоосон бүдүүн баргил дуугаар паржигнуулан инээж

- Миний эмээлийн дор бий гэж авч тавьсан эмээлээ заажээ.

Энэ хоёр амарч мах идэж ус ууж аваад шөнө дундын вед хөдөлж явсаар өглөө нэгэн худаг дээр очиж адуугаа услаад цааш хөдлөв. Эр охин нийлсэн долоон адуу замдаа хаяж довтолсоор гурав хоног яваад дөрөв дэх өдрөө алгуур аянд орж заримдаа замын айлд орж айраг тараг эргүүлэн явжээ. Түгжил хвч тэнхээ орж, Төмөрөөс нууж гурван морь худалдаад өртгийг нь аминдаа завшив. Анхандаа Төмөр мэдвэл яана гэж айн хэлэх вг бодож явсан боловч Төмөр юу ч хэлсэнгүйд лав мэдсэнгүй гэж баярлав. Гэтэл нэг орой Төмөр айлд айраг уухаар явахдаа адууны түрүүнд яваа морийг зааж:

- Чи тэр хээр морийг битгий үгвй хийчээрэй. Тэр гурваар чинь битгий хэл, тийм арваар солихгүй морь шүү гээд давхижээ.

Дараа өдөр нь Төмөр өнчин хоёр хүүхдээ хөтлөөд гуйлга гуйж явсан нэг хүнд сувай гүү барьж өгөөд сэтэрхий тэвнэ ч авсангүй. «Хайран гүү, ингэж сохор зоосгүй үрнэ таран хийх гэж би яваагүй юмсан. Халхын гуйлгачинг тэжээж барах юм уу?» гэж Түгжил бодоод бухимдан уур нь хүрсэн боловч Төмөрт хэлж яахин чадах билээ. Ингэж явсаар нэг мэдэхэд Сайд вангийн нутагт орж ирээд Өлзийгийн дэргэд очив. Гэтэл Эрдэнийн сураг гаргахаар явсан Өлзий буцаж ирээгүй байжээ.

Хуяг Цэнд хоёр Төмөрийг ирсэнд хязгааргүйгээр баярлан саяхан алсан сарлагийн бор махаар дайлав. Бас Пүрэв тажийн тухай ярьж бөөн инээдэм болцгоов. Оройн нар нь унь өөд гарахын вед Төмөр, Түгжил хоёр явах болжээ. Эр эм хоёр хонож өнжөөд явахыг гуйсанд Төмөр морин цагаан шүдээ яралзуулан инээмсэглэж:

- Гэрт орох, гэгээнд мөргөхийг цээрлэсэн хүмүүс шүү дээ. Харин Өлзий гуайг ирэхэд удахгүй уулзана гэж хэлээрэй гээд гарч Өлзийд өгөөрэй гэж бас нэг тарган гүүгээ орхиод «битгий зов гэж хэлээрэй. Халхын нөгөө захаас авсан юм шүү» гэжээ.

Төмөр Түгжил хоёр явсаар нэг ууланд бууж адуугаа хаданд хашаад унтахаар хэвтэв.

- Энэ адуугаа яах вэ?

- Тарган баатар вангийн ядуучуудад тарааж өгөөд эргэнэ

- Үнэ өртөггүй юу?

- Тэднээс ямар балдуугий нь авдаг юм

Төмөрийн энэ үгэнд Түгжилийн гол харлан өдий газар биеэ зовоож явж олсон энэ сайхан амьтдыг сэмэрхий самбайн ашиггүй өгнө гэж үү. Яаж болдог юм бэ? гэж харамсан, эсвэл энэ адууг тууж Төмөрөөс зугтах, эсхүл ямар нэгэн аргаар барьж Луу гүний тамганд тушааж шагнал аваад бас адууг завших бодол төржээ. Гэвч энэ бодлоо яаж биелүүлэхээ арга олохгүй түмэн бодолд дарагдан байтал ядарсан бие нь дийлж нам унтжээ.

Нэг сэрвэл үүр хаяарч, чийг үнэртсэн хүйтэн салхи баруун хойноос үлээж байв. Төмөрийг харвал дөрвөн мөчөө тэлээд тайван унтаж байхад нь сэм босож бүдүүн тэнзэн ташуураа аваад байдаг чанга цохисонд Төмөр өндийн ирэхэд хутгаа сугалан нэг бүлээд эргэж зугтан мордож адууг хөөжээ. Хэсэг яваад гэнэт Луу гүний тамганаас шагнал авах тухай бодогдон эргэж харвал Төмөр зогсоод найгаж байлаа. «Яаж ч магад. Амьд дээрээ салъя» гээд Түгжил улам хурдлав.

Төмөр сүвээгээ хоёр гараараа даран тогтож ядан байх зуур «хэдэн адсагаас болж хүн алах нь байна шүү» гэж шивэгнээд нүд нь эрээлжлэн түс хийтэл газар унаад ухаан алдав.

XIV

Итгэлт Павлов хоёрын худалдаж авсан үхрийг цуглуулан тамга тэмдэг тавьж суурилан

хуваарилаад хөлсний хүнээр Түнхэн рүү туулгах ажлаа Эрдэнэ Петр хоёр дуусах болж байлаа. Энэ ажлын дундуур улам дотно танилцаж сэтгэл зүрхнийхээ үгийг ярилцдаг болжээ. Эрдэнэтэй ярихдаа Петр үлэмж дуртай. Учир нь Эрдэнэ бол хэлсэн үгийн зөвшөөрч байгаа нь ч мэдэгдэхгүй. Эс зөвшөөрсөн ч мэдэгдэхгүй дүнсийн суудаг хүн биш. Хэлсэн үг бүхэнд хариу тавьж, өөрийн бодлыг угтуулан хувийн жижиг зүйл Эрдэнийн зүрхний аль нэгэн утсыг хөндөж аялгуу гаргадаг тул Петрт Эрдэнэтэй ярьж байх зөвхөн зугаацал цаг өнгөрүүлэлт төдий биш байжээ.

Эрдэнэ, Петрийн ярианаас ертөнц дахины олон явдлыг мэдэж авч байсан бол Петр Эрдэнээс монгол орны түүх, зан заншил монгол хүний бодож, хүсэж явдаг зүйлийг ойлгож авдаг байжээ. Бие биеэ баяжуулсан яриа дуусдаггүй болохоор энэ хоёр зав л гарвал ярьдаг болов. Эрдэнэ ярилцах танилцах тутам Петр бол зөвхөн «алиа Петр» биш шархдаж хэд хоног хаданд хэвтээд эдгэрэн нисэх гэж байгаа бүргэд шиг хүн бөгөөд үлэмж ухаан, тод эрмэлзэлтэй эр гэдгийг ойлгож байсан бол Петр энэ уранхай дээлтэй, туранхай царайтай монгол бол харанхуй амьдралын верт урсавч тохиолдсон бүхнээсээ барьж авч чадахаар барахгүй нэгэн цагт хүчтэй сэлэлтээр сөрж чадах чадалтай бөгөөд Тамирын гол шиг тунгалаг ухаантай боловч тэжээмэл бяруу шиг итгэмтгүй хүн байна гэж ойлгож байлаа.

Эрдэнэ Итгэлтийг магтан ярихад Петр «Итгэл чамд сайн, өглөгчдөө биш, чамаас цус, хөлс, сэтгэлийг чинь хямдхан үнээр авч байгаа болохоор одоохондоо сайн байна» гэдэг бөгөөд үүнийг нь Эрдэнэ зөвшөөрдөггүй, эцэстээ уул яриа нь баян, хоосны харьцааг устгах төрийн том асуудал хүрч булаалдан маргадаг байв. Эрдэнэ «манай монгол улс» гэж ярих дуртай. Гэтэл Петр «танай орон бол улс биш. манжийн дээрэмчдээс салаад, оросын дээрэмдэлд орж байгаа орон. Оросын цагаан хаан танайхыг ганцаараа дээрэмдэж байх гэж тоглоомын улс байгуулсан хэрэг» гээд үүнээ нотлох гэж Павловын үхэр худалдан авч байгаа, оросын өдий төдий худалдаачин ямар ч гааль түрээсгүй сэлгүүцэж түүхий эдийг хямд үнээр худалдан авч байгааг нэгэн төрлийн дээрэм гэж хэлдэг байв. Эрдэнэ үүнийг зөвшөөрдөггүй. Оросын цагаан хаан туслаагүй бол монгол улс манжаас салж чадахгүй хэмээн боддог. Оросын худалдаачид монголоос түүхий эд авч байгаа байгаа бол ердийн наймаа гэж үздэг билээ. Та нарт тусалсан цагаан хаан чинь хэрэгтэй болбол дуртай цагтаа та нарыг худалдаад, хэн нэгэнтэй нь хувааж иднэ дээ гэж Петр үргэлж хэлдэг байлаа.

Бид оросын хаант засгийг устгаад, эрх чөлөөт засаг тогтсон цагт та нарт тусалж, танай улсыг сайхан орон болгоно гэж Петрийн хэлэхэд «уухай чи бас биднийг тонох нь уу» гэж Эрдэнэ хошигнон хариулав. «Тийм биш, харин бид дураараа орж ирэхгүй, та нар гуйгаарай» гэж Петр захив.

Би гуйгаад, чи тусалж, монголд диваажин байгуулна. Харганын унгас түүж эсгий хийх шиг хэрэг байна даа гээд Эрдэнэ хөгжилтэй инээв. Петр шашин огт хэрэггүй гээд Богдыг муу хэлэхэд нь «танай орост мэдэхгүй, харин манай монголд шашин богд хоёр шиг хэрэгтэй юм байхгүй» гэж Эрдэнэ хариулдаг. Зарим хүмүүс маргалдахдаа уурлаж хэрэлддэг. Зарим нь урд урдаа орох гэж өрсөлдөн хорон үг хаялцах буюу хашгиралддаг билээ. Гэтэл энэ хоёр тийш биш байлаа. Харилцан нэг нэгнийхээ баталгааг тэвчээртэй сонсож, маргах бүр бие биедээ итгэлцэж, нөхөрлөлийн холбоо нь улам бүр бат болж байлаа. Намар гоёлоо өмсөж, ургамлын өнгө нь шар ногоон туяатай болчихоод, өглөө үдэш өндөр уулын оройд хөхөмдөг манан тунаран, тарга хүч авсан мал налайн билчиж, өнтэй газрын сайханд өнгө жавхаа бүрдсэн шувууд дэгдэхэйнүүдээ дагуулан ганганалдаж байгаа Тамирын голын хөндий нь саяхан суусан нөхрөө дагаад наадамд явах гэж үс гэзгээ самнасан залуу бүсгүйтэй адил байлаа. Нэгэн орой Тамирын голын эрэг дээр морьдоо тавин амарч суугаад Эрдэнэ засагт хан

Гомбожавын бузар явдлын тухай ярив.

- Засагт хан Гомбожав хошууг түмэн зовлонд унагааж байгаа юм. Үлэмж харгис, шунахай, бас тэгээд тэнэг. Бvх бузар хэргийг нь уудалж заргалдвал дийлэх байх гэж бодсон юмсан. За яахав эр хvн аль алдаж явахыг нь тэр гэх вэ? гэж яриагаа дуусгахад Петр нvдээрээ зальтай инээмсэглэснээ «тэгээд яагаад дийлдсэн юм бэ» гэж асуув.

- Гомбожав хошуу дээрэмдэж чаддагаараа хахууль өгч байгаад дийлж, би гуйланчнаараа хахууль өгч чадаагvй дийлдсэн юм.

- Эрдэнэ минь, чи чинь ямар хvvxэд шиг юм ярьдаг хvн бэ? зарга шийдэж байгаа төр нь Гомбожавын юм шvв дээ. Ноёдын төр байсан цагт чи Гомбожавыг дийлэхгvй

- Би заргынхаа бичигт нэг ч худал юм бичээгvй хvн дээ

- Тэр ямар хамаатай юм бэ? ганц нэг хvн заргын бичиг барьж гvйгээд ноёдыг дийлэхгvй

- Чиний бодлоор яавал дийлэх вэ?

- Ноёдын төр өмхөрсөн боловч бvдvүн мод юм шvв.

Энэ учраас олон хvн нийлж байгаад хөрөөдөх хэрэгтэй. Бvр vндсээр нь хөрөөдөж унагаах юм шvв гээд Петр Эрдэнийг ширтэв.

- Уухай. Олноор нийлж байгаад хөрөөднө гэнээ.. надтай хэн нийлэх юм бэ? Шоронд ороход минь эхнэрээс минь өөр хэн зовсон билээ. Эзэн ноёнттойгоо заргалдсан хvн аргагvй л гэж байсан байх. Луу гvний хошуунд бол надтай нийлэх нохой ч байхгvй. Бадарчин ойчиход минь бvх наадамчид баярлаж хашгиралдаж байхыг чи харсан шvв дээ.

- Буруу замаар будаа тээвэл буцахдаа шороо тээнэ гэж танай монголын vг байдаг. Чи тэмцлээ буруу эхэлснээс одоо цөхрөн ир чинь мохсон байна. Амьдралыг нэг удаа тонгороод дийлж хэн ч чадахгvй. Буруу тонгорвол өөрөө шалчийтал дарагдаж орхино.

Эрдэнэ амьдралыг зvсээд гарна гэж бодож байсан удаа бий. тэгээд ч Засагт хантай заргалдаж билээ. Гэтэл зөв хэрэгтэй буруутан, давхар давхар зовлонд нэрвэгдээд vнэхээр цөхөрч байлаа. Заяагдсан амьдралаас хэтэрч, бяруу болоогvй байж бухыг хэрэлтээр хэрснээс болж хагартал мөргvлэх шахав гэж боддог болсон. Эрдэнийн тэмцэх ир нь мохоод Итгэлтийн хишгийг тvшиж амьдрахаас цааш юм харахгvй болжээ. Гэтэл Петр vннийг нь тольдон харсан юм шиг хэлэв. Эрдэнэ бургасны мөчир тасалж аваад холтсыг хумсаараа холцлон нvцгэлж суухад нvдэнд нь гvн бодол тодрон байлаа.

Олонтой хvмvvc олны хvчийг эвлvүлэн тэмцэнэ гэдэг хэцvв юм шvв. Тэвчээр, зориг, гарз хэрэгтэй. Энэ бол хvчир ажил. Гэхдээ сайхан vйл юм гээд Петр баян хуураа авч дуулав.

Дараа нь хуураа өвөр дээрээ тавиад дээр нь эрvвгээ тулан юм бодож байснаа «эрдэнэ, намайг очиход хvв минь таних болов уу?» гэж асуув. Эрдэнэ бургасаа шидээд, Петрийг зөөлөн нvдээр ажиглан харснаа «танина. Эхлээд жаахан бишvүрхэж байснаа тавиад бvр салахаа болино» гэлээ.

Эрдэнийн энэ vгэнд Петрийн нvд сэргэж сэтгэл нь хөнгөрч хөгжмөө алдлан татаж богино огцом аятай аялгуу дарлаа. Тэр орой Эрдэнэ, Петр хоёр айл дээр сvүлийн суурийн vхрээ тамгалаад дуусаж байтал Итгэлт Павлов хоёр нилээд согтуу давхиж ирлээ. Тэр хоёр vлэмж хөгжилтэй бөгөөд олон vгтэй болжээ.

Павлов vхэр тамгалаад дуусаж байсан Петрийн дэргэд очиж мөр рvв нь алагдсанаа нvдээ анилзуулан оросоор баахан юм яриад vгнийхээ төгсгөлд баруун гараараа салаавч хийн хараав.

- Баатар цагаан хаан, Герман хvн хоёр дайтаж эхэлсэн гэнэ. Ширvүн зодоон болж байгаа юм байх аа гэж Итгэлт сонин болгон Эрдэнэд хэлжээ.

- Тийм. Их дайн болж байхав даа. Манай орос гvрний баатар цэрэг германы нутаг руу

довтлон эцэг цагаан хаан үнэн ёстой шашнаа мандуулан сүр хүчнээ бадруулж байхав гэж Павлов монголоор хэлэв.

- Баатар цагаан хааныг хэн дийлэх вэ? хэн ч дийлэхгүй. Тэр герман хаан гэгч дамшиг од нь харваж орхисон хэрэг. Оросын их цэрэг гишгэж орхино гэж Итгэлт хэлээ ээдрүүлэн хэлэв. Павлов дайн гарсныг Тариатаас ирсэн оросоос мэдээд юуны өмнө үхрийн үнэ хадаж өөрөө их олз олно гэж бодсон билээ. Энэ ч учир Итгэлтэд дайн гарсан тухай яриад «одоо бид хоёр цөлхөөв гэдгийг...» гээд хоёр гарын алгаа дээш нь харуулан атгаснаа «ингэнэ» гээд тэр хэвээр нь дээлийнхээ хоёр ташааны уутанд хийжээ.

Олзонд баярлахгүй хэн байх вэ? зүрхтэй л дөрийг нь олж байгаад гулгуулаад байдаг хэрэг ээ. Өвгөн минь гэж Итгэлт маг маг инээн хэлжээ. Орос японы дайны вед шар тос, үхрийн үнэ талийж өгснийг Итгэлт мэдэх тул энэ дайны чимээ сонсмогц үлэмж олзны хурц үнэр хамар руу нь хан хийсэн юм. Тэгээд хоёр найз архи ууж хоёр зуу гаруй үхэр нэмж авах болоод Эрдэнэ Петр дээр иржээ. Харин Петр дайн гарсан тухай сонсмогц царай барайж хөмсгөө үе үе зангидан үг нь цөөхөн болжээ. Тэгээд орой морьдоо аргамжиж явахдаа «Эрдэнэ минь, энэ дайн олон амьтанд их зовлон тарина шүү. Олон орны баячууд олз олох гэж энэ дайныг гаргасан хэрэг. Гэвч сая сая хүний хагацал гашуудлын нулимс хорслын гал болоод түүнд дайны эзэд өөрсдөө шатаж магад юм» гэжээ. Маргааш өглөө нь Итгэлт Эрдэнэтэй уяаны дэргэд зэрэгцэн сууж байгаад «дайны хажуугаар дажин гэж юу ч болж магад. Юу ч гэсэн Бат Хонгор хоёроо лам болгоё» гэхэд нь Эрдэнэ зөвшөөрөв.

Хэдэн өдрийн дараа нэмж авсан зуу гаруй амбан шарыг тууварлах ажлаа дуусч Эрдэнэ, Петр хоёр гэрийн зүг жолоогоо эргүүлэв. Петр энэ хооронд үг л дуугарвал дайны тухай ярьж, баатар цагаан ханыг элдвээр зүхэж, түүний төр мөхөх тухай ярьдаг байлаа. Бас Павловын байрлаж, Итгэлтийн дагаж баясаж байгааг жигшин ярьж «дайн гарахын эзэн бол Павлов, Итгэлт мэтийн хүний цус хөлснөөс алтан зоос нэрж сурсан хүмүүс юм» гэжээ.

Эрдэнэ Итгэлтийн өмгөөлөн «орос герман хоёр дайтахад Итгэлт ямар хамаатай юм бэ? чи хэтрүүлж байна. Оросын хаан, германы хаан хоёр муудаад л дайт гэж цэрэгтээ тушаагаа биз» гэж хэлэв.

-- Эд шууд холбогдолгүй нь үнэн. Гэхдээ Эрдэнэ минь Германы баячууд бол сүүлд гарч ирсэн үлэмж ховдог баян. Тэгээд бусад орны баячуудынхаа юмыг булааж авах гэхэд нь цаадуул нь өгөхгүй гэхээр барахгүй, залуу ховдгийг номхотгож хөрөнгийг нь булааж авах гээд дайн гарсан гэдэг. Павлов дайн гарсанд баярлаж байхыг нь чи харсан биз дээ гээд дайны учир явдлыг тайлбарлажээ. Хоёр том гүрэн дайтсан хойно олон хүн үхэж үрэгдэнэ гэдгийг Эрдэнэ сайн ойлгож байлаа. Гэвч энэ дайнд баячууд гэмтэй гэдгийг огт зөвшөөрсөнгүй. Тэр хоёр Эрдэнийнд ирж хоноод маргааш нь Петр, Павловын суурин руу явахдаа:

- Өвгөн минь, би нутагтаа буцна гэлээ

- Чи цөллөгийн хүн болохоор болдог юм уу? гэж Эрдэнэ гайхан асуув

- Болохгүй. Гэвч оргоно. Харин надад бэл хэрэгтэй байна. Чи тусалж чадах уу?

- Өвгөн чинь хөрөнгө хогшилгүй гуйлгачин. Гэхдээ чадах чинээгээрээ тусална.

- Надад морь хэрэгтэй. Чи олж өгвөл би гялайлаа гэсэн үг гэхэд нь морь байтугай нохой ч үгүй байсан Эрдэнийн сэтгэл хөдөлж

- Олж өгөхийг бодъё хэзээ хэрэгтэй вэ? гэж асуув

- Түргэн л бол сайн. Харин тухай хэнд ч хэлж болохгүй шүү гээд Петр нөхрөө тэврэн сэтгэл нь хөдөлж, баяр бахдал дүүрсэн нүдээр хараад морджээ.

Шогшоор холдож байгаа Петрийг үдэн зогсож байхдаа яаж баймааж морь олж өгөх тухай бодол Эрдэнийн сэтгэлийг эзэмджээ. Бодовч бодын шийр дөрвөөс хэтрэхгүй гэгчээр

Итгэлтээс гуйхаас өөр арга олдсонгүй. Гэтэл авсан гэрийнхээ үнийг төлж чадаагүй байлаа.

- Энэ Петр юу болчихсон юм бол? ингэж дуу шуугуй уруу царайлж явдаггүй эр сэн. Гэр оронд нь зовлон учраа юм болов уу? гэж Эрдэнийн дэргэд ирсэн Нямаа асуув.

- Нутагт нь их дайн гарсан гэнэ

- Орост уу даа?

- Тийм гэнэ

- Хөөрхий тийм байхаа. Өчигдөр орой манайд ороод миний онгорхой харыг үзээд хичнээн үнэтэй юм бэ? хир зэрэг хол тусдаг юм бэ? гэж асуугаад байсан юм. Аваад л дайтах гэж бодож байж л дээ. Уг нь тавьсан суманд эгэл цэргийг бол ч алчихна. Баатар жанжныг бол яаж даах вэ? Петртэй дайралдвал намайг цахиур бугаа ав гэсэн гэж хэлээрэй. Үнийг нь яахав. Дараа дайныхаа олзноос өгнө биз. Би Петрийг луйвардахгүй хүн гэж боддог юм гэлээ Тэр орой Эрдэнэ Итгэлтэй хамт айраг ууж суугаад үгний дашрамд нэг сайн морь аминдаа өгөхийг гуйсанд Итгэлт гайхан харснаа «сайн мориор яах нь вэ.. хол юманд явах нь уу» гэж асуув.

- Тун хэрэгтэй болоод байна. Та өгч л үз

- Энэ жилдээ хэдэн адуунаас минь дуртайгаа унаж бай. Ирэх жил чамд унаа болох бага насны юм өгнө. Харин энэ жил чамд идэш өгнө гээд энэ талаар өөр яриагүй гэсэн бололтой гэрээс гарчээ.

Урамгүй, газар ширтсээр Эрдэнэ гарч гэрийн зүг явахад ямар аргаар морь олж, Петрт хөл залгах тухай бодол сэтгэлийг эзэмдэж бодсон бүхэн нь мухардан арчаагүйдээ бухимдан байжээ. Гэртээ ороод ч морины тухай бодолд дарагдан байхад нь «бие чинь зүгээр үү?» гэж Долгор дахин дахин асуухад «би зүгээр» гэхээс өөр хариу өгсөнгүй. Маргааш нь дэмий л бухимдан сэтгэлийн хар зовлон эдэлж байтал адуунаас тасарсан хоёр морийг эрэх ажилд оногдоод хагас өдөр явж баймааж олоод буцах замдаа хонь хариулж явсан Дулмаатай дайралдаж бугаад тамхи татаж суутал өндөр сайвар хар морьтой Бадарч ирлээ.

Хүвхэн хүний дэргэд тэгэхдээ гоо үзэсгэлэнтэй залуу хүвхний дэргэд сайрхан бардаж баярлах дуртай хүн бишгүй байдаг бөгөөд түүний нэг бол Бадарч байжээ. Тамхи татаж суухдаа морь худалдаж авсан, сайн бөх хаяснаа ярьж байснаа ирэх жилийн наадамд Эрдэнийг гурвын даваанд авч, асрын хэцэн дээр тэгнэж хаяна гэж ам гарахад Эрдэнийн шар нь хөөрч:

- За тэгвэл барилдъя гэжээ.

- Цагаачин хүн ходоод бүтэн байвал дээр биш үү. Ахтайгаа дэмий тоглож болдоггүй юм шүү гэж Бадарч нүдээ анин бүдүүн дуугаар инээв.

- Хоёул мөрийтэй барилдъя. Чи ойчвол надад унаж яваа морио өг гэж Эрдэнийн хэлэхэд Бадарч Дулмаа руу харж нүдээ ирмээд «ээ чи ойчвол» гэж доромжлон асуув.

Эрдэнэ өгчихье гэх юм олдсонгүй болохоор дэмий л түгдрэн ийш тийш харж алгаа барин байлаа.

- Нэрлэх юмгүй гуйлгачин байж, мөрий ярих дуртай өгөх бэлтэй, авах чадалтай хүү мөрий ярьдаг юм шүү гэж Бадарч хэлтэл Дулмаа үгийг нь тасалж:

- Эрдэнэ гуай ойчвол би энэ бөгжөө өгнө гээд түргэн зуур бөгжөө мултлан авч алган дээрээ тавиад Бадарчийн өмнө барив.

Энэ бөгжийг Дулмаад Итгэлт авч өгсөн билээ. Хоёр цэнгийн шаргалтсан шижир алтан бөгжийг хараад Бадарчийн нүдэнд шуналын гал оргилов.

- Үнэн юм биз дээ. Эрчүүдийн тоглоом ширүүн байдаг юм шүү.

- Тийм ээ. Эрдэнэ гуай ойчвол энэ бөгжөө би өгнө. Харин чи ойчвол морио өгнө шүү.

- Бөгжтэй байтугай, бөгжгвй унагааж сурсан юм хонгор минь. Тэр чулуун дээр нуруугаар тавина гээд Бадарч ойролцоо байгаа ургаа хүрэн чулууг заав.

Эрдэнэ Бадарч хоёр өрөн зогсов. Эрдэнэ эвийг нь олж, хийг тааруулж байгаад гвйх бодолтой байсан болохоор зугтаж байлаа. Бадарч барьж авмагц сээрэн дунгуй хийх гэж хэсэг хөөцөлдөв. Бадарч барилдах хүнээ санаа сэтгэлийг нь талаар унагаах буюу хорыг нь хусаж харалган болгодог аргатай билээ. Түмэн газар цагаачин чи зугтаад гвйцэгдэхгвй гэж бодож байна уу? гэвч ахынхаа гараас мултрахгвй гэлээ. Эрдэнэ хариу дуугарсангвй. Нүд нь гөлрөн ухарч байлаа. Тэгээд гвйх гэж ухасхийгээд Бадарч мөрөн дээрээс нь барьж аваад сээрэн дунгуй хийлээ. Эрдэнэ хориглон мултарч барьцаа тавиулав. Бадарч шороо авч алгаа арчих зуур:

- Баян Итгэлтийн цагаа зохиж овоо тэнхээ орж шvv. Гэсэн ч тэр чулуутай нуруугаа нийлvvлэхээс зайлж чадахгвй гээд мөрөө хөдөлгөн өрөв.

Эрдэнэ гвйхээ больж барьцаа хангаж аваад бусгах бодолтой байжээ. Гэтэл хvсэлдээ хүрсэнгвй сэrvvvн барилцав. Бадарч хий мурих гэснээ баруун хөлийг нь суйлж авлаа. Эрдэнэ дагуулж тонгорох гээд барьцыг нь улам лавшруулав. Дулмаа шилбvvрээ чанга атгаж, хөлөө авахуулсан Эрдэнийг тvшиж авах гэж байгаа юм шиг зvvн мөрөөрөө хий тvlхэж байв.

Эрдэнэ хэдий хvчлэвч Бадарч нэгдvгээрт барьцаа хангаж авсан, хоёрдугаарт хvчээр илvv учраас өргөж газраас салган авлаа. Тэгээд хаясангвй. Харин заасан чулуу руугаа явлаа. Хүн алах нь болиоч дээ гэж Дулмаа хашгирав. Бадарч дvлий юм шиг шууд чулуунд ойртож очоод Эрдэнийг ар зоогоор нь тавих гэтэл Эрдэнэ зvvн хөлөө газар хүрмэгц баруун гараар Бадарчийн суга өөд ольж баруун хөлөөр зvvн өвдөг рvv нь тийрээд тонгороход магнай нь ирмэгтэй чулуунд хагалагдаж ухаа ягаан цус гарлаа. Нуруугаараа газар унасан Бадарч «хи э» гэж битvv дуугарахад нь Дулмаа наадамд очоод ирж яваа эхээ харсан хvvхэд шиг дэвхцэн тас тас инээж шилбvvрийн бөгсөөр газар балбаж байснаа гvйн ирж Эрдэнийн магнайгаас гарч байгаа цусыг арчин толгойгоо алчуураар боов.

- Ам алдвал барьж болдоггвй, агт алдвал барьж болдог юм даа гээд Эрдэнэ шууд очиж Бадарчийн эмээлийг аваад ногоон дээр тавив.

- Эрчvvдийн тоглоом ширvvн байдаг болохоор яахав дээ гээд Дулмаа хөгжилтэй инээв. Бадарчийн царай минчийж хүрэн улаан болсноо хvчлэн инээмсэглэв.

Унаснаа мэдмэгц мөрийн улайх гэж бодсон боловч Дулмаагийн vгийг сонсоод нэрэлхvv сэтгэл нь давж ёстой л буруу харж уйлан, зөв харж инээн байжээ. Дулмаагийн хонины хээрийг гуйж эмээллэн унаад явахдаа Эрдэнийг зайдуу газар дагуулж очоод «за яахав чиний аз ирж дээ. Харин энэ явдлыг амьтанд хэлсний хэрэггвй» гэхэд нь Петрт морьтой болсондоо баярласан Эрдэнэ:

- Тvvнд битгий зов. Хэн ч мэдэхгвй гэлээ

- Эрдэнэ буцаж Дулмаа дээр ирээд «зуу наслаарай» гэхэд Дулмаа «хорь насалсандаа гомдож явахад зуу насал гэнэ шvv» гэж хөгжилтэй хэлэв.

- За тэгвэл хэд л хүрэх дуртай бол төдий наслаарай Дулмаа минь. Намайг морь хожсон гэж хэнд ч хэлж болохгвй шvv.

- Хэлж болдоггвй юм бол зарлаж явах хэрэг надад алга гээд ажиггвй эмээлээ авч vvрээд энэ хооронд холдож амжсан хониныхоо хойноос дуу аялан алхав.

## XV

Өлзий Төмөрийн захисныг биелvvлж, ахтай нь биеэр уулзсандаа цаглашгвй баярлан нутгийн зvг эргэв. Гэхдээ яарсангвй. Яарах ч хэрэггвй байлаа. Энэ учраас тогоо нэрсэн айл хэсvvчлэн

аяга тагш юм эргүүлж явсаар орой нар жаргахын вед гэртээ ирвэл хvv бэр хоёр нь эзгvй байв. Гэртээ орвол шинэ махны нялуувтар vнэр гэр дvvрэн ханхлав. Тулганы нь хойно тэвштэй чанасан мах домбо дундуур цай байв. Бас Төмөрийг ирнэ гэж арзтай хадгалсан цагаан бөгст нь хоосон байжээ. Хоёр аяга бвлээн цай залгилаад, тэвштэй манаас огтлон идэж байхдаа ямар хvн ирж эд нар минь ингэж хөл болсон юм бол гэж бодож байв. Төмөрт хадгалсан цагаан бөгстийг минь тvvнээс өөр хvнд өгөх ёсгvй юм сан. Төмөр ирсэн юм болов уу гэж бодогдоод гэрээс гарвал баруун хажуу руу Хуяг, Цэнд хоёр буугаад ирж явлаа.

- Аав аа Төмөр гуай ирээд явчихлаа гэж Хуягийн хэлэхэд Өлзийн нvvрнээс баяр гомдол хоёр зэрэгцэн бутарч нvд нь том болсноо

- Хаашаа явсан бэ?

- Тэр баруун тийшээ гээд Цэнд санаа алдав

- Ганцаараа юу?

- Үгvй хоёул. Бас хэдэн сайхан адуу туугаад явж байна. Танд тэр гvvг өгсөн гэж Хуяг хариулав.

Чухам хэдийд явсан бэ?

- Нар унингд байхад

- Ам мөлтөс зөржээ. Би ахтай нь уулзаад ирсэн юмсан. Үгvй, аав нь гvйцэж хэлье гээд шууд мориндоо мордон баруун тийш эхлээд хатируулснаа удалгvй цогиулав.

Амьдралынхаа ихэнхийг ан агнаж, мөр хөөсөн Өлзий хорь гаруй адуу туусан хоёр морьтой хvний мөрийг мушгин явтал Үдшийн бvрэнхий болж харагдахгvй болоход нь хээр хоноод өглөө цааш явлаа. Маргааш нь Цэнд Хуяг хоёр өдөр шөнө ээлжлэн ирдэг адил малчин хvний тогтмол ажлаа хийж дуусаад хэвтсэн нь нам унтжээ. Хоточ нохой нь хуцахад сэрээд чих тавин чагнавал гэрийн нь баруун талаас морьтой хvн гэлдрэн ирэх чимээ бvдэг бадаг сонсогдов. Нохой хуцахаа больчих чинь, аав ирэв vv дээ гэж Хуяг хэлээд тvргэн босож хувцаслаад тосон дэнгээ асааж гарвал морь хөтөлсөн хvн харанхуйн дундаас тодрон тодорч шууд гэр рvv ирлээ.

- Аав уу даа?

- Тийм ээ. би байна

- Та гvйцэв vv?

- Гvйцэхээр барах уу даа гээд Өлзий гэрийн vvdэнд ирж зогсоод, аль вэ хvvхэд минь хамжилцаарай гэв.

Эмээл дээр хөндлөн тэгнэж ирсэн ухаангvй Төмөрийг эцэг хvv хоёр дамжлан гэрт оруулж, орон дээр хэвтүүлэв. Төмөрийн хvдэр царай vнсэн цайвар болоод, тvргэн тvргэн амьсгаадаж байгааг хараад Цэнд нулимс булгийн ундрал мэт ундрэн урсав. Хvvхэд минь гал тvлж vз. Хvнд байна шvv гэж Өлзийн хэлэхэд Цэнд хариу дуугаралгvй гал тvлэв. Маргааш нь Өлзий оточ залахаар явж Хуяг Цэнд хоёр эцгийнхээ зааснаар зээргэнэ буцалгасан бвлээн усаар ухаангvй дэмийрэн хэвтэж байгаа Төмөрийн шархыг угаав.

Өлзийгөөс усан хайнагийн залуу шар барьцанд авсан оточ ирж Төмөрийг vзээд баахан тун эм өгсөн бөгөөд бас гvрэм буулган барьц авчээ. Гvрэмч отчийг хvргэж өгөхөөр Хуягийн явсан хойно Өлзий Цэнд хоёр дэмийрэн хэвтэж байгаа Төмөрийн дэргэдээс салалгvй сууж эмийг нь шавдан өгч байв. Төмөрийн элий балай хагас дутуу vгэнд газар дээрх ганц ахын нь нэр байн байн гарч байсан ба бас Өлзийн нэрийг хоёр ч удаа дурсав. Хуяг буцах замдаа багш ламындаа орж Хайнагийн гуна амлаж Төмөрийн амийг даатгав. Хуягийг явснаас хойш оточ ламыг явахад архины найз Пvрэв тайж ирээд гуулин домбонд ганзай халааж шимэн уух зуур Төмөр гэдэг хvн Өлзийнд ирээд ухаангvй хэвтэж байгааг сонсож баярлах айх хоёр зэрэгцэв.

- Тэр хvн яасан ч тэсэхгvй. Эрлэгийнд очих морь нь эмээлтэй хvн байна билээ гэж эмчийн хэлэхэд Пvрэвийн сэтгэл хязгааргvй баяр оволзон бадарсан боловч хажуугаар нь айн эргэлзжээ.

- За даа. Тэр чинь эрлэгийн данснаас хасагдсан хvн байх шvv. Луу гvний Бадарч тахарын шир дийлж чадаагvй юм гээд Пvрэв тайж, цахиур Төмөрийн тухай дуулж сонссоноо отчид ярилаа.

- Баатар хvн нэг суманд, баян хvн нэг зуданд гэдэг юм даа. Сvвээний шарх нь идээлж, vлэмж цус алдсан хvн байна билээ. Тийм хvн яалаа ч гэсэн амьдарч чадахгvй гэж отчийн итгэлтэй хэлсэн vг Пvрэвийг зоригжуулав.

Отчийн vг халуун ганзай хоёрт зориг орсон тайж мордож, шууд Өлзийн гэр рvv чиглэв. Гэхдээ Төмөрийг барьж авъя гэж санасангvй. Нэгэнт vхэх болсон Төмөр тvvнд хэрэггvй байжээ. Харин Өлзийг сvрдvүлэн байгаад өчvvхэн хөрөнгий нь салгая гэж бодсон ажээ. Yхсэн буурын толгойноос амьд ат айна гэгчээр Өлзийн гадна очоод нөгөө гал шиг зориг нь эгшин зуур арчсан юм шиг алга болоход гэрт нь ч оролгvй буцаж явтал зээргэнэ тvvгээд ирж явсан Өлзийтэй дайралдав. Өлзий гэрий нь зvгээс ирж явсан тайжийг хараад «энэ золиг бvх учрыг мэдээд, Төмөрөөс хариугаа авах гэж явна» гэж бодоод тайжийг царайчлан амрыг нь эржээ.

- Муу боол чи шилийн хулгайчийг орогнуулж байна гэнээ. Наян жингийн төмөр гинж хvзvvнд чинь хийж яс арьс хоёр болгоно доо гэж хэлэхэд Өлзий мориноос буун сөхөрч

- Тайж гуай минь биднийг өршөө. Өчvvхэн боол эрхэм дээдэс танд юугаа ч хайрлахгvй гэв

- Тэгээд тэр хулгайчийн бие ямар байна гэж Пvрэв асуугаад эргэж Өлзийн гэрийн зvг харлаа.

- Ухаангvй байгаа. Дөнгөж л амьтай байна гэж Өлзий алга хавсран хэлжээ.

- За танайд очьё гэж тайж хэлээд тэр хоёр явжээ. Өлзий гэрийн гадна ирээд ичих зовох хоёрыг аль эрт мартсан тайж

- Боол чи нохой аминдаа хайртай юм бол юу өгөхдөө надад хэл гэхэд нь Өлзий хайнагийн vнээ нэг, сарлагийн vнээ хоёрыг өгье гэхэд нь тайж уурлаж илvv юм шаарджээ.

- Лан, таван цэнгийн алтан бөгж барья гэж Өлзийн хэлэхэд Тайжийн нvд гялалзан

- За бушуу ороод авч ир. Би орохгvй гэхэд нь Өлзий гэртээ орлоо.

Тайж сэмхэн гэтэж тотгыг нь сөхөж харвал баруун талын орон дээр ямар шvлтгvй болсон цонхир царайтай Төмөр хөдлөлгvй өмнө нь Цэнд хvүхэн сууж байв. Тайж сэтгэл уужирч гэрийн vүдийг чанга татан нээж оров. Тэр нэгэн өдөр айхтар доромжлогдсон хорсол нь оволзон Төмөр рvv алхах гэтэл Цэнд Төмөрийн том хутгыг өмнөө хөндлөн барив. Хvүхний нvд эгээ л хэрсэн бухын нvд шиг болон биеэ хураан оронд наав.

- За тэр бөгжөө өг. Бусад малаа маргааш аваачиж өгөөрэй гэж тайж хэлэв. Өлзий эцэг өвгөөс дамжин хадгалсан алтан бөгжөө барихад тайж хvүхнээс нvд салгахгvй байж байгаад гарлаа. Тайж мордоод давхих чимээг чагнан байсан Хуяг

- Гvйцэж очоод хvрэн жалганд учрыг нь олчихьё гэхэд нь

- Болохгvй хvv минь гэж Өлзий хориглов

- Аав аа өнөө шөнөдөө бvх юмаа хаяж майхнаа аваад хангайн нурууны модонд нvвч. Одоо тайжийн гараас гарахгvй гэж Цэнд хэлэв.

Эцэг хvv бэр гурав хэрхэх тухай нилээд ярилцаад тэр шөнө Өлзий нэг мориндоо майхан тогоо шанага, хvнс, нөгөө мориндоо Төмөрийг ачаад уул руу явжээ. Гvн ойд очоод долоо хоносны өглөө Төмөр нvдээ нээж Өлзийг ажиглан харснаа юм хэлэх гэсэн бололтой омголтсон уруулаа хөдөлгөсөн боловч дуу гарсангvй дахин анив.

Yд өнгөрөхийн вед дахин нvдээ нээж эргэн тойрныг удтал ажиглан байснаа уруулаа алгуур



нээж:

- Хэдэн адуунаас болж хvн алах нь байна шvv гээд гашуудалтайгаар инээмсэглэх мэт болоод, толгойгоо өндийх гэснээ шvд нь хяхтнан буцаж хэвтлээ.

- Битгий хөдөл хvv минь гэж Өлзий хэлэхэд нvдэнд нь нулимс нvvрэнд нь баяр тодров. Төмөр хөдлөлгvй хэвтэж байхдаа болсон явдлуудыг сэтгэлдээ сэргээн бодож эхлэв.

-- Би танайд яаж ирэв?

-- Таныг олж ирсэн.

Маргаашаас нь эхлэн Төмөрийн бие өдөр ирэх тутам сайжирч, Өлзийд юу болсноо ярихад өлзий Эрдэнэтэй уулзсан, тvvний захиж хэлсэн vгнээс эхлээд Пvрэв тайж ирсэн хvртэл бvгдийг ярьжээ. Харин өргөл барьц, хээл хахууль байдаг өчvvхэн хөрөнгөө барьж орхисон тухай нэг ч vг дуугарсангvй.

- Хvv минь одоо ингэж явдгаа боливол дээр гэж Өлзий хэлэхэд Төмөр инээмсэглэснээ

- Ах минь цаст уулын цагаан арслан цөхөөд бэлд бууж, төмөр шоргоолжинд бариулж vхсэн гэдэг. Би бол тэгж чадахгvй гэлээ.

Өлзий хариу дуугарсангvй. Гэвч энэ мундаг эр юуны төлөө ингэж vхэл зовлонгийн хавх руу өөрөө явж байдгийн учрыг олох гэж бодовч хариу олдсонгvй.

Гэтэл энэ бодлыг нь ойлгосон юм шиг «шувуунд нисэж яваад vхэх сайхан гэдэг, надад ингэж яваад vхэх сайхан. Хэдэн аймгийн цаана гараад, сvргээр адуу хөөж явахын амтыг та мэдэхгvй болохоор юу гэж хэлэх вэ дээ» гээд Төмөр vгээ таслав. Морины сайныг шилж унаж, «эрдэнэ засгийн унага»-аа дуулан талын жаврыг сөрөөд давхиж чадахгvй байгаадаа харамссан бололтой огцом эргэж майхны хаяа руу харан хэвтлээ.

## XVI

Намрын шар нар дуусаж зэvvн салхи vлээн уулсын оройгоор хааяа цас vзэгдэж шөнөд нь урсгал ус хvртэл зайрмагтаж Булган уулын дээгvвр усны шувууд харийн халуун орны зvг гангар гунгар дуугарах нисэж байлаа. Хөдөөгийн айлууд өвөлжөөгөө бараадан, хот суурин газрын айлууд гэрээ дулаалж эхлэв. Ийм намрын нэг өдөр Заяын хvрээний баруун өмнөх Маанит толгойн оройн дээр хөвөнтэй цэнхэр дурдан дээлтэй бvсгvй сууж толгойн хойт шилээр гарсан замаар явагдсыг ажиглана. Энэ бол нөгөө Цэцэг ажээ. Цэцэг энэ жил арван найман настай бөгөөд арван жилийн өмнө улаан бурхнаар эцэг, эхээс салан өнчирчээ. Тэр вед Чимэгийн эх дайралдаж «охиндоо хань болгоно» гэж vрчлэн тэжээв. Залуу наснаасаа эхлэн Заяын хvрээний дэргэд амьдарч байсан тэр авгай өнгөрсөн жил гэнэт галзуурч нас баржээ. Орж гарсан лам хятад голдуу хvний бэлэг шангаар элбэг дэлбэг амьдарч байсан тэр авгай залуудаа гаргасан охин Чимэг, тэжээвэр охин Цэцэг хоёроо өөрийн замд оруулж, амжсанаар барахгvй хашаа байшин, мөөртэй шалтай таван ханатай тохилог гэр зэрэг овоо хөрөнгө vлдээжээ. Цэцэг энэ амьдралаа жигшин, тvvндээ гутаж, дотор нь vргэлж харанхуй хар мананд умбаж байдаг. Гэхдээ өөрөөр яаж амьдрах вэ? гэдэг асуудалд өгөх хариу байдаггvй ажээ. Хариугvй учраас урьд насандаа хийсэн лайгаас болж заяагvй төрөөд, ингэж яваа юм гэж бодоод ирэх төрөлдөө сайн нөхөртэй, сайхан vртэй болох гэж жилд хоёр удаа Заяын хvрээг сунаж мөргөл вйлдэн өдөр бvр эргэд байжээ. Хорин нас хvрч байгаа Чимэг бол энэ амьдралдаа хvсэл ханамжтай бөгөөд эмэгтэй хvнд сайн амьдрах өөр за энэ хорвоод байхгvй гэж бат итгэж явдаг. Эр л хvн бол миний сайханд унана гэж боддог бөгөөд бусад хvvхнvvд нөхрөө хардаж байгаа, эрчvvд хэд хэдээрээ ирээд харгалдаж, бие биеэсээ баян,

чадалтай болж үзэгдэхийг хичээж байгааг хараад сайхан царай, гуа биеийн минь чадал гэж бахархан явдаг ажээ. Энэ сэтгэлээсээ болоод эр хvн бэлэг өгөхөд надад эс өгвөл хэнд өгөх билээ дээ гэж боддог болохоор хvний бэлгийг үргэлж чамлаж байдаг ажээ.

- Үвгээр ч яах юм билээ дээ гэдэг вгийг алтан бөгжний хариуд ч хэлж байсан. Амбан тарган шарын махны хариуд ч хэлдэг юм.

Үнэхээр ч Чимэгт дутагдах юм байсангvй. Дээл хийж өмсөе гэвэл Буяндалай юмуу, өндөрт хэлээд авна. Тарган мах идье гэвэл нөгөө нэгд нь хэлээд авч чадах байлаа. Цэцэг уулнаас бууж гунигтай алхсаар Бааюугийн зах руу ороод гэлдрэн явж байтал Буяндалай гэдэг пvвсний данжаадтай дайралдав.

- Цэцэг чи сайн уу?

- Сайн. Буяндалай гуай та сайн уу?

- Эгч чинь гэртээ бий юу?

- Байгаа байхаа

- Чи манайхаар орохгvй юу?

- Би яарч явна

- Танайхаар маргааш лав очно би. Ойрдоо их ажилтай гээд Буяндалай толгойгоо сэгсрэн хар тамхинд хөгцөрч харласан шvдээ ярзайлган худал инээв.

Цэцэгийг гэртээ орж ирэхэд Чимэг одтой хvрэн торгоор дээл оёж байлаа. Цэцэг толгойн алчуураа ор руу шидээд аяга хvйтэн цай шунаг залгилаад «хvйтэн боллоо. Шалны шороогоо хатааж гэрээ дулаалах юм сан» гэлээ. Чимэг оёж байгаа дээлээ орхиж гэдрэг нь тавиад ярвайн суниаснаа «нөгөө Жамбал л хvн олж ирнэ гэж бэлхэн ам хэлсэн шvв дээ» гээд жижигхэн манан соруултай гаанс авч тамхи татлаа. Цэцэг орны толгойд байсан шударга хөгжмийг авч «Сvнжидмаа» гэдэг дууг хоёр бадаг тоглосноо намуун зөөлөн бөгөөд гунигтай дуугаар:

Үйтэн хуарын хээ чинь элэгддэг юм даа хө хө хө

Үнэнч нөхөр гэдэг хэрэг болно Сvнжидмаа минь хө хө хө

Үүдэн хоёр шvдийг чинь унаад ирэхийн вед хө хө хө

Ай л Сvнжидмаа минь дээ хө хө хө

Үүд хаалгаа нээгээд суусан чиг

Үзэж харах хvнгvй болно доо хө хө хө

Хамбаны хээ чинь элэгддэг юм да хө хө хө

Ханилсан нөхөр гэдэг хэрэг болно Сvнжидмаа минь хө хө хө

Хар сайхан всийг чинь цайгаад ирэхийн вед хө хө хө

Ай л Сvнжидмаа минь даа хө хө хө

Хаалга vүдээ нээгээд суусан чиг

Харж vзэх хvнгvй болно доо хө хө хө

Гэж уянгалуулан сэтгэлийнхээ гvнээс аялгууг гарган дуулснаа дахин хоёр бадгийг хөгжимдөөд шударгаа тэврэн хэсэг гөлрөн суув.

Цэцэг минь юундаа ингэж гиюврч байдаг юм бэ? бид дутагдсан юмгvй сайхан л амьдарч байна гэж Чимэг уцаарлав. Цэцэг хариу дуугарсангvй гөлрөн байхад нvдэнд нь нулимс тунаран байснаа хэд хэдэн дусал болон тасарч хацрыг нь даган урсав.

-- Орж ирсэн хvн бvхэнд дэвсэж өгдөг хуучин журам дуулж чаддаг бол яг л надтай адилхан дуулах байх даа гээд урсан гарч ирсэн нулимсаа арчих зуур Цэцэг гvн санаа алдав.

Өвчтэй юм ярих юм гэж Чимэг тоомжиргvй ширвэлээ. Энэ хоёрын хооронд иймэрхvв яриа олон удаа болдог. Гэвч энэ ярианаас болоод тэдний амьдрал өөр болдоггvй. Чимэг Цэцэгийн

ийм яриаг гэнэн дэмийн яриа гээд тоодоггүй бол Цэцэг өөрийн нандин зүрхний бодлыг Чимэгт хэлснээс тарваганы нүхэнд хашгиран дүнгэнэж магад гэж бодоод дуугүй болдог. Чи түлээ оруулаад ирээч гэж Чимэгийн хэлэхэд Цэцэг хөгжмөө байранд нь тавиад гарлаа. Тэжээмэл гөлөг нь сүүлээ шарван гүйж ирлээ. Түүнийг тэврэн авч хошуугий нь хацартаа наан нүдээ анин хэсэг зогсоод тэнгэр рүү харахад түмэн өнгө шижир алтаар туяарсан нарны гэрэлд нүд нь цавчлав. Гөлгөө эвтэйхэн тавиад түлээ тэврэн гэрт орлоо. Хоёр хүүхнийг ингэж байхад хашааны үүдэнд дээр цэнхэр торгон дээл өргөн шар бүс ороож том мөнгөн хэрэглэлтэй хутга зүүсэн Түгжил ирлээ. Өндөр цээжтэй, шингэн сүүлтэй ханхар хээр морь унажээ. Энэ бол Төмөрийн «битгий худалдаж орхиорой» гэж байсан морь ажээ. Цахиур Төмөрийг эзгүй ууланд цохиж орхиод зураг шиг сайхан морьдоо Далайчойнхор вангийн хошуунд үнэ тулгаж худалдаж үлэмж ашиг олжээ. Морио уяад гэрийн зүг явахад гөлөг эрхлэн ирлээ. Түгжил өшиглөсөнд гөлөг яншин гасалж сүүлээ хавчин байшингийн доогуур оржээ.

- Сайн байцгаана уу?

- Сайн. Ямар сонин хүн бэ? Манай хаалгыг мартаагүй олсон чинь овоо доо гэж Чимэг хэгжүүн эхлэв.

- Утах хэрэггүй. Өвгөн чинь алс хол яваад ажил толгойтой үснээс илүү байна гэх зуур хоймрын хивсэн дээр суув.

Хоёр хүүхэнтэй дэмий балай шалиг юм ярьж марзаганах зуур арван мөнгөн янчаан гаргаж гүнгэрваатай богд ламын нь өмнөх ширээн дээр давхарлуулан тавиад ихэмсэг нүдээр Чимэг рүү харлаа.

- Арван муу янчаан тавьчихаад арван бөгтөр өмбүү тавьсан юм шиг ханхалзаж байх шив дээ. Нохой долоож үх гээд Чимэг ширвэлээ.

- Чимэгийн хэл яг л өргөстэй харгана гэсэн үг гээд Түгжил шал хуурамч инээв.

Түгжил гарч гудамжны үзүүрт байсан Буянтын пүүзнээс лонх уужаан авчрав. Ингээд хоол болж тэр гурав ширээ тойрон суутал гаднаас Бадарч ирлээ. Бадарч жилийн өмнө Цэцэгтэй танилцсанаас хойш сав л хийвэл энд ирж хонодог болжээ. Түгжилийг бол сайн таньдгаар барахгүй түүнээс учир мэдэж морь мал авдаг ажээ. Бүгдтэй мэндлээд ширээний хажууд хэзээ ёзооны энэ гэрийн эзэн шиг завилан суув.

- Бадарч чи идэшний шар хэзээ авчирч өгөх гэж байна гэж аягатай хоол өмнө нь тавих зуур Чимэг асуув

- Удахгүй. Амбан шар хашаанд чинь уяатай байх бий гээд Бадарч бүдүүн дуугаар маг маг инээв.

- Харж л байж больё. Эр хүнд итгэснээс эрхий хуруундаа итгэ гэж үг байдаг гээд Чимэг Бадарчид савх авч өглөө.

Ингээд тэр дөрөв хөгжилдөн найрлахад Цэцэг хүртэл хольж уусан халуун архинд мансуураад жигшин гуньж явдаг амьдралаа умартан Бадарчийн мөрөнд толгойгоо наан «Үзмээр нэрсэн архийг чинь хө үнэртэж байгаад л согтуурч байна хө» гэж нам хоолойгоор аялан дуулж байв.

- Түгжил ээ унаж яваа хээр морийг чинь авья

- Үнийг нь дийлбэл ав л даа

- Муу гуйлгачин минь, ганц адсага авчих баян байна. Амандаа орсон үнээ хэл л дээ гээд Бадарч цээжээ ханхалзуулан бүдүүн дуугаар байшин доргиулан инээснээ хаяаны юм биш биз гэлээ.

- Сарлагийн тугалтай үнээ арван зургааг холбоод өгвөл эмээлээ авч орхино шүү гээд Түгжил нүдээ ирмэхэд Бадарч их л хөгжилтэй пар пар инээснээ

- Чи арван зургаагаас цааш тоо мэдэхгүй гуйланчин байх аа. За тэгээд хвлгийн сайныг унаж мэддэг болохоор өглөө нухаж вээд болно доо. Чухам аль нутгийн унага вэ? гэхэд нь Түгжил түгдрэв.

Түгжил чухам ямар гэгч газраас авснаа мэдэхгүй байжээ. Авч явах үед хонхолзсон гэдэс нь татаж хоол нойр хоёр бодож явснаас биш ямар нэртэй газар хүрснээ Төмөрөөс асуух ч сөхөө байгаагүй билээ. Их л хол явсан болохоор, аль багадаа газрын тагт тэртээ зүүн зүгт Дариганга гэж нутаг байдаг гэж сонссон тэр газраас л өнгөрсөн байх гэж тааварлаж явжээ.

- Унагатай газрын морь, Даригангын унага шүү гэж Түгжил хэсэг дуугүй гөлөлзөж байсны дараа хариулав.

Түгжил Бадарч хоёр тэр шөнө хоёр хvvхэнтэй наргиж хоноод өглөө босоход намрын хvйтэн шөнө уяж хоносон морьд нь биеэ хурааж бөмбөлзтөл чичрэн зогсож байв. Бадарч, Түгжил хоёр зэрэгцэн явахад Түгжилийн унаж яваа морь хазаар даран усан хар алхаагаар сунан жирэлзэхэд Бадарчийн морь зогсоо жолоогүй шогшин байв. Бас тэр хоёр ухасхийж вээхэд Бадарчийн бор морь хойшоо хаягдсан юм шиг хоцров. Бадарчид хээр морийг авах шунал оргилон тугалтай сарлагийн үнээ тавыг өгсөнд Түгжил сонсох ч дургүй байв. Тамирын голын хөндийг уруудан явахдаа Түгжил ганцаараа олон хоног өл хоолгүй, өргөн говийг гаталж Даригангын нутаг өнгөрч хурдан сайн морьдыг цуглуулан хөөж ирсэн эрэлхэг явдлынхаа тухай яриад Бадарч их л бахдан:

- Чи ч овоо эр болж дээ гэж явлаа.

Ингэж явтал хэсэг морьтой хvvvvс цугларан байгаа харагдав.

- Морь бооцлон цохиж байх шиг байна. Очье гэж Түгжилийн хэлэхэд Бадарч зөвшөөрөн тэр зүг хатируулан яваад очвол үнэхээр ч мөрийтэй морь уралдаж байгаа ажээ.

- За юугаар вэ? бид ч оролцье гэж Түгжилийн хэлэхэд бүдvvн хар гээгтэй өдөр нарийхан хар хvн

- Толгойгоор нь хоёр морь уралдах гэж байна. Бусад нь байгаагаараа цохиж байх шив дээ Та хоёр юугаар цохих вэ? гэлээ

Үнэхээр ч өндөр бор морь, урт нарийхан алаг морь хоёрын сvvлийг шуугаад холбосон морьдыг тойруулан унасан хvvхэд нь нарийхан дуугаар гийнгоолж байв.

- За өвгөн минь. Хээр морио хэд хазуулчих. Уяж хоносон морь өлдөнө. Би ярьж орхиё гээд Түгжил олны дунд орж Би морио явуулчихья. Алдвал аваарай, хожвол хоёр морь хөтөлье гэв.

Морьдын эзэд зөвшөөрч Түгжил нилээд том болсон нэг хvvхэд олж унуулаад хээр морио сvvлээр нь шуугаад явуулжээ. Ингээд цугларсан улс халхын хурдан морьдын тухай элдвийн домог ярилцав. Нөгөө бүдvvн гээгтэй хар хvн дамшиг архи гаргаж бүгд ууцгаахад Бадарч, Түгжил хоёр ч том мөнгөн аягаар ууж бүрзингээ тайлан, ясны нь хөлс чийхран бие тавигдав.

- Бухын миний буган халиун гэж Сан бэйсийн нутагт нэг морь байсан гэдэг. Өглөө нар битvv Сан бэйсийн хүрэн дээрээс мордоод Туулд усалж байсан юм гэнэ билээ. Тийм аргамагтай бол цохиж байхад яахав дээ гэж нэг хvний ярихад нөгөө бүдvvн гээгт хар хvн:

- Ер нь зүүн аймаг морь, харваачаар баруун аймаг бөхөөр гэдэг юм даа гэлээ.

- Манай баруун аймаг бөхөөр ч юу тавих вэ дээ. Намхай Лувсанжамба Ханд чин вангийн хошуу. Чvлтэм аварга Даа вангийн хошуу шүү дээ гэж хvн хэлэв.

Ингээд аль аймаг бөхөөр илvv вэ? гэж ам булаалдан маргалдаж байтал нэг хvн «ирлээ» гэж хашгирахад агшин зуур цөм мордов. Тэртээ хэдэн хошууг тойроод нэг бараан морь гарч ирлээ.

- Тэр биш байхаа. Нөгөө хоёр нь гарч ирэхгүй байна гэж бүдvvн гээгт хэлэв. Ингээд улс мөн биш, гэж маргалдаж байтал хоёр морь ойрхон зайтай хошуу ороон гарч ирлээ. Түрvvчийн

морь, хойнох хоёроосоо улам тасарч байв.

- Хөлөрсөн морь, тоосонд бараан харагддаг юм. Хөөрхий манай бор морь бололтой. Харайлт нь аргагвй л мөн дөө гэж бор морины талд цохисон хvн хашгиралдаж байв.

- Сунаж байгаагвй нь харахгвй юу. Алаг морь мөн байна гэж алаг морины талд цохисон улс шуугилдав. Харин хэн ч Тvгжилийн хээр морийг дурссангвй. Тvгжилийн зvрх цохилж өмнөө яваа Бадарчийг чанга тэврэн

- Чи сайн хараач. Миний нvд бvрхээд байна гэж хацраараа нудран амьсгаадаж явлаа.

Тvрvвчийн морь улам тасарсаар ойртон ирвэл аль нь биш. Тvгжилийн хээр морь ам булаалдан улаан хөөс цахруулсаар давхиж ирлээ. Тvвнийг ирээд хөлсийг нь хусаж дуусаад хөтөлж явахад бор морь, дараа нь ойрхон шиг алаг морь иржээ. Тvгжил хоёр морьтой болж хvмvvc хээр морин дээр цугларан өдөр vнэ энд тэндээс хаялж хэлэв. Урьд шөнө арван зургаан тугалтай vнээ сонсоод «чи арван зургаагаас цааш тоо мэдэхгвй гуйланчин байхаа гэж байсан Бадарч хvртэл тугалтай vнээ хорь, бас тэгээд ярина шvв» гэж хашгирч байв.

Ингээд хорин тугалтай vнээ, дөрвөн залуу мориор Тvгжилийн хээр морийг Бадарч авах болжээ. Тvгжил Бадарч хоёр тэр орой айл хэсэн архидаж хоноод маргааш нь тохирсон юмаа өгч авахаар Бадарчийн гэрийн зvг явжээ.

-- За гуйланчин минь холын морь гэдэг чинь vнэн биз? Хэрэв хаяанаас эзэн нь гарч ирвэл Бадарчийн гараас чи гарахгвй шvв гэж дахин дахин хэлэхэд:

-- Зовох хэрэггвй. Тvгжил хvв аймаг даваагвй юмыг олз гэж бодохоо аль эрт больсон шvв гэж бардамаар хариулж явжээ.

Бадарчаас авсан малаа туугаад Далайчойнхор вангийн нутаг руу явах замдаа айлын бяруу дөрвийг vхэртээ нийлvвлэн явжээ.

## XVII

Өнтэй сайхан өвөл болоход хавар эрт эхэлдгийн адил өрнvн дэлгэр зун болоход налайсан өгөөмөр намар урт байдаг билээ. Тамирын хөндийд сайхан зун болж мал тарга хvчээ ханатал аваад, хонь ахарлах ажил эрт эхлэв. Yржилтэй зун харамгвй бэлэглэсэн гуа чимэглэлээ зvvcсэн ургамлын өнгө vл мэдэг шарлав. Хаашаа л харвал хөхөрсөн манаа цацраад, хорвоо шаравтар туяатай ногоон хивсээр хучигджээ. Пvрэв тайжийнх хамжлага нараа цуглуулж том хонин тогоонд шингэн хар цай чанаад арав гаруй хоног хонь хяргав. Туг, туг ноос энд тэнд нь vлдсэн юмуу эсвэл арьсаа өм цөм хайчлуулснаас төлгөн хонь билчиж явахыг хараад «муу сайн боолууд, хvний буянг ингэнэ гэнээ. Хонгоноос нь банз, хацраас нь шаахай салгахгвй байвал таарах улс» гэж тайж бухимдан гурав дөрвөн хvний ташуурдсан боловч ажил нь олигтой ахисангвй. Тvвгээр ч барахгвй дургвй ажилд цухалдсан хамжлагууд хоорондоо зодолдож хоёрын зэрэг хvн шархдав.

Тайжийнх ингэж мунгинаж байгааг хараад Итгэлтийн бах нь ханаж, уур уцаар болсон урагшгвй тайжид «хожуул хvн хар гөрөөс, ургаа чулуу» гэх мэт элдвийн хоч өгнө.

Тайжийн хотонд дажин болж хvнд данх, хvйтэн хар цайн зодооноор дуусаж байна гээд маг маг инээхэд нь Итгэлтийн нvд сэргэж, хамар нь угтаа хvртэл атиран сархайдаг байв. Итгэлт хониор тайжаас хавьгвй илvв боловч хяргах гэж огт яарсангвй. Энэ тухай Эрдэнийн хэлэхэд «гайгвй яарах юу байхав. Урт л ургаж байг» гэж тайван хариулжээ.

Тайжийнх арай гэж зодоон цохион болж баймааж хонио хяргаж дууссанаас хойш хэдэн дөрийн дараа «маргааш Итгэлтийнх хонио хяргана» гэдэг зар Тамирын голын хөндийд таржээ. Нvнжигт баяны ачаар гэдэс гарч сурсан хvмvvc хайчаа билvвдэн өглөө болохыг хvлээжээ. Ганц ч vүлгвй цэлмэг тэнгэртэй сайхан өглөө Тамирын хойтох өргөн зvлгэн дээр хэдэн морьтой хvн хонь хурааж урт урт холбоонуудад хонины толгой шөрвөглөн ярайв.

Гал түлж, шаргалтсан аагтай цай хонин тогоонд хөөсрөн буцалж, торхтой айраг шуугин, дөрөв таван ямаа боож, бяслаг ааруул овоолсон том цар хүмүүсийг ажилд даллаж байлаа.

- За идэж ууцгаа. Шалавхан шиг хяргаж дуусаад орой цүү хаяцгаая гэж Итгэлт хангинасан дуугаар хэлээд айл хэсэхээр хатируулан алга болов.

Цугласан өдий төдий хүн цадаж ханатал ууж удаан, ядрах зүдрэхээ мэдэхгүй уралдан хонь хяргав. Нямаа олны дундуур явж «хайч нь хурц, ахар нь арвин» гэх буюу «уут нь дүүрэн, унгас нь мяндас», «гар нь бүү ядар, гарах нь бүү багас» гэх зэргээр ерөөн байснаа өөрөө хяргаж эхлэв. Итгэлт гуай ажлыг мөн хийж чадах юм даа гэж Долгорын хэлэхэд хажууд нь хонь хяргаж байсан Эрдэнэ ханцуйгаараа хөлсөө арчиж, нүүрээ үлээснээ:

- Ингэж чаддагтаа л ийм баян байхгүй юу гэлээ

- Чадал, ухаан хоёр нь ч далай шиг юм аа. Ийм хүнийг ч буян даалгуй яахав дээ гээд Долгор хайч руугаа нулимснаа шир шир хяргаж эхлэв.

Үдшийн бүрэнхий болоход нь хонь ахарлаж дуусаад зогссонгүй ноосоо савлаж дууссан байлаа. Ажлаа гүйцсэн хүмүүс алиман сарны тунгалаг гэрэлд цүү хаяж баяр хөөр болжээ.

Итгэлт ч олонтой бужигнаж нэг талыг толгойн тоглов. Долгор цагаан мод эрээд газар шагайн явж байтал Итгэлт дэргэд нь ирлээ.

- Чи олчихоод, сиймхий харж байгаад зугтаачих гэж явна уу?

- Үгүй чиш. Олоогүй. Ер олдохгүй юм

- Тийм бий, үзнэ дээ гээд гараас нь барьж авлаа.

Долгор тоглоомоос өөр юм бодсонгүй. Харин Итгэлт цаг үргэлж бодож явдаг хүслийнхээ хаалгыг ядахдаа нэеэ гэж шийдээд Долгорыг барьж авчээ.

- Итгэлт гуай, надад байхгүй. Үнэхээр би олоогүй

- Тийм бий. Өгөхгүй бол гижигдэнэ бас тэгээд гээд бүр тэврэн хөх дэлэнгий нь базав.

Хэргийн учир буруу тийшээ хандаж байгааг Долгор ойлгож «надад байхгүй тавиач дээ» гэхэд Итгэлт тавих нь битгий хэл, дарж авлаа.

- Тавиач дээ, амьтан юу гэж хэлэх вэ

- Энд олоод зугтлаа, бариад аваарай гэж хүмүүс хашгиралдан гүйцгээв

- Тэр хэлээгүй юу. Тэнд олж гэнэ гээд Долгор хүчлэн босоод гүйв.

Итгэлт хойноос нь урамгүй харж «гайгүй дээ, ямар сайхан биетэй дамшиг вэ» гэж дотроо шивэгнээд босож хэд алхсанаа дуртай дургүй гүйв.

Шөнө дундын вед тоглоом дуусаж хүмүүсийн зарим нь гэр гэртээ зарим нь Итгэлтийн тусгайлан барьсан том хөх майханд битүү дэвссэн эсгий дээр бүхэл бүхлээрээ өнхрөн унав. Сартай шөнийн улаан од гялтганан анивчиж намрын шөнийн сэрүүн бөгөөд ариухан салхи сэр сэр үлээж ажил, тоглоомд ядарсан хүмүүс шинэ хүч залган өгнө. Тамирын гол шуугин урсах нь чихний үзүүр т сонсогдоно. Галсан Дулмаа хоёр сав суулгаа цэвэрлэж дуусаад гэртээ ороход битүү бүгчим агаар нүүр рүү нь цохив. Энэ үмхий, бүгчим гарт унтсанаас гадаа унтъя гээд Дулмаа дээл, дэвсгэр авч гарахад нь Галсан «хэний янаагүй тэгье» гээд дагаж гарлаа.

- Мань ах Долгорыг дөнгөх гээд байгаа бололтой гээд Галсан ишиг шиг майлан инээв

- Эрдэнэ гуай хүзүүгээ мушгиулах нь л дээ

- Буянтай, чадалтай хүн ч хүссэнээ л хийнэ л дээ

- Эрдэнэ гуай, чи биш болохоор дэвхэрсэн газар нь дараад авна л даа

- Гичий минь буянтай хүнийг тэгж болохгүй. Алдас болно хамт унтъя л даа

- Чамтай унтсанаас мэлхий өвөртөлж унтвал дулаахан байх аа

- Дэмий битгий донгос. Авааль нөхрөө ад үзэх нь үү дээ

- Аль эртний хэрэг байхгвй юу даа. Арчаагвй би л тэсэж байгаа болохоос..  
- Битгий донгос гээд Галсан ажиггвй инээмсэглэсэнээ Дулмаагийн хажуугаар хэвтэв.  
Буруу харсан Дулмаагийн ард эхдээ загнуулсан хvvхэд шиг санаа алдан хэсэг хэвтсэнээ  
«Дулмаа аа, нааш хараач дээ» гэлээ. Хариу нь энэ гэсэн шиг Дулмаагийн унтсан жигд  
амьсгал сонсогдов.

## XVIII

Хангай газрын алтан шар намар сайхан бол Тамирын хөндийн намар ч бvр ч вэсгэлэнтэй  
байдаг билээ. Өндөр ургасан өвч халиуран хонгор салхинд алтан өнгөөр найган гялалзаж,  
улиас бургасны шарласан шавчих сэржигнэн унаж, буцах шувуу Тамирын голын усанд  
өнжин vдэлж, тарган мал голоо гарч хөдөөлөн билчиж байх ve Тамирын хөндий юутай  
сайхан. Айлууд зуны дэлгэр цагт хураасан тос өрөмнөөсөө хайлуулан гадуур нь гарахад шар  
тосны хачин хурц эхvvн vнэр, нэрмэл архины эсгэлэн vнэртэй холилдон хамар цоргин  
анхилж байдаг. Ийм нэгэн намрын өглөө Итгэлтийн хот их л хөдөлгөөнтэй байв.

Өнөөдөр Хонгор, Бат хоёрыг Заяын хvрээн дээр лам болгохоор хvргэх гэж байв. Энэ хоёрыг  
явах болсонд Солонго, Сvрэн хоёр бvгдээс илvv гашуудаж, өчигдөр оройноос эхлэн хоолой  
дээр нь хуурай хар юм зангиран нvдний нулимс аяндаа асгарч байв. Должин, Долгор хоёр  
хэдэн өдрийн өмнөөс эхлэн Хонгор, Бат хоёрт зай л гарвал «багш ламынхаа vгийг сайн  
дуулж, гэрээ саналгвй, их хоол идэж, номоо хичээнгvйлэн вээж, хувцас хунараа урахгвй,  
ноцолдож хvрээний зодоончин хvvхдэд зодуулчихгвй» амьдрах тухай тvмэн зvйлийн юм  
нулимсаа асгаруулан сургаж байхад хоёр хvv нь эхийнхээ vглээ олон vгтэйг сэтгэлдээ зэмлэн  
байж билээ.

Хонгор, Бат хоёрын хувьд бол шинэ газар, шинэ амьдрал сайхан санагдавч дассан газар, мал  
сvрэг гэр орон дотно хvmvvсээсээ салах нь хэцvv санагдаж шинэ амьдралын тухай манан  
будан шиг бодол улиг домог болсон боловч, зvрх сэтгэлд нь дассан хэзээний дотно  
амьдралын тухай бодолтой өрсөлдөж байв. Тэр хоёр өглөөнөөс эхлэн ижилхэн лам захтай,  
улаан хvрэн, хөвөнтэй дээл өмсөж, гэрvvдээр хэсэхэд Солонго, Сvрэн хоёр хойноос нь даган  
атаархах, хайрлах сэтгэлдээ дарагдах хоёр хvvгийн дээл мялаан өгсөн юмыг хуваалцан идэж  
уйлахдаа уйлж, инээхдээ инээн явжээ.

- Урд хормойноос нь унага даага, хойт хормойноос нь хонь хурга гэж Нямаа дээлийг нь  
мялаагаад

- За хvvхдvvд минь хvvр дагая гэвэл зурхайч бол, хvн алья гэвэл домч бол, хvvрнэж хэрэлдье  
гэвэл гэвш бол, хvн шиг явья гэвэл төрийн хар хvн бол гэдэг юм даа гээд хөгжилтэй инээв.

- Нvгэлтэй золиг минь, хувраг болох гэж байхад нь ингэж ярьдаг юмуу гэж Хишигт авгай  
өвгөнөө зэмлэв.

Өглөө Эрдэнийг Итгэлтийнд ороход Павловынд очоод орой ирсэн Итгэлт, аль хэдийн нь  
босоод цай ууж байлаа.

- Нөгөө алиа Петр чинь сураггвй гэнэ шvv гэхэд нь Эрдэнэ хөхvvрээс айраг хийж суух зуур

- Хаачдаг юм бол доо гэж ажиггвй хэлэв

- Хаачих юу байхав. Оргосон гэж Павлов хэлж байна. Тэр чинь вймээний эзэн, гайгвй  
дамшиг гэнэ. Цөллөгийн хvн гэнэ шvv дээ гэж Итгэлт хэн ч мэдэхгвй сонин зvйлийг хэлж  
байгаа юм шиг толгойгоо хаялан шогшрон байж ярив.

Итгэлт бас Бадарч хурдан хээр морь өндөр vнэтэй авсныг сонин болгож яриад «хvн мөн  
онгиргоон юм даа томоохон шанагаар нэг утгахад шавхруу vлдэхгвй хөрөнгөтэй байж, тийм  
vнэтэй морь аваад яана даа» гэж хэллээ.

- Эрдэнэ минь манай муу хvv Хонгор чинь юу ч мэдэхгвй амьтан, Батад л сайн захиж өгдөг

юм шvv гэж Должин гаднаас твлээ оруулж ирээд гал твлэх зуур ханцуйгаараа нулимсаа арчин хэлэв.

- Хуруун чинээ хоёр амьтныг хэний нь хэнд нь захих билээ дээ. Дэмий ярих юм гэж Итгэлт хөгжилтэй инээн хэлээд

- Манай Долгор Батыгаа Хонгорт захиж байдаг Должин Батад захиж байдаг таарч дээ гэж Эрдэнэ хэлээд маг маг инээв

- Нөгөө бvсгvй хvний vс нь урт, ухаан нь богино гэдэг чинь л энэ байхгvй юу даа гээд Итгэлт нvдээ жартайлган хадан дээрээс майлсан ишиг лагуу адил инээв.

Удалгvй Эрдэнэ хоёр хvvхдийг дагуулан Заяын хvрээ рvv мордох болоход Долгор, Должин хоёр Бат Хонгор хоёрыг тэврэн vнсэж «томоотой яваарай», «бие биеэ харж яваарай», «гадуур битгий яваарай», «хvрээний нохой хэцvv шvv» гэх зэрэг тvмэн зvйлийн юм захиж уйлан байв. Солонго, Сvрэн хоёр эхэр татан енгэнэтэл уйлж байв. Солонго «ахаа та битгий яв» гэж хашгирахад ээж нь «нvгэл тэгж болдоггvй юм. Миний охин ах нь гэгээний оронд очиж сайн лам болох гэж байна» гэж хэлэв. Эрдэнэ минь наадах Хонгор чинь гэвш багшийн хашааг мэднэ. Ширvvн шиг явахгvй бол ирэхдээ оройтно шvv гэж Итгэлт захив. Тэр гурав мордоод явахад Должин, Долгор хоёр сvvгээр тахил өргөж, далд ортол нь харан байн байн санаа алдан, өөрийн эрхгvй асгаран байгаа нулимсаа хэлээрээ долоож зогсов.

Эрдэнэ хоёр хvvхдээ дагуулан ширvvн хатируулан бага vд өнгөрөхийн вeд Заяын хvрээний баруун хойноос орж ирлээ. Хөдөөнийхөн хорооныхныг «улаан модон гэртэй, усан будаан хоолтой» гэх зэргээр шоолж байдаг бол хорооныхон хөдөөнийхнийг «хөдөөний хөдсөн дээлт, хөх мантуу» гэх зэргээр шоолдог билээ. Бас тэгээд эв л гарвал vгний харцаар бие биеэ чадах дуртай байдаг. Дэмий суухаар тэмээ хариул гэгчээр хvрээ эргэхээр гарсан Чимэг, Цэцэг хоёр хvрдний дэргэд зогсон хэний хувцас аятайхан, хэний дээл муухай, хэний хамар өндөр, хэний ам том зэргийг шvvмжлэн ярилцаж тас тас инээн байтал ижилхэн хоёр хээр морьтой хvvхэд дагуулсан ханхар өргөн цээжтэй нар салхинд борлосон хvрэл царайнд нь гал цог бадарсан том нvд, өтгөн хар хөмсөг нь шинэхэн нөхөртэйгээ яваа залуу авгай ч нvдийг эргvvлж харуулах чадал төгөлдөр хар хvн өндөр бор морин дээр vл мэдэг хөндлөн суусаар ирж явлаа. Өмссөн хуучивтар хөх дээл, толгойгоо боосон шороо хөлсөнд борлосон цагаан янбуу алчуур, морины явдалд нь мөр лvv нь унжсан бvдvvн хар гээг энэ бvхэн нь хотын хоёр хvvхэнд ер бусын зохицсон юм шиг харагдав. Ойртож ирэхэд нь нэгд чадах, хоёрт өдөх гэж бодсон Чимэг:

- Хар хvн гуай цаад руу чинь хоёр бяруу дагуулсан нэг бух vзэгдээгvй биз гэхэд нь хотын хvvхний ёгт vгний далд учрыг нь хэдий нь ойлгосон Эрдэнэ ажиггvй царай гарган

- Тийм юм дайралдсангvй. Харин лам нарын юм бололтой. Нуруу туруугvй төмөр тушаатай хоёр гvv л идэж байна билээ гэж хэлээд дэргэдvвр нь өнгөрлөө.

Эрдэнийн энэ vгэнд Цэцэгийн царай хувхай цайвар болж нvдэнд нь нулимс бvрхэв. Чимэг хvрээний гудамж руу орж байгаа гурван хvний хойноос ажиглан харж байснаа

- Сайхан эр ээ гэж хэлээд тvргэн эргэж хvрд рvv орон эргvvлэхэд тосгvй гол нь хяхтнан гаслав.

Цэцэг нvvрээ гарын алгаар дарж, хvрдний vвдний яс модыг тvшин хөдлөлгvй зогсож байв. Мань гурав хvрээний гудамжаар гэлдрэн явсаар завсар бvрий нь шаварлаж гаднаас юу ч харагдахгvй болгосон бvдvvн шургааган хашааны vвдэнд зогсож мориноосоо буугаад том хvрэн даамангийн бага хаалганы оньсны сурыг татаж твлэхэд төмөр хонх дан, дvн хийж ихэмсгээр жингэнэн дуугарав. Ингээд морьдоо хөтлөн орж уяад хашааны хойт тал саравчинд өндөр шалан дээр барьсан гэрт оржээ.



Үстэй дээлээр бөгсөө ороож, өмнөө шар торгон баринтагтай ном дэлгэн тавьсан дөч гаруй насны тарган шар лам гэрийн баруун талын орны өмнө сууж байв. Арц, хвч, олон жилийн дарагдмал эдийн чийглэг үнэр, холилдон хээрийн салхинд дассан гурвын хамар руу аягвй үнэр ханхлав. Хоймор байгаа хоёр авдар дээрх бурхны гүнгэрвааны шил нь онийлгож татсан өрхөөр орж ирсэн наранд хүйтэн өнгөөр гялтганаж байв. Энэ бүхий байдал хоёр хүүхдийн сэтгэлийг дарж шинэ газар очих сэтгэлийн хөөрөлтийг нь үлээж эхлэв.

- Ламбагуайн амгаланг айлтгая гэж Эрдэнийн хэлэхэд эргүүлэх гэсэн номын хуудсаа барьсан хэвээр орж ирэгчдийг ажиглан харснаа

- Сайн, сайн байна уу? гээд нүдээ жартайлган лавлаж хараад «ээ Итгэлтийн хэлдэг хоёр хүүхэд ирэв үү. За тийшээ сууцгаа» гэж гэрийн зүүн тал руу заав.

Лам босож, орны хөлд зуузай холбон тавьсан гутлаа өмсөх зуур «жаалхүү чи гараад гэрийн баруун талд хураалттай түлээнээс тавыг аваад ир, битгий нураачихаарай. Дараа нь тэр шүүгээнээс тогоо авч зуухан дээр тавьж орхи. Ингэхэд нэр хэн билээ» гэхэд нь Эрдэнэ хүүгийнхээ нэрийг хэлэв.

Бат гарч түлээ оруулж ирээд жижигхэн жалавчин тогоог шүүгээнээс авах гэтэл «мөн түүхий байна даа. Урьдаар зуухны тагийг авч түлээгээ хийдэг юм. Тэр тогооны чинь хажууд бариул байгаа» гэж лам зандрангүй бөгөөд уцаарлангүй хэлэв.

Бат түлээгээ өрж эхэлтэл лам уцаарлан, босож, ирээд түлхэж зайлуулан өөрөө тавхан нарийн мод өрж гал түлэв. Энэ бүхнийг хараад «энэ гэрийн хамаг ажил муу хүүд минь оногдох бололтой. За яахав, эр хүн юм сур ч л байг» гэж Эрдэнэ бодов. Удсан ч гүй цай буцлан, жижиг гуулин данханд юүлэв. Орны толгойн олон нүдтэй эрэн шүүгээнээс гурван модон аяга орны хөндийнөөс зэс савтай дугуй боов гаргаж Эрдэнийн өмнө тавив.

- За цай ууж, идээ ид гэж хэлээд гутлаа тайлан буцаж орон дээрээ завилан суув

Эрдэнэ цайг гурван аягандаа хийхэд яг нэг нэг дүүрэн болоод шавхрав. Эрдэнэ энэ лам нарын энэ мэт харамч амьдралд хэзээнээс дургүй билээ. Үнэндээ ч гэвш лам, Эрдэнэ хоёрын амьдралд төсөөтэй юм байсангүй. Арван хоёртой байхдаа Заяын хүрээнд дээр ирж суусан энэ лам одоо дөч хүрчээ. Гавжийн дамжаа Заяын хүрээн дээр барьж хүрээний гандан дэгчилэн хийдийн баруун даяанд бойпор эргүүлэн гавж мяндаг авчээ. Лам нарын амьдралын нарийн аргад нэвтэрсэн энэ хүн гүрэм дором унших, мэргэлэх, сээрийн игчаа номлох бүхнийг хийж олз омог ихтэй байдаг боловч юм нь их болох тутам харамлах нь их болж хорвоо дээр үлдсэн ганц ахаа айлчлан ирэхэд хоёр хуушуур хайрч өгөөд түүндээ хэд хоног гасалдаг байжээ. Их идэх ухааны дайсан гэж шавь нартаа үргэлж сургадаг боловч өөрөө цадахгүй хонож үзээгүй. Богд ламын игчааг сайн мэддэг хүний нэг гэгддэг лам нарын ариун амьдралыг бусдад сургах, бурхны гэгээний сургаалаар олныг тэжээхэд бие сэтгэлээ зориулсан боловч өөрийн хувьд төдий л сахидаггүй, үдэш орой хороо руу гүйдэг, авах гар нь том өгөх гар нь нарийхан, чадалтай шавь нартаа номч, чадалгүй шавь нартаа ширүүн өөрийгөө бүхнээс ухаантай гэж боддог хүн билээ.

Хорвоо дээр ганц хүнд юугаа ч харамладаггүй. Тэр нь бол нөгөө Цамба юм. Бусдаас олсон юмаа банди Цамбадаа өгч байхдаа Тамирын голын уснаас халбагадан өгч байгаа юм шиг өргөн дэлгэр сэтгэлтэй байдаг.

- Чамд юу хэрэгтэй вэ? гэдэг үгийг Цамбаас өөр хэнд ч хэлж байгаагүй.

Эрдэнэ хоёр сайр хадаг гаргаж хүүхдүүдийг ламд мөргүүлэн шавь оруулав.

- Хоолыг нь зул сараар авчирч өг гэж Итгэлтэд хэлээрэй. Орой боллоо гэж ламын хэлэхэд яв гэсэн үг гэж ойлгосон Эрдэнэ босов. Хүүхдүүд дагаж гарах гэсэн чинь багш лам хориглов. Тэр ч байтугай Эрдэнэ хоёр хүүхдийг үнсэх гэсэнд хэрэггүй гэж хориглоод Эрдэнэд

шалавхан гарах дохио өглөө.

Шинэ амьдралын сургаар сэтгэл нь хөөрөөд тэр шөнө амьдралд юу болох, яахыг бодоогүй хvvхдvvд ламын энэ байдал таалагдаагүй нь мэдээж билээ. Тэр хоёр хvvгийн гол харлан, хоолой нь зангирч энэ бvгчим харанхуй гэр толгой дээрээс дарж хавирганаас нь хавчин амьсгаа давхцан нулимс аяндаа урсав. Ялангуяа том төмөр хонх хоёр дахь удаагаа дvн дан гэж дуугарахад гэрийн дотор пад харанхуй болж хvmvvсийн амьсгалах дуу тэнгэрийн дуу шиг сонсогдож байв.

Лам урьдах хэвээр хөдлөлгvй суун ном уншина. Хvvхдvvд гэрийн зvvн талд зогсон, нусаа татаж нулимсаа ханцуйгаар арчина.

«Та хоёр гарч, хашаанд морины нойтон хомоол байвал хамж аваад баруун урд өнцөгт байгаа аргал дээр дэлгэж хатаа» гэж ламын хэлэхэд хоёр хvvхэд шалавхан гvйн гарлаа. Хаанаас л харвал өндөр хашаа юм бvхнийг таглаж, дээрээс бараан хөх тэнгэр хавхаглан гvн худгийн ёроолд байгаа мэт сэтгэл төрvvлнэ. Хvvхдvvдийн нvvр цог жавхлангvй болж мөн гөлийн зогсоцгооно.

## XIX

Пvрэв тайж богдын хvрээ орж ирсний учир бол нэг биш гурав байв. Нэгдvгээр чадвал ван, эсвэл чадвал бээл зэрэг олж авах, хоёрдугаарт орон гарсан хошуу туслагчийн суурин суух, гуравдугаарт гуа vзэсгэлэнтэй, хот газрын залуу бvсгvй олж богдын лvндэнгээр эхнэр болгож авах бодолтой иржээ.

Автономит засгийн вед ойн шоргоолж шиг өсөж байсан бэйс гvнг бол Пvрэв сайн тоохгvй байжээ. Санаж ирсэн гурван зvйлээ бvтээхээ юуны өмнө Богдын баруун гарын шавар сойвон Данигатай учрах хэрэгтэй гэж бодов. Нэгэн орой тайж Данигай сойвонгийн айлчлан очив. Зvvн хvрээний цэцэн тойны их чөлөө гэж нэрлэгдсэн гудамжны зvvн захын том хvрэн дааман хашааны хойт талын модон саравчинд барьсан том гэрт ороход таргалж хэвээ алдсан том шар лам зузаан дэвсгэртэй орон дээр завилан суугаад тарган мах идэж байлаа. Данигай сойвон Пvрэв тайжийг жинсээр нь тайж гэж таньсан боловч хөмсгөө зангидан харахаас өөр анхаарал тавьсангvй.

- Ламтны амгаланг айлтгая гэж Пvрэв тайж бөхөлзөөд гэрийн нөгөө талд суув.

- Сайн гэж шадар сойвон мах зажлах зуур хэлээд ойрхон зогсож байсан бандид хандаж "гарын алчуур" гэлээ.

- Эрхэм дээд сойвонгийн өргөөнд аймшиггvй бараалхан ирснийг минь өршөөн соёрхох ажаамуу. Би бол Сайд вангийн хошууны Пvрэв тайж гэгч. Танд бараалхаж өчvvхэн бэлэг барих гэснийг минь тогтооно уу гээд өврөөсөө том баранзад хадаг гаргаж дээр нь тавин лангийн цоохор ембvv тавин барилаа. Урт хадаг, хvнд ембvv сойвонгийн занг өөрчилж тайжид мах айраг барих зарлигийг бандид буулгав. Хахууль авч баячуудад өгсөн бэлгийн нь хирээр ван бэйл, бэйс, гvн зэргийг дээдсийн зарлигаар шагнаж сурсан сойвон энэ шодон буурал гэзэгтэй тайж юу хvсэж ирснийг мэдэх гэж олон яриа дэлгэж эхлэв. Пvрэв тайж ч Сайд вангийн хошууны тэргvvн баячуудын нэг дэгээ ярианы завсраар хавчуулж "наран гэрэлт түмэн наст Богд Жавзандамба гэгээний санд чадлынхаа хирээр хандив оруулах хvсэлтэй ирсэн" гэж хэлэв.

Тан шиг буян хишиг төгөлдөр, эрдэм чадалтай хvн дээдэст гавьяа мэдvvлбэл бэйс, гvн зэрэгт хvртэх нь алга урвуулахын төдий хэрэг бус уу гээд сойвон тайжийг нvднийхээ булангаар ажиглаад харснаа нvдээ буруулж гэрийн хойт талыг эзэлсэн бурхан өөд чиглvvлэв. Энэ золиг надад ван, бэйсийн зэрэг өгөхгvй санаатай бололтой, аль эсвэл vнэд хvргэж намайг амьдаар минь шулах гэж бодож байна уу? гэж Пvрэв тайж дотроо бодов.

- Манай монгол ч олон сайхан бэйс, гvнтэй болж байна даа хөөрхий гэж тайж хэлээд нvдээ онийлгон инээмсэглэв.
- Шинэ тутам улс гэр тогтож байхад эд хөрөнгө эрдэнэсээ хайрлахгvй санд хандивлаж байгаа өглөгийн эзэд олон болохоор тэгэлгvй яахав гээд тайжийг хулгай нvдээр харснаа: "бэйс гvнг голж байна шvv нохой чинь, чамд хөрөнгө байвал надад ван аваад өгөх чадал байна" гэж бодоод хоолойгоо зассанаа, Баян, Шагдар санд таван зуун лан, хорин алтан маниад хандивлаад бэйс болсон. Баян Дорлиг хоёр зуун лан есөн цагаан тэмээ хандивлаад заяаныхаа ханийг олж авсан, баян Шарав зуун лан хандивлаад төөрч төрсөн vрээ олж авсан гэж тоочив. Ван зэрэг хэд хүрэх бол? Энэ хомхой золиг хэлэхгvй байна шvv. Ер нь их хөрөнгө орох нь бололтой" гэж бодож байсан тайж сойвонгийн vгийг дуусахад нь намбатай бөхөлзөн инээв. "Нэг л эхэлснээс хойш дуусах хэрэгтэй. Энэ хашир чоно ийм наймаагаа ямар анх удаа хийж байгаа биш" гэж бодоод тайж шууд ярианд орлоо.
- Манай хошуу туслагч бурхан болсон. Одоохондоо хошуу маань туслагчгvй сvрхий өнчирч байна. Бас тэгээд би гэдэг хvн өнгөрсөн жил ханиасаа салсан амьтан. Дээдэст айлтгаж заяаныхаа ханийг заалгаж авах бодолтой, энэ бvхэнд эрхэм сойвон таныг тусалж өгөх болов уу? гэж мунхаг хvн би гvн итгэнэ. Эрхэм таны их тусыг өчvvхэн би хариулж хэзээ нэгэн цагт танд нэгэн мөрний хvч болон зvтгэж чадна гээд нvдээ онийлгон хоолойгоо чичиргэн инээв.
- Мөхөс хvн чи танд тус болохыг л хичээе гэж сойвон ихэмсгээр хэлэв.  
"Энэ шодон гээгтэй хатингар vнэг нэгмөсөн ямар их бодож ирдэг амьтан бэ. Овоо л хөрөнгөтэй золиг юм даа. Чамайг амьдаар чинь огтлоод хvртэж орхиё" гэж дотроо бодон сойвон хэсэг дуугvй байлаа.
- Өчvvхэн хvний хvссэн бага зvйлийг бvтээн соёрхоход орох хөрөнгийг бурхны авралаар аминд оногдсон хомс хөрөнгөөс нийлvvлж, эрхэм мэргэн таны хэлсэн газар хvргэж өгөхөд бэлхэн билээ гэж тайж хэлэх зуур энэ удаа ч бэйс зэрэг олбол барав. Туслагч болж чадвал хошууны хөрөнгөөр вангийн зэрэг авахад болохгvй газар алга гэж бодож байлаа.
- Их санд таван мянган лангийн хандив нийлvvлбэл Нарангэрэлт тvмэн наст богд гэгээн таны гавьяаг ивээн өдөр vзэж хvссэн хишгийг чинь хvртээх буй за гэж сойвон, хошуу тамганд насаа барсан хөгшин бичээч улаан шугамтай дээдсийн бичгийг уншиж байгаа юм шиг, дуугаа өндөр нам болгон хэлээд нvдээ чавчилан юм бодсоноо уул мөнгийг ойрын өдрvvдэд энд авчирч өгвөл таны хэрэг сэтгэлчлэн бvтнэ гэлээ. Их гэрийн дотор хэсэг зуур ямар ч аниргvй байлаа. Тайж энэ золиг чинь намайг амьдаар минь шулах санаатай байна шvv. Өөрөө хичнээнийг ч цуслах бол" гэж дотроо бодож байлаа. "Би арай бага хэлчихэв vv дээ. Бага ч юм биш дээ" гэж сойвон бодов. Тайж өмнөө байсан мөнгө аягыг эргvvлж баахан харснаа "мөн ч vнэтэй аяга байна даа" гэж сойвонд дуулдахаар хэлж орхив. Сойвон хvйтэн инээмсэглэх мэт болсноо "хямд vнээр муу л аяга авна даа. За тэгээд хань болгохоор бодсон хvн байвал надад хэлээрэй" гээд орныхоо толгой дээр байсан хонхыг гурван удаа цохив. Гаднаас жижигхэн шар шовгортой залуухан банди орж ирээд vvдэнд зогсов.
- ганзай халааж ир. Бас өнөө орой Довчингийнд очноо. Тvнд хоргой дээлээ өмс гэж тогооны хvнд хэлээрэй хэмээн Сойвонгийн хэлэхэд банди тvргэн эргэж гарлаа. Тайж тэндээс баахан согтож мордоод хvрээний хэд хэдэн айлаар орохдоо авчихмаар өнгө зvстэй залуу хvvхэн юу байна гэж ажиглан явжээ. Маргааш өглөө нь Буянтын пvvсэнд очиж гурван жилийн хугацаатай таван мянган ланг жил бvр хvvгий нь хониор төлж байхаар хэлэлцэн аваад шууд Сойвонгийнд хvргэж өглөө.
- Шөнө дундын вед Богдын сэрvvн лаврангийн vvдээр хоёр хvн орлоо. Yvний нэг нь бидний танил Данигай сойвон нөгөө нь сангийн яамны тvшмэл Шарав гэгчийн эхнэр Туяа байлаа.

Хорь дөнгөж хүрсэн энэ хvvхэн, хэдэн өдрийн өмнө дээдэст өнгө зvстэй залуу хvvхэн эрээд хүрээний гудамжаар сэлгvvцэж явсан Данигайтай тохиолдоод дөрвөн өдрийн өмнө тvvний хамт энэ хаалгаар орж ирснээс хойш шөнө бvхэн ирж vүрээр гэртээ харьсан байдаг билээ. Туяа бол бурхан, шашны vлэмж чадал агуу ивээлд гvнээ итгэж, санаа сэтгэл нь сvсэглэлийн битvv цалманд бат хvлэгдсэн хvн бөгөөд болж байгаа бvхнийг буян, нvгэл хоёртой холбож vзнэ. Энэ учраас Богдод таалагдаж байгаагаа хvн болж төрсний дээд хувь, арван буяны эх гэж бодоод дээдэстэй самуурч байхдаа хорвоогийн амьдралаас салж диваажинд очих хий мананд хөвж, мэддэг номоо уншин наминчилж байсан ажээ. Хонийг алхаар дээш нь харуулахад намайг тэнгэр харуулах гэж байна гэж боддог гэж ярилцдаг шиг Туяа, сохор самуун тvвдийн зугаа болж байхдаа хувь заяатай төрсөндөө буян хийж байна гэж vнэн сэтгэлээсээ сvсэглэн байж билээ.

Тэр хоёрыг ороод очиход унтаж байсан дээдэс сэрээд чанга эвшээснээ "Данигай чи явж унт. Маргааш vдээс хойш надтай уулзаарай" гэж бувтнан нойрмог дуугаар хэлэв. маргааш нь Данигай сойвон нар ханы элэг өөд гарах вед богдын ордонд ирэхэд vүдний өрөөнд ёслолын хувцастай гадаад явдлын яамны тэргvvн сайд Эрдэнэ дайчин чин ван Ханддорж, орос улсын элчин сайд ерөнхий консул Коростовецтэй монгол оросын харьцааны тухай хэлэлцэн ярилцсанаа айлтгахаар аль өглөө ирээд сууж байлаа. Данигайг ороход зvүрмэг суусан Ханддорж босож

- Сойвон таны амгалан айлтгая гэлээ

- Сайн, сайдын амгаланг эрье гэж Данигай тоомжиргvй хариуллаа.

- Чухал айлтгалтай юмсан. Дээдэст бараалхах боломж бий болов уу? гэж зөөлөн дуугаар асуув.

- Би асууж өгье гээд Данигай дотогш орлоо.

Хvрэн модон орон дээр дотуур хувцастай сандайлж суугаад шилээ хөдөлгөн хvнгэнvүлэн хэхэрч байгаа Богдыг гэгээвчээр орсон нар тал гэрэлтvүлж байв.

- Данигай чи юу? нойр нэг л хvрэхгvй байна. Ямар эрт ирэв. За хувцас өмсvүлээд аль гэж Богд vгээ цувруулан хэлэв.

Сойвон орны тал бvхэнд замбараагvй тайлсан хувцсыг цуглуулан дээдсийг хичээнгvйлэн хувцаслав.

- Ирж байгаа бvсгvйн нэр хэн билээ гэж Богд амьсгаадан асуув

- Жа. Туяа гэдэг

- Аа тийм. Туяа гэдэг. Нас нь vнэхээр хорь зvс нь vнэхээр сайхан юм биз дээ?

- Эзэнтэн минь vнэхээр сайхан хvvхэн

- Бие нь ч зvгээр бололтой. Гэвч нэг хvvхэн болоогvй юм бодож vзээч

- Жа гэж сойвон Богдын товчийг товчлон зуур хэлээд «сохор байж бас хvvхэн голох санаатай» гэж дотроо шоолж байлаа.

- Нөгөөдөр авчирна шvv

- Жа. Доод би мунхаглан бодвол хүрээний зэртэгчин нөхдийн хов жив хэцvv. Энэ учраас Туяаг Сайд вангийн Пүрэв тайжид зарлигаар өгч тэр тайжийг хошуу туслагч болгон вангийн зэрэг хүртээх юм бол уул хэргийн ул мөрийг оргvй болгоно гэж зөвлөв.

Данигай дээдсийн зоогийг авчруулахаар гарах гэснээ зогсож «Ханддорж чухал айлтгалтай гээд хvлээж байна» гэлээ.

Богд нvvрээ vрчийлгэн ярвайснаа урт гэгч нь санаа алдаад « шөнийн архианаас толгой бутрах гэж байна. Данигай чи аргалж vз» гэж хэлэв. Данигайг гарч очиход Ханддорж босож «дээдэс юу гэж зарлиг болов» гэж хэлэв.

«Өнөөдөр дээдэс нямбатай, таныг сүүлд ир» гэж зарлиг болов гээд сойвон ажиггүй өнгөрөв. Богдын завгүй болсны үнэн учрыг сайн мэдсэн төрийн сайд шадар сойвонг атаархаж арга нь барагдсан нүдээр үдээд урамгүй алхаж явахдаа «улсын эзэн байтал ингэж байх ч гэж дээ» гэж бодоод гомдолтойгоор санаа алдав.

Хэдэн өдрийн дараа хүрээний дээдэс Сайд вангийн Пүрэв тайжид гурван хишиг зэрэг хүртээсэн гэнэ. Шарав түшмэл эхнэрээ өгөхгүй гэж очиход нь «тэр хүүхэнтэй байвал сарын дотор үхнэ» хэмээн богд Жавзандамба лүндэн айлдсан гэж амнаас ам дамжин ярилцаж байгаа. Үүнийг сонссон зарим нь вангийн зэрэг, хошуу туслагч, залуу гоо эхнэр нэгэн зэрэг олсон тайжийн аз хийморийг гайхан магтаж, зарим нь түүний хөрөнгийн ихэд атаархаж байлаа.

ХХ

Эрдэнэ, Жамьян вангийн хошуунаас Итгэлтийн өр нэхэхээр явсны маргааш өглөө Должин хоёр хүүхэд эргэхээр Заяын хүрээ рүү явжээ. Итгэлтийн хот энэ жил нутаг хөөж хошууныхаа зүүн үзүүрт өвөлжсөн болохоор Должин гурав дахь өдрийнхөө оройноос нааш буцаж чадахгүй байлаа. Харанхуй болов. Долгор их гэрт хоол хийж Итгэлт инээмсэглэн суув.

- Эрдэнээ санаж байна уу? гэж Итгэлт хөгжилтэй инээмсэглэн асуув

- Яршиг даа ямар хүүхэд биш

- Өнөөдөр би Эрдэнийг орлож үзэх үү дээ гээд Итгэлт жингэнэсэн дуугаар инээн, зальтай нүдээр Долгорыг харав

- Балай юм яриад яах юм бэ? гээд Долгор идэж дууссан тавагтай махыг авч хөлийн авдар дээр тавиад шууд үүд рүү явлаа.

Өглөөнөөс хойш эрс хувирсан Итгэлтийн зан, шунал тачаангуйн гал оволзсон түүний харцыг Долгор ойлголоо. Энэ ч учраас борооны өмнө салхи, боохойн өмнө хэрээ гэгчээр хэлсэн үг нь тоглоом биш гэдгийг Долгор мэдэж байв.

«Долгор оо охиныг унтуулаад яв» гэж Итгэлт ихэмсэг бөгөөд төв дуугаар хэлэв. Аягыг нь дагаж, аягыг нь өнгийсөн зарц хүн болохоор Долгор аргагүй эргэв. Солонгыг хэвтүүлэн хучаад «бухан бяруу, ухна ишиг» хоёрын тухай үлгэр эхэлсэн боловч сэтгэл нь өөр зүйлд эзлэгдээд ярьснаа мартаж нэг юмаа дахин дахин ярьж байв.

Ядарч яваа цагт нь гараа сунгасан Итгэлтийг уурлуулах хүсэл Долгорт байсангүй. Итгэлтийг чадалтай ухаантай хүн гэж бахархан байдаг боловч түүнтэй самуурах хүсэл Долгорт хараахандаа байсангүй. Итгэлт Долгорын хөдөлгөөн бүхнийг ширтэн байхдаа элдвийн юм бодож байв. Өнөө шөнө Долгорыг оролдож, санаж хүсэж явснаа гүйцэтгэнэ гэж шийдсэн.

Гэвч юм бүхний эхлэлт хэцүү байдаг болохоор энэ эхлэлт нь олигтой болсонгүй. Энэ хэргийг Эрдэнэд мэдэгдэхгүй хийх нь чухал. Хэрэв Эрдэнэ мэдвэл юу ч гэж магад.

Хэдийгээр ямаа туйлаад янгиа эвдэхгүй, тэмээ туйлаад тэнгэрт хүрэхгүй гэж бодогдовч Эрдэнэ мэдэж ямар нэгэн хэрэг төвөг гаргавал тусгүй байлаа. Долгор үлгэрээ ярьж чадахгүй мөртлөө түгдэрч байгааг сонсоод түүний сэтгэл догдлон байгааг ойлгов. Тэгээд тогтуун хүйтэн сэтгэлийг эвдэх л хэцүү, харин догдолсон сэтгэлийг олж нударвал эвдрэх нь амар гэж дотроо бодлоо. Төдий л удалгүй Солонго унтаж, Долгор явахаар босов. Гэтэл Итгэлт шууд очиж гар дээрээс нь барьж авлаа.

«Итгэлт гуай хэрэггүй» гээд угзран татлаа. Итгэлт тавьсангүй. Харин нөгөө гараараа тэврэн авлаа. Долгор хүчлэн ноцолдов. Хэсэг ноцолдсоны дараа Итгэлт тавьж «би чамд сайхан санаж явсан байх, муу санавал бас чадах хүн шүү, битгий гомдоорой» гэхэд Долгор гэрээс харвасан сум шиг гүйн галаа. Гэртээ орж орон дээрээ нүүрээ таглан суугаад «тэнгэр минь атаа таван богд минь» гэж уйлав.

«Би чамд сайн санаж явсан байх, муу санавал бас чадах хүн шүү, битгий гомдоорой» гэсэн Итгэлтийн үг дахин дахин сонсдож энэ үлэмж чадалтай хүн яах бол гэж санахад бие нь чичрэн, сэтгэл нь харанхуй манангаар бүрхэж байлаа. Тэгээд хажуулан бүхэл хэвтээд нэг мэдэхэд нам унтжээ.

Долгор хар дарж зүүдлээд хашгиран сэрвэл Итгэлт орны нь өмнө инээн зогсож байгаа нь том дэнгийн гэрэлд тодхон харагдана. Итгэлт унтах гэж хэвтсэн боловч нойр нь хулжиж баахан хөрвөлдөж байгаад босож хувцаслан гарлаа. Жавартай шөнийн хүйтэн салхи сэр сэр үлээн, дулаан бууцанд хэвтсэн хонины шүд хяхтнан хавирч, нэгэн жигд хивж яраглана. Мичид бүр гудайгаад тэнгэрт том мөнгөн сар мэлтийнэ. Хуцаж байсан хоточ нохой нь эзнээ хараад гүйн ирж эрхлэхэд уцаарлаж ёвров. Хэсэг зогсож байгаад Галсангийн гэр лүү харснаа дурамжхан инээмсэглээд Эрдэнийн гэр рүү шууд явлаа. Гэрт ороод том дэнгийн нь асаагаад, Долгорын дэргэд очиход тэр хашгиран сэрсэн ажээ.

- Хар дарав уу?

Долгор ухасхийж босоход Итгэлт бугуй дээрээс нь барьж аваад чичрэн байгаа Долгорыг тэврэн авч дураараа болжээ. Явахдаа «энэ тухай нэг ч үг дуугарч болохгүй шүү» гэж шивнэн тод хэлээд гарлаа. Замдаа хот эргээд явж байсан Дулмаатай яг мөргөлдөв.

- Битгий дэмий яриад байгаарай гээд Итгэлт ажиггүй дэргэдүүр нь өнгөрөв.

Дулмаагийн сэтгэлд Долгортой өрсөлдөх атаархал оргилон Итгэлтийг бариад авмаар санагдсан боловч яаж чадах билээ. Бас Итгэлтээс айдаг болохоор Эрдэнэд хэлэх зүрх ч байсангүй. Харин хэдэн сарын дараа Эрдэнэд хэлээд их уй гашуудалт хэрэг тарих юм хэмээн Дулмаа яахин мэдэх билээ. Болсон явдлыг Эрдэнэ мэдвэл зовлон болно гэж бодсон Долгор нэгэнт л ийм хэрэг болсноос хойш дараагийн зовлонгоос зайлахын тул нөхрөөсөө тус нууц гэж шийдэв. Арваад хоногийн дараа өрөнд авсан зургаан морь холбож хөтөлсөн Эрдэнийн ирэхэд хэдэн өдрийн турш Должингийн царайг харж чадахгүй байгаад арай гэж дасаж байсан Долгорт шинэ зовлон болов. Эрдэнийг инээсээр гэртээ ороод ирэхэд нь Долгор доошоо харан үг дуугүй уйлав.

- Чи чинь юу болов?

Долгор хариу дуугарсангүй. Амьдралдаа нөхөртөө муу санаж, түүнийг мэхлээгүй эмнэг сэтгэл нь чинэрэн догдолж Эрдэнийг хашгиран асуувал бүх хэргээ тоочиход бэлэн байлаа. Эрдэнийн хөмсөг нь зангиран эхнэрээ ширтсэнээ:

- Хүү зүгээр биз? гэж асуув

- Хүү сайн

- Тэгээд юунд уруу царайлаад байгаа юм бэ? гээд эхнэрийнхээ толгойг илэв

Долгор хэсэг түгдэрснээ буруу харж байгаад «чиний тухай муу юм зүүдэлсэн» гэж худал хэлэв. Эрдэнэ гэнэн цагаан сэтгэлээр инээмсэглээд:

- Миний өвгөн, зүүд ямар хамаа байх вэ гээд хоймроо сууж том модон аяганд тавагтай цагаан тосноос авч хийгээд дээр нь цай хийлээ.

Үүд дуугарч Итгэлт их л хөгжил баяртай орж ирлээ.

- За сайн явж ирэв үү? гээд Эрдэнийн дэргэд суужээ.

- Ажил бүтэмжтэй. Харин нэг залуу морины өрөнд бүрэн шүдтэй морь авсан. Арилжаа хатиртай бага наадамд сойвол түрүүлэхгүй ч гэсэн модтой баймаар санагдсан. Таны сэтгэлд тохирох байх гэж Эрдэнийг хэлэхэд Итгэлт аяганд өөрөө цай хийж авах зуур:

- Би морьдыг үзлээ. Ялангуяа тэр бөгрөгтэй хээр морь манай адуунд ховор морь байна гэв.

- Миний хэлдэг чинь тэр дээ Эрдэнэ баяртай хэлэхэд Итгэлт инээмсэглэн толгойгоо сэжилж:

- Сайхан морь, толгой салгая гэхэд одоо өгөхгүй шүү гээд өвгөнийхөө дэргэд уруу царайлан

зогсож байгаа Долгорыг харснаа

- Нөхрөө ирээд байхад модон өмд өмсчихсөн юм шиг зогсоод яаж байгаа дамшиг вэ гээд инээмсэглэв

- Миний тухай муухай зүүд зүүдэлсэн гэнээ гээд Эрдэнийг хэлэхэд Итгэлт хөгжилтэй инээж  
- Амьдралыг зүүдээр харж болдоггүй юм гээд аягандаа цаган тос хийж идэн Эрдэнээс замын сонинг асуун нилээн ярилцав.

Долгор тэсэж чадсангүй гарав. Хэдэн талдаа өндөр уултай битүү өвөлжөө ертөнцийг нуун дарах гэсэн юм шиг хуйлран багширч байгаа хар үүл хаашаа ч гаргахгүй хорьсон юм шиг санагдав.

Тэнгэр бүрхэг ёозгүй өдөр байна. Бас тэгээд ажил бүтэмжтэй ирсэн хойно хэдэн хуушуур идэж аяга тагш юм балгая. Павлов намар явахдаа бэлэглэсэн архианаас хоёр лонх үлдсэн. Чи ингээд очоорой гээд Итгэлт явжээ. Хэдэн өдрийн дараа Луу Гүний хошуу хүрээнд очиход гудамжны үзүүрт байдаг том хүрдний үүдэн дээр адсага, шир дэвссэн новшин дээр олон жил хээр хэвтсэн чихтэй яс шиг нүүртэй Буян чавганц хэвтэж байснаа Эрдэнийг таниад, хучилган дотроосоо хатсан тэмээний үдээр шиг гар гаргаж

- Одоо чи миний зовлогыг цусал. Хойт насандаа чиний зовлогыг би цусална аа. Гишгэсэн газар чинь цөмөрч, дөрөөндөө чиргүүлэн үхээд халуун тамын ёроолд хэвтэнэ дээ чи гээд хоцорчээ.

Орой нь Буян чавганц нас барж хошууны гуйланчин нэгээр хорогдоход баярласан хүн ч үгүй гомдсон хүн ч үгүй байжээ.

Хүүхэд бол амьдралд дасахдаа тун ч түргэн шаламгай болохоор Бат, Хонгор хоёр шинэ амьдралд дасаж тогтмол хийдэг ажлаа гэвш ламд хөдлөх бүрдээ зэмлүүлэн хийж байлаа.

Өдөр бүхэн хавчиг үүрч усанд явах зэрэг аль хүнд ажил нь Батад оногдоно. Нэг удаа усанд явахдаа «багш аа бид хоёр хамт яваад ирье» гэжээ. Лам зүгээр байснаа гэнэт дэмийрэн галзуурч байгаа хүнийг «энэ чинь юу ярьж байна даа» гэж гайхан харж байгаа хүний нүдээр ширтэн харснаа «Хонгор бол хоолоо авчраад ном үзэж байгаа хүн. Харин чи бол ажил хийж байж хоолоо олж иднэ» гээд босоход нь Бат ухасхийн гарчээ. Харин Хонгор аль болохоор Батад туслахыг хичээнэ. Тэр ч байтугай багшаасаа гуйж байгаад өглөө ээлжлэн босдог ажээ. Хоол ундны хувьд бол хоёулаа өлсөж байлаа. Өглөө орой тус бүр хоёр аяга хар цай, дугуйн хэлтэрхий, үдэд бас л тус бүр нэг аяга хоол иддэг өгөөд энэ ч учраас түлээ хөрөөдөж байхдаа гэртээ байдаг донхор модон аяганыхаа тухай шүлсээ залгин ярилцдаг болжээ.

Ном цээжлэхдээ Бат нь илүү боловч амьдрах овын хувьд Хонгор дагуулахгүй байжээ.

Заримдаа гэвш ламын түүний эрх танхил банди Цамба ирэхэд хоёр хүүхэд хуушуур хийж өгдөг бөгөөд дараа нь лам тэдний гадагш гаргадаг болохоор Цамбыг айлчлан ирэхийг тэсгэлгүй хүлээдэг байв. Харин чухам юунд энэ өндөр цагаан лам, гэвч багшийнд нь ирдгийг яаж мэдэх билээ.

Хамар хашааны буюу зарим таньдаг лам нар «танайд Цамба ирээ юу болдог вэ?» гэж асуухад «хуушуур хийж өгөөд гарч тоглодог» гэж хариулдаг байв. Нэг удаа Цамба ирсэн завшаанаар хоёр хүү хашаанаас гараад давхиж байтал хар хүүдий үүрсэн гуйланчин хүүхэд ирж хаалган дээр нь зогсоод «ламбугай юм хайрла» гэж хашгирахад нь «манай лам байхгүй» гэж гэвч багшийн зааж өгсөн үгийг хэлбэл

Тэгвэл та хоёр надад юм өг гэж шалахад хатааж байсан өрмөөс хэсгийг ач өгөөд Жаргал гэдэг нэртэй тэр жаалтай анхандаа найртай тоглож эхэлсэн боловч дараа нь эв тунжин эвдэрч зодолдоход тэр жаал мань хоёрын таглаж орхиод зугтаан алга болжээ. Гэтэл нэг бүдрэхэд долоо бүдэрнэ гэгчээр гуйланчин хүүхдэд өрөм өгсөн хэргээр хоёул торлогдууллаа.

Дараа нь хоёулаа Цамбынд хонины мах хвргэж өгөөд буцаж явтал хиазтай шар хамбан дээлтэй өөрсдий нь веийн нэг жаалыг нөгөө Жаргал гайхал цус нөжтэй нь хутган зодож байхад нь барьж аваад элбэж булуу болтол нь зодож орхив. Арай гэж мултарсан гуйланчин хvvхэд ухаан жолоогvй зугтан vгvй болсон хойно мань хоёр хамбан дээлтэй хvvхдийн цус нулимсыг цэвэрлэж байтал хоёр мундаг лам ирээд чихий нь дvйртэл алгадаж орхив.

Гэгээний ариун лагшинд халдсан энэ хоёр дэггvй жаалыг хорь хорь торлогдоод, байдаг газар нь хvргэж өг гэж гурав дахь ламыг хэлэхэд нөгөө алгаддаг хоёр лам чирч аваачаад цогчин дуганы өмнө хувцсыг нь тайлж байгаад хорь, хорь шавхуурдаж орхиод гэвш ламынд хvргэж өгөхөд багш нь Зая гэгээнийг зодсон гэж айлдаад нэмж адислав. Хvн зодуулаад ядарч байхад нь амь тавин хамгаалсан ачийг умартан, торлогдуулах гээд чирэгдэж явахад нь өмөөрөхийн оронд шоолон инээж байсан Зая гэгээнд минь хоёр ихэд хорсжээ.

Өвлийн цагт хvйтэн эрт өглөө босох шиг хэцvв юмгvй билээ. Гэтэл vн дээр гэвш ламын хэцvв арга нэмэгдэх дээр бvр ч айхтар байжээ. Өглөө босох ээлжтэй аль нэгний нь нөмөрч унтсан дээлийн ханцуйнаас бvс уяж дэргэдээ бэхлээд унтдаг лам өглөө дуг нойронд нь дээлийг нь хуу татахад нvцгэн vлдсэн хvvхэд аргагvй босдог байв. Хонгор энэ харгис хатуу явдалд хорсож яаж зогсоох тухай сэтгэлдээ элдвийн юм зохион бодно. Гэвч бодсоноо бvтээж чадахгvй л байв. Гэтэл Хонгор нэг шөнө орой болтол цагаан сарын банш бууз хийгээд унтахдаа нөмөрсөн дээлийн ханцуйнаас уясан бvсийг сэмээрхэн тайлж гол бурхны ширээний хөлнөөс уяжээ.

Өглөө нvсэр бурхны тачигнан унахад хоёр хvvхэд зэрэг сэржээ. Гэвч нойрмог хvvхэд яаж ч амжаагvй байхад бvх учрыг ойлгосон гэвш лам дэнгээ барьж гэмтэй Хонгор, гэмгvй Бат хоёрыг хоёр өдөр халуурч хэвтгэл балбажээ. Эдгэрэхэд нь Хонгорыг Цамбынд банш бууз хийж өг гэж явуулав. Бат ганцаараа өдөр турш гэрийн ажлаа хийж дуусаад орой гадагш гарвал Хонгорын нvд нь орой дээрээ гаран гvйж ирлээ.

- Бат минь Цамбынд өглөө Бадарч ирээд байна. Тэр чинь Төмөр ахыг банздаж, ширлэсэн хvн байгаа юм. Хоёул сайн чадаж орхиё гэлээ.

- Яаж чадах вэ?

- Их амархан. За намайг дагаад яв гээд гvйхэд нь Бат юу болохыг мэдээгvй боловч ямар нэгэн сайхан юм болох нь гэж сэтгэл хөөрөн гvйв.

Хvрээний захад очоод Хонгор vхсэн хvний төдий л хуучин биш толгой авч хормойлон буцахдаа «Бадарч орой явах юм гэнэ. Би vвнийг эмээлийн нь ганзганаас уяж орхино» гэж хэлжээ.

Yдшийн бvрий өнгөрч, Заяын хvрээг битvв хар бvтээлэг хучин эхлэхэд Бадарч Цамбынхаас гарч мордоод Чимэг хvvхний рvв явжээ. Гэтэл замдаа эмээлийн ганзаганд нь юм байхыг мэдээд энэ чинь юу билээ гээд тэмтрэн vзвэл ямар нэгэн хатуу бөөрөнхий юм байхад нь Цамбын өгсөн юм байх гэж бодоод хvvхнийд очиж морины эмээлээ аваад гэрт орж ганзага юугаа харснаа «ээ багш минь» гэж хашгираад ухаан алджээ.

- Юу болов гээд Чимэг очсоноо бас муужрав. Харин Цэцэг гэрээс гvйн гарч айл амьтныг босгосон боловч орох зvрхтэй хvн байсангvй. Бадарч ухаан ороод «ээ багш минь, ээ гэгээн минь» гэж чичрэхээс өөр vг дуугарч чадсангvй.

Энэ нэг явдлаас хойш болж гvрэм дором болсон төдийгvй Зая гэгээний зарлигаар чогчин дуганд тусгай хурал хурж Хонгор Бат хоёр ч оролцов. Зарим хvмvвс ийм ер бусын ёозгvй явдлын дараа лав л ханиад томуу дэлгэрдэг гэж аль олигтой юмаа барьж амь насаа даатгав. Бас Бадарч Чимэг нарын хэрэг олонд задарч авгай хvvхнvvд уулзахдаа бие биедээ сонин болгон ярих юмтай болжээ.



Намрын дунд сарын хонин хоёрт Заяын хүрээ мөргөлчөөр дүүрээв. Мань хоёр ч мөргөж гарлаа. Галдан зуунд мөргөж гараад Хонгор Батыг хөтөлж олноос хол аваачаад өврөөсөө хоёр хадаг гарган үзүүлж:

- Залбираад бурханд мөргөхдөө өмнөх хадгаас хоёр алганы ирмэгээр хавчин авч болох юм байна гээд өөрийн олсон аргыг үзүүлэн зааж өглөө.

Сүм дуганаар хагас өдөр явахдаа мань хоёр овоо хэд хэдэн хадаг олж бааюу руу очиж худалдаад пүүснээс танзуур боов авч хирээ мэдэхгүй залж орхисон чинь гэртээ харих замдаа бөөлжив. Хашаандаа орвол гурван морь уяатай байв. Хоёр хүү гэрийнхнээс ирснийг мэдэж баярлан орвол Итгэлт, Эрдэнэ, Солонго гурав сууж байлаа. Хэмжээлшгүй баяр болов. Гэвч чухам уулзах дээр нэгдүгээрт бантсан, хоёрдугаарт бишүүрхсэнээс болж үүдэнд хөдлөлгөй гайхан зогсов. Солонго энэ хоёртой уулзахыг мөрөөдөн хүсэж, өглөө явна гэж бодоход шөнө нойр хүрсэнгүй. Гэтэл чухам уулзах дээр зөрвү захтай улаан дээл өмсөж, хөх цамцны зах цухуйлгасан Хонгор, Бат хоёр хүсэж ирсэн хүмүүс нь биш мэт санагдаад царай нь улайн эцгийнхээ хажуу руу шигдэн уйлмаар болж, орох газраа олж ядан байв.

- Миний хоёр шавь ч овоо лам болох шинжтэй гэж гэвш лам Итгэлтэд хэлэхэд Итгэлт инээмсэглэж

- Тархигүйтэхгүй байна уу? гэхэд лам нь зальтай бөгөөд дээрэнгүй нүдээр ирмэн инээмсэглэж

- Тэр ч байдаг. Гэвч зүгээр болно.. за Батаа гараа түлээд хагалж ир. Замдаа нөгөө шар хүүдийтэй банш авчир, гийчдийг дайлцгаая гэхэд нь Бат гарлаа.

Батын хичээнгүйлэн чанасан ганц таваг банш аманд ч үгүй, хамарт ч үгүй өнгөрөв. Орой нь тэднийг явахад Хонгор Бат хоёрын хоолой нь зангиран «бид хоёрыг аваад яваач гэж» хэлмээр санагдавч бүстэй хүүхэд эр хүн шиг болсон гэж бодож байх үедээ үлэмж нэрэлхүү байдаг болохоор хэлж чадсангүй. Гэвч зүрх нь нэрэлхэж чадахгүй болохоор нулимс нь өөрийн эрхгүй асгарав.

-- Хүү минь овоо борогшиж, хал үзэж, хашир таньж байгаа бололтой. Амьдрахад нь хэрэгтэй гэж Эрдэнийг хэлэхэд Итгэлт инээмсэглэх шиг болоод

- Ээ дээ мань хоёр ч олигтой лам болохгүй байхаа. Зөрвү захтай дээл өмсөж хорвоогийн хар амьдралд умбасан шинэ цагийн лам нарын өрөөсөн дугуйнууд л гарах байх гэлээ.

- Гэхдээ ажилд яггүй болж шүү. Тэр гал түлээд банш чанаж байхыг нь хард аа. Дадлагатай лам гүнгэргийн чагж хийж байгаа юм шиг гээд Эрдэнэ дуугүй болжээ.

Гэрийнхнээ явсны дараа хоёр хүү нэг хэсэг дуу шуу ч үгүй, гэрийн зүүн талд зэрэгцэн суужээ. Хоолой дээр нь ямар нэгэн юм нааш ч үгүй, цааш ч үгүй тээглэн, нүд нь байн байн харанхуйлж байлаа. За номоо үзэцгээ гэж гэвч багшийн хэлэхэд хоёр хүүхэд босож шоголтой номоо аваад бувтнан уншиж эхлэв.

XXI

Итгэлт Вангийн хүрээ орж наймаа хийхдээ Эрдэнийг дагуулжээ. Хан өндрийн хүрээн дээр Пүрэв тайжтай дайралдаж тэднийд очив. Пүрэв тайжийн хашаа хан өндрийн хүрээний бараг нэг бүхэл гудамжийг эзэлдэг бөгөөд тайжийн гэр хөдөө байдаг боловч хураасан хөрөнгө нь энэ хашаанд байдаг билээ.

Үхрийн наймаа олон удаа хийсэн баян их л дотно уулзаж тайж сайн архи, тарган махаар Итгэлт, Эрдэнэ хоёрыг дайлав. Пүрэв тайж сүрхий согтож Луу гүний шинэ баянд юмаа гайхуулах сэтгэл төрөөд байшингуудаа үзүүлэв. Нэг байшин нээхэд толгой толгой торго, чирчүү, хунзаар цай, авдраар тамхи хураалттай байв. Дараагийн байшинд том авдруудаар дүүрэн гурил, цагаан шар будаа, хайрцаг хайрцагар чавга, нар хамба, хятад боов байлаа.

Дахиад нэг байшинд ороход боодол боодлоор хураасан сур, олс, хэлхээтэй янз бүрийн сүх, тогоо, давхарлан хураасан шинэ эсгий, их бага хивс, олбог, домбо, савхан хувин, цар зэрэг өдий төдий зүйл байжээ.

Түмэн зүйлийн юм дүүрсэн иймэрхүү зургаан байшинг үзэж явахад лусын хааны сан л ийм байдаг байх гэж Эрдэнэд санагдаж байв. Итгэлт хураалттай торгоны доод талаас барьж үзээд ялзарч эхэлснийг мэдэж ёжтой инээмсэглээд хамраа шантайлган шиншлэв. Удаан жил дарагдсан юмны чийг даасан хөгцний үнэр хамрыг нь хорсгов. Гэвч баярхаж байгаа тайж, баян тайжийн хөрөнгөнд ачирхсан Эрдэнэ хоёр Итгэлтийн энэ байдлыг ажигласангүй. «Энэ бол эцгийн минь вед хураасан торго, энэ бол би Бээжингээс авчирсан чирчүү, яг л шир шиг, энэ бол хивс» гэх зэргээр ярьж байгаа тайжийг шоолж яваа Итгэлтийн залхуу нь хврч хааяа хааяа эвшээн байхыг нь хараад «мань Итгэлт ч аргагүй л юм үзсэн хүн юм даа» гэж Эрдэнэ бодов. Итгэлт тайжтай намар авахаар тавин үхрийн наймаа хийж дэнчин өгчээ. Итгэлтийг дэнчинд орос цаас өгөхөд «оросын дайн удааширч байгаа болохоор цаас нь муудахгүй байгаа даа» гэж Пүрэв тайж асуухад нь:

- Баатар цагаан хааны мөнгө шүү дээ гэж Итгэлт ихэмсэг хэлэв
- Итгэлт чи үлдсэнийг нь мөнгөөр өгч үзээрэй
- Тэр вед нь л болно доо гээд Итгэлт инээлээ.

Итгэлт орос германы дайн удааширч байгааг сонсмогц хадгалж байсан орос цаасаа зарж дуусгахаар наймаа хийж эхэлсэн юм. Тайжийнхаас мордоод зэрэгцэн явж байхдаа « энэ хорвоо дээр ийм баян хүн өөр байдаг болов уу? » гэж Эрдэнийг хэлэхэд Итгэлт

- Эрдэнэ минь ёстой тэнэг байна. Тэр хураалттай торгоны доод тал нь ялзарч байна. Гурил будааг нь оготно идэж байна даа. Хөрөнгийг үргэлж хөдөлгөж байхгүй бол өмхөрч ялзардаг. Сохор зоосыг ч бол сэгсэрч байвал төл өгдөг юм шүү.
- Нээрэн ч тийм байх даа

- Тиймээр барах уу даа. Эхнэрээ ч болсон хайрлахгүй худалдаж баймааж юм олдог юм шүү.
- Тэр ч арай хэтрүүлж байна
- Магадгүй.. ер нь л наймааны дөр иймэрхүү байдаг юм. Пүрэв тайж мэтийн юм цуглуулж хав дарсан баячуудыг Итгэлт шоолон «сохор номин», «тэнхэлгүй хөгшин ухна» гэх зэргээр нэр хоч өгдөг юм.

Өөрийн хувьд нь бол ашиг олбол хайрлах юм байдаггүй. Эцэг нь үхэхдээ «гурван ве зүүсэн юм шүү. Чи дөрөв дэх нь хайрлаж яваарай хүү минь» гэж өгсөн хутгыг ламын гэгээний догшин дүрийн ид шидтэй зэвсэг гэж их үнэ хүргээд өгөхдөө «хайран юм» гэж бодоогүй бөгөөд харин одоо хүртэл амьдралдаа хийсэн хамгийн зөв юм гэж бодон чадал ухаандаа бахархаж явдаг юм. Пүрэв намайг хөдөө гэртээ ирэхэд шинэ авсан залуу эхнэр нь эзгүй байлаа.

- Хатан хаачив гэж тайж зарц нараасаа асуув
- Өглөө морь бариулж унаад явсан
- Хаашаа?
- Гол өгсөөд явсан

Богдын зарлигаар Пүрэв тайжийн энхэр болохдоо Туяа хүүхний зүрх нь хөгшин тайжид дургүй байсан боловч тэр нүгэлт зүрхийг бишрэлээр ялах гэж их хүч гаргалаа. Гэвч хорвоогийн хар нүгэл буцалсан зүрх бол ногтолж аваад уяж орхидог номхон морь шиг биш болохоор юунд тийм амархан ялагдах билээ. Сэтгэл бишрэл Туяа хүүхний өмнөх амьдралын зам бөөн бөөнөөр ялзран тасарч байв. Гэтэл бас л шинэ гамшиг дайрав. Богдын ордонд хэд дахин очихдоо дээдсээс авсан муу өвчин нь илрэв. Энэ өвчний үүр болсноо тайжид

мэдэгдэхгвй байсан боловч хvvхний бие өдөр өнгөрөх тутам ялагдаж сvvлдээ алхах гишгэхэд нь мэдэгдэн шаналах болов. Гэхдээ хvvхэн энэ зовлонг Богдоос авсан гэж яаж бодох билээ. Харин бузар зvрхний нvгэл нэвтэрч байна гэж гэмшин бурхан сахиусандаа мөргөвч тус болсонгвй. Ингээд нэмэгдэн ирэх нvглээс айсан тэр хvvхэн хилэнцэт өвчнөөс салахаар Тамирын голыг өгсөн явжээ.

Тайж хоол идэж, архи ууж аваад гэрээс гарлаа. Хотын бvсгvйчvvд vнээ саах ажилдаа ид ороод энд тэндгvй май тавьсан байлаа. Галууны цуваа шиг зэллvвлэн уясан зуу шахам тугал нvдэнд нь тусаж тайжийн сэтгэлийг баярлуулав. Ингэж байтал ам уруудан хээр морьтой хvн хурдан давхиж ирээд тайжийг хармагц дэргэд нь ирж мориноос всрэн бууж «тайж гуай минь, муухай юм боллоо, яадаг билээ» гэж амьсгаадав.

- Юу болов? гэж тайж зандрав  
- Хатагтай бурхан болчихсон байна  
- Юу?

- Хатагтай бурхан болчихсон байна

- Туяа юу дээ?

- За тийм. Их эрэгний цvнхэлд унасан байна

- Үгvй. Тэр чинь яадаг хvн бэ? Золиг юм болов оо

Тайжийн хотоор бөөн шуугиан дэгдэв. Туяагийн хvvрийг морин тэргээр авчруулав. Сохор итгэлд базагдсан хөөрхий эмэгтэй тунгалаг Тамирын усанд унаж ертөнцийн хар зовлонгоос ангижирчээ.

Нэг Туяаг байтугай мянган Туяаг шингээж чадах Тамирын гол юу ч болоогвй юм шиг яралзан урсаж, усанд нь ч гэсэн, эрэг дээрээс нь ч гэсэн хvчгvй нь хvчтэйхнээ хоол болсон амьдрал урсан доргилж байлаа.

Туяагийн хvvрийг тайж гэртээ оруулсангвй. Харин илvv гэрт хонуулаад өглөө эрт зарц нараараа нутаглуулав. Зуурдаар vхсэн хvний сvнс чөтгөр болоод эргэж ирдэг гэж ярьдгаас айж Хан өндрийн хvрнээсээ лам залж гvрэм хийлгэж, Туяа хvvхний бодийг нэртэй ламаар хөтлvллэв.

Эр хvн өрхөө бvтээж явахдаа хэнийг авахаа боддог гэж ярьдаг нь Пvрэв тайж мэтийн хvмvvсийн тухай хэлсэн бололтой. Бараг л «хатагтай бурхан болчихсон байна» гэсэн vгийг сонсмогц «ийм золиг шиг юм болох гэж, ямар эхнэр олж авдаг билээ» гэж бодсон тайж хэнийг авахаа бодсоор Туяа хvvхнийг амархан мартжээ.

Ханхай гэрт Пvрэв тайж байтугай хvч зориг төгөлдөр эр унтахад аймшигтай байдаг болохоор тайж шөнө бvхэн зарц нараасаа бvл чадалтай залуу эрийг унтуулдаг болжээ. Нэг шөнө тайжийн нойр хулжаад, ойр хавийн олигтой царай зvстэй бvсгvйчvvдийг бvртгэн хэвтэж байтал нохой нь хуцаж, удалгvй морин төвөргөөн сонсогдож, гэрийн баруун талд морьтой хvн ирээд буув.

- Хvн ирлээ сэрээч

Тайжийг манаж хоносон залуу эр цочин өндийв. Эсгий vvd сөхөгдөж том мөнгөн цөгцтэй мөнх зулын гэрэлд бараан дээлтэй ханхар хvн орж ирээд ийш тийш харснаа тайж руу ирлээ. Тайж «ээ бурхан минь» гэж хашгираад нvцгэн босож бурхан руугаа гvйх зуураа манаж хоносон залуудаа «бариац,бушуу» гэж хашгирав. Залуу ухасхийн очтол мундаг эр тvлхэж тулга давуулан унагаагаад тайжийн шилэн дээрээс барьж авлаа.

- Өчvvхэн хvний амь өршөө гэж ямар ч хөггvй зэвхий хvйтэн дуугаар тайж бvтнана.

- Өлзийг дарлавал яана гэсэн билээ гэж Төмөр бvдvvн аргил дуугаар хэлэв. Тайж алгаа

хавсран, нvдээ цагираглуулан гөлөлзөж, шvлсээ сул болсон эрvv рvvгээ савируулан: «амь

өршөө» гэхээр өөр вг дуугарч эс чадна.

- Чамайг хвлж аваачаад, хvн амьтантай харанхуй ойд хаяж чонын хоол болгоно доо гэж Төмөр шvдээ зуун хэлэв. Төмөрийн гутлын vзvvрийг vнсээд «өчvvхэн бор амийг минь өршөөн соёрхоно уу» гэв.

- Өлзийнхөөс дээрэмдсэн юмаа маргаашийн дотор буцааж өгөхгvй бол гээд Төмөр Тайжийн мөрөн дээрээс шvvрэн авч нударсан чинь тайж орны толгойн авдар мөргөж унав.

- Амласнаа биелvvлэхгvй бол доо гээд Төмөр ухасхийтэл тайжийн хоолойн хэржигнэн «жа» гэж муухай дуугарч нvд нь гялалзан тагжрав. Төмөр эргэж гараад мориндоо мордож давхин одлоо.

Залуу ямар ч сvр сvлдгvй гөлийн байгаа тайжийг харан хvд хvд инээвч нөгөө том хvн эргэж ирэх вий гэж айн байн байн vвд pvv хялалзан хөдлөлгvй зогсов.

Удсан ч vгvй тайж ухаан орж өөрийгөө өмгөөлж чадаагvй залууг харснаа их л сvржин болж «хан Өндрийн савдаг биеэрээ заларч ирээд морилохыг харав уу. Чиний барцад арилсан. Хvнд битгий хэлээрэй» гэж хатуу цаазлав.

Маргааш нь хоёр зарцдаа Өлзийнхөөс авсан бvх юмаа өгөөд явуулжээ.

Тэндээс Төмөр шууд явсаар vүрийн гэгээ гарахын өмнө Тамирыг гатлан хойт талын модтой ууланд бvгэв. Шөнө нь Эрдэнэтэй уулзах бодолтой байв. Гэвч гэрийг нь яг мэдэхгvй болохоор ямар нэгэн аргаар заалгаж авах хэрэгтэй байжээ. Модон дотор морио уяад тамхи татаж суутал хэсэг хонь хариулсан Дулма модны захад хvрч ирлээ. Хоньчин хvvхэнтэй уулзаж Эрдэнийхийг заалгадаг юм билvv гэж бодож байтал хvvхэн дээр сайхан хээр морьтой хvн ирэв. Төмөрийн нvд хээр морин дээр тусав. Тvгжилтэй явж хөөсөн адуунд байсан хээр морь мөн ажээ. Бас морины эзэн нь Бадарч гэдгийг танив.

Бадарч Дулмааг олон удаа оролдсон боловч vргэлж ямар нэгэн саад тохиолдоод хvсэлдээ хvрч чадаагvй билээ.

- За Итгэлтийн гэнэн хонгор сайн байна уу?

- Сайн. Та сайн уу?

- Олон амрагтай сайхан хvvхний амтыг vзье гэж ирлээ. Болох юм байгаа биз дээ.

- Дуртай хvнд эдлvvлж байдаг бие надад алга.

- Итгэлт, Цамбад хайрлаж болсон биеийг надад хайрлаж болох байлгvй дээ. Би хvнээс өөр хvн биш гээд бууж очиход нь Дулмаа эргэн гvйж мориндоо мордох гэтэл Бадарч барьж авлаа. Тэр хоёр ноцолдов.

Дулмаа хэдий самбаатай боловч Бадарчийг яаж дийлэх билээ. Удсангvй Дулмааг хумхин авсан Бадарч дарж унав.

Гэтэл Бадарчийн мөрөн дээрээс хvчтэй гар угзран татахад эргэж харвал Төмөр зогсож байв.

- Ухай. Муу хулгайч, ахынхаа гарт өөрөө хvрээд ирэв vv?

- Эмэгтэй хvнийг битгий дарла

- Муу хулгайчид ямар хамаатай юм бэ? Зайл

- Чи битгий хашгир. Ухаангvй байхад минь барьж хvлснээ мартаад одоо дийлнэ гэж андуурч болохгvй.

Бадарч давхин дайрав. Төмөр тvvнийг хумхин аваад нойтон газар тvсхийтэл хаяв. Бадарч хvч хvрэхгvйг ойлгоод тvргэн босож мориндоо мордоод «муу хулгайч чи сайхан мэдээрэй» гэж хашгирав.

- Муу хулгайч гэнээ. Унаж яваа морь чинь хулгайн замаар ирсэн морь. Оролдвол хамт ойчно шvv гэлээ.

Бадарч ум хумгvй давхин алга болов. Дулмаа замбараагvй болсон vс гээг, дээл хувцсаа

засаад идэж байгаа морио цулбуураас нь барьж авла.

- Та их ачтай хvн байна

Төмөр том цагаан шvдээ яралзуулан инээмсэглээд «чоно хонь барьж байхад салгадаг байхад хvн барих гэж байхад салгахvй яахав») гээд Дулмаа руу харлаа.

- Та юун хvн хаанаас гараад ирэв?

- Газар дороос ургаад гарч ирлээ. Та засагт ханы Эрдэнэ гэдэг айлыг мэдэх vv?

- Мэдэхээр барах уу даа. Бид нэг айлын зарц. Энэ амны адгийн дөрвөн гэрийн баруун хойтох нь Эрдэнэ гуайн гэр гээд Дулмаа шилvvрээ газар хаяж урт ургасан ногоон дээр суув.

- Эрдэнэ гэртээ бий болов уу?

- Гэртээ. Та ах дvv нь vv?

- Яаж байна

- Төсөөтэй байна гээд Дулмаа нvдээ солбилзуулан инээмсэглэхэд жигд цагаан шvд нь яралзав.

Энэ эзгvй ууланд зэрлэг Бадарчийн гараас салгасан сайхан эр Дулмаагийн сэтгэлийн нарийн утсыг доргиулж эхлэсэн бол тогтож тэмvvлсэн нvдтэй залуу бор бvсгvйн байдал Төмөрийн хөшиж хөлдсөн сэтгэлийн vзvvрээс vl мэдэг угзарч байв. Төмөр өөрийн мэдэлгvй Дулмаа руу ширтэж байхад Дулмаа урт ургасан хяруу тасалж аваад завьжиндаа зууж нууц инээмсэглэл тодорсон нvдээр vl таних хvнийг байн байн харж байв.

- Та яасан айхтар ширтдэг юм бэ?

Төмөрийн нvvр бадайрч цочин нvдээ буруулахад налайн билчиж байгаа хонь нvдэнд нь тусав.

- Хонь чинь сайхан тогтож байна

- Та аль нутгийн хvн бэ?

- Сайд вангийн гэж Төмөр хэсэг тvгдэрсний дараа хариулав. Хvний нутаг, харь газраас адуу хөөгөөд олон хvнд хөөгдөөд явахад нам жим байдаг зvрх нь ер бусаар оволзоод цохилж байлаа.

Дулмаагийн сэтгэл ч гэсэн хэзээ ч учирч байгаагvй хөгжмийн эгшгээр дvvрч, энэ сууж байгаа газраа хичнээн суусан ч уйдаахгvй мэт санагдаж байв.

Цэлмэг өдрийн баруунаа хэлбийсэн нар, гэнэт оволзсон их дурлалын эхний очоор дvvрсэн сэтгэл хоёрт чимэглэсэн ертөнц ер бус гуа vзэсгэлэнтэй ажээ.

- Та маргааш хишигтэй юу?

Маргааш Дулмаагийн ээлж биш. Гэвч Төмөрийн хишигтэй юу гэсэн асуултанд «vгvй» гэж хариулах сэтгэл Дулмаад байсангvй.

- Тийм, хишигтэй

- Yvгээр ирэх vv?

- Ирж ч магад, та энд байх уу?

- Байж ч болно

- Хонины тvрvvч баруун ухаа давахад тvvнийг буцаах болов

- Би буцаагаад ирье

- Миний мориор яв л даа

- Зvгээр. Морь минь модон дотор бий гээд Төмөр алгуур босож гишгэсэн хөл дээрээ биеэ найгуулан тавьж явахад Дулмаа баяр бадарсан нvдээр vдэв.

Дулмаагийн сэтгэлд хуралдсан уяхан аялгуу цацран гарч намуухнаар дуу аялан, хонины зvг давхиж яваа Төмөрөөс нvд салгалгvй ширтэв.

Тэр шөнө Эрдэнийн гэрийн гадна морьтой хvн ирээд орсон нь Төмөр байв. Долгор дэн барьж

цай хоол болов. Ах дvv амьд мэнд уулзсандаа баярлан ярилцахад ахынхаа ганц мориор хөл залгаснаа сонсож Төмөр ихэд гэмшиж, өөрийн аргагvй ядарч явснаа ярихад нь:

- Төмөр минь чи ингэж явсаар нэг мэдэхэд алуулчихсан байна даа гэж Эрдэнэ хэлэв.

- Ах минь би өөрөөр амьдарч чадахгvй. Зvрх минь цохилж байгаа цагт морин дэл дээгvvр давхиж ноёдын сvргээс хөөнө. Yvн шиг жаргал байхгvй гэж Төмөр хэллэв.

- Чи ноёдын сvргээс авдаг гэж байна. Гэтэл над шиг ядарсан хичнээн амьтныг явгалсан бол доо гэж Эрдэнэ зэмлэв

- Ах минь миний хөлжvvлсэн ядуучууд, явгалснаасаа хавьгvй олон, би таньд нэг морины чинь оронд арав, хорин морь авчирч өгнө

Эрдэнэ дvvгээ гомдолтой бөгөөд арга нь барагдсан нvдээр ширтэж, битvv санаа алдав.

- Надад морь хэрэггvй. Би ариун цагаан хөдөлмөрөөр амьдарна.

- Та миний гардаг өндөр уулын оргил дээр нисэж гараад хорвоог харвал их юм бодохсон доо гээд ёжтой инээмсэглэн, огтолж vмхсэн хэсэг махаа шир шир зажлан залгиснаа, та чинь тэгээд хэнийд зарагдаж байна? гэж асуув.

- Луу гvний баян Итгэлтийнд

- Хvv нь Хонгор уу?

- Тийм. Чи таних уу?

- Танихаар барах уу даа. Хонгор хvvгийн ачаар Бадарч тахрын гараас гарсан юмсан. За гайгvй замын хvзvv урт хойно цахиур Төмөр сайн хvний ачийг хариулж ч дөнгөнө байх гэлээ.

Yvр цайхаас өмнө Төмөр мордон явжээ. Өглөө эрт Итгэлт Эрдэнийд орж ирээд «урд шөнө танайд юун хvн ирэв?» гэж асуухад нь Эрдэнэ «vл таних хоноц ирээд эрт явсан» гэж ажиггvй хариулав.

Эрдэнийд хvн ирээд тогоо шанага хангинаж дvнгэр дvнгэр ярьж байхыг сэргэг Итгэлт мэдсэнээр барахгvй сэм очиж гэрийн гаднаас нь чагнаад цахиур Төмөр бол Эрдэнийн дvv, Хонгор нь Төмөрийг оргох гаргахад тусалсан болохоор Төмөр өөрийнд нь гэм хийхгvй харин нэгэн цагт хvvд нь тус болох юм байна гэж мэдээд баярлаж байлаа.

Итгэлт зальтай нvдээр Эрдэнийг ширтэн байж нэг аяга цай уугаад аягаа тавих гэснээ больж vзэх зуур

- Эрдэнэ минь надаас нуугаад яахав. Би бvгдийг мэдсэн. Хоовон хөх vv дээ. айхтар чоно юм даа. Цувыг минь дvvд чинь өгсөн бололтой. Би ч тэр орой нь vгvйлсэн юм. Гэхдээ өөр хvнийг хардаж нvгэл хураасан байна гээд нарийхан дуугаар янцгаалан инээв

- Над шиг цагаач хvнд хэцvv юм байна шvv. Итгэлт минь гээд Эрдэнэ гэмшилтэйгээр инээмсэглэв

- Чи мөн хянамгай хvн юм даа. Миний бодлоор Төмөр муу хvн биш шvv. Танилцах юмсан гээд Эрдэнэ рvv харлаа. Итгэлтийн нvvрэнд vнэн сэтгэл тодорхой байхыг Эрдэнэ олж харлаа.

- Тэнэж яваад ирвэл танилцуулж болох байлгvй дээ гээд тvрийнээсээ мод толгойгоо авч тамхи нэрэв.

- Зvvн аймгийн хурдтай газраас хязалан vрээ авчир азарга тавих юм сан. Төмөрт захивал юу байхав дээ олоод өгнө дөө.

- Хулгайн юм авчирч өгнө шvv дээ

- Сайн эр холоос авдаг болохоороо хэл ул гарахгvй. Бас тэгээд хулгайн юмыг учир мэдэж авдаггvй баян хvн заяа нь орхисон надаас өөр байдаггvй байх аа гээд хөгжилтэй инээв.

Долгортой хамт Дулмаа орж ирээд Долгорт Итгэлтийн бэлэглэсэн алчуурыг гуйн авч толгойгоо боогоод Долгорын хагархай толийг авч харахад нь Дулмаа наадамд явах уу? Гэж

Итгэлт ёжтой хэлэв.

«Гоёж явбал амьтан харж байх болов уу гэж горьдох юм» гээд Дулмаа гарч одлоо.

Хвйтэн зэврүүн салхи Дулмаа Төмөр хоёрын сэтгэл зүрхнийхээ нууцыг задлан ярилцахад саад болсонгвй. Эрдэнийхээс явсны дараа Төмөр энэ нутгаас холдож чадсангвй хэд хонов.

Шөнө нь модонд хонож өдөр нь Дулмаатай уулзаж байв. Амьдралыг жигшин, бүхнийг занасан Дулмаагийн сэтгэл хувиран дөнгөж гарсан намрын хэнз хурганы үс шиг зөөлөн булбарай болсон бол боргилжиж чулуужсан Төмөрийн зүрх баяр догдлолоор дүүрч сэтгэл нь доргиж байгаа чанга татсан утас шиг чичирч байв.

Дулмаагийн зовлонт амьдралын тухай сонсох тусам Төмөрийн сэтгэл уярч хайрлах, өрөвдөх нэгдэн оволзож байсан бол Дулмаа домог шиг юм сонсож гайхан байсан Төмөртэй өөртэй нь одоо зэрэгцэн суугаад янагийн халуун сэтгэлээ нээн ярьж байхад ертөнцийн хамаг сайн сайхан бүхэн жаргалыг нь бүтээх гэж хүч гарган зүтгэж байх шиг бодогдож байлаа.

- Чи намайг одоо аваад яваач дээ.

- Болохгвй яг л ирэх зуны дунд сарын арван наймны сар гарах үед би дөрвөн хос морьтой энд зогсож байна гэж Төмөрийн хэлэхэд бүх насандаа үнэн үг сонсоогвй мэт бодож явдаг Дулмаа гомдолтойгоор «намайг хуураад яана даа» гэлээ.

- Дулмаа минь намайг итгэ. Би хэлсэндээ заавал хүрнэ. Чи л байж байгаарай гээд Төмөр Дулмаагийн гарыг барьж илэв

- Би чамд итгэе гэж үнэн сэтгэлээсээ хичээж байна

- Би хуурахгвй Дулмаа минь

Хвйтэн салхи үлээн хааяа хааяа урсан хаялж дороо хайлж байгаа малгайрсан цас, дүлийрсэн битүү хар үүл хоёр хайрын гал бадарсан тэдний сэтгэлийг яахин нэвтэлж чадах билээ.

Хвйтэн намар өвөрмөц гуа үзэсгэлэнтэй байдаг бөгөөд түүнийг Дулмаа Төмөр хоёр үнэн сэтгэлээсээ ойлгож гандан шарласан мод хатууран халиурсан хялгасан, цасанд хучигдсан уулын орой цөм энэ хоёртой хамт хөгжимдөж байлаа.

## XXII

Цасанд хучигдсан Шар хөвийн хөтөл өөд өгссөн хар замаар морь хониор нь баазалсан тэрэгний урт цуваа аажим бөгөөд ихэмсгээр гарч ирлээ. Суварган эврүүд нь сэлэлзэж энд тэндгвй цэдрийн бүрээ дуугарч байгаа юм шиг хайнагийн уу хүнгэнэлдэн, сүүлчийн тэрэгнээс зүүсэн янз бүрийн хөгтэй гурван хонх аялгуу нийлүүлэн дүнгэнэж хааяа хааяа хүмүүсийн хөөглөх дуу уянгалах нь сүртэй бөгөөд өвөрмөц гуа үзэсгэлэнтэй ажээ.

Энэ бол шар тос, мэхээртэй тос, сарлагийн зузаан өрөм, тос дааварласан зөөлхөн хурууд мэтийн цаган идээ, эсгий, арьс шир тээвэрлэсэн Итгэлтийн жин ажээ. Монголчууд цагаан идээ хийхдээ, дадлагатай бол Тамирынхан бүхнээс гарамгай гэдгийг ярих юу билээ. Энэ учир Сайд вангийнхаас ирсэн цагаан идээ хүрээний зээл дээр үнэтэй байдаг.

Тас хар эвэртэй, цас шиг цагаан хайнаг хөллөсөн түүчаа тэргэн дээр Эрдэнэ тавтай гэгч нь завилан суужээ. Арван хэдэн насандаа Цонж, Бар хөл рүү халх явалтаар аялж, мичид марлаар нойроо хэмжиж явсан тэмээн жинчин Эрдэнэд эхэндээ үхэр тэрэгний жинг газар хороохгвй нүсэр төвөгтэй юм шиг санагдаж байв. Гэвч яваандаа дасаж, ачаа өргөх, буулгах мэтийн хүнд хүчир ажилгвй аятайхан юм шиг болов. Сүүлдээ түүчаа тэрэг хөтлөхдөө сүрхий дадаад энэ замыг хорь гучин удаа туулсан хашир хүмүүс хүртэл магтдаг болжээ.

Эрдэнэ урьд өмнө богдын хүрээ орж байгаагвй боловч хэдэн жилийн өмнө турш зул сар бүхэн энэ замыг туулж сурсан хөвөн цагаан хайнаг замын голын барин жигд бөгөөд намбатай алхана. Шар хөвийн дөрөлж дээр гарч ирэхэд алс тэртээ униартан байгаа хөх манангийн дунд өндөр жанрайсаг дүнхийн харагдаж, дохио өгөөгвй байхад түүчаа хайнаг

шүдээ хавиран зогслоо. Эрдэнэ үсрэн бууж дөрвөн уулын дунд цогцлон боссон ариун сахиусны орон, Богдын хүрээний зүг наминчлав.

Итгэлт дэргэд нь ирж мориноосоо буугаад «богдын хүрээ» гээд гурвантаа мөргөж залбираад хэдэн чулуу авч овоо руу хаян «овооны их танд, олзны их надад, өлийн их танд, өлзийн их надад» гэв. Жинчид дөрөлж дээр гарч ирээд зарим нь сунаж мөргөнө. Зарим нь амандаа бувтнан юм хэлж наминчилна.

-- За би түрүүлбэ. Та нар өнөө орой хамбын овооны хүрд хоноод, өглөө эрт хөдөлнө биз. Би утгуульа гээд Итгэлт мордож «Эрдэнэ минь хүрээний хулгайч хэцүү шүү. Хянамгай хоноорой» гэж хэлснээ эргэж ч харалгүй хатируулан явжээ. Итгэлт жингээсээ хоногийн өмнө урьтаж хот ороод ачаа бараагаа худалдах нүх сүвийг олдгоор барахгүй буцахдаа тээвэрлэх ачаа олж аваад жин тан болгодог заншилтай ажээ. Бас тэгээд жил бүхэн ирдэг болохоор танил тал олонтой. Жингийн цуваа аажим боловч алхах бүр урагшлан ахисаар үдшийн бүрэнхий болоход бууц дээр буужээ.

Эрдэнэ тэр шөнө хоёр хүн манаанд гаргаж тайван сайхан хоноод өглөө нь хайнагуудаа тавин хуурай цахилдагны үзүүр гүйлгэн хазуулаад хөдлөх гэж байтал Итгэлтийн явуулсан тосуул ирлээ. Энэ удаа ч Итгэлт ажлаа бүрэн хоёр гуравхан хоногийн дотор ачиж ирсэн зүйл нь эзнээ олж, Луу гүний хүрээ, хан өндрийн хүрээ хүргэх пүүсний ачаа ачсан урт жин ирсэн замаар сурсан дуугаа дуулан буцав.

Харин Итгэлт дан мориор хөсгөө гүйцэхээр Эрдэнийн хамт хүрээнд ирэв. Урьд өмнө наймаа арилжаа хийхдээ Итгэлт нүдээ эргэлдүүлэн тоо бодож, цаасан дээр элдэв юмсын дүрс зуран хүн амьтны доог болон явдаг байсан бол энэ удаа Эрдэнийг дагуулан зузаан мутуу дэвтэр дээр данс бичүүлэн, шинэ хүрэн сумаа сампин дээр шажигнуулан тоо бодуулж, тэр бүхнийг нь хэзээ ёзооны бичиг мэддэг хүн шиг ширвэн харж байдаг байв. Зарим хүмүүс Итгэлтийг бичиг үсэгтэй болчихож гэж хүртэл жив жув ярилцаж байв. Жин хүрээд орж ирсний маргааш Итгэлт, Эрдэнэ хоёр Далай хятадын пүүсэнд очиж наймаа хийлээ. Гэхдээ Итгэлт эзний байшинд архи амтганаар дайлуулан, Эрдэнэ хашаа дотор Шушмаа гэгч залуу хятадад арьс шир, тоолон өгч байлаа. Шушмаа монгол үгийг гажуу буруу дуудна. Зарим үгийг хэлэхдээ эрүү нь чичрэн нүд нь том бага болно. Амьдралын өргөн хэрэгцээний үг, олны дунд хэлэмгүй үг болон хувирах нь их л инээдэмтэй. Энэ бүхэн бол үнэндээ Шушмаагийн арчаагүй дуудлагын бүтээл биш, харин гэнэн цагаан сэтгэлтэй монголчуудыг зориуд хэлсэн элдэв гашуу буруу үгээр хөгжөөж анхаарлыг нь хоёрдуулж байгаад хэрэгтэй цагт тоо дарах буюу ахиулах, муу эдээ үнэтэй өгөх зэргээр ашиг гаргаж авдаг ганц мэх нь байлаа. Эрдэнийн хувьд гэвэл Шушмаагийн арга огт явцгүй ажээ. Гэхдээ Эрдэнэ уг залиг мэдсэнээс биш, харин «хятадаар ганц үг хэлж чадахгүй намайг бодвол муу муухай ч гэсэн яриад л байна даа» гэж бодоод ихэнх үгүүдийг ажиггүй сонсон, зарим дэндүү буруу хэлснийг нь засаж өгнө. Тэдний хаалгаар Довчин бэйс ёстой л нүдийг нь бүлтэртэл гоёсон залуу эхнэр Гэрэлийнхээ хамт орж ирлээ. Хашаанд юм хийж байгаа Эрдэнэ Шушмаа хоёр бэйс, хатны анхаарлыг өчүүхэн ч татаж чадсангүй. Тэд шууд л пүүсний эзний байшингийн хаалга чиглэн алхаж байлаа. Шушмаа минь ингэж хэлж болохгүй «алаг» гэдэг юм. Эрээн, цоохор олон өнгийн гэж байгаа шүү дээ гэж Эрдэнийн хэлсэн үг яг дэргэдүүр нь өнгөрч байгаа Гэрэлд сонсогдлоо.

«Ямар сайхан дуутай хүн бэ» гэж Гэрэлд бодогдоод эргэж харлаа. Ер бусын зөөлөн бөгөөд нургисан бүдүүн дууны эзэн бол хуучин нэхий дээлтэй, гуалиг биетэй, өтгөн хар хөмсөгтэй эр ажээ. Хүүхний нүд Эрдэнээс хэсэг зуур салж чадсангүй. Пүүсийн байшингийн хаалганд тулж очоод эхнэрээ хоцорсныг мэдсэн Довчин «Эхнээр, ийш ээ орьё» гэхэд нь танихгүй



хүнийг өөрийн эрхгүй ширтэж байснаа мэдсэн бүсгүй царай уласхийн огцом эргэж түргэн түргэн хэд алхав.

Гэвч холдож чадсангүй зогсоод « та орж л бай л даа. Би энэ арьс ширийг үзье» гээд эргэв. Өөрийг нь сэтгэлдээ бодож явдаг гоё сайхан эрчүүд олон байдгийг Гэрэл сайн мэднэ. Тэдний ихэнх нь Довчингийн сүрээс айгаад Гэрэлд халдаж үл чадна. Зарим нь зориг гаргаж халдах гэж оролдсон удаа бий. Гэвч Гэрэлээс алганы амт, гашуун үг хүртээд, сүртэйгээр шуугин ирээд салам цохиулан сүүлээ хавчаад зугтаж байгаа нохой шиг буцдаг байжээ. Довчингийн их нэр, өндөр сүр, баян хөрөнгө, тэр бүхний бүрэн эрхт эзэн болсон Гэрэлийн ихэмсэг, сэтгэл бол энэ бүсгүйг хүрээлсэн бат, өндөр хэрэм байсан бөгөөд түүнийг давж чадсан эр үгүй билээ. Гэрэл эрчүүдийг хараад өөрийн баян чинээлэг гоё ганган, гуа сайхныг бодон бахархдаг. Гэтэл энэ удаа урьд өмнө байгаагүй сэтгэл түүнийг эзэмдэв. Эрдэнийг хараад өөрийн сайн сайхныг мартан бахархаж явдаг зүйл нь эгшнээ алга болж сэтгэл нь хачин өөр, жигтэй тайван дэлгэр болов. Гэрэлийн баян чинээлэг бардам сэтгэл балрах холдох тутам нөгөө хүрээлж байдаг бат өндөр хэрэм сарниж эхлэв. Гэвч Гэрэл түүнийг эхлээд ойлгосонгүй, зөвхөн л Эрдэнийг хараад баймаар байжээ. Бүр сүүлдээ энэ хүнтэй ямар нэгэн чухал юм ярих гэж энд ирсэн мэт бодогдоод, юу ярихаа бодож олох гэж баахан сандрав.

- Нэг арьс ямар үнэтэй байдаг юм бэ?

- Янз бүр л байна даа гээд Эрдэнэ дүрлэгэр нүдээр харахад Гэрэл өөрийн эрхгүй инээмсэглэв. Чухам энэ үедээ Гэрэл өөрийн байдлыг ойлгон жолоогүй болсон сэтгэлээ хямгадан эргэж Довчингийн орсон үүд рүү явлаа. Явж байхад нь араас нь үлэмж их хүч угзран үүдээр орохдоо эргэж харснаар барахгүй, инээмсэглэв. Гэтэл Эрдэнэ огт ажиггүй ажлаа хийж байсан нь Гэрэлийн сэтгэлийг гомдоовч, дахин харахсан, ярихсан гэдэг сэтгэлийг нь улам оргилуулав.

Гэрэлийг байшинд ороход ширээний хоёр талд суусан Довчин Итгэлт хоёр ярьж байлаа.

- Би мөн таны алдрыг сонсож байсан гэж Довчин хэлэв

- Итгэлт бид хоёр хуучин түнш, дөрвөн жил арьс ширний том наймаа хийж байгаа юм даа. Хатуу гартай боловч буянтай хүн гэж Далай хэлээд зальтай нүдээ анийлган хоолойдоо тог тог инээв

- Дөрвөн жил энэ Далайд идүүлж байгаа хүн дээ гээд Итгэлт өргөн тайван бөгөөд дотуур ёжтой инээв

- Хай таньсан хүн яаж тэгж ярьж болно гээд ширээн дээрх хундаганд архи аягалан энэ архи өмнө газрын сайн архи шүү гэв

- Хойт газрын ус гомдолгүй нэмсэн биз дээ? гээд Итгэлт өмнөх хоолноос савхдан идэв

- Бид хоёрт арай ч үгүй байлгүй дээ гэж Довчин бардам бөгөөд ихэмсэг хэлэв

- Тэр ёсоор үнэн. Буянтай хүнийг хуурвал, буян байхгүй болно шүү гэв. Далай хошуугаа цорвойлгон, толгойгоо санжигнуулан үлэмж итгэлтэй хэлэв.

- Зааныг хаяж, заан болдог гэгчээр харин их болох юм биш шүү гэж Итгэлтийн хэлснийг Далай ойлгосонгүй бололтой «тийм ээ, тиймээ» гэж бөхөлзөв.

Гэрэл торго авчруулан үзэв. Гэвч түүний сэтгэлд гадаа ажил хийж байгаа ханхар эрийн дүр улам бүр тодрон ямар ч сонирхол байсангүй. Эхлээд хүүхэн тэр эрийг бодлоосоо зайлуулах гэж хичээсэн боловч чадахгүй ч үгүй гэдэг нь мөч өнгөрөх тутам их болох боловч одоохондоо хараахан бууж өгөхгүй л байлаа. Далай «өмнө газрын мяндас, тусгай нэхсэн хээ, өөр пүүсэнд байхгүй» гэх зэргээр үг шилэн магтавч Гэрэлийн сэтгэлд таарч тохирох торго байсангүй.

-- Шушмаа чи битгий дүрсгүйтээд бай. Хүүхэд боловч үүнийг бодож чадна гээд Эрдэнэ

Шушмааг дагуулан орж ирээд шууд сампин авч цохив. Түүний таван хуруу хөдөлж байх нь үнэхээр бахдам бөгөөд гайхмашиг ажээ.

- Ёстой л Жамъян гүний сампин байна даа. Тэр хурууг нь гэж Довчин мэдэмхийрэн магтана.

- Миний баруун гар даа гэж Итгэлт хөндий дуугаар ам нийлэн онгирон хэлэв.

- Ийм л байна даа. Шушмаа минь гээд Эрдэнэ сампингаа тавив

- Тийм ээ, тиймээ гэж Шушмаа уцаарлангуй хэлэв

- За Эрдэнэ юу болов?

- Өгч аваад гүйцлээ. Харин энэ Шушмаа гурван янчаан хэдэн мөнгө шомбодох гэж байхгүй юу гээд Эрдэнэ инээмсэглэв

- Шушмаа минь хүнээ олсонгүй дээ гэж Итгэлт хэлээд маш баяртай хангалуун тас тас инээв Гэрэл хулгай нүдээр байн байн Эрдэнийг харан, гартаа байгаа торгонд ямар ч анхаарал тавьж чадахгүй ажээ.

- Эхнээр, сэтгэлд чинь тохирох юм байна уу?

- Үүнийг л авдаг юм билүү дээ гээд Гэрэл барьж байгаа торгон дээрээ тогтов.

- Далай, нэг авдар танзуур авна шүү. Авчруул гэж Итгэлт хэлээд Эрдэнэд хандаж

- За наашаа сууж уу ид гэв

- Гэрэл нөхөртөө ойртон сууж Итгэлт, Эрдэнэ хоёрыг гэртээ урь гэж шивэгнэв.

- Та миний өчүүхэн гэрт маргааш орой морилон гийгүүлэх ажаамуу гэхэд нь

- Бас таны баруун гарыг гээд Гэрэл зовомтгой инээмсэглэв

- Бид хоёр маргааш хүрээ Юндэнгийнд уригдсан билээ.

- Биднийг бас урилаа гэсэн биз дээ? гэж Гэрэл огцом бөгөөд баяртай асуув

- Тийм ээ, эхнэрээ

- За тэгвэл маргааш уулзана гэж Довчин хэлээд босов. Довчин эхнэрийн хамт явахдаа «Далай чи энэ торго, бас дөрвөн жин мэглүү, гурван жин уужаанпий, хоёр жин ганзай аваачаад өгөөрэй» гэв.

Тэднийг гарснаас хойш Итгэлт хэсэг зуур дуугүй сууснаа Эрдэнэд хандан «хатны мэлмий чамаас Галсангийн уургын хээр морь хөөж байгаа юм шиг огт салахгүй байхыг ажиг уу?» гэж Далайд ойлгуулахгүй хэмээн түргэн хэлэв.

- Бүү мэд, огт ажигласангүй гэж Эрдэнэ юм идэх зуураа ажиггүй хэлэв.

- Аятайхан согоо байна шүү, дамшиг чинь гээд Итгэлт жоготой бөгөөд гижиг нь хүрсэн бололтой инээв. Нэг авдар танзуур оруулж ирээд тавихад Итгэлт нэгийг авч үзсэнээ «чулуу шиг хатсан золиг шив дээ» гээд Далай руу харав.

- Хатаагүй, тийм ёс хаана байна

- Үзэхгүй юу?

Хятад авч үзээд уг танзуур бол хатсан биш, харин шоюв тосны онцгой чанар гэх зэрэг түмэн юм ярьж тайлбарлах гэсэн боловч түүнийг сонсох хүн, тэр тусмаа үнэмших хүн байсангүй.

- Чи энэ чулуу шиг эдээрээ жинс хийгээд зарвал одоо вед хар ялаа шиг олон болж байгаа ван, бэйл, бэйс, гүнгүүд үнэтэй авах байсан даа гээд Итгэлт ха ха хэмээн их л хөгжилтэй инээхэд Эрдэнэ ч инээв.

Итгэлт танзуурыг хямд үнээр авлаа. Ингээд тэр хоёр явжээ. Маргааш өглөө нь Итгэлт Эрдэнийг дагуулан Богдод мөргөхөөр явав. Тэр хоёр явсаар Богдын гол лавранд очвол өдий төдий мөргөлчин байв.

- Өнөөдөр дээдэс төрийн чухал албатай учраас мутрын адис өгөхгүй. Сунтгаар өгнө. Тавин лангаас дээш жиндаг өргөж мутраас адис хүртэх мөргөлчид маргааш ирцгээ гэж давхар хиазтай улаан торгон дээлтэй бүдүүн тарган мал унжирсан дуугар зарлав.

- Итгэлт гуай та мутраас адис хүртэнэ биз дээ гэж Эрдэнэ шивэгнэн асуухад Итгэлт нүдээ жартайлган лам руу харснаа

- Сүжиглэж чадвал адилхан. Хоёул сунтгаас л хүртэж орхиё гээд хятад янчаан, орос маниад, цаас хагартал нь чихсэн түрийвчээ гаргаж луутай янчаан нэгийг аваад бусдыг нь суга руугаа өвөртлөн гаднаас нь хэд дахин зөөлөн дарлаа.

Эрдэнэ өврөө уудалж Итгэлтийн өгсөн зургаан янчааны нэгийг авч чанга атгаад урагшлав. Сунтгийн үзвүр барьсан хөгшин лам мөнгө, хадаг цуглуулах гуулин цар барьсан залуу ламыг дагуулан гарч ирэхэд мөргөлчид тэр зүг тэмүүлэв. Мань хоёр хэсэг зогсож байснаа урагш чихэлдэн хөдлөв. Итгэлт янчаанаа мөнгө овоолсон царан дээр тавиад, сунтгийн үзвүрээс адис авлаа. Эрдэнэ гартаа атгасан янчаанаа царан дээр тавих гээд алгаа дэлгэтэл гарт нь наалдсан янчаан нь унасангүйд лам өргөл барьцаас нь авчихна гэж сэжиглэсэн бололтой тавгаа түргэн зайлуулав. Гэтэл Эрдэнийн янчаан газар хангинан унахад түмэн нөхөөс болсон уранхай хувцастай, хөө шиг хар царайтай хүүхэн шүүрэн аваад олны дундуур усанд яваа засаг шиг мурилзан алга болжээ. Эрдэнэ өврөөсөө дахин нэг янчаан авч тавган дээр тавихад лам гараас нь салахгүй ширтэж байв. Ингээд тэр хоёр мордоод буцаж явтал өмнө нь явсан хоёр морьтой хүний нэг нь:

- Сунтгийн нөгөө үзвүр Богдын эрх тогорууны хөлөөс уяатай байдаг юм гэдэг үнэн болов уу? Гэхэд нөгөөдөх нь

- Битгий донгос, дээдсийн мутарт байдаг юм гэнэ билээ. Алдас болно гэлээ

- Та үзээгүй шүү дээ гээд нэг нь чанга инээв. Итгэлт энэ бүх яриаг огт сонсоогүй юм шиг хажуу тийшээ алсыг харан явжээ.

- За ингээд Богд гэгээний алтан мутраас арван хоёр дахь удаагаа адис хүртлээ гэж хэлэв. Эрдэнэ ч биелсэн бурхан Богд Жавзандамба хутагтаас адил хүртсэндээ цаглашгүй баярлаж явсан болохоор тэр хоёр хүний яриаг сэтгэлдээ жигшин зэмлэж явлаа. Тэр орой Итгэлт Эрдэнэ хоёр хотын нэртэй баян хүрээ Юндэн гэгч айлд очив. Итгэлтийг зориуд урихдаа Юндэн олон жил наймаа арилжаа хийж танилцсан Луу Гүний баянд гайхуулах гэж хятад тогооч хөлслөн нарийн хоол хийж их л хөл болжээ.

- Эрдэнэ минь хүрээнийхэн айхтар шооч шүү. Нэр бодож юм бүхнийг нь хэзээ ёзооны үзэж мэдсэн юм шиг байна. Миний хэлсэн бүхнийг анхаарч, эрчийг нь чангалж байгаарай гэж замдаа Итгэлт захилаа.

- Тэр Юндэн чинь баян хүн үү? гэж Эрдэнэ сонирхон асуув

- Юу шалих вэ? нэг муу дамын панзчин

Итгэлт өнгөрсөн жил Юндэнтэй танилцан наймаа хийсэн. Гэхдээ түвнийг бусдын гар харж хийсэн эзэн, хэрэглэх хүн хоёрын хооронд зусардан долдойдсон наймаачин гэж үзээд тоогоогүй учраас «нэг муу дамын панзчин» гэсэн Итгэлийн үгэнд нь юм үзсэнээ гайхуулсан өнгө, Юндэн доромжилсон өнгөтэй холилдон гарлаа.

Мань хоёрыг ороход бараг л бүх зочид цуглараад хүлээж байв. Зургаан ханатай гэрт битүү хивс дэвсээд хашин өнгөтэй ширээнүүдийг хоёр талаар нь тавьжээ. Ороход халуун ганзайн хурц үнэр айргийн исгэлэн үнэр, хятад дүнсэн тамхины нялуун үнэр холилдон ханхалж байлаа. Итгэлт хиймэл ихэмсэг байдлаар бүгдтэй мэндэлж, баруун талын эхний суудал дээр суухад өмнө нь хөл хүргэхгүй бөгтөр иргийн ууц тавив. Итгэлтийн доод талд цэргийн яамны түшмэл Чулуун гэгч ширэвгэр хар сахалтай хүн эхнэрийн хамт суужээ. Түвний доод талд зүүн хүрээний лам Аюуш гэгч жин арилжаа хослуулан хийдэг хүн суужээ. Дараа нь Эрдэнэ суужээ. Зүүн талын эхэнд яамны түшмэл Довчин бэйс, түвний доор өндөр биетэй, хурц тод нүдтэй, Даржаа баатар, алтанд дарагдсан Гэрэл нар суужээ. Юуны өмнө танилцаж, тамхи

солилцон цай ууцгаав. Дараа нь архи барьж Итгэлт ууц таллав. Энэ бүхэн нь Итгэлтийн мэдэх юм байсан болохоор ямар ч өөр гаргасангүй.

Гэтэл янз бүрийн хвйтэн зууш, далайн ногоо, дүүнүү, мөөг зэрэг олон хачиртай хуурга, шөл цувран ирлээ. Огтолсон хурууд шиг дөрвөлжин цагаан юмтай таваг хоол өмнө нь тавихад Итгэлт түвнийг ажиглан харснаа «Эрдэнэ нөгөө Бээжингийн өндөр дэнд бид хоёрын иддэг хоол байх аа» гэж асуув.

- Адилхан л юм байна гэж Эрдэнэ инээмсэглэв

Бээжин мээжингүй тэнэчихсэн эд байна гэж гэрийн зээн урам нь хугаран бодов.

- Үүнийг чинь Нанжин хотын зээлийн гуанзанд идсэн байхаа гэж бас нэг хоолыг амсаж үзмэгц Итгэлтийн хэлэхэд Эрдэнэ «тийм байхаа» гэж нам дуугар хариулав. Бас Нанжин орчихсон байх нь гэж бодоод гэрийн эзэнд атаархах сэтгэл төрөв. Удсангүй хүүмүүс сайхан улаан зээрд болж, дуу хуур дараалан ирэхэд «уяхан замбутивийн нар»-ыг Эрдэнэ дөрвөн давхар шуранхайлж байгаад дуулсан чинь бүгд магтан шагшив.

- - Жан мин-гийн лимбэ шиг хоолойтой хүн юм гэж Чулууныг хэлэхэд Итгэлт Жан мин гэж юу байдгийг огт сонсоогүй боловч «яг тийм шүү. Та ёстой нэг онож хэллээ» гээд нарийхан дуугаар инээв.

- Цээлхэн яруу хоолойтой хүн байна гэж Даржаа баатар хэлэв.

Энэ хүн хар цэрэгтэй гарамгай байлдаж баатар цол гүн зэрэг шагнагдаад одоо богдын торгон цэргийн сумангийн даргын албыг хааж байгаа юм. Даржаа баатар байлдаж явснаа ярих дуртай, зай л гарвал «бид Богдын авралаар» гээд эхэлдэг юм.

Бид Богдын авралаар хар цэрэг рүү цавчлаад ороход ёстой л сэлэм гялс, толгой бөндгөс гэж байж билээ. Би буудаад байсан зургаан хар цэрэг рүү дайрч ороод бүгдийг нь хядаад зэр зэвсгийг нь мориндоо ачиж аваад л ирж байсан юм даа. Гурван улсын гэрээ байгуулагдаагүй бол бид Богдын авралаар өдийд өвөр монголыг өнгөрөөд, хэрмийн цаана цавчилдаж байх юмсан гэж Даржаагийн хэлэхэд Довчин үлэмж хөгжүүн инээмсэглэснээ:

- Дэмий юм ярих тусгүй. Гэрээ байгуулаагүй бол баатар цагаан хаан бидэнд зэвсэг өгөхөө болиод, бид дарагдаж улс гэр сөнөхөд хүрнэ гэлээ

- Тийм биш. Бидний бичиг цэргийн түшмэдийн олонхи нь тэгж бодохгүй байгаа. Та нар бод, бидний монгол олон аймаг бүгдээрээ нэгдэж бүрэн эрх бүхий улс төрийг байгуулан тогтоож эд хөрөнгө хүчин чадал хүрэлцэхгүй гачигдан дутагдаж мохсон зүйл огтгүй, харин хар цэрэгтэй эсэргүүцэн тулж хүчирхэн дийлж харьяат газар орныг бүрэн хамгаалж чадсаар байна. Гэтэл нэгэн угсаа төрлийн өвөр монгол орон чуулган хошууг гадаад улсын харьяат аймаг муж, албат боол болгон өгч яаж болох билээ гэж Чулуун хэлэв.

- Чухам үнэн. Өвгөд дээдсийн онгон нутгийг хүний газар гэсэн булай бичигт гарын үсэг зурсан хүн бол өчүүхэн хэргэмээс үе улирах нэрээ худалдсан дамшиг гэж Даржаа баатар хорсолтой хэлэв.

- Та нар төрийн бодлогын нарийн учрыг мэдэхгүй байна. Гэрээ байгуулах нь түмэн зөв гэж дээдэс болгоон таалсан юм шүү. Та нарт дээдсийг шүүмжлэн хэлэлцэх ёс байхгүй гэж Довчин ширэв татав.

- Та нар шиг өнөөдрийн өөхнөөс улс төрийг худалдахаас буцахгүй амьтад л дээдсийн толгойг эргүүлж байгаад тэр новшийн гэрээг байгуулж, түмэн балаг тарьсан хэрэг гэж Даржаа баатар хэлээд Довчин руу ганц хуруугаар чичин дайрав.

- Даржаа чи өчүүхэн гавьяандаа эрдээд дэндэж байна. Эртэн баатар ган жадаар дийлээгүй юмыг эрдэмтэй мэргэд хулсан бийрээр дийлнэ гэсэн үг юм шүү гэж Довчин хэдэн жилийн өмнө цахар хуурчаас сонссон үгээ хэлж орхив.

- Муу сайн төрийн худалдаачин гэж хашгираад сүрхий согтсон Даржаа нударгаа шамлав  
- Төрийн төлөө оготно гэж та нар яах нь вэ. За одоо дуу барьцгаая гээд Гэрэл хөгжилтэй инээснээ Эрдэнийн дууг сонсмоор байна гэж Эрдэнэ рүү харан урт соромсогтой нүдээ цавчлав.

Довчин Даржаа хоёрын хэрүүл зогсож Эрдэнэ өвгөн шувуу гэдэг дууг дуулав. Дахин нэг таваг хоол авчирч өгөхөд Итгэлт амсаж үзсэнээ «Эрдэнэ, нөгөө Чинан хотын их асарт идсэн хоол мөн байна» гэлээ. Энэ Итгэлт саяхан баяжсан юм гэдэг. Лав намайг давж байх шиг. Хэдийдээ ийм их газар явав гэж дээ. Юу ч гэсэн сорьж үзье гэж бодоод гэрийн эзэн гарлаа. Гэрэл гуйж Эрдэнийг дуулуулсан нь зөвхөн түүний сайхан хоолойг сонсьё гэсэн хүсэл биш билээ. Энэ бүдүүн гээгтэй өтгөн хөмсөг өргөн магнайтай бор хар хүн нүдэнд нь туссанаас хойш өдрийн бодол шөнийн зүүд нь болжээ. Эхнэр хүний хүнд чимэглэл найранд удаан суухад хамгийн адгийн там байдаг. Гэтэл өнөөдөр Гэрэлд тийм биш байв. Эрдэнийг харах бүр шинэ шинэ гоё зүйл нүдэнд нь тусах ажээ.

Гэрэл босож Эрдэнийн дэргэд ирж суугаад «та дуул л даа, гайгвй шүү дээ» гэж шалсаар байгаад дахин хоёр дуу дуулуулав.

- Би сүрхий согтлоо. Бас толгой баахан өвдөж байна гээд Гэрэл босов.

- Би хамт явъя гээд Довчин босов

- Чи сууж бай гээд Довчинг хүйтэн нүдээр ширэвснээ Эрдэнэд хандаж

- Та намайг салхинд гаргаад өгөөч гэж нүдээрээ тоглон инээмсэглэн хэлэв.

«чи сууж бай» гэж Довчинд хэлэхэд Гэрэлийг харсан хүн барс шиг догшин хүүхэн бололтой гэж бодож байсан бол «та намайг салхинд гаргаад өгөөч» гэж Эрдэнээс гуйхад нь Гэрэлийн нүүрэнд эмэгтэй хүний арчаагвй зөөлөн сэтгэл тодорч байлаа. Эрдэнэ яахаа мэдэхгвй гайхан байтал Итгэлт нүдээрээ гарах дохио өгөв. Залуу эхнэрийнхээ хэлснийг тэнгэрийн зарлиг гэж боддог Довчин ч эхнэрийг нь салхинд гаргаж өгөхийг хүсэв.

Эрдэнэ дуугвй босоод гарахад Гэрэл хүүхэн дагаж гарлаа.

- Сайхан шөнө өө гэж Гэрэл хэлээд Эрдэнэ өөд харлаа

- Утаа нь хамар хорсгоод олигтой юм алга

- Тэр ч тэнгэрийн буруу биш. Хүрээний буруу шүү дээ гээд Гэрэл инээв.

Ямар айтгар үгтэй хүүхэн бэ. Цэц булаалдах юм бол би савыг чинь хоосон буцаахгвй шүү гэж Эрдэнэ бодоод ёжтой инээмсэглэснээ «таныг утаан дээр нь сууж байгаад шөнийг нь гайхаж байгааг мэдсэнгвй» гэлээ. Гэрэл ойртож очоод зогсоход нь Эрдэнэ үл мэдэг зайлав.

- Толгой эргээд байна. Би бусад хүнтэй адил хүн хаздаггвй. Битгий ай гээд Гэрэл найган Эрдэнээс түвшин авлаа.

Ямар галзуу хүүхэн бэ. Аль ийм их согтсон юм уу гэж Эрдэнэ бодов. Гэрэл толгойнхоо хэрэглэлээр Эрдэнийг улам шахан налав.

- Та их согтож шүү

- Би их согтож гэж үү. Хацраас минь гал бутраад байна. Та бариад үз л дээ

- Зүгээр, зүгээр

- Гар чинь хүйтэн байх бариад өгөөч гэж Гэрэлийг хэлэхэд түүний дуунд үнэн сэтгэлийн арчаагвй гуйлтын өнгө ил байв.

Эрдэнэ өөрөө бүрэн ухамсаргвй бөгөөд эрс цочмоогоор Гэрэлийн хацрыг барилаа. Гэрэлийн сэтгэл дуулж, тэр аялгуу нь нүүрэнд нь бадран баяртаа согтуурч байлаа. Гэрэл угаас архи уудаггвй боловч өнөө орой хоёр хундага архи ууж үнэхээр ч сүрхий согтжээ. Эрдэнийн гар хацар дээр нь байхад чанга ч амьсгалж чадахгвй байв. Ингээд хэдэн жил ч зогсож болмоор санагдаж байтал гар хацраас нь салахад урт гэгчийн санаа алдав.

- За орьё гэж Эрдэнэ огцом хөндий дуугаар хэлэхэд Гэрэл толгой сэгсрэв. Гэрэл эмэгтэй хүний хийж чадах бүхнийг хир хэмжээнээс нь хэтрүүлж байгаад хийсэн билээ. Гэвч Эрдэнийн хатуу хатан сэтгэлийг эвдэж зүрхэнд нь орж чадсангүйдээ дахиад яахаа ч мэдэхгүй дэмий л газар шагайн санаа алдав. Энэ вед галын гэрээс гэрийн эзний ярих дуу сонсогдов.

- Тэр уушгинаас хүртэл хийж орхи. Тэгээд хаа идсэн гэж залахыг нь сонсьё гээд инээхэд «болно болно» гэж муу монгол хэлтэй хятад хүн хариулав. Эрдэнэ энэ үгийг тодорхой сонсож бүх учрыг мэдлээ. Харин Гэрэлийн чихэнд хэдгэний дуу шиг дүнгэнэн сонсогджээ.

- Орьё гээд Эрдэнэ гэрийн зүг явахад Гэрэл хойноос нь санаа алдан гомдолтой харсаар гэлдрэв. Эрдэнэ Гэрэл хоёрыг орсноос хойш удсан ч үгүй шинэ хоол ирлээ.

- Энэ хоолыг манжийн хаан их таалж байсан гэдэг. Энэ бол гойд амттай юм шиг санагддаг. Бодвол нөгөө үхэр, чихрийн амт, мэддэггүй гэдэг болж байгаа хэрэг байх даа гэж гэрийн эзэн хэлээд хошуугаа мурилзуулан инээж Итгэлт өөд харлаа. Түүний зальтай бөгөөд дээрэнгүй нүдэнд «одоо юу гэж галладаг бол, гууль чинь цухуйх цаг болсон» гэсэн шоолол доромжлолын тодорхой туяа багтан ядан байгааг Эрдэнэ харжээ. Итгэлт ихэмсгээр савх авч хоолноос амандаа хийж удаан зажилснаа «Бээжингийн Буянтын пүүсэнд идсэн хоол шив дээ» гээд Эрдэнэ рүү харлаа. Юндэнгийн хөх инээд хүрч, эхнэр рүү хараад «Итгэлт ч олон газар явсан хүн юм аа» гэлээ.

-- Итгэлтээ чи согтоод андуурч байна. Чи бид хоёр огт идэж үзээгүй хоол байна гэж Эрдэнийн хэлэхэд Итгэлт зарц руугаа гайхан харлаа. Итгэлт хэрэг биш болоод давслалт нь хэтэрснийг Эрдэнийн харцнаас олж харснаа барахгүй гэрийн эзэн өөрийг нь урхидан аваад бахархан баярлаж байгааг мэджээ.

- Нээрэн тийм бололтой. Согтож орхиод алт, гууль хоёрыг ялгахаа больж байна гэлээ.

- Манжийн хааны л дуртай хоол гэдэг юм гэж гэрийн эзэн давтан хэлэв.

- Хятад тогооч гэнэн хүнийг юугаар ч хуурч чадна гэж Эрдэнэ хэлээд өмнөх тавагтай хоолыг түлхэж орхив. Гэрийн эзний урам нь хугарснаар барахгүй царай нь улайв. Энэ бүхнийг хараад Итгэлт учрыг нь бүрэн ойлгож ухаантай сэргэлэн зарцдаа бахархаж тэсгэлгүй баярлав. Тэгээд давалтаа улам давсалж, амттай болгох гэж «тэр тогооч олон хоол хийдэг хүн болох гэж л таныг давж орхисон бололтой» гээд савхаа ширээн дээр тавьжээ.

Хага базуулсан Юндэн хариу юу ч дуугарч чадсангүй минчийтэл улайгаад, хоолойнхоо товчийг тайлав. Гэрийн дотор хэсэг зуур нам гүн болов. Энэ нам гүмийн дотор Итгэлт шиг баярласан, Гэрэл шиг гомдсон, Даржаа шиг уурласан, гэрийн эзэн шиг ичсэн хүн байсангүй.

-- Ер нь та нар олон аавын хүү цус урсгаж баймааж байгуулсан улстөрийг минь худалдаж орхиод гэмгүй хүн шиг гэлбэлзэж байна гэнээ гэж Даржаа бүдүүн боргил дуугаар гэнэт хашгирав.

-- Мэргэдийн явдлыг мэргэд хэлэлцэнэ. Бид бичиг цэргийн түшмэд, амьтныг жаргуулавч бурхны хувилгаан, түмэн наст богд Жавзандамба нэгэнт хамт шийдсэн хэргийг гэж Довчин хүйтэн бөгөөд тайван дуугаар хэлтэл тэвчээр нь барагдсан Даржаа «дуугаа аяд. Бүү донгос» гээд царай нь хүрэн болон босов. Хэрэв гаднаас Богдын шадар сойвон Данигай орж ирээгүй бол Даржаа баатар Дувчинг салам болтол нүдэж орхих байсан нь дамжиггүй.

- Дээдэс өнөөдөр ширнэн жонон вантай сархад зооглож, би ч бас хамт суусаар оройтож орхилоо гээд сойвон бүгдтэй ихэмсгээр мэндлээд суув.

- Төрийн чухал албатай гэсэн биш билvv гэж Эрдэнийн дотор санагдаад сунтгаас адис авсан нь бодогдов.

Сойвон архи уух зуур дээдэс, тэр ноёныг хатнаа соль, тэр ванд тvvний хvvхдийг авч өг, тэр гvнг тvvнийг хатнаа болгож ав, гэж зарлиг болсон, тvvнд тийм зэрэг шагнасан гээд л богдын ордонд болсон сvvлийн шинэ сониныг ярилаа. Шөнө орой болсон хойно Итгэлт Эрдэнэ хоёрыг явахад Гэрэл нөхрийнхөө чихэнд vг хэлэв.

- Та хоёр маргааш манай гэрт гийгvvлэн очихыг урьж байна гэж Довчин худал инээн хэлэв.

- Бид өглөө эрт буцах болохоор энэ удаа чадахгvй болох байх. Гэвч уулзах удаа нэг биш гэж би итгэж байна гэж Итгэл бөхөлзөн дохилзон хэлэв.

Арга нь барагдсан Гэрэлийн нvдэнд нулимс бүрхэн хоцров. Гэрэлийн сэтгэлд арван тавны сар шиг тодорсон Эрдэнэ од шиг харваад өнгөрсөнд дотор нь хар манагаар бүрхэгдсэн нvдэндээ харагдсан бүхнийг ялангуяа Довчинг vнсэн товрог болгосоор санагдаж байв.

Эрдэнэ энэ хvvхний өдрийн бодол, шөнийг зvvдийг эзэлж, хорвоо дээр Эрдэнэ гэдэг хvн байгаа шvv дээ гэж бодон сэтгэлээ баясгаж байв. Гэвч хэдхэн сарын дараа Эрдэнэ өөрөө хvрээд ирэхийг Гэрэл хvvхэн яаж мэдэх билээ. Замдаа Итгэл Эрдэнэд хотын онгиргоон баяныг чадсандаа бахархан яриад «чамгvй бол ч нуруугаа тавиулах байсан шvv сvрхий дамшиг юм даа» гэж хэлжээ.

Гурав улсын гэрээний тухайд бол энэ хоёрын санал зөрж байв. Юу ч гэсэн энэ гэрээ хятадаас холдож, оростой ойртоход тус болно гэж Итгэлт vзэж байсан бол Эрдэнийн сэтгэлд «танай улс чинь улс биш. Цагаан хаан танайд тоглоомын улс байгуулаад, одоо тvvнээ хятадтай хуваан идэх гэж байна» гэж хэлсэн алиа Петрийн vг санагдан гурван улсын гэрээ бол монголыг хуваах гэсэн хар бодлын баталгаа гэж боджээ.

### XXIII

Гудамжны захаар барахгvй дуганы vүдний чулуун шал, паалан дээврийн завсраар лууль цухуйж хааяагvй хавар довтлон ирлээ. Бvх ертөнцийг өөрчлөн шинэчилж чадсан хавар Бат, Хонгор хоёрын амьдралд шинэ зvйл өгч чадсангvй. Хэмжээтэй хоол цай, бvдэг дэнгийн гэрэл, унших ном тvлээ хөрөөдөж хагалах ажил, өдрийн хурал цөм л нэг хөг хэмжээгээр vргэлжлэн байв. Гэвч ламын шавь нар сvv тараг авчирч өгөвч тvvнээс мань хоёрт ховорхон олддог байв.

Харин Цамбынд буюу Чимэг хvvхнийд хувин хувингаар зөөж өгөх ажил хоёр хvvхдэд нэмэгджээ. Хоёр хvvхдийн аль нь ч Цамбынд очих дургvй. Учир нь юу ч өгөхгvйгээс гадна элдвээр оролддог. Нэг удаа Хонгор хувин тараг сvv, тавагтай өрөм аваачиж өгөхөд Цамба нэг ламтай шатар тоглож байснаа болиод очсон юмыг нь амтархан идэх зуур «чи цавын будаа идэх vv, цавуутай толгой тэврэх vv?» гэж асуув. Учир нь олохгvй асуултанд зэvv нь хvрсэн Хонгор эгдvvтэй дуугаар «мэдэхгvй» гэлээ.

Цамба зангидсан гарын хиртэй мөсөн чихэр гаргаж «чамайг хариулбал vвнийг өгнө» гэхэд нь Хонгор бvх юмыг мартаж «цавуутай толгой тэврэнэ» гэсэн чинь хоёр лам учир тоймгvй хөхөрч байснаа «цавуутай толгой тэврэх хэрэгслийг нь vзье» гэж хэлээд барьж авч баахан доромжлоод жижигхэн мөсөн чихэр өгөв. Хонгор чихрийг нь шидэж «та нараас заавал хонзонгоо авна даа» гээд гvйн гарчээ. Гэртээ ирээд бvх доромжлуулснаа Батад уйлан ярьж «Цамбаас өшөөгөө заавал авна» гэж шvдээн зуун хэлжээ.

Харин хоёр хvvхдийн хэн нь ч гэсэн Чимэгийнд юм хvргэх өгөхдөө баярладаг байлаа. Хоёр хvvхэн хvvхдvvдийг өхөөрдөж чихэр боов өгдөг. Нутаг орон төрөл төрөгсдийн нь тухай яриулдаг. Урагдсан хагарсныг нь оёж нөхөж өгдөг байв. Хоёр хvvхдээр vлгэр яриулж, хамтран шагай тоглож байгаад явахад нь багш «хангинавал намайг ажил хийлгэсэн гэж

хэлээрэй» гэж Чимэг хэлдэг байв.

Ялангуяа Цэцэг хvvхдvvдтэй шагай тоглож, оньсого таалцахдаа их дуртай бөгөөд ингэж байхдаа хорвоогийн гутамшигт амьдралыг мартаж, сэтгэл нь сэргэдэг байв. Багш лам нь Чимэгийн очдог, эсэхий хоёр хvvхэд мэддэггүй байв. Гэхдээ багш нь шавь нарынхаа өгсөн сvv, тараг, тос махнаас эхлээд торго дурдан, мөнгө янчаанаа хайр найргүй өгдгийг бvрэн мэддэг байв.

- Яагаад багш танд ингэж юмаа харамнахгүй өгдөг юм бэ? гэж Хонгор нэгэн өдөр асуухад Чимэг инээмсэглэх мэт болоод Хонгорын толгойг илж «миний багш юм» гэж хариулав.

- Багш бид хоёрт юу ч өгдөггүй шvv дээ гэж Бат хэлэв

- Аавын өгсөн хоолыг ч өгдөггүй гэж Хонгор гомдолтойгоор нэмж хэлэв

Нэгэн удаа хоёр хvvхэд Чимэгийн хонины мах авчирч өгөхөд тэнд Тvгжилтэй дайралдав.

- Тvгжил чи баярхаад л байдаг. Энэ хоёр хvvхэд танзуурын мөнгө өг л дөө гэж Цэцэг хэлэв.

- Шалдан банди нарт юм өгөөд яадаг юм

- Бид хоёр шалдан банди юмуу? гэж Хонгор хашгирав

- Омогтой зулбасга вэ? дэмийртэл чинь алгадаж орхино шvv

- Ах нь мөнгөө харамнахдаа тэгж байгаа юм гээд Чимэгийг тас тас инээхэд Цэцэг ч хөгжилтэй инээв

- Бид хоёр vнээс гуйх биш дээ гээд Хонгорыг гарахад Бат дагаж гарлаа

- Энэ цор цор гээд байгаа банди чинь юун банди вэ? гэж Тvгжил ихэмсэг дуугаар тоомжиргүй асуув.

- Луу Гvний баян Итгэлтийн хvv. Үнэндээ ч чамаас гуйхгүй хvн гэж Чимэг, Тvгжилийг доромжилсон дуугаар хэлэв. Зуны дунд сарын эхээр Эрдэнэ хоёр морь хөтлөн ирж хvvхдvvдийг хөдөөлvvлэхээр авч явах гэлээ.

- Нэгэнт л номын хvрд эргvvлэх гэсэн хойно, гурван жилийн дотор хvрээнээс гаргахгүй гэж багш нь хэлээд хоёр хvvхэд дагаж уйлж унжин Эрдэнэ урамгүй буцжээ.

Харин багш нь өөрөө хөдөөлөх гээд сар гаруй явжээ. Хоёр хvvхэд хэмжиж өгсөн юмыг нь хэдхэн өдрийн дотор идээд Чимэгийн хоолыг бууддаг болов. Бас багшийн хамаг юм байдаг байшингийн цонхыг эвдэн орж, тоолж орхисон дугуйн нь захыг өдөржин мэрдэг байв.

Борцноос нь хэдэн гозгорыг авч чанан иджээ. Нэг мэдэхэд багш ирэх болж, мэрсэн дугуй, авсан борцоо яаж аргалах тухай бодолд орлоо.

- Хэдэн хулгана алж, авдар дотор хийе. Боовыг нь хулгана л мэрсэн биз гэж Хонгор баяртай хэлэв.

- Догь арга, бvр баастай нь хийнэ шvv. Харин борцыг нь яах вэ?

- Тэр амархан. Томыг нь зvсэж хуваагаад тоогий нь гvйцээж орхиё. Тэгвэл багш мэдэхгүй.

Хоёр хvvхэд олсон аргадаа баярлаж, хэдэн хулгана алж, бас нилээд баас цуглуулан боовны авдарт хийв. Хэдэн том борцыг нь хувааж тоог гvйцээв.

- Одоо ч дажгүй гэж сэтгэл амран хөгжилдөв. Гэвч багш нь гэнэн хоёр хvvхэд хуурагдах хvн биш шvv дээ. Нэг өглөө тоглож байтал vд нь дуугарч Зая гэгээн орж ирлээ. Хиазтай захтай цоо шинэ улаан торгон дээлтэй монхор цагаан тэр хvvхэд мань хоёртой чулуу овоолон харваж эхлэв.

Зая гэгээн мань хоёроос хэд ах боловч чадал хvч дорой, бие бялдар бага байв. Гэвч тvvний яриа нь гэнэн хоёр хvvхэд ихэд гайхагдав.

- Та хоёр цавын будаа идэх vv, цавуутай толгой тэврэх vv гэж гэгээн ихэмсэг бөгөөд мэдэмхий асуухад Хонгор инээмсэглэв.

Хонгорын сэтгэлд Цамбын асуусан vг,, өөрийн хариул, доромжлуулсан зэрэг нь бодогдов.



- Юу гэж байгаа юм бэ? гэж Бат сонирхон асуув

- Мэдэхгүй гэж үү гээд Зая нялхаараа байгаа хоёр жаалыг шоолж инээв.

- Цавын будаа иднэ гэдэг чинь лам болно гэсэн үг. Цавуутай толгой тэвэрнэ гэвэл эхнэр авна гэсэн үг гэж гэгээн их л мэдэмхий хэлжээ.

Үнэхээр ч гэгээн үлэмж юм мэддэг ажээ. Лам нарын банди шуумрын ёс, авгай хvvхний явдлын нарийн нууц зvйлийг ярьж өгөхөд Хонгор Бат хоёр нvдээ бvлтгийлгэн сонсоод багш нь Цамбатай яаж байдгийг хариу сонин болгон ярив.

- Цамбыг зvгээр банди гэж манай хамба ярьдаг юм. Ер нь сайн банди чинь есөн шуумагтай байдаг. Манай хамба Цамбын ёнзон, танай багш жандаг, Жамц бороохой шуумар юм гэж гэгээн ярив.

- Ёнзон жандаг бороохой гэдэг чинь юу гэсэн үг вэ? гэж Бат сонирхон асууж гэгээнд бас л шоолуулав.

- Ёнзон гэдэг чинь багш, жандаг гэдэг чинь юм өгдөг, бороохой гэдэг чинь зодож, дарлаж байдаг гэсэн үг гээд гэгээн үгээ тасалж хэсэг дуугvй болсноо vргэлжлvүлэн

- Би удахгvй бандитай болно. Бас эхнэр авна гэж ярьжээ.

Дараа нь Бат Хонгор хоёрыг дагуулан гэртээ очив. Хоёр давхар хашааны арын хашааны хойт захад өндөр шалан дээр барьсан шар халзан гэрт ороход нандин хvрэн хvж, хангайн нурууны арцны vнэр хамар дvүрэн ханхлав. Гэрийн хойт хагасыг эзэлсэн vй олон бурхны өмнөх алтан хээтэй ширээн дээр алтан мөнгөн цөгц, завьяа нь тооноор орсон нарны гэрэлд гялалзан тоглож байв. Энэ бvхэн гялбасан хоёр хvүхдэд vл харагдах цагийн жигд цохилт нь зvрхний цохилт мэт сонсогдож бvхнийг амьтай юм шиг болгожээ.

Хvүхдvүд босго алхмагц гөлрөн зогсов. Тэдэнд хөдлөх ч чадал байсангvй.

- Энэ хоёр жаал юу хийж яваа золиг вэ. гар зайл гэж ард нь хашгирахад мань хоёр цочин эргэж харвал нөгөө торлогддог лам зогсож байв.

- Би авчирсан юм. Гэвш бушуу зоог авчир гэж гэгээн зандрав

- Гэгээнтэн минь энэ хогийн хvүхдvүд дээдсийг уруу татна. Бушуу гэтэл гэгээний шидсэн аяганы тавиур халзан магнай дээр нь буув.

Лам гvйн эргэж гарахад гэгээн баруун талын орон дээр всрэн суугаад элгээ хөштөл инээв. Мань хоёр тэссэнгvй инээв. Удсан ч үгvй лойм пvнтvүзтэй шөл, бууз, шар тостой бэрээсий ирэхэд хоёр жаал амаа олохгvй идэв.

Гэгээний багш ирж гэгээнийг зодоод, мань хоёрыг хөөжээ. Гэвч сайхан хоол идэж гэдэс цадаад, харж vзээгvй юм vзэж сэтгэл нь баяссан хоёр инээлдэн явсаар гэртээ ирвэл багш нь ирээд гэр хашаагий нь эзэнгvй хаяад тэнvүчлэн алга болсон хоёр гайхлыг нойтон торлогоор нvдэв.

Нуруугаа улаан гувруу болгуулсан хоёр нvдэндээ нулимстайгаар тvлээ хөрөөдөж, цай чанаад гvйцтэл хаалганы хонх хvн ирснийг мэдэгдлээ. Харвал дэлийг нь сумалж зассан өндөр бор морь хөтлөөд Цамба орж ирлээ. Цамбыг хараад багш ламын ширvүн нvд зөөлөрч зан нь сайжрав.

- За та хоёр явж байгаад бvрэнхий болохоор ирж хэмжиж өгсөн номоо шvүлэг гэж багшийнхаа хэлэхэд гинжнээсээ мултарсан нохой шиг хоёр хvүхэд гарч одлоо.

Их хаалганы төмрөөс уяатай сайхан бор морь толгойгоороо тоглон зогсоно. Эмээлий нь мөнгөн хяр, том баавар жаргаж байгаа нарны гэрэлд гялалзан хvрэн нанжин гахай гөлөм дээр туссан нарны туяа харин цацрана.

Хонгор морь руу харж юм бодон тvр зогссоноо эргэж хашааны ёроолд нуун хадгалж байдаг хутгаа авчраад эмээлий нь хойт жирмийн угсаргааг дутуу огтолж тасрах болгоод «чи ингээд

хүний хамаг юмыг үзэж байгаарай» гэж шивэгнээд гарлаа. Намрын өдөр шар нар жигнэн, гудамжны захаар цагариглан хэвтсэн хүрээний ноход хөдлөх ч үгвй ажээ. Шивтэр үнэртсэн агаар хамар хорсгоно. Тэр хоёр ярилцан явсаар гудамжны үзүүрт гарч ирэхэд баруун хойт амаас үлээсэн цэвэр салхи цээж дүүрч бие нь хөнгөрөх шиг болов.

Хаачихаа ярилцаж байтал дөрвөн банди хүрч ирлээ. Хонзонгвй зөрөх үү гээд Хонгор ханхалзан очив. Энэ хооронд мань хоёр зодоонд овоо болжээ. Ялангуяа Хонгор «далиу Хонгор» гэж нэр аваад Заяын хүрээний вейн хүүхдүүдийн дотор чадвартай зодоочдын нэг болжээ. Дөрвөн банди хөдөлж өгсөнгвй. Мань хоёр элдвээр доромжлон өдөөд болохгвй болохоор нь «та дөрвүүл, бид хоёртой үз л дээ» гэж баймааж арай гэж зодоон эхлэв. Төдий л удалгвй хоёрыгоо тагнуулсан банди нар хулчийж зайлахад нь мань хоёр ялсан баярт сэтгэл нь хөдлөн болсон явдлын тухай ярьсаар жижигхэн голын дэргэд ирж тоглов.

Маргааш нь хуралд хуралдаад ирэхэд багш нь угтаж гараад хоёулангй нь чихдэж байшинд оруулав.

- Нэг борц яагаад илүү болсон бэ?

- Мэдэхгвй

- Боов хэн мэрсэн бэ?

- Мэдэхгвй. Хулгана л мэрсэн байх

- Тийм бий. Ийм шүдтэй хулгана бас байдаг аа гээд нүдэж гарснаар барахгвй хоёуланг нь чармай нүцэглэж хашааны хаалганаас уяв.

Өнгөрсөн хүн бүхэн тэднийг шоолж мань хоёр уйлж ч чадахгвй дэмий л нүүрээ буруулан зогсож байв. Гэтэл нэг лам аахилан гвйж ирээд «Цамба өчигдөр орой эмээл нь холбирч мориндоо чирэгдээд их муу байна» гэхэд багш нь сандран алга болов.

Цамбыг чадсандаа баярлавч хэзээ болтол ингэж хаалганы модноос нүцгэн уяатай байх вэ гэж бодоход хорвоогийн хамаг зовлонгоор үүнээ солиход бэлхэн байв. Гэтэл мань хоёрын аз болж Зая гэгээн тааралдаж хүлгийг нь тайлж сулласнаар барахгвй «эд нарыг битгий зод» гэж багшид нь хэлүүлжээ.

Гэвч багш нь удалгвй гэгээний зарлигийг мартаж, зодох бүхэндээ борц, боовны хэргийг дурьдаж байв. Өвлийн эхэн сарын нэгэн өдөр сүрхий их зодоход нь мань хоёр гэртээ оргож харихаар шийдэж дараагийн шөнө нь Булган уулын зүүн сугаар даван гвйв.

Тэд хоёр дахь өдрөө гэртээ харив. Хоёр эцэг нь дотроо хүүхдүүдээ өрөвдөвч гаднаа бурхны оронгоос оргож ирсэн хоёр гайхлыг байцаан зэмлэв. Ингээд яах тухай ярьж байтал багшийн явуулсан морьтой лам ирж мань хоёрыг буцаан хүргүүлэв.

## XXIV

Итгэлт сүүлийн вед баярхаж, жилд хоёр удаа жасаа уншуулан, их найр хийдэг болжээ.

Өнөөдөр хаврын жасаа дуусаж найр нь эхэлжээ. Итгэлтийн хот үлэмж хөл вймээнтэй ажээ.

Их гэрийн хоймор луутай хятад вааранд хийсэн архинд мөнгөн халбага дүрэн сөгнөжээ.

Гэрийн хоёр талаар суман ширээ нийлүүлэн засаж дээр нь мөнгөн хээтэй зэс царанд улаан чавга, чихэр, танзуур овоолон тавьжээ. Ширээний араар орос улаан цэмбэн бүрээстэй журам хоёр үе болгон дэвсжээ.

Цоо шинэ хөх дээлтэй Дулмаа цагаан шүдээ яралзуулан инээмсэглэж орж ирсэн хүнд «би сайхан хүүхэн шүү» гэсэн янзтай нүдээ эргэлдүүлж дараа нь сөн түшсэн Нямаагаас мөнгөн аяганд хийсэн архийг авч «та тогтоож орхино уу» гэж хэлээд бусдад дамжуулан нүдээ цавчлан тоглуулж инээмсэглэнэ. Харин Должин хүмүүст таваг тавин, хүүхэд багачуудад танзуур боов атган түгээж байв.

Орсон хүн бүхэн Итгэлтийн нүнжигтэй, баян тарганыг магтан шагшиж, ам булаалдан

ярилцана. Гэхдээ ингэх баярхахын тулд Итгэлт хүрээний дэлгүүрүүдээс хатсан танзуур, шороотой чихэр, лүү нь цоорч дотор нь оготно үхсэн архийг хямд үнээр цуглуулж ирснийг хэн мэдэх билээ. Зах нь задгай хөх одончуу дээлтэй Итгэлт гэрийн хоймор завилан сууж «ууцгаа, идэцгээ, ах дүү нар та бүхэнтэй хуваан идэж сурсан хүн. Хамжлага нараа морь илжиг мэт зүтгүүлэхээ мэдэвч, хар ус өгөхөө мэддэггүй Пүрэв тайж шиг хүн биш. Ууцгаа, идэцгээ, Дулмаа Должин та нар тавгаа сэлбээч, Нямаа гуай дахиад барь» гэж байн байн ярьж, хангинуулан инээж байв.

Орой болоход Итгэлтийн найман ханатай гэрээр дүүрэн хүн болов. Эрдэнэ «эр бор харцага», «түмний эх» ийг гурав гурван түрлэг дуулж гэр дүүрэн хүмүүс бүдүүн нарийн хоолойгоор ая нийлүүлэн түрцгээв. Бас Эрдэнийн хоолойн яруу сайныг үг хайрлалгүй магтана.

Эрдэнийг манай зарц гэдэг. Тийм биш. Эрдэнэ бид хоёр аль алиндаа тус болж, хамтран амьдарч байгаа гэж Итгэлт хэлэв. Гаднаас Бадарч Цамбыг дагуулан орж ирлээ. Дулмааг мөрөөдөх Цамбын хүсэл наадам хүлээж чадсангүй учраас Бадарчийнд хөдөөлөх нэрээр Дулмаатай уулзах гэж иржээ. Аяга дүүрэн архинд хацар нь улайж, зан нь сэргэж хөөрсөн Дулмаа улам ч гоо үзэсгэлэнтэй болжээ. Цамба хээг зуур нүдээ салгаж чадахгүй байснаа гэнэт мэдэж царай нь улайсхийв. Гэвч архи боовонд чиглэсэн олны нүд ажиглалгүй өнгөрөв. Итгэлт гуайнх ч бялхаж цэлгэж байх шив дээ гэж Бадарч баргил бүдүүн хоолойгоор хэлээд суув. Бантсан Цамба түнтэр тантар явсаар суусан чинь яг Галсангийн хажууд суусан байв. Гэвч Эрдэнээс хол суусандаа баярлаж байжээ. Сүрхий согтож харц нь чиглэлгүй болсон Галсан «Итгэлт ах шиг минь тос даасан баян хүн хоёр Тамирын саванд байтугай, халх дөрвөн аймагт байхгүй» гэж бувтнавч түвнийг хэс ч эс анхаарна. Цамба хуруу гаргаж хожсон нэрээр аяга дүүрэн архи цутгаж өгсөн Галсан «халх дөрвөн аймагт» гэж солиорсоор дуу нь тасрахад Эрдэнэ босон унтуулахаар өргөн гарахад Дулмаа дагаж гарлаа.

- Чи орж бай. Би унтуулчихаад ирье гээд Эрдэнэ явжээ.

Дулмаа орж ирээд сууснаас хойш Цамба гарах дохио өгч эхлэв. Гэтэл Цамбыг бодох байр Дулмаагийн сэтгэлд байсангүй. Түвний сэтгэлд Төмөр эргэлдэж, зуны дунд сарын арван найман хэзээ болохыг өдөрт хэдэн удаа тоолж байдаг болжээ. Энэ учраас эхлээд Цамбын дохиог мэдээгүй хүн шиг байж үзлээ.

Гэвч сүүлд нь хариу дохио өгөөд гарахад нь Цамба хойноос нь гарлаа. Бараа тэрэгний цаана тэр хоёр уулзахад Цамба хүүхнийг шууд тэвэрч авлаа. Гэтэл Дулмаа хоёр гараараа хавсран байдаг хүчээрээ алгадаж орхив.

Дулмаа чи юу болов гэж цочсон лам нүдээ нээн асуухад Дулмаа ор сураггүй болсон байжээ. Галсанг унтуулан буцаж явсан Эрдэнийн хажуугаар Дулмаа гүйн өнгөрөв. Дулмаа чи юу болов гэсэн Цамбын дуу ч ойрхон сонсогдов. Эрдэнэ завхай хүүхний бузар явдалд жигшсэн сэтгэлд дарагдан гэр рүү эргэж явлаа. Өдрөөс хойш галлаагүй харанхуй гэрээс нь жихүүн чийгний үнэр анхилж сэтгэлийг нь улам ч дарлаа.

Тэмтрэн явж орон дээрээ суугаад «заваан юм. Ийм эхнэртэй бол» гэж шивэгнэн толгойгоо алгуур сэгсрэн хэсэг суув. Үүд нээгдэж Долгор орж ирээд дэн асааж «чи согтоо юу? Итгэлт гуай дуудаж байна» гээд гараас нь барьтал Эрдэнийн хөмсөг хурц шороор хатгуулсан могой шиг атиран эхнэрээ муухай харснаа «чадахгүй» гэж хашгираад түлхэж орхив.

Долгор эрүүлэг түшиж аваагүй бол унах байв. Суусан цагаас хойш түлхэх нь битгий хэл, хялайн харж байгаагүй нөхөр нь ингэж аашилж байгааг Итгэлттэй болсон явдлыг мэдсэнээс болов гэж бодоод Долгорын бие арзасхийн чичирч ямар зовлон юу болохыг хүлээн нүднээс бөөн бөөн нулимс дусалж байв. Эрдэнэ дахиад л эвгүй харсан бол Долгор бүх нүглээ тоочин өршөөл гуйхад бэлэн байв.

Түмэн зовлонг хамт туулсан эхнэрийнхээ нулимсыг хараад «энэ муу минь ямар гэмтэй биш дээ» гэж бодон босож ханцуйгаараа арчив.

- Өвгөн чинь намайг өршөө гээд Эрдэнэ эхнэрийнхээ магнай дээрээс үнсэн аргадав.

- Зүгээр. Эрдэнэ минь гэж бүх хэрэг үүгээр дууссанд баярласан Долгор хэлжээ.

Тэгээд эхнэрийнхээ гараас хөтөлж гэрээс гараад шууд их гэрийн үг алхав.

- Эрдэнэ энд суугаад «эрдэнэ засгийн унага»-аа дуулаарай гээд Итгэлт дэргэдээ зай тавьж өгөв.

- Зүгээр гэж бүдэгхэн хэлээд Эрдэнэ баруун талын арын эгнээнд суув. Мөнгөн аягатай архи бариад тас тас инээн хүмүүсийг шахаж байгаа Дулмаагийн дуу чих рүү нь буцалмал цус цутгаж байгаа юм шиг сонсогдож байв

Дулмаа мөнгөн аяганд бялхам архи хийж Эрдэнэд барихад Эрдэнэ шазуураа зууж хүйтэн инээмсэглэн толгойгоо сэгсрэв.

- Дуу барих дугараа барьж байна шүү дээ гэж Дулмаа хэлэв

- Би уухгвй гэж байна хэмээн Эрдэнэ огцом бөгөөд ширүүн дуугаар хэлээд нүд нь хүйтнээр солби татлаа.

- Дуулах хүнийг битгий шах гэж Итгэлт хэлээд тал зассан дулаан нүдээр Эрдэнийг харж мишээж нүдээ ирмэлээ.

Эрдэнэ өндийж суугаад «Эрдэнэ засгийн унага»-аа доргилуулан дуулж эхлэв. Нүдэнд нь Тайширын нуруу, Алангийн хөндий зэрэг өссөн төрсөн нутагт харагдах шиг болоод саяхан шиг Дулмаа, Цамба хоёрыг жигшин оволзож байсан сэтгэл нь аяндаа зөөлөрч бүх бодлыг нь эх нутгийн дүр, архины аагаар манарсан үл үзэгдэх, үл ойлгогдох боловч, зүрхийг нь хөдөлгөсөн баярын зэргэлээгээр дүүргэв.

Сүүлийн түрлэг дуусаж цугларагсад Эрдэнийн хоолойг олон сайхан үгээр магтан сайшаахад Эрдэнэ ч хий баярын зэргэлээнээс салж хар амьдралын ертөнцөд бууж ирлээ. Маргааш өглөө нь хот малтаж байсан Эрдэнэ Дулмаатай бууж ирлээ.

- Дулмаа минь чи ямар завхай юм бэ. Орооны гичий биш дээ гэж Эрдэнэ тэссэнгвй хэлж орхив. Дулмаа гайхан харснаа тас тас гэж шал худал инээгээд «юу болов» гээд цааш эргэн ажиллав.

Төмөртэй уулзсанаас хойш Эрдэнийг хүндлэн, дотно хайртай болжээ. Заримдаа ах аа гэж ч дуудмаар байдаг юм. Долгорыг ашиглаж Эрдэнийг дарлаж байгаа Итгэлтийн булай явдал Дулмаад өөр утга чанартай болж, урьд Долгортой атаархаж байсан бол одоо гэнэн цагаан сэтгэлээр доромжлуулж байгаа Эрдэнийг өмөөрч Итгэлтээр барахгвй Долгорыг жигшинэ. Заримдаа Эрдэнэд хэлж орхимоор ч бодогдоно. Хэлээгвй учир бол энэ бузар явдлыг мэдсэн Эрдэнэ уурандаа тэнгэрт тулсан хэрэг төвөг гаргаж, эцэстээ хохирно гэж эмээснээс болжээ. Эрдэнэ бол Галсан биш.

Нөгөө талаар Цамбыг алгадаж орхисон нь Дулмаад мөн ч их юм байлаа. Харамсалтай нь харсан бүхэн бахдам баярламаар тэр явдлыг Эрдэнэ харагвй. Харин сэтгэл нь хөөрсөн Дулмаад бол зөвхөн Эрдэнэ биш бүх хорвоо харж мэдэн баярласан юм шиг бодогдож байлаа. Гэтэл Эрдэнэ түүнийг ямар ч хайр, энэрэлгвй адгийн үгээр доромжлов. Төмөртэй уулзаж өөр хүн болоогвй бол Дулмаа энэ зэргийн үгэнд гомдохгвй байсан. Одоо бол үлэмж гомдов. Гэхдээ эхлээд зайлж гарья гэж бодоод зайлуулах гэж оролдов. Бүтсэнгвй.

- Ёсолж авсан эр нөхөртэй байж тэр асман ламтай юу болоод байдаг юм бэ? Хүнд чинь ёс дэглэм гэж байдаг юм шүү гэж Эрдэнийн хэлэхэд Дулмаагийн нүд нь галзуу үхрийн нүд шиг гөлрөн зангирч, барьж байсан шилбүүрээ газар шидэж, хөмхийгөө зуун ойртож ирснээ:

- Өөрийнхөө эхнэрийг захирч байгаад намайг захираарай гээд шууд эргэжээ.

- Бузар эм, хvн гvтгэнэ гэнээ гээд всрэн очиж Дулмаагийн мөрөн дээрээс барьж авлаа. Дулмаа эргэж Эрдэнэ рvв тогтонгуй бөгөөд хорсолтой нvдээр харснаа зvрх зvсэм хvйтэн инээмсэглэж

- Эхнэрээ Итгэлттэй завхайраад байхад нvд балай, чихэн дvлий болоод сууж байдаг мөртлөө миний явдалд оролцоно гэнэ. Аядвал дээр байхаа гээд мөрөө угз татан цааш явлаа.

Эрдэнэ дутуу бяртай хvнд ойчоод буултаа өгөх гээд зогсож байгаа бөх шиг хоцров. Хvрзээ газар тавиад гэр рvвгээ ажиглан харснаа хөлд дөнгөж орж байгаа хvвхэд шиг энд тэнд гишгэн явлаа. Эрдэнэд бvх амьдрал нь хvн бvхэнд хуурагдаж доромжлогдсон харанхуй нvх мэт санагдаж, тvвнийг ингэж доромжлогдоход хайрт эхнэр, итгэж явсан ганц хvн нь гэмтэй байсан нь хамгаас гомдолтой, жигшилтэй байлаа.

Гэвч миний Долгор тийм юм хийхгvй гэсэн горьдлого сэтгэлд эргэлдэж гэртээ орж ирэхэд нь их гэрээс гар рvвгээ ирэх замдаа Эрдэнэ Дулмаа хоёрын яриа сонссон Долгор бутанд шахуулсан туулай шиг бvлтэгнэж байв. Эрдэнэ бvх нvврнийхээ арьсыг хянган хамар дээрээ зангидаж байгаад харахад Долгор гөлөлзөн доош харлаа.

- Үнэн vв гэж Эрдэнэ хашгиран асуув.

«Худал» гэж эхнэр нь хэлсэн бол Эрдэнэ энэ хорвоо дээр хамгийн жаргалтай хvн болон хувирах байж билээ.

- Үнэн гээд Долгорын нvдэнд нулимс бvрхэв. Эрдэнийн нvдэнд хорсол, жигшил оволзсоноо «бузар янхан» гээд алгадав. Долгор тулга татан өнхрөн унав. Эрдэнэ эгшин зуур эргэн гарч шууд мордоод хошуу хvрээний зvг ум хумгvй давхилаа.

«Эрдэнэ зогсооч» гэж Долгорын хашгирсан дууг сонссон. Сонссон ч зогсохгvй байж билээ. Дулмаа энэ бvхнийг гэрээсээ хаяанаас харж байлаа. Тэр хийсэн хэрэгтээ гэмших сэтгэлийн хажуугаар амьдралд гомдсон гашуун хорслын бахдал сэтгэлд нь төрж байв. Эрдэнэ адуу дайрч байдаг ганц хээр морио унаад хорвоогоос зугтах, тэгэхдээ хаачихаа мэдэхгvй явж байтал тэр өглөө Галсантай хамт хvрэн дээр очоод ирж явсан Итгэлттэй яг мөргөлдөв.

- Эрдэнэ хаачиж яваа билээ гээд Итгэлт инээмсэглэв. Эрдэнэ мориноосоо бууж «та нар барагтай дарлаарай» гээд Итгэлтийг морин дээрээс гуд татаж унагаагаад яргай ташуураар балбаж хэлэв.

Галсан шуугин хvрч Итгэлтийг өмгөөлсөн боловч Эрдэнийн нэг ёвролтонд алд газар тонгорцоглон унаж занчилт дуусаад Эрдэнэ мордож алга болсон хойно босжээ. Хөх булуу болтол нvдvүлсэн Итгэлт «муу цагаач чамайг хонгоны махыг чинь борвин дээр чинь буулгана даа» гэж шvдээ хавиран явахад «тэнэг золигийн цус, нөжий нь хутгах хэрэгтэй» гэж Галсан дуу нийлvүлж явлаа.

Задарсан Эрдэнээс яаж өшөөгөө авах тухай Итгэлт арга сvвэгчлэн бодсоор Луу Гvний хошуу захирагчид хахууль өгч, халх дөрвөн аймаг, шавь тавд гэгээн цагаан өдөр, гэрэлтэй шар наранд хvн дээрэмдэх гэж оролдсон Эрдэнийг барьж Луу Гvний хошуу тамганд хvргvүлэх зар гаргаж, баригдаж ирсэн цагт нь Галсангаар гэрч болгон өдрийн дээрмийн хэрэгт унагааж, Бадарчийн гарт өгөөд амьдаар нь хатаахаар шийджээ.

Дараа өдрийн өглөө таван лангийн орос гулдмай авч хошуу тамган дээр очоод захирагчид хахууль өгч гэгээн цагаан өдөр дээрэм хийх гэсэн Засагт ханы Эрдэнийг тохиолдсон газар нь баривчлан авч Луу Гvний хошуу тамганд vлдэн хvргvүлэх тухай улаан шугамтай бичиг шийтгvүлэн өртөөгөөр дамжуулан тараав.

Тэндээс Эрдэнэ эргэж баахан давхисан боловч анхандаа хаашаа, юу хийх гэж яваагаа мэдэхгvй байлаа. Мориныхоо амыг татаж гэлдрэв. Туруу халж, хөлөрсөн морины хамар нь онголзон амьсгална. Одоо хаачих вэ? гэдэг асуулт сэтгэлд нь байн байн төрж юу ч гэсэн

Заяын хүрээ орж хvvтэйгээ уулзаад богдын хүрээ рvv амьдрал хөөхөөр шийджээ. Энэ ертөнцөд үнэнч юм огтгvй ажээ. Эрдэнийн хийсэн гэм гэвэл үнэнчээр амьдарч болно, үнэн ёс байна гэж нялх хvvхэд шиг гэнэн бодож явсан сэтгэл ажээ. Өөрийн гэнэн сэтгэлээс болж алхам бvхэндээ хvний ухаанд багтан маллагдаж явснаа бодоход Тамирын голд унаж, Тайхар чулууг мөргөн vхэхэд гомдох газаргvй мэт. Гэвч доромжилсон хорвоогоос хариуд нь доромжилж баймааж өшөөгөө авах хэрэгтэй мэт бодогдоно.

Орчлонг занасан сэтгэл цээжинд нь оволзож явахад Тамирын хөндий ч явцуу юм шиг санагдан уул ус бvгд Эрдэнийг шоолон байх шиг байж байлаа. Эрдэнэ явсаар оройн нар жаргахын үед Заяын хүрээ рvv орж ирлээ лам ном уншихаар айлд залагдаад хоёр хvv хашаан дотор дур мэдэн тоглож байхад хаалганы хонх сvртэй дуугарч морио хөтөлсөн Эрдэнэ орж ирлээ.

Баярын нар нь гарсан хоёр хvvхэд дуу алдан угтаж очиход Эрдэнэ магнай дээрээс нь үнсэв.

- Та бидний эргэж ирэв vv?

- Үгvй аав нь өөр ажилтай яваа

- Өндөр ах та өнөөдөр хоноод яв л даа

- Морины тэжээл байхгvй болохоор хонож болохгvй.

- Бид хоёр сайн эгчтэй танилцсан. Тэднийд их өвс бий гэж Бат баяртай хэлэв.

Ингээд тэд гурав гэрт орж хvvхдvvд багшийнхаа гурван өдөр хэмжиж өгсөн цай хоолыг чанаж Эрдэнийг дайлав.

Энэ хооронд Эрдэнэ, Итгэлтэй эв эвдэрч, Долгороос салсан, Богдын хүрээ орох гэж яваагаа ярьсанд, хоёр хvvхэд уйлав. Эрдэнэ тамхи угсран татаж сууснаа гvн санаа алдав.

- Та хоёр битгий уйл. Эр хvнийг нулимс шиг гутаадаг юм байдаггvй.

- Бид ч уйлаагvй л байна гээд Хонгор нулимсаа ханцуйгаараа шудран арчсанаа нvд нь сэргэж баяр гялалзан өндөр ахаа бид аав та хоёрыг эвлvvлж өгье.

- Хэрэггvй. Ах нь бvр шийдсэн

- Ээж минь ганцаараа хөөрхий байна даа. Таныг санана даа гурвуулаа очиж ярья

- Хэрэггvй. Ээж чинь намайг гомдоосон. Харин аав нь хүрээ орж суурьшаад эргэж ирж хvvгээ авна.. гэхэд Эрдэнийн хоолой нь зангирав.

Хоёр хvvхэд Эрдэнийг гэрт нь буцаах гэж байдаг vгээ зарцуулсан боловч чадсангvй. Харин өнөө шөнө энд хонох болжээ. Өмнөх замын манан, болсон явдлын гунигт дарагдсан Эрдэнэд яарах хэрэг байсангvй.

- Хэн ирэв гэж юм оёж суусан Чимэг хонхны дуу сонсоод асуухад тvлээ оруулж ирсэн Цэцэг

- Хоёр хvvхэд гээд дуу нь гэнэт тасрав.

Эрдэнэ морио уяад гэр рvv явахад Цэцэг хормойтой тvлээгээ барьсан хэвээр гэрийнхээ vүдэнд зогсож байв.

- Чимэг эгчээ миний аав, моринд нь өвч байхгvй. Тэгээд танаас гуйх гэж ирлээ гээд Бат дэргэд нь очив.

Цэцэг нууц баяр туяарсан нvдээ солбилзуулан инээмсэглэж Батын толгойг энхрийлэн илснээ «орцгоо» гээд vүдээ нээв.

Хоёр хvvхэн цай таваг барив. Суурин газрын дулаалсан гэрт шаазан дvvрэн тос хөвсөн аагтай цай ууж, эрээн авдар бурхны гvнгэрваагийн уран хийцтэй хээ харж суухдаа Эрдэнэ тvр боловч хорвоогийн зовлон, жигшvvрт явдлыг мартаж байжээ.

- Та нар өвс чирж багшийн хашаанд хог тариад яах вэ. Хvрээний лам нар нарийн цэвэрч. Аав нь манайд морио тэжээж хоноод маргааш явна биз. Та хоёр ч манайд хоно л доо гэж Чимэг хэлэв.

- Бид хоёр ч болохгүй. Хашаа эзгүй хаявал багшийн нүүрийг яаж харна гэж Бат хэлэв.  
- Турсага хуулна шүү гэж Хонгор нэмлээ. Гаднаас хар хургаар эмжсэн өнгө нэхий дээл дээр шар бажгар дурдан бус ороосон Түгжил орж ирлээ.

Хүүхэд өглөө ирэхээр явахад Чимэг боорцог ётон атгаж өглөө. Түгжил Эрдэнэ хоёр хүүхнүүдтэй амттай хоол идэж халаасан ганзай уув. Хятад савангийн нялуун үнэр, халуун ганзайн ааг биед нэвтэрч амьдралын гуниг хорсол нь манаран сарнихад Эрдэнэ дуу аялан сэргэв.

Цэцэг мөрөн дээр нь хацраа нааж, хагас хоолойгоор Эрдэнийг дагаж гиншиж байснаа өвдөг дээр нь гараа тавихад Эрдэнийн хүдэр гар атгаж авлаа. Бүх амьдралаа хүний зугаа болж байсан Цэцэг анх удаа өөрөө таалж, согтож хөлөрсөн нүдэнд нь хангалуун сэтгэлийн гал улалзан, уруулд нь баярын инээмсэглэл бүжиглэж байв.

Эрдэнэ тэнд хоёр хоног. Гуравдахь өдөр, хүрээ эргэж салхинд гарахаар явсан Чимэг сандран ирж Луу гүний баян Итгэлийг өдрөөр дээрэмдээд оргосон Эрдэнийг хаа яваа газар нь барьж хүргүүлэх зар гарсан тухай сонссоноо хэлэв.

Эрдэнэ энэ үгийг сонсоод Итгэлтэй нэгийгээ үзмээр санагдсан боловч зөв хэргийн төлөө зүтгэж байгаад Гомбожаваас хүртсэн зовлон нь бодогдож, юу ч гэсэн хүрээ орохоор явах болов. Мордоход нь Цэцэг гаргаж өгөөд гараасаа хэн бэлэглэж өгснийг нь аль эрт мартсан цэнгийн алтан бөгжөө мултлан өгч «сайн яваарай» гэхэд нь нулимс мэлтэлзэн тунарч байв. Эрдэнэ бөгжийг авсангүй боловч хүүхний ширтэн байснаа «чи сайн сууж байгаарай» гэж хэлэв. Зүүн зүгийг чиглэн явахад Долгор сэтгэлд нь байн байн бодогдож хүний нутагт ганцааранг нь орхисондоо хайрлах сэтгэл төрөвч Итгэлтэй нийлж доромжилсныг бодоход хэзээ ч өрөвдөж болохгүй байлаа. «Итгэлт чамд сайн өглөгчдөө биш, чамаас цус, хөлс, сэтгэлийг чинь хямдхан үнээр авч байгаа болохоор одоохондоо сайн байна» гэж алиа Петрийн хэлж байсан дуу чихэнд нь дахин дахин сонсогдон дүнгэнэж байлаа.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### I

Идэр гурван есийн хүйтэн эхэлсэн өвлийн нэг орой өргөн талыг баруунаас зүүн тийш зүсэж гарсан замаар лам захтай уранхай улаан хүрэн дээлтэй банди сүрхий ядарч, даарсан бололтой элгээ тэврэн гэлдэрч байлаа. Хамар нь борооны хонь шиг шуухитнан яваа энэ хүү бол бидний танил Бат байв. Цуцсан хөл нь томдсон гутлаа даахгүй пар пар чирэн, өвдгөөрөө нугарах шахавч эцгээ мөрөөдөх сэтгэл нь түүнийг хөтлөн явуулж байжээ. Бат хүрээ ороод сураггүй болсон эцэгтэйгээ уулзахаар шийдэж Заяын хүрээнээс гараад хэд хоног яваад энд иржээ. «Ээж чинь аавыг нь гомдоосон. Аав нь хүрээ орж, төвхнөмөгц эргэж хүүгээ авна» гэсэн үг байн байн чихнээ сонсогдоно. Гэтэл аав нь өдий болоход эргэн ирэх байтугай, сураг чимээ өгсөнгүйг бодоход ямар нэгэн сүрхий саад тотгор учирсан мэт санагдана. Аавынхаа тухай өдрийн бодол шөнийн зүүд болж, эцэст нь түүний хойноос явахаар хатуу шийдээд Хонгорыг хамт явъя гэхэд «өвгөн чинь аав ээж, дүү эд хөрөнгөө хаяад явж болохгүй. Харин чамд тус больё» гээд зургаан соном хадаг, хэдэн дугуй гэвш ламаас хулгайн авч өгсөн бөлгөө. Тэгээд салахдаа Булган уулын өвөрт ургасан хоёр моносны дэргэд очиж, үлгэрт гардгийг дууриан нэг нэгээр хуваарилан аваад «азтай сайн явбал мод минь цэцэглэж байг, муу явж доройтвол навч цэцэг нь унаж хувхайраг. Том болоод уулзахгүй бол хэн амьд

маань ирж үзэж байя» гэж ярилцсан билээ.

Хэсэг амарч суугаад босож алхав. Тэнгэрт түрүүчийн од гялалзаж эхэлснээс удалгүй үй түмэн од мяралзав. Үдшийн хүйтэн салхи уранхай дээлийг нь нэвт үлээж эрүү толгой нь аяндаа зодолдов. Гүйвэл дулаацах боловч хөл нь бээрч хөшилдөх ажээ. Зам хөөж гарахдаа эхтэйгээ уулзъя гэж бодсон. Гэвч нэгдүгээрт буцаан хүргэж өгөхөөс айсан, хоёрдугаарт ах гэж авгайлдаг Итгэлтийн цэвдэг хүйтэн нүдийг дахин харах хүсэл байгаагүй билээ. Нойр нь хүрээд айл олж унтъя гэвч өвлийн цагт айл байдаггүй энэ өргөн талд торойх юм үл үзэгдэнэ. Байн байн айх сэтгэл төрж цагаан ногоон дархи уншиж эхлэвч хэдэн шад уншаад залхуу нь хүрч болино. Ингэж явтал ард нь хүн ярих сонсогдов. Цочин эргэж харвал харанхуйн дундаас тэмээн жинчийн түрүү тодрон гарлаа. Бат замын хажууд гарч зогсов.

- Хүн үү дээ, гэж зэрэгцэн ирсэн тэмээтэй хүн хэлэв

- Тийм ээ, ах аа би хүн байна гэж Бат хэлээд өөрийн мэдэлгүй ойртон очив

- Юун хүн бэ?

- Би хүрээ орж ном үзээд сайн лам болох гэж яваа хүүхэд байна даа гэж Бат хэлэв.

Энэ үгийг Хонгор зааж өгсөн билээ. «Чи ингэж хэлж л явбал хүн чамд тусална» гэж хэлсэн бөгөөд гарснаас хойш хоёр дахин айлд хонохдоо энэ үгээ хэлсэнд хөгшид «Номын хүрд эргүүлэх гэж гэгээний орон чиглэж яваа хүү байна. Буян болно» гэж сайн хоол хийж өгдөг байлаа.

Жинчид анхандаа хянамгай байсан боловч шүдэнз зурж хараад том үстэй дээл нөмрүүлэн тэмээн дээр суулгажээ. Ингэж явсаар мичид гудайх вед жинчид буудаллаж, хоол идэхдээ Бат бас хоол идээд том хар хүний өвөрт орж унтжээ. Тэр жинчид бол Нар ванчингийн шавь нар байсан бөгөөд хүрээ рүү пүүсний арьс тээвэрлэн яваа ажээ. Өдөрт унтсан жингийн дарга хар хүн бол Балдан гэдэг дөч шахам насны хүн байлаа. Замдаа тэдний ойр зуурын ажлыг нь хийж явсаар нэг мэдэхэд Богдын хүрээ орж ирлээ.

Заяын хүрээнээс том л болохоос биш байдаг юм нь ялгаагүй газар байлаа. Өдрийн төдий ноход, улаан шар хувцастай лам нар алтан оройтой дуган сүм, хар хөх хувцастай хятадууд, морьтой явган хүн, илжиг морь хөллөсөн тэрэг, хар хүүдий үүрсэн гуйлгачин, том хар аяга зүүсэн янз бүрийн дуутай дулдайчин цөм л байв.

Харин зах хязгааргүй юм шиг л санагдаж байсан болохоор «ахаа хүрээний нөгөө талд гарвал хэд хоног явах бол» гэж асуусанд Бадан «ах нь гар ч үзээгүй, цаад талд нь хөлийн модчин гэж газар байдаг гэдэг юм» гэлээ.

Богдын хүрээ хорь шахам орж ирсэн хүн захад нь гарч үзээгүй болохоор учраа алдсан их юм байна гэж бодоод Бат дуугүй болжээ. Балдан нутгийн нэгэн ламтай ярилцаж Батыг тэднийд байлгах болжээ. Тэр лам урьд залуудаа Нар Ванчины хүрээнээс явган явж гандан дээр ирж суугаад юлжингээс эхлэн зиндааны анги болж хэдэн жилийн өмнө аграмбын дамжаа барьсан хүн байлаа.

Энэ хүний Эрэнчин гэдэг бөгөөд өглөөнөөс орой хүртэл зиндаа бүхий бөөн бөөн хүн ирж ном заалгадаг байжээ. Шавь нар нь ээлжээ хүлээж байхдаа хамаг ажлыг нь хийдэг болохоор Батад хийх ажил бараг байсангүй.

Бат Заяын хүрээнд сууж байхдаа Богд ламын Игчаа үзэж байж билээ. Гэтэл Эрэнчин «Бурхны номд ялгаа байхгүй гэхдээ Гүнчин ламын игчаа гүн бодолтой юм шүү» гэж хэлээд Дашчоймбол дацанд оруулжээ. Шинэ багш нь Батыг зодоггүй боловч за чөлөөгүй ном үзүүлэн суулгадаг байв.

Эрэнчин эсхүл ном зааж эсхүл өөрөө ном уншиж байдаг болохоор түвнийг хэзээ босдогийг Бат бараг л мэддэггүй байсан бөгөөд оройн цайгаа ууж өрхөө бүтээсний дараа үстэй дээлээр



хөлөө ороон завилан өмнөө том гэгчийн өөхөн дэн бариулан номоо дэлгэн сууж эхний хуудсаа эргүүлээд Бат руу инээмсэглэн харж «за гэвш минь номоо унш» гэж хэлдэг байв. Бат шоголтой номоо авч дэнгийн нөгөө талд бас л дээрээ хөлөө ороон суудаг билээ. Шөнө дундын вед далаа хөдөлгөж суниагаад «за гэвш минь нойрс» гэдэг байв.

Бат өглөө босоход багш нь сууж л байдаг бөгөөд нар гарахын вед шавь нарын эхний ээлж нь ирдэг юм. Гадаалах бүрдээ Батыг дагуулж явдаг бөгөөд гандангийн захад хүмүүс ерөөл өргөж утастай зvv, шүдэнз зэрэг юм өгөхөд «явсан нохой яс зууна гэж энэ дээ. за гэвш минь хүний юм авсан хойно ерөөлөө уншина даа» гээд амаа хөдөлгөж эхэлдэг.

Эрэнчин Батыг эзгvй байхад шавь нартаа тvvний ой ухааныг магтан «хэрэв гай барцад учрахгvй бол яггvй гэвш болно» гэж хэлдэг байв. Энэ хооронд эцгээ эрж хэдэн удаа хүрээ, хороогоор явсан боловч сураг ч гаргаж чадсангvй. Харин хүрээ гэдэг тийм учраа алдсан том юм биш байна гэдгийг ойлгов.

Арга барагдахдаа эцгийнхээ тухай багшдаа хэлсэнд Эрэнчин шавиа удтал ажиглаж байснаа: - Гэвш минь эрт хэлэхгvй дээ. За яахав. Хvvхдэд захивал сураг гаргаж өгөх магад гэж хэлжээ. Эрэнчин хvvхдvvд гэж шавь нараа хэлдэг бөгөөд маргаашнаас эхлэн ирсэн шавь бүхэндээ Эрдэнийн сургийг гаргаж өгөх тухай захидаг байв. Гэвч нэрээ өөрчилсөн Эрдэнийг олсонгvй. Гэвш минь эцгийн чинь тухай сураг гарахгvй болохоор амьд л яваа юм байна даа. «Эрсэн хүн олдог, ширтсэн хүн хардаг» гэж бид хоёр эрээд байвал ч олно доо гэж багш нь хэлжээ. Батад цааш явах газар байсангvй. Бас тэгээд Эрэнчингийн дунд байхад дургvй хүрэх юм байсангvй бөгөөд Эрэнчин Туулын гvний нэг шавийндаа хэд хоног хөдөөлөхдөө Батыг авч явжээ. Хөдөө явахдаа өдөр турш Батыг дагуулан уулын орой дээр сууж элдвийн юм ярьж байдаг байв.

Монгол хүн малчин болохоор юм бүхэн нь тvvндээ тохирсон байх юм. Жишээ нь эмээл байна. Хээр хоновол дэр, тохон нь дэвсгэр, дээл бол өмсөж явахад гадуур хувцас, унтах цагт хөгжил, гутал бол дөрөөнд маш эвтэй, мал үргэхэд түргэн өмсөж болох зохиомжтой эд гэж нэгэн удаа ярьсан ба бас хаяагийн нь шуусан гэрт хэвтэж байснаа гэвшээ тооно гэдэг чинь толгой дээр гэсэн vг бололтой, дээвэр гэдэг чинь дээд юм гэсэн бололтой, хана гэдэг чинь хаяа гэсэн vгтэй холбоотой шvv гэж хэлээд бодол болон байдаг байв.

Эрэнчингийн зөөлөн зан, саруул ухаан нь Батын сэтгэлд улам бүр таалагдаж тvvнийг хүндэтгэх нь өдөр ирэх тутам их болж байлаа. Хөдөөнөөс ирэхэд нь шавь нар нь ирж Түвдэд ном үзэж ирсэн нэг нэртэй гэвхийг Дашчоймболын шилдэг гэвш нар дийлж чадахгvй байгаа тухай яриад, очиж ном хаялцахыг Эрэнчинд хүсэв.

- За яахав өглөө очье гэж хэлээд шавь нараа явуулжээ.

Бат цай чанаж Эрэнчингийн өмнө тавихад тэр уусан ч vгvй. Үдэш болоход замын тоос болсон хувцсаа ч сольсонгvй юм бодон суусаар байв. Бат унтаад өглөө босоход багш нь оройнхоо байдлаар толгойгоо vл мэдэг гилжийлгээд юм бодон сууж байв. Шавь нар нь ирж:

- Багшаа явах болсон шvv гэхэд гэнэт цочсон юм шиг босон суниснаа гарч явах гэхэд нь хүмүүс хэлж хувцсыг нь солиулав.

Ингээд тэр хүнтэй хоёр өдөр ном хаялцаж байхыг Бат харж үнэхээр бишрэв. Эрэнчиний дуу нь улам чангаран, залуу болсон юм шиг харагдаж байсан бөгөөд хөлс нь дааварлан, нүд нь гялалзаж, заримдаа царай нь ухаа ягаан болон ном хаяж байхад нь дуган дvvрэн хүмүүс шагшин гайхаж байв. Энэ вед «энэ чинь миний багш» гэж хашгирмаар Батад санагдаж байжээ.

Хоёр дахь өдөр үдээс эхлэн Түвдээс ирсэн хүний буцах ил болж орой бүр мухардаад Эрэнчингийн хэлсэн бүхнийг хүлээх болж дийлэгдэв. Эрэнчин дуганаас гармагц газар

эрээлжлэн найгаж ухаан алдан унахад шавь нар нь дамжлан гэрт нь хвргэв. Үүрээр ухаан орж нүдээ нээгээд гар дүүрэн зогсож байгаа шавь нараа ажиглаж байснаа:

- Хvvхэд минь, их юм мэддэг хvн байна. Шавь орцгоо гэж хэлснээр барахгvй Батад урт гэгчийн аюуш хадаг өгч шавь оруулахаар явуулжээ.

Харин хоёр өдрийн дараа нөгөө гэвш ирж Эрэнчинд шавь оржээ. Тэр нөмөр хөдөөлж ирсэн шавь нар нь Эрэнчинд мэхээртэй тос, сарлагийн зузаан өрөм, чихэртэй ааруул, гvзээ гvзээгээр нь шар тос авчирч өгсөн боловч орж ирсэн шавь нараа дайлсаар байгаад бараг л юм vлдсэнгvй. Бат Юлжингийн зиндаанд орсноор барахгvй арван толгойд орж дөрөв дээр босох болоод баяртай ирж хэлэхэд багш нь их баярлаж:

-- За гэвш минь одоо vүрийн шувуу жиргэтэл суугаад гvнчин ламын игчааг цээжиндээ баринтаглана даа гэж хэлжээ.

Намрын сvүл сарын нэгэн өдөр Балдан бас л жинтэй ирж, Эрэнчингийн хонув. Эрэнчин Балдан хоёр багадаа нэгэн хотод өсөж, хонь хамт хариулж, хамт чулуу гэр барьж хамт морь унаж уралдан явжээ. Хожим Эрэнчин лам болж, Балдан төрийн хар хvн болсон боловч vргэлж верхэн, уулзах бvрдээ хууч хөөрч сэтгэлийнхээ vгийг илэн далангvй ярилцаж явжээ. Эрэнчинг гандан дээр сууснаас хойш ч Балдан жингээр ирэх бvрдээ ирж хонодог бөгөөд Эрэнчин нөхөртөө нарийн хоол хийж өгдөг юм.

Балдан хоол идэж сууснаа гэнэт нэг юм санасан бололтой өврөө уудалж, хэдэн давхар муутуу цаасанд боодолтой том соном хадаг гаргаж Эрэнчинд өгөв.

- Нөгөө Жавзан чамд барьж, хойтохоо даатгаж байдаг шvv гэлээ.

Жавзанг Эрэнчин сайн мэднэ. Багадаа тvvнтэй их л дотно верхэж байснаар барахгvй сууж гэр бvл болох тухай хvртэл ярьсан удаа бий. Гэтэл Эрэнчингийн зам өөрчлөгдөж хvрээнд суусан. Дараа сайн гэвш болохоор Богдын хvрээ рvv явахын өмнө Жавзантай уулзаж «за би номын хvрд эргvvлэхээр явлаа. Чамд сайн сайхан бvхнийг ерөөе» гэхэд нь Жавзангийн нvднээс нулимс дусалж байсан. Эрэнчин Жавзангийн өгсөн хадгийг авч чанга атгаж, хэсэг юм бодон дуугvй байснаа:

- зайлуул, тэгээд бие нь сайн уу дээ? гэж асуув

- олон хvvхдэд дарагдаад уймраа хөгшин болсон.

Намайг гарахын урьд өдөр ирж энэ хадгийг өгсөн. Эрэнчин өндийж толгойнхоо шvvгээнд эвтэйхэн эвхэн хийлээ. Хэсэг зуур хоёр найз юм ярилгvй хоол идэж байв. Эрэнчингийн сэтгэлд багын явдал бодогдож, ширгэж хатсан зvрх сэтгэл нь усанд норсон хуурай мод шиг бамбайж байлаа.

- За маргааш чинь гэгээнд нэг мөргөж, энэ муу толгойгоос нvглийг нь авч ариутгая гэж Балдангийн хэлэхэд Эрэнчин их л хөгжилтэй инээж

- Богд ч яахав даа. Ном хаялцвал мань гэвшид мад тавиулах тvвд байгаа юм гэхэд нь Балдангийн нvд нь томорч залбиран

- Бурхан гончиг сvм минь, чи ч яах вэ. Нvгэл даах хvн. Би ийм vг хэлбэл халуун тамын ёроолоос салахгvй гэв.

- Үнэндээ богд, архи авгай хоёроос болоод аятайхан маань ч мэдэхгvй болчихсон амьтан даа гээд Эрэнчин нvдээ анивчин инээв.

Арга нь барагдаж нvглээс айсан Балдан бурхан минь гэгээнийг ингэж болохгvй гэж дахин дахин хэлж байлаа.

## II

Эрдэнэ богдын хvрээ чиглэн явах замдаа хамгийн дотно vнэнч гэж итгэж явсан Долгортоо

ариун цагаан сэтгэл, гvн хайраа доромжлуулсандаа гомдон, амьд бvхнийг жигшин занаж байлаа. Нэг нь нөгөөгөө мэхлэх, хvчтэй нь хvчгvйгээ идэх бусдын чөмөг ташиж байгаад ч олз олох эрмэлзэл бол энэхэн хорвоогийн жам ажээ. Өнгөрvүлсэн амьдралд нь vнэн юм байсангvй. Учирсан бvхэн тvүний маллаж, ашиглахыг хичээж байжээ.

Энэ бvхнийг бодоход ертөнцийг vнсэн товруу болгомоор санагдавч өшөөгөө авах чадалгvйдээ хорсон бухимдана. «Итгэлт өглөгч, нинжин сэтгэлтэйдээ чамд сайн байдаг биш өгснөөсөө илvv ашиг чамаас олж байгаа болохоор сайн юм» гэж алиа Петрийн хэлж байсан vг дахин дахин бодогдож өөрөөс нь Итгэлт хэзээ ч эргvүлж авч болохгvй ашиг олж доромжилсон мэт санагдана. Итгэлтийн ухаанд багтаж тvүний харуулсан боовонд хvүхэд шиг хууртан, янаг хайраа доромжлуулсныг бодоход өөр шиг нь тэнэг хvн энэ хорвоо дээр vгvй мэт бодогдон давчдана.

Ингэж явсаар найм дахь өдрийн vд өнгөрөхийн вед хvрээний зах руу орж ирлээ.

Хаа хоргодох юу хийж амьдрах билээ гэж бодсоор гайхан сажилж явтал «Эрдэнэ гуай» гэж эмэгтэй хvн дуудах шиг болов. Цочин харвал хэдэн алхмын тэртээ алд сувд, магнаг гуравт дарагдсан залуу эхнэр инээн зогсож байлаа.

Хараач нөгөө Довчингийн эхнэр Гэрэл ажээ. Тэмээнээс хvн унахдаа ширхэг vснээс базаад авдгийн адил, орох орон, идэх хоол байхгvй Эрдэнэ морины амыг эргvүлж Гэрэлийн зvг очлоо. Хvрэн торгон дээл дээр алтан одтой цэнхэр торгон нөмрөг нөмөрч оюу шvр шигтгэсэн алтан хэрэглэлтэй данхар vс тавиад, атгаж хvрэмгvй сувдын хэлхээ хоёр шанаа руугаа унжуулсан Гэрэл, том хээтэй хөх торгон дээлтэй Довчингийн хамт зогсож байлаа. Энэ хоёрын хажууханд өөр болчих вий гэсэн юм шиг ижилхэн хоёр зээрд халзан морийг нэг залуу бариад зогсож байв.

- Эрдэнэ гуай хэзээ ирэв? гэж Гэрэл баярын царай гарган асуув

- Саяхан ирлээ

- Манай муу овоохойгоор орохгvй яагаа вэ?

- Зав болоогvй л байна

Гэрэл тэр нэгэн орой Эрдэнэтэй учирснаас хойш тvүний тухай бодлоос салж чадахгvй болжээ. Эрдэнийн тухай бодож, ярьж байхдаа тvүний ширvүн зан нь зөөлөн болдог учраас Довчин хvртэл Гэрэлийг ууртай байхад нь Эрдэнийн сайхан хоолойн тухай ярьж эхнэрээ тайтгаруулдаг байжээ.

Довчин Эрдэнэтэй дайралдаад тvмэн зvйлийн муу юм бодсон боловч ярианаас нь салахгvй болсон хvнтэйгээ санамсаргvй гэнэт учирсан их баярын бvлээн мананд умбасан эхнэрээ хараад худал инээв.

Гэрлээс ухаан улдан айдаг Довчингийн тухай таних хvмvүс нь өдий төдий шог ярьж инээдэг. Өнгөрсөн жил «Чулуун мөн баларсан эр юм даа. Эхнэртээ хvүхэд шиг загнуулаад л өглөө бvхэн тантантай юм асгаж явах юм» гэж Довчингийн хэлэхэд өөр юм бодож байсан Гэрэл догшин нvдээр ширвэж харснаа «юу гэнээ чи» гэж асуухад нь «би бол хэрэлдэж, маргалдалгvй асгаж орхино» гэж нvдээ жартайлган инээмсэглэснийг зарц эмэгтэй нь сонсоод нэг хvнд хэлж орхисон нь тарж хvрээнийхний ярьж инээдэг хошин яриа болжээ.

Гэрэл Эрдэнээс баярын нvдээ салгахгvй цавчлан хэсэг ширтлээ.

- Довчин оо, гийчнийг уриад гэхэд нь энэ vгийг хэзээ хэлэх бол гэж хvлээж байсан нөхөр нь цочиж

- Та өчvүхэн хvний гэрт морилон очно уу? гэлээ

Эрдэнэ юунд татгалзах билээ. Тэр гурав зэрэгцэн явахад дайралдсан хvмvүс Довчингийн амрыг эрж Довчин ихэмсгээр толгой дохиж явлаа.

Гэрэлийн сэтгэл баяраар бялхаж, нүүр дүүрэн инээмсэглэн явахад хүрээ юутай сайхан байж билээ. Хашаандаа ороход нь түүний баяр жаргал туяарсан царайг хараад «Авгай юу болчихоо вэ?» гэж зарц нар нь гахайн шивэгнэлдэж байв.

Удалгвй хоол унд, архи дарс бэлхэн болж Эрдэнийг дайлав. Гэрэл сэтгэлийн үгээ, санаж хүсэж байснаа ярих гэж оролдовч Эрдэнэ өөр ярианд шилжүүлэх тутам Гэрэлийн Эрдэнийг хүсэх сэтгэл оргилон байжээ.

Эрдэнэ хотод амьдрах гэж ирснээ ярихад «Та манайд бай л даа» гэж Гэрэл хэлжээ. Алсын замд ядарсан Эрдэнэ халуун архинд нам цохиулан унтжээ. Өглөө нь сэрвэл Гэрэл дэргэд нь сөхрөн суугаад магнайг нь илж байлаа. Гэрт тэр хоёроос өөр хүн байсангвй. Эрдэнэ шууд ухасхийн боссонгвй. Нүднийхээ булангаар ажиглавал хүүхний нүднээс нулимс бөнжигнөн дусалж, нүүр царай нь туяаран уруул нь үл мэдэг хөдөлнө. Эрдэнэ нүдээ алгуур нээхэд Гэрэл цочин гараа татаж бослоо. Эрдэнэ өндийж эвшээв.

- Та мөн бөх унтлаа шүү

- Бүр цохиулж орхижээ

- Зүүдлээд л юм яриад л байна билээ

- Аа тийм үү?

- Довчин таныг манайд бай гэж гуйж байдаг шүү гээд Гэрэлийн энгэсэгтэй хацар нь үл мэдэг ягааран улайв.

Орон гэр таних хүнгвй тэнүүчлэн яваа Эрдэнэ энэ урилгыг хүлээж авахгвй байх арга одоодоо үгвй байлаа.

- Хэрэв та нарыг төвөгшөөж дургвйцэхгвй бол хэд хоноё гэж Эрдэнийн хэлэхэд Гэрэл учир тоймгвй баярлав.

Үүнээс хойш Гэрэлийн ширүүн зан, догшин ааш эрс өөр болж нүүрэнд нь байнгын инээмсэглэл тодрон байдаг болжээ. Зарц нар нь «Эрдэнэ байгаад байгаасай. Авгайн зан хайлсан тугалга шиг л байх юм» гэж ярилцан Эрдэнэд сайн байхыг хичээж байлаа. Эрдэнийг унтаж байхад Гэрэл удтал дэргэд нь сууж илэн таалж байхдаа хорвоог мартаж, сэтгэл дүүрэн жаргаж байдаг байжээ. Нэгэн удаа унтаж байгаа Эрдэнийн дэргэд хэсэг сууж байснаа үнсэхэд нь Эрдэнэ цочин өндийвөл Гэрэл гэмшилтэй бөгөөд арчаагвй нүдээр ширтэн сууж байлаа.

- Яаж байна даа. Нөхөртэй хүн шүү дээ гэж Эрдэнэ зэмлэн хэлэхэд Гэрэлийн уруул нь хөдөлж таталдан байснаа:

- Тийм нөхөртэй. Та нарыг харахад би нөхөртэй. Арван зургаа настай байхад минь тавин настай Довчин худалдаж авсан. Яг мал шиг. Гэвч би мал биш хүн болохоороо сохор боол нь болоогвй. Надад хайрлах, баясах хувь заяагвй гэж үү гэж хашгиран хэлэхэд хоёр нүднээс нь зовлон жаргалын нулимс мушгиран урсав.

Эрдэнэ энэ хүүхний занг зэмлэж, жигшин байжээ. Гэтэл энэ үгийг сонсож, байдлыг хараад сэтгэл нь уярав. Учир нь Довчин, Гэрэл хоёрын ялгаа даанч тод байлаа.

- Ёсолж авсан нөхөртэй хүн болохгвй шүү дээ гэж Эрдэнэ зөөлөн дуугаар хэлэв

- Ёсолж авсан нөхөр өө. Танд тийм байх. Үнэндээ бол худалдаж авсан эзэн минь гээд Гэрэл өнгөнэтэл уйлав.

Гэрэлийн энэ үг үнэн үг байлаа. Эрдэнэ яахаа мэдэхгвй дэмий л хавчигнан уруулаа долоон байв.

- Дүү минь уйлаад хэрэггвй амьд явсан хүн алтан аяганаас ус уудаг юм гэж Эрдэнэ хэлсэн боловч өөрөө энэ үгэндээ итгэхгвй байлаа. Гэрэл зогсолтгвй уйлаад байхаар нь Эрдэнэ нулимсыг нь арчин аргадав. Түүнээс эхлэн Эрдэнэ Гэрэл хоёрын хооронд дотно харьцаа

тогтон зовлон жаргалаа ярилцдаг болов. Өрөвдөхөөс хайрлахад ороход тун ойрхон зай байдаг ажээ. Эрдэнэ өөрийн амьдралыг ярьж өгөхөд Гэрэл их анхааралтай сонсож байснаа: - Хэрэв би тан шиг нөхөртэй бол хар хvүдий vүрээд хорвоо тойрохдоо vүргэлж инээж явна гэлээ.

- Хvн эхлээд ингэж л хэлдэг юм. Гэвч амьдрал тийм биш шvү гэж Эрдэнэ хариулжээ. Нэг орой Довчин эхнэртэйгээ ярьж байснаа Эрдэнэ бол гэгээн цагаан өдөр Луу гvний баян Итгэлтийг дээрэмдээд зугтсан оргодол гэнэ. Тохиолдсон газар нь барьж аваад Луу гvний хошуу тамганд хvүргэж өг гэсэн бичиг vзлээ. Оргодлыг нууж байгаад мэдэгдвэл дэмий юм болно гэж хэлэв.

Эрдэнэ, Итгэлт хоёрын хооронд юу болсныг мэдсэн Гэрэл баахан бодол болж сууснаа:

- Муу дур нь хvрвэл, тахиж байгаа бурхнаа босоо ороолон болгодог, сайн дураа хөдөлбөл хvн алсан яргачинг бурхан болгодог башир аргыг мэднэ. Эрдэнийн нэрийг өөрчлөөд хөдөө мал дээрээ гаргана. Хэн ч мэдэхгvй. Харин баригдах юм бол vxэж орхино шvү гэлээ. Ингээд Эрдэнэ нэрээ өөрчилж Доной болоод Довчингийн хөдөө мал дээр гарлаа.

Довчингийн хувьд бол Эрдэнийг барьж өгөхөд бэлхэн байлаа. Гэвч одоодоо Гэрэл өөрийнх нь болохоор тvүнийг барьж өгч болохгvй мэт санагдав. Гэрэл юу ч хийхээс буцахгvй гэж Довчин боддог болохоор «харин баригдах юм бол би vxэж орхино шvү» гэсэн vгийг нь дэмий vг биш гэж хатуу итгэж байжээ.

Нэг бvдрэхэд долоо бvдэрнэ гэгчээр Эрдэнэ морь уургалж байгаад унаж хөлөө хугалжээ.

Yүнийг сонссон Гэрэл дан морьтой давхин очив. Эрдэнэд тусгай гэр бариулж өөрөө сувилан дэргэд нь байдаг болжээ. Зарц нараа барьж идчих гээд байдаг Гэрэл Эрдэнийн дэргэд байхдаа хайлсан тугалга шиг эелдэг зантай, өчvүхэн булбарай эмэгтэй болдог байлаа. Намайг аваад хэн ч мэдэхгvй хол газар оргооч гэж заримдаа Гэрэлийн гуйхад «Дэмий юм битгий ярь» гэж Эрдэнэ хариулдаг байжээ. Гэрэл бол яг л өөр шиг нь амьдралд доромжлогдсон амьтан гэж Эрдэнэ бодож тvүнийг vнэн сэтгэлээс өрөвдөж байвч янаг хайрын сэтгэлээ тэр хvүхэнд өгсөнгvй.

- Чиний зовлонг ойлгож байна. Тэгээд ч чамайг vнэнээсээ өрөвдөж гэж Эрдэнийг ярихад Гэрэл тасалж

- Надад өрөвдөх нинжин сэтгэлтэй хvн хэрэггvй гэлээ.

Гэрэл арчаагvй ядарсандаа оргож зайлж чадахгvй Эрдэнээс аврал гуйж байгаа хvн огт биш.

Хэдийгээр Довчин мөрдөх хөөх, өшөө хонзон авна гэж хөөцөлдөхийг мэдэж байсан ч дуртай цагтаа vнэтэй юмыг нь аваад оргон зайлж чадах байжээ. Гэтэл vүнийг хийгээгvйн учир бол Довчингийн гэр, хөрөнгөнд бvрэн эзэн болж, өдий төдий зарц нарыг өөрийн дураар захиран чичрvүлж алт сувдыг дураар эдлэн, өмссөн зvүсэнд нь хvрээний гоё эхнэрvүд атаархан, найр хуримын голд суун яваагаа жаргалын дээд гэж бодож явжээ. Гэтэл Эрдэнэтэй учирснаас хойш хvний жаргалд хөрөнгө мөнгө, эрх ямбаас өөр зvйл байдгийг ойлгож, тэр нь өдөр өнгөрөх тутам их болж байлаа. Довчинд илvүлж торгон дээл өмсөж, дуртай хоолоо идэж байснаас Эрдэнэд зодуулж, уранхай навтас нөмрөн гуйлга гуйж явбал жаргал мэт бодогдож, тэр жаргалыг олж авах гэж чадах бvхнээ хийж байлаа. Энэ учраас Эрдэнээс өрөвдөл, нинжин сэтгэл хvссэнгvй. Харин сэтгэлийн хайр, янагийн халуун зvрх гуйж байлаа.

Өөрийгөө хууран сэтгэлээ тэжээж байсан юмыг нь авч орхино гэдэг чинь хvний жаргалыг булаан аваад таягдан хаяна гэсэн хэрэг. Чи миний тийм юмыг авч хаялаа. Гэхдээ оронд нь юу ч өгөхгvй байна. Эсхvл чи хvний адаг, эсхvл vлэмж сайн хvн, надад чамайг ойлгох чадал алга гэж Гэрэл нэгэн удаа гомдолтой хэлжээ.

Архи уугаад мансуурч байхдаа хvн жаргаж байгаа юм шиг байдаг. Харин маргааш нь толгой

нь өвдөөд тарчилж эхлэхдээ юунд ч тэр хар усыг уулаа даа гэж боддог юм. Гэдсэнд чинь хоолгвй мөрөнд чинь хувцасгвй болоод ирэхэд энэ гуйланчинг гэж намайг жигшинэ чи. Хэрэв чи байгаагвй бол би амьдралд хууртаад жаргалтай хvн шиг өнгөрөх байсан. Би ямар нvгэл хийснээс энэ хорвоо дээр чи төрсөн юм бэ? гээд Гэрэл нvдэнд нь нулимс бvрхэн Эрдэнийн дэргэд сууж байж билээ.

Эрдэнэ бол Гэрэлийн халуун vгэнд итгэж чадахгвй байжээ. Энэ хvvxэн сэтгэлийнхээ халуундаа ингэж байна. Хэдэн өдөр надтай хамт зовох юм бол Довчингийн хөрөнгө заавал бодогдоно. Тэр вед хамгийн заналт амьтан нь гуйлгачин Эрдэнэ болно гэж боддог байжээ. Эрдэнийн хvйтэн зvрхийг ойлгох тутам Гэрэлийн хvсэх мөрөөдөх сэтгэл оргилж арга нь барагдана. Ярих дургвй хэвтэн юм бодож байгаа Эрдэнийг арга нь барагдсан боловч хvсэл нь шатсан нvдээр ширтэж байснаа «эхнэр хvvxдээ бодож байна уу» гэж атаархсан сэтгэлээс асуудаг байлаа.

Өөр юу бодох билээ дээ гэж Эрдэнэ хэлэхэд Гэрэлийн царай цайж, хөмхийгөө тасартал хазна. Эрдэнэд хvв, эхнэр нь дахин дахин бодогдон сэтгэлийг нь зовоодог байжээ. Заримдаа Долгорт дэндvв хатуу зан гаргаж хvний нутагт хаяснаа бодоход vлэмж буруу хэрэг хийсэн мэт санагдана. Гэвч vvний хажуугаар Итгэлтэй нийлж ариун сэтгэлийг нь доромжилсныг бодоход бузар эмийг өршөөж огт болохгвй санагдана. Нэгдvгээр бодол нь дийлсэн цагтаа Гэрэлийг харахаас дургвй хvрч, Гэрэл бол амьдралд нь хор хvргэсэн шиг бодогдоно. Хоёрдугаар бодол нь дийлсэн ведээ Гэрэлтэй удтал ярьж, заримдаа тvvний гарыг барьж суухад Гэрэлийн бие чичрэн татвал тасрах утасны vзvvрээс барьж байгаа хvн шиг чанга амьсгалахгвй суудаг байжээ. Эрдэнийн биеийг бvр сайжруулахад Гэрэл хvрээ рvв буцсан бөгөөд Эрдэнэ өвөл нь адуу хариулж хавар Гэрэлийн дуудсанаар хvрээ оржээ.

### III

Тамирын хөндий өвлийн баринтгаа өмсөж, сэвсгэр цасанд дарагдсан мод, дах нөмөрсөн манааны өвгөн шиг нэвсийн харагдаж байлаа. Тамир мөсөөр хучигдаж, зарим газар нь хvйтэн харз жирвэлзэн урсаж, хөх уур савсан манарна.

Итгэлтийн хот Тамирын хойт талын өргөн амных эхэн дэх өвөлжөөн дээр харлан харагдана. Цасанд дарагдсан талыг алсаас харахад ямар ч өөгвй мэт байвч яваад vзэхэд хонхортой, гvдгэртэй байдгийн адил Итгэлтийн хотыг гаднаас харахад өөрчлөгдсөн юмгвй мэт боловч vнэндээ өөр болсон юм арвин их байлаа.

Намар Итгэлт vxрийн наймаанд Павловтой хамт явахдаа Долгорын орж, цай ууж удтал ярьж байснаа, «Долгор минь аль бvр ганцаараа хоосон гэрт уйтгарлан суух вэ. Ганц мод гал болдоггвй ганц хvн айл болдоггвй. Галсан та хоёр нийлбэл хэн хэндээ тvшиг болох байх даа. Миний хувьд бол чамайг орхихгвй» гэлээ.

- Чамаас болж би нөхрөөсөө хагацсан. Одоо намайг эрлэгийн очуульа гэж бодоогвй юм бол энэ юмаа дахин битгий яриарай гэж Долгор хариулжээ.

- Давахгвй гэсэн даваагаар гурав давдаг юм даа гэж Итгэлт хэлээд хvйтэн инээмсэглэхэд нь «надтай зөрөөд ч гялайхгвй байхаа» гэсэн дээрэнгвй бодол нvдэнд нь тод байлаа.

Энэ тухай Итгэлт хэд дахин Долгорт хэлсэн боловч хvчилсэнгвй. Гэхдээ Долгороос айж, тvvнийг өрөвдсөнөөс биш, нэгдvгээрт яарах хэрэггвй байв. Хоёрдугаарт ганц бие эмэгтэй удах тутам номхон болно гэж бодож байлаа.

Энэ хотод Долгорын зовлонг хуваалцдаг хvн гэвэл Нямаа Хишигт хоёр байсан. Заримдаа «Эрдэнэ чинь ирэх байлгвй дээ» гэж Долгорын сэтгэлийг засна. Заримдаа «Хvв минь нутагтаа буц. Тураг ядрахдаа уул барааддаг, хvн ядрахдаа төрхмөө барааддаг» гэж зөвлөнө. Нутагтаа очоод би яах юм бэ? гэж Долгорын асуухад хоёр хөгшинд өгөх хариу байдаггвй.

- Эм хүний зовлон барагдахгүй дээ гээд Хишигт уйлахад «Зөнөг минь битгий хvvхэд уруу тат» гэж Нямаа зэмлэнэ.

Заримдаа Нямаа дал түлж, есөн зоос гvйлгэн мэргэлэж өгдөг байлаа. «Эрдэнэ чинь сайн явж байна. Хөл нь эргэх төлөвтэй. Ялимгvй цагаан саад байна. Удахгvй сураг сонсох байх» гэж хэлэхэд нь Долгор хязгааргvй баярлана.

- Наадах чинь заримдаа сvрхий мэддэг юм шvv. Ирнэ гэж бууж байгаа бол ирнэ шvv хvv минь гэж Хишигт Долгорын сэтгэлийг засна. Долгорын зовж шаналж байгааг хараад Должин бах нь ханаж дотроо хязгааргvй баярлавч Итгэлтээс айгаад энэ бvхнийг мэдэхгvй хvн болж нvдэн балай, чихэн дvлий мэт явдаг байжээ.

Ингэж байсаар өвөлтэй золгож, нэг өдөр Итгэлт орж ирээд «Долгор чи хvvхдvvдийн хоолыг хvргэж өгөөд ирэхгvй юу» гэжээ.

Долгор vvнийг дуртай зөвшөөрч, хайнаг тэргэнд vхэр хонины мах ачиж аваад Заяын хvрээний зvг явжээ. Морь алдахынхаа урд орой буугаад, алгын чинээхэн майхандаа инээлдэн хөгжилдөж байсан газрынхаа дэргэдvvр гарлаа.

Амьдралдаа жаргаж vзсэн бол энд л жаргалын нар байсан мэт бодогдоод нулимс бор хацрыг нь дагаж урсана. «Урьд насандаа ямар нvгэл хийснээс энэ насандаа ингэж зовлон эдэлдэг юм бэ? Лам багш гурван эрдэнэ минь намайг харахгvй яагаа вэ» гэж бодоод бvр енгэнэн уйлав. Хайнаг нь чиний зовлон барагдахгvй шvv. Би ч чамд тусалж чадахгvй гэсэн юм шиг жигд алхлан толгойгоо хаялна. Хоёр хар хэрээ дээгvvр нь өмнө хойноо орон хөгжилдөж гуаглан өнгөрөв. Цагаан цасанд дарагдсан Тамирын хөндий ертөнцийн зовлонг харах ч vгvй сонсох ч vгvй гэсэн бодолтой дvлийрэн vргэлжилнэ. Эрдэнэ минь чи намайг өршөөгөөч. Би чамд огт муу санаагvй шvv гэж хашгирахад хайнаг нь цочин vргэж ухасхийснээ дахин жигд алхав. Доошоо газар хатуу, дээшээ тэнгэр хол болохоор уйлан vймрэн явсаар орой болоход айлд хонож өглөө эрт хөдлөв.

Үдийн хирд Заяын хvрээ рvv орж гэвш ламын хаалган дээр зогсон, бага хаалгыг нь түлхэн ороход том хонх дvнгэнэн дуугарав. Гэрийн vvd нээгдэж Хонгорын толгой цухуйгаад:

- Долгор эгчээ гээд гvйснээ гэнэт зогсов.

«Хvv минь гараад ирэхгvй яасан юм бол» гэж бодоод Хонгор өөд алхах зуур ажиглавал тэр нь ойртох тутмаа толгойгоо унжуулаад байлаа. Хvv минь зvгээр байгаа даа гэж сэтгэлд нь олон янзын хагас дутуу хар бодол жирэлзэн өнгөрөв.

- Бат нь хаачаа вэ? гэж Долгор ер бусын зэвхий дуугаар асуув.

- Бат байхгvй.

- Юу яасан бэ?

- Богдын хvрээ орж, ном vзэх гээд явсан. Багшид битгий хэлээрэй гэсэн юм шvv гэж Хонгор нам дуугаар гонгинон хэлэв.

- Хэзээ явсан бэ? гэж Долгор асуусан боловч юу асууснаа ойлгосонгvй. Хонгор юу гэж хариулсныг сонссонгvй. Долгор буцаад согтуу хvн шиг найган явахад нь Хонгор нэг явах гэснээ зогсов.

Хvvтэй нь хамт байгаад ганцааранг нь явуулсандаа гэмшин, Долгороос айсан сэтгэл тvvнийг татан зогсоожээ. Нилээд удаан зогсож байгаад хойноос нь гарвал мах ачсан тэрэгтэй хайнаг их хаалганы нь том төмөр гогцооноос уяатай зогсож байна.

— Долгор эгчээ гээд ийш тийш харвал байсангvй. Сандран ийш тийш баахан гvйсэн боловч олдсонгvй.

Энэ хооронд Долгор өөрөө хаашаа явж байгаагаа мэдэхгvй гэлдрэн явсаар байлаа.

Дайралдсан хvн галзуу, согтуу нь vl мэдэгдэх хvvхний замаас зайлна.

Лоовууз нь цасан дээр унахад Долгор мэдсэнгвй явсаар л байлаа. Нүд нь гөлрөн, үс нь салхинд сэвэлзэн хийсэж явахад Долгор юу ч бодсонгвй. Гүвний ухаан санаа юм бодох сөхөө ч үгвй байлаа.

Заяын хүрээний баруун өмнөх Мааньтын шилээр гараад жижигхэн ам уруудахдаа хоёр дахин бүдэрч унасан боловч арай ядан босов.

Урд Тамирын эрэгт тулж очоод зогссонгвй. Мөсөн дээгүүр цас шажигнуулан явжээ. Өмнө нь байгаа уур савсан харз ч Долгорыг зогсоосонгвй. Нэг гишгэхдээ гүн усанд гишгээд далд орлоо. Гар нь хоёр дахин гялалзаад зузаан мөсний доогуур шурган алга боллоо.

Долгорыг цүлхийн ороход буцлан долгиолсон Тамир хэдэн мөчийн дараа юу ч болоогвй юм шиг уур савсуулан мэлтэлзэж байлаа.

Хорвоо! Чи хүний зовлонд цадах болоогвй юу!

IV

Өөлд бэйсийн нутагт үлэмж цас орж зуд болоод амьд амьтан тогтохын аргагвй болоход хэсэг айл Луу гүний нутгийн зах руу нүүв.

Турж эцсэн малаа замын нэг цувуулан хаясан нүүдэлчид Тамирын захын бургасанд нөмөр дагаж хатгуур барин буудаллаа.

Энэ жил Луу Гүний нутаг өнтэй болохоор бэлчиж байгаа тарган малыг хараад нүүдэлчид «Сайхан аа төлөгний сүүл хүртэл бундайгаад харав уу» гэж ярилцан өөрийн нум болсон малаа хараад санаа алдана.

Нүүдэлчид дээр хөлөрч цан болсон тарган морьд унасан нэлээд согтуу хоёр хүн давхиж ирлээ. Энэ бол Итгэлт, Бадарч хоёр байжээ.

«Амгаланг айлтгая» гэж үнээ өргөн босгож байсан хижээл насны хар хүн хэлэв.

Харь хошуу нутагт аргагвйн эрхэнд орж ирсэн нүүдэлчин хэзээ, хэн ирж хөөх бол гэж харагдсан бүхнээс айж байжээ. Энэ учраас уур савсаж, толгойгоо хаян амгайгаараа тоглосон морьдтой хоёр хүнийг царайчилж эхлэв.

«Хүний нутагт зээр шиг дураараа сэлгүүцэж явдаг аль газрын цагаач вэ?» гэж Бадарч бүдүүн дуугаар зандран хэлэв.

«Бид өөлд бэйсийн албат нар, зуданд хөөгдөөд явж байна» гэж хүйтэн, нас хоёрт дарагдсан чавганц дорой дуугаар хариулав.

«Гийчид бидний хар хатгуурт залран орж сархад тогтоохыг хүсье» гэж нэг хар хүн хэлээд зогсож байсан хоёр залуу руу хандаж:

— Гийчдийн морийг уя гэлээ.

— Ороод мордох уу даа гэж Итгэлтийн хэлэхэд Бадарч дуртай дургвй буув.

Намар алсан тарган хонины мах чанаж, нэрмэл архи халааж хоёр зочныг дайлав.

-- Хэдэн малаасаа салаад ядрахдаа л ингэж харь нутгийн зах руу нүүдэллэн явна. Монгол ах дүү болохоор туслах л байх гэж нөгөө хар хүн мөнгөн аяганд халуун архи хийж Итгэлтэд барих зуур хэлэв.

-- Бид ч хөөхгвй. Бас бусдыг ятгахыг оролдъё. Гэвч Луу Гүний албат олон. Олон хүн сайнтай муутай байдаг шүү дээ. Энэ хүнийг та бүхэн таних уу? Луу гүний баян Итгэлт гэдэг хүн дээ. Нутаг олондоо хүндтэй, үг нь жинтэй гээд Бадарч хар хүн рүү нүд ирмэлээ.

Итгэлтэд хахууль өг гэсэн Бадарчийн санааг хар хүн ойлгож мэдээд авдар руугаа эргэж хэсэг шуухитнаснаа эргэв.

-- Итгэлт таны алдрыг эрт дээр сонссон боловч танилцах завшаан олдсонгвй. Өнөөдөр миний бор овоохойд нар гийгүүлэн морилж ирсэнд өчүүхэн би баярлавч баршгвй. Тантай танилцсаны өчүүхэн бэлэг барья, тогтоож хайрла гэж хуучирсан Аюуш хадган дээр жинхэнэ



тойгон ембvv тавьж барив.

Итгэлт тоомжиргvй хумхин авч шууд өвөртлөв. Өвгөн бас нэг соном хадаг гаргаж Бадарчид барив.

Хошуу түрvvлсэн Баян гvнгийн шадар тахар хоёрт тал зассанаар Луу гvний нутагт хэд хонох боломжтой болов гэж сэтгэл нь тайвширсан хар хvн нутагтаа болсон нинжин сэтгэлгvй зудын тухай толгой сэгсрэн ярив.

Тэндээс Итгэлт Бадарч хоёр нэлээд архи ууж аваад мордож, замдаа Бадарч байн байн Итгэлт рvv харж заримдаа уруулд нь инээмсэглэл, заримдаа нvдэнд нь гvн бодол төрж явав. Бадарч олон юм бодсонгvй. Зөвхөн л Итгэлтийн авсан тойгон ембvvний хагасыг ямар аргаар салгах вэ гэж бодож явлаа.

-- Итгэлтээ олзыг олуулаа гэдэг биш билvv гээд хоолойгоо паржигнуулан худал инээв.

-- Шагай шиг юмыг хуваах юу байх вэ? надаас нэг эм хонь аваарай гэж Итгэлт морио зөөлхөн гуядав.

Аз хvv байвал ёоз хvvгээр хожно гэгчээр аманд сул орж байгаа ганц юманд ганц эм хонь ч хаа юм бэ гэж Бадарч дотроо баярлан явжээ.

— Бадарч аа олз vнэртээд байна.

— Хаанаас!

— Маргааш орой хэдэн хvнтэй мордоод эднийг идэж орхиё.

— Хэнийг?

-- Хэнийг байх вэ дээ. Энэ нvvдэлчдийг. Бадарчийн барзгар нvvрэнд шуналын гал манаран оволзож саран хайнагийн бvдvvн дуугаар орчмын бургасыг донслуулан инээв.

«Буянтай хvний ухаан булаг шиг л байдаг байна. Үнэхээр юм олж болох нь байна шvv» гээд давирахад морьд улам хурдлав.

Өмнөөс нь хvйтэн салхи vлээвч, дотроос нь халуун архи тарган мах жигнэж морьдын хөлөөр нь бөөн бөөн цас шидэгдэн явахад сэтгэлд нь ядарсан нvvдэлчингээс дээрэмдэн авах их олзны зэрэглээ харагдан морьд улам хурдлах бvрд тодорч байлаа.

Маргааш орой нь Итгэлийн гаднаас урт урт ташуур барьсан хорь гаруй морьтой хvн нvvдэлчдийг хөөхөөр мордох болов. Тэднийг Итгэлт, Бадарч хоёр толгойлжээ.

— Нөхөд минь хэрэггvй. Хэний ч нутагт зуд болж магад гэж Нямаа хориглов.

— Өглөгч хvн өөртөө хоосон гэж Итгэлтийн хэлэхэд хvmvvc инээлдэв.

— Цаана чинь ядарсан монгол ах дvv нар байхад хуваагаад идэж болох нутгийг харамлах хэрэггvй юм биш vv Итгэлт минь гэж Нямаа хэлэв.

— Тэр vнэн боловч Өөлд бэйсийнхэн хvний нvнжиггvй амьтад. Халхыг хvйс тэмтрэх гэсэн Галдан бошигтын шавхруунууд гэж Итгэлт их л мэдэмхий хэлэв.

- Бошигт хаан чинь их л ухаантай хvн байсан гэдэг шvv гэж Хишигт авгай хэлэв.

- Энэ хvний vг туранхай ямааны шөл хоёр ижил гэж Бадарч хэлээд өөрөө чанга инээв.

- Юу ч гэсэн би энэ хэрэгт чинь оролцохгvй, ер нь ч өнөө шөнө ажилтай гээд Нямааг дуудах вий гэсэн бололтой эргэж түргэн алхав. Зугтаж байгаа Нямааг хараад «Могой алахад мод нэмэргvй» гэж Итгэлт бодов. Тарган бөгөөд амгалан морьтой хvmvvc нvvдэлчдийн ойролцоо байгаа бургасанд орж ирэхэд vдшийн бvрэнхий эхлэв. Хөлөрсөн морьд нь цангаар бvрхэгдэн Итгэлтийн унасан хилэн хар морь хvртэл буурал болжээ.

- Бууцгааж олмоо чангал гэж Итгэлтийн хэлэхэд бvгд мориноосоо бууцгаав. Хvmvvcийн сэтгэл хөөрөн зvрх нь цохилно. Бургас битvv дуугаар шуугин Тамирын мөс тас тас хагарна. Морьдын тогтон ядан хөдлөх хөлөөр цасны ширхэг хяхтнан шажигнаж хvйтэн цагийн гvн хөх тэнгэрт одод мичид гялалзана.

- За та минь эсэргүүцвэл цохилно шүү гэж Бадарч түмэн цэргийн жанжин их тулалдаанд орохын өмнө цэрэгтээ тушаал өгч байгаа дуугаар хэлээд мориндоо мордов. Хүмүүс явсаар нүүдэлчдийн гэрт тулан очиж зогсов. Олон морьдын хөлийн чимээнээр гэрээс хүмүүс гарч ирцгээв.

- Луу гүний албат нар нутгаасаа та нарыг хөөх гэж ирлээ. Өөлд бэйсийн гуйланчид түргэн зайлцгаа. Одоо ачаалахгүй бол хэрэг түвэг гаргана гэж Бадарчийн бүдүүн дуу харанхуйн дунд тэнгэрийн аянга шиг цуурайтав.

«Миний дуу ч ёстой нэг эр хүний дуу шүү. Энэ гуйлгачин нарын сүнс лав зайлсан байх» гэж бодоод дотроо инээв.

- Та минь бүгд зуданд ядарсан улс гэж нүүдэлчдийн нэг хариулав.

- Зуд болгосон нутгийн сахиусандаа гомд гэж Луу Гүнийхний араас нэг нь шингэн дуугаар хэлсэн нь Итгэлт байв.

Хүний нутагт орж ирсэн нүүдэлчид хэсэг дуугүй нам болов.

- Нүүж чадахгүй. Харсаар байтал чинь аргагүй болсон улс байна гэж нүүдэлчдийн дотроос шийдэмгий хэлээд Бадарчид ойртов. Бадарч бүдүүн суман ташуураа далайн толгой руу нь цохисонд тэр хүн хөлдүү газар падхийн унав.

- Задарсан гуйлгачингуудыг дэлсээд бай гэж Бадарч царгил дуугаар хашгиран хөдлөв.

Нүүдэлчин олдсон юмаа барин хамгаалж эхлэв. Эхнэр хүүхэд хашгиран уйлж зуданд цадсан тарган ноход хуцалдан цохиулсан хүмүүсийн ёолох дуутай нийлж зүрх зүссэн авиа үүсэв.

Гэвч улайрсан хүмүүс хашгиралдан бие биеийг хайр найргүй цохиж байв.

Эмс, хөгшид хүүхдээ тэврэн бургас руу зугтав. Нүүдэлчид хэдийгээр зоригтой тэмцэлдсэн боловч тарган морьтой бүдүүн ташуур барьж бэлтгэсэн хорин хэдэн дээрэмчдэд дийлдэн, зарим нь цус нөжөө цувруулан гэр орноо хаяж бургас руу ухарцгаав.

Хүмүүс цохилдож байхад Итгэлт Бадарч хоёр эзгүй гэрүүдээр орж өнгөтэй, өөдтэй бүхнийг цөлмөв. Луу Гүнийхэн аргамж сур, гэрийн бүслүүр, хурган дотортой дээл зэрэг юм авсан боловч Итгэлт, Бадарч хоёр шиг алтан бөгж, эхнэр хүний толгойн хэрэглэл, эмбүү мэт чанартай юм олж авсангүй бөгөөд хоёр гайхлын юу авсныг ч хэн ч мэдсэнгүй.

Энэ зодооноос болж хэдэн хүн хүнд шархдав. Харин аз болж хүний амины хэрэг гарсангүй.

Луу гүний, Өөлд бэйсийн хоёр хошуу нийлж зарга хэлэлцсэн боловч хохирсон улсын юмыг эргүүлж өгсөнгүй. Идсэн улсын завшаан болж хоёр хошууны түшмэд хэрэг нийлэх нэрээр хэд хоног тарган хонины мах идэж, цэц булаалдан, айраг ууж байгаад таржээ.

## V

Тал нутгийн юм бүхэн шижрийн өнгөөр гялалзсан алтан намрын нэгэн өглөө жижигхэн толгойн энгэр дээр ганц бор гэр байгаа нь тарган хүний хүйс шиг харагдана. Гэрийн тооноор аргалын хөх утаа гарч цэнхэр тэнгэрт өнгө нийлэн замхарна.

Өмнөх хөндийд налайн идэж байгаа хонины толгой гэрийн зүг чиглэжээ. Хоньчин нь байн байн бор гэр рүү харж морио хөтлөн хонины эргэсэн хэсгийг гэрийн зүг алгуурхан гилнэ. Гэрээс хуучин цэнхэр дээлтэй залуу гээгт гараад хонь руу ажиглах харснаа инээмсэглэв.

Энэ хүүхний гөлгөр бор нүүрний ширхэг бүрээс баяр, хөгжил бадарна. Гэзгээ сурамгай хөдөлгөөнөөр засаж, овоолттой аргалаас хормойлон аваад гэрт орох завсраа хонь руу хэд дахин харж, харах бүрдээ инээмсэглэж байлаа. Цог жавхлан, баяр жаргал арван тавны сар шиг толилзсон нүүрэнд нь багтаж ядсан энэ гээгт бол Дулмаа байлаа. Зовсон хүнд уурлах шалтгаан мундахгүй байдгийн адил жаргалтай хүнд инээх учрал захаас аваад бэлэн байдаг билээ.

Дулмаа амьдралаас их юм горьдоогүй бөгөөд зөвхөн хvнд юуны өмнө эд биш хvн гэж харагдах, янаг хайрын сайхан шимийг хvртэх гэж мөрөөдөж явлаа. Одоо энэ хvсэл нь биелжээ.

Итгэлтийн доромжлол, жигшилт Галсангаас салж Төмөрийг дагаж гарснаас хойш жил гаруй болжээ.

Зуны дунд сарын арван наймны сар гарахын вeд Төмөр болзсон газраа арван хэдэн согоо шиг морь туусаар иржээ. Төмөр өнгөрсөн жил Дулмааг дагуулж яваагvйн шалтгаан бол орон гэргvй шилээр нутагтай хvн энэ эмэгтэйг дагуулж яваад жаргуулж чадахгvй, тэнvvлийн зовлонд унагана гэж хайрласнаас болжээ.

Дулмаа юуны өмнө Эрдэнэд тохиолдсон зовлонг ширхэгчлэн ярихад Төмөр хөмсгөө атируулан дуугvй сонсож байгаад «Эрдэнэ минь барагтай юманд хөнгөн хөдлөхгvй хvн юмсан» гэлээ.

Төмөр ганц ахаа өрөвдөж, тvвний зовлонг хуваалцаж чадахгvй байгаадаа гомдож байлаа. Ах нь харь нутагт доромжлогдож, ор сураггvй алга болсныг бодоход тvвнийг доромжилсон бvхнийг vнсэн товруу болгосоор бодогдоно. Гэвч өөртэй нь уулзалгvйгээр хөнгөн хөдөлж боломгvй ажээ.

Ингээд аргагvй болж Луу гvний нутгаас Дулмааг дагуулан гарч шууд довтлон явсаар хэд хоногийн дараа Баатар бэйлийн хошуунд Төмөрөөс олон удаа хишиг хvртсэн хоёр хөгшний гадна барьж орхисон дөрвөн ханатай гэртээ очжээ.

— Чи надтай суух дургvй бол сэтгэлээ битгий албадаарай. Ямар нэгэн сэв байвал надаас бvв нуу. Энэ гэр, энэ морьд цөм чиний хөрөнгө гэж Төмөрийн хэлэхэд Дулмаагийн нvднээс нулимс асгаж хэсэг дуугvй байснаа:

— Би чамд хязгааргvй хайртайгаа хэлсэн. Гэвч би vнэгvй хvн, шавхруу шvв дээ гээд дуу нь хоолойндоо тагжрав.

Ингээд тэр хоёр сууж билээ. Намар нь Төмөр адуу хөөхөөр алс газар явах болоход нь Дулмаа уйлан хориглож зогсоов. Ер нь Төмөрт ч явах оргилсон хvсэл байгаагvй. Хайрт хvнтэйгээ хамт амьдрах, хvнд хайрлагдахын гvн жаргалд сэтгэл нь дэвтсэн Төмөр өдөр өнгөрөх тутам тэнvвч амьдралаас холдож, эхнэрээс нь vнэтэй, дотно юм сэтгэлд нь vгvй болжээ. Нутгийн нэгэн баян айлын хэдэн зуун хонь авч хариулав. Бас хэдэн морьдынхоо хоёрыг шилж vлдээгээд бусдыг нь vржлийн малаар солив. Ялангуяа Дулмаа хөл хvнд болсон нь Төмөрийг шинэ амьдралд улам бvр хадлаа.

Дулмаагийн хувьд бол энэ амьдрал хорвоогийн жаргалын дээд байлаа. Энэ учраас өдөр бvхэн энэ жаргалыг хэвээр байлгаж өгөхийг хvсэн залбирдаг байжээ.

Ингээд сэтгэлээр учирсан энэ хоёр бусад хvнд жижиг боловч, өөрсдөд нь vлэмж жаргалын төлөө зvтгэж эхлэв.

Хонио ихэнхдээ хамт хариулна. Аль нэгэн нь эзгvй цагт нөгөө нь хоолоо хийгээд идэлгvй хvлээнэ.

Хариулсан мал нь тарган сайхан орж хавартай золгов. Гэтэл гай болж нэг эр төлөг эрэг рvв унаад vхжээ. Эр эм хоёр ярьж байгаад өөрийн нэгэн хязаалан хонийг оронд нь тавих болов. Хавар өнгөрөөд зуны дэлгэр цаг ирлээ. Дулмаагийн хөнгөрөх цаг ч ойртон vрээ харах баярын хvсэл Төмөрийн сэтгэлийг гэрэлтvвч байлаа.

Нэгэн өдөр малын эзэн Баян мал тоолохоор хоёр хvн дагуулан ирлээ. Бусдын мал хариулсан хvн эзнийг нь ирэхэд аргагvй л хөл алддаг билээ. Баян хоосноор дvврэн энэ хорвоогийн жам болсон ёсыг Төмөр ч дагахгvй байж чадсангvй. Хонь гаргаж малын эзнийг дайлав.

- Өнгөрөгч хавар нэг хундан эр төлөг эрэг рvв нисэж vхсэн. Би оронд нь энэ хонийг

тавьчихъя. Дөрвөн шүдтэй юм шүү гэж Төмөр хонь тоолж байсан Баянд хэлэв.

- Баяны нүд солби татаж хөмсөг нь эрчлэн зангирснаа «Та нар л тэгж байгаа байх даа. Нас гүйцсэн иргийг минь цусалж орхиод түүнээ булах санаа байна уу? Би малаа гуйж хариулуулдаггүй. Миний малыг хүн гуйж хариулдаг юм шүү» гээд л бууж гарлаа. Төмөр үнэн явдлыг эвээр тайлбарлах гэж янз бүрээр үзэхэд Баян улам бүр ширүүсэж гуйланчин түүлэгчинд нь хүрлээ.

Ямар нэгэн яршиг төвөг болохоос айсан Дулмаа сандран «тэгвэл үүнийг өгье» гэж ганц байдаг эр хонио заасан чинь, зарц нарынхаа аль дөмөг юмыг элдэв аргаар луйвардаж сурсан Баяны омог улам догширч «Та нараас гуйж байгаа биш. Оногдсон буянгаа бачтай гуйланчин нарт идүүлэхгүй гэж байна. Өгье гэнэ шүү. Их гялайлгах нь» гээд Дулмааг түлхэж орхисон чинь ардаа байсан хөгнөнд тээглэн тас гэдрэгээ унав.

Төмөрийн нүд галзуу үхрийн нүд шиг дув дугариг болсноо царай нь чинэсэн, өргөн шанаа нь зангиран Баяныг огцом түлхэн үсрэн эхнэрээ тэвэрч авлаа.

Цахиур Төмөрийн уурласан гарт түлхэгдсэнээ янгинаж байгаа ясаараа ойлгосон баян уухилан босож зальтай нүдээр инээмсэглэн «Халх даяар нэрд гарсан эрийн уурлахыг харах гэсэн юм. Над шигт нь ахдах тоглоом боллоо» гэлээ.

- Тогоо шиг гэдэстэй эхнэрээр минь тоглоод яах нь вэ? гээд Төмөр Дулмааг гар дээрээ нандигнан өргөсөөр гэртээ оржээ.

Баян Төмөрийн эр чадал, зоригийг үг хайрлахгүй магтан тал засаж байгаад явжээ. Гэвч түүний дотор аймшиггүй зарцаас өшөөгөө авах хорт бодол оволзон элдэв арга сүвэгчлэн байжээ.

«Энэ хүн зүгээр орхихгүй шүү. Нүдний нь гүнд хорсол буцалж харагдсан. Бушуухан эндээс зайлъя» гэж Дулмаа уйлан хэлэхэд Төмөр гэнэн цагаан сэтгэлээр том шүдээ яралзуулан инээмсэглэж:

- Өвгөн минь. Эр улсын тоглоом. Би харин тоглосныг нь мэдэлгүй нам цохичих шахсан шүү. Бас тэгээд миний өвгөн хэзээ хэзээгүй хөнгөрөх гэж байхад хаашаа явах юм бэ гэж хариулдаг байлаа.

Дулмаа өвдөж, Төмөрийн бор гэрт шинэ хүн мэндэлснээ хашгиран зарлав. Хүүтэй болсон Төмөр түмэн баяр, мянган жаргалын булгаар дүүрч хэлэх үг, гишгэх газраа олохгүй байв. Нэхий өлгийтэй хэвтэж байгаа хүүгээ инээмсэглэн харж байснаа «Энэ лав над шиг мангар юм болно шүү» гээд паржигнуулан инээдэг байлаа.

Орж гарсан хүн хүүгий нь хараад «Эцэгтэйгээ ямар адилхан юм бэ» гэхэд учир тоймгүй баярлана.

Өдөр хонь хариулж явснаа оодонгийн үхэр шиг гэнэт давхиж гэртээ очоод намуухан унтаж байгаа хүүгээ харж инээмсэглэн буцахдаа «Эрдэнэ засгийн унага» аа чадлаараа хашгиран явдаг байлаа. Төмөр жаргаж, Төмөр инээж, Төмөр дуулж байхад түүний энэ жаргалын доогуур хорссон Баян зогсоо жолоогүй дарь булж, нэг өдөр түүнийг арван зүгт нь бутаргаан эвдэхэд бэлтгэж байжээ.

Төмөрт түлхүүлснийхээ дараахан найз захирагчийндаа айлчлан очиж цадиггүй зарцаас хариугаа авах тухай зөвлөн ярилцжээ.

-- Төмөрийг барихад шалтаг хэрэгтэй. Гэтэл бидэнд байхгүй. Бусад хошуугаар хэргийг нь сөхүүлбэ гэхэд оргодлыг жил дарсан хэрэг босож ирнэ. Бас тэгээд Төмөр болбол жирийн нэг эр биш. Өө сэв андахгүй чөтгөр гэж захирагчийн хэлэхэд «бүгж байгаа оргодол гээд л барьж аваад хонгоны нь махыг борвин дээр нь буулгаж орхихгүй юу» гэж Баян хэлжээ.

- Бас л тэгж муйхардаж болохгүй. Ямар ч болов нэг шалтаг гаргах хэрэгтэй гэж захирагч

буурал гэзгээ маажин хэлжээ.

Тэр хоёр хэсэг дуугүй суув. Том гэрийн дотор айраг архины исгэлэн үнэр ханхалж, ногоон ялааны дүнгэнэн дуугарах нэг хөгтэй дуу Төмөрийг эрүүдэх арга олоход нь саад хийх гэсэн юм шиг шуугина.

- Би нэг морийг минийх гээд заргалдвал яах вэ?

- Цаадах чинь хичнээн уравч хүлээхгүй. Тэгэхлээр чамайг ураг болно шүү дээ.

-- Тэгвэл ч давдаггүй хэрэг ээ

-- Захирагч нүдээ цавчлан, хааяа халуун архи шимэн хэсэг суув. Баян захирагчийн ам руу яс горьдсон нохой шиг далжигнан ширтэж байлаа.

-- Надад нэг арга байна. Гэвч даруйдаа хийж болохгүй гэж захирагч үг бүхнээ таслан маш аажим бөгөөд итгэлтэй хэлэхэд баяны нүүрэнд баярын туяа тодорчээ,

## VI

Намрын бүгчим өдөр Богдын хүрээ халуун там хоёр адил гэдэг үнэн ажээ. Эссэн бохир шаврын хурц үнэр хамар хорсон халуун агаар нар хоёр хэлэлцэж тохирсон юм шиг жигнэж, хувцас биед наалдан хар ялаа зай завсаргүй шавах нь тэсвэрлэхэд бэрх. Хааяа хуй босож хөлөрсөн биед шороо наалдуулна.

Ийм нэгэн өдөр Эрдэнэ Довчингийн хашаанд байшингийн саравчинд хийх юмгүй сууж байлаа. Бодолд нь төрсөн нутаг Сүхийн гол түвний алтан шар намар эргэлдэж, сэтгэл нь уйтгараар дүүрнэ.

Байшингийн довжооны хажуугаар ургасан бут ногоо үзүүрээсээ шарлаад амь тэмцэн, амьсгаа нь давхцаж байгаа мэт харагдана. Ганц хүн мод хөрөөдөж байгаа хоёр аялгуут чимээ гол тасрахын өмнө гэрээсээ өгч байгаа хүний амьсгаадах шиг сонсогдоно.

Арга барагдахдаа Гэрэлийн өгсөн самбуутай янжуурыг байн байн татавч огтхон ч тус болохгүй ажээ.

-- Та галаа өгөөч гэж хажууд нь хүн дуугарахад харвал нам зузаан биетэй бор эр уул нь цагаан байсан болов уу гэмээр алчуураар урсан гарч байгаа хөлсөө арчиж байлаа. Энэ бол нөгөө бидний танил Дорж юм.

Дорж одоо Хужирбулангийн цэрэгт байгаа бөгөөд өнөө өглөө чөлөө авч хүрээнд орж ирээд хэдэн мөнгө олох гэж түлээ хөрөөдөж байгаа ажээ.

Шүдэнз авч байшингийн довжоон дээр сууж тамхи , татах зуур:

-- Мөн бүгчим байна. Маргаашнаас орох л байх даа гэлээ.

-- Орох гээд л байх шиг гэж Эрдэнэ бөртөй ч үүлгүй тэнгэр рүү ширтэж байж хэлэв.

-- Уул нь танай хашаа ч цэлгэр зайтай юм байна гэж шинэхэн чирчүү дээл сугалдаргалан өмссөн Эрдэнийг энэ хашааны эзэн гэж бодсон Дорж эргэн тойрныг харах зуур хэлэв.

--Том хашаа гэж Эрдэнэ хариулах зуур янжуураасаа нэгийг авч Доржид өгөв.

Дорж янжуурыг асааж зуух зуур:

-- Дэндүү нялуун үнэртэй сэрүү татсан эд байна. Бодвол үнэтэй тамхи байх даа гэж ярилаа.

--Та түлээ хөрөөдөж амьдардаг хүн үү? гэж Эрдэнэ асуув. Үгүй би цэргийн хүн. Хэдэн мөнгө олох л гэж түлээ хөрөөдөж явна гэлээ. Дорж хариулаад янжуураа сорж утаагийг нь алгуур үлээснээ, - уул нь би Луу гүний хүн. Та манай нутгаар явж байсан уу? гэв. Эрдэнэ Доржийг ажиглан харснаа:

-- Явж байсан. Таны алдар хэн гэдэг бол гэж асуув.

-- Дорж гэдэг. Солгой Дорж ч гэдэг, урьд барилдахдаа солгой тонгордог байсан. Тэгээд л солгой нэртэй болчихсон гээд нүдэнд нь гашуудал гэрэлтэн, магнайн арьс нь үрчлэн зангирснаа нутагт хөгшин эх минь үлдсэн юм сан. Сүүлийн гурван жил огт сураг гарсангүй гэлээ.

-- Эхийн чинь нэр хэн гэдэг юм бол гэж Эрдэнийг асуухад Доржийн нүд сэргэж:

--Та манай нутгаар саядаа явсан уу? гэж асуув. Өнгөрсөн жил явж байсан гэж Эрдэнэ хариулаад хэрэггүй хэлэв үү дээ гэж бодлоо. Дорж баярлан, ойртож суугаад:

-- Буян гэдэг. Хоёр тамирын бэлчирээр нутагладаг. Баян Итгэлтийн хонийг хариулдаг чавганц шүү дээ гээд Эрдэнэ өөд ширтэхэд нүдэнд нь сайхан сураг сонсохыг хүссэн баярын горьдол, олиггүй хэл сонсохоос айсан болгоомжлол зэрэгцэн энэ хүн ямар юм хэлэх бол, муу ээж минь сайн байгаа болов уу гэсэн асуудал сэтгэлд нь орж гарч байлаа.

Эрдэнийн нүдэнд хүрдний дэргэд хэвтэж байсан чавганцын харц, харагдах шиг, хараал зүхэл нь сонсогдох мэт болоход өөрийн эрхгүй анивчив. Бас тэр ядарсан чавганцын үхэхэд гол гэмтэн нь би шүү дээ гэж бодогдоод энэ хүнээс бушуухан зугтмаар санагдав.

--Таних байх аа гээд Эрдэнэ дуугүй болоход Дорж гайхан харснаа гэдрэгээ болов.

-- Ээж минь сайн уу? гэж Дорж нам дуугаар асуув.

-- Бид хоёр эр хүн. Бие биеэс нуугаад яах вэ дээ Эх чинь..гээд Эрдэнэ үгээ тасалж доош харлаа.

Доржийн нүд нь гөлийж, хүрэн бор хацар дээгүүр нь нулимс урсаж байснаа «хэзээ бол?» гэж асуугаад санаа алдав.

-- Цаад жил бурхан болсон.

-- Хоёр тамирын билчрээр нутагтай, Буян чавганц мөн биз дээ. Баян Итгэлтийн хонь хариулдаг юм шүү дээ гэж Доржийн асуухад нь нүдэнд нь «тэгвэл биш» гэдэг үг хүссэн гүн горьдлого харагдав.

-- Тийм ээ, бурхан болсон гэж Эрдэнэ намуухан бөгөөд тод хэлжээ.

Доржийн нүд манаран гөлөрч нулимсны дусал буланд нь тунарч байснаа хацар руу нь доголжин дуслав. Ганц эхийнхээ толгойг түшиж чадалгүй, түвний үгийг сонсолгүй салсандаа гомдож, хоолойд нь бөөн хар юм тагларан сэтгэл нь юу ч бодолгүй хар гаслангаар дүүрч байв.

-- Таны алдрыг хэн гэдэг бол гэж Дорж гүн санаа алдсаны дараа асуув.

-- Миний нэр... Доной гэдэг гэж Эрдэнэ түгдчин хэлэн. Дорж босож түр зогссоноо,

- Доной гуай би орой ирээд түлээгий чинь хөрөөдөж орхиё. Заавал ирнэ гэж авгайдаа хэлээрэй гээд хашааны хаалга руу явжээ.

Үүнээс хойш Эрдэнэ Доржтой танилцав. Гэвч түвнд үнэн нэрээ хэлсэнгүй. Нэгэн өдөр зах дээр явж байгаад Доржтой дайралдав.

--Би нэг хөгшний ганц охинтой холбоотой болсон. Энүүхэнд бий. Доной гуай хамт очъё гэж Доржийн хэлэхэд Эрдэнэ дуртай дагаж явлаа

Замдаа Дорж цэргийн амьдралын зовлон. Хот газрын ширүүн амьдрал, амьтны түлээ хөрөөдөж чавганц охин хоёрын амьдралд тус болдог тухай ярьж байлаа.

-- Ингэж түлээ хөрөөдөөд хэд гурван мөнгө олох зав олдоод байдаг зүгээр юм даа гэж Эрдэнэ хэлэв.

--Тийм ч биш. Манай дарга гоймон Баатар гэж ядуу хүний зовлон мэддэг хүн бий. Бас тэгээд би цавчих, буудах, ялангуяа морин сургуульд овоо болохоор чөлөө өгдөг юм гэж Дорж хэлээд инээмсэглэв.

Доржийн хадмын гэрт очиход ижилхэн хөх даавуу дээлтэй хоёр эр сууж байв. Тэр хоёр

Доржийг хармагц босож нэг нь

-- Чамайг бушуухан олоод ир гэсэн. За явъя гэлээ.

-- Юу болоо вэ?

--Цэргийн яамны өмнө жагсаж очоод хоол нэхье гэж шийдсэн, Бид төрийн цэрэг болохоос гуйлгачин биш гэж тэр хvн хөмсгөө зангидан уруулаа шазалзуулан хэлэв. Тэгээд тэр гурвыг явахад Эрдэнэ сонирхон юу болохыг вээх гэж дагаж явлаа. Цэргvвдийн жагсан ирэхэд яамнаас тvшмэд унан гарч ирэв.

-- Та олон цэргvвд юу гэж явна гэж нэг тvшмэл юу болж байгааг огт мэдээгvй дvр вэвчлэн асуув.

-- Бид төрийн цэрэг болохоос биш гуйлгачин биш. Гэтэл бидэнд өттэй зовлогоор хийсэн хоол хэд дахин өглөө. Ингэж байж чадахгvй гэж олон цэргvвд зэрэг зэрэг хашгирав. Эрдэнэ тэр тvшмэлvвд энэ задарсан цэргvвдийг зад загнаж элдэн хөөх байх гэж бодож байлаа. Гэтэл цагаан жинстэй малгайтай хvн цэргvвд өөд элэгсэг инээмсэглэн «Олон цэргvвд минь тогтож айлд. Бид та бvхний хоолыг сайжруулан өттэй хоол өгсөн гэмтэнг цээрлvвлэнэ» гэж сандран хэлэв.

Тогосны өдөн отготой, магнаг дээл өмссөн, ширэвгэр хар сахалтай, нэг ноён яамнаас гарч ирээд цэргvвдийг тоомжиргvй ширвэн харж тамшаалав.

-- Өлсөх гэдэг vнэг гvйцэх боллоо. Хоол өг гэж хэлээд нэг цэрэг олны дундаас урагшлан гарлаа.

-- Дуугаа аяд. Чи ямар аймшиггvй цэрэг вэ гэж ноён сvр бадруулан хэлэв.

-- Хоол, Хоол. Бидний хоолонд халх дөрвөн аймгаас татаж авчирсан их юмыг өгөхгvй идэж байгаа хvнийг цээрлvвлж өгөхийг бид шаардаж байна гээд л цэргvвд ам амандаа хашгирч гарлаа.

Дорж олны дундаас давхин гарч «Хоол өгөхгvй юм бол бид яаманд дайран орно. Нөхөд минь орцгооё» гэлээ.

Ноёны царай агшин зуур хувирч, ихэмсэг омог нь салхинд vлээгдсэн мэт алга болж «Олон цэрэг та бvхний хоолыг сайжруулж өгөхийг бид амлая. Та бvхэн тайвширч хуарандаа буцагтун» гэж хэлэхэд магнай дээр нь хөлс бурзайж байлаа.

Цэргvвдийг тайвшран хуарандаа эргэж очихыг бас нэг лам залбиран байж гуйв. Ингээд цэргvвдийг тараахад Эрдэнэ Дорж хоёр буцав.

-- Та нарыг зvгээр өнгөрөөх болов уу? гэж Эрдэнэ асуухад Дорж тоомжиргvй инээмсэглэснээ:

-- Нэг хоёроороо ирсэн бол барьж аваад банздах байсан. Гэвч эвт шаазгай буга барина гэдэг шvв дээ гэлээ. Хэдэн өдрийн дараа цэргийн хоолыг аргагvй сайжруулж, цэргvвд хvч нийлэн хөдөлснөөс хvссэн зvйлээ гvйцэтгэж авсан тухай сонсоод «олон хvн нэгдсэн цагт юуг ч дийлж юуг ч олж чаддаг юм» гэж байсан алиа Петрийн vг санагдаж байв.

## VII

Усан манан хадсан өвлийн хvйтэн өдөр Тамирын мөсөн дээгvвүр шороо асгаж огтолсон харгуйгаар цан болсон морьтой хоёр хvн давхиж гарлаа.

Өмнө нь Итгэлт, хойно яваа нь Галсан ажээ. Итгэлт өнөө өглөө Павловыг иржээ гэж сонсоод найз нөхөртэйгөө уулзах гэж яаран яваа юм.

Павлов маань өвөл ирэх ёсгvй юмсан. Нэг л сvрхий хэрэг гарч дээ гэж дотроо бодож чухам ямар хэрэг гарсныг тааж ядан элдвийг сэтгэн явна.

Өнгөрсөн зун Павлов ирэхдээ урьд урьдаас олзтой ирж билээ. Бас Тvнхэний орчим мал маллах газар хамтарч байгуулбал улам ч их ашиг олох тухай ярьж байсныг санаж энэ хэргээ

түргэн хийхийг бодоод ирсэн болов уу гэж бодно. Павлов зун ирэхдээ их юм ярьсан. Орос оронд хаант засаг унаж, шинэ засаг тогтсон бөгөөд баян чадалтай хүмүүс олз олох сайхан цаг ирсэн гэж ярьсан. Бас германтай хийж байгаа дайныг заавал дийлж дуусгах болсон болохоор үхрийн үнэ улам хадаж олох мөнгө үлэмж болно гэж ярьж байсан санагдана. Найз минь олз үнэртэж орхиод довтолж ирсэн байх гэж бодоход морь нь урагшаа ахиж өгөхгүй байгаа юм шиг санагдан давхина.

Ингэж явсаар Павловын сууринд ойртож очвол яндангаар нь хөх утаа бургилан гарч харагдав.

Павловын хашаанд ороод морио уяж байхад байшингаас Павлов, эхнэр охины хоёрын хамт гарч ирээд зогсов.

«Бүр энэ хоёртойгоо ирсэн байна шүү» гэж бодоод ойртон очиж

-- Орос оо чамд намайг согтоох архи байна уу? гээд Итгэлт царгил нарийхан дуугаар инээхэд Павлов дурамжхан инээмсэглэв.

Уулзахдаа баяр бахдал гэрэлтэж байдаг Павловын нүүрэнд ямар нэг занал хорсол буцалсныг Итгэлт ажиглав. Түүний царай нь барзайн хөмсгөө зангидан байшингийнхаа үүдийг түвшин хөдөлгөөнгүй зогсоно.

-- Мое почтение гэж Итгэлт хөгжилтэй мэндлэв. Павлов хариу дуугаралгүй шууд ирж Итгэлтийг тэврэн аваад үнсэв.

-- Итгэлт минь их орос улс баларсан гэхэд Итгэлт бүгдийн нүүрийг гайхан харлаа,

-- Муу амтай дамшиг вэ гэж нөхрийнхөө үгний бүрэн учрыг ойлгож хариулав.

-- Үнэн. Орос улс сүйрсэн гэж хэлэхэд Павловын хоолой нь чичирч байлаа.

--Германд дийлдсэн үү?

-- Түүнээс доор юм болсон. За орж ярья гэлээ? Байшинд ороход чийг үнэртэж зэвүүн хүйтэн үлээв. Авдар савтай юм энд тэндгүй хөглөн хэвтэж байв.

-- Манай орост улааны үймээн болж ядуучууд засаг булааж аваад миний байшин хашаа хамаг юмыг дээрэмдэн авсан. Би үнэтэй цэнтэй жижиг сажиг юмаа аваад энэ хоёртойгоо хамт зугтаж ирлээ гэж Павлов хэлэв.

--Тэд бол нүгэлтэй, бурхан шашингүй улс гээд эхнэр нүднээсээ том, том нулимс дуслуулан уйлав.

-- Муухай юм болж дээ. Золигуудыг зад буудаад цусыг нь хольж орхихгүй гэж Итгэлт хэсэг дуугүй байсны дараа хэлжээ.

-- Ихэнх цэрэг тэдний талд орчихсон гэж Павлов гомдолтой хэлэв.

- Галсан чи миний морийг хөтөлж давхиад Буянтын дэлгүүрээс хэдэн шил архи, хашаанаас үхрийн гуя аваад ир. Бас Буянтыг хоёр шуудай ногоо өг гэж намайг хэлсэн гээд аваад ир. Бусдыг маргааш больё гэж Итгэлтийг хэлэхэд Галсан гүйн гарлаа.

-- Павлов, төр булаагаад зогсоогүй, хөрөнгийг нь хураасан оросын ядуучуудыг занаж, эхнэр нь хураагдсан хөрөнгөндөө харамсан уйлж, Итгэлт элдэв үгээр тайтгаруулахыг оролдож байтал Галсан хэлсэн зүйлийг нь авчирлаа.

Тэр шөнө хоёр найз архи ууж ярихад Павлов согтож пад пад хийтэл ширээ шааж өөрсдөө юу ч хийж чадахгүй байж хүний буяныг булаасан зэрлэг хүмүүсийг элдвийн үгээр занан өшөө авна гэж яриулав. Гэвч чухам хэрхэн өшөө авахаа мэдэхгүй байв.

Заримдаа бухимдан муухай хашгирч, оросоор аль муухай хараалыг урсгаж байлаа.

-- Юманд учир, довонд хужир бий. Чи бухимдах хэрэг алга. Учир нь олдоно. Нэгэнт л чи бид хоёр хоршоо болохоор миний хөрөнгө байсан цагт чи газардахгүй гэж Итгэлтийг хэлэхэд Павловын сэтгэл хөдөлж учир тоймгүй үнсэнэ.



Хэдэн өдөр Итгэлт нөхрийн сэтгэлийг засах гэж хамт хүрээний хятад пүвсээр хэсэн архи ууж хөгжилдөн явжээ.

Павлов ч гэнэт учирсан гунигт явдлаас сандарч бахардсан сэтгэлээс салж, цаашид юу хийх тухайгаа бодох чадалтай болжээ.

Нэгэн өдөр тэр хоёр Буянтын пүвсэнд очиж ихэд дайлуулав.

-- Та хоёр намайг тоодоггүй шүү. Хэрэв бид гурав нийлж наймаа хийвэл ертөнцийн бүх мөнгийг өвөртөлж чадна гэж Буянт шар шүдээ арзайлган хэлэхэд Итгэлт тоомжиргүй бөгөөд ихэмсгээр:

-- Чам шиг хорголоо тоолсон наймаачин бидний аяыг даахгүй шүү дээ. Олон юм шулганаад байх алга. Архи аваад ир. Миний жинчид чиний барааг хүрээнээс авчирч өгнө гэв.

- Одоо орос газар үймээн болсон. Үхэр худалдаж болохгүй. Харин дотор газар бол цаг тайван, их наймаа хийж болно. Гагцхүү надад тийм бэл байхгүй гэж Буянт хоёр найзад халуун ганзай аягалах зуур хэлэв.

Буянт бол хэдэн жилийн өмнө ар газар ирж дэлгүүртэй болоод одоо хирдээ их хөлжиж чадаагүй учраас арьс ширний наймаа хийхээс хэтэрч чадаагүй хүн юм Тэгээд Павловын том наймаа хийж байхыг хараад атаархан байдаг бөгөөд тэр ч байтугай гулдмай цавчиж хаясан газар нь шөнө очоод лаа барин мөнгөний хэлтэрхий түвж байсан ч удаатай билээ.

Гэвч жил өнгөрөх тутам хөлжиж, олох нь их болж байгаа ажээ.

-- Чи тэгээд бид хоёртой нийлбэл юуны наймаа хийх хүн бэ? гэж Павлов асуув.

-- Юу ч хийж болно. Манай газар хонь, гүү их үнэтэй шүү гээд Буянт нүдээ жартайлган толгойгоо гилжийлгэн инээмсэглэв.

-- Бид хоёроос жаал юм идье гэж бодож байна уу? хэмээн Итгэлт хөгжилтэй инээв.

-- Тийм ёс хаа байна.

-- Бэлийг чинь харж байж болно. Бас тэгээд надад хийх чухал юм байна гэж Павлов хэлжээ.

Сар гаруй болсны дараа нэг өдөр Павлов Итгэлтийнд ирж ярилцав.

-- Өвгөн чинь нутаг буцъя. Харин чи эхнэр охин хоёрыг минь харж байгаарай гэж хэлэв.

-- Одоо чи яваад яах нь вэ?

-- Өшөөгөө авна. Тэд биднийг гэнэдүүлж дийлээд хөрөнгийг минь хураасан бол одоо бид тэднийг дийлээд эхнэр хүүхэдтэй нь дүүжилж ална.

-- Дийлбэл ч дүүжилж алахаар барах уу даа.

-- Заавал дийлнэ. Яаж албал зүгээр вэ?

-- Зоосны нүхээр огтолж албал зохино, зэр зэвсэг хэрэгтэй шүү дээ. Яаж олно доо.

-- Олдоно. Би ганцаар биш.

Хэдэн өдрийн дараа Павлов явахаар мордоход:

-- Өвгөн минь. Эхнэр хүүхэддээ бүү зовоорой гэж Итгэлт хэлжээ. Бас хэдэн жилийн өмнө гурван мориор худалдаж авсан мөнгөн тоногтой япон сэлээдий буугаа бэлэглэн өглөө.

Нөхрөө явахад эхнэр нь хашгиран уйлж, ухаан алдсан ба харин охин нь хэдэн нулимс дусаасан боловч нэг л их гашуудсангүй,

## VIII

Өвлийн дунд сарын хуучаар, Төмөрийнх Халзан хад гэдэг газар өвөлжив. Цаг сайхан, цас нимгэн болохоор мал ч тарган сэтгэл ч тэнэгэр ажээ.

Өнөтэй өвөл, хонь хотолсноос хойш малчин хүн өөхөн дэнгээ барьж хоолоо идээд

ярьж суухаас сайхан юу байх билээ.

Төмөр, Дулмаа хоёр хонио хотолж гэртээ ороод, инээж баясан хvвгээ хуурайлав.

-- Аль вэ?... эр хvндээ хөө, гэж Төмөр суниаж байгаа хvвгээ харан инээв.

Дулмаа хацраа Төмөрт нааж хэсэг байснаа хvвгээ өлгийдөх гэхэд нь «Жаахан тарвалзаг» гэж нөхөр нь хориглов.

-- Даарчихгvй байгаа?

- Хаанаас, дулаахан байна. Аль вэ...би хvвдээ хонгор морио өгнө... мэдэж байна шvв, инээж байна, эр хvндээ хөө гээд Төмөр эргэж гал тvлэв.

-- Өлгийдье. Зогисчиж магад.

-- Гал өрдөж орхиё дэрвэлзэж л байг, эр хvндээ, хөө гээд Төмөр эргэж гал тvлэв.

Хvвхдийн яраглан тоглох авиа, хvвгээ өхөөрдөх Дулмаагийн дуутай холилдон Төмөрийн сэтгэлийг хэмжээлшгvй жаргалын хөгөөр дvвргэж байлаа.

Хоточ нохой нь хуцаж эхлэв. Төмөр чих тавин чагнаснаа «Хоёр морьтой хvн ирэв бололтой» гэлээ. Үнэхээр ч удалгvй төвөргөөн тод сонсдож, гэрийн гадаа ирээд «нохой хорио» гэх дуу гарлаа. Төмөр гарвал хөтөлгөө морьтой хvн зогсож байлаа. Нохойгоо хорьж гийчнийг урьж оруулав. Хөх дээлтэй өндөр нуруутай туранхай хар хvн ажээ. Харилцан мэнд амрыг мэдээд ирсэн зочин Дулмаагийн дэвссэн журам дээр суужээ.

Цай хоол болж, алс газрын зочинг хvндэтгэн дайлав. Тэр хvн, Шагдар гvний хошуунаас өртөөнд хөөгдөж зудын зургаад очоод одоо уул нутгаасаа ацагны өр авахаар яваа гэж ярьжээ.

Төмөр гарч зочны морийг чөдөрлөн тавив. Үнэндээ энэ гийчин биш хорссон баяны хорт санаагаар Төмөрийг барих шалтгааныг тарих гэж иржээ. Гэвч vвнийг Төмөр Дулмаа хоёр яаж мэдэх билээ.

Эр эм хоёр монгол хvний сайхан заншлаар ирсэн зочныг хөл алдан хvндэлж зузаан дэвсгэр засан олигтой дээлээрээ хучиж өглөө.

Өглөө босоод цай ууж байхад ирсэн зочин:

--Нэг морь маань эцээд явахаа болилоо. Та худалдаж аваач гэж гуйв.

-- Хээр морь нь уу?

- Тийм ээ, Яг тэр чинь.

--Холын унаа биш байна билээ гээд Төмөр бодолхийлснээ, бодвол оронд нь морь л хэрэгтэй биз дээ гэж асуув.

-- Явуулын хvнд унаа л хэрэгтэй, Би мөнгө хайрлахгvй нэмж өгнө.

-- Холын хvнийг яана гэх вэ. Нэг ажлыг чинь бvтээчих унаа өгье. Буцах замдаа залуу морь өгнө биз дээ.

- Толгой, салгаж өгнө гэж байгаа юм биз дээ?

-- Би муу морь өгөхгvй,

-- Нэгэнд нь хээр морийг авна биз дээ,

-- Тэгэхээс биш дээ гэж Төмөрийн хэлэхэд зочин бие нь тавиран инээмсэглэв. Энэ хээр морийг л Төмөрт худалдах зорилготой ирсэн юм. Ингээд давхар саран тамгатай хээр морио Төмөрт орхиод оронд нь Төмөрөөс зээрд морий нь авч баярласан гялайснаа дахин дахин хэлсээр ирсэн хvн явжээ.

Хэдэн хоногийн дараа Төмөрийнд бас нэг хvн ирж авсан хээр морийг нь «Өөрийн алдсан морь, гэхдээ ганцаарангий нь биш азарга адуутай алдсан» гээд Төмөр азарга адууны хэрэгт сэрдэгдэж хошуу тамганд баригдан банздуулав.

Хээр морь өгсөн хvний нэрийг асууж аваагvй болохоор буулгах эзэн буцах зам байсангvй.

Гэвч хилс хэргийг яаж хвлээх билээ. Баахан эрүүдэж байгаад гав гинжилж хар гэрт хорив.

Дулмаа нөхөртэйгөө уулзах гэж хэд дахин очоод чадсангвй. Сvvлд нь алтан бөгжөө хахууль болгож баймааж нэг удаа уулзаж хоол өгөх болжээ.

Хаврын дунд сарын шинийн нэгний vдийн хирд өргөн хашааны хаалга Дулмаагийн өмнө нээгдэж хуягийн хамт ороход тэсэж боломгвй vнэр хамрыг нь цоргиж vs сахал нь ургасан хvmvcsийн толгой мөглөнгийн нvхээр цухуйн гялалзсан хурц хар нvд тал бvрээс нь ширтэнэ. -- Төмөр тэр байна гэж дагаж явсан хуяг vs гээг нь сэгсийсэн нэг хvн рvв заав.

Тэр хvн Дулмааг харснаа инээмсэглэх мэт болоод гинжээ хангинуулан дэгэж ирлээ. Дулмаа угтан гvйх гэснээ шурган унав. Босох гээд чадахгвй болохоор мөлхөн очиж Төмөрийн гинжтэй хөлийг тэвэрч авлаа. Битгий уйл! Миний өвгөн бос гээд Төмөр гавтай гараараа татаж босгов.

-- Бие чинь ямар байна?

-- Сайн байна. Та хоёр ямар шvv байна даа? гээд ханцуйгаараа эхнэрийнхээ нулимсыг арчив.

--Сайн сайн гээд Дулмаа эхэр татан уйлав.

Төмөр аргадаж хvvгийнхээ тухай асуун «эр хvн дээ хөө» гэж дахин дахин хэлнэ. Дэргэд нь vргэлж хуяг харуулдан зогсох тул өөр юу ч ярьж болсонгвй. Төмөрийн хоолой нь зангиран нvдний нь байн байн нулимс бvрхэвч сэтгэлээ чандлан барьж байлаа.

Дулмаа уйлан байж Төмөрийн гэзгийг самнаж өгөөд авчирсан хоолоо нулимстайгаа холин өглөө. Ингэж шөргөн хашааны хаалгаар гартал Төмөрийн дуу хангинав. Чагнавал цээлхэн хvдэр хоолойгоор «Эрдэнэ засгийн унага»-ыг дуулж байлаа. Гэтэл vгий нь өөрчлөн дуулав:

«Эрдэнэ засгийн унага уу даа

Эрмэг болоод хонгоруудаа

Элсэн толгойн өвөрт хөө

Эргэж хоринд, уулзана хөө

Товоо засгийн унага уу даа

Товолзос гээд жороо доо хөө

Тодрох vvрийн гэгээгээр хөө

Товчилс гээд очно доо хөө»

гээд Төмөрийн дуу тасрав.

Төмөр морин дээрээ давхиж явахдаа «Эрдэнэ засгийн унага»-ыг vргэлжлvvлэн дуулдгийг Дулмаа сайн мэднэ. Yг аялгуугий нь ч бvрэн тогтоожээ.

-- Чи энэ дууг юунд vргэлж дуулдаг юм бэ? гэж Дулмаагийн асуухад «Холын замд давхиж явахад нөхөр болдог юм. Нутгаасаа хол явахад нутаг минь болдог, ядрахад хvч, өлсөхөд хоол болдог сайхан дуу юм шvv» гээд инээдэг билээ.

Энэ ч учраас vгийг нь өөрчлөн дуулсан нь сэтгэлд таавар бодол төрvvлэв.

«Миний нөхөр хоосон vt хэлэхгвй нэг л учиртай ингэж дууллаа» гэж бодоод сажлан явтал нvдэнд нь алгуураар баярын цог асаж ундарсаар нvvp дvvрэн инээмсэглээд дөрөөн дээрээ босож хатируулан «Эрдэнэ засгийн унага»-ыг дуулахад Төмөр нь дэргэд нь давхиж яваа юм шиг бодогдож байлаа. Төмөр баригдаж хар гэрт хоригдсон нь Дулмаад vзсэн бvх зовлонгоос нь хvнд зовлон байсан бол хайрт хvнээ гаргахад өөрөө оролцох болсон. Төмөр ухаанд нь итгэж ёгт дуу дуулсныг ойлгож чадсандаа хэмжээлшгвй баярлаж байлаа,

«Би л ойлгосон хойно миний Төмөр хэлсэн газраа болзсон цагтаа очно» гэж бодоход хорвоо дээр хамгаас vнэтэй хvнтэйгээ удахгвй учрах их жаргалын нар сэтгэлд нь бадарч байлаа.

Гэртээ ойртож ирэхэд саахалт айлын авгайтай орхисон хvv нь уйлж байлаа. Хvvгээ авч vнсээд «Эр хvн дээ хөө» гээд хөхvvлэв.

-- Дулмаа! хvv чинь бvлээрээд байх шиг. Ажиж байгаарай. Авгай чинь төсөөрч орхиж дээ гэхэд нь хvvгийнхээ магнайг vнсэн хацраа нааж vзвэл vнэхээр халуунтай ажээ.

Авгай сандран харьж цагаан тан авчирч өгсөн боловч хvvхдийн халуун нь буурсангvй эмч залж хонио, лам залж хоёр vнээ нэг шараа барин гvрэм уншуулсан боловч тус болсонгvй.

Гурав дахь хоногийн шөнө дундын хирд бvр хvндэрч авгай эсэргэнэ гэдгийг мэдэж

Чингисийн хар домгоос эхлэн зээргэний шvvс өгөх хvртэл бvгдийг хийсэн боловч яаж ч чадалгvй vүр шөнө хаяарахын алдад vрэгдэв.

-- Ээ бурхан тэнгэр минь ямар өршөөлгvй юм бэ? Эцэгт чинь би юу гэж хэлдэг билээ. Миний хvv хараач, эцэгтээ ирээч, заяагvй эмийг өршөөгөөч гэж тас тэврэн хичнээн хашгиравч тус болсонгvй хvvгийн бие улам улам хөрсөөр хөшив.

Авгай уйлан «Хvv минь сэтгэлээ барь. Одоо яая гэхэв» гэж байлаа. Үрээс салахын гашуудлыг олон удаа vзсэн энэ хөгшин эх өөр юу ч хэлэх билээ дээ.

Маргааш нь өвгөн эмгэн хоёртой хамжиж хvvгээ оршуулан гэртээ буцаж ирээд ухаан алдаж vдэш болсон хойно сэрэв.

Хvн жаргалын төлөө тэмцэж чаддагийнхаа хирээр зовлонг дааж чаддаг болохоор Дулмаагийн өчvvхэн бие энэ хvнд зовлонд няц даруулчихсангvй уйлсаар cvүлдээ нулимс нь гарахаа болив.

Ингэж байтал хорины өдөр маргааш болоод ирэхэд vдэш орой нь хонгор морио барьж Төмөрийн эмээлээр эмээллээд хоол авч шөнө дундын вед хос морьтой давхиж Элсэн толгойн венд очиж vүрийн гэгээ хvлээн зогсов.

Зvрх нь цохилон байн байн нулимс асарна. Сэрvvхэн салхи баруун хойноос vлээн уулзах баярын хажуугаар юу гэж хэлэхээ мэдэхгvй сэтгэл зовнин байтал дорно зvгээс vүрийн гэгээ тодорч эхлэв.

Гэтэл хажууд нь төмөрийн жингэнэх дуу гарч харвал тушаатай Төмөр дэгсээр хvрч ирлээ. Хайрын халуун сэтгэлээр холбогдсон энэ хоёр хvн яаж уулзсаныг бичихэд vг всэг хоёр хvч хvрэхгvй мэт,

-- За бушуухан хариад хvvгээ аваад эндээс зайлъя гэж Төмөрийн хэлэхэд Дулмаа хариу дуугаралгvй хэсэг тvгдэрснээ:

-Зvгээр чи минь бушуухан яв. Хvv бид хоёр vлдье. Даваа давж явахад манайд хэдэн морьтой хvн ирэх шиг болсон. Харихыг чинь отоож байж магад гэлээ.

--Ядахдаа хvvгээ vнсээд мордохсон... vгvй би ууланд бvгж байя, Чи хvvгээ аваад ир.

-- Болохгvй, Миний өвгөн яв. Бид хоёр алзахгvй, Май! гээд том хуурай өглөө.

--Чи минь хэлж байгаа хойно явдаг нь зөв байхдаа «Эр хvн дээ хөө», vг хэлж байна уу?

--Хэлж байнаа. Тvргэл миний өвгөн.

-- Ааваа гэж байна уу?

--Ааваа гэж байнаа... Тvргэл миний өвгөн!

-- Удсан ч vгvй Төмөр гинжийг мултлан «Дахиад гэмгvй хvнийг зовоохгvйн тулд элсэнд булж орхиё» гээд булав.

--Хvvгийн минь хоёр хацар дээр гурав гурав vнсээрэй. Аав нь удахгvй эргэж ирээд авна гэж хэлээрэй... «Эр хvн дээ хөө» гээд Дулмаагийн авчирсан хоолыг идэх зуур,

-- Номхон амьдаръя гэхэд болдоггvй хорвоо юм бол чадлаараа vзнэ дээ гэлээ.

Ингээд Төмөрийг мордоход Дулмаа «Тvргэл миний өвгөн гэж» тэвдэж байлаа. Нөхрөө далд орсны хойно элс тэвэрч унаад чарлан уйлав.

Ингээд үдийн хирд гэртээ ирэхэд нь үнэхээр ч хэдэн морьтой хvн оргосон Төмөрийг мөрдөж ирээд байлаа. Дулмааг хошуу тамган дээр дуудаж хорь шаахайдан байцаасан болов ч «Мэдэхгvй ээ. Та нар л миний нөхрийг мэднэ»-гэхээс өөр хариу сонсолгvй буцаажээ.

## IX

Монголын автономит засгийг унагаасны дараа гамин цэрэг Богдын хvрээнээс монголын чухал чухал боомтыг эзлэхээр гарчээ. Энэ цэргvүд зам зуур тохиолдсон энгийн номхон малчдыг дээрэмдэн, эмс охидыг хvчирхэж, тvмэн зовлон тарьж бvгж дvрвэсэн хvн аглаг уулаар дvүрч, хvүхэд эмэгтэйчvүдийн гаслан уйлах дуу хадаж, буу дуугарах бvрд хэнийг алав гэж зvрх шимширнэ.

Баруун тийш Улиастайг эзлэхээр гарсан хэсэг гамингийн сvүлч арван хvн Луу гvний хvрээний өмнө Тамирын эрэг дээр буудаллаад дvрвэж амжаагvй айлуудыг цөлбөн дээрэмдэж байлаа.

Бадарч гамин цэрэгт нvүр олох гэж нутгийнхаа хvмvүсийг сvрдvүлэн хэдэн морь дайчилж аваад буудалласан цэрэг дээр очив.

Майхандаа хоол идэн шуугилдаж байсан гамингууд морин төвөргөөнөөр гарч зогсов. Зарим нь буугаа авч бэлтгэв. Өчигдөрхөн дээрэмдэж авсан том эрээн майхны өмнө буунуудаа хэд хэдээр нь шорлон тавьжээ. Майхны цаана гурван тэрэг, тvүнээс цааш хэдэн морь идэж байлаа. Бадарч «энэ хэл мэдэхгvй золигнууд чинь арай буудаж орхихгvй байгаа даа» гэж зvрх нь цохиловч сайн сэтгэлээсээ ирж байгаа хvн гэдгээ vзvүлэх гэж шууд явж очоод мориноос бууж унаа морио тушиж хөтөлгөө морьдоо хvзvүнээс нь холбон уяад гайхан зогсож байсан гамингуудын өмнө очиж алгаа хавсран марсайтал инээв.

-- Эрхэм ноёдын тvмэн амгаланг айлтгаж, та бvхнийг ёс алдаж, угтаж аваагvйн өршөөлийг гуйя гэж Бадарч хэлэв.

-- Энэ лав эндvүрч ирээд аргагvй болох дээр залилах гэж байгаа хvн бололтой гэж гамингийн ахлагч хэлэв.

--Гарцаагvй гэж нэг цэрэг хариулав.

Гамингууд өөр хоорондоо юу ярьж байгааг vл ойлгосон Бадарч дуугарсан гамингийн амыг харж худал инээмсэглэнэ.

--Чиний морьдыг бид авна гэж ахлагч сvртэйеэ хашгиран хэлэхэд Бадарч:

-- Тийм тийм би сайн хvн байна гэлээ.

- Чамайг морьдоо өгөхгvй бол буудаж ална.Чи чөтгөр болно гээд ахлагчийн инээхэд бусад нь дагалдан инээв.

-- Миний нэрийг Бадарч гэдэг. Луу гvний тахар хvн. Та нар бол аз хийморьтой улс байна гэхэд

-- Энд чинь нэг сум орно гэж нэг гамин магнай руугаа долоовор хуруугаараа чичлэн заахад бусад нь нирхийтэл инээлдэв.

-- Би та нарт морь нохой мэт зvтгэн дуртайяа тусална. Буутай цэрэг өгвөл хvссэн бvхний чинь өгнө гээд Бадарч хи хи инээв.

-- Морьдыг чинь бид авна ойлгож байна уу? Чи чөтгөр болох хvсэлгvй бол бушуу зайл! гээд ахлагч ойртон очиход Бадарч сөхөрч:

-- Алт, мөнгө, авгай хvүхэд алийг ч авчирч болно гэлээ.

-- Эмээлтэй морий нь би авна. Бусдыг нь та нар ав гэж ахлагчийн хэлэхэд цэргvүд уралдан гvйж очоод морьдыг нь тайлан авцгаав. Бас нэг цэрэг унаа морийг нь хөтлөн ирж ахлагчид цулбуурыг нь атгуулав. Бадарч «морийг нь өгч байна» гэж бодоод цулбуураа

ахлагчийн гараас авах гэтэл ахлагч Бадарчийн хуруун дахь том алтан бөгжийг харснаа барьц үзээд шувт татан авлаа. Хэрэг буруу тийшээ эргэж байгааг ойлгосон Бадарч босч «Би их сайн хvн» гээд цулбуураас барив.

Дарга гар буу гаргаж муухай хашгираад дээгvвр нь хоёр дахин буудав. Бадарч бөгсөөрөө хийтэл суув.

Гамингууд хөгжилтэй инээлдэв. Бадарч инээх гээд чадсангvй шvдээ ярзайлгав.

--Яв гэж ахлагч дохиод Бадарч руу буугаа Бадарчийн сvнс зайлан vнхэлцэг хагарах шахан гэдрэг гэж мөлхөн ухрав. Бадарч ухарсаар, ахлагч шагайсаар цэргvвд инээлдсээр хэсэг болов.

Бадарчийг нилээд холдсон хойно гамингуудын зарим нь майхандаа орж, зарим нь олсон морьдоо чөдөрлөж эхлэв. Бадарч эргэж гvйх гэтэл хvнд биеэ даасангvй шургачин унажээ. Шар цай ч ололгvй морьд, бөгжөө алдсандаа гол нь харлаж гамингуудад хорсон явжээ. Тэр шөнө айл ололгvй хээр хоноход шөнө дундын вед тэнгэр бvрхэж юв ч харагдахгvй болсноо цахилгаан гялалзаж тэнгэр нижигнэн вер буужээ. Золтой л осгож vхсэнгvй арай гэж өглөө болгов.

Шөнийн верт Тамир хөөсрөн буцлан верлэж өглөө эрт хөдлөх гэж байсан гамин хоригдлоо. Нар гарахын вед тэнгэр цэлмэж хурц нар ертөнцийг соёрхов. Нойтон дээлэндээ дагжин чичирч, учирсан гарздаа бухимдан гэлдэрч явтал гурван морь хөтлөөд Өлзийнд очих, дараа нь Долгортой уулзах тэгээд уулзаж чадаагvй ганц ахынхаа мөрийг гаргах гэж явсан Төмөртэй яг дайралдав. Тvрvүлж таньсан Бадарч нvүрээ буруулан, “Одоо ч Төмөрийн гараас гарахгvй боллоо. Сахиус минь өршөөгөөч» гэж амандаа шивэгнэн явжээ. Гэтэл Төмөр давхиж ирээд өмнө нь хөндөлдөн зогсов.

-- Сайн байна уу?

-- Сайн та сайн байна уу? гэж Бадарч газар шагайн хариулав. Төмөр өмнөө зогсож байгаа хачин хvнийг ажигласнаа бvдvүн дуугаар инээж,

-Бадарч уу даа? Өршөөлтэй хvн даваан дээр, өртэй хvн зээл дээр гэдэг болж байх шив дээ гэлээ.

Гарцаагvй танигдсанаа ойлгосон Бадарч, Төмөр рvү эгц харж

-- Тийм байна, Бадарч байна. За яахав уулзаж дээ гэж хэлэв.

Төмөрийн бvдvүн яргай ташуур хэзээ гавал руу нь буух бол гэж бодоход зvрх нь цээжиндээ багтахгvй цохилоч биеэ барьж юу ч гэсэн бvх чадлаараа эсэргvүцэн тэмцэлдэхээр бэлтгэж байлаа.

-- Чи чинь архи ууж яваад мориноосоо салж бороонд шалба цохиулж орхио юу?

- Үгvй ээ. Гаминд дээрэмдvүлж орхиод явж байна.

-- Гаминд аа! гэж Төмөр сонирхож асуув.

-- Тийм ээ. Чи ч одоо надаас өшөөгөө авах юм байгаа биз дээ?

-Ядарч яваа эр хvнээс өшөөгөө авах ягтаа тулсан эр би биш ээ гээд Төмөр мориноосоо буугаад Бадарч руу ойртов. Бадарч хутгаа сугалж амь тэмцэн тулалдахад бэлтгэв.

-- Хутгаар яах нь вэ? Хэрэггvй. Би чамайг цохиё гэвэл мориноосоо юунд буух вэ дээ. Чи намайг итгэхгvй байвал би урдаар чамайг хvлээд өгөх vү? гээд Төмөр хөгжилтэй инээв.

Тvүний ИНЭЭДЭНД нь сэжиглэлтэй юм огт байсангvй. Тэгээд ч морьтой ташууртай Төмөр хэрвээ Бадарчийг алъя гэвэл алга урвуулахын төдий хэрэг гэдгийг Бадарч ойлгож байлаа.

— За чи эр хvн юм бол хэлсэн vгэндээ хvрнэ биз дээ. Эвдрэх нэг өдөр байхад эвлэрэх нэг өдөр байдаг юм даа гээд хутгаа шидэж орхиод Төмөрийн дэргэд шууд ирлээ.

-- Тэр жилийн цагаан сараас хойш чи бид хоёр золгоогvй байх аа? Юу ч гэсэн золгож орхиё

гэж Төмөр хэлээд энэ хоёр золгов.

Тэгээд зэрэгцэн сууж. Бадарч гаминд буу тулгуулан дээрэмдүүлснээ сүр бадруулан ярив.

Гэхдээ ямар хэргээр очсоноо хэлсэнгүй.

--Би хүрэнээс гараад нааш явахдаа дээрэмдүүлсэн айлууд, дүрвэж сандарсан зөндөө хүмүүс үзлээ. Алагдсан хүмүүс ч мэр сэр дайралдаж байна гэж Төмөр хэсэг дуугүй болсноо, -- хичнээн гамин байна? гэж асуув.

-- Арваад гамин байна гээд Бадарч Төмөр лvv харснаа, цөм буу зэвсэгтэй гэлээ.

--Арваад гэнээ! Хоёул дайраад цохилж орхиё гээд Бадарч руу харахад:

-- Цөм хурдан буутай шvv дээ!

-- Гэмгүй хүмүүс шиг ойртож очоод гэнэт дайрч морины сайнаар зав өгөлгүй цохилж орхиё.

--Юу ч гэсэн бодъё. Чамд идэх юм байна уу? Бузар их өлсөж байна. Юу ч гэсэн гэдэс гарч авъя гэхэд нь Төмөр богцноос чанасан мах гаргаж өгөв.

--Осолтой л ажил даа. Хурдан буу... гэж мах том том огтлон захлах зуур Бадарч хэллээ.

-- Олон яриа хэрэг алга. Энэ модноос хоёр цохиур бэлтгэж аваад явъя, Чи миний эмээлтэй морийг уна. Би зайдан унана гээд Төмөр босов.

Бадарч шийдэмгий бөгөөд итгэлтэй хөдөлсөн Төмөрийн зориг сэтгэлд захирагдан босож түүний морийг унажээ. Гамингууд бороонд нэвт норсон юмаа хатааж, буугаа майхныхаа өмнө овоохойлон тавиад, наранд ээн хэвтэж байлаа. Зарим нь дуу аялан, зарим нь орон гэр үр хүүхдээ бодон гуниглаж байв.

Харь нутгийн ард түмнийг жигшин үзэх бузар хороор хордуулагдсан энэ хүмүүс үнэндээ бол яг л дээрэмдүүлэн доромжлуулж байгаа хүмүүстэй адил эх, эцэг, ах дүү, эхнэр хүүхэдтэй өөрийн улс үндэсний санаж сарвайх юмтай билээ.

Монгол орон тэдэнд гэм хийгээгүй. Буруу нь гэвэл тусгаар улс болохыг хүсжээ. Гэтэл өөрсдийн нь хүсэж мөрөөдөж явдаг юмыг адилхан хүссэн ард түмнийг жигшин үзэж өөрийн эцэг, эх, ах дүү эхнэр хүүхдийг энхрийлэн хайрлаж үздэг атал бусад ард түмэнд тийм эрх өгөхийг хүсэхгүй нь юунд байдаг билээ! Энэ бол тэр хүмүүсийн буруу биш, тэдний жолоог барьж, тэдний хүн чанар цагаан сэтгэлийг, миний гэр, миний ах дүү амраг садан болж байвал бусдын тэр бүхэн хамаагүй гэж хордуулсан нийгмийн буруу билээ.

Хятад бол их улс, том орон болохоор түүнтэй зэрэгцээ орших жижиг улс орон дагуул нь боол нь байх ёстой. Эсэргүүцвэл хүчээр дагуулах нь хятадын бүрэн эрх гэж тэд ойлгожээ.

Төмөр Бадарч хоёр гэмгүй дүрс үзүүлэн сажилж зэрэгцэн явсаар ойртож очмогц мориндоо ташуур өгч шийдмээ эргүүлэн дайрав. Гамингууд хэрэг биш болсныг ойлгож буу руугаа гүйсэн боловч амжиж чадсангүй цохиулав. Ахлагч нь сэлээдийгээ авч Бадарч руу чиглүүлэв. Бууны аманд онилуулсан Бадарчийн сэтгэлд үхлийн хар цахилгаан цахиж могой харсан хулгана шиг гөлрөв.

Төмөр шийдмээ шидэж орхив. Цочсон ахлагч хэсэг зуур зог тусахад Төмөрийн бүдүүн ташуур толгой дээр нь бууж дайван унав.

Ганц босоо үлдсэн гамин зүүн зүгийг чиглэн байдаг чадлаараа гүйв. Төмөр хашгиран дайрав. Гамин гэнэт эргэж суугаад ямар нэг юм шулганан залбирав. Үхлийн аюул бадран хүн дүрсээ алдтал айж, барайж харласан нүүр, галзуу бухын нүд шиг дугариг бөгөөд час улаан болсон нүд нь Төмөрийн өрөвдөх сэтгэлийг татсангүй, өших жигших сэтгэлийг төрүүлэв. Нэгэн мөч өнгөрөхөд хашгирснаас цээжнээсээ урт болсон гамингийн толгой дээр Төмөрийн ташуур буужээ.

Төмөр морины амыг эргүүлэн харвал Бадарч мориноос буугаад үхэж гүйцээгүй гамингуудын

толгойг бүдүүн шийдмээр бяцлан цохиж байлаа. Төмөр мориноос бууж ямар нэгэн хүчинд хөтлөгдөн саяхан цохиж унагаасан гамингийн дэргэд очив. Арван хэдэн настай бололтой залуу ажээ. Муруйсан нүүрний нэг талд нь үхлийн сандрал нөгөө талд нь хүүхдийн гэнэн инээмсэглэл тодорч байлаа.

Төмөр Бадарч хоёр дайрахын өмнө ахмад гамингуудын яриаг сонсон инээж байсан нь ч нүүрнээс нь салж чадсангүй.

Төмөр явган сууж тэр гамингийн хэвүүн доогуур гараа хийж өргөв. Тэгээд зүрхий нь чагнавал цохихоо байжээ.

--Чамайг хэн энд ир гэв гэж Төмөр дотроо шивэгнээд,

-- Толгойг нь бяц цохь гэж дэргэд нь ирсэн Бадарч хэлэв.

Төмөр гаминг тавиад бостол Бадарч толгой руу нь дэвсэх гэж хөлөө өргөв.

-Хэрэггүй гэж Төмөр хориглов

--За хөө олзоо хуваана даа. Чи буу авна биз дээ гэж Бадарчийг хэлэхэд Төмөр гүн бодол болсон нүдээр ажиглан харснаа,

— Би юу ч авахгүй гээд эргэж мордоод баруун зүг явлаа.

Х

Хавар хаяагүй эхлэв. Олон жилийн турш түмэн ламын хөлд давтсан Заяын хүрээний гудамжинд ч хавар довтлон орж ирлээ. Хашааны ёроолоор лууль, хэнз ногоо соёолон, гудамжинд шалбааг тогтож өдөр өнгөрөх тутам дулаарч байлаа. Байн байн салхи шороо босож, туйлаадас манаран оровч хавар ялж тэнгэрийн өнгө улам бүр хөхрөн тунгалаг болно. Хавар хөлөг морины харц хүний хүүгийн сэтгэл нутгийн зүг чиглэдэг болохоор хүрээнд байгаа банди нарын яриа хонь хурга хариулж, хурдан морь унаж явсан дурдатгалын хүрээнээс холдож чаддаггүй билээ.

Заяын хүрээний их дацангийн зэрэгцүүлэн тавьсан жавдангийн арын эгнээний дунд хирд Хонгор хэдэн бандийн хамт суугаад Луу гүний хушуу наадамд уралдсан тухайгаа ярьж байтал хурал тарж лам нар гарцгаав.

Хаврын цагт хүний бие (нозоорон алхаа нь удаан болдог болохоор тарж байгаа лам нар өвөлтэй адил шахалдан дайрдаггүй. Харин банди нар гүйлдэн гарч зодолдохоос эхлээд наймаалах хүртэл бүх ажлаа хийдэг юм.

Хонгор дуганаас гараад, олны хөлөөс зайлан зогстол дэргэд нь гурван банди ирлээ.

-- Хонгор оо, Жаргалыг зодоод өгөөч. Шангий нь гомдоохгүй өгнө шүү гэж гуйхад нь Хонгор тэднийг тоомжиргүй харан ихэмсэг ярвайж:

-Саваагүй нохой саранд хуцна гэгчээр Жаргалд хуцаж байж нийлгэсэн үү? гэж асуув.

Жаргал гэдэг бол нөгөө Хонгор, Бат хоёрыг зодсон гуйлгачин жаал билээ. Жаргал хүрээний захад овоохой гэр алин болох нь танигдахгүй болсон бор гэрт эхтэйгээ хамт байдаг бөгөөд өдөржин гуйж олсон юмаар хоёр толгой амьдардаг. Хатуу амьдрал Жаргалыг их юманд сургасны дотор барагтай бандид дарлуулахгүй урьтаж нармайнд нь хүрч чаддаг сургуультай болгожээ.

Анх хүрээн дээр ирсэн цагаас хойш Хонгор сүрхий зодооч болжээ.

Анхандаа зүгээр явсан гэмгүй бандийг ч өдөж байгаад зодож байсан бол сүүлдээ сайн зодоончин гэж нэрд гарсантай нь шилж зодолддог болжээ. Бас сүүлийн вед банди нараас хөлс авч өшөөтэй хүнийг зодож өгдөг болсон. Харин Жаргалтай анх зодуулснаас хойш зодолдож үзээгүй явжээ. Үүний шалтгаан бол тэр хоёрын аль нэгэн нь нөгөөгөөсөө айсан хэрэг биш. Харин зүгээр л учирч дайралдаагүйгээс болжээ.

Гурван банди өшөө авч өгөхийг зэрэг зэрэг гуйв. Жаргал амаргүй зодоончин бөгөөд түүнийг



оновчтой цохилт, шаламгай зайлалт, ялангуяа өө алдахгвй хамар онодог өшиглөлтийг Хонгор хэдэн удаа бахархан харж байсан. Хонгорт Жаргалыг дийлнэ гэх найдвар байсангвй. Гэхдээ дийлдэнэ гэж айсангвй.

-- Та нар юу өгөх юм бэ?

-- Хагас жингийн нэг нэг дугуй өгье гэж нэг банди хэлэв.

-- Улаан үстэй тугалган тэвгээ нэмж өг.

-- Яаж болдог юм бэ? гэж нэг банди сандран хэлэв.

-- Тэгвэл зодуулж байхгвй юу гээд Хонгорыг явах гэхэд нь гурван банди зогсоож хэлсэн тэвгийг нь өгөх болов.

Гурван банди хариад юу хэлж, багшаасаа ямар адис хүртэхийг бодолгвй тэр өдрийн олсон гурван дугуй, улаан үстэй тугалган тэвгээ Хонгорт өгөхөд нь ташуур орхимждоо боож аваад хамт явжээ. Замд тохиолдсон банди нар Хонгор, Жаргалтай зодолдохоор явааг мэдээд сонирхон үзэхээр дагацгаав. Банди нарын тоо улам олшрон явж байтал «ламбугай юм хайрла» гэж хашгирах танил дуу хангинан сонсогдов.

Хонгор банди нарын хамт нэг хашааны үүдэн дээр зогсон, гуйж баймааж олсон боовны хэлтэрхий, үмх өөхөө хар хүүдийдээ хийгээд дараагийн хашаа руу явж байсан Жаргал дээр очив.

-- За. Жаргал чамтай зөрөх гэж ирсэн. Хулчийхгвй бол хонзонгвй нулилцья даа гэж Хонгор хэлээд жижигхэн бөөрөнхий чулуу Жаргалд барив.

Ламын зодоон өөрийн дүрэмтэй байдаг. Зодолдохын өмнө юм санаж хонзогнохгвй гэж хөөрөгтэй тамхиа солилцдог. Гэвч хөөрөггвй банди нар чулуу солилцож тамхилалцдаг. Зодолдож байхдаа барьж болохгвй, эмзэг газар өшиглөж болохгвй, унавал цохихгвй. Тэгээд хэн хамраас нь цус гаргавал тэр дийлсэн болдог. Бас нүдийг нь таглавал дийлсэнд үзэх удаа бий. Гэвч үүнийг хоёр талын яриагаар болдог юм.

-- Чамайг хэн хөлслөсөн бэ? гээд Жаргал хүйтэн инээмсэглэв.

- Чамд хүртээлгвй, хаданд чимээгвй. Харин хулчийгаагвй бол зөрье.

Жаргал юу ч дуугаралгвй Хонгорыг ширтэн харж байснаа хар хүүдийгээ хашааны ёроолд эвтэйхэн тавиад нусаа дотогш татсанаа:

--Хүсээд байгаа юм бол хангаад өгье гээд жижиг чулуу авч Хонгорт өгөв.

Тэр хоёр чулуугаа солилцон, тамхилж байгаа ихэмсэг дүр үзүүлээд буцаан өгч хоёр тийш нь шидэв.

-- Хонзонгвй гэж зөрөөд, хануулчих дээрээ үг нь үхрийн баас, яриа нь ямааны хоргол болохгвй шүү гээд Жаргал бэлтгэн зогсов.

Сонирхогчид тойрон зогсож, халз зодоон эхлэв. Жаргал хэдийгээр чадлаар илүү, бие бялдар том боловч өрөмний өт шиг Хонгорыг олж цохиж чадахгвй ажээ. Ихэнхдээ Жаргал довтолж Хонгор хамгаалж байв. Тойрсон улсад шахаж байгаад Хонгор руу довтолсон чинь хий цохиод золтой л өөрөө намалдаглуулчихсангвй болохоор Жаргал хянамгай болж нэрд гарсан өшиглөлтөө хэрэглэхээр шийдэж өө харан явлаа. Яг л хүссэн ёсоор нь Хонгор эгц довтолж ирэхэд нь үл мэдэг ухарч хүмүүсийг түшиж байгаад өшиглөв. Хонгороос бусад хүн бол хэдий нь хамраа чимхэж авах байсан. Харин Хонгор баруун хацраа хадруулав. Сэхээ авч амжаагвй байтал Жаргал довтолов. Толгойгоо зайлуулан булзтал Жаргалын хүнд гарт мөр нь дайрагдаж, гишгэдлээ олж чадалгвй унав.

-- Гурван боовны зодоончин дэмийртлээ цохиулж байна гэж олны дотроос нэг хэлэхэд хэсэг нь инээцгээв.

Хонгорын царай чавга шиг улаан болж түргэн босоод шүдээ тас зуун Жаргалд ойртов.

Түүний нүд цох хорхой шиг гялалзан гөлчигнөж байв.

-Дөрөв дэх боовыг чинь өгнө дөө гээд Жаргал довтолсон боловч гүйцэж чадсангүй.

Гуравхан боовоор зодож өгнө гэснийг нь бодох тутам Хонгорыг занах сэтгэл оргилон Жаргал тэвчээрээ алдан гэнэн довтолгоо дахин дахин хийж байв. Бас

«Гурван боовны зодоончин...дөрөв дэх боовыг чинь өгнө дөө» гэсэн үгийг сонссон Хонгор ч тайван ухаантай зодолдож чадсангүй.

Яваандаа хоёр тал улайрч, зөрж нийлэх нь улам олон боловч оновчтой цохилтыг хийж хэн нь ч чадсангүй. Хоёул нэг нэг нүдээ хөх булуу болгосон боловч зодооноо зогсоосонгүй улам махруун үзэлцэж байлаа.

Хvvхдvvд хашгиралдан хоёр зодоончийн сэтгэлийг улам хөөрvvлэн байв. Жаргал хоёр гарын дараалсан цохилтоор довтлон ирэхэд доош сууж ольсон Хонгорын тэнэмэл цохилт нь Жаргалын хамрыг дайрч цус садрав. Жаргал сууж хамраа чимхэн авлаа.

Цус үзэж сэтгэл ханасан сонирхогчид, таран явж эхлэв. Хонгор орхимжинд боосон гурван боовоо аваад явах гэтэл нөгөө гурван банди Жаргалын хар хvvдийтэй юмыг цацан хаяад гvйн алга болов.

Өдөржин явж олсон юм нь гудамжны нэг болсныг хараад Жаргал дуу алдан, цусаа гоожуулан тvvж эхлэв. Жаргалын нүдэнд нулимс бүрхэж гудамжны шороо болсон юмаа цустай гараараа базан авч байв.

Хонгор юмнаас нь тvvж өгөх гэсэн боловч Жаргал тvlхэж орхив. Хонгор огтхон ч уурласангүй. Харин Жаргалын өмнө хэмжээлшгүй гэм хийсэн юм шиг санагдаж, тvvнтэй яаж байж эв засах хvсэл оргилов.

-- Май, чи ав гээд орхимжоо задалж гурван дугуйгаа гарган өгөв.

-- Хvний цусаар худалдаж авсан бузар идээг би авахгүй гээд гар руу нь цохисонд дугуй тал бүр тийш өнхрөн алга болов.

Жаргал хvvдийгээ vүрээд булан тойроод далд ороход Хонгор юу ч дуугарч чадалгүй зогсож байв. Тэгээд гэнэт амилж ухаан орсон юм шиг гудамжны нөгөө тал руу гvйв.

Гудамжаар тэнэж явсан хамуутай халтар нохой газар шиншлэн явсаар хэвтэж байгаа дугуйн өрөөсөн галаас хазлан идэж эхлэв.

Хөлсний зодоончин, цусаар худалдаж авсан бузар идээ гэдэг vг Хонгорын сэтгэлийг маажин, өнөөдрийн зодоонд дийлсэн биш, дийлдсэн юм шиг хар сэтгэл төрж байв. Хойноос нь хvmvvc гурван боовны зодоончин гэж хашгираад байх шиг санагдаад гvйсээр байлаа.

Хашааныхаа vүдэн дээр ирж зогсоод алгаараа нvvрээ даран уйлав. Бас өөрөөсөө хэдэн сар хvсэж мөрөөдөж байж өнөөдөр олж авсан улаан vстэй тэвгийг авч гараа хөдөлсөн зvг рvv таягдав. Түүнийг хаясны дараа сэтгэл хөнгөрөх шиг болж нулимсаа арчив.

Дахиад хөлсөөр хэзээ ч зодолдохгүй гэж бодоход хөлсөөр өдий төдий бандийг зодсон нь юутай ч жишиж боломгүй гэмт бузар хэрэг мэт санагдав.

Хашааны хаалгыг алгуур онгойлгоход том хонх дvн дан гэж чичрvvлэн дуугарчээ. Энэ хонхны дуу гэвш ламд хvн орсныг хэлж өгдөг бол Хонгор гэм хийсэн вед гэвхийг хуурах vгээ бодох дохио болдог юм. Гэвч хэдийгээр өнөөдөр өдий төдий цагаар зодолдож, ирэх цагаасаа хожимдсон боловч Хонгорт багшдаа хэлэх vг бодох чадал байсангүй. Гэртээ ороход лам хялайн харснаа:

-- Хvрээд ир! гэлээ.

Хонгорыг ойртоод очиход урт хар эрихээр нvvрэн дундуур нь ороолгоод, юу ч болоогүй юм шиг номоо уншив. Эрихний ширхэг бүрийн хэвээр нvvрэнд нь улаан гувруу тодрон гарлаа.

Гэвч Хонгорт өвдөөгвй юм шиг байв.

Хэдэн өдрийн дараа ус вүрээд явж байтал Жаргалтай дайралдаж мэндэлсэнд тэр хариу дуугарсангвй ширвээд өнгөрөхөд нь

--Хонзон санахгвй гэсэн биш билvv. Үг чинь vxрийн баас, яриа чинь ямааны хоргол эр шив дээ гэж Хонгор хэлэв.

-- Би хөлсний илжигтэй зодолдох гэж байснаа мэдээгвй юм гэж хэгжvvн бөгөөд хvйтэн хариулаад эргэж ч харалгвй явжээ.

XI

Тэнгэрт од гялалзан, хүрээний нохдын ян ян хуцах дуу тасралтгвй сонсогдож, шөнө дунд ойртож байхад хятадын пvvсэнд уригдаж найрлаад Довчин, Гэрэл хоёр нилээд халамцуу ирэхэд Эрдэнэ морьдыг нь авч тэжээхээр явлаа.

-- Маргааш бидний бичиг цэргийн тvшмэд, Богд гэгээнд бат өршөөл өргөхийн учир би өглөө эрт явна. Чи хамт явж морь барьж байна шvv гэж Довчин хэлээ ээдрvvлэн хэлэв.

-- Чи орж бай. Би Эрдэнэтэй хамт морь тэжээлцэнэ гээд Гэрэл Эрдэнийн хойноос явах гэтэл нөхөр нь ханцуйнаас нь барьж,

-- Эхнэр ээ орж унтъя гэж тушаангуй хэлэв.

-- Дуртай юм бол ороод ширвэж бай гэж ханцуйгаа угз татан авч эргэж ч харалгвй Эрдэнийн хойноос алхав.

-- За яв, яв хонгор минь, би хорихгвй гээд Довчин гэрийн зvг найган явжээ.,

Өглөө нь Эрдэнэ эрт босож хоёр морь эмээллээд бэлхэн болгов. Архиндаа шартсан Довчин хаван нvдлэн арай гэж босоод шар тайлах гэж хэдэн хундага архи халааж уугаад, бантан хийлгэж хоёр аягыг идээд Эрдэнийг дагуулан морджээ.

Замдаа Аюуш лам, Чулуун занги хоёртой нийлж цааш явлаа. Хvрээний том худалдаачин лам нарын нэг Аюуш саяхан бээс болсноо бардамнан ярьж Богдод заяаны эмээ заалгах гэж зуун лан мөнгийг Данигай сойвонгоор дамжуулан барьснаа ярив. Бас Бадамдорж шанзав Сангийн яамны тvшмэл болгож өгсөн тухай онгирон ярьжээ.

-- Лам нар та бvхэн баахан дэндэж байна. Төрийн хэрэгт орох хэрэг алга гэж Чулуун, ламыг зэмлэв.

-- Халхын заяа буянг шарын шашин сахиж байгаа болохоор бид лам наргvйгээр төрийн хэргийг жолоодох нь сохор хэрэг гэж Аюуш бардам бөгөөд ихэмсэг хэлж хоолойгоо засав.

-- Төр бол хоёр баганатай байдаг. Нэг нь бол бид ван, бэйл, бэйс, гvн зэрэг бичиг цэргийн тvшмэд, нөгөө нь гэвэл хутагт хувилгаан, хамба, цорж зэрэг санваартан лам нар болохоор төрийн баганыг бид хамт тvшилцэх ёстой билээ гэж Довчин мэдэмхий хэлжээ.

-- Лам нар төрийн төлөө залбирч л байвал дээр. Хоёр багана байдаг юм бол нэг нь бичгийн тvшмэд, нөгөө нь цэргийн тvшмэд. Өөр багана байхгвй гэж Чулуун хэлжээ.

Хэрэв цогчин дуганд тулж ирээгвй бол Аюуш Чулуун хоёрын энэ маргаан юунд ч хvрч магадгвй байв.

Ямбаны хувцсаа өмсөж тогосны өдтэй отгоо намилзуулсан ноёд, тvшмэдийн цуваа дуганы вvдээр орох гэтэл мундаг биетэй хэдэн дуганч зам хөндөлдөн хаажээ.

-- Юу болоод зогсоож орхив.

~ Цаад дуганч нар чинь юу гээд зам хөндөлдөөд байгаа юм бэ? гэх зэрэг vг ноёд тvшмэдийн эгнээнээс сонсогдож байв.

-- Хэнийг ч битгий оруул гэж Шанзавын яамнаас зарлиг буулгасан гээд дуганч нар гэдрэг нь шахаж эхлэв.

Довчин олны дундаас урагшлан гарч шахмал бvдvvн дуугаар: «дуганч та бvхэн зvйн явдлыг

ухамсарлаагвй боллолтой. Бид бол тулгуур төрийн өрөөсөн багана болсон бичиг цэргийн түшмэд байна» гээд ихэмсгээр толгойгоо сэжлэн, ханцуйгаа даллан хаяж урагш алхав. Гэтэл дуганч нар барсын сүүл, өргөстэй торлогоор ноёд түшмэдийг нүүр нүдгвй занчиж эхлэв.

Түшмэдийн зарим нь учирлан ярихыг оролдоно. Зарим нь «Шалдан банди нар дэндэж байна», «Бид нар төрийн түшмэд байна» гэсэн боловч тус болсонгвй. Сүүлдээ ноёд түшмэд морьд руугаа сандран гвйв.

Довчин барсын сүүлэнд дайрагдан шургачин унаад нүүрэн дундуураа нойтон бургасаар ороолгуулаад арай ядан мөлхөж мориндоо хүрээд ум хумгвй зугтав.

Түшмэдүүдийг ингэж доромжлох зарлигийг их шавийн да лам Бадамдорж шанзав өгчээ.

Төрийн эрхмийн төлөө болж байсан хар, шар феодалын тэмцэлд үлэмж хонжоо олохын учир Бадамдорж ийм хэрэг хийжээ.

Доромжлогдсон түшмэдүүд гомдол нэхэж заалдахад шавь яам богдын зарлиг гэж уг хэргийг шилжүүлэн аваад ноёд түшмэдүүдийг тус бүр нэгэн мянган зулын үнээр торгожээ. Түүгээр ч барахгвй Богдын дэмжлэгээр Бадамдорж шанзав төрийн эрхийг эзлэн авч улсын ерөнхий сайд болов.

Ингэж шар феодалууд төрийн эрхийг гартаа авч дураараа дургиж эхлэв. Энэ вед орос оронд бадарсан Октябрийн их хувьсгалын эрх чөлөөний гэрэл монгол оронд нэвтрэн ирлээ.

Нэгэн дор пролетарийн их хувьсгалаас айн сандарч, нөгөө дор шар феодалуудад хорссон засаг ноёд бахардахдаа балиусаас атгаж авна гэгчээр хятадад төрөө худалдахаар шийдэж хүрээнд байсан хятадын элчин төлөөлөгч сайд Чин ванд бараалхаж хятад улсад дагаар орж захирагдахыг хүсэв.

Монголын ард түмний олон зуун жилийн баатарлаг тэмцлийн ачаар байгуулагдсан улс төрийг хэргэм зэргээр худалдах вед хүрээнийхэн «богц, богц мөнгөөр богдыгоо худалдсан сайдууд, дэнс дэнс мөнгөөр дэлхийгээ худалдсан сайдууд, магнаг дээлтэй сайдууд гуай, маньгаа худалдаад гялайв уу» гэж гашуун дуу зохион дуулдаг болжээ.

Монголын эзэнт хаант төрийг залгих аятай цагийг хүлээж байсан хятадын хөрөнгөтний засгийн газар төрийн энэхүү наймааг дуртай хүлээн авчээ.

Хятадад дагаар орохоор хэлэлцээ хийхээр очсон ноёдыг Чин И сайд ямбаныхаа хувцсыг өмсөөд үүдэн дээрээ хүлээж аваад, арзгар урт шар шүдээ ярзайлган, нүдээ жартайлган инээж:

-- Эрхэм хүндэт сайд, түшмэдүүдийг ёс алдаж холоос угтаж чадаагвй түмэн ялыг минь өршөөх ажаамуу. Тэнгэрийн хишгээр та бүхэн миний өчүүхэн гэрт гийгүүлэн ирсэнд баярлавч барахгвй гээд түшмэд, ноёдыг урин оруулж янжуур тамхи, сайхан хоол, мэглүү архиар дайлав.

Сайдуудын хүсэлтийг Чин И их л анхаарч сонсож толгойгоо дохин, янжуурынхаа үнсийг тамхины шаазан сав руу алгуур унагаж байлаа.

-- Энэ бол сайхан хэрэг. Дундад, монгол хоёр бол эзэн Чингэсийн веэс төр улсаа хамт байгуулж байсан түүхтэйг мэргэн сайд ноёд мунхаг хүнээр заалгах юун билээ. Та бүхний энэ хүсэлтийг засгийн газраа мэдүүлнэ. Мэргэн та нар биднээс хүсэх өөр зүйл байхсан болов уу?

-- Гагцхүү Богд хаантан ба олон аймаг хошууны засаг ноёдын тушаал хэргэмийг хуучин хэвээр хэрэглүүлэх биз гэж аймшиггвй гуйна гэж нэг ноён хэлэхэд Довчин алгаа хавсран, өрөөсөн нүдээ анин хоолойдоо инээж «бичиг цэргийн түшмэд биднийг төрийн албанд хэрэглэн, цалин пүнлүүг зохих ёсоор хүртээж байхыг эрхэм мэргэн сайдаас хичээнгвйлэн хүсэж байна» гэж нэмлээ.

-- Та бүхний энэ үлэмж хүслийг дундад улсын засгийн газар биелүүлнэ гэж өчүүхэн би итгэж байна гэж элчин хэлжээ.

Ингээд түүхэнд Чин И-гийн жаран дөрвөн зүйл гэж нэрлэгдсэн гэрээ бий болсон ба удалгүй баруун хойт хязгаарыг сэргийлэн хамгаалах их цэргийн ерөнхийлөн захирах жанжин Сю Шү Жан их цэргийн хамт монголд нэвтрэн орж ирэв.

Чин И сайдад монголын төрийг худалдах их олз, үлэмж гавьяанаас хожимдсон Бадамдорж шанзав Шү жанжинд нүүр тал олохоор шийдэж хэдэн цаас захиа бичлээ.

Бадамдорж шанзав шадар нөхдийн хамт Шү жанжинд өргөх бичгийн эхийг өглөөнөөс эхлэн бичээд оройн нар хана өөд цойлон гарахын үед дуусав.

-- За та нар харьцгаа. Би явуулчихъя гэж Бадамдорж хэлэв.

-- Шанзав аа би хүргэж өгье,

-- Болохгүй. Бидэнд атаархаж байгаа засаг ноёдод мэдэгдэж болохгүй. Та нарын аль нэгнийг хүргэж өгөхийг харвал хэрэг буруу тийшээ эргэнэ. Энэ учраас найдвартай, бас тэгээд бидэнтэй холбоотой гэдгийг нь хэн ч мэдэхгүй хүнээр явуулна.

-- Шанзавтны ухаан ч мөн саруул гэгээн байна.

-- Давхар бодож байна шүү.

--Ийм саруул бодолтой хүнийг ч яаж дийлэх билээ дээ.

Шанзав босож суниагаад хүйтэн инээмсэглэв. «Монголыг буулгаж авсан гавьяаг булаалдаж байгаа Чин И, Шү жанжин хоёрын дунд яс хаяж, Шү жанжны цэргийн сүрээр Чинг зайлуулбал давхар хонжоо олох ажээ». Гавьяа олж, засаг ноёдоос өшөөгөө авна. Түүгээр ч барахгүй Монголын орой дээр сууж Шү жанжны хүчээр дайснуудаа бяц цохиж чадах мэт бодогдоно.

«Та нар Бадамдоржийг араар нь тавьж хэзээ ч чадахгүй. Хөгшин чинь шүдгүй ч гэсэн дүү нараа хүлхэж орхино» гэж дотроо шивэгнээд хөмсгөө зангидав.

Үүд дуугарч донир лам орж ирэхэд Шанзав цочин эргэв.

-- Гэгээний элч ирээд танд бараалхахыг хүсэн айлтгаж байна гэж донир алгаа хавсрав.

-- Хэнтэй ч уулзахгүй. Харин морь бэлхэн болгоорой

-- За сайвар хүрэнг бэлхэн болгоё гээд донир ухран гарлаа.

Хэсэг болсны дараа донир буцаж ирээд алга хавсран «дээдсийн чухал бичгийг өгөх юм гэнэ» гэж хэлэв.

-- Тийм бол түргэн оруул гэж шанзав огцом дуугаар тушаав. Хаалга нээгдэж, шар дугтуйтай бичиг, өргөн барьсан Жамбал орж ирээд өрөөсөн өвдөг дээрээ сөхрөн «Эрдэнийн тамгат, тавантаа залж, есөнтөө өргөмжлөгдсөн Зая бандид гэгээн эрхэм шанзав таны түмэн амгаланг эрж энэ бичгийг дэвшүүлэн барив» гээд нахисхийснээ босож зогсов.

— Үгүй энэ чинь дээдсийн бичиг гэсэн биш билүү?

- Жа тийм ээ. Бандид гэгээнийг бид шавь нар дээдэс гэж өргөмжилдгийг эрхэм шанзав юу айлдах билээ дээ гээд Жамбал нүдээ таталзуулан инээмсэглэв.

Сүүлийн үед Бадамдорж шанзав богдын зарлигаас өөр хүнтэй уулзахаа больсныг Жамбал мэдсэн учир ийм арга хэрэглэжээ.

Нэгэнт бичгийг авсан болохоор Бадамдорж нүдний шилээ хийж аажим хөдөлгөөнөөр дугтуйг задлан бичгийг гаргаж хошуугаа жуумалзуулан уншив. Дуусаад Жамбалыг ажиглан харахад өмнөөс нь хоёр ногоон нүдээ гөлийлгөн ширтэж байв. Бадамдорж тэссэнгүй харцаа хариулав. Уул бичигт Бадамдоржоос шавь нарыг ивгээж, хошуудыг хавчиж байгааг магтан сайшааж, Заяын шавь Жамсран бэйсийн хошууны хооронд гарсан газар нутгийн будлианыг түргэн тасалж өгөхийг хүсчээ.

-- Та нар хvний нутгийг луйвардах гэж байгаа байлгvй дээ гэж шанзав сvр бадруулсан ширvvн дуугаар хэлэв.

--Халхын наймхан тамгатай хутагтын нэг тийм сvнсгvй юм хийхгvй гэдгийг өчvvxэн би эрхэм шанзавт аймшиггvйгээр айлтгая гээд өврөөсөө алтан тойгон ембvв гаргаж «гэгээн таны лагшинг асуун барьсан билээ» гэж худал инээгээд барив.

--Чи чинь эрvvl хvн vв?

--Нэгд бол манай гэгээн таны сайн нөхөр бус уу? Хоёрт бол хошуудын засаг ноёд таны өмнөөс муна баривал бид шавь нар таны төлөө морь нохой мэт зvтгэх бус уу? гээд Жамбал нахис гэлээ

-Анхандаа «Ямар улаан амьтан бэ?» гэж зэвvв нь хvрч байсан шанзав Жамбалын vгийг таслах гэсэн боловч зогсож өгсөнгvй. Сvүлд нь Жамбалын «улаан дайралт» д шанзав ялагдаж олбог дээрээ завилан сууснаа:

-- Заяын гэгээн олон ийм шавьтай бол халхад хэцvв хэрэг болж магад юм байна гээд инээмсэглэв.

-- Гэгээний өчvvxэн шавь нарыг Эрдэнэ шанзав таалан ивгээж байгаа бол бидний жижигхэн хvсэл биелэгдэх болжээ гээд Жамбал гөлөлзөн зогсоно.

Шанзав будлиантай нутгийг Заяын шавьд өгөх тухай улаан шугамтай бичиг хийж өгснөөр барахгvй Жамбалыг vнэлж бичгээ Шv жанжинд хvргvүлэв.

-- Шанзавын бичгийг Шv жанжипд барьж, таныг нууцаар нvүр учруулж өгөхийг өчvvxэн шавь аймшиггvйгээр хvлээн авна гээд Жамбал явсан билээ.

Yнэхээр ч Шанзав Шv жанжинтай хэд дахин нууцаар учирч богд хааны төрийг буулгах тухайн бvх асуудлыг ярьж тохиролцов.

Шv жанжин цагийг алдалгvй хөдөлж Чин И-г гэрийн газар нь хорьж жаран дөрвөн зvйлийн гэрээг хvчингvй болгон Богдын ордонг цэргээр бvслvүлэн монгол нь хятадад vүрд захирагдах бичгийн эхийг зохиож Бадамдоржоор гарын vсэг зуруулан Бээжинд явуулжээ. Ингэж Шv жанжны цэргийн дарангуйлах засаг тогтон Монголын ард түмний зовлон зvдvүр хязгааргvй болов.

Шанзав Жамбалын чадлыг vнэлж өөрт нь хvчин зvтгэхийг хvсвэл «өчvvxэн би Зая бандид гэгээний найдварыг хvлээсэн элч болохоор хэн миний толгойг мэдэх билээ» гээд буцжээ. Yнэндээ Жамбал Бадамдоржийн энэ хэрэгт итгэхгvй байжээ. Монголд гаминг эсэргvүцсэн тэмцэл өдөр ирэх бvр өсөж байгааг харсан Жамбал Сю-Шv-Жан Бадамдорж шанзав хоёрын наймааг, ямар урт наслах юм биш, гэж бодсон учир энэ хэргээс хол явъя гэж шийдсэн билээ.

## XII

Өвлийн нэгэн жихvвн хvйтэн өглөө Эрдэнэ Довчингийн дөрвөн морийг дунд голоос усалж ирээд пинд оруулж овъёос тавин өгөөд гартал хашааны хаалга нээгдэн гамингууд орж ирээд олон таван vг ч ярьсангvй шууд морьдыг нь холбон авч явах гэхэд Гэрэл, гvйн очиж гамингийн даргын хөтөлж явсан жороо хээр мориныхоо цулбуураас барин угз татаж авлаа. Гамингийн дарга Гэрэлийг шалиг нvдээр харснаа мориноос бууж дэргэд нь очоод «ямар зоригтой хvvxэн бэ» гэж ярьайн инээмсэглэв.

--Эрдэнэ минь яадаг билээ. Салгаж vз. Цаадах чинь яаж ч магад хvн шvү гэж Довчин хоолойгоо чичрvүлэн Эрдэнийн ард орж тvлхэнэ.

-- Илжиг минь чамд морио өгөхгvй гээд Гэрэл тэвэрч авах гэсэн гамингийн даргыг алгадав.

--Яасан догшин байна. Тан шиг сайхан хvvxний морийг эс авбал би эр хvн биш болно гэж гамингийн дарга эрх хав шиг сагсагнан хэлэв.

Довчин «Эрдэнэ минь Эрдэнэ минь» гэж аахилна. Гамингийн дарга Гэрэлийн урт нударгаас

барьж авлаа. Эрдэнэ ухасхийн очиж гамингийн даргын зэвхий саарал цамцны мөрөн дээрээс базан авч угз татан Гэрэлийг салгав.

Дарга сэлээдий бууныхаа ишнээс шvvрэн авснаа болиод Эрдэнэ өөд харвал тэр нь чулуун хvн шиг хөдлөх ч vгvй, дуугарах ч vгvй зогсож байлаа. Энэ хоёр хэрсэн бух шиг ширтэлцэн зогсов.

-- Эхнэр минь, хэрэгvй. Энэ муу адсага олдож болно. Өгч орхи! гээд Довчин амьсгаадавч тvvнийг анхаарч сонссон хvнгvй.

Гамингийн дарга хvйтнээр инээмсэглэснээ түргэн эргэж мориндоо мордоод явахад цэргvүд нь дагав.

--Муу сайн дээрэмчид чинь гурван морийг минь өгсөнгvй шvv. Турсагыг нь хуулах юмсан гээд Довчин нvдээ хурцлан хошуугаа мурилзуулж байв.

Хэдэн өдрийн дараа монголын автономит төрийг буулгах бузар ёслол болж, Очир дарийн хувилгаан богд Жавзандамба хутагт, Да Жунтан Юудань-Ши Кай-гийн зурагт мөргөн, Бадамдорж Шанзав монголыг буулгаж өгсний шанд хагартлаа баяжив.

Монгол нутгийг боолчлол, доромжлолын хар манан бүрхэж маргаашийн цуст яргалал бүхний зүрхийг базсан тэр нэгэн өдөр Эрдэнэ гудамжинд Доржтой дайралдав.

--Эрдэнэ минь vнээс илvv гутамшигт хэрэг байхгvй шvv дээ. Эзэн хаан маань хятадын зурагт мөргөнө гэсэн чинь юу гэсэн vг вэ. Бид тулалдсан бол тийм ч амархан дийлдэхгvй юм шvv. Даржаа баатар бууж өгөхгvй, vзэлцэнэ! гэж дээдэст айлтгахад дээдэс « тэгж болохгvй» гэж зарлиг буулгасан гэнэ. Одоо тэгээд маргааш өглөө бид цэрэг зэвсгээ хураалгана гэж Дорж түмэнтэйеэ гашуудан гаслан ярилаа.

-- Бид чинь ингээд дахин боол болох хэрэг vү? гэж Эрдэнэ асуув.

-- Боолын боол болох нь тэр. Гэвч монголын заяа их л дээ. Гаслах цаг байхад баярлах өдөр бас байх ёстой гэж Дорж хэлсэн боловч юу болоод хэзээ баярлахаа өөрөө л мэдэхгvй байжээ.

Маргааш нь Богдын цэрэг гаминд зэвсгээ хураалгав. Саяхан гартаа чанга атгаад ялж байсан зэвсгээ хураалгаж байгаа өмссөн дээл нь ноорхой боловч хvдэр, эрсийг хараад Эрдэнийн сэтгэлд харийн дайсныг занан хорсох бодол өөрийн эрхгvй дvрэлзэв.

Доромжлолоор зүрхий нь атгах гэсэн гамингийн бодол монгол хvн бүрийн сэтгэлийг жигшил хорслын галаар дvүргэв. Тэндээс Эрдэнэ харанхуй бодолд дарагдан гэлдэрч явтал хоёр гамин нэгэн эмэгтэйг хашгируулан чирч яваа харагдав.

--Монгол ах дvү минь. Энэ буруу номтноос авраач. Би нөхөртэй хvн шvv гэж тэр эмэгтэй хашгиравч хоёр цэрэг тvvнийг тавьсангvй. Орчин тойрны хvмvүс ч тусалсангvй.

Эрдэнийн уур нь гэнэт буцалж шуугин очоод хvнд гараараа нэг нэг цохисон чинь хоёр цэрэг тонгорцоглон унаж, хvүхэн алга болов.

Энэ үед зэвсгээ хураалгасан шившигт явдлыг vзээд хорсон буцалж явсан Цэвээн тэргvүн, Гомбо бэйс хоёр нэг монгол хvн хоёр гаминг унатал цохихыг бахдан харлаа.

Эрэмгий чадал, эр зориг ч бидэнд байгаа л юм даа. Гагцхvү хөтлөөд явах хvн л дутагдаж байна гэж Гомбо бэйсийг хэлэхэд:

-- Би ер нь Семоновоос тусламж гуйя гэж бодож байна. Элч л явуулъя. Та зөвшөөрөх vү? гэж Цэвээн тэргvүн хэлэв.

-- Мэргэн санаа байна гээд vгээ таслав.

Эрдэнэ рvү хашаанаас гарч ирсэн зургаан гамин дайрав. Эрдэнэ баруун зvүнгvй vсчиж зодолдсон боловч шоргоолж шиг овоорсон гаминд баригдан хvлэгдэв.

-- Ийм хүнийг явуулбал зүгээр үү гэж Гомбо бэйсийн хэлэхэд Цэвээн тэргүүн ямар нэгэн мэргэн арга олсон бололтой морины амыг эргүүлж, хүлээтэй Эрдэнийг тойрон байгаа цэргүүддээ юм хэлж байсан даргын дэргэд очиж, түрийвчнийхээ буланг нударган дотроосоо цухуйлган үзүүлж:

--Эрхэм ноён, надад энэ муу боолыг өгөөч гэж хүлээтэй хэвтэж байгаа Эрдэнэ рүү зангав. Дарга инээмсэглэн, Цэвээн тэргүүний дэргэд ирээд «хэд вэ» гэж шивэгнэв.

--Хорин таван янчаан

--Хорин тав.

-- За яахав хорин тав.

Дарга, Цэвээн тэргүүний өгсөн хорин таван мөнгө янчааныг авч эргэмэгц Эрдэнийн хүлээсийг тайлуулаад зогссонгүй, Эрдэнэд анхны цохиулсан хоёр цэргийг хэд хэд алгадав. Эрдэнийг аваачаад гурав хоног сэлээдий буугаар буудах сургууль хийлгэж байлгаад нэг орой Цэвээн тэргүүн уулзав.

-- Чи ч гамингуудтай сайн зодолдсон шүү. Би хараад их л баярласан.

--Эмэгтэй хүнийг түмний нүдэн дээр доромжилж байхыг хараад тэвчиж чадаагүй юм.

-- Манай монгол ч бузар доромжлогдож байна даа гээд Цэвээн тэргүүн гүн санаа алдаж Эрдэнэ рүү харлаа.

-- Зэвсгээ хураалгахгүй үзэлцэх л ёстой байсан юм даа гэж Эрдэнэ хэлэв.

Цэвээн тэргүүн чухам энэ үгийг хүсэж байжээ. Эрдэнийг зальтай нүдээр ажиглан харснаа урт санаа алдаад:

-- Тийм л байсан. Гэвч одоо нэгэнт хожимджээ. Өөр зам хайх хэрэгтэй байна.. гээд Эрдэнэ рүү ширтэв.

-- Өөр зам байвал та хэлээд аль. Би морь нохой мэт зүтгэхэд бэлхэн байна гэж Эрдэнэ шууд хариулав.

Цэвээн тэргүүн их л бахдалтай инээж босоод том гэрийн дотуур ийш тийш хөрөөдөн хэсэг алхсанаа:

-- Эр хүний яриа шууд бол сайхан. Ялангуяа улс орон маань ийм зовлонд ороод байхад эрс яриа, ганц зориг хэрэгтэй. За ийм байна. Чит хотод Атаман Семомов гэж орос улсын нэртэй ноён их цэрэг хөдөлгөж, бидэнд туслах гэж байгаа. Түүний явуулсан хүн одоо хөвчийн жонон вангийн нутагт бидний төлөөлөгчийг хүлээж байгаа. Түүнд чамайг явуулья гэж бодож байна. Замд саад аюул их. Гамингууд хүрээг бүслээд шувуу ч орж гаргахгүй байцаан шалгаж байгаа. Гэтэл та бол бидний бичгийг авч явах болно гэж хэлэв.

-Тэр ноён монголыг гамингийн доромжлолоос салгаж өгөх юм уу?

-- Яриа юу байхав дээ!

-- За тэгвэл хэзээ гарах вэ?

-- Өнөө орой гарч болно.

Тэнгэр бүрхэж байснаа гэнэт цэлмэж том гэгчийн дугариг сар ертөнцийг гийгүүлэв. Эрдэнэ хос морьтой явсаар Наймаа хотын өмнө хүртэл гаминтай тулгарав.

--Би гэмгүй хүн байна гээд морио татан зогстол өмнөөс нь дөрвөн морьтой гамин гарч ирлээ.

-- Эрдэнэ бөөнд нь барин буудаад мориндоо ташуур өгч зүүн зүгийг чиглэн хурдлав. Гэнэт дуугарч нэг морийг нь алсан бууны дуунд сандарсан гамингууд ухаан орж амжаагүй байхад Эрдэнэ тэд нараас нилээд холдож морины дэл рүү бөхийн, хааяа хааяа эргэж харан давхиж явлаа. Гэтэл олон буу тачигнан сум тал бүрээр нь шуугин исгэрч эхлэв. Нэг мэдэхэд Эрдэнэ Улиастайн голыг гарч Туулын хойт талыг барин давхиж явлаа.

Буун дуу холдсоор, салхит хошуу хүрэхэд бүр чимээ тасрав.



Эрдэнэ хурдаа татаж урагш эргэн Туулыг гаталж гараад голын шугуй дагаж хатируулан явжээ.

Салхинд шуугих бургасны дуу, морины амьсгаадахаас өөр чимээ сонсолгвй явсаар горхийн ам өнгөрч вүрийн гэгээтэй золгов.

Дорнот уулсын орой дээгвүр манхайн цайж байгаа шинэ өдөр Эрдэнийн амьдралд юу авчирч өгөхийг таахад хэцүү боловч том аюулаас энэ удаа мэнд гарсан их завшаан сэтгэлд нь ямар нэгэн баярыг авчирч байлаа.

### ХIII

Гамингийн замаас оргон зайлсан Итгэлтийнх Хануй голын өмнөх дүнгэр хар уулын ард нутаглаж байлаа. Суурь малуудаа зайлуулж чадсанаас гаминд өнчин ишиг ч алдсангвй. Монголд болж байсан вймээн Итгэлтийн гэрт орж ирээгвй эзний нь сэтгэлийг ч хөндөөгвй байжээ. Гамингууд Луу гүний хүрээнд орж дээрэм хийсэн боловч хоёр гурван навтархай хар гэр зориуд буулгасан Итгэлтийн хашаанд тоож орсонгвй өнгөрчээ.

Нэгэн өдөр Итгэлт хоёр морь бариулж хос морьтой Луу гүний хүрээ рүү Павловын гэр бүлийг эргэх, бас бус ажилтай явжээ.

Павловын эхнэр хүүхэд гамингийн замаас дүрвэж зайлсангвй. Учир нь гамингууд оростой эвдрэлцэхгвйг хичээн оросын харьяат нарт халддагвй байжээ.

Гарсныхаа маргааш орой нар жаргахын өмнө Павловын сууринд ирвэл хашаанд нь арван хэдэн морь уяатай байлаа. Байшинд өдий төдий хүн шуугилдан их л хөгжилтэй байв.

Морьдоо уяад орвол сүрхий согтсон Павлов угтан ирж тэврэн үнсээд «миний сайн нөхөр баян Итгэлт гэдэг хүн. Эд бол миний нэгэн зорилгот анд нар танилцацгаа» гэж хэлэн орос хэлээр өөрөө орчуулав.

Павлов Ангарын хотод очоод цагаантны бослогод идэвхтэй оролцож Омск хотод гадаадын зэвсэг, дэмжлэгээр байгуулагдсан Колчакийн цэрэгт оржээ. Улаан армийн эсрэг гарамгай тулалдаж большевикуудыг хайр найргвй хядсанаас офицер болжээ.

Уралыг өнгөрөн байлдаж явтал улаан армийн их хүч Колчакийн эсрэг довтолж, Омскийн засаг устаж арми нь эргэж харалгвй зугтав. Нэгэн талаас улаан армийн хүчтэй довтолгооны буцлан хөөсөрсөн их үер, нөгөө талаас хагд өвсөнд орсон твймэр шиг овозон гарсан Сибирийн партизанд шахагдаж хаданд хавчигдсан төмс шиг болсон Павлов нөхдийн хамт монгол руу оргон иржээ.

--Бид эхлээд улааныг зад цохисон. Дараа нь дийлэгдсэн. Гэвч бууж өгөөгвй. Хүч залгаж байгаад үзэлцэнэ гэж Павлов урт яриагаа дуусгав.

Павловын шар сахал нь урт ургаж, царай нь барзайн дуу нь баргил болсныг Итгэлт ажиглав. Колчакийн дээрэмчдийн өчүүхэн хэлтэрхий болсон энэ хүмүүс ялагдлын хорсол гасланг архины аагаар дарж дуу дуулалдан хашгиралдах нь сэг булаалдсан хэдэн хэрээ гуаглалдан шуугих мэт ажээ.

«Хожигдсон шатрын ноёныг өрөг дээр хичнээн чанга тавивч мадаас аварч болдогвйн адил, та нарын ажлын хөг өнгөрсөн бололтой» гэж Итгэлт бодовч өнгөн дээрээ нөхрийн гашуудал зовлонг хуваалцан «эр хүн долоо дордож, найм дэгжиж явдаг юм даа» гэж байлаа.

--Бид большевикийн хар тахлыг арилгасан цагт Итгэлт бид хоёр монголд арьс ноосны том том вйлдвэр барина гээд Павлов дэргэдээ сууж байсан Итгэлтийн нуруу руу алгасанаа миний Итгэлт бол арми хангаж чадах хөрөнгөтэй, Сава Морозовыг хожиж чадах ухаантай хүн гэж нөхдөдөө гайхуулан хэлэв.

--Өвгөн чинь ч бас балраад байна. Байдаг хэдийгээ гаминд идүүлж орхисон гэж Итгэлт гашуудалтай хэлжээ.

--Хаа байна. Тэр гамингийн хавнууд, бид тэднийг дэвсэж орхиё. Үнэн шvv Итгэлт минь. Бид дэвсчихнэ гэж Павлов завьжаараа хөөс сахруулан агсрав.

Тэр шөнө Итгэлт Павловын байшинд согтуу оросуудтай унтаад маргааш нь бас л архидав. Үдийн хирд хоёр морьтой хvн ирсэн нь Жамбал, Зая гэгээн хоёр байлаа. Павловын эхнэр охин хоёр гэгээнийг хөл алдан угтав.

Гэгээн хар захтай цэнхэр торгон дээл дээр шар дурдан бvс бvслээд орос улаан эрээн эсгий гутал өмсчээ.

Итгэлт босож адис авлаа. Павловын авгай хэдэн vг хэлэхэд бvх хvмvvc босов.

-- Зvгээр, сууцгаа гээд гэгээн баясгалантай инээмсэглэв. Павловын эхнэр охин хоёр гэгээнийг хуучин, дотно танилын ёсоор vлэмж хvндэтгэн зочилж байгааг хараад «Эд хэдийд ийм сvрхий танилцсан юм бол» гэж Итгэлт гайхав.

Үvнээс өмнө хичнээн хvн цугларавч Павловын байшингийн хамгийн хvндэт зочин нь Итгэлт байдаг билээ. Гэтэл энэ удаа Заяын гэгээн хамгаас илvv хvндлэгдэж, бvхний анхаарлыг татаж байгааг хараад Итгэлтэд атаархах сэтгэл төрлөө.

Заяын гэгээн өнгөрсөн намар Луу гvний хvрээнд заларч ирэхдээ Павловын охиныг харж тvvvнийг шохоорхон Жамбалаар дамжуулан танилцаад тогтмол ирдэг зочин болжээ.

Гэгээн, ширээний эхэнд сууж, авгайн хийж өгсөн архийг ууснаа «та бvхэнд чих баярлуулсан чихэр шиг vг хэлье. Саяхан бурхны авралаар баатар цагаан хааны их жанжин тавдугаар богдын хувилгаан Барон-Унгерн гаминг тамын замаар тонилгож хvрээг эзлэн, Богд хааныг ширээнд нь суулгав. Одоо улаан намын хулгайг vнсэн товруу хийх Шамбалын дайнд бэлтгэж байна» гэж хэлэхэд Итгэлтээс бусад хvмvvc баярлалдан шуугилдав.

-- Ийм сайхан баяр болсны төлөө нэг нэг хундага дэвшvvлье гээд Павлов бvхний өмнө хундаганд архи хийхдээ миний өчигдрийн ярьж байсан vг хоосон vг биш байгаа биз гэж Итгэлтээс асуухад тэр хvчлэн инээснээ «Тийм. Чиний vг хэзээ ч хоосон vг байгаагvй» гэлээ. Хvмvvc хундагатай архиа тулгаад хөнтрөхөд Итгэлт бусдын нvдийг хариулж байгаад цацаж орхилоо. Жамбал гэгээний хажууд суун хэлэх vгийг нь заана. Нvvp нь нилээд улайсан гэгээн, ам халан ярьж байхад согтсон хvмvvc эвшээвч сонирхон сонсож байгаа дvр vзvvлнэ.

--Хатан, авхай хоёрт манай гэгээн өчvvхэн бэлэг авчирсан юм гээд Жамбал өврөөсөө хадаганд боосон очиртой алтан бөгж, эрхий дарам сувдтай ээмэг хосыг гаргаж өгөхөд бvх цугларагсад шижир алтны чанарыг гайхан шагшрав.

-- Энэ бөгж, ээмгийг Цогт бэйсийн хvрэн дархан гэдэг хvн хийсэн юм гэж бэлэглэсэн юм нь олны анхаарлыг татаж байгаад баярласан гэгээн хэлэв.

-- Алт, та нар хараач гээд Павлов бөгжийг гэгээвчээр орсон нарны гэрэлд барьснаа нарны гэрэл хvртэл шунаг гэгч нь шингэж байна гэлээ.

--Алт шиг сайхан юм хаа байх вэ? Одоо арван пvv алттай бол большевикуудыг бут ниргэхэд тун амархан байна гэж нэг хvн хэлэв.

--Манай хааны алт арван пvv лав байсан. Тэгээд тус болсонгvй. Үнэнч албат бид нь энд аглаг ойд зэрлэг араатны дунд архи уугаад баларч байна гэж бас нэг согтуу хvний ойворгон дуугаар хэлэв.

--Алтыг цэгнэж чаддаг байх хэрэгтэй. Тэгвэл тvvний хvч хязгааргvй их. Одоо арван пvv алттай бол Америкт очоод юу ч хийж болно гээд Павлов бөгжийг эхнэртээ буцааж өгөв. Хvрээнд гамин ялагдсан мэдээг аль эрт сонсож зvрх чичирч, сvнс нь зайлсан хятад пvvсvvdээс архи зээлээр авчруулан хоног гаруй найрлаад гэгээн буцахдаа «Та бvхэн миний өчvvхэн гэрт зочлон очихыг хvсье» гэлээ.

Тэр орой Итгэлт буцахдаа «Павлов минь. Би удахгvй нvvж ирнэ. Тэгээд газрын хөрсийг

эргүүлнэ» гэжээ.

Бадарч хүрээнд гамин дарагдсаныг сонсмогц Төмөртэй хамтарч олсон буу зэвсгээ хэрэглэн хэдэн хүний хамт мордож Луу гүний хүрээний хэд хэдэн хятад лангуунуудын өнгөтэй, өөдтэй бүхнийг цөлмөн авчээ.

Энэ вед улаан армид бут цохигдсон цагаан цэргийн хэсгүүд Түнхэнээр дамжин монголын нутагт орж Павловын удирдлагын дор нэгдэн баронтой холбоо барьжээ.

Чингисийн их тулгуур төрийг босгож, их монгол улсыг байгуулна гэсэн бароны хуурамч үгэнд итгэсэн монголын феодалуудын идэвх сэргэж Богдын лүндэнгээр нутгийн ардуудаас агт морь татан цэрэг дайчилж, ямар ч хаалгыг тогтоохгүйгээр монгол нутгийн умраас нэвтрэн гэрэлтсэн эрх чөлөөний их нарыг таглах тэмцэлд орлоо.

Ингээд сайд Ван, Заяын шавь Луу гүний нутагт орос монголын хамтарсан цэрэг байгуулагдаж монгол жанжин нь сайд вангийн Пүрэв туслагч, орос жанжин нь Павлов болжээ.

Энэ цэрэг нь юуны өмнө хятад пүсүүдийг дээрэмдэж эхлээд дараа нь монгол малчдыг дээрэмдэж очсон газраа архидан завхайрч байлаа.

Аюул аюул зэрэгцэн, амьсгалах зай хомсдсон энэ вед Өлзийнх Гүнжийн уулын ар хормойд нутаглаж байлаа.

Нэг өдөр тэднийд хоёр янзын гийчин ирж энэ бор гэрийн доторхи амьдралыг өөрчлөв. Өглөө Цэнд үнээгээ гилж явахад зээрд морьтой, хөх даалинбуу хуучин дээлтэй баргил бор хүн ирж нөхрийг нь сураглан асуугаад гэртээ бий гэхэд нь шууд очлоо.

-- Нохой хорио гэсэн гийчний дуугаар гарч ирсэн Хуяг нүд нь том болон инээмсэглэснээ «Чи чинь газрын хаанаас гараад ирэв» гээд морио гэрийн бүслүүрээс уяж байсан Доржийн дэргэд очив.

Цэрэг дайны хэцүү цагт танилцан нөхөрлөсөн хоёр цайз уулзаж юуны өмнө золгоод, бие биесийн өөрчлөгдсөнийг гайхан яриу.

Гэрт орж Өлзий, Хуяг хоёр цай чанаж байтал Цэнд ирж цай хоол, архи болон Доржийг дайлав. Дорж цэргээс хэрхэн буцаж ирсэн. Хужирбуланд яаж амьдарч байсан, гамин орж ирсэн Богд, да Жунтангийн зурагт мөргөж, цэрэг зэвсгээ хураалгасныг нэгд нэггүй яриад «одоо нэг бол үхэх, эсхүл сэхэх цаг болжээ. Үхэхийг хүсэх хүн байхгүй болохоор сэхэхийг зорих, сэхэхийн тул үзэлцэх цаг иржээ. Юуны өмнө манай орныг дур мэдэн дээрэмдэж байгаа гадаадын хулгай нарыг хөөж гаргах хэрэгтэй болоод байна» гэж хэлэв.

-- Барьсан зэвсгээ хураалгаж орхиод юугаараа хөөх юм бэ? гэж Хуяг асуугаад Дорж руу сэтгэл хангах хариу горьдон ширтэв.

-- Зэвсэг олдох болно. Чи гоймон баатрыг танина шүү дээ! гээд нүдээ цавчлан Хуягийг ажив.

--Танилгүй яахав. Золбоотой эр шүү гэж Хуяг хэлээд тамхи асааж авлаа.

Дорж бас тамхи асааж аваад хэсэг дуугүй сууснаа өмнөх аягатай архиас том балгаж тавиад «гоймон баатар, бид нар, ардын нам байгуулаад, оросын шинэ засгийн газраас тусламж олж монгол улсаа чөлөөлөх гэж байгаа...» гэхэд нь үг дуугаралгүй сонсож суусан Өлзий:

-- Ардын нам гэнээ? гэж лавлан асуув.

-- Тийм. Ардын нам! гэж Дорж давтан хэлэв.

-- Чи чинь тэр ардын намын хүн үү? гэж Өлзий асуув.

-- Тийм. Би бол ардын намын хүн.

-- Та нар чинь улаан оростой сүлбээтэй амьтад уу?

-- Тийм.

-- За тэгвэл хvv минь явж vз. Хvvгий минь битгий уруу тат. Бид чинь бурхантай шашинтай монгол хvн Ардын нам, улаан оростой нийлж сvнс, сvлдээ алдахгvй гэж Өлзий ууртай бөгөөд шийдэмгий хэлэв.

-- Аав аа та юу болж байна. Энэ чинь миний сайн нөхөр шvv дээ гэж Хуягийн хэлэхэд нь:

-- Юу ч гэсэн тэр. Би тэр улаан намын чинь тухай сайн мэднэ. Хvv минь зvгээр явж vз.

Эсвэл ах нь хошуу тамганд очиж хэлнэ. Бид та нартай адил бурхан шашнаа харааж чадахгvй гээд Өлзий өндийж суув.

Дорж ардын намын vзэл бодлогын тухай ярихыг оролдсон боловч Өлзий яриулсангvй. Хан өндрийн хvрээн дээр байдаг лам багшаасаа хэдхэн өдрийн өмнө ардын намын тухай сонссон Өлзийн сэтгэлд ардын намыг жигшин зангах бодол оргилон Доржийн vг бvхний хариуд «Чи яв. Тvргэн зайл» гэдэг ганцхан хариу өгч байв.

Хуяг бол ардын намын тухай ац бодолтой байлаа. Монголыг чөлөөлөх гэдэг нь зөв мэт боловч бас л гадаадын хvmvвстэй нэгдэж байгаа болохоор эргэлзээтэй ажээ. Доржийн ярианаас vзэхэд цэрэгт танилцсан нөхөд нь бараг л тэр намтай нийлснийг бодоход бас л учиртай мэт. Гэтэл Доржтой удаан ярьж учрыг ойлгоё гэхэд Өлзий тvvнийг хөөгөөд боломж өгсөнгvй.

-- Үнэн явдал хэзээ нэгэн цагт давж гардаг. Бидний хэрэг vнэн, зөв болохоор давж гарна. Өвгөн та тэр вед буурал толгойгоо шаана даа гээд Дорж vдийн хирд явжээ.

Орой нар ханын элэг өөд гарч байхад буу зэвсэгтэй хоёр хvн ирж Хуягийг тавдугаар Богдын хувилгаан Барон жанжны цэрэгт дайчлах тухай улаан шугамтай бичиг өгчээ.

--За мэдлээ. Би цэрэгт явж сурсан хvн. Маргааш өглөө мордоод хошуу тамган дээр очъё гэж Хуяг тайван бөгөөд итгэлтэй хэлэхэд нь хvн бvхнийг хvчээр эхнэр хvvхдий нь бахируулж чарлуулан vдvvлж, нус нулимсаар нь угаалган дайчилж авсан цэргvvд зөвшөөрөн явжээ.

--Хvv минь бас л салдаг болжээ. Гэвч Барон жанжин гэдэг чинь тавдугаар Богдын хувилгаан гэнэ билээ. Миний хvvг бурхан өршөөг гээд Өлзий уйлав.

-- Зvгээр аав минь. Би эргээд л ирдэг шvv дээ.

-- Уул нь Богд маань дааж байгаа цэрэг юм гэдэг шvv хөөрхий. Хvvгий минь төрийн сvлд өршөөж, тvмний заяа тvшиг. Баруун хацарыг чинь vнсье. Ирэхэд чинь аав нь зvvн хацрыг чинь vнсэнэ гээд хvvгийнхээ баруун хацрыг vнэрлэн vнслээ. Байн байн ханцуйгаараа арчивч Өлзийн нулимс ундран урссаар байлаа. Цэнд эхэр татан хvvхэд шиг уйлан, гарсан нулимсаа шимж байв.

Хуяг хар морио унаж явахдаа Цэндэд «Пvрэв тайжийн дээрэмчидтэй нийлэхгvй. Харин ардын намтай нийлнэ. Аавд маргааш хэлээрэй» гэжээ.

Нар ертөнцийн тvмэн зовлонг харахгvй гэсэн юм шиг хэсэг vлний цаагуур орж нvvрээ барайлгав.

Эргэн эргэн харсаар хатируулан холдож байгаа Хуягийн хойноос харж байсан Цэндийн нvдэнд гялалзсан хар солонго татан тvргэн гулгаж байгаа могой шиг жирвэлзсээр vргэлжилсэн битvv хар туяа болов.

#### XIV

Бароны цэрэг хоёр дахь удаагаа хvрээ рvv довтлоход Эрдэнэ, Цэцэн хан аймгаас татсан зуун цэргийн дарга болоод байлаа.

Нэг дэх удаагийн довтолгооны вед Хоолтын давааны ард байсан хорь шахам гаминг устгахад гарамгай байлдсанаар Эрдэнэ ингэж дэвшжээ. Хорь шахам гаминг дайран орж устгаад олзолсон зэвсэг болон бусад юмаа хоёр морин тэргэнд ачин очиход Барон жанжин «өрөө

гарыг нь атгаж, таван алтан маниадаар шагнажээ.

Амьдралдаа атгаж үзэх нь битгий хэл санаж байгаагүй энэ их хөрөнгөтэй болоод байхдаа Итгэлтээс баян болсон юм шиг санагдаж байжээ.

Хоёр дахь довтолгооны вед Эрдэнийн анги Улиастайн голыг уруудаж Наймаа хот руу дайрчээ. Модчингоос буудсан Бароны их буунд сандарсан гамин Наймаа хотоос ухарч амжаагүй байхад угаас Галшараас гаралтай өндөр цагаан морьтой Эрдэнээр манлайлуулсан цэрэг Наймааны хойт хэсгийг эзлэн хүрээ рvv ухарч байгаа гаминг цавчилж байжээ.

Үдийн хирд гамингийн санд мэнд орхисон хүрээ рvv хуйгвй сэлээдий бугаа бvсэндээ хавчуулсан Эрдэнэ цагаан морин дээрээ vl мэдэг хөндлөн суугаад Гороодын улааны өмнvvр гарч зvvн сэлбэд ойртон ирлээ. Ард нь яваа цэргvvд «Арын замаар алхалж байдаг. Атриа сvvлтэй борлог морь, албаар биднийг захиран суугч атаман хэргэмтэй Семонов» гэж бvдvvн нарийн хоолойгоор дуулалдан явах нь Эрдэнэд сонсогдон дууны аяыг хамраараа даган гиншиж явлаа.

Гэнэт Эрдэнийг морины амыг татан зогсоход ард нь жагсан явсан зуун хvн зогсож, дуу гэнэт тасрав. Өмнө нь нуруу модноос дvvжлэгдсэн хоёр хvн vl мэдэг найган хөдөлж байв.

Энэ бол гамингууд биш, тэдэнд монголыг худалдсан ноёд ч биш, харин ядуу зvдvv хувцастай энгийн монгол хvmvvс байлаа.

Бароны хоёр орос цэрэг уранхай хөх дээлтэй ахимаг насны хар хvнийг дvvжлvvр рvv чирэн явахад арваад насны бvстэй хvvхэд «Аав аа, миний аав аа» гэж хашгиран гvйж очиход нэг цэрэг өшиглөв. Хvvхэд гэдрэгээ унаснаа босож нэг алхаад дахин унаад сэтгэлийн гvн ёроолыг доргиулсан дуугаар «Аав аа, миний аав аа» гэж хашгиран байв.

Эрдэнэ ухасхийн давхиж хар хvнийг чирч яваа хоёр цэргийг дvvжлvvрийн дэргэд гvйцэж очив.

-- Болохгvй. Та нар энэ хvнийг тавь гэж хашгиран хэлэв.

Хоёр цэрэг омголон цагаан морио тогтоож ядан байгаа Эрдэнийг, урамдан ойртож байгаа бяруун бухыг ногоо хазах зуур хялайн харж байгаа нас шvд гvйцсэн том бухын нvдээр харж байснаа, нэг нь баргил бvдvvн хуруугаараа салаавч хийж нулимаад Эрдэнэ рvv барив.

Эрдэнийн уур дэлбэрэн шатаж бvсэндээ байсан сэлээдийг атган автал дэргэд нь ирсэн монгол цэрэг гарыг нь шvvрэн барьж аваад:

-- Та болохгvй гэлээ.

«Аав аа. Миний аав аа!» гэж хvvхэд хашгирсаар байхад цагаан цэрэг хар хvнийг дvvжлээд хөгжилтэй инээв. Бароны цэрэг бол монголыг аврагч гэж Эрдэнэ итгэж байсан билээ. Гэтэл ядуу монголыг нялх vрийн нь нvдэн дээр дvvжлээд хөгжилтэй инээж байгааг хараад өөрийн гэнэн сэтгэлийг ойлгов.

Тэгээд мориндоо ташуур өгч баруун тийшээ нvд анин давхилаа. Хойноос нь цэргvvд нь хэд дахин дуудсан боловч Эрдэнэ сонссонгvй.

Хvрээний зvvн талд буу дуугарч эхлэхэд Бат сэрж босоод хааны хаалгаар гvйн гарах гэтэл хэдий нь босоод хашаан дотор зогсож байсан багш нь хориглоход арга буюу зогсов.

-- Гэвш минь энэ лvн лvн гэж байгаа чинь нөгөө vхэр буу гэдэг нь бололтой. Хvнд ингэж бие биеэ алж байх ямар хэрэг байна даа гээд Эрэнчин явж гэрийнхээ хатавчийг тvшин зогсов.

Гамин орж ирээд энд тэндгvй дээрэмдэн монгол, хvний нэр төрийг доромжлон байхыг Эрэнчин сэтгэл өвдөн харж байлаа. Тэгээд төр, шашныг толгойлж байгаад монгол орныг тvмэн зовлонд унагаасан Богдод хорсох сэтгэл нь улам их болж «Монгол орныг явал аврах вэ?» гэсэн асуудлыг өөрөө өөртөө байн байн тавьдаг болжээ. Гэтэл ямар ч хариу олддоггvй бөгөөд хэрэв бурхны сургаалаар хичээнгvйлэн номхон суугаад байвал улс vндэс сөнөхөд

хүрэх нь дамжиггүй байжээ.

Монгол шарын шашныг зовлонг тонилгож жаргалыг эдлүүлэхийн тул залжээ. Гэтэл монгол, шашин нэвтэрснээс хойш өөдөлсөнгүй явсаар эцэст нь ийм байдалд хүрэхэд аврах хвч шашинд үгвй ажээ.

Эрэнчин ямар ч гэвштэй хэд хоног маргаж, түүнийг уг дуугарах чадалгүй болгож чадна. Гэтэл гамингийн ганц суманд хариу хийж чадахгүй байлаа. Зөвхөн Эрэнчин ч биш гандан хүрээний бүх лам нар нийлж ном уншаад гамингийн үйлдэж байгаа бузар булай зүйлийг зогсоох чадалгүй гэдгийг Эрэнчин мэдэж байлаа .

Шарын шашнаас болж монгол хүн бүхэн бурхан болох гэж зүтгээд улс орон, үндэс угсаагаа мартсанаас дэлхий дахины бусад улс түмнээс арчаагүй хоцроод гар нь загатнасан бүхэнд доромжлогдох болжээ гэж Эрэнчин боддог болжээ.

Гэвч Эрэнчинд энэ орныг аврах нь битгий хэл, аврах замыг зөвхөн зааж ч чадах эрдэм ухаан байсангүй. Эрэнчинг эрдэм ухаантай лам гэж олноор хэлэлцдэг. Гэтэл хийсэн юм гэвэл өдий төдий хүнийг өөр шигээ арчаагүй болгожээ. Энэ бүхнийг бодоход Эрэнчингийн сэтгэлийг ямар ч гэрэл гэгээгүй бухимдал эзлэв.

Уулаасаа хөл, чимээ багатай гандан салхинд хөдөлсөн бургаснаас айж зугтаад бутанд хурсан туулай шиг нам гүм болоод тэртээ зүүн зүгт сонсогдож байгаа бууны дуу ертөнцийн ганцхан хөг аялгуу болж байлаа.

--Багш аа гэртээ орё гэж Батын хэлэхэд Эрэнчин шавь руугаа ажиглан харснаа «өөр ч яах вэ дээ» гээд гэртээ оржээ.

Үдээс хойш бууны дуу тасрав. Бат гадаалах нэрээр гарч, гинжнээсээ тавигдсан нохой шиг алга болов. Явсаар хятадын их чөлөөнд хүрч очив. Эзэд нь дүрвэж эзгүй үлдсэн хятад пүүснээс хүрээнийхэн шуудайгаар юм зөөж гүйлдэн байв.

Бат үүнийг гайхан, түүнийг сонирхон алмайрч өмнөөс нь сайхан цагаан морьтой монгол хүн мориныхоо хар хурдаар давхиж ирлээ. Тавиад алд газар ирэхэд нь эцгээ гарцаагүй таньсан Бат «Аав аа. Миний аав аа» гэж хашгиртал Эрдэнэ морины амыг залж хойш эргүүлэн улам хурдлав.

-- Аав аа. Миний аав аа гэж байдаг тэнхээгээрээ хашгиран хойноос нь гүйв.

Саяхан нүдний нь өмнө дүвжлэгдсэн хүний хүүхдийн дуу дахин чихэнд нь хадсан Эрдэнэ мориныхоо дэлэнд хацраа наан бөхийж, зүүн хүрээний баруун талаар хойш давхин удалгүй далд оржээ.

Эцгийн нь бараа аль хэдий нь тасарсан боловч Бат гүйсээр андуу нарын их чөлөөний баруун зүүврт ирээд бахардан унав.

Зүүдэндээ учирч ярилцан өдөр бүр хүсэн мөрөөдөж явсан эцгээ хэдхэн алхмын тэртээ харсан боловч уулзаж чадаагүй Бат оройн нар жаргах вед багшийндаа ирлээ.

Батыг ор сураггүй алга болсонд сэтгэл нь зовсон Эрэнчин байж болохоор айл бүхнээр шавиа сураглан олж ядаад хэдэн шавь нартайгаа хамт гудамжинд зогсож байв.

Батыг хараад үлэмж баярлан угтаж очоод:

-- Иш гэвш минь гэрээ мартсан гэсэр гэгчээр энэ үймээний цагт хаагуур морилж яваад ирэв дээ гэхэд нь:

--Аав. Миний аав... гэхээс өөр хариу хэлж чадсангүй. Хэсэг байж тайвширсны дараа Эрэнчинд бүх болсон явдлаа ярьсанд:

-- Амьд явбал алтан аяганаас ус ууна гэдэг юм. Аавтайгаа заавал уулзана гэж Батыг тайтгаруулав. Тэр орой нэг шавь нь ирж Эрэнчинд хүрээний сүүлчийн сонинг ярьжээ.

-- Багш аа Барон жанжныг богд, тавдугаар Богдын хувилгаан гэсэн гэнэ. Мөн хол хувилж шvv гэхэд нь Эрэнчин их л хөгжилтэй инээж:

--Хар архины шилэн дотроос харсан юм болов уу. Халх нэг богдоос мундахгвй балаг хүртсэн юмсан. Хоёр болсон бол хэцүүджээ гэлээ.

-- Бароны цэрэг хүрээний эзэн болж өдий төдий гэмгвй номхон хvнийг дvvжлэн, айл гэрийг дээрэмдэн байлаа.

Нэг орой Эрэнчингийн д, нөгөө твдэд ном сураад ирсэн гэвш ирж тэр хоёр удтал ярив,

-- Ер нь бодоод л байхад бурхны сургаал гэдэг чинь хоосон зvйл байна гэж Эрэнчинг хэлэхэд нөгөө хvн гайхан харснаа:

-- Багш минь та дэмийрч байна уу?

--Огт vгвй, харин ухаан орж байна.

--Ландором яг ингэж асуугаад эхэлсэн юм шvv. Чи эртхэн хүрээнээс зайлбал дээр байх гээд нөгөө хvн босож тvргэн гарлаа.

Эрэнчин хамаг сайхан насаа бурхны ном vзэхэд зориулжээ. Тvvний уншсан номыг тэргэнд ачвал олон даачаа болно. Гэтэл сvvлийн вед vзсэн мэдсэн бvхэн нь хоосон юм шиг санагдаж эхлэв. Хvсэл эрмэлзлийг тэвчиж нярваан дvрийг олох хэрэгтэй гэж бурхны ном сургадаг байлаа. Гэтэл хvсэл эрмэлзлийг бvх нийтээр тэвчвэл хорвоогийн амьтад сөнөхөд хүрнэ.

Тэгвэл бурхан, тvvний сургаал амьдралын эсрэг, амьд явахын эсрэг ажээ.

Эх болсон зургаан зvйлийн хамаг амьтны тусын тулд гэдэг бурхны сургаал тэдэнд амьдрал жаргалыг биш, харин нийтийн vхэл, мөхлийг ерөөдөг ажээ.

Сvсэгтэнг номхон дорой байлгахын тулд олон зvйлийн сvрдvvлэх аргыг богд зонхов зохиосныг Эрэнчин сайн мэдэж байлаа. Гэтэл бурхны шавь нар өөрсдөө хvсэл эрмэлзлээс салж байсан удаагвй. Эцэстээ монгол оронд буу зэвсэг барин тvмэн хvний амийг сvйтгэхээр ирсэн бароныг тавдугаар богдын хувилгаан гэж олон тvмнийг хуурч эхлэв. Энэ бvхэн бодогдоод ирэхэд «чи хvн амьтныг жаргуулахын тул юу хийсэн бэ?» гэдэг асуудал Эрэнчингээс салахаа болив. Гэтэл хий цэц булаалдахаас өөр юу ч хийгээгвй бөгөөд Эрэнчингийн цэц булаалдан ном хаялцсанаас болж өлсөж зовсон нэг ч амьтан цадаж жаргасангвй. Эрэнчин богд зонховын сургаалд эргэлзэж эхлэх ведээ бvр ч шургуу ном уншиж эхэлсэн. Гэвч унших тутам эргэлзэх нь их болж билээ.

-- Гэвш ээ! Чи бурханд итгэдэг vв? гэж нэг орой Эрэнчин Батаас асуув.

Бат багш нь чухам яагаад ийм юм асууж байгаагийн учрыг олж ядан гайхаж тvvнийг ширтэв. Эрэнчин цагаан сэтгэлийн туяа бадарсан зөөлөн нvдээр шавиа харж байснаа гашуудалтайгаар санаа алдаад «Гэвш минь ертөнц дээр итгэлээ алдах шиг хэцүү юм байхгвй бололтой» гээд хэсэг дуугвй бодол болон байснаа «Чамтай ч юу гэж ярих вэ дээ» гэж хажуулдан хэвтлээ.

Ингэж байтал багш нь ном vзэхээ бvр болиод, vг дуу нь цөөхөн болсноор барахгвй уцаар ууртай болов.

Нэгэн удаа Батыг дагуулан гадаалж явахад нь нэг авгай ирээд хайрцаг шvдэнз барьж ерөөл авах гэхэд «би ерөөл гэдэг юв юм бэ гэдгийг мэдэхгвй» гэж уцаарлан хэлжээ.

## XV

Твд газрын нандин хvжний анхилуун vнэр нэвтэрсэн том тасалгааны дунд тавьсан ногоон сандал дээр муу хийцтэй улаан шавар бурхан шиг Богд гэгээн морилон суув.

Ширээнд нь хийсэн баян хуур оросын хөгжмийн их зохиолч Чайковскийн дөрөвдvгээр симфонийн хэсгийг эгшиглэвч тvvнийг сонсож байгаа шинж байсангвй. Энэ ширээг баатар цагаан хаан бэлэглэжээ.

Богдын сохорсон хоёр нүд цагааран гөлөрч хааяа, хааяа шазуур нь татвалзана. Гаднаас нэг лам орж ирээд алгаа хавсран сөхөрч:

-- Нарангэрэлт түмэн наст богд Жавзандамба танд айлтгахын учир, гэгээний аврал тавдугаар богдын хувилгааны чадлаар хүрээнээс хөөгдсөн гамин хойт зүг зугтан явахдаа мал хөрөнгө дээрэмдэж, хүн амьтан сүйтгэж байгаа мэдээг авлаа гэж уянгалуулан өгүүлэхэд богд эвшээснээ:

-- За мэдлээ. Чи энэ чихэнд чийр болсон юмаа зогсоогооч гэх зуур том алтан бөгжтэй долоовор хуруугаар сандлаа заав.

Лам бөхөлзөн очиж ширээний баян хуурыг зогсоогоод дахин алгаа хавсран сөхөрч:

-- Нарангэрэлт түмэн наст Богд Жавзандамба танд айлтгахын учир, их төрийн сайд ноён ирээд таныг хүлээж байна гэлээ.

--Би завгүй. Харин чи Данигай сойвонг оруул гэж амандаа бүвтнэв.

Удсан ч үгүй нөгөө шадар сойвон орж ирээд өмнө нь сөхрөв.

-- Данигай юу?

-- За, эзэнтэн минь би байна.

--Чи анги Эрэнчинг мэдэх үү?

--За мэднэ. Эзэнтэн минь

-- Өчүүхэн тэр хорхой өдөр шөнийн хорин дөрвөн цагт намайг муу хэлж байдгийг чи мэдэх үү?

-- За мэдэхээр барах уу даа. Би танд хэдэн удаа айлтгасан билээ.

-- Аа тийм билүү. Түүний насны тоо гүйцсэн.

-- За мэдлээ гээд Данигай гарч одлоо.

Өнгөрсөн өвлийн эхээр Жамбал Цамба хоёр хүрээ орж ирээд Бароны анхны дайралтаас чангарсан гаминд хоригдож, гандан дээр Далайчойнхор вангийн нэг ламын сууж байлаа.

Ингэж байхдаа мөрийтэй хорол тавьж алдаад нилээд өртэй болжээ. Барон орж ирсний дараа түүнээс айж хүрээний айлуудаар нуугдсан энгийн худалдааны хятадуудыг Баронд барьж өгнө гэж сүрдүүлэн хахууль авч овоо юм олсон боловч өрөө дарж бас л чадсангүй.

Нэг орой зүүн хүрээнд айлд байж байтал Данигай сойвон орж ирээд түүнтэй танилцаж маргааш нь тэдний гэрт зочлов.

Сойвон тэр хоёрыг архи, айраг, тарган махаар дайлж удтал ярилцав.

-- Та хоёр богд Жавзандамбын их хишиг хүртэх хүсэл байна уу? гэж Данигай асуув. Данигай, энэ хоёроор анги Эрэнчинг тонилгуулах бодолтой байснаас ингэж сайхан зан гаргажээ.

--Яаж хүртэх гэж? гэж Цамба асуув.

Данигай хэсэг дуугүй суув. Цамба сойвонгийн амыг ширтэж байлаа. Харин Жамбал хултай айргийг авч шимлээ.

-- Гандангийн анги Эрэнчинг таних уу?

--Танина гэж Цамба хэлээд Жамбал руу харлаа.

-- Тэгвэл богдын тааллаар түүний насны тоо гүйцсэн гэж Данигай хэлэхэд Жамбал гөлийсөн хүйтэн нүдээр ажиглан байснаа:

-- Тэгээд бид хоёр анги Эрэнчинг алах хэрэг үү гэж шууд асуув.

-- Тийм.

-- Бид хоёр лам улс. Хойтохоо бодно гэж Жамбал хэлжээ.

Данигай Жамбалыг ширвэн харлаа. Тэгээд гурван мөнгөн аяганд архи хийж, нэгийг өөрөө аваад удаан шимж уув.

--Тус бүрд чинь зуун алтан маниад өгнө. Цамбын нүд том болж нүүрэнд нь баярын



туяа алгуур тодорч «хэрэв Нарангэрэлт...» гээд үгээ эхлэх гэтэл Жамбал нүдээрээ дохио өгч зогсоов.

--Бид сүнстэй улс. Тийм том нүгэл хийж чадахгүй гэж Жамбал хэлэхэд Данигай онигор нүдээ зальтай, цавлан инээмсэглэж

-- Гурван зуун алтан маниад өгье гэж хэлэв.

Жамбал ширтэж байгаа Цамбын нүдэн «за одоо боллоо» гэсэн тэмдэг тодорхой байв.

Гэвч Жамбал нэгэн удаа ширвэж харснаа дуугүй хэсэг суув.

--Бидэн шиг усан нүдтэй, цусан зүрхтэй улсад дааж боломгүй нүгэл байна гээд Жамбал аягатай архийг авлаа.

-- Дөрвөн зуу болгоё.

Жамбал нүүрээ алгаараа арчиж бодолхийлэн хэсэг сууснаа:

-- Дээдсийн таалал тийм бол бид дагая гэж хэлээд Данигайг ширтэв.

Энэ ярианы дараах орой Эрэнчин Батыг дагуулан гадаалахаар гандангийн захад гарлаа.

Хотын олон нохдын хуцах тасралтгүй дуу янгинаж, тэнгэрт вй түмэн од мяралзан баруун хойноос тасалдсан хүйтэн салхи үлээж байлаа. Хэдхэн алхмын цаана байгаа юм харагдахгүй ажээ.

-- Гэвш ээ, мөн харанхуй шөнө өө. Ийм шөнө чи хонь манаж үзсэн үү? гэж Эрэнчинг асуухад дэргэд нь явсан Бат:

-- Хавар үзээгүй. Зун бол үзсэн гэв.

--Би иймэрхүү шөнө адуу ч манаж үзсэн гэж хэлээд Эрэнчин тэнгэр рүү харснаа:

-- Балдан бид хоёр багадаа яг л иймэрхүү шөнө хонь манаж байгаад хот руу гэтэж байсан нэг чоныг гишгэчих шахаж билээ гээд инээмсэглэв.

Эрэнчин сүүлийн вед багын өнгөрүүлсэн амьдралаа ярих дуртай болжээ. Ингэж ярихад Эрэнчинд хоёр сэтгэл төрдөг байв. Нэгдүгээрт багын тэр амьдрал нь түүний хамгийн сайхан үе санагдаж баяр жаргалын сэтгэл төрнө. Хоёрдугаарт тийм сайхан амьдралаа эцэст итгэл утга чанараа алдсан энэ амьдралаар сольсноо бодох тутам гомдоод барагдашгүй гунигтай сэтгэл төрнө. Энэ удаа ч яг энэ хоёр сэтгэгдэл зэрэгцэн байлаа.

-- Гэвш ээ чи хүнд хэрэгтэй юм хийсэн үү? гэж Эрэнчинг асуусанд Бат учрыг нь олж хариу өгч чадсангүй.

-- Хомны шатыг удаан эдэлдэг юм уу?

Эрэнчин урьд залуудаа тэмээний хомны шат хэд хэдийг хийсэн билээ. Тэгээд одоо бодоход, хүнд хэрэг болох юм түүнээс өөр юу ч хийгээгүй мэт санагдав. Гэтэл тэр нь одоо байдаг эсэхийг өөрөө мэдэхгүй байжээ.

--Уддаггүй юм аа багш минь. Эвдрэх дээр нь чавганц нар бяц цохиод түлчихдэг юм гэж Бат сүрхий мэдэмхий хариулав.

Эрэнчин гомдолтойгоор санаа алдав. Хомны шат удаан байдаг юм гэж хариулсан бол Эрэнчин хязгааргүй баярлах байж билээ. Гэвч Бат түүнийг яаж мэдэх билээ дээ.

Тэр хоёр цааш хэд алхтал хажуугийн хүрднээс хоёр хүн гарч шууд Эрэнчингийн дэргэд очмогц бүдүүн бороохойгоор зэрэг цохиж унагав.

Дахин цохих гэтэл гудамжны үзүүрт хэдэн хүний ярилцах дуу гарч нөгөө хоёр хүн харанхуйд шингэж алга болов.

Юу болсныг өнгөрсөн хойно нь мэдсэн Бат багшийгаа тэврэн авч «Багш аа! Багш аа!» гэж хашгирав.

Батын чарлаж хашгирсан дуугаар хүмүүс гүйн ирэв. Эд бол номын нийлэг хийгээд тарж явсан Эрэнчингийн шавь нар байжээ.

Зарим нь багшийгаа авч гэр рvv нь явцгаав. Зарим нь цохисон хvнийг олох гэж ийш тийш гvйлдсэн боловч харанхуй шөнө зугтан алга болсон тэднийг яаж олох билээ.

Өглөө нь гандангаар анги Эрэнчинг гадаалж явахад нь хоёр дээрэмчин цохижээ гэдэг яриа бvр дэлгэрсэн байв.

Yд өнгөрөхийн вeд Эрэнчин нvдээ алгуурхан нээж дэргэд нь байсан шавь нараа ажиглан харж:

-- Намайг битгий зэмлээрэй. Би өөрөө төөрч явсан хvн шvv гэжээ.

Орой бусад шавь нараа явуулаад ганц Батыг дэргэдээ vлдээжээ.

- Намайг хэн цохисон бэ?

-- Дээрэмчин цохисон.

-- Юугий минь авсан бэ?

-- Юу ч аваагvй

-- Юу ч аваагvй болохоор дээрэмчид биш бололтой. Богд цохиогvй байгаа?

-- Хаанаас даа. Багш минь Богд гэгээн юу гэж таныг цохих вэ?

-- Юу ч л гэсэн дээрэмчин биш. Чин ван Ханддорж, Чин сvжигт чин ван да лам

Цэрэнчимидийг хэн алсныг чи мэдэхгvй биз дээ. Богдын гар нь урт юм шvv дээ. Дvv минь энэ харанхуй нvхнээс зайлж vз гээд дуугvй болов.

Гэрийн дотор нам гvм бөгөөд том тосон дэнгийн гэрэл их бага болон асаж Эрэнчин удаан бөгөөд тасалдан амьсгалж байв.

-- Гэвш ээ чи ухаантай хvн. Өөрийн замыг бодох хэрэгтэй байна. Над шиг өнгөрvүлсэн амьдралаа эргэж харж vр ашиггvй гаслах, vзсэн бvх юмандаа итгэл алдах гунигт битгий хvрээрэй. Миний амьдрал дууссан газраас амьдралаа эхлэх хэрэгтэй. Эхлээд явахад өргөн дэлгэр зам шиг санагдаж байсан. Гэтэл одоо миний өмнө жим ч vгvй болов. Хvv минь чи эхлээд нарийн боловч явах тутам өргөн болдог замыг олж ав. Тэр бол энгийн хар амьдралын зам бололтой...гээд баахан дуугvй болсноо чи нөгөө хадгаа аваад өгөөч гэв.

-- Соном хадаг уу?

Эрэнчин нvдээрээ «тийм, нөгөө хадаг» гэж дохио өгсөнд Бат шvvгээнээс нандигнан боосон Жавзангийн хадгийг авч өглөө. Эрэнчин хадгийг чанга атгаж нvдээ анихад нvдний нь булангаар тунгалаг нулимс бултайв.

Төгсгөлд нь хоосон өнгөрvүлснээ мэдсэн амьдралд нь энэ хадгаас vнэтэй, vнэнч юмгvй байв. Гэвч хойтохоо даатгаж өгсөн энэ хадгийн хариуд өгөх юм өөрт нь байсангvй. Хvссэн гуйсан номыг нь уншина гэхэд өөрөө, тvvнд нэгэнт итгэлгvй болжээ.

-- Энэ хадгаар нvүрийг минь бvтээгээрэй...гээд Эрэнчин аньсан нvдээ нээхэд хоёр хацар руу нь нулимс урсав. Хэсэг дуугvй байснаа юм хэлэх бололтой уруулаа хөдөлгөснөө хэд ангалзаад амьсгал нь тасрав.

Эрэнчинг шавь нар нь оршуулахад Бат хэд дахин ухаан алджээ. Далан давхрын энгэрт Эрэнчинг оршуулж байхад Богдын ордонд төрийн ерөнхий сайд Жалханз хутагт тэргvүтэйн сайд ноёд цуглараад барон жанжин, Богд хоёрыг хvлээж байв.

Богд өөдөлж, хэдэн хvнээр хувцаслуулаад хөтлvүлэн ширээнд сууж өглөөний зоогоо барьж байхад Данигай орж ирлээ.

-- Анги Эрэнчинг таны тааллаар болгосон. Харин энэ хэрэгт таван зуун алтан маниад зарцуулав.

-- Мэдлээ гээд Богд том гэгчийн мах амандаа хийгээд удаан гэгч нь намчуулав.

Гаднаас нэгэн лам орж ирээд алга хавсран мэхийж «тавдугаар богдын хувилгаан, их жанжин барон Унгерн морилон ирээд төр шашныг хослон баригч богд Жавзандамба таныг хvлээж

байна» гэхэд Богд босож Данигайгаар хөтлүүлэн цугларсан ноёд хутагт руу явжээ. Богдыг тасалгаанд ороход нилээд богинодсон хүрэн торгон дээл дээр сэлэм, гар буу зүүсэн Барон жанжин угтан очиж

-- Төр шашинг хослон баригч нарангэрэлт түмэн наст богд Жавзандамба таны өлмий баг орших болтугай. Би бол цагийн заалт, бурхны авралаар виймээнээс болж зовлонд учирсан гурван хааныг ширээнд нь буцаан мандуулах хувийг олжээ. Нарангэрэлт түмэн наст богд Жавзандамба таныг ширээнд чинь залав. Одоо улааныг бут цохиж баатар цагаан хааныг ширээнд нь зална. Түүний дараа Манж их гүрний эзэн хаан их Хуандийг ширээнд залах билээ гэж эхлээд энэ гурван зүйлээ гүйцэтгэхийн тулд юуны өмнө улааны халдварыг үүрэнд нь устгах хэрэгтэй. Энэ эрхэм вийлийг түргэн зуур бүтээхэд төр шашныг хослон баригч, нарангэрэлт түмэн наст богд Жавзандамба та туслах ёстой. Надад цэрэг хэрэгтэй. Хичнээн олон бол төдий чинээн сайн. Халх дөрвөн аймаг, шавь таваас зэвсэг барьж чадах бүхнийг морьдын хамт дайчлах лүндэн та буулгаж ажаамуу. Богдын энэ лүндэнг ноёд хутагт та бүхэн дагаж биелүүлнэ гэдэгт би гүнээ итгэнэм. Бидний хооронд буй болсон холбоог эрхэм та бүхэн хүндэтгэн үзэх буй заа гээд шууд эргэж гарлаа.

Ноёд хутагт нар Богд руу харахад байшингийн булан руу чиглэсэн түүний цагаан нүд, үзүүр нь товчлон улайж байгаа хамар нь ямар ч хөдөлгөөнгүй гөлийж байлаа.

Барон, Богдын ордонгоос гарч мориндоо мордон давхисаар саяхан Сийлэн Пуугийн яам байсан байшинд ирж буув. Түүнийг угтаж хурандаа Сапойлло уузлав.

-- Шоронд байсан улсыг гаргасан уу?

-- Гаргасан.

-- Магсаржавыг надтай уулзуул.

-- За мэдлээ гээд Сапойлло эргэхэд Барон зогсоож «барьж ирж болохгүй, урьж ирэх хэрэгтэй. Ойлгов уу?» гэлээ.

-- Мэдлээ. Урьж ирэх хэрэгтэй гээд Сапойлло явжээ. Магсаржав гаминд баригдаж гянданд хоёр сар гаруй суужээ. Эхлээд гамингууд барьж авсан хүмүүсээ ширүүлэн эрүүдэв. Хатанбаатарыг хорин удаа банздажээ. Гэтэл баригдсан монголчууд зодуулах тутам догшрон хорсож зангах нь үлэмж болов.

Ялангуяа хэдэн өдөр хүндээр эрүүдүүлсэн манлай ван Дамдинсүрэн, Жигжид гүн нар шархны халуунаар үхэхдээ «энэ муу сайн дээрэмчдэд хэвтэж үхэхгүй» гээд гяндангийн хана түвшин босоогоор үхсэнээс хойш монголчуудыг зодох бүр хараал зүхэл нь арвин болов. Энэ учраас гамингууд ширүүн зодохоо больж элдэв нарийн бүр нялуун арга хэрэглэх болов. Нэгэн удаа Го Си лин өөрөө Магсаржавтай уулзжээ. Магсаржавыг тасалгаанд ороход Го-Си-лин хар тамхинд шарласан шүдээ ярзайлган инээж босоод «Дундад монголын олон түмэнд алдар нэрээ мандуулсан их хүн тантай уулзах завшаан олдсонд өчүүхэн би үлэмж баярлана» гээд намалзан хоёр гараар дээш суухыг урив.

-- Одоохондоо би таны гинжинд байгаа болохоор надтай уулзах нь юун завшаан байх билээ. Эрхэм та андуурч байгаа бололтой гээд Магсаржав хүйтэн инээмсэглэв.

-- Төрийн их явдлыг үүсгэж байгаа вед хүндэт нөхрийг хүртэл чилээх аргагүй цаг байдгийг та юун андах билээ гээд Го Си-лин зузаан шилний цаадах улаан зовхитой нүдээ анивчин, нүүрнийхээ бүх арьсыг үрчийлгэн инээв.

-- Их явдал, бузар хэрэг хоёр зай олон өртөө гэдгийг генерал та юу эс андах билээ.

- Та дээшээ морил гээд генерал Хатанбаатарыг харахад нүдэнд нь хорсол, нүүрэнд нь инээмсэглэл тодров.

Магсаржав намбатай алхаж урьсан байранд нь суув. Намайг эдэнд урван бууж өгөхгүйг

мэдсээр атал ингэж ёсорхдогийн учир юу билээ. Аль хор өгөх гэж байна уу? гэх зэрэг элдвийг бодож байлаа. Гэтэл генерал дийлэгдэж доройтсон орны энэ хвнтэй зөөлөн аргаар яривал бас ч учир буй. Үхэхийн өмнө амьдралыг хайрлах нь хвн бvхний зан гэж бодож байлаа.

Генерал хонх дуугаргахад гамин ирээд хvрээнд байгуулагдсан янхны газраас шилж авчирсан vзэсгэлэнтэй хоёр хятад хvvxэн элдвийн зууш, дарс авчирч ширээ нь дээр тавив.

Го Си-лим уруулаа татгануулан зальтай инээмсэглэснээ: «Энэ хоолыг Бээжингээс ирсэн тогооч танд зориулан хийсэн юм. Зооглож vзээд таалбал танд ийм тогооч олж өгч өчvvxэн би лавтай чадна» гээд урт цагаан ясан савхаар дийзтэй хоолноос авч vмхэв.

-- Бидний хvсэл, зай суртахуун өөр болохоор танд таалагдсан хоолыг амтархан идэж чадахгvй байх гэж айж байна гээд Магсаржав ёжтой инээмсэглэв.

Го Си-лин нvдээр дохиход хоёр хvvxэн нvд, хошуугаар тоглон Магсаржавын хоёр талд сууж архи аягалан бариад, хацраа мөрөнд нь шалиглан наав.

-- Эднийг гаргахгvй бол би тантай нэг ч vг солихгvй гэж Магсаржав ууртай хэлэв.

-- Уул нь бидэн шиг цэргийн хвн гуа охидоос зугтаах хэрэггvй юм. Гэвч танд тааламжгvй байгаа бол...гээд хөмсгөө зангидан ширvэхэд хоёр хvvxэн эгшин зуур гарлаа.

Магсаржав хоолноос тайван идэж гурван хундага архи уужээ. Го Си-лин хоол идэж архи уух зуур хулгай нvдээр байн байн ажиглав.

-- Та бид цэрэг эрс болохоор шууд ярих сайхан гэж би бодож байна. Монгол хятад хоёр хэзээнээс төр улсаа хамтран байгуулж, ээлжлэн барьж ирсэн билээ. Гэтэл сvвлийн вед зарим нэгэн ухвар мөчид хvмvvc гадаад орны дэмий балай vгэнд орж нэгэн гэр бvлийг тасалж, тvмнийг вймvвлэн зовлонд учруулахад хvрлээ. Зvй ёсыг тогтоон, нэгэн гэр бvлийн сайхан ёсыг сахих их вйл хэрэгт эрхэм их жанжин нэгэн морины хvч тусалбал манай улсын засгийн газар таны гавьяаг яаж мартаж буй заа. Харин дэмий эсэргvвцэж хвчинд дарагдвал хойч өдөр гэмшиж барахгvй хэрэг болно гэдгийг та юу андах билээ гээд Го Си-лин Хатанбаатар өөд харлаа.

~— Та баахан сархад зооглосноос болж тvvx судраа мартаж байгаа бололтой. Бид төр хамтран байгуулж байсан удаагvй.

Харин нэгэн нь хвчирхийлж, нөгөө нь зарагдаж байсан. Сvвлдээ хоёул Манжийн эрхэнд орж дарлагдан байсаар эцэст хоёул тусгаар улс болсон. Гэтэл та нар цэргийн хvчээр тvрж биднийг эзэлсэн билээ. Гэвч эзлэгдэх, дарагдах хоёр шал өөр зvйл болохоор бид эзлэгдсэн боловч дарагдаагvй байгааг эрхэм жанжин ойлговол зvгээр юм даа гээд Магсаржав савхаа өмнөх ширээн дээр тас хийтэл тавив.

-- Та манай улс, танай энэ өчvvxэн орноос хэдэн давхар илvv хvчтэй гэдгийг ойлгодог биз? хэмээн Го Си-лин хэлэхэд нvвр нь уласхийж, шазуур нь татвалзав.

-- Гэвч өндгөө хамгаалсан шувуу, чонын нvдийг сохолж дийлсэн vлгэр байдаг юм шvv гэж Магсаржав тайван бөгөөд хэгжvvn хэлэв.

Го Си-лины маяглал дуусаж нvвр нь минчийж vрчлээтэн шал дэвсэлж «vхэр монгол», «тэнэг монгол» «Танай цагаан сарыг би улаан сар болгоод та нар өндгөө яаж хамгаалахыг vзнэ» гэх зэргээр хашгиран догширч хоёр цэрэг дуудаж Магсаржавыг гаргажээ. Тэр өдөр Магсаржавыг дөч банздаад, гянданд хийжээ.

Гэтэл хvрээ рvv барон довтолж, гамин хөөгдөөд Магсаржав суллагдан гэртээ хариад байж байтал Бароны явуулсан хурандаа Сапойлло ирж «Чингис хааны төрийг дахин байгуулахаар бурхнаас заяагдсан тавдугаар богдын хувилгаан их жанжин барон Унгерн халх Монголын Дайчин баатар таныг морилон ирнэ vv? гэж урив» гэхэд нь Хатанбаатар татгалзалгvй явжээ.

Барон Унгерн монголд сайныг хийхгүй гэдгийг Магсаржав мэдэж байсан. Гэвч монгол оронд хүнд бэрх энэ үед нийслэл хүрээнээс гаминг хөөсөн энэ хүн нэр олж авсан тул түүнтэй хөнгөн харьцаж болохгүй байлаа.

Хатанбаатар Магсаржав Зөвлөлт орос улсаас тусламж гуйхаар явсан Сүхбаатар нарын хэрэг үйлийн тухай сайн мэдэж байсан болохоор тэднийг цаг хожуулахын тулд бололцоотой бүх аргыг хэрэглэж Бароныг саатуулах нь одоо цагийн хамгийн зөв арга гэж боджээ.

Хатанбаатарыг барон их л хүндэтгэн хүлээж авлаа. Гурван хааныг ширээнд нь суулгаж, оросын улаан намыг устгах зорилгоо яриад «Энэ хэрэгт минь баатар та тусална гэж би гүнээ итгэж байна» гэлээ.

-- Ганзаганы сумтай та нар, газар нутаг дээрээ байгаа улаан намыг яаж дийлэх билээ гээд Хатанбаатар ширтэн харлаа.

-- Бидэнд хүчирхэг том гүрэн тусална гэж Барон хэлээд босож модон гаансандаа тамхи нэрж татах зуур Хатанбаатарыг ажиглав.

Хатанбаатар ажиггүй байшингийн доторхийг ажиглан харж байв. Барон хамар амаараа утаа зэрэгцүүлэн савсуулж хэсэг зогссоноо «Улааныг дарах зэвсгийг бид гадаад хүчирхэг гүрнээс худалдаж авна» гэлээ.

-- Юугаар? гээд Магсаржав амаа мурийлган ёжтой инээмсэглэв.

-- Барон шууд хариу өгсөнгүй. Тамхиа татсаар тасалгаан дундуур ийш тийш хөрөөдөн хэсэг явлаа.

-- Энэ тухай бид сүүлд ярья. Нэгэнт богд гэгээн бидэнд тусална гэсэн болохоор та бидэнд тусална байх гэж би бүрэн итгэж байна гээд шууд ирж сандал дээр суугаад Магсаржавын өмнөөс хөнхөр ногоон нүдээрээ цавчилгүй харав.

--Монголын тусгаар тогтнолын төлөө биеэ хайрлахгүй зүтгэх тангаргийг би өгсөн хүн.

Гэхдээ уул үзээгүй хормой шуух, ус үзээгүй гутал тайлах гэгчээр юу болохыг мэдээгүй байж таны үгэнд итгэхэд хэцүү. Бас тэгээд гамингийн гянданд суусан учир бие баахан доройтсон болохоор одоохондоо төрийн явдалд хүчлэн зүтгэх чадал мөхөс байна гэж Хатанбаатар хариулав.

-- Та улаан оросоос тусламж гуйхаар явсан Сүхбаатар, түүний нөхдийг таних уу? гэж Барон шууд асуув.

-- Танина гэж Хатанбаатар ажиггүй хариулав.

-- Улаан орос бол гуйлгачингууд, тэд та бид шиг тэнгэр язгууртанг дүүжлэн алах бодлоготой улс. Энэ учраас бид хүчин хавсарч дарахгүй бол дэлхий дахинд үлэмж аюул болно. Та үүнийг сайн ойлгож байгаа гэж би итгэж байна гэхэд Бароны нүд хурц нар туссан шар шувууны нүд шиг гөлөлзөж байлаа.

-- Би улаан оросын зорилгыг сайн мэднэ гэж Хатанбаатар хариулав. Ингээд Барон, Магсаржав хоёрын яриа дууссан бөгөөд хэдэн өдрийн дараа Бароны хэлснээр Богд Хатанбаатар Магсаржавыг Цэргийн яамны сайд болгожээ.

Гэтэл Магсаржав монголоос цэрэг татах Бароны ажилд элдвээр саад хийгээд байхад нь баруун хязгаарыг тогтноулах бүрэн эрхт сайдын тушаалд томилж нийслэл хүрээнээс зайлуулжээ.

## XVI

Хаврын өдөр хүн бүхэнд залхуутай бол том дашмагтай ус үүрээд арай ядан хөлөө солбиулж байгаа Хонгорт бүр ч залхуутай бөгөөд зүдэргээтэй ажээ.

Гэртээ ойртох бүр амрах нь олон болж, амрах бүр суух нь удаан болж байлаа. Ингэж явсаар хашаандаа орж ирвэл багш нь шазуураа зууж очоод дашмагийг нь авмагц «түргэн явж ирээд

цай чанаж өгөхгүй, харанга дуулж алах нь уу» гээд хар хүчээрээ алгадав. Дахин алгадах гэхэд нь зайлж орхисон чинь ламын уур улам бадарч бүдүүн модоор цохих гэхэд модон дээрээс нь бариад татаж орхитол шургачин унав. Босоод дахин дайрах гэхэд нь «Би илжиг биш, энэ хүнд дашмагаа өөрөө үүрээд үз» гээд Хонгор бүдүүн модоо барин хөдлөлгөй зогсов.

Лам Хонгорыг хүчээр дийлэхгүй болсноо ойлгож бачимдавч яах ч аргагүй болон:

-- Лам багшдаа гар хүрнэ гэнээ гээд дэмий л амьсгаадав.

-- Би илжиг биш гэж Хонгор давтан хэлээд зогсож байхад нүдэнд нь олон жил зодуулсны хорсол багтан ядаж байв. Лам дахин довтлох юм бол Хонгор дайралдсан газраа бүдүүн модоор цохиход бэлхэн бөгөөд шийдэмгий байлаа.

-- Заяагүй хог чи зайл! гэж уурандаа бахардсан лам хашгирав.

--Хөөлтгүй. Би явна гээд Хонгор тайван эргэж гартал хашааны хонх жин жан гэлээ.

Гудамжинд хаашаа явахаа бодон түр зогсов. «Гэртээ харья. Дахиад энд ирэхгүй» гэж шивэгнээд Булган уулын зүүн амыг чиглэн алхжээ.

Үд хэлбийж нар араас нь шуналтайяа шарж нүдэнд нь ve ve нулимс хуралдан дусална.

Хонгор явсаар даваа давж газрын уруу руу бүр шогшиж эхлэв. Ам уруудах вед нар жаргаж, оройн сэрүүн болон салхи үлээв.

Хэсэг явсны дараа бүрэнхий болсон боловч зогссонгүй явсаар л байлаа. Шөнийн сэрүүн салхи тэрлэгийг нь нэвт үлээж эрүү толгой нь өөрийн эрхгүй зодолдож эхлэв.

Гэтэл сар гарч, явахад нилээд амар болов. Нэгэн хот айлын хойгуур явж өнгөрөх гэтэл баахан ноход хуцалдан ирэхэд нь газар хий шүүрэн, ойртож ирснийг нь хөөж явтал эмээлтэй тавьж хоносон морьтой дайралдав.

Бүсээ чөдөртэй нь залгаж ногтлон мордоод цааш явахад ноход хэсэг дагаж хуцсанаа буцав.

Маргааш орой гэрийн бараа харагдахад баярлах, айх зэрэгцэн морио тавиад явгалан харилаа.

Должин уйлан тэвэрч аваад учир тоймгүй үнсэв. Гэртээ ороод аяга дүүрэн өрөм амаа олохгүй идэж байсан хүүгээ нүднийхээ булангаар хялайн харж байсан Итгэлт

-- Чи оргоод ирэв үү! гэж гэнэт асуув.

Хонгор бүлтэгнэн түгдэрснээ «тийм ээ» гэж аман дотроо бувтнан хэлэв.

-- Явган ирэв үү?

-- Тийм ээ гээд Хонгор доошоо харлаа.

--Тийм байх аа. Хар хошуун дээр морио тавьж байхыг чинь хараагүй гэж бодож байна уу гээд Итгэлт Хонгор руу жижигхэн нохойг яс хэмлэж байхад нь ойртон ирж байгаа бүдүүн нохойн нүдээр ширтэв.

--Явган ирсэн гэж Хонгор давтав.

Хонгорыг морио тавьж байхад нь гэрийн гадна зогсож байсан Итгэлт хараад «хар хошуун дээр морио тавиад нэг явган хүн манай руу чиглэн ирлээ. Морь нь эцсэн юм болов уу?» гэж байсан юмсанжээ.

-- Хоовон хөх нохой, хэний морийг унаж ирснээ хэлэхгүй юу гээд Итгэлт босож унинд хавчуулаатай байсан жижигхэн яргай ташуурыг авлаа.

Хэрэг биш болсныг ойлгосон Хонгор босож «Явган ирсэн» гэж ер бусын тайвнаар хэлэв.

-- Хөөрхийг цайгий нь уулгаач. Биднийг санаад л ирж байхгүй юу гэж Должин уйлав.

-- Дуугүй бай гэж гэр дүүрэн хашгираад Итгэлт яргай ташуураар Хонгорыг гурав дахин ташуурдав.

-- Аав аа. Ахыг битгий зод гээд Солонго дундуур нь орсонд Итгэлт түлхэж орхив. Хонгор

хөдөлсөн ч үгвй. Уйлсан ч үгвй.

-- Чи яс зааж байна уу. Хэний морь унаж ирээд, юунд тавьсан бэ? Хулгайлсан уу гэж хашгиран асуугаад дахин гурван удаа ташуурдав.

Хонгор хариу дуугарсангвй. Шүд нь хяхтнан нүдэнд нь нулимс цийлэгнэвч дусаалгвй шингээж гарлаа.

«Итгэлтийн хvv ч мөн дөө» гэж дотроо бахархан бодовч гаднаа сүр үзvvлэн хашгирч хоёр дахин цохив. Гэвч энэ удаа зөөлөн цохижээ. Хонгорыг хөдөлгөж ч чадсангвй. Ташуураа хаяа руу шидэж орон дээр сандайлан суув.

Хонгорын нүд гялалзан, жавьж нь татвалзана. Гэрийн дотор Должин, Солонго хоёрын уйлах дуу енгэнэнэ.

-- Биднийгээ гээд ирж байхад нь ингэж байдаг хvн бас байдаг аа гэж үгээ тасалдуулан хэлээд Должин Хонгорыг тэвэрч авлаа.

-- Одоо хvргэж өгнө дөө дамшгийг гэж Итгэлт хэлэв.

-- Очихгвй. Яасан ч очихгвй гэж Хонгор шийдэмгий хэлэв.

-- Хvлээд хvргэж өгнө дөө.

-- Дахиад оргохдоо эргэж ирэхгвй шvv.

-- Боль хvv минь, аавтайгаа ингэж болдоггвй юм гэж Должин хvvгээ хориглоно.

-- За сууж тэр аягатайгаа ид гээд Итгэлт гарч Галсанг дуудав.

Галсан гvйн ирэхэд нь «шалавхан мордоод, хар хошууны цаад руу ор. Бараан морь байгаа байх. Бариад ир» гэснээ.

-- Хонгор оо эмээлтэй юм уу. Үгвй юу? гэж асуув.

-- Би явган ирсэн гэж Хонгор тод хэлэв.

-- Уургатай мордоорой гэж Итгэлтийн хэлэхэд Галсан гэр түшvvлэн тавьсан урт уургыг аваад хар хошууны зvг давхив.

Удсан ч үгвй Галсан пойлс тоногтой, ширэн гөлөмтэй хуучин эмээл тохсон хар хээр морь бариад ирлээ.

Итгэлт хvvгээ зодож ч үзлээ. Аргадаж ч үзлээ. Гэвч «явган ирсэн» гэхээс өөр хариу сонссонгвй.

«Дахиад оргохдоо эргэж ирэхгвй шvv» гэсэн Хонгорын үгийг дэмий үг гэж бодоогвй Итгэлт хvvгээ буцааж хvргэсэнгвй. Харин Галсанг явуулж юмыг нь авчруулав.

Хонгорын унаж ирсэн морийг хvрээ рvv явж байсан замын хvнд худалдаад эмээлийг нь илvv гэрийн бараанд хийжээ.

Үүнээс хэдэн хоногийн дараа арван хэдэн морьтой хvн дагуулсан Хатанбаатар Магсаржав Итгэлтийн хотонд ирж улаа унав.

-- Бид Заяын хvрээ рvv явна. Сайн морьд эмээллэж, хоёр улаачаар нэхvvл гэж Хатанбаатар тушаав.

Итгэлт олонтой сонссон энэ хvний нэрийг сонсмогц сvнс нь зайлан адис авч морьд барьж эмээллэх зуур хонь гарган дайлав.

Магнай дээрээс нь цагаан солонго татаж, Мэлмийнээс нь гал улалзаж байна. Хөгшин минь охиноо авч очоод адис хvрт гэж мөргөөд гарсан Нямаа авгайдаа хэлээд залбирав.

Нямаа Хонгор хоёр улаа нэхэв. Хөх торгон дээл дээр гурван ve улбар шар торгоор эмжсэн хар торгон хантааз өмсөж нэг тал руугаа алтан бариултай урт сэлэм унжуулж, нөгөө тал руугаа модон хуйтай сэлээдий буу зvvсэн бvдvvн хар гээгтэй, зvлгэсэн хvрэн царайтай тэр сайхан эрээс Хонгорын нүд салж чадахгвй явлаа.

Харин Нямаа хvmvcsийн сvvлийг барин «Хатанбаатар вангийн улаа нэхсэн хойно, би гэдэг

хүн мөнхжиж дээ» гэж үглэн баярлан байн байн залбирч явлаа. Шөнийн турш давхисаар наран мандахын вед Заяын хүрээ орж шууд явсаар гэгээний хашаанд морьтойгоо давхин орлоо. Хонгор Хатанбаатараас салалгуй дагаж явсаар Заяын гэгээний өндөр шалтай гэрийн өмнө очив.

Хатанбаатар ван мориноос үсрэн бууж, цулбуурыг нь Хонгорт өгөөд хүрэн суман ташуураа барин гэр рүү орлоо.

Зая бандид гэгээн Павловын охинтой өргөн орон дээр тэврэлдэн хэвтэж байв. Хатанбаатар түр зогсоноо гэгээний шилэн дээрээс базан авч чармаа нүцгэнээр нь чирэн хаалгаар гарч ирлээ.

Хүвхэн чухам юу болж байгааг ойлгож ядан цагаригласан нүдээ нухлан гайхаж хоцорлоо.

-- Төр донсолж түмэн үймсэн хатуу вед та ингэж байхдаа ичихгүй байна уу? гээд баатар ван, гэгээнийг ташуурдаж гарлаа.

Нүцгэн гэгээний царай шатаж байгаа шар тосны гүзээ шиг үрчлэлдэн чухам юу хийснээ мэдэхгүй «Би больё. ЁО аллаа. Байя» гэж хашгирч байгааг хараад Хонгор тэсгэлгүй инээв. Хоёр өдрийн дотор зуун залуу эр, хоёр зуун сайн морьтой гаргаж өгөхгүй бол таныг төрийн цаазаар аваачна мэдэв үү, та! Би дахин ярихгүй шүү гээд баатар, чичирч байгаа гэгээнийг тавилаа.

-- Хоёр бурхан зодолдож байхад инээж болохгүй, алдас болно хүү минь гэж нэг хүн шивэгнэн хэлэхийг харвал дэргэд нь Нямаа гуай залбиран зогсож байв.

Гэвч Хонгор инээдээ барьж чадсангүй. Гэгээний уйлан хашгирсан дуунаар өндөр цагаан хурган малгайтай Павлов, хэдэн хүнтэй гүйлдэн ирсэн боловч Хатанбаатарын эсрэг юу ч хийж чадсангүй.

Үдийн хирд Хонгор, Нямаа хоёр морьдоо тууж буцах замдаа Хонгор байн байн инээхэд «Дамшиг минь алдас болно» гэж өвгөн хориглон наминчлна.

Бүр чармаан нүцгэн байсан шүү. Нямаа гуай та харсан биз дээ.

-- Харалмар чинь ямар гэм хийчихсэн юм болдоо... үгүй үгүй алдас болно. Хөөрхий гээд жуумалзсан хошуугаа алгаараа таглан.

Тэнгэрт бөөн бөөн үүл нүүн хуралдаж удахгүй нүсэр бороо орохыг зөгнөн бүлээн салхи өмнөөс нь үлээхэд Хонгор, Нямаа хоёр морьдоо гуядан шамлав.

Хонгор хурдан хээр морио унаад адууныхаа шилдэг морьдыг холбоод исгэрэн хөөж явахад эр хүний жаргалын оройд гарсан юм шиг бодогдоод дөрөөн дээрээ босон ташуураа мориныхоо дал руу хөндлөн тавив.

Маргааш хонины хишигтэй, нөгөөдөр хошуу сахиусанд мөргөж, цөгц, архи, атга балин олж иднэ гэж бодоод арааныхаа шүлсийг залгиж авсан Нямаа Хонгорын дүүлж яваа хөгжилтэй бодлыг яаж ойлгох билээ.

## XVII

Заяын хүрээнээс цэргээ дагуулаг гарч явсаар Хатанбаатар ван Магсаржав Улиастайд хүрч очлоо. Түүний цэрэгт, хиагт руу явах замдаа дайралдсан Хуяг, тавьтын дарга болоод явж байв.

Улиастайд Бароны тушаалаар урьд очсон Ванданов цагааны дарга нарын хамт монгол цэрэг дайчилж Зөвлөлт улс, Хиагтад буй болсон монголын ардын түр засгийг эсэргүүцэх бэлтгэл хийж байжээ.

Гэтэл татсан цэрэг нь оргож хүнс тэжээл агт морьд тасалдаж, ажил нь огт бүтэхгүй байлаа.

Бухимдаж уурласан Ванданов, Улиастайн сайд Чүлтэмийг дуудав.

Чүлтэм бол нэгэн жижиг хошууны засаг ноён бөгөөд автономитын вед монголын өмнө зүгээс



довтолсон харийн цэргийг цохих хэрэгт гавьяа байгуулан нэрд гарч Улиастайн сайд болсон хvн юм.

Энэ хvн гадаадын буу зэвсэгтэй хvмvvc монгол оронд ямар зорилготой ирдгийг нvдээр vзэж зvрхээр таньсан бөгөөд монгол бол тусгаар улс байх ёстой. Тvvний хэрэгт гадаадын хvн оролцох ёсгvй гэдэг vзэлтэй хvн байсан юмаа.

-- «Монгол улс тусгаар байвал ямар засагтай байсан ч надад хамаагvй!» гэж vргэлж хэлдэг хvн билээ.

Энэ ч учраас Вандановын дураараа загнаж байгааг хараад жигшин, тvvний ажилд аль болохоор саад хийж монголын ардын тvр засгийн газар элч явуулжээ.

-- Би очиж чадахгvй. Дуртай бол ирж уулз гэж Вандановын элчид хариулжээ.

Элчийг явсны дараа «төрөлх нутгаасаа хөөгдөж ирээд төрсөн нутагтаа байгаа хvнийг дуудна гэнэ» гэж ойрын хvмvvcтэй ууртай хэлж байлаа.

Чvлтэмийн хариуг сонсоод Ванданов хагартлаа уурлаж «Чамд би хэн гэдгээ vзvvлье» гэж хашгирав. Орос нь цагааны арав гаруй дарга явуулж Чvлтэмийг барьж зайдан морь унуулан авчрав.

-- Нохой чи, миний тушаал ёсоор яагаад ирдэггvй юм бэ? гэж Вандановын хашгиран асуухад Чvлтэм хvйтнээр инээмсэглэсэнээ:

-Хойноос ирээд хотонд, хоёр хоноод авдранд гэж чамд намайг дуудах эрх байхгvй. Би бол Богд эзний зарлигаар томилогдсон төрийн сайд гэлээ.

-- Богд эзэн гэж Ванданов ёжтой хэлээд хөмсөг нь зангирснаа дуудах нь битгий хэл, бариад ирснийг харахгvй юу гээд ихэмсэг инээв.

-- Чиний чадалтайнх биш. Олон тvмэндээ хөөгдөж орох оронгvй болсон тэнvvл дээрэмчдээр толгойгоо мэдvvлж байгаа бидний арчаагvйнх гэж Чvлтэмийн хэлэхэд шанааны нь судас гvрэлзэн бvх бие нь чичирч байна.

-- Чамайг би буудаж алав ший гээд Ванданов мөрөө ханхалзуулав.

-- Өөр чи юу ч хийж чадахгvй шvv дээ гэж хэлэхдээ Чvлтэм хvйтэн бөгөөд тавлангуй инээмсэглэв.

Ванданов, нааш цааш холхиж шал шагайж бодолхийлэн алхав. Энэ хvнийг хvчээр айлгаж чадахгvй гэдгийг ойлгов. Буудаж орхиход тун амархан байв. Гэтэл өөрт нь энэ хvн хэрэгтэй бөгөөд хэрэв монголчуудын дунд нэртэй энэ хvнийг алж орхивол тэртэй тэргvн унаж байгаа нэр хvнд нь бvр дампууран унана гэж ойлгож байлаа.

-- Та чинь амьд явахаас уйдсан хvн vv? Надад агт морьд, эр цэрэг, хvнс саадгvй нийлvvлж өгвөл таны амийг өршөөхөөр барахгvй Барон жанжинд айлтгаж хэргэм зэрэг нэмнэ гээд худал инээмсэглэв.

-- Та нар vхэхийг хvcээгvй байхад төрсөн нутаг, газар шороон дээрээ байгаа би хvcэхгvй. Гэвч өчvvхэн биений vхлээс айгаад та нартай нийлж ард тvмнээ дээрэмдэх хэрэгт орж нэр алдраа гутаахгvй.

-- Та буруу ярьж байна. Манай жанжныг богд гэгээн тавдугаар богдын хувилгаан гэсэн. Бид богдыг ширээнд нь суулгасан. Улсыг чинь тусгаар тогтноулж өгснийг та мартаагvй биз? Сайдын хvлгийг тайл гэхэд барьж ирэлцсэн цагааны нэг дарга Чvлтэмийн хvлгийг тайлж өгөв.

Чvлтэм хулгана харсан муурын нvдээр Вандановыг нэвт ширтэн толгойгоо дохиж байснаа цэвдгээр инээмсэглээд «хvvхэд хуурч байгаа биш дээ та нар. Та нар бол нэр нvvр байхгvй луйварчид дээрэмчид» гэж хашгирав.

-- Баатар цагаан хааны албат нарыг тэгж болохгvй.

-- Тэр тусмаа болно. Тэр хаан чинь ширээнээсээ ширдэг дээр бууж хөөгдсөн, орон гэр санах сарвайхгүй новшнууд минь! гээд Чүлтэм амьсгаадан ойртоход Ванданов нохойд бүслэгдсэн муур шиг гэдрэгээ ухарч байв.

— Үүнийг даруй бууд гэж Ванданов хашгирав.

Тэр орой Вандановын дээрэмчид Чүлтэм сайдыг буудаж алав.

Хэдэн өдрийн дараа Хатанбаатар Магсаржав цэргийн хамт Улиастайд хүрэлцэн иржээ. Ажил нь улам бүр бүтэмжгүй болж байгаа, бас тэгээд Чүлтэмийг алсандаа бантсан Ванданов цагааны даргуудаа дагуулан угтав.

-- Халх монголын их жанжин та энх амгалан морилж ирэв үү? гэж Ванданов ёслол. Хатанбаатар бүрэн зэвсэгтэй зогсож байгаа дарга нарыг тойруулан харснаа. «өнөө орой миний цэргийн тооллого дээр ноёд та бүхэн морилж очихыг урья» гэлээ. Ванданов дураараа загнаж ард олныг хэлмэгдүүлэн Чүлтэм сайдыг буудаж алсныг Хатанбаатар бүрэн мэдэж байсан. Тэгээд Улиастайд очмогц барьж авна гэж бодсон юм. Гэтэл тэд бүрэн зэвсэглэснийг хараад «Ингээд барихад эд эсэргүүцэж, хэдэн хүн алагдах болно. Энэ учраас оройн тооллого дээр очиход нь гэнэт дайран барьж авъя» гэж боджээ.

Оройн тооллого болж, юу хийхээ мэдсэн монгол цэргүүд Хатанбаатарын дохиог хүлээн бэлхэн зогсож байв. Цагааны дарга нар цувралдан ирэхэд Ванданов алга байлаа. Хатанбаатар Хуягийг дуудаж «Өмхий санаатай золиг чинь ирэхгүй нь бололтой. Хоёр хүн дагуулж яваад амьд барьж ир» гэж шивэгнэн хэлэв.

Цэргийн тооллого эхлэв. Цагааны дарга нар уранхай хувцастай, олдсон юмаар зэвсэглэсэн монгол цэргийг доромжилсон нүдээр харж «ийм байж ардын засаг байгуулах санаатай» гэж дотроо бодож байлаа. Гэхдээ өөрсдөө Англи, Америк, Японы шилдэг зэвсэг хэрэглэж яваад Сибирийн хутга, шөвөг барьсан партизануудад үхтэл цохиулж шавар шаазангийн хагархай шиг болсноо мартсан ажээ.

Магсаржав дохио өгмөгц монгол цэргүүд зэрэг хөдөлж цагааны дарга нарыг баривчлав. Энэ вед Ганцын даваа өөд өндөр бор морьтой Ванданов сэлээдийгээ бэлхэн барин эргэж харсаар давхиж явлаа. Түүнээс нилээд хойно Хуяг хоёр цэргийн хамт хурдлан давхина. Өдөр Магсаржавын хүйтэн харцнаас сайн юм болохгүй нь гэдгийг Ванданов ойлгосон. Гэвч дарга нарт хэлбэл байлдаан болоод монгол цэрэгт баригдах буюу алагдана гэж бодоод ганцаараа оргохоор шийджээ. Ингээд нөхдөө орхиж, тооны үеэр сэм оргосон боловч Хуягт мэдэгдэж хөөгдөв.

Өртөөчид буу тулгаж сүр бадруулсан Вандановт муу морь эмээллэж, Хуягт шилдэг морио өгч байснаар Шороотын өртөөн дээр гүйцэгдэж буудалцсан боловч зайлж чадалгүй баригдав.

Маргааш нь хандарга хүлэгтэй Ванданов Хатанбаатар Магсаржавын өмнө дагжин зогсож байв.

-- Чи Барон жанжны тушаалыг зөрчиж намайг барьж авсан ялаас өршөөгдөхгүй.

-- Бидэнд Бароны өршөөл хэрэг болохгүй. Харин чамайг Чүлтэмийн хариуд буудаж ална.

-- Чи үнэн ярьж байна уу?

-- Надад тоглох зав алга.

-Чи бид хоёр монгол хүн шүү дээ.

-- Монгол хүн гэж ярихын тул монголын төлөө цохилох зүрхтэй байх хэрэгтэй. Чамд тийм зүрх алга гээд Хатанбаатар шууд гарлаа.

Тэр орой Вандановыг аваачиж буудахад тэр нь уйлж, хашгирч, мөлхөн сөгдөж амь гуйсан бөгөөд яг буудах вед ухаан алджээ.

Хатанбаатарын цэрэг Улиастайгаас хөдөлж Дөрвөд Далай хааны өөд аялав. Тэнд бугшиж байсан цагаантан ард олонд багагвй балаг тарьж гэгээн цагаан өдөр аллага дээрэмдлэг хийж байжээ.

Ногоорсон ургамал, өнгийн цэцгээр чимэглэгдсэн хорвоо хөхөөн дуу юутай сайхан бэ? Мандах наранд түмэн зүйлийн өнгө бадарсан урт амыг уруудан Хуягийн захирсан Хатанбаатарын магнайн тавин цэрэг цувран явлаа.

Хуяг урт биетэй, өндөр цээжтэй сайхан бор морь унаад цэргийн өмнө явна. Хажуугийн уулнаас хорь шахам адуу хөөсөн хvн гарч ирээд цэргийг хармагц зогсов.

Хуяг дуран авч тэр зvг харснаа «Төмөр гуай» гээд vг сэггvй давхиснаа явдал дундаа «Төмөр гуай би Хуяг байна» гэж дахин дахин хашгирч явсаар ойртон очиж «Төмөр гуай» гээд всрэн буув.

Үнэхээр ч Төмөр байлаа. Тvvнд өөрчлөгдсөн юм гэвэл нvvр нь овон товон цоохор болоод сvрхий турснаас хамар нь өндөр болжээ.

Бадарчтай нийлж гаминг цохиод хэдэн өдрийн турш залуу гамингийн урт нvvр харагдаж сэтгэл нь зовж явсан билээ. Тэгээд Цэцэн Сартуулын хошуунд урьд хамт адуу хөөж явсан танилындаа очиж хэд хоноод буцаж эхнэр хvvхдээ авах бодолтой явжээ. Гэтэл бvх бие нь янгинан, заримдаа тогтон ядан чичирч ve ve нvд нь харанхуйлан манарч, уруул нь омголтон хатаж явахын аргагвй болжээ. Үнэнийг хэлэхэд Төмөр тулдаа л байлаа. Тvvнд цагаан бурхан тусчээ.

Ямар нэгэн даваан дээр гарч мориноос буугаад овоо өөд чулуу шидээд мордох гэснээ эмээлийн бvvргээ түшээд нvдээ анин хэсэг зогсов. Өвдөг нь чичрэн бие нь салганан амьсгаа нь давхцана. Хvчлэн мордоод цааш явахад байн байн газар тэнгэр хөрвөлдөх шиг болоход нь бvvргээсээ чанга тэврэн явж байлаа.

Тарвагачны майханд ухаантай, ухаангвй ороод унтсан чинь шөнө дэмийрч ухаан алджээ.

Тарвагачин эр эм хоёр хашир улс байсны ачаар ирсэн танихгвй хvнд ямар өвчин туссаныг мэдээд нэгэнт өөрсдөө болсон болохоор туслан өргөв.

Төмөр дэмийрэхдээ догшин биш бөгөөд гагцхvv Дулмаагийн нэрийг дурдаж «эр хvн дээ хөө» гэж давтан хэлдэг бөгөөд энэ vгээ хэлж байхдаа халуундаа барзайсан нvvр нь vлэмж баяраар дvvрдэг ажээ.

Сар гаруй хэвтээд ухаан орсон боловч эдгэрсэнгвй. Үгдэрч хvндэрсэн өвчин нь хэвтэрт яг хадаж хvний гарт орон хэдэн сар болжээ.

Сайхан сэтгэлт тарвагачин эр эм хоёр Төмөрийг орхиж ад vзэлгвй өргөжээ. Намрын сvvлээр тарваганаас бууж бор гэртээ харихдаа гэрийнхээ нэг талд зузаан бамбайгаар ор засаж өгөв.

Цагаан сараас хойш бие нь сайжирч, сайжрах тутам эхнэр хvvхдээ бодох нь их болж, арчаагвйдээ бухимдана.

Хавар нь очих гэж явсан нөхөртөө хэл хvргvvлж уулзсан бөгөөд нөхөр нь Төмөрийг авч явахдаа гэрийн эзэнд тавин лангийн ембvv хадгийн хамт барьжээ.

Нөхрийндөө очоод Төмөрийн бие улам сайжирч эхнэр хvvхэд хоёртойгоо уулзахаар явах тухай бодож эхлэв. Гэтэл нэг өдөр нөхөр нь Дөрвөд далай хааны руу адуу хөөхөөр явъя гэлээ. Төмөрийн өргөн магнай vрчилдэн нvд нь солбин бодолхийлснээ: «Тэр зvг бол явахгвй. Надад авах өшөө нэхэх авлага бий. Баатар бэйлийн баяны адууны аль олигтой бvхнийг хөөж, сэтэртэй хониор нь боодог хийж идээгвй цагт сэтгэл минь амрахгвй, цахиур Төмөр өөхөн цагаан чулуу биш гэдгийг мэдэж аваг» гэлээ.

Хоёр найз хос морь хэрэглэн хэдэн хоног довтлоод баатар бэйлийн нутагт орж нэгэн хадтай ууланд амрахаар бvгэв.

Төмөр адуу хөөхийнхөө өмнө цэдрийн бүрээ шиг хангинуулан хурхирч, унтан амардаг билээ. Гэтэл энэ удаа унтаж чадахгүй байн байн тамхи татаж тэртээ харагдах аманд байгаа айлуудыг ширтэнэ. Тэр айлуудын нэгэнд хайрт Дулмаа нь хvvтэйгээ хамт байгаа шvv дээ гэж бодоход өнөөдрийн нар аргамжаатай мэт бодогдоно.

Өнөө шөнө эхнэр хvvхдээ авна. Маргааш тэр ууланд амраад орой нь Баяны сэтэртэй хониор боодог хийж иднэ. Нөгөөдөр орой адуу хөөнө. Миний хvv аавдаа дvvрvvлээд тэр адууг хөөж эцэг хvv хоёрыг салгаж зовоовол ингэдэг юм гэдгийг Баянд хэлж өгнө гээд Төмөр босож хадан дээр зогсон аманд байгаа айлуудыг ширтэв.

Удахгүй болох уулзалтын их баяр сэтгэлийг нь хөөргөн эхнэр хvvхэд хоёр нь байн байн харагдах шиг болж, нvvрний нь ширхэг бvхнээс баяр гэрэлтэнэ.

--Тэр хоёр минь намайг өдөр шөнөгүй хvlээж байгаа. Гэхдээ өнөөдөр ирнэ гэж огт зvvдлээгүй шvv дээ. Хөөрхий минь гээд инээмсэглэв. Унтсан нөхөр нь хариу дуугарсангүй. Гэвч сэтгэл нь хөөрсөн Төмөр эхнэр хvvхэд хоёр нь өдийд юу хийж яаж байгаа тухай зохион ярьж байв.

Төмөрийн сэтгэл баяраар дvvрэн байлаа. Гэвч тvvний энэ баяр нь хоосон манан байж билээ. Учир нь өнгөрсөн өвөл Дулмаа хос морьтой алга болсон юм.

Харанхуй болж од жигдрэн тvгэхэд мордож шууд захын айлын ойр очиж нохойн дуугий нь чагнав.

-- Энд алга бололтой гэж Төмөр шивэгнэн хэлээд морины амыг эргvvлэв.

Хэдий харанхуй шөнө боловч Төмөр зорьсон айлдаа шууд орж чаддаг. Билчээрт байгаа мал, нохойн дуу, гэрээс гарсан хvний төрх намба, чингэлэг бараа, гэр зэрэг өдий төдий тэмдгээр олж чаддаг. Гэтэл энэ шөнө гэр нь олдсонгүй. Харин айл явдаг өвгөний гэрийг нохойн дуугаар нь таньж очоод гэрээ сурагласан чинь эхнэр нь өнгөрсөн өвөл баримжаалах зvггүй алга болсон байлаа.

Төмөрийн сэтгэл хоосон болох шиг болж, санаа алдан хэдэн удаа тамхи угсран татсанаа «хvvтэйгээ хамт явсан уу?» гэж нам дуугаар асуув.

Хашир өвгөн эмгэн хоёр Төмөрийн сэтгэлийг давхар зовлонд унагаахгүйг хичээн «тийм» гэж сулхан хариулав. Хэрэв Төмөр өвгөн эмгэний нvд рvv харсан бол бvх явдал илрэх байсан билээ.

Төмөр нөхрөө дагуулан явахдаа юу ч дуугарсангүй. Гашуудсан сэтгэлийг засах vг олдохгүй болохоор дэмий юм ярихын оронд дуугүй явбал дээр гэж боддог хvmvvc байдаг бөгөөд тэдний нэг бол Төмөрийн нөхөр байлаа.

- Хvv эхнэр хоёр минь хаа яваа бол доо гэж Төмөрийн асуухад нөхөр нь өөрөө явуулчихсан юм шиг хулчганан займарснаа «Хаа явдаг бол доо?» гэж асуултыг асуултаар хариулав.

-- Халх нутгийг нэгжиж байгаад олно доо. Баатар бэйлийн хошуу хэнтэй учраатай болсноо мэднэ гайгүй. Төмөрийн зvрхийг маажсан хvний хумс нь хугарна гэж шvдээ хавиран шивэгнэн хэлэхэд нөхөр нь дорой бөгөөд намуухан дуугаар «Тийм» гэж хэлэв.

Yvp цайхын вед нөгөө хадтай ууландаа очиж буув. Төмөр юу ч дуугаралгүй дээш харан хэвтэж, сэтгэл нь тvmэн зvйлийн бодолд дарагдан «Дулмаа, хvv хоёроо хаа байгаа бол?» гэсэн асуудалд хариу эрж байлаа, Орой нь мордож шууд явсаар Баяны гэрт очиж буув.

Хоёр бага хvvтэйгээ хоол идэж байсан Баян Төмөрийг хармагц гэмт хvн гэлбэлзэнэ, дайрт морь далбилзана гэгчээр «Төмөр минь сайн явж байна уу. За дээш суу. Хоол ид» гэж юу болохоос чичрэн айсан зvрхээ гаднах сайхан зангаар далдлахыг хичээв.

-- Чамайг харанхуй модон дотор хvlж хаяад хээрийн нохойн идэш болгоно доо. Хамт явъя. Явахгүй гэвэл хvчээр авч явна гэж Төмөр тайван бөгөөд хорсолтой дуугаар хэлэв.

-- Төмөр минь би эхнэр хvvхэдтэй хvн. Намайг өршөө. Намайг нигvvлсэн өршөө хэмээн гуйж Баяны нvднээс бөөн хар нулимс асгаран ам нь ярвалзан татганаж байв.

-- Надад ч байсан. Харин чи тэр бvхнийг минь юман чинээ бодоогvй. Өөртөө байхгvй нинжин сэтгэлийг бусдаас горьдсоны хэрэггvй, Өрийг нь цоолж байхад гэнэн нvдээ бvлтэлзvvлэн харж байдаг хонь биш. Бушуухан явъя.

Хөрөнгөтэй хvн юу ч хийж болно гэж бат итгэж явсан Баян сvvлчийнхээ аргыг хэрэглэв.

-- Агт морь, амбан шар, алд хадаг барья. Амь өршөө гэж магнай дээрээ хvйтэн хөлс бурзайлган зэвхий дуугаар алгаа хавсран хэлэв.

-- Олон таван vг хэрэггvй. Явъя гээд Төмөр Баянд ойртов. Би явахгvй гэж байдаг чадлаараа хашгираад vүд рvү гvйх гэтэл Төмөр хуучин торгон дээлийн нь дал дээрээс базаж авлаа. Баяны муухай дуугаар илvv гэрээс гуйн ирсэн хоёр зарц нь эзнээ хамгаалах гэсэн боловч хvрч чадсангvй. Төмөрийн нөхөрт цохиулан том гэрийн хатавчинд нам цохиулан унав. Төмөр Баяныг дарж аваад эвхэртэл нь хvlэв. Гэвч хоёр хvvхэд нь «аав аа! Миний ааваа. Аавыг минь болиоч» гэж яс янгинуулан чарлаж хvlээтэй эцгийнхээ дээрээс хэвтэв. Сэтгэл зvссэн хvvхдийн дуу, өшөө хорслоор дvврэн Төмөрийн зvрхийг зөөлрvvлэв. Төмөр яахаа мэдэхгvй тvр зогсов. Зогсолтгvй чарлан байгаа хvvхдийн дуу Төмөрийг бvрмөсөн ялав.

-- Амийг чинь хvvхдэд чинь vлдээе. Алдсан морьдоо битгий эрээрэй гээд гарлаа. Мордохдоо сэтэртэй шар халзан хонийг нь алж аваад явсан ба тэр шөнө гуч гаруй морьдыг нь хөөжээ.

Баян арав гаруй хvнээр нэхvvлээд гvйцэж чадаагvй учир Засагт ханы хошуунд заргалдсан боловч нэгэнт Төмөрийг барьж чадаагvй болохоор өнчин ишиг ч олж авсангvй. Ирэх намар нь баатар бэйлийн сvргээс тавь гаруй шилдэг адуу хөөжээ. Ингэж явахдаа эхнэр хvvхдээ тааралдсан бvхнээс сурагласан боловч олох нь байтугай мөр ч гаргаж чадсангvй.

Хавар нь баатар бэйлийн хошуу захирагчийн манааны хvнийг нь хvlж орхиод хорин нэгэн шилдэг морьдыг нь хөөгөөд сураггvй болжээ.

Баатар бэйлийн хошуу нэртэй лам нараа цуглуулж, Төмөрт хоёр дахин хараал хийж сор залан, жинсрэг цутгуулсан боловч тус болсонгvй. «Дайны хажуугаар дажин» гэгчээр нэг зальтай эр Төмөрийг чадвал барьж өгнө. Эс чадвал алж өгнө гэж хошуу сангаас нилээд юм аваад ор сураггvй алга болжээ.

Зэргэлдээ хошууддаа бичиг явуулж гайхал Төмөрийг барилцаж өгөхийг гуйсанд цаг төрийн самуунд нэрвэгдсэн хошууд ямар ч дэмжлэг өгсөнгvй.

Ингээд Төмөр баяны адуунаас хоёр дахь удаагаа хэсэг морь хөөгөөд явж байхдаа Хатанбаатар вангийн манлай цэрэг Хуягийн тавьттай тааралджээ.

Хуяг Төмөр хоёр дотно нөхдийн ёсоор уулзаж юуны өмнө золгож тамхилалцав. Тэгээд Хуяг цэргvvдээ буулгаж амруулах зуур Төмөртэй тавтай ярилцжээ. Төмөрийг өөрийн амьдралд тохиолдсон юмаа яриад дуусахад Хуяг тамхи татаж баахан дуугvй бодол болон сууснаа «Та чадалтай, сайхан санаатай хvн. Гэвч төр донсолж, тvмэн вймж байгаа хатуу цагт олны төлөө тэмцлээс аймхай туулай шиг зугтааж зөвхөн хар амиа бодож явах таарах уу даа» гэж шууд зэмлэв.

Төмөрийн нvд сэрвэсхийн Хуягийг ажиглан харлаа. Нөхдөдөө хэзээ нэгэн цагт зэмлэгдэж vзээгvй эмнэг сэтгэл нь хөндөгдсөн боловч уурласангvй.

-- Надад өөр зам байгаагvй. Би энгийн номхон амьдаръя гэж бодсон. Бvтээгvй гэж өөрийгөө

өмгөөлөв.

Хуяг марташгвй тус олон удаа хвргэсэн энэ эрийг хвндэтгэж байсан боловч сэтгэлдээ бодсон внэнийг хэлэхээс буцсангвй.

-- Энэ цагт энгийн номхон амьдарч болохгвй. Зовсон орон, доромжлогдсон олонд тус болох цаг ирээд байна гээд ноёд баядын дарлалд зовж ядарсан монгол орныг гадаадын дээрэмчид тал бүрээс нь хэмлэн мэргэж байгаа гашуун явдлыг яриад Хатанбаатараар удирдуулан яваа өөрсдийн тэмцэл, зорилгыг хэлэв.

Төмөр хэсэг дуугвй сууснаа:

-- Би ядарсан хвнд тус болж байсан гэж нам дуугаар хэлэв.

-- Одоо вед таны тэр тус бол хор. Та өнөөдрийн аяга хоолыг залгуулж өгөөд, маргаашийн нь жаргалын хвсэл эрмэлзлийг мохоож байна. Хар тамхи татахад нэгэн ве бvх зовлонг умартаж, хоосон жаргалын хий мананд умбадаг боловч внэндээ цогц бие нь ялзарч байдаг гэж Хуяг хэлэв.

Төмөр гашуун бөгөөд гомдолтой инээмсэглэв. Хуягийн вг хатуу боловч тvvнд внэн юм их байх шиг санагдав. Ялангуяа эрс шулуун хэлж байгаа Хуягийн сэтгэл ихэд таалагдав. Өглөөний нар хэнийг ч голж шилэлгвй бvхнийг ээн жигнэж хажуугийн ууланд өвөөлж бvвтнэн дуугарч байлаа.

Төмөр бодол болон сууснаа

-- Энэ морьдыг цэргvүддээ унаа болгож ав гэж гэнэт хэлэв.

-- Тvvгээр ч барахгвй та өөрөө цэрэгт ороод бидэнтэй яв гэж Хуяг хvvхэддээ хэлж байгаа эцгийн дуугаар хэлэв. Давааны наад руу Хатанбаатарын гол цэрэг цувран орж ирлээ. Намилзан яваа туг хиур нь салхинд тоглож, өглөөний нарны гэрэлд зэр зэвсэг нь гялалзан сvртэй бөгөөд жавхлантай ажээ.

Төмөр тэр зvг ажиглан харж байснаа «Баатар вантай уулзаж болох болов уу?» гэж асуув.

## XVIII

Гvн цасанд дарагдсан ойн дундуур гарсан нарийхан замаар эцэж ядарсан морьтой ганц хvн гэлдрэн явж байлаа. Баруун ташаанд нь модон хуйтай сэлээдий буу санжигнан, зvvн ташаанд нь орос морин цэргийн урт сэлэм унжина.

Үдийн наранд цасны өнгө гялтганан, модны мөчрийг дарсан сэвсгэр цас салхинд бут бутгаар унана. Арай ядан хөлөө зөөж байгаа морины хөлд цас удаан бөгөөд залхуутай чахарна. Газар шагайн явж байгаа энэ хvн бол Эрдэнэ ажээ.

Цагаанаас салж явснаас хойш хэд хоног явсан боловч хаашаа юу хийх гэж яваагаа мэдсэнгвй. Мэдэхийг ч хвссэнгвй. Тvvнд урьдын жавхаа, хийморь огтгвй болоод чихэнд нь «аав аа, миний аав аа» гэж хашгирсан хvvхдийн нарийхан дуу хоногшин, тэр хvvхдийн зовлонгийн хамаг гэмтэн нь цагааныг хврээнд авчирсан Эрдэнэ өөрөө мэт бодогдож байлаа.

Морь нь зогсоход хэд давирсан боловч хөдөлсөнгvйд бууж хөтлөн цааш гэлдрэв. Ингэж явж байснаа зогсож буу сэлэм хоёроо цасанд шидэж орхив. Хамгийн хэрэггvйгээр барахгвй хамгийн гэмтэй зvйлээсээ салах шиг бодогдож бие нь хөнгөрөх шиг болов.

«Энэ хог байсан цагт хvн жаргахгвй» гэж шивэгнээд бушуухан тэндээс зайлахаар хөдөлж хэсэг явтал ард нь хvн дуугарах шиг болов.

Эргэж харвал том хврэн морь унаж, халиун морь хөтөлсөн, хврэн дээлтэй, том внэгэн лоовуузтай хvн ирлээ. Үvрсэн урт бууны ам нь дээш ёрдойн харагдана. Эрдэнэ, зэвсэгтэй хvн мөрдөн ирж явааг хараад юу болохыг хвлээн зогсов. Хараач дээ! Даржаа баатар ажээ. Баатрыг дэргэдээ ирж зогсоход «Баатрын амгаланг айлтгая» гэсэнд «сайн, та сайн уу» гэж хариу мэндлэв.

-- Чамайг юун хүн юм бол гэж баахан сэжиглээд хойноос чинь нилээд дагалаа. Буу сэлмээ хаяж байхыг чинь ч харж л байлаа. Ийм цагт сумтай буу, иртэй сэлмийг хаяж болдог эд биш дээ гээд мориноос буув.

Эрдэнэ болж өнгөрсөн явдал, ямар ч зорилгогүй явж байгаагаа яриад,

-- Энэ эзгүй ууланд тантай учирна гэж зүүдэлсэн ч үгүй гэв.

-- Эзгүй биш, Одоо энэ нарийхан зам монголыг аврах зам болоод байгаа юм. Үүгээр хиагт руу өдий төдий хүн явж, Сүхбаатартай нийлж, монгол орноо гадаадын хар хэрээнүүдээс аврах хэрэгт нэгдэн орж байгаа юм шүү. Би ч бас тэр зүг явж байна гээд Сүхбаатарын үйл явдлын тухай ярьж өгөв.

-- Намайг цагаантантай нийлж явсан болохоор авах болов уу? гэж Эрдэнэ асуув.

-Авалгүй яахав. Май буу сэлмээ гэж Эрдэнийн хаясан зэвсгийг богцноос гаргаж өгөв.

Хоёр хоног яваад гурав дахь өдрийнхөө үдийн хирд Хүдэр харуулд цэрэг элсүүлж байсан Сүхбаатартай учрав.

Даржаа угаас Сүхбаатарыг таньдаг болохоор дотно уулзаж Эрдэнийн бүх явдлыг хэлэв,

-- Бидэнд өнөөдөр нэг сум хэрэгтэй байхад та арван хэдэн сумтай хурдан буу, сэлэмтэйгээ хаяж байдаг чинь тусгүй хэрэг. Манай орныг хэмлэж байгаа дайсан олон байна. Хүчтэй ч байна. Зөвхөн Хиагтад арван мянга гаруй гамин байна. Биднийг устгахаар хүрээ, баруун аймгуудад цагаан намын этгээд хүч хуралдуулж байна. Эднийг зөвхөн буу сэлэм хоёроор хөөж болно. Гэтэл та буу, сэлмээ хаяж байх. Бид нэгэн санаа нийтийн хүчээр зүтгэвэл хүрэхгүй газар, чадахгүй юм байхгүй. Бидэнд оросын ажилчин тариачин нар Зөвлөлт засаг, большевик нам тусална...Бид одоо цөөхөн байна. Гэвч дийлнэ гэж Сүхбаатар ярилаа.

Эрдэнэд «большевик нам» гэдэг үг хэзээ хаана дуулснаа санахгүй боловч нэг л их таньдаг хүнтэйгээ учирсан юм шиг бодогдов. Гэтэл алия Петр сэтгэлд нь орж танил үгийн эх олдов. «Бид засгаа байгуулаад, та нарт тусална» гэж Петрийн хэлсэн үг санаанд нь орж «Даанч итгэлтэй ярьдаг байсан. Ийм учиртай юм байсан байж шүү. Мунхаг золиг. Сөргүүлэн мэтгэж байхын оронд ярьсан хэлснийг нь ойлгож авсан бол өдийд хаанаас ингэж эргүү хурга шиг мангуурч явах билээ» гэж биеэ зэмлэв.

Энэ хүнийг тавьтдаа авч сургууль хийлгэ. Буу зэвсэгтэйгээ хүн шүү гэж Сүхбаатар орж ирсэн хүнд хэлэхэд нь Эрдэнэ, Петрийн тухай бодлоос салж харвал Дорж зогсож байв.

-- Доной сайн байна уу?

-- Сайн, мэнд амгалан уу?

Сүхбаатарын хөмсөг нь зангиран Эрдэнийг сэжиглэлтэй харснаа «Яагаад Доной билээ! Сая Эрдэнэ байсан биш билүү?» гэж асуув.

Эрдэнэ сандран бүхий л амьдрал явдлаа нэгд нэггүй тоочин ярилаа. Сүхбаатар байн байн Эрдэнийг ажиглан харж, заримдаа ярьснаас нь лавлан асууж байв.

-Та Долгорт дэндүү хатуу сэтгэл гаргасан бололтой гэж Сүхбаатар хэлэв.

-- Намайг доромжилсон шүү дээ.

-- Хатуу амьдрал, гэмт хэрэг ч хийлгэдэг юм шүү! Тэр хөөрхий эмэгтэйн буруу биш ч байж болно. Та сайн бодоорой гээд Сүхбаатар гарлаа.

Ингээд Эрдэнэ ардын журамт цэргийн цоохор цэргийн хорооны нэгдүгээр тавьтын цэрэг болжээ.

Өдөр ирэх тутам ардын журамт цэргийн тоо олширч эгнээ нь батжин өсөж байлаа. Дарлал зовлонгоор жирэмсэлсэн монгол орны тал бүрээс зэвсэгтэй зэвсэггүй морьтой явган хүмүүс цугларан, эх орон ард түмэндээ эрх чөлөө, тусгаар тогтнолыг олгох болд илдийг давтаж эхлэв.

Булаг шандаас гол горхи, горхи нийлж мөрөн, мөрөн нийлж далай болдог шиг доромжлол дарлалаас хорсол, хорслоос тэмцлийн далай үүсэн долгиж, тэр далайг сөрсөн бүхнийг хөмрөн живүүлэх шуурга исгэрэн шуугив.

Гадаадын хүмүүс харахад босох нь битгий хэл, хөдөлж чадахаа больсон архаг өвчтэй эрүү өвдөг нь нийлсэн өвгөн шиг болсон монгол орны булчинд, залуу эрийн хүч зангирч найман үе Богдыг залаад ч, наян тохой майдар босгоод ч олж чадаагүй эрх жаргалыг хүнд ажилд цэврүү болсон малчин ардын хүдэр гараар дайсны гараас булаан авах аварга тэмцлийн түүдэг гал улалзаж ийнхүү эхлэв.

Орос оронд мандсан их хувьсгалын ширүүн аянганд гүн нойрноосоо сэрсэн ард олны бие нь тэвээрч улс гэрийн төлөө шударга тэмцэлд нэгдэн зангирлаа.

Муу амьд явахаар сайн үхэх нь сайхан гэж боссон олны тэмцлийн хүчит верийг Богдын лүндэн, бароны бардам дээрэнгүүлэл, гамингийн догшин авир аль нь ч хориглох хүч байсангүй.

Хуралдан бойжиж байсан ардын журамт цэргийн хэсгүүд, гаминтай хэд хэдэн удаа тулалдаж, ялаад хүч зориг нь улам ч бадарлаа. Гаминтай тулалдсан хэдэн удаагийн жижиг байлдаанд Эрдэнэ гавшгай оролцож Сүхбаатар жанжнаас сайшаал хүртжээ.

Нэгэн удаа Сумъяа бэйстэй уулзахаар явахдаа Сүхбаатар гучаад хүн дагуулж явсны дотор Эрдэнэ оролцож билээ.

Сүхбаатар замдаа ямар нэгэн богино дуу аялан явснаа хажуудаа явсан Эрдэнэд хандаж «дуу дуулж явахад газар амархан дөхдөг юм шүү» гээд инээмсэглэснээ «гэхдээ одоохондоо чанга дуулж болохгүй байна.» гэж нэмж хэлэв.

Эрдэнэ эхний нь үгэнд «Эр бор харцага»-ыг дуулья гэж бодсон боловч сүүлчийн нь үгийг сонсоод уушгиндаа хураасан хийгээ алгуур буцаан гаргалаа.

Цэргүүд үг дуугүй цувралдан явж байлаа. Гэтэл Сүхбаатар дөрөөн дээрээ өндийж эргэн хараад «нөхөд минь мөөгний хятад шиг газар шагайн цувралдаад юу хийх билээ. Цөм хүрээд ирээч» гэхэд нь цэргүүд зэрэгцэн ирлээ.

Сүхбаатар бадарчны тухай хоёр шог үлгэр ярьсанд цэргүүд хөгжилдөн зарим нэг нь хариу болгож шог үлгэр ярьжээ.

Ингэж инээлдэн явтал өмнөөс нь морьтой монгол хүн давхин ирж гамингууд ард олныг дээрэмдэн, тэдний өвсийг хураан авч байгаа тухай мэдээ хүргэж ирлээ.

- Гамин олон юм уу? гэж Сүхбаатар асуув.

-- Зуу шахам.

Сүхбаатар хэсэг бодолхийлснээ цэргүүддээ хандаж, үзээд алдах уу? гээд том цагаан шүдээ яралзуулан инээмсэглэн.

-- Бароныхонтой байлдаж байх нь арчаагүй юм байна билээ. Үзэлцье гэж Эрдэнэ хэлэв.

-- Эндээс хол байна уу? гэж Сүхбаатар асуугаад хүний ирсэн зүг харлаа.

-- Ойрхон. Энэ уулын цаад дор.

-- Бид юуны өмнө алалдахыг хичээх хэрэг алга. Болбол ярилцаж байгаад буулгаж авъя.

Тушаалгүйгээр буудаж огт болохгүй.

-- За явцгаая гээд Сүхбаатар явжээ.

Замдаа ирсэн хүнээс гамингийн байрлаж байгаа газрыг нэгд нэгэнгүй мэдэж авсан Сүхбаатар уулын орой дээгүүр цэргүүдээ байрлуулаад өөрөө хоёр хүний хамт гамингуудын зүг хатируулан явлаа.

Давхисаар ирж яваа гурван морьтой хүнийг хараад гамингууд майхнаас гарч зогсов.

Сүхбаатар майханд тулж очоод морины амыг татаж зогсоод «Ноён чинь хаа байна?» гэж



асуув.

Гамингийн ноён, хэлмэрчийн хамт Сүхбаатар өөд явж ирлээ.

--Та нарыг монголын ардын журамт цэрэг бүслээд байна. Хэрэв эсэргүүцэлгүй бууж өгвөл амийг чинь эсэн мэнд үлдээнэ. Хэрэв бууж өгөхгүй бол... гээд уулын толгой руу харахад хэлсэн ёсоор нь явган морьтой хүмүүс энд тэнд булталзаж байлаа.

Гамингийн ноён уулын толгой руу ажиглан харж баахан дуугүй зогссоноо эрс бөгөөд шийдэмгий дуугаар «бид бууж өгөхгүй» гэлээ.

-- За тэгвэл зэвсгийн хурцаар үзэлцэх болж дээ гээд Сүхбаатар тайвнаар морины амыг эргүүлэв.

Гамингууд холдож байгаа хүмүүсийн хойноос нилээд удаан гөлрөн зогсов. Бүрэн зэвсэгтэй зуу гаруй хүний дэргэд ямар ч аймшиггүй орж ирээд ямар ч аймшиггүй буцаж байгаа гурван хүний ган зориг, хүрээнээс хөөгдсөн аюултай явдалд цөс нь хайлж, зүрх нь шантарсан гамингуудыг үл харагдах ган цалмаар хүлж зогсоосноос ингэж гар хөдөлж чадсангүй. Ирсэн хүмүүсийг холдсон хойно ухаан орсон гамингийн ноён «Байраа эзлээд» гэж хашгираад өөрөө өвс ачсан тэрэгний доогуур орж хэвтлээ.

Удсан ч үгүй хоёр талын уулнаас буудаж эхлэхэд гамингууд хариу буудаж бараг хагас өдөр үргэлжилсэн тулалдаан болоод эцэст нь ашиггүй байр эзэлсэн гамингууд тэрэгтэй өвсөө шатаан зугтсан боловч амьд гарсан хүн ховор ажээ.

Партизанууд буу, сум үлэмжийг олзлон авч их л баяр болов.

1921 оны 3-р сарын 16-ны шөнө ардын журамт цэрэг, Хиагтад байгаа гаминг хөөх их тулалдаанд мордов. Доржийн удирдсан цоохор цэргийн хорооны нэгдүгээр тавьт Хиагтын баруун хойноос довтолохоор ойртон очив.

Орой бууж өгөхийг гамингаас шаардсан хоёр дахь бичгийн хариу ирэхгүй болохоор нь Сүхбаатар цэргээ цуглуулж «бид гамингаас энх тайвнаар бууж өгөхийг зүй ёсоор шаардсан боловч тэд хариу өгсөнгүй. Одоо бид зэвсэг хэрэглэхээс өөр замгүй болжээ. Энэ байлдаан бол монгол улс байх, эсэхийг шийдэх юм. Биед нь монгол эхийн цус эргэлдэн, цээжинд нь монгол зүрх цохилж байгаа хүн бүхэн өнөөдөр хатан зориг гаргах хэрэгтэй. Дайсан арван мянга гаруй бид дөрвөн зуу гаруй. Гэвч бидний хөл доор минь доромжлогдсон эх орон, ард минь зовсон ард түмэн байгаа болохоор бид дийлэхгүй байж болохгүй. Айж сандарч байгаа хүн байвал одоо буцаж болно» гэж хэлэв.

Олон цэргүүд «жанжны алдар бат оршиг!» гэж нижигнүүлэн хашгирав. Монгол оронд ардын хувьсгалын твймэр дүрэлзэж энэ тэмцлийн төв нь Хиагт болов.

Сүхбаатар дэлтэй хонгор мориндоо мордож цэргийн өмнө явахад түүний бие нь аварга том болсон юм шиг Эрдэнэд харагдав.

Шөнө дундын вед цэргүүд анги хуваагдан байраа эзэлж дохиог хүлээв.

Үүрийн гэгээ хүлээн зогсож байхад Эрдэнийн зүрх цохилон «Монгол ах дүү минь...» гээд хашгирч байсан хүүхний дуу, өөрийг нь барих гээд ноцолдож байсан гамингийн нүүр царай харагдан бахиралдах нь сонсогдох мэт болж сэлэмийнхээ бариулыг гараа бадайртал атгаж байлаа.

Үүр гэгээрэхийн вед довтолгоон эхлэв. Анхандаа сандарч зугтсан гамин сэхээ авч зарим газраа хориглож эхлэв.

Гэтэл үхэр буу дуугарч шороо манан хадуулан дэлбэрэв. Гамингууд эргэлтгүй сандран эхлэхэд партизан цэргийн довтолгоо эхэлж орой болоход Хиагтыг эзлэв.

Дорж тавин цэргийнхээ хамт хэдэн пүүсний хашаанд орвол эрүү өвдөг нь нийлэх шахсан хөгшин луухаанаас өөр хүн байсангүй. Дорж түүнд буу тулгаж байгаад «Торго дурдан,

нанжин чавга, нар хамба чинь хаа байна. Хэлэхгвй бол пүн гээд чи чөтгөр болж нутаг буцна гэтэл хятад сандран мөлхөв.

-- Ямар зусарч золиг вэ. Тэр хэлсэн юм бушуу гаргаж өг! гэж Дорж зандрал.

Хятад бvх байшингаа нээж өгөхөд«чадах чинээгээрээ авцгаа. Үнэндээ бидний хөрөнгө. Дийлсэн цэргийн сvр» гэж Дорж ихэмсэг бөгөөд бардам дуугаар хэлэв.

Эрдэнэ цэргvвдийн хамт торго хураасан байшинд орлоо. Нөхөд нь толгой, толгойгоор хураасан торгоноос доод тал нь хоёр гурван толгойг авч байв. Зарим нэг нь хэд хэдэн толгойг ч баглаж боогоод дааж ядан vүрнэ.

Эрдэнийн сэтгэлд Долгор бодогдов. Амьд мэнд явбал хэзээ нэгэн цагт тvвнтэй уулзах мэт санагдав. Би дэндvү ширvүн зан гаргасан болов уу? Тэр минь намайг дагаж зовлон vзсэн хvн дээ. Хатуу амьдрал vнэнч сэтгэлийг нь сохолсон ч байж болох юм даа. Хөөрхий минь бvх насандаа мөрөндөө торго углаж vзээгvй юмсан» гэж бодоод цэцгэн хээтэй цэнхэр торго авч задалснаа «Дээл хийхэд хэдэн ам торго ордог юм бэ? гэж хажууд нь толгой торго бариад vзэж байсан Доржоос асуув.

-- Ялсан цэргийн дээлд толгой ордог юм. Энгийн хvнд бол арван хоёр ам болно гээд Дорж бvдvүн дуугаар ха ха гэж хангалуун инээв.

Эрдэнэ цэнхэр торгоноос арван хоёр амлаж хутгаараа огтлон аваад муутуу цаасанд эвтэйхэн боож өвөртлөөд эргэхэд нь «Ийм юманд ороод алгын чинээ юмаар яах вэ? Ядахдаа нэг толгойг аваач» гэж Дорж хэлжээ.

-- Зvгээр. Надад энэ болно гэж Эрдэнэ явдал дундаа эргэж хэлэв.

Маргааш өглөө нь Доржийн тавьтыг жагсаав. Хэдэн хvний хамт Сvхбаатар давхиж ирээд мориноос бууж хөмсөг нь мушгиран эрчилснээ: «Та нар бол ардын журамт цэрэг болохоос биш, бvлэг дээрэмчид биш. Өчигдөр орой пvвснээс дээрэмдсэн юмаа одоо энд авчирч тавь» гэлээ.

Цэргvвд дуу ч гарсангvй, хөдөлсөн ч vгvй.

-- Доржийг тавьтын даргаас огцруулж арав банздана. Танай тавьтын даргаар Даржааг томилов. Энгийн номхон ардаас сэтэрхий зvү, сиймхий самбаа авсан хvнийг хамгийн хатуу цээрлvүлнэ гэж Сvхбаатар өндөр дуугаар хэлэв.

-- Жанжин аа! Банздах гэдэг чинь харгис засгийн шvүлт биш vү. Манай ардын засгийн вед ард биднийг эрvүдэн шvүх явдалгvй болно гэж хэлсэн бус уу? гэж олон дундаас нэг хvн хэлэв.

Сvхбаатар хvйтэн инээмсэглэснээ «Дээрэм бол харгис засгийн юм болохоор шийтгэл тохирсон байх нь зvйн хэрэг» гэлээ.

Цэргvвдийн дунд шивэгнэлдэн ярилцах битvү чимээ сонсогдож байлаа. Тэгээд авсан юмаа авчран овоолов.

Бvгдийн сvүлд Эрдэнэ аажим алхаж очоод өврөөсөө муутуу цаасанд нандигнан боосон торгоо гаргаж боодолтой нь тавив.

-- Юу юм бэ? гэж Сvхбаатар асуув.

-- Дээлийн торго.

-- Задлаач гэж Сvхбаатар намуухан боловч тод дуугаар хэлэв.

Эрдэнийн тавьсан юм бусад цэргийн юмнаас шал өөр зvйл шиг Сvхбаатарт санагджээ.

Эрдэнэ торгоо унтаж байгаа манцуйтай хvүхдээ задалж байгаа эхийн гараар задлаад Сvхбаатар өөд гэмшилтэй бөгөөд гомдолтой нvдээр харлаа.

-- Хэнд өгөх гэсэн юм бэ? гэж Сvхбаатар асуугаад Эрдэнийг ажиглан зөөлхөн нvдээр ширтэв.

-- Долгорт гэж Эрдэнэ нам дуугаар хэлээд доош харлаа. Сvхбаатар нэг хvнийг дуудаж ирээд:

«Надад Сумьяа бэйсийн бэлэглэсэн торгыг Эрдэнэд өг»гээд олон цэргийн зүг харснаа «Ардын журамт цэргийн зорилго нь сайхныхаа хирээр бузар ажил хийсэн хүнд оногдох шийтгэл хатуу байна гэдгийг бодож дахин ийм булай юм бvv хийцгээ» гээд мориндоо мордож манаруулан давхилаа.

Хэдэн өдрийн дараа Бароны түрvvч цэрэг Баяр гvнгийн удирдлагаар довтлон ирлээ. Энэ байлдаанд Эрдэнэ гарамгай оролцож Сvxбаатар олны өмнө нэрийг нь дурдаж сайшаав.

Хэдэн өдрийн турш бароны гол хvчтэй тулалдах хориглолтын бэлтгэл хийлээ. Ардын журамт цэрэг гvвээний орой дагаж ашигтай байрыг эзлэн авчээ. Хаврын нар нvvрнээс жигнэж ухсан окопны чийгтэй шороо доороос хайрч довтлон ирэх дайсныг хvlээсэн цэргvvдийн зvрх цохилон хоорондоо богинохон vг шивэгнэн ярилцаж байлаа.

Нар нилээд хөөрсөн тэнгэр рvv харахад энд, тэнд хэсэг хэсэг бөөн vвл өмнө зvг нvvж vл мэдэг бvlээн салхи умраас vлээнэ.

Бароны цэрэг хэсэг хэсгээр давшин байр эзэлж эхлэв. Сvxбаатарын дохиогоор ардын журамт цэрэг гал нээлээ. Ширvvн тулалдаан хэдэн цаг vргэлжлэхэд дайсны хvч нэмж ирсээр байлаа. Үдээс хойш цагаантан их буугаар хэсэг буудсанаа хэдэн пулемётын галын доогуур давшив. Уулаас сайн бууддаг Эрдэнэ хоёр гурван хүнийг унагаав. Ардын журамт цэргийн байдал хүнд болж, зарим газраар Бароны цэрэгт шахагдан ухарч эхлэв.

Сvxбаатар Эрдэнийн дэргэд ирж нэгэн бичиг өгөөд «vvнийг түргэн цээжил» гэлээ. Тэр бичиг бол дээд шивээнд байсан улаан цэргийн зуун гуравдугаар бригадаас яаралтай тусламж гуйсан бичиг байлаа.

Удсан ч vгvй Эрдэнэ уул бичгийн vгийг нэгд нэгvй цээжлээд дайсантай буудалцаж байсан Сvxбаатарт хэлэв.

-- Хамгийн сайн морь унаад vvнийг хvргэж өг. Цагаантанд баригдах болбол устгах хэрэгтэй гэж Сvxбаатар хэлжээ. Бичгийг авч мордоод Дээд Шивээний зvг довтлоход цагаантан хойноос нь буудсан боловч оносонгvй. Явсаар Дээд Шивээнд ирж зуун гуравдугаар бригадын гурван зуун тавдугаар хорооны штабын манаатай учир явдлаа яриад даргатай нь уулзахаар явлаа. Удсан ч vгvй даргын тасалгаанд орж ёслоод бичгээ гардуулав. Тэр дарга орчуулагчаар дамжуулан уул бичигтэй танилцаж байхад цаад тасалгаанаас шинелээ нөмөрсөн орос хүн гарч ирээд Эрдэнийг харснаа «Уухай даа. Эрдэнэ . Би чамтай лав уулзана гэж бодож явсан» гээд шууд ирж номхон зогсож байгаа Эрдэнийг тэврэн авлаа.

--Алиа Петр... амьд мэнд vv, чи минь гэж Эрдэнийн нүд нь том болоод дуу алдав.

-- Амьдаар барах уу. Чамд туслахаар ирээд байна гээд том ногоон нүдээ эргэлдvvлэн бvдvvн дуугаар инээв.

-- Комиссар аа Сvxбаатар биднээс даруй туслахыг гуйсан байна гэж дарга Петрт хандаж оросоор хэлэв.

-- Зөвлөлт засгийн газар, монголын түр засгийн газрын хэлэлцээгээр монгол нутагт бугшсан цагааны дээрэмчдийг дарахад Зөвлөлт улс тусална гэсэн болохоор бид түргэн туслах хэрэгтэй байна. Бас тэгээд Эрдэнэ бид хоёр vхрийн наймаа хийж явахдаа энэ гуйж, би тусална гэсэн юм сан. Тийм яриа бий байх аа! Эрдэнээ гээд Петр tvvнийг чанга тэврэв.

-- Бий байх шvv гээд Эрдэнэ инээв.

Удсан ч vгvй цэргийн түргэн жагсаалын бүрээ хангинаж монголын ард түмний эрх чөлөө тусгаар тогтнолоо байлдан авах их тэмцэлд ах дvvгийн тусламж vзvvлэхээр ажилчин тариачны улаан цэргийн нэгэн анги хөдлөхөд түрvvнд Петр, Эрдэнэ хоёр зэрэгцэн явлаа.

XIX

Цагаантны Резухин генерал Заяын шавь, сайд Ван, Далай Чойнхор ван, Луу гvний зэрэг

хошуудаас гурван мянга орчим монгол цэрэг дайчилж, орос орноос хөөгдөн дүрвэж гарсан мянга гаруй оросын цагаан цэрэгтэй нийлвүлээд Бароны баруун жигүүрийг буй болгов. Энэ цэргийн зорилго нь Хиагтад байгуулагдсан монголын ардын түр засгийн газрыг устгаад Бароны гол хүчтэй нийлэн улмаар Зөвлөлт орос улсыг довтлох ажээ.

Үүний нэг хороог Павлов захирав. Цэрэг байгуулж эхлэх вед Павлов Итгэлтийнд ирж уулзаад «өвгөн минь бид улаантай үхэлдэн тулалдана. Үүний тул Монголын аймаг, хошуудаас цэрэг, агт, хүнс хоол дайчилна. Энэ учраас чи Резухин генералтай нүүр учирч арван сайн морь, амбан шар арвын хамт их цэргийн хэрэгцээнд өгье гэж айлтгах хэрэгтэй. Тэгэхгүй бол хүчээр дайчлагдах болно» гэлээ.

-- Юу болохыг нь мэдээгүй байж, тийм их хөрөнгөө зүгээр өгөх хэрэг үү?

-- Амлах өгөх хоёрын дунд их зай бий гээд Павлов хөгжилтэй инээн ширэвгэр шар сахлаа эрхий хуруугаар шударснаа улааныг унагааж авсан цагт чи бид хоёрын өмнө алтан зам нээгдэнэ гэлээ.

-- Та нар улааныг давах уу даа гээд Итгэлт зальтай нүдээр Павловыг харлаа.

-- Давна. Олон жилийн дайнд улаанууд цуцаж ядарсан. Бас тэгээд газар дээр нь өлсгөлөн болж байгаа болохоор бид дийлж их эзэн хаант орос улс дахин мандана гэж Павлов бардам хэлээд аягатай архиа хөнтрөв.

-- Мэдэхгүй дээ. Бусад хүн хэлсэн бол ч итгэхгүй... Чамд бол итгэж байна... За тэгээд тэр жанжинтай чинь хэзээ уулзах вэ?

-- Маргааш Заяын хүрэн дээр очиж уулзахад болно. Хамт явах уу?

-- Тэгье.

Энэ орон нутаг, зөөр хөрөнгөгүй, хэдэн оргодлууд, улааныг дийлнэ гэдэгт Итгэлт итгэсэнгүй, гэвч хөрөнгөө дээрэмдүүлэхгүйн тул Павловын хэлснийг хийх нь зөв гэж бодов. Должин, генералд барих урт шар хадаг авдраас гаргаж, Галсан, Итгэлтийн морийг эмээллэж байхад улаан, цагааны тэмцлийн тухай хоёр найз үргэлжлэн ярилцав.

-- Өвгөн минь чи, бидний үйл хэрэгт нэг л итгэхгүй байна даа. Уул нь итгэж болох юм шүү гэж Павлов хэлэв.

-- Хаанаас даа. Ямар үмхий санаатай золиг вэ, Би чамд итгэхгүй хэндээ итгэх вэ гээд Итгэлт нарийхан дуугаар худал инээв.

Хоршоо хоёр Заяын хүрээ рүү явах замдаа улаан, цагааны явдал, улс орны хэргийн тухай өдий төдий юм ярьжээ. Гэвч Павлов улааныг бут цохиж их орос улсыг байгуулан алтан замаар халбиулах үлэмж хүчинд Итгэлтийг итгүүлж чадсангүй.

Итгэлт байн байн худал инээж «за би ч яахав амласнаа өгч болно. Харин цааш нь горьгүй шүү» гэж явлаа.

-- Бид чамаас юу ч авахгүй байж болно. Хэрэгтэй бүхнээ дайчлаад авах хүч бидэнд байна.

Харин ингэх нь нэгдүгээрт чамд хэрэгтэй. Хоёрдугаарт бидэнд хэрэгтэй. Ер нь тэгээд чиний хөрөнгийг үрэх гэж би бодохгүй шүү дээ гэж Павловын хэлэхэд «би чамд итгэнэ» гэж Итгэлт дахин дахин хэлнэ.

-- Дайн дуусаад хоёул том үйлдвэр байгуулна шүү

Павлов хэлэв.

-- Мэргэн ухаан байна. Би хөрөнгөө арвижуулж л байя. Цэмбэний үйлдвэр байгуулна шүү гэж Итгэлт хариулав.

Гэвч Итгэлт «чи энэ дайнаас амьд ирээд, бид хоёр үйлдвэр байгуулах ч алганы хонхорхой хазахтай адил хэрэг байхдаа» гэж дотроо бодож байлаа.

Маргааш нь Итгэлт, пүүсний байшинд хэдэн хошууны захирагч нарыг цугларуулан цэрэг,

морьд, хvнс дайчлах тухай Богдын зарлигийг сонсгож байсан Резухин генералын өрөөнд Павловын хамт орж ирлээ.

Өндөр оройтой цагаан хурган малгай өмсөөд нэг ташаандаа сэлээдий буу, нөгөө ташаандаа гялгар хуйтай сэлэм зvvcсэн Резухин генералын өмнө Итгэлт очоод өврөөсөө урт гэгчийн шар хадаг гаргаж барин бөхийж «аварга хvчит баатар цагаан хаант орос гvрний их жанжин таны тvмэн амгаланг айлтгаж өчvvxэн хvн би төр улсыг минь мандуулж өгөх их хэрэгт хандив болгож бага буурай хөрөнгөнийхөө дээж агт морь арав, амбан шар арвыг сэтгэлчлэн барья» гэсэн vгийг Павлов генералд орчуулж өгөв.

Генерал баясгалантай инээмсэглэж, хадгийг өрөөсөн гараараа дээрээс нь чавчиж аваад «олон тvшмэд та нар сонсож байна уу. Монголын олон тvмэн Богд хааныг ширээнд нь залсан бидний хэрэгт гvн итгэж хvчин туслах ёстой юм» гээд Итгэлтийг тэврэн авч нуруун дээр нь алгадав.

-- Хэрэв та миний цэргийн албанд зvтгэхийг хvсвэл таныг хорооны туслах дарга болгоход би бэлхэн байна гэж генерал нvдний шилээ авч арчих зуур хэлэв.

-- Өчvvxэн би инээхээс бусад эмгэг өвчинд баригдсан болохоор эрхэм таны энэ өндөр хишгийг хvlээн авах хувьгvй билээ гээд Итгэлт бvдvүн генералын гараас салж алгуурхан хаалга руу ухрав.

-- Таны хувьд бол дурын хэрэг гээд генерал баяртай мишээв. Хэдэн өдрийн дараа хошуудаас агт морьд, цэргийн хvнс буу зэвсгийн хvчээр дайчлахад Итгэлтийн мал сvргээс өнчин ишиг ч авсангvй.

Хаврын эхэн сарын нэгэн өдөр Резухиний цэрэг Хиагт хотын зvг хөдлөх болов. Цэргийн хамт Зая гэгээний бие төлөөлөгчөөр Жамбал явах болжээ. Хошуудаас дайчлагдан ирсэн монголын цэрэг Заяын гэгээнээс адис авлаа. Цагаан цэргийн өндөр хурган малгай өмсөж, жижигхэн гар буу бvсэндээ хавчуулсан гэгээний өмнvүр мянга гаруй хvн толгойгоо бөхийлгөн залбираад өнгөрөхөд гэгээн баруун гараар бvгдэд нь адис тавьжээ.

Ингээд цэрэг хөдлөхөд Павлов даргатай монгол цэргийн хороо хошуучлав. Энэ хорооны туслах даргаар Сайд Вангийн хошуу туслагч Пvрэв тайж явжээ.

Пvрэв тайж өөрөө хийлгэсэн өндөр цагаан хурган малгай дээрээ вангийн хvрэн чулуун жинсээ хатгаж өмсөөд цэнхэр торгон дээл дээр шар дурдан бvс бvсэлж том хvрэн морь унажээ.

Энэ цэрэг зам зуурын тохиолдсон газраас хоол хvнс, унаа хөсөг дээрэмдэн нулимс цусаар зам гарган урагшлахдаа хошуудаас цэрэг дайчлавч монголын ардын намын олонд тунхаглах бичгийн учир явдлыг ойлгосон монгол цэргvүд бөөн бөөнөөр оргон алга болж цэргvүд оргох тутам цагаан дарга нар ширvvcсэж байлаа.

Ингэж явсаар Павловын хошууч хороо орос монголын хилд Зэлтэр харуулын тушаа газраар ойртон ирлээ, Өглөөний нараар угтаж ирсэн Монгол Зөвлөлтийн цэрэгтэй тулгаран гурван цаг гаруй ширvүн байлдсаны дараа цагаан цэргийн хvчин суларч тvүнний монгол цэргvүд нь буцаж дуртай зvгтээ бутран алга болжээ.

Оросын цагаан цэрэг тавь гаруй хvн буудалцан vд өнгөрvүлээд бас л зугтаж эхлэв. Эдэнтэй хамт vлдсэн ганц монгол гэвэл хорооны туслах дарга Пvрэв тайж байлаа. Гэвч Пvрэв тайж зоригтой сайндаа vлдсэнгvй. Харин буу эхэлж дуугарахад бут бургасанд шурган нуугдаад өндийж ч чадахгvй бугаа тэврэн хэвтжээ. Нэг харвал сvүлийн орос цэрэг морь руугаа гvйж харагдахад нь босоод гvйх гэтэл ар талаас нь хvчтэй юм цохиут унаж агшин зуур vхжээ. Унахад нь хол унасан жинстэй цагаан хурган малгай нь цагааны зугтсан цэргийг хөөсөн монгол зөвлөлтийн цэргийн морины хөлд дайрагдан навсарч шороонд булагдав. Алдар эрж,

охид бузарлаж явсан энэ хэрцгий тайж шороо үмхээд үхсэн байлаа.

Энэ байлдаанд оролцсон монголын ардын журамт цэргийн дотор Эрдэнэ явалцсан бөгөөд цагааныг зугтахад мориндоо мордон нэхэв. Сумьяа бэйсийн хошуунаас ирсэн өндөр зээрд морь нь бүхний өмнө гарч довтлоход Эрдэнэ сэлээдий буугаар хааяа нэг буудан давхилаа. Хэсэг явтал өмнө нь хүрэн морьтой цагааны дарга жижиг буугаар эргэж буудсаар давхиж явлаа. Энэ бол Павлов байжээ. Гэвч Эрдэнэ түүнийг таньсангүй. Мориндоо ташуур өгч бөхийн хурдлав. Нилээд хөөцөлдөвч зай нь ойртсонгүй морийг нь буудаж орхивол дээрх хүн нь тэртээ хол тонгорцоглон унав.

Мориноосоо салахдаа буугаа алдсан Павлов босож ядаж байтал Эрдэнэ давхиж ирээд үсрэн бууж буу тулгав.

Павлов гараа алгуураар өргөн зогсов. Эрдэнэ, ажиглавал хөлс шороо болсон нүүртэй энэ орос бол өөр хэн ч биш нөгөө Павлов байжээ.

-- Эрдэнэ гээд Павлов гараа буулгаж өмнөөс нь явах гэхэд «зогс» гэж Эрдэнэ зандрав. Павловын магнайгаас цус урсан хөлс шороотой зууралдан хар хүрэн болоод хацар руу нь урсаж байлаа. Омголтсон уруулаа хэлээрээ чийглэн амьсгаадна.

-- Чи энд юу хийж яваа юм бэ? гээд Эрдэнэ буугаа хуйнд нь хийх гэтэл Павлов үсрэн ирж буу дээрээс нь барьж авлаа. Эрдэнэ буутай гараараа хүчлэн түлхсэнд Павлов гэдрэгээ алдлан унав.

Эрдэнэ буугаа түүний зүг чиглүүлэлт Павлов өндийж өвдөг дээрээ сөхрөн «Эрдэнэ минь, бид хоёр эртний танил. Чи миний эхнэр хүүхдийг танина. Амь өршөө!» гээд уйлж гарлаа.

Эрдэнэ гайхан зогсов. Павлов бүр мөлхөн хонин шар нүдээ гөлөлзүүлэн «Амь өршөө! Чи бид хоёр адилхан эхнэр хүүхэдтэй шүү дээ. Амь өршөө!» гээд бүр энгэнэтэл уйлав.

Павловын арчаагүй байдлыг хараад «Энэ мундаг эр ингэж байх гэж дээ. Үнэхээр ч эхнэр охин хоёрыг нь өнчрүүлж яах билээ дээ. Над шиг будилж яваа ч юм билүү» гэж бодоод «муу золиг минь бушуу зайл. Харин дахиад зэвсэг барьсан байвал даа» гэлээ.

Павлов юу сонссоноо ухаарч ядан Эрдэнийг ширтэн байснаа босоод «Би хаачих вэ?» гэж хоолойгоо чичрүүлэн суув.

-- Цааш яв.

-- Чи намайг араас буудахгүй биз

-- Дуугүй яв.

Павлов эргэж явлаа. Анхандаа эргэж харан удаан явснаа сүүлдээ шогшиж эхлэв. Эрдэнэ түүнийг далд ортол нь хараад орчин тойрныг ажиглавал Павловын хаясан буу нүдэнд нь тулав.

Авч үзвэл ганц ч сумгүй болжээ.

Тэр орой улаан цэргийн нэмэлт хүч ирэхэд Петр ирж Эрдэнэ Петр хоёр дотно уулзав.

-- Өнөөдөр би нөгөө Павловыг тавьж орхилоо. Бүр уйлаад амиа гуйж байна гээд Эрдэнэ болсон явдлыг ярив.

-- Эрдэнэ минь. Нэг галзуу нохойг тавивал хэдэн нохойг галзууруулдаг юм гэж Петрийн хэлэхэд Эрдэнэ инээмсэглэснээ «Эхнэр хүүхдээ дурдаад л сөхөрч, мөлхөж гуйгаад байх юм» гэлээ.

Петр Эрдэнийг хурц нүдээр ширтэн байснаа «хувьсгал хийнэ гэдэг бол тоглоом биш юм шүү. Нэг бол чи үхнэ. Эсхүл би үхнэ гэсэн хэрэг. Одоо чиний тавьсан Павлов чинь Резухиний ангид очоод дахин зэвсэглэж өнөө шөнө юм уу, маргааш чамайг нөхөдтэй чинь хамт хүйс тэмтрэхээр ирнэ» гэлээ.

Эрдэнэ гэмшилтэйгээр Петрийг харж инээмсэглэснээ «Арай ч үгүй байлгүй дээ» гэлээ.

-- Үзэж л байгаарай Эрдэнэ минь. Нинжин сэтгэл сайхан боловч зэвсэг барьсан дайсанд гаргахын хэрэггүй зүйл гээд Петр цаасан тамхи гаргаж нэгийг Эрдэнэд өгөөд өөрөө нэгийг татлаа.

Маргааш нь нар гарахын вед Резухиний гол анги, Монгол Зөвлөлтийн цэргийн хориглосон байр руу давшиж эхлэв.

Их буугаар хорь гаруй удаа буудаад дараа нь хэсэг, хэсгээр урагшлан байр эзлэв. Ингээд Монгол Зөвлөлтийн цэргийн хориглосон шугаманд ойртон очтол пулемётын шөргөлсөн галтай мөргөлдөж буцаад байр эзэлж үд өнгөртөл буудалцав.

Зэвсгийн боломжоор хомсхон Резухиний цэрэг хориглолын удаан дайн хийх чадалгүй байжээ. Энэ учраас мянга гаруй морьтой монгол цэргийг модон дотуур нууцлан явуулж монгол зөвлөлтийн цэргийн баруун гараас нь гэнэт дайрав. Гэтэл эхний буун дуугаар хошууран эргэж модны нэг болон тарж хошуу нутгийн зүг алга болжээ. Цагаан дарга нар хвчлэн хоригловол заримыг нь хвлж хаяад, заримыг нь буудан алжээ.

Оройн нар ханын элэг өөд гарах вед цагаан цэрэг бүрмөсөн бут цохигдож сарнин зугтав. Жамбал явган гүйж явтал хойноос нь ирсэн Павлов морины амыг татаж зогсоод тэр хоёр сундалдан цааш давхилаа..

-- Нэг бол улаанууд энэ хорвоо дээр амьдарна. Эсхүл би амьдарна. Бидэнд нэг нар байхгүй гэж Павлов шүдээ зуун хорсон ярьж явахад Жамбал дуугүй: «Энэ оросыг барьж улаанд тушаавал зөвхөн амьд гарахаар барахгүй гавьяа шагнал хүртэнэ» гэж бодож явлаа. Гэвч энэ мундаг эрийг яаж барих арга олдохгүй ажээ.

Ум хумгүй давхисан морь хөлрөн эцэж эхлэхэд тэр хоёр бууж модон дотор амрав. Хааяа нэг дуугарч байгаа бууны дуу чихний үзүүрт сонсогдож байлаа. Павлов бие засахаар суух вед Жамбал бууны бөгсөөр цохиж ухаан алдуулав. Янгинатал хвлж аваад сууж байтал Павлов ухаан ороход нь шууд өргөн аваад эмээл дээгүүр хөндлөн тавиад морио хөтлөн эргэж явлаа.

-- Чи хаачих гэж байна гэж Павлов амьсгаадан асуув.

-- Чамайг улаанд аваачиж өгнө.

-- Чи бид хоёр нэг талын улс шүү дээ!

Жамбал хариу дуугаралгүй явсаар байлаа. Павлов эхлээд «амь өршөө!» гэж гуйв. Гэвч Жамбал дуугарсангүй «улаанд очиход хоёуланг маань ална» гэж сүрдүүлэхийг оролдов. Гэвч Жамбал улаан хэнийг нь алж, хэнийг нь шагнаж сайшаахыг сайн мэдэж байлаа. Арга нь мухардсан Павлов «улаанд аваачиж өгснөөс энд буудаж орхиоч» гэж гуйхад нь Жамбал хүйтэн инээмсэглээд «Павлов минь би хvvхэд биш» гээд дахин дуугарсангүй.

-- Та нартай хамт ардын засгийн төлөө морь нохой мэт зүтгэх гэж цагааны энэ ноёныг барьж ирлээ гэж монгол зөвлөлтийн цэрэгтэй учраад Жамбал хэлжээ.

Павловыг Петр байцааж байхад Эрдэнэ дэргэд нь байжээ. Хэнтэй учирсан, юу болохоо сайн мэдсэн Павловын нүдэнд нь үхлийн шийдсэн галзуурал оволзон «Чамайг Тамирын голын бургасанд буудаж орхилгүй, тэжээж байсандаа харамсаж байна» гэлээ.

-- Биднийг алаад та нар барахгүй байсан шүү дээ. Хонгор минь гэж Петр тайван хэлэв.

- Их Оросын аль олигтойг та нар баллаж дууссан улс. Та нарт хайрлах харамлах юм байхгүй. Намайг бушуу буудаад аль. Намайг амиа гуйна гэж горьдож байна уу. Хол байна гээд Павлов, Петрийн нүүр рүү нулимлаа.

Петр ханцуйгаараа нүүрээ арчсанаа

-- Бидний шинэ орос улсыг үзэх хувь тавилан чамд байхгүй. Амь гуйхын хувьд бол хэзээ ч чамайг өршөөхгүй гэлээ.

Павлов, Эрдэнэ рүү ажиглан харснаа.

-- Эд нар манай орныг баллаж орхиод, одоо танай орныг баллах гэж байна. Гэнэн харанхуй хvмvвсийг хуурахдаа чадамгай амьтад шvв гэлээ.

-- Дуугvй бай. Үрийн нь дэргэд эцгийг нь танай цагаанууд дvвжилж орхихыг би vзсэн хvн шvв. Би гэнэн харанхуй ч гэсэн цагаан харыг ялгаж чадна гэж Эрдэнэ хашгирав, Орой нь Павловыг буудаж элсэнд булж орхиод буцаж явахдаа

-- Өнөөдрийн байлдаанд алагдсан манай нөхдийн хэд нь Павловын суманд vхсэнийг бид хоёр мэдэхгvй шvв дээ гэж Петрийн хэлэхэд Эрдэнэ гэмшилтэй бөгөөд хорсолтойгоор санаа алдан доош харлаа.

XX

Дулмаа хэдэн хонь ямаагаа хотлуулан гэртээ орж хоёр аяга тараг идээд ганцаараа тулганыхаа дэргэд суухад Төмөрийн янз бүрийн дvр нvдэнд нь ээлжлэн харагдана.

Удахгvй эргэж ирнэ гэсэн Төмөр хоёр жил гаруй болоход ирэх нь битгий хэл, сураг ч гарсангvй. Анхны вед шөнө бvхэн чагнаж, нохой хуцвал гарч хараад ирээгvй байхад нь чихрээр хууруулсан нялх хvвхэд шиг енгэнэтэл уйлдаг байжээ. Сvүлдээ уйлахаа болив. Тэгээд «нохой хорь» гэж явуулын хvний дуу гарахад дуртай дургvй гарна.

Ганц эмэгтэй хvн, тэгээд гоо vзэсгэлэнтэй бол хэн зvгээр байлгах билээ. Зовлон дээр зовлон нэмж доромжлол дээр доромжлол хvлээдэг болжээ. Дулмаа заримыг нь vгээр, заримыг нь модоор, заримыг нь хутга шөвгөөр хөөж гаргадаг байлаа.

Гэтэл зарим нь өшиж хvний нутагт цагаачилж байгаа атал сэхvүн зантай хvвхнийг элдвээр хавчдаг болжээ.

Эндээс зайлъя гэж бодохоор Төмөр минь ирээд хэнтэйгээ уулзах бол гэж бодоод больдог байжээ. Гэтэл өдөр өнгөрөөд л байдаг Төмөр эргэж ирэхгvй ажээ.

«Намайг энд орхичоод сураг чимээгvй алга болдог арилсан дотортой амьтнаа» гэж бодоод Төмөртөө гомдовч тэр сэтгэл нь удаан тогтож чаддаггvй байлаа. Учир нь «Төмөрт минь ямар нэгэн саад тохиолдсоноос ирж чадахгvй байна» гэдэг сэтгэл тvвнийг хөөж гаргадаг байв. Харин ингэж бодох дээр Төмөрийнхөө тухай, тvвнд юу учирснаар ингэж ирэхгvй байна гэж бодоод сэтгэл нь шанална. Тэвч доошоо орьё гэхэд газар хатуу, дээшээ гаръя гэхэд тэнгэр хол тул яах билээ дээ.

Дулмаа алгуур босоод ороо засах гэтэл нохой нь хуцав. Хэдэн морьтой хvн ирж яваа чимээ сонссон боловч Дулмаа гарсангvй.

-- Нохой хорио гэж шахмал бvдvүн дуугаар хvн хэлэхэд аргагvй тарлаа.

Баяны хvв хоёр залуу хар хvнтэй орж ирлээ.

-- За гоо бvсгvй сайн байна уу?

-- Сайн. Та бvхэн сайн байна уу?

-- Нөхөр чинь чимээгvй юу?

-- Чимээгvй.

-- Нөхөргvй залуу бvсгvйн цангааг гаргаж өгөх гэж бид гурав ирлээ гээд баяны хvв Дулмааг шууд барьж авлаа.

Дулмаа чадал мэдэн ноцолдов. Гэвч гурван залуу эрийг яаж гэтлэх билээ. Дулмаагийн хашгирсан дуугаар айлын нь хоёр хөгшин орж ирснийг гурван залуу хvчээр хөөж гаргалаа. Ингээд Дулмааг хvслээрээ доромжлоод явахдаа «дахиад олон ирнэ шvв. Гурав багадаад байвал дөрвvүл ирж болно» гээд доромжлон инээмсэглэв.

Дулмаад эндээс зайлахаас өөр аргагvй болов. Хэдэн малаа хоёр хөгшинд захиж орхиод хоёр морьтой хөдлөв.

Хаачих вэ? гэдэг асуудалд анхандаа хариу байсангvй. Хоёр өдөр явсны дараа юу ч гэсэн



Төмөрийн нутаг Засагт ханы хошуу орохоор шийджээ.

Гэтэл нэг морь нь эцэж аргагвй болоод нэг айлын гадна орхиж цааш явлаа. Баахан явж байтал үлдсэн ганц морь нь эцэж танихгвй газар явгарах болов.

Хээр сууж байгаад хашгиран уйлав. Эцсэн морь нь хаврын өлөн цагаан өвс хазлахаас өөр ямар ч хариугвй ажээ. Уйлсаар морио хөтлөн өргөн хөндийг туулав. Хвйтэн шөнө айлгвй газар морио идүүлэн чичрэн дагжиж хоноод өглөө цааш явахад эцсэн морь нь улам ядарсан байхад чирч гулдарсаар арай ядан явж нэг айл дээр ирлээ.

Овоо малтай энэ айлын эзэн Дуламын яриаг сонсоод ганц эмэгтэй хвний зовлон зүдүүрийг хуваалцан, сэтгэл нь их л хөдөлсөн байдалтай байлаа.

Ядарч яваа хвн, нүүр өгсөн хвнд итгэх нь амархан байдаг болохоор явах газаргвй болсон Дулмаа тэр айлд байх болжээ. Яагаад гэрийн эзэн, Дулмаад тийм сайхан зан гаргав?

Үнэхээр Дулмааг өрөвдөв вү? Үгвй. Саяхан эхнэр нь талийгаач болсон дүүдээ татлаа түлхлээгвй ганц бие, үзэсгэлэнтэй хүүхнийг эхнэр болгон авч өгөх гэж боджээ. Гэвч юуны өмнө ямар зантай хвн гэгчийг нь мэдэх хэрэгтэй болохоор хонио хариулуулав.

Хвний хоол идэж байгаа хвн сайн хвн болж үзэгдэхийг хичээдэг болохоор Дулмаа ажилд сэтгэлээсээ хичээн зүтгэв.

Дулмаагийн ажилсаг гэрийн эзний сэтгэлд таалагдаж, аажмаар дүүгээ Дулмаатай дасгаж эхлэв. Ингэж байсаар нэг өвөл өнгөрөхөд Дулмаа гэрийн эзний дүүтэй суучихсан байлаа.

Дулмаагийн шинэ нөхөр бол олон таван үгвй, биед халамжтай хвн байсан бөгөөд ахаасаа учир тоймгвй айдаг, үгнээс нь огт гардаггвй байлаа. Тэр бол үнэндээ ахынхаа хөлсгвй үнэнч зарц нь байж билээ.

1921 оны зун. Дулмаагийн нөхрийн ахынх өртөөн оногдоход Дулмаа нөхөртэйгөө хамт очжээ. Дулмаа элчид хоол хийх, морь эмээллэх, заримдаа улаа эхлэх зэрэг ажил хийж байлаа. Үе үе Төмөр нь бодогдож зүүд шиг өнгөрсөн жаргалынхаа тухай харамсан суудаг байлаа. Заримдаа Төмөрийнхөө тухай зүүдлэн босон харайна. Нөхөр нь юу болсныг асуухад «Төмөр шиг эр надад дахиад олодохгвй. Заяа минь яасан ч муу юм бэ! Нүгэл минь яасан ч их юм бэ?» гэж шууд хэлнэ

Харин ингэж хэлэхэд нөхөр нь гомдолтойгоор ширтэн, юу ч дуугардаггвй байлаа. Нэг өдөр баруун зүгээс олон цэргүүд ирлээ. Энэ бол баруун хязгаар дахь цагаантантай байлдаж яваа Хатанбаатар Магсаржавын цэргийн түрүүч байлаа. Хатанбаатар Магсаржав ирж явааг сонссон өртөөнийхөн сандарч, хоол, унд, агт морьд урьдчилан бэлтгэв.

Оройн нар жаргахын вед цэргийн гол анги хүрэлцэн ирэв. Цэргийн өмнө зэрэгцэн яваа хоёр цагаан морьтой хвн улаан, шар туг намируулан барьжээ. Түүний хойно зургаан ижил хар морьтой хүүмүүс сэлэм огшин явна.

Энэ эгнэсэн зургаан хвний ард улаан зээрд морь унасан Хатанбаатар ван Магсаржав явна. Өртөөний өмнө ирээд Хатанбаатарын дохио өгөхөд олон цэргийн дундаас сайвар бор морьтой хвн гарч ирээд хадаг яндар болсон том цагаан дунг уянгалуулан татав.

Цэргүүд зогсож морьдоос бууцгаав. Өртөөний занги ёслолын хувцсаа өмсөн Магсаржавын дэргэд ирж тусгай бэлтгэсэн улаан халзан өргөөнд морилон орохыг урив.

Хэдэн мөчийн дараа улаан халзан өргөөний өмнө улаан, шар хоёр тугийг босгож тус бүрийг дөрвөн цэрэг манан зогсов. Цэргүүд тавьт тавьтаар хуваагдан байрлав. Хуягийн тавьт гэр майхан хоёрт оржээ.

-- Бузар цангаж орхилоо. Уух юм олж ирье гээд Төмөр, алсан цагаанаас олзлон авсан жижиг саваа барьсаар майхнаас гарч ийш тийш харахад тэртээ хойно том гэрийн гадна зуух татаж галласнаас багширсан хөх утаа манаран харагдав.

Дэргэд нь хүрэн дээлтэй эмэгтэй хvн тvлээ хагалж байлаа. «Гал байсан газар, ус байх биз» гэж бодоод Төмөр том том алхлав. Сав бариад цээжээ vл мэдэг бөхийн ирж байгаа мундаг эрийг ажиглан харж байсан Дулмаа гэнэт «Төмөр, Төмөр минь» гэж хашгираад гvйх гэснээ шургачин унав.

Төмөр зогсож ажиглан харснаа «Дулмаа минь, ямар сайхан учрал бэ» гээд гvйн очиж ухаангvй хэвтэж байгаа Дулмааг тэврэн авлаа.

Хvмvvc цугларан ирэхэд тvvний дотор Дулмаагийн нөхөр «Юу болов. Юу болов» гэсээр гvйн очлоо, Хэн нэгэн нь усаар тургисны дараа ухаан орлоо. Бvгдийг тойруулан хараад «Төмөр минь» гээд нvднээс нь нулимс урсана.

-- Амьд уулзсанаас хойш уйлаад хэрэггvй гэж Төмөр цээжний гvнээс гарсан намуун дуугаар хэлэв.

-- Та хоолойны нь товчийг тайлаач гэж Дулмаагийн хар хvн Төмөрт хандаж хэлэв. Төмөр тэр хvнийг гэнэн цагаан нvдээр харснаа vл мэдэг мишээгээд Дулмаагийн захны товчийг тайлав. Дулмаа өрөөсөн гараараа Төмөрийн дээлээс дахин алдчих бий гэсэн бололтой базаад элгэнд нь толгойгоо нааж байхдаа хэдхэн мөчийн дараа юу болж ямар зовлонд учрах бол гэж айн эмээсэн сэтгэлээ дарагдан зvрх нь луг луг цохилоо.

Дулмааг тэврэн сууж байгаа аварга том хvн хэн гэдгийг нөхөр нь сайн мэдэж байв. Энэ учраас «бушуухан Дулмааг Төмөрөөс салгаж авахгvй бол энэ сайхан хvvxэн дахиад чамд олдохгvй» гэж ямар нэгэн дуу шивэгнээд байхад нь өөрийн эрхгvй очиж «эхнэрийг гэрт оруулъя» гээд Дулмааг авах гэхэд нь Төмөр гарынхаа vзvvрээр зайлуулж «юу? Эхнэр ээ! хэний эхнэр?» гэж огцом асуув.

Дулмаа Төмөрийн өвөр дээрээс босож зогсоод «Төмөр минь би аргагvй болсон шvv. Намайг юунд мартаж орхив» гэхэд нь нvдэнд нь гомдол, гэмшил хосолж, нулимс хацрыг даган жирэлзэн урсав.

Төмөр алгуур босож согтуу хун шиг гөлрөн найгаж байснаа:

-- «Хvv минь хаа байна?» гэж хөндий дугаар асуув.

-- Төмөр минь чамайг оргоод явахад би чинь хvvгээ алдчихаад байсан. Тэгээд чамайгаа зовоохгvй гэж худал хэлсэн. Би яасан заяагvй амьтан бэ?

(Ертөнц тэр чигээрээ эргэлдэн Төмөрийн нvдэнд өдрийн хурц нар манаран харлаж дундаа өчvvхэн нvхтэй хар тогоонд хөмрөгдсөн юм шиг болов. Баргил гараараа магнайгаа тулж доош харан зогсох зуур «эр хvн дээ хөө» гэж шивэгнэн хэд давтаж хоолойнхоо товчийг тайлж урт гэгч нь санаа алдаад газар тавьсан саваа авч Дулмаа руу хараад:

-- Эмээлтэй юу, чи гэж асуув.

## XXI

Хиагт руу довтолсон цагаантны гол хvчийг ардын журамт цэрэг, улаан армийн ангитай бут цохисны дараа Сvxбаатар, Эрдэнийг хvрээний нөхөдтэй холбоо бариулахаар явуулжээ. Явахын өмнө Сvxбаатараас чөлөө авч Петртэй уулзаж, салснаас хойш хоёр биедээ тохиолдсон учралыг харилцан ярилцав.

-- Өвгөн чинь чиний өгсөн морийг унаж Хөшөө модоор дамжин Бийск орж худалдаад нутагтаа эсэн мэнд хүрсэн. Очиход хvv минь яг л чиний хэлдгээр эхлээд жаахан бишvvрхэж байснаа таниад, бvр салахаа больсон. Гэтэл нам намайг дайны талбарт явуулж хувьсгалын ажил хийлгэсэн гэж эхлээд Зөвлөлт улсыг байгуулах их тэмцэлд оролцож явсан амьдралаа Петр ярилаа.

Эрдэнэ бодолхийлэн хэсэг дуугvй сууснаа:

-- Танай оросыг чинь өлсгөлөн, бөөс хоёрт баригдаад тогтож чадахгүй болсон гэж ярих юм гээд Петрийг харлаа.

-- Өлсгөлөн бөөс хоёр ч үнэхээр манайд бий. Бид нэг үе сандарсан шүү. Зэвсэг, хоол дутагдаад бүх юм минь эвдэрч хэмхрээд байхад дэлхийн арван хэдэн том гүрэн оросын цагаантантай нийлээд тал бүрээс дайрсан. Дайсан хүчтэй байсан боловч бид дийлж гараад одоо та нарт туслахаар ирээд байна. Зовлон үзсэн хүн, зовсон хүнд тусалдаг. Одоо ч гэсэн бидэнд хүнд, хэцүү байна Гэвч хэдэн арван жил өнгөрсний дараа бид дэлхийн хамгийн хүчирхэг, хамгийн сайхан улс болно гэж Петрийг ярихад Эрдэнэ урьдын адил сэргүүлсэнгүй. Айлд зарагдаж, барих олигтойхон модгүй байхдаа л оросын цагаан хааны төрийг булааж авна гэж ярьж байгаад үнэхээр булааж авсан энэ хүний үгэнд үнэмшихгүй зүйл Эрдэнэд байсангүй.

-- Одоо манай улс ёстой нэг улс болох уу гэж Эрдэнийн асуухад Петр нөхрийгөө чанга тэвэрч хацарт нь хацраа нааснаа:

-- Ёстой тусгаар тогтносон улс болно. Гэхдээ хийх юм маш их байна. Засгийг байлдаж авахаас шинэ улс гэдгийг байгуулан тохиуулах илүү төвөгтэй, нарийн ажил юм шүү. Хэрэв та нарыг хүсвэл бид тусалж болно гэлээ.

Эрдэнэ Петр хоёр үүрийн гэгээ манхайж байхад салав. Тэр өглөө Эрдэнэ хүрээний зүг хос морьтой гарчээ. Замдаа онц юм тохиолдолгүй явсаар хүрээнд ирж заасан хүнд нь Сүхбаатарын бичгийг хүргэж өглөө.

Хүрээний хувьсгалчид Баронд биеэ худалдсан Довчин бэйсийн тухай жигшин ярилцаж, түүний гарт байгаа нэгэн чухал бичгийг хэрхэн авах тухай ярилцаж байхыг сонсоод «Би тэдний зарц байсан. Довчинг ч гэсэн, эхнэрийг нь ч гэсэн сайн танина. Уул бичгийг салгаж авч өгөхийг оролдъё» гэж Эрдэнэ хэлэв.

-- Бароноос өндөр тушаал хүртээд, манайханд багагүй балаг тарьсан зальтан хөгшин зөнөг байгаа юм гэж нэг хүн хэлэв.

-- Юун бичиг юм бэ? Та нар сайн хэлж аль. Би яагаад гэсэн ч авчиръя гэж Эрдэнэ хэлэв.

-- Барон ялагдвал Баронтой нийлж байсан Найдан ван тэргүүтэй хүмүүс зугтах тухай бичиг байгаа юм. Олж ирвэл их тустай зүйл гэж хүрэн торгон дээлтэй нэг залуу хэлэв. Үдээс хойш нар ханын элэг өөд гарах үед Эрдэнэ Довчин бэйсийнд очив. Бэйс гэртээ байсангүй. Харин Гэрэл Эрдэнийг ирсэнд үлэмж баярлан:

-- Юу болоод ор сураггүй алга болсон бэ. Та чинь хүнийг өрөвддөггүй хүн байна гэж гомдол нэхэн угтлаа.

-- Энэ үймээний цагт над шиг хүн нэгэн газар удаан тогтож болохгүй байна гэхээс өөр үг Эрдэнэ хэлсэнгүй, Гэрэл ч сонирхсонгүй. Учир нь түүнд Эрдэнэ л ирсэн хойно юу болсон нь падгүй байлаа.

Гэрэл хоол унд авчруулж Эрдэнийг дайлах зуур түүнийг ажиглан харж байснаа:

-- Таны үс цайж эхэлсэн байна гээд үг дуугарахын завдал өгөлгүй хоёр, гурван ширхэг цагаан үс тасалж авлаа.

-- Зовсон будилсан хүний үс цайдаг юм бол минийх цайх болсон гэж Эрдэнэ хэлэв.

-Гэрэл Эрдэнийг ажиглан хэсэг дуугүй сууна. Өргөн магнайд нь хоёрын зэрэг үрчлээ буй болсон нь Эрдэнийг улам ч сайхан болгосон мэт санагдав.

-- Довчин юу хийж байна даа?

Гэрэл Довчингийн цагаантантай нийлж байгааг зэмлэн яриад:

-- Миний бодоход яг л гаминтай адил дээрэмчид бололтой гэж хэлэв.

Гэрэлийн энэ үгнээс гогцоодож аваад Эрдэнэ, цагаантан бол монголыг дээрэмдэхээр ирсэн

зандалчид гэдгийг ярьснаар барахгвй эднийг хөөх хвч бий болж байгаа. Тэр хвчинд монгол хвн бvхэн туслах хэрэгтэй гэж ярилаа. Хvвхэн баахан дуугвй бодол болон сууснаа:

-- Над шиг нь юугаар туслах билээ дээ гэжээ.

-- Ардын нам байгуулагдаад, Хиагтад байсан гаминг хөөж ардын тvр засгийн газар байгуулагдсаныг ,чи, сонссон уу?

-- Довчингийн ярьж байхыг сонссон. Бурхан шашингвй айхтар л улс гэнэ билээ.

-- Тийм биш Гэрэл минь би тэр намын хвн шvв дээ. Бас Даржаа баатар тэнд буй гээд Эрдэнэ Гэрэл рvв ширтэв.

-- Үнэн vв?

-- Би чамд худал хэлэхгвй.

-- Тийм дээ. Та худал хэлэхгвй байх аа гээд Гэрэл

санаа алдсанаа, Довчинд ардын намын хвн гэдгээ мэдэгдвэл амьгвй гэсэн vг шvв дээ гэлээ.

-- Тvвнийг би сайн мэднэ. Харин чи нэг тус болохгвй юу?

-- Юугаар?

-- Довчинд нэг чухал бичиг байдаг юм. Тvвнийг бидэнд олж өгвөл vлэмж тус болох байна.

-- Би ямар бичиг мэдэх биш. Олон л бичиг байдаг юм.

-- Хоёул хамт vзье. Гэрэл хариу дуугарсангвй нэлээд сууснаа босож, «Таны төлөө би юу хийхээс ч буцахгвй» гэлээ.

- Гэрэл минь зөвхөн миний төлөө биш. Зовсон монгол орны төлөө юм шvв.

-- Би л таны төлөө гэж хийе. Харин та хэний төлөө гэж хийхээ өөрөө мэд гээд Эрдэнэтэй хамт Довчингийн бичиг сэлтийг нэгжин vзсэн боловч хэрэгтэй юмаа олсонгвй.

-- Өөрөө нэг хавтастай бичгээс огт салдаггвй. Тvвнд л байгаа байх даа.

Орой болж хоол идэж байтал Довчин орж ирээд Эрдэнийг хармагц царай нь барсхийгээд «Аа Эрдэнэ хаанаас гараад ирдэг билээ?» гэж асуув.

Эрдэнэ «гаминд баригдаж хатуу ажил хийсээр Бароны цэргийн ачаар суллагдаж ирсэн» гэж яриу. Довчин Эрдэнийн энэ vгэнд vнэмшсэнгвй. Харин тvвнийг сэжиглэж байлаа. Гэхдээ айгаад яах аргаа олохгвй дэмий л элдвийг асуун байцааж байв. «Хэрэв энэ Эрдэнэ улааны тагнуул бол намайг хөдөлбөл барьж аваад яаж ч магад» Үвний чадал хайнагийн шар шиг. Юу ч гэсэн ингээд л сууж байя. Нэг учир нь олодох байх» гэж дотроо бодлоо.

Орны толгойн жижиг ширээн дээр тавьсан хавтастай бичиг Эрдэнийн нvдэнд байн, байн тусавч Эрдэнэ сэжиг авахуулахгвйг хичээн байлаа. Довчинг хvлж орхиод хавтсыг vзэж болох мэт. Гэтэл уул бичиг байхгвй бол ямар ч ашиггвйгээр барахгвй хор болно гэж Эрдэнэ тvмэн зvйлийн юм бодож байв.

Гэрэл айраг авчруулахаар гарахад Довчин Эрдэнийг хулгай нvдээр ажиглаж байснаа:

-- Эрдэнэ минь чи бид хоёр гэмгвй явсан шvв дээ гэлээ.

-- Та намайг хардаад байна уу даа гэж Эрдэнэ тайван хэлэв.

-- «Улааныхан гэдэг чинь намрын зангуу гэсэн vг гээд Бароныхны хвч чадал, мэргэн ухаан ач тусыг магтав.

Гэрэл айраг авчруулав. «Юу ч л гэсэн ноён Сапойллод хэлж vвнийг байцаалгах нь зөв. Гэвч би яаж мэдээ өгөх вэ. Аргалж байгаад нэг гарах уу» гэх зэргээр бодовч чухам хэрхэн гарах арга Довчинд олдсонгвй.

-- Би ганзай халаалгуулсан. Одоо болж байгаа байх. Чи хэлээд авчруул гэж Гэрэлийн хэлэхэд Довчин vг дуугаралгвй босов.

Довчин гараад юуны өмнө нэг зарцдаа бичиг хийж өгөөд Сапойлло руу явуулав. Гэвч энэ хооронд хэрэгтэй бичиг Эрдэнийн өвөрт орсноор барахгвй, хашааны хаалга дуугаран хэн

нэгэн хvн гарах чимээг Эрдэнэ сонсов.

-- Довчин хvн явуулав бололтой гэж Эрдэнийн хэлэхэд Гэрэл дуугаралгvй гvйн гарснаа удалгvй буцаж ирээд.

-- Тийм бололтой. Морь нь байхгvй байна гэлээ.

-- Одоо би явахгvй бол болохгvй гээд Эрдэнэ хөдлөх гэтэл Гэрэл ойртон ирж нүднээс нь нулимс ундрал гарч:

-- Намайг нэг ч болсон vнсээч гэлээ.

-- Чиний тусыг мартагvй гээд Эрдэнэ Гэрэлийг чанга тэврэн авч уруул дээр нь vнсээд

-- Би амьд мэнд ирвэл уулзана гээд гарлаа.

- Би таныг хvлээе гээд Гэрэл хоцров,

Гэрэлийн царай баяр жаргалаа багтааж ядан, хацар нь улайран сэтгэл нь догдлон байлаа.

Гэвч тvвний энэ жаргал удсангvй. Довчинг гэртээ ороход Эрдэнэ хашаа даван vгvй болов.

-- Эрдэнэ хаачаа вэ?

-- Мэдэхгvй гараад л явсан

Довчин ийш тийш ажиглан харснаа хавтас руугаа гvйн очиж вээд:

-- Уухай чи төрийн дайсантай нэгдэж миний чухал юмыг хулгайлна бий гээд Гэрэлд ойртон очиж:

-- Бичиг яасан бэ?

-- Мэдэхгvй. Чиний бичгийг би хадгалж байсан биш.

-- Тийм бий. Хар янхан гээд Довчин хашгирав.

-- Чиний хажууд хэлдэг чинь байхаас өөр хэн байх вэ. Янханд дарлуулж суусан хохь чинь гээд Гэрэл хорсолтой бөгөөд жигшилтэйгээр чанга инээв.

-- Өлөгчин чамайг Сапойллогийн гарт өгч арьс махаар, чинь хэлvүлнэ дээ.

-- Тvүнээс чинь өмнө! гээд Гэрэл тавагтай махан дээр байсан vйсэн иштэй хутгыг авч Довчин руу, хавханд орсон чоно алахаар ирсэн хvнийг харж байгаа нүдээр ширтэн ойртов.

-- Yгvй Гэрэл ээ. Чи галзуурав уу? гээд Довчин гэдрэг ухарч байснаа гэнэт ширээ авч хутгатай гар руу, нь цохилоо.

Гэрэл хутгаа алдаад дахин авах гэтэл Довчин барьж авлаа. Хашир Довчин хvнд биеэрээ Гэрэлийг дарж авсан боловч хөдөлгөхгvй болгож чадаагvй учир хэсэг ноцолдов. Yүд нээгдэж Бароны дөрвөн цэрэг орж ирлээ.

-- Энэ өлөгчин эмийг барь. Улааны оргодолтой нийлж намайг алах гэлээ. Аваачиж байгаад махыг нь урахад улааны тагнуулынхаа хаана байгааг хэлэхгvй яахав гэж Довчин амьсгаадан байж хэлэв.

Гэрэлийг хоёр цэрэг чирээд гарахад «муу шивэгчин гичий хоолыг минь идэж идчихээд алах нь байна шvү. Ёх гэж магнайнаа хөлсийг арчин амьсгаадаж байлаа.

Гурван өдрийн дараа тамлан эрвүдэвч юу ч хэлэхгvй байсан Гэрэлийг цагаантан улааны тагнуул гэсэн пайз цээжин дээр нь зvүгээд их чөлөөнд дvүжлэн алжээ.

Шөнө Эрдэнэ хvрээний хувьсгалчтай хамтран Гэрэлийн хvүрийг авч маргааш өглөө нь далан давхрын нэгэн жалганд оршуулав.

Гэрэлийг гар дээрээ өргөөд явж байхад тvвний «би таны төлөө гэж хийе» гээд харж байх шиг санагдаж хөхөрсөн уруул нь хөдлөх мэт болж байлаа.

Гэрэлийг оршуулаад босох гэснээ Эрдэнийн нүд харанхуйлан, бvх биеийн чадал нь алдраад дайвахад нөхөд нь тvшиж авлаа.

Өөрийн нь төлөө ямар ч баатарлаг vйл бvтээхээс буцахгvй байсан энэ аварга хvний нандин хайрыг бvрэн ойлгоогvй байснаа санах тутам гашуудал нь их болж өмнөх замаа харахгvй

мэгдчин явлаа.

Тэдний дээгүүр хоёр хар хэрээ гуаглан хөөцөлдөж өнгөрөхөд Эрдэнэ нүдээ дахин аньж хажуугийн нөхрөөс түвшин авахад бүх бие нь чичирч байв.

Уужим талбай байвч  
Устай намгийг нь мэдээрэй.  
Учирсан амраг байвч  
Ухаан сэтгэлийг нь таниарай,  
(Ардын дуу)

Сайр шандын усыг  
Шавхаад шавхаад барахгвй.  
Сайн хүний үрийг  
Дараад дараад дийлэхгвй.  
(Ардын дуу)

Жороо баахан улааныг  
Жолоогий нь дөмөөд мордоорой  
Зорьсон газар холхон шүү  
Зоригоо битгий мохоорой.  
(Ардын дуу)

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### I

Хүрээний хойт талаас орж төмөрчний захаар нэвтрэн гарсан баруун Сэлбийн гол байгаагвй бол хүрээний хогийг Туулд хэн хүргэж өгөх байсан бол доо? Энэ гол верлээгвй цагтаа хуурай сайр байвч верлэх бүрдээ савнаасаа хальж хамар шархируулсан эхүүн үнэр ханхлуулан түмэн зүйлийн новш тээвэрлэн улаанаар эргэлдэнэ.

Үдшийн бүрий харанхуй хүрээг нөмөрсөн зуны нэг орой баруун Сэлбийн голын хуурай сайр, зүүн хүрээнээс гарч хорооны зах руу орсон зааг дээр барьсан Жадарын гүүр гэгч улаан зосон будаг нь хуучран цайвар ягаан болсон модон гүүрийг чиглэн нэг хүн бүртгэлзэн гвйнэ.

Үүрэглэж эхэлсэн хүрээ рүү Чингэлт уулын зүгээс сэргүүн салхи тасалдан үлээж түг түмэн нохойн өнгө бүрийн хөгөөр хуцах тасралтгвй дуу чих базлан яншина. Хэрэв энэ дуу байхгвйсэн бол хүрээ шөнийн цагт эзэнгвй хуучин балгастай яг адил байх сан. Шөнө цагийн нохойн дуу унтсан хүрээний амьд байгаагийн тэмдэг зүрхний нь цохилт байлаа. Нөгөө хүн шууд явсаар хуурай сайрын хайрга чулууг шажигнуулан гүүрийн доогуур ороод хэд алхтал цагираглан хэвтсэн нохой дээр гишгэж давхийн цочиж гэдрэг болов. Нойрон дундаа гэнэт гишгүүлсэн нохой ч айхын ихээр айсан бололтой сүүл хавчин гасалж зайлав. Гүүрийн дор харанхуй бөгөөд шивтэр даасан гашилмал чийг үнэртэнэ. Сэлбэ верлээгвй цагт энэ гүүрийн дор орон гэргвй хүмүүс нохойтой хутгалдан хорогдоно. Хэрэв догшин урсгал нь шуугин ирдэг верийн ус арчиж цэвэрлэдэггвй бол энэ гүүрийн доороос юу эс гарах билээ.

Гүүрийн баруун зүүрийг тулсан эрэгний ёроолоос «Бат уу?» хэмээн асуух нойрмог сулхан дуу гарлаа. Энэ дууны эзэн бол Заяын хүрээний гуйлгачин хүү Жаргал байлаа. Одоо арван найман нас хүрсэн Жаргалын ганц эх нь хоёр жилийн өмнө нас барж өнчрөөд жинчин дагаж Богдын хүрээнд ирээд айлд зарагдаж билээ. Гэтэл өнгөрсөн хавар хоёр гангар шаазан аяга хагалснаас болж хөөгдөн Жадарын гүүрээр шөнийн гэрээ хийдэг болжээ.

Сар гаруйн өмнө Бат, Жаргал хоёр учирч билээ. Чингэхдээ Заяын хүрээний өшөө хонзонг санах нь битгий хэл, олон жил салж сарнисан ах дүү гэнт уулзсан юм шиг баяр хөөр болон бараг л уйлах шахжээ. Анги Эрэнчинг нас барснаас хойш Бат ганданг орхиж хүрээний золбин хүүхэдтэй нийлжээ. Богдын хүрээний гүжир амьдралын хвчтэй верийн аймшигт долгионд цохигдон урсаж явахдаа гар гараасаа барилцаж авсанд энэ хоёр бие биендээ түшиг болон, өдөр нь мах хүргэх, айлын хашааны хог цэвэрлэх зэрэг хар бор ажил хийж шөнө нь энд хононо. Одоо ч яахав ирж байгаа дулаан цаг болохоор өдөр, шөнө ээлжлэн өнгөрч л байлаа. Харин өвөл болоход уранхай дээл, маажгий гуталтай энэ хоёр хүн яаж амьдрах бол доо. Гэвч эдэнд өвлийн тухай бодох чадал ч, хүсэл ч байсангүй ажээ. Амьдралын хүнд ачаанд дарагдсан энэ хоёр амьтан өвөлтэй золгохыг бодохоос ирэх өдрийн өглөөтэй яаж золгохоо бодох нь чухал байлаа.

- Тиймээ. Би байна. Яасан зэвүүн шөнө вэ? гэж нохой гишгэснээс цочсон Бат чичрэн тасалдсан дуугаар хариулав.

- Байранд чинь нөгөө шар жингэр байгаа шүү.

- Харин гишгэж орхилоо.

- Хэд дахин хөөгөөд яваагүй юмаа, өнөөдөр олз омогтой юу? гэж Жаргал асуух зуур шуухитнан хөдөлж хэвтрээ засав.

- Амбан хааны хороонд нэг хонины мах хүргэж гурван мөнгө, Даригангын хороонд хоёр иргэний мундаг мах арай гэж хүргээд найман мөнгө олсон. Амбан хааны хорооны айлын авгай овоо зантай юм. Нэг ул боов өгсөн. Бас будаатай хоол хоёр аягыг идлээ. Ул боовоо хоёулаа хуваагаад гүвдэж орхиё гээд Бат өврөөсөө боовоо гаргахад идэх юмны сураг сонссон Жаргал дэргэд нь хэдийн иржээ.

- Аятайхан амттай юм байна гэж Жаргал боовыг тачигнуулан идэх зуур хэлээд хэвтрийнхээ зүг эргэв. Бат унтдаг байраа эзлэн тавтай сууж боовоо идлээ. «Талийгаач багш минь, өглөө бүхэн шар тосонд чанасан зэс шиг хүрэн зөөлхөн дугуй өмнө минь тавиад л за гэвш минь бор ходоодоо божийтол цохиод байдаг хэрэг ээ гэдэгсэн» гээд зогисов.

- Чи үргэлж л багшаа ярьж байх юм даа. Ганц аяга халуун цай уух юмсан. Ижий минь байхдаа гуйж ирсэн юмны минь аль олигтойг аяганд хөшиглөж, халуун хар цай хийгээд өгдөгсөн гээд Жаргал шүлсээ залгиж дуугүй болов.

- Аавтайгаа уулзах юмсан. Сайхан цагаан морьтой энэ хойшоо давхиад явчихсан юм даа.

- Чи буруу хүн харсан байлгүй дээ.

- Хаанаас даа. Очиж, очиж аавыгаа буруу таних гэж юу гэсэн үг вэ.

- Надад ч уулзах, хүсэх хүн байхгүй болохоор амар ч юм уу даа.

- Тийм ч бишдээ. Аав, ижий хоёроо бодож байхад сэтгэл минь нэг л аятайхан байдаг юм. Би ч удахгүй уулзана гэж итгэдэг шүү.

- Үзээгүй юмыг юу ч гэж маргах вэ. За унтъя. Хоёр залуу байр байрандаа цагираглан хэвтлээ. Гэвч Батын нойр хулжаад унтаж чадсангүй. Түүнд бодож санах юм бишгүй байлаа. Эцэг, эхтэйгээ хамт өнгөрүүлсэн амьдрал нь эргэлдэн хувирч байснаа анги Эрэнчингийн тухай бодол болон хувираад дараа нь Хонгорт шилжив. Үүгээр дамжин урьд өмнө огт бодогдож байгаагүй шинэ бодол сэтгэлийг нь эзэмдэв.

Итгэлтийн охин Солонгын тухай бодол сэтгэлд нь зөөлөн уянга дүүргэж жихүүн шөнө, өлөсгөлөн гэдсийг нь мартагнуулан ертөнцийн хамаг муу муухай бүхэн зайлан, торгон хөнжилтэй, зөөлөн оронд сайхан зүүд зүүдлээд инээмсэглэн унтаж байгаа баян хүний эрх хүүхэд шиг байж билээ. Сайхан бодолд тэжээгдэн хэсэг байснаа санаа алдаад «Баян хүний хангал охины тухай над шиг хүн бодоод ч яах билээ дээ» гэж гомдолтой шивнээд хэвтрээ

засав.

Шөнө дундаас хойш гvн нойронд дарагдан унтжээ. Нэг сэрвэл нар гарсан бөгөөд чихний өмнө урьд өмнө огт сонсогдоогvй олон зvйл хөгтэй хөгжим дуулдана. Нvдээ анивчин өндийж харвал Жаргал нь өглөөний дулаанд бие нь тавиран дvнгэнэтэл хухирч байлаа. Босож суниах гэснээ толгойгоо гvүрний хөндлөвч модонд цохиж ярвайв. Чингээд бөхийн очиж Жаргалыг дуудаж сэрээгээд хоёулаа тарвага шиг мяраан гарч чагнавал баруун хойш хачин жигтэй дуу гарах ажээ.

- Юуны дуу вэ?

- Бvү мэд гээд Бат толгойгоо сэгсрэв.

Үл мэдэгдэх дуу гарч байгаа зvг морьтой явган хvмvvc цувран явааг харахад тэнд ер бусын сонин явдал болж байгаа юм шиг санагдаад мань хоёр тэсэлгvй гvйв. Явсаар хятадын өргөн чөлөөнд орвол өмнөөс нь зэрэгцэн олон морьтой хvн гарч ирлээ. Цувран яваа энэ хvмvvcийг хvрээнийхэн гудамжны хоёр талаар эгнэн зогсоод харцгаана. Морьтой хvмvvc бvгд буу vүрч, зvүснийг бодвол цэрэг эрс ажээ. Өнгө бvүрийн дээлтэй, зvсэн бvүрийн морь унасан энэ хvмvvcийн өмнө ижилхэн бор морьтой хоёр хvн улаан шар туг барьсан нь зөөлөн салхинд намилзан сvртэй бөгөөд vзэсгэлэнтэй ажээ. Энэ бол Богдын хvрээг эзэлж байгаа ардын журамт цэрэг байлаа.

Гудамжинд зогсоод харж байгаа хvмvvc цэргийн дотор таних хvмvvcээ харахдаа баярлан нэрийг нь дуудна. Цэргvүд ч хvмvvcийн дунд таних хvмvvcээ хайн, олбол ялсан цэргийн эрхэмсэг баярыг инээсэн нvдээр буюу толгой дохин дэвшvүлнэ.

Тvмэн зовлонд нэрвэгдэж, дуртай бvхэнд доромжлогдсон эх орноо чөлөөлөх их хэргээ бvтээсний цаглашгvй баяр, бахдал энэ хvмvvcийн нар салхинд борлосон нvүрний ширхэг бvхэнд гэрэлтэн vнэхээр цог жавхлан төгөлдөр ажээ.

- Та нар хараач! Гаминд бууж өгч байхад манай цэргийн хурдан буу хvртэл эгээл зэвэрсэн царил шиг харагдаж байсан. Гэтэл одоо эдний ташуур нь хvртэл наранд гялалзан тоглоод сvртэй байна хөөрхий.

- Улс сэргэж, vндэс угсаа өндийнө гэдэг энэ дээ хөө гэлцэх олны дуунд нэмэрлэж

- Богдын минь аврал-гэж тэдний дунд зогсож байсан Чулуун занги хэлээд сахлаа ихэмсгээр шувтрав.

Тvүнээс нилээд зайтай зогсож байсан Автономитын сангийн яамны тvшмэл агсан Шарав, Чулууны vгэнд цочин эргэн харснаа «завхай тvүд манай монголд гамшиг зовлон хоёроос өөр юу л гялайлгаж байлаа даа» гэж амандаа шивэгнэв.

Хоёр тугийн дараа сагсалзсан дэлтэй өндөр цомбон биетэй, өргөн ташаатай ухаа хонгор морьтой Сvхбаатар жанжин нэг гараараа жолоо цулбуураа хумин атгаж, нөгөө гараараа ташаагаа тулан гvн бодолд дарагдан явна.

- Гоймон баатар гэж олны дунд нэг хvн дуу алдав.

- Юуны чинь гоймон. Ардын журамт цэргийн их жанжин Сvхбаатар байхгvй юу.

- Эр цэргийн эрдэмд нэвтэрхий, хатан зоригтой хvн гэнэ билээ.

- Манай монголын заяагаар тодорсон хvн дээ.

- Цагаа болоход төр самуурч, цагаа болоход тvвшин болно гэдэг юм даа. Одоо нэг олны зовлон, цаг төрийн вймээн арилж тонилох байлгvй дээ гэж Чулуун занги бvдvүн дуугаар хэлээд хоолойгоо намбатай заслаа.

- Манай монголчууд тэвчиж, тэвчиж нэг хөдөлбөл яг л их мөрний вер шиг тохиолдсон бvхнийг дэлбэ татан гардаг улс гэдэг шvү. Ялангуяа цусаа vзэх дээр ч буцах гэдгийг мартаж орхидог гэнэ билээ.



Цугларсан олон, ардын журамт цэргийн сүр жавхаа, унасан морь, хэрэглэсэн зэвсгийн тухай магтан ярилцах нь холоос сонсвол их мөрний нүсэр шуугиан мэт ажээ.

Өгөөмөр зуны өглөөний нар бүхнийг сэргээн гийгүүлж торойх ч үүлгвй цэнхэр тэнгэр ивээсэн хүрээ дэлбээ нь шинэхэн дэлгэсэн хаврын хөх яргуй шиг бөгөөд амирлангуй тайван ажээ.

Сүхбаатарт жилийн өмнө гаминд эзлэгдсэн хүрээндээ оргон гарч, эх орон, ард олноо түмэн зовлон мянган гашуунаас аврах их хүсэл эрмэлзлийг өвөрлөн умрыг зорьж явсан нь бодогдоно. Тэр цагийн хэцүү хатууг бодох тусам бүтээсэн үйл хэргийг нь гайхамшиг улам тодрох бөгөөд явахад нь гаслан шаналж байсан хүрээ одоо инээн баясаж байна.

Олны шуугиан оволзож, баярын мишээл тодорсон хүрээ, шаналан байж гаргасан хүүхдийнхээ энхрий дууг сонссон залуу эх шиг байлаа. Жилийн өмнө харанхуй шөнө, харийн дайсны мөрдлөгөөс зайлан явахдаа Сүхбаатар инээж баяссан хүрээнд эргэж ирэхэд итгэж тэр өдрийн хэмжээлшгвй баярын тухай бодож байсан. Гэтэл одоо тэр өдөр ирээд байхад хүсэл, эрмэлзлэл нь дуусагвй.

Сүүлийн хэдэн сарын дотор улс оронд үлэмж хвчтэй шуурга болж бүхнийг нухчин дарж байсан хар үүл сарнин, тэнгэр цэлмэв. Энэхэн ахар хугацаанд Сүхбаатарын амьдралд их юм болж өнгөрчээ. Партизан цэргийг цуглуулж, ширүүн тэмцэлд бэлтгэж байхдаа үсээ хусуулж билээ. Нилээд ургасан үсийг нь хурц тонгоргоор шир шир хусаж байсан хөгшин хар хүн «ганц ч цагаан үс байхгвй, ёстой л нэг залуу хүний үс байна даа» гэж байсан. Хиагтыг эзэлсний дараах өдөр үсээ бас хусуулахад «Жанжны тэргүүнд хэдэн цагаан үстэй юмаа» гэхийг сонссон.

Хиагтад үүрлэсэн гаминг дөтийн замаар тоннилгоод утасны хорооны жижигхэн шавар байшинд орж «дэлхий дахинд тунхаглан зарлах нь: Монгол орон тусгаар улс болов. Улс гүрэн бүхэнтэй найрсаг холбоо тогтоохыг шинэ монгол хүснэ» гэж амьсгаадан байж зарлаад гарч ирэхэд ухаа хонгор морийг нь бариад хүлээж байсан партизан «Жанжин аа таны нүдэнд юм орчихоо юу?» гэж асуухад.

- Тийм. Баярын од харвасан гээд том шүдээ яралзуулан инээснээ шууд мордож баруун гүвээ өөд мориныхоо хурдаар гарч Тужийн нарсны зүг удтал ширтэн зогсож билээ. Бие хамгаалагч партизан дэргэд нь очиход «шинэ монгол улсын өрхийг бид татлаа. Одоо улс гэрийг төвхнүүлэх цаг ирэв» гэж хэлэв.

Хэдэн зуун жилийн турш монгол орон бусдын боол болж үндэс угсаа сөнөхөд хүрч байлаа. Шившигт доромжлолоос улс үндсээ чөлөөлөх гэж боссон олон зоригт эр алтан амиа алдсан түүхтэй. Гэтэл тэр баатар эрчүүдийн ариун хүсэл, мөрөөдөл биелэгдэв гэж бодоход Сүхбаатарын сэтгэл баяр бахдалын галаар буцлан байлаа. Гаминг ялж хиагтаас үлдэн хөөгөөд сэлээдийнхээ амыг үлээн хуйд нь хийж байхад түмэн хүсэл биелэгдсэн юм шиг бодогдож байж билээ. Сүхбаатар монгол орны төлөө, түүний дайсантай тулалдах гэж цавчиж, буудаж сурсан. Хий буудахгвй, хоосон цавчихгвйн эрдмийг сурсан нь талаар өнгөрсөнгвй. Гэтэл шинэ улс гэрийг байгуулахад цавчиж, буудахаас өөр олон зүйлийн эрдэм хэрэгтэй ажээ. Монгол гэрт гэрэл оруулахгвйн тулд өрхний оосроос зуурч байсан дайсны гарыг цавчсан. Одоо өрхийг татаж гэрэл оруулсан тэр гэрийнхээ юмыг төвхнүүлэх ёстой болов. Доторхи юм нь зуун задгай, жаран хагархай гэрээ тохижуулах гэсэн монгол хүн тусгаар орон болсноо ертөнц дахинд чанга дуугаар бахархалтай зарлажээ. Гэтэл Зөвлөлт Орос улсаас өөр орон тоомсорлон хариу өгсөнгвй. Энэ бол шинэ гэрээ хоёр гараараа төвхнүүлэх ажилд нь зүйл бүрийн саад учруулна гэсэн үг. Энэ учраас сэлмээ хуйд нь хийлгвй, буугаа сумлаж нэг гартаа бариад, нөгөө гараараа ажлаа хийх хэрэгтэй ажээ.

Сүхбаатар бол энгийн нэгэн цэргийн эр байж билээ. Гэтэл одоо шинэ тогтож байгаа улсын бүх цэргийн жанжин, шинэ монгол улсыг байгуулах их хэргийг удирдах үлэмж үүрэг оногджээ. Урьд бодож байгаагүй юмыг бодож олох, шийдэж байгаагүй юмыг шийдэх, юм бүхнийг төр улсын өмнөөс харах ёстой болжээ.

Бас нэг нарийн зүйл бол Богдын тухай асуудал байлаа. Богд гамин, баронтай нийлж монгол оронд түмэн зовлон учруулсан. Богдоос болж эдэлсэн зовлонг тооловч баршгүй. Үүнийг нь бодоход Богдыг устгах хэрэгтэй. Гэтэл энэ урвагчийг шууд устгаж болохгүй байлаа. Олон түмэн Богдод бишрэх сохор итгэл гүн байсан цагт түүнтэй халз тулж бас л болохгүй.

Богдын элчийг очоод байхад нутгийн ардууд бөөн бөөнөөр мөргөж өдий төдий өргөл барьц өгсөн. Ардын журамт цэргийг Богдын төлөөлөгч угтаж Сүхбаатар жанжинд Богд урт гар хадаг барьсан гэнэ гэдэг энэхэн хооронд дэлгэрсэн яриа нь ардын засгийг дэмжих хүчийг улам зузаан болгож байгаа нь илт байлаа.

Богдоос ирүүлсэн бичгийг цэргүүд дахин уншиж өгөхөд нүдээ анин залбиран сонсож дуусахад нь «Богд Жавзандамбын мэлмий бат орших болтугай» гэж олон хүн хашгирчээ. Богд бол үлэмж хүчтэй дайсан юм. Үүнийг Гамин, Барон шиг зэр зэвсгийн хүчээр дайран устгаж болохгүй. Гамин Барон бол монголын биед шигдсэн хувалз байсан болохоор тэдгээрийг чимхэн авч хага дэвсэх ёстой. Харин Богд шарын шашин бол бугласан хатиг байлаа. Үүнийг шууд авч хаях гэвэл сэдэрч хавдах аюултай болохоор анхааралтай хандаж, гэрий нь ул үндэстэй нь цэвэрлэх хэрэгтэй юм.

Энэ бүх бодол Сүхбаатарын сэтгэлийг эзэлж өмнө нь түмэн зүйлийн «яах вэ» гэдэг асуудал тавина.

Бат Жаргал хоёр цэргийн цувааг нүд салгахгүй ширтэн «түүнийг хараач!», «үүнийг хараач» гэж бие биеэ угзарна.

- Энэ хонгор морь лав хурдан морь доо.
- Яагаад? гэж Жаргал нэг л их сонирхохгүй асуув,
- Тэр ташаа, борви нь

Жаргалд морь сонирхох дур хүсэл огт байсангүй. Дургүйн учир бол цэргүүдийн үүрсэн буу, зүүсэн сэлэм, өмссөн хувцас хунар зэрэг нь ямарч мориноос илүү сонин байлаа. Хүсэлгүйн учир бол бүх насандаа морь бараг унаж үзээгүй болохоор юугий нь харж гайхах билээ.

Монгол цэргийн цуваа дуусаж орос цэргийн цуваа эхлэв. Гамин, Бароны зандалчин нарын хөлд доромжлогдон гасалж, үндэс угсаа сүйрэхэд хүрсэн монгол орон үхэх сэхэхээ үзэх ширүүн тэмцэлд босоход Зөвлөлт орон, түүний улаан арми ах дүүгийн тусламж үзүүлэв. Эдний тусламж байгаагүй бол хүч давуу, зэвсэг ихтэй улайрсан дээрэмчидтэй тэмцэх нь үлэмж хүчирхэг хэрэг байлаа. Энэ ч учраас монголын ардын түр засгийн газрын хүсэлтээр зөвлөлтийн улаан арми хүрээг эзлэхэд хамт оролцов.

Орос цэргийн тэргүүнд нь яваа дөрвөн том хүрэн морьтой хүний үлээж байгаа шар бүрээ өглөөний наранд гялалзан түүнээс цацарсан хурц гэрэл жирвэлзэн тоглоно. Орос цэргийг хармагц Батын нүүрэнд бөөгнөрч байсан сонирхол задран сарниж айх эмээх туяа зангиран, хүн дүүжилж, бууддаг цагаан цэрэг нүдэнд нь харагдан «цагаан цэрэг байна. Ум хумгүй дүүжилдэг юм шүү» гэж шивэгнэн мэдэмхий хэлээд Жаргалыг угзран «түргэн зугтъя!» гэлээ. Гэтэл олон янзын сонин хачин бүрээ, бас хачин гээчийн төмөр хэнгэрэг цохиж зүйл бүрийн аялгуу үүсгэн яваа хачин дүрстэй хүнийг харсан Жаргал үг сонсох ухаангүй байлаа.

- Хүүе. Зайлъя гээд Бат дахин угзархад Жаргал эргэж:
- Өвгөөн тэр хоёр том бүрээг хараач. Хүний биеийг эгээл могой шиг ороосон юм билээ.
- Юуны чинь бүрээ. Цаадуул чинь барьж аваад дүүж.. гэснээ Бат дуугаа тасалж нүд нь өндөр

хүрэн морьтой хvн дээр тусан гөлөрч ам нь өөрийн эрхгvй: «Алиа Петр гуай!» гэж чанга бөгөөд огцом хашгирав.

Хүрэн морьтой Петр олныг тойруулан харснаа Батыг олж харахын вeд Бат дахин « Алиа Петр гуай» гэж хашгирав.

Петр морины амыг залан жагсаалаас гарч Батын зvг амаа ангайн инээмсэглэн ирлээ. Өөрийг нь чиглэн ирж байгаа оросоос зэвvүцсэн Жаргал гэдрэгээ ухрав. Бароны аймшигт цэргийн хөлд дайрагдаж хаширсан хvмvүс ч гудамж гарган ярагдав. Ингээд ганц Бат олноос тасран vлджээ.

Петр мориноос vсрэн бууж Батын гараас барин:

— Чи Бат байна. Би таньж байна гээд vнсэв.

— Тийм. Би Бат байна.

Амьдралын хатуу ачаанд нуруугаа нухлуулсан Бат багын таних хvнтэй дайралдсандаа эцэг, эхтэйгээ уулзсан юм шиг баярлаж нvүрэнд нь инээх уйлах хослов.

-- Ижий нь хаана байна вэ? гээд Петр олны зvг Долгорыг олох гэж нvдээ эргvүлэн харлаа.

Петр Бат хоёрын дотно уулзалтыг харсан хvмvүс сонирхон ойртлоо.

-- Зайлуул хvү нь бололтой гэж олны дундаас нэг авгай сөөнгөтсөн өрөвдөлтэй дуугаар хэлэхэд:

-- Адилгvй юм байна. Монгол хvүхэд байна шvү дээ, гэж дэргэд нь байсан хижээл хар хvн vг сөрөв.

-- Ижий нь хаана байна гэнэ шvү. Ямар монголжуу орос вэ? гэж авгай хэлэв.

— Ижийг мэдэхгvй. Хvрээнд аавыг эрж ганцаараа ирсэн.

-- Хэлээгvй юв. Хvү нь байна. Эрлийз хvүхэд алийг тэр гэх вэ. Хөөрхий! гээд авгай бvр ойртож очлоо.

Петр Батыг ажиглан харснаа нvдэнд нь гvн бодол зурвас гунигийн аль нэгэн нь тодрон шинелийнхээ халааснаас хатсан жижигхэн талх гаргаж өгөв.

— Yүнийг ид!

— Зvгээр Петр гуай.

-- Зvгээр биш. Нvд чинь хоол идье гээд байна гээд чанга дуугаар зориуд инээв.

Батын өлсгөлөн гэдгийг хоржигнох авиагаар нь Петр амархан мэджээ. чингээд өглөө идээд vлдэхэд нь өвөртөө хийсэн жижигхэн талхаа өгөв.

Бат талхнаас нэг хазаж зажилснаа эргэн харж энэ хооронд зайлан холдож амжсан Жаргалаа дуудаж vлдсэн хэсгээ өгөв.

Орос цэрэг юм өгөхийг хэдий нь харсан хvүхдvүд ойртон очиход Петр өврөөсөө том домбон ёотон гарган сэлмээ сугалав.

Та минь цавчих нь гэж нэг хvн сандрэн хэлээд зайлахад ойртож байсан хvмvүс эгшиг зуур ярагдав.

Петр хөгжилтэй инээмсэглэн олныг тойруулан харснаа сэлэмнийхээ мөрөөр домбон ёотонг хагалж сэлмээ хуйлав. Хамгийн томыг Батад өгөөд нэг хэсгийг холдож амжсан Жаргал руу барьж «май» гэхэд уг явдлын vнэн учрыг ойлгосон олон дахин дөхөж ирлээ. Yлдсэн хэдэн хэсгийг бусад хvүхдvүдэд тvгээж өгөөд «дууслаа» гэснээ мэдэгдэн алгаа vрэн цэвэрлэж хянган хамраа угт нь vрчийлгэн марсайн инээмсэглэв.

— Улаан орос танай монголын нөхөр, сайн улс шvү! Гэлээ.

-- Ээ мэдэхгvй. Гамин ч Барон гайхал ч анх орж ирэхдээ нөхөр л гэж байсан, харж л байж больё гэж нэг хvн шивэгнэн хажуугийн хvндээ хэлэв.

-- Хэдэн минутын дараа Петр морио хөтлөн Бат Жаргал хоёрыг дагуулан цэргийн хойноос

явахад хүмүүс санасан бодсоноо ярилцав.

-- Улаан орос чинь идэх юмгвй гуйланчин улс байна билээ. Энэ хоёр жаалыг дагуулж аваачаад зооглочих гэж байгаа байх гэж хүрэн торгон дээлтэй, минжин нударгатай намхан тарган шар хvн хэлэв.

-- Зооглох гэвэл чам шиг арай чөмөгтэйг нь аваачдаг байгаа даа гэж хөдөөний бололтой нэхий дээлтэй хар хvн хэлэхэд олон шуугилдан инээлдэв.

-- Юу ч л гэсэн модоо барьсан улс гэнэ билээ гэж тарган шар мөчөөгөө өгөлгвй хэлэв.

-- Чи хөрөнгий нь тоолж үзсэн хэрэг үү?

-- Тус болохдоо ядуу нь дээр гэдэг дээ.

-- Мэдэмхий эр байх нь гэх зэрэг олон хvн тарган шарыг мохоов.

-- Та нар ингэж л байж энэ оросуудад боорцогныхоо савыг хагалуулна байх даа гэж тарган шар хэгжvүн хэлэв.

-- Юу ч л гэсэн чиний бүдvүн гэдэснээс гарах хийнээс сэжиглээд хагалахгвй. Битгий ай! гэж нөгөө нэхий дээлт хэлэхэд хүмүүс шуугилдан инээж тарган шарын царай нь улайн цааш түргэн алхав.

Заримдаа Бат эцгийнхээ тухай Петрээс сайн сонсож авлаа. Эрдэнэ баруун хойт зvгт байгаа цагааны үлдэгдэлтэй байлдах тусгай ангийн цэрэгтэй явсан ажээ.

-- Эцэгтэй чинь би заавал уулзуулж өгнө. Одоо чи надтай бай гэж Петрын хэлснийг Бат Жаргал хоёр зөвшөөрчээ.

Петрийн анги хот дундуур нэвтлэн Улиастайн аманд майхан барьж хуарагнан буусан бөгөөд мань хоёр Петрийн хамт нэг майханд оржээ. Хэдийгээр хэл мэдэхгвй авч удалгвй цэргvүдтэй танилцан, тэдний бууг цэвэрлэх, морьдыг нь арчих услахад тусалдаг болжээ. Хэд хоноход зарим нэгэн орос vг ч мэддэг болов. Тэр хоёр улаан цэргийн хуаранд хөгжилтэй амьдарч том шинель, саравчтай малгай, шөвгөр хар гуталтай болж билээ. Заримдаа улиастайн голын айлуудаар хэсэж андахгвй болсноор барахгвй «номхон борын тэжээмэл хvүхдvүд» гэж нэрлэжээ.

Ингэж айл хэсэхдээ Жаргал нь үлэмж худал ярих бөгөөд Бат хоригловч тус үл болно.

Заримдаа vүнээс болж хэрэлдэн дахин хамт явахгвй гэх боловч маргааш нь бүгдийг мартана.

Өвөлд нь Наймаа хотод өвөлжиж зунд нь Улиастайн голд хэдэн хонь ямаатай зусдаг хоёр хөгшинийд нэг удаа тараг идэхээр очиход гадна нь эмээлтэй сайхан хээр морь сойлттой байлаа. Орвол баруун орон дээр нь цагаан цамцтай, нэг эр цааш харан хэвтэнэ. Гэрийн эзэн өвгөн гадаа хонины хашаа засах бөгөөд авгай нь гэрийн зvүн хоймор юм оёж байлаа.

Авгай босож агар хувинтай тараг тавьж өгөөд Жаргал нэг том аягыг гvүдэж орхиод хоёр дахиа өмнөө тавьж Бароны цэрэгтэй байлдаж явсан, Бароныг хүртэл буудаж шархдуулсан, нисэж яваа шувууг орос ланжуугаар нэг л бууддаг гээд ум хумгвй туйлж гарахад нь Бат хичнээн нудравч тус болсонгвй.

Авгай юмаа оёх зуур «хөөрхий минь» «цогтой л хvү байна даа» «зайлуул, ёстой доо» гэнэ.

Үүнд нь зоригжсон Жаргал өндийж суугаад нүдээ гялалзуулан ярина.

-- Манай энэ нөхөр бол сэлэмний эрдэмд хосгвй хvн. Ёстой л сэлэм гялс, толгой бөндөс гэж цавчина даа. Нэг цавчихдаа гурван толгой бөндийтөл нь аваад тээр тэнд өнхрvүлж орхидог эр дээ. Сэлэм эргvүлж байхад бие нь нэг бөөрөнхий хөх юм л харагддаг. Мөн ч мундаг гэхэд нь Батын нvүр чавга шиг болж

-- Жаргал минь таргаа түргэн идээд явъя гэжээ.

-- Мундаг цавчдаг эр байна даа гээд орон дээр хэвтэж байсан хvн тачигнатал инээгээд эргэв. Хараач, ардын журамт цэрэг хотод орж ирэхэд ухаа хонгор морьтой явсан, гоймон баатар

гэж олны нэрлэж байсан эр байлаа.

-- Яаж эргүүлнэ, цавчина гэнээ гээд Сүхбаатар хөгжилтэй инээмсэглэв.

Сүхбаатар эцэг нь амьд байхдаа үй зайгвй верхэж байсан өвгөнийд амралтын өдрөө ирээд амарч байсан нь тэр билээ.

Жаргал толгойгоо маажин дуугвй болов. Бат идэж байсан аягатай таргаа барин гөлрөв.

Орос цэргийн хугархай саравчтай эрвв малгай үл мэдэг хажуудуулан тавьсан бөгөөд элбэгдэж гэлбийсэн саарал шинельтэй, хэн ч харсан томдсон бахиал гутал гялалзтал арчиж өмссөн хоёр залуу Сүхбаатарын анхаарлыг татлаа. Ер нь хэн ч анхаарлыг татахаар дүрстэй байлаа. Зэрвэс харсан хвн бол хотын хажууд босгодог мануухай гэж андуурмаар хоёр залуу ажиглан зугаатай инээмсэглэж байснаа «Чингээд та хоёр чинь аль газрын цавчигчид билээ» гэж асуув. Мань хоёр хариу дуугарсангвйд Сүхбаатар тавтай гэгч нь суннаснаа «залуу, бароныг буудаж шархдуулснаа яриач дээ» гэлээ.

Бат аягатай таргаа тавьж «явъя» гэж нудран шивэгнэв.

-- Явах болоогвй. Байлдаж цавчиж явснаа ярих дургвй бол хаа байдаг тухайгаа юу хийдгээ ярь л даа гэж Сүхбаатар хэлэв.

-- Хойт номхон борын тэжээмэл хvvхдvvд. Энэ хvv гэж Жаргалыг заагаад

-- Хvний зууж байсан гаансыг vxэр буугаар тас бууддаг юм гэдэг шvv өөрөө эртvvд ярьсан юм гэж хэлэв.

Сүхбаатар нvдээ анивчин хэсэг зуур хvд хvд инээлээ.

-- Та хоёр чинь яагаад орос цэргийн хvvхэд байдаг билээ?

Бат газар шагайн байж учир байдлаа бувтнан ярилаа.

-- Аа Петр комиссар Эрдэнийн хvvг олсон гэж ярьсан чи юм бий. Аавд чинь чиний цавчдаг тухай, сэлэм эргvүлдэг эрдмийг ярина даа гээд том цагаан шvдээ яралзуулан инээв.

Батад орох газар олдохгвй байлаа. Сэтгэлдээ Жаргалыг загнаж «Гайгвй дээ эндээс нэг гарсан цагт» гэж бухимдана.

Жаргал ч авгайг элэг барьж ярьсан чинь болдоггвй хvнд нь мэдэгдэж илрэхийн муугаар илэрсэндээ гэмшин шилээ маажин, нусаа шоржигнотол татна.

— За тэр буудах цавчих ч яамай. Харин аав чинь сайн яваа даа. Ёстой л цагаантай цавчилдаж байгаа гээд Сүхбаатар хоёр хvvхдийг өхөөрдсөн хошин нvдээр харлаа.

-- Аав минь одоо хаана байгаа бол?

-- Ханд чин вангийн хvрэн дээр саяхан очсон. Чи ааваа санаж байна уу?

-- Ааваа их санаж байна гэж Бат нам дуугаар нэрэлхэлгвй внэнээ хэлэв.

-- Аав их санагддаг юм шvv гээд Сүхбаатар гvн санаа алдав. Ард тvмэн эх орноо чөлөөлөх их хэргийг vүсгэн шодож зөвлөлт улсыг зорин явахад нь Сүхбаатарын эцэг хvнд өвчтэй vлдэж билээ. Зорьсон хэргээ бүтээгээд ирэхэд нь амьд хvлээж байна гэж эцэг хvv хоёр итгэж тэр итгэл ба их хэргийн төлөө тэмцлийн зоригоор хагацлын гашууныг эдэлж явсан. Гэтэл хайрт аав нь хvлээж чадсангвй, хальж оджээ. Бат аавынхаа тухай ярих тусам Сүхбаатарын сэтгэлд аав нь орж тодорно.

-- Аавтай байх сайхан юм шvv гээд Сүхбаатар вгээ таслаад хvрэн данх авч цай аягалан уув. Аавынхаа тухай энэ хоёр залууд яримаар санагдаад эхэлсэн боловч вгээ тасалжээ. Учир нь аавтайгаа уулзахыг өдрийн бодол шөнийн зvүд болсон Батын сэтгэл, уулзах итгэлийг эвдэхээс айж билээ.

Нас барсан аавын нь дvр Сүхбаатарын бодлоос салдаггвй бөгөөд аав нь vлэмж бодогдсон вeд тvvний верхдэг байсан энэ өвгөнийд ирж сэтгэлээ зогоодог юм.

-- Эрдэнэ удахгвй дайснаа дарж, дархан цолоо мандуулаад ирнэ дээ.

-- Бас ижий минь яаж явдаг бол доо гээд Бат санаа алдав.

-- Зүгээр дvv минь. Чи ижийтэйгээ ч уулзана.

-- Бат нvдээ алгуур өргөж Сvxбаатар өөд харахад тэр дотоод сэтгэлийн уудам бөгөөд итгэлтэй мишээл бэлэглэв. Сvxбаатарын бvlээн мишээл дөлгөөн харц Батад баяр, учралын туяа болон дамжиж сэтгэлд нь итгэл найдварын гэрэл цацрав. Тогоон дээр хөөрvvлж байсан cvv төвийхөд авгай ухасхийн бослоо.

-- Би гаргаж орхиё гээд Сvxбаатар бариул авч жижигхэн жалавчтай cvvg эрэгнэг дээр тавиад хувинтай таргийг авч хоймор суугаад нэг аягыг идэх зуур «залуучууд идэхгvй юв? Буудах, цавчихад элгэн тараг зvгээр гэдэг» гэлээ.

-- Бид хоёр идсэн гэж Бат нам дуугаар хэлэв.

Сvxбаатар таргаа идэж дуусаад босож орны өмнө байсан хvрэн торгон дээлийг өмсөн өргөн шар бvc дэгжин ороов.

-- Ах аа бид хоёрыг цэрэгтээ авахгvй юв? гэж Жаргал хэлэв.

-- Цэрэгт ороод цавчиж гарах уу? гээд хөгжилтэй инээснээ царай нь гэнэт хувирч төв болоод хэсэг дуугvй болсноо:

-- Дvv нар минь одоо манайд цавчих буудахаас илvv хэрэгтэй юм байна. Тэр бол эрдэм. Та хоёр эрдэмтэй хvн бол, Удахгvй ардын хvvxдэд ном эрдэм заах оюутан багш нарыг сургах танхимд байгуулах гэж байгаа. Та хоёр тэнд ороорой. Петр комиссар ч надад ярьсан юм даг гэлээ.

-- Хvv минь явах уу? гэж Сvxбаатарт хандаж гаднаас орж ирсэн өвгөн асуув.

-- Тийм. Ирэх сайн өдөр чадвал ирнэ.

Хоёр залуу гэрээс гараад явж байхдаа «Чи мөн cvнsgvй залдаг эр юм даа» гэж Бат Жаргалыг зэмлэв.

-- Сvxбаатар жанжин байна гэж хэн бодох вэ дээ. Авгайг элэг бариад л ярьж орхисон хэрэг.

-- Гурван хvний толгой шvv! Аманд чинь яаж багтав аа.

-- Би тав гэх гээд арай хэтэрчих байх гээд гурав гээд зогссон юм шvv.

-- Хэтрэх ч буудахад эхэлсэн л дээ. Юунд хэрэгтэй гэж ингэж хазааргvй юм шиг хадуурч байдаг юм бэ?

-- Гоё худал хэлэх бол амьдралыг чимэглэдэг юм гээд Жаргал цайлган цагаан сэтгэлээр хөгжилтэй инээв.

Майхандаа Петрт болсон явдлаа ярьсанд элгээ хөштөл инээж билээ.

-- Би Сvxбаатар гуайд та хоёрын тухай ярьсан. Та хоёр тэр сургуульд ор. Шинэ улсыг байгуулахад эрдэмтэй хvн олон байх хэрэгтэй гэж Петр хэлжээ.

Хэд хоногийн дараа хоёр залуу сургуульд орох болж цэргvvд шинэ шинель, өмд цамц, гутал өгч хувцаслав.

«Ийм догь хувцастай хvн ч тэнд байхгvй, гайхуулж гарна даа» гэж Жаргал хувцас өмсөж байхдаа бодон хөх инээд нь хvрч байлаа. Цэргийн хvнс авах морин тэргэн дээр сууж морьтой Петрийг дагуулан явах вед ижил дасал болсон цэргvvд гаргаж өгөхөд Батын сэтгэл хагацлын гунигт дарагдан нэг л эвгvй байлаа.

Халуун нар дээрээс төөнөж, бие нь нозоорон дугуйгаар боссон нарийн тоос хамар хорогсоно.

II

Оросын улаан намтай нийлж тусламж авсан ардын намын цэрэг газар бvхэн цагааны цэргийг дийлж Богдын хvрээг эзлээд Богдын эрх ямбыг хязгаарлаж гэдэг мэдээ монгол орон даяар төмөрт хvрсэн цахилгаан цэнэг шиг тарж билээ. Энэ мэдээ Тамирын голын урсгалыг сөрж явсаар Итгэлтийн хотод хvрлээ.

Улааныхан дийлсэн гэнэ гэсэн үг Итгэлтийг анхандаа үлэмжхэн сандруулав. Чингээд алт, мөнгө мэтийн үнэтэй юмаа хадны хонгилд нууж харин малаа яах ч аргагүй байв.

Гэтэл нэг өдөр ардын түр засгийн газраас гаргасан тунхаг бичиг олж аваад өртөө шахам газар давхиж бичигтэй хүнээр уншуулав.

Уул бичигт Итгэлтэд харшлах зүйлгүй мэт ажээ. Гадаадын зэвсэгтэй хүмүүсийг монгол орноос хөөж гаргах тухай дурьдсан нь түүний бодолтой яв цав тохирч байснаас гадна Итгэлт бол ард угсаатай хүн билээ.

Гагцхүү зовох нь: Манай монголын дунд олз ашиг ба зэрэг хэргэмд шуналтай ховдог ноёд муу зальтай ард хааяагүй агаад өөрийн амны баахан ашиг тусыг эрхэм болгож, санаа урван манай монголын газар, ус, улс төр, ард юугаа шууд худалдахаас үл буцна. Эл учрыг бүгдээр мэдэж байгтун гэсэн тунхагийн үг эхэн удаа сонсоход нэг л аягүй авч уншиж өгсөн хүнтэй ярьж, шүүн бодоход өөрт нь падгүй мэт ажээ.

Резухинтэй уулзсан нэгэн явдал буй. Гэвч нэгдүгээрт Итгэлт тэр цагаантан нарт өнчин ишиг ч өгөөгүй, Хоёрдугаарт тэр явдлыг мэдэх хүнгүй. Гуравдугаарт түүнээс болж ардын засагт хор хүрсэнгүй гэж бодогдоно.

Тунхаг бичигт баян ардын бүх хэл хаад ноёдын хөрөнгийг хураана, булаана гэсэг санаа байхгүй бөгөөд бүр ч «гадаадын хэвийн номхон иргэний амь хөрөнгийг батлан хамгаалсугай» гэжээ.

Хэрэв гадаад иргэний хөрөнгийг хамгаалах юм бол өөрийн монголын тэр тусмаа ард угсаатай хүний хөрөнгийг дээрэмдэх ёсгүй.

Итгэлт тэр өдөр дахин явж бас нэг хүнээр уншуулж нилээд ярилцахад урьдахиас өөр бодол төрсөнгүй. Гагцхүү энэ тунхгийг сонсоод шийдсэн зүйл гэвэл Павловын эхнэр, хүүхдээс нь хол явбал дээр ажээ. Павловыг явахад эхнэр, хүүхдүүдийг нь харж байя гэж ам өгсөн нь бодогдов. Тэд нарыг харахгүй байгаад хэзээ нэгэн цагт Павловтай уулзвал хуншгүй юм болно гэж бодогдов. Сүүлийн үед Зая гэгээн Павловын охиноос салахаа больсныг Итгэлт мэднэ. Чингээд ч эх хүүхэн хоёр Заяын бааюу дээр нүүж буусан билээ. Зая гэгээн аль байдгаа өгч, эх хоёрыг тэжээж байгаа болохоор Итгэлтийн тусламж тэдэнд хэрэггүй байлаа. Гэвч хожим Павловтай уулзах юм бол хэлэх үгтэй байх, бас цагийн байдал, төрийн бодлого тодорхой болтол уулзахгүй холуур явахын тул одоо нэг уулзаж эргэсэн болох нь зөв гэж шийдээд бааюу руу явжээ.

Тэр үдэш Павловынхны шинэ байранд очиход охин нь Зая гэгээний өрөөнд очоод эзгүй харин эхнэр нь ганцаар байв. Итгэлтийг хармагц уйлан хайлан, нөхрөөс нь ямар ч сураггүй байгааг ярилаа.

- Цаадах чинь дажгүй, оготоны нүхэнд орж унтаж чадах дамшиг гэж хэлсэн үгээ Итгэлт эхнэрт арай гэж ойлгуулав.

Эхнэртэй хамт нилээд ууж сүрхий согтсонд эхнэрийн сэтгэл тайтгарснаар барахгүй хөгжин дуу дуулж, Итгэлтийг хошуун дээрээс нь шов хийтэл үнсэв. Итгэлт гайхсан нүдээр эхнэрийг харан маасайн инээв. Эхнэр юу ч болоогүй юм шиг тайван хөдөлгөөнөөр хоёр хундагаа архиар дүүргэв.

-- Их орос гүрэн унаж хаан эцэг нь буудагдсан. Юуг хайрлах вэ. Юуг ч хайрлахгүй гэж орос монгол үг холин хэлснийг Итгэлт ойлгосонгүй, ойлгохыг ч эрмэлзсэнгүй. Учир нь Итгэлтийн санаанд өөр нэгэн бодол үүсээд мөч өнгөрөх тусам арвижиж байлаа. Тэр бол тачаангуй хүчтэй гал юм.

-- Үзье. Ямар байдаг дамшиг бол гэж бодсон Итгэлт эхнэрээс нүд салгахгүй ширтэв.

Гэтэл юу ярьж, яахаа мэдэхгүй учраас хаалгыг нээх арга олдохгүй ажээ. Урьд нь энэ

эхнэрийг харахад Итгэлтэд нэг л эв хавгвй юм шиг санагддаг байсан. Гэтэл одоо харах тусам зохицсон аятайхан юм олон харагдаж байв. Тvvний бор нvд хvрэн vс, хянган хамар нь бас л сонин харагдана. Ялангуяа хол газар давхиж ирсэн сайн морины хөх мах шиг тvхэлзэн буй цээж нь сэтгэлийг хөдөлгөнө.

Нэгэнт тачаангуй гал ассанаас хойш Итгэлтэд ямар ч юм саад хаалт болж чадахгвй. Итгэлт итгэлээ алдаагвй цагт хvслээ биелvvлж заавал чадна.

-- Өөртэй нь адилхан vнсээд авъя. Дамшиг чинь гэж бодоход бvх бие нь загатнах шиг болов. Гуйван босож эхнэрийн дэргэд зогссоноо хvзvvдэн авч vнсээд харвал ичих айхаа мартсан хоёр бор нvд харцтай нь тулгарав. Итгэлт эхнэрийг шууд өргөтөл «би өөрөө» гээд Итгэлтийг зайлуулснаа ор руу явлаа. Итгэлт ширээн дээр байсан лааг vлээгээд эхнэрийн хойноос хөх инээд нь хvрэн алхав. Маргааш нь Итгэлт өглөө эрт босож явсан билээ.

Гэрийн зvг хатируулан явахад нь намрын өглөөний сэрvvн салхи өмнөөс нь vлээн архианаас толгой нь vл мэдэг дvйрэн бадайрч өнгөрсөн явдал бодогдон нvvрэнд нь бардам мишээл байн байн бодогдоно.

Замдаа архи нэрсэн айл дамжиж явсаар vдшийн бvрэнхийд нилээд согтуу харихад:

-- Энэ вймээний цагт юунд ингэж согтдог юм бэ? гэж Должин зэмлэв.

-- Чамд падгвй хэрэг гээд Итгэлт гаднаас орж ирсэн Хонгорыг харж:

-- Миний морийг тавьж орхиорой гэлээ.

-- Морийг чинь тавьчихсан. Ааваа унтаж амар гээд Хонгор шууд очиж хувцсыг нь тайчихад Итгэлт эсэргvvцсэнгвй. Хонгор хэдийгээр арван долоон настай боловч бие бялдар тэгш, эцэг шигээ хурц нvдтэй, гонзгой бөгөөд хөрстэй хvрэл хvрэн царайтай хэн ч харсан цогтой эр болжээ. Харин Солонго эмэгтэй хvнд баймгвй махлаг, бадируун биетэй, өргөн хамар, зузаан хvзvvтэй хvн болжээ. Гэвч Солонгод Итгэлтийн гэр бvлийнхэнд ч байхгвй зөөлөн нvд дөлгөөн харц байв.

Солонгын нvд Итгэлтэд магтуулчихаад байгаа эхийнхээ нvдийг өвччихсэн юм гэж Нямын хэлдэг vг ёстой л нэг оносон vг юм.

Харин Хонгорын нvд тогтож ядсан хоёр хурц нvдийг бол Итгэлт ч эгцлэн харахаас зайлсхийдэг юм. Хэдийгээр Итгэлт Хонгорыг загнах дуртай боловч тvvний эрс хэлсэн vгнээс нь зөрдөггвй. Итгэлт голомт сахих ганц хvндээ хязгааргвй хайртай бөгөөд энэ хөрөнгийг тvvний төлөө цуглуулсан. Эзэн нь зөвхөн Хонгор гэдгийг хvндээ ойлгуулж хөрөнгөндөө баясан бахархах сэтгэлийг зvрхэнд нь хадаж өгөхийг хичээдэг билээ.

Гэтэл Хонгор хөрөнгө мал гэхийн оронд эмнэг адуутай ноцолдох морь уургалах, сайн морь унахыг эрхэм болгодог бөгөөд шагай, сурын алинд ч шигшээ багт боловч гай болохгвй болжээ. Бас зодоон цохионд ч оролцохоос буцдаггвй ажээ. Эцэг энэ бvхэнд сэтгэл зовох боловч залуугийн өвчин удахгвй арилж хөрөнгө хогшлын төлөө сэтгэл ундарна гэж итгэж явдаг байлаа.

Солонгыг «Ажилгвй дамшиг, урагшгвй амьтан» гэж vргэлж нvд vзvvрлэдэг. Итгэлт заримдаа унах морио хvртэл Хонгороор заалгадаг байлаа.

Галсан урьдын хэвээр Итгэлтэд vнэнчээр зарагдан адууг нь хариулсаар бөгөөд өнгөрсөн жил Итгэлтийн хvчээр Ханд гэдэг нэг хvvxэнтэй суужээ. Тvvнийг Итгэлт мөн л гоочилдог бөгөөд Хандад Дулмаатай жиших юм огт байсангвй. Зангаар номхон, царай зvсээр ч гавихгвй эгэл бор хvvxэн байжээ.

«Залуу болохоос биш Должингоос илvvчлээд байх юм алга даа» гэж Итгэлт адуу манахаар явсан Галсангийн гэр рvv явж байхдаа боддог байлаа.

Ням өвгөн, эхнэр, охины хамт Итгэлтийн хаяа тvшин хонийг хариулсаар бөгөөд охин Сvрэн



влэмж төгөлдөр болжээ. Итгэлт Заяын хврээний замд явах гээд уяа руу зэрэгцэн явж байгаа Сврэн, Солонго хоёрыг хараад «Манай Солонго гэж тарган хандгай шиг халбалзаад, эх шигээ нэг галбир муутай юм болох нь. Сврэн ч сойчихсон согоо шиг бие бялдар царай зүс тэгшхэн амьтан болох нь дээ. Лянхуа цэцэг шавраас гардаг гэгчээр Ням, Хишигт хоёроос ийм эрдэм төрдөг байжээ» гэж бодож байжээ.

Хэзээ эхэлснийг хэн ч мэдэхгүй хайрын сэтгэл Хонгор Сврэн хоёрын дунд буй болсон бөгөөд энэ сэтгэл нь өсөх тусам хоёр залуу бие биеэс бишvvрхэх болсноор барахгүй тvvнээ бусдаас нуухыг хичээдэг болжээ. Гэвч муур хумсаа хичнээн нуувч уурлахдаа гаргадгийн адил энэ хоёрын сэтгэл харах нүд, баясах зан бүхэнд нь цухалзаж байлаа. Тэр ч байтугай хамт байхдаа зан нь хвртэл өөр болно. Сврэнгийн дэргэд Хонгорын эрс гэжvvн зан зөөлөн, онгиргон цагаан болдог бөгөөд Хонгорын дэргэд Сврэнгийн зан ширvvн, дээрэнгүй болдог байлаа. Жишээ нь: Хонгор шагай авах, бөгцөг няслахдаа булхайцах гэдэг нь хэцvv. Гэтэл сvvлийн вед Сврэнгийн дэргэд бол хайлсан тугалга шиг болдог бөгөөд булхайгүй сайхан тоглохыг хичээдэг болжээ. Үвнийг нь Солонго үргэлж Сврэнтэй нэг тал болж хэрэлдэхгүй мар тоглодог болов.

Сврэн, Хонгор хоёрын сэтгэлийг Ням, Хишигт нар сайн мэдэж байсан авч, Итгэлт хоосон хvний охинтой ганц хvvгээ лав суулгахгүй гэж зовно.

«Сврэн хvvд минь хань биш. Ядахдаа сvйндээ ганц азарга адуу авчрах юмтай суудаг байгаадаа» гэж Должингийн хэлснийг дам сонсоод Ням, Хишигт ганц охиныхоо хувь заяаны тухай сэтгэл нь улам их зовдог болжээ.

- Хонгортой сууж баян хvний зарц болсноос сэтгэл нийлсэн юмтай суугаад бор гэртээ богд, хар гэртээ хаан болж явбал дээр гэж Ням хэлнэ. Гэвч энэ vгийг Ням охиноо Хонгортой суулгах дургvйдээ хэлсэн биш харин охинд нь тийм заяа байхгүй байх гэсэн бухимдлаас хэлжээ. Ганц охины нь заяа ирж баян Итгэлтийн голомтын эзэн ганц хvvтэй нь сууж жаргал эдлэхэд Нямын сэтгэл баярлахгүй байж хэрхэн болох билээ.

- Энэ хоёр багаасаа дассан юм. Миний охины магнай, чихний гэдэс буянтай хvн шvv гэж Хишигт хэлнэ. Хишигт ганц охиноо Итгэлтийн бэр болгож маргаашийн хоол гэж зовохгүй, юу өгөх бол гэж хvний царай харахгүй явуулахыг сэтгэлийн угаас хvсэж нууцаар бурхан сахиусанд залбирдаг байлаа. Хvн харахад Итгэлт хоёр залуугийн явдлыг огт мэдэхгүй, тvvнийг сонирхдоггүй юм шиг байлаа. Гэвч Итгэлт ийм юмыг мэдэхгүй өнгөрвөл нөгөө нар баруун хойноос навтас нөмрөөд гарна гэдэг болох биз ээ.

- Хонгор чинь буруу зvг рvv л хатираад байх шиг. Арай хоолтой юм олж өгдөг дээр байх шvv гэж нэг удаа Должингийн хэлэхэд Итгэлт огт дугарсангүй.

Итгэлт юу гэж дуугарах бол гэдгийг хоёр залуугийн явдлыг мэдсэн бүхэн, бүрхсэн тэнгэрээс аянга буух бол уу аль эсвэл намираа зөөлөн бүлээн хур буух бол уу гэж хвлээж байгаа мэт тэсэн ядан хвлээж байлаа.

Гэвч Итгэлтийн зvгээс аянга ч vгүй, хур ч vгүй ажээ.

### III

Оюутны сургууль гэж vүдэн дээрээ бичсэн ханхай хашааны дотор барьсан хэдэн том гэр байлаа. Петр тэргvvлэн хоёр залуу дагаж хашаанд ороод гэрvvдийн өмнөх талбай дээр гайхан зогсож байтал нэг гэрээс хvний толгой цухуйснаа «гурван номхон бор» гэж хэлтэл гэрvvдээс хорь гаруй идэрчvvд шуугилдан гарч ирлээ.

Идэрчvvд мань гурвыг тойрон сонирхож шvдийг нь татаж vзэх нь л холгvй байлаа.

- Сайн байна уу, залуучууд аа! гэж Петр хөгжилтэй инээмсэглэв.

- Ямар догь номхон бор вэ? Залуучууд аа гэнэ шvv гэж тав гээгтэй, сармай нэхий дээл

өмсөж, бүсэндээ төмөр хэт бэлтэй богино хутга зүүсэн залуу инээн хэлэхэд бусад нь хөгжилтэй шуугилдав.

- Залуучууд аа гэхгвй өвгөд өө гэх хэрэг үү гээд Петр нүдээ ирмэн улам ч хөгжилтэй инээнэ.

- Бүр өвгөд өө! гэнэ шүү гээд бүгд баясгалантайяа инээцгээв.

- За өвгөд өө! гэхэд шоолж байгаа бол чавганцуудаа гээд нэг азаа үзэх үү?

Петрийн монгол хэлэнд бахархан баярласан залуучууд баяр хөөр болон шуугилдав.

Цугларсан хүмүүс бол цөм арван долоо найман настай үе тэнгийн идэрчүүд байлаа.

--Танай багш гуай хаа байна. Энэ хоёр хүү танай сургуульд шавь орж ном үзэх гэж орж ирсэн.

-- Таны хүү юу?

-- Адилхан байна уу?

-- Үгвй адилгвй байна гэж уранхай лам тэрлэгтэй мулзан толгойтой Вандуй бусдаас урьдах гэсэн юм шиг түргэн хариулав.

-- Жаал аа гутлаараа мөрий тавиад барилдах уу? гэж хөх шандан дээлтэй, богинохон гэзэгтэй, хөл нүцгэн залуу хэлээд Жаргалын мөрөн дээрээс нь татлаа.

Жаргал түүний нүцгэн бөгөөд сайртсан хөлрүү тоомжиргвй хялайн харснаа «Чи юугаараа мөрийцөх юм бэ?» гэлээ.

-- Авна гэж итгээд үзэлцье гэж байна.

-- Яана гэнээ чамд үзүүлээд өгөө гээд Жаргал өрлөө. Барилдаан эхлэв. Жаргал хүчээр илүү авч гутлаа алдаж орхихоос айн хянамжтай ноцолдоно.

- Жаргал аа ирсэн өдрөө хөл нүцгэрч болдоггвй юм шүү гэж Петр хэлээд гуян дээр нь алгадав.

-- За хөө бөх гутал бололтой. Яйран хаяад сайран хөлдөө углаж орхидог хэрэг ээ гээд сармай дээлт хөх дээлтийн бөгсөн дээр хар хүчээрээ алгадав.

Хүчээр илүүгээ сайн ойлгохын хамт хазахаас бусад мэхийг чадамгай хийдэг Жаргал бусгамагц найдвартай унагах гэж өхийлдөж орхив.

-- За хө гутал өгнө дөө

-- Сайртай хөлөө барихгвй бол өөр юм алга даа гээд хөх дээлт ажиггвй бослоо.

Хэзээ гуталтай байснаа мэдэхгвй энэ залууг Чулуунбаатар гэдэг бөгөөд модчины өртөөнөөс сургуульд орох гэж ирснээс хойш шинэ ирсэн гуталтай хүн бүхэнд хэгжүүн үг хэлж өдөн барилдсан боловч хөл нүцгэн хэвээр үлджээ.

-- Сургуульд ирсэн хүүхдүүдийг бүртгэж авдаг хүнтэй Перт уулзаж хоёр залууг захиж өгөөд явахдаа «би эргэж байна» гэлээ.

Петрийг явснаас хойш мань хоёрын өмссөн номхон борын хувцсыг идэрчүүд үлэмж сонирхон зарим нь догь хувцас гэж худалдахыг гуйж үнэ өгнө. Зарим нь орос хувцас өмсвөл сүнс нь зайлж буруу номын чөтгөр болдог юм мэдэмгий ярина.

Мань хоёр хувцсаараа гайхуулахын хамт номхон борын тухай ярьж гарлаа. Ялангуяа Жаргал жолоогоо алдаж амандаа орсныг дур мэдэн авч эхлэв. Бат дарахыг оролдовч тус болохгвй ажээ.

Жаргалын яриагаар бол номхон борын цэрэг усанд ороод загас болчихдог, нэг сумаар хэдэн юмыг ч зэрэг онож чаддаг ажээ.

-- Усанд орж загас болчихоод дараа нь яаж хүн болох вэ? гэж мулзан толгойт асуухад «ил гарсан бие нь хүн болоод байдаг юм. Түүндээ л айхавтар байхгвй юу» гэж Жаргал ажиг ч үгвй тайван хариулав.

-- Дэндэж байна шүү гэж Жаргал минь гэж Бат тэсэж ядаад хэлж орхив.

-- Хааяа голд орж морь угаахад чи яваагч шүү дээ гэж Жаргал нь уцаарлангуй хэлжээ.

-- Номхон борын хэлийг мэдэх үү?

-- Мэднэ. Өглөө босоод «доров» гэнэ. Сайн гэхэд «харошо» гээд эрхий хуруугаа гозойлгодог. Юм гуйвал «можно» гэдэг. Явахдаа «арш» боовыг «хлеб» өглөө босохыг «поодьем» гэдэг. За за олон үг мэднэ. Та нарт зааж өгч болно шүү гэж Жаргал гайхуулан яриад номхон борын ланжуугаар олон гөрөөс буудаж сум тоолуулсан тухай ярихад нь Бат арга нь барагдан гарлаа. Жаргалыг ам мэдэн ярьж байхад сармай дээлт «аль вэ? чиний малгайг өмсөж үзье» гээд Жаргалын малгайг авч нулимаад өмсөв.

-- Хүн зааж өгөөд байхад яасан нөхөр вэ. Урьдаар «можно» гээд намайг «да, да» гэхээр «спасибо» гээд авдаг юм гэж хэлээд малгайгаа шүүрэн авлаа.

Хэдэн өдрийн дараа Жаргал шинель ба олмон бүсээ жижигхэн манан соруултай гаансаар сольжээ. Харин том улаан таван хошуутай эрүү малгайд нь аятайхан хийцтэй төмөр соёо цохиуртай тамхины сав өгч шалсан боловч худалдсангүй.

Хэд хонож байтал монгол хөх дээл, малгай оросын хар шөвгөр хар гутал сангаас тавьж өгөхөд орос хувцас өмсөж буруу номын чөтгөр болохгүй гэдэг хүмүүс хүртэл баярлан авч өмсөв.

Нэг өглөө шавь нарыг эрт босож шинэ дээл хувцсыг нь өмсүүлээд жагсааж билээ.

-- Та нар одоо ном заалгах багшдаа шавь орцгоо гэж жагсаасан хүн хэлжээ.

Гэрийн өмнө цагаан эсгий засаж дээр нь олбог дэвслээ. Том гэрээс ширэвгэр хар сахалтай, хүрэн дээл дээр хөх хантааз өмссөн, цагаан жинстэй хилэн малгай духдуулан тавьсан Чулуун занги намбатай бөгөөд ихэмсэг алхаж ирээд олбог дээр завилан суухад залуучуудыг нэг нэгээр нь цувуулан мөргүүлэв. Дараа нь сурагчдад бийр, янтай, цаас, үнсэн самбар тавин олгожээ. Чингээд хамгийн том гэрт оруулан суулгав.

Нарийхан боловч урт гэзгээ гөлийтөл гамнаж сүлжсэн Чулуун занги орж ирээд сахлаа өрөөсөн гараараа имэрснээ «за шавь нараа та нар бол манай монголын ард түмний үр хүүхдийг бичиг эрдэмд сурган боловсруулах анхны багш нар болох гэж байгаа хүмүүс мөн билээ. Эрдэм номд хичээнгүйлэн сурцгаах нь чухал. Та нарт монгол бичиг заах завшаан өчүүхэн надад олдсоныг баярлан хэлэх юун. Миний нэрийг Чулуун гэдэг. Автономитын вед цэргийн яаманд түшмэлийн алба хааж явсан. Уг язгуур ард бөгөөд шавь нар та бүхэн багш миний нэрийг цээрлэхийн учир намайг багш гэж болох ажээ» гэлээ.

Ингээд а, э зааж эхэлжээ. Өдөр өнгөрөх тутам ахисаар нэг мэдэхэд шавь нар монгол бичгийг үгчлэн уншдаг болжээ. Бас тоо бодлогын ухааныг сангийн яамны түшмэл агсан Шарав зааж эхлэв. Хоёр багш нь зан авир, хүсэл эрмэлзэл, бие бялдарын хувьд шал өөр хүн байлаа.

Хэрэв Чулуун занги яриа бүхэндээ Богдыг магтан «Богдын авралаар ардын засаг тогтож амьтны жаргах цаг ирсэн» гэдэг бол Шарав «Богд бол монголыг баллах шахсан хүн. Тэр ямарч бузар хэрэг хийхээс буцахгүй амьтан» гэж хэлэхэд нь нүдэнд нь хэмжээлшгүй хорсол тодордог байлаа.

-- Юунд Богдыг байлгадаг юм бэ? гэж Батын асуухад Шарав Ардын засгийн хийсэн ганц буруу юм л тэр дээ гэж хариулжээ.

Харин Чулуун бол Богдыг хэмжээт эрхт хаан болгосон нь Ардын засгийн хийсэн хамгийн зөв ажил, Богдгүй бол монгол улс байхгүй гэх зэрэг ярина.

Хоёр багшийн үзэл шавь нарт халдварлаж зарим нь Богдод биширнэ, Зарим нь Богдыг жигшин үзнэ. Бат бол Богдыг бүхнээс илүү жигшин үздэгээр барахгүй багшийнхаа ярьсныг ярьж өгнө. Гэвч Богдод биширдэг хүмүүс «чиний багшийг Богд алсан гэдгийн чи яаж мэдэж байгаа юм бэ?» гэхэд хэлэх юм байдаггүй байлаа.

Өвлийн нэг өдөр Эрдэнэ, Петртэй хамт ирлээ. Хуучин хөх чисчvv дээл, цагаан хурган хувин малгай өмсөж модон хуйтай буу, урт хар хуйтай сэлэм зvvсэн эцгээ хараад Бат яах учраа олохгvй гайхан зогсож билээ. Эрдэнэ хvvгийнхээ хоёр хацар дээрээс vнссэнээ нvднээсээ гарсан нулимсыг алгаараа арчив.

Эрдэнэ, Батыг бодоходоо урьдын бага бандиар нь дvрсэлдэг байсан. Гэтэл одоо тvvний өмнө том биетэй ханхар хар хvv зогсож байсан тул нэг бодоход vлэмжийн дотны хvн шиг, нэг бодоход аль нэг газар хальт харсан таних, танихгvйн хоорондох хvн шиг байлаа. Бат аавыгаа хараад бас л хоёрдмол сэтгэл төрнө. Өмнө нь зогсож байгаа хvн бол хэдэн жилийн өмнө хорвоо дээр хамгийн дотно бөгөөд юм бvхэнд дуурайл болж байсан аав биш мэт учраас бишvvрхэх сэтгэл буй болно. Гэвч харах тусам олон жилийн турш зvvдлэн бодож, хvсэл мөрөөдлийг эзэлсэн ааваас нь өөр хэн ч байж боломгvй ажээ.

Зовлонгийн цагт гардаг, баярын цагт бас гардаг болохоор учрал, уулзалтын гvн баярт умбасан эцэг хvvгийн аль алины нvдэнд баярын нулимс цэлэлцэн, дуугарч чадахгvй ширтэлцэн хэсэг зогслоо.

-- Хvv чинь сайхан эр болсон байгаа биз?

Эрдэнийн нvvрэнд инээмсэглэл бахдал баярлал зэрэгцэн тодорч:

-- Сайхан эр болжээ! Батыг удтал ширтэх зуур нь баяр бахдал нь алгуурхан гунигийн туяа болон хувирч,

-- Ижийгээс чинь сурагтай юу? гэж сул боловч ер бусын тод дуугаар асуув.

-- Огт сураггvй, та юм сонсоогvй биз?

-- Үгvй хvv минь.

-- Удахгvй та хоёр Долгортой уулзана гэж Петрийн хэлсэн vг уулзалтын мөрөөдөл дvүрсэн бөгөөд энэ уулзалтын учрахын сайхан элчинд ивээгдсэн эцэг хvvгийн сэтгэлийг энэ уулзалтын найдварын зvг эргvvлж хөнгөлөв.

Зовлонгийн вeд шинэ зовлонгоос амархан айдгийн адил учирлын вeд шинэ учралд итгэх нь хялбар байдаг ажээ.

Эрдэнэ хvvдээ чөлөө авч гэртээ авч ирэв. Баруун хойт нутгаар бугшсан цагаан намын цэргийг дарах тусгай ангид гарамгай байлдсан Эрдэнэ монгол улсын ардын цэргийн морин салааны дарга болжээ. Чингээд өчигдөр хvрээ орж ирээд цэргийн бэлтгэлээс хvн барьж байгаад нvvсэн таван ханатай ханхай гэр авчээ. Өнөө өглөө Петртэй уулзаж хvvгийнхээ сургийг сонсмогц хамт ирсэн нь энэ билээ.

Эрдэнийн гэрт хогшил гэх юм байсангvй. Эзэн нь нvvгээд олон хоносон энэ гэрт ороход ёстой л мөсөн хонгил л байлаа. Гэвч олон жилийн турш өөрийн гэх гэр оронгvй тэнvvчилж явсан эцэг хvv хоёрын сэтгэлд энэ гэр юу юунаас илvv дотно, бvлээн байлаа.

-- За хоёулаа энэ гэрт сууна даа гээд Эрдэнэ малгай сэлэм буугаа авч ханын толгойд авч өлгөв.

Бат дуугарсангvй. Тvvнд дуугарах тэнхээ байсангvй. Энэ өдрийн хэмжээлшгvй баяр тvvний сэтгэлийг мансууруулж гэрийн дотуур бөндөгнөн гvйж шинэ хоёр улаан баганаас эхлэн бvгдийг барьж vзэв.

— Ааваа энэ манайх уу?

-- Тийм. Манайх гэж Эрдэнэ «манайх» гэсэн vгийг гоцлон хэлээд инээмсэглэв.

Батын нvд гялалзан, тогтож ядан бvхнийг харж, урт урт амьсгаадан байхад «Жаргал» гэсэн vг нvvрэнд нь тодорч байв. Малгайгаа авч ханын толгойд өлгөв.

Эцэг хvv хоёрын баярын гэрч болсон Петр орж ирээд л багана тvшин инээмсэглэн зогсоод том гэгчийн тамхи ороож татлаа. Тамхины нь утаа суунаглан тооноор савсан гарах нь энэ

гэрийн дотор амьдрал эхэлснийг гаднах ертөнцөд тунхаглаж байлаа.

-- Ингээд та хоёр айл болдог байжээ.

-- Юу ч л гэсэн өөрийн гэх оронтой боллоо.

-- Итгэлтийн гэрээс гоё гэр байна шvv дээ.

-- Тэр чинь утаатай хар шvv дээ. Энэ чинь шинэ будагтай сайхан гэр гээд Бат тэнvvн инээв.

Итгэлтийн гэрийн тухай яриа Эрдэнийн сэтгэлд Долгорыг бодогдуулж царай нь бараан санаа алдав. Гэвч баяр нь багтаж ядсан хvv нь мэдээгvй бөгөөд харин Петр «Юунд Итгэлтийн тухай яриа гаргав даа» гэж өөрийгөө зэмлэж байлаа.

Айлын тvlээ авч галлан данханд цай чанав. Бат халин нисэж байгаа сэтгэлийн баяраа барьж чадахгvй байн, байн гарч өрхөө их бага болгоно.

Цай болж хашааны айлаас аяга авчран Эрдэнэ богцноосоо чанасан хөлдvv мах гаргаж аягандаа хөшиглөн идлээ. Бат зуухын хажууд тавтай завилан суугаад аяган дотроосоо хуруугаараа мах идvvрдэн идэж байхад хорвоогоос хvсэх өөр юм байсангvй.

-- Юуны өмнө Долгороо олж ирье.

-- Зөв дөө хөө. Чи ч гомдоосон доо.

-- Итгэлтээс л болсон хэрэг.

-- Биш ээ. Та хоёроос л болсон хэрэг.

Эрдэнэ дуугарсангvй. Петрийн хэлсэн vг хатуу боловч vнэн vг гэдгийг энэ хооронд хагацал мөрөөдөлд дэвтсэн сэтгэлдээ сайн ойлгож авчээ.

Эрдэнэ өглөө нь түргэн явж Долгортой уулзахаар хатуу шийдээд юуны өмнө Хорооны дарга Даржаа баатартай уулзахаар явахад Батат гэрийн хэрэглэл авах хэдэн янчаан өгчээ.

Эрдэнийг очиход морио хөглөөд хашааны хаалгаар гарч байсан Даржаа баатар «ашгvй чи хүрээд ирэв vv? Бид хоёрыг жанжин дуудаж байна. Бушуу явъя» гэлээ.

Замдаа Эрдэнэ Долгортойгоо уулзах шийдвэрээ хэлээд Даржаа баатраас чөлөө авахад нь туслахыг гуйв.

-- Юу ч гэсэн жанжин юу гэх нь вэ. Сонсьё. Чухал хэрэг гарч яв гэвэл бид ардын төр улсын төлөө амь биеэ хайргvй зvтгэх тангарагтай улс гэж баатар хэлжээ.

Тэд шууд явж жанжины албан байранд очив. Буутай цэрэг зогсон vvдийг татаж жижигхэн тасалгаанд ороход битvv захтай ногоон цамц, өргөн өвөртэй өмд өмсөж гялтганасан хар савхин гутал гялалзуулсан Сvxбаатар инээн угтлаа. Даржаа Эрдэнэ хоёр цэрэг эрийн хөл хавсран номхон зогсож ёслол.

-- Довчин бэйс цагаантантай нийлэн цэцэн ханы аймагт цэрэгт агт татаж, бидэнтэй байлдахаар бэлтгэж байна. Цаг алдвал гvйцэж дарахад бэрх болно. Тэднийг дарахаар та хоёрыг явуулна. Арван цэрэг, гурван зуун винтов, сумын хамт аваад өнөөдөр гар, цэрэг эрийг замаасаа элсvvл. Та нарын хамт улаан цэргийн анги явна. Үдээс хойш энд ирж тэдний дарга нартай уулзана. Мэдэв vv? гэж Сvxбаатар хэлэв.

-- Мэдлээ гэж бараг зэрэг хэлээд ёслол. Гэвч «мэдлээ» гэдэг vг Даржаа баатраас ухамсартай гарсан бол Эрдэнээс Даржаад татагдан аяндаа гарчээ.

Сvxбаатар янжуур гаргаж татаад Эрдэнийн дэргэд очив.

«Одоо л хэлж чөлөө авахгvй бол Долгортойгоо уулздаг хөг өнгөрлөө!» гэж бодоод Эрдэнэ vгээ эхлэх гэтэл:

-- Эхнэрээс чинь сурагтай юу гэж Сvxбаатар гэнэт асуув.

-- Үгvй, явж уулзах л санаатай байдаг.

-- Эрдэнэ минь одоохон тун боломж алга. Энэ ажлын дараа чамайг явуулахыг хичээе.

-- Амьд мэнд байдаг болов уу? гэж санаа зовох юм даа.

-- Амьд гэж итгэнэ шvv. Итгэх шиг сайхан юм хаа байх вэ. Итгэлтэй цагт хvн ухаантай ч, хvчтэй ч байдаг. Итгэлээ алдсан хvн хий нь гарсан нойтон гvзээ шиг болдог, хvвтэйгээ уулзсан биз?

-- Уулзсан.

Сvхбаатарын нvд нь жийхайж инээмсэглэснээ талийгаач аавынхаа танил хөгшнийд очоод байхад нь Жаргалын ярьсныг дурьдаад:

-- Хvвтэй чинь би тэгж дайралдсан. Цовоо эр байна билээ гэлээ.

-- Одоо хоёулаа л ном vзэж байгаа юм байхаа.

-- Тийм. Эрдэмтэй хvн мөн ч их хэрэгтэй байна даа.

-- За та нар ард тvмэнд засаг төрийн бодлогыг нарийн тайлбарлаж элбэрэл журамтай яваарай.

-- Мэдлээ гэж дахин зэрэг дуугарав.

-- Одоо дарга, комиссар хоёрын дуу яг нийлж нийлж байна гэж Сvхбаатар явж ширээн дээрээс тамгатай бичиг авч Эрдэнэд өглөө.

Тэр бичиг бол Цэцэн хан аймагт явах цэргийн даргаар Даржаа баатар, комиссараар Эрдэнийг томилсон vнэмлэх байлаа.

Тэр хоёрыг гудамжинд гарахад бударсан цас орж байв. Морьдоо уяанаас тайлж унаад хамт хэсэг явснаа Даржаа баатар цэрэг зэвсгээ авч явахад бэлтгэх, Эрдэнэ хvвтэйгээ уулзаж гэр бараагаа тушааж өгөхөөр салан одлоо. Мөн vдээс хойш цэргийн яамны vвдэнд уулзаж хамт явах улаан цэргийн дарга нартай учрахаар тогтов.

Эрдэнэ бага vдийн хирд гэртээ ирэхэд хvв нь шинэхэн тогоонд гурилтай хоол хийж байлаа.

Бат Жаргал болон бусад нөхөдтэйгөө хамт ирж гэрээ сvрхий янзалжээ.

-- За аав аа хэзээ явах болов? гэдэг vгээр Бат эцгээ угтав.

-- Зун тийшээ л явна даа.

-- Яагаад ? Би ижийд ийм юм авсан гээд өврөөсөө vнгэсэн муутуу цаасанд боодолтой юм гаргаж задлав. Тэр нь хайрцгийн чавганцаас авсан битvв пойлсон бөгж байлаа.

Эрдэнэ бөгжийг авч алган дээрээ удтал ажигласнаа санаа алдаад:

-- Чухал ажил гарсан гэлээ.

-- Ижийтэй уулзахаас уу?

-- Ардын засгийн дайснуудыг дарахаар явна. Бид тэднийг дарахгvй бол, тэд биднийг дарна шvv дээ. Эцгийнхээ ярьснаас сэтгэлт нь зөвхөн «явна» гэдэг харваж орсон аягvй vгийг Бат vлдээж авлаа. Салж хагацахын зовлонг хэмжээнээс хэтрvвлэн vзсэн тvвнд vвнээс хvнд vг байсангvй.

-- Одоо танаас салахгvй. Явдаг юм гэхэд хамт явна гэж шийдэмгий дуугаар хэлэв.

Гэрийн дотор нэгэн хэсэг анир чимээгvй байсан бөгөөд Эрдэнийн хувьд хvвгээ зэмлэх, тvвнд «Би явна. чи vлд гэж » шууд хэлж чадахгvй байлаа. Арга нь барагдсан Эрдэнэ тойрон зогссон залуучуудыг харлаа. «Та нар Батдаа хэлж өгөөч, Би явалгvй болохгvй» гэсэн гуйлт Эрдэнийн нvврэнд бичээстэй байлаа.

-- Өвгөн минь аав чинь хvрээд л ирнэ шvv дээ гэж Жаргал эхлэн дуугарав.

-- Би л ааваас одоо салахгvй.

-- Иш хvв минь. Аав нь дайнд явах гэж байна шvv дээ.

-- Тэр тусмаа салахгvй.

-- Аав чинь улс орны чухал хэрэгт явах гэж байна. Чингэхэд чи нялх хvвхэд шиг дагаад, болохгvй гэж нэг залуу хэллээ.

-- Сvхбаатар жанжин намайг vвнд явуулж байгаа юм гээд Эрдэнэ хvвгээ харлаа.

Yвд нээгдэж Петр орж ирээд:

-- Цагаантантай байлдахаар зvvн аймагт явах улаан цэргийн комиссараар явах боллоо. Бидэнтэй Даржаа баатар та хоёр явах юм гэнэ. За хамт явдаг болж дээ гэлээ.

-- Петр ах нь ч бас явах нь байна шvv дээ.

Бат дуугарсангvй бодол болон хэсэг зогссоноо:

-- Тэгээд хэзээ явах юм бэ? гэж сулхан асуув.

-- Өнөөдөр гарна. Миний хvv гэртээ байх уу? Аль сургууль дээрээ.. гэтэл

-- Сургууль дээрээ байвал дээр гэж Петр зөвлөв. Тэр орой эцгийгээ цэргийн яамны vүднээс хөдлөхөд Бат очиж vдэж өгсөн бөгөөд Сvхбаатар жанжин байсан болохоор уйлж чадсангvй. Эрдэнэ улаан цэргийн ангитай Уу буланд нийлэх ёстой байв. Од тvгж vдшийн хvйтэн салхи хувцас нэвт vлээсэн тэр нэгэн шөнө зэвсэг ачсан морин тэрэгний өмнө гvн шөнө гаминтай буудалцан давхиж байсан нь тодхон санагдана.

IV

Монгол орны өвөл догшин боловч өвөрмөц гуа vзэсгэлэнтэй бөгөөд өвөлжөөндөө буусан айлууд халуу бутран уур савсуулсан, юм бvхэн ve бусын тайван байдаг Мод хvртэл цагаан дахаа нөмрөөд vүрэглэж суугаа манааны өвгөн шиг навсайн харагдана.

Гэвч энэ өвөл тийм биш. Цаг төр вймэн, зэвсэг барьсан хvмvvc холхилдон аллага, дээрэм энд тэндгvй гарч, айл амьтан мал хөрөнгөө орхин дvрвэж байлаа. Урьд өвлийн цагт айл, мал багширч байдаг боловч энэ жил эзгvй зэлvүд газар болсон урт амны даваагаар Хатанбаатарын цэргийн цуваа гарч ирлээ.

Бvх юм хэдхэн хоногийн өмнө орсон сэвсгэр цасанд дарагдаад нарны гэрэлд гялалзан тоглож урт ургасан хялганы vзvүр цагаан хорвоог шаргал хачиртай дэвсгэрээр бvрхжээ.

Туг хиур нь намиран хийсэж, зэр зэвсэг нь гялалзсан их цэргийн цуваа, энэхэн өвлийн хурц өнгөтэй өрсөлдөн сvртэй бөгөөд цог жавхлантай ажээ.

Хатанбаатарын цэрэг цагааны цэрэг Казанцовын гол хvчийг бут цохин сарниулаад генерал Бакичийн дээрэмчидтэй байлдахаар аялан яваа нь энэ юм. Цэргээс зуу гаруй метр зайтай өндөр улаан зээрд морь унаж зэр зэвсгээ бvрэн агссан Хатанбаатар Магсаржав явах бөгөөд тvүний зvүн гарт нь тарган бор морьтой Хуяг дагана.

Магсаржав алсыг ширтэн баруун гарын ханцуйдаа урт тэнзэн ташуурын ихэнхийг нуун унжуулж, зvүн гартаа эр хар суран жолоо, цулбуураа хумин атгаж, хааяа хааяа хагас эргэн цэргийн цуваагаа харан явах нь сvртэй бөгөөд ялагч цэргийн ер бус сvр сvлдийг биедээ шингээнэ.

Цэргийн цувааны сvүлд нь хvнс зэвсэг хэрэглэл ачсан тэмээн цувааг хөх шандан өнгөтэй, vзvүрсгэн дотортой дээл өмссөн залуу хvүхэн хөтөлжээ. Энэ бол Дулмаа байв. Алсын аялалд борлосон царай, хайрт хvнтэйгээ хамт яваагийн ёроолгvй баяр, жаргал энэ бvсгvйг улам гоо vзэсгэлэнтэй бөгөөд цог хийморьтой болгожээ.

Ачааны сvүлд цэргийн бэлтгэлд агтыг арав гаруй хvмvvc урт уурга барин тууж яваагийн дотор Хатанбаатарын цэргийн агтны ерөнхий захирал Төмөр сартай хээр морь унан явна.

-- Нэг ч морь, эзэнд нь мэдэгдэлгvй авч болохгvй шvv гэж Төмөрийг агтны ерөнхий захирал болгохдоо Хатанбаатар хэлэв.

-- Авахгvй жанжин минь. Тангараглах уу?

-- Эр хvний vг бvхэн тангараг байх ёстой биш vv!

-- Тийм ч байхдаа гээд Төмөр инээмсэглэв. Төмөр нэг удаа Гvний хошуунаас агт дайчлахаар очиж билээ. Хатанбаатарын тамгатай бичгийг хошуу захирагчид vзvүлж гурав хоногийн дотор зуун шилдэг морь гаргаж өгөхийг тушаав. Гэтэл ноён «Хориос илvүг өгч чадахгvй гэж тэр элчид хэл» гэж захирагчдаа хэлэв.

Энэ үгийг сонсоод Төмөр ноёны өргөөнд шуугин орж «Төр донсолж, түмэн зовж байхад юу гэнээ чи. Үүнийг барьж аваад хвлж орхи» гэж дагаж очсон хоёр хүндээ тушаав.

Тэр хоёрын замыг хөх чисчүү дээлтэй ханхар эр хөндөлдөв. Энэ бол долоо хошуу даншингийн заан цолтой хүн бөгөөд ноёны шадар хиа юм.

-- Ноёнд гар хүрвэл хэзүүг чинь мулт алгадна шүү гэж тэр эр бүдүүн дуугаар ханхалзан хэлэв.

-- Овоо эр байх нь хө. Та хоёр зайлж бай. Аль вэ миний хэзүүг мулт алгадаад аль гээд Төмөр очтол нөгөө эр нь хөдлөв. Юу болсныг хэн ч мэдсэнгүй. Нэг л харахад хиа гулдайн хэвтэж байлаа.

-- Зуун морь өгөх үү? Аль эсвэл би хвлж авах уу?

-- Жа, морьдыг гаргаж өгье гэж ноён бөхөлзөн хэлэв.

-- Ноён сүрэг, хошуу жасын адуугаа маргааш бэлхэн байлга. Би өөртөө шилж авна гээд Төмөр гарлаа.

-- Энэ хэн гэгч вэ? гэж ноён Төмөртэй хамт ирэгчийг гарах гэхэд нь асуув.

-- Алдар нь Засагт ханы цахиур Төмөр, Алба нь их жанжин Хатанбаатарын зарлигийн элч гэж тэр хүн инээмсэглэн хэлээд эргэв.

-- Бурхан минь гээд ноён ширээндээ пад хийтэл суув. Гурав хоногийн дараа ноён сүрэг, хошуу жасын адуунаас өөрөө шилэн зааж бариулан авсан зуу морь туугаад явахад нь «Та агт авсан бичиг шийтгэн өгнө үү?» гэж ноён хэлэхэд нь «Юу. Тийм юм хэрэгтэй байдаг юм уу? Бид бичиг мэдэхгүй»гээд Төмөр хөгжилтэй инээв.

-- Жа. Тэгвэл бид энэ бичгийн хийсэн билээ. Та зөвхөн л гарын үсгээ зураад өгнө үү гээд захирагч муутуу цаасан дээр бичсэн бичиг барилаа.

-- Уншаад аль!

-- Хошуу захирагч бичиг дэлгэн барьж жингэнэсэн өндөр дуугаар халхын их жанжин Хатанбаатар Магсаржавын цэрэгт зуун шилдэг морь дэвшүүлэн барьсан тухай өдий төдий сул үгтэй урт бичиг уншив.

Уг бичгийг уншиж байхад Төмөр анхааралтай чагнан сонсоод «За бэх аваад ир!» гэлээ.

Хошуу захирагч мөнгөн бийр, янтай өмнө нь байхад Төмөр баруун гарын эрхий хуруугаа бэхэнд нугалан дүрж бичиг дээр палайтал дарж орхиод явсан билээ.

-- Төмөр гуай таван зуун морь авсан гэж бичсэн юм шиг байгаа даа гэж нэг нөхөр нь хэлэхэд — Мянга гэж бичсэн ч яадаг юм бэ гээд Төмөр инээжээ.

Хатанбаатарын цэрэг ам уруудан явсаар байлаа. Дулмаа байн байн эргэж харахад Төмөр зөөлхөн бөгөөд уудам хайрын уяхан инээмсэглэл бэлэглэнэ. Зовж гуньсан сэтгэлд хорвоо бөгчим явцуу бөгөөд дээрэнгүй байдаг бол баяр жаргалаар дүүрсэн сэтгэлийг орчмын юм бүхэн чимж дэлгэх уужим болгодог билээ. Дулмаагийн нүдэнд туссан бүхэн хөнгөн гавшгай гэрэл гэгээтэй санагдана.

-- Харийн дайсан хаврын цас шиг хайлан дарагдаж монгол орон тусгаар улс болоод яргуй цэцгийн адил дэлгэрэн сэргэх цагт бид их салхинд орон гэрээ тогтоож ядсан эзэн хүний бахдам сэтгэлээр баясан амар жимэр амьдрах болно гэсэн Хатанбаатарын үг Дулмаагийн сэтгэлийг эзлэнэ.

Учир нь гэвэл энэ эмэгтэй дайн самуун бушуухан дуусаж, Төмөртэйгөө хамт өөрийн гэх орон гэрээ босгон энх тайван амьдрахаас илүү хэсэл мөрөөдөлгүй байлаа. Тэр сайхан өдрөө Дулмаа сэтгэлдээ элдвээр зохион урлаж түүний төлөө юу ч хийхээс буцахгүй байлаа. Аль нэгэн цагт Төмөрийнх гэж дөрвөн ханатай гэртэй, хэдэн малтай айл буй болоод тэр гэрийн эзэгтэй нь Дулмаа байна гэдэг бодол Дулмаагийн хүслийн үзүүр байсан бол энэ айл ямар



байх вэ? гэдэг бодол Дулмаагийн санаа сэтгэлийг эзэмдэнэ.

Ороо хаа яаж засах, хөлийн авдартаа юу юугаа хийх, өглөө яаж босох, гарах хvүдээ хэн гэж нэр өгөх, яаж өсгөх зэргийг бодно гэдэг юутай сайхан билээ.

Дулмаа хvний эхнэр байж ч vзсэн. Хөлийн авдрын эзэн ч болж vзсэн. Гэвч одоо ирэх амьдрал нь тэр бvхнээс шал өөр байх ёстой гэж итгэлтэй бодно. Тэр ялгавар бол сэтгэл санаанд биш ор дэвсгэр, хөлийн авдар цөмд байх ёстой юм гэдэгт Дулмаа огт эргэлздэггүй байжээ.

Өглөө бvхнээс эрт босоод Төмөртөө ve сvүлтэй, тос самарсан хийцтэй шаргал цай цай чанаж өгөхөө хvртэл хэд хэдэн янзаар эрэгцvүлэн бодно. Ирээдvйд буй болох Төмөр гэдэг жаргалтай айлын тухай бодож яваад эргэж харах бvрд тэр бодлыг нь сайшаасан мэт халуун хайраар чимэгдсэн инээмсэглэл бэлэглэхэд нь «Төмөр минь бас л бодож байгаа шvү дээ» гэж санаад vргэлжлvүлэн шинэ амьдралынхаа тухай бодно.

Yнэндээ Төмөр ч шинэ амьдралын тухай дахин дахин боддог байлаа.

Дайн дуусаж амар тайван болсон цагт Дулмаатайгаа хамт амьдрах тухай бодохгүй байж Төмөр чадахгүй нь мэдээж хэрэг. Төмөр өөрийн гэрт хөл жийн амьдрахын амтыг удаан эдлээгүй, гэвч Төмөр ирэх шинэ амьдралаа хэдэн мал хотолсон, дөрвөн ханатай гэрийн дотор шахаж оруулдаггүй байв.

«Монгол орны тvүхэнд шинэ ve эхэлнэ. Ард тvмэн эрх олж, улсын эзэн болно. Тэр вед шударга ёс ялж, хөрөнгөтэй нь хөрөнгөгүй ээ, эрх ямбатай нь эрх мэдэлгүй ээ дарлан зовоож чадахгүй болно» гэсэн Хатанбаатарын vг Төмөрийн сэтгэлийг vлэмж хөдөлгөж тэр өдөр удахгүй ирэхэд хязгааргүй итгэжээ.

Уулаас итгэмтгий Төмөр Хатанбаатарын цэрэгт орсноос хойш улам ч итгэмтгий болжээ. Гэхдээ урьд «энэ над гэм хийж чадахгүй» гэх буюу «энэ бол ядарсан амьтан» гэж итгэдэг байсан бол одоо «энэ ч зөв юм хэлж байна» гэх буюу «энэ ч ухаантай хvн юм даа» гэж бодоод бишрэн итгэдэг болжээ.

Төмөр ноёд, баядын хэмжээлшгүй эрх мэдлийг эр зоригоор доромжлон явж билээ. Чингэж явахдаа өөрөөс нь чадал зориг ухаантай эргүй гэж бодож явсан. Энэ ч учраас хорвоогийн хар амьдралыг жигшиж, хурдан морины нуруу, эзгүй хээр өндөр уулаар нөхөр хийж явлаа. Гэтэл Хатанбаатарын цэрэгт орсноос хойш Төмөрийн бvгдийг дээрээс хардаг бардам сэтгэл алгуураар дарагдан бусдын ухаан санаа, эр чадалд итгэх сэтгэл бадран байлаа.

Өөрийг нь хос морьтой нисэж явахад гахай явганаар барахгүй гуйлгачин байсан бөгөөд өөрийн нь сайн сэтгэлийн тусламжаар хөл залгаж нутагтаа харьж байсан Хуяг одоо Хатанбаатарын баруун гарын хvн болоод тулалдаанд ялж явааг харахад эрийг хэзээ ч басаж болохгүй ажээ. Ингэж явахад Хуяг өөрийн нь бодож явааггүй бодож, мэдээгүй зvйлийг мэддэгийг Төмөр ойлгов.

Өөрөөсөө дор гэж vзэж явсан хvн дээр болоход зарим хvнд атаархах сэтгэл vүсэн гарч хайрлан vзэж байснаа дайсагнан vздэг удаа бишгүй байдаг. Ер нь ч хорвоогийн атаа жөтөө vүнээс vүсдэг билээ.

Харин Төмөр бол Хуягтай атаархах сэтгэл огт байсангүй. Өдөр хоног өнгөрөх тутамд тvүнд итгэн бишрэх сэтгэл нь хөгжиж байлаа.

Хатанбаатар бол Төмөрийн сэтгэлд эр хvний vлгэр болон бэхжиж байжээ. Нөхөртөө намрын ногоо шиг, дайсанд орсон буур шиг байдаг Хатанбаатарын занг харах тусам Төмөрт амьдралдаа гэнэдэж явсан бvхэн нь нөхөр дайснаа ялгаж чаддаггүйгээс болсон мэт бодогдож байлаа.

Yүнээс гадна энэ дайн дууссан цагт Төмөрийнх гэж ариун шударгаар амьдарсан жаргалтай айл буй болоход Төмөр итгэж байлаа. Гэхдээ хуучин төр, хэмжээгүй эрх ямба байсан цагт

тэр айл буй болохгвй гэдгийг мэднэ. Нэгдүгээрт хуучин төрийн өмнө хийсэн ял их байв. Хоёрдугаарт Дулмаатайгаа энх амьдрах гэсэн хүсэл нь хуучин төрийн вед биелэгдээгвйгээр барахгвй зовлон болсон. Гуравдугаарт Хуяг олон дахин ярьж өгснөөс шинэ төрийн вед шинэ амьдрал буй болохыг ойлгож авсан билээ.

Цэргийн өмнөөс цагаан цан болсон хоёр морьтой хүн яаралтай давхин ирлээ. Унасан бараан морьд нь хөлрөн бууралтжээ. Тэд шууд Хатанбаатарын өмнө ирж зогсоход морьд нь тогтон ядна. Эд бол өчигдөр орой өмнөх замыг тагнахаар явсан хайгуул, туршуулууд билээ.

-- Эндээс өртөө гаруй зайтай байгаа хошуу тамгын жасаан дээр арван нэгэн цагаан цэрэг ирээд хоёр хоножээ. Цөм орос ланжуутай, олон хайрцаг сумтай юм байна. Хошуу захирагчийг барьж хар гэрт хорьжээ. Хошуу ноён туслагч нар нь айн сандарч тэдэнтэй нэгджээ. Бакичийн цэргийн түрүүч юм гэнэ гэж ирэгсдийн нэг нь Хатанбаатарт хэлэв. Хатанбаатар мориноос бууж цасан дээр завилан суугаад үг дуугаралгвй хоёр гурван гаанс тамхи угсран татлаа. Хялгана авч имрэн барилдуулаад дийлснээр нь шүдээ чигчийлэн бүлтгэр том хар нүд нь цавчилж магнай дээр нь хэдэн үе үрчлээ байн байн тодорно.

— Хошуунаас цэрэг татаж байна уу?

— Үгвй боллолтой.

— Дээрэмдэж байна уу?

-- Үгвй. Тамганы гэрт хонь гаргуулан идээд л хэвтэж байна. Нэг нэртэй лам, ойрын өдрүүдэд майдарын ван тавих гэж том дуганан гэр бариулж байна.

-- Хичнээн?

-- Том дуганан гэр нэг, 7 ханатай гэр хоёрыг.

-- Мөн дөө. Майдарын ван гэнээ гээд баатар ёжтой инээмсэглэснээ «тэр харагдаж байгаа хар үзүүрийн өвөрт цэрэг хуарагнан бууна» гэж Хуягт хэлэв.

-- Өнөөдөр юу болоод ийм эрт буух болов оо гэж майхны гадас шааж байсан Төмөр хажуудаа ирсэн Хуягаас асуув.

-- Бакичийн цэргийн түрүүч тамгын жасаан дээр ирээд байна гэнэ.

-- Олон юм болов уу?

-- Арваад хүн гэнэ.

-- Аа тийм бий.

Цэргүүд бууж хоол цай болов. Хатанбаатар майхнаасаа гарч жаргаж байгаа нар руу ширтэн зогсож байтал дэргэд нь «багш аа» гэх дуу гарахад харвал Дулмаа зогсож байлаа.

-- Юу гэв?

-- Би явж тэр цагаантныг сайн мэдээд ирье.

-- Өнгөрсөн намар захчин Гурван цэнхэрийн хүрэн дээр үүрлэж байсан цагаантны тоо, зэвсгийг мэдэх гэж хоёр хүн явуулсны хоёр нь баригдаж, нөгөө нь зугтан юу ч мэдэж чадалгвй ирэхэд Хатанбаатараас Дулмаа гуйж байгаад явсан билээ.

Үдийн хэрд хүрээний гудамжаар навсархай дээлтэй, шивэр болсон нүцгэн хөлтэй галзуу хүүхэн хангинтал дуу дуулан хүүхэд банди нарыг айлган явсан нь Хатанбаатарын тагнуул Дулмаа байсныг хэн ч мэдсэнгвй.

Цагаантныг дарсны дараа «манай Дулмаа цагаантны толгойн үсний ширхгийг бараг мэдэж орхиж шүү» гэж Хатанбаатар магтсан юм.

Хатанбаатар Дулмааг зөөлөн бөгөөд бахдалтай нүдээр ажиглан хэсэг зогссоноо эргэж майхандаа ороод удалгвй хүрэн цэмбэн хүрэм барин гарч ирээд «чиний оёсны дээд талаар урагдсан байна билээ» гээд өгөв.

-- Багш аа. Би..

-- Гомбын дээлийн суга урагдсан л харагдаж байдаг шvv. Бодвол энэ хvйтэнд салхи шуурч л байгаа байх даа.

Дулмаа хvрмийг авч эргэж алхав. Орой нь Магсаржав хоёр хvнийг туршуулаар явуулав. Харанхуй болов. Агтчины майхны нэг буланд өөр өөрийн дээлийг өрөөлдөн нөмөрч Төмөр Дулмаа хоёр зэрэгцэн хэвтлээ. Анх тэр жил Итгэлтийн хонь хариулж явсан Дулмаатай модны захад уулзсанаа Төмөр шивэгнэн эхэлж ярьсанд Дулмаа ч энэ олон дахин ярьсан боловч vргэлж сэтгэл хөдөлгөж шинээрээ байдаг яриаг дэмжиж «чи ч ингэж байсан», «би ч ингэж байсан» гээд л ам булаалдан хөгжилтэй бөгөөд сэтгэл дvvрэн ярилцав.

-- Тамираас оргож давхиж явахад чи намайг vргэлж хөтөлж явдагсан гээд Дулмаа бахтай сайхан мишээхэд

-- Чамайг унаанд сайныг мэдээгvй байсан болохоор ойчих бий дээ гэж сэтгэл зовоходоо л гэв. Гэтэл тэр хоёрын гунигтай ведээ ойртох тусам vг нь цөөхөн болж дуу нь нам болсоор нэг хэсэг тасрав. Төмөр урт гэгч нь санаа алдаж «эр хvн дээ хөө» гэж шивэгнэв. Энэ хар бодол Төмөрийн сэтгэлд анх удаа орж байгаа юм биш. Үvнийг орж ирэхэд нvд нь хөдөлгөөнгvй болон гөлөрч зvрх нь гаслан уйлдаг юм.

Ер нь хvн бvхэн уйлдаг бөгөөд Төмөр ч бас л уйлдаг билээ. Гэвч энэ бол нулимсгvй битvv уйлалт. Хэрэв нулимстай уйлахад гуниг гашуудал гадагш гардаг бол нулимсгvй уйлахад гуниг гаслал нь зvрхэнд нь орон тарж шингэдэг юм. Энэ учраас хvчтэй сэтгэлийн битvv уйлалт бол хvнд ч, даацтай ч байдаг шvv дээ. Хөнгөн сэтгэлийн гуниг хөнгөн байдгийн адил, их сэтгэлийн гаслан гvнзгий байдаг болохоор хvvгээ бодсон Төмөрийн зовлонг зөвхөн Төмөрийн зvрх сэтгэл нь давж гардаг юм.

-- Одоо яахав дээ гэж vлэмж сулхан хэлээд Дулмаа агсарч байгаа нулимсаа алгаараа арчив. Өглөө цэргvвд эрт босож цааш явахад, бэлхэн байсан авч Хатанбаатар явах тушаал өгсөнгvй. Орой нь Хатанбаатарын явуулсан хvмvvc ирж хошуу тамгын жасаан дээр Бакичийн дөрвөн зуун тавин найман орос цэрэг, гунан буу гурав, vхэр буу хоёр, гурван зуун хорин долоон монгол цэрэг ирсэн тухай мэдэгдэв.

-- Монгол цэргийн зэвсэг нь.

-- Зуун арван хоёр бярдан ба цахиур буутай, бусад нь ташууртай юм.

Хатанбаатар Бакичийн цэргийн тоо, зэвсгийг мэдэж аваад хоёр шийдвэр гаргажээ. Бакичийн хvч бол өөрийнхөөс нь давуу ажээ. Үvнээс vзэхэд шууд тулалдаж болохгvй байв.

Ингэхлээр сvр vзvvлэн хэлэлцээ хийж буулган авах, эс чадвал монгол цэргийг салгаж аваад гэнэдvvлэн байлдах хэрэгтэй ажээ.

-- Маргааш өглөө бууж өгөхийг шаардсан бичиг явуулья.

-- Очсон хvнийг минь барьж аваад алж орхивол яана гэж Хуягийн хэлэхэд Магсаржав инээмсэглэснээ

-- Бакич бол Казанцов биш. Юу ч гэсэн генерал хvн. Нэрээ бодно. Сvvлийн вед Бакичийн цэрэг дээрэм хийх нь бага болсон. Морьд хvнсээ зөвхөн хошууны урвасан ноёдоор дамжуулан залгаж байна. Бодвол монголчуудын хvчээр амьд гарахыг хичээж байгаа бололтой. Бас чиглэлийг нь харвал өмнө зvг, монголд хувьсгалтай тэмцээд ашиг олохгvйг ойлгожээ. Миний элчийг алахгvй гэлээ.

Ингээд бичиг хийж элч явуулаад цэргvвд унтацгаав. Өглөө нь Хатанбаатар эрт босоод харвал амны эхэнд нэгэн хэсэг адуу, амны адагт нь бас нэгэн хэсэг адуу байв. Дурандаж харвал амны эхэн дэх адуу нь цэргийн нь агт байв. Тvvнийг буутай зургаан хvн туугаад ирж явлаа. Амны адгийн адууг нутгийн айлын адуу бололтой гэж бодоод ажиглан харвал унага, даага нэг ч vгvй морьд байв.

-- Энэ доорх юун адуу вэ?

-- Мэдэхгүй. Дандаа л морьд байна гэж дурангаар харж байсан Хуяг хариулав.

-- Цагааны агт арай энд хүрээд ирдэг юм биш байгаа даа.

-- Манасан хүнгүй юм байна гэж Хуяг хариулав. Оёсон хүрмээ барьсан Дулмаа ирж «багш аа таны хүрэм» гээд Магсаржавт өгөв.

Жанжин хүрмээ авч өмсөөд «Төмөр байна уу?» гэж огцом асуув.

-- Орой агт эргэнэ гээд л явсан. Хэдийд ирснийг мэдэхгүй. Одоо унтаж л байна.

Магсаржав жанжин зүүн хойт талын манааны хэдэн цэргийн ойролцоо идэж байгаа чөдөртэй хэдэн морьдыг ажиглан харж байснаа Хуягийн чихэнд хэдэн үг хэлэв.

Хуяг түргэн явж майханд орвол баруун талд нь давхарлан дэвссэн ширмэл бамбай дээр Төмөр дээлээ өрөөлдөн нөмрөөд дүнгэнэтэл хухиран унтаж байлаа. Хамраас нь уур савсан, өргөн нүүрийг нь манантуулж, амьсгалах бүрд нь дээл нь оволцон сүртэй ч, жавхаатай ч харагдана.

Хуяг майхны хаяанд тавьсан Төмөрийн эмээлийн тохмыг барьж үзээд тааламжтай мишээн Төмөрийг ширтэж хэсэг зогссоноо эргэж гараад Хатанбаатарын дэргэд очиж «Яг тийм, тохом нь нойтон байна» гэлээ.

-- Дулмаа чи Төмөрийг дуудаад ирээч гэж Хатанбаатар хэлээд Хуяг руу харж инээмсэглэв.

Удалгүй Төмөр ирлээ. Хатанбаатар нүдээ цавчилгүй ажиглаж байснаа «энэ юу вэ?» гэж амны адагт идэж буй адууг заав.

-- Агт л байна гэж Төмөр ажиггүй хариулав.

-- Чи чинь над тангарагласан биш билүү?

-- Дайсны агт шүү дээ. Жанжин минь.

-- Аваад ир гэж чамд хэн хэлсэн юм бэ?

-- Түүнийг хүнээр хэлүүлээд яах юм бэ гэж Төмөр хэнэггүй хариулав.

-- Би хэлэлцээр хийх гэж байхад чи агтыг нь хөөгөөд ирсэн байдаг. Хүн алсан уу?

-- Гурван бээвийсэн юм байсан уурганы бөгсөөр гуядсан үсэрч л орхино билээ. Арай үхээгүй байх аа.

-- Агт үлдсэн үү?

-- Үлдсэн байхаа. Энд барагцаалвал гурван зуугаад л юм байна билээ.

-- Миний хэлэлцээр хийх гэж байгааг чи мэдсэн үү?

-- Мэдсэн. Чингээд морьтой хүнтэй ярьж байснаас явган хүнтэй яривал үгэнд орох нь дээр байх гэж бодсон юм.

Хатанбаатар тэсэж чадалгүй инээд алдсанаа:

-- За юу ч гэсэн хүн явуулья гэлээ.

Өчигдөр хошуу тамгын жасаан дээр Бакичийн цэрэг ирэхэд ямбаныхаа бүрэн хувцсыг өмссөн ноён угтагчдын тэргүүнд зогсож байсан билээ. Бага үд өнгөрч Бакич цэргийнхээ өмнө цагаан морь унаж хар нөмрөг өмсөөд сүртэй гарч ирлээ. Ноён туслагч хоёр мэхэлзэн угтаж авлаа. Дараа нь орос цэргүүд бэлтгэсэн гэрүүдэд хуваагдан буужээ. Хошуудаас дайчилсан монгол цэргүүдийг майхан барин нилээд зайтай газар хуарагнуулав.

Үдээс хойш генерал хошууны ноён туслагч хоёрыг гэртээ урив.

-- Та бүхэн намайг хүндэтгэн хүлээн авсанд туйлгүй баярлалаа. Энэ бол монголын ноёд, угсаатан нар баатар цагаан хаан, их орос улсыг талархан үздэгийн гэрч билээ гэж Бакичийн хэлснийг монгол хэлтэй орос орчуулан өгөхөд «Жа» гэж ноён туслагч хоёр зэрэг өчив.

Генерал том гэрт битүү дэвссэн хивсэн дээгүүр ийш тийш алхаж баахан явснаа зогсож:

-- Монгол оронд самуун дэгдэж улс төр вймж байна. Би үүнийг зогсооно. Ноён та зэвсэгтэй

морин цэрэг, дор хаяж хоёр зууг гурван хоногийн дотор бэлхэн болгож өгнө гэдэгт итгэж байна гэснийг монгол хэлд орчуулж өгөв.

-- Жа гэж хөг нийлүүлэн давтлаа.

Монгол хэлд Бакичид цэрэг татахыг эсэргүүцсэн хошуу захирагчийг хар гэрт хорьсон тухай ярив.

-- Түрүүлж ирсэн хүмүүс захирагчийг хар гэрт хорин чилээж байгаа бололтой. Дайны вед аргагвй юм байдгийг эрхэм та бүхэн юун андах билээ гэж Бакич хиймэл дотно дуугаар хэлээд хагас мэхийн ёслол.

-- Жа мэдлээ гэж тэр хоёр хариу мэхэлзэв.

-- Би захирагчтай өөрөө ярина. Их хэргийн төлөө та бүхэнд ажил удаж байгаадаа би уучлал гуйж байна. Монгол орон их орос улсын дэмжлэгээр хятадаас салсныг монголын ноёд лав мартаж болоогвй байх гэж би итгэнэ хэмээн генерал ёжтой боловч намбатай бүдүүн дуугаар хэлэв.

Орос жанжины хвйтэн царай, ёгт үгнээс цөс нь хайлж, сүнс нь зайлсан ноён туслагч хоёр цэрэг татах тушаал шийтгэн хэдэн зүгт тахар гаргав.

Тэр орой Бакич хошуу захирагчийг ирүүлж их л хүндэтгэсэн маяг үзүүлж ёсорхон яриагаа эхлэв.

-- Миний явуулсан хүмүүс ёс алдаж, эрхэм захирагчийг барьж хорьсонд би тун их харамсаж байна.

-- Би ч мөн харамсаж байна.

-- Цагийн байдал түвшүүртэй болж, улс гэр сүйдэх гэж байгааг захирагч та сайн мэдэж байгаа болохоор ярих юун билээ. Бид их орос улсын цэрэг, Богд эзэнт монгол улсад тусалж, улааны хөнөөлөөс аврах зорилготой. Үүнийг хийхэд та бүхэн дэмжиж, нутаг орноосоо цэрэг дайчлан өгөх нь зүйн хэрэг.

-- Нэгдүгээрт хошуу ядуу, хүн ард цөөхөн. Хоёрдугаарт их орос улсын та бүхэн өөрсдөө дийлж чадагвй улаантныг ядуу бидэнтэй нийлээд яаж дарж чадах билээ.

-- Та бүхэн бидэнтэй хамтарвал улааны цэрэг монголд орж ирэх ёсгвй биш үү?

-- Манай улсын төв засгийн газар улааны цэргийг урьж ирүүлснийг та лав болгоож байгаа биз дээ. Ингэж хэлсэн генерал захирагч хоёрын яриа эцэстээ ширүүсэж захирагч, «Төв засгийн газрын шийдвэргвйгээр та нарт морь, хүнс, цэрэг нийлүүлж чадахгвй» гэж билээ. Бакич улааны хувьсгал дэлгэрсэн монгол оронд удаан тогтож чадахгвй гэдгийг сайн ойлгож байв. Энэ учраас хорогдох газар бол хятад. Гэтэл хятад хүртэл их зай байжээ. Бас замыг нь Хатанбаатарын цэрэг, монголд туслах гэж ирсэн улаан армийн ангиуд хаажээ. Ийм вед зөвхөн нутгийн хүмүүсээс тал олж, тэднээс хүч сэлбэж чадвал зорьсондоо хүрнэ. Хэгжүүн захирагчийг доор нь цавчиж орхимоор байсан авч худал инээмсэглэн үдэхдээ «Бид хоёр лав ярилцаж тохиролцоно гэж бодож байна. Одоохондоо би таныг суллан тавьж чадахгвйдээ тун харамсаж байна. Гэвч энэ цаг удахгвй ирнэ гэдэгт итгэнэ» гэжээ.

Бакич шөнө орой болтол хэдэн даргатайгаа хөзөр тоглож баахан архидаад унтав. Гэтэл өглөө нэг дарга ирж өнгөрсөн шөнө манааны хоёр монгол, нэг орос цэргийг цохиж алаад агтыг нь хөөгөөд явчихсан тухай гунигт мэдээ сонсов.

Энэ хошуунаас унаж болох дөрвөн хөлтэй бүхнийг дайчил. Эсэргүүцсэн хүнийг дор нь бууд гэж генерал хашгирахад дарга «за» гээд ёслоод гарлаа.

Гэтэл гаднаас орж ирсэн өөр нэгэн дарга Хатанбаатар Магсаржавын элч бичиг хүргэж ирснийг мэдэгдэв. Удалгвй гаднаас Магсаржавын элч орж ирээд генералд бичиг өгөв.

Монгол хэлт бичгийг задлан орчуулж өгсөнд Бакичийн царай барайж хөмсгөө зангидан хэсэг

дуугвй суулаа. Хатанбаатар цэрэг зэвсгийн нь тоог өөрөөс нь илvv мэдэх ажээ. Чингээд бууж өг гэж ийм зоригтой шаардаж байгааг бодоход тvvний хvч vлэмж бололтой. Энэ учраас юу ч гэсэн хэлэлцээр хийх нь зөв гэж мухардсан генерал шийдээд монгол хэлэн дээр бичиг хийлгэн элчид өгч «би өглөөний нарнаар Хатанбаатарыг хvlээн авахад бэлхэн байна» гэлээ. Элч буцаж очоод өгсөн бичгийг Хатанбаатарт барихад яаралгvй задлан уншаад «Би Төмөрийг дагуулан явж Бакичтай уулзана. Өглөө нуурын мананг ашиглаж монгол цэргийн хуаранг эзэлж аваад цааш маш тvргэн хөдөлж орос цэргийн гэрvvдийг бvсэл» гэж Хуягт тушаав.

-- Ямар зэвсэгтэй явах вэ? гэж дуудагдаж ирээд юунд хэнтэй явахаа мэдсэн Төмөр асуув.

-- Хэлэлцээр хийх улс зэвсэгтэй явна.

-- Энэ ташуурыг аваад орж болох уу гэж Төмөр жижиг яргай ташуур vзvvлэв.

-- Тэр олон хурдан буутай улсын дунд ийм юм байсан байгаагvй хоёрын ялгаа юу байх вэ гээд Баатар инээмсэглэв.

-- Гэрийн ялихгvй зодоонд энэ чинь ямар ч хурдан буунаас дээр дээ, жанжин минь.

-- Цахиур Төмөр ч мөн дөө гээд Магсаржав сэтгэл дvvрэн инээв. Өглөөний нарнаар Төмөрийг дагуулсан Хатанбаатарыг ирэхэд Бакич гэрийн гадна зогсон угтаж авлаа.

Харилцан ёс гvйцэтгэсний дараа Хатанбаатар:

-- Генерал та цэрэг дагуулан хvний нутагт зvй бусаар орж ирсэн болохоор зэвсгээ даруй хураалган бууж өгөхийг шаардаж байна. Эсэргvvцвэл та юу болохыг бvрэн мэдэж байгаа биз дээ гэлээ.

-- Оросын цэрэг монголд орох гэрээ буй шvv дээ.

-- Нэгдvгээрт тэр гэрээг бидэнд хvчээр тулгасан. Хоёрдугаарт тэр орос улс байхгvй. Оронд нь тогтсон шинэ орос улс монголын хэрэгт оролцохгvйгээ тунхагласан.

-- Бидний амь биеийг хамгаалан хятадын нутаг руу гаргаж өг.

-- Бууж өгвөл амь биеийг чинь хамгаалж болно. Харин хятадын нутаг руу гаргахыг бид амлаж чадахгvй.

-- Генерал цэргийг нь хятадын нутагт саадгvй гаргах шаардлага тавиад, Магсаржав тvvнийг vл зөвшөөрөв. Гэтэл нэг цагаантан ирж монгол цэрэг урвасан тухай хэлж амжаагvй байтал Хатанбаатарын цэрэг орос цэргийн гэрийг бvслэн авсан тухай мэдээ ирлээ. Цагааны дарга нэг буу гаргасныг Төмөр бvдvvн ташуураар цохисон нь буугаа алдсанаар барахгvй бугуйн яс нь бяц vсэрчээ.

Удсан ч vгvй Бакич ба тvvний цэргийн зэвсгийг хураан буулгах ажил дуусав.

Хатанбаатарын зарилгаар ноён туслагчийг огцруулан хошууны хэргийг захирагчид шилжvvлж баригдсан цэргийг хvрээ рvv тэмээн жингээр хvргэх болжээ.

V

Хvрээнд цагаан сар болов. Баян хvний бахдалын сар, хоосон хvний хохирлын сар гэж хvрээнийхэн цагаан сарыг хэлдэг. Энэ vнэн vг. Учир баячууд хэд хэдэн хонины ууц тавьж айраг, архи бялхуулан сайн дээлээ өмсөж, сайхан морио унаж бие биедээ гийчлэн нэгээсээ авсан бэлгээ нөгөөдөө дамжуулан өгч, цэнгэдэг. Иймд цагаан сар бахдалын сар байдаг.

Харин ядуу зvдvv нь бол олны урсгалд татан онгирч орон гэрээ цагаан сар өнгөрмөгц буулгаж өгөхөөр худалдаад мөнгөөр нь хэд хоног цэнгээд дараа нь боож vхэхэд хvрдэгийг аль тэр гэх билээ. Иймд нь бол цагаан сар хохирлын сар байдаг.

Харин гар хоосон гуйлгачин хvнд цагаан сарын өдрvvдэд гэдэс цадаж авах завшаан болдог. Энэ ч учраас цаг, цагт нь цаддаг, цагаан сараар нэг цаддаг, ve ve нэг цаддаг, vхэр алахад нэг цаддаг гэж ярьдаг байлаа.

Хврээний энэ жилийн цагаан сар урьдахаас шал өөр цагаан сар юм. Гамин Бароны хөлд вймж нэрвэгдэн өглөө болоход яасан байхаа мэдэхгүй байсан хврээ сүүлийн хэдэн жилд олигтой цагаан сар хийж чадаагүй, гамингийн сүр хвчинд сүүл нь босон зарим худалдаачид хятад 1920-1921 оны өвөл хврээнийхэн гэнэн цагаан сэтгэлээр цагаан сарын аар саар юм худалдан авах гэхэд нь «энэ жил танай цагаан сар улаан болж магад, улаан чавга авбал звгээр биш үү?» гэж доромжилж байв.

Түүнээс хойш жил өнгөрөв. Энэ нэгэн жилийн дотор хврээний амьдрал олон шинэ зүйл болжээ. Хврээнд улаан сар бэлтгэж байсан гамин өөртэй нь адилхан идэш эрх монголд ирсэн Баронд дарагдан Хиэгтын зүг дээрмийн зам татуулан арилжээ. Барон хврээнд жаргал авч ирсэнгүй. Орж ирсэн өдрөө хүн дүүжилж, буудаж, эд хөрөнгийг нь дээрэмдэж эхлэв.

Гэвч тэр бүхэн «дөтийн замаар» тонилоод идсэн эрүү хувхайрч идүүлсэн бут ногоорон хврээ шинэ засгийн анхдугаар цагаан сартай золгожээ.

Хврээнд цагаан сар болж хүмүүс аль олигтой дээлээ өмсөж айл хэсэн «Сар шинэд сайхан шинлэж байна уу?», «манайд очоорой», «Танайд очиж золгоно шүү» гэж бүдүүн нарийн дуугаар давтан золгоцгооно.

Цэцэн ханы хороо гэдэг одоодоо хадгалж байгаа Зүүн хврээний нарийхан бөгөөд махир гудамжаар цагаан хурган үстэй цэрэг шовгор малгайтай шинельтэй хүн, цэрэг эмээлтэй тарган хврэн морь унаж амандаа дуу аялан алхуулна. Нэг ташаанд нь модон хуйтай сэлээдий, нөгөөд нь морин цэргийн урт сэлэм харагдана. Нилээд согтсоноос улаан зээрд болсон царайд нь бардам бөгөөд амьдралдаа ханасан сэтгэл тодорно.

Энэ бол Жамбал байлаа. Павловыг барьж өгч, ардын журамт цэрэгт ороод бичиг мэдлэгийн ачаар бэлтгэлийн бичээч хийж эхлээд яван явсаар цэргийн бэлтгэлд том нь биш боловч овоо мэдлэгтэй дарга болжээ. Ялсан цэргийн дарга нараар нүүр хийж хот газрын хөгжилтэй амьдралд умбан хэд хэдэн овоо бүсгүйчүүдтэй нууц амрагийн холбоо тогтоожээ. Энэ бүхнээс Жамбалд ардын засгийг зангах учир байсангүй эвийг нь олж зүтгээд байвал нэгэн цагт төрийн том хүн болж, хул дүүрэн шуугиж байгаа айраг шиг амьдарч болох мэт санагдана.

Жамбал явсаар хврээ Юндэнгийн хаалган дээр очиж буугаад бага хаалгын сурын татан мөрөөрөө түлхэн нээгээд морио хөтлөн орж хэдэн морь уясан саравчтай уяанаас уяв.

Ханхар хашааны дунд барьсан том цагаан гэрээс шар одон хээтэй, хврэн торгон дээл өмсөж, урт бөгөөд бүдүүн сувдан санчиг хоёр энгэр рүүгээ унжуулсан залуухан дэгжин хүүхэн шагайснаа «Жамбал дарга байна» гээд гарч гэрийн зүг үл мэдэг гуйван яваа Жамбалыг угтан аальгүй нүдээрээ тоглон инээмсэглэж байв.

-- За сайхан шинэлж байна уу гээд Жамбал хүүхэнтэй золгох гэснээ бэлхүүсээр нь тэврэв.

-- Юндэн харчихна. Битгий маягла гэж хүүхэн шивэгнээд нүдээ маягтайхан солби татаж ёвров.

-- Сар шинэ болж байхад үс гэзгээ тавьдаггүй яасан задарсан эхнэр вэ гээд Жамбал хаа хаа инээв.

-- Миний үс ч яамай ардын засаг мандаж, аймгийн хулгай ч хүртэл дөнгөнөөсөө салж байхад бид үүний дараа үснээсээ салах нь зөв юм биш үү. Чи ч яахав дээ. Манайхыг хундага архигүй гэж бодоод шал согтуу ирж байна уу. Хаалгаар минь багтвал ор л доо гэлээ

Жамбал хамрын уг дээрээ арьсаа хураан үрчийлгэж нүд ирмэн инээгээд гэрт орлоо.

Том гэрийн хоёр талд хашин өртэй суман ширээ тавиад их гарын гуулин царанд хөл

хүрэхгүй хоёр тарган иргийн ууц тавьж айраг, архийг том гэгчийн эрээн бааранд сөгнөжээ.

Гэрийн хоёр талд эгнэн суусан хүмүүсийн зарим нь айраг зарим нь архи ууна. Жамбалыг ороход бүгд босож золгон цагаан сарын мэнд солилцов.

Энд Цамба байлаа. Тvvнтэй Жамбал их л дотносог золгож мэндлээд

-- Өчигдрөөс хойш чамайг эрж гандан хүрээний нvх бvхнийг сийчлээ гээд инээв.

-- Гэрээ мартсан гэсэр гэгчээр vгээр л айл хэсэж явна.

-- Хорвоогийн ариун санваартан гээд л гандан хүрээгээр ирээд байсан чинь хороогоор явдалтай зальхай байж л дээ гээд Жамбал чанга инээхэд хvmvvc хөгжилтэйгөөр дагаж инээв.

-- За дарга дээшээ суу. Аль вэ айраг, архи хийж барь гэж хүрээ Юндэн их л зочломтгой хэлэв. Жамбал мөр тэргvvлэн сууж хvндэт зочдын ёсоор дайлуулж байхдаа гамин, цагаантай эрэлхэг байлдсан тухай санаандаа орсны зоргоор галлаж байлаа.

Жамбалын шорвог яриаг сонсох хvсэлтэй хvнгvй боловч ялсан цэргийн даргыг зусардах сэтгэл олныг дарж анхааралтай сонсогчид болцгоон «мөн ч зоригтой байна даа», «аргагvй самбаатай хvн юм даа» гэж худал магтан шогширч байв.

Сvрхий согтсон Жамбалыг гарч сэrvvцэхэд нь гэрийн эзэн хамт гараад

-- Өвгөн чинь чиний тусыг мартахгvй. Овоо ч хонжоо гарсан. Чи цавдир морийг минь шалаад байдаг. Аваарай л даа гэлээ.

-- Өвгөнд чинь тоолоод өгчих юмгvй л байна шvv.

-- Хээцэс. Чамд цагаан сарын алчуур болгоод өгч орхиё. Харуулын суманд танилтай юу?

-- Надад муу сайн танил мундах биш дээ гээд Жамбал бардам инээмсэглэв.

-- Тэр ч vнэн байх аа гээд хүрээ Юндэн хоолойдоо зальтай инээснээ царайгаа төв болгож:

-- За хөө, харуулын сумангийн хоол нийлvvлэх ажил байна гэнэ. Чи ярьж байгаад над авч аль. Чамайг гомдоохгvй.

Хөвчийн жонон вангийн хошуунаас эхэлсэн vхрийн шvлхий зvvн аймагт тарж байгааг сонссон Юндэн хямд vнэтэй мах олж, ашиг гаргах таатай нvх олсон юмсанжээ.

-- Урт чихтэй эд юм даа чи чинь гэж Жамбал хэлээд Юндэнг ширтэв.

Жамбал харуулын сумангийн аж ахуйн даргыг таньдгаар барахгvй хоёр хоногийн өмнө цэргийн хоолны мах тасарч сандрангуй явахад нь замаас нь ашиг цохих гэж бодоод «махны гэрээ хийх хvн чамд олж өгье. Чи надтай л яриарай» гэсэн юм. Энэ ч учраас тvvнийг олж мэдсэн Юндэнг «урт чихтэй» гэж хэллээ.

Гэтэл Юндэн өвчтэй vхрийн мах авч цэргийн хоолонд нийлvvлэх гэсэн санааг Жамбал мэдэв гэж бодоод сандарч

-- Юун урт чихтэй байх вэ дээ. Өвгөнд чинь баруун аймгийн нэг баян хvн хэдэн шарын өртэй юм. Удахгvй тvvндээ явна гэлээ.

-- Чамд байна олж өгье гээд цээжинд нь оргилсон баяраа нуух гэж тvргэн эргэж гэрийн зvг явлаа.

Жамбалд баярлах хоёр шалтгаан байв. Нэгдvгээрт ашиг олохын баяр, хоёрдугаарт хүрээ Юндэн хөдөө явж саяхан авсан залуу эхнэр Жамбалын мэдэлд vлдэх баяр байв. Энэ ч учраас Жамбал тэр дороо явж харуулын сумангийн аж ахуйн даргыг авчран хүрээ Юндэнгийн гарт хийж өгөөд найрлажээ.

Тэр өдрийн өглөө Бат Жаргал хоёр багш Чулуун зангийн ирж илvv гэрт нь зочдын хоол хийж өнжив. Чулууны баруун хамрын тал шиг том хашаа бол хүрээ Юндэнгийнх юм. Тэднийд болж байгаа найрын дуулах, хуалах шуугиан мань хоёрт тод сонсогдоно.

Орой нар жаргахын вед хоёр залуу гарч тvlээ хагалан сэrvvцэхдээ Юндэнгид юу болж байгааг хашааны завсраар шагайн харлаа.

-- Тэр цавьдар морь ёстой л согоо байна. Унахад яасан хөнгөн бол гэж Батын хэлэхэд Жаргал «Ийм баян айлд юу эс байх вэ дээ» гээд өнгөрсөн хаврын нэг өдөр мах vврч ирэхэд нь гоё эхнэр том гэгчийн ул боов өгсөн тухай ярилаа.



-- Гэрт нь орж үзсэн үү?

-- Намайг хаанаас оруулах юм бэ?

Гэрээс Жамбал, Цамба хоёр гуйван гарч ирээд хоёр залуугийн нүдний өмнө хураалттай байгаа түлээн дээр суув.

-- Энэ хоёр хүнийг би танина. Нөгөө миний ярьдаг Жамбал, Цамба хоёр шүү дээ гэж Бат шивэгнэж хэлэв.

-- Ийм улс юм уу? Нэг нь цэргийн дарга болж шүү дээ.

-- Жамбал л байна..

Түлээн дээр сууж байсан Жамбал босож суниахад түүний баруун гарын дунд хуруундах том алтан бөгж нарны гэрэлд гялалзав.

-- Ямар сайхан бөгж вэ гэж Цамбын хэлэхэд Жамбал бөгжтэй хуруугаа өмнө нь үзүүлэн нөгөө тэр жилийн алман маниадаар цохиулсан юм. Сайн хийсэн юм шүү.

-- Ямар алтан маниад?

-- Яагаав дээ анги Эрэнчинг түншиж орхиод богдоос хүртдэг маниад.

-- Мартаж орхиж шүү. Богд ч түүнийг нэг далд хийе гэж үнэхээр бодсон дог оо. Мөн үнэ хүрсэн шүү гээд Цамба баяртай инээв.

Жамбал, Цамба хоёрын энэ яриаг Бат нэгд нэггүй сонсоноор барахгүй босон харайв. «Чи ямар ухаантай хүн байж вэ дээ гайгүй, муу сайн яргачин» гэж нам боловч гүн хэлэв. Жамбал Цамба хоёр ярилцан цааш явлаа. Батын сэтгэлд бүх болсон явдал багшийн нь хэлж байсан үг жирэлзэн өнгөрөв. «Богдын гар урт юм шүү дээ» гэсэн багшийн үг бодолд нь тодрон үлдэв.

-- Сохор түвдийн заавраар багшийг чинь алсан хар яргачин гэж Бат хэлээд эргэж гүйн сүх барьж авлаа. Анги Эрэнчингийн үхсэн тухай Батын яриаг олон удаа сонссон Жаргал бүх учрыг мэдээд Батыг барьж авлаа.

-- Чи одоо яах юм бэ? Галзуурч байна уу?

-- Үгүй харин ч бүр ухаантай болж байна. Хоёр яргачдын толгойг.. гээд Бат хашаа руу тэмүүлэв. Баттай ноцолдох зуур Жаргал

-- Ямар тэнэг амьтан бэ чи энэ хоёрыг алаад яах юм бэ? Алж чадах ч үгүй. Багшийг чинь алсан хорын үндэс бол Богд байна. Гэтэл Богдыг чи одоодоо битгий хэл, Шарав багш дийлэхгүй байгаа шүү дээ. Өшөөг ухаанаар авахаас биш уурын мунхгаар авч чадахгүй гэх зэрэг олон юм ярив.

Бат сүх барьж авахдаа шууд хашаан давж гэрт ороод Жамбал, Цамба хоёрын толгойг хага цохиё гэж шийдсэн билээ. Чингээд нэг зүтгэлтээр бараг хашааны оройд гарахад нь Жаргал хөлөөс нь татан буулгажээ. Харин сүүлд нь халуун хорсол нь дарагдаж мунхаг ажлаа ойлгосон боловч багшийнхаа хариу авах бодлоос ухарсангүй.

Бат хүзүүндээ хэзээ зүүснийг мэдэхгүй үргэлж зүүж явдаг булигаар гэртэй сахиусныхаа оосрыг таслан авч шидэв.

Ижий нь тэр булигар гэрт Богдын баринтгийн өөдөс байгаа гэж хэлдэг байсан юм. Маргааш өглөө нь эрт босож Жаргалаас нуугдан Богдын өвлийн ордны үүдэнд очоод орох гэхэд нь хоёр мундаг лам зодоод зайлуулав. Яах юу гэхээ мэдэхгүй гайхан, Өшөө хорслын галаар цээж нь оволзон байтал мөргөлчин цугларан ирэв.

Өвлийн хүйтэн өдөр жижигхэн ширхэгтэй цас хялман бүх юмыг битүү саарал өнгө даржээ.

Батын дэргэдүүр нь мөргөлчин өнгөрөн гарч ойрхон шиг очоод сөхрөн сууж залбиран мөргөнө.

Бат гэнэт мөргөлчдийн өмнө үсрэн гарч «олон түмэн ардаа! та нар энэ сохор түвдэд битгий мөргө. Энэ түвд чинь миний багш анги Эрэнчинг олон маниадаар алуулсан яргачин..» гэтэл

олны дотроос хэдэн хvн босож ирээд «чи галзуу амьтан уу»гэлээ.

Бат хариу хэлэх гэтэл «галзуу золиг байна», «нөгөө эцэг эхээ ална гэж тангараг өргөсөн улааны новш бололтой», «зад цохиод энэ ариун орноос зайлуулж орхи» гэж хашгиралдав.

-- Энэ балай тvвд чинь манай Шагдар багш.. гэтэл хэдэн хvн дайран ирж нvвр нvдгvй балбаж эхэлснээр барахгvй эхнэр хvvxэд, бvр чавганц нар хvртэл өшиглөж чөтгөр шулмас чаралба, ландром гэж нэрлэв.

Энэ аймшигт занчилтад Бат яаж тэсэх билээ. Ухаан алдаж унасан боловч довтолт зогссонгvй. Цус нөжтэйгөө холилдсон Батыг хэдэн хvн дамжлан хаяа голын мөсөн дээр шидэв. Хялмайж байсан цас vргэлжлэн орж удсан ч vгvй хvрээ нимгэн цагаан дээлээ өмсөв. Туулын голыг даган хvйтэн салхи vлээн Батын хамар амаар гарч байгаа цус нь мөсөн дээр ягааран царцаж бие нь цасанд дарагдана.

## VI

Шороо шуурсан хаврын нэгэн зэвvн өдөр Итгэлтийн урт жингийн цуваа хvрээнд орж ирлээ. Гамин, Бароны vймээний жилд жинтэй битгий хэл, дан морьтой хvрээ орж ирээгvй Итгэлт энэ жил ийм орой Тамирын хөндийн шар тос, цагаан идээ, арьс ширийг хамж ачсан урт жинтэй ирдэгийн учир юу вэ? Хvрээнд тогтсон ардын засгийн ааг занг товтой мэдээгvй байж их хөрөнгө хөдөлгөх тийм гэнэн бодол Итгэлтээс яаж гарах билээ. Ардын засаг хvний юмыг гамин, барон шиг дээрэмдэн цөлмөдөггvй, наймаа арилжаа хийхэд саад тотгор алга гэдгийг хvрээ орсон хэд хэдэн хvнээс багтай мэдсэний эцэст Итгэлтийн гаднаас урт жингийн цуваа олон хөгтэй хонхоо дvнгэнvвлэн хөдөлжээ.

Жин хvрээнд бууснаас хоёр бvтэн хоносон авч Богдод мөргөх ганц хvсэлтэй ирсэн Ням өвгөн хvрээг vзэж чадсангvй. Жин буумагц нэг хvний хамт майхан авч толгойтын аманд шар хариулахаар гарчээ.

-- Зэвvн байна ходоодоо дулаацуул гэж Итгэлт явахад нь их гарын цагаан бөгст хар архи өгсөн нь өвгөний Богдод мөргөх хvслийг мартуулснаар барахгvй «Энэ шааруудыг надаас өөр хэн таних вэ дээ» гэж хэлvвлжээ. Очсон орой нь том дvгрэг мөнгөн сар гийгvвлэн гарахад хамт vхэр хариулагч нь тvвнийг харж байснаа «Пээ яасан сайхан сар вэ. Манай Тамирт гарч байгаа болов уу» гэж асуухад Ням гуай их л мэдэмхий дуугаар «Хаанаас гарах вэ энэ чинь бурханы орон Богдын хvрээний сар. Чингээд ийм том тунгалаг байгаа юм. Манай Тамирт жижиг байдаг шvв дээ» гэж хэлжээ.

Цаг улирал зэвvн, салхи ихтэй боловч нэгэнт хавар эхэлсэн болохоор урин ve гэдэг нь юм бvхнээс тодорхой байлаа.

Олон хоногийн аянд ядарсан шар нь нутаг голохгvй тогтон иднэ. Ийм вед цагаан бөгстөө тэврэн галтай майханд бууж байхад Богдод мөргөх тухай бодох зай Ням өвгөн даанч байсангvй. Харин хоёр дахь өдрийн өглөө босоод хоосон лонхоо шиншилж, гомдолтой санаа алдаад «Итгэлт гайхал муу өвгөнийг хэдэн шартай энд тагт насан турш аргамжъя гэж бодоогvй бололтой» гээд босож майхны зөрvүлсэн ваадангаар толгойгоо цухуйлган хvрээний зvг харж билээ.

Ашгvй тэр орой Итгэлтийн явуулсан хоёр хvн очиж Ням нөхрийн хамт халаагаа өгөөд хvрээ рvв явах болжээ.

-- Хvvxдvүд минь. Суварган хараар толгойлуулсан хэдэн хайнаг загатнаад байдаг шvв. Шөнө уяж орхиорой гээд Ням явжээ.

Нямыг очиход хийсэн наймаанаас vлэмж ашиг олж баярлан нилээд согтуу байсан Итгэлт их л дотно уулзаж халаасан ганзай сайхан хоолоор дайлж:

-- Ням гуай өглөө гэгээнд мөргөж нvгэлтэй буурал толгойгоо ариутга гээд гурван мөнгөн

янчаан өгөв.

-- Гэгээнд мөргөөд гэлэн болох нь ч юу юм бэ. Гэм нүгэл хийсэн бол арилах байх гэж бодох юм гэж хэлээд Ням халуун ганзай шимж байлаа.

Ням гуай хүрээ их хол гэл үү?

-- Яриад яах вэ. Хүрээ гэдэг хол. Хүний амь гэдэг бүх эд ээ гэхэд бүгд хөнжилтэй инээв.

-- Ням гуай та их юм үзэж байна гэл үү?

-- Хэлээд яахав, Тамирын голын хөндийгөөс гарвал гэмсэг хорвоо даший шог. Ноорсон муу Хишигт минь талийвал ертөнцийн хүн даший шог гэж бодож явсан. Би их л юм үзлээ гэж өвгөний хэлэхэд халмаг хүмүүс улам хөгжилтэй шуугилдан инээлдэж билээ.

Ням өглөө эрт босож Богдын ордныг заалгаж билээ. Байн байн өврөө дарлан алчууртаа янгинатал боож сугандаа хийсэн мөнгөн янчааныг барьж үзлээ.

Нээлттэй хэдэн дэлгүүр дайралдахад нь намбатай гэгч нь алхан орлоо. Лангуу дээгүүр нь өнгийн ийш тийш баахан харлаа. Барьж үзэх нь битгий хэл олж хараагүй торго дурдан зэрэг түмэн зүйлийн юм нүдэнд нь тусна. Ямар нэгэн танил бөгөөд аятайхан үнэр хамар руу цохилоо. Өвгөн эргэн тойрныг харвал тэртээ буланд халбага дүрсэн лүүтэй архи харагдав.

— Хурц үнэртэй дамшиг бол доо гээд түргэн эргэж нөгөө тийшээ буруулан харснаа, - За наймаа юу байна гэлээ.

— Ай хүний хар нүднээс бусад юм цөм байна. Чамд юу хэрэгтэй?

— Хүний цагаан нүд хэрэгтэй, байна уу?

Худалдагч арзгай хар шүдээ гарган зальтайяа нүдээ жартайлган худал инээснээ:

— Өвгөн чамд юу хэрэгтэй. Шулуухан хэл гэлээ.

«Шүдий нь, Хишигтийн саварны шүд шиг. Өмд үгвй байж өвдөг цоорхойг шоолоод ч яахав» гэж бодоод

— За хө тэр чирчүүг үздэг хэрэг ээ гэв.

Худалдагч хуй хөх чирчүүг авч өдөн дэвүүрээр хэдэн удаа савснаа Нямын өмнө тавилаа. Чирчүүг үзэж байхад Нямын нүдний булан архины зүг хэд хэдэн удаа чиглэж харах бүр ярвайна. Ням худалдагч хоёр зургаан ам чирчүүний үнийг хаялцаж гарлаа.

Хүрээ орсон хүн байна ганц охиндоо дээлийн юм аваачиж өгье гэж бодсон Ням бараг хагас өдөр үнэ хэлэлцэж байгаад чирчүүг авч бүсэндээ хавчуулав.

Чингээд гарах гэснээ өврөө даран амьсгаалан хэсэг зогсов.

— Данжаад аа, жин архи яаж вэ?

— Манай архи сайн. Бас тэгээд хямд. Тавин мөнгө

Ням бүдүүн дуугаар ха ха гэж хөгжилтэй инээснээ:

— Унгадаг золиг вэ! Таван мөнгөөр авъя гэлээ.

— Жин архи таван мөнгөөр хэзээ авч байсан.

— Авч л байсан даа.

— За шулуухан дөчин мөнгө.

— Арван шөнө.

— За яахав таньсан хүн гучин таван мөнгө. Чи ийм архи олохгүй.

— Ийм муу архи олохгүй нь үнэн байхаа.

— Чи үз гээд худалдагч халбагаар хэдэн дусал хутгаад Нямд өглөө.

Ням нэгэнт амталсан хойно яаж тэсэх билээ дээ. Хорин мөнгө гэж хэлье гээд гай болсон хэл нь халтираад гучин мөнгө гэсэн чинь «За яахав таньсан хүн байна өгье!» гээд сурмаг хөдөлгөөнөөр халбагадан хутгаад авчирч «Чи саваа аль» гэжээ.

— Данжаад аа миний хэл халтираад би буруу хэлж орхисон байна. шулуухан хорин мөнгөөр

авна.

— Ийм настай хvн байж наймаа буцаж болохгvй гээд худалдагч ууртай хэлэв.

— За за. Авъя. Аяга аваад ир гээд Ням цагаан сэтгэлээр нvдээ анивчин инээв.

Жижиг шаазангаар нэг дугтарсан чинь бvх биеийн нь хөлс чихран гарч халаасан ганзайнаас пологтсон шар нь тайлагдав. Ням шаазандаа дахин хийж “За данжаад нэг тогтоож орхи” гээд худалдагчид өгөв.

Худалдагч эргэж хялайн харснаа аягатай архийг бушуухан авч шимэн уугаад дахин эргэж харлаа. Ням дахин нэг хийж тавтай гэгч шимэн ууж байтал хvрээний гудамжны архичин нэг өвгөн орж ирээд хоёр өвгөн лангуу тvшин шалан дээр тавтай завилан суун ууснаар барахгvй Ням мөнгө гаргаж дахин авч хоослов.

Нэг мэдэхэд гурван мөнгөн янчаан сураггvй алга болоод архичин өвгөн ч vгvй болсонд Ням гудамжинд гарч «Хоёр хангайн нутаг ...» гэж бувтнан гиншиж салдархилэн алхав.

«Хоёр хангайн нутаг ...»-аа давтан гудамжны хоёр талыг мөрөөрөө ээлжлэн цохиж явтал өмнөөс нь ижилхэн ногоон дээлтэй хоёр залуу ярилцан гарч ирлээ.

Энэ бол оюутны сургуулийн сурагч Бат, Жаргал хоёр байжээ. Хатуу ширvнн жанчуулсанаас удаан өвчтэй хэвтээд арай гэж хөл дээрээ боссон Бат анд нөхрөө дагуулан таньдаг айлаар ороод яваа нь энэ билээ. Бат өмнөөс нь гуйван ирж яваа согтуу өвгөнийг харснаа «Ням гуай» гээд гvйн очиж гараас нь барив.

— Чи чинь хvрээний дээрэмчин vв?

— Ням гуай. Би Бат байна. Ижий минь сайн байна уу?

Ням өвлийн цасны ятуу шиг нvдээр Батыг ажиглан харснаа «Зайл, Та хоёр чинь тэр нэг ядуу бvсгvйг алах гэж төрсөн амьтад уу!» гэж хашгираад Батыг тvлхэх гэснээ гэдрэгээ унав.

— Ням гуай. Ижий минь сайн байн уу? гэж Бат хоолойгоо чичрvвлэн хашгирав.

— Ум маани бад ми хум. Хар төмөр дотортой зулбасга минь. Өдөр бvхэн мянган маань уншиж бай

— Ижий минь ... гэж хашгираад Бат гэдэргээ болоход нvд нь нулимсаар дvврэв.

— Нvгэлтэй золиг. Ум маани бад ми хум. Эрлэг номон хааныд очоод тэр эхдээ юу гэж хэлэх амьтан бэ? гээд босож Бат руу гөлийн харснаа найган явжээ.

Бат хашаа тvшин авч эхэр татан уйлав. Жаргал юу ч дуугарч чадахгvй тvвний дэргэд зогсож байв.

Өвгөн «Хоёр хангайн нутаг...» гэж гиншин аялсаар далд ороход хоёр залуу харсангvй алджээ. Маргааш өглөө нь нар мандахын вед Итгэлтийн урт жин Хамбын овоо өнгөрөн нутгийн зvг зам хөөж байв. Ням өвгөн тvвчээ тэргэн дээр хөдлөлгvй хэвтэнэ. Тэр хоёр залуутай дайралдсанаа мэдэхгvй зөвхөн зvвдэлсэн мэт бодно.

Хоёр дахь өдрийн буудал дээр дан морьтой хоцорсон Итгэлт гvйцэж ирээд:

— Ням гуай шамбалд очиж чадаагvй юу? гэлээ.

— Эсгий хийхэд нохой хэрэггvй гэгчээр над шиг хэрэггvй амьтан тэнд vгvй байхаа гээд Ням хулчгар инээв.

Богдод мөргөх гэж яваад шал согтуу ирсэндээ гэмшиж, Итгэлт зэмлэж магад гэж хулчийж байлаа.

— Богдод мөргөсөн билvv, vгvй билvv?

— Мөргөсөн гэж хэлээд Ням нvдээ буруулан мод толгойгоо гаргаж тамхи татлаа.

— Яаж мөргөв дөө?

— Өргөөнд нь ороод л мөргөж орхисон.

Нямын байдал, ярианы сэжvврээс нь Богдод мөргөөгvй гэдгийг нэвт харсан Итгэлт

цаашлуулж:

— Ямар шvv байх юм бэ дээ гэж Нямын ярианд vнэхээр итгэсэн дvр vзvvлэн асуув.

— Том гэгчийн улаан халзан өргөөний баруун талд барсын арьсан дээр шар тос самарсан манж зооглоод морилж байх юм.

— Бурхан хvн болохоор таныг лав таньж байгаа байх даа

— Хэлээд юу байхав. Чи чинь Луу гvний Ням биз дээ гэсэн.

— Та ч тийм л гэсэн биз дээ ... За чингээд хоол сархад гээд л сvйд болоо биз дээ.

— Тэгэлгvй яахав. Их дагинаа дуудаад Нямд ганзай халааж өг гэсэн. Би гэдэг хvн Богдын хишиг хvртэж орхиод тийм ухаангvй согтуу ирж байхгvй юу.

Итгэлт хөгжилтэй инээв. Нямыг шахаж дэгсдvvлэн буудуулж байх нь зугаатай хэрэг байлаа.

— Ямар хоол өгөв.

— Эх дагина гуай хөлдvv тарган мах оруулж ирээд сайхан бууз хийж өгсөн гэж Нямын хэлэхэд «Таны аз гэдэг ч тvмний эх унасан хvvхэд шиг яваа юм байна»гээд Итгэлт толгойгоо хаялан жингэнvvлэн инээж нvднийхээ нулимсыг арчив.

Гадаа хvйтэн салхи vlээн, цэвдэг зэврvvн байсан авч гал тvlсэн давхар майханд суугаад халуун цайтай цагаан тос идэж байгаа зузаан хувцастай хvmvvс тvvнийг эс мэдрэн Нямын ярианд хөгжилтэй инээлдэж шуугилдана.

ҮII

Хатанбаатар Магсаржав хvрээнд ирэх гэнэ гэдэг яриа нэгээс нөгөөд дамжин хvрээнийхэн Чойжин ламын сvмийн ар талбайд аль өглөө цугларчээ.

Оюутны сургуулийн сурагчид энэ мэдээг сонсоод их л хөл вймээн болж билээ. Тусгаар тогтнолын тэмцэлд яруу алдраа бадруулсан баатрыг харах хvсэл энэхэн өглөө хэдэн мянган хvний сэтгэлийг эзэлжээ.

— Өвгөн минь, баатрыг угтъя гэж Жаргал орон дээрээ буруу харан хэвтэж байгаа Батын мөрнөөс угзрав.

Бат зөвхөн толгойгоо алгуур эргvvлэв. Нулимсандаа тvlэгдэж хавдаад улайсан хоёр улбагар нvд Жаргал руу ширтэв.

Эхийгээ vхсэнийг мэдсэнээс хойш Бат өөр хvн мэт болжээ. Уулаас vг цөөнтэй Бат бараг л битvv амтай хvн болов. Нvдэнд нь нулимс цийлэгнэн хэдэн цагаар хөдлөхгvй гэрийн унь ширтэн хэвтэнэ. Гартаа тааралдсан ном бvхнийг уншдаг нь ч vгvй болжээ. Сэтгэлд нь хvний газар, хар элэгтний дунд орхиж, нас барсан хайрт эх нь тvvний хайрын сэтгэл, дөлгөөн нvвр, царай нь салахгvй эргэлдэнэ. Би хvрээ рvv яваагvй бол доо? Ижий минь яаж байж нас барсан бол? Аав бид хоёрт их гомдсон шvv дээ? гэх зэрэг тvмэн асуудал оволзон гарахад гашуун нулимснаас өөр хариу байдаггvй байв. Хагацлын гашуудал ганцаараа хvний сэтгэлийг эвдэж чаддаг байхад гамшигтай нийлэхдээ бvр ч хvчтэй болдог ажээ.

— Би явахгvй гэж Бат нам дуугаар хэлэв. Жаргал нөхрөө өрөвдөж хайрласан нvдээр ширтэж байснаа “Сэтгэлээ барь, өвгөн минь” гэж догдлон хайрласан дуугаар хэлэв.

Бат хариу дуугарсангvйд Жаргал орон дээр нь сандайлан сууж гvн бодолд дарагдан ханцуйгаараа оролдов.

— Бат аа хоёулаа гаръя.

— Хөөрхий ижий минь ... гэснээ нvднээс нь нулимс дуслав.

— Сэтгэлээ барь. Уйлаад дахин босгож чадах биш дээ.

— Тэр ч тийм дээ. Гэвч ...

Жаргал босож шийдэмгийгээр Батын мөрөн дээрээс татаж хамт гарахыг шаардав. Удсан ч vгvй тэр хоёр талбай дээр цугларсан олны вймээнд орлоо.

Бага үд болж тогтуун зөөлөн салхи Тасган овооны зүгээс үлээхүйеэ хүрээг тагласан гашуун хар утаа шингэрэн зайлж хөнгөн бөгөөд тааламжтай болов. Хан уулын орой цэнхэр тэнгэрт дэвсгэрлэн сүртэй бөгөөд үзэсгэлэнтэй харагдана.

Их талбайн баруун өмнө захаас бараг гол дунд нь цогцолсон шовгор модон индэр хүртэл цагаан эсгий дэвсчээ. Индрийн зүүн өмнө хэдэн үхэр буу урд зүгийг харуулан зэрэгцүүлэн зоогоод баярын буудлага хийхэд бэлхэн болгожээ.

Жин үдийн хирд талбайн баруун өмнөөс Соёмбо үсэгтэй хуучин улаан туг намиран гарч ирэхэд хүмүүс тэр зүг харцгаав.

Дайны утаа шингэж хэд цоорсон энэхүү тугийг өндөр, тарган цагаан морьтой хүн дөрөөвчлөн барьжээ. Дараа нь мөн л хуучин шар тугийг гал зээрд морьтой хүн барин гарч ирэв. Тугуудын баруун зүүн талд нь гурав гурван морьтой хүн сэлэм огшин явах нь наранд гялалзан сүртэй ажээ.

Тугчдын морьд цагаан эсгий зам дээр гарч индрийн зүг аажим бөгөөд үргэж хулгалгүй явах нь ийм ёслолыг олонтой үзсэний шинж билээ. Тугийн дараа хоёр талдаа нижгээд хүн жигүүрлэн дагуулсан Хатанбаатар том сартай бөмбөн сайвар хээр морь унаад гарч ирэхэд цугларсан олны дунд үргэлжилсэн шуугиан хуран нүржигнэв.

Вангийн хүрэн жинстэй, булга татсан тоорцог үл мэдэг хазгай тавьж, элгэн хүрэн хүрэмтэй хуучивтар хар хөх дээл өмсөж мөлгөр хоншоортой наамал ултай гутал жийжээ. Зөрүүлэн татсан мөрөвчийн баруун үзүүрт модон хуйтай сэлээдий, зүүн үзүүрт урт сэлэм унжсан нь морины явдалд урагш хойш хаялна.

Хатанбаатарын морь эсгий дээр гарч ирэхэд дагагсад нь ярагдан эсгийн хоёр талаар явлаа. Баатар вангийн баруун гарт яваа урт ланжуу буу үүрсэн хүн бол Өлзий өвгөний хүү Хуяг ажээ.

Энэ үед индрийн дэргэд хүрэн дээл дээр өргөн хөх бүс ороосон хүдэр бор эр инээмсэглэн зогсоно. Энэ бол шинэ тогтсон Монгол улсын бүх цэргийн жанжин Сүхбаатар байлаа. Үхэр буунууд гурвантаа баярын буудлага хийхэд дэлхий ертөнц хөдлөн нижигнэв.

Хатанбаатар гудамжлан зогссон олныг харан таних хүмүүст нүдээрээ инээмсэглэн мэнд хүргэнэ. Баатар ван мориноос буухад Хуяг цулбуурыг нь авч гэдрэг болов. Сүхбаатар очиж Баатар вантай элэгсэг дотноор золгов. Дараа нь Хатанбаатарыг дагуулан индэр дээр гарахад Баатар ван гараа элгэн дээрээ хавсран олны зүг гурван удаа мэхэсхийн ёслов.

— Олон аавын хүү халуун амь бүлээн цусаа хайрлалгүй өгсөн их хэрэг ардын намын мэргэн бодол, шинэ Орос улсын халуун дэмжлэгийн үрээр ялж морь бие амрах цагийн алтан босгон дээр бид гарлаа. Манай орон эрх чөлөөтэй, тусгаар улс, Монгол нутаг минь бидний юм болсныг бодоход юутай сайхан хэрэг вэ. Тусгаар тогтносон Монгол улс түмэн үеийн үед дэгжин дэвжиж бат орших болтугай! гээд өргөн магнай хурц нүдэнд нь цаглашгүй баяр бахдал тодорсон Хатанбаатар олны нүдэнд дахин дахин мэхийн ёслоход «баатар ван бат орших болтугай» гэсэн нэг хүний дуу олны дуугаар дэмжигдэн үргэлжилсэн хүчирхэг дуу болон нүржигнэн их талбайг оволзуулах мэт цуурайтав.

— Ах та алсын замд алжаасан болохоор өнөөдөр амарч, маргаашнаас бидэнтэй уулзах биз ээ. Ардын засгийн газраас эрхэм ах таны улс гэрийн төлөө зүтгэсэн их гавьяаг үнэлэн чин вангийн хэргэм, шар хүрэм шагнасныг баяртай мэдэгдье гэж Сүхбаатар ноцтой хэлэв.

— Хишигт мөргөө гээд Хатанбаатар толгой дохин ёслов. Индрээс бууж ирэхэд индрийн хажууд Чулуун арслан шиг хөдлөлгүй ихэмсэг зогсож байсан жонон ван Ширнэндорж намбатай бөгөөд эрхэмсгээр нударгатай урт ханцуйгаа даялзуулан хаясаар алхаж ирээд толгойгоо үл мэдэг тонгойн мэндэлж «Очир дарийн хувилгаан Богд Жавзандамба хутагт,

баатар ван таныг бараалх гэж зарлиг буулгасан билээ» гэлээ.

— Би бол цэргийн хvн болохоор, амар гэсэн жанжны тушаалыг ямар аймшигтvй зөрчих билээ гээд Магсаржав намбатай бөгөөд ёжтой мэхийн ёслол.

Ширнэндоржийн ширэвгэр хар сахлын vзвvр татганан Сvхбаатар өөд хялайн харсан боловч тvвний хурц нvдтэй учраад ширэв татан зайлав.

— Баатар ван олон хоногийн урт аянд алжаасан болохоор амарч хvч залгах нь улс гэрийн хэрэг болжээ гэж Сvхбаатарын хэлэхэд энэ тухай дахин яриад хэрэгтvй гэсэн тод өнгө байсныг сонссон Жонон ван зэвvүнээр далаа хөдөлгөснөө эргэж явлаа.

Хатанбаатар цулбуураа Хуягаас авч мордлоо. Тvвнийг тvмэн хvний нvд vдэв. Энд Хатанбаатарыг ёслол хvлээн авч байхад тvвний цэргийн зэвсэг хэрэглэл ачсан арваад морин тэрэг хvрээний баруун талаас орж ирлээ. Энэ цувааг хөтөлсөн хонгор морьтой хvн бол цахиур Төмөр байлаа. Тvвний хажууд хуучин ногоон дээл дээр хөх бvс бvслээд жижигхэн боловч шавхарсан зэгзгэр биетэй саарал морь унасан Дулмаа хvхэн явна.

Анх удаа харж байгаа Дулмаагийн нvдэнд хvрээний юм бvхэн сонин бөгөөд нэг юмнаас нөгөө юманд нvдээ шилжvүлэх бvрдээ Төмөрийг их хайр vлэмж баяр хосолсон нvдээр харж инээмсэглэнэ.

Энэ цуваа аажмаар явсаар Чойжин ламын сvмийн араар гарч ирэхэд Бат Жаргал хоёр чихэлдэн зvтгэж явсаар олны өмнө гарч зогсов. Төмөрийг олж харсан Батын нvд дув дугариг болсноо «Төмөр ах аа. Ах аа!» гэж байдаг чадлаараа хяхтнуулан хашгирсан нь олны анхаарлыг татлаа.

Тvргэн очихгvй бол нvдэнд нь туссан Төмөр алга болчих юм шиг бодсон Бат гvйн очиж тvвний цулбуураас барьж авахад морь нь vргэв.

Салан сарнисан улсын уулзалт шиг сайхан юм энэ орчлонд юу байх билээ. Энэ учрал нь хагацал гашуудлаар дvүрсэн Батын сэтгэлд баярын хур, жаргалын цэцэг буй болгов.

Баярласан сэтгэл нь барьцгvй гуд татуулсан бөхийн гар шиг бvхнээс тэмтэрч уйлах, инээх зэрэгцэн сарвалзана.

Төмөр Дулмаа хоёр Хуягтай нийлэн мөн л нэгэн ханхай гэрт бууж билээ. Гэвч эмэгтэй хvнтэй гэр хэдэн цагийн дараа бvлээ бутарсан орон болжээ.

Дулмаа нь Төмөр ахын нь эхнэр болжээ гэдгийг Бат дор нь ойлгосон боловч энэ хоёр яаж яваад хэрхэн суусныг яаж мэдэх билээ. Мэдэхийг ч төдий л хvссэнгvй.

Ижийнхээ тухай Нямаас сонссон тасархай боловч хатуу vгийг Бат нулимсаа дуслуулан ярихад «Дvв минь хорвоо гэдэг хэцvв юм даа. Нэгэнт өнгөрсөн хойно уйлаад босох биш»гээд Дулмаа өөрөө уйлав.

Сандрахдаа сар өөд самардах гэгчээр хайрт хvнээ vхсэн гэдэг ёозгvй мэдээ сонссон хэн бvхний сэтгэлд өөрөө мэдэхгvй авч горьдлого хэзээ ямагт байдаг билээ. Энэ ч учраас сайхан найдлага төрvүлсэн ямар нэгэн vг сонсох дуртай байдаг бөгөөд тvвнд итгэх, эргэлзэх нь амархан байдаг шvв дээ.

«Согтуу Ням гуайн vгэнд итгэх хэрэгтvй. Хаанаас л тийм амархан vхдэг юм бэ» гэж Батад хэн нэгэн хvн хэлсэн бол Батын сэтгэлийн гаслал алга болохгvй ч гэсэн сарних байж билээ. Гэтэл ийм vгийг Дулмаа Төмөр хоёр хэлж чадахгvй байлаа.

Тэр хоёр Луу гvний хошууны нэг хvнээс Итгэлтийн зарц Эрдэнэ гэгч хvний хаясан эхнэр нь Заяын хvрээ рvв яваад алга болсон бөгөөд урд Тамирт орж vхсэн гэдэг хэдэн гар дамжсан яриаг сонссон болохоор эхээсээ салсан хvвгийн сэтгэлийг хоосон горьдлогоор цатгаж чадахгvй байлаа.

Харин Долгорын vхэлд Дулмаа Итгэлтийг зэмлэж «тэр барамаас л болсон хэрэг» гэдэг бол

Төмөр «ах та хоёроос л болсон хэрэг» гэж эцэг хvv хоёрыг шууд зэмлэнэ.

Хэн ч хазгай гишгэж болно. Гэвч юуны өмнө тvvнийг татаж авахыг хичээдэг юм. Энэ бол хvний ёс. Гэтэл хазгай гишгэсэн эхнэрээ татаж авахын оронд тvлхэж орхисон байв. Талд vлдсэн өнчин ишиг шиг хоцорсон Долгорын ганц найдлага болсон хvv нь бас тvvнийг орхин алга болжээ. Энэ учраас Долгорын бүх зовлонгийн эзэн бол эцэг хvv хоёр гэж Төмөр бодож байлаа. Төмөр ч ингэж ч бодох эрхтэй хvн. Хэрэв хvний эхнэр болоод байсан Дулмааг тvлхэж орхисон бол Дулмаа ч жаргахгvй байсан. Төмөр ч жаргахгvй байсан. Харин Дулмаагийн аргагvй эрхэнд хийсэн гэмийг уужим сэтгэлээр уучилж чадсанаар одоо тэр хоёр бие биеийн сэтгэлд гандашгvй цэцэг болон хамт яваа ажээ.

Гэхдээ усан бэлцрvv болсон нvдэнд нь гэмшлийн тvмэн туяа зангирсан Батыг хараад хатуу зэмлэх сэтгэл Төмөрт төрсөнгvй.

— Дvv минь хатууж. Эр хvний хамгийн сайн чанар бол сэтгэлээ барих юм шvv гэж Төмөр дvvгээ аргадна.

Дулмаа заримдаа Баттай хамт уйлна. Гэвч Батын сэтгэлд гагцхvv эхээ харамсах, өөрийгөө зэмлэх, гvн гашуудал нулимсын сурвалж болдог бол Дулмаагийн сэтгэлд Долгорыг хайрлах сэтгэлийн хамт «Төмөртэй учирснаас Долгорт тохиолдсон зовлонгоос зайлж чадсан» гэдэг хэмжээлшгvй баяр байдаг байлаа.

Долгор vxэж гэдэг vгийг сонсоод Дулмаа Итгэлтийг хараан зvxэж билээ. Гэвч яваандаа Төмөрийн сэтгэлийг хуваалцдаг болсон.

Нэг өдөр оюутны сургууль дээр хурал болж Бат, ах эгч хоёроо урихад тэр хоёр дуртай очлоо. Заасан бүхнийг олон шавь нарын дотроос онцгой сурдаг хичээнгvй шавь Батыг багш нь дээд vгээр хөхvvлэн магтаж дээлийн даалимба, ном дэвтрээр шагнахад «Бичиг ном сурахдаа ахын ухааныг дуурайж шvv» гэж Төмөр ачаа магтав.

Харьж явахдаа Бат шагналд авсан даалимбаа Дулмаад өгч «Та ав даа. Над өгөх өөр хvн байх биш» гэхэд нvдэнд нь нулимс тунаж байлаа. Тэр орой Хуягийн урт шинель өмсөж нэг талдаа өөрөө хуй дээр нь гуулиар элдэв хээ хайчилж чимсэн урт сэлэм, нөгөө талдаа урт оосортой сэлээдий буу унжуулан зvvсэн сvрхий согтуу Дорж орж ирлээ.

— Ардын улаан цэргийн тасгийн дарга Дорж гэдэг чинь би дээ гээд Төмөртэй гар барьж танилцаад өврөөсөө хоёр шил хятад архи гаргаж шалны өрөн дээр тавих зуураа:

— Зусарч золигнууд орохоор л хөл алдаад архи өгөх юм гэлээ.

— Чи чинь хэзээ чингэж олон зусарчуудыг таньдаг болсон билээ? гэж Хуяг асуув.

— Таних танихгvй ямар хамаа байна. Ороод л сэлээдийгээ өвөр дээрээ тавиад суухад хөл нь газраас салаад, сvнс нь зайлж чичирдэг юм гээд хоёр далаа зайчин ханхалзав.

Дорж хотын хятад худалдаачин нарыг сvрдvvлж архи авч уудгийг мэдсэн Хуяг «Энгийн худалдаачныг ингэж сvрдvvлэх нь ардын засгийн бодлогод харш» гэж зэмлэхэд «Тэр дэмий, би ардын засгийн бодлогыг мэднэ. Гэвч хятад бол хятад шvv дээ. Тэр чиний хэлдэг энгийн номхон худалдаачин чинь бидэнд улаан сар бэлтгэж байхыг би мэднэ. Уг нь цөмийг нь дvvжилж орхих байсан юм. Манай засаг дэндvv өршөөлтэй байна» гээд нэг шил архиа задалж том шаазанд хийж цvл цvл залгиад «дарлагдсан vгээгvй ядуу ардууд дэлхий дахинд улаан хувьсгалыг мандуулж баяд, ноёд худалдаачинг буудаж ална» гэснээ дахин нэг хөнтөрч «Улаан тугийг мандуулаад, улсын сvрийг бадруулья» гэж ганхан vглэсээр унтахад нь Төмөр бvсийг нь тайлж орон дээр хэвтvvлмэгц эзгийг буцалгаж эхлэв.

Согтуу Доржийн ааш авирыг харсан Бат бүхнийг мартан хөгжин инээж байлаа.

ҮШ

Даржаа баатрын анги явдал дундаа өсөж, буудаж цавчих сургууль хийж улаан цэргийн



ангитай хавсран цагааны цэрэгтэй байлдаж хаврын эх гэхэд үндсэнд нь дарж чадлаа. Цэцэн хан аймгийн хойт тал, монголын хилийн дагуу байлдаж байсан Довчин бэйсийн гол хвч дарагдсан авч түүний үлдэгдэл ард олонд уршиг удаж, түүнтэй хөөцөлдсөөр 1922 оны зунтай золгов.

Бароны байгуулсан тоглоомын засгийг унахын өмнөхөн Довчин бэйс хэд хэдэн хошууны ноёд лам нартай ярилцан Цэцэн ханы аймагт хвчээ хуралдуулан цагааны үлдэгдэл хвчтэй хамтарч ардын засгийг унагах тухай тохиролцож билээ. Гэтэл их хайрын ариун сэтгэлээр баатарлаг гавьяа байгуулж Гэрэл хүүхний авч Эрдэнэд өгсөн бичгээс Довчингийн төлөвлөгөө ардын засгийн газар мэдэгдэж хань нөхдийн зарим нь баригдаж, зарим нь цөөн цэрэг дайчилж амжсан боловч нэгдэж чадалгүй цохигджээ.

Ингээд орос буриад голдуу цөөн тооны цагаантнаас өөр түшиж тулах хвчгүй болж сэдсэн хэрэг нь дампуурсан Довчин ардын цэрэг, улаан армийн нэгдсэн хвчинд шахагдав.

Довчингийн цэрэг халз тулсан байлдаанаас зайлан зугтаж ард олныг дээрэмдэн хвч залгаж байлаа. Тэд хэсэг хэсэг болж хврээ хийд алс бөглүү хөдөө нутгаар нуугдан бvгж голдуу шөнийн цагаар ардын цэрэг улаан армийн ангийн жижиг хэсэг рүү довтлон гай уршиг тарьж байв.

Улаан армийн ангитай хвчин хавсарсан Даржаа баатрын анги оргодол дайснуудтай хөөцөлдөн байлдсаар Сан Бэйсийн хврээн дээр ирж байрлав. Эрдэнэ нэг гэрт Петртэй хамт орж билээ. Тал бүр хайгуул туршуул тавин Довчингийн дээрэмчдийн тухай мэдээ авч мөр нь гарсан тухайд явж хөөцөлдөн байлдана.

Дайн тулалдаангүй чөлөө цагтаа Петр, Эрдэнэ хоёр удтал ярина. Энэ хоёр удаан цагаар ярьж байсныг аль тэр гэх билээ. Гэвч одоогийн яриа, урьдынхаас шал өөр шинж сэдэвтэй байж билээ. Урьд Эрдэнэ маргах дуртай байсан бол одоо сонсох дуртай болжээ. Урьд шударга бус ёс тэр нь мөнх байх эсэх, түүнийг яаж устгах тухай ярьж байсан бол одоо шинэ ардын засгийг яаж байгуулах тухай, тусгаар тогтнолоо олсон Монголын ард олон цаашид хаашаа явах, юу хийх тухай ярьдаг болжээ. Ярих тусмаа ярианы нь сэдэв өргөжин, утга учир нь гүн болно. Бас энэ хооронд Эрдэнийн хувьд их өөрчлөлт буй болжээ. Түүний уулаас сэргэлэн ухаан өргөжиж, олон жилийн өмнө бичигдсэн хэдэн хуучин монгол номын хврээнээс халин гарч, одоо цагийн нийгэм улс төрийн асуудалд идэвхитэй нэвтэрч байлаа. Петртэй ярьж байхдаа Эрдэнэ улс төрийн бодлогын нарийн явдлыг ойлгож, түүний цаадах учир утгыг эрэгцүүлэн бодох түлхүүрийг олж авна.

— Та нар л бидэнд их тус боллоо доо. Та бүхний л хвчээр улс орондоо бид эзэн нь болов. Монгол хүн энэ ачийг үеийн үед мартаггүй гэж Эрдэнийн хэлэхэд Петр инээмсэглэснээ, — Эрдэнэ минь үүнийг нэг талаас нь харж огт болохгүй. Зэвсэг барьсан олон дайсныг та нар бидний тусламжгүй дийлж чадахгүй байсан нь үнэн. Гэхдээ зэргэлдээ орондоо дайсан үүрлэж байхыг хэн ч хвсэхгүй. Гэтэл та нар цагаантантай нийлж тэдэнд нутаг усаа тавьж өгсөн бол бидэнд бөөн гай болно. Бид танай нутагт дур зоргоороо дайран орох эрх байхгүй. За тэгэхлээр та нар биднээс тусламж гуйсан чинь бидэнд монголд цэргээ оруулж, нийтийн дайснаа нэгдэж дарах боломж олгосон. Цагаантан бол бидний дайсан. Биднийг дайснаа дарахад та нар хвч хавсарсан, нутгаа өгсөн. Та нарыг дайснаа дарахад чинь бид хвч хамтарсан хэрэг. Энэ барилцсан ах дүүгийн гараа л тавилцалгүй зүтгээд байх нь чухал! гэж билээ.

Энэ хоёрын ярианы салшгүй хэсэг бол Монгол орны ирээдүйн хувь заяаны тухай асуудал байлаа.

— Танай нэг гол дайсан бол олон зуун жилийн хоцрогдол. Үүнийг давж гарна гэдэг нвсэр

ажил даа. Бас Хятад та нараас маш их өр нэхэж байна гэж би саяхан сонссон...

— Тэр өр ч яахав. Түүнийг Монголын ард түмэн тавиагвй. Бас чингээд үнэндээ бид олон жил шулуулж, түүнийг олон хувь нугалан төлсөн юм.

— Хэн тавьсан нь падгвй гээд зэвсгийн хвч, цэргийн сүрээр дайрвал яах вэ?

— Арай та нар биднийг орхихгвй юм байгаа биз дээ. Юу боллоо гэсэн ч үзэж алдаж, үсэрч наалдана даа. Хуучны нэг сударт улс төрийг тогтооё гэвэл эдийн засаг, эрдэм соёл, эр цэргээ базаах нь чухал гэж сургасан байдаг.

— Гол нь хвн, хвнээ мөлждөг ёсыг л арилгах хэрэгтэй. Чингэвэл та нар түргэн хөгжиж чадна.

— Та нарыгаа л бараадаад байдаг хэрэг дээ.

— Манай хоёр орны зорилго төсөөтэй боловч байдал өөр болохоор бараадаж дууриагаад ч хол явахгвй шvv. Би урьд Монголд байхдаа бvх ноёдыг буудаж орхивол энэ ард түмэн жаргалын замд орно гэж бодож байсан. Гэтэл танай хувьсгалд идэвхитэй зvтгэсэн ноёдыг би нvдээр харсан. Бас шарын шашин байна. Би чамтай Тамирын голд ярьж байхдаа шашныг устгах тухай ярьдаг байсан. Гэвч тийм ч амар эд биш бололтой. Өмнө чинь устгах ёстой хоёр дайсан байхад тэдний хвчийг нэгдvvлэхгвйг л хичээх нь зөв.

Энэ хоёр Монголын ирээдvйн замын тухай ярихдаа Петр энэ орны тухай асуудлыг шийдвэрлэхдээ юуны өмнө түүний өвөрмөц байдлыг анхаарах нь чухал гэдгийг онцлон хэлдэг байлаа.

Эрдэнэ ард түмэнд ардын засгийн бодлогыг тайлбарлан яриа хийхээр явах бүрд нь «Одоо вед танай ард түмэн, ардын засаг яах бол? Миний мал, хөрөнгийг яах бол? Шарын шашныг яах бол? Надад юу өгөх бол? гэж бодож байна. Үvнийг зөв тайлбарлаж өгвөл тэдний сэтгэлийг татаж, нөхөд олно. Эс чадвал тvlхэж дайсан олно. Өгч чадахгвй юмаа худлаа амлаад эцэст нь өгөхгвй бол итгэл алдана» гэж Петр анхааруулдаг байлаа.

Хойт талын хошуугаар ардын засгийн газар Богд гэгээнийг барьж хар гэрт хийсэн, шарын шашныг устгаж, сүсэгтэн ардыг хядах гэж байна. Мал хөрөнгийг нь булаан авч, эмс охидыг нь хвчирхийлэн бузарлах гэнэ гэх зэрэг элдэв цуурхал дэгдээж олны санаа сэтгэл вймэхэд Эрдэнэ, Петрийн хамт орос монгол нийлсэн арваад цэрэг дагуулан явж билээ.

Ард олонтой нvvр учран, засаг төрийн бодлогыг тайлбарлан хагас сар шахам явахдаа цагаантай нийлж байсан хоёр хошууны ноёнг огцруулан эрхийг нь хасаж, хошууны засаг даргаар олонд нэртэй, бичиг үсэгтэй хvmvвсийг тохоон тавьжээ.

Зуны сайхан өдөр. Эрдэнэ, Петр хоёр нөхдийн хамт жирэлзэн урсах тунгалаг голын дэргэд буудаллан хувцсаа угаан, усанд орж амарч байлаа.

— Эрдэнэ ээ, нэг барилдах уу?

— Зоогоороо газар арчмаар байна уу? Тэр жил Бадарчид унаж байхыг чинь харахад мэхгвй юм байх чинь билээ.

— Дэгдээхэйг намар тоолдог гэж оросын vг байдаг юм. Үзье гээд Петр босож хонгоо алгадан гараа сэлэн дэвлээ.

— Яадаг юм бэ. Үзье гээд Эрдэнэ босоод суняав. Петр «Тэр бөх хэний хэн бэ» гээд хэсэг эргэлдэн гvйснээ шавж гарлаа. Эрдэнэ өмнө нь очиж өрөн зогсов. Петр гэнэт дайран хоёр шуун дээрээс нь атгаж аваад эргvvлж гарлаа.

Цэргvvд тойрон барилдагчдыг хөгжөөн хашгиралдана. Петр баахан эргvvлж байснаа хажуулдуулан тавих вед Эрдэнэ нvцгэн хөлөөрөө Петрийн хөлийг гэтээд нойтон газар дээр тэр хоёр пад хийн унав.

— За хайнцсан. Дахина даа.

— Больё. Алах нь байна. Хоёр гарын булчин сугалчих шахлаа гээд Эрдэнэ гараа сэгсрэн

инээв.

Тэр хоёр дахин барилдсангвй. Бвлээн элсэн дээр элгээрээ хэвтэхэд нар араас халаан, элс дороос жигнэж таатай байлаа. Хөх магнаг тэнгэр мэлрэн цэнхэртэж, голын шуугин урсах чимээ чих таалж, зун цагийн ганган байгаль ер бусын тайван, тэнvнvн сэтгэл төрvнлнэ.

— Хvний амьдрал аа гэж мөн сонин юм даа. Би Засагт хантай заргалдаж хэрэг буруудаад бат гvнд сууж байхдаа ингээд төрийн төлөө зvтгэж явна гэж зvүдлээгvй шvв дээ. Хvний амь бөхдөө л би тэсэж гарсан юм.

— Хvн шиг бөх, тэвчээртэй амьтан хаа байх вэ. Би Александрын төв шоронгоос оргож зугтаж явтал Ангар мөрний таван алд шахам эгц эргэн дээр тулж ирлээ. Чингээд ёстой л азаа vзэх, эсхvл баригдах болов. Би vсэрч орхисон. 1905 оны хавар юмсан. Манай заводын ажилчид жагсаал хийв. Би эхний эгнээнд явж байтал морин цэргvүд буудсан. Манай эгнээний бvх хvн шархдах буюу vхсэн, гэхэд би шалбараагvй юм шvв. Сум хаагуур минь гарсан юм бvв мэд. Би vхэхгvй хvн шvв.

— Чингэж ч болохгvй. Баян хvн нэг шуурганд, баатар хvн нэг суманд гэдэг. Нэг сум амин газар оноход л гvйцээ шvв дээ.

— Хvн vхнэ гэж бодвол юу ч хийж чадахгvй. Үхнэ гэж бодсон хvнд ч чадал огт байхгvй. Тийм vү?

— Нээрээ ч тийм юмуу.

— Манайх дорнод фронт руу гарахад бага хvв минь «Аав аа чи намайг унтахаас өмнө ирэх vү?» гэж асуусан юмсан. Тvнvнээс хойш бvтэн дөрвөн жил боллоо.

— Гайгvй дээ хөө. Удахгvй уулзана.

— Тийм ээ. Дахин хэзээ ч салахгvй гээд Петрийн нvд нь сайхан уулзалтын тэнэгэр баяраар гэрэлтэн, зангидсан гараараа торгон элс рvв хvчлэн шааж байлаа.

Ингэж ярилцан байтал нэг хvн сандран ирж төдий л хол vгvй газар Довчин бэйс арав гаруй хvний хамт дээрэм хийж архидан яваа мэдээг авчрав.

— Уухай. Хар яргачин чи надтай энд дайралддаг буй. Одоо хоёулаа Гэрэлийн талаар дансаа бодох цаг ирсэн гээд Эрдэнэ ухасхийн босов.

— Юу ч гэсэн хойшоо мэдээ явуулья гэж Петр хэлээд бас бослоо.

Эрдэнэ хоёр хvнийг Даржаа баатарт хэл хvргэхээр Сан бэйсийн хvрээ рvв явуулаад өөрсдөө дээрэмчдийн байгаа газар тийш яаравчлан довтлов. Гэтэл Довчин бэйсийнхэн мэдэж зайлан одсон байхад нь мөрдөн хөөж явсаар хоёрдахь өдрийн өглөө нь гvйцтэл өмнөөс нь буудаж эхлэв.

Өглөөний нар уулын толгойноос салан ядаж байсан вед буудалцаа эхэлсэн бөгөөд Эрдэнэ нөхдийн хамт баруун талд нь байраа эзлэв. Хурц нарны гэрэл нvд рvв нь гялбан цохиж дайсныг олж харахад vлэмж хэцvв ажээ. Бас дайсны нэг нь аюултай мэргэн буудаж эвгvй л хөдөлбөл магнайд сум зоож орхих гээд байлаа.

— Нар дээр гартал босох ч vгvй, босгох ч vгvй байхыг бодъё гэж Эрдэнэ нөхөддөө хэлээд аятай байр эзлэв.

Энэ зуур Эрдэнийн талын хоёр монгол, нэг орос цэрэг мэргэн буудагчийн суманд өртөн алагдав.

Эрдэнэ Петр хоёр нэг том чулууны ард зэрэгцэн амжиж хэвтэв. Довчин бэйсийн талд хэд хэдэн цагааны орос цэрэг байгаа нь тодорхой харагдана. Эрдэнэ дайсны байрыг ажиглах гэж vл мэдэг өндийх гэтэл малгайны нь оройг сэт буудаж орхилоо.

— Бууд, хөдлөх нь байна шvв.

—Хамаагvй хөдөлж тун...гэснээ Петр дуугvй болж гохоо мултлахад дайсны нэг нь нам унав.

Петр биеэ далдлах, мэргэн буудахын эрдмийг нэвт гарамгай сурсан ажээ. Дайсны хөдөлсөн бүхэн түүний суманд оногдон нэгмөсөн далд орж байлаа. Эрдэнэ ч мөчөөгөө өгөхгүй буудаж дайснаас хоёрын зэрэг хүнийг алах буюу шархдуулав бололтой. Хоёр талаас буу тасралтгүй дуугарсаар үд өнгөрч эхлэв.

Нэг харвал хөх торгон дээлтэй том тарган хүн сохор номингийн овгор хар шороогоор далдлагчаа болон цаад талын мод руу намрын тарган тарвага шиг халбалзан мөлхөж байхыг хараад Петр буугаа чиглэн гохоо дарах гэтэл Эрдэнэ угзран зогсоож «Довчин! амьдаар нь» гээд ухасхийн бостол «галзуурав чи» гээд Петр мөрөн дээрээс нь шүүрэн хүчтэй дарахдаа өргөн цээж нь хаднаас мултран гарлаа.

Яг энэ үед Эрдэнийн гэнэт шоволзсон толгойд чиглэсэн цагааны мэргэн буудагчийн сум түүний магнайн оронд Петрийн цээжинд нэвтрэн орлоо.

Цэнхэр тэнгэр эгшин зуур харанхуйлан бүх юм эргэлдэн манарч, хүчирхэг том бие нь тэнцүүрээ алдан үхлүүт шархадсан Петр Эрдэнийн гар дээр налан унав.

— Ээ халаг минь. Өгөр надаас боллоо гэж хашгираад Эрдэнэ нөхрөө тэврэн авлаа.

— Аяггүй буудаж байна гээд Петр инээмсэглэх мэт болсноо цээж нь хэржигнэн сум туссан газраас нь хүрэн цус бургिलाхад бие нь татганан нүдээ хагас анив. Эрдэнэ цус бургилан буй газар нь дарахад төдөлгөй бүх гар нь улаан болов.

— Тэр буу ... гээд Петрийн гар нь сарвалзан өндийх гэснээ ам нь ангалзан чичрээд бие нь хөшин талийгаач боллоо.

—Петр Петр гэж Эрдэнэ хашгираад нүд нь харанхуйлан хорвоо үргэлжилсэн гялтгар улаан толбо болон хувирав.

Эрдэнэ нөхрийнхөө цээжийг биедээ наан чанга тэвэрч «Петр Петр» гэж сулхан давтсаар нэг хэсэг хөдлөлгөй суухад бүх юм нь улаан цус болов. Хүнд гашуудалд ухаан алдтал цохиулсан Эрдэнэд юу болсон тухай бодох тэнхээ байсангүй. Нүд нь гялтганан гөлөлзөж эрүү нь сулран цус нь дүүрч бахардсан зүрх нь «ээ халаг Петр минь» гэж давтана.

Бууны дуу тасраагүй байсан авч Эрдэнэ түүнийг огт сонссонгүй. Нэг ширхэг ч амьд юмгүй болсон мэт хар хорвоо Эрдэнийг хавчин дарж байлаа. Ингэж хичнээн сууснаа ч, үлдсэн ганц улаан цэрэг нь үхтэл буудалцаар хүнд шарх олсныг ч мэдсэнгүй. Ганцхан нуугдаж байсан хаданд нь сум тусаж улихад «энэ чинь юу билээ» гэсэн бололтой тэр зүг гайхан харлаа.

Петрийн жижиг буу хэвтэж байгаа нь нүдэнд туслаа. Түүнийг авах гэж мөлхөн гар нь хүртэл зүүн хөл рүү нь хүнд юмаар хүчтэй нудраад авах шиг болов. Эрдэнэ хөдлөх гээд чадалгүй, дайсны зүг харвал хоёр хүн зогсож байлаа. Шилбийг нь даган бүлээн цус урсаж байгаа нь тод мэдэгдэн тал бие нь бадайран мэдээ алдаж эхлэв.

Эрдэнэ Петрийн жижиг бууг хормойдоо далдлан бариад хөдлөлгөй хэвтэж байв. Нар баруунаа хэлбийж, шар туяа цацран газар дэлхий хачин нам гүм болж юм бүхэн амьсгалаа хураасан мэт ажээ. Ингэж нэгэн хэсэг болтол ойрхон шиг хүн ярих сонсогдов. Нүдний булангаар харвал хоёр морьтой хүн ойртон ирж явлаа.

Хараач! Нэг нь Довчин ажээ. Эрдэнэ хормой дороо жижиг буу бэлтгэв. Цагаантны талаас модонд орж нуугдсан Довчин, мэргэн буудагч орос хоёр үлджээ. Хүнд шархадсан боловч амьтай байсан хоёрыгоо тээр дараа болно гэж жадлан алаад Эрдэнийхний буу зэвсгийг хураан авах гэж ирж байгаа нь энэ билээ.

Довчин алагдсан нэг монгол цэргийг хэд дахин өшиглөөд бүүгий нь авч нөхрийнхөө хамт шууд Эрдэнэ рүү ирэхэд нь мэргэн буудагч руу жижиг буугаар хэд дараалан буудахад тэр найган салгалснаа пид хийтэл унав.

Гэтэл Довчин «Хар гуйлгачин» гэж хашгираад Эрдэнийн гар руу хүчтэй өшиглөхөд жижиг

буу нь тэр хол үсрэв. Эрдэнэ бүх хвчээ дайчлан үсрэн босож Довчин бэйсийг барьж авлаа. Шархдаагвй сан бол, ядахдаа цус алдаагвй сан бол Довчинг зажлалгвй залгиж болохсон. Мөч өнгөрөх тутам хвч нь зайлж сулран удаан ноцолдож чадахгвйгээ мэдсэн Эрдэнэ бүхнийг мартан тонгорох гэтэл хөл нь тулгуур болж чадсангвй. Довчин зайлав. Гэвч Эрдэнэ дахин үсрэн барьж авлаа. Шархадсан барс л амиа гарахын өмнө ингэж үсэрдэг байх даа. Эрдэнийн баруун гар Довчин бэйсийн төвөнх мөгөөрсөөс базаж аваад хвчиндээ савж хоёулаа унав.

— Эрдэнэ минь чи яаж байнаа гээд паржигнасан шахмал сөөнгө дуугаар хэлэв.

— Петр. Гэрэл ... өшөө гээд Эрдэнэ шүд хяхтнан гараа чангаруулан угзарч ухаан алджээ. Тэр шөнө амь гарсан Довчингийн төвөнх мөгөөрсийг тас базсан гар нь үнсэн хөх болсон Эрдэнийг Даржаа баатрын цэрэг олж аваад гарыг нь салгаж ядан төвөнхтэй нь огтлон авчээ. Петрийн шарилыг монгол цэргүүд мөрөвчлөн өргөж явсаар Сан бэйсийн хүрээн дээр ирж билээ.

Монголын ард түмний төлөө, монгол найз Эрдэнийхээ төлөө, гал усны аюулыг нэвтлэн гарсан алтан амиа өгсөн Петр нүдээ хагас анин хэвтэж байхад үхэл түвний амийг авсан боловч нүүрэнд нь тогтсон мишээлийг авч чадсангвй.

«Би үхэхгвй хүн шүү» гэж тэр тогтсон мишээл л хэлж байхад цохилохоо аль эрт больсон зүрх нь өөр үг хэлж байв. Олон оны дарлал зовлонгийн эсрэг зориглон боссон монголын ард түмний хүнд хвчир тэмцэлд зөвлөлтийн ард түмэн ах дүүгийн халуун гараа сунгаж тусалсан. Ах дүүгийн гараа барилцсан ширүүн тэмцэлд олон аавын хүүгийн ариун цус урсаж алтан амь алдагдсаны нэг нь Тамирын голд алиа Петр гэж нэртэй явсан бөгөөд хожим улаан армийн нэгэн ангийн комиссар байсан эгэл нэгэн орос билээ.

Энэ хүний шарилыг Сан бэйсийн хүрээнээс хойш нэгэн жижиг толгой дээр оршуулж тэнд байсан хүмүүс нэг нэг чулуу тавьсан нь том овоо босжээ.

## IX

Намрын дунд сарын бүлээн хорвоод амгалан тэнүүн сэтгэлийн үр цацаж юм бүхэн тайван тэнэгэр бөгөөд ертөнцийн өнгө шаргалтан хувирч тэртээ холоос гялалзан харагдах суварган хайрханы мөнгөн дуулга сүртэй бөгөөд ихэмсэг харагдана. Өдрийн нар бараг хоймор голлох шахсан үес урд Тамирын зүүн гараас орсон амыг уруудан арилжаа хатиртай, сумлан зассан дэлтэй зээрд морь унасан хүн дөрөөн дээрээ үл мэдэг жишүү жийгээд яралзтал галгиулж явлаа.

Энэ бол Итгэлт, Хөх өнгийн нарийн шандан дээл дээр ногоон бажгир дурдан бүс өргөн биш боловч түшиг болохоор ороож, зузаан наамал ултай хар булигаар гутал өшиглөөд ногоон эмжээртэй цэнхэр одончүү юүдэн дагзан дээрээ зангиджээ. Үлэмж нарийн ураар өлзий хээ сийлж цохисон хар төмөр хэт бэлтэй вйс яс алаглуулж хийсэн иштэй мухар тохой орчим хутга ардаа хавчуулжээ. Хэрэглэсэн бүх юм нь гангалах, дэгжирхэх хүслээс ангид боловч ингэж явахад нь зохимгвй буюу илүү гэж хэлмээр юм огтгвй ажээ.

Гэрээрээ өчигдөр гарсан боловч холдож чадалгвй архидаж хоноод өглөө мордож газар дөхөх гэж айлд оролгвй довтолжээ. Гэтэл хэт ууснаас бие хөшилдөн, толгой хүндэрч эсгийгээр балбуулсан юм шиг бэмбийн дүйрч явахын аргагвй болоход бага үдийн орчим тогоо нэрж байгаа айлд бууж чанга гарсан халуун архи том мөнгөн аягаар хоёр удаа дугтармагц биеийг нь барьж байсан үл үзэгдэх нажидтай хүлээс задран ясны нь хөлс чийхран нэг л аятайхан болов.

Итгэлт энд дэмий тэнэж яваа биш, Заяын шавийн нэг айлаас унагатай гүү гурвыг авах өрөө нэхэж авах гэж яваа нь энэ билээ. Өглөө үүрийн гэгээгээр замыг нь өвөр дарж чоно огтлоход баяртай мишээж «Авлага бүтжээ» гэж өөртөө шивэгнэв.

Итгэлтийн ажил үргэлж бүтэмжтэй байдаг болохоор бэлэг дэмбэрэлтэй учрал тохиолдвол баясдаг. Харин муу ёрын учрал тохиолдвол «Азтай аавын хүүд энэ юу болох вэ» гэж бодож явдаг хvн.

«Тэнгэртэй яваа хvнд чөтгөр ч саад хийж чадахгvй, тэнгэргvй яваа хvнд бурхан ч тус болж чадахгvй гэж заримдаа хэлдэг юм»

Урд Тамирын өргөн хөндий зөөлхөн хөх униараар мансууран найгаж, дэлгэр зунаас салан ядаж байгаа дэлхий өвөрмөц гоёмсог бөгөөд дэгжин ажээ.

Зээрд морь толгой хаялан хатирч, халуун архи биед нь таран явсаар өндөр ургасан улиасанд орлоо. Сэрvvхэн салхи өмнөөс нь тасалдан үлээж, өвлийн гvн нойрондоо бэлтгэж зуны чимгээ хаян биеэ хөнгөлсөн улиасны орой салхинд битvv шуугин, товцож эхэлсэн газар гишгэсэн морины төвөргөөний пад пид, пад пид гэсэн чимээтэй нийлэн нэгэн зvйл намрын дохио өгнө.

Учраатай айлаа сураглаж урд Тамирын өмнө этгээдэд байгааг мэдэв. Харин чухам хаа байгааг яг хэлээд өгөх хvнтэй тохиолдоогvй учир ойртож очоод сураглах хэрэгтэй болжээ. Голын захад бууж морио услан нvvрээ угаав. Тамир тунгалаг тэр тусмаа намрын тамир бvр ч тунгалаг ажээ. Сvрэг загас өмнvvр нь яралзан өнгөрөхөд чулуу аваад шидвэл бужигнан дөрвөн зvг найман зовхист бутрав.

Итгэлт инээмсэглэн босов. Бие нь улам ч хөнгөрөн тавиун тавтай болоход гэдэс өлсөж байгаагаа мэдэв. Амгайвчилсан морио хазаарлаж мордоод Тамирыг гарч явсаар удалгvй улиасны захад гарахад гадна нь сарлагийн ганц торой аргамжсан нэг бор гэр харагдав. «Орж айлаа ч асууя» гэж бодоод шууд очиж уяан дээр нь зогсоод “нохой хорь” гэж хангинасан төмөр дуугаар уянгалуулав.

Гэрээс хуучин хvрэн дээлтэй чавганц гарч ирээд ирсэн зочин руу ямар ч хvндэтгэлгvй хуцаж байсан дөрвөн нvдтэй улаан халтар нохойг барьж авлаа.

Бvдvvн халтар нохойн суран хvзvvвчнээс бариад «аахай чи тэгээрэй» гэж байгаа авгайн дэргэдvvр Итгэлт гарахдаа «сайхан намаржиж байна уу» гээд гэрийн vүдэнд очсоноо нvд нь орой дээрээ гарч биеэ хураан зогсов.

Итгэлтийн нvдэнд vнэхээр vнэмшиж боломгvй хачин юм харагдав. Хуучин хөх дээлтэй эмэгтэй цааш харж суугаад хонины хашаа засаж байгаа нь ийм байдалд оруулжээ. Тэр эмэгтэйн бvдvvн хар гээг, гунагар хvзvv, нарийхан бөгөөд ер бусын гоолиг бэлхvvс нь олон удаа тохиолдсон танил боловч одоо ингээд байж баймааргvй хvнийг санагдуулав. «Байх ёсгvй дээ» гэж Итгэлт шивэгнээд авгай руу ярвайн харлаа.

Нохой хvзvvдэж байгаа авгай ч гэрийн нь vүд дээр гөлрөн зогсож байгаа хvнийг гайхан хэсэг байснаа нугалаа бvрд нь хатуу амьдрал бат шингэсэн нvvрэнд нь баярын туяа алгуурхан тодров.

—Долгор, хvв минь эргээд хараач гэж ер бусын эелдэг бөгөөд долгилсон дуугаар хэлэв. Энэ авгайн нэрийг Дэжид гэдэг. Өвгөнтэйгээ хамт амьдардаг бөгөөд гарсан гурван хvвгээс нь vлдсэн ганц нь Заяын хvрэн дээр сууж байгаад хvрээ оржээ. Явснаас хойш арав гаруй жил болсон авч нэг ч удаа буцаж ирээгvй. Сонсвол гандан гэгч ариун номын оронд суугаа ном, эрдэм бясалгаж байгаа сурагтай байв. Гэтэл нэг намар ариун шашны мөр хөөсөн тэр хvв нь цагаан бурхнаар нас барсан тухай гашуудалтай сураг сонсож өвгөн дан мориор хvрээ орвол гарцаагvй vнэн байв. Ингэж хоёр хөгшин их говийн хуурай хөрсөнд байгалийн ямар нэгэн тохиолдлоор ургаж том болоод дөрвөн зvг найман зовхист цацсан vрээс нэг нь ургалгvй өмхөрч байгаа тоорой шиг өнчрөн хоцорчээ.

Өвгөний нэрийг Баяр гэдэг бөгөөд уул нь урд Тамирын эхээр нутагтай Жамсран бэйсийнх

гэдэг жижиг засаг хошууны айл юм. Олноо өргөгдсөний тавдугаар онд Заяын гэгээн Богдын дэмжлэгээр тэр хошуунаас арав гаруй өрх таслан дээрэмдэж авсны нэг нь Баярынх ажээ. Хэдэн жилийн өмнө урд Тамирын бургасанд өвөлжиж байхад энэ нэг явдал болсноос хойш Баярынх ам гурвуулаа болжээ. Тэр жил өнтэй байснаас Тамирын гол харз элбэг бөгөөд хэд хэдэн нугас ч өвөлжжээ. Нэг өдөр Дэжид авгай бургас тvvгээд голын захаар явж байтал усны нөгөө талаас хөх дээлтэй толгой нvцгэн эмэгтэй хvн ирж явлаа. Бургасны чөлөөгөөр ажиглавал вс нь сэгсийн хийсэж, хөл нь салдар балдир яваа нь галзуу буюу согтуу аль нэгний тэмдэг бололтой. Энэ бол Долгор байлаа. Иш Долгор минь чамайг зовлонгийн туйлд хvрээд ухаангvй гэлдэрч явахад чинь сайн санаат хvн харж байсныг хэн мэдэх билээ. Тамирын бургас тvvнийг нуужээ.

Долгор шууд явсаар уур савсан харз руу ороод гар нь хоёр дахин гялалзан мөсөн доогуур далд орж билээ. Тэр вед «Хорвоо чи хvний зовлонд цадах болоогvй юу?» гэсэн гаслангийн дуу хангинан гарсан юмсан.

Дэжид гуай дуу алдан хашгирч эмэгтэйн орсон харзаас арваад алхам байгаа хөлийн цоорхойд гvйн очтол ухаангvй болсон Долгор хайргадан урсаж ирэхэд нь хормойноос нь барьж авлаа. Дэжид гуайн сандарсан дуугаар ойрхон шиг бургас огтолж байсан Баяр гуай сандран ирж хоёр хөгшин Долгорыг дамжлан гэртээ авчраад биенээс нь хувцас хунарыг нь салгаж хэсэг зуур тvрvv урагш нь харуулан хэвтvүлжээ. Хамар амнаас нь ус баахан гоожиж байснаа амьсгаа ороход нь vзvvрэгэн нэхий дээлд битvv ороожээ.

Шөнө нь бvр ухаан орсон боловч халууран хэдэн сар vлгэн салган өвчтэй байлаа. Алдаг оног хоолтой байсан боловч сайхан сэтгэлт хоёр хөгшний асралтын ач, өргөлтийн сайн, залуу чийрэг биеийн хvчээр хавар нь тэнхээ тамир цог жавхаагvй боловч эрvvл хvн болжээ. Зун нь бvр тэнхээ орж Баяр, Дэжид хоёрт төрсөн vр шиг нь хайрлагдан, тэдний бvх хөрөнгө нь болсон хоёр сарлаг, нэг хайнагийн шарыг бөөцийлөх ажилд тусалдаг болжээ.

Долгор өөрийн биед оногдсон энэрэлгvй хатуу амьдралаа уйлан байж ярин өгөхөд «Хvв минь амиа хорлосон хvн чинь эрлэг номон хааньд хvний амины хэрэгтэй очдог юм гэдэг шvv хөөрхий. Ийм сайхан залуу хvн яаж vхэж болох юм бэ. Амьд явсан хvн алтан аяганаас ус уудаг юм» гэж Дэжид гуай зэмлэн сургав.

— Би vхье гэж бодоогvй. Харин ухаангvй явсаар тэр харзанд орчихсон. Дэндvv их зовлон намайг сохолсон юм гэж Долгор хариулжээ.

Үнэндээ Долгор vхье ч гэж бодоогvй vхэхгvй ч гэж бодоогvй, хvнд зовлонгийн пад харанхуйд бэдчин амьдралын нь найдварын ганц зул болсон хvvгээ эцгийнхээ хойноос хэлэлгvй явсныг сонсоод бодох, харах чадлаа алдсан билээ.

— Сохорсон ... зовлонтой хvн сохордог юм бол энэ хорвоо сохроор дvvрэх сэн. Хорвоогийн хvний жаргалтай нь нар сар шиг байхад зовлонтой нь од шиг олон байдаг юм гэдэг шvv гэж Баяр гуай хөмсгөө зангидан vлэмжийн гvн бодол болон хэлжээ.

Сайн санаат хоёр хөгшин зовлонт бvсгvйд амьдралын итгэл буй болгож өгөх гэж vлэмж хvч зарсан. Энэ зvтгэл нь ч талаар өнгөрсөнгvй.

Долгорыг явснаас хойшхи тав дахь өдөр урд Тамирын эрэг, яг Долгорын орсон харзын ирмэг дээр морьтой хvн ирээд «Ээ бурхан минь. Яасан хатуу хорвоо вэ» гэж хашгираад залбиран морины амыг эргvүлж нvдээ анин маань мэгзэм холин уншаад давхин арилжээ. Тэр бол Ням гуай байсан юм. Гэвш ламын явуулсан хайнаг тэргийг авч Долгорын ор сураггvй алга болсныг сонсоод Итгэлт «Юу ч гэсэн Хонгортой уулзаад ир» гэж Нямыг явуулжээ.

Ням, Хонгор хоёр элдвээр сураг тавьсан боловч юу ч олж мэдсэнгvй. Аргагvй болсон Ням буцахын өмнө хvрээ эргэж яваад нэг авгайгаас асуусан чинь «Хэдэн өдрийн өмнө согтуу

галзуу нь мэдэгдэхгүй залуухан бүсгүй хажуугаар минь өнгөрсөн. Би гайхаж хойноос нь хараад байсан чинь тэнд малгайгаа хаяад авалгүй явсаар Мааньтын шилээр давж бараа тасарсан» гэжээ.

Ням заасан зүг рүү хэсэг яваад сэжиглээд хэн ч авалгүй хэд хоносон лоовуузыг цасан дээрээс олжээ. Тэгээд Хонгор хүү Чимэгийн хашаанд уяж орхисон морио авч унаад Долгорын мөрийг мушгин явж Тамирын голын эрэгэнд тулаад буцжээ.

Ням буцаж очоод Долгор бүсгүй урд Тамирт унаж үхсэн тухай яриа тарааснаар барахгүй Луу гүний хүрэн дээр очиж багш ламдаа даш хадаг, мөнгө янчаан Эрдэнэ хүрээ орж ирэхдээ Долгорт авчирч өгсөн ногоон дурдан бүсийг 1 барьж зуурдаар үхсэн бүсгүйн бодийг хөтлүүлээд бас зургаан толгой шүдэнз тарааж ерөөл авчээ.

Итгэлт Долгорын үхсэнийг сонсоод царай нь барзайн хувирснаа өөрийн биш зөвхий дуугаар «Нэг нь төрж байхад нөгөө нь үхэж байдаг хорвоогийн ёс болохоор яая гэх вэ дээ» гээд босож мордоод хүрэн дээр очиж дөрвөн гэлэнгийн гүнрэг хуруулсан бөгөөд гудамжинд багшийндаа орох ээлж хүлээсэн арав гаруй лам нар дайралдахад нь дэргэд нь очиж өврөөсөө нэг мөнгөн янчаан гаргаж «Лам нар минь ерөөл айлтгая» гээд дунд нь өгчээ.

Буцах замдаа «Өгсөн нэг янчааныг минь хуваах гэж дээлдээ хүрдэггүй байгаа даа» гэж бодоод инээх гэсэн гэнэт царайгаа хувирган дуугүй болжээ.

Сайн зантай хоёр хөгшний түшигт орсон Долгор хүнтэй уулзахгүйг хичээн, хонь хариулж явахдаа нөхөр хүү хоёрынхоо тухай бодно.

Өөрөө Эрдэнийн өмнө аргагүй гэмтэйгээ мэдэвч хүний газар, ямар ч нинжин сэтгэлгүй орхиж алга болсон Эрдэнэд гомдоно. Харин хүүдээ гомдох сэтгэл Долгорт байсангүй. «Хөөрхий бид хоёроос болж тэр нялх амьтан хүний нутагт ямар зовлон үзэж яваа бол» гэж бодоход зүрх эмтрэн нулимс нь хаалтгүй асарна. Эрдэнийн тухай бодохдоо өөрийгөө зөвтгөхийг хичээнэ. Батын тухай бодохдоо өөрийгөө буруутгахыг хичээнэ.

Өдөр бүр хэдэн удаа уйлах учраас нүд нь үргэлж хавантай явах бөгөөд нэгэн удаа гэзгий нь самнаж байсан Дэжид «Хүүгийн минь толгойд хэд хэдэн цагаан үс буй болчихжээ. Залуу хүнд тусгүй. Зулгаагаад хаячихъя» гэхэд нь Долгор «Хэрэггүй ижий минь зовлонгийн минь тэмдэг болон үржиг. Ижий би сахил авч чавганц болох юмсан» гэхэд нь авгай нулимсаа асгаруулан «хүү минь болохгүй, эм хүн бузар арилаагүй байхад сахил хүртэж болдоггүй юм гэнэ билээ» гэжээ.

Долгор шинэ амьдралдаа дасаж хоёр хөгшний төрсөн охин шиг дотно болж ажилд нь туслан Эрдэнэ, Бат хоёрыг бодож зүүдлэн явсаар хувьсгалтай золгожээ.

Амьдрал өөрийн батлагдаагүй хуультай бөгөөд хэн бүхнийг түвгээрээ хөтлөн залдаг жамтай. Энэ ч учраас Долгор амьд яваа болохоор амьдралын хатуу хуулиар залагдаж байв. Ойроос Долгорыг нутгийн нэг бэлбэсэн эр Содном гэгч сууя гэж хоргоодог болов. Анхандаа «сууя» гэдэг үгийг жигшин түвнийг хэлсэн Содномыг хөөдөг байсан бол сүүлдээ «хэрэггүй Содном минь. Би нөхөртэй хүн» гэх боловч түвний үгийг тэвчээртэй сонсон байн байн санаа алдаж байдаг болов.

Содномын гуйлт Долгорын зүгээс талархал аваагүй боловч түвнийг амьдралд ойртуулж, амьд явахын баяраар ундаалж байсан сан. Долгорын сэтгэлд амьдралын хүсэл эрмэлзэл аажим боловч зогсолтгүй хуримтлагдан томорсоор байлаа.

— Залуу хүн хэдий болтол ганцаар явах юм бэ. Ханьтай болбол дээр байх. Өвгөд дээдэс нь төлөв томоотой л улс юмсан гэж Долгор, Содномын яриаг мэдсэн Дэжид авгайн хэлэхэд:  
— Зүгээр л хүн шиг байна. гэвч би Эрдэнийн амьд байгааг хараагүй цагт хэнтэй ч суухгүй гэж хэлээд Долгорын уйлахад Дэжид гуай ч хайлж гардаг байлаа.



Содном бараг өдөр бүхэн ирж Долгорыг гуйна. Долгор ч хөдлөхгүй хатуу байлаа.

— Долгор минь. Би чамд сэтгэлтэй болжээ. Ингэхэд чи дэндүү хатуу аашилж байна даа.

Амьдралд далавчаа хугалуулж элгээ эмтрүүлсэн бид хоёр бие биедээ түшиг бүтэн элэгтэй болж болох сон. Жаргал тун ч ойрхон байна сан.

— Содном минь би хүний ёсолж авсан эхнэр шүү дээ.

— Тийм нөхрөөр яадаг юм бэ?

— Чи намайг битгий зовоо. Би Эрдэнийг амьд явахыг нь хараагүй цагт хүнтэй суухгүй.

Содном минь чи амьдралаа бод. Намайг хүлээж огт болохгүй.

Содном Долгорыг зөвхөн хань гэж бодсонгүй. Долгорын гуа үзэсгэлэн, түвний дорой зөөлөн мэт боловч эрс хатуу зан, сэтгэлийг нь эзэлж, зөвхөн Долгортой суусан цагт өнчрөл бэлбэсрэлийн хатуу хайрцгаас гарч чадах мэт бодогдоно.

Долгорт Содномыг жигших сэтгэл байсангүй. Зөвхөн өөрийгөө Эрдэнийн ёсолж авсан эхнэр гэж хатуу бодсон бодол түвнийг Содномын эхнэр болохоос хамгаалж байлаа.

Ингэж амьдарсаар нэг өдөр хонины хашаа боож байхад нь уяан дээр буусан Итгэлт араас нь хараад таньжээ.

— Долгор хүү минь эргээд хараач гэж Эрдэнэ ирлээ гэж андуурсан Дэжид гуай хэлэхэд Долгор эргэвэл нүд нь дугараг болсон Итгэлт зогсож байлаа.

Долгорын нүд хорслоор дүүрч гөлөрснөө амьтан руу гэтэж байгаа шилүүс шиг биеэ хураан хөлөө алгуурхан зөөж явсаар Итгэлтэд бараг тулж очоод «Миний зовлонд чи бас цадаагүй юу» гэхэд Итгэлт худлаа инээмсэглэн «Чи минь юу болж байна. Амьд уулзсандаа баярлах ёстой биш үү? Юу ч гэсэн золгоё» гээд гараа сарвайхад Долгор хөдөлсөн ч үгүй дуугарсан ч үгүй. Гэвч түвний нүд чаддаг сан бол Итгэлтийг тасчин идэхээс буцахгүй байгаа сэтгэлийг илчилж байлаа.

— Долгор минь би чиний хойноос Ням гуайг явуулсан шүү дээ. Харин цаад зөнөг чинь хутгаж орхисон. Гэтэл би өнөө өглөө чамайг энд амьд байна гэж сонсоод тус больё гэж ирсэн...

— Уухай, Надаас чамд авмаар юм бас байна уу?

— Иш. Тусалъя. Тус больё гэж ирсэн гээд байна шүү дээ. Итгэлтийн хурц нүд ингэж байхдаа Долгорыг ажиглав. Урьдын Долгор биш болжээ. Түвний нүүрэнд оргилж байдаг амьдралын гал, идрийн цог жавхлангүй болсон авч насжин тогтсон эмэгтэй хүний намбатай гуа үзэсгэлэн буй болжээ. Дөрвөлжин магнайд нь буй болсон үрчлээ хүртэл шуугдан хацар, нарийсаж, өндөржсөн хамартай яг л дүйжээ.

Бас ч Итгэлтийн сэтгэлийн буланд гэмшлийн өчүүхэн туяа байсан нь Долгортой учрахад пүр пүр хийн сэргэж ширүүн харьцахыг хориглож байлаа.

— Чи бушуухан зайл гээд Долгор ухасхийхэд Итгэлт зайлж хөөрхий эмэгтэй таварцаглан унав.

Дэжид авгай Долгорыг тэврэн өндийлгөж «хүү минь тайвшир» гээд Итгэлт өөд харснаа

— Чи чинь Итгэлт үү гэж асуув.

— Тийм ээ. Би Итгэлт гэж тайван бөгөөд бардам хариулав.

— Тэгвэл хүү минь явж үз. Энэ хүүхнийг дахин тамлах хэрэггүй.

Итгэлт явсангүй. Эндээс бушуухан явсан чинь дээр. Юу хийх юм бэ гэж нэг сэтгэл хэлэвч нөгөө сэтгэл нь үүссэн гал өчүүхэн боловч унтраагүй орхивол их твймэр болж магад байдаг болохоор болбол үүнтэй эвлэрээд явбал зүгээрсэн гэж зөвлөж байлаа.

— Долгор минь урьдын явдлыг мартаж, хойтын амьдралыг бодвол дээр биш үү? Би чамд тус болоход бэлхэн л байна.

— Бушуухан зайлаад аль. Тэр л надад тусламж ... гэж Долгор өндийн шийдэмгий хэлжээ. Итгэлт эвлэрч чадсангвй явжээ. Харин нутагтаа эргэж очоод Долгортой уулзсанаа хэнд ч хэлээгвй бөгөөд хойно Долгор амьд гэдэг вгээр санаснаа хийсэн нэгэн цагт алсын бодолтойдоо хэмжээлшгвй баярлан бахархаж билээ.

Х

Түргэн урсгал, шил шиг тунгалаг усаараа тоглон гайхуулж байгаа Тамираас Итгэлтийн адуу ус уугаад билчээртээ азарга азаргаар цувран гарахад тvvний хойноос хээр морь унаад бөгсөнд нь булцуутай нарийхан хар модон уургаа барьсан Хонгор явна.

Хонгорын морь хазаар даран хөндөлдөж, уурга нь савлан сүртэй бөгөөд ихэмсэг харагдана. Ингэж хэсэг явснаа бууж олмоо чангалаад уургаа газар хаян мордоод адуугаа вргээн давхиснаа мориныхоо хажуу тал руу унжин чулуу шvvрэх гэж оролдоно.

Хоёр дахин мориноосоо ойчсон боловч сургуулиа зогссонгвй. Заримдаа гарын взvvр нь газарт хврэвч чулуу авч вл чадна. Сvvлийн хэдэн өдрийн турш Хонгор морины хурд дунд чулуу шvvрэх сургууль хийсэн билээ. Эцэст нь газар хүрдэг болсон. Гэвч чулуу авч бас л чадахгвй байлаа.

Нэг удаа ойчсоны дараа зvvн хөл дээрээ майжигнан доголж морио хөтлөн хэсэг явснаа мордож «заавал болгоно доо» гэж шvд зуун шивэгнээд мориндоо ташуур өгөв.

Уулаасаа омголон морь ташууранд улам галзууран хурдлав. Хонгор буруу тал руугаа унжин бөөрөнхий чулуу шvvрэн автал нөгөө талын хөл нь эмээлийн дээгvvрээ давуулсан дөрөөнөөс мултран өрөөсөн хөлөөрөө дөрөөндөө чирэгдэв.

«Дөрөөндөө чиргvvлж, дөрвөн мөчөөрөө тасчуул» гэсэн хараал бол монгол хvний хамгийн булай хараал билээ. Морь нь вргэж улам хурдлав. Хонгор ойн буун газар цохилж, гар нь сарвалзан, дээл нь сэвсэлзэж морио улам вргээнэ.

Ашгвй аз болж гутал нь сугаран Хонгор вхсэн элээ шиг навсайн влдэв.

Салсан гутал нь хаягдаж, вргэсэн морь гөлмөө дэрвэлзvvлэн адууны зvг харвасан сум шиг алга болов.

Нэг удаа босох гээд Хонгор яраглан буцаж хэвтсэн боловч удалгвй нvдээ дахин анин, хөмхийгөө зуун босоод хэдэн удаа дэвхэрч дэвхрэх бүрдээ «ёо» гэж дуу алдаж байв. Өрөөсөн гараараа сvвээгээ барин найган зогсож байснаа адууны зvг алхав.

Сvвээ, суга нь хэд хэдэн газраа тэсэж боломгвй өвдөвч шvд зуун явсаар орхисон уургаа авч хэсэг зогсов.

Нуруу нь хэд хэдэн газраа шалбарсан бололтой халуу шатан хорсоно. Хуучин хврэн дээлний нь ар шимт ногооны шvvсэнд будагдан хар ногоон болжээ. Чулуу шvvрч болдоггвйн учрыг бодож эхлэв. Урт ганзаганаасаа өрөөсөн гараараа барьж налбал мориноосоо салахгвй мэт бодогдов. Энэ бодол орж ирмэгц морио түргэн барьж аваад взэх хvсэл оргилов.

Уургаа чирэн хазганан явсаар эмээлтэй морио барьж аваад буруу талын урд ганзаганд хуйваа залгаад мордов.

Хэд хэдэн удаа шалгаж взсэний дараа зоригтой гэгч нь зангидсан гарын чинээ чулуу атгаж аваад хуйваа даган эмээл дээрээ гараад гар доторхи чулуугаа ялалтын баяр гялалзсан нvдээр харж инээмсэглэв.

Хонгор инээж, Хонгор баярлаж, бvх болсон явдал, хөхөрч шалбарсан биеийн өвчнөө мартаж сэтгэл нь хөөрөн оргилов. Үд өнгөрөхөд харж цохсон чулуугаа алдалгвй шvvрдэг болсноор барахгвй хоёр талын алинаас ч авч чаддаг болжээ. Уургаа авч гэрийн зvг явахад аяндаа дуу дуулж, хурдалж байгаа морь нь удаан юм шиг Тамирын хөндий явцуу мэт санагдаж байлаа. Дуу хангинуулан аялж, хурдлан явтал тугал буцаагаад харьж явсан Сврэнтэй дайралдав.

— Чи хаачаад ирэв? гэж Сүрэн бүлээнээр инээмсэглэн асуув.

— Адуугаа услаад, бас дээд хотоор айл хэсэж яваад ирлээ гэж Хонгор хариулав. Сурсан сургуулиа Сүрэнд үзүүлж эрмэг чадалтай эр болсноо түүнд гайхуулахаас илүү сайхан юм үгүй болсон Хонгор: «Сүрэн чи намайг хараач» гээд ухасхийн адууны бөөн хомоолоос шүүрч аваад шидсэн чинь гай болж Сүрэнийн нүүрэн дээр бутрав.

Болчимгүй хийсэн хэрэгтээ гэмшсэн Хонгор толгойныхоо алчуураар нүүрээ цэвэрлэж байсан Сүрэнд юу ч хэлэхээ мэдэхгүй түмэн гэмшил бадарч барзайсан царай гаргасаар ойртон очлоо.

— Өвчтэй золиг. Мориноосоо унаад үхвэл яах юм бэ гэж Сүрэн өндөр юман дээрээс унаад ямар ч гэмтэлгүй босож ирсэн ганц хүүхдээ загнаж байгаа эхийн дуугаар зэмлэв.

— Би чамайг ононо гэж огт бодсонгүй хэмээн Хонгор гэмшилтэйгээр хэлээд Сүрэнийн хацар дээр үлдсэн хомоолын үртсийг авах гэж алгаараа илснээ гар нь хацар дээр нь наалдсан мэт хөдөлж чадахгүй болов.

Сүрэнийн царайд улаан туяа цацран хөдлөлгүй зогсох бөгөөд Хонгорын нөгөө гар нь Сүрэнийн гарыг атгаж авлаа.

— Чи ингэж байж мориноосоо ойчно доо гэж Сүрэнийн хэлэхэд зэмлэх, сайшаах ямар ч шинж байгаагүй бөгөөд энэ бол хэлэх юмаа олж ядсан хүнээс арай ядан гарсан үг байв.

Нэг хэсэг ширтэлцэн байсан дөрвөн нүд аяндаа буруулж Хонгор ч аажмаар нэг гараа татаж нөгөө гараа сулруулав. Их хайраар ширтэлцсэн дөрвөн нүд бусад хүнд эв хавгүй болдог боловч бие биедээ улам гуа болдог болохоор энэ дөрвөн нүд ч бие биеэсээ шинэ сайхан зүйл олж аваад буцав.

Бас энд чинь гээд Сүрэнийн магнай дээр байгаа хомоолын үртсийг зөвхөн хурууны үзүүрээр, нямбай хүн дээл дээрх үсээ авч байгаа мэт цэмцгэрхэн авч няслав.

— Морин дээрээсээ юм шүүрч байгааг аавд чинь хэлнэ шүү гэж Сүрэн зэмлэнгүй хэлснээ тэсэж чадалгүй жуумалзан инээв.

Хонгор ч хөгжилтэй инээв. Сүрэн Хонгорын мөрөн дээрээс аяархан татаж далы нь харснаа «чирэгдээ юу» гэж огцом асуув.

— Чи гүвээд аль л даа.

Сүрэн хэдийгээр хичнээн арчивч ногооны шүүс яаж арилах билээ.

— Хүүхэд шиг. Аав чинь мэднэ дээ. Яана.

— Чулуу шүүрэх чинь халхын сайн эрийн ажил шүү. Би чамайг дүүрээд явъя.

Яршиг, чи өөрөө яв. Хонгор мордож эргэн харсаар, харах бүрдээ дүүрэн хайрын инээмсэглэл бэлэглэж, хариуд нь бас түүнийг авч явахад ертөнц, амьдрал юутай сайхан байлаа.

Хонгор өдөр өнгөрөх тутам морин сургуульд чадамгай болж давхилт дундаа чулуу шүүрээд гэдрэг нь хүчтэй шидэж чаддаг болсноор барахгүй, дөрөөндөө чирэгдэн яваа дүр үзүүлэн давхиж чаддаг болжээ.

Нэг удаа Сүрэнд сургуулиа үзүүлэхэд түүний сэтгэлд догдлол, бахархал хоёр хослон байж билээ. Хүнийг хайрлаж, түүний төлөө догдлол, түүний хийж байгаа юманд бахархаж байх нь хүн болсны ёстой аз, жаргал гэдгийг Сүрэнг харсан хүн ойлгох байсны адил хайртай хүндээ чадал эрдмээ үзүүлж байгаа хүн ямар хүч самбаатай болдгийг Хонгорыг харсан хүн ойлгож чадах байлаа. Хонгорын сэтгэл баяраар дүүрэн, биед нь уран чадал, хүч зориг бадран, урьд нь олигтой болдоггүй юм нь хүртэл Тамирын урсгал шиг амархан бүтэж байлаа.

Намрын адаг сарын нэг өдөр Итгэлтийнх өртөөний ээлжийн морь явуулах болж аль ороо тарган морьдыг барилахад Тамирын голын шилдэг уургачид цугларав.

Урьд өмнө Галсан иймэрхүү ажлын вед бүхний магтаалыг хүртэж, ярианы гол болон

гайхуулдаг байж билээ. Энэ удаа ч Галсангийн уран хаялт, эвтэй бөгөөд хийгий нь дайруулан ямар ч морийг эргүүлдэг таталтыг цугларагсад үгээ олж ядан магтаж байлаа.

Ороо хээр гэж алдаршсан пагдгар зузаан биетэй бор хээр морийг барих болж хоёр ч хvн модон сэтэр зvvж алдав.

— Галсан ах бид хоёрт шургуулаад аль гэж Хонгор хэлэв. Итгэлт хvв нь адуунд эр чадалтай, овоо уургач болж байгааг мэдэх боловч ороо хээрийг шургуулж уургалах өдий гэж бодоод «онгирсон дамшиг минь гуд татуулж vxэх нь vv» гэлээ.

— Ах аа та Хонгорыг мэдэхгvй байна. Айхтар болсон шvv гээд Галсан Хонгор руу харлаа.

— Би эмнэг хvрэн азаргыг тогтоодог юм гэж Хонгор нам дуугаар хэлэв.

— Задарсан дамшиг, билчээрт азарга уургалдаг байх нь ээ гэж Итгэлт дотроо инээн хэлэхэд тvvний үгэнд зэмлэх өнгө огт байсангvй.

Хvв нь ороо хээрийг уургалаад тогтоовол Итгэлтэд тvvн шиг баяр хаа байх билээ.

— Та хоёр тэнд зогсож бай. Бид шахаж өгье гээд Итгэлт эргэснээ зогсож Галсанг дуудаад «Эхлээд цаадахдаа өгөөрэй» гэж шивэгнэн хэлэв.

Хээр морь Хонгор Галсан хоёрын дундуур харвасан сум шиг чавхдан дайрч өнгөрөхөд Хонгор мориныхоо далтай хацраа нийлvvлэн сунаж уургаа хаян эргvvлсэнд нарийхан хуйв морины чихлуурар чавдан орлоо. Харсан бvхэн Хонгорын уран хаялтыг магтахад Итгэлт «Дамшиг минь гуядаад тат тат» гэж эмээл дээрээ тогтон ядан хашгирна.

Хонгор, хээр морийг тогтоосой гэж Итгэлтээс өөр бас нэг хvн сэтгэл, зvрхээ шаналуулан бодож байлаа. Энэ бол хэдэн өдрийн өмнө Хонгор унаж амийг нь мэдvvлж өгсөн бор даагыг унаад vнээ гилж явсан Сvрэн юм. Харин:

— «Аргагvй л уургач хvн юм даа», «Адууны дэргэд нvvр бардам зогсох эр дээ» гэж зэрэг олон сайхан vгийг амтай бvхнээс сонсож сурсан Галсанд атаархах сэтгэл аяндаа оволзов. Учир нь морь уургалах бvрд нь Галсанг мялааж байдаг үг одоо Хонгорыг мялааж байлаа.

— Уургач хvв юм даа.

— Адуутай хvний хvв шиг байна.

— Хуйв нотлоод авч байгаа юм шиг.

— Морио гуядаж байгаа самбаа нь, өнчин хурга уургалж байгаа юм шиг гэх зэрэг хvmvvсийн шагшин ярилцахыг сонсож байгаа Галсан дотор нь харлахдаа «Таталт нь хvчгvй байна» гэснийг анхаарсан хvнгvй бөгөөд гай болж сонссон ганц өвгөн «Нас нь бага цус нь шингэн байна даа. Эр бие гvйцээд ирэх дээр энэ хvвгийн гараас арслан ч мултрахгvй» гээд толгойгоо алгуурхан ганхуулж байлаа.

Уургаа хагас алд ахиулж авсан Хонгор эмээлийнхээ араар суугаад татахад хээр морины нь толгой өөрийн эрхгvй эргэлээ.

— Дамшиг чинь тогтоож орхилоо шvv гэж Итгэлт бараг хэлж дуусаагvй байтал уурга чирсэн хээр морь баруун уулыг чиглэн хангинав.

Хээр морь Хонгор хvвгийн гарт орлоо эргэлзээгvй болсон хvmvvс юу болсны учрыг олж ядаж байхад Хонгор урд зvгт мориндоо ташуур өгч салхи мэт хурдлав. Хvmvvсийн анхаарал тэр зvг шилжиж гэдсэндээ эмээлээ чирсэн бор даага давхиж байгааг сая олж харцгаав.

Энэ хэний даага вэ. Хонгорын морь уургалж байгааг бахдан харж байсан Сvрэн салхинд хийсэж ирсэн навтасаас үргэж бултсан дааганаасаа унаад, эмээл нь холбирон алджээ. Үvнийг ороо хээрийг тогтоосон бахархалт нvдээ хамгаас тvрvvнд Сvрэнд бэлэглэх гэж харсан Хонгор хараад уургаа хээр морины хvзvvнд сэтэр болгон vлдээжээ.

Улс гvйцэт ухаарч гvйцээгvй байхад Хонгор алдагдсан даагыг гvйцэж очоод мориныхоо хажуу руу налан унжиж эмээлийг нь салгаснаар барахгvй цулбуураас нь барьж авсан ажээ.

Хvvгээ ил магтахыг цээрлэсэн мэт явдаг Итгэлт энэ бvхнийг хараад «миний хvv ч эр болж дээ» гэж чанга хэлэв. Энд байсан хvн битгий хэл, алтан намраар гоёсон дуулим хорвоо, ганц ч vвлгvй цэнхэр тэнгэр, гялалзан жирэлзэх холын аянаа хийж байгаа тунгалаг тамир цөм Хонгорт бахархаж тvvнийг магтан буй мэт эрхэмсэг бөгөөд гуа байлаа.

XI

Довчингийн дээрэмчид бvрмөсөн устаад шархтай Эрдэнэ өнөөдөр ирж цэргийн эмнэлэгт хэвтжээ гэдгийг Хуягт мэдэж ирээд Төмөрт нууцлан шивэгнэж хэлэхэд гурил элдэж суусан Бат нэг ч vг сонсоогvй атал ямар нэг ёозгvй юм болжээ гэж тааварлав. Зовлон туулсан хvн шинэ зовлонгийн сэжгийг vлэмж соргог хvлээн авдаг бололтой.

Бат босож Төмөр, Хуяг хоёрыг том дугуй нvдээр ээлжлэн ширтэж байснаа айсан зэвхий дуугаар:

— Надаас битгий нуу. Аав минь яасан бэ? гэж шууд асуухад «Би яасан азгvй амьтан бэ?» гэж тvvний гөлөрсөн нvд хэлж байлаа. Хуяг амаа мурилзуулан инээмсэглэх мэт болсноо:

— Дvv минь, аав чинь зvгээр шархтай ирээд эмнэлэгт хэвтсэн. Одоо ингээд очиж уулзъя гэлээ.

Гашуудлын гунигт хар мэдээ сонсоно гэж айн бачимдсан Бат «аав чинь зvгээр шархтай ирээд эмнэлэгт хэвтсэн. Одоо ингээд очиж уулзъя» гэсэн vгэнд баярлан «шархтай...» гэдэн vгийн учрыг бvрэн ойлгосонгvй. Бат дахиад олдохгvй учир нэг сайн амьсгалж авъя гэсэн юм шиг цээж дvvрэн агаар татсанаа:

— За явъя. Тvргэн уулзъя гээд малгайгаа өмсөв.

— Ахад талийгаачийн тухай хэлж болохгvй шvv. Дараа эдгэрсэн хойно нь хэлнэ. Мэдэв vv гэж Төмөр ачдаа хатуу захижээ.

Хvvгээ ороход Эрдэнэ хэвтэж байснаа өндийж магнай дээр нь vнссэнээ дvрлэгэр нvднээс нь тунгалаг хар нулимс дуслав.

«Аав минь ижийн тухай сонсож дээ» гэж бодсон Бат гvн санаа алдаад харцаа буруулан доош харлаа.

— Петр ах ирсэн vv? гэж Бат нэгдvгээрт ачит тэр хvнтэй уулзах гэж оргилсон хvслээс, хоёрдугаарт эхийн нь тухай муухай мэдээгээр элэг нь эмтэрсэн эцгийнхээ сэтгэлийг тvр болсон төөрvvlэх бодлоос асуув.

Эрдэнийн царай барайж хөмсөг нь зангиран, хацар нь татвалзсанаа толгойгоо аажим сэгсрэв.

— Хэзээ ирэх вэ?

— Огт ирэхгvй хvv минь.

— Юу?

— Петр ах чинь намайг хамгаалж байгаад алагдсан гээд нам бөгөөд ямар ч өнгөгvй дуугаар юу болсныг ярилаа. Гэвч Бат «алагдсан»-аас хойшхи vгийг сонсож чадсангvй.

Батын сэтгэлд Петрийн мөнхөд vлдсэн дvрvвд солигдон гашуудлын бөөн хар тээг хоолойд нь зангиран, амьсгалах агаар тасалдаж эхлэв. Тасалгааны юмсын өнгө аажмаар бараантан бvдгэрсээр эцэстээ нэлийсэн хар манан болов.

— Би яасан азгvй хvн бэ? гэж гунигтаа хахаж тасарсан битvv дуугаар хэлэв.

— Яая гэхэд дээ хvv минь, дайн гэдэг ийм л байдаг байна. Мөн ч ховор сайн хvн юмсан гээд Эрдэнэ байшингийн туургыг цавчилгvй ширтэн байхад бvлээн сувдан хэлхээ хацрыг нь даган бөмбөрнө.

Тэр орой оюутны сургууль дээр гашуудлын хурал болж Бат ямар ч хориглолгvй урсаж байгаа нулимсаа гарынхаа алгаараа арчин байж Петрийн тухай ярилаа.

Луу гvний хошуу наадмын вед тэрэгний аралд хага цохиж өгсөн мөсөн чихэр, хvрээний их

чөлөөнд өлсөж байхад нь өгсөн талх бүгдийг яриад «амьд явсан цагтаа ахаа мартахгүй» гээд үг нь тасрав.

— Үхэл юунд ингэж сайн хүний амьдралд ховдог байдаг юм бэ гээд нэг хүн эхэр татан уйлж байсан нь Жаргал байв.

Бусад шавь нар ч гэсэн үргэлж ирж Бат, Жаргал хоёрыг эргэж байсан хөгжилтэй орос даргыг бодон бодон гашуудан байж билээ.

«Ардын цэргийг ерөнхийлөн захирах жанжин Сүхбаатар танаа өргөн гуйх нь:

Оюутны сургуулийн шавь нар бид, улс төрийг минь хамгаалж яваад алтан амиа алдсан Петр ахын өшөөг авахын учир ардын улаан цэрэгт орж хувьсгалын муусайн дайсан нарыг үнсэн товрог болгох хүсэл оргилон байна. Анхааран үзэж бидний хүслийг тогтоон соёрхоно уу?»

гэж шавь нар өргөдөл бичээд бүгд гарын үсэг зурж, хоёр хүн томилуулан явуулсныг

Сүхбаатар хүлээж аваад «Петр комиссар бол манай монголын ард олны сайн, сайхны төлөө тэмцэж явсан хүн. Та нар ном эрдмээ хичээнгүйлэн сурч, сайн багш нар болох нь дайснаас өшөө авч байгаа хэрэг. Бас цөм залуучуудын эвлэлийн гишүүн болж сургууль дээрээ үүр байгуулж түүнээ «Петр» гэж нэрлэвэл зүгээр» гэж зөвлөв.

Хэдэн өдрийн дараа оюутны сургууль дээр залуучуудын эвлэлийн үүр байгуулагдаж түүндээ Петрчүүд гэдэг нэр өгчээ.

Сар гаруй хэвтээд Эрдэнэ суга таягтай боссон боловч үг дуу цөөнтэй, нилээд оворжуу шал өөр хүн болжээ.

Нэг өдөр Төмөр, Дулмаа хоёр ирж удтал ярилцаж байгаад Долгорын гунигт төгсгөлийн тухай хэлжээ. Эрдэнийн царай ямар ч өнгөгүй болоод ганц үг дуугарсангүй. Үнэндээ дуугарах ч чадал байсангүй билээ.

Тэднийг явснаас хойш ганцаар хэвтэж байхдаа өршөөлгүй хорвоод өнгөрүүлсэн амьдралаа бодно. Долгор үхсэн, түүнтэйгээ би дахин уулзахгүй гэж бодоход сэтгэл нь хөндий хоосон болон өөрийн мунхаг бөгөөд богино ухаан, хатуу сэтгэлийг жигшин харааж «бүх хэрэг надаас гарсан. Надаас болсон. Би дэргэд нь байсан бол хаанаас ийм юм болох билээ» гэж бодно.

Заримдаа өөртэй нь учирсан бүхэн үхэж үрэгдэж байдаг юм шиг бодогдоод «Би гэдэг хүн салах хагацах одонд төрсөн амьтан юм уу» гэж бачимдан өөрөөсөө асууна.

Маргааш нь үдийн хирд Бат ирээд учир тоймгүй уйлахад Эрдэнэ хүүгийнхээ толгойг элгэндээ наан чанга тэвэрч дуугүй хэсэг сууснаа «хүү минь чи бид хоёртой амьдрал арай хатуу тоглож байх шиг...уйлаад яахав. Нэгэнт ийм болсон хойно сэтгэлээ барьж хатуужна.

Хүү минь чи миний богцонд байдаг торгыг аваад Дашчойнхорын дацанд аваачиж эхдээ ерөөл айлтга. Бас нэгэн мөнгөн аяга буй. Түүнийг аваад Консулын дэнж дээр байдаг оросын сүмд өг» гэлээ.

Зэрэг зэрэг болсон гуниг гашуудал Эрдэнийн сэтгэлийг нугалан эвдэх шахаж байлаа.

Харанхуй манан Эрдэнийн бодлыг хаан мухардуулж байлаа.

Бат нулимсаа ханцуйгаараа арчих зуур толгойгоо сэгсрэв. Эцэг хүүгээ гайхан харлаа.

— Би аваачиж өгөхгүй.

— Би тэр торгыг чинь ижийд чинь хадгалж явсан юмсан. Тэр мөнгөн аягыг Петрийг буцахад нь бэлэн болгоё гэж бодож байсан юм.

— Би тэр гандан, сүмд чинь очихгүй.

— Аав нь ч эргэж орхилоо. Нэгэнт өгөх гэсэн эзэд нь алга болсон болохоор аваачаад өгчихвөл тус болохгүй ч хор болохгүй байх гэж бодсон юм.

— Ямар ч тус болохгүй. Богдоосоо аваад цөм яргачин, мөнгө өгөөд л гэмгүй сайн хүнийг

алдаг юм. Нүгэл гэж яривал тэд л хийдэг гэж Бат хоолойгоо хяхруулан хашгирахад саяхан уйлж байсан нүд нь хорсол, жигшлийн галаар эргэлдэж байснаа:

— Яасан ч өгөхгүй гээд Бат анги Эрэнчинг Богд яаж алуулсныг яриад ёстой яргачин, дээрэмчин гэлээ.

Эрдэнэ хvvгээ ахин шаардсангvй. Батыг явахад нь магнай дээр нь vнсээд «Аав нь юм бодох чадалгvй болоод байна» гээд гэмшилтэйгээр харжээ.

Эрдэнэ өдөр ирэх тусам сайжирч таяггvй босож явдаг болов. Төмөр нэг удаа эргэж очоод, цэргээс халагдаж Дулмаатайгаа хамт өсөж төрсөн Сvхийн голдоо очиж хэдэн малтай болоод ариун цагаан хөдөлмөрөөр амьдрах тухай шийдэж Хатанбаатар вангаас гуйсан нь ёсоор болж, ардын цэргийн албанаас халагдан тавин лан мөнгө, дээлийн хоёр чисчvv, бярдан буугаар шагнагдсан тухайгаа баяртай ярив.

Гурван өдрийн өмнө Төмөр Дулмаа хоёр Хатанбаатартай уулзаж нутагтаа буцаж мал маллан амьдрах хvсэл мөрөөдлөө ярихад «Би та хоёрын хvслийг сайн ойлгож байна. Ариун шударгаар амьдарч чадахад чинь итгэж байна. Өөрсдөө сайн ярилцаж бодсон юм бол тусалж өгнө» гэсэн билээ.

Эрдэнэ бодол болон Төмөрийг ажиглаж байснаа:

— Ээ дээ дvv минь, хичээж л vзээрэй. Хулгайч хvнд дон шvглэсэн байдаг юм гэдэг шvv гэлээ.

— Ахаа би хулгайч биш гэж танд мөн олон хэлсэн дээ. Хорвоо дээр хоёулахнаа нэг эхээс төрсөн байж бие биедээ итгэж байвал зvгээр сэн. Би танд хэлсэн vгнээсээ буцаж байгаагvй байх аа гэж Төмөр гомдолтой хэлэв.

— Чамайг сайн яваасай гэж бодсоноос л хэлэх юм даа.

— Та над мууг хvсэхгvй. Гэвч дэмжлэг хvссэн ариун санааг минь буруу талаас нь нударх тун эвгvй байх юм.

— Юу ч гэсэн бодож яваарай. Чи дэндvv цайлган санаатай шvv дээ.

— Тэр ч vнэн шvv.

— Чи тэгээд Тайширт очиж нутаглах хэрэг байна уу? Ээ дээ хэцvv нутаг шvv.

— Нутаг минь муу биш ээ. Тэр чинь бид хоёрын өвөг дээдсийн нутаг. Бид хоёрт тэр нутаг муу юм хийгээгvй.

— Би ч бараг хөөгдсөн хvн дээ.

— Харгис ноён нь хөөснөөс биш, нутаг ус олон тvмэн нь хөөгөөгvй биш vv?

— За тэр ч яахав. Чи хэзээ гарах гэж байна?

— Нэгэнт таны бие сайн болсон хойно ойрын өдрvvдэд гарна. Үнэхээр ч хэдэн өдрийн дараа Дулмаагаа дагуулсан Төмөр баруун зvгийг чиглэн ачаа ба хөтөлгөө морьтой гарч билээ. Хvрээнд урт ч, сайхан ч намар болов. Өдөр бvр номин цэнхэр тэнгэр дээрээс мишээж гол дээрх айлын зарим нь хvртэл тэндээ өвөлжих гэж байгаа юм шиг хөдлөхгvй байлаа. Гэвч өвлийн эхэн сар ирж хvйтний vзvvр хvмvvсийн хацрыг илбэж эхлэв.

Өвлийн эхэн сарын нэг өдөр зvvн Сэлбийн зvvн эрэг дэх ардын цэргийн эмнэлгийн цагаан байшингаас зvvн хөл нь мижилзэн доголсон Эрдэнэ гарч ирлээ. Эмнэлэгт удаан хэвтсэнээс царай нь цонхийж нүдний нь доод талын арьс сулран vрчийжээ. Хvнд шархдан шаналж турснаас нүд дvрлийж шанааны яс нь овойжээ.

Эрдэнийг Хуяг, Бат хоёр угтан авч мордуулахад хvv нь сундалдав. Ингээд тэр гурав Дvнжингаравын дэнж дээр байдаг Хуягийн гэрт очив. Дулмааг байхад халуу бутарч, тос дааварлан байдаг гэр цэвдэг бөгөөд новширхуу болжээ.

Өдөр бvхэн Хуяг ажилдаа, Бат сургуульдаа явах бөгөөд Эрдэнэ чөлөөний овоо хугацаатай

учир гэрийн ажил хийнэ.

Аргын шинэ гарч Эрдэнэ цэргийн яаманд түшмэлийн ажил хийж байтал Сүхбаатар дууджээ. Эрдэнийг ороход Сүхбаатар жижигхэн дөрвөлжин цагаан дэвтэр барин дүүрэн баяртай угтаж ирээд амар мэндийг нь мэдэж биеийг нь асуув.

— Чамд манай ардын намын гишүүний бат илэрхийлэх гардуулан өгөхийг Намын Төв Хороо над даалгасан юм гээд дэвтрээ өгч «чанга унш» гэлээ.

Эрдэнэ Сүхбаатарын царай руу харж инээмсэглэснээ «Монгол ардын намын төв хорооны бичиг. Бат илэрхийлэх тэмдэгт бичиг шийтгэн олгосны учир Засагт хан аймгийн Засагт ханы хошууны Цогтын Эрдэнэ манай намын журам суртлыг зөвшөөрөн хүлээж, шашин төр ба ард түмний тусад чин зориг, үнэн санаагаар амь болоод хөрөнгө хайрлалгүй зүтгэсвгэй гэсэн учир бат илэрхийлэх тэмдэгт бичиг шийтгэн олгов. Иймийн тул аливаа ардын намын гишүүд нар учрыг мэдэж үнэнийг илтгэн улс төрийн их хэрэгт харилцан туслалцах ажаамуу» гэж уншив.

— Чи минь Хиагтыг дайрах өглөө намын гишүүн болсон биз дээ.

— Тийм ээ. Үүр хаярахын өмнөхөн.

— Тэр өглөө хаярсан үүл одоо монголыг гийгүүлээд байхад бат илэрхийллээ авч байна.

— Тийм байна. Жанжин минь. Зорьсон хэрэг биелэх шиг сайхан юм алга бололтой.

— Тэр тусмаа сайхан хэрэг сэтгэлчлэн бүтнэ гэдэг бол хүн болсны гавьяа гээд ширээн дээрээ байсан хайрцаас урт цагаан соруултай орос янжуур авч Эрдэнэд өгөв.

— Жанжин та талийгаач Петрийн тухай сонссон биз дээ. Сүхбаатар гүн бөгөөд урт санаа алдсанаа

— Сонссон. Хайран хүн. Ховорхон эр шүү. Бидний төлөө, монголын ард түмний төлөө Зөвлөлт улсын олон тийм сайхан хүмүүс алтан амиа өгснийг мартаж болохгүй юм шүү ... Петр комиссар та хоёр ч бүр эртний танил шүү дээ.

— Тийм ээ. Эртний танил.

— Хувьсал хийнэ гэдэг сайхан атал хэцүү ажил байна даа. Би Долгорын чинь тухай Хуягаас сонссон. Харамсалтай юм болж дээ.

— Одоо яахав дээ. Жанжин минь. Би ч гэмшээд барахгүй байна.

— Лав үхсэн байдаг байгаа даа.

— Тэр ч гарцаагүй үхсэн хэрэг.

Тасалгаанд нам гүм бөгөөд хоёр хүний амьсгалах нь дархны том хөөрөг үлээх адил сонсогдож байлаа.

— Петрийн гэр оронд нь нэг захиа бичье гэж бодох юм. Гэтэл нэгдүгээрт хаа байдгийг нь мэдэхгүй, хоёрдугаарт орос хэл мэдэхгүй болохоор гээд Эрдэнэ гомдолтой санаа алдав.

— Бид засгийн газрын өмнөөс захиа сэлт бичсэн. Чи монголоор бичээд надад аль. Би орчуулаад өгье.

— Чингэвэл гялайх нь тэр гээд Сүхбаатарыг харлаа.

— Сүхбаатарын хүнд ажил, хүчир бодолд дарагдан нойргүй хонож сүрхий ядарсан боловч цог гэрэлтсэн хурц нүд өөдөөс нь ширтэж байлаа. «Хүнд байна. Маш хүнд байна. Гэвч давж гарна шүү» гэж тэр хоёр нүд хэлж байв.

## XII

Өгөөмөр намрын цагт Тамирын сав нутаг сүрхий согтсон онгиргоон бөгөөд өглөгч хүнтэй төсөөтэй байдаг билээ. Өндөр ургасан өвс халиуран найгаад, намрын цэцгүүд өнгө булаалдан дөнгөж үзүүр нь шарласан мод нарны гэрэлд шижир алтан туяа цацруулан, хайнаг сарлаг алаглаж бэлчинэ.



Бөргийх ч үүлгвй тэнгэр цайвар хөх туяагаар ертөнцийг гийгүүлэн хаашаа харвал манан татан, сүрлэг өндөр уул униартана. Айлын тооноор гарсан утаа хүртэл энэ хөхөмдөг униараас үл ялгарах ажээ.

Тэнгэр намрын ийм өдөр бүхэн ер бусын тайван, ихэмсэг бөгөөд намбатай байдаг. Иймэрхүү цагт энэ нутгийнхан өөр газар төрөөгвй азаа магтаж хултай айраг, аягатай архи барьж «хошууны орон тамир» гээд өндөр, нам, нарийн бүдүүн хоолойгоор хангинуулах дуртай.

Өлзийнх хойт Тамирын урдах эрэгт нэг тал нь хадан хошуугаар хашигдсан амны адагт намаржиж байлаа. Өлзий, ач хүү Хүрэлийн хамт хэдэн өдрийн турш түвсэн мангир нь хатаж, Цэнд хүүхэн өрмөө хайлж, холих цаг болов.

Хуягаас удтал ямар ч сураг чимээгвй байжээ. Гэтэл өнгөрсөн хавар нэг хүн ирж хүү нь Хатанбаатар вангийн цэрэгт эсэн мэнд сайн явж байгаа урамтай хэл авчирчээ.

— Баатар вангийнхантай байлдаж яваа хэрэг үү?

— Манай орныг идэх гэж ирсэн цагааны дээрэмчид, тэдний сүлбээ нарыг дарж яваа юм.

— Ардын нам гэдэг чинь аль талд нь байна?

Анх Өлзий ардын намыг жигшин үзэж байсан. Гэтэл сүүлийн үед сонссон олон хүний ярианаас ардын нам гэдэг тийм ч муу зүйл биш гэдгийг ухаарч эхлээд ганц хүүгээ түвний эсрэг цэрэгт явуулсандаа гэмшин явжээ.

— Манай баатар ван ардын нам бол монгол орныг аврах тавилантай юм гэж айлдсанаар барахгвй, өөрөө түвний гишүүн нь болсон. Бодвол танай хүү ч ардын намын гишүүн байх шүү.

— Гишүүн гэнээ. Албат нь болж дагаж орсон хэрэг үү?

— Тэгж ойлгоход болл.

— Би ч мөн тэнэг хүн юм. Миний хүн ч мөн ухаантай хүн юм даа гэж Өлзий намуу дуугаар хэлээд санаа алдав.

Хатанбаатар ван ардын намын алба нь болсон гэдгийг сонссоноос эхлэн Өлзий өвгөний ардын намын тухай бодол эрс өөр болжээ.

Нэг өглөө Цэнд тосоо хольж эзгийг буцалгаж эхлэхэд энэ жил арван хоёр хүрч байгаа Хүрэл хүү нь түлш авахаар хайнаг тэрэгтэй явжээ. Харин Өлзий өвгөн Тамирын хөндий өгсөн аяга тагш юм эргүүлэн шогшив.

Хүрэл явсаар модонд хүрч тэргээ буулгаж хайнагаа уяв. Асга бүхний захаар ургасан хад, харсан хүний хүслийг аргамжин авдаг учраас намар цагт Тамирын захын ууланд гарсан хүүхэд ардаа гэртэйгээ амархан мартдаг юм.

Үнэхээр ч Хүрэл хүү түлээ түвхээ мартаад яргуйд орсон ямаа шиг молцоглосон хар цэнхэр хадыг үмхэлж бут яргуй дамжин гүйв.

— Сайн байна уу? жаал хүү гэж дуугарахад Хүрэл цочин харвал хад идсэнээс ам нь улаан хүрэн болсон залуу эр зогсож байлаа.

— Сайн, ах та сайн байна уу?

— Сайн... хүүгийн гэр хаана вэ?

— Их амны адагт. Ах аа та юу гэж яваа хүн бэ?

— Ах нь уу? Хад түвж явна. Миний дүү хэнтэй яваа юм бэ?

— Хэнтэй явдаг юм бэ гэж эгдүү нь хүрсэн огцом дуугаар хэгжүүн хэлсэнээ цээжээ түрэн дээгүүр харж байгаад, «би ганцаараа хайнаг тэрэгтэй түлээ авч явна. Би үргэлж ганцаараа явдаг» гэлээ.

— Сайн хүү байна, миний дүү гээд залуу ийш тийш харснаа, —хайнаг тэрэг чинь хаана байна вэ? гэлээ.

— Доор, модны захад буй. Ах аа энэ бутны хад гоц амттай юм та идэхгвй юв?

Тэр хоёр баахан хад идэж аваад залуу дагуулан явж модны жижигхэн чөлөөнд уясан согоо шиг гурван морины дэргэд очив.

Том том мөнгөн тоногтой, хээ тавьж оёсон хар булигаар гөлөмтэй эмээл морьдын дэргэд хэвтэж байлаа.

Залуу ногоон дээр тавтай завилан суугаад, Хврэл рvv харж, инээмсэглэв. Хэдийгээр энэ залуугийн дуу хөдөлгөөн нь ихэмсэг бөгөөд нилээд настай эр хvний шинжийг зориуд дууриах боловч vнэн хэрэг дээрээ арван зургаа, долоон насны хvн байлаа. Хөх даалимбуу дээл дээр ногоон дурдан бvс сулхан ороож, хуучин хар луучин гутал өмсчээ.

Эдэлсэн эмээл, уясан морь, мухар сөөм хиртэй цагаан соруултай гаанс, бvдvvн бөгөөд урт тэнзэн ташуур бvхнийг нь гайхан ширтсэн Хврэл хvvгийн нvдэнд энэ хvн бол нас бие гvйцсэн дэгжин сайхан залуу эр харагдах ажээ. Өмнө нь зогсож байгаа хvvxэд «Ах та» гэхийг сонссон залуугийн байдал улам ч ихэмсэг бөгөөд намбатай болно.

Хvvg залуу эр ярвайн ширтэж байснаа нvд нь зөөлрөн эрт тэртээ цагт болсон дурсгалт бодлын яруу туяа нvvrэнд нь тодорлоо.

— Эр хvн, эр хvндээ хайртай байдаг юм даа хөө... за дvв минь энд суу. Хоёулаан хvйтэн мах идье гээд залуу эмээлийн дэргэд байсан хар булигаар богцоо авлаа.

Хврэл хvв дуулгавартай хөдөлж заасан газар нь очиж өрөөсөн өвдгөө нугалан цэмцгэр бөгөөд шошгор суув. Энэ залуу бол Итгэлтийн хvв Хонгор байлаа. Хэдэн өдрийн өмнө Богдод мөргөөд буцаж яваа хошуу бэйсийн мөргөлчний хөтөлж явсан ижилхэн хоёр зээрд моринд дурлаж дөрвөн залуу морь өгч билээ. Гэтэл зvvн аймгийн хvнээс өндөр vнээр авсан хоёр мориндоо ханаагvй мөргөлчин өгсөнгvй.

Хоёр зээрдийг ямар ч vнээр хамаагvй авч өгөх тухай Итгэлтээс гуйхад эцэг нь анхандаа загнасан боловч «дурласан морио аваад уначихаж чадахгvй бол баян Итгэлтийн ганц хvв гэж явснаас хоёр мод бариад хот хэсэж явсан нь дээр байх аа» гээд хvvdээ бууж өгөв.

Итгэлт хоёр зээрдэд найман залуу морь өгөхөд эзэн нь «vнэ хэмжээнээс хэтрээд байна. Гэвч хоёр морио ямар ч vнээр ч зарахгvй» гээд хөдөлсөн хөсөгнийхөө хойноос явахад нь «арван залуу морь өгье» гэж эцгийнхээ дэргэд зогсож байсан Хонгор хашгирав. Морины эзэн эмээл дээрээ хагас эргэж инээмсэглэснээ «хvв минь ах нь худалдахгvй» гэж өндийж хатируулжээ. Эцэг хvв хоёр хэсэг зуур дуугvй бөгөөд урамгvй зогсож байлаа. «Тэнэг дамшиг даа. Гайгvй сайндаа л дөрвөн залуу морины vнээр аваа биз дээ» хэмээн Итгэлт мөргөлчинг шоолж билээ. Мөргөлчид явснаас долоо хоногийн дараа Хонгор уяж байгаад тавьсан хурдан хар морио барьж, Солонгоор илvv гэртээ нууцаар мах чануулж аваад морджээ. Анх vзсэнээс хойш өдрийн бодол шөнийн зvvdнээс салахаа больсон хоёр зээрдийн хойноос мөрдөн явсаар Жамьян вангийн нутаг өнгөрvvлж гvйцээд нууц дагаж гурав хонов.

Нэг vдэш мөргөлчид хоол идэх вед хоёр зээрдийг аваад баруун өмнө зvгийг барин шууд зугтахад хойноос нь хэдэн морьтой хvн хөөсөн боловч улам бvр холдсоор бараа тасран алджээ.

Зvг буруулан тэр шөнөдөө яваад маргааш нь бvхэл өдөр бvгж өнжөөд нутгийн зvг жолоо дарав. Хойт Тамирын сав нутагт орж ирснээс хойш хоёр ац сэтгэлд будлин явдал нь удаан болж оволзсон хvсэл эрмэлзэл зориг шийдвэр нь айх эмээх бодлоор солигджээ.

Өчигдөр өглөө vvp цайхын вед энд ирсэн. «Хоёр зээрдийг хараад аав бvх учрыг мэдэх нь дамжиггvй. Хулгай баригдах тэр цагт...» гэж бодоход тавиад дуртай зvгт нь хөөчихмөөр санагдана. Гэвч чухам яагаад ч юм бэ харамнах сэтгэл оргилон «дурлаж байж, арай гэж аваад тавих гэж vv?» гэж ямар нэгэн дуу зогсоо жолоогvй асуугаад байлаа.

Ингэж шунаж авсан хоёр морь нь залгиж ч болохгүй, нулимж ч болохгүй хоолой дээр нь тээглэсэн хатуу бүлх болоод харьж чадахгүй модны чөлөөнд унтаж байхад нь Хүрэл иржээ. Хонгор, Хүрэл хоёр мах идэж хэсэг ярилцав. Хонгор мах идэх зуур хиймэл ихэмсэг байдлаа мартаж эхлэхэд өөртэй нь ярьж байгаа залуу эр өөрөөс нь төдий л ахмад биш юм шиг Хүрэлд санагдаж байлаа. Хонгорын хоолой дээр нь тээглэсэн хатуу бүлх хvvхэдтэй ярьсан эх захгүй түмэн ярианд уусан түр боловч сэтгэл нь амарч байв.

— Та... хэдэн настай вэ? Гэж Хүрэл хvv түгдрэн асуув.

— Ямар олон үгтэй жаал бэ гэж Хонгор ширvvн дуугаар зэмлээд шахмал бүдvvн дуугаар хоолойгоо засав.

Хvvхэд гэмшилтэйгээр мөрөө хавчигнан дуугүй болов. Гэвч цаг өнгөрөөн ядаж байгаа Хонгор удаан дуугүй байж чадсангүй. Тvvгээр ч барахгүй ардаа эхнэр хvvхэдтэй, морины наймаа хийдэг хvн гэж баахан залав.

— Миний дvv хэдэн настай вэ?

— Арван дөрөвтэй.

— Зайлуул их хvvтэй минь чацуу юм байна гээд Хонгор намбатай хөдөлгөөнөөр Хүрэлийн толгойг илэв.

Хонгорын энэ бүхий байдал нь Хүрэлийн сэтгэлд нэг үе оволзож эхэлсэн үерхэх хүслийг нэгмөсөн дарж насаа хоёроор нэмсэн ч тус болоогвйд урам нь хугарсан хvv бууж өгөв.

— Ах аа. Таны морьд яасан сайхан морьд вэ?

Хонгор морьд өөдөө харж санаа алдсанаа толгойгоо алгуур дохих зуур «тийм ээ. Сайхан морьд» гэлээ. Авсан морьд яах вэ гэдэг бодол дахин орж ирээд сэтгэлийг нь хвлэн базалж эхлэхэд энэ хvvхдэд өгвөл яах бол гэсэн хvvхдийн гэнэн бодол хүртэл хэд дахин бодогдов.

— Миний дvv моринд дуртай юу?

— Дуртай. Сайхан морь эрийн чимэг. Сайн морь эзэндээ нөхөр гэж манай аав хэлдэг юмаа.

— Заримдаа сайн морь дараа болдог юм шvv дvv минь гээд урамгүй бөгөөд гvн санаа алдав.

— Манай аавд нэг сайн хар морь байсан, аав маань тvvнээ унаад хол явчихсан. Өвгөн аавд хоёрхон бүдvvн гэдэстэй, шогшихоос өөрийг мэддэггүй хашин морь буй. Унаад жаахан явах дээр элэг өвддөг юм.

— Одоо орой болж байна миний дvv харь. Ахынхаа тухай хэнд ч хэлж болохгүй шvv. Би орой танайд очиж унтаж магад. Ахыгаа танихгүй хvн шиг л байгаараа гэж Хонгор хэлээд тэр хоёр хамт түлээ тvvн ачаад Хүрэл хvv буцав.

Хүрэл хvv мод ачсан тэргэн дээрээ нvцгэн хөлөө унжуулан суугаад Тамирын хөндийд битгий хэл, монгол даяар тарж амжсан «Шивээ хиагт» гэдэг дууг хvvхдийн нарийн жингэнэсэн дуугаар хадаан явахад гэрийн зvг дуртай яваа хайнаг нь жигд бөгөөд түргэн алхана.

Араас Өлзий гуай, нутгийн нэг өвгөнтэй хамт гvйцэж ирлээ. Нилээд согтуу хоёр өвгөний хэл нь дультран яриа нь олон болжээ.

— Миний хvv эр болж тусад орсон, Чи харж байна уу? Түлээ ачаад явж байна.

— Түлээ ачаад явж байна аа?... түлээ ачна гэдэг чинь сайн хэрэг. Хамгийн ухаантай нохой гэсэн ч түлээ ачиж чадахгүй. Тийм ээ өвгөн минь.

— Үнэн үг. Шар тос. Түлээтэй бол нэрж болно.

— Ёстой доо. Чи бид хоёр яг нэг хvн шиг бодож байна. Согтуу хоёр өвгөн баясан солиорч байгааг сонсоод хvv гижигдvvлсэн юм шиг ход, ход инээн шоолно. Явсаар голын эрэгэнд тулж ирээд захыг нь барин уруудав. Тамирын гол жаргаж байгаа нарны гэрэлд жирэлзэн тоглож, ялаа шvvрч байгаа загас энд, тэндгүй пvлхийн үсэрнэ.

— Нэг өглөө бостол Тамирын голын арз болчихсон байвал яана гэж Өлзий хэлэв.

Нөгөө өвгөн нь их л хичээнгвйлэн бодсоноо «Дэмий. Чулуун дээр түрүү урагшаа харж хэвтсээр байтал элэг хатаж орхино» гээд шүлсээ залгив.

— Нээрэн ч тийм байх аа. Гол сахисаар байгаад л хэдэн малаа тураачих хэрэг болно.

— Би бол ногоон тохой орчим буучихаад л гээд тамшаалан, алгаараа нүдээ арчив.

— Богд ламдаа дээжий нь барина. Тийм ээ?

— Зөв. Манай энд залраад ирнэ дээ.

— Богдоор барах уу даа. Халхын ноёд лам нар заларч ирээд манай Тамирын хөндий гэдэг чинь даншиг долоон хошуу наадам өргөж байгаа юм шиг болно.

— Чингэвэл эзнээ алдсан хэрэг болно. Тамирыг минь ховх сорж... үгвй нүгэл... зооглож орхивол яана. Өвгөн минь дээжий нь аваачиж барихаа больё. Тамираасаа салах гэсэн хэрэг.

— Чиний хэлдэг түмэн зөв. Ховх сорохгвй ч гэсэн тас зооглож магад. Бас тэгээд бид мэтийхнийг нь хөөж орхино гээд жирэлзэн урсаж байгаа Тамир руу харснаа

— Өвгөн өө хоёулаа морио усалъя гэж өвгөн хэлэв.

Өлзий дуртай нь аргагвй мориныхоо амыг голын зүг залав. Хоёр өвгөн голын эргэн дээр очиж буугаад түрүү урагшаа харан том том балгаснаа бие биес рүүгээ хулгайн нүдээр харлаа. Хүрэл хүү унан тусан инээж байгааг хараад «инээх юу байсан юм. Настай улсыг шоолж огт болохгвй. Алдас болно. Миний хүү хайнагаа услаач» гэж Өлзий хэлэв.

Тэднийг гэртээ ойртож очиход гадна нь таван сайхан морь уяатай байлаа.

— Манайд айлчин ирж дээ гэж Өлзий хэлээд амаа сул ангайн нүдээ гвйлгэн харснаа,

— Чухам хэдэн морь байна? гэж асуув.

— Лав л дөрвөн морь байна. Танайд юм бий юу?

— Тамирын голын айл байна хө гэмгвй танил хүү очиход ганц цагаан бөгст гаргахгвй бол голомт түшиж угаа манаруулж явсны хэрэг юу байхав дээ. Тийм биз?

— Ёстой доо хө. Өлзийг морио уяад гэрийн зүг найган явтал өмнөөс нь Цэнд бараг гвйх шахан ирээд «аав аа, Засагт ханы Төмөр гуай ирсэн» гэлээ.

Их согтсон хүүнд гэнэт баяр буюу зовлон сонсогдоход архи нь алга болдог гэж ярьдаг нь ортой үг ажээ. Өлзийн санжигнасан толгой төв болж «Тийм үү. Хүү минь» гэснээ ард нь амандаа ямар нэгэн дуу гиншин савлаж ядсан өвгөндөө «За хө Засагт ханы цахиур Төмөр морилж ирээд байна гэнэ. Битгий найгаад л бай л даа» гээд шамласан нударгаа сэгсэрч эргүүлээд хутгаа буулгаж төв бөгөөд түргэн алхалж гэрт орлоо.

Өлзий гэрийн баруун талд суугаа Төмөрийг харж намсхийн ёсолсноо хоёр гараа сунган очиж золгов.

— Тарган тавтай намаржиж байна уу?

— Сайхан намаржиж байна. Та сайн морилж ирэв үү?

Төмөр нүүр дүүрэн инээмсэглэснээ «сайн явж ирлээ» гэж уянгалуулан хариулав. Өтгөн хар гэзгээ авахуулснаас Төмөрийн царай улам өргөн, баргил бүдүүн сүртэй болжээ.

Өлзий Дулмааг гайхан харснаа:

— Энэ бүсгвй юун хүү билээ? гэж асуув.

— Миний гэргий. Дулмаа гэж Төмөр дүүрэн баяртай хариулав.

— Ээ буруудаа. Өлзий гуай нь таньсангвй. За золгож орхиё гээд өвгөн хоёр гараа сунган ойртов.

Дулмаа инээмсэглэн босож золгоход өвгөн нүдээ цавчлан бодолхийлснээ:

— Тэр жил Эрдэнийнд очиход орж ирж байсан хүүхэн мөн шиг байна. Аль би буруу таньж байна уу гэлээ.

Дулмаагийн нүдэнд гунигтай бодлын бүдэг гэрэл тодорч, өнгөрүүлсэн гашуун амьдрал нь

жирэлзэн өнгөрөх мэт болоход гvн санаа алдаад тvvнээ булах гэж мишээх дvр vзvvлэн уруулаа хөдөлгөснөө:

— Тийм ээ гэж нам дуугаар өчив.

Хаврын зөөлхөн боловч яруухан нар ертөнцийг гийгvvлж байхад туулай цасны цайвар бөгөөд цэвдэг vвл бүрхдэгийн адил инээж баярлаж байсан Дулмаагийн нvдийг өнгөрсөн гашуун амьдралын мартагдаж яваа бараан манан бүрхсэн боловч хөгжилтэй ярин сууж байгаа нөхрөө хармагц нvдэнд нь дахин нар мандав.

Төмөр өврөө уудалж боодолтой юм гарган өвдөг дээрээ тавин задалснаа урт хадаг, хорин мөнгөн янчаан, дугуйтай захиа гаргаж:

— Өлзий гуай хvv чинь танд өгсөн юм гээд өвгөнд барилаа.

— Хуяг минь уу?

— Өөр хэн байх вэ?

— Мэнд сайн л яваа юу?

— Гялалзаж яваа гээд Төмөр ярьж гарлаа.

Хvv нь хэдэн зуун цэрэг захирсан жанжин болсноор барахгvй эгэл биш хvн гэж бишрэн залбирч явдаг энэ мундаг эрийн жанжин нь байсан гэдгийг сонсоод Өлзий өвгөний сэтгэл гайхах баярлахын туйлд хvрлээ.

Зуун цэргийг захирсан хvн жирийн биш бурхан байдаг гэдэг vгэнд итгэсэн өвгөн ганц хvv нь хэдэн зуун цэргийн жанжин болсон болохоор эгэл хvн биш бололтой мэт санагдана. Алтны дэргэд байсан гууль шарладаг гэгчээр бурхны дэргэд байсан хvн төрөл арилждаг юм болов уу гэж бодоод хvvгийнхээ гаднах байдлыг хvртэл асууж эхлэв.

— Хvvгээ бат хаалгын байлдаанд явж ирээд баатар болоогvйдээ гомдон ярихад нь чи, бид хоёр шиг эгэл хvн болдог хэрэг биш гэж байсан юмсан. Над шиг усан нvдтэй, цусан зvрхтэй амьтан нэхий дээлийн цаана юу нуугдаж байгааг яахин мэдэх билээ дээ гэж Өлзий хэлэв.

Цэндийн хувьд бялхсан савтай сvv айргийн аль нэгийг барьсан хvн хөдөлж чаддаггvйн адил дvvрэн баяртай багтраад инээж ч чадахгvй, уйлж ч чадахгvй, ярьж ч чадахгvй байлаа.

— Хуяг удахгvй нэг чөлөө аваад та нараа эргэж ирэх байх гэж Төмөрийн хэлэхэд Дулмаа

— Эргэж ирэхээр барахгvй аваачих байх. Өөрөө л тэгж ярьж байна билээ гэв.

— Би ч Тамирын хөндийгөөс салахгvй гээд Өлзий тааламжтай мишээснээ, Төмөр гуай хаа хvрэх гэж яваа билээ? Гэж асуув.

— Хоёр хоног морь бие амраагаад явна даа гээд Төмөр өссөн төрсөн Тайширтай очиж хэдэн малтай болон ариун цагаан хөдөлмөрөөр амьдрах тухай бодлоо ярилаа.

— Тийм бол хаа ч монгол нутаг. Манай Тамир сайхан газар. Бас тэгээд гэргийн чинь нутаг байна. Та энд айл болбол хэн, хэндээ тvшиг гэж Өлзий эхлээд Төмөрийг Тамирын голд айл болон амьдрах тухай гуйж гарлаа.

Өлзийн гуйлтыг Цэнд хvvхэн ч бүрэн дэмжиж:

— Дулмаа гуай ч хөл хvндтэй болсон бололтой тэр хол газар ядарчихна гэлээ.

Төмөрийн нvдэнд тvmэн баярын тvймэр дvрэлзэн Дулмаа руу хэсэг харснаа:

— Үнэн vv? гэж огцом асуужээ.

Дулмаагийн царайд улаан туяа цацарч нvдэнд нь vl мэдэг мишээл тодорсноо «vнэн» гээд доод уруулаа хазлан толгой дохив. Олоод хоёр сар гаруй болсон хvvхдээ Төмөрийн нутагт очих хvслийг эвдэхгvй гэж тас нуужээ.

— Над юунд хэлээгvй юм бэ?

— Нутагтаа явахад чинь саад болохгvй гэж бодсон.

Тайшир хаан, тарлан хайрханаа харж, тvvний нөмөрт хайрт тvvнтэйгээ ариун сайхнаар

амьдрах хвсэл Төмөрт үлэмж их байсан. Гэвч Дулмаагийн хэвлийд хvvхэдтэй гэдгийг сонссоноос хойш мориор олон арван өртөө явах нь битгий хэл түргэн алхуулахгvй гэж бодлоо. Хэрэв Дулмаа хүрээнд байхдаа үнэнээ хэлсэн бол Төмөрийг тэндээс хөөсөн ч явахгvй байсан.

— Тамирын голд айл болно. Чи юу гэж бодож байна. Сайхан нутаг шvv гэж Төмөр хэсэг дуугvй суусны дараа хөгжилтэй дуугаар хэлээд Дулмаа руу харлаа.

— Би дуртай байна гэж Дулмаа баяртай өчив. Дулмаа энд айл больё гэхдээ Тамирын хөндийг төрсөн нутаг гэж дотночилсноос хэлсэн хэрэг биш. Харин нэгдvгээрт хань татсан, хоёрдугаарт «буруу эс сонсвол vгvй гэдэггvй хvvхэн» гэж гоочлуулж байсан энэ нутагт Дулмаа чухам хэн бэ? Гэдгээ харуульа гэж бодсоноос хэлжээ.

Өлзийнх хонь гаргаж, хавь ойрын айлаас архи айраг авчран найр хийж хөлгvй баяр хөөр болжээ. Олон хvн цугларч дуу барин хөгжилдөхөд сэтгэл нь хөдөлсөн Өлзий ч «хошууны олон тамир» аа тасалдсан эв хавгvй баргил хоолойгоор дуулжээ. Хvмvvc гуйж Өлзий дугараа барьж баймаажин Төмөрийг «Эрдэнэ засгийн унага»-г дуулуулав. Чанга биш боловч сэтгэлийн гvнээс нургин гарсан баргил хоолойгоор «Эрдэнэ засгийн унага» гэж дуулж байхад өргөн дэлгэр Сvхийн гол хөхрөн манантаж Тайшир хаан нь нvднээ харагдаж сэтгэл хөдлөн хэдэн түрлэг дуулав.

Хуягийнхаа тухай тvмэн зvйлийг зогсолтгvй шивэгнэж асууж, хайрт нөхөр нь аз хийморьтой яваад хязгааргvй баярлан байгаа Цэндтэй ярих зуураа Дулмаа нөхрийнхөө дууг сонсон баярлаж байлаа.

Өлзийн гэрт иймэрхvv найр болж байхад хоёр морь хөтөлсөн Хонгор ойртож ирээд олон морьд байхыг хараад зайлан явжээ.

Маргааш орой нь Хонгор хоёр морио аваачиж адуундаа нийлvүлсэн бөгөөд Итгэлт өглөө нь хараад зальтай бөгөөд тавтай инээмсэглэснээ «хvvгийн худалдаж авсан тэр хоёр морины урьдахийг нь бариад надад эмээллэчихээрэй» гэж Галсанд хэлжээ.

### XIII

1923 оны хаврын нэг өдөр тэнгэр цэлмэг боловч хааяа хааяа бөөн цагаан vүл Чингэлтэй уулын дээгvүр гарч өмнө зvгийг барин хүрээний аль нэгэн хэсгийг бараантуулан нvүнэ. Хавар дөнгөж эхэлж буй болохоор цаг бас л цэвдэг хvйтэн бөгөөд Хан уулын орой гvн цасан хуягаа тайлах шинж vгvй ажээ.

Хүрээ хэдэн тvмэн яндангаар гарсан утаандаа мансууран хахаж, агаар амьсгалахад гашуун бөгөөд заримдаа бvр хиншvv хамар руу цоргино.

Ийм нэгэн өдөр хүрээ өртөөний том хүрэн хаалгаар шинэхэн хөх чисчvv дээл дээр цайвар ногоон бvс ороож модон хуйтай сэлээдий буу баруун ташаа руугаа унжуулсан Эрдэнэ бор хээр морьтой гарч ирэхэд том булигаар богц ачсан хөтөлгөө морьтой залуухан улаач хойноос нь дагалдан хөдлөв.

— Хавар цаг, бас тэгээд хотын өртөөний морь. Ширvүн давхилгvй галигуухан явж Шар хөвтэй золгодог хэргээ гэж Эрдэнийн хэлэхэд улаач нь «юу ч л гэсэн хий хуйд хөөгдсөн юм шиг довтолдог элч биш бололтой» гэж бодоод баясавч «элгээ тэврээд газар ахиж өгдөггvй мөөгний хятад золиг биш байгаа даа. Тэгвэл ч гэгээтэй буцаж ирж чадахгvй золиг болно» гэж тvвэгшээж байлаа.

Өнгөрсөн өвөл цагаан сарын дараа нэг орой Бат, Жаргал хоёр нарийн хоол хийж Эрдэнэ, Хуяг хоёр нэг шил архи хуваан ууж тавтай ярилцаж байтал цэргийн яамны зарлага ирж «Таныг маргааш өглөө яг есөн цагт ир» гэж бvх цэргийн жанжин Сvхбаатар тушаалаа хэмээн Эрдэнэд дамжуулав.

Тэр намар Хуяг Сүхбаатарыг дагаж зөвлөлт улсын нийслэл Москва орж монгол зөвлөлт улсын хооронд гэрээ байгуулах ажилд оролцож ирсэн билээ. Энэ учраас түүний ярианы ихэнх нь их багш Ленинийг харсан тухай Москвад үзсэн зүйл, замын хөг байдаг юм.

Сүхбаатарыг Москвад очоод хэд хоносны дараа зочин буудалд нь гадаадын хөрөнгөтөн улсын сонин сурвалжлагч ирж уулзахад Хуяг дэргэд нь байсан. Тэр сурвалжлагч их л намбатайгаар нэр усаа хэлж танилцаад

— Ноён Сүхбаатар танд Москвагийн агаар цохиж байна уу? Гэж асуув.

— Яг л манай нутгийн агаар шиг байна гээд Сүхбаатар нүдээрээ хөгжилтэй инээмсэглэв.

Сурвалжлагч монголын хувьсгалын тухай, монголд тогтсон засгийн тухай элдвийг асууж байснаа:

— Ноён Сүхбаатар та монгол улс гэж ярих юм. Гэтэл гадаад монголыг улс гэж дэлхий дахины гүрэн Англи, Америк, Франц зөвшөөрөөгүй шүү дээ гээд л ёжтой харлаа.

— Зэвсэг барьж боссон монголын ард түмэн өөрсдөө зөвшөөрсөн. Бодвол Англи, Францын засгийн газар хэзээ нэгэн цагт хийсэн алдаагаа ойлгож зөвшөөрөх байх гэж итгэж байна гэхэд Хуяг тэсэж чадсангүй. «Ёстой доо жанжин минь» гэж дуу алдав.

Хуягийг ингэж дуу алдахад нь Сүхбаатар харж тайван инээмсэглэсэн бөгөөд сурвалжлагчийг гарсны дараа «Чи минь уулгамч чавганц шиг яасан хамаагүй хашгирах юм бэ?» гэж зэмлэсэн юм.

— Та бичиг үсэг мэдэхгүй, бас олигтой хутга ч хийж чадахгүй малчдыг яаж тийм том зорилгонд босгож чадсан юм бэ? гэж сурвалжлагч асуув.

— Би босгоогүй. Тоногдож, дарлагдаж тэсэхээ больсон ард түмэн өөрсдөө боссон. Би бол түүний нэг нь.

— Та байгуулсан улс гэгчээ тогтож чадна гэж итгэж байна уу? —

— Нэгдүгээрт та буруу ярьж байна. Улс гэгч биш, улс юм шүү. Хоёрдугаарт тогтож чадахад ямар ч эргэлзээгүй итгэдэг.

— Та ямар шидтэй хүн байснаас тэгж итгэдэг юм бол?

— Дарлагдлын гинжинд яснаасаа жигшсэн ард түмэн байна. Бас ойрын өдөр нэг баримт бичиг дэлхий дахины сонорт хүрнэ.

— Зөвлөлт Монголын гэрээ юу?

— Та яг тааж байна.

— Танайх жижиг, орос бол их улс шүү дээ гэж сурвалжлагчийн хэлэхэд дуунд нь «Удахгүй та нарыг оросууд залгиж орхино доо» гэсэн ёгт өнгө байлаа.

— Та их багын тухай тун балархай ойлголттой хүн юм даа. Одоо чинь шинэ үе, шинэ түүх эхэлсэн болохоор зарим нэгэн балархай ойлголтоо тод болговол зүгээр сэн дээ.

— Харж л байж больё.

— Тэр л ёстой үнэн үг.

Ингэж яриад сурвалжлагч явсны дараа Сүхбаатар хэсэг дуугүй байснаа:

— Харуулж чадах уу? гэж Хуягаас асуув.

— Чадна жанжин минь гэж Хуяг хэлээд цэргийн хүний ёсоор давхийтэл ёслов.

Хуяг энэ бүхнийг Эрдэнэд олон дахин ярьсан билээ. Гэвч Эрдэнэ дахин дахин сонсох дуртай.

Учир нь монголчууд хэн бэ гэдгийг дэлхий дахинд харуулах хүсэл бол бүхний хүсэл.

Эрдэнийн хүсэл байж билээ.

Эрдэнэ, Хуяг хоёр шөнө орой болтол ярилцаж байгаад унтжээ. Маргааш нь яг есөн цагт

Эрдэнэ Сүхбаатарын тасалгааны үүдэнд очтол дотор нь жанжны дуу хадаж байлаа.

— Луйварчинтай нийлж цэргийн хоолонд үхсэн үхрийн мах бэлтгэнэ гэнэ ээ. Маргааш авсан

махаа өгөөд цэрэгт сайн мах нийлвүл өгөхгүй бол нөгөөдөр өглөө шар хаданд очно гэж мэдээрэй! Гар! гэж сүртэй хашгирав.

Үүдээр нүүрний нь хөлс асгарсан Жамбал гарч ирээд шинелийн ханцуйгаар магнайгаа арчсанаа ухасхийн алга болов. Эрдэнэ тасалгаанд ороход царай нь ер бусын хүрэн хар болон барайж, бараан болсон Сүхбаатар хоёр гартаа урагдсан цаасны тасархай чанга базан зогсож байлаа.

Эрдэнэ өмнө нь ёслон зогсов. Жанжин гар дахь цаасаа харснаа: «Гэрээ гэнэ. Улсын хөрөнгийг тэгж идэх үү? Бодол чинь богино байна» гээд шидэж орхиод нүдээ тас анин далаа хавчиж шилгээснээ гараа сунгав. Эрдэнэ тэр гарыг баривал халуун цайтай данханд хүрсэн мэт ажээ. «Би гаднаас орж ирсэн болохоор жанжны гар ийм халуун байгаа юм болов уу» гэж бодов.

— За суу гээд Сүхбаатар цаасан тамхи гаргаж зуугаад чүдэнз зуран асааж сорсноо.

— Ямар хачин амттай юм бэ? нэг л эвгүй юмны үнэр шингэсэн бололтой. Зүгээр л байдаг сан. Норчихсон юм болов уу? Чамд тамхи байна уу? гэлээ.

— Гаанс тамхи л байна.

— Савтай тамхиа өгөөч гээд эргэж ширээн дээрээсээ том дөрвөлжин цаас авч хэсгийг таслан, Эрдэнийн савтай тамхинаас чимхэн сурамгай цувуулан, хэлнийхээ үзүүрээр шүлдэн ороох зуур, — Автономитын цэрэгт байхдаа орос сургагч нараас сурсан юм гээд зууж асаан нэг сорсноо «үгвй энэ чинь юу болж орхив оо. Тамхинаас гарах нь юм болов уу, бас л эвгүй амттай байна. Аль юм хольсон юм уу?» гээд тамшаалав.

Эрдэнэ жанжны гар халуун байсны учрыг мэдэж

— Та лав халуурч байгаа байх гэвэл.

— Яаж байна?

— Тамхи эвгүй амтагддаг юм.

— Үгвй байлгвй дээ. Би халуурах нь битгий хэл, хамрын ханиад хүрдэггвй юмсан гээд тамхиа үнсний саванд нухаж унтрааснаа,

— Чамайг ийш тийш нь хөдөлгөхгвй сэн гэж бодсон. Гэтэл бидэнд бичиг үсэгтэй хүн ховор байна. Чухал ажилд томилохоос өөр аргагвй дээ.

— Өчүүхэн биеийг ардын намын вйл хэрэгт зориулна гэж тангараг өргөсөн хойно, та бүхний хэлснийг хийхэд бэлэн байна.

— Чамайг баруун хэдэн хошуудад ардын засгийн төлөөлөгчөөр явуулах бодолтой байна.

— Ямар хошуудад?

— Заяын шавь, Луу гүн, Сайд ван

— Жанжин минь

— Бид бодсон. Ярисан. Тэнд очиход чинь сэтгэлд чинь хэцүү. Гэвч зугтах хэрэггвй. Хүн хартай ярьж учир явдлыг нь мэдвэл сэтгэл чинь хөнгөрөх байх. Эцэг минь нас барсан тухай дахин сонсоход над тун хүнд байдаг. Гэвч сонссоны дараа хөнгөрөх шиг болдог. За бас тэгээд чи бол тэр нутагт байсан шүү дээ.

— За явъя гээд Эрдэнэ толгойгоо дохилоо.

Сүхбаатар тасалгаан дундуур холхин хэсэг явснаа Эрдэнийн дэргэд ирж:

— Шинэ засгийг байгуулна гэдэг бол дайтахаас хавьгвй хэцүү юм байна. Дайтахад дайсан ил байдаг. Харин шинэ улс төрийг байгуулахад нэг үлэмж хүчтэй дайсан бидний өвөрт минь байна. Тэр бол мэдэхгвй, бүдүүлэг гэдэг бол айхтар зүйл. Чамд засаг бүрэн эрх өгнө. Үүнийг буруу ашиглаж огт болохгвй.

— Мэдлээ жанжин минь



— Заавраа Төв Хорооноос аваарай. Үнэмлэхээ засгийн газраас шийтгүүлж ав.

— За гээд Эрдэнэ дахин толгой дохилоо. «Ялсан засгийн бүрэн эрхт төлөөлөгчөөр Тамирын хөндийд очиход учрах хvн, бодох данс буй» гэдэг бодол сэтгэлд нь орж ирэхэд инээмсэглэв.

— Тэнд шинэ засгийн төлөөлөгчөөр очно гэдэг чинь нэг ёсондоо тэр хошууны ноён болж байгаа хэрэг шvв дээ гээд Сvхбаатар инээмсэглэснээ царай төв болон хөмсөг нь vл мэдэг зангирч, — их эрх хvнийг эвддэг удаа байдаг шvв. Энэ учраас юм бvхэнд төрийн уужим хараа, өргөн сэтгэлээс ухаантай хандаж байвал зохино гэхэд Эрдэнэ цочих шиг болов.

— Засаг ноёд, худагт хувилгаад, баячуудыг яах вэ? Сvхбаатар, Эрдэнийг ширтэн нvд нь удаанаар цавчлан байхад нvврэнд нь гvн бодол тодорно.

— Мэдэхгvй. Одоодоо бидэнд тvр гэсэн хань хэрэгтэй. Бид Богдод хайртайдаа тvвний хэмжээт эрхт хаан болгосон биш. Тvвний нэрийг ашиглах, монголын биед хэдэн зуун жилийн турш шигдэж ухаан бодолд шингэсэн шарын шашныг ашиглах гэсэн хэрэг. Гэхдээ зорилгоо гvйцэлдvүлэхийн тулд шvв. Харин ханьтай болох гэж зорьсон хэргээсээ ухрахгvй. Очоод харахад чинь ил болно биз дээ. Бидний дайсан ухаантай ч, зальтай ч бид тэднээс ухаантай, тэднээс зальтай байж ялна гээд духаа атган барьснаа, —энд нэг юм хатгаад байх чинь толгой өвдөж байгаа хэрэг vв? гэлээ.

Сvхбаатарын өргөн духыг Эрдэнэ барьж vзсэнээ:

— Та халуурч байна. Харьж хэвтвэл дээр байх аа. Ер нь царай чинь сvрхий барайж шvв гэлээ.

— Бие нэг л эвгvй. Ингээд засгийн газрын хуралтай. Дараа нь харьж хэвтдэг хэрэг ээ. Уул нь ч өдөр өнгөрөх тусам л засаг төр минь баттаж байна санж дээ. Дөч, тавин жил болсон хойно манай орныг харвал чи...харвал ч гэж дээ. Бид өөрсдөө харна. Үг олдож vхэр холдож байна. Би ч хуралдаа явъя.

Эрдэнэ тэндээс гарч хүрээний цастай гудамжаар явж байхад сэтгэл нь баяртай ч юм шиг, гунигтай ч юм шиг байлаа. Баяртай юм шигийн учир бол ардын засаг өөрт нь итгэж, өндөр vүрэг өгсөн хэрэг байлаа. Гомдолтой юм шигийн учир бол алд биед энэ их итгэлийг бvтээх эрдэм, ухаангvй мэт ажээ.

Өмнөөс нь vл мэдэг салхилан, өчигдөрхөн агтнаас авсан морь нь толгойгоо хаялан гvйн хар алхална. Эрдэнийн толгойд Сvхбаатарын хэлсэн vг эргэлдэн, тэр бvхнийг бодох тусам өмнөх замын vлэмж бартаа тодорно. Харин тэр бартааг хэрхэн давж гарах нь одоохондоо тодорхойгvй байлаа.

Эрдэнэ vнэмлэх заавраа аваад алсын замд мордох гэж байтал монголын ард тvмнийг гvн гашуудал бvрхэж авлаа. Тэр бол монгол орныг хvлэн доромжилж байсан боолын гинжийг тас цохиж, эрх чөлөөний саруул бамбарыг асаах их тэмцэлийг толгойлсон аймшиггvй чин зоригт Сvхбаатар нас барснаас болжээ.

Эрдэнэ, Хуяг хоёр жанжин Сvхбаатарыг оршуулах ёслолд оролцож ариун шударга монгол хvн бvхний зvрхийг шимшрvүлсэн энэ гvн эмгэнэлийг нийт олонтойгоо хамт эдэлжээ.

Үvнээс ч болж Эрдэнийн явах хойшилжээ.

«Хэн бvх цэргийн жанжин болох вэ?» гэдэг асуудал олны сонирхолыг татаж байлаа. Учир нь энэ асуудал монгол орны цаашдын хөгжилд аль нэг хэмжээгээр нөлөөлөх зvйл байлаа.

Нэгдvгээрт улс төр дөнгөж бvрэлдэж байгаа ve. Хоёрдугаарт ширvүн тэмцэл болж байхад цэргийг ямар хvсэл, мөрөөдөлтэй хvн удирдах нь vлэмж учиртай асуудал юм.

— Магсаржав жанжныг томилох хэрэгтэй. Энэ хvн хэзээ ч монгол улсаасаа урвахгvй гэж Хуяг хэлнэ.

—Данзан л болж магад. Одоодоо тун их дэмжлэгтэй байна гэж Эрдэнэ таавраа ярина.

—Данзан хятадын худалдаачинтай нягт холбоотой. Зарим пvvстэй хувь нийлvvлсэн ч байх. Хэрэв жанжин болвол балаг тарьж чадах л амьтан.

—Одоо ч монголчууд хятадын гарт дахин орохыг хvсэхгvйгээ даанч сайн мэднэ.

—Зальтай шvv дээ. Бас хvчээр эзлэх гэж оролдож ч магадгvй юм шvv.

—Одоо ч зөвлөлт улс биднийг орхихгvй.

—Тэр ч тийм. Гэвч дотоодын ямар нэгэн хvч хятадыг дэмжвэл хэцvv болно шvv дээ.

—Хуяг минь, хятадыг дэмжиж байгаа хvч одоо ч байгаа шvv дээ. Ганц хvv ард тvмнээс айгаад ил гарч чадахгvй байна.

Энэ хоёр зай л гарвал төрийн бодлого тvмний хувь заяаны тухай ярьж байлаа. Ингэж ярьж байхад Бат идэвхитэй оролцоно. Богд, шарын шашныг устгаж, тvvнээс салаагvй цагт монгол орон хөгжихгvй гэдэг бол Батын хатуу vзэл байлаа.

Чингэхдээ хvч хэрэглэн шууд устгах санаа дэвшvvлнэ. Хааяа энд ирдэг Дорж бол Батын vзлийг бvрэн дэмждэгээр барахгvй, хятадууд байсан цагт монгол тайван унтаж болохгvй гэж ярина.

Амьдралын хувьд бол Хуяг зун буюу хавар нутагтаа очиж эцэг, эхнэр, хvvхдээ хотод авчирч амьдрах тухай боджээ. Бат ирэх жил сургуулиа төгсгөж багш болон тааралдсан бvхнийг бичиг vсэгтэй хvн болгох ирмvvн хvслээр дvврэн байлаа.

Ингээд Эрдэнэ баруун зvгийг чиглэн явж билээ. Ардын засгийн бvрэн эрхт төлөөлөгч гэсэн улаан шугамтай vлэмж хvч, эрх бvхий бичиг өвөртлөн ташаа тулан явж байх нь сэтгэл нь баяртай, хөгжvvн байсан нь дамжиггvй билээ.

Амбан хааны хороо гэж нэртэй бөгөөд хvрээний баруун талд тасархай байгуулагдсан хэсэг хашааны хойгуур гарахад далан давхрын нугачаа харагдаж, ариун сэтгэлт Гэрэл хvvхний тунгалаг дvр нvдэнд нь тодрох шиг болов.

Эрдэнэ мориноос буун Гэрэлийг оршуулсан жалга руу ширтэн зогсоход нvднээс нь хэдэн дусал нулимс өөрийн эрхгvй урсав.

«Гэрэл минь, чамайг хэзээ ч мартагvй намайг бvv зэмлээрэй» гэж сэтгэлийн гvндээ хэлэхэд «би таны төлөө хийе, та хэний төлөө хийхээ өөрөө мэд» гэсэн Гэрэлийн vг сонсогдох шиг болж билээ. Гаднаа vргэлж инээд баясгалантай байдаг боловч сэтгэлийн гvнд нь vргэлж гуниг vргэлж байдаг Гэрэлийн торомгор хар нvд сэтгэлийг эзэлнэ.

—Мориноос буугаагvй зогсож байсан залуу улаач Эрдэнийн нулимсыг хараад учрыг vл олон гайхан зогсоно.

#### XIV

Хаврын нэг өдөр Тамирын хөндийг дагаж уруудан өндөр сэрвээтэй тарган сайвар хээр морьтой, хуучин хөх шандан дээлтэй хvн сэмбэлзvvлэн явна. Энэ бол Итгэлт ажээ.

Хаврын нар зөөлөн боловч тааламжтай жигнэн цасанд хайлж эхэлсэн хөндий энд тэндээ хурган vл хуралдсан тэнгэрийг дуурайсан мэт тарлантан өнтэй орсон мал сvрэг сvргээр билчинэ.

Хөл хөнгөнтэй сайхан морины явдлын аясаар Итгэлтийн бодол эргэлдэн сэтгэл нь аятай бөгөөд уужим байв.

Итгэлт шийдвэртээ эргэлзсэнгvй гэвч бодох юм тодотгох зvйл бишгvй ажээ. Луу гvний хошуунд ардын засгийн бvрэн эрхт төлөөлөгч өнгөрөх шөнө иржээ гэдгийг өглөө сонсоод очиж уулзахаар барахгvй хоёр зуун таягт янчаан, эмээлийн хойт бvврэгтэй нь хавиралдахад Итгэлт баадангийн vзvvрийг тайлж бэлхvvслэн зангидав.

«Хоёр зуун мөнгөн янчаан бага зvйл биш. Мөнгө хэрэггvй газар байхгvй. Ялангуяа шинэ тогтож байгаа засагт мөнгө хэрэгтэй. Энэ учраас миний хоёр зуун мөнгөн янчаан над их юм

хийж өгнө» гэж дотроо бодно.

Ардын засгийн хийж байгаа бүхнийг Итгэлт нүд цавчилгуй ширтэн, чих тавин сонсож байлаа. Шинэ тогтсон засгийн хийж байгаа бүхэн Итгэлтэд хор болохгүй харин сэтгэлд нь яв цав тохирно.

Хамжлага, угсаа залгамжлах ёсыг устгасан ардын засгийн шийдвэр бол Итгэлтийн олон дахин бодож, хүсэж байсан зүйл байлаа. Өртөө улаа, албан татварыг ард, тайж, ноёд гэж ялгалгүй залгуулах болсон нь Итгэлтэд хэмжээлшгүй баярлах сэтгэл төрүүлжээ.

Ноёд, тайж, хувилгаадын морьд бэлчээр шил нь таргалж байхад Итгэлтийн морьд суман өртөөнд сунаж байдаг цаг ардын засгийн ачаар дуусах болжээ. Итгэлт жил бүхэн өдий төдий хонь мал, мөнгө албан татварт өгч байхад ноёд тайж нарын хөрөнгө хөдлөлгуй ялзарч байдаг ёс дэглэм алга болох болжээ. Ноён Сүрэнгийн хангал морьд өртөөнд гүйх, ноёд тайж нарт албан татварт өгөх мөнгө олох гээд хөлсөө гарган зүтгэж явахыг харна гэж бодоход Итгэлтийн хөх инээд нь хүрч, гижиг нь хүрэх шиг болно.

«Бидний ардыг улсын алба залгуулахаас бүрэн чөлөөлж энэ дамшигуудаар хийлгэх байсан юм, чадахгүй тасалдуулаад баллачих байх даа. Өртөө албанд шахагдаад өвөгнийхөө өмнө сөгдөх цагт хэлэх үг над бий» гэж бодоход хошуу туслагч гэрт нь ирээд хошуугаа цорвойлгон мөнгө зээлүүлэхийг гуйж царайчлан байгаа сайхан дүрс нүдэнд нь харагдах шиг болж инээмсэглэн хөмсгөө зангидав.

Ингэж бодох тусам ардын засагт баярлан талархах сэтгэл оргилон ард угсаандаа баярлана. Заримдаа «Должин золигийн тайж угсаа хөг тарихгүй байгаа даа» гэж бодогдон сэтгэл зововч тэр ёозгүй бодлыг «ямар өрхийн тэргүүлэгч биш. Бас тэгээд хүнд очсоноор балран алга болдог охин тайж» гэдэг бодлоор зайлуулна.

Шинэ засгийн төлөөлөгчтэй яаж уулзаад, юу гэж хэлэх тухайгаа өглөөнөөс хойш бодоод шууд орон хадаг мөнгөө барин «Би бол язгуураас ард суман эр. Алд биеийн хүчээр ноёд тайж нартай уулзан байж өчүүхэн хөрөнгө малтай болсон боловч өртөө улаа, алба татварт хавчигдан хэлмэгдэж явлаа. Гэтэл бидний аз завшаанаар ардын засаг үүсэж дэлгэр сайхан цаг ирлээ. Язгуур угсаагүй бидний түшиг, гэгээн нар минь болсон засаг төрдөө өчүүхэн нэмэр болтугай гэж аюуш хадаг, хоёр зуун мөнгөн янчаан барья. Тогтоон соёрхоно уу» гээд талтай сайхан болвол «Би мунхаглан бодвол манай засгийн өргөө урьдын засгийнхаас доор байж болохгүй бизээ. Ингэхлээр найман ханатай улаан халзтай гэр нэгийг хувийн хөрөнгөөр барьж өргөө» гэнэ гэж шийджээ. Тэр үед Итгэлт ардын засгийн дотнын хүн болж хүсэл нь биелэнэ гэдэгт огт эргэлзсэнгүй. Бодож, хүссэн юм нь биелэгдээгүй өнгөрч байсныг Итгэлт санахгүй байлаа. Ийм ч учраас Итгэлт бүх юмыг гэрэл, гэгээтэй, цагаан замтай бодож, мөрөөдөж байлаа.

Унасан морь нь сэмбэн сэмбэн сайварлаж толгойд нь сайхан бодол эргэлдэн явахад Тамирын хөндий юутай дэлгэр, юутай сайхан ажээ.

Өмнөөс нь улаа бор морьтой бадарч хуухилан ирлээ. Түүний царай, зүс, эмээл дээрээ суусан байдал цөм сандарсан бухимдсаныг илчилнэ.

—Тарган сайхан хаваржиж байна уу?

—Яахав дээ гэж Бадарч хусмаа чамласан хүүхэд шиг урамгүй огцом дуугаар хэлэв.

«Ноёны эрх тахар гэгдэж, амьтны юм луйвардаж явсан цаг чинь дуусаж байна уу. Далавч чинь хугараад усанд унасан элээ шиг болоо шив дээ» гэж Бадарчийн сэтгэлийн хорсол, бухимдлыг нэвт мэдсэн Итгэлт тавлан бодовч, өнгөн дээрээ гэнэн цагаан дүр гарган:

—За Бадарч тахар шартаж орхио юу гэж хөгжилтэй асуув.

—Итгэлт минь өнгөрөөд байна. Ардын засгийн төлөөлөгч хошуу тамган дээр ирээд ноёны

тамгыг хурааж авсан. Удахгвй олны саналаар хошуу дарга сонгох юм гэнэ. Тэр ч гайгвй. Хошуу гянданд байсан хvmvvcийг суллаж гаргаад бид мэтийн хvmvvcийг «Хуучин засаг устаж шинэ засаг тогтсон учир гэр гэртээ харьцгаа» гээд албанаас зайлуулж байна. Ингээд л хошуу эзэнгвй болдог байна шvv. Ямар вэ дээ? гэж Бадарч нvд амаа татвалзуулан хорсолтой боловч мухардсан гомдолтой дуугаар хэлэв.

«Чам шиг тэнэг муна, тэнэг засагт хэрэгтэй болохоос биш, ардын засагт бол эсгий хийхэд нохой хэрэгтэй гэдэгтэй адил байх даа» гэж Итгэлт дотроо бодсон боловч  
— Тийм юм болж байна уу? Гэж өөрт нь огт падгвй юм сонссон хvний задгай дуугаар асуув.  
— Итгэлт минь тэгээд тэр төлөөлөгч нь хэн гэж бодно. Санахаас бөөлжис хvрээд байна. Нөгөө танайд зарагдаж байсан гуйлгачин Эрдэнэ шvv гэж Бадарч «төлөөлөгч» «гуйлгачин» гэдэг vгийг шvд зуун хэлэв.

— Эрдэнэ ээ! гээд Итгэлт жолоогоо угзран гэдрэг болов. Итгэлтийн бие сулран, санаж явсан өргөн бодол нь атга элс цацсан юм шиг сарнин алга болж хоёр талын уул хавчин авах шиг боллоо. « Эрдэнэ надтай данс бодно», «Одоо яах вэ» гэдэг хоёр бодол жирэлзэн солигдож зогсолтгвй хариу шаардав.

— Тийм ээ. Тэр муу цагаачин ноёны тамгыг хурааж авсан шvv гэхэд нь Бадарчийн нvд нvвр нь татганан чичирч байлаа. Харцганд баригдах гээд бутны ёроолд бүлтэгнэж байгаа болжмор шиг болсон биеийнхээ байдлыг мэдмэгц Итгэлт бие сэтгэлээ барьж өвөр түрийгээ ухан гаанс тамхиа гаргаж аваад:

— Эрдэнэ ч чи бид хоёрын дэргэд эрдэм номтой хvн байхгвй юу гэлээ.

— Тэр гуйлгачны эрдэм ч нохой долоож vx дээ гэж Бадарч хэлээд мориноосоо буув. Итгэлт ч мориноос буув. Эрдэнээс зугтаад хаачих вэ. Хөрөнгө хогшлоо хаяхгвй. Байдлыг ажих хэрэгтэй. Хэрэв данс бодоход хvрвэл эр хvнд зай ч буй, лай ч буй. Юу ч гэсэн тvvнтэй одоо очиж уулзья чингэхдээ бvр дотно уулзья гэдэг бодол Итгэлтийн дотор орж ирлээ.

— Уул vзээгвй хvн хормой шууж, ус vзээгвй хvн гутал тайлж болохгвй. Эрдэнэ их зантай, эрдэс номтой хvн шvv. Учир нь олдох байх. Тамирын хvvxэд ч шөрмөстэй улс даа гээд Итгэлт зальтай нvдээр Бадарчийг ширтэв.

— Энэ төр ч вймж гарлаа бололтой. Туслагч гуайн лагшин хиртээд өргөөндөө морилж байгаа. Очиж ярья. Хамт явах уу?

— Би хашаагаар орох чухал ажилтай. Дараа танайхаар очно гэж Итгэлт хэлээд тэр хоёр салжээ. Нэгдvгээр нь Эрдэнэтэй түргэн уулзаж бvх бодсоноо хэлэх, хоёрдугаарт нь тэр хэрэв шазуур зууж данс бодох гэвэл Бадарч мэт тэнэг мунуудыг ашиглан хариу данс бодох ийм хоёр бодол төрөөд тэр нь цаг өнгөрөх тусам гарцаагвй зөв зvйл болон бэхжив.

Ардын засгийн төлөөлөгч Эрдэнэ урьд шөнө Луу гvний хошуунд ирээд өглөөнөөс эхлэн нилээд ажил хийжээ. Хошууны ноёд гvшмэдийг цуглуулан ардын засгийн бодлогыг ярьж өгөөд хошуу ноёны тамгыг хураан, удахгвй хошуу нийтийн сонгууль явуулж засаг байгуулах тухай ярихад цуглагсад нь их л хvйтэн хvлээж авсан. Дараа нь гянданд байсан бvх хvmvvcийг суллан гаргаж Бадарч мэтийн хэд хэдэн хvнийг гэр гэрт нь тараажээ.

Өртөөчин нарыг цуглуулж хошуу нийтийн хурал хийж сонгууль явуулах өдрийг тогтоосон зарыг олонд хvргэхээр зvг бvрт мордуулав.

Харин Долгорын тухай хэд хэдэн хvнээс асуух гэснээ сонсох хатуу хариунаас халшраад зvрхэлсэнгвй. Урьд шөнө Луу гvний тамган дээр ирээд буухад Долгорын дvр бvх сэтгэлийг нь эзлэн нvднээс өөрийн эрхгвй ундрэн амьдралдаа юугаар ч засаж чадахгвй гэмт хэрэг хийсэн хатуу сэтгэлээ зэмлэж харамсав. Сэтгэлээс нь Долгор салаагвй учраас унтаж ч чадсангвй.

Гагцхvv өглөө ажилдаа болоод Долгорын тухай бодлоос бага боловч хөндийрч байлаа. Нар ханын элэг өөд гарч байхад өртөөний гэрт орж цай ууж байвал гэнэт Итгэлт орж ирээд шууд урт хадаг гарган дээр нь давхарласан мөнгөн янчаан тавиад «Би язгуур угсаагvй суман эр, эрх ямбатныг vзэж чаддагvй жигшиж байсныг чи сайн мэднэ. Ардын засаг бол миний хvсэж мөрөөдөж явсан засаг мөн. Урьдах төрийн вед элдвээр нvд vзvvрлэгдэж аль олигтойгоо албан гувчуурт өгч явсан бидэндээ тvшиг, гэгээн нар минь болсон засаг төрдөө өчvvхэн нэмэр болтугай гэж аюуш хадаг, хоёр зуун мөнгөн янчаан барья. Тогтоон соёрхоно уу» гээд барилаа.

Хадаг мөнгө бариад vг хэлж байгаа Итгэлтийг өшиглөн тvlхэж гаргамаар санагдаж хязгааргvй занал хорслын гал Эрдэнийн дотор буцалж байвч тvvний хажуугаар Сvxбаатар, Петр нарын дахин дахин сануулж байсан төрийн хараа гэдэг vг бодогдож сэтгэл нь хоёрдмол болжээ. Хоёрдмол сэтгэлээс эрс шийдвэр хэзээ ч гарч байгаагvй, энэ удаа ч Эрдэнээс гарсангvй.

Шинэ тогтож байгаа засаг төрд дэмжлэг хэрэгтэй. Ардын засгийн бодлогыг дэмжсэн бvхэн бидний нөхөр, юм бvхнийг төрийн зvгээс харж байгаарай гэсэн Сvxбаатар, Петр нарын vг яваандаа Эрдэнийн ганц бодол болон хувирч Итгэлтэд доромжлогдсоноос олон жил хуримтлагдан бугласан хорслыг нь чөдөрлөв.

Эрдэнэ хадаг мөнгийг авахаас өөр замгvй болов. Итгэлт амьдралд нь багагvй балаг тарьсан авч ардын засгийг дэмжиж байгаа болохоор хувийн хорслыг тvр боловч дарж төрийн заавар, тvмний итгэлд захирагдан төрийн сууриас хандах нь ганц зөв зам болжээ. Эрдэнэ хадаг мөнгийг авч орон дээрээ тавиад эргэтэл Итгэлт «За хөө муугийн ёс биш монголын ёс болохоор золгож орхиё» гээд гараа сунгахад Эрдэнэ ухаараагvй боловч дадаж сурсан хөдөлгөөнөөр золгов.

Энэ бvхэнд зоригжсон Итгэлт Эрдэнэд сэхээ өгөхгvйг хичээн гэрийн нөгөө талд гарч суух зуур:

— Бид хоёрын дунд ёозгvй юм болж байсан. Гэвч тэр бол залуугийн гай, ухааны мунхгаас болжээ. Эр улсын хооронд юу эс болох вэ. Гэвч эвдрэх нэг өдөр байхад эвлэрэх нэг өдөр байдаг шvv дээ. Бид хоёрт Долгорын хувьд их нvгэл хийсэн улс даа гэлээ.

«Долгор» гэдэг vг Эрдэнийн занал хорслыг дахин оволзуулж хоёр гар нь зангирав.

Итгэлт ашгvй доош харан:

— Чамайг явснаас хойшхон Долгор Заяын хvрээ ороод алга болсон. Нас барсан гэж ярьцгаасан. Гэтэл урьд Тамирын голд амьд мэнд байна билээ. Гэтэл Эрдэнэ vгийг нь таслан:

— Юу гэж хачин зэвхий дуугаар асуув,

Итгэлт Эрдэнийг харж инээмсэглэх мэт болсноо:

— Би Долгортой дайралдсан. Нөгөө мань Ням гуай л талийгаач болсон гэж амьтан вймvvлсэн хэрэг гэлээ. «Долгор амьд» гэдэг vг Эрдэнийн сэтгэлийг бvр мөсөн өөрчилж, оргилж байсан хорслыг нь замхруулав. Эрдэнийн нvднээс нулимс дуслав. «Долгор амьд» гэдэг vгийн төлөө ямар ч гэмтэй хvнийг өршөөхөд Эрдэнэ бэлхэн байжээ. Энэ vгийг хэзээ ч сонсохгvй. Долгорыг дахин харахгvй гэж бодож явсан харанхуй сэтгэлд нь нар тэр хэвээрээ орж ирлээ.

Итгэлт яаж яваад Долгортой уулзсанаа нэгд нэгэнгvй яриад:

— Намайг хараад шууд хөөсөн, хөөрхий амьтан аргагvй шvv дээ. Би ч залуугийн хар гайгаар буруу хэрэг хийсэн хvн, чи ч гэсэн дээ. Үнэнийг хэлэхэд дэндvv ширvvн аашилсан шvv гээд санаа алдаж Эрдэнэ өөд харан гунигтайгаар инээмсэглэв.

Гэрийн дотор хэсэг зуур нам гvн болж хоёр хvний амьсгалах нь ган хайнагийн дуу шиг

сонсогдож байлаа. Тооноор орсон нарны гэрэл зүүн талын унийн дунд хирд гялтганан тоглож, «Долгор амьд» гэдэг үгэнд баярлах, догдлохын хязгаарт хүрсэн Эрдэнийн сэтгэлтэй наадах гэсэн мэт жирвэлзэнэ.

— Долгортойгоо л уулзъя.

— Өвгөн чинь хамт явъя.

— Ингээд өртөөчин нэг морь авчирч өгнө гэсэн. Тэгээд мордъё, за танайхан цөм сайн биз дээ.

— Цөм мэнд сайн л байна. Хүүхдүүд өсөөд Должин бид хоёр хөгширч л байна гээд Итгэлт хөгжилтэй бөгөөд жингэнэсэн нарийхан дуугаар инээв.

— Манай Бат ч сайхан эр болсон. Одоо хүрээнд оюутны сургуульд бичиг ном үзэж байгаа.

— Бат ч шөрмөстэй дамшиг даа. Чиний хойноос оргоод л алга болсон. Уулзаж орхидог байна шүү.

— Бид хоёр зовж баймаажин уулзсан.

— Бүгд эрүүл, мэнд, энх тунх хойно гүйцлээ. Амьд мэнд явбал алтан аяганаас ус ууна гэдэг энэ дээ. Ээ сэтгэл хөдөлсөндөө болоод таг мартаж орхих шахлаа. Өвгөн чинь шинэ засгийн өргөөг хувиас барьж өгье. Бид ясны ард угсаатай улс энэ засгийг дэмжихгүй бол хэн дэмжих вэ. Тийм биз дээ өвгөн минь.

— Ёстой доо. Тэр чинь зөв л бодол байна. Тэр хоёр гэрээс гарлаа. Жаргаж байгаа нар баруун уулын толгой дээр тоглон наадаж зөөлхөн салхи Тамирын хөндий дагаж үлээнэ.

Өртөөчин залуу Эрдэнийн морийг эмээллээд уяанаас уяв.

— Дүү чинь муу Галсанг халуулж Дулмаатай суугаад одоо энэ дээр Хан өндрийн хүрээний орчим нутаглаж байгаа шүү. Мөн ч сайн эр юм даа.

— Би мэднэ. Түргэн явж Долгортой л уулзъя.

«Долгор амьд» гэсэн үгийг сонссон Эрдэнийн амьдралдаа үзсэн баярын дээдэх нь байсан авч амьд Долгортой уулзана гэж бодоход их баярын хажуугаар халшран айх сэтгэл төрнө.

— Тэгье. Харин урьдаар манайхаар дайраад явъя гээд Итгэлт уяа руу хөтлөв. Харин тэр шөнө Бадарч гэртээ хариад Төмөртэй хамт гамин цохиж хурааж авсан арваад бууг сумтай нь хамт урт авдраасаа авч тэргэнд ачаад өвөлжөөн дээрээ аваачиж газар ухаж цардмалаар нямбай боож булаад «гайгуй дээ. Удахгүй хэрэг болно» гэж шивнэн хэлээд хөлсөө урт нударгаар арчиж билээ.

XV

Хавар болж цас ханзран ногоо соёолж, яргуй гарах вед хангай нутаг юутай сайхан.

Хаваржаандаа буусан Баяр өвгөний гэрийн гаднаас том хүрэн хайнаг хөллөсөн тэрэг өмнөх уулын арын модны зүг хөдлөв.

Хэсэг, хэсэг сэмжин цагаан үүл цэнхэр тэнгэрт бие биеэ хөөцөлдөн нүүнэ. Уулын нуга, жалгаар үлдсэн цас нарны гэрэлд гялалзан, ертөнц зөөлөн бөгөөд дулаан өнгө туяарах ажээ. Тэргэн дээр хөх дээлтэй Долгор хөлөө унжуулан суугаад хайнагийн жигд бөгөөд эрмэг алхалтанд найган, хагас хоолойгоор урт бөгөөд гунигаар дүүрсэн аятай дуу аялна. Хойт эхдээ аль муугаа дуудуулсан өнчин хүүхдийн нүдийг харсан бол Долгорын нүд яг л тийм байлаа. Хорвоо энэ хүнтэй хатуу тогложээ. Заримдаа яах гэж амьд яваа юм бэ? гэж өөрөөсөө асуудаг юм. Гэвч энэ зовлонт хорвоогийн аль нэгэн газар хань нөхөр, хайрт хүү нь яваа болохоор хоёулант нь эс боловч нэгэнтэй нь уулзана гэж бодно. Гэхдээ тэр хоёрыг эрээд явах бодол Долгорт байсангүй. Долгор хатуу хувь заяандаа дарагдан цөхөрсөн хүн байлаа. Нулимс нь ве ве өөрийн эрхгүй асгарах бөгөөд заримдаа унтаж байгаад хашгиран босож эхэр татан уйлна. Эрдэнэ өдийд эхнэртэй, бас хүүхэдтэй болсон ч байж магад. Гэвч хүү минь намайг эрж, надтай уулзах л ёстой шүү дээ. Би хүүгээ гомдоогоогүй. Юу ч болсон би түүний төрсөн эх

нь. Тийм биз дээ гэж бодоход хоолой нь зангиран аялж явсан дуу нь хяхран тасарч нулимс нь ямар ч саадгүй асгарна.

Хажуу талаас морьтой хvн гарч ирэхийг Долгор мэдсэнгүй. Тэр хvн бол Долгорыг сууя гэж гуйдаг Содном байлаа. Содном гvн гашуудалд дарагдсан Долгорыг хараад хэсэг дуугүй дагаж явлаа.

— Долгор, чи хаачих нь вэ? Гэж Содном тvлээнд явж байгааг мэдсээр байгаад асуув. Долгор толгойгоо гэнэт өргөн харснаа огцом хөдөлгөөнөөр нулимсаа арчиж мишээх дvр vзvvлэн:

— Ээ чи ирсэн юм уу? Гэлээ.

— Тvлээнд явж байна уу?

— Тийм ээ.

— Тэгвэл чамд тусалъя.

— Дураараа л бол доо гээд дээлийнхээ ханцуйгаар нvврээ хэд дугуйлан арчаад газар шагайж явснаа нvвр лvvгээ унжсан шанхаа гэдрэг илэв.

— Чамайг би хvlээж байна шvv.

— Би чамд хэлсэн шvv дээ. Нэг бол Эрдэнийг амьд нvврийг харах юмсан эсхvл гэснээ Долгор дуугүй болов. «Эсхvл Эрдэнийг эхнэртэй болсон гэдгийг сонсох юмсан» гэж хэлэх гэсэн боловч, Долгорын амнаас гарч өгсөнгүй хоолойд нь тээглэжээ.

— Гэхдээ чи миний сэтгэлийг бодох л хэрэгтэй.

Долгор хариу дуугарсангүй. Харин тvvний нvвр өөд зөөлөн нvдээр харж, тvмэн таавар нуугдсан уруул нь vl мэдэг хөдлөв.

— Ижий минь намайг чамтай л суу гэдэг юм. Тэгээд намайг л суухгүй гээд байгаа юм шиг, удахгүй муу ижий нь өнгөрөөд өгнө. Хvv минь хань ижилтэй бол. Долгор бол сайн ч хvн, сайхан ч хvн гэдэг юм гээд санаа алдан инээмсэглэв.

— Ижий чамд ухаангүй байх аа.

— Миний төлөө vx гэвэл дуртай vxэх амьтан. Саяхан чамтай удаан ярьсан биз дээ.

— Тийм ээ, удаан ярьсан. Би чамайг муугүй хvн гэж боддог юм шvv. Гагцхvv..

— Би ойлгодог. Тэгж итгэж хvlээдэг. Ингэж ярьсаар явтал модны захад ирлээ. Тэргээ буулгаж хайнаг, морио уяад сvх авч модруу хэд алхтал Долгорын өмнө саяхан гарсан хомбон шар яргуй харагдав. Долгор сөхрөн сууж тvvнийг таслалгүй хоёр гараараа тосон барьж энхрийлэв.

— Ямар сайхан цэцэг вэ?

— Тийм. Сайхан цэцэг байна гээд Содном хажууд нь өрөөсөн өвдгөө нугалан суухдаа баруун гараа Долгорын хоёр далыг хөндөлдvvлэн тавилаа.

— Чи хараач. Энэ цэцгэнд ямар ч хир алга гээд Содномын өөдөөс харахад нvдэнд нь баяр тодорлоо. Содном баруун гарын хуруунуудаа нугалж мөрнөөс нь бариад зөөлхөн атгахад Долгорын толгой хацарт нь наалдав.

Долгор урт гэгч нь санаа алдан инээмсэглэн байснаа эхлээд нvдэнд нь алгуураар гуниг тодорсноо бvх нvврийг нь эзлэн цочсон мэт гэнэт хөдөлж зайлаад хvvхэд шиг енгэнэтэл уйлав.

Содном хуучин хэвээрээ хэсэг сууснаа алгуур босож Долгорын ард очоод «Битгий уйл» гээд мөрөнд нь гараа зөөлөн хvргэв.

Долгор толгойгоо сэгсрэн «намайг тавиач» гэж нам бөгөөд тасалдсан дуугаар хэлэхэд бvх бие нь чичирч байлаа. Содном гараа алгуур татахад хоёр гар нь ямар ч шөрмөсгүй юм шиг сул сунаж, мөр нь мултарсан мэт унжив. Долгор газар шагайн цааш явжээ.

Хойноос нь Содном явах гэснээ больж эргэн яргуйн дэргэд орхисон сvхийг аваад тvргэн

алхаж гүйцэн очиход «бушуухан хэдэн гишүү аваад буцъя» гэж Долгор сул бөгөөд зэвхий дуугаар хэлжээ.

Тэр хоёр удсангуй тэрэг дүүрэн хуурай гишүү ачиж тэргээ хөллөн явахад үд хэлбийж байгаа нар араас нь бүлээн илчээр жигнэж үл мэдэг зөөлөн салхи өмнөөс нь үлээнэ.

— Чи ч хатуу сэтгэлтэй хүн юмдаа гэж Содном гомдолтой хэлээд Долгорыг арга нь барагдаж, гайхсан нүдээр харлаа.

— Юуны сэтгэл байх вэ дээ.

Тэр хоёр өөр юм ярьсангүй. Гэвч дуугүй явахад сэтгэл хамгийн чанга хашгирч байдаг вэ амьдралд тохиолддог бөгөөд энэ хоёрын хувьд яг тийм л вэ байлаа.

Долгор шийдвэртэй үг хэлэх үгүй удах тусам энэ хүний Долгорыг хвсэх сэтгэл их болох ажээ. Үүний хажуугаар «ингэж байтал нэг өдөр Эрдэнэ хүрээд ирвэл би элгээрээ газар тэврээд хоцорно шүү дээ» гэдэг сүрхий юм бодогдож Долгорт өгсөн сэтгэлдээ хурц сүхээр нэг мөсөн тасалмаар санагдана. «Би залуу хүн биш. Энэ хүүхнийг горьдож амьдралаа үрэхээ больё» гэж шийдэх гэтэл «харин Эрдэнэ ирвэл зүгээр юм биш үү. Эрдэнэ Долгор хоёр бие биеэ гомдоосон болохоор уулзахад нь олон жилийн турш бугласан гомдол нь дэлбэрэн гарна» гэж ямар нэгэн дуу хэлж горьдлого төрүүлнэ. Чухам энэ учраас Содном Эрдэнийн сургийг зогсоо жолоогүй тавьж дээгүүр нь ниссэн шувуунаас ч Эрдэнийн тухай асуух шахаж байлаа.

Заяын хүрээний мэргэлдэг, түргэлдэг лам нар, дал түлдэг, зоос гүйлгэдэг хүмүүсээс Долгорын тал, Эрдэнийн эргэж ирэх тухай асуусаар байгаад аль ч учраа олохгүй болжээ.

Зарим нь Долгорыг заяаны хань гэнэ. Зарим нь хань болохгүй гэнэ. Зарим нь учир, үзүүр нь олдохгүй юм хэлнэ. Зарим нь Эрдэнийг амьд гэнэ. Зарим нь үхсэн, ирэх замгүй болжээ гэнэ. Зарим нь ирэх, ирэхгүйн хооронд хэлнэ.

Эрдэнийг явж ирж уулзмаар санагдана. Гэвч бүдэг бадаг ч сураг сонсоогүй байж хаашаа явах юм билээ. Нэг удаа арга нь барагдахдаа «чамайг харж горьдоод ч тусгүй шив дээ» гэж хэлэхэд нь «тийм ч байхдаа» гэж Долгор өөрийн бус дуугаар хэлжээ.

«Тийм ч байхдаа» гэсэн үг Содномын зүрхийг базсан боловч энэ үгийг хэлсэн Долгорын дуу сэтгэлд нь ямар нэг найдвар төрүүлжээ.

Долгор бол Содном зүгээр хүн өөрт нь сэтгэлтэй хүн гэдгийг сайн ойлгож байсан ба өөрөө ч энэ хүнд сэтгэлгүй биш байлаа. Гагцхүү «би бол Эрдэнийн ёсолж авсан гэргий. Бид хоёрын хүү ч буй» гэдэг бодол сэтгэлийг нь барьж, Содномын шургуу гуйлтаас хамгаална.

Гуч гарсан Долгор, Эрдэнэ ирэхгүй буюу эхнэр авсан байгаад энэ хүнийг алдвал хорвоог ганц биеэрээ туулах дардан зам нээгдэнэ гэдгийг сайн ойлгож байв.

Эрдэнэ хүрээд ирвэл яах вэ гэдэгт Долгор шийдвэртэй хариу өгч чадахгүй байлаа. Эрдэнэ эхнэр авсан бол нэг өөр хэрэг. Харин эхнэр үгүй ирвэл яах вэ? Би ч үнэхээр гомдсон. Гэвч Эрдэнэ намайг гомдоогоогүй хүн биш. Эрдэнэ эхнэр аваагүй бол түүнтэй суусан, суугаагүй хамаагүй хорвоог бэлбэсэн эмээр өнгөрүүлэхэд гасалж гомдох юм байсангүй. Харин эхнэртэй болсон бол ганцаар хохирох ёсгүй мэт санагдана.

Заримдаа «чингээд Эрдэнэ ирнэ гэж хэн над хэлсэн юм бэ?» гэж өөрөөсөө асууна. Хэн ч хэлээгүй. Гагцхүү сэтгэл нь ирэх байх гэж зогсолтгүй хэлдэг байлаа.

Эрдэнэ ухаантай сайн хүн. Нэг өдөр талд орхисон намайг эргэж заавал ирнэ байх гэж горьдох сэтгэл Долгорыг тэжээж байлаа.

— Эрдэнэтэй уулзаагүй цагт би түүний эхнэр, тэр бол миний хар үсийг хагалсан нөхөр минь. Түүнтэй уулзалгүй хүнтэй суугаад, эцэст нь эрлэгийнд очиход над хэлэх үг байхгүй гэж хэсэг дуугүй явсны дараа хэлэв.



— Тийм ч атугай Эрдэнэ чамайг үнсэнд хаясан шалз шиг орхисон шvv дээ.

— Би гомдсон.

Ингэж ярьсаар явтал хайнаг тэрэг гэрийнхээ гадна ирж зогсов. Үүнээс хэдэн хоногийн дараа Долгор Тамирын тунгалаг уснаас хэдэн хонь ямаагаа услаад буцаж явтал дороос сайхан сайвар буурал морьтой эмэгтэй хvн Тамирыг огтлон гараад ирж амар мэндийг нь мэдлээ.

Цэнхэр торгон дээл дээр ногоон дурдан бvс бvсэлж, толгойдоо мөнгөн торгон оройтой, улаан хилэн эмжээртэй тоорцог өмссөн нимгэн цагаан царайтай гуч дотор насны хот маягийн хээнцэр энэ хvvxэн бол таньдаг айл дээрээ хэд хоног хөдөөлөх гэж яваа Цэцэг юм.

— Сайн. Та сайн явж байна уу? гэж Долгор ирсэн гуй бөгөөд дэгжин хvvxний мэндийг хариулав.

Цэцгийн очих айл бол өнгөрсөн өвөл Баяр өвгөнийхтэй хамт өвөлжсөн бөгөөд одоо саахалтаар барахгvй хургаа тавьдаг айл байсан болохоор Долгор сайн зааж өгөв.

Буурал морио сайварлуулан холдож байгаа Цэцэгийн хойноос харсаар хоцрохдоо «нvvрэнд нь хар гуниг шингэсэн ямар хачин хvvxэн бэ? аль над шиг тvмэн зовлон туулсан амьтан юм болов уу?» гэж бодож байлаа.

Хөдөө газар нэг хvн ирнэ гэдэг бол ойр орчмын айлуудад бөөн сонин явдал болдог билээ.

Ирсэн зочны авчирсан боовоос хувь хvртэх, уулзаж танилцах гээд л сонин сайхан юм олон гардаг.

Туулж гарсан амьдралаас гуниг зовлонгоос өөр юу ч олж аваагvй мэт болсон Долгор, Цэцэг хоёр хэл vгээ тvргэн ойлголцож хэдэн өдрийн дараа зав л гарвал ярьж суудаг байлаа.

— Та хоёрын яриа дуусаагvй л байна уу? залуу байхад ийм байдаг сан даа гэж саахалтын айлд нь ирсэн гоё хvvxэнтэй ярьж байгаа Долгороо харсан Дэжид гуай хэлнэ.

Нэг өдөр Долгор өөрийн зовлон, гунигаар дvvрсэн амьдралыг Цэцэг хvvxэнд ярьж өгөв.

Гэхдээ Эрдэнэ гэж нэрлэсэнгvй тvvнийг миний нөхөр гэдэг нэрийн дор ярьжээ. Цэцэг хvvxэн vг дуугаралгvй сонсож байснаа «нөхөр чинь хэн гэдэг байсан юм бэ?» гэж асуув.

— Чи танихгvй. Эрдэнэ гэдэг байсан юм. Харин чи Заяын хvрээний хvн байна. Миний хvvg таньж магад. Гэвш ламын даян Итгэлтийн хvв Хонгорын хамт ном vзэж байсан Бат гэж нэг бор хvв. Цэцэгийн царай хувирч, зэрэгцэн сууж байсан Долгороос биеэ зайлуулсан боловч гуниг, гашуудалд дарагдсан Долгор ажиж яаж чадах билээ.

— Эрдэнэ ч ирэхгvй байхдаа гэж Цэцэг гэнэт хэлэв.

— Надад ширvvн vг хэлж байгаагvй юмсан. Тийм хvн нэг эргэвэл буцаж харах хэцvv. Гэвч ирэх байх гэж би итгээд байх юм даа. Бид хоёр дахиад суухгvй ч гэсэн амьд яваагийн нь харах юмсан.

— Ай даа. Эр хvнд итгэсэнээс эрхий хуруундаа итгэ гэдэг чинь vнэн юм шvv. Өдийд чамайг мартчихсан байж магад.

— Би ч гомдоосон, гэхдээ Эрдэнэ уул нь сайн хvн. Ухаантай ч хvн,

Нөхөртэй, хvvxэдтэй болох юмсан гэдэг бол Цэцэгийн ганц мөрөөдөл байж билээ. Энэ тухайгаа Чимэгт ярихад «тэнэг минь тvvгээр яах юм бэ? муу зөнөг Буяндалайг чи хар л даа. Нутагтаа эхнэртэй бас таван хvvxэдтэй золиг гэнэ шvv. До захирагчийн эхнэр манайд галзуу юм шиг орж ирээд надад доромжлуулаад, нөхөртөө аль муухайгаа дуудуулаад явж байсныг харсан шvv дээ. Ариун бурхан гэгдэж байгаа Заяын гэгээн, орос эхнэрээ яаж дарлаж байна. Удахгvй хуучин оймс сольж байгаа юм шиг хаяна даа» гэх зэрэг завхай эрэгтэйчvvдийн тухай жишээ татан ярьдаг байлаа.

Ер нь яваандаа Цэцэгийн мөрөөдөл нь амьдралын хатуу нударалтанд эвдэрчээ. Нөхрөө хардсан эхнэрvvдтэй Цэцэг олон тохиолдсон. Заримд нь туг vсээ бэлэглэж, нvvрэндээ

хумсны хэв үлдээлгэж үзсэн. Энэ бүхний эцэст хорвоогийн хуурамч амьтан бол эр хүн гэж бодоход хүрсэн.

Долгорын зовлонг сонсож Эрдэнийг хүлээсэн гэнэн нялх сэтгэлийг нь ойлгох бүр Цэцэгийн эр хүний тухай бодол батжина. Долгорыг орхиод хоёр хоноогүй байхдаа Эрдэнэ өөртэй нь яаж байсныг бодоход «Эрдэнэ ирэхгүй. Чиний сэтгэлийн гарз. Би сайн мэдэж байна» гээд болсон явдлыг нэгд нэггүй тоочмоор санагдана. Гэтэл Долгор бол Эрдэнэ ирнэ гэдэг горьдлогоор сэтгэлээ зогоож байгааг ойлгосон учир тэр горьдлогыг нь таслана гэдэг бол доголлон хүний таяг, сохор хүний тэмтрэгч модыг булаан авч хаяхтай адил болохоор «Эрдэнэ бол бусад эр хүний адил хуурамч хүн. Ирэхгүй» гэж хэлж чадахгүй байлаа. Гэвч «Эрдэнэ ирнэ. Чи хүлээх нь зөв» гэж энэ зовсон эмэгтэйг мэдсээр байгаад хуурах сэтгэл байсангүй. Энэ ч учраас эр улсын хуурамч чанарыг дахин дахин ярьж, Эрдэнийг хүлээж сэтгэлээ дэмий зовоосны хэрэггүй гэж зөвлөнө.

Харин Батын тухай бол өөр хэрэг байлаа. «Бат сайн хүүхэд. Эхээ гэж чам дээр заавал ирнэ. Боломж л олодохгүй байгаа байх» гэж үрээ хүлээсэн эхийн итгэмтгий сэтгэлийг уулзалтын баяраар дүүргэнэ.

Нэг өдөр Баяр гуайн араг боох гэж дэвтээсэн ширийг зүсэж нарийлах ажил хоёр хүүхэнд оногдож гэрийн сүүдэрт суун удтал ярилаа.

— Чи бол над шиг хүлээсэн хүн байхгүй болохоор нэг сэтгэл нийлсэн ханьтай болбол дээр юм даа гэж Долгор зөвлөв.

— Эр хүн гэдэг чинь бие далдалж, гэдэс цаггавч, сэтгэлийг ямагт зовоож байдаг юм шив дээ. Би эрчүүдийн муу муухайг дэндүү сайн мэднэ.

— Үгүй шүү. Би Эрдэнээ гомдоогоогүй бол бид хоёр зовбол ч хамт, жаргавал ч хамт байсан юм. Сайн нөхөр гэдэг чинь амьдралын түшиг, амьд явахын баясгалан. Нэг өдөр, хоёр өртөө явган явж орхиод, Эрдэнийнхээ түмэн хайр гэрэлтсэн нүдийг хармагц бие минь сэргэж хөнгөрдөг байсан. Эрдэнэ минь миний төлөө амьсгалж, амьдарч байсан хүн дээ.

— Чи ч мөн гэнэн юм даа. Бааюу дээр ирэх бүрдээ манай Чимэгтэй уулздаг нэг хүн байсан юм. Согтуу дээрээ эхнэрээ муу муухай, ёсолж авсан болохоор л салж чадахгүй байна.

Түүнээс хар гичийгээр би яах юм бэ гээд л түмэн зүйлийн юм ярьдаг байлаа. Нэг өдөр нөгөөх чинь цам дээр эхнэртэйгээ ижилхэн бор морь уначихсан гунхан явж байна. Тэгээд бидний хажуугаар гарахдаа танихгүй хүн шиг явсан. Бас нөгөө муу муухайгийг нь дууддаг эхнэрээ мориноос нь сугадан буулгаж байсныг яана гэнэ. Орой нь зав чөлөө олж манайд ирсэн. Би зад загная гэсэн Чимэг хорьж «Яах юм бэ. Би авдгаа л авч байвал боллоо» гэсэн, эрчүүд гэдэг чинь ийм л байдаг юм даа.

— Эрдэнэ минь тийм ч муу хүн биш ээ.

— Чи алхам бүхэнд нь дагаж яваагүй шүү дээ. Чамайг шалз шиг орхиод явснаас хойш юу хийж явааг хэн мэдэх вэ дээ.

Энэ хоёр хичнээн яривч Цэцэг хүүхний эр хүний шившигт явдлыг баримтаар нотловч Эрдэнийн тухай Долгорын бодлыг өөрчилж эс чадлаа. Эрдэнийн тухай Долгорын бодлыг амьдрал мэдэхгүй, гэнэн цагаан сэтгэл гэж Цэцэг санадаг бол эр хүний тухай, Цэцэгийн бодлыг олон хүнд хууртсан сэтгэлийн бухимдал гэж Долгор санадаг байлаа. Хайр сэтгэл халамжтай нөхөр гэж юу байдгийг үзээгүй Цэцэг өөрөөс нь илүү зовсон хүн гэж Долгор өрөвдөнө. Долгор бол хайр сэтгэлийг сайн мэднэ. Эрдэнэтэйгээ байхдаа зовлонгийн дундаас жаргал олж чаддаг байсан. Үнэн сэтгэлээр хүнд хайрлагдах, хүнийг хайрлахын жаргалыг Долгор мэддэг учраас түүний сайн сайхны амтыг үзээгүй Цэцэгийг хорвоогийн хир хэмжээнээс хэмэрсэн зовлонтой гуниг дүүрэн амьдарч яваа хүн гэж хайрлана.

— Чи хvнд сэтгэлтэй болж vзсэн vv? гэж Долгор асуув.

Цэцэг цочмоор Долгорыг харснаа харцаа буруулж газар шагайн нам бөгөөд гэмшилтэй дуугаар

— Vзсэн. Тэр намайг нэгэн цагийн зугаа хийж vзсэн. Явахад нь би арга барагдаж бөгжөө тайлж өгөхөд аваагvй. Одоо бодоход би мөн ч тэнэг байж дээ гээд санаа алджээ.

Yдшийн нар хэлбийж, тэнгэр ер бусын зөөлхөн бөгөөд бvлээн өнгөөр гийгvвлэн, нялх ногооны хурц vнэр vл мэдэг салхины аясаар ханхална. Хажуугийн ууланд хөхөөн дуу чихний vзvvрт сонсогдон, өмнөх уулыг давж ирсэн нvвдлийн шувууны журамтай цуваа Тамирын голын бараагаар гудайн цаад дахь хар энгэрт шингэнэ.

Тамирын голын зvгээс бараан морьтой хоёр хvн Баярын гэрийн зvг юманд хөөгдсөн мэт хурдлан давхисаар нарийхан голын зvлгэн дээр суугаад шир зvсэж суусан хоёр хvний дэргэдvвр гарах гэснээ нэг нь «тэр байна» гэлээ.

Долгор шир зvсэж байсан хутгаа шидээд, хяхарсан дуугаар:

— Эрдэнэ минь хэлээгvй юу? гэж хашгираад гvйснээ зог тусан зогсов.

Эрдэнэ мориноос всрэн буугаад Долгорын өмнөөс том том алхаад очиход Долгорын нvднээс нулимс асгаран гэдрэгээ өөрийн мэдэлгvй унав. Өмнөөс нь ирж яваа хvн яахын аргагvй Эрдэнэ мөн боловч бишvврхэх эвгvйцэх сэтгэл бадарчээ. Энэ сайхан уулзалтаас хойш хэд хоног.

Хаврын адаг сарын цэлмэг өдөр чийгтэй хорвоогоос дэгдсэн буданд гандсан хуучин цэнхэр торгоны өнгөтэй болсон тэнгэрт мандсан нар ертөнцийг шарж тvлэхгvй боловч таатай дулаан илчээр жигнэх нь юутай сайхан билээ. Ийм өдөр нуруугаа наранд ээж, удаан буухад нарны илч биеийн ширхэг бvхэнд шингэн ордог бөгөөд бие тэнийдэг билээ. Гэвч хайр нь хөрч цэвдэг болсон сэтгэлийг ийм нар хэчнээн жигнэвч бvлээцvвлж vл чадна.

Баяр гуайн бор гэрээс морины аргамжааны зайтай газар Долгор Эрдэнэ хоёр зэрэгцэн сууж ярилцана. Гэрээс Дэжид авгай байн байн шагайж тэр зvг хараад гvн санаа алдана. Олон жилийн турш хvлээсэн хvнтэйгээ уулзсан Долгорын царай өдөр өнгөрөх тусам баяр жаргалаар биш уйтгар гунигаар дvврэх болсныг тааварласан Дэжид гуайн сэтгэл шаналж эхлэв. Гэхдээ жаргал заавал авчирвал зохих энэ учрал яагаад гуниг авчирсан нь далан уулын цаадах нууц болохоор энэ хоёрын хэрэгт барин тавин оролцож vл тавина.

— Хvв минь та хоёр юу болоод байна даа? гэж өнгөрсөн орой хурга хашиж байхдаа Долгороос асуужээ.

— Юу ч болоогvй, ижий минь гээд Долгор хэлээд дахин дуугарсангvй.

Эрдэнийг ирсэн өдөр Долгор хязгааргvй баярлаж байх шиг хоёр хөгшинд санагдсан билээ. Ирсэн оройгоо буцсан Итгэлт явахдаа «сайхан вед муухай бvхнийг мартаж ёстой юм шvв» гэхэд «Ёстой доо. Хvв минь. Амьд явсан хvн алтан аяганаас ус ууна гэдэг энэ шvв дээ » гэж Дэжид гуай хэлжээ.

Тvвнээс хойш таван өдөр өнгөрөв. Гэтэл Долгор Эрдэнэ хоёрын харьцаанд vлэмж өөрчлөлтгvй болжээ.

— Өвгөн минь. Энэ хоёр нэг л биш. Бие биедээ гомдсон сэтгэл нь эвдэрч өгөхгvй байгаа бололтой. Ярьж сургаж өгье гэж Дэжид гуай өвгөндөө хэлжээ.

— Яарвал даарна гэдэг. Болохгvй харж байж буурьтай хөдөлнө шvв. Эмзэг юманд эвгvй хvрвэл тасалж орхино. Тэгвэл ёстой л нуухыг авах гээд нvдийг нь сохолно гэдэг болно гэж Баяр гуай хаширлажээ.

— Яадаг билээ дээ. Эдний хооронд нэг л муу зай гарч орхилоо гээд авгай нулимсаа, салбан ханцуйгаар нухлан арчив.

Үнэхээр ч Долгор Эрдэнэ хоёрын дунд Дэжид гуайн хэлдгээр муу зай буй болоод мөч өнгөрөх тутамд гvн болж байлаа. Долгор орхиод явсан мөчөөс нь Эрдэнийг хвлээсэн. Сайн ч хвлээсэн. Үнэн ч хвлээсэн. Анх уулзаад ч хязгааргvй баярласан Баяраас хvн хагардаг бол Долгор хагарах байсан. Гэтэл оволзсон баяр нь оволзсон баяр нь оргилж байхад гомдлын сэтгэл vүсэн гарч яваандаа Эрдэнэ бол хвлээж байсан хvн нь биш юм шиг санагдаж эхэлсэн. Анхандаа Долгор энэ сэтгэлээ хvчлэн дарах гэж оролдсон. Гэтэл хvчлэх тутам Эрдэнэ ангид, хvйтэн болж байлаа.

— Би ч чамд эртний Долгор биш, чи ч надад эртний Эрдэнэ биш болж дээ. Одоо ч чи бид хоёрын хамт амьдардаг хөг өнгөрсөн бололтой гэж эцэст нь Долгор хэлжээ.

— Долгор минь. Чи намайг гомдоосон vнэн. Гэхдээ овоо босгоогvй бол шаазгай хаанаас суух вэ гэж vг байдаг. Чи бодооч бид өнгөрснийг мартаж, ирээдvйгээ бодож амьдаръя. Бид хvвтэй шvв дээ.

— Тиймээ хvвтэй гээд Долгор хэсэг дуугvй сууснаа нам тэлvвн дуугаар

— Гэвч гомдож хvйтэрсэн сэтгэлийг хvчилж болдоггvй бололтой. Хvчлэх гэвэл дэлбэрч магад байна. Миний туулсан зовлонг чи сонссон. Гэвч vзээгvй.

— Зовлон туулсан бидний сэтгэл ингэж жаргалын өмнө сарних ёсгvй.

— Би ямар нvгэл хийсэн хvн бэ. Юунд тэр өвөл vхсэнгvй вэ. Би тэр өвөл vхсэн бол чи хэнтэй уулзаж, хэнтэй ярих байсан бэ гээд уйлахад нь Эрдэнэ аргадаж мөрөн дээр нь гараа тавьтал эрс хөдөлгөөнөөр тvлхэж зайлуулав.

— Долгор минь чамайгаа хvний газар өнчин ишиг шиг орхиж хатуу сэтгэл гаргасан миний буруу. Намайг бодохгvй гэхэд чи хvвгээ бод.

— Эрдэнэ чи битгий дуугараач гээд Долгор цааш харан толгойгоо сэгсрэхэд бvх бие нь халуун хижиг туссан хvн шиг чичирч байлаа.

Долгорын сэтгэлд «бузар янхан» гэж vсэртэл нь алгадаад эргэж ч харалгvй давхин алга болж байгаа Эрдэнэ бодогдоно. Тvвнээс хойш Долгорын vзсэн зовлонг Долгор л мэднэ. Сайхан сэтгэлт хоёр хөгшин тохиолдоогvй бол юу болох байсан бэ? амьд гарсан нь vнэн. Гэвч хувхайрч vхсэн сэтгэл нь тамын зовлонг эдэлсэн шvв дээ. Тvвнээс хvнд, тvвнээс гашуун, тvвнээс тарчилгаатай зовлон энэ хорвоод байхгvй.

Тэр нvдэнд гуйлтын хажуугаар шийдсэн зориг тодорхой харагдав. Тэр нvдэнд айх эмээхийн зэрэгцээ хязгааргvй гомдлоос буй болсон жигшил тод ажээ.

Маргааш нь аргагvй болсон Эрдэнэ явлаа. Хоёр хөгшин учир зvйг нь олох, эвдэрсэн сэтгэлийг эвлvүлэх гэж уран цэцэн vгээ, усан нулимстайгаа холин байж, аргадаж загнаж vзсэн боловч тус болсонгvй.

Хvчтэй газар хөдлөлтөөс хагарсан уул боловч он жил өнгөрөх тусам эрvүлжин эдгэрдэг билээ. Харин хvнд шарх олсон сэтгэл бол эдгэрэх нь хэцvү ажээ. Эдгэрэвч шархадсан учраатайгаа уулзахдаа сэтрэх нь vлэмж тvргэн бөгөөд тэр цагтаа улам ч аюултай. Хvний хайрын сэтгэл, хайр нь хазайснаас vүссэн гомдол, морины бvдрэлт хоёр төсөөтэй. Хурдан явсан чадалтай морь нэг бvдэрвэл босох нь хэцvү байдгийн адил их хайрын сэтгэл нэг гомдвол эвлэрэх нь хэцvү байдаг ажээ.

Санаа сэтгэл нь хоосон болсон Эрдэнэ Тамирын голын зvг гэлдрэн явахад ард нь нэг дуу гарах ёстой тэр дууг сонсохгvй бол амьдралын жаргал нь алга болох юм шиг бодогдон чих тавина. Гэвч тэр дуу гарсангvй харин нэг мэдэхэд голын эргэн дээр ирсэн байжээ.

Эргэж харвал тэртээ аманд байгаа Баяр өвгөний жижигхэн бор гэр зэрэглээн дунд харлан тоглож байлаа. Амьдрал гэж хэцvү юм даа. Хэрэв Эрдэнэ «Чи бид хоёр хамт амьдардаг хөг өнгөрсөн бололтой» гэж тvрvүлэн хэлсэн бол, Эрдэнийн гомдол эхлээд дэлбэрсэн бол

Долгорын гомдол, гомдлоос гарсан жигшил оргилохгвй байж болох байсан болов уу? Аль твймрийн хоёр vзvvр нийлээд оволздог шиг болох болов уу. Үвнийг хэн ч тогтоож чадахгвй зөвхөн тааж л чадна. Харин таасан тэр нь зөв буюу буруу байсныг баталж болохгвй.

Амьдралд ийм олон нууц байдаг болохоор тэгсэн бол яах байсан бол, ингэсэн бол яах байсан бол гэсэн мухардмал өдий, төдийн таавар өнгөрсөн юмны хойноос сvvдэр шиг дагаж явдаг бөгөөд гомдол, харамслын эх булаг болдог жамтай.

Мордоод алгуурхан холдож байгаа Эрдэнийн хойноос хаяаг нь шуусан гэрийн хананы нvдээр харж нулимсаа асгаруулан байсан Долгор «Эрдэнэ миний нөхөр, би өөрөө тvмэн буруутай хvн. Намайг гээд ирж байхад нь би хуншгвй зан гаргаж байна» гэж нэг бодовч нөгөө нэг сэтгэл нь «Энэ бол миний Эрдэнэ биш чамайг харийн нутагт гарын угаадас мэт хаясан хvн. Чамайг орхиж явснаас гарсан зовлонгоо чи мартаагвй юу. чи vxэж болох л байсан. Үхсэн бол Эрдэнэ хэнтэй уулзах байсан бол» гэж vглээд «Эрдэнэ минь зогсооч» хэмээн хашгирах дууг хоолой дээр нь таглаж байлаа.

Эрдэнийг явсан орой Содном ирж билээ. Тvмэн бодолд дарагдан хийсэн ажил, гаргасан зангийнхаа зөв буруугийн аль нь болохыг бодож олохгвй вймрэн байсан Долгорын дэргэд удтал дуугвй сууж билээ.

Долгорын царайд гомдол, таавар холилдон, хэдэн өдрийн турш уйлсан бэлцгэр нvдэнд нь ямар нэгэн шийдвэртэй сэтгэл тодровч доороо эргэлзэх шийдвэрт дарагдан сарниж байлаа. Долгор сvv хөөрvvлж байгаа тогоо руу хэсэг харж байснаа босож «Хоёулаа гарья» гэж эрс дуугаар хэлсэнд Содном дуугвй босож дагаж гэрээс гарлаа. Долгор шууд явсаар морины уяаны дэргэд очиж зогсоод, гvйцэж очсон Содномын нvд рvv эгцлэн харж «Чи яв. Би бvр эргэж орхилоо» гээд морины нь цулбуурыг тайлж өгөөд «Одоо миний сэтгэлд хэн ч багтахгвй байна» гэлээ.

- Чи тоглож байна уу?

- Тоглох чадал надад алга гээд эргэж гэрийн зvг явлаа. Содном хээр талын чулуун хvн шиг хөдлөлгвй гөлрөн баахан зогссоноо цочсон мэт ухас хийн мориндоо мордоод давхин алга болжээ.

Эрдэнийг ирээд байхад нэг удаа Содном ирсэн бөгөөд хэн ирснийг мэдээд зогсоогвй, юу болж байгааг тааварлаж Долгорын хийж өгсөн аяга дvvрэн цайг их л билэгшээн амтархан уугаад буцсан билээ.

- Энэ юун хvн бэ? гэж Содномыг уяанаас төдий л холдоогвй байхад Эрдэнэ огцом ширvvн асууж билээ.

- Нэрийг Содном гэдэг их сайн хvн шvv гэж Долгор ямар ч зовсон шинжгвй хариулжээ.

- Сайн хvн гэнээ? Хорвоо дээр сайн хvн алийг гэхэв дээ.

- Энэ бол сайны дотроос онц сайн хvн юм шvv.

Долгорын энэ vгийг сонсоод Эрдэнийн сэтгэлд хардах, харамнахын оч всэрч билээ. Гэвч би энэ ганц бие эмэгтэйг хvний нутагт хаяж орхиод юу боллоо гэж хардаж харамлах вэ. Амьд байгаа нь боллоо шvv дээ хөөрхий гэсэн бодлоор хардлагын очноос гал оволзох аюулыг дарж билээ.

Хэсэг дуугвй суусан Долгор гэнэт эрс, шийдэмгийгээр Содномын тухай, өөртөө нь сууя гэдэг тухай нэгд нэггвй хачин тайван ярьж билээ.

— Тэгээд чи vвнтэй суух хэрэг вv?

— Мэдэхгвй би чамайг иртэл Содномтой суухгвй гэж хатуу бодож байсан бурхан минь энэ бол vнэн юм шvv.

— Одоо юу гэж бодож байна?

— Одоо бол мэдэхгүй.

Долгор тэр нэгэн цагт ертөнцийн ямар ч жаргалаас солихгүй гэж байсан нөхөртөө Эрдэнэдээ хүйтэрч, түүнээс хөндийрч байгаа сэтгэлийг зогсоох гэж өнгөрсөн хэдэн өдрийн турш мэддэг уншлагаа ч уншсан. Бурхан сахиусандаа ч тоочин аврал гуйсан билээ. Гэвч тус болсон зүйл үгүй билээ.

Эрдэнэ урд Тамирын голыг гаталж, Луу гүний хүрээг чиглэн явж байхад Долгорыг тойрсон түмэн зүйлийн бодол дотор нь эргэлдэнэ. Гэвч Долгорыг буруу шаах сэтгэл хараахан байсангүй. Содномын тухай бодоход дотор харлан, үнэтэй эрдэнээ өөрийн мууд өөрөө л бусдад алдсан юм шиг санагдана. Гэвч Долгор нь үүрд өөр хүний Долгор болсон гэдэг сэтгэлтэй эвлэрч бас л чадахгүй байлаа.

«Үүнээс гашуун юм болж болох л байсан шүү дээ амьд байгаа нь их юм. Долгор минь ухаантай сан Батыг үзсэн цагт сэтгэл нь өөр болох л ёстой» гэсэн бодол сэтгэлийг нь гэжээнэ.

Хаврын нар араас жигнэн нутгийн зүг тэмүүлсэн морь хоргодсон сэтгэлийг нь бушуухан зайлуулах гэсэн мэт толгой хаялан гүйн хар алхална.

Голын хөндийд урьхан хаврын яруу дэлхийн шимтэй золгосон мэт налайн билчиж, энд тэндгүй нүүдлийн шувууны гангар гунгар дуу ирэх цагийн уяхан хөгийг чих таалан үүсгэнэ. Гэвч өөрийн бодолд дарагдсан Эрдэнийн сэтгэлийн цацарсан утас энэ бүхэнтэй хөг огт нийлэхгүй зөрж байлаа.

## XVI

Заяын бааюу дээр намын үүр байгуулах гэж хэдэн өдрийн турш Эрдэнэ хүмүүстэй уулзаж ардын нам засгийн бодлогыг тайлбарлан ярилцав. Үүний хажуугаар «улаан оросын гуйлгачин нартай нийлсэн ардын нам бол шашин бурханыг баллах гэсэн учир түүнд орогсод хойтох сүнсгүй болно. Эцэг эх лам багшаа ална гэж хүүхэд гаргаагүй бэлэвсэн эмийн өмднөөс адис авч тангараг өгдөг» гэсэн цуурхал дэгдэж байлаа. Үүнээс болж сүсэгтэн хүмүүс ардын намаас холуур явахыг хичээнэ.

Луу гүний хошуунд намын үүр байгуулах ажлаа Эрдэнэ хэдэн өдрийн өмнө дуусгажээ. Намд орно гэсэн хорь шахам хүмүүсийн дунд зургаан тайж, гурван лам байснаас хоёр тайж, нэг ламыг авч арав гаруй хүнтэй үүр байгуулаад бичээч Гончиг гэдэг ард хүнийг намын үүрийн даргаар сонгожээ. Шинэ засаг байгуулах, юуны өмнө хошуу засаг дарга сонгох ажлыг эрхлэн хийх нь намын үүрийн чухал ажил гэдгийг Гончигт хэлээд чухам юу, хийхийг зааж өгсөн билээ. Сонгууль болтол Луу гүний хошуу тамгын жасааны дарга, Гончигыг дэд даргаар түр томилж үлдээв.

Хошуу даргад сарын гурван эр хонь, дэд даргад хоёр эр хонь, бичээчид хоёр төлөг, зарлагад нэг хагас төлөг гэх зэргээр цалин тогтоож өгөөд хошуунаас ямар ч албан татвар авч болохгүй гэж чандлан тушаажээ. Бас өртөөг өөрчилж тайж нарыг өртөөний албыг залгуулах ажилд дайчлав.

Хошууны харьяат айл өрхийн тэргүүлэгчдийг цуглуулж бүх хийсэн өөрчлөлтөө ярьж өгөхөд «Ингэх л ёстой байсан. Аргагүй л ардын засаг байна. Өчүүхэн би хошуу тамгын жасаандаа найман ханатай улаан халзтай цагаан гэр нэгийг өргөө» гэж Итгэлт хэлж билээ.

Итгэлт энэ үгийг хоосон хэлсэн биш. Мөн гэр бэлэглэх гэсэн нь ч учиртай. Ардын засаг ноёд тайж нарыг ард түмний нэг адил өртөөний алба хийлгэдэг болж Итгэлтийг хэмжээгүй баярлуулсан билээ. Одоо Итгэлт урьдын цаг шиг өртөөний албыг дөрвөн цагийн албанд ээлжгүй залгуулахгүй, өртөөнд оногдсон хэд хэдэн тайж Итгэлтээс бараг л мөргөх шахаж, гуйж гувшиж баймааж нь ацаглаж билээ. Итгэлт үүнээс олсон ашгаар найман ханатай, улаан

халзтай цагаан гэр хэд хэдийг төхөөрч болно. Одоохондоо л ардын засаг Итгэлтэд халтай юм хийсэнгүй.

Эрдэнэ Луу гүний хошуунд ажлаа ингэж эхэлсэн бөгөөд одоо Заяын шавьд ажиллах болжээ. Гэтэл Заяын шавь бол өөр байдалтай газар юм. Энд харын талын ямар ч захиргаа байгаагүй, бүх юм Эрдэнэ зая бандид гэгээний нэрээр хийгдэж гэгээний мөргөл, номын зардал, жанчны зардал гэх зэрэг хэд хэдэн хүнд алба төлдөг байлаа. Хошууд өртөөний алба гэж нэг сүрхий албатай байсан бол шавь нар түүнээс чөлөөтэй байлаа. Шавь нарын ихэнх нь хэдэн жасын сүрэг хариулж түүгээр амьдарч байсан болохоор гэгээний зарлиг зөвхөн сүсэг бишрэлийн нөлөөгөөр зогсохгүй аж амьдралын үлэмж хүчтэй байжээ. Бас Зая гэгээний нөлөө зөвхөн шавь нараар зогсохгүй хошуудад үлэмж өндөр байсан болохоор түүнийг Луу гүний зэрэгт үзэж огт болохгүй ажээ. Бас тэгээд Зая гэгээн мэдэлтэй сэн бол ажил их хөнгөрөх байжээ. Хөнгөн зантай залуу банд Заяыг дуртай зүг рүүгээ хөтлөж чадах ухаан Эрдэнэд байсан. Гэтэл энэ нэр хүнд нь үлэмж бөгөөд хэдэн түм буман хүний сэтгэлд амьд бурхан болон итгэгдэж бишрүүлсэн гэгээний мэдэл өчүүхэн бөгөөд юм бүхнийг дэргэд нь байгаа хэдэн хэрсүүд хөгшин чоно, том лам нар дураараа аашлан хөтлөх ажээ. Эд өндөр хүчит Зая гэгээнийг бусадтай адил итгэж шүтэх дүрийг гаднаа үзүүлэвч үнэндээ бол гэгээний нэрээр зөвхөн Заяын шавийг биш, ойр орчмын хошуудын хэргийг залж байгаа бүлэг байлаа. Эрдэнэ энэ бүхнийг сайн ойлгож байсан учраас Заяын шавийн хэрэгт дотроо бодлоготой, дороо ухаантай, учир хужрыг нь сайн тунгаан хандахгүй бол болохгүй гэж боджээ. Хиагтыг эзлэн авах байлдаанд идэвхтэй оролцсон Хасбаатар тэргүүтэй хэд хэдэн лам нар өндөр мяндаг, тушаалтай байсан авч Сүхбаатар ардын намын гишүүн болгосныг Эрдэнэ сайн мэднэ.

Ардын намыг гүтгэсэн элдэв ярианы эх бол лам нар гэдгийг Эрдэнэ сайн ойлгож байлаа. Чухам тийм ч учраас том лам нарыг зохистой цаг иртэл ойрхон шиг аргамжин хараандаа байлгах нь зөв гэж бодов.

Ингээд шууд очиж Зая гэгээнтэй ярилцаж билээ. Гэтэл залж байдаг хэдэн хөгшин чоно, ялангуяа үмхий санаа, давхар бодлогын үүр болсон хүрээ хамба дэргэдээс нь холдсонгүй. - Монголын ардын нам бол ард олны тусын тулд зүтгэх ариун зорилготой болохоор өндөр нэрт ариун санваартан гэгээн та гишүүн болон орох биз гэж гүн итгэнэ гэж Эрдэнэ хэсэг ярьсны дараа шууд тулгажээ.

Гэгээн орохгүйн төлөө тэмцэж элдвээр бултах байх. Тэгэхлээр нь шахна гэж бодсон Эрдэнэ дараагийнхаа үгийг бэлтгэж байлаа.

Нэг гартаа цас шиг цагаан хаш хөөрөг бариад нөгөө гартаа урт шар эрх эргүүлэн нүдээ хагас анин суусан хамба ардын засгийн төлөөлөгчийн далд бодлыг аль эрт мэджээ. «Уухай чи биднийг тээрэмдээ илжиг шиг оруулж авъя гэж бодож байгаа бол бид дотор нь ороод твймэр асааж өгье» гэж бодон хөх инээд нь хүрч суужээ. Эрдэнийн үгээ дуусахад нь хамба хоолойгоо намбатай зассанаа «Эх болсон хамаг амьтны тусын тулд бие сэтгэлээ харамнахгүй гэж санваар хүртсэн бид ардын намд орж олон шавь нарынхаа төлөө зүтгэх хүсэл дүүрэн байна. Үүнийг эрхэм сайд өндөр ухаандаа тогтоож багтаан авахыг хичээнгүйлэн гуйна» гэлээ.

Хэрэг явдал Эрдэнийн санасан зүг явсангүй. Гэвч Эрдэнэ «Уухай, хашир чоно чи бидний дотор орж авъя гэж бодож байна? Хэн нь хэнийхээ хөлд нь суухаа үзье» хэмээн бодоод өргөн тэнэгэр инээмсэглэн «Та бүхний хүслийг өчүүхэн би баяртай хүлээн авна. Гэвч нэгдүгээрт ардын нам бол олон түмний нэгэн санаагаар эвлэлдэн нэгдэх зүйл болохоор орохыг хүссэн бүх хүмүүс хамтран тунгаан ярьж хэнийг оруулах, хэнийг үгүйгээ шийднэ. Хоёрдугаарт

бидний ярилцсаныг дээд газар хянан үзнэ» гэж хэлэв.

«Чингэх тусмаа сайн» гэж хамба бодов. «Чамайг шилбүүрээ бариад хот руу өнгийж байхад чинь би учрыг нь олж болох байлгвй дээ» гэж Эрдэнэ бодож байлаа.

Хамба, намд орох өдий төдий сам нарын нэр гаргаж өгөхөд нь «Нэгдүгээрт балын бага нь дээр гэдэг, хоёрдугаарт юу ч гэсэн та бүхэн урьдаар үүр байгуулж аваад дараагийн хүмүүсийг өөрсдөө ярина биз» гээд гэгээний хамт зургаан лам нарын нэрийг үлдээж бусдыг нь хасчээ.

- Гэгээн ардын намын гишүүн болох энэ гэдэг яриа талын салхи шиг хурдан тархав.

Зарим хүмүүс «Ардын нам зорилго нь сайн болохоор гэгээн орох болжээ» гэж ярина.

Юу ч гэсэн намын үүр байгуулах болов. Хороо харчууд хэд малчид хэд, бас Цэцгээ хүүхэн намд орохоор саналаа өгчээ. Гэгээн болоод хамбатай ярилцаж, шавь тамгын газрын дэргэд том гэр бариулан, өдөр сонгож нам элсэх гэж саналаа өгөгсдийг цугларах тухай зарыг тарааж байлаа. Хүмүүсийн хамгийн тэргүүнд Заяын гэгээн, ойр дотны лам нарынхаа хамт ирлээ. Цэцгээ хүүхэн ирсэнгвй. Харин Чимэг хамаг гоёлоо өмсөж зүүгээд ирэхэд нь «Цэцгээ ирсэнгвй юу? Яасан юм болоо?» гэж Эрдэнэ асуув.

— Намд орно гэдэг хойтохоо баллах гэсэн үг гэнэ гээд ирсэнгвй. Над баллах хойтох байхгвй болохоор оронд нь ирлээ гээд толгойгоо хаялан тас тас инээсээр лам нарын өмнүүр алхаж дээд талд нь гараад жавдан дээр тавлаг суулаа.

— Эсгий хийхэд нохой хэрэггвй гэгчээр энэ янхан энд юу хийнэ дээ гэж нэг лам нөгөөдөө шивэгнэв.

— Цаг зэвүүн болоход ямааны мах ямбаны царанд орж, эмс эзний ширээнд сууна гэж чулууны бичигт байдаг юм гэнэ билээ гэж нөгөө лам хариу шивэгнэв.

Хамба лам хөмсгөө зангидан ширэв татахад шивэгнэн ярилцагч хоёр лам гөлсхийн дуугвй болов. Хэдэн харчуул цувралдан ирээд хүрээний нэртэй лам нар, Заяын гэгээний хамт морилон ирснийг хараад өөрийн эрхгвй сүрдэн наманчилж мэндлээд үүд хатадчаар шахалдан сууцгаав. Үүнийг харсан Эрдэнэ «Та бүхэн дээшээ морилон сууцгаа. Эрхэм гэгээн болоод хүндэт лам нарыг эрхэмлэн үзэж бишрэн сүрдэх нь зүйн хэрэг боловч өнөөдөр та бүхэн нэгэн намын үүрт дагаж орохоор ирсэн болохоор эрх тэгш билээ» гэж харчуудад хандан хэлээд «Тийм биз дээ» гэж лам нараас асуув.

Заяын гэгээн инээмсэглэх мэт болон хамба руу харлаа.

— Ардын засгийн мэргэн сайдын хэлдэг түмэн зөв гэж нэг лам хэлээд марсайн инээв.

— Ёс ёмбогор, төр төмбөгөр гэж хэцүү юм даа гэж хэлээд гэсгвй хоолойгоо засав.

Үүдэнд сууж байсан хүмүүс дуртай дургвй босож дээшлэн сууцгаав. Эрдэнэ босож ардын нам, засгийн зорилгын тухай тайлбарлан нилээд яриад «Ардын намын тухай янз бүрийн ор үндэсгвй яриа дэлгэрч байна. Энэ яриаг монгол орон, монголын ард түмэнд сайн сайхныг хүсэгчид гаргаж байгаа биш. Биднийг, монгол улсыг баллах гэж байгаа хүмүүс гэж ярьдаг тэр хүмүүс гаргаж байгаа хэрэг. Энэ яриа бол ор үндэсгвй худал үг. Монгол оронд улс байгаагвй, гадаадын эзэрхэг түрэмгий нарт доромжлогдсон ард түмэн байсан. Бид тэр түмэн зовлонд нэрвэгдсэн монгол орныг гадаадын дарлалаас чөлөөлөх гэж тэмцээд түүнээ биелүүлсэн. Зовж зүдэрсэн монгол оронд тусгаар улсыг байгуулах гэж манай шилдэг хүмүүс тэмцэн босоод алтан амиа өгч байсан. Амарсанаа, Цэнгүнжав мэтийн баатар эрс монгол улсаа гадаадын доромжлолоос салгаж тусгаар улс болгох гэж тэмцээд алтан амиа алдаж байсан түүх буй. Бид тэдний гвйцээгвй хэргийг гвйцээсэн. Энэ буруу гэж үү? Биднийг шашин бурханыг баллах гэж байгаа улс гэдэг. Гэтэл бид гамингийн шоронд орж, Бароны хоригдол болж байсан Богдоо хэмжээт эрхт хаанаар өргөмжлөөд, ард олныг шүтэх, бишрэх



эрхийг хүндэтгэн үзэхээ тунгаасан билээ. Энэ шашин бурханыг баллаж байгаа хэрэг үү? Биднийг эцэг, эх лам багшаа ална гэж тангараг өргөсөн улс гэж гүтгэдэг. Бид тийм тангараг өргөөгүй. Бид бүх хүмүүс адил тэгш эрхтэй байх шударга зөв ёсыг тунхагласан. Бид монгол орноо зөвхөн тусгаар тогтносон улс болгоод зогсохгүй эрх чөлөө эрдэм соёлтой улс болгох гэж тангараг өгсөн билээ. Энэ бүхнээ биелүүлэх гэж хамжлагатай байх, угсаа залгамжлах ёсыг устгасан. Энэ муу юм гэж үү? Бидэнд хорсохдоо мухар толгойтон гэж хүртэл нэрлэдэг. Манжид дагаж өгсний булай тэмдэг болсон гээгээ зарим маань тэмцэлд саад болохоор нь хусаж хаясан нь үнэн. Энэ буруу гэж үү? Мухар толгойтон муу хүмүүс байдаг юм бол энд байгаа гэгээн болоод эрхэм лам нарыг муу ёрын хүмүүс гэх үү?» гээд Эрдэнэ үгээ таслахад хэдэн хүн жуумалзав.

Эрдэнэ хоолойгоо засаж, цугларагсдыг тойруулан харснаа «Ардын засагт дургуй хүмүүс буй. Тэд ардын нам, засгийн эсрэг гүтгэлэг дэлгэрүүлж байна. Гэвч цаасан шувууны бичигт цул модон хэнгэрэг дуугарах тусмаа янзгүй гэж мэргэн үг байдаг. Ард олны төлөө тогтож, ард түмний тусын төлөө ажиллаж байгаа засаг төрийг гүтгэх нь цул модон хэнгэрэгтэй адил биш гэж үү? Ардын засаг бол улс шиг улс болохсон, хүн шиг амьдрах сан гэж хвссэн монгол нийтийн засаг» Миний ярих гэсэн юм ийм л байна. Та бүхэн лавлан асууж ярих юм байвал асууж ярьцгаа гээд түшлэгтэй олбогон дээр бахархалтай бөгөөд ихэмсэг суулаа.

Гэрийн дотор хэсэг зуур нам гүм байлаа. Заяын хүрээний зүүн дацангийн гэсгүй бүдүүн лам эрихээ эвхэж өвөртлөөд намбатай босож хоолойгоо намжиртай засаад «ардын нам бол ариун цагаан явалтай нигүүлсэнгүй хүмүүс эвлэлдэн нэгдэх эрхэм холбоо гэдгийг ардын засгийн өндөр сайд номлон айлтсаныг мунхаг бид ойлгон авлаа. Иймийн учир энэ өдөр ардын намын гишүүн болох хүн болбол ариун явалтай байх ёстойг хэлэх юун билээ. Гэтэл энд байгаа хүмүүсийг ажин шинжвэл энэхүү гэгээн зорилгод нийлэхгүй байгааг мэргэн сайд оюун ухаандаа тогтоон соёрхох ажаамуу» гээд алга хавсран намс гээд суув.

Өглөө хамба, намд орох болсон, лам нарыг цуглуулж, харчуудаас аль болохоор цөөн хүн оруулахыг хичээх тухай ярьсан билээ. Энэ учраас гэсгүй яргачин Доёд, Чимгээ мэт хэзээнээс бурхан шашингүй хүмүүсийг намд олноор оруулбал ашиггүй болно гэ бодоод ингэж хэлэв. Хүрээ хамба хэрэг болохгүй үг хамаагүй ярьсан гэсгүйг, идэж байгаа ясанд нь ойртсон жижиг гөлгийг архиран харж байгаа уяатай нохойн нүдээр ширвэв. Хамбын бодлоор ингэж халз дайрч болохгүй ажээ. «Хар тэнэг, үмхий өөх дуугүй л сууж байхгүй» гэж дотроо бухимдан байлаа.

Үнэхээр ч гэсгүйн үг харчуудыг гижигдэж тэд шуугилдаж эхлэв. Заяын хүрээний идэх махыг залгуулж байдаг хоёр яргачин Доёд гэгч ярих хар хүн нүдээ гялалзуулан босож «Гэсгүй та ардын намын зорилгод нийлэхгүй хүмүүс гэж хэнийг хэлж байна аа? Түүнээ шууд хэлж орхи» гэж эрс шаардав.

Хамт босож Эрдэнийг зальтай нүдээр харан толгойгоо дохин ёсолсноо «хүндэт гэсгүй нэр цохож хэлээгүй, харин хүн болгон адилгүй, морь болгон жороогүй байдаг болохоор эрхэм сайдыг тунгаан соёрхоно уу гэсэн билээ» гээд суулаа.

—Би мал нядалж гэдсээ тэжээдэг мулгуу бодолтой мунхаг ухаантай хүн. Гэвч хүний хэлсэн үгийн цаана нааныг мэднэ. Гэсгүй та над мэтийн хүнийг ардын намд орох хувь завшаангүй гэж хэлж байх шиг байна. Нэрлэж орхи. Тэгээд ярилцъя гэж Доёд хэлэхэд хэдэн хүн дэмжин шуугив.

— Бидэнд бие, биеэ хардаж, хар санаа өвөрлөх бол хамгийн муухай биш үү. Ардын намын зорилго бол эрхэм сайдын айлдсанаар эв нэгдэлтэй байх ёстой билээ. Гэнэт хэрэг буруу тийшээ эргэж байгаад сандарсан хамба чулуун хүн шиг гөлрөн нэг хөгтэй унжирсан дуугаар

хэлэв.

Гэвч Доёд хэдэн хvний ил дэмжлэгээр дахин босож «Ардын намын гишvн байх хувь зохиолгvй хvн» гэж хэнийг хэлснээ шууд нэрлэхийг шаардав. Хамба лам уран зөөлөн vгээр хоёр талыг эвлэрvvлэхийг хичээн оролдсон боловч нэгэнт дэгдсэн шуугианыг дарж эс чадлаа.

Эрдэнийн ганц дохиогоор энэ шуугиан дарагдах байлаа.

Гэвч vvнийг зогсоохыг Эрдэнэ оролдсонгvй. Харин улам дэврээж, чадвал лам нарын нөлөөг бусдаас салгахад тус дөхөм болно гэж бодоод «Гэгсгvй та нэр заагаагvй боловч энд байгаа хvmvvc гэж тодорхой хэлсэн болохоор бусад нөхдийн шаардах нь тvmэн зөв билээ. Ер нь нуух, бултах нь манай намын vзэл бодолгонд vl нийцэхийн учир та шударгаар нэрлэх нь зvйн хэрэг биш vv» гэж шаардлаа.

Тулгагдсан гэгсгvй аргагvйн эрхэнд босож эргэн тойрон харлаа. Ардын засгийн газрын төлөөлөгчийн дэргэд сууж байгаа олонд нэр хvндгvй Чимэг хvvхнийг л зааж орхивол энэ хэрэг тасрах биз гэж горьдоод хоолойгоо засаж «Намын зорилго шударга учир vнэнийг хэлэх нь зvйн хэрэг болно. Энэ Чимэг хvvхэн бузар самуун явдалтай болохоор манай намд байх гавьяагvй буюу» гэтэл Чимэг хvvхний царайд тvймэр шатан ухасхийн босож нvдээ гялалзуулан хөмсгөө зангидан уруул чичирнэ.

— Юу гэнээ. Та өөрөө хэн бэ? бvдvvн хулсан бэрээгээр манзач ламыг ухаан алдтал цохиж байсан чинь ариун явдал уу? цагаан оросын ноёд том шар хадаг бариад бөхөлзөж байсан чинь ариун явдал уу? би ч яах вэ бузар самуун явдалтай. чи сайд вангийн Гомбо тайжийн залуу эхнэрийг багш нь багш нь гэж байгаад хvvхэдтэй болгож, нөхөрт нь баригдаад халзан толгойгоо ялз цохиулсан шарх чинь харагдаж байна. Тэр чинь ариун явдал уу? гээд багтран дуугvй болов.

Олны дотроос ганц эмэгтэйг нvд чичлэн vзсэн гэгсгvйн авирыг харчуудын олонхи нь зэмлэв. Ингээд хэрvvл намжсангvй харин их болов.

— Ардын засгийн сайдын дэргэд ийм балай юм ярих гэж байдаг аа. Намын хэргийг ч бузарлаж байна даа гэж гэгсгvй бувтнан хэлэхэд халзан магнай нь улаан чавга шиг болсон байлаа.

— Намын хэргийг бузарлах биш. Гэгсгvй таны бузар явдлыг уудалж байна гэж Доёд хэлэв. Хамба намбатай босож хоолойгоо засан эрихээ гартаа эргvvлэн эвхсэнээ «гэгсгvйн бодсон бодол, хэлсэн vг манай намын бодлогод тохирохгvй харш учир намд авахгvй байвал зохино гэж би бодож байна» гэлээ.

— Эрхэм гэгсгvйн айлддаг зvйл худал биш билээ гэж нэг шодон гэээгтэй хар хvн хэлж орхисноос болж чи, би дээ тулсан хэрvvл дэгдэж нэг нь нөгөөгөөсөө хортой муухай vг хэлэхийг хичээн шуугилдав.

Эрдэнэ vvнийг ашиглан босож өндөр дуугаар «та бvхэн дуугvй болцгоо» гэж сvртэй хэлсний дараа саяхан оволзож байсан гэрт нам гvm болов. Бvхнийг тойруулан өтгөн хар хөмсгөө зангидан харснаа: «Зая бандитан гэгээний шавьд ардын намын vвр байгуулна. Гэвч энд байгаа хvmvvcийг бvгдийг нь авч болохгvй. Нам бол нэг талаар төрийн талын байгууллага болохоор шашны мөрийг хөөсөн лам нарын эрдэм номоо бясалгахад нь саад болж магад билээ. Гэвч нам бол монгол улсыг мандуулах, ард тvmнийг жаргаах болохоор лам нар оролцох нь зvйн хэрэг. Иймийн учир намд лам нарын төлөөлөгч болгож Заяын гэгээн, эрхэм хамба хоёрыг оруулъя гэж бодож байна. Төрийн хэрэг бол харын талын хэрэг болохоор хар талын хvmvvcийг намд олноор оруулах нь зvйтэй билээ» гээд vгээ таслахад араараа тавиулсан лам нар юм ярих гэж зэрэг, зэрэг өндөлзөв. Тэднийг яриулж болохгvй. Эрдэнэ

ялсан ард түмний сүрээр лам нарын оволзсон уурыг дарахаар шийдэж модон хуйтай сэлээдийгээ ширээн дээр авч тавив. Үүний бараагаар лам нар дээрээсээ хvнд лантуугаар цохиулсан мэт намсхийн сууцгаав.

Энэ бүхнийг нүдний булангаар ажиж амжсан Эрдэнэ инээдээ хvчлэн барьж «Бас Заяын шавьд хошуу байгуулна. Энэ бол төрийн захиргаа. Хошууны бүх ажлыг шийтгэн явуулна. Намын vүр vүнийг байгуулах ажлыг эрхлэн хийнэ» гэлээ.

Тэр орой Эрдэнэ арван нэгэн хvмvвсийг vлдээн авч биеийн байцаалтыг бичиж vүрийн тэргvүн даргаар бичээч Гомбо гэгч хvнийг, дэд даргаар Доёдыг, тэргvүлэгч гишvүнд Заяын гэгээнийг сонгуулав.

— Та бүхэн өнөөдөр арван нэгэн хvнээр намын vүр байгуулж авлаа. Одоо энэ vүртэй нэр өгье гэж Эрдэнийн хэлэхэд Доёд эхлэн босож «мөнх дэлгэрэх vүр» гэж нэрлэх санал гаргав.

— Бадран мандах гэвэл ямар вэ?

— Жаргалын манлай гэвэл зvгээр мэт.

— Арван тавны сар гэвэл зvгээр мэт.

— Арван тавны сар том боловч арван зургаанаас эхлэн бага болж эхэлдэг болохоор тусгvй.

Харин «мөнх мандах» гэвэл өлзийтэй сайн нэр болно гэж Гомбо хэлжээ.

Ингэж ярилцсаар «Мөнх мандах» гэж нэрлэхээр тогтоцгоов.

Эрдэнэ хэдэн хоногийн дараа Далай вангийн хошуу руу явахдаа Гомбо, Доёд хоёртой аминчлан уулзаж хошуу байгуулах бэлтгэл ажлын тухай заавар өгөөд «Одоо нэг ч ламыг намын гишvүнд авч болохгvй шvү» гэжээ.

Ингээд «Мөнх мандах» vүр хошуу захиргаа байгуулах ажилдаа орж билээ.

## XVII

Зуны сайхан цагт хангай нутагт эсгий хийх нь нэг ёсондоо баяр наадам байдаг бөгөөд тунгалаг Тамирын хөндийд Итгэлтийн эсгий хийх нь бүр ч өргөн дэлгэр болдог ажээ.

Хойт Тамирын өргөн зvлгэн дээр гурван том майхан зэрэгцvүлэн шааж, өдий төдий эр, эм хvмvвс хvүхэд багачуул цугларан, дэлгэж хатаасан эсгийнvүд ногоон хамбан дээр дөрвөлжин цагаан хээ мэт жигдхэн ярайна.

Майхан бүхэнд эсгий дэвсэж, том торхтой шуугиж буцалсан айраг сөгнөж, урт ширээ тавин дээр нь их гарын царуудад чанасан хvйтэн мах, өрөм бяслаг овоолон тавьжээ.

Гадна газар ухаж, зуух татан дөрвөн тамгатай тогоонууд тавин авгай нар таташ ч хийж, сvү амтагдсан шаргал цай чанана. Эрэгтэйчvүд, залуу эмэгтэйчvүдийн хамт унгас зулна. Зарим нь усалж цахилдаг цацна. Зарим нь эсгий бооно. Харин бүгдээрээ Итгэлтийн баян, буяныг vг хайрлалгvй магтан хvч хайрлалгvй ажил хийнэ.

Дөрөв дөрвөн мориор гурван зэрэг эсгий татах бөгөөд нэгэнд нь Хонгор, гурван залуугийн хамт явна. Эдний эсгий буух болсон бололтой.

Тэд туруу халж хөлөрсөн морьдоо ташуурдан цогино. Үнэхээр ч талын арван хоёр гэж Хонгор хэлээд майхны зvг жолоогоо эргvүлэв. Буусан эсгийг олон хvн тойрон задалж эхлэхэд Хонгор нөхдийн хамт морьдоо уяд майхны зvг хөгжилдөн явлаа.

— Хонгор оо! гэж нэг залуу унгас зулж байгаа Сvрэнгийн зvг нүд ирмэн нударав.

Хонгорын хөлөрсөн царай vл мэдэг улсхийж, нүд нь өөрийн эрхгvй Сvрэнгийн зvг харлаа. Сvрэнгийн нvүрнээс баяр зовнил хосолсон дулаан туяа цацарна.

Хонгор, Сvрэн хоёрын холбоо, Тамирын голын олонд тодорхой болж зарим нь «Ням ч заяатай эр юм» гэнэ. Зарим нь «Тийм сайхан амьтныг хөрөнгө, vзэсгэлэн, хосолсон тийм цогтой эр авахгvй яахав» гэлцэнэ. Зарим нь Ням өвгөний азанд битvү атаархан «тэр хөрөнгийг барагтай буян даахгvй» гэх буюу «Итгэлт ганц хvүгээ тийм заяагvй гуйлгачин

охинтой суулгахгвй», «хвний буян, хвнд шингэхгвй» гэж ярина.

Должин ганц хvvгээ ядуу хвний охинд сэтгэлтэй болсонд бухимдавч Итгэлтээс айдаг болохоор тvvний амыг ширтэн, vгийг хвлээнэ. Гэтэл Итгэлт энэ явдалд нvдэн балай, чихэн дvлий мэт ажээ.

— Ганц хvv чинь Сврэнгээс салахаа больж шvv. Буруу замаар будаа тээвэл буцахдаа шороо тээнэ гэдэг. Заяа буян тохирсон юмтай нийлvvлэхийг бодвол дээр бишvv гэж Должин нэг удаа зориг гарган хэлэхэд мах идэж байсан Итгэлт эхнэрээ ёжгвй нvдээр ширтэн харж байснаа «Сврэн заяагвй хвн гэж чамд ямар шулмас нь шивэгнэж орхив» гэлээ.

— Сврэнг гарснаас хойш Нямынх өөр л болсонгвй гэдэг.

— Залуусын явдал бидэнд падгвй гээд Итгэлт хутгаа арчиж хуйлаад босов. Нөхрийнхөө занг шууд мэддэг Должин цааш юм хэлсэнгвй

Хэдэн өдрийн дараа адуунд явж ирээд айраг ууж суусан Хонгорт «Хvv минь Сврэн чамд хань биш. Заяа буяны нь харахгвй бол болдоггвй юм» гэж Должин хэлжээ.

Хонгор хариу дуугарсангвй. Гэвч тvvний хөлс дааварласан бор царай «Ижий минь ийм юмыг дахин над битгий хэлээрэй» гэсэн тод vгээр гэрэлтэж байлаа.

Итгэлтийн дvлий дvмбий байдлыг хvmvvc янз бүрээр тайлбарлана.

Зарим нь баян хвн болохоор ганц хvvдээ хөрөнгө харж эхнэр авахгвй гэнэ. Зарим нь Нямын охиныг vрж хаясны дараа өөр юм авч өгөх гэж байгаа юм гэнэ. Зарим нь ганц хvvдээ халдаж чадахгвй дураар нь тавьж байгаа юм гэнэ.

Энэ дотор ганц охиноо Хонгортой суулгаж Итгэлтийн их хөрөнгөнд хуруу дvрэх бодолтой нэг хвн байлаа. Тэр бол Бадарч билээ. Yвнийгээ биелvvлэх гэж сvvлийн хоёр жил Итгэлтийнтэй саахалт явдаг болов. Хэд хэдэн удаа эхнэрээ зориуд явуулж Должинтой яриулжээ. Должин энэ саналыг баяртай дэмжиж Итгэлтэд хэлсэн. Гэтэл нөхөр нь хvйтэн инээж «Бадарч миний хөрөнгөнөөс долоох азгвй байх аа» гэжээ.

Бадарчийн эхнэр, Должин хоёр хуйвалдаж хоёр залууг аргалж байгаад хошуу цанд хамт явуулсан. Гэтэл орой нь цувран иржээ.

Итгэлийн эсгий хийж байхад Бадарчийн эхнэр охиноо нvдийг нь бvлтэртэл гоёод Хонгорын нvдийг татах гэж хэд дахин ирсэн бөгөөд эсгий хийх вед орой бvхэн болдог цагаан модны тоглоомд орсон боловч гайхал Хонгорын анхаарлыг татаж чадсангвй.

Ням өвгөн ялангуяа авгай нь Итгэлт нэг юм хэлэх болов уу гэж горьдох бөгөөд тохиолдох бүрдээ ам руу нь, ширтэн зогсоно. Гэтэл Итгэлтээс vг сонсох нь битгий хэл, хоёр залуугийн холбоог Итгэлт зэмлэж байгааг ч, дэмжиж байгааг мэдэж эс чадна. Хишигт авгай өглөө бүр тахил өргөх буюу орой бурхандаа зул барихдаа «Ганц охинд минь заяа буян хайрла» гэж vргэлж залбирдаг байлаа.

Эсгий хийж ажлын шувтарга болж байхад нилээд согтсон Бадарч Итгэлтийнд ирлээ. Тvvнийг Хонгорын сэтгэлийг татаж чадаагvйдээ бухимдсан эхнэр нь «Чи ганц охиноо буянтай айлын хоол идvvлье гэж боддог юм бол очиж Итгэлттэй ярь» гэж уйлан баймаажин явуулжээ.

Бадарчийг ирсэнд баярласан Должин арз гаргаж мөнгөн аяганд хийн барилаа. Нутаг орон, мал ахуй, хурдан морь, хвчит бөхийн тухай Итгэлттэй удтал ярьж байснаа «Итгэлт минь бид хоёр эцэг өвгөдөөсөө энэ нутагт хаяа нийлvvлэн нутаглаж гэмгвй явлаа. Одоо чиний хvv эр болж, миний охин нас бие гvйцлээ. Энэ хоёроо холбож, айл гэр болговол болохгвй газар мэт. Миний өчvvхэн хөрөнгө, чинийхтэй зvйрлэхэд юу болох вэ. Гэхдээ би ганц охиноо хэн ч чамлахгвй инжтэй буулгана гэж боддог юм шvv» гэлээ.

Итгэлт дvлий дvмбэ оргин хариу дуугарсангvйд Должин «Өвгөн минь, Бадарч чамд сайхан vг хэлж байна» гэлээ.

Итгэлт далаа хөдөлгөн суниаснаа өмнөө байсан мөнгөн аяганд архи хийж удаан гэгч нь шимж уулаа. Гэрийн дотор ямар ч чимээгүй бөгөөд Должингийн хоёр нүд Итгэлтээс үл сална.

— Миний охин заяатай хvн юм шvv. Чи бидний мэргэн багш буян, баян хосолсон ордонд төрсөн хvн гэж айлдсан юм гэж Бадарчийн хэлэхэд Должин угтан авч

— Танай охины чихний нь гэдэс ч олон хvнд байхгvй заяатай хvн юм шvv. Мэргэн багшаас тал асуухад найман намсрай шиг элбэг дэлбэг айл болно гэсэн гэлээ.

Итгэлт эхнэр рvvгээ харж, завжиндаа ёжтой бөгөөд нууц инээмсэглэсэнээ:

— Чи нөгөө хадгийг аваад өгөөч гэлээ.

— Ямар хадаг вэ?

— Нөгөө урт аюуш.

Баяр нь багтаж ядсан Должин гялалзан эргэж авдраасаа өндөр хvн боловч хоёр vзvvрийг нь газраас салгаж чадахгvй, цэнхэр тэнгэр шиг аюуш хадаг авч Итгэлтэд өгөв.

Бадарч ханцуйгаа засаад орон дээр тавьсан ялбигар хилэн малгайгаа нүдний булангаар харлаа.

Итгэлт хадгийг хэсэг vзсэнээ хэт нугалж бариад зуны цагт ханын толгойгоос өлгөөстэй байдаг хуучин хилэн малгайгаа өмсөөд эргэхэд нь «ёс төртэй юм, гэрт нь очоод баривал дээр биш vv?» гэж Должин шивэгнэв.

Гэтэл сонсоогvй дvр vзvvлэн хадгаа алгуур эвхэж өвөртлөөд шууд гэрээс гарч эсгий хийж байгаа газар руу дэвхрэн алхав.

Арга барагдаж, гонсойсон Бадарч Должин хоёр бие биеэ ширтсэнээ Должин гарч Итгэлтийн хойноос гарав.

Итгэлт зогсолгvй явсаар эсгий хийж байсан олны дэргэд очоод «Настайчуудыг дунд майханд орохыг урья» гэж чанга дуугаар хэлээд түргэн гэгч нь хагас эргэж голын том эрээн майхан руу хэд алхсанаа зогсож ойрхон байсан Галсанг дуудаж чихэнд vг хэлэв.

Удалгvй том майханд олон хvн цугларав. Хэдэн өдрийн эсгий ажилд ядарсан Ням ханцуйгаараа хөлсөө арчиж том хултай айраг хийж аваад тавтай завилан шимнэ.

Юу болох гэж байгааг тааварлаж гайхсан олон майхны урд багананы өмнө зогсож байгаа Итгэлтийг ширтэнэ. Галсан боосон эсгий татахаар мордох гэж байсан Хонгорын оронд хvн явуулаад тvvнийг дагуулан орж ирэхэд «Миний хvv нааш ир» гэж Итгэлт захирангуй бөгөөд ихэмсэг дуугаар дуудаж дэргэдээ зогсоогоод өврөөсөө аюуш хадгаа гаргаж дэлгэн бариад Нямын өмнө очиж «танайд олонд гайхагдсан, орчлонд хосгvй тана сувд байдаг. Манайд хольцоогvй хонгор шар шижир алт байдаг билээ» гэж хэлж эхэлтэл майханд орж ирсэн Должин «хvн Итгэлт ээ бодооч, ухаараач» гэж хашгирав. Итгэлт юу ч сонсоогvй юм шиг хоолойгоо засаад vргэлжлvvлэн: «Энэ хоёр vнэт эрдэнийг нийлvvлж бөгж цохиулбал лус баярлаж, ус долгиолох гайхамшигт эд болохын учир ариун хадаг барьж танай эрдэнийг тал засан гуйж байгааг тогтоон соёрхоно уу» гэлээ.

Олны ард байсан Хишигт авгай дуу алдан ухас хийн «Ням минь чи толгой нvцгэн байна» гээд ойролцоо байсан нэг өвгөний ювдэнг мулт татан авч өвгөнийхөө толгой дээр тавьж «аваач» гэж хяхарсан дуугаар хэлээд бvlээн нулимсаа ямар ч хаалтгvй асгаруулав.

Энэ бvхнийг харсан Бадарчийн царай хар хүрэн болсноо шазуураа зуугаад эргэж явлаа.

Итгэлт нүдээ онийлгон, эв хавгvй инээмсэглэсэнээ «Би ч бэр гуйж яваагvй, бас тэгээд уран цэцэн vггvй болохоор олигтой юм хэлж чадахгvй юм» гэлээ.

Хонгорын минчийж улайсан царайд нь багтан ядсан илэрхий баяр шатан оволзож амьсгаа бачимдан, зvрх цохилон, бие нь чичрэх мэт болов.

Ням дээлтэй гараа арчиж «Хашийн өнгөтэй таныг минь хайрлаж яваарай. Харах нүдний цөцгий мэт энхрийлж яваарай, ураг төрлийн барилдлагааг миний тана гутаахгүй, үргэлж танай гэрт буян хишиг дэлгэрэх болтугай» гээд хадгийг хүндэтгэн авлаа.

— За одоо юу гэж хэлье дээ гээд Итгэлт олныг тойруулан харж марсайн инээмсэглэснээ

— Лав болсон байхаа. Үлдсэн эсгийгээ түргэн хийгээд, дуусгая. Өнөө орой сүй тавьсны найр хийнэ гээд юу ч болоогүй юм шиг эргэж гэрийн зүг явлаа.

Ганц охины нь заяа буян дэлгэрсэнд бахардан баярласан Хишигт майхны вааданд нүүрээ наан уйлна. Гэтэл болсон энэ явдлын учрыг ойлгож явсан олон дуугүй хэдэн мөч болсноо хорвоогийн нэг том явдлын гэрч болсноо мэдмэгц дур мэдэн шуугиж гарлаа.

«Миний хувь над шиг хөрөнгө харж эхнэр авахгүй. Сүрэн шиг сайхан хувхнийг миний хувь эс авбал хэн авах вэ» гэж бодоод алхаж явахдаа ховдог Бадарчийн хошууг тас цохисон бахдал, ганц хүүдээ сэтгэлтэй ханийг нь гуйж өгсөн баярт дарагдан өөрийн шийдвэрийн мэргэнийг магтан явлаа.

Эсгий хийж дууссаны нэг баяр, сүй тавьсны хос баярын их найраас буцаж яваа хувьд удахгүй болох их хуримын тухай ярилцана.

Баян Итгэлтийн ганц хүүгийн хурим болно гэж бодоход Тамирын голын сархданд тааламжтай өвгөчүүдэд энэ жилийн өдөр үлэмж урт болоод хоног явахгүй юм шиг санагдаж байлаа.

## XVIII

«Хүрээ орж хүүтэйгээ уулзъя» гэж ганц бодол Долгорын сэтгэлээ салахгүй болов. Гэтэл энэ бодлоо хоёр хөгшинд хэлэхгүй байлаа. Тэдний тусламжгүй бол Долгор явж чадахгүй. Хүрээ ороход унаа унаш, хувцас хунар, хоол хүнс гээд их л юм хэрэгтэй. Энэ бүхнийг Долгорт хоёр хөгшин бэлтгэж өгөх гэвэл гүдэсдэх нь дамжиггүй.

Эрдэнэтэй уулзаж, түүнийг хөөж явуулснаас хойш Долгор өөр хүн болжээ. Нөгөө зовлонд дарагдсан уйланги эмэгтэй үгүй болоод хөгжилтэй шинэ Долгор дахин төржээ. Эрдэнийг хөөж явуулсанд нь Баяр гуай Долгорыг зэмлэнэ. Харин Дэжид гуай хүний хуншгүй хаяж явсан Эрдэнийг хөөж явуулан нь Долгорын зөв гэнэ. Ингэж хоёр хөгшин нэгдсэн бодолгүй болохоор Долгорыг зэмлэж ч чадахгүй, сайшааж ч чадахгүй байлаа. Зөвхөн Долгорын эзгүйд үргэлжлэн маргана.

— Ганц муу эмэгтэйг тийм цэвдэг сэтгэл гаргаж хаясан хүнийг тэгэх нь түмэн зөв.

— Долгорт буруу байсан шүү дээ. Бас тэгээд Эрдэнэ буруугаа ойлгоод ирж байхад дэндүү юм.

— Үхсэн бол хэнийг эргэж ирэх байсан юм бэ?

— Та нарыг үс нь урт, ухаан нь богино гэдэг ёстой оносон нэр шүү.

— Чиний ухаан тийм урт юм бол Долгор үхчихсэн байвал тэр хархув хэнтэй уулзах гэж ирэх юм бэ? гэдгийг хариулаад аль!

Өвгөн хэсэг түгдэрч ээрснээ «үхээгүй амьд байна шүү дээ» гэлээ. Үнэхээр ч Долгор үхсэн бол Эрдэнэ хэнтэй уулзах билээ гэж өвгөнд бодогдовч чавганцдаа бууж өгөхгүй гэсэн бардам сэтгэлээс ч юм уу аль Төмөрийн хэлдгээр эр хүн хүндээ хайртайгаас болсон юм уу юу ч л гэсэн Эрдэнийг өмөөрөх гэж мэрийн оролдоно. Овоо босгоогүй бол шаазгай хаанаас суух вэ гэгчээр Долгор эхлээгүй бол Эрдэнэ хаанаас чингэж хатуу сэтгэл гарган орхиж явах билээ.

— Үхсэн бол тэр хүний сэтгэлд шуудрахгүй юу? гэж өвгөн маргаандаа хор нь буцлахдаа хэлж орхив.

Энэ үгэнд авгай догширч

— Эр хүн ч тийм л дээ. Тэр жил би цагаан бурханаар сажилж орхисон бол энэ золиг өдийд

нэг юмаар цайгаа чануулчихсан байж байгаа даа гэхэд өвгөн буруу вг хэлсэндээ бантаад амандаа бувтнан гарлаа.

Хоёр хөгшин хичнээн маргавч тvvнээс болж өөрчлөгдсөн юмгvй ажээ. Харин Дэжид гуай ил далд элдэв хэлбэрээр Долгорыг Содномтой суулгах гэж ятгана. Гэвч Долгор «За» ч vгvй, «Yгvй» ч vгvй ажээ.

Цэцгээ хэдийгээр ч Эрдэнийг хөөж явуулсан Долгорын сэтгэлийг зөв гэх авч Дэжид гуайн гуйсныг бодож

— Долгор минь чи Содномтой суугаач. Тун сайн хvн гэж ярилцах юм гэлээ.

Долгор гэзэгнийхээ vзvvрийг оролдон доош харан хэсэг сууснаа Цэцгээ өөд харж санаа алдав.

— Тэгээд чи Содномтой суухгvй юм бол Эрдэнийг юунд хөөгөөд явуулсан юм бэ?

— Чамд хэлэх нь битгий хэл, өөрөө мэдэхгvй байна. Их гомдсоноос болсон юм болов уу? аль царай алдаж аргадаад, өмнө минь сөхрөх шахаад байх дээр нь зэvvv хvрсэн болов уу? Юу ч л гэсэн дургvй хvрсэн.

— Би чиний сэтгэлийг огт ойлгохгvй юм. Чи над хэлэхдээ залуу нас гуа vзэсгэлэн гэдэг чинь шуугиад өнгөрнө. Харин сайн эр нөхөр бол амьдралын тvшиг амьд явахын жаргал гэдэг байсан. Тэгээд ёстой л уул хад шиг хоёр эр гуйгаад байхад шийр заагаад байх юм. Ёстой л тааж боломгvй оньсого байна даа.

— Өвгөн минь би бvр мансуурч гvйцлээ. Гэхдээ над нэг л хөнгөн байх юм. Би л лав усан тэнэг хvн байх аа гээд инээв.

Нэг өдөр Содном ирлээ. Долгор хvрээ орох унаа гуймаар аман дээр нь хэд дахин гарч ирсэн боловч хэлсэнгvй. «Унаа гуйхад энэ өгнө. Авна гэдэг бол дотночилсон сэтгэлийн тэмдэг. Yгvй. Yвнээс л гуйхгvй. Одоо л гуйхгvй» гэж дотроо vглэж байлаа.

Содном суух тухай ярихад «Нэг vгийг олон дахин сонсоод байх дээр дургvй хvрдэг юм шvv.

Хэрэв чи бушуухан эхнэртэй болохгvй бол амьдарч чадахгvй байвал би Цэцгээд хэл өгье.

Зовлон vзсэн зvгээр хvн бололтой» гэж Долгор хэлжээ. Тэр орой Долгор «Хvрээ орж хvвтэйгээ уулзъя» гэдэг бодлоо хоёр хөгшинд хэлж орхив. Yвнийг сонсоод хөгшидийн царай бараан дуугvй хэсэг сууснаа «хэзээ явах бодолтой байна» гэж Баяр гуай асуув.

Дэжид гуай доод уруулаа хазан дуугvй сууж байснаа нулимс нь хөөрөн урсав. Долгорт хоёр хөгшин сэтгэлийн угаас дасжээ. Энэ учраас Долгорын «хvрээ орно» гэдэг вг «бvр явна» гэсэн утгаар сонсогдов.

— Өөрийн, хvний аль нь ч тогтдоггvй гэснээ Дэжид гуайн хоолой зангиран вг нь тасарч өнгөнэтэл уйлав.

— Ижий минь би бvр явахгvй. Баттай уулзаад л та хоёр дээрээ буцаад ирнэ. Одоо бол та хоёроос салахгvй гэж Долгор хэлэв.

Долгор хоёр хөгшинд vнэтэй хvн гэдгээ ойлгов. Энэ нь тvvний сэтгэлийг хоёр хөгшний хvзvvнээс уяж өгөв. Долгорын «Одоо би та хоёроос салахгvй» гэсэн vгийг сонсоод хоёр хөгшин хэсэг зуур тvvнийг хөлрөн ширтэв.

«Одоо би та хоёроос салахгvй» гэж Долгорын хоёр нvд дахин дахин хэлж байлаа. Дэжид гуай Долгорыг тэврэн авч удаан гэгч нь vнсээд:

Миний хvv хээр морио унаад яв гээд салбан ханцуйгаараа нулимсаа нухацтай сайн арчив.

— Иш Дэжид минь хvvхэд шиг юм ярих юм. Энэ хөгшин морь гэр хол газар яаж хvрэх вэ.

Харин хvрэн хайнагтай тэрэг хөллөөд явбал найдвартай хvv минь.

— Мөргөлчин дагаад ч явж болно шvv дээ.

—Тэр дэмий хvv минь. Аав нь Бээжин хvрсэн ч эвдрэхгvй тэрэг хийгээд өгнө. Тэгээд л

явахад хаа ч хүрнэ.

Орой нь Цэцгээ ирж удахгүй буцах тухайгаа ярив. Долгор «Хүрээ орж, хvвтэйгээ уулзах» тухайгаа ярьсанд Цэцгээ хэсэг дуугүй бодол болон сууснаа Эрдэнэд өгөөд аваагүй бөгжөө авч өгөв.

— Өвгөн минь хэрэггүй.

— Авахгүй бол гомдоно шvv. Зовсон хоёр эмэгтэйн нэгэн нь нөгөөдөө тус больё гэж байна.

— Өөрт чинь хэрэг болно. Ийм vнэтэй юмаар би яах вэ?

— Би ч бvсгvй хvн. Чи ч бvсгvй хvн шvv дээ. Би хөрөнгөө барж ядсан баян хvн биш. Над илvv хөрөнгө байхгүй. Гэхдээ хамгийн цагаан сэтгэлээс чамд өгч байна.

Долгорын нvднээс нулимс асгарав. Гэвч энэ бол баярын нулимс байлаа. Хvн гэдэг яасан сайхан амьтан бэ.

Гурав хоногийн дараа Цэцгээ бааюу руугаа буцсан бөгөөд Долгор явах бэлтгэл хийлээ. Хоёр хөгшин хөл болж байр гуай шинэ тэрэг урлаж гарлаа.

Ядуу хvн холын замд бэлтгэх хэцvv. Гэвч сэтгэл сайхан бол юм бvтэх нь амар ажээ.

«Долгор хүрээ орох гэнэ» гэдэг ярианы сэжvврийг сонсмогц Содном давхиж ирээд тусалъя гэх нь битгий хэл, хамт явъя гэснийг Долгор хvлээж авсангүй. Харин Содномын эх ирж замын хvнс болгож хоёр гvзээ цагаан тос, том гэгчийн ширэн савтай борц өгснийг авлаа. Хавь ойрын айлууд цөм юм авчирч өгсөөр байгаад хайнаг тэргэнд бараг багтахгүй юмтай болов. Хvмvvc голдуу л хvнсний юм авчирч өгөх бөгөөд зарим нь хүрээ орж худалд гэж хурганы арьс ч бэлэглэнэ.

Дэжид гуайн шинэ хөх даалинжингаар тэрлэг хийж өгсөн ба гутлыг нь маш зузаан ширээр хэдэн давхар уллаж өгөв.

Хэдэн өдрийн дараа хүрээний зvг том хүрэн хайнаг хөллөсөн цоо шинэ цагаан модон тэрэгтэй Долгорыг хөдлөхөд хоёр хөгшин хээр морин дээрээ сундалдан бараг хагас өртөө газар гаргаж өгөв.

— Хvv минь хоёр нарны хооронд яваад бай. Хайнагаа ногоотой газар аргамжиж хоно.

— Жижиг хайрцагт чинь утас зvv хийсэн шvv.

— Хөмөн богцонд чинь бэлэн шаантаг буй. Тэргээ усаар гаргаж байгаараа. Тэгэхгүй бол хагсадаг юм шvv.

— Дотоод энгэртээ хадсан мөнгөө vргэлж барьж vзэж яваарай.

— Дөрөв тав хоног сайн яваад нэг бvтэн өдөр хайнагаа амрааж идvvлж бай.

— Хүрээнд янз бvрийн зантай хvн байдаг юм гэдэг шvv. Хvv минь хичээж яваарай.

— Богцонд чинь шинэ сур бий шvv. Хvнээс замаа сайн асууж яваарай гэх зэргээр хоёр хөгшин захиана.

Ингээд салах болж уйлалдан хоцров. Зуны дунд сар болохоор ногоо цагаа элбэгтэй бөгөөд хаа ч хоносон даарах хөрөхийн зовлонгvй ажээ. Замд тохиолдсон айлууд хүрээ орох гэж яваа ганц эмэгтэйд шинэ цай чанаж, сайн хоол хийж өгнө. Тараг цагаа бол огт тасрахгүй ажээ. Хэдийгээр хүрэн хайнаг жигд бөгөөд том алхавч vхэр тэрэг болохоор зам хорох нь даан ч бага ажээ. Ингэж явсаар Туул голыг гарч Богд хаан уулын аймгийн төвийн захад очиж нэг сайхан зvлгэн дээр буув.

Хайнагаа ногоон дээр аргамжиж орхиод хойт энгэрт байгаа хэдэн хоньтой айлаас цайны cvv гуйхаар жижиг хувин барилаа.

Аймгийн төвөөс нэг сайхан бор морь хөтөлсөн ижил зэвхий ногоон дээлтэй хоёр залуу чанга чанга инээлдэн ирж явлаа. Бодвол морио услахаар явж байгаа бололтой.

Хол замд ядарсан Долгор тэднийг анхааралгүй урьдаж зам огтолж айлын зvг гэлдрэн явлаа.



Араар нь өнгөрч байгаа залуусын нэг нь

— Сургууль эхлэхээс өмнө нэг эхнэр олж авах юмсан. Хvv минь чамайг ханьтай болбол тусгай гэр барьж өгнө. Гэрлээгvй цагтаа тэр бусад багш нартайгаа хамт л нэг гэрт морилж бай гэж аймгийн дарга хэлсэн шvv гэхэд нөгөө нь

— Бушуухан л нэг гэзэгт уургалаад авахгvй юу? Гэв.

— Сэтгэлд тохирсон юм зам дээр хэвтэж байхгvй юм байна шvv дээ.

— Зам дээр ч байхгvй. Гэхдээ гэртээ ходоодоо элж хэвтээд байвал өөрөө хврээд ирэхгvй шvv дээ гэхэд хоёр залуу чанга бөгөөд хөгжилтэй инээв.

Долгор гэнэт зогсоод маш алгуур эргэж харлаа. Өнгөрөөд гарсан залуусын нvvр нь харагдсангvй. Холдож байгаа тэдний хойноос нvд цавчилгvй ширтэж байснаа саяхан хөлд орж байгаа хvvхэд шиг тэнтэр, тунтар гэж алхав.

Жаргаж байгаа нарны алтан туяа нvvрэн дээр нь тусаж гялбах бөгөөд хоёр залуугийн арыг хөтөлж яваа морь нь халхална. Долгор явсаар л байлаа. «Бишvv, ийм жаргал байх ёсгvй» гэж бодовч хөл нь зогссонгvй.

Залуус Туулын татуурга дээр очиж исгэрэлдэн морио услав.

— Өглөө эрт л мордох хэрэг vv?

— Нэг мордвол ийм морьтой хvн тоос татуулаад л буучихна.

— Чи яг энэ замаар ирсэн vv?

— Тийм. Яг л энэ замаар. Мөн ч хvйтэн байсан шvv.

Долгор зогсов. Нvvр нь татвалзан, нvд нь гөлрөн хэн ч vl сонсох тагжирмал сөөнгө хоолойгоор «Бат хvv минь!» гэвч хөдөлж vl чадна. Ингэж хэсэг байснаа гэнэт байдаг хvчээрээ «Бат аа миний хvv. Ижий нь..» гэж ер бусын хахир дуугаар чарлаад дотор нь манаран сууж уйлав.

Тийм дээ. Эх хvvгээ буруу танихгvй. Энэ бол яахын аргагvй Бат байлаа. Оюутны сургуулиа төгсөж Богд хан уулын аймгийн танхимын дагавар сургагчаар ирээд байгаа нь энэ билээ.

Хэдэн өврийн өмнө эцгээсээ «Эх чинь амьд» гэсэн vtгэй захиаг аваад эхлээд юу ч уншсанаа мэдэлгvй гайхсан ба дараа нь сайхан зvйл мэт санагдан хэд дахин уншив.

— Аавын бичиг мөн vv? гэж хамт ирсэн Чулуунбаатараас асуув.

— Аавын бичиг ээ. Аль? гэж Чулуунбаатар гайхаж асуув.

— Мөн байна, энэ сvvл.. аав яг ингэж татдаг юм гээд захиаг хэд дахин уншина.

Эх нь яаж явсаар хэрхэн усанд орсон, яаж аврагдсан тухай тодорхой бичсэн ажээ. Бас одоо хаа хэн гэгч айлд байгааг ч бичжээ. Тэнэг зан гаргаж орхин явсан намайг өршөөсөнгvй:

«Амссан зовлон нь их болохоор гомдсон сэтгэл нь хатуу байх нь аргагvй л байх даа. Гэвч амьд энэ л цаглашгvй баяр» гэсэн захианы сvvлийн хэсэг Батад бодол, таавар төрvvлэв.

Эцэг, эх хоёр нь хамтарч суугаагvйг ойлгов. «Тэгэх ёсгvй. Би л tvргэн очихгvй бол болохгvй» гэж бодоод анхныхаа цалинг өчигдөр авмагц бор морио өнөөдөр авч өглөө Тамирын зvг мордох гэж байгаа юм.

Эхийнхээ дууг сонссон Бат гvйн очив. Ганц хvvгийнхээ толгойг элгэндээ тэврэн аваад енгэнэтэл уйлж байхдаа хорвоо дээр зовлон байвч жаргал бас байдгийг бvх сэтгэлээр мэдэрч байлаа. «Амьд явбал алтан аяганаас ус ууна» гэж Дэжид гуайн давтан ярьдаг нь энэ уулзалтыг л хэлсэн бололтой.

— Ижий минь битгий уйл. Амьд уулзлаа шvv дээ гэж Бат хэлэвч өөрийн нvднээс нулимс дусална.

Орчлонгийн жам ёс хvнийг зовоож чаддагийн адил баярлуулж чаддаг нь юутай сайхан бэ! энэ жам ёс өнөөдөр энэ хоёр хvнд баяр, жаргалыг өчvvхэн ч харамгvй өгч байлаа.

— Ижий та хаанаас гараад ирэв?

Ингэж уулзсан эх хvv хоёр ярьж эхлэв. Тэр яриа дуусахад хэцvv. Ярьсаар явж хайнаг тэргийг авч Батын гэр очив. Гэрийнхээ гадна очиход хүрэн хайнагийг тэрэгнээс буулгаж «Ижийг минь авчирч өгсөн сайхан хайнаг байна» гээд магнай дээр нь vнсэж орхисонд vргэж суварга шиг хоёр эврээрээ золтой л сvлбэж орхисонгvй.

Бат, Чулуунбаатар нар цай чанаж хоол хийн, Долгор тэрэгтэй юмаа задалж, саяхан ирсэн багштай танилцаж амжсан хvmvvc «танхимын багш жаал хvvгийн эх иржээ» гэж салж сарнисан эх хvvгийн учралд талархан баярлалцаж байлаа.

Эцгийнхээ тухай асуусан Батын эхний асуултад эх нь зөвхөн «Аав чинь над дээр очсон» гэж хариулсан билээ. Гэвч цаг өнгөрөх тусам уулзалтын баярын согтолт тайлагдан гарч эцгийнхээ тухай хvv асуун шалгааж эхлэхэд эхийн нь vг цөөрч дуу нь хахир огцом болов.

— Бид хоёр муудалцаж хэрэлдээгvй. Гэхдээ цаашдаа нэг гэрт хамт амьдарч чадахгvй болжээ.

— Яагаад?

— Мэдэхгvй, дэндvv гомдсон юм бол уу даа.

— Аав уу?

— Үгvй ижий нь, бvгд амьд мэнд хойно одоо гvйцлээ.

— Үгvй гvйцээгvй. Бид гурав хамт байх ёстой.

— Хvv минь болохгvй юмыг болгох гэж зvтгэх хэрэг алга. Үvнээс жаргал гарахгvй. Ижий нь зовсондоо гээд урт гэгч нь санаа алдаж хэсэг дуугvй сууснаа, миний том эр болж дээ гэлээ.

«Миний хvv том эр болж дээ» гэдэг vгийг Долгор «хvv минь одоо өнчрөхгvй. Хойт эхтэй болсон ч алзахгvй» гэж хэлсэн болов уу?

Юу ч л гэсэн эцэг эхийн уулзалт нь баяраар дуусаж чадаагvй бөгөөд тvvний гэм бол эхийн нь гомдсон сэтгэл байж гэж Бат ойлгов. Гэхдээ «Ижий минь vнэхээр зовсон. Тэр зовлонд би ч нэмэр хандив оруулсан шvv дээ» гэж бодоход эхээ зэмлэх сэтгэл гарсангvй.

«Одоо тэгээд яах вэ? Ижийн минь гомдсон сэтгэл нь алгуур арилахад нь бид хоёроо хайрлах байлгvй дээ» гэж сэтгэлээ засна. Гэтэл «Чи л ярьж эцэг эхээ нийлvvлэхгvй бол хэн нийлvvлэх билээ дээ. Чи бол энэ хоёрыг холбож байгаа ганц шижим шvv дээ» гэж өөр нэг сэтгэл дахин дахин шивнэнэ.

Гэрийн дотор нэг хэсэг ямарч анир чимээгvй байлаа. Бат доош харан хоёрдмол бодолдоо дарагдан байснаа толгойгоо алгуур өргөж эхээ эгц харлаа.

«Энэ тухай надаас асууж битгий зовоогооч нэгэнт дууссан хэрэг» гэж эхийн хоёр нvд гуйж байв. Хэдэн өдрийн дараа Долгор Батын өгсөн морийг унаж хайнаг тэргээ хөтлөн баруун зvг хөдлөв. Монгол орны зун, нутгийн зvг тэмvvлэн алхах хүрэн хайнаг цөм хөгжvvн баяртай ажээ.

Долгорын сэтгэлд шинэ амьдралын тухай шинэ бодлын цэцэг ургаж бушуухан урд Тамирын хөндийд очиж Содномтой уулзах хvсэл оргилон сэтгэл нь нэг л хөнгөн уужим явах бөгөөд амандаа аялна.

Зовлон дундуур туулсан энэ эмэгтэй шинэ амьдрал өөд шийдэж хөдлөв.

Тэр шинэ амьдрал нь жаргал болох болтугай.

XIX

Заяын хүрээний цамын өмнө олны шуугиан дэгдсэн нэг сүрхий явдал гарчээ. Яг цам эхлэх өглөө хүрээний цогчин гэсгvйн овоодойн бvч, мөнгөн бишгvvр зэрэг өдий төдий vнэтэй, цайтай юм vгvй болсныг vгvйллээ.

Зарим хvmvvc цаг зэvvvн болсноос муу ёр болов гэж сэжиглэн, vvнээс юу болохыг тааварлан ярилцана. Зарим нь бvчийг ардын засгийн мухар толгойтон зориуд авсан гэнэ. Зарим нь нарт

гэгээний жасад хойчийг бодолгвй орж өдий төдий юм авсан хулгайчийг гайхна. Зарим нь зүгээр л сонин болгож дамжуулан ярина.

Их жасын нярав гэгээн сан өдий төдий үнэтэй юмаа алдсаныг аймгийн даргад мэдэгдэж тэмдэглүүлэв. Ингэж элдвийн яриа тэнгэрт тулж, хоёр хvн уулзахдаа мэндчилэхийн оронд бvчний тухай ярьж байсан авч энэ яриа Хонгорт хүрсэнгvй.

Шаазгай зөв олоод хийх газаргvй сvлбvүлж vхсэн гэдэг шиг Хонгор авсан юмаа харанхуй модонд нуугаад бараг өдөр бvхэн очиж vздэг байлаа. Цамд очихоор явах замдаа тэр газраа очиж юмаа урьдах ёсоор дэлгэж vзвэл ер бусын хийцтэй, тvүд хоргой бvч нvдэнд нь тусав. Барилж сонирхон vзсэнээ сvүлийн вед дэгжирхэн шилэндээ унжуулан явдаг болсон эцгийнхээ хэдэн малгайд угсарч vзвэл яриагvй зохиж байв. Урт сайхан бvчтэй малгайгаа ар руугаа угжуулан сvүдрээ харвал бvчний vзvүр газар шvүрч байв. Энэ сайхан бvчээр гоёвол өнөөдрийн цам дээр очсон бvхнээс ялгарсан гоё дэгжин хvн болсоор бодогдов.

Замдаа явахдаа эргэж харахад урт бvч морины нь хондлой руу хаялан мөн ч дэгжин санагдаж байв.

«Сvрэн минь харвал Хонгор чи ч гарч өгчээ» гээд л бvчийг минь сонирхон гайхах байсан даа гэж бодогдов. Бас жасын гол байшинг ухаж орхиход хэн ч мэдэхгvй сар гаруй болсныг бодоход эр чадал ухаан хосолсон сайн эрийн шинж өөрт нь бvрдсэн мэт санагдаж байлаа. Цам жигдрэхээс нилээд өмнө очиход тойрон зогссон морьтой хvмvүсийн дунд орж зогсов. Хэд хэдэн танил хvнтэй тохиолдож мэндлэв. Хvмvүс бvчийг нь харан жив жув ярилцахад «миний дэгжинг гайхаж байна» гэж баярлан байлаа.

Цогчин гэсгvйн бvчийг Итгэлтийн Хонгор зvүж явна гэж нэгээс нөгөөд дамжсан яриа тарж байв. Ингэж байтал хошууны тахар, хоёр ламын хамт ирээд Хонгорын морийг шууд цулбуурдан олны дундаас хөтлөн гарчээ.

Тэр өдрийг Хонгорыг хэнтэй ч уулзуулсангvй аймгийн гянданд хорьжээ. Ганц хvү нь жас ухсан хэрэгт баригдсаныг сонсоод Итгэлт мэддэг чаддаг хvмvүсээр явсан боловч «учир нь олдоогvй байна» гээд уулзуулсан ч vгvй.

Маргааш нь Хонгорыг байцааж эхлэв. Анхны хулгай илэрснийг ойлгож, Хонгор сандрахдаа «засагт ханы цахиур Төмөр өгсөн» гэж өчив.

Ингээд дөрвөн дагуултай Төмөрийн зvг хөдлөхөд Заяын жасын донир бvчийг боож өвөртлөөд явжээ. Хан өндрийн тамган дээр хоноход Хонгор оргочихъё гэсэн боловч эв таарч өгсөнгvй. Маргааш нь vдийн хэрд Төмөрийнд очиход хvрэн торгон тэрлэгтэй Төмөр нохойгоо хорьж өгөв.

Улаан хvзvүвчтэй том халтар нохой бариад Төмрийн дэргэдvүр гарахдаа «Би Хонгор. Ах минь намайг бодоорой» гэж шивэгнэн хэлжээ. Гэвч Төмөр энэ vгийг нь сонссон, эссэн тэмдэгт огт мэдэгдсэнгvй.

Улс ороод суухад Дулмаа том том vндсэн хуланд айраг хийж өгөв. Төмөр хvмvүстэй, ногоо цагаа, малын тарга хvчийн тухай ярьж тайван байхад Хонгорын зvрх цээжиндээ багтахгvй цохилон байлаа. Дулмаа Хонгороос хэд хэдэн юм асуухад толгойгоо сэгсрэх, дохихоос өөр хариу өгч чадсангvй.

— Хонгор минь юу болчихоов. Гэрийнхэн чинь сайн уу гэж Дулмаа асуув.

Донир өврөө уудалж боодолтой бvчийг гарган маш удаан задлан, унжуулж бариад:

— Та энэ бvчийг таних уу? гэж Төмөрөөс асуув. Төмөр юу ч дуугаралгvй бvчийг аваад ажиглан харж байхад хэн ч vл ойлгох инээмсэглэл нь нvүрэнд нь тодорч байв.

Гэрийн дотор ямар ч чимээгvй хэсэн болов. Бvхний нvд Төмөр рvү чиглэв. Төмөрийн хэлэх vг л амь, амьдрал хувь заяаг нь шийдвэрлэх юм гэж бодсон Хонгорын сэтгэл буцлан догдолж

энэ агшин өнгөрүүлсэн бүх амьдралаас нь урт юм шиг санагдаж байв.  
Төмөрийн нүд солбис хийж, өтгөн хөмсөг нь эрчлэн зангираад, Донирыг ширтэн харлаа.  
— Танина. Тэгээд юу гэж?  
— Энэ бүчийг энэ хархувуу цам дээр зүүж яваад баригдсан. Уул нь манай алдсан бүч. Тань дээр буулгаж байна гэж Донир Төмөрийн ширтсэн цог шиг хоёр нүднээс хараагаа зайлуулан, өмнөө байгаа хултай айраг руу гөлөлзөн хэлэв.  
— Тийм ээ. Би Хонгорт өгсөн гээд Төмөр бүчийг өвөр дээрээ тавив.  
Хонгорын зүрх цохихоо больж зогсох шиг болон тал бүрээс нь хавчиж байсан хүлэг задран унав.  
— Тэгвэл бид гэж Донирын ярих гэтэл Төмөр тасалж  
— Би зургаан сайн морио нэг шөнө алдсан хүн. Тэгээд мөрийг нь мөшгиж явтал энэ бүч хэвтэж байсан. Нэгийг нь таван мориор өгөхгүй хүлгүүдээ алдаад оронд нь энэ бүчийг авсан хүн дээ. Тэгээд арга барагдахдаа энэ Хонгорт өгч хувуу минь найр, наадамтай олны газар зүүж яваад сэжигтэй харсан хүнийг ахдаа авчирч өгөөрэй гэсэн. Энэ бүч та нарын юм бол миний морьдын орсон нүхийг та бүхэн хэлж өгнө дөө гэж Төмөрийн хэлэхэд Донир цочиж гэдрэг болов.  
Халхад нэр гарсан түшмэлүүд уран мэргэн өчгөөс нь залхсан энэ айхтар амьтантай заргалдах гэдэг бол тайхар чулууг өргөхөөс хэцүү мэт санагдсан Донир доор сууж байсан хүмүүс рүүгээ дүрлийсэн нүдээр харлаа. Ардын засаг үүссэнээс хойш өнчин ишиг аваагүй Төмөртэй энэ засгийн өмнө хэлэлцээд хэрэгт орохоос өөр замгүй мэт Донирт санагдав.  
— Жас ухсан хулгай, Төмөр гуайн морьдыг авсан байж болно шүү дээ гэж нэг ламын хэлэхэд ухаан орсон Донир:  
— Үнэхээр тийм, Төмөр гуай минь ер нь л бид эрлээ нэгтгэх болжээ гэж бараг л хашгиран хэлэв.  
— За мэдэхгүй. Ээдрээтэй утасны үзүүрийг барьсан хүн тавихгүйг л хичээдэг юм даа гээд Төмөр түмэн уулыг ч нэвт хармаар ер бусын хурц нүдээр бүхнийг тойруулан ажиг.  
Ирэгсэд ам булаалдан өөрсдийн гэмгүй гэдгийг нотлон эрлээ нэгтгэх тухай дахин дахин ярилаа.  
— За яахав. Заяын гэгээний Донирыг хардаж сөрдэхээ больё гэж Төмөрийн хэлэхэд Донир нүдээ жартайлган ишиг майлж байгаа юм шиг инээснээ.  
— Энэ бүч цогчин жасын юм болохоос миний юм биш. Тэгээд би сахил санваартай гэлэн хүн шүү дээ гэлээ.  
— Гэлэн гуай нарыг ч сайн мэднэ гэж Төмөр ёжтой бөгөөд хэгжүүн хэлэв.  
Удалгүй мухардсан лам нар эрлээ нийлүүлэх тухай Төмөртэй ярьж тохироод явах болоход Төмөр уул бүчийг Хонгорт өгч «За хувуу минь олонтой газар зүүж яв. Сэжигтэй харсан хүнийг ахтайгаа уулзуулж орхиорой» гэлээ.  
Донир дагагсдын хамт явж Хонгор үлдэж хонь гаргуулан дайлуулж хонов.  
— Дүү минь одоо ийм ажил хийсний хэрэггүй гэж орой Хонгорт Төмөр хачин зөөлхөн дуугаар хэлэв.  
— Хиймээр санагдаад байх юм. Тантай жалганд учирснаас хойш сайн эр болохсон гэж бодсон.  
— Цаг өөр болсон. Ах чинь шилийн богд дээр тангараг тавьсан хүн. Гэвч одоо дахиад тийм ажил хийхгүй гэж Хатанбаатарт тангараг өгсөн. Би ноёдтой хүчээ сорьё гэж бодсон хүн. Тэдэнд хэдийгээр хасаг, шорон банз байвч надад эр чадал байгаа болохоор үзэлцье гэж бодсон. Одоо бол тийм биш.

— Шилийн богд дээр яаж тангараг тавьсан юм бэ?

— Шилийн богд гэж Даригангын нутагт байдаг уул. Одоо дээр нь гарч халхын сайн эрсийн нэрийг дуудан тангараг тавиад үүрийн цагаан гэгээ тусахыг морин дээрээс харсан хvн сайн эр болдог гэдэг юм.

— Та тэнд тангараг тавьсан юм уу?

— Тавьсан. Миний дvv ахынхаа vгэнд орж битгий ийм ажил хий.

Хонгор хариу дуугарсангvй. Төмөрийн ярианаас гагцхvv шилийн богдын тухайг vлдээж аваад бусдыг нь анхаарсангvй. Гэвч энэ бодол тvvнийг ямар гашуун эмгэнэлт явдалд хүрэхийг Хонгор одоо хэрхэн бодож чадах билээ.

Маргааш нь гэрийн зvг жолоо даран явахдаа төвд хоргой бvчийг ар руугаа сугсалзуулж хөгжилтэй давхиж байлаа.

Сайхан намрын бvlээн нар өмнөөс нь жигнэн гийгvvлж халхад алдаршсан сайн эр болох өрнvvн бодлын будан манан толгойд эргэлдэн явахад эргэн тойрон юутай сайхан байсан гэж бодно.

XX

Хvрээ рvv бараг хоосон явуулсан хоёр шахам тэргээ Жирэмийн цагаан нуурын арын хатаж эхэлсэн цахилдаг дотор vдлээд байхад нутгаасаа тус бvр хос морьтой гарсан Итгэлт Хонгор хоёр гvйцэж ирлээ.

Утаа болсон жижигхэн хөх майхны гадна хөл нvцэглэн намрын оготор шар наранд тарайн хэвтэж байсан Галсан Итгэлт, Хонгор хоёрыг хараад всрэн босож «Ах дvv хоёр ирлээ. Цай чанаж хоол хийгээрэй» гэж майханд унтаж байсан хөлсний залууг хашгиран сэрээгээд гvйн очиж Итгэлтийг буугаагvй байхад морины нь цулбуурыг барьж авлаа.

— За та хоёр сайн явж байна уу?

— Сайн. Та нар сайн явж байна уу? гэж Итгэлт амандаа огцом хэлээд бууж шууд майхан руу явлаа.

Галсан, Хонгор хоёр морьдын эмээлийг авч чөдөрлөн, тавихад хол замд ядарсан морь шууд л хошуугаа өвсөнд шаав.

Итгэлт яагаад хоосон тэрэг хvрээ рvv энэ намар эрт хөдөлгөв. Юу болов? Ирэх өвөл хийх ганц хvvгийнхээ хуримын юмыг төхөөрөх гэж явуулжээ.

Маргааш өглөө нь хvvгээ дагуулан мордохдоо «Тахилтын амны орчим би хvн тосуулна» гэж Галсанд хэлэв.

Итгэлтэд vlэмж ажил байлаа. Ганц хvvгийнхээ хуримыг нэр төртэй хийе гэж Итгэлт шийдсэн учир авах юм, бэлтгэх зvйл их байсан болохоор хvрээ рvv тусгай тэрэг хөдөлгөжээ. Бас тэгээд буулгах бэр нь олигтой гэж яривал ганц хуучин чисчvv дээл, нарийхан мөнгөн бөгжөөс өөр юмгvй хvн болохоор тvvний бvх юмыг төхөөрөх хэрэгтэй байлаа. Юуны тэргvvнд бэрдээ хоёр алтан бөгж, ээмэг, толгойн хэрэглэл цохиулах, хуримандаа өмсөх дээлийн өнгийг нь авах, мөнгөн эмээл хазаар, тэгэхдээ бvр боржигон хийцтэйг авах гэж бодож явлаа.

Итгэлтийн хvv сайхан хvvхэн авна. Тэр сайхан хvvхнийг ёстой л нvдийг бvlтэртэл гоёно.

Итгэлтийн хvv эхнэр авч хурим хийнэ. Тэр хурим бол Луу гvний гэрлэлтээс илvv байх ёстой гэж бодож байлаа. Тvvгээр ч барахгvй анхандаа хvvдээ хvрээ хийцтэй гэр барьж өгдөг юм уу гэж бодож байсан. Харин сvvлийн вед энэ бодлоо орхисон. Учир нь нvvн суухад дараа болно гэж боджээ. Харин хэдэн сайхан эрээн авдар авах хэрэгтэй байлаа. Сав суулга гэвэл өөрт нь байжээ.

Ер нь тэгээд бvтэн айл төхөөрөх, тэр тусмаа Итгэлт ганц хvvгээ айл болгох гэж төхөөрөх нь

хэцүү ажил. Үүнд Итгэлт тулдаа тайван байна.

Хүрээнд орж ирээд тэр оройдоо баахан архи ууж аваад өглөө эрт босож ажил хөөцөлдөв.

Бодсон бүхэн нь үлгэрийн юм шиг бүтэж удалгуй хорь гаруй тэрэг дүүрэн ачаатай болжээ.

— За Галсан минь хичээж яваарай. Наадах хэдэн тэргэнд чинь хэдэн зуун тэрэгний ачаанаас үнэтэй юм буй. Нөгөөхөө тав сумлаад нүд хамхилгүй явдаг юм шүү гэж ачаа хөдлөхийн өмнө Итгэлт шивэгнэн хэлжээ.

Нөгөөхөө гэж Итгэлт нутгаасаа гарахын өмнө Бадарчаас залуу мориор авсан тавин сумтай япон ланжууг хэлж байгаа юм. Тав, зургаан сум зарж баймаажин Галсанг сумлаж буудаж сургасан нь энэ үнэтэй ачааг манаж хүрээнээс Тамирт хүргүүлэх гэсэн бэлтгэл хийж байж билээ.

— Ах сэтгэлээ бүү зовоо гээд Галсан марсайн инээв.

— Бага нойртой явснаас хүн үхдэггүй юм шүү.

— За ах аа.

— Бид Лүн орчимд гүйцэж очно.

Хөсөг явсан орой Итгэлт айлд архидах болж дөрвөн морио хан уулын аманд идүүлэх ажил Хонгорт оногдов. Үдэш орой дөрвөн морио авч Туул голыг гатлан Чандманийн аманд очиж чөдөрлөн хос хосоор нь хэрж тавиад тохмоо дэвсээд эмээлээ дэрлэн түмэн одтой гүн хөх тэнгэрийг ширтэн хэвтэхэд Хонгорын сэтгэл нэг л сайхан байж билээ.

Шөнө дундаас хойш хүйтэн салхи үлээж эхэлсэн боловч хучсан хоёр одончуу цувыг нь нэвтэлж чадсангүй. Үүр манхайн цайсан хойно сэрж харвал зүүхэнд нь хэрж тавьсан хоёр морины нь цаана нэг хүн унтаж байлаа. Тэр хүнээс хориод алхмын цаана чөдөртэй хар хээр морь идэж байна.

Хонгор босож суниагаад хэрээтэйдээ болж холдож чадаагүй морьдоо ажиглан хэсэг зогссоноо нар гартал тавьж идүүлэхээр шийдэв. Баруун талд нь идэж байсан хоёр морио салгаж тавиад, нөгөө хүний наадах морьдынхоо дэргэд очиж салгав.

Энэ вед нөгөө хүн сэрж өндийн Хонгор руу харлаа. Хонгор ч тэр хүнийг ажиглав. Хараач! Багын найз Бат ажээ.

— Бат аа гэж байдаг хүчээрээ хашгираад түүний зүг гүйв. Нэрээр нь дуудаад ирж яваа хүн бол өөр хэн ч биш Хонгор гэдгийг Бат танилаа.

— Бат минь чи чинь хаа газраас гараад ирэв. Амьд мэнд уулзах юутай сайхан бэ? За золгож орхиё гээд гараа сунгав. Хоёр найз үлэмж дотно золгов. Бат сургуулийн хэрэглэл авах тухай ярих гэж дан морьтой хотод орж ирээд хоёр хоножээ. Өдөр нь ажлаа хөөцөлдөж, шөнө нь морио идүүлдэг байлаа. Найзууд юуны өмнө бие биеийн том болсноо харилцан гайхалцсаны дараа Хонгор Долгорын амьд байгаа тухай Эрдэнэ очиж уулзсан тухай ярив. Гэвч энэ бүхэн Батад сонин зүйл биш болжээ. Тамирын голд айл болсон Төмөрийнд очсон тухайгаа ярилаа. Гэвч ямар хэргээр очсоноо хэлсэнгүй.

Нар гарахын вед тэр хоёр хотын зүг явлаа. Замдаа Хонгор «За өвгөн минь чамаас гуйх нэг юм байна. Аав маргааш гарна гээд байдаг. Чи намайг хэд хоног авч үлд. Аав чамайг гуйвал үгүй гэхгүй. Тэгээд хоёулаа Лүн дээр очоод салъя» гэлээ.

Батад ч Хонгортой хэд хоног хотод байхад сайхан санагдаж Итгэлтээс гуйжээ. Анхандаа зөвшөөрөхгүй байсан авч хоёр залуугийн зэрэг зэрэг гуйлтад тэвчиж чадсангүй.

— Хоёр дамшиг минь дарвиад хэрэг төвөг гаргаж болохгүй. Хоёр гурваас илүү хонож болохгүй. Бат минь наадах чинь амаргүй хүн шүү. За Хонгор чи Лүн дээр битгий удаарай гэлээ.

— Яалаа гэж удах юм бэ гэж Хонгор үлэмж уриалган хэлжээ. Итгэлт хүүдээ хос морь, хорин

мөнгөн янчаан өгөөд нутгийн зүг мордохдоо «Бат аа би чамд л найдаж байна шvv. Түргэн л гарч үзээрэй» гэж билээ.

Итгэлтийг явсаны орой хоёр залуу морьдоо хөлсний идvvлгэнд өгч Хуягийнд очиж Цэндээр хоол хийлгэн идээд ор засуулан зэрэгцэн хэвтэж бараг vvр цайтал шивэгнэн ярилаа.

— Батаа гэж Хонгор хэсэг дуугүй болсноо жуумалзан инээмсэглээд «Өвгөн чинь эхнэр авч хурим хийх гэж байгаа» гэлээ.

— Сайхан хэрэг. Ямар эхнэр авах нь вэ?

— Ням гуайн Сүрэнтэй шvv дээ.

— Тийм vv. Догь хэрэг байна даа. Ням гуай ч намайг баллах шахсан шvv гээд Бат инээв. Батын сэтгэл нэг л хачин болов. Сүрэнгийн нэрийг сонсмогц Солонгын тухай бодогдоод ахаас нь тvvний тухай олон юм асуумаар санагдавч ичих мэт болоод байлаа.

— Өвгөн чинь чамаас гуйх юм байна гэж Хонгор хэлээд Батын гар дээрээс барьж авлаа. Солонгын тухай бодолд дарагдан Бат хариу дуугарч чадсангвй.

— Би цөөхөн хоног энvvхэн зvvн тийшээ явах нэг чухал хэрэг байна.

— Яаж болдог юм бэ? Аав чинь түргэн гар гэсэн шvv дээ.

— Зүгээр өвгөн минь. Би Галсан ахыг нутагт хүрэхээс нь өмнө гvйцээд очиж чадна.

— Чи ямар хэрэгтэй юм бэ?

— Өчvvхэн хэрэг. Чамд сvvлд хэлнэ.

— Солонгын бие сайн уу? гэж Бат тэсэж чадсангвй асуугаад нvvр нь халуу шатан бадайрна.

— Тэр юунд алзах вэ. Аавд загнуулаад л ижийд магтуулаад л явж байдаг. За өвгөн чинь маргааш мордьё.

— Түргэн ирнэ шvv. Сүрэн, Солонго хоёр ч том болчихсон биз дээ.

— Том болсон. Солонго аавын хажуугаар намайг загнах гэдэг юм. Ямаа туйлавч янгиа эвдэхгвй гэдэг л болж байгаа нь тэр.

— Аан тийм vv. Солонго ч айхтар амьтан шvv. Ням гуайн өгсөн балингийн гурил булаалдаж бид хоёр сайн ноцолддог байж билээ гээд Бат баяртай инээмсэглэв.

Тэр шөнө Батын нүдэнд Солонго харагдаад удтал унтаж чадсангвй. Маргааш нь Хонгорыг мордуулж өгөв.

— Чи түргэн ирнэ шvv.

— Тvvнд санаа зовох хэрэггвй гээд дорно зүг хатируулан явлаа. Хэрэв Хонгорын явж байгаа зорилгыг Бат мэдсэн бол тvvнийг явуулахгвй байсан. Хонгор бол Төмөрийн ярианаас сонссон Шилийн Богдын орой дээр гарч тангараг өргөөд vvрийн гэгээг морин дээрээсээ харсан хvн сайн эр болдог гэж сонссоноос хойш тэр гайхамшигт уулын орой дээр гарч үзэхсэн гэдэг бодол Хонгорын сэтгэлд буй болоод эцэст хvсэл, санааг бүрмөсөн эзлэн зовоодог болсон юм.

Баян Итгэлтийн адууны шилдэг хоёр морь Хонгорын довтолгоонд найдвартай унаа болж явлаа. Хонгор хааяа ганц нэг хvнтэй уулзаж «Ювнчир ламхайд мөргөх гэж яваа хvн» гэж элдвийг зохион ярих зуур газрын чигийг асууж авлаа.

— Үертэй Туулын усанд мориноосоо салаад vxэх гэж байхдаа амьд гарвал Ювнчир ламхайд мөргөж шавь орно гэж тангарага барьсан ч нэг мэдэхэд усны эргэ дээр гараад байсан гэж зохион ярихад тохиолдсон айлын авгайчуул сайхан цай чанаж, амттай, нvнжигтэй хоол хийж өгдөг байлаа.

— Алдарт шилийн Богд ойртох тутам Хонгор өдөр явахаа зогсож шөнө явдаг болов. Нэг өдөр хонь хариулж байсан хvvхдээс ярианы завсар Шилийн Богдыг асуусанд «тэртээ харагдаж байгаа өндөр уулыг хэлдэг юм гэнэ билээ» гэж зааж өглөө.

Тэр бол талд ургасан жижиг толгой байв. Хонгор хэдийгээр Шилийн Богдыг жижигхэн толгой гэж сонссон боловч Тамирын өндөр ууланд өссөн түүнд голох сэтгэл төрүүлэв. Бас тэгээд «Шилийн Богд» гэдэг өндөр нэр Хонгорт тодорхой сэтгэгдэлийг буй болгосон байлаа. — Чи худал хэлж байна

— Үгвй. Түүн дээр чинь эр хvн гарвал Шилийн сайн эр болдог юм гэнэ билээ. Би том болоод гарна гэж бодож байгаа. Тагт нь таван зуун адуу оруулчихаад харагддагвй юм гэдэг гэж хоньчин хvнгийн ярьсан Хонгорын сонссонтой яв цав тохирчээ.

Ингээд юу ч гэсэн хvнгийн заасан тэр ууланд очихоор шийдэж, ойрын худаг заалгаж аваад шөнө очиж морьдоо усан, авч гарсан тулмандаа ус хийж аваад өдрийн турш алс тэртээд зэрэглэн хөхөрч харагдсан уулын зvг хурд хуваан давхилаа. Шөнө турш давхиад маргааш нь хvн амьтангвй өргөн талыг нэвтрэн явсаар vдшийн бүрийд хvсэж мөрөөдсөн Шилийн Богдын тагийн хонхорт оржээ.

Мориноос бууж чөдөрлөн тавиад алс хойд зvгийг ширтэн өвдөг нугалан сөхрөн суугаад «эрийн хийморь сэргэсэн Шилийн Богд дуулж бай. Тоорой банди, тогос Чvлтэм, ганган Төгөс, харцага Бор, хvрэл Дампил, хvрмэн Шар, цахиур Төмөр, царцаа Гомбо, хагархай Цэнд, харлаг Дорж холын тэртээ газраас Хонгорын vгийг сонсож бай. Хаяагаа хадрахгвй, харсанаа авахгвй, морины сайнаар холыг гэтэлнэ. Эрийн сайнаар хошууг давна. Сайраг ингэ авахгвй хий. Сайн нөхрөөс урвахгвй хийе» гэж өндөр дуугаар тангарага өргөөд босож богцноосоо чанасан мах гаргаж хэсгийг таслан дөрвөн зvгт өргөж, туламтай уснаас баахан залгилан тохмой дэвсэн, эмээлээ дэрлэн хэвтлээ. Гэвч нойр нь хулжаад удтал унтаж чадсангвй

Тvмэн од дээр нь мяралзан, шарлан хатаж эхэлсэн ногоо ховдоглон зулгааж байгаа морьдын шvдний чимээ шир шир сонсогдоно. Элдвийн өрнvн бодол сэтгэлийг нь эзэлж, хөгжvн бөгөөд баяртай байлаа.

Сэрvнхэн салхи ve ve vлээх боловч дулаан бөгөөд ер бусын тайван, аятай ажээ. vvp цайхын өмнө босож морьдоо барьж мордоод дорно зvгээс цагаан гэрэл манхайн цайхыг харж зогсов. Тэгээд шууд морины амыг зvн хойш нь эргvүлж vдшийн бүрийд нэг худаг дээрээс морьдоо усалж аваад цааш довтолсоор наран гарахын вед нэг толгойн орой дээр гарвал зvн талын хөндийд нь хэдэн зуун адуу бэлчээрлэн идэж байлаа. Тvвнийг ажиглан өдрийг нуугдан өнгөрvүлээд vдэш мордож адуунаас хэдэн сайхан морьд ялган хөөж билээ. Маргаашийн vд өнгөрөх вед Шилийн Богдын оройд ирж нэг зээрд морь барьж унаад зогсолгвй довтлов. Гурван шөнө явсны дараа алгуур аянд орж зургаа дахь хоногийн vд хэлбийх вед хvрээний зvн vзvүр хөлийн модчинд орж ирээд ирэх очихын хэдэн хоног зарснаа бодвол яг арван нэг болжээ. Анх хөөсөн арав гаруй морьдоос хоёр нь эцэж замд хаягджээ.

Хонгорын сэтгэл баяр бахдалын хvчтэй аялгуугаар дуулан олон хоногийн довтолгоог бие яаравч сэтгэл бодол нь тvвнийг огт дагахгвй байлаа.

## XXI

Зуны адаг сарын урт өдөр дуусаж, нар баруун уулын ноён нуруун дээр цацран солонгорч гялалзах бөгөөд өдрийн бөгчим халуун өнгөрч оройн сэрвvн эхэлсэн нь юм бvхнийг тэнэгэр уудам болгожээ.

Суман дэлтэй өндөр зээрд морь унасан Эрдэнэ эмээл дээрээ ялимгвй хэлтгий сууж ямар нэгэн гvн бодолд дарагдан явах бөгөөд морь нь шогших гэхэд сурмаг хөдөлгөөнөөр амыг татаж алхлуулна. Тvвнийг жаргаж байгаа наран доогуур сөрж харахад дөрвөн зvг, найман зовхисоос нь алтан шар гэрэл цацарч сvртэй vзэгдэнэ.

Эрдэнэ, ардын засгийн бүрэн эрхт төлөөлөгч болж гарснаас хойш засгийн бодлого, буй



болон тогтож байгаа шинэ журам, хүмүүсийн хоорондын шинэ харьцааны гүн учир утгыг олон түмэнд ойлгуулах хэрэгтэй гэж бодсон Эрдэнэ яриа таниулгыг очсон газар, уулзсан хүн бүхэндээ хийж байлаа. Гэвч ардын засгийн бодлогыг гуйвуулж гүтгэсэн элдвийн цуурхал яриа олны дотор тарах бөгөөд түүнийг том лам нар, ноёд гаргаж байгаа нь илт боловч чухам тэр тараав гэж буулгах эзэн буцах зам нь олдохгүй. Нэг яриаг дарахад нөгөө яриа дэлгэрнэ. Ер нь л хийж байгаа ажил бүхэнд ил, далд элдвийн саад мундахгүй ажээ. Гэвч ардын засаг довтлон өдөр өнгөрөх тутам газар эзэлж байлаа.

Хамжлага, эрх ямба, угсаа залгамжлан эдлэх ёсыг устгасан тайж нарыг өртөөний алба хийлгэж, албан татвар төлүүлэх болсон зэрэг ардын засгийн шийдвэрүүд нь ард олны сэтгэлд хүрч тэдэнд таашаагдаж байлаа.

Эрдэнийн төрийн ажил бол юу ч л гэсэн удаан боловч урагш давшиж байжээ. Харин амин хувийн амьдрал нь нэг л эвлэрч өгөхгүй ажээ. Хэдэн сарын туршид өөрийн гэх гэр оронгүй ёстой малгай тавибал манайх, маргааш болбол танайх гэж яваад саявтар нэг гэртэй болж Засагт ханы хошуунаас өртөөнд хөөгдөж ирээд тулах модгүй, туух ишиггүй болсон Дампил гэдэг ганц бие эртэй нэгдэж айл болов.

Долгорыг хүлээж ядаад очсон нь хүүтэйгээ уулзахаар хүрээ рүү явчихсан байлаа. Эрдэнэ түүнд баярласан хүүгээ харсан эхийн сэтгэл дэвтэж эцэг рүү нь эргэх болов уу гэж горьдсон. Гэтэл саяхан шиг хүүгээс нь ирсэн захиаг уншихад тэр найдвар тасарсан нь тун тодорхой байлаа.

Эрдэнэ явсаар голын зүлгэн дээр барьсан хоёр гэрийн өмнө босгосон уяан дээр бууж морио уяад баруун гэрийн зүг алхав.

Гадна зуухан дээр хоол чанаж байсан Дампил Эрдэнийг дэргэдээ очиход толгойгоо хагас эргүүлэн «таныг нэг гээгт асуугаад явсан удахгүй буцаж ирэх байх» гэлээ.

— Ямаршуу гээгт байна?

— Хөх шандан дээлтэй, дунд зэргийн насны. Таньдаг айлдаа очоод удахгүй эргэж ирнэ гэсэн. Долгор байх гэсэн бодол чиглэн орж ирснээ зайлав. Учир нь ардын засгийн төлөөний түшмэлтэй уулзахаар ирдэг хүмүүсийг алийг тэр гэх билээ. Тийм хүмүүс өдөр ч, шөнө ч тасрахгүй ирдэг. Том ч юм лавлаж асууж ирдэг, бага ч юм лавлаж асууж ирдэг. Тэдний нэг л байлгүй гэж бодоод гэртээ орлоо.

Гэтэл хоол идэж суутал Долгор орж ирлээ. Холын аянд үл мэдэг борлосон царай, өтгөн хар үс, нас нь тогтож зөөлөрсөн царай цөм ер бусын гуа үзэсгэлэнтэй харагдав. Эрдэнэ Дампил хоёр их л хөл боловч Долгор нэг л хөшүүн, янзгүй ажээ. Хүүтэйгээ уулзаж ирснээ зөвхий, хуурай яриад хэсэг дуугүй сууснаа «би чамтай уулзах гэж ирсний учир бол ... чамд нөхөртэй болохоо хэлэх гэж...» гээд үгээ таслав. Эрдэнэ удтал дуугүй бодол болон сууснаа

— Чи бид хоёр хүүтэй шүү дээ гэлээ.

— Тиймээ хүүтэй. Одоо ч том эр болж дээ. гэж Долгор хэлэв

«Одоо ч том эр болж дээ» гэж нухацтай хэлсэн үгний цаана «чи намайг үсэртэл алгадаад, эргэж харалгүй орхин явахад чинь бид хоёрын дунд үүнээс нялх хүүхэд байсан гэвч чи түүнийг бодолгүй явсан шүү дээ» гэсэн тодорхой өнгө байсныг Эрдэнэ олж сонсов.

— Долгор минь хатуу сэтгэл гаргаснаа би ойлгож, сэтгэлийн хүнд зовлон эдэлсэн шүү дээ.

— Би мунхагаасаа болж буруу хэрэг хийсэн. Чамайг гомдоосон. Чи намайг яаж ч болох байсан. Түүнээс болж миний эдэлсэн зовлонг дайрч гарахгүй бол хэнч ойлгохгүй. Тэгээд одоо би чамд хуучин Долгор чинь биш, чи над хорвоогийн хамгийн үнэтэй хүн гэж бодож явсан Эрдэнэ минь биш болжээ.

— Бүхнийг мартаад шинээр амьдарч болох бишүү?

— Би мартаж чадахгүй. Чи ч хэрэгтэй цагтаа санах л болно. Бид хоёр бие биендээ үнээ алдсан. Дагширсан өвөлжөө боловч хэдэн жил орхиход эдгэрч ногоо ургадаг. Харин хиртсэн сэтгэлийг угааж огт болдоггүй юм байна. Угаах гэж оролдвол хир нь улам тодрох бололтой. Чамайг энэ чинь миний Эрдэнэ шүү дээ гэж бодоход «үгвй биш» гэж гомдсон сэтгэл минь хашгираад байх юм. Би ч Эрдэнээ дахиад олохгүй. Чи ч Долгороо дахиад олохгүй болжээ.

— Би Эрдэнэ биш хэрэг үү?

— Миний сэтгэлд л, миний хуучин Эрдэнэ минь биш

— Чи Содномд сэтгэлтэй болж орхиод ингэж хэлж байна. Тийм үү?

— Хуучин Эрдэнээ бол зуун Содномоос солихгүй байсан. Чамайг бол солино. Содном бол зовлонгийн дунд минь дайралдсан хүн. Намайг хүүтэй уулзаад ирэхэд ижий нь үхлүүд байсан, амьсгалаа хураахын өмнө «хүүд минь сайн хань болоорой» гэж над хэлэхэд нь «за» гэж би хэлсэн. Тэр хүн «хүү минь ханьтай боллоо» гэж бодоод нүдээ аньсандаа

— Чи тэгээд Содномтой суух хэрэг үү?

— Тийм. Содномтой сууна гээд Эрдэнийн нүүр рүү эгц харлаа.

Эрдэнэ «чи минь яах нь тэр вэ? Би чамаасаа салахгүй. Намайг битгий орхиоч дээ» гээд уйлан гуймаар байсан авч сэтгэлээ захиран барилаа. Нэгдүгээрт Долгорын гомдож шийдсэн сэтгэл нь гуйх тусам холдохыг ойлгож байлаа. Хоёрдугаарт нэр төр гэгч бодол нь гуйх, мөргөхийг чанд хориглож байлаа.

Чиний өөрийн дурын хэрэг. Би чамайг Содномтой суухад чинь хорихгүй ээ. Уг нь чи бид хоёр бие биеэ уучлан сайн сайхнаар амьдарч болох л байсан юм.

— Эрдэнэ хагарахдаа бут үсрэн жижигхэн хэсэг болдог учраас эвлүүлэхэд үлэмж хэцүү.

Харин бүдүүн шавар шаазан бол болдог юм шүү гэж бурхан боловч ижий минь хэлдэгсэн. Чи битгий над гомдоорой би ч чамд тэр нэгэн цагт хязгааргүй сэтгэлтэй байсан минь үнэн. Түүнийг чи мэдэх учраас би юу гэхэв ээ.

Долгор тэр оройдоо эргэн явсан бөгөөд хэдэн хоногийн дараа Содномтой суусан билээ.

Эрдэнэ сэтгэл дотроо гаслан гашуудавч гаднаас нь хүчлэн барьсан хатуу савнаас халин гарч чадахгүй байлаа.

Амьдрал гэдэг маш нарийн бөгөөд хэн ч мэдэж тайлаагүй хатуу хууль, өөрийн жамтай байдаг ажээ. Нэг үед Эрдэнэ дассан Долгорын сэтгэл шиг ариун тунгалаг, гүн бат юм байгаагүй, тэр сэтгэлийг их л гэхээс юутай ч жишиж, юугаар ч хэмжиж болохгүй байлаа.

Гэтэл өнөөдөр Эрдэнийг занах, жигшихэд хүрчээ.

Долгор бол амьдралын босгон дээр гараад хаашаа явахаа мэдэхгүй алмайран зогсож байгаа охин биш. Энэ бол хал үзэж халуун чулуу долоон насажсан хүн.

Гэтэл «чи яагаад Эрдэнэдээ дургүй болов» гэвэл түүнд «энэ гээд» товтой хэлэх хариу байсангүй. Үлэмж гомдсоноос болсон хэрэг үү? Эрдэнэ эхлээд царайчлан гуйснаас болов уу? Нэгэнт л өнгөрсөн гэж бодов уу?

Юуч л гэсэн Эрдэнийг хуучин уранхай хувцас гэж үзээд шинэ дээлтэй больё гэж санасан хэрэг биш.

Намрын адаг сар хошуудад сонгууль болж, анхан хошуудыг өөрчлөн байгуулахад хошуу тамгын жасааны даргаар үлдээсэн ноёдыг зайлуулан ард угсаатай хүмүүсийг сонгов. Энэ ажилд Эрдэнэ үлэмж хүч гаргажээ. Ингэж байтал бас нэг том ажил босож иржээ. Их уул хошууны дарга Базар гэгч хүн олноо өргөгдсөний зургадугаар онд хошууны ноён Бээжинд жуулчлан очихдоо хятадын пүүсэнд тавьсан өрийг ардуудаар төлүүлэх тушаал гаргаж дааж давшгүй алба тулгав.

Энэ мэдээг авмагц Эрдэнэ шууд очиж Базарыг огцруулан хошуу даргаар өөр хүнийг тохойн

томилсон бөгөөд ардуудаас хураасан мал хөрөнгийг эздэд нь эргүүлэн өгчээ. Үүний хамт бусад хошуудад урьд хятадын пүвсэнд тавьсан өрийг хэрхэвч төлж болохгүй бөгөөд төлсөн этгээдийг хатуу шийтгэх тухай бичгээр зарлан мэдэгдэв. Гэтэл ерөнхий сайдын орлогч бөгөөд бүх цэргийн жанжин Данзангаас нэг бичиг ирлээ. Тэр бичигт хоёр улсын найрамдлыг эрхэмлэн үзэж урд хошуудаас хятадын пүвсэнд тавьсан өрийг хүүтэй нь хамт хошуу нийтээс гаргуулан төлүүлэхийг тушаасан байлаа. Энэ өрийг төлөх гэвэл сүүлийн хэдэн жилд овоо өсөж байгаа малаа цөмийг нь туучих байсан учир уг бичгийг дарж харин хятадын пүвсэнд тавьсан өр бол хэдхэн ноёд феодалууд өөрсдийн жаргалын төлөө аминдаа хэрэглэсэн мөнгө болохоор ард нийт төлөх ёсгүй гэсэн бичиг хийж Данзанд явуулжээ. Гэтэл Данзан шууд хошуудад хятадын пүвсэнд урьдах өрийг төлөх тухай бичиг явуулсан байлаа. Түүнээс болж зарим хошуудын дарга нар пүвсэнд өгөх өрийг ардуудаар төлүүлэх гэхэд нь Эрдэнэ ардын хурал хийлгүүлэн төлбөр гаргуулах гэсэн хүмүүст хатуу ял зэмлэл тулган заримыг нь торгож билээ.

Пүвсэнд өр төлөх гэсэн Заяын гэгээн, хүрээ хамба мэт хэсэг феодалуудыг намаас хөөж мөн ардын хурал хийлгэн юуны учир тэднийг намаас хөөсөн тухай тайлбарлан зарлажээ.

## XXII

Тамирын хөндийд намар уянгын дуу тасарч өвлийн царгил сэргүүн дуу эхэлсэн нь билээ.

Богино боловч цэлгэр амны эхэнд том бөгөөд тэнүүн дулаан өвөлжөөнд том гэгчийн хонины хашааны дэргэд жижигхэн бор гэр харагдана. Энэ бол Ням гуайх юм.

Яагаад Итгэлтийн гаднаас салдаггүй энэ бор гэр энд ингэж ганцаар байдаг болов? Итгэлттэй эвдэрч хөөгдсөн хэрэг үү? Үгүй тийм биш

— За Ням гуай хурим хийхэд бэр хаяанаасаа мордуулах нэг л тусгүй санагдаад байна. Хоёр гэр зайтай бол дээр мэт. Бас хэд хоногийн дараа бид ураг төрөл болно. Ингэхлээр уул усны ойр нь дээр, ураг төрлийн хол нь дээр гэсэн хуучин үг байдаг. Би таньд сарлагийн хоёр сайн үнээ өгнө. Манайхаас хонь авч хариулбал дуртай сууриа ав гэж Итгэлт хэлсэн билээ.

— Буянаас чинь их л хүртлээ бас тэгээд хүүхнээ өгөхөд инжэнд нь ядаж хэдэн толгой мал өгье гэхэд чи авахгүй юм

— Хэдэн толгой мал өгөөд та хоёр юугаараа амьдрах юм бэ? Би хуримыг бүх ёсоор нь хийнэ. Харин инжинд нь өнчин ишиг ч авахгүй. Би ганц хүүгээ ханьтай болгож байгаа хүн Сүрэнг би гарахаас нь аваад сайн мэднэ. Миний хоовон хард эрдэнэ юм шүү.

— Би чиний ачыг хариулна гэж хэлж чадахгүй харин мартаггүй гэж Ням гуай хэлсэн билээ. Ингээд Итгэлтийн таван зуу гаруй хонийг авч өөрөө хорь гаруй хонь таваас зургаан үхрээ таслан нүүж өөр өвөлжөөнд буусан билээ.

Итгэлт яагаад Ням гуайхныг холдуулан нүүлгэв. Үнэхээр бэрээ холоос мордуулах нь дээр гэж бодоо юу? Үгүй. Төрсөн гэр, эх эцэг нь айл байгаад байвал Сүрэн юм зөөнө. Гэтэл тэр зөөсөн юмыг харахад бага боловч хэдэн жилийг нийлүүлэн бодвол үлэмж их юм болно гэж ойлгожээ. Тэгээд өгсөн ч, авсан ч нэр байхгүй. Харин шууд хоёр үнээ өгөөд нүүлгэвэл би өгсөн нэртэй. Ням авсан нэртэй сална гэж бодов. Энэ бодлоо Должинд ч хэлээгүй ажээ. Бэр мордуулахын өмнөхөн Итгэлт Ням гуайнд ирж зузаан мөнгөн чимэг, ногоон нанжин гахайн гөлөмтэй хүрээ хийцийн эмээл, өнгө бүрийн дөрвөн торгон дээл, сувд шүр шигтгэсэн шармал толгойн хэрэглэл бас бус юм авч ирж өгөөд «бэрийн минь хэрэглэл, явсан замын лус баярлаг» гэжээ

— Иш. Итгэлт минь ёсоороо болбол энэ бүхнийг чинь би л бэлтгэх жамтай шүү дээ.

— Тэр ёсыг ярихгүй. Хишигт гуай аяга тагш юм халааж өгөхгүй юу

— Мангуу золиг чинь мартаж орхижээ гээд Хишигт ор хөлийн авдар хоёрын завсраас

жигжигхэн борвитой хөлдүү архи гаргаж галын дэргэд тавилаа.

— Саяхан хүүхдүүд байсан, одоо ингээд л гэрлэх болж байдаг. Цаг ч мөн хурдан юм даа гээд Итгэлт өөрөө цай хийж уув.

Итгэлт Ням гуай хоёр элдвийг ярилцаж байх зуур Хишигт гуай архи халааж аягалав.

— Охиноо мордуулах гэж байгаа юм гээд амьтан ах дүү авч ирж өгөх л юм. Энэ зөнөг өвгөн нь уучих гээд болдоггүй.

— Өөр юмтай болсон бэ дээ

— Уг нь овоо л юм болж байна

— Маргааш Галсангаар хурган лүү хар архи явуулна. Ууц ч хар халзангаа унагаад авсан гэх шиг билээ дээ.

— Ганц охиндоо юугаа харамлах вэ?

Тээгээд халсан Итгэлт мордохдоо

— Тав хоносны дараах өглөө бэр мордуулна шүү дээ. юм дутвал нэрэлхэлгүй очиж аваарай гээд явжээ.

Баян Итгэлтийн хүүгийн хурим болно гэдэг нь Бадарчынхаас бусдыг баярлуулж байлаа.

Нэгэнт энэ явдалд саад хийж чадахгүйгээ мэдсэн Должин ч ганц хүүгийнхээ хуриманд өдөр шөнөгүй бэлтгэнэ.

Итгэлтийн хотонд өчүүхэн ч хар ноос ороогүй цагаан эсгий бүрээс, сарлагийн савгаар хийсэн хар хошлонтой таван ханатай цоо шинэ цагаан гэр бослоо. Энэ гэрт чагтаганаас нь уясан хадгаас бусад нь цөм шинэ ажээ.

— Энэ гэрийг мөн тааруулж чаджээ гэж барьж байсан нэг хүн хэлэхэд Итгэлт ганц хүүдээ барьж байгаа гэр шүү дээ гэж өөр нэг хүн хариулжээ.

Бэр мордуулахын урьд орой Итгэлтийнд өндөр цээжтэй ханхар бор морь хөтөлж, нарийхан хүрэн морь унасан Төмөр ирлээ. Төмөрийн Хонгор биеэр очиж урьснаар хуриманд оролцох гэж ирж байгаа нь энэ бөгөөд бас Сүрэнтэй жил таарсан болохоор дүүрч ирэх албанд оногджээ.

Дулмаа ч уригдсан. Гэвч «Би Итгэлтийнд очих нь битгий хэл харахыг хүсэхгүй» гээд яваагүй.

— Би ганцаараа явахгүй гэж Төмөрийн хэлэхэд «Чи бол өөр хэрэг. Хонгорыгоо бодоод оч. Хонгор чамд туслаагүй, чи Бадарчийн гарт дахин орсон бол би өдийд ингэж жаргал явахгүй байсан юм шүү. Миний өвгөн оч» гэж Дулмаа хэлжээ.

Харин уригдсан эрхэм зочдоос нэг хүн ирж чадахгүй байсан нь хүрээ рүү албаны хэргээр явсан ардын засгийн төлөөний түшмэл Эрдэнэ байлаа.

Маргааш бэр мордуулах болоход охины талын бэргэн ирж Нямынд хонов. «Хүү минь эрт гарна гэдэг эм хүний заяа. Гутарч гуниж болохгүй» гэж тэр эмэгтэй Сүрэнг сургана.

Сүрэн албаар богтлогдож байгаа биш. Хорвоо дээр ганц сэтгэлтэй хүндээ очих гэж байгаа хүн. Хонгорыг баян тарган хүний ганц хүү гэж Сүрэн сэтгэлтэй болоогүй. Түүнийг мод барьсан гуйлгачин байсан ч түүний суух нь Сүрэнд дээдийн жаргал байсан юм. Энэ учраас Сүрэнгийн сэтгэл баярлаж байлаа. Гэвч төрж өссөн гэрээс холдож айлд үүрд очино. Эцэг эхээсээ сална гэж бодоход нэг л хачин байлаа.

— Хэдий сэтгэлтэй боловч гэрээсээ явахад уйлдаг юм гэдэг шүү гэж Хишигт гуай уйлан байж охиндоо хэлнэ.

Ням гуайн бор гэрт хэдийгээр салахын гунигт агаар байсан нь үнэн авч бүхэлдээ баяр хөөр, хөл үймээн болж байжээ.

Өглөөний нар гарахын үед Итгэлтийн гаднаас бэр мордуулах хүмүүс хөдлөх болоход Төмөр

ирсэн бор мориныхоо цулбуурыг Хонгорт өгч «Ах нь цулбуураа одоо өгч орхиё, унаад яв наадах чинь жороо ч хурдан ч морь биш. Гэхдээ эр хүнийг явгалалгвй, зорьсон газарт нь хүргэж чадна» гэж хэлэв.

Энэ бүхнийг харж байсан Итгэлт үлэмж баярлан «vvнээс илvv бэлэгтэй юм гэж байх вэ. Эр хүнд морь. Тэгэхдээ ийм эрийн гараас шvv. Аль вэ. Галсан чи хvvгийн эмээлийг тохож орхи» гэжээ.

Эр хүний нүдийг булаасан энэ ханхар бор морь ёстой л аргамаг хвлэг байж билээ. Хожим энэ морь Хонгорыг олон удаа аварч баярлуулсан. Бас Хонгорт хүнд балаг тарьсан юм. Гэвч өнөөдрийн хувьд нэг морины тухай урьдаж хэн таах билээ.

Төмөр, Хонгор хоёр арваад морьтой хүний хамт Нямын өвөлжөөний зvг хөдлөв. Тэдний хамт ганц эхнэр хүн явсан нь хvvгийн талын бэргэн байлаа.

Хурган дотортой хар хөх чисчvv дээл дээр ногоон дурдан бvс ороож хэт хутга зvvж буу vүрсэн Хонгорын царай үл мэдэг улайвч сэтгэлийн доторхи хэмжээлшгвй баяр нь хэн бүхэнд тодорхой ажээ.

Эдний хамт яваа хижээл эр очоод юу хэлэх, яаж байхыг Хонгорт дахин дахин ярьж байлаа.

Гэрийн гадна очиход багана барьсан хүн ирж «урьсан зочин байхгвй сан. Хуран ирэх нь юу вэ» гээд цохих гэж байгаа дүрс vзvvлэн хөөнө.

— Урьж биднийг дуудаагвй ч, хуран ирэхийн учир буй. Угтаж авахын оронд хөөхийн учир юун бэ? гэж хамт ирсэн хижээл эр хариулаад бүх хvmvvc бууж морьдоо уялаа.

Гэрт ороход гоёлоо өмсөж нvvр рvvгээ алчуур унжуулсан Сvrэн зvvн орон дээр бууж байлаа.

Хонгор орж бурханд хадаг тавиад суухад нь аяга дvvрэн цай хийж өгөхөд амсан тавилаа.

Шагай нь хөндөгдсөн шаант өгөхөд тvvнийг мултаж орхив.

Сvrэн нvvр рvv нь унжуулсан нимгэн даавууны цаанаас мэнчийж улайн, хижээл эрийн заавраар ёс бүхнийг сандран гvйцэтгэж байгаа Хонгорыг харан инээд нь хүрэн тvvнээ барих гэж гуяа сэм базлан хэлнийхээ vзvvрийг хазаж байлаа. Ингээд найр эхэлж нэрмэл архи, хар архитай хольсон хvmvvcийн царай удалгвй улаан зээрд болцгоон заримын нь хэл ээдрээд ирлээ.

— Авах хүнээ аваад буцах газраа буцъя гэж тогтоосон цаг болоход хижээл эр босож хэлэв.

Хvmvvc гарч морьдоо уяанаас тайлж авлаа. Хонгор ч гэр дээр тавьсан бугаа авч vүрээд бор мориндоо мордов.

Төмөр эмээлийнхээ хойгуур сууж гэрийн vүд чиглvvлэн дэвссэн цагаан эсгийн vзvvрт зогсов.

Yүд сөхөгдөж нvvр рvv нь алчуур унжуулсан Сvrэнг хvv, хvvхний талын хоёр бэргэн сугадан цагаан эсгий дээгvvр хөтөлж ирээд Төмөрийн эмээл дээр мордуулав.

Хишигт гуай енгэнэтэл уйлж гарахад төрж өссөн vүрээсээ нисэн холдохын гуниг Сvrэнгийн сэтгэлийг базан авч нүднээс нь өөрийн эрхгвй нулимс дуслав. Энэ бол сэтгэлтэй хүнтэйгээ амьдралаа холбох гэж байгаа Сvrэн шvv дээ.

Хэдэн арван эмэгтэйчvvд албын хүчээр чирэгдэн сэтгэлгвй хүнд богтлуулан очиж байхдаа хашгиран уйлж, тийчлэн тэмцэлдэж байхыг харж зvрх шимшрэн байсан хvmvvc энд олон байлаа. Тэр хvmvvcт Сvrэнг мордуулах нь баяр баясгалан байсныг хэлэх юун билээ. Ийм ч учраас хижээл наст эр мориндоо мордоод бүх бэрс ийм байх болтугай гэж дотроо залбиран ерөөв. Ням гуай Сvrэнгийн эмээлтэй морийг хөтлөн ирж нэг хүнд өгөхөд өөр нэг хүн том ширэн богцтой юм авчирч эмээл дээгvvр тавилаа. Энэ бол Сvrэнгийн дээл хувцас зэрэг нь байжээ.

Цуваа аажим бөгөөд эрхэмсгээр гэлдэрсээр явж Итгэлтийн гадна ирэхэд vүднээс уяа хүртэл ахрын цагаан эсгий хоёр велэн дэвсчээ.

Хонгор, хижээл насны эрийн хамт явсаар үүдэнд хвлээж байсан Галсанд буугаа өгөөд орлоо. Хойноос нь хоёр бэргэнд хөтлүүлсэн Сүрэн оржээ. Гэрт үлэмж дөлтэй ил гал түлжээ. Түүний дэргэд Сүрэнг суулган хажууд нь халбага дүрсэн том хувинтай хайлмал шар тос тавин бэр галд мөргүүлэх ёслол эхлэхэд тос орсон гал шажигнан дүрэлзэж сүртэй бөгөөд эрхэмсэг ажээ.

Энэ их найр сунжирч эндээс ухаантай гарсан хүн цөөн.

— Ниссэн шувуу эргэдэг, ирсэн зочин харьдаг. Хуримласан залуучууд нойрсох болов гэж нэг хүн хэлэхэд ухаан орсон Ням гуай гэрээс гарч харвал мичид марал баруунаа хэлбийсэн байлаа.

Маргааш нь дахин найр үргэлжилсэн бөгөөд хэд хоног үргэлжилснийг тоолох сүүхээтэй хүмүүс ховор байжээ.

### XXIII

Тамирын голын хөндий, урьд Пүрэв тайжийнх нутаглаж байсан хивс шиг сайхан зүлгэн дээр хэдэн гэр харагдана. Гэрээс зүүн урагш хэдэн морьд сойсон зэл уяа, түүнээс зүүн тийш арваад унага барьсан зэл байлаа.

Зуны дунд сарын сүүлийн цэнхэр тэнгэр, хурц нар газар дэлхийг ивээж, ногооны уур дүүрсэн хөндий зэрэглээтэн жирвэлзэн харагдана. Уул ус, ургамал, билчиж байгаа мал, гэрийн тооноор гарч байгаа утаа цөм ер бусын эрхэмсэг ажээ. Иймэрхүү өдөр Тамирын хөндийд байгалийн гуа бүхэн цуглараад аль нь сайхан бэ гэдгийг олох гэж тэмцэлдэж байгаа юм шиг байдаг билээ.

Морины уяаны дэргэд гурван хүн тамхи татан ярилцана. Түүний нэг нь Төмөр, нөгөө нь Өлзий, гурав дахь нь тогоо нэрсэн айлын гадуур өнгөрдөггүй, морь уясан уяаны дэргэд бууж халхын хурдан морины тухай хэдэн домог давслан ярилгүй явбал амны хишигт буу гэж үздэг нодгор буурал гээгтэй Өлзийн насны хоёр хүн байлаа.

Төмөр Хатанбаатарын шагнасан мөнгөөр хөл хийж хоёр азарга шахам адуу, хэдэн үнээтэй болоод Дулмаагийн хүсдэгээр Тамирын голын хөндийд Төмөрийнх гэдэг айл буй болжээ. Төмөрийхтэй үргэлж хамт явдаг айл бол Өлзийнх юм.

Хуяг өнгөрсөн намар ирж эхнэр хүүхдээ аваад явжээ. Эцгээ авч явъя гэхэд нь «танай тэр хүрээнд хаан болсноос Тамирын голд жараахай байсан нь дээр» гээд явсангүй учир Төмөр, Дулмаа хоёрын хаяа сахиж хэдэн малаа маллана.

Дулмаа хоёр гэрийн тогоо шанаганы ажлыг хийх бөгөөд Төмөр гадуур ажлыг хийдэг болохоор Өлзий гуайд аяга тагш юм эргүүлэх, тугал бяруу буцаахаас өөр ажил бараг л байдаггүй ажээ.

— Алаг морь чинь түмний эхийн хээр алаг шиг өнгөтэй байна гэж буурал гээгт их л мэдэмгий хэлэв.

— Түмний эхийн хээр алаг гэж ямар морь байсан юм бэ? гэж Өлзий сонирхон асуужээ.

— Та үзсэн үү?

— Олон хүнээс сонссон. Тавих өглөөгөө уяан дээрээ унтаад л байдаг юм гэнэ билээ. Чиний алаг энэ жил шувууг ч урдаа гаргахгүй байх даа.

— Морь таньдаг хүний морь л түрүүлдэг юм бол миний хүүгийн алаг ирэх л ёстой гэж Өлзий хэлэв.

— Би таньж юу базаах вэ дээ.

— Тархан вангийн бүдүүн Со гэдэг хүн гурван зуу гаруй морь мордоход айргийн таван морийг алдалгүй зааж байсан юм гэнэ билээ.

Тэр гурав босож Төмөрийн гэрийн зүг хурдан сайн морь, мэргэн сайн уяачийн тухай ярьсаар

явлаа.

Гэрт ороход Төмөрийн хvv Бадрах, зvvн орон дээр инээмсэглэн нойрсож байгааг хараад эцэг очиж магнай дээр нь vнссэнээ «эр хvн дээ хөө» гэхэд нь нvvрэнд нь хэмжээлшгvй жаргал бялхан оволзоно.

Гэрийн сvvдэрт суун наадмынхаа дээлийг оёж байсан Дулмаа орж ирээд тулган дээр загсааж байсан тогоотой сvvгээ гаргах гэхэд нь «өвгөн нь аваад тавьчихъя» гээд Төмөр бариул авч эрэгнэгийн тавиур дээр тавив.

Тэр гурвын өмнө Дулмаа модон хувинтай шуугиж буцалсан айраг тавьж өглөө.

Зvvн хойд талын авдар дээр эхнэр хvний толгойн vс харагдана.

— Манай Дулмаа наадамд бэлхэн болоод байх шив дээ гэж Өлзий баяр баясгалантай хэлэв.

Цаад жил Дулмаа эхнэр болно гэж байгаад жил нэгтэй гэж Өлзийгөөр vсээ хагалуулан эхнэр болсноос хойш эр эм хоёр Өлзийг аав гэдэг болжээ.

— Одоо цаг тэр аргалын эвэр шиг данхайсан хvнд юмаар яах нь гэж Төмөр хориглоход «Тамирын голд жаргалтай эхнэр нэг нэмэгдэг» гэж Дулмаа хариулсан.

Төмөр эхнэрийнхээ хvсэлд саад болсонгvй бөгөөд Дулмаад эхнэр vс зохисон нь хэлэхийн аргагvй. Дулмаагийн эхнэр болсны найраас буцаж явсан нэг хvн

— Тэнгэрийн дагина гэдэг хvн л ийм байдаг байх даа гэхэд нь нөгөө нь дагиныг vзсэн биш дээ. Зvгээр Төмөрийн эхнэр ч эхнэр юм аа. Сайхан эхнэрийг хараад лус баярладаг юм шvv. Манай голд өлзий болог гэж билээ.

Дулмаа эхнэр болсноос хойш Төмөрийн гэрт ертөнцийн хоёрдугаар нар мандаж хvv гарсанд Бадрах гэж нэр өгсөн нь одоо хоёр нас хvрч байгаа ажээ.

Төмөрийнх тавь орчим малтай бөгөөд өдөр бvхэн хvvдээ нэрлэж өгсөөр байгаад бvгдийг Бадрахын нэртэй болгожээ. Эцэг, эх Өлзий гурвын хайр дээр бөмбөрсөн Бадрах хvvгийн эрхийг ярихын ч хэрэггvй бөгөөд Төмөр, Өлзий хоёр модоор зорж өгсөн элдвийн амьтны эв хав муутай дvрсийг хаялгvй цуглуулан байсан бол хан өндрийн лам нарын хашаанд байдаг тvлээнээс дутахгvй мод болох байсан байх аа.

Төмөр, Дулмаа хоёр хvссэн жаргалаа эдэлж гэр дvvрэн баяр, сэтгэл дvvрэн хөөр байлаа.

Тэр орой Төмөрийн хот наадамд явах найр хийлээ. Айраг, архи ээлжлэн сөгнөж дуу шуугиан болоход Төмөр «Эрдэнэ засгийн унага» аа дуулж билээ.

Найранд хураасан айраг дуусахад нилээд согтсон Өлзий «гvv билчээрт хvрэхэд айраг исдэг юм» гэж саам хийсэн хөхvүртэй айргаа ууж найр тарахын вед дөнгөж хөрөнгөтэй vлдэв.

Тэр орой Төмөрийнд ирсэн бvхэн айргийн сайхныг ам дvvрэн ил магтаж, Дулмаагийн сайхныг дотроо нуун гайхан байж билээ. Дvvрэн жаргал нь гэрэлтэн бадарсан сайхан хvн гэдэг юутай гуа байдаг юм бэ.

Төмөр өглөө эрт босож Дулмаагийн унадаг жороо зээрд морины дэлийг засаж, чихний нь vсийг тэгшлэн, эрvvний сахлыг хайчлаад, мөнгөн тоног, ясан хяртай, боржигон хийцтэй эмээл тохоод уяанаас нь уяхад нь «зээрд морь ч согоо шиг байна даа» гэж Өлзий хэлэв.

Төмөр ханцуйгаараа зоогий нь арчих зуур «Дулмаагийн минь морь муухай байж болохгvй» гэж дотроо бодлоо. Дулмаа ч өглөөнөөс эхлэн гоёв. Хөх торгон дээлтэй элгэн хvрэн ууж өмсөж нарийхан боловч цэвэрхэн хийсэн мөнгөн хэрэглэлтэй эхнэр vс тавиад шагай дээрээ дугуй хээтэй, булигаар гутал өшиглөөд зогсож байгаа Дулмаа бол харсан эр хvн бvхний хийморь сэргэж, эхнэр хvний атаархах сэтгэлийг аргагvй хөдөлгөх болжээ.

Өлзий, Бадрах хоёр гэртээ vлдэж, Төмөр уясан морьдоо хөтлөн Дулмаа, морь унуулах гэж саахалтаас авчирсан жаал хvv хоёроо дагуулан наадмын зvг явах болов.

Эхнэр хувцсаа өмссөн Дулмааг гарч ирэхэд эмээлтэй зээрд морийг хөтлөн ирж явсан Төмөр

зогсов. Түүний царайнаа баяр, жаргал, үлэмжийн хайрын гэрэл цацарч дүрлэгэр хар нүд нь бахдалаар дүүрэн цавчилна.

Төмөр эхнэрээ сугадан мордуулах гэхэд нь «өвгөн минь зүгээр. Би өөрөө» гээд Дулмаа цулбуурыг авах гэхэд нь «хэл мэдэхгүй адгуус. Яаж ч магад» гэж өргөн мордуулав. Хан өндрийн хүрээний өмнөх зүлгэн дээр өдий төдий янз бүрийн майхан барьж, дэлийг засаж хэд хоног сойсон морьд унасан, хурц өнгийн дээлтэй олон зуун хүн сүлжилдэх нь уулын цэцэгтэй адил ажээ.

Наадамчин олны дунд Луу гүний Бадарч ногт ганзагалж ирсэн гэдэг үг нэгээс нөгөөд дамжин тарж Хан өндрийнхний хорыг буцалгана. Үнэхээр ч бардам Бадарч наадамд түрүүлж байд өгөх их насны морийг нь авна гэж бүдүүн суран ногт ганзагалж ирсэн ажээ.

Сайд вангийн хошуу бол хэзээнээс шөрмөстөй бөхчүүд олонтой билээ. Гэвч долоон хошууны заан догшин Бадарчид наадмаа алдах бий гэдэг бодол нутгийн олны сэтгэлийг зовооно. Наадмаа харийн хүнд алдана гэдэг муухай. Бас тэгээд хамгийн тусгвй нь халуун хошуутай малаа байд өгч харийн хошуунд явуулна гэсэн үг билээ. Энэ бүхэн ч гайгвй. Харин бүхэл хошууг доромжилж ногт ганзагалж ирсэн Бадарчийн бардам зан «хэдэн банди нарыг нь нясалж орхиод, өгсөн морийг нь хөтлөөд шогшдог хэрэг ээ» гэж хэлсэн үг нутгийн олны чихийг доргиулж хор шарыг нь буцалгаж байлаа.

Бадарчийн энэ яриа Төмөрийн чихэнд хүрч түүний сэтгэлийг ч хөдөлгөв. «Ирээд хүн шиг л барилдаж, хүчээ үзэхгвй. Бүх л хошуу доромжилно гэнээ. Задарсан золиг» гэж бодон зэвүү хүрч билээ.

Их насны морио мордуулж орхиод, бөхийн бичээч ирээд ирж нэрээ бичүүллэв. Гэтэл өмсөх зодог байсангвй. Майханд байгаа хүний зодог хэрэглэлийг гуйгаад таарч багтах юм олодохгвй ядаж байсан Төмөрийн дэргэд нэг даваад ирсэн Бадарч зодогоо тайлж «миний хэрэглэлийг өмс. Эр хүний биеийг хучих хэрэглэл. Сайд вангийн байхгвй» гэлээ.

Хошуу нь том, эр нь олон юм байна болох байх наадах зодог чинь хэрэггвй. Хүний хонгоны цус үсэрсэн эд байлгвй дээ гэж Төмөрийг хэгжүүн хэлэхэд Бадарч зад ширвэж далаа хөдөлгөөд явжээ.

Бардам Бадарчид хэлсэн Төмөрийн хатуу хариу тэр дороо олны хүртээл болж нутгийн олны хайр талархал Төмөрийн зүг эргэж билээ.

Долоон хошуу даншигийн арслан, одоо дал гарсан нэг цуут бөх хуучирч энд тэндээ ухагдсан боловч хэрэглэж бүрэн болох хөх чисчүү хэрэглэлээ Төмөрт авчирч өгсөн нь яг таарав. Төмөрийн их насны морь нь арван нэгд давхиж, харин хязаалан алаг үрээ нь түрүүлэв. Төмөр тавын даваанд бэлтгэж байлаа.

— Та намайг Луу гүний Бадарчтай барилдуулж өгөхийг бодоорой гэж Төмөр бөхийн бичээч годгор гээгтэй хар хүнд хэлэв.

— Хар бардам чинь даншигийн заан болохоор амарчилж аваад болохгвй байна. Та чинь ямар цолтой вэ? гэж тэр хүн хулсан бийрээ гарын салаандаа эргүүлэн асуув.

— Урьд хошуундаа начин болсон. Өөр цолгвй.

Төмөр багадаа хүүхэд багачуудтай барилдаж байсныг аль тэр гэх билээ. Арван долоон насандаа Засаг ханы хошуу наадамд барилдаж начин болсон. Түүнээс хойш шилийн сайн эр болоод наадамд ноцолдохоо больсон бөгөөд барилдах ч дургвй байлаа. Гагцхүү энэ удаа хуучин танил Бадарчийн дээрэнгвй аашинд зэвүүн нь хүрсэн учир ингэж барилдаж байгаа ажээ.

Явсаар байгаад нутгийн нэг бөх Төмөр, Бадарч гурав үлдэхэд нутгийн бөх хий мөргөж, Төмөрөөс зайлан байсан Бадарч аргагвй тунаран учрах болов.



Төмөр мэхээр гавихгвй. Барилдалгаа муутай Бадарч хэдий нь ажиглаж мэдсэн болов түүний тэнхээ сарлагийн бухтай адил тул хэлсэн үг бардам ам нь салхинд хийсэх болсонд сандрав. Аманд хувчвнд хурдалж ирсэн даагаа буулгаж аваад хусаж байхад Бадарч дэргэд нь ирж «өвгөн чинь ам гарсан хвн. Чамаас өнгөрвөл цаадах мууг чинь хэд л бол хэд. Чи над бууж аль хоёр залуу морь өгье» гэж шивэгнэв.

— Дэмий битгий ярь. Чадлаа мэдэхгвй байж бvхэл хошуунд юунд ам гарсан юм бэ?

— Чамд ам гараагвй. Чи бид хоёр эр хвн шvv дээ.

— Тэр тусмаа үзнэ дээ гээд Төмөр том цагаан шvдээ яралзуулан инээв.

Бадарчийн хор шар нь туйлдаа хvрч эргэн явлаа.

— Миний өвгөн, энэ Бадарч муухай амьтан шvv. Мэх гэдэг нь айхтар юм гэдэг. Ямар ч хорлогчин юм хийж магад. Яана даа гэж Дулмаа сандран хэлэхэд хэлэхэд Төмөр тайван бөгөөд баяртай инээмсэглэж «чи л миний нvдэнд харагдаж байгаарай, гайгвй» гэлээ.

Бадарч тэндээс Хан-өндрийн хvрээний гvрэмч хараалч гэж нэрд гарсан нэг ламынд очиж урт хадаг барьж Төмөрт хараал хийж, өөрийг нь тvрvvлж өгөхийг гуйгаад, «тэр нохойг газардуулж өгвөл лам гуай танд залуу морь барина» гэжээ.

— Би энэ хошууны албат шvv дээ гээд лам намбатай залбирав.

— Хоёр залуу морь барина.

— Таньдаг хvний нvвр халуун юм даа. Харин Төмөрт хараал хийж өгсөн гэдгийг манай хошууныхан мэдвэл намайг үзэхээ болино шvv.

— Түүнийг би сайн мэднэ гээд Бадарч явжээ.

Төмөр бол засагт ханы цахиур Төмөр гэдгийн лам сайн мэднэ. Гэвч долоон хошуу даншигийн заан, хазахаас бусад мэх хийдэг наадмын талбай дээр нэр нь огт гараагвй Төмөрийг лав хаяна биз гэж итгэж байлаа.

Наадамчин олны бvх анхаарал шаван зогссон хоёр бөхийн зvг шилжиж нутгийнхан өөрийн энэ хошууны харьяат болсон Төмөрийн төлөө сэтгэл нь зовж байлаа. Сэтгэл нь зовохын учир бол Бадарч сvрхий бөх гэдгийг мэднэ. Харин Төмөр сайн эр гэдгийг мэдэвч сайн бөх гэдгийг хэн ч мэдэхгвй.

— Хан өндөр уулын хошууны... гээд засуул нь Төмөрийн цолыг дуудаж эхлэхэд эв муухантай шаван дэлж байх зуураа олны дунд зогсон сандарч байгаа Дулмааг хараад нvдээрээ инээв.

— Төмөр ч сайхан эр юм аа. Гэвч тэр Бадарчийн мэх даанч хэцvv дээ.

— Төмөр ойчвол ч энэ Бадарч тvрvvлж, хошуу нутгаараа муухай доромжлуулж дээ.

— Манай хошуу ч азтай л сан гэх зэрэг яриа олны дотор дамжиж байлаа.

Бадарчийн нvвр барайн, шvд нь тачигнан хийх мэхээ бясалгана. Энэ хvнд барилдалгааны олон арга буй. Зориг зvрх муутай эрд арслангийн сvр үзvvлж мохоо болгож чадна. Хор шартай эрийг vмхий vгээр утаж байгаад ухаан салбаагий нь бусниулж чадна.

Төмөрийг сvрдvvлж чадахгвй гэдгийг Бадарч сайн мэдэж байсан тул энэ аргыг хэрэглэхгвй байлаа. Бас хор шарыг нь хусаад уужим тайван Төмөрийн ухаан самбааг салгаж чадахгвйг ойлгожээ. Харин гэнэдvvлж байгаад шийдсэн мэх хийх нь Төмөрийг унагаах ганц арга гэж бодов. Гэхдээ ламын хараал ямар нэгэн тэмдэг өгөх байх гэж бодон хвлээнэ.

Төмөр нэг хэсэг барьж авах гэж оролдоход Бадарч зайлаад байлаа.

— Заан заагаад өгнө. Битгий яар хvv минь гэж сайд вангийн хашир буурал чоно гэж долоон хошуу даншигт нэр гарсан Төмөрийн засуул өвгөн зогсоо жолоогвй хэлж байлаа.

Гол асарын өмнөөс боссон жижигхэн хуй эргэлдсээр ойртон ирэхийг нь нvдний булангаар ажиж ламын хараалын тэмдэг гэж итгэсэн Бадарч хуйг ирмэгц атгаж байсан шороогоо

Төмөрийн нүд рvv цацаад шийдэн орж баруун хөлд нь дархан дотуур дэгээгээ ороож гэдрэг нь дарах гэж бvх хvчээ зvvн талдаа өглөө.

Зvvн нүдэнд нь нунтаг шорооны ширхэг орсноос өрөөсөн нүдээ аньсан Төмөр баруун гараараа Бадарчийн тохой руу хvчтэй алгадаж, бvх биеэрээ тvлхэж орхисонд Бадарчийн дэгээ ороосон хөл нь махиралдсан чигээрээ мултарч шургачин урагш унахдаа баруун гараараа газар тулж авлаа.

— Бөгс рvv нь алгадаад, баруун хөлий нь торго гэж өвгөн засуулч байдаг хvчээрээ хашгирахад Төмөр бvгдийг ёсчлон хийвэл Бадарчийн урт бие тvрvv урагшаа харан газар тэвэрч гулдайв.

Наадамчин олон хашгиралдан баярлаж «бардам амт, шороо vmхэж байна», «Болж хар барам», «Өөдгvй амьтан. Ингэх л ёстой байсан» гэлцэв.

Бадарч босоод Төмөрт буултаа өгөхдөө дотроо «гуйлгачинд гvйж орхидог байжээ. Хар бадарчингаас болж гоомой юм хийлээ» гэж шvд зуун зvхэж байлаа.

Энэ наадамд Төмөр тvрvvлж, бах нь ханасан олон Бадарчийг илд далд инээлдэв.

Yvнээс хойш Төмөр Сайд вангийн хошууны олон тvмний хайр талархлыг татаж хvндтэй хvний нэг болжээ.

#### XXIV

Намрын нэгэн зэврvvн өдөр билээ. Өглөөнөөс эхлэн хvйтэн салхи сэржигнэн vлээж нэг л ёозгvй байлаа. Урин цаг сан бол хvн ийм өдрийг тоохгvй байсан. Гэвч харьж байгаа ve болохоор «За даа хvйтрэх нь ээ» гэсэн бодол төө vстэй нэхий дээл хэд хэдтэй хvний дотор ч зvсэн орно.

Ёлтгор нар ёлойж гудамж зэлvvд болсон орой Заяын хvрээний шивтэр vнэртсэн гудамжаар хоёр хvн зэрэгцэн хөгжилтэй ярилцаж, хаяа хаяа чанга инээн алхана.

Нэг нь хvрэн тэрмэн дээл дээгvvр тvвд гяраг бvслээд жижигхэн цэмбэн шовгор vл мэдэг хазгай тавьжээ. Нөгөө нь захан дээрээ гурван дөрвөлжин улаан тэмдэгтэй хөх петлиз хадсан урт саарал шинель өмсөж нилээд өндөр өсгийтэй хар савхин гутал гялалзуулан баруун ташаандаа хvрэн гэртэй цагаан буу зvvжээ. Yvний лам нь Цамба дарга нь Жамбал ажээ. Жамбал хэдэн цэргийн хамт баруун хязгаар орохоор яваа бөгөөд Заяын хvрээн дээр ирээд хуучин найз Цамбатайгаа уулзаж хэдэн өдрийн турш архи айраг хvvхэн эргvvлэн жаргаж байгаа ажээ.

Явах замдаа хошуудаас баруун хязгаарын цэрэгт зориулан зуун агт морьд худалдан авах vvрэг аваад улсын мянга гаруй янчаан авч яваа юм. Гэтэл наргиандаа ташуураад тvvнээс нилээдийг зарсан нь эрvvл байхад сэтгэлийг нь тамлан зовооно.

Гэтэл өнөөдөр Жамбалын энэ хэргээс ямар ч ял зэмлэлгvй мултрах гаргах аргыг Цамба олжээ. Азхvv байвал ёоз хvvгээр цохино гэгчээр Бадарчтай тохиолдож Жамбалд тохиолдсон явдлыг ярьсанд «би тавь орчим морьдыг гурав гурван янчаанаар олж өгье. Харин шагналд нь зуун янчаан өгнө биз» гэлээ.

Жамбал нэг морь дунджаар арван янчаанаар дvйж авахаар санаас мөнгө авсныг Цамба мэднэ. Гэтэл моринд нь гурав, шагналд нь хоёр нийт таван янчаанаар авна гэдэг бол vнэхээр догь хэрэг мөн.

— Сайн морьд шvv дээ.

— Шилдэг морьд.

— Ийм хямд морьд яаж олох нь вэ?

— Яаж олох нь миний хэрэг. Харин Жамбал та хоёр хэнд ч ам алдаж болохгvй шvv.

— Тэр болно.

— Морьдыг чинь Жамьян вангийн нутаг өнгөрүүлж өгнө. Дэнчингээ урьдаж авна. Морьдоо тушаагаад бусад мөнгөө авна.

— Тэр ч болно.

— За ингэж тохирвол өнөө орой Да чавганцынд ороорой. Тэнд та хоёрыг нэг хвнтэй танилцуулж өгнө гэж Бадарч хэлсэн юм.

Бадарч ийм хямдхан морьдыг хаанаас, хэрхэн олох хвн бэ? тавин сайн морь олно гэдэг тавин атга шороо олохын нэр биш. Гэвч өчигдөр орой Түгжилтэй тохиолдож ярилцан тохирсон нэг зүйл бий. Тэр бол өнгөрсөн жил Хан-өндрийн наадамд ногт ганзагалж очоод шившгээ холин хутгаж буцсаны өшөөгөө авах тухай яриа юм.

Түгжилтэй уулзаж архидаж байгаад Төмөрийн адууны бахдал болсон согоо шиг морьдыг хөөж алс нутагт аваачин хямд үнээр тууж орхихыг гуйжээ.

— Төмөрийн морьдыг гэнээ. Тэгж үхсэнээс тээглэж үхсэн минь дээр. Ярихгвй.

Төмөр хойт Тамирын хөндийд ирээд нутаглаж байна гэдэг товтой сургийг сонсоод Түгжил хэд хоног тавтай ч унтаж чадагвй. Аглаг уулын тагт хадуулан үхсэн гэж баттай итгэж байсан тэр гайхал амьд ажээ. Түүнтэй энэ орчлон дээр дахин учирвал амьд гарахгвй. Гэтэл энэ Бадарч морьдыг нь хөөж өгөхийг гуйна гэнээ. Тэр морьдын тоогоор жиг алт өгье гэсэн ч аминаасаа уйдаагвй цагт үүнийг хийхгвй.

— Нэг шөнө л хөөж орхихгвй юу хэн ч мэдэхгвй.

— Тэр чинь Цахиур Төмөр шүү дээ. Мөрөөр чинь яг мөшгиж очоод пэндийтэл чинь хүлж модны мөчрөөс дүүжилж байгаад хуушуур хийж орхино. Би л чадахгвй.

Бадарч хэсэг зуур бодол болон дуугвй суув. Үнэхээр ч Төмөрийн морьдыг авна гэдэг бол өлсгөлөн арслангийн амнаас мах булааж авахтай адил хэрэг. Төмөр мэдмэгц алдалгвй мөрдөн очно. Тэр вед амьд гарна гэхэд хэцүү. Гэвч хэцүүг бодоод байвал доромжлогдсоныхоо өшөөг яаж авч чадах билээ.

— Би эзгвй газар чиний мөр дээр отож байгаад хурдан буугаар бодийг нь хөтөлчихье.

Түгжил нүдээ алгуур эргүүлж Бадарчийг шалган удтал ширтэв. Хэрэв ингэж чадвал ярихгвй сайхан хэрэг ажээ. Гэвч тэр бол бүдүүн суман ташуураар улаан суга руу нь ёворч магнай дундуур нь байдаг хвчээрээ цохин, тохой хутга бараг далд ортол шаагаад үхээгвй Төмөр шүү дээ.

— Ээ дээ. Өвгөн чинь больё гэж Түгжил хэлэв. Бадарч элдэв янзаар гуйж, зуун сумтай ланжуу буу өгөх болов. Түгжил удаан бодол болон доод уруулаа хазлан байснаа мөнгөн аягатай архи авч гүд гүд уугаад

— Чи миний мөр дээр Төмөрийг угтаж хүлээх хэрэг үү гэж асуув.

— Эзгвй газар мөр дээр чинь хоцорно. Тэгээд тэр гайхлыг ирэх дээр нь сум зоож орхино.

Алдаж орхих юм уу, тонилгоод баригдвал баларна шүү дээ. Төмөр чинь ардын засагт нэртэй хвн.

— Энэ өргөн нутагт бололгвй дээ. Тийм заяа нь орхисон юм хаа байдаг юм бэ?

— Морьд Жамбалын гарт ороход буу чиний мөрөнд углагдана. Энэ хоёр Төмөрийн морьдыг авах, бас түүнийг тонилгох тухай ингэж ярилцан тохирчээ. Гэтэл өнөөдөр Бадарч тэр морьдыг Жамбалд дамжуулан амархан дал оруулах аятайхан нүх олов. Төмөрт тавин морьд байхгвй. Гэвч түүний арван хэдэн морь бол цөм армагийн дээд билээ. Бусад морьдын тухайд Түгжил ойрын хошуунаас сохор зоосны үнэгвй амархан олж чадах байлаа.

Цамба, Жамбал хоёр бааюуны гудамжаар явсаар Чимэгийн хашааны өмнүүр гарахад «Эд бий юу» гэж Жамбал асуув.

Чимэг ардын намын гишүүн болоод хврээ орж ном сурах гэж явсан. Цэцгээ хэдэн малтай

болоод энэ цагаан давааны ард нутаглаж байгаа. Эртүүд би нэг хүртэх санаатай очсон чинь хавьтуулахгүй байдаг шүү.

— Үнийг нь хантал өгье гэж хэлэхгүй дээ гээд Жамбал чанга инээв.

Тэр хоёр да чавганцын хашаанд ороход Бадарчийн тохом татаастай морь ногоон өвс идэн тавтай байлаа. Үүд хяхтнан дуугарахад морины чих сэртэс хийснээ чоно биш хүн ирснийг мэдсэн бололтой тайвшран өвсөө идлээ.

— Сайн байцгаана уу? гэж гэрт орсон Жамбал ихэмсэг бөгөөд хөндий дуугаар мэндлэв.

— Сайн. Сайн байна уу?

Бадарч, Цамба, Жамбал гурав хятад архи халаалгаад ууж, морьд өгөлцөж авалцахаа ярилцан дэнчингээ тавилцав. Дараа нь даалуу гаргаж тавилаа.

— Танай энд ардын засгийн төлөөлөгч хэн бэ?

— Нөгөө Эрдэнэ. Ханан хээтэй чанс, хамбан хээтэй зургаа гэж Бадарч тоомжиргүй хэлээд чанс чулуудав.

— Ямар Эрдэнэ вэ?

— Яахав дээ. Нөгөө дэвхрэг Итгэлтийнд зарагдаж байсан Эрдэнэ. Тэр чинь ардын засгийн төлөөний түшмэл болчихоод мандаж байгаа даа гэж Цамба хэлэв.

— Аль тийм новшнууд мандахыг хэлэх вэ? гэж Бадарч хэгжүүн бөгөөд хүйтэн хэлэв.

— Юу гэнээ. Чи барагтай холиогооч гэж Жамбал хэлээд Бадарчийг хялайн харлаа.

Нэгдүгээрт ардын засгийн албанд зарагдаж яваа бас нэг новшны дэргэд аягуй үг хэлсэн.

Хоёрдугаарт дороо байсан бажгарыг нүд хариулан сольж орхисондоо Бадарч «Бас тэгээд тэр чинь бичиг эрдэмтэй сүрхий новш гэнэ билээ» гэлээ.

Гэрийн дотор нэг хэсэг нам гүм болж зууханд шатаж байгаа хар мод хааяа хааяа тас тас дуугарах нь үлэмж их чимээ шиг сонсогдож байлаа.

## XXV

Туулын голын мөсөн дээр асгасан харуугаар гуч орчим тэмээн жин огтлон гарч Лүн толгойн өмнүүр гарч явсаар Богд хан уулын аймгийн төв рүү орж ирлээ. Холын аянд ядарсан тэмээнүүд хэвдүүгээ сунган аажим боловч хол хол алхална. Жингийн бөгсөнд эзүүрсгэн нэхий дээлтэй, жар орчим насны хүн хүрэн тайлаг унан явна. Урд бөхийг нь хучиж хоёр тийш нь унжуулсан ямаан дах тайлагны алхаагаар савлана. Лоовуузаа ардаа унжуулсан энэ хүний шодон гээгний тав нь цантан бууралтаж уур савсана.

Уулын энгэрээс бусад нь цөм цасанд хучигдсан тул хаашаа л харвал цагаан бөгөөд наранд гялтганан нүд гялбана.

— Хүүхдүүд ээ. Та нар явж л бай. Би дэлгүүрт ороод очъё гэж хүрэн тайлагтай хүн хэлээд тэмээн цувааны хажуугаар зогдор хөдөлгөн сэмбэлзүүлэн шогшуулав.

Энэ хүн бол анги Эрэнчингийн танил бөгөөд олон жилийн өмнө Батыг хүрээнд хүргэж өгсөн Балдан юм. Явсаар дэлгүүрийн өмнөх уяан дээрээс тайлгаа уяад орж эргэн тойрныг ажиглан хэсэг зогссоноо явж лангуун дээр дэлгэн тавьсан барааг барилан, үнийг нь асууж гарлаа.

— Балдан гуай гэж хажууд нь хүн дуугарахад цочин харснаа нүдэнд нь баярын инээмсэглэл тодрон

— Чи чинь Бат уу даа? гэлээ.

— Тийм. Би Бат байна.

Хуучин танил залуу хөгшин хоёр уулзаж юуны өмнө золгож дараа нь харилцан байцааж гарлаа.

— Энд яриад яахав. Манайд очъё. Ер нь манайд хоноод яв.

— Тэр болно хүү минь. Гагцхүү жингээ эргүүлэх.

— Таны тэмээгээр мордоод би эргүүлээд ирье. Энүүхэнд явж байна билээ. Харин та манай очоод байж бай. Ойрхон гээд ийш тийш харснаа нэг хүнийг дуудаж «өвгөөн, чи энэ Балдан гуайг манайд хүргэж өг. Халуун цай тос, боорцог өгөөрэй. Би удахгүй ирнэ» гэлээ.

Балдангийн жин сургуулийн ханхар хашаанд бууж жинчдийн нэг нь тэмээ идүүлэхээр гарлаа. Балдан тэргүүтэй бусад нь Батын гэрт дээлээ тайлан тавтай сууцгааж нарийн хоолоор дайлуулав. Бас Бат архи авчран өгсөнд олон хоногийн хатуу аянд ядарсан хүмүүсийн сэтгэл нь сэргэж үг яриа олшрон дуу чангарав.

— Хүү минь чи багшийгаа таалал төгсөхөд хар болсон хэрэг үү?

— Тийм ээ. Багш минь намайг хар бол гэсэн.

— Сургуульд орж төгсөөд танхимын дагуур сургагч багш.

— Багш чинь дээрэмчинд цохиулаад таалал төгссөн гэдэг үнэн үү?

— Цохиулж таалал төгссөн нь үнэн. Гэхдээ дээрэмчинд биш гээд Бат анги Эрэнчин нас барсан тухай ярилаа.

Батын яриаг Балдан үлэмж анхааралтай сонсож байхад нүүрэнд нь урт бөгөөд хүнд амьдралын тамга болсон үрчлээнүүд улам бүр тодрон ам нь үе үе буйтнана. Халхын заяа буяныг сахигч, биелсэн бурхан Богд Жавзандамба хутагт хүн ална гэдгийг санахад ухаанд багтамгүй. Гэвч Батын үг бүхэнд «энэ бол үнэн юм шүү» гэсэн нугаршгүй өнгө байгаа нь Балданд дамжин халдаж айх, гайхах сэтгэл төрүүлнэ.

— Иш хүү минь. Ингэж ярьж болохгүй. Халхад ховорхон эрдэмтэй ламыг Богд гэгээн юу боллоо гэж... гээд үгээ таслан залбирснаа... хороох билээ? Гэж шивнэв.

— Балдан гуай минь энэ бол та бид хоёр уулзаад ярьж байгаа шиг үнэн хэрэг гээд Хүрээ Юндэнгийн хашаанд Жамбал Цамба хоёр юу гэж ярьж байсныг хэлэв.

Богд дургүй агсан Чимэдцэрэн даа лам, Чин ван Ханддорж, Засагт хан Содномцэрэн зэрэг олон хүнийг бузар булай аргаар хороосон тухай яриаг Балдан олонтаа сонссон. Засагт хан Содномцэрэнд эх дагина Дондогдуламаар хортой архи өгүүлж алаад хааны хатан эгэл нэгэн бүсгүйг шулам учраас нөхрөө алав гэж зар тараажээ. Чин ван Ханддоржид мөн л Дондогдуламаар архи өгөхөд нь урьтах гунигт явдлыг мэддэг ван их согтсон дүр гарган уулгүй явахад нь хүн явуулж дунд голын орчим цохиулж алаад мориноос унаж чирэгдэн үхэв гэж зар тараажээ. Чимэдцэрэн да ламыг хэд дахин алах гээд чадахгүй болохоор Баруун хязгаарыг тогтнуулах сайдаар томилож явуулан замд нь алуулжээ. Энэ бүхнийг Балдан сонссон. Гэвч тэр бүрхан хүн ийм хилэнцэт юм хийх ёсгүй гэж сэтгэлээ хүчлэн итгүүлж явсан билээ. Гэтэл өнөөдрийн Батын яриа бол зайлж болшгүй баримттай зүйл байлаа. Урьд Богд түүнийг чингэж алсан гэнэ. Үүнийг ингэж алсан гэнэ гэдэг яриа хэд хэдэн хүнээс дамжуулан сонсож байсан бол энэ удаа анги Эрэнчингийн хажууд байсан бөгөөд алсан хүмүүсийн энэ бузар яриаг сонссон хүнээс шууд сонсож байлаа.

— Бурхан минь. Юу боллоо гэж хороосон байх билээ.

— Богд бол юу ч мэдэхгүй тэнэг хүн. Түүний явдал бол бузар болой. Багш бол их мэддэг ухаантай хүн. Энэ учраас Богдын муухай ажил, тэнэг занг жигшин, илэн далангүй ярьдаг байсан. Үүнд нь хорсож өшсөн байхдаа.

Балдан дуугүй доош харан суув. Шанааны нь арьс татвалзан чичирч урт бөгөөд тод амьсгалана. Толгойгоо алгуур өргөж Батыг удтал гөлрөн ширтлээ. Батын нүд, нүүрний ширхэг бүр «миний багшийг Богд алсан» гэж байлаа.

Бурхан минь гээд Балдан залбирснаа ертөнцийн бузар явдлыг харахгүй гэсэн шиг нүдээ аньж хэсэг болоод уртаар санаа алдаад нүдээ алгуур нээв. Арга нь барагдсан тэр нүд «Энэ тухай цааш битгий яриач дээ» гэж үглэн гуйж байлаа.

Балдан гуай, унтъя гээд Бат босож жинчин өвгөнд ор засаж өглөө.

Балдан зузаан дэвсгэр дээр тавтай хэвтэж, Батаар тумлайдуулан хучуулж авснаа «Хvв минь багш чинь цаньдийн намын оройд нь гарсан эрдэмтэй лам байсан» юм гэдэг шvв. Ямар бага эрдэмтэй анги болох билээ дээ. Мөн ч гоц ухаантай хvн дээ. Бид хоёр багадаа хврээн дээр ах ламын хоол хвргэж өгөөд буцаж явлаа. Өвлийн дунд сарын эхээр байсан юмсан. Бидний өмнө явсан тэмээтэй хvний мөр дайралдав. Хэсэг явтал буугаад явсан мөр нь байлаа. Багш чинь тvвнийг ажиглаж байснаа «Баруун нvд нь сохор тэмээтэй, хөл хvндтэй хvн явж шvв» гэлээ. За тэгээд гvйцэж очвол яг л хэлсэн ёсоор нь байдаг байна. Яаж мэдсэнийг нь асуувал «Тvвнийг мэдэж ядаад байх юм юу байхав дээ. Тэмээ нь өвс идэхдээ баруун талын өвсөө дутуу хазаж, зvвн тийшээ эргэж идсэн байна билээ. Эзэн нь сууж байгаад босохдоо хоёр гараа ардаа тулж боссон мөр нь цасан дээр илэрхий байсан» гэсэн юм шvв. Мөн ч ухаантай гярхай хvн дээ гэлээ. Эрэнчингийн агуу цагаан, сайхан сэтгэлийн тухай Бат Балдан хоёр ээлжлэн ярьсаар шөнө дунд өнгөрvүлж унтав. Маргааш нь Балдангийн жингийн цуваа хврээний зvг хөдлөв.

— Цэрэнчимэд да лам, дээд засагт хан, ханд чин ван цөм л багш шиг чинь л таалал барсан юм гэдэг шvв хөөрхий. Бурхан минь гэж Балдан хэлээд залбирснаа тэмээндээ мордож холдсон жингийнхээ хойноос явж билээ.

## XXVI

Намрын эхэн сарын хврээний бvгчим гудамжаар шинэхэн хөх чисчvв дээл өмсөж шөвгөр хар гутал өшиглөсөн Эрдэнэ нуруугаа vүрэн vl мэдэг бөхийн нэлээд юм бодсон бололтой нэлээд алхалж явлаа.

Өчигдөр хврээнд орж ирээд намын гуравдугаар их хурлын төлөөлөгчдөд зориулсан Дунд голын эрэг дээр барьсан гэрvүдийн нэгд бууж унтав.

Гэтэл өглөө нэг цэргийн хvн ирж «Цэцэрлэг Мандалын аймгийн төлөөлөгч Цогтын Эрдэнийг бvх цэргийн жанжин Данзан дуудаж байна» гэлээ.

Данзан сайшаах гэж, сайн юм ярих гэж дуудаагvйг Эрдэнэ мэдэж байлаа. Гэвч Данзан бол жанжин. Бас ерөнхий сайдын орлогч хvн болохоор очихгvй байж болохгvй.

Данзан эрх мэдлээ ашиглаж, өөртэй нь зөрөлдсөн хэд хэдэн хvнийг хатуу шийтгэсэн тухай Эрдэнэ товтой сонссон билээ. Хоёрхон хоногийн дараа их хурал болно. Гэвч хоёр хоногт Данзан юу ч хийж магад шvв дээ.

Өнгөрсөн зун Бат ирж Содномын хэд хоноод дараа нь эцгийн дээ ирсэн бөгөөд бааюу дээр тарган морь унаад тэнэж явсан Хонгортой дайралдаж юуны өмнө Булган уулын өвөрт ургасан хоёр монсон дээр очив. Мойл нь арайхан болоогvй байсан авч өөр, өөрийн модноос авч амаа заваартал идэж, Заяын хврээн дээр байсан амьдралынхаа аль инээд хөгжилтэй хэсгийг ам булаалдан өрсөлдөж ярьж инээлдэв.

— Энэ мод бид хоёрын аль нь тvрvүнд vxэх бол гэж Бат инээмсэглэн хөгжилтэй дуугаар асуув.

— Би л vүнээс тvрvүн vxэхгvй.

— Мод ч урт настай байдаг юм шvв.

— Юу ч л гэсэн тэр гээд Хонгор хэсэг мойл шувтран авч амандаа хийлээ.

Маргааш нь хоёр залуу Төмөрийн зvг гарч тэнд нэг хоноод Итгэлтийн хотонд очиход зvүн өмнө талын шинэхэн гэрээс Сvрэн Солонго хоёр гарч дvүрэн баяр, хөөр болж билээ.

Орчлонд салах жам байвч бас учрах зам байдаг ажээ.

Хонгорын зочилсон гуравхан хоног Батын сэтгэлд цахилан өнгөрсөн боловч амьдралд нь vlэмж их юм өгч билээ.

Нэг өглөө дөрвөн залуу мордон явж урьд тоглож байсан чулуун дээрээ иржээ. Олон он өнгөрсний ул мөр болж өвс ургаад зарим чулуу нь харагдахаа больсон тэр гэрүүдийг сэргээн барьж юу хаана байсныг хөгжилдөн санаж үд өнгөртөл яг л багадаа тоглож байсан шиг бие биедээ айлчлан, хомоолоор морь хийн хурууны салаандаа хавчин унаж заримдаа тонгочин булгиулж байлаа.

Сүрэн, Солонго хоёрын гэрийн хоймор нь бурханы авдар гэж нэг ногоон чулуу байдаг байлаа. Тэр үнэхээр гоё чулуу байсан бөгөөд хичнээн эрэвч олодохгүй болохоор Хонгор шууд л булааж авснаас хэрэг гарч Сүрэн, Солонго хоёр авах гэж оролдоод чадахгүй болохоор уйлалдав. Орой нь Хонгор түүнээс болж аавдаа зодуулсан юм. Үүнээ санасан Хонгор шууд очиж хоёр эмэгтэйн гэрийн бурханы авдарыг авч зугтсанд хөгжилдөн ноцолдов. Чулууг Хонгор шидэж Батад дамжуулахад шүүрэн эргэж зугтах гэтэл мөрөн дээрээс нь Солонго базаж авлаа. Эргэж харвал ер бусын зөөлөн бөгөөд сүүлийн вед сэтгэлээс нь холдож өгөхөө больсон хоёр нүдтэй тулгарав. Энэ вед ч Бат гар дахь чулуугаа мартаж, Солонго ч яах гэж барьж авснаа мартлаа.

Эгшин зуур гөлрөн ширтэлцсэн дөрвөн нүд нэг үе салж чадахгүй зууралдсанаа мишээх мэт эв хавгүй дүрс тодруулан салахад Батын мөрөн дээр байсан Солонгийн нар шувтран унав. Бат атгасан чулуугаа нүдэндээ тулган харснаа царай нь минчийн улайж, Солонгод сарвайн өгөв.

Энэ бүхнийг харсан Хонгор дэргэдээ зогсож байсан Сүрэнг аяархан нудраад «бид хоёр хариад хоол хийж байя. Та хоёр жаахан тоглож байгаад очоорой» гээд эхнэртэйгээ мордон явлаа.

Бат, Солонго хоёрын зүгээс ямар ч хариу дуу гарсангүй.

— Тэр хоёр явчихлаа.

— Тийм ээ явчихлаа.

— Чи үүнийг ав л даа.

— За гээд Солонго сарвайн Батын гар дахь чулууг авах гэтэл гар нь Батын гарт хүрэв.

— Хоёул энд жаахан суух уу?

— За гээд Солонго чулууг авалгүй өвдөг нугалан дороо суув.

Тэр хоёр үг дуугүй нилээд сууж байснаа Бат

— Надад сургууль гэр барьж өгсөн. Би тэр гэрт ганцаараа л суудаг гэлээ.

— Аа тийм үү. Тэр Лүн гэдэг газар чинь хол уу?

— Ойрхон. Арваад л өртөө.

Бат газар шагайж байснаа харцаа алгуур эргүүлэв.

Солонго доош харан өрөөсөн гараараа газар тулан хөдлөхгүй байхад шанх нь салхинд үл мэдэг хийснэ.

Бат гүн, гэгч нь амьсгаагаа татаж, цээж дүүрэн агаар хурааж буцааж гаргахгүй хэсэг болсноо «Би энэ жил хорь хүрлээ. Одоо ижилтэй болмоор байна... чи миний хань болохгүй юу. Бид хоёр багаасаа бие биеэ мэднэ» гээд доош харж санаа алдав.

Их баяртай мэдээ сонсоод инээх уйлахын дундуур бахардан байгаа хүнийг харсан бол энэ үгийг сонссон Солонго яг л тийм байлаа. Энэ үгийг сонсохсон гэж Солонго Батыг ирсэн өдрөөс хүсэн хүлээж билээ. Хэлэх ч байх гэж итгэн өгөх хариугаа олон янзаар бэлтгэсэн юм. Гэтэл хүлээж байсан үгээ сонсох дээр нөгөө бэлтгэсэн үг нь ор сураггүй алга болсноор барахгүй дуу оволзсон зүрх зогсох шиг болж дэмий л бүлтэгнэн хэсэг болов.

— Аав л мэднэ дээ гэж хэсэг түгдрэн байсны дараа шивэгнэн хэлжээ.

Батад цааш яриад хэрэг ч байсангүй. «Аав л мэднэ дээ» гэсэн үгний цаана «Надаас битгий

асуу. Над тvvнээс илvv жаргал байхгvй» гэсэн тодорхой vг сонсогджээ.

Маргааш нь Бат явахынхаа өмнө зориг гарган Итгэлтэд

— Солонго бид хоёр бие биедээ дасаж хань ижил болох гэж ярилцсан. Гэвч та л мэднэ шvv дээ. Бид таныг дургvйцэхгvй болов уу? гэж бодох юм гээд нvvр өөд нь ширтэв.

Итгэлт нvдээ цавчлан, байн байн Батыг ажиглан хэсэг бодол болон сууснаа аяга авч зөөг цай бялхам хийж яаралгvй уув.

Итгэлт хоёр залуугийн харилцан хөдөлсөн сэтгэлийг бараг эхний харцнаас нь мэдсэн бөгөөд Батаас ийм vг заавал сонсоно гэж хvlээн өгөх хариугаа бас л бэлхэн болгоод байсан юм.

Ингэж бодолхийлэн цай ууж дvвчигнэсний учир бол хариу өгөхийг хvlээсэн Батын байдлыг ажих, энэ асуудалд хөнгөн хандахгvй байгаагаа тvvнд ойлгуулах гэсэн бодлоос гарчээ.

— Хvv минь! Юу боллоо гэж би дургvйцэх вэ. Та хоёрын сэтгэл л мэдэх хэрэг. Гэвч цаадах чинь Должин бид хоёрын сэтгэлийг дэвтээж байдаг ганц охин минь болохоор уг нь чи бидэнд ойртож ирээд ёс төртэй нийлбэл зvгээр юм даа. бас тэгээд аав чинь юу гэх бол доо гэж Итгэлт хэлэв.

Yнэндээ ч Итгэлт энэ хоёр залууг суухад нь дургvй биш байлаа. Хураасан хөрөнгий нь ганц эзэн Хонгор нь сэтгэлд нэг л хvрэхгvй байв. Эхнэр аваад хөрөнгөдөө хайр бахдал төрөх байх гэж бодсон нь одоохондоо бас л биелээгvй. Гэвч Хонгорын нас бага, цус шингэн болохоор цаашид яаж ч хувирч болох юм. Эхнэртэй хязгааргvй хайртай бөгөөд тvvний vгнээс гажихгvй байгааг Итгэлт мэдэж байлаа. Хэзээ нэгэн цагт Сvрэнгийн тусламжаар Хонгорыг энэ хөрөнгөтэй хvзvvгээр нь холбож чадна гэдэгт Итгэлт итгэж байлаа. Сvрэн байсан цагт Хонгорын хувь заяаны талаар зовох хэрэггvй мэт. Бас тэгээд vнд яарах хэрэггvй мэт. Учир нь нэгдvгээрт Хонгорын нас бага, цус шингэн, хоёрдугаарт амьдралын учрыг олоогvй.

Гуравдугаарт өөрөө одоодоо ануухан байгаа билээ. Харин Солонгын тухай бол өөр хэрэг байлаа. Солонго бол vгнээс нь гардаггvй. Хvний аясаар амьтан болохоор тvvний хувь заяаны талаар Итгэлт бодохгvй байж чадахгvй. Солонгыг зальтай хvний гарт өгч, идэш болгож болохгvй. Бат бол охиныг минь хэзээ ч идэхгvй хvн болохоор хvргэн нь болоод хөрөнгөнд нь ойртож ирвэл арвижуулж чадах ч гэсэн, vрэхгvй хадгалж чадах хvн гэж Итгэлт мэдэж байлаа. Энэ бvхнийг бодсоны дараа Батыг хvргэнээ болгохоос Итгэлт татгалзахгvй болсон юм.

Бат ингэж Итгэлтийн охинтой амьдралаа холбох болсноо эх эцэгтээ хэлэхэд Эрдэнэ талархаа ч vгvй, дургvйцэж хориглоо ч vгvй. Харин Долгор

— Хvv минь хэрэггvй биш vv. Итгэлтийн бидэнд учруулсан зовлон бага биш юм шvv гэхэд

— Ижий минь Солонго бидэнд огтхон ч гэм хийгээгvй шvv дээ гэж хэлсэн.

Yнэхээр ч Солонго өчvvхэн ч гэм хийгээгvй бөгөөд «Ижий минь та над хайртай. Би Солонгоос өөр хvнд сэтгэлтэй болж чадахгvй» гэж байгаа Батын нvд их хайрын сэтгэлд өөрийн эрхгvй хөтлөгдсөн шийдэмгий дуу нь тов тодорхой хэлж байлаа. Бас залуу сайхан насандаа буй болсон ариун хайрын их хvчийг Долгор сайн мэддэг хvний нэг байсан болохоор хvvгээ хvчлэн хориглосонгvй.

Эрдэнийн хувьд бол юу ч гэсэн ганц хvv нь эхнэр авах болсон нь vlэмж баяр байлаа. Эрдэнэ хуралд явахдаа Заяын хvрээнээс хvvтэйгээ хамт гарч явсаар Лvн дээр ирж Батын өнжиж амраад хvрээ рvv гарчээ.

Хvрээнд Эрдэнэ энэ удаа баяртай орж ирсэн юм. Гэтэл Данзан дуудав. Харин яах гэж дуудсан бэ? Эрдэнэ ардын засгийн өмнө ямар ч ял хийгээгvй. Данзан өшөө санадаг. Дотуур тамиртай хvн. Гэвч Эрдэнэ тvvнээс айсангvй. Ариун санаат монгол хvн бvхэн ардын засгийн хуулиар тэгш эрхтэй, гэхдээ Эрдэнэ сэтгэл тайван байж чадсангvй. Очих дээр яах бол? Юу



гэх бол? гэдэг асуудлууд сэтгэлд нь эргэлдэнэ.

Явсаар цэргийн яамны үүдэнд очиж хэний дуудсанаар хэн гэгч ирснээ мэдэгдээд шууд Данзангийн өрөөнд оржээ.

Эрдэнийг хармагц Данзан их л дотночлон инээмсэглэж, угтан ирээд гарыг нь хэзээний дотны танил хvн мэт барьж урин зэрэгцэн суугаад асууж самбуутай янжуураар дайлав.

Дараа нь төрийн бодлого улам нарийн болж байгаа тухай баахан юм ярьснаа

— Манай орны эдийн засгийн дорой хvн ам цөөн болохоор бусдын гар харахгvйгээр тогтнон байж чадахгvй. Ялангуяа хятад улсын хувьд ухаантай бодлого явуулахгvй бол тун хэцvv.

Хятад бол том ч улс, чадалтай ч орон. Хэзээ нэгэн цагт гамингийн гунигт явдал дахин нөмрөн ирвэл улс гэр тогтохгvйд хvрнэ. Бас манай ард тvмэн олон зуун жилийн турш хятадын бараа, ялангуяа цай тамхинд дэндvv дасчээ. Нэг өдөр энэ бvхнээр тасалж орхивол ард олон маань хvнд гачигдалд, дутагдал амсаж сэтгэл санаа эвдрэх болно. За тэгвэл яах вэ? Ядахдаа л Хятадын пvvсэнд тавьсан өрийг өгч ая тал засаж найр тавьж хожих чухал мэт гэлээ.

— Тэр өрийг ард тvмэн тавиагvй шvv дээ.

— Хэн тавьсан нь хятад улсад хамаагvй биш vv.

— Бидэнд бол тун их хамаатай, бас тэгээд хятадын пvvс олон жилийн турш монголоос хvv авч асар их хонжоо олоод анх зээлдvvлсэн хөрөнгөө хичнээн дахин өсгөж авсан. Сvvлдээ завшиж олсон хvvгээ зээлдvvлж дахин дахин хvv авч байдаг болжээ.

Данзан босон тасалгаан дотуур холхин хэсэг явснаа Эрдэнийн эгц өмнө ирж, гурвалжин ногоон нvдээр ширтэн «Дайраад ирвэл ч яах вэ? Цай тамхиар тасалж орхивол яах вэ» гэж vгээ огцомоор таслан сvртэй асуув.

Монголчууд Хятадаас цай худалдаж авах гэж vргэлж боогдож байсан билээ. Үvнээс болж vссэн дайнаас хоёр талын өдий төдий хvний амь сvйдэж байсныг тvvх шаштир гэрчилнэ.

Цай олж уухын тулд монгол хvн сөхөрч vзсэн, зэвсэг бариад дайрч vзсэн. Цайг ямар их vнээр олж ууж байсны баримт монголчуудын амьдралд бишгvй байдаг. Бvтэн цай хагалахдаа хормойгоо дэвсэж байгаад адис авдаг. Цайгаа ашиглаад зориуд асгахдаа саваа дутуу барив гэж гараа зэмлэж гасалдаг. Цай мөнгөний оронд гvйж байсан ч удаа буй. Энэ бvхнээс vзэхэд монгол хvн цайг vлэмж зvдэрч баймаажин олж авч байжээ. Тvvнийг Эрдэнэ мэднэ. Гэвч Эрдэнэ олон веийн турш дамжиж байж арай гэж олсон тусгаар улсаа цайнаас болж алдах гэсэн Данзангийн vгийг зөвшөөрөхгvй байлаа.

— Дайраад ирвэл Зөвлөлт улс тусална. Цайны хувьд бол улс төрөө тvvгээр худалдах ариун санаат монгол хvн одоо байхгvй гэж Эрдэнэ хэлэв.

— Зөвлөлт улс. Зөвлөлт улс. Өөрсдөө ядарч байна шvv дээ.

— Үvнээс ядарч байхдаа бидэнд тусалсан биш vv. Данзан өмдний халаасандаа өрөөсөн гараа хийж Эрдэнийг ширтэн байснаа хvйтэн инээмсэглэв.

Данзан бол монгол орныг гадаадын боолчлолоос чөлөөлөх хувьсгалд идэвхтэй оролцож хувьсгал ялсны дараа өндөр их тушаалтай болжээ. Гэвч сvvлийн вед ашиг олж баяжихыг хичээн дусал дулаар боловч хөрөнгө хуримтлуулах ажлыг хайв. Энэ бодол нь хувьсгал хийхэд нь тусалсан Зөвлөлт улс тус болохгvйг Данзан ойлгосон. Бас хувьсгалыг хамт хийлцсэн нөхдийн ихэнх уул бодлыг эсэргvvцэв. Хvсэл мөрөөдлөө биелvvлэх ганц зам бол хятадын пvvсвvдтэй холбоо тогтоож тэдний дэмжлэгийг авах арга байв. Ингээд зарим пvvсэнд хувь нийлvvлэн оров. Гэтэл монголын ноёд хаадаас тавьсан өрийн тухай асуудал босож ирэхэд тvvнийг төлvvлэх гэж оролдоод бvтсэнгvй. Тvvгээр ч барахгvй монгол улс цаашид яаж, ямар янзтай хөгжих вэ гэдэг асуудал босож ирээд Монгол Ардын Хувьсгалт

Намын олонхи гишүүд хөрөнгөт ёсноос өөр шинэ замаар улс орноо хөгжүүлэх тухай ярьж эхлэв. Энэ вед коминтернээс Ресскуловыг төлөөлөгчөөр ирүүлэн 1920 онд их Ленинээс заасан хөрөнгөтний бус хөгжлийн замыг сонгон авахад нам тусална.

Энэ бүхнээс болж Данзан тэмцлээ идэвхжүүлэн намын гуравдугаар их хурлаар өөрийн бодлогоо дэмжүүлэх, эс чадвал бүх цэргийн жанжны тушаалаа ашиглан цэргийг хөдөлгөн засаг төрийг хүчээр булаан авахыг нууцаар бэлтгэж түүндээ хань олж авахыг хичээж байлаа. Энэ ч учраас Эрдэнийг урьж ирүүлсэн билээ. Гэтэл Эрдэнэ хятадын пүүсний өрийг төлөх бодлогыг дэмжиж өгсөнгүй.

«Үүнтэй цааш ярих хэрэг байна уу? үгүй юу» гэж Данзан бодох зуур Эрдэнэ байн байн хулгай нүдээр ажиглаж байв.

Эрдэнэ тайван суух бөгөөд байшингийн дотоод байдлыг ажиглана. Хэн юу гэж хэлсэн ч хятадын пүүсэнд өр төлөхгүй гэж Заяын хүрэн дээр, лааны гэрэлд Данзангийн бичгийн хариуг бичиж байхдаа шийдсэн болохоор Данзангийн саяын ярьсан зүйлийг буруу ойлголтоос гарсан төөрөгдөл гэж бодсоноос биш буруу үзлийн хорт уршиг гэж санаагүй билээ.

Данзан зэрэгцэн суугаад мишээх мэт болсноо «Хятадын өрийг ч төлөхөө больё. Магадгүй таны хэлдэг зөв ч байж болно. Ер нь хувьсгалын хэрэгт ган зоригтой байх нь дээр гэж талийгаач хэлдэг сэн» гээд санаа алдаад нам дуугаар

— Манай намын гуравдугаар их хурал монгол улсын хөгжлийн тухай асуудлыг ярих байх. Түүнийг та юу гэж үзэж байна. энэ бол тун чухал зүйл биз дээ? гэж асуув.

Энэ асуудлыг сонссон Эрдэнэ нүд сэргэж нүүр дүүрэн мишээснээ «Би олноо өргөгдсөний дөтгөөр онд Луу гүний нутагт нэгэн оростой танилцсан. Тэр бол Большевик намын гишүүн байсан хожим арван нэгэн онд манайд туслах гэж ирсэн. Зөвлөлтийн улаан цэргийн нэг ангийн комиссар байсан. Та таних ч байх. Петр гэдэг. Тэгээд зүүн аймагт бидэнтэй хамт цагаантны эсрэг дайтаж яваад осолдсон юмсан гээд нүд нь гөлрөн гүн гэгчийн санаа алдсанаа тэр хүн танай монголд хүн хүнээ дарлан мөлжихгүй шинэ зам хэрэгтэй. Түүнд чинь бид тусална гэж хэлсэн. Би түүнийг ёстой бидний ганц зөв зам гэж боддог. Хүн бүр ариун шударгаар ажил хийж, улс орноо эрдэм боловсрол, эдийн засаг өндөртэй болгох нь юу юунаас чухал хэрэгтэй хэмээн боддог» гэж хэлээд Эрдэнэ монгол орны хөгжлийн тухай бодож явдаг зүйлээ ярилаа.

Данзан энэ яриаг арай ядан сонсов. Гэвч яриандаа баярласан Эрдэнэ түүний залхуу хүрч, зэвүүцсэн байдлыг ажигласангүй. Данзан цамцны халааснаас алтан цаг гаргаж харснаа «За тантай сайхан ярилаа. Би ингээд өөр ажилтай болохоор удаан ярьж чадахгүй нь» гээд босов. Эрдэнэ ч босож гарах гэхэд нь «Дараа уулзаж тавтай ярья» гэж хэлэв.

Эрдэнийг гарсан хойно хаалга руу хурц ногоон нүдээр ширтэж хэсэг байснаа «хн» гэж шүд зуун дуугараад жижигхэн дэвтэр гаргаж хэсэг нэрсийн дотор «Цэцэрлэг мандал, Цогтын Эрдэнэ» гэж бичив. Энэ нэрс бол зэвсгийн хүчээр засаг төрийг авмагц барьж, далд оруулах хүмүүсийн жагсаалт байлаа. Намын гуравдугаар их хурал болж, Данзан ба түүний нөхөд намд хорт бодлого тулгах гэж үхэлдэн оролдоход Эрдэнэ идэвхтэй эсэргүүцэж хэд хэдэн удаа үг хэлэв.

Нэг орой хурлын завсарлагаар таних хүнээс морь гуйж Хужир буланд байсан Хуягийн очиход Хуяг, Цэнд хоёр хөл алдан баярлаж нарийн хоол хийж архи гарган дайлав.

Хуягтай хурал дээр болж буй тэмцлийн тухай шүүн хэлэлцэж байтал түргэн жагсаалын бүрээ дуугарч Хуяг хувцаслан явлаа.

Эрдэнэ, нөхөр хоёрын нь улс төрийн өндөр яриа завсарласныг ашиглаж Цэнд Өлзий гуайн

тухай байцааж гарлаа. Гэтэл олон хувьд шуугилдан байн байн хашгиралдаж эхлэхэд Эрдэнэ тэсэлгвй гарвал гэрээс төдий л хол биш газар Данзан өндөр тавцан дээр гарч зогсоод уг хэлэх бөгөөд сонсогчид нь шуугилдана.

Юу болж байгаа нь мэдэгдэхгвй болохоор Эрдэнэ явж очвол Данзан намын гуравдугаар хурлыг гүтгэн, даруй очиж тэр хурлыг хөөн тарааж, төлөөлөгчийг барьж монгол орноо аврах тухай цэргүүдийг уриалж байлаа.

Олны дундаас Хуяг гарч шууд явж Данзангийн зогсож байгаа тавцан дээр гараад Данзангийн ярьсан зүйлийг эсэргүүцэн харин өөрсдийг нь даруй барьж засагтаа тушаахыг уриалав.

Данзангийн дохиогоор нэг хүн буу гаргаж ярьж байсан Хуяг руу чиглүүлтэл араас нь хвчтэй гар, буу дээрээс нь шүүрэн авч нударав. Энэ бол Эрдэнийн гар байж билээ.

— Эд төрд тэрсэлж намд харшилж байна. Олон цэрэг та бүхэн эднийг даруй барьж ав. Би намын хурлын төлөөлөгч хүн гэж хэлээд булааж авсан буугаа барин тавцан руу ойртох вед Данзан чийчаандаа бууж хотын зүг алга болов.

Эрдэнэ, Хуяг хоёр толгойлон Данзангийн талын цөөн хувьдсийг барьж авлаа.

Хотод очиж зэвсэглэсэн хятад жолооч нарыг хөдөлгөн вймээн дэгдээх гэсэн Данзангийн бодол ч биелсэнгвй баригдаж намын гуравдугаар их хурал монгол улс шинэ замаар, их Лениний заалтаар хөгжих түүх тогтоолыг батлав.

Намрын сүүл, өвлийн эхээр Эрдэнэ Цэцэрлэг Мандалын аймаг руу гарч билээ.

## XXVII

Төмөр, арслан шиг хоёр азаргатай болохоор адуугаа хашдаг ч үгвй манадаг ч үгвй үргэлж тавьж хонодог ажээ. Ялангуяа дэл нь өвдөгтөө хүрсэн бор азарга нь адуундаа чоно ойртуулах нь байтугай, гэрийн нохойг ч хавьтуулдаггвй. Өнгөрсөн намрын нэгэн шөнө энэ азарга хоёр чоно цавчиж алаад өглөө Төмөрийг адуугаа хураах гэж очиход нь өмнөөс нь довтлон дайрч билээ.

— Олон хавар нэгэндээ гэж чоно элбэгтэй газар хашиж хонож байвал дээр юм биш үү гэж Өлзий гуай нэг удаа хэлэхэд Төмөр хөгжилтэй инээж

— Хоёр азарга минь дөрвөн хөлтөөс манаж чадна. Харин хоёр хөлт бол Цахиур Төмөрийн адуу гэж мэдвэл ганзаган дахь ногтондоо гар нь хүрэхгвй байх гэжээ.

Энэ дэмий үг биш байсан. Төмөрийнх гэж айл буй болсноос хойш нэг унага ч боохойд өгөөгвй. Нэг морь ч хулгайд алдаагвй юм.

Өлзий орой бүхэн гарзны үүд хааж байгаа нь гэж галын хайчны ам боож хатавчинд хавчуулна. Тэгээд өглөө тоо бүрэн адуу ирэхийг үзээд «хайчны ам боосны ач» гэж гүн итгэж залбирна. Намрын нэг шөнө Төмөрийн адууг орой билчээрт гарахаас нь эхлэн модон дотроос ажиж байсан нэг хүн адуунд улам бүр ойртож байлаа. Тэр бол Түгжил гайхал байлаа. Шөнө дундын вед адууны дунд урт гэгчийн хар модон уурга барьсаар орж ирээд чимээ чагнан хэсэг зогсов. Зүрх нь түргэн түргэн цохилж, нэг л эвгвй ажээ.

Бадарчтай нийлж дөч шахам морь Эгийн даваа давуулан Загийн голын орчим Жамбалд хүргэж өгчээ. Одоо Төмөрийн морьдыг аваачиж өгвөл хэлэлцсэнээрээ сүүл мөнгөө авна. Гэвч Төмөрөөс айх сэтгэл Түгжилд их болохоор «ингэж яваад Төмөрт баригдвал...» гэж бодоход хүйтэн хөлс нь чийхран, модны бүдүүн мөчирт дүүжлүүлэн түлээ овоолуулж байсан нь бодогдоно.

Шунал хүнийг шийдэмгий болгодог. Аажимдаа шунал нь аймхай сэтгэлийг хайлуулан Түгжил зоригжиж эхний морио уургалж ногтлов.

Морьд барилж холбох бүр шунал нь оргилон «Цахиур Төмөрийн адуунд орох эр, халх даяарт надаас өөр бий болов уу?» гэж бодоход баярлах, бахдах сэтгэл төрж байлаа. Ганцаараа

уургалж, ганцаараа ногтлох бол амаргвй ажил болохоор нилээд удав. Шөнө дунд нилээд өнгөрсөн хойно Төмөрийн ороо хээр гэдэг өндөр бор хээр мориноос бусад морьдыг ногтолж холбон авснаар барахгвй Дулмаагийн найр наадамд унадаг жороо зээрд морийг эмээллэж авлаа.

«За ингээд хуйхалдаг хэрэг ээ» гэж сэтгэлдээ хэлээд хуйваа тайлан авч бүсэндээ хавчуулан уургаа хаяж морьдоо хоёр велэн хөтлөөд мордов. Эхлээд баруун урагшаа хэсэг явснаа жижигхэн гол гатлаад эгц урагшаа эргэн Тамирын урд талын өндөр хар уулын зүг довтлов. Өглөө үүр цайхын вед болзоотой газраа очиход Бадарч хүлээж байлаа.

— Одоо яах бэ? гэж Түгжил асуугаад хөлсөө арчив.

— Морьдоо энд уяж оройг хүлээе. Мөрдөөд ирвэл эрлэг хааныд явуулчихъя гээд Бадарч баярласан хэрээ бахирна гэж баяр бахдалтай инээв.

Морьдоо зайдуу газар бэхлэн уяад Төмөрийн ирэх зүгийг отож ланжуугаа хөллөн отов.

Төмөр өглөө эрт босож уяж хоносон хязаалан үрээгээ эмээллэж унаад адууныхаа зүг хэсэг хатируулснаа «Эрдэнэ засгийн унага» -аа дуулж хурд хуваа давхилаа.

Намрын хүйтэн салхи өмнөөс нь дээл нэвт үлээн, хөрч нягтарсан агаарт Төмөрийн бургисан бүдүүн дуу нь нарийсаж тохойлдон чирсэн уурга нь савлан намалзаж өндөр ургасан өвсийг налуулан зам гаргана.

Адуун дээрээ очмогц юу болсныг мэдээд «Хонго нь загатнахаар хааныгаа хараана гэгч болж байна уу. Миний гараас гараарай» гээд хүйтэн инээмсэглэв.

Үлдсэн адууг хурааж ороо хээрээ барьж унаад хулгайчийн мөрийг мөшгин явж нөгөө жижигхэн голыг гатлав. Гэтэл мөр эгц өмнийг чиглэн явжээ. Төмөр морины амыг татан зогсож өргөн магнайд нь байн байн гүн бодол тодорно.

— Энэ гүн хөвч өөд цоройлоод хайчих нь вэ? ахыгаа нүдийг нь боосон гөлөг шиг төөрүүлэх нь үү? Уул үзэх нүдгвй, уушиг даах шүдгвй болдог юм гэхэд ах нь ийм юманд хууртахгвй гээд эгц баруун тийшээ эргэж үг дуугвй давхилаа.

Ардаа морь холбон хөтөлсөн хүн хөвч рүү явах ёсгвй. Энэ мөр бол зөвхөн чулуу хөөлгөх гэсэн тэнэг бодол гэдгийг Төмөр эс мэдвэл хэн мэдэх билээ. Ингээд мөрийг орхиж Эгийн даваа чиглэн хурдалжээ.

Бадарч Түгжил хоёр үдэш болж харанхуй эхэлтэл зам харуулдаад Төмөр ирсэнгвйд Бадарч үлдэж, Түгжил цааш явах болжээ. Бадарч маргааш үд хүртэл хүлээгээд ирэхгвй бол Түгжилийн хойноос явахаар шийдэж тохмоо дэвсэн унтлаа.

«Төмөр мөр алдахгвй хөөж заавал хөөж ирнэ гэж хэн хэлсэн юм бэ? Өдийд Түгжилийн мөрийг алдаж орхиод, мунгинаж, мунгинаж буцсан байж болно. Тэгсэн бол чи ингээд өдөр турш хүйтэн газар тэврэн, хэвтэх юун билээ» гэж бодож байлаа.

Шөнийн тэнгэрт од гялалзан, салхинд шуугих модны чимээ тийм гэхийн аргагвй зүсэн зүйлийн аягвй авиа үүсгэнэ. Модноос аргамжсан морь нь байн байн хамраа тачигнуулна.

Алаг хөвчид ганцаар хэвтэж байгаа хэн боловч сэтгэл нь тэнэгэр сайхан байж яаж чадах билээ. Хэсэг хөрвөлдөн чимээ бүхнийг анхааран чагнаж байснаа өдөржин гөлрөн хэвтсэндээ хөшиж ядарсан бие нь гүйн нойронд цохигдон нам унтав.

Өглөө үүр манхайн цайх вед сэрж харвал морь нь алга болжээ. Босож аргамжсан газраа очтол таслан явжээ. Эрж хайвал ойр саахалтын чинээ газар хоёр чоно унагааж аваад идэж байлаа.

Сэмхэн буцаж хэвтсэн газраасаа бугаа авч ойртон очоод хар буурал зоотой бяруу шиг азарган чонын дал хавсраад буудсан чинь алдаж орхив. Хөвчинд дуугарсан бууны дууны цуурай тасраагвй байхад цадаж авсан хоёр боохой ор сураггвй алга болжээ.

— Хар зэв. Гамингийн муу царил гэж чанга хараагаад шидэж орхив.

— Хар зэв. Гамингийн муу царил гэж хөндий дvvрэн хадан цуурай сонсогдов.

— Ийм барам шиг юм болдог оо. Хайран морь гэж том дуугаар хэлээд шогшрон гаслав. Морины сэгэн дээр очиход тvvний хөдөлгөөнгvй болсон өрөөсөн тунгалаг нvд «чамаас л боллоо» гэх мэт ажээ. Хөрс нь эрдэлсэн ойр хавийн газар нь энд чөдөртэй нэг морь, хоёр чонотой vхтлээ тэмцэлдсэний гэрч болжээ.

Морины хөшсөн хөлнөөс чөдрөө салгаж бvсэндээ хавчуулаад эргэж буугаа аваад унтсан газар руугаа явав. Эндээс ойрын айл хагас өртөө гаруй. Тэр хvртэл эмээлээ vvrэн явах болжээ. Үдийн хирд эмээлээ vvrэн баруун өмнө зvгийг чиглэн явжээ. Бадарчийг ингэж мунгинаж байхад Тvгжил явсаар Жамьян вангийн нутагт орж, Жамбалтай болзсон газраа чиглэн явлаа. Замд хvн дайралдаж сэтгэл зовоосонгvй. Жижигхэн даваа давж урт амны эх рvв ороод хэсэг явтал замын хажуугийн хэсэг модноос өндөр улаан хээр морьтой, хөх дээлтэй ханхар эр давхин гарч

— Муу хулгайч өвөг аавынхаа гарт ороо биз гэж явдал дундаа хашгирав.

— Төмөр. Заяа нь орхи гэж Тvгжил хашгираад хөтөлж яваа морио орхин зугтав.

Төмөр морьдыг нь Тvгжил авсан гэж огт зvүдлээгvй билээ. Морьдыг нь Тvгжил хөтлөн явахыг хараад уур нь хvрч барьж аваад доор нь тонилгож орхиё гэж бодов.

Жороо зээрд, ороо хээрийн суналтаас зайлж чадсангvй. Удалгvй Төмөрийн морины туурай ар шилэнд нь тачигнахад Тvгжил эргэн харлаа.

Төмөрийн ам нь ангай, бvдvvн ташуур далайн бөхийжээ. Нvд нь сvртэйеэ гялалзана. Зугтаад гарч чадахгvйг ойлгосон Тvгжил мориноос vсрэн пид хийтэл унав. Төмөр хvчиндээ хажуугаар нь өнгөрөн морио тогтоогоод эргэж ирэхэд өвдөг дээрээ сөхөрсөн Тvгжил «Төмөр гуай минь утсын чинээ улаан амийг минь өршөөгөөч. Яадаг билээ. Өчvvхэн би больё» гэж хяхарсан дуугаар хашгирна.

Шар тосны шатаж байгаа гvзээ шиг vрчийсэн Тvгжилийн хэв нь эвдэрсэн нvвр хавтгай улаан хэл гарган хашгирч байгаа тарваганы нvх шиг том амыг хараад Төмөрийн шатсан уур нь гарч «ийм ч эр байх гэж дээ» гэж бодон инээд нь хvрэх шиг болов.

Төмөр мориноос бууж ташуураа барин Тvгжил рvв явлаа.

— Ах минь би эхнэртэй, нялх хvvхэдтэй юмсан... Би чинь яадаг билээ. Би vхэхгvй гэж залбирна.

Тvгжилийн энэ vгэнд амь гуйж байгаа нь л vнэн бөгөөд эхнэр хvvхдийн тухай бол оргvй худал байлаа.

— Замын хvзvv урт, зааны хvзvv богино гэдэг энэ дээ. Тэр жил намайг алж орхилоо гэж горьдсон биз. Одоо хоёулаа данс бодно доо. Чи бас амь гуйна гэнээ гээд Тvгжилийн мөрөн дээрээс нь базаж авлаа.

Гэвч Төмөрийн анхны уур алга болоод «энэ новшийг алж гараа бузарлаад ч яахав. Харин баахан ташуурдаж амьтай нь орхиё» гэж бодоод ташуураа далайв.

Ирж байгаа vхлээс сvнс нь зайлсан Тvгжилийн нvднээс ус асгаран, гар нь хий сарвалзаж «аа, аа...» гэж уул хад янгиуулсан дуугаар хадаан хашгирав.

Ташуур Тvгжилийн нуруун дээр пин хийж битvv дуугаран буув. Дахин цохих гэтэл Тvгжилийн нvд нь цагаанаар эргэлдэн бие нь дундуур устай гvзээ шиг шалчийн сул болж, дуу нь тасрав.

— Бааштай золиг гээд угзран харвал завьжаар нь цус урсан гарч ирлээ.

Муужран унажээ. Гэвч чагнаж vзвэл зvрх нь цохилж байв. Хэд сайн цохиж авъя гэсэн Төмөрийн урам нь хугарах шиг болоод «өвс идэж, ус ууж явсан золиг уу даа» гээд ногоон дээр эвтэйхэн хэвтvvлэв.

Хэсэг байтал Түгжилийн амьсгалах нь мэдэгдэж эхлэв. «Арай ч үхчихгүй нь бололтой» гээд Төмөр босож хаясан ташуураа авлаа.

Хэдий болсныг Түгжил мэдсэнгүй. Ухаан орж сэрвэл ууц нь хүнд юманд даруулсан мэт өвдөх бөгөөд хажуугийн модноос эмээлтэй морь уяатай харагдлаа.

Бүх юм нам гүн. Төмөр морьдын хамт ор сураггүй алга болжээ. Тэнгэрт сэмжин үүл манаран, түвний доогуур хэсэг турлиах бараантан өмнө зүг ниснэ.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

I

Зуны сайхан гадна нь мал багширсан Итгэлтийн хот хөл хөгжөөн ихтэй ажээ. Нийт таван гэр байгаагийн зүүн хойт талын дөрвөн ханатай жижиг гэрээс бусдын тооноор хар модны өтгөн бараан утаа эрчлэн гарна.

Энэ утаа бол өглөөний саамаа хөөрүүлж байгаагийн тэмдэг байжээ. Гэвч гэр бүхэнд хөөрүүлж байгаа сүү адилгүй нь гэр бүхний доторхи амьдралын адилгүйн гэрч ажээ.

Их гэр гэгч Итгэлтийн гэрт таван тамгатай хоёр тогоо сүү зэрэг хөөрүүлж байхад Галсан болон Нямын оронд ирж буусан шинэ хоньчны гэрт томоос том хонин тогоотой сүү хөөрч байхад Батын гэрт хөөрүүлэх сүүгүй байлаа.

Танхимын зуны амралтаар Солонго элдвээр царайчлан гуйсан учир Бат гэрээ нүүлгэн ирж энд буужээ.

Унагаа чагталж дууссаны дараа урт уурга барин адуу хурааж байсан Хонгор

— Бат аа чи өнөөдөр хаачих нь вэ? гэж өндөр дуугаар асуув.

— Танхим дээр очно. Ажилтай.

— Бас л танхим дээр очих хэрэг үү. Яасан барагддаггүй ажил бэ? гэж хазаараа барин өнөөдөр ямар морь барьж унахаа бодон адуун дотуур холхиж явсан Итгэлт зэвүүн бөгөөд уцаарласан дуугаар хэлэв.

— Бат аа хазаараа аваад ир. Би чамд хатир шаргыг өлгөөд өгье гээд Хонгор ухасхийж, урт биетэй, өндөр сэрвээ, өргөн ташаатай гоонолзсон шарга морийг уургалав.

Гэтэл Итгэлт түргэн гэгч нь дэвхрэн очиж хазаарлан аваад:

— Батад эртүүдийн Галсангийн амыг нь халаагаад тавьдаг бор үрээг бариад өг гэлээ.

— Аав аа... гэж Хонгор дуугарах гэхэд нь тасалж:

— Одоодоо хэнд юу барьж өгөхөө би мэднэ. Юу ч л гэсэн явганаас дээр. Галсан! Бор үрээг уургалаад өг гээд Итгэлт шарга морио хөтлөн эргэв.

Бат Солонготой суугаад гурван жил болжээ. Анхныхаа жил Лүн дээр, дараа нь Бааюу дээр. Ноднин намар Цэнгэл уулын хошууны бага сургуулийн дагуур сургагчаар ирж ажиллав. Хол байхад Итгэлт уулзах бүрдээ «хоёр хүүхэд минь бидэндээ ойртож үз!» гэж шаарддаг байлаа. Тэгээд ч Бат ардыг гэгээрүүлэх яамнаас гуйж баймаажин ойртон иржээ.

Итгэлт ингэж Батыг дэргэдээ ирүүлэх гэсний учир бол алсдаа түвнийг сургууль танхимын ажлаас нь салгаж мал хөрөнгө дээрээ авчран хөлсгүй зарах гэж боджээ.

Шинэ засаг нь хөрөнгөнд нь хор болохгүй бололтой. Харин ч хийх өртөөний алба, өгөх татвар нь урьдах засгийн веес хөнгөрчээ. «Одоо өөрийн үнэнч хэдэн хүнтэй сэн бол... Ямар ч жаа тоглож болмоор байна» гэж Итгэлт боддог байлаа.

Бат хөрөнгө цугларуулж чадахгүй боловч хэрэв нэг зүтгэвэл буй болсон хөрөнгийг хадгалж чадах ухаантай хүн гэж Итгэлт бодно. Гэтэл санасанд нь Бат хүрсэнгүй бөгөөд хүргэн, хадам хоёрын холбоо хэврэг эдээр бүтсэн нь удахгүй илэрчээ.

Өнгөрсөн өвөл Цэнгэл уулын хошууны танхимын хүүхдийн хоолонд мах бэлтгэх болоход Итгэлт арван таван тарган үнээний мах нийлүүлэх болж гэрээ хийж эхний мөнгийг авчээ.

Тэгээд хуучин заншлаа намрын сүүл сар малаа заазалж онд орохгвй хөгшин хөвөөг нь нядлаад арьсанд нь боож хөлдөөв. Урьд өмнө ингэж бэлтгэсэн махаа битүүгээр нь Тамирын голын ядуучуудад ирэх жил хургатай хонь, тугалтай үнээ унагатай гvv авахаар өгдөг байсан бол энэ жил сургуульд аваачиж өгөхөд нь Бат задлан үзэж

— Аав минь сургуульд ийм юм өгч яаж болох вэ дээ. Та тарган үнээний үнээр бодож мөнгийг нь авсан шvv дээ гэлээ.

— Чи бид хоёр чинь нэг гэрийн хvн биш билvv гэж Итгэлт хэлээд хvйтэн инээв.

— Тэр ч тийм. Гэвч сургуулийн хөрөнгө, улсын хөрөнгө. Олны юм болохоор энэ тухай ярихад бидний садан сүлбээ хамаарагдахгвй. Эсхүл бид хямд үнээр авна. Эсхүл тарган мах авчирч өг гэж Бат шууд хэлжээ.

Итгэлт нүднийхээ булангаар Батыг хялаан ажиглаж байснаа худал инээмсэглэж «би ер нь чамд яршиг болох нь байна. Үүнээ би өөрөө далд хийе. Харин чи сургуульдаа өөр хvнээс мах авбал дээр» гээд урьд авсан мөнгөө буцааж өгөөд, махаа эргүүлэн авч явсан билээ.

Үүнээс эхлэн хадам хvргэн хоёрын дундуур чөтгөр орж хvйтэн харьцаа буй болжээ. Гэхдээ Итгэлт энэ тухайгаа хэнд ч хэлээгвй бөгөөд нvvрэн дээрээ Батад юм санаагвй юм шиг дvр vзvvлэвч цаанаа араагаа зууж элдвээр хавчдаг болов. Ер нь бодоод байхад Бат өөрт нь тохирохгвй хvргэн ажээ. Энэ их хөрөнгө байхад тvvнд татагдахгвй танхим сахиж, учир мэдэхгвй хэдэн хvvхэдтэй хэрэлдэж суух. Ёстой л илжиг модон хударгандаа дуртай гэдэг vг энэ хархvvгийн тухай vг ажээ. Аажмаар оролдож доор нь дарь булж байгаад Солонгоос салгахыг бодъё. Ямар сэртэнжингээс болж vвнтэй Солонгыг суулгав даа. Амьдралд хохирохгвй, алдахгвй болоод л байдаг сан. Алдсан, буруудсанаа мэдсэн хойно залж засна гэх зэрэг Итгэлт боддог байлаа.

Бат ч махны тухай болсон явдлыг зарлан тараасангвй. Гэхдээ хадмынхаа хувирсан занг мэдэж байлаа. Заримдаа Итгэлттэй салам хэрэлдмээр байдаг авч эхнэрээ бодон шvд зуун тэвчиж байлаа.

Ганц хvv нөхөр, эцэг хоёрын нь хооронд vl vзэгдэх шуудуу буй болоод өдөр ирэх тутам улам гvн гvнзгий болж байгааг ойлгосон Солонгын сэтгэл шаналан зовно. Гэхдээ энэ хэрэгт аль нэгийг нь буруутгаж, зөвтгөж чадахгвй байжээ. Итгэлтээс айдаг, эцгээ гэж хvндэтгэдэг учраас тvvнийг буруутгаж vl чадна. Батад сэтгэлтэй учраас тvvнийг буруутгаж vl чадна. Ингэж өвөл өнгөрч хавар дамжин, зунтай золгов. Танхимын завсарлага болоход Хонгор тэрэг авч очоод Батын гэрийг нvvлгэн авчирчээ. Бат өглөө бvр танхим руугаа явах бөгөөд Итгэлтийн морийг унана. Үвнийг хараад «өглөө бvр морь унаж өдөр бvр танхимын гадна сойно. Би танхимын өртөө хийж байгаа биш» гэж бодон хорсоно. Гэхдээ морио хайрласнаас энэ бодол гардаг биш. Унаа гуйсан хvнд өгдөг л морь. Зөвхөн өөрт нь сургуулийн махнаас ашиг олъё гэхэд нь саад хийсэн Бат унаж байгаад дургвй нь хvрч байлаа.

Энэ бодол нь буглаж дэлбэрэх болсон вед Хонгор хатирт шаргыг Батад барьж өгсөн билээ. Бат тэвчиж чадалгвй Итгэлтэд хариу vг хэлсэн бол хэрvvл гарах нь дамжиггвй байсан. Батын царай минчийн улайрч Итгэлтийг шvд зуун харснаа Галсангийн уургалсан бор vрээг чихдэн хазаарлаж аваад Хонгортой нийлэн эмээллэв.

— Аавын ямар тахилыг буруу өрчихсөн юм бол доо гэж Хонгор гэнэн цагаан сэтгэлээр хэлээд инээмсэглэв.

— Цөгцөнд нь өөр голын ус орчихсон байлгвй дээ гээд хиймэл хөгжилтэй инээмсэглэснээ, — За би мордлоо гээд Бат сэв хийтэл мордож цулбуураа авлаа.

Бат муу санаатай болоод Хонгорт vнэн явдлыг хэлээгвй биш, тvvний сэтгэлийг зовоохгвй гэснээс ингэж займруулан өнгөрүүлжээ.

Бор үрээ булгиж гарлаа. Бат нилээд тогтож байснаа дөрөөгөө алдаж ар нуруугаараа пид хийтэл унаад цулбуураа тавилгвй чирэгдэж байгаад тогтоов.

Энэ бүхнийг их гэрийн гадна зогсон харж байсан Солонго дуу алдан «тавьж орхи, тавьж орхи» гэж хашгиран гвйв. Гэвч очиж чадсангвй. Учир нь Бат түргэн босож зvvн гараараа бор үрээг чихдэж байгаад дахин морджээ.

Үрээ омогшин нилээд булгисан боловч шүд зуусан Бат дахин шороодсонгвй шанаа руу нь ташуураар цохин залсаар хошуу захиргаа руу явлаа.

Итгэлт шарга морио уяанаас уяад хонгорын гэрт орлоо. Сүрэн том гуулин шанага барин сvv самарч байлаа.

— Аав нь өр нэхэхээр Гичгэнэ өөд явлаа. Чи нөгөөдрөөс хонио хяргуулж үзээрэй.

— Би нөгөөдрийн маргааш эхэлье гэж бодоод нилээд улсад хэл хүргэж орхисон. Өнөөдөр Галсан ахыг явуулж хашаанаас майхан авчруулъя. Орой хэдэн бяслаг шахчихъя. Та санаа зовсны хэрэггвй.

Итгэлт бэрээ бахдалтайгаар харж сэтгэл дvvрэн мишээв. Сүрэн бол Итгэлтийн санаанд тохирсон бэр бөгөөд үнэндээ тvvний баруун гар байлаа. Өөрөө ажилд сүрхийгээс гадна бусдыг ажил хийлгэж чаддаг уран нарийн ухаантай бас олз авах ажлын дөр мэднэ.

Буугаад мордсон хүнээр боловч адагтаа л түлээгээ хагалуулаад авчихна. Хул айраг өгвөл унага татуулж орхино.

Өнгөрсөн жил ахар хяргахаар цугларч ирсэн олон хүнийг дөрвөн хэсэг болгоод дунд нь зузаан цай соном хадаг тавьж «хэний хэсэг олон хонь хяргавал тэр үүнийг авна» гэсэн бөгөөд цай соном хадаг авах гэж хэсэг бүхэн өрсөлдөн, нар шингэх вед ажил гвйцэж билээ.

Үүнийг бахдан харж байсан Итгэлт «чи миний бэрийг юу гэж байлаа. Заяатай хүн гэдэг чинь угсаатай хүнийг биш, ухаантай хүнийг хэлдэг юм шvv дээ» гэж Должинг тавлаж билээ.

Хотод тарваганы арьс үнэд орсныг мэдээд өнгөрсөн намар баахан тарвагачинд өдрийн хоёр арьсаар унаа хөлслөн өгч хэдэн зуун тарваганы арьс авсныг Итгэлт хот оруулан худалдаж үлэмж ашиг олжээ.

«Манай Сүрэн атга шороо аваад гарахад мөнгө болгочихоод ирэх ухаантай хүн» гэж Итгэлт бэрээ дотроо магтаж явдаг болжээ.

Өөрөөс нь гарамгвй ухаан Сүрэнгийн хэлсэн үг хийсэн ажил бүхэн нь үргэлж зөв урагштай болон тvvнд бахархах тусмаа Итгэлт өөрөө мэдэлгвй Сүрэнгийн гарт орж заримдаа зөрөхөд нь аяыг нь дагадаг болов.

Саяхан шиг Итгэлт нутгийн нэг хүнээс үнэтэй морь авахаар ярилцаж байхад нь сvv хөөсрvvлж байсан Сүрэн:

— Аав минь өдөр шөнөгвй зүтгэж олсон юм аа шороо шиг цацаад яах нь вэ? гэхэд нь

— Манай Итгэлт наймаа хийхдээ хүнээр заалгахгвй байх аа гэж морио үнэ хүргэж өгөх болсонд баярлаж байсан хүн ёжтой хэлээд хүйтэн инээмсэглэхэд

— Таны цаасан малгай манай аавын толгойд багтахгвй гээд Сүрэн хөгжилтэй инээж билээ.

Энэ вед гадна нохой хуцсаныг далимдуулан нөгөө хүн «Танайх овоо хуцдаг сүрхий нохойтой болжээ» гэж Сүрэнг дайрав.

—Хоол сайтай нохой ингэж сайн хуцдаг юм. Танайх муу хуцдаг бол нэг бол муу нохойтой байжээ. Эсхүл харамлаад тэжээж чаддаггвй байж л дээ гэж Сүрэн ажиггвй хэлээд төвийсөн сvvгээ самарснаа

— Аав та халуун сvv хийлгэх үү? гэж юу ч болоогвй юм шиг тайван асуув.

Итгэлт тэр морийг авагвй бөгөөд хүн доромжлох гээд амруугаа алгадуулж үг дуугарч чадахгвй болоод царай нь минчийн хор нь буцлан суусан хүнийг хараад хөх инээд нь хүрч,



бэрдээ бахархан байж билээ.

Тэр өдөр Солонго хонь хариулав. Сайхан зуны өдөр морьтой хонь хариулахын сайхныг зөвхөн үзсэн хvн л мэднэ. Хаашаа л харвал цэцэг ногоо амьсгалахад даанч саад болох юмгvй ажээ.

Батад тамхины уут хэдэн өдөр урлан шагласнаа өнөөдөр дуусгая гэж морио чөдөрлөн тавиад оёж байтал дэргэд нь

— хонь тогтож байна уу? гэж бvдvvн дуутай хvн асуухад цочин харвал Бадарч байлаа.

— Тогтож байна. Та сайн явж байна уу?

Бадарч сайхан борлог морь унаж нvд булаасан өндөр хээр морь хөтөлжээ. Тvр зогсоход нь тэр хоёр морь толгойгоороо тоглон газар цавчилж байгаа нь Солонгын сэтгэлд нэг юм төрvүлэв. «Бат чинь өөрийн гэх морьгvй учраас өнөө өглөө амаа мэдэхгvй эмнэг vрээ унаад явсан. Ийм морьтой бол хаанаас тэгж боогдох вэ. Чи энэ хоёрын нэгийг авч Батдаа өг» гэж сэтгэл нь vглэн гуйж гарлаа.

— Бадарч гуай, та энэ хоёр мориныхоо нэгийг худалдах уу?

— За чи мориор яах нь вэ? гэж инээмсэглэн хэлээд Бадарч мориноос буув.

— Зvгээр. Худалдвал авъя гэж бодсон юм.

— Үнэ ханавал худалдахгvй юм ахад нь байдаггvй юм шvв дээ гээд Бадарч ногоон дээр тавлан сууж тамхи татлаа.

— Та ямар vнээр өгөх юм бэ?

— Чи vнэхээр авъя гэж бодож байна уу?

— Тийм ээ. Авъя л гэж бодож байна.

— Хорин янчаан тоолвол дуртайгаа мултлаад ав.

Солонго морьд руу харан хэсэг дуугvй байлаа. Тарга хvчээ авсан хоёр сайхан амьтан сэтгэлийг нь хөдөлгөн хаашаа ч явахад бэлхэн гэсэн юм шиг хазаар дарна.

— Би энэ бөгжөө өгвөл та нэгийг нь өгөх vв? Гээд Солонго хурууныхаа бөгжийг vзvүлэв.

Солонгын хуруу руу Бадарч харлаа. Бvдvвн гэгчийн шижир бөгж нарны гэрэлд гялалзан тоглож байлаа.

— Аль вэ? аваад аль.

Бадарч бөгжийг авч гар дээрээ хаян vзэв. Нэг морь байтугай хоёр морио өгөөд эмээлээ vврэн явахад алдахгvй харин хожих ажээ.

— Гуравхан цэн орчим юм уудаа.

— Үгvй таван цэн.

— Чи тэгээд мориор яах нь вэ?

— Надад хэрэгтэй

— Ах нь наймаа хийвэл буцдаггvй хvн шvв. Азанд муу байдаг юм.

— Би буцахгvй.

— Аль нь ч номхон, хөл хөнгөнтэй, залуу морьд шvв. Уг нь зармааргvй л байна.

— Надад аргагvй л нэгийг нь өгчих л дөө.

Хэсэг цааргалсны эцэст Бадарч хээр морио бөгжөөр тулгаж солиод явахдаа

— Наймаа наанатай, цаанатай байдаг. Буцах гэвэл ах нь хvлээхгvй шvв. Наймааг хийхгvй байж болно. Харин буцаж болохгvй. Азанд муу гэлээ.

Хэдэн морины vнээр нэг морио өгсөн Бадарч тэнгэртэй яваадаа бахархан явсан бол Батыгаа өөрийн гэх унах морьтой болгосондоо Солонго баярлана. «Одоо тэр минь vvнээ унаад явахад хэн ч харамнаж чадахгvй» гэж бодон хээр мориог таалан зогсов. Эмээллэж унах гэснээ «Бат минь эхэлж унаг» гээд болив.

Оройн хонь орох цаг болоход хээр морио хөтлөн гэрийн зүг хонио гилж эхлэв. Ингэж явтал сэтгэлд нь нэг сүрхий юм орж ирлээ. «Үүнийг хараад аав юун морь вэ гэвэл юу гэх вэ?», «Бөгж чинь хаана байна вэ?» гэвэл яах билээ? гэж бодогдоод хариу нь олдохгүй бухимдан айж эхлэв.

Замд нь бэлчиж байгаа сувай адуу нь тааралдахад ногтыг нь мултлан тавив. Гэртээ ойртон очиход зэл уяан дээр Батын эмээлтэй үл таних цавьдар морь байлаа. Бат тэр өдөр Итгэлтэд шаралхсандаа хорин мөнгөн янчаанаар залуухан бөгөөд бие бялдар сайтай, жороо, сайхан сайвар цавьдар морь авчээ. Ашгүи тэр өдөр Гичгэнийн гол орохоор явсан Итгэлт буцаж ирсэнгүй. Шөнө нь Солонго нөхөртөө морь юугаар авснаа нэгд нэггүй ярив.

— Иш өвгөн минь. Аав чамаас бөгж нэхнэ. Үүнээс болж хадам бид хоёрын харьцаа улам муудна. Ер нь энэ хээр морь бидэнд жаргал өгөхгүй, зовлон л авчрах байхдаа. Гэвч одоо түүнийг ярихын хэрэг алга.

— Тэгвэл Бадарч гуайд морийг нь буцааж өгөх үү?

— Цусаар уйлж гуйсан ч тэр буцаахгүй

— Тэгвэл бөгжөө буцаан худалдаж авъя

— Хээр морин дээрээ бид хоёрыг нэмүүлээд ч өгөхгүй дээ.

— Ижийд яг ижил бөгж буйг гуйж авна.

— Хадмын гараас ижий чинь яаж мултрах вэ?

— Сурсан юм болно байх. Харин Бадарч гуай л аавд хэлж орхивол яана даа

— Бадарч хэлэхгүй. Хээрээс олсон олзондоо баярлаад мий хумсаа нуудаг шиг нууна. Харин хээр морийг мөнгөөр авсан гэж ярина шүү.

Маргааш нь адуу манаж ирсэн Галсан

— Бадарчийн хээр манай адуунд нийлж орхижээ гэхэд нь :

— Би өчигдөр худалдаж авсан юм. Өлгөөд аль гэж Бат хэлж билээ.

Хээр морийг унаад танхимын зүг явж байхдаа Бат эхнэрийнхээ сайхан сэтгэл Итгэлтийн хатуу занг бодож эцэг охин хоёрын нэгэнд нь хорсож, нөгөөд нь баярлана.

«Солонгоо бодоод л тэвчээд байя. Гэвч тэвчээрт эцэс бий. Тэгээд нэг өдөр хадам бид хоёрын дундаас түймэр асвал яана даа. Би л хадмын аяыг харж түүний зарц нь болохгүй. Алт дэвсэж өгөвч сургуулийн хаяанаас салахгүй. Солонго минь намайг л дагах байх» гэх зэрэг бодож явлаа.

## II

Заяын хүрээний хамбын уужим хашааны баруун хойд булан дахь хагас модон саравчинд шалыг нь өндөрлөн барьсан гэрийн ихэнхийг янз бүрийн гүнгэрваа, жаазтай их бага бурхан эзэлсний голд нь алтан хээ тавьсан улаан гүнгэрваатай буддагийн том хөрөг харагдана. Тавтай завилан сууж өвөр дээрээ тавьсан зүүн гартаа том хар аягаа тосон бариад ер бусын зөөлхөн нүдээр үүдрүү ширтэн гөлөрсөн тэр дүрс, түүнд газрын хүрэн хувийн сэнгэнэм нялуувтар үнэр, хангайн нурууны арцны гашуувтар боловч исгэлүүн зөөлөн үнэр, цэнхэртэн униартсан битүү өнгө энэ бүхэн нь гэрийн дотрыг эрхэмсэг байдалтай болгожээ.

Хамба лам гэрийн баруун талд байх өргөн бөгөөд хашлагатай нам модон орон дээр бор баавгайн арьс дэвсэж хурган дотортой хазгай захтай шар торгон дээлээр бөгсөн биеэ ороон суужээ.

Гэрт лам голдуу арваад хүн суусны дотор гэсгүүн, гэвш зэрэг хэдэн хүн байх бөгөөд дөрвөн харчуудын нэг нь Бадарч байлаа.

— Бүгд цугларсан уу? гэж хамба гэрийн зүүн талын хүмүүсийн дээгүүр ширтэн байж асуув.

— Жа бvгд ирсэн гэж Цамба өчив.

— Яндангаа авч орхи. Үвгээр чинь дамжуулж улааныхан сонсож орхидог юм гэдэг шvv гэж гэсгvй хэлэхэд хамба шоолон инээмсэглэх мэт болсноо

— Тэр ч яамай. Харин vvd хаалган дээр хvmvvc тавьсан биз гэж Цамбад хандан асуув.

— Тал бүрд арваад хvн бий.

— Итгэлтэй улс биз.

— Итгэлтэй. Сайн хvmvvc.

— Цаг зэvvvн болоод хvн итгэхэд яггvй болж дээ гэж нэг лам хэлээд бvхнийг тойруулан харлаа.

Хамба хоолойгоо засаж, эрихээ өмнөх ширээн дээрээ шар хийтэл тавиад «Өнөөгийн байдлыг ажиглавал ардын засаг өдөр хоног өнгөрөх тусам газар авч биднийг хаврын туранхай төлөг шиг хөдөлж ядсаар байтал идэж орхих гэж байна. Жас болоод угсаатан татвар төлж, өртөө хийх болов. Хамжлагатай байх, угсаа залгамжлах ариун ёсыг vгvй хийжээ. Анх засаг дарга гэгч нэрээр хошуудын эрхэнд vлдээсэн ноёдыг сонгууль гэгчийг хийх нэрээр зайлуулав.

Ардын намдаа анх бидний зарим нэгийг элсvүлж авсан нь цаг хожиж, хvч хуримтлуулах гэсэн башир арга байжээ. Есдvгээр богдын дvрийг залахгvй нь тодорхой болов. Ингээд бvх эрхийг эзлэн авч, толгой дээр маань бvрэн суулаа. Ийм вед нэг бол намрын ялаа шиг бээрч эвхрэн хэвтсээр vхлээ хvлээх болжээ. Эсхvл шашин бурхан, ёс суртахуунаа хамгаалан занчилдах цаг болжээ» гэж эхлээд ардын засагтай тэмцэж, тvvнийг устгах арга замын тухай ярилаа.

Хамбын бодлоор ардын засгийг устгахад гурван гол зvйлийг дэс дараатай, тун нарийн хийх ёстой ажээ.

Нэгдvгээрт тvvнийг ард олноос салгаж олныг тvvнд дургvй болгох ёстой. Монгол орон бол шарын шашинд гvн орж жаргал зовлонгоо тvvнтэй нягт холбожээ. Ардын засаг vвнийг айхтар мэдэж шашныг олны нvдний өмнө ил хөндөлгvй орхив. Гэвч vргэлж тvvний доогуур дарь булж байна. Энэ учраас ардын засаг бол шарын шашинтай харш бөгөөд нэг нь нөгөөгөө устгах тавилантай гэдгийг олонд ойлгуулах нь чухал юм. Мөн монгол хvний амьжирлага бол хувийн хэдэн мал мөн. Ардын засаг бол олон тvмнийг мал хөрөнгөөс нь салгаж, бvхнийг мод барьсан гуйлгачин болгох эцсийн бодлоготой гэж нийтэд ойлгуулах нь чухал. Үвнийг хийж чадвал ардын засгаас олныг салгаж чадна.

Хоёрдугаарт ардын засаг бол улаан орос улстай дотно барилдалгаатай болж тvvнээс тусламж дэмжлэг авч байна. Энэ учраас чадвал тvvнийг орос улсаас салгах, олныг орост дургvй болгох, vвний тул элдэв яриа цуурхал гаргах, оросоос ирж байгаа барааг хvртэл муу хэлж олныг авахгvй болгох. Үвний хажуугаар гадаадын хөрөнгөтөн улсуудтай холбоо барьж зэр зэвсгийн тусламж авах. Бас энэ ажлыг бvтээхээр найдвартай хvнийг томилон явуулах.

Гуравдугаарт ардын засгийг эсэргvүцсэн олны хvчийг нэгтгэж цагийг тохируулан зэвсэг барин vзэлцэх. Энэ дайн бол шамбалын дайн гэж олон сvсэгтэнд ойлгуулах хэрэгтэй ажээ.

Хамба удаан ярилаа. Ярьж байх завсраа байн байн хамрын шар тамхи татаж хөндий ханиалгана. Нэгэн хэсэг цугларагсад дор бvрнээ бодол болон дуугvй сууж байтал <Би есөн ланжуу буу олон хайрцаг сумтай билээ. Үвнээ энэ хэрэгт нийлvүлэхэд бэлхэн байна. Бас ардын засгийн хvmvvc, тvvнийг талархагчдыг алж хороох ажлыг хийе гэж бодож байна> хэмээн Бадарч хэлэв.

Хамба хvйтэн инээмсэглэснээ <Бадарч минь тэр бол тэнэг хэрэг. Нэг хоёр хvнийг алаад ардын засгийг хөндөж чадахгvй. Харин олон тvмэн тvvнийг улам бvр шvтэх болно. Буу зэвсгийн хувьд бол далайд дусаал нэмэр гэж сайн хадгалж бай. Нэгэн цагт хэрэг болно>

гэлээ.

- Ардын засаг хошууд шавьд өдий төдий танхим байгуулж байгаа нь эцэстээ манай шигманын шашинд үлэмж хортой юм болохоор танхимыг олонд нэр хүндгүй болгох нь чухал байна гээд гэвш лам, хамба руу харлаа.

- Тэр түмэн зөв. Үүнийг хийхэд цагийг хүлээх хэрэггүй. Танхим гэдэг чинь сүүлдээ шашны толгой дээр цахиур хагалах газар гээд нүдээ анивчин хэсэг дуугүй сууснаа өмнөх эрихээ авч хэд шувтраад бид юуны өмнө нэгэн сэтгэлт улсаа олох хэрэгтэй. Тэгэхдээ тун нарийн хийнэ шүү. Өчүүхэн боловч хазгай гишгэвэл ардын засгийн гарт орж их хэрэг унаж магад. Цамба чи нөгөө Жамбалтай ярьснаа эдэнд хэлж өг гэлээ.

- Жамбалыг та бүхэн цөм мэднэ. Бид хоёр багаасаа верхсэнийг ч мэднэ. Одоо тэр цэргийн дарга болоод Ховдын хязгаарын цэргийн аж ахуйн даргын алба хааж байгаа. Үүгээр дайрч өнгөрөхөд нь би хагас сар хамт наргилаа. Дарга болсондоо сэтгэл нь ханаад, ингээд зүтгээд байвал жанжин ч болж магад гэж боддог бололтой. <Өвгөн чинь ардын засгийн нүүрэн дээр муугүй амьдарч, төрийн төлөө зүтгэж явна> гэж уулзмагц надад хэлсэн. Надаас ардын засгийг муу хэлсэн үг цухуйхын хамт <цэргийн даргын дэргэд ийм юм ярьж болохгүй> гээд огт халгаагаагүй.

- Золиг чинь бидэнд гай тарих юм биш биз? гэж гэвш асуув.

- Чадахгүй. Энд өр алдаж аргагүй болоод хулгайн морь хямд үнээр авч баларсан. Бас мянга гаруй сумтай гурван орос ланжуу надаар дамжуулж зарсан. Тэр ланжуу бидэнд буй. Ингээд миний гарт орсон болохоор гай тарьж чадахгүй. Харин ч нэгэн цагт тус болно.

Энд цугларагсад ардын засгийг хэрхэн унагаах тухай ярьж байлаа. Гэхдээ тэдний хэн нь ч хувийн өшөө хонзонгоос биш зөвхөн л шашин шүтлэгээ хамгаалах, нийт монгол үе улиран дагаж ирсэн ёс заншлаа аврах сэтгэлээс болж ардын засагт өшсөн тухай ярина. Үнэндээ бол цөм л ардын засгаас болж ямар нэгэн хохиролд учирсан хүмүүс байлаа.

Цамбын бодлоор бол ардын засгийн бодлогыг олонд гутааж, түүний хүчин чадлыг доройтуулахын тул хүн үнэмшмээргүй юмыг ч ярихаас буцахгүй ажээ.

Орос чихэр бол орос эхнэрийн мөөмний сүү гэж хүрээний лам нар ярьж эхлэхэд ийм тэнэг ярианд хэн итгэх вэ гэж бодож байсан. Гэтэл хүмүүс худалдаж авах нь үлэмж хорогдсоныг би нүдээр үзсэн. Том худал хэлэхэд арай ч тийм том худал хэлэхгүй байх гэж итгэх ёс байдаг бололтой гэж Цамбын хэлснийг хамба, гэвш зэрэг хэд хэдэн хүн ихэд дэмжин зөвшөөрөв.

Бас ардын засгийг унагаахын учир гүрэм хийх, золиг гаргаж хараал хийх. Жигжидийн сор залах зэрэг олон төрлийн хурал, ном хурахаар тогтов.

- Энэ бүхэн хэрэгтэй. Гэхдээ л бид нэгэн цагт шамбалын дайнд мордоход бэлхэн байх нь чухал. Бидний өмнө цэрэг зэвсэгтэй догшин чаралба байна. Түүнийг гагцхүү цэрэг зэвсгийн чадлаар даран туулах болно. Богд ламын ариун шашны түүхэнд зэвсэгтэй дайсныг зэвсгийн чадлаар, мэтсэнийг мэсийн хүчээр доройтуулж байсан удаа олон билээ гэж хамбын хэлэхэд гэвш энэ үг гарцаагүй үнэн болохыг баталсан олон зүйлийг иш татан ярив.

Гэвшийн яриаг хамба толгой дохин, үлэмж таалалтай сонсож завсарт нь баталсан үгнүүд нэмж байлаа.

- Гар хөдлөх цаг болсон. Гэхдээ би өнөө маргааш гэж байгаа юм биш шүү гээд хамба суудлаа засах зуур олныг ажиглан нүдний булангаар харснаа гэнэт огцом дуугаар, - За тэгээд хэнийг явуулах вэ? гэж тулган асуув.

- Хаашаа?

- Ванчин Богд түүдээс оргож залраад, хятад нутагт ирээд байна. Юуны өмнө түүнд бараалхаж хэрэг явдлаа айлтгах нь чухал. Та бүхэнд итгэн хэлэхэд миний хүрээний багш

минь Ванчин богдой холбоо барьсан. Биднийг хвчлэн хөдлөх цаг болсон гэж зарлиг буулгасныг саяхан надад тусгай хvнээр хэлvвлсэн. Биднээс элч болж явахад хамгийн талтай хvн бол Цамба байна. Олон лам нарын төлөг тохирсон. Цамбыг хил гаргаж өгөх хvн бол Бадарч. Энэ хоёрын зам нь цагаан, мөр нь балархай байгаа юм. Тэдний замыг ямар ч бартаагvй байлгахаар Гомбын сор зална. Сор залснаас арав хоногийн дотор мөрөө баруун өмнө зvг гарган хөдлөх ёстой гээд Цамбыг ширтэн харлаа.

Хамба сvвлийн вед ардын засгийн эсрэг шургуу ажиллаж байгаа хvн, хvрээний нэгэн сэтгэлт лам нартай холбоо барьж ойрын жил ардын засгийг унагаах зорилго тавин, энэ хэрэгтээ гадаад орны тусламж олохыг хичээж байгаа бөгөөд дундаж холбоо нь Далай ламтай эрх булаалдан тохирохоо болиод тvвдээс хөөгдөн дотоод монгол, Манж нутагт оргож ирээд орогнож байсан Ванчин Эрдэнэ болж байлаа.

Алс холын аюултай замд явах дур Цамбад ч, Бадарчид ч байсангvй. Гэвч тангараг өргөсөн болохоор шууд няцаж явахгvй гэж болохгvй. Элдэв гачигдал зовлон тоочин энэ удаа явахаас чөлөөлж өгөхийг гуйсан боловч тус болсонгvй чихэгдэв.

Ванчин Богдод барих бичгийг хамба тvвд хэлээр зохион бичээд хэдэн хоногийн дараа хvрээний лам нарыг ханиад томуунаас зайлуулах нэрээр Гомбын төмөр голтой сор залах болов.

Цогчин дуганд сор залах хурал өглөөнөөс эхлэн хуралдаж оройн нар жаргахын вед төмөр голтой, том улаан балинг дөрвөн лам дамжлан дуганы хаалгаар гаргахад хойноос нь өндөр хоргой оройтой, булга татсан овоодой өмссөн улаан торгон дээлтэй хамба хадаг яндар ишнээс нь зvвсэн урт төмөр пvрэв барин сvртэй чичилж, амьдрал нь шувтарч яваа хvний хөндий бөгөөд зэвхий дуугаар ном уншин гарч ирлээ.

Балинг дагасан лам нарын урт цуваа аажим явсаар хvрээний баруун өмнө талд гарахад хуурай модоор барьж шар тос нэвтлэн шингээсэн овоохой байлаа. Балин барьсан дөрвөн лам хөл нийлvвлэн аажим алхаж явсаар овоохойд тулж зогсоход хамбын нvд нь гялалзан хоёр хөлөө ээлжлэн урдуураа махийлган өргөж, гараа дээш нь цацлан цамнаж пvрэвээ гялалзуулах нь сvржин бөгөөд эгэл жирийн хэрэг биш мэт харагдах ажээ.

Овоохойд гал хvрмэгц тос нэвтэрсэн хуурай мод шажигнан дvрэлзэж ёстой л тэнгэрт тулсан гал оволзон асаж хар утаа оргилов. Хэнгэрэг цангийн дуу хvчтэй болж цохилт нь тvргэсэн Хамбын пvрэвтэй гар балингийн том зэс царанд хvрэхийн хамт дөрвөн лам гал руу балингаа шидэв. Үй тvмэн оч бужигнан хvмvвс шахцалдан галаас зайлав.

Хэсэг болсны дараа лам нар эргэж явахад дутуу шатсан балингийн vлдэгдэл олж идэх гэсэн нохой банди нар л vлдэж билээ.

Үvнээс хэдхэн өдрийн дараа Ламын гэгээний хvрээ орох нэрээр дөрвөн морьтой хоёр хvн мааньтын шилээр өглөө эрт давсан нь Бадарч, Цамба хоёр байж билээ.

### Ш

Нялх ногооны анхилам vнэр ханхалсан зуны эхэн сарын найртай сайхан өдөр Цэнгэл уулын хошуу захиргааны өмнvвр гарсан Тамирын голын нөгөө талын эрэгт саарал морьтой хvн ирж буугаад хайрга дээр явган сууж нvврээ угаав.

Баруун уулын орой руу хэлбийсэн нарны туяа тvргэн урсгалт тунгалаг голын мандал дээр жирвэлзэн тоглож байгаа нь харсан бvхний нvдийг татна.

Эрдэнэ ус харан хөдлөлгvй сууна. Тvвний өргөн магнайд хэдэн ve үрчлээ байн байн тодрон,

заримдаа нүд нь хөдөлгөөнгүй болон гөлөрнө. Эрдэнэд бодох юм их байлаа.

Ардын засгийн хийж байгаа ажил бүхэн лам нар болоод эрх ямбаа хасагдсан ноёд тайж нарын ил, далд эсэргүүцэлтэй тулгарч байлаа. Тэгэхдээ эдний хүч их бөгөөд гарт нь малын ихэнх байсан болохоор түүнээ түшиж ардын засгийн ажлыг эсэргүүцнэ. Тэдний мал сүргийг хариулан амьдардаг хүмүүс олон байлаа. Энэ учраас зарим ийм хүнийг танхимд хүүхдээ өгөх буюу засаг захиргааны сонгуульд оролцвол хариулуулж байгаа малаа авна гэж айлгасан удаа ч гарч байлаа.

Ард түмний ихэнх хэсэг нь гүн бишрэлд автагдсан учир үүнийг ашиглан ардын засаг, түүний хийж байгаа ажлыг эсэргүүцнэ. Тийм бурхны номд, ийм гэгээний лүндэнд ардын засаг тэгж устах ёстой, ардын засаг буй болсноос цаг зэвүүн болж байна гэж ярина. Ард олны хүүхдийг бичиг эрдэмд сургах гэж хэд хэдэн сумын дунд тавин хүүхдийн орон тоотой танхимууд байгуулав. Гэтэл түүнийг устгахын тул чулуу мэрэхээс бусдыг хийх ажээ. Үүнээс зарим хүн хүүхдээ танхимд өгөх дургүй болов. За тэгээд арайхийж хэдэн хүүхэд цугларуулж авах дээр танхим дээр чөтгөртэй болов гэх буюу өвчин тахал хүртэл тарааж байлаа. Хүүхдийг элдвээр ятган орлуулах нь бараг л ердийн явдал болжээ. Ингээд ажиллах нөхцөлгүй болгоход нь аргагүй болж хөхөө өвлийн хүйтэнд нүүлгэж ч байлаа.

Танхимын хүүхдийн орон тоог гүйцээх гэж Эрдэнэ хүүхдийг айл, өрхөд оногдуулан дайчлах шийдвэр хүртэл гаргаж билээ.

Энэ зун малын тооллого явуулсан нь маш бага тоо гарчээ. Шалтгааныг судлан үзвэл баячууд, жас малаа үлэмж хэмжээгээр дарж, мөн зарим ядуу дунд ардыг ч энэ хэрэгтээ татан оруулав. Мал дарах явдал хоёр үндсэн шалтгаантай байлаа. Нэг хэсэг нь зориуд ардын засгаас хийж байгаа ажлыг эсэргүүцсэнээс мал сүргийг тооноос нуужээ. Энэ бол бага хэсэг нь байлаа. Нөгөө хэсэг нь малын хөлд оногдуулах албан татвар, өртөөний албыг хорогдуулах гэснээс малаа даржээ. Хэдийгээр эцэстээ энэ хоёр хэсэг нь засгаас өөрийн орны эдийн засгаа зөв ойлгоё гэж хийсэн ажилд сүрхий хор хүргэсэн авч адилд үзэн тэмцэж болохгүй байлаа.

Эрдэнэ ардын засгийн төлөөний түшмэлийн хувьд малыг дахин тоолуулах болж хошуудад хүмүүс томилон явуулсан бөгөөд өөрөө Цэнгэл уулын хошуунд тооллого явуулахаар ирж байгаа нь энэ билээ.

Урьд Итгэлт хэдэн малтай байсныг Эрдэнэ бараг л нас, шүд, зүс хүйсээр нь мэднэ. Гэтэл саяын тоогоор Итгэлтийн мал хэдэн жилийн өмнөхөөс үлэмж хорогдсон байлаа. Ингээд бодоход гаргасан тоо хуурамч нь эргэлзээгүй. Гэхдээ дахиад тоолоход дахиад дарна. Ахиулж чадахгүй бол тавлан шоолно.

Даруулахгүй гэвэл нутгийн хүмүүсийг оролцуулах хэрэгтэй. Гэвч энэ бол ийм хялбар ажил биш. Нэг хэсэг хүмүүс нутгийн ах дүүтэй өштөн болохгүй гээд дарсан малыг илчлэн гаргахгүй. Нөгөө хэсэг хүмүүс бусдын муу үзэхгүй гээд хэлэхгүй. Гуравдахь нь айж зовоод хэлэхгүй. Бас тэгээд энэ өргөн нутгийн аль хонхорт буюу модонд хичнээн мал дарж нуусныг олоход бэрх.

Бэрхшээл саад их. Гэвч тоолох хэрэгтэй. Тэгэхдээ урьд гарснаас ахиулах нь чухал.

Эрдэнэ алгуур босож мордоод Тамирыг гатлав. Хир зэрэг гүн байсныг ч, бараг л мэдсэнгүй бөгөөд нэг мэдэхэд Тамирын гол ард нь үлдсэн байлаа.

Хошуун дээр ирж удирдах хүмүүстэй ярихад хийсэн тоогоо буруу болсон гэж хэн нь ч хэлсэнгүй.

Хошууны намын үүрийн дарга Гончиг <одоогийн байдлаар даруулалгүйгээр тоолох боломжгүй байна. Манай хошууны хувьд бол маш бага дарсан байх даа> гэж хэлэв.

Бүх айлын малыг ганц өдөр зэрэг тоолбол үлэмж зөв тоо гаргаж болохсон. Гэвч тийм хүч

боломж байхгүй.

Эрдэнэ шууд мал тооллогодоо орсонгүй. Харин ирснийхээ маргаашаас эхлэн айл хэсэж авгай хvvхэдтэй баахан ярьж, бас замд тааралдсан малын дотор ямар нэгэн содон тэмдэгтэй нэгийг нь дотроо цээжилж байлаа. Бас хэд хоног Гончиг зэрэг хvmvвсийг ингэж ажиллуулав. Иймэрхvv ажилласан нь сайн, муу хоёр талтай байлаа. Сайн тал гэвэл юу ч л гэсэн бэлтгэж авсанд байв. Муу тал гэвэл тооллого дахин явахыг хvmvвс мэдээд бас бэлтгэв.

Эхний айлыг маш сайн тоолж, урьдахтай зөрvv гарвал хvнд торгож шийтгэвэл дараагийнх нь дарахаас айх болов уу гэж бодлоо.

Мал дахин тоолох болсныг мэдсэн айлууд зvсэн бvрийн башир арга хэрэглэж эхлэв. Зарим нь таслан зэлvvд газар хөөнө. Зарим нь урьд тоо явагдаж өнгөрсөн сумдын нутагт явуулна. Зарим нь эхнэртэйгээ хvртэл өрх данс салгана. Луйвардах гэж бодоогүй л бол малын өрийг өгөх дуртай болсон байлаа. Харин авлагыг бол яарахгүй болжээ.

Итгэлт юунаас хоцрох билээ. Мал дарж, албан татвар хөнгөлvvлэх ямар арга байдаг бол бvгдийг хийж амжив. Хэсэг малыг өөр сумын нутагт явуулав. Хэсгийг зэлvvд нутагт гаргав. Галсанг эхнэртэй нь хамт тусгай өрх болгож нэр дээр нь хэсгийг тоолуулах болов. Энэ бvхнийг хийхэд хамгийн ойрын туслагч нь Сvрэн байсан бөгөөд <хvv минь хvнийг яаж мэдэх вэ? Өндөр ахынхаа мэдэх содон малыг дарж болохгүй. Цаадахын чинь нvд тун гярхай шvv> гэж тvvнд хэлдэг байлаа.

Ингэж бэлтгэсний дараа Итгэлтийн их гэрийн мал хошууны тэргvvн баяны сvрэг биш дунд чинээлэг айлын зэрэгт хvрэв.

Эрдэнэ намын vврийн дарга Гончиг, намын гишvvн хоёр хvний хамт цогчин жасын малыг тоолж эхлэв.

- Суварган эвэртэй хvрэн хайнаг, далиу эвэртэй хар тарлан хайнаг тэргvvтэй хэсэг малаа та нар мартаж орхих шиг байна гэж Эрдэнэ хэлэв.

Цогчин жасын нярав том тарган шар лам гайхсан байдалтай инээмсэглэснээ

- Тийм сvнсгүй ажил хаанаас хийх вэ. Дарга та лав ташуу болгоож байгаа байх гэлээ.

- Хайрханы арын модонд өнөө өглөө vврээр оруулсан хэсэг адуу хичнээн юм байсан бол гэж намын vврийн дарга Гончиг шууд асуув.

Хэрэг буруу тийшээ эргэснийг ойлгосон жасын нярав сvрэгчин нартаа хандаж <би та нарт нэг ч мал дутааж болохгүй тоолуулах хэрэгтэй гэж хэлсэн биш билvv. Энэ чинь юу болж байна> гэж vлэмж сvржин бууж гарав.

Сvрэгчид нь бараг нэгэн зэрэг <би л мэдэхгүй > гэж хариулав. Энэ хариултыг хэдэн өдрийн өмнө бэлтгэж билээ. Ингэж хариулаагүй хvн маргаашаас нь эхлэн жасын мал хариулж гэр бvlээ тvvний сvvгээр тэжээх эрхгүй болох байжээ.

Гэвч баримт гэдэг хэцvv. Няравын магнайд хvйтэн хар хөлс бурзайж байлаа.

- За юу ч гэсэн та хvн явуулаад хайрханы ард нуусан адуугаа авчруул гэж Эрдэнэ тулгав.

Бvтэн хоёр өдөр Эрдэнэ нөхдийн хамт ингэж няравтай байлдсаны эцэст мал дарсан цогчин жасыг хорин таван бодоор торгов. Эрдэнэ нөхдийн хамт мордоод явахад <Хэцvv чоно оо. Орхон руу явуулсан малыг маань мэдээгүй нь л яамай. Мэдсэн бол дахиад хэдэн бодоор торгох байсан шvv> гэж нярав бодоод өврөөсөө том хөх хадаг гаргаж хөлсөө арчив.

<Мал тооллогын тvшмэл Цогчин жасыг хорин таван бодоор торгожээ. <Дарсан малыг зvсээр нэхэж байна гэнэ> гэсэн яриа Тамирын хөндийд салхи шиг тарж, малаа дарж байсан хvmvвсийн сэтгэлийн мөсийг хайлуулан, цөн урсгав.

Заримтай нь хэрэлдэж, заримтай нь инээлдэж, заримыг нь торгож, заримыг нь сайшааж явсаар мал тооллогынхон Итгэлтийнд очив.

Энэ вед Бат Улаанбаатарт багш нарын уулзалтад явсан учир эзгвй байлаа. Мал тооллогын гийчид ирсэн гэж Итгэлт хонь гарган айраг, архи сөгнөв.

- Зарим айл малаа бодолгвй дарах юм. Юунд тэгж засгийн бодлоготой харгалдаж байдаг юм бол доо гэж Эрдэнийн хэлэхэд Итгэлт нүдээ жартайлган их л гайхсан дүрс үзүүлэн сонсож байснаа хоолойдоо янцаглан инээж

- Ухаанд нь ухна үхсэн дамшгууд. Юунд тийм тэнэг юм хийж байна вэ дээ. Төрийн сүлд гэж нэг юм байдаг юм шvv. Миний хэдийг ч чи таван хуруу шигээ мэдэх болохоор би юу гэх вэ. Салгаж тасалж өгсөөр байтал бараг юм үлдээгвй. Бас тэгээд чамайг ирсэн болохоор надад бүр хэцvv байна. Хvv хvvхэн нь суусан хадмын сүлбээтэй болохоор Итгэлтийн малыг хөнгөн тоолов гэж амьтан ярина шvv дээ. Эрдэнэ ээ энэ жил идэж орхих хэдэн мал байх юм. Тvvнийг заавал тоолуулах уу? гэж асуув.

- Амьд л байгаа бол тоолох л болно доо.

- Би ч бас тэгж бодсон юмаа.

Итгэлтийн малыг бүтэн хагас өдөр тоолов. Гэхдээ ямар ч өө гарсангвй. Нэг хэсэг мал байхгвйг Эрдэнийн хамт явсан нэг хvн үгвйлэв. Гэтэл тэр малыг Галсан мартсан болж, тvvнийг Итгэлт золтой л барьж зодсонгвй. Бас нэг хэдэн үхрийн тухай яриа гарсанд <Та аавд хувь болгоод өгчихсөн шvv дээ. Аав хөгшрөөд хэнд юу өгснөө ч мэдэхээ больжээ> гэж Сүрэн хэлээд аврав. Тvvгээр ч барахгвй Сүрэн гарч Нямын руу Галсанг явуулан хэл хүргэж билээ.

<Итгэлт чи л мал дараагвй байх даа. Нар баруун хойноос навтас нөмрөөд гарсан цагт чи тооноос мал дарахгвй болох байх. Сүрэн хэцvv гэж Батын ярьдаг ортой л юм байна> гэж Эрдэнэ дотроо бухимдавч тулгах баримт байсангвй.

Ингэж байтал Эрдэнэтэй ирсэн нэг хvн Итгэлтийн зэргэлдээ хошууны айлд өгч маллуулсан бөгөөд энэ тоондоо оруулаагвй зуугаад хонины тухай гэнэт санаж яриа гаргахад аргагвй болсон Итгэлт <юу байдаг билээ. Би л огт мэдэхгвй юм гаргаад ирлээ> гээд Сүрэн рvv харлаа.

- Аав та мэдэхгвй. Би өгсөн юм. Тэгээд өөр хошуунд байгаа юм болохоор тэндээ тоолуулдаг юм байх гэж бодоод хэлээгвй юм гэж Сүрэн хэлэв.

- За Итгэлт минь саяын тоо, урьдах тооноос олон малаар зөрж байна. Тэрхvv малаа дутуу тоолуулсан учир таван бодоор торгоно доо гэж Эрдэнэ хэлж билээ.

Ингээд тоочид явжээ. <Би мөрийтэй шатар тоглодог байсан бол манай Сүрэнгээс уран бэрийн хожил гарах байсан даа> гэж Итгэлт бэрээ магтсан ба харин хонь сааж байсан Солонгын дэргэд очиж <Хадам эцэг чинь, манайхыг таван бодоор торгож сэтгэл нь ханаад явлаа. Итгэлт мөчөөгөө өгөхгвй дээ> гэж шүд зуун, зэvvн хэлэв.

Солонго хариу юу ч дуугарсангвй. Гэвч нулимс бүрхсэн тvvний нүд <хадны завсар хавчуулсан халиуны зулзага хөөрхий> гэж дуулж байлаа.

Эрдэнэ мал тооллогоо дуусаж дvнгээ гаргавал Цэнгэл уулын хошуунд урьдах тооллогоос арав гаруй хорь шахам мянган мал илvv гарсан байлаа. Энэ бол бага хэрэг бишээ.

#### IV

Тамирын хөндийд өгөөмөр намар болов. Зvvн хойшоо харсан өргөн амны адаг, дэлгэр цагаан талбай дээр хоёр том эрээн майхан байх бөгөөд эргэн тойронд нь өдий төдий зvсэн бүрийн өнгөтэй том жижиг майхан, чөдөртэй буюу уяатай морьд харагдана. Зарим майхны гадна тvлж байгаа галаас хөх утаа суунаглан байлаа.

Энд шагайг харваж байлаа. Баруун талын майхны vүдэнд дөрвөн хvн суугаад хоймор нь тавьсан шагайг харваж байлаа. Хоёр талаар нь зэрэгцэн суусан хvmvvc янз бүрийн



хоолойгоор уухайлах бөгөөд вандан дээр ганц шагай үлдсэнийг харахад тоглоом тэмцэлтэй болж байгааг гэрчилнэ.

Хонгорын зүүн гарт суусан дөч эргэм насны бүдүүн лам харвах болоход зүүн талын эхэнд суусан хижээл хар хүн <мэргэн минь хичээж үзээрэй. Хожиход ганц хуруу дутуу байна шүү> гээд хахир паргиа дуугаар уухайлахад бусад нь түрэв.

Лам хуруугаа мулталж орхив. <Дутаж байна. Мэргэн минь> гэж хижээл хар хүн хашгирав. Хонгор өвдөг дээрээ хашлагаа зоож том гэгчийн дугуй ясан сум тавиад дунд хуруугаа үлэв. - Манай баг, үхэх сэхэх чиний гарт шүү гэж баруун талын магнайд суусан ханхар эр хэлээд хоолойгоо засав.

Хонгор инээмсэглэх мэт болсноо хуруугаа мултлав. Сум гялалзан нисэж тас гэж буухад жижигхэн шагай үсрэн ор сураггүй алга болов. Хүмүүсийн уухайлах дуу гэнэт хадан хэсэг үргэлжлэв.

- Залуу байхад ч ийм л байдаг сан.

- Үзүүлээд өгч байна даа.

- Сум нь эгээ л бууны сум шиг байх шив гэх зэргээр Хонгорыг магтаж байлаа.

- За яахав. Дүүжин тавьж орхиё гээд зүүн талын оройд сууж байсан хижээл эр өврөөсөө хайрцагтай шүдэнз гаргаж толгойг нь хугалаад тавив.

Тэмцэлтэй болж байгаа энэ шагайг харахаар олон хүн цугларав. Гурван хүн оносонгүй. Хонгорын ээлж болов. Удаан гэгч нь онилж байгаад тавив. Вандан дээр гал манас гэхэд мэргэн харваачийг магтах дуу битүү шуугилдаан, уухайлах дуу майхныг доргиулж байлаа.

- Аргагүй л шагайны дэргэд сууж байхад зовмооргүй харваач байна даа.

- Өчигдөр жавхтай хүнтэй дүүжин өрсөлдөж харваад хожиж байхыг нь би харсан.

Олны магтаалд хөгжин инээмсэглэснээ Хонгор сум хашлагаа хадганд боож өвөртлөөд босов.

- Чи ч харваач эр юм аа гээд танил нэг залуу нь Хонгорын замыг хаав.

- Сайн байна уу. Аз хүү байвал ёоз хүүгээр хожно гэдэг л болж байна гээд Хонгор урамтай инээв.

- Сайн хө. Аз сохор, хуруу мэргэн гэдэг юм даа.

- Чи дороос ирэв үү?

- Тийм. Сумаас гараад ирлээ.

- Ногоон тохойд манайх харагдана уу?

- Юм харагдаагүй шүү. Чи гараад удаж байна уу?

- Өвгөн чинь арваад хонож байна. Уг нь манайх ногоон тохойд л байсан юмсан. Нүүж орхиж л дээ. Аав Сүрэн хоёр дүрэвсэн юм шиг нүүдэг улс даа гээд Хонгор нарийхан бөгөөд урт цагаан шүдээ яралзуулан инээмсэглэв.

Хонгор нэрэлхэж арваад хонож явна гэжээ. Үнэндээ бол гэрээс гараад хорь гаруй хонож яваа юм. Энэ хооронд хийсэн ажил гэвэл шагай харвасан. Ерөөсөө Хонгорын хийдэг ажил нь сайн морь унаж, айл хэсэх, тоглох, дарвиж айраг, архи эргүүлэх, найр наадам хэсэх л юм.

Гэртээ очиход аав, эхнэр хоёр нь нэг бол юм хийж байна. Эсхүл ажлын тухай ярьж байдаг бөгөөд үүнийг хараад Хонгорын залхуу хүрч <насан турш л юм хийх буюу үүнийг ингэе, түүнийг тэгье гэж байхдаа уйддаггүй хачин улс шүү> гэж боддог. Гэхдээ Хонгор эхнэртээ дургүй болсон хүн огт биш. Харин түүний нэг хөгийн амьдралаас уйдсан хүн байлаа.

Сүрэн ямар нэгэн ажил хийж гүйцээд буюу олзтой ажил сэдэж бодоод хязгааргүй баярлан ярихад Хонгор шал өөр юм бодож суудаг билээ.

Сүрэн энэ жил эсгийгээ толгойлж хийлгүүлээд түүндээ баярлан <Чи манай эсгий ямар болсон гэж бодно. Аав ойрын жил ийм олон, ийм чансаатай эсгий хийгээгүй гэж хэлсэн. Би

чамд зориуд тохмын эсгий хийсэн. Удахгвй улаан цэмбээр эмжээд өгнө> гэж баяртай харахад нь <Сүрэн минь мориор үргэлж шогшдог хвн элэгний өвчтэй болдог юм гэдэг шvv> гээд Хонгор эвшээв.

- Би ажил бодож байхгвй бол чи шагай харваж чадахгвй шvv дээ гэж Сүрэн урамгвй хэлснээ,  
- Чи маргааш голын урд гарвал Дамбыг намрын ноос авчирч өг гэж хэлээрэй гэлээ.

Эцэг, эхнэр хоёрын алин нь ч Хонгорын ингэж явахыг хвчтэй зэмлэдэггвй. Итгэлт хааяа нэг хэлэхэд Хонгор ёстой л нэг чихээрээ оруулж нөгөөгөөрөө гаргана.

Өнгөрсөн өвөл Сүрэнгээс хvv гарсан бөгөөд тvvнийг Идэр гэж нэрлэсэн. Тэр хvvхэд үргэлж л Должинтой байдаг. Хонгор хvvдээ хайртай. Гэвч тvvнийг ховорхон барьж үзсэн.

Хонгор майхнаас гарч тэнvvн тааламжтай суниах зуур <Харьдаг хэрэг ээ, нөгөө морь минь хаа байдаг бол> гэж бодоод явах гэтэл ард нь нэг хвн <За Хонгор мэргэн. Манай баг босоо тоглосны найраа манайд хийнэ. Хамт мордоцгооё> гэлээ.

- Өнөөдөр нэг гэрийн бараа хардаг юм бил vv гэж бодож байсан юмсан.

- Тэр яахав. Маргааш л явахгвй юу. Чамайг ноцтол аваад хаяхад чинь Гончигийн багийнхан муужран унах шахсан шvv гээд чанга дуугаар тас тас инээв.

Найран дээр Хонгор голлож, тvvний мэргэнийг хvmvvc ам амандаа магтаж байлаа. Нилээд согтсон Хонгор морь харахаар гэрээс гарлаа. Баруун хойноос салхи нэг ve бүлээн, нэг ve сэрvvн холилдон үлээнэ. Тарга хвчээ авсан хоттой хонины хивж яраглах чимээ үргэлжлэн шуугина. Цэлмэг тэнгэрт үдшийн од сvvмэлзэнэ. Толгой нь үл мэдэг манаран, нvvр нь бүлээ татан нэг л аятай ажээ.

Өмнөөс нь хоёр хувин дvvрэн ус барьсан залуу бvсгвй Тэрбиш ирлээ. Тэрбишийн нөхөр Раднаа өнгөрсөн хавар цэрэгт дайчлагдан явжээ. Урьд хурдан морь хамт унаж байсан болохоор Тэрбишийг Хонгор сайн мэднэ.

- Сайн байна уу? Тэрбиш танайх чинь энд билvv?

Раднаагийнх энд гэдгийг Хонгор сайн мэднэ. Гэвч яриа эхлэх гэж ингэж асуув.

- Сайн. Чи сайн уу? Манайх тэр шvv дээ. Заримдаа чи овоохой дайрчих гээд л гардаг юм байх чинь билээ гээд Тэрбиш хөгжилтэй инээв.

- Согтож орхилоо. Танайд орж унтъя. Хөөхгвй биз.

- Сүрэн мэдвэл толгойг чинь хага цохино доо гээд Тэрбиш усаа тавив.

- Раднаагаас сурагтай юу?

- Улаанбаатар хотод байгаа. Хот орвол уулзаад авгай чинь мэнд гялалзаж байна гэж хэлээрэй.

- Больё. Хэрэгт орно.

- Чи ч хаширдаа л амьд яваа хвн байх даа.

- Айж явбал аминд өлзийтэй хө гээд Хонгор согтуу хvний бүдэг хоолойгоор инээв.

- Тэрбиш хувинтай усаа авч хөдлөхөд нь Хонгор үл мэдэг ганхан <хвлээж бай> гээд хойноос нь дагав.

Маргааш нь vvрийн гэгээ тvгэн цайх вед Раднаагийн гэрээс нэг хвн гарч нөгөө гэрvvд рvv хялалзан харсаар уяж хоносон морио унаад зvvн тийш явлаа. Энэ бол Хонгор байж билээ. Өнгөрсөн оройн уусан нэрмэл толгойг нь ангалзуулж эхэлсэн тул холдож чадалгвй нэрж байгаа айл бараадан орой нь Раднаагийн амьтан унтсан хойно буцаж ирлээ.

Анхны өглөө Раднаагийн гэрээс vvрээр мордсон Хонгорыг харж амжсан нэг хvvхэн <Итгэлтийн Хонгор Раднаагийнд хоноод явсан шvv. Тэрбиш ч зvрхтэй золиг юмаа. Битгий хvнд хэлээрэй. Сүрэн дуулбал газар тэнгэр нийлvvлнэ шvv> гэж найддаа хэлжээ. Тэр найз нь бас нэг хvvхэнд <Хонгор, Тэрбишээс салахаа больсон гэнэ. Тийм сайхан эхнэртэй байж хөх

мантуугаар яана даа. Өвгөн минь битгий хвнд яриарай. Ховонд орж баларна шvv> гэв. Ингээд Раднаагийн хоёр дахь оройгоо гэтэн ирж байхад урьд шөнийн явдал нь Тамирын хөндийд сvvлийн сонин болон нэг хvvхний амнаас нөгөө хvvхний чихэнд дамжиж явсаар Сврэнгийн чихэнд өрөмдөн орлоо.

Yvp цайж гэрийн доторхи бvх юм тодорсон вед Хонгор сэрээд ухасхийн босоод тvргэн зуур хувцаслан гарах гэхэд нь <Аяга сvv ууж, өлөн элгээ тайлаад яв л даа> гээд Тэрбиш өндийв. Тvvний жартганан тоглож байгаа нvд <Би сайхан байна уу? Сврэнгээ мартаж орхив уу?> гэж асууж байлаа.

- Зvгээр гэж Хонгор ёворлосон дуугаар хэлээд шууд гарахдаа «Эрvvл байсан бол эднийд би хаанаас буцаж ирэх билээ дээ. Заяа нь орхисон толгой, тvй гэж дотроо хэлээд мориндоо мордон ямар нэгэн юманд хөөгдөж зугтан буй мэт гэрийн зvг давхилаа.

Нvд нь бэлцийн цагариглаж, царай нь шарлан vрчийгээд базаж vнгээд хаясан муутуу цаас шиг болсон Хонгорыг гэртээ ороход Сврэн оёж байсан дээлээ тvлхэж орхиод биеэ хураан муухай харлаа. <Булай амьтан. Чи мэдээгvй юм гэж санаж байна уу? Зvгээр өнгөрөх байх аа> гэж тvvний хорслоор дvvрсэн хоёр хурц нvд хэлж байлаа.

Ирэх бvрийд баяр хөөр болж, болсон явдлыг тоочин ярьдаг эхнэр нь ер бусын байхыг хараад хэрэг биш болж паян задарсныг ойлгосон Хонгор, гэмт хvн гэлбэлзэнэ, дайрт морь далбилзана гэгчээр гөлөлзөн яахаа мэдэхгvй байлаа. Тулганы хажууд товшрогдон суугаад гаанс тамхиа гаргаж нэрэх гэснээ <Миний тамхи хаана байгаа вэ?> гэж сулхан асуув.

- Энд байна гэснээ Сврэн всрэн Хонгорын баруун чихнээс базаж аваад тохиолдсон газраа балбаж гарлаа.

- Yгvй чи яаж байна, болиоч дээ, ёо гэж зайчин байлаа.

- Барагтай дарлаарай. Чамд огт дарлуулахгvй.

- Хэн чамд юу ярьж орхив оо.

- Тийм бий. Тэрбиштэй чи яана гэнээ. Хар ухна! гэж хашгираад улам хvчтэй балбав.

Хонгор арай гэж Сврэнгийн гараас мултран салаад гэрийн нөгөө талд зайлан гарав.

Сврэнгийн нvд гялалзан всчиж гартаа өртсөн бvхнээр шидлээ.

Хонгор шидсэн юмны заримыг барьж авна. Заримаас нь зайлна. Гэвч дэнгийн цөгц баруун нvдэн дээр нь яг буугаад доороо хөхрөн хавдав.

Сврэн баахан харааж нvдэж аваад хэнэггvй гарлаа. Итгэлт хvvгээ ирэхийг хараад орох гэж гэрт нь ойрттол бэр нь нөхрөө газар доогуур ортол хараан, нvдэж байхыг сонсоод орж чадалгvй буцаж хонины хотонд орж модон хvрз барин арилгаж байгаа дvр vзvvлэн чагнав.

<Дамшиг чинь юу хийж орхисон юм бол. Сврэн ч Должин биш дээ. Болгож тавина. Нvд амыг нь бvлт цохичихгvй байгаа даа... Эмээ толгой дээрээ гаргасан хvн их шившиг болно> гэж дотроо бодон хvvгээ харамсаж байлаа. Гэвч орж нэг л чадсангvй ажээ.

Сврэнг хараад модон хvрзээрээ тvргэн тvргэн ажиллаж эхлэв. Сврэнгийн царай минчийн улайгаад нvд нь эрчилжээ.

- Аав та хот арилгаж байгаа юм уу?

- Тийм. Би хот арилгаж байна. Та нар чинь юу болоод л хашгиралдаад байна даа?

- Юу ч болоогvй. Архи ууж ирээд агсагнаж байхгvй юу гээд их гэрт орж хөөрч байгаа тогоотой сvvг юу ч болоогvй юм шиг самарч эхлэв.

Тэр өдөр Хонгор гэрээс гарсангvй. Бас хэн ч тvvнийг орж хөндсөнгvй. Маргааш нь хөх булуу болсон нvдтэй Хонгорыг гvvний зэлэн дээр очиход нь <Юу болоов? Нvд чинь гэж Итгэлт асуухад <Мод всрээд цохичихсон юм> гэж ажиггvй хэлээд царай нь vл мэдэг улайв.

- Тvлээ сэрэмжтэй хагалж байхгvй дээ гээд Итгэлт барьсан унагаа чагтлах зуур <дамшиг

чинь нуух санаатай> гэж бодон дотроо инээж билээ.

Хонгор нэг хэсэг тэнэж алга болохгүй байснаа Төмөрийн өгсөн бор морь, өөр нэг морьтой хамт хэд хоног сойж унаад нэг өдөр алга болов.

Хоёр долоо хоног шахам болоод ирэхдээ арван хэдэн согоо шиг морь хөөн авчирч билээ.

V

<Цэцэрлэг мандалын аймгийн намын хороо> гэж улаан шунхан будагтай гуунд шиллэн хийсэн хаягийг халзтай том цагаан эсгий гэрийн тотгон дээр хоёр хvн хичээнгvйлэн хадаж байв.

- Тэгш болж уу хараач.

Том янхир биетэй нарийхан боловч урт хар гээгтэй дунд насны эр гэрээс гурав дөрвөн алхмын зайд очиж зогсон өрөөсөн нvдээ аньж саравчлан харснаа <догь болж шvв> гэлээ.

Нөгөө пагдгар биетэй эр нь амандаа зууж байсан хадаасаа авч ширэн уутанд хийгээд алхаа ишээр нь түрийлэх зуур <Дарга аа гvйцлээ> гэж бvдvвн паргиа дуугаар хэлэв.

Гэрээс Эрдэнэ гарч, vдэн дээр хадсан хаягийг ажиглан харж байснаа <Болох нь ч болж. Уг нь алтан хvрээтэй гуунд том улаан vсгээр бичээд хийсэн бол зvгээр байж дээ> гэлээ.

- Тэгж гоёод яах юм бэ? Ямар бурхны гуу биш гэж бvдvвн эр хэлэв.

- Yвн дээр юу гэж бичсэнийг та мэдэх vв?

- Ална гэсэн ч мад шvв дээ гэж бvдvвн эр инээв.

- Цэцэрлэг мандалын аймгийн намын хороо гэсэн vг шvв дээ

- Гууны нь хvрээнд арслан барс сийлж хийе. Дарга та бичгийг нь гараа гаргаж байгаад бичиж өгнө vв гэж бvдvвн хэлэв.

- Арслан барсаар яах нь вэ? гэж янхир эр асуув.

- Ардын нам маань хvчин төгөлдөр, сvр бадрангуй гэсэн билэг тэмдэг болно шvв дээ.

- Тэр зөв. Та хийгээд орхиорой. Би бичгийг нь бичиж өгнө гэж Эрдэнэ хэлжээ.

- Эрдэнэ Цэцэрлэг мандалын аймгийн намын хорооны даргын ажлыг хийж байгаа бөгөөд гэртээ байх нь ховор, бараг л хошуудаар явж ажиллана.

Нэг удаа Хан өндөр уулын хошуунд дvнгийндээ очиж ирэг гаргуулан өнжив. Ах дvв хоёр засаг төрийн бодлогын тухай ярьж байхыг Өлзий их л хичээнгvйлэн сонсож байснаа.

- Би ч ардын засгийн хvчээр жаргаж байна. Харин урьд надтай адил байсан ядуучууд юу олж авсан бэ. Юу ч олоогvй. Та нар Даансран өвгөнийг хар л даа. Бахь байдаг Гонжоо тайжийн хонь дагаад, хараалгаж, заримдаа зодуулаад л явж байна.

Эртvвд туранхай ямаа мөлхөө шард өгч орхиод ухаан алдтал ташуурдуулж байхыг би харсан, хөөрхий минь. Энэ жил жаран нэг хvрч байгаа амьтан шvв дээ гээд толгойгоо сэжлэн гаслав.

- Одоо цагт зодуулна гэдэг чинь юу гэсэн vг вэ? Хонийг нь хаяад явчихгvй юу. Хошуу тамгандаа хэлэхгvй юу гэж Эрдэнэ хэлэв.

- Яаж амьдрах вэ? Тэр чинь Гонжоо тайжид зарагдсаны хvчээр бор хоног залгаж яваа хvн шvв дээ. Хөөж орхивол эрvв толгой зодолдуулах юм vгvй болно. Бас тэгээд хvний буяныг идэж байгаад эзэнд нь муу юм хийвэл ачийг усаар гэгч болж нөгөө заяа чинь зайлж орхино. Ардын засаг тvвнийг тэжээхгvй шvв дээ гээд Өлзий тамхиа нэрж татлаа.

- Ардын засаг тvвнийг хамжлага биш болгосон. Эрх чөлөө өгсөн, тvвнийг дарлавал төрийн хууль өмгөөлнө шvв дээ.

- Гэхдээ тvвнээс болж гэдэс нь цадахгvй «Ээ дээ хоол олж иднэ гэдэг vв, амаргvй эд шvв хvв минь» гээд буурал толгойгоо сэгсрэхэд vзvврт нь сур уясан шодон гээг модолзож байлаа.

Аймаг руугаа буцаж явахдаа Эрдэнэ энэ ярианы тухай их юм бодов. Өлзийн яриа гэнэн боловч түүнд үнэн юм их байлаа. Өнгөрсөн жил Намын Төв Хороон дээр болсон нэг яриан дээр ядуу хүмүүсийн амьдралыг яаж сайжруулах тухай ярьж удал маргалдсан юм. Эрдэнэ тэр ярианд идэвхитэй оролцож нилээд юм ярьсан. Нэг хэсэг хүмүүс Феодал болон жасын хөрөнгийг хурааж ядуучуудад өмч болгон хувааж өгөх хэрэгтэй гэж байлаа. Нөгөө хэсэг нь өмч болгон өгч болохгүй. Харин улс хурааж аваад ядуу хүмүүст хөлсөөр хариулуулж амьдралыг нь сайжруулбал зохино гэнэ. Гуравдахь хэсэг нь тэр хөрөнгийг хураах цаг болоогүй бөгөөд хураах юм бол улс орны эдийн засагт үлэмж хохирол учирч хожим гашуудавч барахгүй болно гэж байлаа. Эрдэнэ нэгдүгээр хэсэг хүмүүстэй санал нийлж байсан.

- Феодал болоод Жасын хөрөнгийг шууд хурааж ядуучуудад өмч болгон өгсөн цагт бид, олонхи хэсэг нь өлсөж, цөөн хэсэг нь язартлаа идэж байдаг ёсыг устгаж чадна гэж Эрдэнийг хэлэхэд нэг хүн босож <феодал гэж хэнийг хэлэх вэ?> гэж асуув.

- Ноёд, тайж нарыг л хэлнэ.

- Ган хийх нохойгүй буюу зөвхөн амьжиргааны хэдэн малтай хохь тайжийн хөрөнгийг бас хураах хэрэг үү?

- Гэхдээ тэд бол олон биш. Бодын тоогоор тогтоож болох мэт санагдаж байна.

- Хэдэн бодоор?

- Үүнийг ярьж байж тогтоох нь зөв юм.

- Олон бодтой суман эрийн хөрөнгийг яах вэ?

- Жасын хөрөнгийг хураахад ард түмний санал сэтгэл эвдрэхгүй юу? Олон түмний дотор шашин их хүчтэй байгаа шүү дээ гэх зэрэг өдий төдий асуудлыг дөрвөн зүг найман зовхисоос тавьж гарлаа. Эрдэнэ энэ олон асуудалд аргагүй самгардав.

- Урьдаж феодал, жасын хөрөнгийг хураах нь зөв үү? Аль буруу юу? гэдгийг шийдэх нь чухал. Тэгээд хураах нь зүйтэй гэтэл хэний хөрөнгийг хэзээ яаж хураах, дараа нь тэр хураасан хөрөнгөө яах вэ гэдгийг нарийн бодож тогтоох хэрэгтэй гэж хэн нэг хүн хэлэхэд Эрдэнэ харвал намын төв сургуулийн нэг сурагч залуу байлаа.

- Манай ард түмний дунд шарын шашин үлэмж хүчтэй. Энэ учраас одоо вед сүм, хийдийн хөрөнгөнд халдах нь олны санаа сэтгэлийг эвдэнэ гэсэн үг. Харин хар феодалын хөрөнгө бол өөр хэрэг гэж бас нэг хүн хэлэв.

- Хар шар феодал ямар ялгавартай юм бэ? Адилхан л ардыг дарлан мөлжигч шүү дээ.

- Нарийн бодож үзвэл тун их ялгавартай.

- Нэг нь лам дээлтэй, нөгөө нь хар дээлтэйг ялгавар гэж үзэхгүй бол яг л нэг хэвийн боов.

- Их хөрөнгөтөн, олон зарцтай суман эрийг яах вэ? гэдэг чинь сонин асуудал байна шүү.

- Хичнээн хөрөнгөтэй байлаа гэсэн ч суман эр гэдэг чинь ард гаралтай хүн. Манай засаг бол ардын засаг гэх зэрэг удаан маргалдав.

Бараг бүхэл өдөр үргэлжилсэн энэ маргалдаанаас ямар нэгэн шийдвэр гараагүй. Гэвч оролцогсад бүхэн их юм бодож гарсан билээ.

Төмөр бол энэ талаар тодорхой саналтай байлаа. <Тайж угсаатай бүхний хөрөнгийг хурааж ядуучуудад өгвөл зохино. Одоо тэд өлсөж, бид жаргах цаг болсон. Шилэн жинстэй хохь тайж, чадал хүчин зааж баймаажин овоо хэдэн малтай болсон суман эрийг ухаан алдтал нь ташуурдаж орхиод ямар ч зэмлэлгүй өнгөрч байхыг би үзсэн. Одоо угсаагаар ярих цаг болсон> гэж хэлдэг байлаа.

Төмөр ингэж үзэх шалтгаан хоёр байлаа. Нэгдүгээрт гэвэл хуучин монголд тайж л гэвэл цагаан ястай, тэнгэр угсаатан гээд түүнээ далимдуулан ард олонд түмэн зовлон тарьж байв.

Өдөр шөнөгвй ажил хийж баймаажин хэдэн малтай болсон хвн зөвхөн ард угсаатай учраас өртөөний хвнд албыг хийж байхад тайж нар өртөө унахаас өөр юу хийж байлаа даа. Засагт хааны хошуу наадам дээр үзүүрт хоёр бөх үлдэж билээ. Нэг нь хохь тайж, нөгөө нь овоо хөрөнгөтэй суман эр айлын хvv байлаа. Гэтэл Гомбожав хааны зарлигаар ард хvнийг нь барилдуулалгвй буулгуулж байсныг Төмөр хараад сэтгэл нь нь хорсол, жигшлээр дvvрч байсан. Хоёрдугаарт энэ хооронд Төмөр тавь гаруй цэврvv шиг бодтой болжээ. Үvнийг хэнээс ч булааж авагвй. Зөвхөн өөрийн хvч чадлаар Дулмаатайгаа жаргалтай чинээлэг амьдрахын тул олж хуримтлуулсан билээ.

Энэ хэдэн мал бол нэг ёсондоо Төмөрийн баяр баясгалангийн вндэс болжээ.

Энэ учраас нэгэн хэсэг баян чинээлгийн нь хөрөнгийг хурааж, нөгөө хэсэг ядууд өгөх нь зvйтэй гэж Эрдэнийн хэлэхэд Төмөр

- Баян хоосон гэхгвй, тайж ард гэж ярина. Одоо цагт ажиллаж чадвал хэн ч хэдэн малтай болж чадна. Харин тайж нараас бол эцэг өвгөдийн хариуг авах хэрэгтэй гэж Төмөр хэлдэг юм.

Эрдэнэ буцаж ирээд хэдэн өдөр сууж баймаажин намын төв хороонд феодал, жасын хөрөнгийг ойрын вед хурааж, ядуучуудад ам бvлийг нь харгалзан хувааж өгөх тухай өөрийн саналыг бичжээ. Гэтэл хариу нь ирсэнгвй.

Өвөл нь аймгийн өмнөд хэсэгт сvрхий зуд болж ядуучуудын амьдрал үлэмж хвнд болсноор барахгвй зарим газар өлсгөлөн гарлаа. Эрдэнэ тэр зvг тvргэлэн очиж хошууны жасуудад маш их хэмжээний хvнсний зvйл байгааг мэдээд гол хvрээний хамба ламтай уулзаж зовлонд нэрвэгдэгсдэд будаа гурил өгөх тухай ярьсанд лам их л уриалган зөвшөөрч, хэзээ хөсөг ирсэн цагт нярав нараа байлгаж байна гэж билээ.

Эрдэнэ гурав хоногийн дотор гуч гаруй тарган тэмээ, дөрвөн хvн дайчилж хошуу хvрээний гол жасын хашаанд орлоо. Гэтэл хэсэг лам нар ирж Эрдэнийг тойрон зогсоод нэг ханхар том биетэй гуч орчим насны лам өмнө нь ойртон

- Энэ гэнэтийн гийчин чинь юу билээ? гэж хэгжvвн асуув.

- Будаа гурил ачих гэж ирсэн хvмvвс.

- Хэн гудрах нь вэ? гээд ханхар лам ташаагаа тулан цээжээ займчин хөдөлгөв.

Эрдэнэ тэр ламыг нvдээ цавчлан ажиглаж хэсэг зогссоноо

- Өлсгөлөн гараад, улс амьтан vхэх гэж байгааг та сонссон уу? гэлээ.

- Хvрээ хийдээс болж зуд болоогвй. Тэр зуд болгосон тэнгэр бурхнаасаа очиж будаа гурил авахгвй юу. Манай энд зудын будаа байхгвй гэхэд тойрсон лам нар хөгжилтэй инээлдэв.

- Бид танай хамбатай ярьсан шvv дээ.

- Хэнтэй ярьсан чинь бидэнд падгвй. Будааны чинь сав бvтэн дээрээ ирсэн замаараа сурсан дуугаа дуулаад морилбол зvгээр байх шvv.

- Ард тvмэн өлсгөлөнд нэрвэгдээд байна юу ч л гэсэн бид будаа гурил ачна. Нэг ч удаа авахгвй, хэдэн удаа авна гэж эрс хэлээд Эрдэнэ хөдлөх гэтэл ханхар лам мөрөн дээрээс нь барьж авлаа.

Эрдэнэ хvчлэн угзарч тавиулав. Гэтэл ханхар лам <навсартал чинь цохиод өгөх дээр нэгийг бодох ухаантай болох байлгвй дээ> гээд Эрдэнийг цохилоо.

Энэ лам нарын зодоонд нэвтэрхий хvн юм. Хvрээнд тусгайлан очиж нэртэй зодоочин нартай халз тулж хэд хэдийг нь дийлснээр <махан муна> гэдэг хочтой болсон ажээ.

Эрдэнэ тэнцvврээ алдаж гэдрэгээ алдлан унав. Гэвч тvргэн босож ухасхийн <махан муна>-ыг барьж аваад тонгорч орхисонд ард зоогоороо пидхийн унав. Эргэх гэтэл олон лам тал бvрээс нь довтлон ирж нvвр, нvдгвй балбаж гарахад жинчдийн зарим нь туслахаар ирсэн

боловч харчуул дийлэгдэж хөх булуу болоод тэмээгээ хөтлөн хүрээнээс гарлаа.

Жинчид ёстой л навсайтал зодуулаад явсан хойно лам нар дээр хамба лам ирж <махан муна>-ыг сайшаан <олуулаа болоод буцаж ирж магад. Нэмж өгөөд явуулдаг юм шvv. Тэр Эрдэнэ гэгч надтай дахин уулзвал юмаа өгөхгvй гэж хилэгнэсэн лам нарыг би яаж ч чадахгvй гэж хэлнэ. Харин хvн алж болохгvй шvv. Тэгвэл бид буруудаж цэрэг ирээд сvйд хийнэ> гээд явжээ.

Жинчид хийдийн захад орхисон майхандаа ирэхэд сахиж vлдсэн өвгөн эхлээд их л гайхсан боловч учир явдлыг мэдээд лам нарыг адгийн vгээр хараав.

- Тэмээгээ битгий тавиарай. Одоо буцна шvv гээд Эрдэнэ майханд орж богцноосоо сэлээдий буугаа авч зvvгээд гарч <Өдий төдий хvн өлсгөлөнгийн аюулд ороод байхад та нар дээрэмдсэн юмаа буцааж өгөхгvй байна гэнээ. За буцаад явцгаана. Бушуу!> гээд унаа тэмээгээ хэвтvvлэн мордов.

- Хvний амины хэрэг гарч магад. Би явахгvй гэж лам нарт баруун нvдээ хөх булуу болгуулсан нэг эр хэлэв.

- Ардын засгийн нэрээр тушааж байна. Бушуу хөдөлцгөө гэж Эрдэнэ өндөр дуугаар тушаав. Жинчид явсаар жасын хашаанд буцаж орлоо. Лам нар бvр ч олон болжээ.

- Идсэн боов чинь багадаад буцаж ирэв vv гэж <Махан муна>-ын хэлэхэд бусад нь өндөр нам дуугаар инээлдэв. Эрдэнэ сэлээдийгээ модон хуйнаас нь гаргаж бариад <Бид бол хулгайч, дээрэмчин биш. Ардын засгаас олгосон бvрэн эрхийн ёсоор энэ байшинд хадгалагдаж байгаа будаа гурилыг авч өлсгөлөнд нэрвэгдсэн хvmvvст өгнө. Энэ буу арван зургаа vсэрдэг юм. Эсэргvvцэж ямар нэгэн саад хийсэн хэн бvхнийг зогсоогоор нь буудна. Байшингаа бушуу нээ. Тэр нярав чи тав тоолоход vvdээ нээхгvй бол засгийн цааз хэцvv гэж мэдээрэй> гээд <нэг, хоёр> гэж чанга бөгөөд сунжруулан тоолов.

Лам нарын омог дарагдан дуугvй болж бие биеийг харалцав.

<Дөрөв> гээд Эрдэнэ тэмээний урд бөхөн дээр тавин барьж байсан бууны амыг эргvvлэхэд нярав огцом хөдөлж тvlхvvрээ цоожинд хийлээ.

Лам нар хашааны хаалга руу урамгvй хөдлөх гэхэд нь Эрдэнэ <та нар явж болохгvй. Гурил будааг тvргэн гаргаж энэ тэмээнд бушуу ачицгаа> гэж ер бусын свртэй тушаав.

Удсангvй гурил будаа ачсан тэмээн жин жасын хаалгаар цувран гарахад <удахгvй энэ хvmvvс буцаж ирнэ. Би өөрөө ирэхгvй. Будаа гурил авахад саад хийсэн хvнд ял тулгана. Хэрэгтэй болбол хүрээнээс цэрэг ирvvлнэ. Ойлгов уу? Бас та нар ачиж өгнө шvv> гээд явж билээ.

Өлсгөлөнд нэрвэгдсэн хvmvvст туслах ажлыг ингэж хийгээд баяртай буцаж ирээд байтал Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга Жадамбын гарын всэгтэй нэг бичиг иржээ. Тэр бичигт жасын хөрөнгийг хууль бусаар хурааж хvmvvст тарааж өгсөн Эрдэнийг зэмлээд богино цагийн дотор алдаагаа засаж жасуудыг хохиролгvй болгоод өөрийн биеэр төв хороонд хүрэлцэн ирж илтгэл тавихыг чандлан даалгажээ.

Хэдэн өдрийн дараа Эрдэнэ өртөөгөөр Улаанбаатар хотын зvг мордлоо. Гэхдээ жасуудаас татварлан авч тараасан юмаа эргvvлж өгөх талаар юу ч хийсэнгvй.

<Юу л болбол болог. Би л хувьдаа өнчин ишиг ч идээгvй юм даг. Ардын засаг тэр ядарсан ард тvмэнд тус болох л ёстой. Тэднийг тэтгэх өөр арга надад байгаагvй> гэж урт замын аялалд Эрдэнэ бодож явлаа.

VI

<Ардыг гэгээрvvлэх яам> гэж том цагаан всгээр хар төмөр дээр бичиж хээ тавин сийлж нарийхан дөрвөлжин модоор жаазалсан хаягтай ганц давхар хөх байшингийн өндөр

довжоотой үүдээр хөх чисчүү дээл дээр улбар шар дурдан бус бусэлж торгон савхин хар гуталтай Бат гарч ирээд төв дундаа дугуй модон индэртэй их талбайн зүг харан зогсов.

Энэ тэнд бөөн цагаан үүл хөшилдөн нүүсэн цэнхэр тэнгэр, оройн мананд умбасан Богд уул хурц биш боловч төөнөн шарсан шар нар хотын бүгчим бөгөөд эхүүн агаар намар ойртож байгааг илтгэнэ. Бат оюутны сургуулийн байшингийн зүг баяртай алхан өмнө нь очиж зогсоод бахдалтай харлаа.

Батыг сурч байхад энэ ханхай хашаанд хэдэн том хар гэрээс том юм бараг байгаагүй бөгөөд төгсгөх жил нь нэг том байшин барих тухай явган яриа болж байж билээ. Гэтэл одоо тэр байшин босчээ. Хашааны том хаалгаар орж гарч байгаа шавь нарыг харахад таних хүн огт байсангүй. Энэ бүхнийг бодоход төгсөөд удсан бололтой. Гэвч хэдэн жил болсноо бодвол дөрвөн жил гаруй болжээ. Энэ нь ч бага хугацаа биш.

<Цаг ч түргэн өнгөрөх юм даа. Саяхан л энэ хашаанд барилдаж байсан шүү дээ> гэж бодтол бууны дуу пин хийж газар доргиулахад цохиж эргэн харснаа <үдийн буу> гэж шивэгнээд инээмсэглэв. Урьд оюутны сургуульд сурч байхдаа үдийн буу тавьдаг газар очиж, түүнийг тавьдаг ширвэгэр хар сахалтай хар хүнд газрыг нь ухалцан дарь бортогийг нь булж өгч байснаа санав. Мөн хар хүний нүдийг нь хариулж байгаад дариас нь шомбодон авч бирдаан бууны хонгиогоор буу хийж Тасганы овооны ард очиж буудаж байсан нь санагдав.

Тэгээд Дүнжингаравын сүмийн урьдахь голын зүлгэн дээр байдаг Хуягийн очихоор санаа шулуудан алхав. Бат хотод ирээд хэд хоножээ. Өнөөдөр ардыг гэгээрүүлэх яамны сайд уулзаж Тариатын танхимын дарга сургагчаар томилсон тушаал өглөө. Хуучин танхимдаа дагуур сургагчаа хийе гэж хэлмээр байсан авч хэлж чадсангүй. Учир нь <Тариатын танхимын ажил маш муу байгаа юм. Түүний дарга сургагч Гомбо тайж үл бүтэх этгээд байсан болохоор бид халсан билээ. Чи бол ард хүн. Ардын хүүхдийг сургах танхимыг өөрийн юм гэж өөд татах хэрэгтэй> гэж сайдын хэлсэн үгнээс болоод дуугарч чадаагүй билээ.

Хотод хэд хоног болоход зах зээлээр явж Солонгодоо дээлийн торго, чисчүү зэрэг ойр орчмын хүмүүстээ өгөх бэлгээ базааж аваад том ширэн богцондоо хийж авсан билээ. Маргаашаас эхлэн сургуулийн ажлаар хөөцөлдөж, түргэн бүтээгээд бушуу очих нь юу юунаас чухал гэж бодов.

Үнэхээр ч хэдэн өдрийн турш борви бохис хийхгүй гүйж баймаажин ном дэвтэр, шохой, харандаа, үзэг зэрэг нилээд юм төхөөрч хэдэн үхэр тэрэг олж хөлслөн ачуулаад өөрөө өртөөгөөр явжээ.

Сааталгүй явж гэртээ хариад хамгийн түрүүнд Солонгодоо бэлгээ өгөхөд баярласан эхнэр нь их гэрт орж Должинд үзүүлэв.

- Нохой долоож үх. Хялгасан торго л байна гэж Должин баярласан урмыг нь хугалан хэлжээ.

- Гялтганасан ийм сайхан хээтэй, өнгө зохимжтой аятайхан л торго байна л шүү дээ гэж Солонго дургүй нь хүрсэн бололтой хэлээд гарлаа.

Эхдээ нөхрийнхөө өгсөн бэлгээ голуулж баярын сэтгэл гундсан Солонгыг орж ирэхэд <Хадам юу гэж байна> гэж Бат баяртай асуув.

- Аав алга байна. Харин ижий сайн торго гэж байна гэж Солонго нам дуугаар хэлээд мурилзан мишээв.

- Би Тариатын танхимын дарга сургагчаар томилогдсон, ойрын өдрүүдэд нүүдэг хэрэг ээ.

- Яаж болдог юм бэ?

- Нэгэнт л томилогдсон болохоор явахаас өөр ямар ч аргагүй дээ.

- Иш Бат минь юу болох бол доо. Аав зөвшөөрөхгүй байх аа.



- Чи бид хоёр л зөвшөөрч байгаагаас хойш хамаагүй биш үү. Тэгээд уул усны ойр нь ураг төрлийн хол нь гэдэг. Хоёулаа холхон явж тусгай айл болсон нь дээр. Ингээд байвал хадмын хатуу үгийг олон өнгөрөөж чадахгүй. Бид хоёрт бөөн зовлон болно. Тийм биз дээ.

- Чамайг дагаад би тамд ч орж чадна. Харин аав л хэцүү дээ. Чи аятайхан л ярьж үзээрэй.

Тэр орой Итгэлт нилээд согтуу ирэхэд нь Бат царайчлан угтаж мориноос нь сугадан буулгаж гэрт нь оруулаад хот явж ирснээ яриад <аав аа намайг Тариатын танхимын дарга сургагчаар томилсон. Ойрын өдрүүдэд Солонго бид хоёр тийшээ нүүх болоод байна> гэж нам дуугаар хэлэв.

Итгэлт завьжаа зууж, Батыг архинд мөхсөн боловч доромжлол гэрэлтсэн нүдээр ёжтой ширтэн харахад <Залуу минь мөн л гэнэн байна даа. Итгэлт ганц охиноо шалдан гуйланчинг дагуулаад явуулчихна гэж бодов уу?> хэмээн хоёр нүд хэлж байлаа.

Бат хэсэг дуугүй байснаа үргэлжлүүлэн <Солонго бид хоёрын жаргал таны гарт л байна. Солонго танаас айдаг. Өөрийн мэдэлгүй хүн. Миний хувьд бол би ч танаар дутагдахгүй. Та ч надаар дутагдахгүй. Өнөөдөр таныг царайчилж байгаа минь Солонгод сэтгэлтэйгээс болсон хэрэг> гэлээ.

Батын энэ үг Итгэлтийн сэтгэлд тохирсонгүй. Завьж нь татганан, нүд нь хурц болон сэтгэл нь оволзоно.

- Энэ хэдэн мал бол наанадаж миний хөрөнгө, үр хүүхдийн минь хөрөнгө, цаанадаж улсын хөрөнгө, олны буян. Солонго энэ хэдийгээ харж байвал өөрт нь ч, олонд ч хэрэгтэй. Ер нь тэгээд шууд хэлж орхиход та хоёрын зам нийлэхгүй бололтой. Солонго бол малын захад төрж өссөн, малын шимийг мэдэх хүн. Чи бол малаас айдаг хүн. Бичгийн хүн. Миний угсаанд тарвагачин хүн байсан. Гуйлгачин хүн байсан. Малчин хүн байсан. Харин бичээч хүн байгаагүй. Та хоёрын заяаны амьдрал өөр гээд Батаас нүд салгалгүй ширтэв.

- Солонго бол миний ёсолж авсан эхнэр болохоор намайг дагах л ёстой доо. Хэвлийд нь миний хүүхэд бий.

- Эзэрхэг засгийн үе шиг гэрийн минь зарц гэх нь үү? Тэгж ч ярихгүй шүү.

- Юу ч л гэсэн миний эхнэр. Удахгүй миний хүүхдийн эх болно.

- Ганц охиныхоо толгойг би мэднэ.

- Эмэгтэй хүн толгойгоо мэдэх эрхтэй болсон.

Итгэлт хүйтнээр инээснээ <Солонгоо хүрээд ир!> гэж хахир дуугаар хашгирав. Удалгүй Солонго орж ирээд царай нь чинэрэн нүд нь гялалзаж, завьж нь татганаж байгаа эцгээ хараад буруу тийшээ эргэж, хэрэм бутарч эхэлснийг ойлгов.

- За миний охин суу гэж Итгэлт ер бусын зөөлөн дуугаар хэлэв.

Батыг дагаж явахгүй, эх эцэг, мал хөрөнгөөсөө салахгүй гэдэг үгийг Солонгоос гаргуулахын тул Итгэлт юу ч гэхээс буцахгүй байлаа. Сая болтол Солонгыг үргэлж доромжлон загнаж заримдаа нудраад авдаг байсан. Харин энэ удаа эхлээд зөөлнөөр үзье гэж шийдэв.

- Ах чинь тусгай айл болсон. Бас тэгээд эх бид хоёрыг чинь харж хандахгүй бололтой. Ухаан орж эргэхгүй бол өөдтэй хүн болно гэхэд хэцүү болжээ. Бид хоёрын түших тулах ганц хүн бол чи. Гэтэл чи маань үүнийг дагаад явах хэрэг үү? Хонгор та хоёрын төлөө Тамирын мөсийг долоох шахаж баймаажин хуримтлуулсан энэ хөрөнгөө яах вэ?

Солонго үнэн хүслээ ил гаргаж <Би Баттай хамт явна> гэсэн бол Итгэлт яах байсныг таахад хэцүү. Итгэлт босож Солонгын өмнө очоод нүдээ нүднээс нь салгалгүй ширтэв.

Солонгын хоёр нүднээс тунгалаг нулимс урсан гарлаа. Тэр нулимс <Би ямар нүгэл хийснээс ингэж зовох ёстой болсон хүн бэ?> гэж өөрөө өөрөөсөө асууж байлаа.

- Чи үүнийг дагаад бид хоёрыг үнсэнд хаясан шалз шиг орхих цэвдэг сэтгэлтэй үр юм бол

түүнээ түргэн хэлээд аль гэж Итгэлт үргэлжлүүлэн хэлэв.

- Үгвй. Аав минь гэж Солонго шивэгнэв.

- Хvv минь. Чанга хэлж орхи.

Солонгын үгийг сонссон Бат босож нүд нь гөлрөн том болоод Солонгод ойртон очвол Итгэлт хоёр залуугийн дундуур оров.

- Хаанаас та хоёрыг орхих билээ дээ. Итгэлт ялалтын баяр нь багтаж ядсан дээрэнгвй бардам нүдээр Батыг доромжлон харж <Ийм л байна даа. Залуу минь. Дарга сургагчаа ганцаараа явж хийвэл дээр байх даа> гэлээ.

Бат vvd рvv хэд алхсанаа зог тусан зогсож Солонгыг харахад түүний ус болсон хоёр нүд <Би аргагвй боллоо шvv дээ> гэж хэлэх авч Бат гомдсон сэтгэлдээ автагдан ойлгосонгвй.

Бат тэр оройдоо хүрэн морио унаад Тариатын зvг хөдөлжээ. Явахад нь Солонго юм ярих гэж оролдсон боловч Итгэлт, Должин хоёр боломж олгосонгвй.

Тариатын сургууль гэж ёстой л нэг баларсан газар байлаа. Хэдэн эвдэрхий хар ширээ, бvрээс нь урагдсан ширvvn салхи vлээвэл яйран унах болсон том, бага дөрвөн гэр, олхиогвй айлын саврын шvд шиг ийш тийш яйжийсан том хашаа, хэдэн модон ор энэ бvхнийг харсан нэг өвгөн галчаас өөр юм байсангвй.

Орой очсон тул жижиг гэрт нь орж газар дэвсгэр засан унтаж өглөө нь эрт босоод нvvр гараа угааж байтал уг сургуулийн дагуур сургагч Жаргал хаван нүдэлчихсэн давхиж ирлээ.

- Өвгөн чинь чамайг ирсэн гэж сонсоод ёстой л ум хумгвй давхиж ирлээ. За хоёулаа явъя. Энэхvv аманд Гомбо гуайнд найр болж байгаа гээд Жаргал Батыг тэвэрч авахад амнаас нь архины хурц vнэр ханхлав.

- Ямар Гомбо бэ? Энэ сургуульд ажиллаж байсан уу?

- Биш чиш. Тэр муу феодалтай нийлж архидах ч арай хүрээгвй. Хошууны хоршоон дарга. Харлаг Гомбо гэдэг хvн.

- Сургууль чинь ийм байхад архи ууж найрлаж явахдаа сэтгэл чинь зовохгвй байна уу?

- Би яах юм бэ? Тэмцээд дийлээгвй юм. Одоо л хоёулаа нийлж байгаад өөд татъя. Ягтвй газар шvv гэлээ.

Жаргал өнгөрсөн жил ирээд сургуулиа сайжруулах гэж vнэхээр тэмцсэн юм. Гэтэл дарга сургагч байсан Гомбо тайж хэлсэн бvхнийг нь эсэргvвцэн хошуу даргын дэмжлэгтэйгээр золтой л хөөж орхиогвй билээ. Хоёр ч удаа Гомботой барилцаж авсан. Эхэн удаад нь сургуулийн хvvхдvvд ханиад хүрээд Гомбо олон лам залан ирж сvртэй гvрэм хийлгэн, сангийн мөнгөнөөс vлэмж барьц барихад нь хэлээд болохгвй болохоор зад хэрэлдэн барьж аваад хүрэн торгон дээлийн нь заамыг урж орхив.

Гэтэл хошуу дарга Чогсом гэдэг хvн дуудаж авчраад хvн зодсон хэргийн учир хар гэрт хийх шахсан билээ.

- Манай оронд шарын шашин гvн дэлгэрсэн. Энэ учраас хvvхдийн дотор ханиад дэлгэрээд байхад гvрэм хийлгэхгвй бол ард түмний сэтгэл санаа эвдрэхэд хүрнэ. Бас тэгээд Гомбо бол энэ танхимын дарга сургагч гэж хошуу дарга зэмлэжээ.

Тэгээд бас өнгөрсөн өвөл хоёр хvvхэд хувцас муутайгаас хөлөө хөлдөөж бас өдий төдий хvvхдvvд бөөсдөж нүднээс гарахад нь <Чи улсаас өгсөн мөнгийг нь гvрэм хийлгэж, жасаа уншуулж барчихаад хvvхдийг ийм болгож орхилоо. Ямар санаатай этгээд вэ?> гэж хэлсэн чинь Гомбо харь нутгийн цагаач гөлөг гэх зэргээр доромжлоход нь барилцаж аваад тонгорч орхисон чинь баашлан ухаан алдан унаж билээ.

Хошуу дарга тахар гаргаж Жаргалыг бариулан хоёр хоног хар гэрт хийлгээд суллажээ.

Үvнээс хойш Жаргал номхорч, оногдсон хичээлээ заагаад зав л гарвал нутгийн улстай

нийлэн архидаж, найр эргүүлдэг болсон ажээ.

Гэтэл энэ зун Ардыг Гэгээрүүлэх Яамны шалгалт ирж дарга сургагчийг сольсон бөгөөд удсан ч үгвй хошуу даргыг сольж билээ. Харин Жаргал шинэ дарга сургагч иртэл зуны дэлгэр цагт тарган морь унан шимийн архи балгаж түмэн шалтагт найр эргүүлдэг байлаа.

Бат өөрөө ч найранд явсангвй. Жаргалыг ч явуулсангвй. Харин бага гэрийг засан барьж багш нарын гэр болгон хоёр ор тавьж тохижуулав.

Гэр засалцаж байсан галч өвгөн Мягмар <Хvv минь манай энд чинь харь нутгийн хvнийг сvрхий гадуурхдаг газар. Нутгийн улстай сайн танилцаж авахгвй бол хэцvv дээ> гэлээ.

- Ярвигтай газар даа. Чи удахгвй мэднэ гэж Жаргал өвгөний үгийг лавшруулж билээ.

Бат сургуулийг шинэ хичээлийн жилд бэлтгэх ажилдаа орлоо. Юуны өмнө хэдэн гэрийг нь хvн сууж хичээл хийж болох юм болгох. Дараа нь ширээ сандлыг нь засах, сурагчдын хоол бэлтгэх ажил байжээ.

Ойр хавийн эмэгтэйчvвдийг цугларуулан гэрийн бvрээс оёулав. Бас нилээд дэл худалдаж аваад унийн оосор, бvслvvр зэргийг томуулж авлаа. Ингээд хэдэн гэр нь овоо юм болов.

Ширээ сандлыг засъя гэтэл мужаан олдохгвй сандрав. Гэтэл аз болж Тариатын төмөр утасны газар ажиллах гэж нэг орос хvн ирсэн нь мужааны ажилд сvрхий гарын дvйтэй учраас Жаргал, Шагдар хоршооны нягтлан бодогч залуу Даш зэргийн хэдэн хvнтэй хавсран заслаа.

Ингээд хvvxэд авах болов. Ардыг Гэгээрүүлэх Яам тавин хvvxдийн орон тоо өгсөн билээ.

Өнгөрсөн жил дөнгөж гучин хоёр хvvxэдтэй байсан арав нь оргож хариад ирээгвй. Ес нь төгсжээ. Төгссөн хvvxдийн нэг нь хошуу захиргаанд тал бичээч болсон. Дөрөв нь Улаанбаатарт сургуульд явсан. Хоёр нь мал дээрээ эргэж очсон билээ.

- Юу ч л гэсэн хоёулаа тавин хvvxэдтэй хичээллэнэ дээ. Заавал шvv гэж Бат хэлэв.

- Ярьдаггвй хэрэг ээ. Сайн дураар өгдөг айл гэж өдрийн од шиг байдаг юм. Тэгэх дээр албадуулах хэрэгтэй. Гэтэл албадуулж баймаажин авчирсан хэдэн хvvxэд нь оргож, алга болчих гээд мөн хэцvv хоол доо гэж Жаргал урамгвй хэлэв.

Жаргалтайгаа сум хуваарилан, хошуу захиргаанаас бичиг шийтгvвлэн авч хоёр тийшээ, хуучин хvvxдийг дуудах, шинэ хvvxдийг хуваарь ёсоор сумдаас гаргуулахаар явлаа.

Хvvxдээ сайн дураар явуулах айл Жаргалын хэлдгээр өдрийн од шиг цөөн бөгөөд ихэнх нь түмэн зvйлийн шалтгаан тоочин өгөхгвйг хичээнэ.

- Нэгэнт сумын захиргаанаас оногдсон хvvxдээ танхимд явуулахгвй юм бол засгийн шийдвэрийг эсэргvвцсэнд тооцон ял хэлэлцэнэ гэж сvрдvвлэн байж зарим хvvxдийг мордуулж байлаа.

Зарим эх эцгээс салахгвй өдөржин гуйхад <Иш хvv минь чи чинь Утайн хуушаан шиг яасан салдаггвй хvн бэ дээ> гээд мордуулав.

Хvvxэд нь танхимд очих хvсэлтэй байхад эцэг эх нь явуулахгвй байсан нэг айлын хvvxдийг оргуулан авчээ.

Ингээд есдvгээр сарын арван тавны вед арай гэж гучин зургаан хvvxэдтэй болоод хуучин шинэ хvvxдээр тус бvр нэг анги байгуулж хичээлээ эхлэв.

- За ийм л байдаг юм даа. Бас тэгээд удахгвй энэ золигууд чинь оргож эхэлнэ гэж Жаргалын хэлэхэд <Үлдсэн арван дөрвөн хvvxдээ Тариатын хvрээнээс банди нараас урвуулан нөхөж авна> гэж Бат хэлжээ.

Бат урьд ажиллаж байсан сургуулиуддаа хvрээний банди нараас урвуулан олон хvvxэд авч байсан авч Тариатын хvрээ өөр байлаа. Эндэхийн лам нар сургуульд банди нараа өгөх нь битгий хэл, сургуулийн хvvxдийг тараах их ажил хийж байсан юм.

Хэд хоносны дараа найдлагатай том хvvxдээ цугларуулан хvрээний банди нартай

танилцуулан найзлуулахаар явуулахдаа <Та нар урьдаар сайхан танилц. Сургууль дээгүүрээ авчирч тоглож бай. Хоол идүүлж, дайлж болно. Надтай уулзуул> гэж зааварлав.

Орой нь явсан хvvхдvvдийн ихэнх нь банди нарт хавсайдуулан балбуулаад энд, тэндээ хөх няц болон иржээ. Харин дөрвөн хvvхэд нутгийнхаа хvvхдийг олж уулзаад хэзээ нэгэн цагт сургууль дээр очиж хоол идэхийг урьсан байлаа.

Зодуулсан хvvхдийн нэг нь <Би нэг хvvхэдтэй уулзаад аятайхан тоглож байтал нэг том лам ирээд <Чи энд юу хийж байгаа юм бэ. Харьж номоо vз> гээд нөгөө бандийг шууд барьж аваад чирэв.

- Хvн зодох бол харгис засгийн ёс. Та яасан задарсан лам бэ. Шоронд хийнэ шvv гэж би хэлэв. Лам юу ч дуугаралгvй чирж явсан бандиа орхиод явлаа.

Гэтэл удалгvй дөрвөн том банди ирээд намайг золтой л алчихсангvй. <Би л дахиж очихгvй> гээд уйлж байв. <Банди нарыг хар болгож, сургуульд оруулах гэдэг бол хувьсгалын чухал ажил. Та нар цөхрөхгvй явах болно. Ангийн тэмцэл бол зориг, тэвчээр хэрэгтэй яггvй ажил> гэж Батын ярихад нэг шавь нь ангийн тэмцлийн тухай асууж билээ.

- Нэгэн талаас ард тvмэн бид нар, нөгөө талаас ноёд, тайж, лам нар тэмцэж байгааг ангийн тэмцэл гэдэг юм гэж Бат хэлэв.

- Өнгөрсөн жил хvрээний дуганч Майдар, манай нутгийн Гончиг заан хоёр барилдсан бол ангийн тэмцэл тийм vv? Гончиг гуай ч харин сайхан тонгорсон доо гэж нэг хvvхэд хэлэв.

Нилээд ярилцсаны эцэст ангийн тэмцэл бол нэг талаас ноёд, тайж, лам нар, нөгөө талаас ард харчуул зодолдох, хэрэлдэх, барилдах, бас хvvхэд булаалдах зэргийг хэлдэг гэж хvvхдvvд ойлгож билээ.

Хоёр өдрийн дараа сургууль дээр нэг банди ирснийг хөл болон дайлж, Бат өөрөө уулзан ярилцаж сургуульд орохыг зөвлөв.

- Би ч ормоор л байна. Гагцхvv ааваасаа айж байна гэж тэр банди хэлжээ.

- Чи тэгвэл манай сургуульд ор. Би аавтай чинь яриад ирье гээд Бат морджээ.

Тэр бандийн гэр төдий л хол биш хойт Тэрхийн голд байсан болохоор нар жаргахын өмнө Бат очиж эцэгтэй нь уулзав.

Бандийн эцэг дөч эргэм настай, сарлаг голдуу цөөн малтай Дандар гэгч хvн байлаа. Банди бол ганц хvv нь бөгөөд дvv нь долоон настай охин байлаа.

Эхлээд ярихад vxэхдээ толгой дээрээ ерөөл уншуулж, хонхны дуу сонсох гэж лам болгосон ганц хvvгээ сургуульд өгөх дургvй гэдгээ шууд хэлжээ.

- Та ардын засагт дvргvй хvн юм даа.

- Тэр ярихгvй. Би хамжлага байсан хvн. Манай тайж гэж архи, хvvхэн, даалуу гурваас болсон нэг золиг шиг амьтан байсан. Байсан ч гэж дээ. Одоо энэ дээр гуйлга гуйх шахаад байж байгаа. Тvvний өрийг төлөх гэж модоо барьсан улс даа. Ардын засгийн ачаар тvvний гараас салж одоо хэдэн сарлагтай болоод юу ч гэсэн тараг, өрөм гуйхгvй болоод байна. Энэ бол төрийн минь сvлд.

- Тэгвэл танаас ардын засаг хvvг чинь гуйж байна. Ном эрдэмд сургаж өгье гэж байна.

- Би энэ засагт ганц хvvгээ харамнахгvй. Зvгээр нvд анихдаа хонхны дуу сонсох гэсэн юмсан.

- Та нvд анитал хаа байсан юм бэ. Харин манай засагт эрдэм номтой хvн тун хэрэгтэй байна. За юу ч гэсэн би хvvгий чинь сургуульд авлаа гээд Бат шууд буцсан билээ.

Энэ мэтээр цуглуулсаар байгаад дөчин хоёр хvvхэдтэй болжээ. Гэтэл хvрээний лам нар банди нараа сургуулийн хvvхэдтэй уулзуулахгvй болсноор барахгvй сургуульд хэдэн банди нараа алдсаны хариуг авах гэж Бат Жаргал хоёрт vлэмж гай тарьсан билээ.

VII

Хотын морин зах дээр вймээн шуугиан үлэмж бөгөөд олон зуун хvн, морь цугларчээ. Халуун өдөр нэгэн дор цугларсан олон малын эхvн внэр ханхлан хvмvvc морьдоо магтах, бие биедээ цэцэрхэх, чанга сул, бvдvн нарийн дуу холилдон алсаас чагнавал нэгэн дvлий шуугиан болон сонсогдоно.

Өглөөний нар нилээд дээр гарах вeд энэ захын зvн хойт талаас хар суман ногт бvсэндээ хавчуулсан Эрдэнэ алгуур алхлан хvрч ирлээ. Нvврэнд нь гvн бодол, нvдэнд нь гуниг бухимдал тодорхой.

Цэцэрлэг мандалын аймагт ардын засгийн бодлогыг гуйвуулж жасын хөрөнгийг хураан хvмvvcт хувааж өгсөн гэж тvннийг аймгийн намын хорооны даргын тушаалаас халжээ.

Өчигдөр өглөө нэг том аймгийн намын хорооны дарга байсан бол орой нь намын өмнө гэмтэн, ажилгvй хvн болжээ.

Эрдэнэ зөвөө батлах гэж оролдсон. Дэмжсэн хvмvvc ч тэргvвлэгчдийн дотор байлаа. Гэвч нарийн бичгийн дарга Дамбадорж, Жадамбаа нар махран зvтгэж байгаад зэмлэсэн хатуу тогтоол гаргаж ажлаас огцруулав.

Тэр судар бичиг, нэрт их хvмvvcийн ном зохиолыг дурдан иш татаж Эрдэнийн хийсэн ажил бол ард тvмний сэтгэл санааг тохинуулах, улс орны эдийн засгийг хөгжvвлэхэд үлэмж хортой юм гэж зэмлэв. Тэдгээр судар бичгийг Эрдэнэ мэдэхгvй болохоор эсрэг хэлэх юм байсангvй. Ганц хар ухаан, сэтгэл зvрхээрээ бодоход Дамбадорж, Жадамба нарын явуулж байгаа бодлого буруу мэт байжээ. Юу ч л гэсэн Эрдэнэ Намын Төв Хорооноос зэмлvвлжээ. Энэ нь намын гишvн Эрдэнэд гунигтай явдал байлаа.

<Би буруу юм хийгээгvй. Энэ засаг бол ард тvмний төлөө засаг. Би цөөн жасыг хохируулж, өлсөж ядарсан олонд тус болсон. Энэ чинь ардын засгийн бодлогыг гуйвуулсан хэрэг гэж vv? Жас, хийд хөрөнгөтэй байсан цагт ардын төрд муу болохоос тус болохгvй> гэж бодоход хилс шийтгvвлэв гэж бухимдана.

Эрдэнийн тухай гарсан тогтоолын эцэст <Нөхөр Эрдэнийг тэнцэж тохирох ажилд тохоон томилохыг нарийн бичгийн дарга нөхөр Жадамбаад даалгасугай> гэж дурджээ.

<За яахав. Өнөөдөр Жадамбаа чи Эрдэнийг дийлэв гэж баярлаж байгаа. Гэвч чи внэнийг дийлэхгvй. Удахгvй их хурал хуралдаж буруу зөвийг ялгаж өгнө. Би ирэхгvй ч гэсэн надтай адил боддог гишvнд намд буй. Юу ч л гэсэн Жадамбаагийн өмнө царай алдан зогсохгvй> гэж бодоод ажил гуйж очсонгvй. Морь худалдаж аваад юуны өмнө гэртээ харихаар шийджээ.

Заримдаа улс төрийн ажлыг орхиж хэдэн мал олж аваад хөдөө гарч малчин болмоор санагдана. Гэвч энэ бодлын хажуугаар <Би энэ засгийг байгуулах ширvн тэмцлийн вeд орсон хvн. Үvний төлөө цусаа ч урсгаж явсан. Тэгээд замын хагасаас эргэж болохгvй. Бодсон хийснээ зөв гэж итгэж байгаагаас хойш Дамбадорж, Жадамбаа нарын хийж байгааг буруу гэж бодсоноос хойш vхэлдэн тэмцэх хэрэгтэй> гэж бодогдоно. Ардын засгийн төлөө хийх тэмцэл дуусаагvй. Харин улам ч ярвигтай болж байгаа мэт.

Зэллэн уясан морьдын дундуур орж иртэл нэг хvн ханцуй дээрээс нь барьж аваад <Сайн морь авъя гэвэл энд байна. Сайхан морь vзье гэвэл энд байна> гэж баргил хvнгэнэсэн дуугаар хэлэв.

Харвал ялбигар хилэн малгай духдуулан тавьж хуучин хөх даалимбуу дээлийн захыг нь задгай тавин өмссөн гуч эргэм насны эр байлаа.

Эрдэнэ морьдыг ажиглан байснаа зэгзгэр хул морийг зааж

- Ямар внэтэй юм бэ? гэж огцом асуув.

- Үнэ гэвэл сул хө. Зан гэвэл хонь хө. Хорин төгрөг тоолоод өгвөл хөтлөөд яв. Хонжоо гараагvй юм шvв.

- Ямар ид шидтэй морь болохоор ийм тэнгэрт тулсан үнэтэй байдаг билээ?
- Дэнжийн чулуу дэргэтэл, дээлийн хаваас сугартал, уулын чулуу доргитол, уруул ам чичиртэл хатирна. Хүссэн газар хүргээд өгнө. Хүний морийг тэлээд хаяна. Урт замд явгалахгүй. Унасан хүнээ хаяхгүй. Булгих гэдгийг мэдэхгүй, бүдрэх гэдгийг үзээгүй морь доо. Авах хүсэл үнэхээр байвал өгөх үнээ хэл хө. Арилжаа наймааны ёс, тоолох мөнгө нь байвал тоочих үнэ нь хөдөлдөг юм.
- Эрдэнэ инээмсэглэж:
- Өө гэмгүй морь юм биз дээ? гээд эрийг ширтэв.
- Амьд юм байна өөтэй, адуу юм байна гэмтэй хө. Гэм нь гэвэл гэдсээ татах тусам хурдална. Өө нь гэвэл уруу газар удгалдаг, уруул ам нь шазганадаг морь доо.
- Эрдэнэ хөгжилтэй инээв. Морь худалдагч толгойгоо хаялан нүдээ солбиулан цавчсанаа:
- Алсыг ширтсэн нүдийг нь хар л даа. Ачаатай тэрэг орчихмоор салтаагийг нь үз л дээ. Эмээллэж аваад унаж үз. Эр хүн юм бол сэтгэл чинь сэргэнэ.
- Арван төгрөг өгье.
- Саарал илжиг худалдах гээгүй, сайн хөлөг зарах гэж байна. Тэгж ярихгүй.
- Энэ хүний уран цэцэн үг, хөгжилтэй занд Эрдэнэ аяндаа татагдан болсон явдлыг түр мартан, түвний хөг аялгуунд орж:
- Барьж мордох дэлгүй, батгана үргээх сүүлгүй, ийм юмаа ингэж үнэрхэж байхдаа зовохгүй байна уу? гэж орхив.
- Дээр нь унах гэж байгаа биш, дэл сүүлийг нь авч дээс томох гэж байгаа юм уу? Тэгвэл бөөн сүүлтэй хөгшин азарга, бөөдий дэлтэй гүү авбал зүгээр дээ. Бас тэгээд хар санаатын үг уран, хашин морины сүүл өтгөн гэж үг байдаг биш үү?
- Чухам даа гээд Эрдэнэ том цагаан шүдээ яралзуулан инээснээ овжин нүдээр морь худалдагчийг харж
- Таны уран үг юм, санаа чинь ямар бол? гэлээ.
- Морь худалдагч гэнэн цагаан сэтгэлээр паржигнуулан инээж Эрдэнийн далыг зөөлөн алгадах зуур <Тэгэхдээ би залилж иддэг панзчин биш, залгиж иддэг мангас биш. Хэдэн морь худалдах гэж Хэрлэнгийн хөвөөнөөс ирсэн хүн. Арван наймаар бол ногтолж ав. Авсан хойноо гомдохгүй нь лав> гээд цээжээ займруулан ханхалзав.
- Үнээ би хэлсэн. Өгөхгүй гэвэл нэмэхгүй гээд Эрдэнэ цааш явлаа.
- Морь худалдагч эр дээр жар гаруй насны ханхар мөртэй янхир өвгөн ирэв.
- Хүү минь морьдоо зарж чадав уу?
- Өглөөгүүр өндөр борыг арван зургаагаар ам дүйгээд өгчихсөн. Сая нэг хул моринд минь хор маажсан хомс үнэ өгч орхиод явлаа.
- Хэд гэж байна.
- Арай ядан байж ам нь ангайгаад арван төгрөг л гэж хадуурч байна.
- Морь таньдаггүй хүн байж л дээ хүү минь.
- Эрдэнэ морьдын дундуур цаг гаруй явж үзэхэд анхны харсан хулаас илүү сэтгэл татсан морь харагдсангүйд буцаж ирлээ.
- Нөгөө хүн чинь эргээд ирлээ, ааваа
- Өвгөн харснаа нүдэнд баясгалан тодрон угтаж хэд алхсанаа ханцуйгаа засаж хоёр гараа сунган <Эрдэнэ комиссарын амгаланг айлтгая. Золгож орхих уу> гэлээ.
- Эрдэнэ тэр хүнийг таньсангүй. Гэвч сүрхий танимхайрч байгаа энэ хүнд тал өгөн <Таны амгаланг эрье> гэж хариу мэндэлж золгов.
- Энэ өвгөнийг үзсэн газраа Эрдэнэ бодоод олсонгүй. Тамхиа солилцон, хэрхэн зусаж

байгаагаа асуулцаж их л ёсорхов. Эрдэнийг өвгөн хэсэг харж байснаа:

- Та намайг нэг л танихгүй байх шиг? гэлээ.

- Нэг л санаанд орохгүй байна гэж Эрдэнэ үнэнээ хэлэв.

- Довчин бээсийн дээрэмчдэд баригдаад алагдах гэж байхад минь та салгаж өгсөн шүү дээ.

Бас хэдэн морьдыг минь дээрэмдсэнийг та л эргүүлж хайрласан. Та хул морийг минь авах гээ юу? Үнэ мөнгө гэхгүй барьчихъя гээд хул морийг тайлан ногтны цулбуурыг Эрдэнэд өгөв.

- Зүгээр. Би үнээр нь авна гээд Эрдэнэ өврөөсөө түрийвчээ гаргав.

- Авахгүй. Би таны ачаар өнөөдөр хорвоо дээр тоос хөдөлгөж явна.

- Миний ач биш. Ардын засгийн ач шүү дээ гээд Эрдэнэ инээмсэглэснээ мөнгөө гаргаж тоолов.

Өвгөн хул морио бэлэглэн өгөх гээд Эрдэнэ зүгээр авахгүй гэж хэсэг маргалдав. Арга нь барагдсан өвгөн <Та ядахдаа хямд ав л даа> гэж гуйв. Ингээд хоёр тал найр тавьж арван дөрвөн төгрөгөөр хул морийг Эрдэнэ авчээ.

- Та одоо ямар алба хааж байна. Цэрэгтээ юу?

- Одоо хийсэн ажилгүй. Нутаг явах санаатай. Морь авч байгаа нь энэ.

- Эрдэнэ гуай та миний энэ хүрэн морийг ав л даа. Би танд зүгээр барья.

- Зүгээр, зүгээр гэвэл

- Хол явах хүнд хос морь дээр гээд хүрэн морио хөтлөн ирж цулбуурыг нь өгөв.

- Зүгээр. Би танд тун их баярлаж байна. Манай нутаг энүүхэн баруун Туулд гэж Эрдэнэ аргалан морийг авсангүй.

- Зам тааралдвал манайд зочлон очдог юм шүү.

- За очно.

- Миний нэрийг Дамба, хүүгийн нэрийг Гомбо, Ерөөлч Гомбо гэвэл хуучин Бээсийн хошуу, одоо Баян уулын хошуунд мэдэхгүй хүн байхгүй. Заавал очдог юм шүү.

- За, зам таарвал заавал очно.

Маргааш нь Эрдэнэ гэрийн зүг явлаа. Хул морь үнэхээр холын замд аялж баймаар унаа байсан бөгөөд Дамбатай уулзсан нь Эрдэнийн сэтгэлийн гунигийг бага боловч хөнгөлж билээ.

Эрдэнэ яаралгүй явсаар зургаа дахь хоногийн шөнө дундын хирд гэртээ очив. Эрдэнийг харихаас өмнө түвний хэрэг явдал, муу юм модон улаатай гэгчээр Цэцэрлэг Мандалын аймаг даяар таржээ. Нэг өдөр Ням өвгөн архи, сүү цагаан идээ бас нэг хонины мах ганзагалан ирж их л талархан уулзаж ярилцав.

- Чамайг даргаас чинь халсан гэж хүн ярилцах юм үнэн үү? гэж хоол идэж байгаа Эрдэнээс гэнэт асуув.

Эрдэнэ өвгөнийг удаан ширтэн харж гомдолтойгоор инээмсэглэх мэт болсноо

- Тийм ээ. Халагдсан. Буруу хэрэг хийснээс халагдсан гэлээ.

- Яахав. Эр хүн туг ч барьдаг, тугал ч хариулдаг юм гэдэг шүү дээ. Нэг ханьтай болж, хэдэн мал аваад айл болбол зүгээр юм биш үү? гэлээ. Ням энэ үгийг зөвхөн л Эрдэнийн сэтгэлийг дэмжих бодлоос хэлжээ.

- Тэгж ч болох л юм. Гэхдээ замын хагасаас буцаж л болохгүй. Би хохирох ч бас бага хэрэг. Харин байгуулсан засаг төрөө л хохироход хүргэж болохгүй. Тийм үү? гэж Эрдэнэ хэлэв.

Эрдэнэ хэд хоног гэрээс гарсангүй. Учир нь хэдийгээр буруугүй гэж итгэн бодовч шийтгэгдэнэ, тэр тусмаа Намын Төв Хорооноос шийтгэл авна гэдэг бол хэцүү ажээ. Сэтгэл нь нэг л эвгүй.

Нэг өглөө гарч зээл дээр явж байтал заяын хүрээний хамба лам дайралдаад их л ёжтой

инээмсэглэснээ мэндлээд <ардын засгийн төлөөний түвшмэл гээд манай нутагт ирж байхдаа гялалзсан хархувуу байж билээ. Одоо ч өтлөх шинж орж дээ. Манайд сайхан айраг ирсэн. Очиж зоогловол би хэмжээлшгвй баярлах байна> гэж хэлэв.

Эрдэнэ хамбын нүдийг эгц ширтэв. Цэхэр хүрээ татаж цийлгэнэсэн боловч амьдралын муу санаа, заль ухаан бүрдсэн хоёр бор нүд өмнөөс нь харах ажээ. Тэр хоёр нүд нууц инээн бахдалтай тавлаж байлаа.

<Бадарчин баярлах болоогвй> гээд нүүр рүү нь нулимж орхимоор санагдсан авч Эрдэнэ биеэ барин тэвчиж яралзтал инээмсэглэж <өтөлсөн юмыг аль тоочиж барах вэ. Харин хамба гуайд айраг зохиж л байна уу? Айхтар биетэй юм даа> гэлээ.

Хамба айраг уухаар нэрд гарсан хүн билээ. Түүнийг хагас өдрийн хугацаанд хонин тогоо шиг хултай хар нүдэн хоёрыг уудаг гэж ярьдаг юм. Гэвч Эрдэнэ энэ удаа тэр тухай ярьсангвй. Харин тэр яриаг ашиглан битүү ёжолжээ. Хашир хамба ч Эрдэнийн энэ үгийн утгыг айргийн тухай биш гэдгийг ойлгов.

- Ууж сурсан юм болохоор одоохондоо зохиж л байна гээд хоолойдоо хүд хүд дуугаран инээв.

- Нэг зохихоо болихоор хэцүү юм гэдэг шүү!

- Үзээгвй болохоор юу ч гэх билээ дээ. Та хэзээ миний өмгөр гэрт морилон очих бол? Тантай сууж уулзан хөөрөлдөх юмсан.

- Одоохондоо зав муутай байна. Гайгвй, цаг ирэх байлгвй дээ.

- Ёстой доо гээд хамба бөхөлзөн тонголзон найр тал өгч салаад хоёр ламаа дагуулан улаан орхимжоо намируулан, хилэн нударгатай урт ханцуйгаа алгуур бөгөөд ихэмсгээр хаялан явжээ.

Түр ч гэсэн энэ гайхлын омог дарагдана гэдэг бидэнд л сайн. Ардын засагтаа гомдсон бол бүр ч сайн. Судсыг нь барьж, бодлыг нь мэдэх сэн. Ийм хүн нэг эргэвэл эргэх шиг эргэнэ. Тэр вед нь олоод авбал зуун Бадарчаар солихгвй олз. Сайны буянаар юу магад гэж хамба Эрдэнийн тухай бодож явсан бол хөгшин чоно минь баярлах болоогвй, ардын засаг байсан цагт чи хол тэлчилж чадахгвй. Нэг л өдөр хамарт чинь дөр орчихсон байх бий гэж Эрдэнэ хамбын тухай бодож явлаа.

Эрдэнийг гэртээ ойртож ирэхэд хэдэн хүн намын хорооны дарга байхад нь барьж өгсөн том гэрийг буулган хайнаг тэргэнд ачиж байлаа. Эрдэнийн царай барзайн, магнайд нь үрчлээ тодров. Ойртож очвол намын хорооны аж ахуйн дарга мэндлээд гэмшилтэйгээр Эрдэнийг харлаа. <Би тушаал биелүүлж байна> гэж түүний нүд хэлж байлаа.

- Цэрэгт явсан хүүгийн минь гэр Доёд гуайн хашаанд дараастай байгаа шүү дээ. Бага гэхгвй бол би танд барьж өгье гэж намын хорооны галч өвгөн хэлэв.

- За би барина гэж Эрдэнэ энэ тухай аль эрт бодчихсон юм шиг хариулав.

- Үүнийг буулгачихаад энэ хайнаг тэргүүдээр бид ачиж авчраад барилцаж өгье гэж аж ахуйн дарга хэлэв. Тэр өдөрт Эрдэнэ уул гэрийг авчран барьж шинэ айл болон төвхнөв. Маргааш нь аймгийн намын хороонд очиж ажил гуйсанд аймгийн эд хэрэглэгчдийн хоршооны орлогч сургагчаар томилжээ.

Ажил хийж шинэ байдалдаа дасан, хүнтэй ярихад ижил бодолтой хүмүүс олон ажээ. Хүмүүстэй сэтгэл бодлоо солилцох тутам бухимдлын бөглөө суларч сэтгэл нь чөлөөтэй болно.

Энэ үе бол Төв Хорооны дарга асан Дамбадорж, Жадамбаа нар хувьсгалаар улс төрийн эрхээ хасагдсан шар хар феодалтай тэмцэх намын шугамыг мохоож, намын хувьсгалт бодлогыг буруу зүг хөтлөх гэж ил далд элдэв аргаар оролдож байхад түүнийг эсэргүүцсэн намын олон



гишvvдийн тэмцэл хуралдан бүрэлдэж байсан ve тул Эрдэнэ энэ тэмцлийн верт орж ирлээ.

### VIII

Итгэлтийн хот тавтай сайхан өвөлжиж, хөрөнгө нь арвижин, эзний сэтгэл хангалуун байлаа. Энэ хот айлын амьдралыг Сврэн хvvхэн хөтөлж, Итгэлт арилжаа наймаа хийх, өр шир нэхэх зэрэг гадуур ажлыг бүтээнэ. Бас заримдаа олонтой нийлж ан гөрөө хөөцөлдөнө. Өнгөрсөн намар хоёр удаа vнэгний ав хийсэн ба жинд явахын өмнө чоно авлажээ. Дараа нь хот явж шар тос, cvv зэрэг цагаан идээний наймаа хийхийн гадна амбан шар хэдийг зараад иржээ.

Солонгын хvvхэд хэзээ, хэзээгvй гарах болов. <Хvv минь хөдөлж л бай. Хvvхэд гэдсэнд таргалчихвал гарахдаа зовоодог юм!> гэж Должин цаг vргэлж хэлдэг болохоор Солонго хот арилгах, vнээ саах зэрэг ажлаас хоцордогvй байлаа.

Батыг явснаас хойш тэдний гэрийг буулгаж хvрэн дээр аваачин хураасан учир Солонго их гэрт байдаг болов. Харин арваад хоногийн өмнө Хонгор отрын адуун дээр очих нэрээр алга болсон болохоор Сврэнд хань болж Хонгорын гэрт хонодог болжээ.

Нэг өдөр Итгэлтийнд элгэн хvрэн торгон дээлтэй залуу ирлээ. Энэ бол Жаргал байлаа. Бат тvvнийг аймаг руу сургуулийн мөнгө авахаар явуулахдаа зам муруйж Солонготой уулзаад ирэхийг захижээ. Мөн Солонгод захиа, бас дээлийн торго зэрэг юм явуулсан юм.

Солонго хязгааргvй их баярлаж Батын халуун дотнын vtтэй захиаг Жаргалаар хэд дахин уншуулахдаа нулимс асгаруулан байв.

Батын элч ирсэнд Итгэлт илэрхий дургvйцсэн ч vгvй, гэхдээ баярласангvй. Өвлийн урт шөнө үйдсэн Сврэн, Солонго хоёр Жаргалтай шагай шvvрч хужирхайгаа тэнийтэл тоглов.

Ирэхдээ маргааш явна гэж байсан Жаргал, маргааш нь болохоор дахин нэг хонож морио амраагаад явъя гэлээ. Гэвч vнэн учир vvнд биш байлаа.

Сврэнгийн хөгжvvн задгай ааш, тормолзсон хар нvд нимгэн цагаан царай тvvний сэтгэлийг хөнджээ. Хонгорын тэнэмэл амьдрал, ялангуяа Тэрбиш хvvхэнтэй хийсэн нvгэлд хор нь хөдөлж байсан Сврэн ч хvрэн бор царайтай, бvдvvн ханхар биетэй залуу багшийг анхаарахгvй өнгөрөөгvй билээ. Хоёр залуу хvн бие биедээ талтай бол тvvнээ мэдэхгvй өнгөрөх нь тун ховор байдаг билээ. Энэ учраас шагай тоглож байхдаа Сврэнг ойлгосон Жаргал дахин нэг хоноод явахаар шийджээ. Эр хvний замд юу эс тохиолдох вэ.

Ингээд орой нь их гэрт хоол идэж байтал Солонго дуншин өвдөж эхлэв.

- Хvv минь өнөө шөнө тоглоод яах вэ. Ижийнхээ дэргэд унт гэж Должин хэлжээ.

Должингийн энэ vгийг Сврэн доор нь ашиглаж <Та надтай хань болж манайд унтаач> гэж Жаргалаас гуйв.

Энэ vгний далд утгыг ойлгосон Итгэлт <Бvгд л эндээ унтъя. Шөнө Солонго хөнгөрөх болбол бvгд байлгvй болохгvй> гэлээ.

- Гайгvй байлгvй дээ. Гэр эзэнгvй орхиж болохгvй. Солонго өвдвөл дуудаарай гээд Сврэн Жаргалыг дагуулан явжээ.

Ахын нь эхнэр нөхрийн нь найзтай нэг бишийг хараад Солонго хардах сэтгэл төрж байсан боловч дуншин өвдөж байснаас Сврэн, Жаргал хоёрыг гарахад ямар ч саад хийж чадсангvй.

Итгэлтийн хор хөдөлж арга нь барагдаж байсан авч бэрдээ тvvнийгээ хэрхэн ил гаргаж болох билээ. Бас тэгээд Должингийн ам асуултаас зэvvцэж байлаа.

Юу ч л гэсэн төдий л удалгvй Хонгорын гэрт Жаргалд зориулан зассан ор хоосорч Сврэн Жаргал хоёр хамт хэвтэв. Жаргалд холын сэтгэл эргэлдэж байлаа. Сврэнг Хонгороос салгаж суух тухай ч бодогдож билээ.

- Би гэдэг хvн хань ижил байхгvй гэж Жаргал тvгдчин хэлэхэд Сврэн ёжтой инээмсэглэсэнэ

- Олоод л авахгvй юу. Нөхөргvй сайхан хvvхнvvд алийг тэр гэх вэ гэлээ

Сүрэнгийн хувьд бол Жаргалтай суух тухай бодол огт байхгүй. Зөвхөн Хонгороос хариугаа авах тухай л бодсон. Тэр ч учраас <хоовон хар чи намайг дарладаг билvv? Би чиний боол чинь биш> гэж бодоход сэтгэлд нь байсан хар бөглөө алга болсон шиг нэг л аятайхан байлаа. - Чи одоо орон дээрээ очиж унт. Манай аав хврээд ирэх хvн шvv гэж Жаргалын чихэнд шивэгнэн хэлтэл тvгжээтэй vvd тvлхэх чимээ гарлаа.

Жаргал ухасхийн босож зассан орондоо орлоо. Сүрэн сэрж байгаа дүрс vзvvлэн чанга гэгч нь тамшаалснаа <хэн бэ?> гэж нойрмог дуугаар асуув.

- Би байна. Солонго нэг л биш гэж Итгэлт хэлэв.

Сүрэн босож дэн бариад хаалга тайлахад Итгэлт орж ирээд хэвтэж байгаа Жаргалыг харснаа огцом эргэж Сүрэнг ажиглав.

Сүрэнгийн царай чинэрээд ирлээ. Гэвч жижигхэн дэнгийн бүдэг гэрэл тvvнийг нууж чадлаа.

- Наадах vс толгойгоо гэж Итгэлт бэрдээ зэvvн дуугаар хэлэв.

- Муухай зvүдэлж, хар дараад гэж Сүрэн сулхан дуугаар хэлээд, vсээ илснээ

- Солонго яаж байна, аав аа гэлээ.

- Нэг л биш. Чи очиж vз гэх завсраа Итгэлт гэрийн доторхийг дахин ажиглав. Сэжигтэй юм харагдсангүй.

Сүрэн шалавхан бvсээ бvслээд шууд их гэрийн зvг явахдаа vс толгойгоо янзлав.

Итгэлт хэвтэж байгаа Жаргалыг жигшилтэйгээр харснаа эгдvvтэй дуугаар <өнөө шөнө ч явуулын хvнийг тавтай хонуулахгүй нь бололтой> гэж хэлээд өмнө нь очиж суун нvvр рvv нь зэvvн ширтэв.

<Энэ өвгөн чинь толгой руу цохиод авах нь уу?> гэж Жаргалд бодогдон vl мэдэг цааш болов.

Итгэлт хийх юмаа олж ядсан бололтой. Хvйтэн цай нэг аягыг уух зуур Жаргалын хучсан хөнжил дотуур гараа аяархан оруулж дэвсгэрийг барьж vзэн Хvн саяхан хэвтсэнээс бvlээцэж амжаагүй хvйтэн дэвсгэр гарт нь баригдав. Итгэлт удаан босож дэнг унтрааж орхиод гарлаа.

Тэндээс гараад энэ жил зориуд хаяандаа буулгасан туршлагатай эх баригч чавганцыг сэрээж аваад гэртээ орсон билээ.

Yүр цайснаас хойнохон час гэсэн дуугаа өргөн цангинуулсаар ертөнц дээр шинэ хvн, шинэ хvv мэндлэв.

Маргааш нь Жаргал ёстой л буруу харж уйлан, зөв харж инээн явлаа. Тvvний сэтгэлээс Сүрэн огт гарахгүй байлаа. Харин Сүрэн бол тvvнд нvvр өгсөнгүй.

Жаргал богцоо аваад мордох гэж гэрээс гарахдаа Сүрэнг хойноос гарч ирэх болов уу гэж vlэмж горьдсон боловч гарч ирсэнгүй. Өвөлжөөний зvг эргэн эргэн харсаар санаа алдан баруун хөтлийг давж билээ.

Сүрэнгийн цагаригласан нvдийг харах бvр Итгэлтийн хор нь буцалж тэсэж чадсангүй <Хvv минь нөхрөө эзгvйд гэртээ хvн хонуулаад, амьтны хэл ам хэцvv шvv> гэлээ.

Сүрэнгийн хөмсөг татав гэж алаг нvд нь эргэлдэн ширвэв. <Та нар намайг хадам ижий шиг номхон боол болгоё гэж бодож байна уу?> хэмээн хадам эцэгтэйгээ хэрэлдмээр байсан авч сэтгэлээ барин хариу дуугарсангүй. Гэвч тvvний харцнаас дахин олон юм хэлбэл юу ч болж магад гэж ойлгосон Итгэлт нэмж юм хэлсэнгүй.

Тэндээс Жаргал явсаар танхим дээрээ хоёр хоногийн дараа ирлээ. Хvvтэй болсондоо Бат хязгааргүй баярлан, цагийг хvlээлгvй мордон давхиж очмоор санагдсан боловч нэгдvгээрт Итгэлтэд гомдсон сэтгэл, хоёрдугаарт танхимын ажлаас болоод явсангүй.

Жаргал Солонгын тухай, тvvний хэлж захисан vг, шинэ төрсөн хvvгийнхээ тухай дахин дахин шалгаан сууна. Жаргал бол Сүрэнгийн тухай яримаар байвч <Бат бол юу ч л гэсэн

Итгэлтийн хвргэн, Хонгорын багын найз> гэж бодоод тэмүүлсэн сэтгэлээ уургалан барьж байлаа.

Цагаан сарын өмнө хойт сумаас ирсэн хоёр хvvхэд оргож, тэднийг хөөцөлдөн олж ирэх гэж Бат дөрвөн хоног зараад иртэл гэрт нь Хонгор сууж байлаа.

Хонгор дуртай дургvй мэндлээд ярианы завсраар Солонгоос гарсан хvv нь нас барсан тухай гашуун мэдээг сонсгов.

Батын дотор харанхуйлан, гэр нь эргэлдэж шалан дээр пидхийтэл суув. Хорвоо дээр мэндлээд хоёр сар арван дөрөвхөн хоноод алга болсон хvvгээ бодоход Батын нулимс аяндаа асгарна.

Энэ хvvхдийг мэндэлсэн тухай сонссоноос хойш тvvний тухай зvvдлээгvй нэг ч шөнө Батад vгvй билээ. Би хvvтэй болсон, гал голомтын эзэнтэй болсон гэж бодоход тvмэн баяр оволзон байдаг сан. Гэтэл тэр баяр пад харанхуй гашуудлаар солигдов.

<Хар тэнэг толгой, сонсмогц очихгvй яалаа. Очсон бол> Хонгор, Жаргал, Шагдар зэрэг нөхөд нь тvvний сэтгэлийг тайтгаруулах гэж аль байдаг уран vгээ хэрэглэвч тус vl болно.

- Тэгээд яасан бэ? гэж зэвхий дуугаар Хонгороос асуув.

- Нэр авалгvй осолдсон хvvхдийг хоол хvнстэй нь шуудайд хийж зам дээр орхидог ёстой юм гээд аав хvрээ зам дээр тавьсан. Би шөнө очоод оршуулчих юм билvv гэж бодсоноо чамд хэлье гэж бодоод ирсэн гэж Хонгор нэг хөгтэй дуугаар хэлэв.

Бат нvvрээ таглан хэсэг зуур дуугvй сууснаа огцомхон хөдөлгөөнөөр босож <Хамт явъя. Надад зааж аль> гэж Хонгорт хэлэв.

Yвнээс хоёр хоногийн дараа нар жаргахын вед Ням өвгөний гаднаас гурван морьтой хvн гарч баруун тийшээ зэрэгцэн явлаа. Хvн бүрийн бvсэнд нижгээд хvрз хавчуулсан бөгөөд нэг нь том чигчийн царил эмээлийн бvvрэг дээгvvр хөндөлдvvлэн барьжээ. Энэ гурван хvн бол Хонгор, Бат, Ням өвгөн нар байлаа.

Жаргаж байгаа нарыг хаасан vүлний доод зах нь шинэхэн гарч байгаа цус шиг ухаа ягаан өнгөөр туяаран, дээшлэх тусмаа нөжирсөн юм шиг хар хvрэн болсоор гялтганасан хар өнгөнд замхарсан байлаа.

Бат нvдээ бараг л цавчилгvй тэнгэрийн хаяа ширтэн, хөмсгөө эрчлvvлэн зангидаж, хааяа, хааяа гадна vl мэдэгдэх боловч дотроо гvн бөгөөд зvрхийг нь хавчин базсан урт санаа алдана.

Хоёр талд нь яваа залуу, хөгшин хоёр дуугvй боловч Батаас нvд салгалгvй ширтэн, тvvнээс ямар нэгэн эрхэм юм ойчиход алдалгvй барьж авах vvргийг амь цөлмөн авсан юм шиг хөдөлгөөн бvхнийг нь ажин явна.

Бат Хонгор хоёр өнөөдөр vд өнгөрч байхад Нямынд ирсэн юм. Хонгор гэртээ очъё гэж Батаас гуйж шаардаж vзсэн авч Бат очоогvй.

- Юу ч гэсэн хvvгээ оршуулна. Нэргvй vхсэн гэнэ. Тийм бий гэж шивэгнэн маш гvн угтай хэлж билээ. Тэгээд шууд Нямынд очиж цай уугаад Бат ганцаар гарч өвөлжөөний хойт хаданд нилээд удаан болоод ирсэн билээ. Ням өвгөн Батын гуйсан ёсоор хvрз царил бэлтгээд байсан. Тvvнийг авч мордоод явж байгаа нь энэ билээ.

Хэсэг явсны дараа Бат өндийж хатируулсанд нөгөө хоёр нь бас л хатируулав. Хөлдvv газар гишгэсэн гурван морины туурайн дуу сvртэй бөгөөд эзгvй зэлvvд vлдсэн зуслан газрыг амилуулж байлаа.

Тэд явсаар цастай толгойн шилээр давахад хvрээ зам өмнө нь харлан зурайв. Замын хажуугийн хунгарласан цасан дээр байгаа бор шуудайтай юм бараг л Тайхар чулуу шиг хөглийн бараантаж харагдав.

Түүнийг харснаас хойш Бат морио ташуурдаж бүр хурдлав. Цас манаруулан давхисаар шуудайн дэргэд ирж зогсоод мориноос бууцгаав.

Тэгээд морио хөтлөн ойртох гэсэнд хамраа тачигнуулан хулгаад явж өгсөнгүйд Бат үг дуугүй, цулбуураа Хонгорт өгөөд цас шажигнуулан урагш явахад Ням гуай ч морио Хонгорт өгөөд хойноос явлаа.

Бат шуудайд тулж очоод сөхрөн сууж, дээрээс нь бөхийн ямар нэгэн юм хэлэх буюу амьсгалыг нь сонсох гэсэн юм шиг чагнан байлаа.

Ням өвгөн дэргэд нь тэргүүнээ унжуулан, хамар нь шуухитнан зогсож байснаа эхэр татан уйлав. Бат хөдөлсөнгүй.

- Хүү минь. Сэтгэлээ барь гэж Ням чичирсэн хоолойгоор хэлээд ханцуйгаараа нулимсаа арчив. Морьдоо чөдөрлөж холбон орхиод ирсэн Хонгор өвгөний хажуугаас тохойгоороо ёврон чихэнд нь <та өөрөө уруу татаад байна шүү дээ> гэж шивэгнэв.

Нар бүр жаргаад үдшийг бүрэнхий эхэлж дүлийрсэн орог хар тэнгэр бүхний дээрээс хавхаглан бүрхэв. Хааяа морьдын тогтон ядсан хөлөөр гарсан чимээ шажигнан гарахгүй байсан бол энд амьд амьтангүй мэт ажээ.

- Бат аа хатуу бай. Сэтгэлээ барь. Явъя даа гэж Хонгорын хэлэхэд Бат толгойгоо алгуур эргүүлж харлаа. Харанхуйн дотор Хонгорын нүүр, шөнийн цагт алсад гялалзах гал шиг сүүмэлзэн харагдав.

Бат дахин бөхийж, хоёр алгаа дээш харуулан шуудайн доогуур түүний доторхи юмыг цочоохгүй гэсэн мэт аажим бөгөөд хянамгай хийгээд өргөж, цээжиндээ наагаад босож, эргэн тойрныг харснаа зүүн хойш, цас шажигнуулан нэг том нэг бага алхаж явахад нь <Та морьдоо аваад ир> гэж Нямд хэлээд Хонгор гүйн очиж Батыг сугадан авлаа.

Өвгөн морьдоо хөтлөн хойноос нь алхана. Энэ гурав ингэж их л удаан явсан боловч нэг ч үг дуугарсангүй.

Гээгт толгойн энгэр дээр ирээд Бат сөхрөн сууснаа <Миний тохмыг аваад ирээч> гэв. Хонгор эргэж эмээлийг нь аваад тохмыг нь авчран Батын өмнө ирэхэд <энд дэвсэж орхи> гэж бүдэг боловч үг бүхэн нь ер бусын тод дуугаар хэлэв.

Хонгор сөхрөн сууж хоёр тохмыг давхарлан дэвсэж байхад Батын жигд бус амьсгал нь элгэндээ шахаж тэвэрсэн шуудайг нэвтлэн энэ тасалдсан хвчирхэг амьсгал, шуудайны дотроос гарч байгаа юм шиг сонсогдож байлаа.

Бат бүх цээжээрээ бөхийж тохом дээрээ шуудайтай юмыг тавиад, хэсэг зуур элгээ салгалгүй дарж байснаа салж ядан өндийж <За газраа ухъя> гэж хэлээд босож бүснээсээ хврээ авч тавихад хөлдүү газар дан гэж дуугарав.

- Хүү минь булах хэрэг үү?

- Тийм

- Болох уу даа

- Болно. Ням хүүхдийг булна гэдгийг сонсоход хэрэггүй болов уу гэж хэлсэн билээ. Гэвч Батын шийдвэрийг эргүүлж чадаагүй. Энэ удаа бол түүний бодлыг өөрчилнө гэж хэлээгүй харин бараг л өөрөө мэдэлгүй хэлжээ.

Хонгор тэрэгний төмөр голоор хийсэн хүнд царилаа дээр өргөж цохиход дан гэж дуугараад хөлдүү газраас ойв. Тэр гурав ээлж ээлжээр хөлдүү газрыг угсран ухаж эхлэв.

Удалгүй шуурга эхэлж, салхины исгэрэх дуу, хөлдүү газар туссан хврээний хангинах дуутай хослон, хааяа хааяа оч бутран гарч байв.

Амьдралд хичнээн шуугилдан яривч бие биеэ ойлгодоггүй үе байдгийн адил нэг ч үг дуугаралгүйгээр харилцан бүрэн ойлгодог удаа байдаг юм. Энэ гурвын хэн нь ч нэг ч үг

дуугараагвй боловч бие биесийн бодлыг бүрэн ойлгож нэгэн ve Хонгорын хvнд царил битvv дуугаар дvн, дvн гэхэд дараа нь нөгөө хоёрын хvрз тачигнан хангинаж байлаа.

Чөдөртэй байгаа морьд нь шуурга уруудан биеэ хураан зогсоод бөмбөртөл чичирч байвч эзэд нь огт даарсангвй. Шөнө дундын вед нvхээ ухаж дуусав.

Бат хvрзээ газар хаяад шуудай руугаа алхах гэснээ шургачин унав. Хонгор ухасхийн очтол Бат өөрөө босоод шуудайн дэргэд очиж урьдахийн адил сөхрөн суугаад тэврэн авч vг дуугвй нvх рvв явахад нь Хонгор нэг гараараа шуудайг доороос нь тулан, нөгөө гараараа Батыг тэврэн авлаа.

Нvхний ирмэгт тулж зогсоод Бат шуудайд хацраа нааж, бvввэйлж байгаа юм шиг найгахад Ням өвгөн бvр енгэнvвлэн уйлав.

Хэсэг ингэж байсны дараа Бат баруун гараараа хормойгоо дэвсэж суугаад дээр нь шуудайгаа тавьж амыг нь задлах гэснээ

- Энэ чигээрээ дээр байх даа? гэж хажуудаа зогсож байгаа Хонгор руу харж асуув.

- Тийм байх аа гэж Хонгор хариулсан боловч өөрөө чухам юу гэж хэлснээ мэдсэнгвй. Бат шуудайг дахин авч нэг удаа чанга тэвэрснээ бөхийж толгойгоо нvхэнд оруулан, алгуур тавиад өндийхдөө гарынхаа алгаар нvдээ арчив. Хоёр гараар хажуугийн хөлдvv шорооноос атгаж, нvх рvв зөөлөн хийж эхэлсэнд Хонгор бас хийж эхлэв.

Нилээд ажилласны дараа нvх шороогоор дvврснээр барахгвй жижигхэн овоо босож Бат өврөөсөө өдөр өвөлжөөний хойт ууланд хоёр цаг гаруй болохдоо сийлсэн <Батын хvв Чулуун> гэсэн всэгтэй дөрвөлжин хөх чулуугаа тавихад орчин тойрны бvх юм хувиран ирээд дээрээс нь дарах шиг болов.

Хонгор Батыг тэврэн авч <Өвгөн минь сэтгэлээ барь> гээд ойр хавийн агаарыг бvгдийг нь уушгиндаа хийх гэсэн юм шиг амьсгаагаа дотогш уртаар хvчтэй татлаа.

Маргааш нь Бат шууд Итгэлтийнд морь хөтөлж очоод тvвнтэй ёстой л зад хэрэлдэн Солонгоо аваад буцжээ.

## IX

Дэлгэрхэн зуны тавиун өдөр Батцэнгэлийн хvрээ гэж нэрлэх болсон Луу гvний хошуу хvрээний баруун өмнөх өргөн зvлгэн дээр барьсан том гэрийн vвдэнд улаан одончvв бvтээлэгтэй ширээний ард <улаан хувьсгалч> гэж олонд нэршсэн Дорж зогсоод толгойгоо гэдрэг байн байн хаялан, магнай руугаа унасан урт всээ хойш болгон өндөр дуугаар ярина.

Гэрийн бvсэнд хавчуулсан унийн vзvvрээс vвдний дээгvвр татсан улаан даавуун дээр <Хар шар феодалуудыг сөнөөж vгээгвй ядуу ард тvмний ангийн хувьсгалыг өрнvвлье> гэж цагаан шохойгоор хичээнгvйлэн чадамгай бичсэн лоозон зөөлөн салхинд vл мэдэг хөдлөн нарны хурц гэрэлд гялалзана.

Ногоон дээр суусан олон хvний ихэнх нь эрэгтэйчvвд бөгөөд цөөвтөр эмэгтэйчvвд энд тэнд бөөгнөрөн Доржийн ярианы хажуугаар амин хувийн явдал, сум оронд болсон сонин, сонсож мэдсэн ховоо солилцон ярилцана.

Гараа зогсоо жолоогвй даллан феодалууд ба нударган нарыг аль муухай vгээр зvхэж байгаа Доржийг харсан хvмvвсийн зарим нь <аргагвй л улаан хувьсгалч хvн юм даа> гэлцэнэ. Зарим нь <Буян чавганцын энэ хархvв мөн галзуурч байна даа> гэж бодоод эвшээлгэнэ. Дорж vгийнхээ төгсгөлд нэг, хоёр, гурав гэж дугаарлаж байгаад лоозон тавьж даруй хорин таван удаа уриа хашгирав.

Дорж сууснаа дахин босож <Одоо феодал болоод нударган нараас хураасан хөрөнгөнөөс зарим нэгэн ядуу буурай ардуудад тавин олгох малын хуваарийг уншин сонсоно> гэсэнд цугларсан хvмvвсийн дунд битvv шуугиан долгион тархав.

Доржийн дэргэд сууж байсан залуу босож цугларсан олныг эргүүлэн харснаа урт цаасан дээр бичсэн бичиг задлан <тус сумын Гомбо овогтой Ням бол ядуу харц гаралтай бөгөөд нударган Итгэлтийнд зарагдаж мөлжигдөн байсан учир феодал болон нударган нараас хураасан хөрөнгөнөөс тугалтай үнээ зургаа, унах морь гурвыг хувьд нь олгосугай> гэж эхлэхэд бусад хэд хэдэн айлд олгох малыг тоочин уншлаа.

Залууг уншиж дууссаны дараа нэгэн хэсэг нам гүм болсноо хүмүүсийн эх захгүй шуугиан эхлэв.

Олны дундаас Ням босож <хүний буян хүнд шингэдэггүй болохоор өчүүхэн муу өвгөн ах нь та бүхний энэ хишгийг авч чадахгүй. Нохойн гэдсэнд шар тос тогтдоггүй гэж бурхан болооч аав минь үргэлж хэлдэг сэн. Надад битгий өгч үз> гээд нүднээсээ нулимс дуслуулав.

Нямын сэтгэлд баярлах, айх, холилдон байлаа. Хүн гэж үзээд ийм их хөрөнгө өгч байгааг бодоход баярламаар боловч хүний буян ямар ч үнэ хөлсгүй авна гэдэг нэг л ухаанд нь багтахгүй бөгөөд хоол болохгүй хор болох юм шиг бодогдоно.

- Би бол нөхөр Ням шиг засаг төрийн хишгийг авахгүй гэж чадахгүй. Төрийн сүлдэнд мөргөж уул хишгийг хүртэе гэж Галсан босож алга хавсран хэлэв.

Галсанд гурван тугалтай үнээ, таван хургатай хонь, нэг морь оногджээ. Ням олныг ширтэн гайхаж хэсэг болсноо <Надад оногдох хувийг Галсан хүүд өгчих. Хамтралд адуучин хийдэг. Намайг бодвол дээгүүр албаны хүн> гэлээ.

- Ням гуай та чинь ямар ухаанд чинь ухна үхсэн амьтан бэ? Ардын засаг танд үнэ хөлсгүй өгч байна. Ойлгож байна уу? гэж нэг хүн хэлэв.

- Над мал өгсөнгүй гэж би засагтаа огт гомдохгүй. Би тэгж гомддог хүн биш гээд Ням, Дорж руу харахад нүдэнд нь аль ч учраа алдаж айсан шинж тод байлаа.

- Нөхөр Ням та бол балрын суртлыг баримталж феодал болоод нударган нарын талд орж ангийн хувьсгалын дайсан болоход хуруу дутуу болоод байна. Үүнийг авахгүй бол хатуу ярина гэж мэдээрэй хэмээн Доржийн зандран хэлсэн үг олны шуугианыг нэг мөсөн дарлаа. Аргагүй болсон Ням өгсөн малыг тууж буцсан билээ.

Хотонд нь байгаа хангайн хад шиг тугалтай зургаан үнээ, гадна нь чөдөртэй байгаа согоо шиг гурван морийг хараад хэдэн өдрийн турш минийх ч хүнийх ч гэж хэлж чадахгүй байсан Ням аажимдаа дасаж миний юм гэдэг бодол бүхнийг ялжээ. Энэ бүхэн бол надад өгсөн миний юм гэдэг бодол бүх сэтгэлийг нь эзэлж түүнээ хайрлах, арчлах хүсэл оргилов.

Эцэг нь хүүдээ, ах дүү улс бие биедээ өмч тасалж өгдөг шиг засаг төр минь надад өмч тасалж өгсөн хэрэг гэж бодож хүний буян хүнд юм болдоггүй гэдэг бодлыг зайлуулав.

- Хөгшин минь үнээгээ саая гэж өглөө авгайдаа хэлэхэд өөрөө ивэлгэж өгдөг болсон бөгөөд <бүлтийсэн гайхал, бөөрөнхий дамшиг> гэх зэрэг үгээр тугалаа өхөөрдөн илж байдаг болов.

Нэг өдөр Ням хүнээс цоо шинэ бүрхээр худалдан авчирч <Хөгшин минь өөрийн тогооны халуун архи уудаг цаг болсон> гэхэд Хишигт гуай амьтан шоолж муу хэлнэ гэж хориглосон боловч шийдсэн сэтгэлийг эргүүлж чадсангүй.

Зуны сайхан өдөр Ням гуайн бор гэрийн тооноор хөх утаа манаран халуун цагааны эхүүн үнэр гэр дүүрэн ханхалж байлаа. Нямын нүүрэнд нь хөлс бурзайн дусал бүхэнд нь түмэн баяр, цаглашгүй жаргал хөвж галын энд тэнд нь гаран бөгтөгнөж байлаа.

Дээжийг нь бурхандаа тавиад донхор хар модон аяга дүүрэн халуун архи авгай нь барихад Ням эцэг өвгөөс дамжин ирсэн бөгөөд цагаан сараар өмсдөг хуучин хилэн малгайгаа үл мэдэг хазгай тавин уранхай нударгаа сэгсрэн эргүүлж их л намбатай аваад хошуу нь мурилзан нусаа шоржигнуулан татаж уугаад <Сайхан гарч хөөрхий минь> гэснээ <төрийн

минь сүлд> гээд хоолой нь чичрэн нүднээс нь нулимс үргэлжлэн урсав.

Гурван аяга халуун архинд согтсон өвгөн гэрийнхээ хоймор завилан суугаад <Нямын угсаа нэрж байгаагвй> гээд ташаагаа тулан, далаа хөдөлгөснөө <Муу хvv нь нэрж байгааг бурхан болооч аав минь харсан бол юу гэх байсан бол> энгэнvvлэн уйлахад авгай нь хар нулимс муу. Өвгөн минь битгий уйл гэсэн боловч өөрөө тэсэлгвй нулимсаа дуслуулж байлаа.

Үдийн вед сүрхий согтсон Ням хоёр галуун хvзvvт архи аваад мордож шууд шогшсоор хошуу сахиусны өмнөх мөнгөн цөгцөнд хийж <олон жил таны сархдыг хvртсэн өвгөн би танд барья> гээд залбирав.

Тэндээс Ням шууд явсаар Итгэлтийнд ирлээ. Урьд адуу мал багшран вймж байдаг Итгэлтийн гэрийн гадна гурав дөрөвхөн сарлагийн торой идэж байлаа. Гэрийн цаад талын звлгэн дээр дөрвөн унага уяатай байх бөгөөд зэлнээс нилээд зайтай азарга орчим адуу идэж байлаа.

Итгэлтийн гадна угсраатай байдаг олон тэрэгний оронд тав зургаан тэрэг харагдана. Урьд гадна нь байдаг айлууд vгвй болоод Итгэлтийн том гэр, илvv гэр хоёр байлаа. Харлан байдаг хонины том хашаа ор сурагвй алга болжээ.

Энэ бүхнийг хараад <Манай гадна долоо, найман сарлагийн торой тоглож байхад Итгэлтийн гадна хоёр гуравхан байдаг, төр өөрчлөгдөнө гэдэг vvнийг хэлдэг байх даа. Хөөрхий> гэж бодоод гэрээс хол бус зоосон модон шонгоос морио уяж гэрийн зvг явлаа.

Гэрт ороход Итгэлт сур элдэж байлаа. Ням Итгэлттэй мэнд амраа мэдэлцээд авчирсан халуун хvзvvтээ жижигхэн даш хадган дээр тавин <Архиныхаа дээжийг чамд барих гэж ирлээ. Олон жил чиний хаяаг тvшиж сайн сайхан явсныг би мартагвй. Манай архи овоо гарсан шvv> гэлээ.

Итгэлт сураа тавьж баяртай мишээн архи хадгийг намбатай хvндлэн авч <зарим улс ч манайхыг хижиг гарсан айл шиг л тойроод байдаг болж шvv. Эр хvнд доройтох нэг өдөр байхад сэхэх нэг өдөр байдаг юм даа. Би энэ засагт муу санаагвй, санах ч vгвй> гэснээ босож Должинг дуудан Нямыг урьж хойроо зэрэгцэн суув.

Итгэлтийн хөрөнгийг өнгөрсөн хавар хураажээ. Хороос бусдаар хоол хийж, холтсоноос бусдаар эд хийж, хэмжээлшгвй хvч ухаан зарцуулан байж хуримталсан хөрөнгөө хураагдсанд Итгэлт vлэмж бухимдан сэтгэл бодол нь хоосон хөндий болоод хvч чадал нь далавчаа огтлуулсан бүргэд шиг болжээ.

Өглөөнөөс эхлэн vдэш хvртэл ямар нэгэн юм хийж харласан сэтгэлээ зугаацуулан уур бухимдлаа дарж байлаа.

Ноёд, тайж нар болон жасын хөрөнгийг хураасан нь тvмэн зөв бөгөөд тэр хөрөнгөнд тэдний нэг дусал ч хөлсгвй болохоор тvvнийг эзэмших эрх тэд нарт vгвй юм. Харин би бол тэдэнтэй адил биш. Би бол нэгдvгээрт ард хvн. Хоёрдугаарт миний хөрөнгө бол миний хөлс, ухаан учраас намайг тэдэнтэй адилд vзэж болохгвй байсан шvv дээ гэж бодоод хөрөнгийг нь хураасан засаг төрд гомдож байсан. Гэвч энэ гомдлоо гаргавал нэмж хохирно гэж бодоод засаг төрийг муу хэлдэгвй байлаа.

Яваандаа шинэ байдалдаа дасаж, бүх гуниглал бухимдлыг Итгэлт, хэзээ ч хvнээс доргвй амьдарч чадна гэдэг бодлоор дарж байжээ.

Итгэлтэд дарсан хөрөнгө байсан. Амны эхний модонд vнэтэй зvйл чихэж хийгээд булсан дөрвөн авдар буй юм. Сүрэн бол ядуу ардын охин гэдэг нэрээр Хонгор, Сүрэн хоёр мал хөрөнгө нэлээдийг тасалж авсан. Авдартаа бол их юм хийжээ. Тэгээд Хонгорынх салж нvүсэн бөгөөд Итгэлт дуртай өдрөө хvвгийнхээ хотноос хонь шилж аваад идэж болох байв.

Сүрэн тэр хөрөнгөнд бүрэн биеэ дааж эзэгнэн байх нь Итгэлтийн бахдалыг төрvvлнэ. Ингээд

Итгэлт дуртай цагтаа малжиж чадах байв. Гэвч цагийн байдал юу болохыг харах нь чухал байлаа.

Хөрөнгө малгвй болсноос хойш орж гардаг хvний хөл татарч урьд Итгэлт гуай гээд л свйд болдог хvмvvc бараг мэндгвй зөрдөг болсон. Үвнд Итгэлт влэмж хорсож олноос тусгаарлагдмал байдал нь тvvний сэтгэлийг дарж байлаа.

Гэтэл Ням өвгөн архиныхаа дээжийг муу боловч хадагтай барьж ирсэнд Итгэлт хагартал баярласан билээ.

- Ням гуайд идээ, цай гэж орж ирсэн Должинд хэлээд өвгөний ирсэн учрыг нvдээ гялалзуулан ярьж архи, хадгийг vзvvлэв. Должин ч баярлан Нямын хvн сайтайг магтан, цай идээ тавьж өгсөн ба мөнгөн аяга гаргаж нөхөртөө өгөв.

Итгэлт архинаас амтархан уугаад <Үнэхээр сайхан гарч дээ. Архийг ч би мэднэ. Эзэн хичээвэл заяа хичээнэ гэдэг юм даа Ням гуай минь. Засаг төр ивээж өгсөн хөрөнгийг сайхан бөөцийлөх хэрэгтэй> гээд мөнгөн аяга дvврэн архи хийснээ <идээ эзнээ таньдагвй> гэж хэлээд Нямд өгөв.

- Ням гуай ч ажилч, малч, хvн дээ. Өгсөн юмыг өөд нь татаад авч чадах байх гээд Итгэлт дуугвй болж архийг аяганд хийлээ.

Итгэлт хамтрал хомооныхны ажил нь бvтэмжгвй, мал нь vхэж vрэгдэж байгааг хараад <Ээ чааваас даа. Миний гарт өгөөсэй хайран мал гэж боддог байсан. Энэ ч учраас Нямд <Эзэн хичээвэл заяа хичээнэ> гэж хэлсэн билээ.

- Манай Итгэлт ч ухаантай хvн юм даа. Нөхөр го туслагч хөрөнгөө авахуулсны маргааш нь хар vзvvрийн улиасанд боож талийсан гэдэг шvv. Ум маний бад мий хум гэж Ням хэлээд залбирав.

- Би ч vхэхгвй. Манай мал сайхан мал байсан шvv.

- Яриа юу байхав. Цэврvv шиг л амьтад байж билээ. Нөгөө танай жороо хээрийг хамтралын адуучин унаад явж байхыг харсан. Ясан яндан болчихсон байна билээ гэж Нямын хэлэхэд Итгэлт санаа алдан гомдолтой мишээснээ <За тэр ч яахав> гэлээ.

- Энэ хоёр архи уун ярьж байтал морин төвөргөөн сонсогдож удалгвй сvрхий согтсон Галсан орж ирлээ. Бvгдтэй мэнд амраа мэдээд суухад нь Должин цай аягалж өгөхөд уусангвй өмнөө тавиад <Би ардын засгийн ачаар саах vнээтэй, унах морьтой, идэх хоньтой болсон> гээд хэл нь тультран их л бардамнан хэлэв.

- Аштай юу даа гэж Итгэлт тоомжиргвй хэлээд гаансаа гаргаж тамхи татлаа.

- Та аштай юу даа гэнэ. Нударган Итгэлт бол чамайг мөлжиж дарлаж байсан харгис этгээд гэж Дорж гуай хэлсэн. Энэ бол аргагвй vнэн vг. Чи намайг загнадаг байсан тийм vv? Одоо загнаж чадахгвй. Хэрэв чи загнавал би Дорж гуайд хэлж орхино гэж Галсан агсагнан хөндөлдөхөд Ням тасалж,

- Галсан минь дэмий олон vг хэрэггвй. Чи бид хоёр Итгэлтээс идэхээрээ болсон! гэлээ

- Хурга тэжээвэл тосдоно. Бэлтрэг тэжээвэл устгана гэдэг л болж байна гээд Должин ширэв татлаа.

- Должин оо! Галсанд архи хийж өг гэж Итгэлтийн хэлэхэд нvдэнд нь хязгааргвй хорсол тодорч байлаа. Итгэлтийн уур багтан ядан бадарч Галсанг одоохон өшиглөөд хөөж гаргамаар байсан авч сэтгэлийн гvнд тэгж болохгвй, өнөөдөр Галсан vнэтэй болохоор хэрэгт амархан орно. Гэвч чи ухаантай хvн шvv гэж нэг хvн хэлээд байх шиг байлаа. Итгэлт тэвчин:

- Галсан чи согтож шvv гэж давтаж байлаа.

Хэсэг дуугвй байсан Галсан

- Итгэлт чамаас болж Дулмаа надаас зугтсан. Чи намайг ямар хvн болгосноо мэдэж байна уу?



гэж хашгирав.

- Харин миний хвчээр чи Дулмааг хэд хоног тэвэрсэн биш үү. Чи архины халуунд битгий олон үг хэлээд бай гээд Итгэлт өндийснөө буцаж суув.

Итгэлтийн гүрээ оволзон магнайд нь хөлс бурзайн царай нь минчийн, хврэн хар болон гөлөлзөж байлаа.

- Би чамайг бушуухан зайлахгүй бол үүгээр цохиж орхино шүү гээд Должин үнснийхээ төмөр малтуураа барилаа.

- За яахав. Муу сайн нударган нар сөнөтүгэй гээд Галсан босож найгасаар гэрийн үүдээр гарлаа.

Том гэрийн дотор ямар ч анир чимээгүй бөгөөд хэн ч энэ нам гүм байдлыг эвдэхийг хүссэнгүй. Итгэлтийн шанааны булчин зангиран тавирч нүд нь тулга руу ширтэн гөлөрч байлаа. Должин нөхрөө ширтэн нүдэнд нь нулимс тунаран уруулаа үл мэдэг татвалзуулна.

Ням, хадам эх, төрсөн эх хоёрынхоо хэрүүлгийг сонсон юм л дуугарвал цааш шатаахаас өөр тус болохгүйг мэдээд арга барагдан байгаа залуу хархүүгийн царай гарган бүлтэлзэж байлаа.

- Тэжээсэн бяруу тэрэг эвдэнэ гэдэг болж байна гэж Должин хэлэв.

Маргааш нь Ням гуайнд Эрдэнэ ирлээ. Өвгөн эмгэн хоёр их л хөл болж тогоо нэрж донхор модон аяга дүүрэн халуун архи хадгийн хамт барихад Эрдэнэ энгэрийнхээ товчийг товчлон, малгайгаа өмсөж сөхрөн сууж аваад

<Зээ, архи нэртэй амтат идээгээ

Алтан амсартай агар аяганд

Амсар дүүрэн бялхуулж барьсан

Ашдын баярт, үлэмжийн учралт энэ сайхан өдрөө

Зээ, идээ бүхэн чинь амттай болтугай

Эзэн хүн нь жаргалтай болтугай

Өлзий буян чинь цацран дэлгэртүгэй

Өмнө зам чинь саруул байтугай

Хүсэл бүхэн чинь биелж байтугай

Хойчийн өдөр чинь гэгээн байтугай

Хот билчээр чинь малаар дүүртүгэй

Хувин сав чинь сүүгээр бялхтугай

Урт удаан насалж

Улам улам жаргахын

Өлзийт сайхан ерөөлийг

Өөд нь дэвшүүлэн барья >

гэхэд Ням <тэр ерөөл бат орштугай> гээд өөрийн эрхгүй бөмбөрөн гарсан нулимсаа арчив.

Эрдэнэ том балгаж залгиснаа <сайн гарч шүү> гэж магтав. Эрдэнийн тавьсан аяганд Ням дахин архи хийх зуур <миний өвгөд ч нэрж байсан хүнгүй. Муу Нямын вед нь тогоо, бүрхээр нийлүүлэх учралтай байсан юм байх даа, хөөрхий минь. Ах чинь шавхруу л горьдож байсан болохоос өөрөө нэрээд ууж байна гэж зүүдлээгүй явлаа. Одоо ч нэрээд л сөгнөөд л байдаг хэрэг ээ. Ирж халуун архи ууж байгаарай> гэлээ.

- Төр өөрчлөгдөнө гэдэг энэ дээ Ням гуай минь.

- Ёстой доо. Итгэлтийн буян. Тэр хүнээс мөн ч их хүртлээ. Надад өгсөн энэ хэдэн мал чинь уул нь Итгэлтийн мал юм шүү. Олон хүн хүртлээ дээ.

Итгэлтийн ачаар нэрж байгаа юм бол та олон жил хонийг нь хариулж байхдаа л нэрж байхгүй яасан юм бэ? гэж Эрдэнэ өвгөнийг зальтай нүдээр харлаа.

- Хоёроос дээш шувтрах юмтай байж үзсэнгүй шvv дээ. Зарим жил ганц ч үнээ сааж байлаа. Хоногийн тараг л залгуулж байсан хэрэг.
- Тэгвэл ардын засаг л зургаан үнээтэй болгож өгөөд нэрж байгаа хэрэг байна шvv дээ.
- Тийм дээ. Гэхдээ над өгсөн мал чинь Итгэлтийн хураалгасан мал юм.
- Ням гуай минь Итгэлт таныг зараад өгөөгүй байсан малыг ардын засаг авч өгсөн хэрэг шvv дээ. Ням гуай хэсэг зуур гөлрөн бодолхийлснээ эрvvний сахлаа шувтарч
- Манай Итгэлт ч овтой нь ч овтой хvн. Гэхдээ би буруу санахгvй. Алдас болно гэлээ. Эрдэнэ юм хэлэх гэснээ болив. Энэ өвгөн Итгэлтийн хонийг олон жил бараг хөлсгvй хариулж хvчээ, хайрлалгvй өгчээ. Бас охин нь тvvний бэр болов. Тэгээд ардын засгийн хvчээр хэдэн үнээтэй болсноо Итгэлтийн ач гэж бодож байна. Эрдэнэ ч ингэж бодож байсан. Чамайг Итгэлт мөлжиж байна гэж Петрийн хэлэхэд огт хvlээхгvй маргаж явсан. Гэвч хожим Петрийн vгийн үнэнийг ойлгосон. Харин Ням гуай бол тvvнийг ойлгоогvй. Одоодоо ойлгох ч vгvй. Ойлгосон ч алдас болно гээд зөвшөөрөн хvlээхгvй юм.
- Эрдэнэ минь ардын засаг маань тэгээд цаашдаа олон малтай болсон хvний хөрөнгө малыг хураагаад л байх хэрэг vv? гэж Ням гуай хэсэг дуугvй байсны дараа асуув.
- Юу ч л гэсэн таны хөрөнгийг хураахгvй гээд Эрдэнэ хөгжилтэй инээв.
- Эрдэнэ энд хаанаас ирсэн бэ? Хоршооны орлогч сургагчаар ажилласнаас хойш юу болсон бэ?
- Намын долдугаар хуралд Эрдэнэ Цэцэрлэг мандалын аймгийн төлөөлөгчөөр сонгогдон очиж хоёр сар гаруй хуралдав. Энэ хуралд оролцох зуур тун их юмыг ойлгож авлаа.
- Монгол орон бол өвөрмөц, шарын шашин гvн нэвтэрсэн орон болохоор феодал, ялангуяа жасын хөрөнгийг шууд хурааж болохгvй гэсэн Дамбадорж, Жадамбаа нарын бүлгийн бодлогыг олонхи төлөөлөгчид шvvмжлэн буруушаав.
- Ард тvmний аж амьдралыг сайжруулахад тvvнд олгосон эрх чөлөөг баттай болгох гэвэл шар хар феодалууд, зарим баян чинээлэг суман эрийн хөрөнгийг даруй хураах нь зөв билээ. Шарын шашин хvчтэй нь үнэн. Гэвч бид тvvнээс айгаад зорилгоосоо няцаж болохгvй гээд Эрдэнийг vгээ төгсгөхөд хэсэг төлөөлөгчид алга ташиж баяр хvргэв.
- Тэмцэл хvчтэй өрнөн таньдаг хvmvvс ч мэндгvй зөрдөг болов. Эрдэнэ олон дахин босож vг хэлсэн бөгөөд тvvний vгэнд онолын дэлгэр санаа хомс авч, амьдралын зайлшгvй баримт арвин болохоор хvmvvс ч сонсох дуртай байдаг байлаа.
- Хурлын завсарлагаар тамхи татаж суусан Эрдэнийн дэргэд Жадамбаа бас нэг өргөн шанаатай тарган хvний хамт ирлээ.
- Энэ тарган хvнийг хэдэн улсын хэл мэддэг, өндөр боловсролтой гэж ярилцахыг Эрдэнэ сонссон билээ.
- Та энэ орны хэдэн малд тун их өшөөтэй хvн юм аа. Монгол улс малгvй болбол яахыг бодсон уу? гэж Жадамбаа асуув.
- Монгол улсыг малгvй болгох гэж энэ орны хоолыг идэж байгаа хэн бүхэн бодохгvй байх гэж би итгэж байна гэж тайван хэлэв.
- Та бод л доо. Цөөн малтай, олон ам бүлтэй нэг айл байна. Тэр айл цөөн болохоор идэхдээ хайрлана. Гэтэл тvvнд хvний малыг хурааж аваад өгч орхиё. Идэж орхино шvv дээ гэж тарган хvн хэлэв.
- Тэр айл vргэлж өлсөж байх хэрэг vv?
- Бид тvvнийг цатгахын тул өөр вйл бодох чухал. Улсын эдийн засагт хор болохгvй юм бодож олбол сайн байна.
- Би та бүхэн шиг тэнгэрийн мэргэн бодолтой хvн биш. Гэвч би өлсгөлөнд нэрвэгдсэн

хүмүүсийн хурц нүдийг үзсэн хүн. Тэр нүдний өмнө том гэгчийн хар цоожтой байшинд гурил будаа дүүрэн байсан юм шүү.

- Урьдаар эдийн засгаа хүчтэй болгож авах ч алсын бодол. Та бол хээлтэй үнээгээ идэж орхиё гэж бодож байна. Бид бол тэсвэрлэж байгаад тугалыг нь гаргаж авъя гэж бодож байна.

- Олон жил тэсвэрлэж, олон дахин тугаллуулсан боловч нөгөө өлссөн хурц нүд арилаагүй шүү дээ. Цөөн хүний гарт их хөрөнгө байсан цагт олны амьдрал сайжрахгүй гэдэгт л би итгэж байна гээд Эрдэнэ хуралд орж билээ.

Эцэстээ Дамбадорж, Жадамбаа нарын бүлэг ялагдаж тэд төв хорооны удирдлагаас зайлуулагдав. Хурал дууссаны дараа Эрдэнэ Намын Төв Хороонд ажиллаж байгаад феодалын хөрөнгө хураах ажлаар Цэцэрлэг мандалын аймагт томилогдон явж билээ.

Аймагт очмогц Эрдэнэ салбар комиссуудыг байгуулан ажилдаа орсон бөгөөд өөрийн биеэр Заяын гэгээний сангийн хөрөнгийг хураасан. Ажлынхаа голыг нь амжилттай нугалж байтал Улаан уулын хошууны намын хорооны даргаар томилогдов. Энэ вед уул хошуунд хамтрал байгуулах ажил эхэлж байлаа. Хамтралд зөвхөн сайн дураар оруулах ёстой гэсэн намын шугамыг Эрдэнэ хатуу баримтлан ажиллав.

Хувьсгалын жил хэдэн малтай болон эхэлж байгаа хүмүүс бол хамтралд орохдоо тун хойрго байлаа. Гэтэл Улаан уулын хошуунд хамтрал байгуулах ажил удаан явж байгааг аймгийн намын хороо зэмлэн буруушаагаад уг ажлыг түргэн болгохоор Эрдэнийн хуучин танил Доржийг ирүүлжээ.

Дорж ирмэгц ардуудыг шахаж хэдэн өдрөөр хорьж хуралдуулан орохгүй байсан хүмүүсийг элдвээр хавчиж нугалаа хийснээр барахгүй хомооно гэгчийг байгуулж эхлэхэд Эрдэнэ эсэргүүцэв.

Доржтой хэдэн удаа учран ярилцахад тэр нь өөрийн хийж байгааг зөв гэж зүтгээд Эрдэнийг ангийн хувьсгалын зорилгыг ойлгохгүй хоцорсон этгээд гэж доромжлоход нь <Одоохондоо би энэ хошууны намын хорооны дарга. Чи зайл. Явахгүй бол хүчээр барьж аваад хүргэж өгнө> гэж заналхийлэв.

Дорж аймаг руу явсан боловч аймгийн намын хорооны дэмжлэгийг авч эргэж ирээд хошууны намын хурал хийлгэж, Эрдэнийг Довчин бэйсийн эхнэрийн нууц амраг, цагааны цэргийн дарга байсан хүн. Ганц хүү нь нударган Итгэлтийн хүргэн гэх зэргээр хатуу шүүмжлэн барууны этгээд нэр зүүлэн ажлаас нь халсан бөгөөд эцэст нь хошуунд байгуулагдсан хамтралын нягтлан бодох болгожээ.

Тэгээд хот орж хамтралдаа мөнгөн зээллэг олж аваад буцаж явах замдаа Нямынд айлчлан ирсэн юм. Нямынд нарийн хоол хийлгүүлэн идэж хоноод маргааш нь эрт мордож явсаар Хануй голын урд эрэг дээр харуй бүрий болох вед нэг айлд ирж хоновол Содном гэдэг айл нүүдэллэн ирсэн тухай сонсож өглөө нь очив.

- Энэ жил нутгийн тал асуувал багш Хануйд нутагла. Нүүхгүй байвал модоо барина гэсэн. Тэгээд л энд нүүж ирээд байна гэж Содном шинэ нутагт нүүдэллэн ирснээ тайлбарлан ярилаа.

Эрдэнэ замын дагуу нүүдэллэж яваа хэд хэдэн айлаас <тал муу> гэснээс хойшилж яваа тухай сонссон билээ. <Лам нар юу болоод ингэж айлуудыг хойт зүг рүү нүүлгэж байгаа юм бол? Энэ жил урьд нутгаар зуд болох ямар нэгэн шинж тэмдэг олж мэдээд, мэргэн болох гэж байна уу? Нэг л учиртайдаа> гэж Эрдэнэ бодов.

Содном бол их шүтлэгтэй хүн бөгөөд лам багшаас тал асуулгүй нутаг ч сольдоггүй хүн юм. <Өвгөөн, багш пүрэв гаригт нүүгээд хэрэггүй гэж байна>, <Өвгөөн хонио даваа гаригт хяргаж эхэлбэл сайн гэж багш айлдаж байна>, <Өвгөөн эсгийгээ мягмар гаригт зээрд

звсмийн мориор эхэлж татвал сайн гэж багш айлдав> гэх зэрэг юмыг Долгорт үргэлж хэлдэг бөгөөд хоёр биеийн час өдөр, ижийгийн бурхан болсон өдөр гэж хэсэг өдрийг хvндэтгэн цээрлэнэ. Ер нь л алхам бvхнээ лам багшаар мэдvүлсэн хvн байлаа. Тэгээд өнгөрсөн хавар Заяын хvрээний хамбаас нутгийн тал асуувал Хануйн гол өнгөрч нутаглавал биед барцад, хөрөнгөнд гарзгvй гэсэн ажээ.

Чухам юу болоод ингэж олон айлыг хойш нь нvүлгэж байгаа юм бэ? гэвэл ардын хувьсгалыг эсэргvүцсэн лам голдуу хvчин их тэмцэлд бэлтгэж байлаа. Тэд энэ вед Архангай гэж нэртэй болсон аймгийн хойт хэсэгт буюу Хөвсгөл аймгийн өмнөд хэсэг бөглvү нутагт хувьсгалын эсэргvү зэвсэгт бослого гаргахын тул хvмvүс хуралдуулж байв. Гэвч тvүнийг Эрдэнэ ч, Содном ч хэрхэн мэдэх билээ.

Эрдэнийг ирэхэд Долгор vнээгээ билчээрт гаргаж залж явсан билээ. Гэрт нь морьтой хvн ирэхийг танихын аргагvй холоос харсан. Гэвч сэтгэлд нь <Эрдэнэ ирэв vү дээ> гэж нэг дуу шивэгнэх шиг болоход эхлээд бушуухан очиж уулзмаар санагдаад гэрийн зvг тvүргэн явснаа алхалт нь аажим болов. Гэхдээ буцаж эргэсэнгvй явсаар гэртээ орвол гэрийн баруун талд нь Эрдэнэ товсрогдон суугаад цай ууж байлаа.

Долгорыг хармагц Эрдэнэ аягатай цайгаа тавьж ханцуйгаа сэгсрэн босоод <золгох уу?> гэхэд Долгор инээмсэглэх мэт болсноо шууд очиж Эрдэнэтэй золгоод Содном өөд сэтгэл нь зовсон бололтой харлаа.

Зөвхөн энэ зовсон харцанд их учир байлаа. Гэмт хvн гэлбэлзэнэ гэж vг байдаг. Эрдэнэ сэтгэлд нь ер бусын дотно санагдсан учраас л Содномд ямар нэгэн гэм хийсэн мэт Долгорт бодогдсон бөлгөө.

Халимаг нь шанаанаасаа бууралтаж эхэлсэн Эрдэнэ, тvүний дасал болсон бөгөөд сvүлийн вед зvүдэнд нь байн байн vзэгдэх болсон зөөлөн том нvдийг хармагц Долгорын хацарт улаан туяа гэрэлтэн, өдөр шөнөгvй эрж байж арай гэж олсон vнэт юмаа харж байгаа хvний догдолмол боловч өрнvүн гэрэлтэй сэтгэл тvүнийг эзэмдэв. Тvүгээр ч барахгvй Эрдэнэд дотнын сайхан vг хэлмээр бодогдов.

- Хавьдаа чи хvүтэйгээ уулзсан уу?

- Хавар Солонготойгоо ирж уулзаад явсан. Одоо Солонгын хvүхэд лав гарсан байх.

- Гарсан бол харах юмсан. Тvүрvүчийнх нь хvү байсан юм гэнэ билээ гээд Долгор хөврөн гарсан нулимсаа ханцуйгаараа арчив.

- Тэр хоёр ч Итгэлтээс болж нилээд юм vзсэн байх аа. Одоо ч нэг болох байлгvй дээ.

- Уржнан жил аймгийн наадам дээр Төмөр, Дулмаа хоёртой дайралдсан. Дулмаа сайхан эхнэр болсон байна билээ. Хvү нь ёстой л тоостой гараар барышгvй амьтан байдаг гээд Долгор vл мэдэг мишээв.

Эрдэнэ тэр өдрөө явсан бөгөөд холдолгvй зvс таних айлд очиж унтав.

Тvүний бодлыг Долгор эзэмдэж байлаа. Долгорыг бодох тусам өөрийн тvүргэн занг зэмлэж хорвоо дээр дахин олдохгvй хvнээ засагдашгvй гомдоосондоо харамсана.

Эрдэнэ нь Долгорт холын ангид байсан бол энэ өдрөөс эхлэн урьдын дотно Эрдэнэ сэтгэлээс нь салахгvй болов. Их хайрыг ойртуулах хvүчтэй зvйл бол салалт гэж хэлдэг нь vнэн бололтой.

Зовлон салалт хоёрыг давж гарсан энэхэн хоёр сэтгэл гомдлын хэрмийг эвдэж эхлэв. Урьд Эрдэнийн тухай бодохдоо өөрийгөө зөвтгөхийг хичээдэг байсан Долгор Эрдэнийг ирээд явснаас хойш <Эрдэнэ минь намайг гуйсан шvү дээ? Би л, мунхаг эм, болоогvй> гэж бодож байлаа.

Эрдэнийн явсан орой vнээ сааж байхдаа Долгор бараг л өөрөө мэдэлгvй амандаа дуу аялж

байлаа.

Х

Хамтралд шинэ гишүүн элсүүлэх хурлыг удирдаж хийлгэхээр аймгаас улаан хувьсгалч Дорж ирж гэнэ гэдэг яриа Хан өндөр сумынхны сүүлчийн сонин яриа болжээ.

Энэ яриа сониноо алдаагүй байхад маргааш өглөө сумын төв дээр хурал болно гэсэн зар тархаж Төмөр, морио барьж хонов.

Хамтрал байгуулагдаад хоёр жил шахам болсон авч Төмөр ороогүй байлаа. Анхны хурал хийхэд хотод жин тээж явсан. Өвөл нь хамтралын мал үхэж, гишүүд нь хурал хийхээс өөр ажилгүй байгааг хараад хоёр удаагийн хурал дээр хичнээн шахавч дуугаралгүй сууж өнгөрүүлэв. Гэтэл энэ хавраас эхлэн нутаг усаар хавчиж, хоршоонд ирсэн цай, тамхи нь ч олдохгүй болов.

- Өвгөн минь энэ хамтралд бушуухан орьё. Тэгэхгүй бол юу ч болж магад гэж Дулмаа үргэлж хэлдэг болов. Өглөө эрт босоод Дулмаагийн урлаж хийсэн шинэ торгон дээлээ өмсөж, том мөнгөн хэт бэлээ зүүгээд мордохдоо <Өвгөн минь би орж орхий. Чи минь өгөх малаа бодчихоод байгаарай. Ардын засгийн ачаар үржсэн мал > гэжээ.

Төмөрийг очсоноос хойш хүмүүс цугларан ирж хурал болов. Ногоон даавуу дээл дээр мөрөвтэй суран бүс бүслээд, мөрөвчийн нь дагуу элдэв тэмдэг зүүсэн Дорж улаан даавуу бүтээлэгтэй ширээний ард зогсож, нүүр рүүгээ унжсан халимаг үсээ толгойгоо гэдрэг сэжлэн хаяад, хүмүүсийг тойруулан зангидмал ширүүн нүдээр ажиглаад <Ангийн хувьсгалыг мандуулж, таван жилийн төлөвлөгөөг биелүүлэн тариа будаа тарьж, үйлдвэрийг хөгжүүлж харгис дээд ангийн хар шар феодалууд болоод нударган нартай хоёр тийш тэмцэж нийгэм журмыг байгуулахад ядуу дунд ард түмэн хамтралд орох хэрэгтэй. Ангийн тэмцэл бол хүүхдийн тоглоом биш болохоор ширүүн байдаг. Биднээс хамтралыг байгуулахад барууны этгээдүүд саад тотгор хийж, феодализмын мал аж ахуйг түших гэж оролдож байна. Тэд бол японы тагнуулууд мөн. Нийгэм журмын зам бол ядуу ард та бүхний ганц зөв зам. Энэ учраас хамтралд ороогүй хүмүүс бол хар шар феодалуудын зарц, баруун болоод японы түрэмгийчүүдийн гар хөл мөн> гэж эхлээд үргэлжлүүлэн ярьж байхдаа зангидсан гараа сүртэй даллан, цээжээ зогсоо, жолоогүй ханхалзуулж байлаа.

Дорж хоёр цаг гаруй ярилаа. Зарим хүмүүс дуг нойрондоо унтаж байв. Зарим нь хазаар дарж байв. Зарим нь ажил төрөл, арилжаа наймаагаа ярилцана.

Төмөр илтгэгчийн үгийг анхааралтай сонсоогүй. Гэхдээ бусдын адил унтаагүй. <Хамтралд орох саналаа өгөөд бушуухан харих юмсан. Нөгөө сэнсээ зорж дуусгавал хүү минь баярлана> гэж бодон үгийн төгсгөлийг тэсэн ядан хүлээж байлаа.

Доржийг суухад Төмөр босож олны дундуур аажмаар алхсаар дэргэд нь очив.

- Сайн байна уу?

- Сайн. Нөхөр Төмөр сайн байна уу? гэж Дорж ихэмсэг хөндий дуугаар хариулав.

- Би хамтралд орох саналтай байна.

- Туйлын зүйтэй. Үгүй. Чи чинь өдий болтол ороогүй байсан юм уу?

- Тийм ээ. Ороогүй байсан юм.

- Муу байна даа. За овог нэр хэн билээ? гэж огцом ширүүн дуугаар асуув.

- Засагт хааны цахиур Төмөр гэдэг шүү дээ гэж Өлзий олны дундаас хариулав.

- Элэнцэг, баланцгийн чинь Засагт хаан. Феодалын ийм яриа, хамтралын гишүүдийн дотор байж болохгүй. Нөхөр Өлзий мэдэв үү гэж Дорж нүдээ солбилзуулан зандрав.

- Бурхан Гончигсүм минь үүнээс хойш болъё гээд Өлзий гэмшилтэй суув. Хүмүүс нирхийтэл инээв.

- Чимээгвй нөхөд өө! За нөхөр Төмөр хэдэн бодтой билээ?
  - Зуун гурван бодтой.
  - Юу зуун гурав аа?
  - Тийм ээ. Зуун гурав. Юу гэж?
- Доржийн царай барайн, хэсэг бодолхийлснээ шийдэмгий дуугаар <Чи бид хоёр танил. Гэвч хувьсгалын хэрэгт танил талыг харж огт болохгвй. Чи болбол хамтралд орох гавьяагвй этгээд байна> гэж Дорж долоовор хуруугаа гозойлгон хэлэв.
- Яагаад?
  - Ардыг мөлжигч ангийн дайсан нударган байна.
- Өлзий босож хэсэг зуур ангалзан ээрснээ <улаан хувьсгалч гуай. Энэ Төмөр бол нударган биш. Нударгатай дээл ч өмсөхөө бараг больсон хвн. Ардын засгийг байгуулахад улаан сахиусны> гэтэл Дорж вгийг нь тасалж:
- Нөхөд өө: Ангийн тэмцэл хурц болж байгаа вед энэ мэтийн нударган нар хамтралд шургалан орох гэж оролдоно. Иймийн тулд хувьсгалт сонор сэрэмжийг всний тонгорог шиг хурц байлгах хэрэгтэй. Энэ учраас нударган Төмөрийг алга ташиж хурлаас даруй твргэн хөөх хэрэгтэй гээд Дорж алгаа ташихад хэдэн хвн дагаж ташив.
- Төмөрийн уур нь хврч, бие нь чичрэн босоод
- Би нударган бишээ! гэж бвдvvн дуугаар хашгирав.
  - Нударган биш гэнэ шvv гээд Дорж ха, ха гэж инээснээ царай нь хувирч, долоовор хуруугаараа Төмөр рvv чичлэн зааж, vvнийг өмссөн эдэлснийг хараач. Ангийн дайсан ийм л зальтай байдаг юм даа. Бушуу зайл гэлээ.
- Төмөр шууд ухасхийн гараад морио унаад эргэж ч харалгвй давхилаа.
- Бид хувьсгалын өндөр сэрэмжтэй байсан учраас нударганыг илрvvлж чадлаа гэж Дорж ихэмсгээр хэлэв. Олны дундаас Цамба босож <Ер нь энэ Төмөр бол нударганаас гадна Улаан хайрхан уулын хошууны дарга байж байгаад барууны этгээд болсон Эрдэнийн төрсөн дvv байгаа юм. Ийм дайснуудын өмнө манай хамтрал vvd хаалгаа чанга хаах хэрэгтэй> гэлээ.
  - Хvv минь чи гvvээний цаанаас тархидаад яах юм бэ. Ямар хөгшин борхи биш гэж Өлзий хэлэхэд цугларагсад шуугилдан инээлдэв.
  - Нөхөр Өлзий, нударганыг хамгаалж байдгаа зогсвол дээр гэж Цамба хэлэв. Олны дундаас хот хийцтэй хврэн дурдан дээл ногоон бvc бvcэлж, саравчтай малгай тавьсан хvvхэн босож царай нь улайсхийснээ
  - Төмөр гуайг нударган гэдэг бол буруу. Хувьсгалын өмнө ядуу зvдvv улсад тусалж явсныг нь би сайн мэднэ. Хувьсгалын хэрэгт идэвхтэй орсон хвн гэж ярихад Дорж тасалж:
  - Урьд ямар байсныг ярихгвй. Бас ардын хувьсгалын хэрэгт оролцож явсан хвн. Ангийн хувьсгалаас урваж зайлахыг алийг тэр гэх вэ. Хуяг комиссарын гэргий ийм яриа ярьж болохгвй гэж хэлэв.
  - Тийм биш. Төмөр гуай бол сайн хвн гэж хvvхэн хашгирав.
  - Та vзэмж гуа авч ухаан чинь богино байна гэж Цамба хэгжvvн хариулав.
  - Миний vзэмж чамд падгвй. Олдох ч vгвй гэж хvvхэн хорсолтой инээмсэглэв.
  - Нөхөр өө. Ядуу ардыг битгий дарлаад байгаарай гэж Цамба хэлээд шар нvvр нь төмсний цэцэг шиг болов.
  - Наадах хvvхэн чинь Төмөрийн нууц амраг болоод л ингэж хашгирч байгаа бололтой гэж саяхан хар болсон нэг хвн хэлэхэд хэд хэдэн хвн хөгжилдөн инээлдэв.
  - Нөхөд өө. Та нар хэтэрч байна. Эмэгтэй хvнтэй ингэж харилцах нь феодализмын ёс. Дуугвй болцгоо гэж Дорж зандран хэлэхэд хvmvvc чив чимээгвй болов.

- Хар дээлийнхээ цаана халзан магнай чинь далдлагдахгвй шvv. Шударга ардыг хавчиж байгаагийн чинь хорт санааг би илрүүлнэ дээ гээд хvvхэн явлаа.

Энэ хvvхэн хэн гэдгийг уншигч та лав мэдэж байгаа биз ээ. Энэ бол таны танил Хуягийн эхнэр Цэнд шvv дээ. Хэдэн өдрийн өмнө эцгээ эргэж нутагтаа ирээд өнөө өглөө хамтралын хуралд сонирхон ирсэн юм.

Тэр орой Төмөрийн гэрт Цэнд орж өдрийн болсон явдлыг шvvмжлэн ярилцав.

- Чи аймаг орж учраа ол гэж Дулмаа хэлэв.

- Аймаг орохоор барах уу даа. Хэрэгтэй бол төвд очиж гомдол эрэх хэрэгтэй гэж Цэнд зөвлөв.

- Больё доо. Үнэнээр явбал vxэр тэргээр туулай гvйцнэ гэдэг. Юу л болбол болог. Би энэ засгийг байгуулахад бага боловч оролцсон нь vнэн юм даг гэж Төмөр хэлэв.

Цэнд хот явахдаа <Би таны тухай Хуягт хэлнэ. Бид хоёр заавал ярина. Яагаад ч ийм байх л ёсгvй> гэлээ.

Төмөр хамтралд орох тухай яриа дахиад гаргасангvй. Гэтэл хавчиж гадуурхах нь улам их болж наадамд түрүүлсэн морийг нь нударганы морь гээд бай өгсөнгvй. Бас Төмөрийн бухыг хамтралын бух мөргөсөн эсэргvv бух гэж хамтралын идэвхтэн Цамба буудаж алсан байлаа.

Бухныхаа тухай сумын захиргаанд гомдол гаргаж очсон чинь <цадиггvй бухаа харж байлгvй мөргүүлсэн нь чиний буруу> гэж хариулжээ.

## XI

Шөнө дунд өнгөрч Зая бандид гэгээний хүрээ гvн нойронд дарагджээ. Баруун хойноос зэvvvн хvйтэн салхи vлээн, тэнгэрт тvг тvмэн од анивалзан мяралзана. Хvрээний тал бvхэнд нохой янз бvрийн дуугаар яншин хуцах нь хvйтэн агаарт төмөр дэлдэх мэт сонсогдоно. Энэ шөнө хамба ламын гэрт арваад хvmvvc цугларан бүдэг дуугаар шивэгнэн ярилцана. Энэ хvmvvcийн дунд Ванчин богдтой хоёр дахин холбоо барьсан Цамба, баруун хязгаарын цэрэгт өндөр алба хааж байгаад улсын хөрөнгө vрэгдvvлсэн хэргээр халагдсан Жамбал, хулгайн хэргээр шоронд ороод саяхан суллагдаж ирсэн Тvгжил, эхнээс нь аваад эдvгээ хvртэл бараг гvн нойрондоо ардын засгийг зvхэж байдаг Бадарч мэт хvmvvc байлаа.

- Хийд жасын хөрөнгийг цөлмөн хураав. Зая гэгээнийг барьж аваачаад хороов. Лам нарыг хар болохыг уриалан дэмжиж байна. Ардын засаг шарын шашныг vндсээр нь устгах гэж байна. Ноёд дээдсийг бузарлаж гvйцэв. Одоо бид гар хумхин vvrэглэж сууж болохгvй болов. Эсхvл ингэж зvүрмэглэн сууж байгаад шашин бурхан ёс дэглэмтэйгээ хамт булшлуулах, эсхvл эрэгчин эмэгчнээ vзэх, vxэх сэхэхээ харах цаг ирлээ гэж хамба хэлээд Цамба руу хяламхийн толгойгоо дохив.

- Ванчин богд хөдлөх цаг болсон гэж хэлсэн. Биднийг эхэлмэгц тусална гэж айлдсан. Ванчин богдыг их наран улс дэмжиж байгаа билээ. Ялангуяа намайг сvvлийн удаа Долнуур хотод очиж уулзахад <цаг болсон хойшилбол хожимдоно> гэж хэд дахин айлдсан. Иймд ардын засагт дургvй бvх хvчийг нэгдvvлэн нэгэн зэрэг хөдөлж vxэлдэн занчилдах цаг болжээ гээд Цамба vгээ тасалж бvхнийг тойруулан харснаа чимхэж байсан шар тамхиа татаж хөндий ханиагаад, - миний хэлэх гэсэн юм энэ л байна гээд нимгэн манан хөөргөө даалиндаа хийх гэхэд хажууд нь сууж байсан нэг лам гараа тосож

- Таны тамхи яасан сайхан vнэртэй юм бэ. Аль вэ? гэлээ.

- Ёстой гvйхуар гээд Цамба хөөргөө өгөв. Лам хэд дахин халбагадаж чимхээд татсанаа:

- Аргагvй л юмтай газрын эд байна даа гэв.

Цамба Ванчин богдтой хоёр дахь удаа холбоо барьж ирээд хагас сар болж байгаа юм.

Ирэхдээ хэдэн боодол шар тамхи, хоёр манан хөөргө авчирчээ. Очоод Ванчин богдод зөвхөн

мөргөсөн ба харин нэг япон хүнтэй уулзаж хамбын захиаг өгч хариу заавар авсан юм.

- Ванчин богд, монголын олон лам нар та бүхэнд их найдаж байгаа юм шүү. Та бүхний зүтгэлийг бурхан болоод их наран улс өндөр үнэлж байна. Цаг сайхан болсон хойно Токио хотод айлчлан очихыг урья гэж япон хүн салахдаа хэлжээ.

Цамбын ярианы дараа хүмүүс нэг хэсэг дуугүй сууцгаав. Хамба олны байдлыг хулгай нүдээр ажиглан, шүрэн толгойтой том хашин хөөргө алган дээрээ цохиж суув.

- Ард түмний олонхийн дэмжлэгийг авсан бүхэл төрийн эсрэг зэвсэг барин босно гэдэг амар хэрэг биш. Та нарын дунд уг ажилд оролцохоос айж байгаа хүн байвал үнэнээ хэлэх хэрэгтэй. Миний хувьд гэвэл бурхан шашин ёс төрөө аврахын төлөө юу ч хийхээс буцахгүй болсон хүн гэж хамба хэлэв.

- Ардын засаг бид хоёр нэг нарны дор байж чадахгүй болсон. Ингэхлээр хамба таны хэлснээр үхэх, сэхэхээ үзэх цаг болжээ. Хөдлөхөд бидэнд зэвсэг л хэрэгтэй. Би хувьдаа арваад л хүнийг хурдан буугаар зэвсэглэж чадна. Орос ланжуу шүү дээ. Сум гэвэл хоёр хайрцагтай гэж Жамбал хэлээд хүйтэн инээмсэглэснээ орост байгаа зэвсэг бүхэн ардын засагт буй шүү дээ гэлээ.

Жамбал баруун хязгаарын цэргийн хүнсний мөнгө үрэгдүүлснээс болж халагдсанаас эхлэн ардын засгийг занаж, арав гаруй винтов, хоёр сэлээдий, хоёр хайрцаг сум, хэдэн гар бөмбөг хулгайлж авсан юмсанжээ. Халагдсан тушаалаа аваад гарахдаа <гайгүй дээ. Жамбал хэн болохыг та нарт үзүүлээд өгнө> гэж дотроо бодон шүдээ хяхнуулан хавирч явсан билээ.

- Зэвсэг олоход тун хэцүү байна даа. Наран ноён юуны өмнө та нар өөрийн газартай бол. Тэр үед чинь бид зэвсэг хүргэж өгнө гэсэн гэж Цамба хэлэв.

- Зэвсгээс чухал зүйл байна. Энэ бол олны сэтгэл. Одоо бол тун аятай цаг. Ардын засаг шашныг дайрч байна. Монгол шашиндаа хайртай. Олон түмэн хамтралд дургүй болжээ. Гэтэл ардын засгийнхан түүнийг байгуулах гэж хүчилж байлаа. Энэ байдал, удаан үргэлжлэхгүй. Ухаантай хүмүүс нь энэ бүхнийг буруу гэж ойлгоод байна. Та нар нөгөө манай энд дарга байсан Эрдэнийн тухай сонссон биз дээ. Хамтралыг хүчлэн байгуулах нь буруу. Чинээлэг ардын хөрөнгийг хавтгайруулан хураах нь буруу гэж тэмцээд ажлаасаа халагдсан гэнэ билээ. Эрдэнэ мэт бодож байгаа хүмүүс олон байгаа юм. Ингэхлээр тэд энэ алдаагаа засаж авч чадна. Түүнээс өмнө л амжих нь чухал. Бас энэ алдааг нь аль болохоор дэврүүлэх ажил хийх хэрэгтэй байна. Цамба мэт хүмүүс хар болж хамтрал, хомоонд орж дотор нь дарь булаах цаг болжээ гэж Хамба хэлэв. Ардын засгийг устгахад зэвсэг тэгэх тусмаа маш хурц зэвсэг хэрэгтэй гэдгийг хамба хэн бүхнээс илүү ойлгож байлаа. Гэвч зэвсгийн тухай яриаггүйн шалтгаан бол нэгдүгээрт тэр нь олдохгүй зүйл байлаа. Энэ учраас байгаагаа барьж хөдлөөд цааш нь юу болохыг дараа нь бодохоос өөр аргагүй ажээ. Өнөөдөр зэвсэггүй гээд хөдлөхгүй, цаг алдвал маргааш ардын засаг улам хүчтэй болно. Хоёрдугаарт зэвсгээр биш бурхны хүчээр ардын засгийг ялж болно гэдгийг сүсэгтэнд ойлгуулах нь чухал болохоор зэвсгийн тухай ярих хэрэггүй ажээ. Гуравдугаарт цагийг нь олж цохивол арсланг саваагаар алж болно гэж боддог хүн юм.

Жамбал нүүрээ гарын алгаар илж эвшээн, суниаснаа <надад ярих хэдэн зүйл байна> гээд хэн нэгний зөвшөөрлийг хүлээлгүй <зэвсэгтэй хөдөлгөөнийг олны хүчээр гэнэт алс бөглүү газар гаргаж чадвал бид түргэн зуур ардын засаггүй газар оронтой болно. Тэгвэл Ванчин богд одоо цагийн нисдэг тэргээр бидэнд зэвсэг хүргэж өгөх боломжтой болно. Ийм зэлүүд газар бол энэ аймгийн хойт нутаг. Хөвсгөл аймгийн өмнөд нутаг. Тал бүрээсээ усаар хаагдсан болохоор машин тэрэг явах боломж муутай, үлэмж зохимжтой нутаг> гээд бүхнийг харлаа.

- Энэ тун мэргэн санал байна. Энэ учраас тэр зүг сүсэг бишрэлтэй олныг дөхүүлэх ажлыг



хийвэл зохино гэж хамба хэлэв.

Урт цагаан соруултай гаансанд тамхи татан, бусдын яриа сонсож дуугвй суусан Түгжил - Нэгэнт хөдлөөд явах юм бол хүмүүсийг хүчээр дагуулж болно шүү дээ гэлээ.

Хамба хамрын тамхиа сайн гэгч нь татаж аваад

- Гэгээнийг барьж авч хороосныг олонд тараан ярих нь чухал. Тэгэхдээ ардын засаг хороосон боловч гэгээн удахгүй эргэж ирнэ гэж айлдсан. Ардын засгийг хуурч цагийг хүлээн таалал барьсан дүрс үзүүлжээ гэж ярина шүү гэлээ.

Зая гэгээн бол хорин хэдхэн настай гэнэн залуу байж билээ. Гэтэл энэ хамба түвний нэрийг барин түмэн зүйлийн хорт цуурхал дэгдээсэн юм. Ардын засгийн газраас аргагүй болж Зая гэгээнийг олноос тусгаарлаж хотод аваачсан. Гэтэл хамба санаачилж Заяын гэгээн ардын засгийг тэгж чадсан. Ингэж давсан гэж өдий төдий худал цуу яриа дэгдээв.

<Шөнө шар хаданд аваачиж буудаж алсан чинь, маргааш нь дотоодыг хамгаалах газрын байшинд урьд шөнө хээр хоноод ирлээ. Бузар хүйтэн байна гээд орж ирсэн гэнэ>, <Арав гаруй цэрэг туугаад явж байтал гэнэт шар гэрэл татаад алга болжээ. Сандарч байтал маргааш нь урьд шөнө Бээжин орж усгүй хар архи дарж дарж ирлээ. Толгой сүрхий өвдөж байна. Балгачих юм байна уу? гэсээр Шүүх яаманд орж ирсэн гэнэ > гэх зэрэг хамгийн гэнэн хүмүүсийг хуурахад зориулагдсан цуурхлыг хамба санаачлан тарааж билээ.

Ард олны дунд Заяын гэгээний ер бусын ид шидийн тухай цуу яриа тарааж түвнд сүсэг бишрэлт гэнэн хүмүүс итгэж байсан учир Улаанбаатар хотод олон нийтийг оруулан ил шүүхийн хурал хийж улсын яллагч нь <Гэгээн чи үнэхээр ер бусын ид шидтэй бол түвнээ энд үзүүл. Энэ олон харж байг> гэсэн юм.

Зая бандидын гэгээн ер бусын ямар нэгэн ид шидгүй жирийн нэгэн хүн гэдгээ олны өмнө хүлээсэн билээ. Гэтэл Зая гэгээний тухай нөгөө цуурхал дарагдсангүй улам ч ер бусын хэлбэрээр тарж байлаа.

<Байсан байгаагүй нь адил энэ гэнэн залуугаар шашин хохирохгүй. Харин ардын засгийн гарт үхвэл сүсэгтэн олон ардын засгийг буруушаахад тус болно> гэж хамба дотроо бодож байсан. Харин бусад нэг ч хүнд энэ санаагаа хэлээгүй билээ.

Хамбын гэрт цугларсан хүмүүс ардын засгийг унагаахын тул нилээд юм хийхээр тогтон ярьжээ. Бадарч, Түгжил хоёр аль болохоор зэвсэг, ялангуяа хурдан буу олох, Жамбал өөрийн хэлсэн нутагт очиж, хүмүүсийг хөдөлгөхөд бэлтгэх, Цамба хэдэн лам нарын хамт даруй хар болж хамтрал, хомоонд орж ардын засгийн алдааг улам шатаах, хамба найдвартай хүмүүсийг бослого гаргах газар руу ойртуулах зэрэг ажлыг хийхээр хуваарилжээ.

- Одоо үүрэглэж суух цаг байхгүй. Ирэх хавар гэхэд бууны дуу гарсан байх хэрэгтэй. Би Ванчин богдод энэ тухай айлтгал явуулна гээд хамба хүмүүст тарах дохио өгчээ.

Хүмүүс гэрээс гарч, хамбын бурхны гэр, галын гэрээр таран унтацгаав.

Үүний дараа өдөр хамба нилээд олон лам нарыг янз бүрийн нэрээр хүрээ хийдэд явуулахдаа нэгэн санаат том лам нартаа Хаврын дохиог хүлээж бүх ажлыг ян тан болгох тухай хэлүүлжээ.

Өөрөө Ванчин богдын элчтэй маш нууцаар уулзаж бүх бодлоо хэлээд ирэх намар буюу өвөл Ванчин богдыг монголд морилон ирэхийг урьжээ.

Хувьсгалын эсэргүү хүчин их тэмцэлд бэлтгэв. Гэтэл хамтрал хомооныг хүчээр байгуулан ард түмний сэтгэл санааг эвдэх явдал улам ч ширүүн болж байлаа.

Нэг мянга есөн зуун нэгэн онд японы империализм Манжуурыг эзэлж монголын дорнод хилд бөөн аюул заналхийлэв. Энэ бүхэн нь тогтоод хэдхэн жил болж байгаа ардын засгийг хүнд хэцүү байдалтай болголоо.

## ХII

Тариатын хүрээний харанхуй гудамжаар хоёр хүн явсаар хүрээнээс гарч танхимын зүг чиглэв.

Тэнгэрт одод мяралзан гялалзаж, хүрээний ноход бүдүүн нарийн дуугаар яншин хуцаж, ам уруудан жихүүн хүйтэн салхи үлээнэ.

Хэрэв өдөр байгаад энэ хоёрын нэгийг харсан бол галзуу хүн гэх байлаа. Сарлагийн сүүлээр үс хийж унжуулан, үстэй дээл эргүүлж өмсөөд нүүрээ элдэв будгаар эрээлэн будаж, эхнэр хүний тал үс зүүжээ. Харин нөгөөх нь бол лам хүн байлаа.

- Том гэрийн гадна очоод муухай дуугарахад хүүхдүүд нь айж шуугина. Тэгээд лаагаа барина. Яг тэр үед нь ор. Үймээн эхлэхтэй зэрэг маш түргэн гарч ирээрэй. Би хүлээж байна гэж лам хувцастай нь шивэгнэн хэлээд би хоцорьё гэхэд золигийн багш нар нь унтаж байдаг байгаа даа. Го туслагчийн хураагдсан хөрөнгөнөөс хоёр бярдан буу олон сумтай авсан гэдэг шүү гэж нөгөө хачин хувцаст хэд алхсанаа эргэж шивэгнэв.

- Хар авсан биш. Битгий олон үг ярь. Хэлснээр хийгээд ир. Буудсан ч харанхуй шөнө, бурхан сахиус хоёр хамгаалж чадах байх.

- Тэнэсэн сум толгойд гэж айхтар үг бий шүү.

- За бушуу.

Хачин хувцаст гэтэн алхсаар пад харанхуйд хайлан алга болов.

Энэ хоёр юун улс вэ? Яах гэж яваа юм бол?

Чөтгөр болж сургуулийн хүүхдийг айлган тараах гэж яваа юм.

Өдөр өнгөрөх тутам лам нар сургуулийг эсэргүүцэх тэмцлээ өргөжүүлж байгаа үе билээ. Тэд танхимын хүүхдийг элдэв аргаар ятгаж гэр гэрт нь хариулах гэж оролдсон, Цөмийг нь чадаагүй. Харин арваад хүүхдийг оргуулсан. Бат Жаргал хоёр арав гаруй өдөр хөөцөлдөж баймаажин буцааж авчирсан.

Танхимын хоолны гэрийг шатааж бас үзсэн. Гэтэл харин, амар байна уу гэсэн гай болно гэгчээр Батын шаардлагаар хошуу захиргаа цогчин жасад байсан гурил будааг дайчлан авч танхимын хүүхдийн хоолонд өгсөн ба феодалуудаас хураагдаж ирсэн малын аль тарганыг алж бэлтгэв.

Нэг удаа Батын орны араас сэлэм орж ирсэн. Хэн хутгалсныг барьж чадсангүй. Харин түүнээс хойш багш нар орон дээрээ унтаж чадахгүй болжээ.

Аз болж Бат Жаргал хоёр хураагдмал хөрөнгөнөөс нилээд сумтай бярдан буу тус бүр нэгийг худалдаж авснаас хойш овоо зоригтой байдаг болов. Өдөр бүхэн буугаа тослон зүлгэж, шөнө бүхэн сумлаж унтдаг болов.

Хүрээ хангалын үеэр багш Бат, Жаргал сумын анхны хоршооны нягтлан бодогч Шагдар зэрэг эвлэлийн гишүүдийн хүчээр лам нарыг эсэргүүцсэн жвжиг зохиож цогчин дуганы өмнөх талбай дээр тоглож билээ.

Лам, ноён, пүүсийн данжаад гурав гарч ирээд ардын засгийг элдвээр муучлан ярьсны дараа түүнийг устгахын учир хүчээ нэгтгэхээр шийдэж байтал буутай хүмүүс хүрч ирээд барьж авч жвжиг дуусдаг байлаа. Бат пүүсийн данжаадад тоглож хувьсгалыг муучлахын завсраар эхнэр хүүхдийн тухай алиа завхай юм ярьж, яр өвчиндөө болон алцагнан явж, гуншаа дуугаар ойр хавьд байсан эмэгтэйчүүдийг дуудахад хүмүүс их л хөгжилдөн инээлдэнэ.

Жаргал гурван нүдтэй тогосын өдтэй малгай, хамбан дээл өмсөж янгинасан дуугаар

<Манжийн хааны үед малгай дээрээ жинстэй, автономитын үед алба хахууль ихтэй явлаа.

Ардын засгийн үед аль муугаа үзэж алт мөнгөнөөс салж, авгай хүүхэн эргүүлэх завгүй явна> гэж дахин дахин ярьж байв.

Шагдар том гэгчийн шанам малгай, шар торгон хиазтай дээл өмссөн, урт бөгөөд бүдүүн шар эрих барьж бүдүүн дуугаар хүнгэнүүлэн хэхэрч ойр хавиар гарсан залуу бүсгүйчүүдийг дуудан <Багшийндаа очоорой. Банш бууз бэлэн гэж бодоорой> гэхэд тэд хөгжилтэй хөхрөлдөн зугтааж байлаа.

Жүжиг төгсөх дөхөж байтал хэсэг лам нар олны дундуур зүсэн ирж Батын дэргэд очоод ханцуйгаа шамлан <Эндээс түргэн зайлахгүй бол намалдгий чинь чихэж орхино шүү> гэж занал хийлэв.

<Та нар биднийг хувьсгалын дайсан нарын хар мунаар занчих санаатай байна уу? Удахгүй, харин бид та нарыг хувьсгалын улаан лантуугаар няц цохино. Бидэн рүү дайраад ирвэл ард маань улаан цэрэг бий. Цөмийг чинь барьж аваад холбож аваачаад буудна> гэж Бат хэлэв.

Лам нар баахан хаахалзаж байгаад зодож чадахгүй явсан бөгөөд Бат ч жүжгийн ёсоор лам ноёдынхоо хамтаар буутай хүмүүст туугдан явж билээ. Иймэрхүү тэмцлээс болж өдөр бүхэн хүрээний банди нар танхимын хүүхдийн хооронд зодоон болж байлаа.

Хачин хувцаст сэмхэн гэтсээр эрэгтэй хүүхдийн том гэрийн хаяанд очоод муухай дуугаар хэдэн хүүхдийн нэрсийг дуудав. Унталгүй үлгэр ярьж байсан хүүхдүүд шуугилдан тосон дэнгээ барих вед үүд нээгдэж муухай амьтан орж ирээд <Та нарыг цөмийг чинь эрлэг номон хааныд аваачиж, арван найман халуун тамын адгийн тамд зовооно> гэж чарлав.

Хүүхдүүд хашгиралдан үүдэнд ойр ортой нэг жаал ухаан алдан унав. Муухай амьтан буцаад алга болов. Хүүхдийн багш нар босож бярдан буугаа барин гарлаа.

Жаргал хачин хувцастын гүйх хөлийн чимээг сонсож тэр зүг буудаад гүйсэн боловч юутай ч тохиолдсонгүй. Багш нар хүүхдийн гэрт ороход зарим хүүхэд <Чөтгөр чөтгөр> гэж хашгиралдан уйлна. Зарим нь уйлах ухаангүй нүд нь дүрлийж, ам нь ангалзана. Нэг хүүхэд ухаан алдан шалан дээр гулдайн хэвтэнэ. Ухаан алдсан хүүхдийг орон дээр тавьж бусдыг нь тайвшруулах гэсээр байтал үүр цайлаа.

<Танхим дээр чөтгөр гарч> гэсэн үг нэгээс нөгөөд дамжин тарж нилээд хүүхдийн эцэг эх үрээ амьд мэнд дээр нь авъя гэж ирлээ. Заримд нь ухуулж, заримтай нь хэрэлдэж баймааж буцаав. Ухаан алдсан хүүхэд, өглөө нь ухаан орон боссон боловч нэг хэсэгтээ дүйнгэ, үлгэн салган явлаа. Эцэг нь ирж авах гэхэд Бат өгсөнгүй.

- Миний ганц хүү шүү. Осолдох юм бол чамаас нэхнэ гээд тэр хүн явжээ.

Багш нар чөтгөр гэж байхгүй Дайснууд манай танхимыг тараах гэж хийсэн ажил гэж хичнээн яривч нэг их тус болсонгүй. Харин сургуулийн хашааны энд тэнд чөтгөр явж байгаа тухай яриа хүүхдийн дотор дамжиж байлаа. Эцэст нь аргагүй болж танхимыг шинэ байранд нүүлгэв.

Хангай газрын уяхан хавар эхэлж дов ногоорон модны захад шар яргуй үзэгдэж, нүүдлийн шувуу гангар гунгар дуугаран таатай ажээ. Байгаль сэргэж, өвлийн нойрноос хорвоо салж тэнүүн амьсгал ирэхэд сургуульд шинэ гай тохиолдов. Хүүхдүүдийн дунд өвчин гарч яах ийхийн зав өгөлгүй нэг хүүхэд нас барлаа.

Бат аймгийн төвөөс эмч дуудахаар явах болов. Сумын эвлэлийн гишүүдийн дотроос Жаргал, Шагдар зэрэг өөрийн итгэдэг арваад хүмүүсийг цуглуулан <За нөхөд минь, танхимыг нүд салгалгүй хамгаалж бай. Дайсан улайрч байна шүү. Осолдож огт болохгүй. Би маш хурдан ирнэ > гэж хэлээд маргааш өглөө нь шинэ татагдсан цэрэгтэй хамт мордох гэсэн боловч чадсангүй. Учир нь танхимд будаа, гурил зэрэг хоолны хольц бага болсон тул хамтралын захиргаанаас үүнийг олж авах гэсээр байтал үд өнгөрөв.

Үдээс хойш өртөө хэрэглэн гарлаа. Удтал өртөөнд гүйсэн хаврын харшмал морь явахгүйн зовлон, шинэ цэргийг гүйцэх хүслэн хоёр мөргөлдөн явсаар нар хэлбийх вед Дархан уулын

өртөөн дээр ирээд гэрт оролгвй морь түргэн эмээллэхийг шаардав.

- Хvv минь хоноод, маргааш хvmvvcтэй нийлж явахгвй бол болохгвй. Замд чинь мөстийн царманд Хоовон хар бvгж байгаа. Ганц нэгээр явж болохгвй. Сум даадагвй эр гэнэ билээ гэж өртөөний ахлагч хижээл насны хар хvн хэлэв.

Батад хvнд хэрэг болох юм байсангвй. Тvvний өмсөж яваа сургуулийн хуучивтар ногоон даавуу дээл тэр хулгайчид хэрэг болохгвй нь мэдээж хэрэг байлаа.

- Би яаруу яваа хvн. Надад муу янгиа тохоод дараачийн өртөө хvргэж чадах хөл хөнгөнтэй вээмж муутай гvv, азарга аль. Тэр хулгайчид хэрэг болох юм надад байхгвй гэж Бат шийдэмгий хэлэв.

Өртөөний ахлагч Батыг хориглож ядсан боловч Бат бодлоосоо буцсангвй тул хөл хөнгөнтэй байдсан гvv, ачаатай элчид хэрэглэдэг будаггвй янгианд хавирган дөрөө хийж өгөөд явуулав.

Хулгайчийн бvгж байгаа уул ойртох тусам Батын сэтгэл аягвй болж сэтгэл нь доголдон дөрвөн зvг найман зовхисыг хялалзан ажиглаж, байдсаа давирна.

Хаанаас ч юм бэ гарч ирээд бvдvvн ташуураар цохиж орхивол яах билээ гэж бодоход бие арзасхийж вс нь босох шиг болно.

Гэтэл хажуугийн модон дотроос сум шиг гэдэстэй улаан бор морь унасан, бvдvvн ташуур барьсан хvн гарч ирлээ. Батын хоолой зангиран, нvд нь бvрхэв. Гэвч ирсэн цагт нь эсэргvvцэхээр богино боловч овоо бvдvvн хулсан ташуураа чанга атгаж бэлтгэв.

Удсан ч vгвй тэр хvн Батын ойр ирээд морины амыг татаж ажигласнаа <Батаа ямар сайхан учрал бэ> гэж дуу алдав.

Бат нvдээ цавчиж, бvрхээсээ гаргаад харвал цэнхэр торгон дээлийн энгэр заамыг задгай орхиж улбар шар бvс ороогоод наамал ултай шинэ булигаар гутал өшиглөж, цагаан алчуураар толгойгоо ороосон дэгжин эр өөр хэн ч биш, харин багын найз Хонгор нь байлаа.

- Хонгор ... чи юу? гэж Бат хашгирав. Бие биеэ таньсан хоёр найз мориноосоо всрэн бууж өмнө өмнөөсөө инээмсэглэн очиж золгов.

- Чамтайгаа энд учирна гэж огт бодсонгвй шvv. Сайхан аа! гэж Хонгор баяр багтаж ядсан нvдээ гялалзуулан амьсгаадаж хэлэв.

- Хоовон хар гэхэд нь чамайг гэж огт бодсонгвй гэж Бат хэлэхэд гэнэт учралын их баяр нvvрний нь ширхэг бvрээс хуурай хар модны оч шиг всэрч байлаа.

- Багад минь аавын хайрласан хоч шилийн хулгайч болсон ч хамт явдаг учиртай бололтой. Өртөөнийхөн хоовон хар гээд л вср бадруулан шуугиж байна уу?

- Ярьж л байна. Чи энд юу хийж явдаг юм билээ?

- Баруун талаар ажлаа хийж явсан сэдэв авахуулаад буутай хvmvvcт хөөгдөж бор мориныхоо хvчээр энд зугтааж ирлээ. Тvрvvлж ирсэн нэгийг нь чулуугаар цохиж унагаагагвйсэн бол салахгвй улс байдаг шvv. Тэгээд энэ ууланд хоёр хоног морь биеэ амраагаад явъя гэж бодсон юм. Гэтэл шvдэнз ч vгвй болоод өчигдөр энэ замаар хоёр юм явах дээр нь всрдvvлж байгаад хайрцаг шvдэнз авч орхисон юм. Бодвол өдийд хоовон хар өртөө зам дээр дээрэмдэж байна гэж ярьж байгаа байх. За тэр ч яахав. Өвгөн чинь өнөө өглөө энэ ууланд сууж байхдаа замаар шинэ татагдсан цэрэг дуу дуулан хөгжилтэй явж байхыг хараад сэтгэл хөдлөөд өдөржин юм бодлоо. Ингэж цасаар унд хийж, цармаар гэр хийж явахын оронд цэрэгт мордьё гэж бодлоо.

- Зөв Хонгор минь. Одоо вед ингэж яваад хэрэг алга. Чи ухаантай сэргэлэн хvн Зөв замаар явбал олонд их тус хvргэж чадна.

- Өвгөний чинь хийсэн хэрэг багагвй болохоор очиход минь барьж аваад гянданд хорьж орхивол яана?

- Буруугаа мэдээд зөв замд орьё гээд өөрөө очиж байгаа хүнийг тэгэхгүй.
  - Гэхдээ би хүн алааггүй юм шүү. Энэ ардын засаг гэдэг чинь үнэндээ ямаршуу зорилготой эд вэ дээ?
  - Хуучин харгис лам ноёдын засгийг унагаагаад оронд нь тогтсон засаг. Энэ засгийн эзэн бол жирийн харц ард түмэн. Бүгд эрх тэгштэй. Харин дарлаж мөлжих явдлыг цээрлэнэ. Үнэнч шударга ёсыг эрхэмлэнэ гэж Бат тайлбарлав.
  - Би харц ард мөн үү?
  - Чамд ноён, тайж угсаа байхгүй болохоор харц ард мөн шүү дээ.
  - Ижий минь ч нэг муу тайж угсаатай шүү дээ.
  - Тэр хамаагүй. Аавын талыг авч хэлэлцэнэ гэж Бат мэдэмхий бөгөөд итгэлтэй хэлэв.
  - Чамтай хамт яваад байдаг хэрэг ээ.
- Хоёр найз мордож хатируулав. Хонгорын бор морь толгой даран хатирахад Батын байдас сарвайж байлаа. Яриандаа болсон хоёр хаврын туранхай байдас тэлэгдэн хөдөлж чадахгүй эцэхийг бодсонгүй. Нэг мэдэхэд байдас яг болж таг зогсов.
- Хаяж орхиод миний бор моринд сундалдаад явъя.
  - Энэ эзгүй газар эцсэн байдас орхивол чонын идэш болгоно. Хоноод өглөө дараагийн өртөө хүрч чадах байх гэж Бат хэлэв.
  - Уул нь ч Архангай хүрэхэд юмгүй газар үлдсэн юмсан. За тэгвэл наадах муугаа ногтоор нь миний морины хүзүүнээс холбоод тавьж орхи.
  - Алга болчихгүй байгаа.
  - Намайг амьд байхад миний бор морь явгалахгүй. Морьдоо Хонгорын хэлсэн ёсоор тавьж Хонгор богцноосоо жижиг тогоо, борц, цай давс гаргаж <Иймэрхүү л аж төрж явна даа> гээд тааламжтай инээмсэглэв.
- Тэнгэрт од түгж, үдшийн хүйтэн салхи үлээв. Гэвч удалгүй мөнгөн сар уулын оройгоос тасран гарч дэлхийг цэвдэг саарал гэрлээр гийгүүлэв. Чихний үзүүрт уулын үү үү гэж жигд бөгөөд амьсгаадан дуугарах аягүй дуу сонсогдож байв. Тэр хоёр тохмоо дэвсэн, эмээлээ дэрлэж хэвтэхэд монгол хүний амьдралд эмээл, тохом дээлийн зохицсон тухай анги Эрэнчингийн хэлж байсныг яриу.
- Дүнгэр дүнгэр ярилцан ve ve инээж хэвтэхэд хорвоо хосгүй сайхан бөгөөд юм бүхэн баяр жаргалын аялгуугаар дуулж байлаа.
- Аав чамайг ингэж явахад загнахгүй байна уу?
  - Нэг удаа зэмлэхэд нь би таны хоточ нохой болоод мал хөрөнгий чинь манаж чадахгүй гэсэн. Түүнээс хойш юм хэлэхээ больсон.
- Үүр цайхын өмнө хоёр найз түр дуг хийлээ. Нам унтсан Батыг Хонгор сэрээхэд зүүн уулын орой дээгүүр үүр манхайн цайж байв.
- Түргэн шиг хөдөлдөг хэрэг ээ гээд Хонгор босож гурай, гурай гэж уянгалуулан дуудахад бор морь нь хүзүүнээсээ уясан байдсыг хөтөлсөөр шогшин ирлээ.
  - Муу нөхрөөс дээр морь байна даа.
  - Яриад юу байхав, өвгөн минь. Цэрэгт үүнийгээ аваад явна даа гэж Хонгор дүүрэн баяртай хэлэв.
- Хонгор богцноосоо боодолтой юм задалж цахиур бууны тугалган сум хэдийг гаргаж өвөртлөв.
- Чи үүнийг өвөртөлж яах нь вэ?
  - Өртөөн дээр очиж түвчирхэнэ. Чи харж байгаарай гээд хөгжилтэй инээв.
- Тэр хоёрыг өртөөн дээр очиход хүмүүс Хонгороос айн хоорондоо шивэр авир ярилцаж чоно

харсан зээр шиг сэрвэлзэж байлаа.

- За та нар битгий сэжиглээд бай. Хоовон хар хvн болж ардын засгийн цэрэгт явж байна. Энэ элчийн морийг солиод өг. Бид яарч яваа улс гээд Хонгор ажиггvй гэрт орж хувинтай тарагнаас аягалан идэж байлаа.

Өртөөнийхөн гэрт орж хатавчинд зогсон Хонгорыг гайхан харж байв. Хонгор тэднийг харж нvдээрээ инээмсэглэсэнээ бvсээ тайлахад хэдэн бөөрөнхий тугалган сум унав.

- Эртvнд намайг хөөж буудсан улсад vvнийг өгөөрэй. Харин цоолуулсан дээлээ цэргээс ирээд оёулж авна гэж байна гэж хэлээрэй гэв.

Энэ vгийг дуулсан өртөөчдийн нvд нь том болон биеэ хурааж хана руу шигдэж байлаа.

Хэсэг хvмvвс гэрийн гадна зогсон улаан бор морийг шагшин магтана.

- Ёстой армаг л ийм байдаг байх даа.

- Тэр хоёр чихийг нь, гунжин согоо шиг

- Ташаа нь тэлсэн асар шиг.

Хонгор, Бат хоёрыг гарч ирэхэд хvмvвс нам гvм болов. Өртөөний ахлагч ийш тийш хялалзан байж Батын зарыг шалгаж vзээд мордоход нь улаач залууд: <Битгий давхиарай. Энэ бор морины энг даахгvй шvв> гэж шивэглэв.

Хоёр найз өртөө дамжин довтолсоор нар ханын элэг өөд гарч байхад Цэцэрлэг мандалын аймгийн төв заяын бааюуны хойтох амыг уруудан орж ирлээ.

- Хоёулаа модон дээрээ очих уу? гэж Бат асуув.

- Маргааш очъё. Нэг л сэтгэл хөөрөөд байна.

- Хоёулаа танхим дээр таньдаг багшийнд хоноод, маргааш цэрэгт ор гэж Батын хэлэхэд нэгэнт шийдсэн хойно нь шууд очъё. Улаан дээр нь давт, бvлээн дээр нь ооч гэж vг байдаг. Өвгөн чинь явъя, маргааш уулзана гээд цэрэг дайчилж байсан гэр майхны зvг тоос татуулан давхив.

Багын найз, анд нөхөрт нь ямар сvрхий учрал тохиолдож, амьдралын зам нь хаашаа эргэхийг Бат яахин тааж мэдэх билээ.

- Өглөө заавал уулзана шvв гэж Хонгорын хойноос хашгираад танхимын зvг явлаа.

Бат танхим дээр очиж урьд сургуульд хамт байсан найзындаа хоол идээд хэвтсэн нь нам унтжээ. Нэг сэрэхэд өглөөний нар тоонын цагирагт тусаж байлаа. Тvргэн босож юм идэж уугаад гарлаа.

- Хонгортой уулзах оргилсон хvсэлд хөтлөгдөн шууд цэрэг татлагын байр руу алхав. Нэгэн гэрт орвол улаан даавуугаар бvтээсэн ширээний ард хоёр хvн сууж байлаа.

- Сайн байна уу?

- Сайн, сайн байна уу? Юу гэж явна гэж цэрэг татлагын комиссын дарга ширvвн дугаар асуув.

- Би Хонгортой уулзах гэсэн юмсан.

- Хонгор оо! гээд цэрэг татлагын комиссын дарга Батыг хөмсөг зангидан ажигласнаа, - хулгайч хоовон хар уу? гэж асуув.

- Тийм ээ. Хонгортой уулзах гэсэн юм.

- Барьж аваад шоронд хийчихсэн. Тэнд л очиж уулзахгvй юу гэж тоомжиргvй хэлэв.

- Юу? гээд Бат тэр хvнд ойртсоноо зогсож, тэр минь vнэн сэтгэлээсээ цэрэгт орох гэж ирсэн хvн. Барина гэсэн чинь юу гэсэн vг вэ?

- Үнэн сэтгэлээсээ гэнээ. Хулгайч нарын цэрэг биш. Ардын цэрэг Ламын гэгээний жасын хорин атны хэрэгтэй оргодлыг ардын цэрэгт авах уу? Болдоггvй хэрэг хvв минь.

- Би Хонгорыг сайн мэдэж байна. Тэр бол буруу замаар будилж явснаа мэдээд ардын цэргийн

албанд орж, ард түмэнд тус больё гэж ирсэн хүн гэж Бат чичирсэн дуугаар амьсгаадан хэлэв.  
- Бид төрийн ажилтай улс. Өөрөө хойноос нь орох гээгвй юм бол гар. За дараагийн хүнийг оруул гэж комиссын дарга өндөр дуугаар хэлэв.

Бат энэ хөлдүү царайтай хүний нүүр өөд нулимаад барилцаж авмаар санагдсан боловч биеэ барьж гараад шууд гяндангийн газар очсон боловч хуяг сахиул нь оруулсангвй. Өдөр турш аймгийн дээд мэдлийн хүмүүстэй хөөцөлдөж уулзаж баймааж оройн нар жаргасан хойно арай гэж уулзах зөвшөөрөл олоод очвол орой болсон өглөө ир гэж буцаав.

Батаас салаад Хонгор цэрэг дайчлагын газар очиж билээ. Татлагын комиссын даргатай уулзаж үнэн учир явдлаа яриад <Чоно шиг хот өнгийж явахаа болиод ардын цэрэгт орж хүн больё гэж бодсон юм?> гэлээ.

Дарга зальтай нүдээр Хонгорыг харан бодож байснаа, <авна, авна. Би гараад эмч авчирья. Эртүүд мэндийг чинь үзнэ. Чи үүдний майханд ороод хувцсаа тайл> гээд инээмсэглэв.

Хонгор гэрийн хаалганд асарлаж барьсан майханд дуу аялан хувцсаа тайлав.

Дөрөв таван залуу хүмүүс гэрт орж байх нь нүдний нь буланд харагдав. Хонгор бүх хувцсаа тайлж гуяа алгадан дэвтэл орж ир гэж гэрээс дуудав. Дээлээ авч нөмрөөд орвол том биетэй дөрвөн залуу тал бүрээс нь довтлон ирж ноцолдов.

Нөмөрсөн дээлээ алдаад чармаа нүцгэн болсон Хонгор хүч тэмцэн ноцолдсон боловч мултарч чадалгвй баригдан хүлэгдэв.

Хүлээтэй хэвтэж байгаа Хонгорын дэргэд нөгөө хүн ирээд ёжтой инээмсэглэснээ <Энэ хулгайч мөн цэрэгт оров оо> гэлээ.

Хонгор хариу дуугарсангвй. Нүд нь гөлөлзөж шүд нь тачигнаж хөмсөг нь зангиран хорссондоо бие нь чичирнэ. Ингээд Хонгорыг гянданд хүргэхээр аваад явахад <Эр хүний замын хүзүү урт гэдэг юм шүү> гэж тэр хүнд хэлжээ.

Бат өглөө босож гяндангийн газар очвол бөөн шуугиан болоод байлаа. Тэр шөнө пийшингийн нүхээр Хонгор оргож гараад шинэ цэргийн морьдын хамт байсан бор морио аваад алга болсон ажээ.

Маргааш нь Бат Архангай аймаг дээр ажиллаж байсан Зөвлөлтийн эмчийг аваад танхимын зүг буцав.

### XIII

Дөнгөж хаваржаандаа буусан айлд цөм хөтөлгөө морьтой буу цоор болсон дөрвөн хүн ирж буув. Тэдний дотор модон хуйтай сэлээдий буу зүүж, хүрэн торгон дээл дээр шар гяраг ороосон эр байсан нь нөгөө Түгжил гайхал байлаа.

Энэ бол Содномынх байсан бөгөөд <биднийг хамба багш явуулсан> гэж ирэгсдийн нэгний хэлснийг сонсмогц Содном хөл алдан тарган мах чанав.

- Дөрөө чангалах юм бий юу? гэж ирэгсдийн нэгэн нь хэлэв.

- Мартаж орхижээ гээд Содном авдраасаа морин шил арз гаргаж халаалган өгөв. Морин шил чанга арзанд халж, ам нь цоорсон хүмүүс ярьж гарлаа.

Маргааш өглөө ардын засаг болоод хамтралыг үнсэн товрог болгох их дайн бүх монгол орон даяар эхлэх тухай тэд нар ам булаалдан үлэмж түрэмгий ярилаа.

- Ардын засгийн цаг нь гүйцсэн гэж Ванчин богд Лүндэн буулгасан гэж нэг нь хэлэхэд <Бид өнөө шөнө хамба багшийн зарлигаар улааныхны сумын дарга Дорж, хамтралын нягтлан бодох Эрдэнэ бас бус хэдэн хүний бодийг хөтөлнө> гэж үлэмж согтсон Түгжил тультран хэлэв.

Долгорын царай үнс шиг хөх болсноо эрс эргэж шууд гараад уяан дээр байсан морьдоос хамгийн дөмгийг нь унаад давхилаа.

Морин төвөргөөний чимээгээр хэрэг биш болсны сэжиг авсан ирэгсэд гэрээс цувралдан гүйж гарлаа. Долгор морио ташуурдан баруун өмнө зүг хурдалж байлаа.

- Сум руу явлаа. Буудаач.

Түгжил сэлээдийгээ авч нэг буудаад дахиж буудах гэтэл Содном гараас нь барьж авлаа.

- Миний эхнэр битгий буудаач. Алчихвал яана.

- Бушуухан мордооч. Хөөгөөч.

Түгжилийг уяа руу явах гэхэд нь Содном, зууран авч ноцолдон <та нар яаж байна> гэж амьсгаадна.

- Хамаг хэрэг нурлаа. Бушуул.

Түгжил хвчтэй өшиглөхөд Содном гэдрэгээ унасан боловч дахин зуурч авлаа. Гэтэл буугаа гэдсэнд нь тулгаж байгаад буудаж унагаагаад морио авч мордон Долгорын хойноос хурдлав.

Энэ хүмүүс шөнийн харанхуйгаар гэтэн очиж Дорж, Эрдэнэ зэрэг нэр бүхий хүмүүсийг барьж аваад шууд буудаж алах зарлигийг хамбаас хүлээж аваад явж байгаа юм. Гэтэл архины халуунд чалчиж орхив. Маргааш өглөөний нарнаар ардын засгийг эсэргүүцсэн дайн хамбын хэлснээр бүх монголд гарах ажээ. Хэлэхгүй юмаа хэлснээс болж тэр дайны өмнө хийх ёстой юмаа бүтээж чадахгүйд хүрэв.

Түгжил морины дэлэнд хацраа нааж байн байна ташуурдан буугаа бэлхэн барин давхина.

Долгор уяан дээрээсээ овоо морь авчээ. Гэвч хамгийн сайныг олж чадсангүй бололтой. Удаан боловч мөч өнгөрөх тутам зугтаж яваа Долгор, нэхэж байгаа Түгжил хоёрын зай ойртоно.

Сум хүртэл уг нь юм үгүйсэн. Хагас өртөө шүү дээ. Түгжил хааяа хааяа буудаж эхлэв.

<Морь минь бага газар үлдлээ шүү дээ. Яваач дээ> гэж Долгор үглэн морио ташуурдан байн байн эргэж харна. Баруун далыг хавсран нэг сум оноход Долгор золтой л мориноосоо унасангүй. Сумын захиргааны бараа харагдав.

Долгорын цус ямар ч хаалтгүй урсан бүх юм нь улаан боловч давхисаар байлаа. Дахин нэг сум буслэхээр нь онов. Ухаан нь балартан урьд бүүргээсээ зууран барьж авлаа.

Энэ вед оройн нар жаргаж, уулын сүүдэр хувшлэн байлаа. Бууны дуугаар сумын төвийн хэдэн гэрээс хүмүүс гарч хөөцөлдөн яваа хоёр хүнийг гайхан харлаа. Гүйцэхгүй болсноо мэдээд Түгжил урамгүйгээр морины амыг эргүүлэн хурдлав.

Гээг нь задран сэгсийж, бүх юм нь цус болсон Долгор шууд явсаар Эрдэнийн гэрийн дэргэд очиж зогсов. Гаднаа зогсон буудалцан хөөцөлдөж яваа хүмүүсийг гайхан харж байсан Эрдэнэ ирсэн хүн бол Долгор гэдгийг арай ядан таньж мориноос нь тэврэн буулгав.

Сум зад татан гарсан хөхөө зүүн гарын алгаар дарж байгаад <Эрдэнэ минь чамайг өнөө шөнө ирж алах гэж байна. Бас хушуу даргыг.. маргааш өглөө буутай хүмүүс ардын засгийг устгах ... гээд үгээ хэлж дуусалгүй тормолзож байдаг хоёр алаг нүд нь цагаанаар эргэлдэн бие нь сулран хөшив.

- Долгор минь. Долгор минь гэж Эрдэнэ хяхарсан давчуу дуугаар хашгирав. Тэвэрсэн гар нь цус болж нүднээс нь ойрын жил гараагүй гашуун нулимс ундрэн гарлаа.

Хацраа Долгорын хүйтэн хацарт наан <Чи минь яав даа> гэж гүн санаа алдаж хэлснээ тэврэн босож гэртээ оруулаад орон дээрээ тавьж сөхрөн суугаад амьдралын тэмдэггүй болсон нүүрийг удтал ширтсэнээ хацарт нь цустай наалдсан шанхыг салгаж хойш нь илэв.

- Би чамайг ирнэ гэж үргэлж хүлээж байсан юмсан гээд өргөн магнай дээр нь үнсээд босож гарын алгаараа нулимсаа арчаад ханын толгойд дүүжлээстэй байсан бярдан бууг авч мөрөвчлөн авдраасаа сум авч өвөртлөөд гарах гэснээ зогсож <Би буцаж ирж чадахгүй ч байж магад> гээд эрс эргэж гарлаа.

Урьд Эрдэнэд олон сумтай сэлээдийг буу байсан. Гэтэл баруун болсон найдваргүй хүнд



хурдан буу байлгаж болохгвй гээд тvvнийг нь хураажээ. Энэ бярдан бууг хэдэн сарын өмнө хvнээс худалдаж авсан юм. Шууд явж Доржийнд очвол тэр нилээн халамцаг унтаж байлаа. Эрдэнэ угзран сэрээж эхнэр хvvхдийг нь зовоочихоос болгоомжлон бараг чирч гаргаад учир явдлыг хэлэв.

- Чи ямар санаатай ингэж ярьдаг эсэргvv вэ? Ард тvмэн засагтаа тэрслэх ёсгвй. Би сумын дарга мэдэж байна.

- Ард тvмэн биш. Эсэргvv нар. Миний хэлдэг vнэн болох нь.

Эрдэнэ сvүлийн вед лам нарын зан нэг л биш болоод байгааг тод баримтаар биш боловч зөн ажиглалтаар мэдэж байв. Өмнөх нутгаас улаан хан сумын нутагт нvvдэллэн ирсэн айлуудын заримтай нь ярьж vзэхэд цөм л лам нарын заавраар иржээ. Үе улиран нутагласан газар нь өдий олон хvний аминд зэрэг барцадтай болно гэдэг vлэмж сонин хэрэг байлаа. Өөрийн сэжиглэлтийг Доржид хэлэхэд <Эрдэнэ чи ямар санаатай хvн бэ? Дахиж ийм яриа гарвал зvгээр орхихгвй шvv> гэсэн юм.

Гэвч Эрдэнэ санаа амраагвй. Ялангуяа хоршооноос бярдан бууны сум хайрцгаар авсан нэг хvн саяхан хар болсон лам байсныг мэдсэнээс хойш тун сэрэмжтэй болж хэн нэгэн хvнд сум, дарийг их хэмжээгээр хамаагвй худалдахаа зогсохыг худалдагчид нь зөвлөжээ. Гэтэл vүнийг нь Дорж мэдээд учиргвй уурлан <Ард тvмнийг хардаж байгаа> Эрдэнийн зан байдлыг намын vүрийн ойрын хурлаар авч хэлэлцэх болсон юм.

Доржийн согтуу нvд гөлрөн байснаа <Чи өөрөө эсэргvv мэдэв vv> гэж хашгирав.

- Чи саяын бууны дууг сонсоогвй гэж vv? Өнөө шөнө бид хоёрыг алах гэж байна. Маргааш өглөө буутай хvmvvc ардын засгийг устгахаар босох гэж байна. Тvргэн хөдлөхгвй бол болохгвй гэж Эрдэнэ нам боловч тvргэн бөгөөд тод хэлэв.

- Юу, намайг алах гэнээ? Хэн,

- Буутай эсэргvv нар гээд Эрдэнэ Доржийг орхиж сумын төвийн бvх эрэгтэйчvүдийг цуглуулбал Доржтой арав болов. Доор нь хэдэн хvн явуулж хамтралын ойр байсан адуунаас дөч шахам морь авчруулав. Ингээд хамтралын дарга толгойтой дөрвөн хvн хоёр бярдан, зэс малгайт, цахиур буу тус бvр нэгийг өгч, бvх эхнэр хvvхдийг авахуулан аймаг руу бөглvv замаар явуулав.

Хоёр бярдан, нэг зэс малгайт хоёр цахиур буутай vлдсэн хvmvvc сумын төвөө хамгаалах болов. Харин Дорж бол герман хийцтэй хурдан буутай байлаа. Эхлээд Дорж нэг л итгэж өгөхгвй байсан боловч бусдын эхнэр хvvхэд явахад эхнэр хvvхдээ явуулжээ. Гэвч маргааш өглөө нь лам нарын зэвсэгт бослого эхэлснийг сонсоод Эрдэнийн эрхэнд орлоо.

Бага vдийн вед зэрэглээ хойт сумын хамтрал, хоршоог зэвсэгтэй лам голдуу хvmvvc талж, vлдсэнийг нь шатаасан тухай мэдээ ирлээ.

Орой нар ханын элэг өөд авирахын вед сумын хойт даваагаар Бадарч, Тvгжил хоёр удирдсан гуч гаруй морьтой хvmvvc орж ирэхэд харвал бараг л буутай ажээ.

Эрдэнэ хvmvvcээ нууцлан хэвтvvлж <Дохио өгөхөөс нааш буудаж огт болохгвй`!> гэж тушаав. Хvmvvc ойртож ирэхэд Эрдэнэ өндөр дуугаар <Та нар буц. Нааш нэг л алхвал буудна шvv> гэж хашгирав.

Тэр тvр зогссоноо мориндоо ташуур өгч дайрахад Эрдэнэ буудах тушаал өгөв. Зургаан буу нижигнэн сvртэй дуугарав.

Эсэргvvнvvд морьдын амыг эргvvлэн зугтав. Гэтэл нэг хvн мориноос унаснаа босоод бусдынхаа хойноос гvйв. Эрдэнэ Доржийн бууг шvvрэн аваад буудав. Гvйж байсан хvн тvрvv урагшаа унав. Удалгвй морьтой хvmvvc хойт даваагаар даван алга болов.

Тэр унасан хvн бол Бадарч байсан бөгөөд тvрvvчийн сум мөрийг нь хальт шархдуулсан

бөгөөд Доржийн буугаар буудсан Эрдэнийн сум зузаан гуяар нь оножээ.

Эрдэнэ, Дорж хоёр буу онилон барьсаар ойртон очиход Бадарч уйлан залбирч амь гуйв.

Эрдэнэ эсэргүү нарын тухай мэдээ асуухад Бадарчийн нүүр нь татганан, амьсгаа нь давхцан хариулж байлаа.

- Үүнийг яах вэ?

- Таны хэлдгээр ангийн тэмцэл ширүүсэж байгаа вед гээд Эрдэнэ Бадарчийг буудаж орхив. Маргааш нь үүрийн гэгээ хаяарахын вед эсэргүү нар нилээд их хүчээр Улаан хан сумын төв рүү дайрч хоёр цаг гаруй байлдсаны дараа Эрдэнийн дөрвөн нөхөд алагдаж, Дорж баруун мөрөндөө хүнд шарх авлаа.

- Одоо бид тогтоохгүй. Би түр ч гэсэн тогтоож байя. Чи урд гүдгэрт байгаа морьдоос нэгийг унаад бушуу зайлж, аймагт юу болсны мэдээ хүргэ гэж Эрдэнэ буудах зуур хэлэв.

- Үгүй хоёулаа хамт зайлъя.

- Бушуу яв.

- Эрдэнэ минь. Чамайг таниагүй миний сохор нүдийг өршөөгөөрэй.

- Бушуу яв. Хожимдвол болохгүй.

- Хамт явъя

- Одоо явахгүй бол чамайг буудна шүү.

Чи үүнийг ав гээд Дорж буу сумаа Эрдэнийн дэргэд тавиад цааш гүйв.

- Гүдгэрээ дагаж яваад урьдах модонд ороорой гэж Доржийн хойноос Эрдэнэ хашгирав.

Өглөөний нар дээр мандсан хойно эсэргүү нар сумын төвийг эзэлж юуны өмнө хоршоо, хамтралын юмыг цөлмөн хувааж үлдсэнийг шатаав.

Хүлэгтэй Эрдэнийг Түгжилийн өмнө авчрав. Эрдэнийн халимаг үсийг Түгжил их л шогтой харж байснаа <Алив. Тэр сайхан үснээс над нэг тугийг аваад өгөөч> гэж нэг хүнд хэлэв.

Тэр хүн ирж Эрдэнийн үснээс чангааж нилээд ноцолдоход <Биш ээ. Ингээд авахгүй юу> гээд Түгжил өөрөө очиж <Ингээд, ингээд> гэж гурав дөрвөн туг үс авч хаялаа.

Эрдэнийн толгойн хуйх халуу оргино. Гэвч цааш юу үзэхийг бодоход үс зулгаах нь юу ч биш байлаа. Бидний өмнөөс буудаад байдаг чинь чи биз дээ.

- Бид буудсан.

- За үүнийг хадгалж бай. Дүвчин гэгээн ирээд ямар янзаар тамд хүргэж өгөхийг зааж өгнө гээд Түгжил эзэнгүй орхисон гэрүүдийн зүг явлаа.

Орой нар жаргасан хойно Цамба ирлээ. Хүмүүс түүнийг Дүвчин гэж мөргөнө. Эрдэнийг Цамбын буусан гэрт оруулахад Түгжилтэй хамт архи хамт уун сууж байлаа.

- Уухай. Хуучин танил хүн байна.

- Содномын эхнэрийг орон дээрээ алаад орхисон хүн дээ.

- Би алаагүй.

- Тийм бий? Урьд Луу гүний хошуу наадмаар бид хоёр нэг оосор зангилсан юмсан. Би түүнийг одоо тайлна. Чамаар нар тахина. Өглөө яг мандахад нь зүрхийг чинь амьдаар чинь сугалж шүү дээ гээд нэг хүнийг дуудаж Эрдэнийг харж хонох зарлиг буулгав.

Цамба Түгжил хоёр ойр орчмоос залуу бүсгүйчүүд авчруулан архидан завхайрав. Эсэргүү нар цөм хэн юу олсноо ууж шуугилдан хашгиралдсаар нам болов.

Шөнө дунд нилээд өнгөрсөн хойно Далай Вангийн хошуунд ардын засгийн төлөөлөгчөөр очиж байхад нь галч нь байсан нэг хүн Эрдэнийг тавьж морь өгөөд аймгийн зүг довтолгов.

XIV

Өвөл өнгөрч хавар болов. Гэтэл нэг өдөр Төмөрийнд дөрвөн морьтой хүн ирлээ. Цөм Хан өндөр сумын таних хүмүүс ажээ.

- Төмөр минь. Цаг зэвүүн болж байна. Зуу илүү бодтой хүнийг барьж аваад Дотоодыг хамгаалах газрын нүхэнд хориод зовоож зовоож буудах гэнэ. Зарим газар барилж эхлэхэд нь тэмцэлд гарч байна. Рашаантын хүрээн дээр Очирбатын яам байгуулагдаад хамтралын эсрэг байлдахаар цэрэг эр цуглуулж байгаа гэнэ. Түүний нэг удирдагч нь Жамбал гэдэг ардын цэргийн дарга байсан хүн болжээ. Бид баригдаж муугаа үзэхийн өмнө уралцъя гэж шийдээд Очирбатын яам руу явж байна. Чи ч амьд дээрээ явбал дээр гэж нэгэн нь хэлэв.

- Уул үзээгвй хормой шууж, ус үзээгвй гутал тайлах гэгчээр учрыг нь мэдээгвй байж юу гэж очих юм билээ дээ гэж Төмөр бодолхийлэн хэлэв.

- Учрыг нь олох гэсээр байтал нэг шөнө л баригдана. Явж үзье. Төмөр минь.

Ингэж баахан ярилцаар Төмөр явах болж шилдэг морио барьж ирлээ.

Энэ хамтрал байгуулах буруу нь буруу болсон гэдэг нь Төмөрт тодорхой байлаа. Үүнийг устгахгвйгээр энэ улс орон хөгжиж чадахгвй. Мал хөрөнгө ч сүйдэх болж байна. Энэ учраас тэнд юу болж байгааг үзье гэж Төмөр бодсоноос явах болжээ.

- За эхнэр минь. Би очиж үзээд ирье гэж Төмөрийг мордоход Дулмаа <Өвгөн минь хянамжтай яваарай> гэж хэлээд хойноос нь тахил өргөжээ.

Гурван өдөр яваад дөрөвдэх өдрийнхөө өглөө Рашаантын хүрээн дээр очив. Олдсон юмаараа зэвсэглэсэн хэдэн зуун хүн бужигнан сүлжилдэж бүрээ бишгүүр хангинаж их л хөл вймээнтэй ажээ. Хүн бүрийн хувцвнээс элдэв өнгийн зангиа хадаг зүүсэн харагдана.

Төмөр олны дунд орон байдлыг ажиглан явлаа. Хүмүүсийн ярианы ихэнх нь хамтралыг устгах, улаан мухар толгойтон халимаг үстэнг дарах тухай байв.

Шинэ ирсэн улс цогчин дуганы өмнө цуглаарай. Шамбалын дайнд мордох тангараг өргөнө гэж хэд хэдэн хүн өндөр дуугаар зарлаж байгааг сонсоод Төмөр хамт ирэгчдийн хамт очив.

Очсон хүмүүсийг морьдоос буулган, газар суулгав. Төмөр урд эгнээнд тавтай гэгч нь завилан суув. Цогчин дуганы үүд алгуур нээгдэж барсын сүүл барьсан хэдэн лам гарч ирээд хоёр талаар зэрэглэн зогсов.

Хиазтай улаан торгон дээл өмсөж хадаг яндар болсон сэлээдий буу баруун ташаандаа зүүсэн лам гарч ирлээ. Харвал хэдэн сарын өмнө халимаг үстэй хар хүн байснаар барахгвй, хамтралын идэвхтэн гишүүн байсан Цамба ажээ. Түүний дараа хөх торгон дээл дээр ногоон бус бүслээд баруун ташаандаа сэлээдий буу, зүүн ташаандаа хадаг яндар болсон урт сэлэм зүүсэн Түгжил гарч ирлээ.

- Шамбалын дайнд мордох гэж байгаа олон шавь нар аа! Энэ бол халхын хаяа буянгаар тодрон гарсан Цамба гэгч хувилгаан билээ. Та бүхэн цөм шавь орж, тариндсан зангиаг нь хувцвндээ зүүвэл улааны суманд огт даагдахгвй гэж нэг лам хэлээд Жамбал руу эргэж энэ бол улаантныг дарах ариун дайныг удирдахаар заяагдан тодорсон их жанжин төрийн багана Жамбал. Улааныг дарах дайныг дуусгаж, төр түвшин болтол үхэшгвй мөнхийн хутаг олсон хүн гээд ихэмсгээр хоолойгоо засаж Түгжилийг заан энэ бол шар цэргийн өмнийг нээгч, барсын хүчит ямар ч суманд үл автагдагч хувилгаан жанжин Түгжил гэлээ.

Төмөр тоомжиргвй хүйтэн инээмсэглэсэнээ босож шууд явсаар цогчин дуганы довжооны дээр гарахад хэн ирж байгааг таньсан Түгжил ум хумгвй дуган руу зугтан орлоо.

- Төмөр цугларсан олныг тайвнаар тойруулан харснаа энэ зальтай этгээдүүд та нарыг мэхэлж байна. Эд нар өөдтэй юм хийхгвй. Саяын дуган руу зугтан ордог Түгжилийг хувилгаан жанжин гэж байна. Үнэндээ хэдэн морины төлөө, хамт явсан нөхрөө хутгалж байсан хулгайч шүү дээ. Цамба чинь саяхан хамтралын идэвхтэн гээд хамтралын бухыг мөргөсөн эсэргүүв бух гэж миний бухыг буудаж алж байсан биш бил үү? Өнөөдөр та нар бие биеэ хувилгаан өргөмжлөн олныг мэхэлж байна гэлээ.

- Олон шавь нар аа. Энэ бол улааны нохой байна. Үвний үгийг битгий сонс гэж Цамба хоолойгоо чихруулан хашгирав.

- Чамд үнэн үг аягвй байна уу? Тийм байх ёстой. Та нар бол худалч луйварчингууд. Олон түмэн минь эд засаг төртэй чинь тэмцэлдүүлэн амийг чинь сүйтгэх гэж байна. Аль вэ чи тийм сүрхий хувилгаан юм бол зүүж байгаа буюгаа надад аль. Би буудъя. Тэгээд чи үхэхгүй юм бол бид үнэмшье. Чиний хэлсэн бүхнийг дагая.

- Олон түмэн шавь нар аа. Үвнийг барь гэж Цамба дэргэдээ зогсож байгаа хэдэн лам нарт дохио өгөв. Тав зургаан лам Төмөр рүү дайран ирэхэд заримыг нь өшиглөн заримыг нь цохиж унагаав. Гэтэл араас нь хүнд юмаар мөр рүү нь хүчтэй цохив. Эргэж харвал Жамбал том муна газар шидээд зугтав. Хүмүүстэй зодолдож байгааг нь далимдуулан том мунаар Төмөрийн толгойг хага цохъё гэсэн нь алдаж мөрөн дээр нь буужээ.

Төмөр ухасхийн Жамбалыг барьж аваад толгой дээрээ өргөж <Чи үхдэггүй мөнхийн хутаг олсон хүн билүү? Чамайг ардын засаг хүн гэж байхад чи ингэж яваа гэнээ> гээд үлэмж их хүчээр чулуун шалан дээр хаясанд <хэг> гэсэн битүү дуу гараад хамар амнаас нь цус оргилон эгшин зуур амь нь гарлаа.

Цамба хичнээн хашгиравч Төмөрт халдах хүнгүй болжээ.

- Олон түмэн нүдээ нээцгээ. Төрд тэрсэлсэн энэ зандалчин нарыг барьцгаа гэтэл нэг том биетэй лам үсрэн ирж ноцов.

Дуганд орсон Түгжил арай чамай сэлээдий буюгаа авч гэгээвчээр Төмөр руу шагайхад гар нь чичирч, зүрх нь цохилон гохоо дарж чадахгүй байлаа. Гэвч Төмөрийг залуу ламтай ноцолдож байх зуур жаахан сэхээ орж буудвал барилцсан хоёрыг давхраар онов.

Түгжил ингэж өөрийгөө хоёр удаа алаагүй өршөөсөн Төмөрийн ачийг бачаар хариулжээ. Эхлээд оногдсон залуу ламын гар сулран Төмөрийн дээрээс салж унахад Төмөр босоогоороо үлдэв. Гэвч амьсгалах бүрийд өргөн цээжнээс нь хөөсөрсөн цус бургилан гарч байлаа.

- Та нар энэ зальтай дээрэмчдийг барьж засагтаа тушаах гэтэл Түгжилийн дахин буудсан сум хоёр далны хооронд тусав. Төмөр бүх биеэр алгуур эргэж харснаа хоёр хөлөө чирч урагш бөхийн алхав.

Түгжил сандран хэд хэд буудаад эргэж зугтав. Тэр сумууд Төмөрийг оносонгүй. Харин ард нь байсан хүмүүсийн заримыг алж, заримыг шархдуулав.

Төмөрийн гар гэгээвчний сараалжин модноос атган авч хүчлэн угзрахад хэсэг нь хугаран салсан учир гэдрэгээ пад хийтэл үлэмж чанга унаад дахин боссонгүй.

Энэ бүхнийг харсан хүмүүс вймэлдэж, зарим нь эндээс зугтан алга болов.

Цогчин дуганы довжоог ухаа ягаан цусаараа будаад хөдлөлгүй хэвтэж байгаа Төмөрт удтал хэн ч ойртож чадсангүй. Түгжил дуганы арын хаалгаар гарч байн байн эргэж харж гүйсээр тусгай бэлтгэсэн гэрт ороход тэнд байсан лам нар <Энэ золиг чинь галзуурчихав уу> гэж бодон зайлж байв.

Тэр орой их гал түлж Төмөрийн шарилыг шатаах гэтэл алга болжээ. Харин Төмөрийг буудсан суманд алагдагсдыг шатаагаад <Олон түмэн шавь нар аа? Эд бол шамбалын дайнд оролцох хувь зохиолгүй нүгэлтэн байсан болохоор ингэж үхсэн байна> гэж Цамба хэлжээ.

XV

Бат аймгаас эмч авчран, өвчтэй хүүхдээ эмчлүүлснээр удалгүй өвчин дарагдаж хүүхдүүд эдгэрэв. Ингээд нэг өглөө эмчээ аймагт хүргэж өгөх болоод өртөөнөөс морьд авчрав.

- Таныг Жаргал хүргэж өгнө. Энэ алс нутагт ирж биднийг аюултай өвчнөөс аварсан ачийг чинь хэзээ ч мартаггүй. Миний нас барсан орос ах <Монгол Зөвлөлт хоёр ах дүү. Гар гараасаа барилцаад явсан цагт алзахгүй> гэж үргэлж хэлдэгсэн.

- Тэр бол миний ч ах байсан юм. Петр комиссар гэдэг юм. Та таних уу? гэж Жаргал асуув.

- Танихгүй байх аа. Намайг тусал гэж ард түмэн минь явуулсан болохоор би үүргээ гүйцэтгэж яваа хүн шүү дээ.

- За баяртай.

- Харошо. По ко-ням! гэж Жаргал уянгалуулан хэлээд эмчид морины цулбуурыг өгөв. Эмч Жаргал хоёр мордох гэж байтал морьтой хүн хүрээний зүгээс сандран давхиж ирээд лам нар ардын засгийг эсэргүүцэн зэвсэг барьж боссон тухай мэдэгдэв.

- За та хоёр бушуухан мордож яв. Шагдар чи түргэн явж сумын даргад хэл.

- Би явахгүй.

- Лам нар олон. Аюултай. Та бол гадаадын хүн. Бушуу яв.

- Монгол Зөвлөлт хоёр ах дүү. Гар гараасаа барилцаж явсан цагт алзахгүй шүү дээ гээд эмч Батын дэргэд ирж

- Би явахгүй гэлээ.

Эмчийг явуулах гэж Бат чармайн оролдсон боловч чадсангүй. Лам нарын бослогын сургаар сумын зарим хүмүүс зайлан алга болов. Хоршооны манаач арав гаруй сумтай бярдан буугаа хаяад алга болсныг эмчид өгөв.

Сумын дарга толгойтой долоон хүн буу сум зэхэж төвөө хамгаалахаар бэлтгэв. Орой сургууль руу зэвсэгтэй лам нар дайрахад буудалцав. Бат эмч хоёр маш мэргэн буудаж бараг л сум тоолж байлаа.

Сумын дарга, хоршооны нягтлан бодогч бараг л эхний бууны дуугаар алагдаж, намын үүрийн дарга хүнд шархдахад эмч үүрэн гэр рүү хөдлөх гэтэл шархдав. Бат мөлхсөөр дэргэд нь очиход үхлүүт шархадсан эмч муу амьсгаатай байв. Бат тэврэн авч <эмч ээ!> гэж хашгирав.

Эмчийн нүд гөлрөн огцмоор амьсгаадан байснаа <би ч өнгөрөв бололтой. Ленинград, Невскийн гудамжинд ижий минь буй...захиа> гээд дуу тасран ам нь хэд дахин ангалзсанаа бие нь сулраад явчихлаа.

- Эмч ээ! эмч ээ! гэж хичнээн хашгиран, сэгсрэвч дахин хариу дуу гарсангүй.

Удсан ч үгүй намын үүрийн дарга ч шархаа даалгүй нас барж, эвлэлийн үүрийн дарга Шагдар гарын булчингаараа шархдав.

Ингээд сумаа дуусан аргагүй болж хүчинд түрэгдсэн гурван хүн харанхуйг ашиглан явган нүцгэн зугтаж дөрөвдэх шөнийн үүр цайхын үед хэсэг модонд оров.

Тэд сумгүй болсон хоёр бярдан буугаа ээлжлэн үүрч явахад түүнээс хүнд юм энэ орчлонд үгүй ажээ. Ийм үед сумтай буу бол хөнгөн байхсан. Сумтай буу бол амь, амьдрал, харин сумгүй буу бол хүчгүй, хүнд ачаа. Гэвч хаясангүй.

Учир нь нэгдүгээрт хоосон буунаас хорин хүн айна гэж үг байдаг. Хоёрдугаарт сум олдвол энэ хүнд төмөр сэргэж амь орно. Гуравдугаарт хоосон ч гэсэн зэвсгээ хаявал бүрэн ялагдсаны шинж билээ. Гэтэл энэ гурван хүн ялагдсан гэж огт бодсонгүй. Харин тэмцлээ эхлэж байна гэж бодож явлаа. Энэ бодол ч тэдэнд хүч чадал, ухаан санаа өгч байлаа.

Өлссөн гэдэс нь заримдаа мушгирч, заримдаа хоржигнох бөгөөд хэзээ нэгэн цагт идсэн сайхан хоолны тухай бодол алсад харагдах их талын зэрэглээ лугаа адил ажээ. Удалгүй модны оройд өглөөний шар нар тусаж зөөлөн ногоон туяа бүхнийг гийгүүлэв.

<Яагаад ч болсон аймгийн төв орох хэрэгтэй> гэсэн санаа гурван хүний хөлийг аажим боловч зөрүүлэн урагш ахиулна.

Шагдарын шархадсан гар нь янгиан өвдөвч шүд зуун нөхөддөө шаналж байгаа зовлонгоо мэдэгдэхгүйг хичээнэ.

- Гар чинь яаж байна гэж хоёр нөхөр нь заримдаа шивэгнэн асуухад Шагдар шүдний завсраар <зүгээр> гэж хий үлээн хариулна.

Гэвч энэ <зүгээр> гэдэг үгний цаана хатуу тэвчээр нуугдаж байгааг нөхөд нь сайн ойлгож сэтгэлээ хамт шаналгана. Морин жим нарийсан бүдгэрсээр уулын оройд гарлаа.

Тэр замын адагт хэдэн гэр байна гэж түрүүлж явсан Жаргал хэлээд зогсон магнайн хөлсөө ханцуйгаараа арчив. Бат, Шагдарын эрүүл гараас сугадан тусалж мацсаар Жаргалын дэргэд ирж амьсгаадан зогссоноо <Тамир, Тунгалаг Тамир> гээд доод уруулаа хэлээрээ чийглэв.

Тэртээ өмнө зүгт манаран харагдах хөх уулын наад талаар махирлан урсаж байгаа Тамир голын мандал нь нарны гэрэлд цайран харагдана.

- Аймаг хүртэл өртөө гаруй үлдээд байна уу? гэж Шагдар асуугаад дэргэдээ байсан том чулуун дээр сандайлан суув.

- Тийм л байх даа гээд Бат бүдүүн хар модыг түшив.

- Уг нь юмгүй үлдэж байна санж дээ гээд Жаргал өвөр түрийгээ хий тэмтэрснээ санаа алдав. Хатуу тамхи хэдхэн сорохсон гэдэг бодол Жаргалын сэтгэлийг маажихад хоолой нь хатаж, толгой нь үл мэдэг өвдөх шиг санагдана.

- Гайгвй дээ. Аймаг дээр очиж зэвсэгжиж аваад эргэсэн цагт уу. Энэ муусайн эсэргүү нарт ардын засгийн хүчийг амтлуулна даа гэж Шагдар хэлээд ухасхийн босох гэснээ гараа хөндөж нүүр нь галд хийсэн шар тосны гүзээ шиг хуниралдав.

Тариатын хүрээг би энэ гараараа үнсэн товрог болгоно доо гээд Жаргал зангидсан гараараа зангахад чичирч байв.

- Хүрээ ямар гэмтэй юм бэ?

- Үүр нь шүү дээ

- Үүрийг нь устгахад чоно үхдэггүй гээд Бат Жаргалыг харав.

Аймаг дээр очно гэдэг бол аврагдахын нэр. Шинэ хүч олж задарсан эсэргүү нартай тэмцэж ялахын нэр билээ. Гэвч аймаг дээр очиход та нар сургууль, хоршоо зэргийг орхин амь зулбан зугтаж ирсэн гэж ял тулгаж магад. Энэ засаг төрд тэрсэлсэн вймээн гарах сэжгийг мэдээд мэдэгдсэний хариуд ард түмнийг итгэдэггүй, цуурхал дэгдээгч гэдэг нэр авч зэмлэл хүлээснийг бодоход ямар ч үг дуулж болох мэт. Гэхдээ зарим нэгэн хүнтэй адилхан эсэргүү нартай нийлээгүй болохоор тэдэнтэй зэвсэг барин тэмцсэн, хэрэв сумтай байсан бол зогсолтгүй буудалцах нь үнэн болохоор Батын сэтгэлд хөнгөн байлаа. Дохио өгөөд байхад юу ч хийгээгүй цаг алдсан гэмтэй хүмүүстэй ярих хэрэгтэй. Гэвч одоо түвнийг хөөцөлдөх цаг биш. Юуны өмнө зэвсэг барьж ардын төрд тэрсэлсэн дайсныг дарах нь чухал. Түвний дараа хэн нь юун дээр алдсан, хожсоныг ярих хэрэгтэй гэж Бат бодно.

Пулемёт, их буу, нисэх онгоц авчирч энэ балмад хулгай нарыг тэдний хүрээ хийд, ялангуяа Тариатын хүрээг газрын хөрснөөс арчвал зохино. Тэр ч байтугай энэ хэрэгт орсон бүхнийг ялангуяа зайлж алга болсон хамтралын орлогч даргыг буудан алах бага байна цавчиж албал таарна. За яахав. Хэдэн өдрийн дараа Жаргал багш пулемёт барьж ирээд та нарт сайхан хичээл зааж өгнө. Уулзах цаг бий гэж Жаргал сэтгэлдээ ярина.

Ай даа. Энэ муу гар юу болох юм бол доо. Нэг хурдан буу, мянган сумтай бол та нарыг уу даа. Тэр гэр хутгалдаг ламыг алж орхисон бол ийм юм болохгүй ч байсан байж магад юм. Бат ч түвн дээр муухай алдсан даа. Харин шашин бурхныг бүдүүлгээр доромжилсноос учир мэдэхгүй олон хүнийг бид дайсны талд өгсөн гэж Батын хэлдэг ч голтой байх шүү гэж Шагдар бодно.

- За алхаад байдаг хэрэг ээ гээд Бат түрүүлэн хөдлөх гэтэл хажуугийн модон дотроос <Зогс, Гараа өргө> гэж хэдэн хүн огцом бөгөөд гэнэт хашгирав.

- Гурван нөхөд цочин ухасхийснээ замгийн тачигнах дуугаар зогсож эргэж харлаа.
- Буугаа хая. Гараа өргө. Хөдөлбөл буудна шvv гэж зvvн хажуугийн модон дотроос нэг хvн хашгирахад Бат харвал ногоон цамц, өмдтэй хэдэн цэргvvд буу шагайн хэвтэж байлаа.
- Бид эсэргvv нар бишээ гээд Бат мөрөндөө байсан буугаа авч тавиад алгуураар гараа өргөхөд нөхдийн нь гар холбоотой юм шиг дээш болов.
- Модон дотроос буутай арваад цэрэг гарч ирлээ.
- Манайхан гэж Шагдар сөөнгө хоолойгоор хяхтнуулан хэлэхэд нvднээс нь том том нулимс дуслав.

Ингэж гурван нөхөд ардын цэргийн нэгэн салаатай уулзаж юуны өмнө Шагдарын шархыг боолгож дараа нь хоол идэж гол ороод бvх явдлыг ярьж өглөө.

- Та нар болбол цэргийн эрдэм мэдэхгvй учраас дайсанд ялагдсан байна. Хэдий тийм боловч та нөхөд улс хувьсгалын төлөө бярдан буу барин байлдсанаар барахгvй хэдэн нөхөд чинь улаан цусаа асгаруулсан гавьяаг бид сайшаан vзэж газарчнаар авна. Ангийн дайсантай ган зоригтой тэмцэх тангараг өргөх хэрэгтэй гэж салааны дарга залуу эр ойворгон огцом дуугаар хэлэв.

<Онгиргон хvн байна даа> гэж Бат бодсон боловч тvvний зааснаар сөхрөн сууж тангараг өргөв.

- Бидэнд зэвсэг хэрэгтэй . Эсэргvv нарыг уу. Эхнэр хvvхэдтэй нь vнсэн товрог болгоно доо гэж Жаргал нvдээ гялалзуулан хэлэв.

- Тэр буруу. Эсэргvv нарын хvчинд авагдан дагаж яваа ядуу буурай хvmvvc буй. Тvvнийг буудаж болохгvй. Энэ дайн бол ангийн дайн юм. Бид ухуулан сэнхрvvлэх аргаар ард тvмнийг эсэргvv нараас салгаж чадах хэрэгтэй. Үvний тул дарга миний тушаалгvйгээр буудсан хvнийг цэргийн цаазаар аваачна. Ойлгов уу.

- Ойлголоо гэж Шагдар өчив..

Тэр гуравт морь зуун сумтай гурван винтов өгч явсаар хэд хэдэн хот айлтай тохиолдсон авч эзэд нь vгvй ажээ. Зарим айлын хурга нь хашаатай хэвээр заримы нь бүрсэн тараг нь хучаастай хэвээр байлаа.

Хоёр дахь өдрийн нар шингэх хирд нэгэн жижигхэн толгойн хажууд бууж харуул манаагаа тавин хонох болов. Тэнгэрт нэг ч vлгvй, сэрvvн бөгөөд ариухан салхи vлээнэ. Хоёр ангир өмнө зvгийг барин шууд дэвсээр харагдахгvй болов.

Нялх ногоонд тавьсан морьдын тургих чимээ, цэргvvдийн дvнгэр дvнгэр ярилцахтай холилдон vргэлжилсэн битvv шуугиан гарч байлаа. Шөнийн харанхуй эхэлж, одод сvvмэн гэрлээр татвалзан анивчиж гялалзах нь хорвоогийн амьтдын хvсэл бодлыг таах гэж цавчлан бодож байгаа мэт харагдана.

Дорно зvгээс шинэ өдөр тvмэн уулсыг даван айлчилж ирэх болсон вед салааны дарга Батыг таван цэргийн хамт хайгуулаар явуулав.

Хайгуул баруун хойт зvгийг барин явсаар vvpийн гэгээний эхний цайвар туяа зvvн уулсын орой дээгvvр өнгийн цацрах вед давааны орой дээр гарвал тэртээ доор аманд хvн малын vлэмж чимээ сонсогдож байлаа. Нэгдvгээрт холын бараа харагдахгvй. Хоёрдугаарт давааны арын мод бvхнийг далдалж байгаа болохоор хайгуулын гурав нь vлдэж, Бат нэг цэргийн хамт алгуурхан бөгөөд хянамгай уруудав. Модны зах хаяа хүрэхэд холын бараа харагдаж эхлэв. Хоёр гурван саахалт зайтай газарт хэдэн зуун морьтой хvmvvc замбараагvй цувралдсаар даваа өөд ирж явлаа. Хvmvvcийн магнайд яваа өндөр хар морьтой хvн гурван бvчтэй том шар туг дөрөөвчлөн барьж хоёр талд нь ижил улаан зээрд морьтой дөрвөн хvн сэлэм огшин хос хосоор зэрэгцэн явлаа.

- Дайсан гэж Бат шивэгнэв.

- Тугчийг нь унагааж орхиё гээд цэрэг винтовоо мөрөвчлөн шагайсанаа нүд бүртэлзээд овоо хараа нийлэхгүй байна гээд Бат руу харлаа.

- Ачийг нь бачаар гэгч болж ардын засгийг буу барьж эсэргүүцнэ гэнээ гээд Бат винтовоо шагаймагц гохоо мултлав. Гол шар туг налан гэдрэгээ унаж, тугч нь мориныхоо буруу тал руу алгуурхнаар гулгав.

- За нисээд байдаг хэрэг гээд цэрэг эргэж мориндоо ташуур өгөхөд Бат ч мориныхоо дэлэнд хацраа нийлүүлэн хурдлав.

Батын морь хурдан ажээ. Өмнөө явсан цэргийг гүйцэж түрүүлэх үед ард нь морьдын туурай сонсогдоход эргэж харвал арваад хүн цувралдан яваагийн өмнө бор морьтой, хөх дээлтэй хүн хуй салхи шиг хурдлан явлаа.

Энэ бол Хонгор байжээ. Гэвч зугтаж яваа Бат ч, нэхэж яваа Хонгор ч хэн хэнээ таньсангүй.

Батаас хорь гаруй метр хоцорсон цэрэг эргэж харах гэтэл Хонгорын урт бугуйл хэзүү ороож мориноос нь гуд татан унагаав.

Даваан дээр хүлээж байсан хайгуулчид буудаж эхлэхэд эсэргүү нар мод руу таран орж алга болов. Бугуйлдуулсан цэрэг чирэгдэж явахдаа толгойгоороо бүдүүн мод савсан учир доороо үхжээ.

Энэ хооронд хайгуулчид шаламгайлан довтолж ангидаа хүрээд учир явдлыг хэлжээ. Хэдэн зуун морьтой хүн ирж яваа болохоор ардын цэргийн салаа хоёр толгойг эзлэн хориглолтод бэлтгэв. Бат баруун талын толгой дээр байр эзэлж авлаа. Бугуйлдуулсан цэргийн зэвсгийг Түгжил жанжны зарлигаар Хонгорт шагнаж, Хонгор дал гаруй сумтай винтов буутай болжээ.

Үд өнгөрөхийн үед эсэргүү нарын зуу гаруй морьтой хүн ардын цэргийн эзэлсэн байр өөд халз довтолсон боловч хоёр толгой дээр байрлуулсан хөнгөн пулемётын шөргөн галд дайрагдаж нилээд хүн, морьдоо алуулаад буцаж байр эзлэн хааяа хааяа энд тэндээс буудаж эхлэв.

Удаан буудалцах сумгүй учраас Түгжил бууны ам долоосон хүмүүсээр халхавч хийж байгаад довтолхыг оролдсон боловч бас л амжилт олсонгүй.

- Мориндоо ташуур өгч, улааны буруу номтонг дайраад гэж Цамба хичнээн бахиравч хоёр пулемётын эсрэг дайрах хүн гарсангүй.

- Жанжин та над шилдэг морьтой зуун хүн өгвөл би улааныхныг бүгдийг нь хүлээд ирье гэж Түгжилийн дэргэд ирсэн Хонгор хэлэв.

- Бачимдан хашгирч байсан Түгжил ширүүн нүдээр Хонгорыг харснаа <Дуртай хүмүүсээ аваад яв> гэлээ.

- Бид нар тэр уулын оройд гараад улааныхны баруун гараас дайрна. Та нар тэр үед зогсолтгүй буудаж байгаад биднийг баруун талын толгой дээр гармагц мөн дайрна шүү гэж Хонгор хэлэв.

- Энэ хэргийг гүйцэтгэсний дараа залуу баатар чамайг туслах жанжин болгоно гэж Түгжил ярвайн инээмсэглэх дүрс үзүүлэн хэлэв.

- Залуу баатрын амь насыг би даана гэж нэг хүн хэлэхэд нь харвал Цамба байлаа.

Хонгор тоомжиргүй хүйтэн инээмсэглэв. Түүний сэтгэлд Заяын хүрээн дээр байсан нь, Цамбад доромжлуулсан нь бодогдов. <Хүний амийг даана гэнээ. Өөрийнхөө нохой амийг аргалж явбал дээр бишүү> гэж Хонгор дотроо боджээ.

Хонгор зуун шилдэг морьтой хүмүүсийг сонгож аваад ардын цэрэгт үзэгдэлгүй явж, түүний баруун гарт байр эзлэв. Оройн нар баруун уулын оройд наалдаж алтан шар гэрлээр юм бүхний баруун талыг гийгүүлэв.



Энэ вед Хонгор зуун хvнээ мордуулж явсаар ардын цэргийн баруун гарт очиж оройн нар дагаж ойртон гэнэт довтлов. Наранд гялбасан цэргvвд чухам юу дайрч байгааг ойлгож ядаж байтал захын хvний толгой дээр Хонгорын хvнд бороохой буужээ . Мөн энэ вед эсэргvв нарын гол хvч дайрав . Хэсэг зуур ширvвн тулалдаан vргэлжлэв. Цэргvвд vхэлдэн байлдсан боловч эзэлсэн байранд нь хэдэн зуун морьтой хvмvвс орж ирээд баруун зvвнгvй цохилцох тул ихэнх нь алагдаж ухаантай ухаангvй арваад хvн баригдав. Бат хоёрыг тоолон буудаж алаад гуравдахаа буудах гэж байтал хажуунаас нь дайрсан хvнд цохиулан ухаан алджээ . Шархадсан хvмvвсийн шаналах дуу чих зvсэн зvрх шимшрvвлж, шархадсан морьдын тэлчлэх нь нvд рvв харваж харахын аргагvй ажээ.

Эсэргvв нар их ялалтын баяр хийж Хонгорыг дэд жанжин өргөмжилж <Хатан зоригт бvргэд баатар> цолоор шагнав. Дайны талбараас нилээд зайтай газар байгаа хивс дэвссэн юм шиг ногоон зvлгэн дээр буудаллаж Тvгжил жанжны улаан халзтай гэр, Цамба дvвчингийн шар халзтай гэрийг зэрэгцvвлэн бариад ард нь <Хатан зоригт, бvргэд баатар>-т тусгай гэр барьж өгөв.

Тэр орой ухаангvй баригдсан салааны дарга ухаан орж тvвнийг эрvвдэн шvвж эхлэв.

- Цэцэрлэг мандалын аймаг дээр улааны хичнээн цэрэг ирээд байгаа вэ? гэж Тvгжил асуухад салааны дарга

- Дээрэмчин та нарыг vнсэн товрог болгож чадах цэрэг ирээд байгаа гэж хариулжээ.

Зодож элдвээр эрvвдсэн боловч нам биетэй, залуухан бор дарга vг дуугарсангvй ажээ.

Yвнийг харсан Хонгорын сэтгэл гайхан бишрэх бахдалаар дvврч байлаа.

Эцэст нь тэр залууг янгинатал хvлж байгаад өрийг нь цоолж зvрхийг нь сугалан туг руу шидэв. <Ижий минь> гэсэн битvв дуу залуугийн цээжнээс гарахад Хонгор чихээ даран нvдээ аньжээ.

Шөнө нь Тvгжилийн улаан халзтай гэрт архидав. Нилээд согтож байтал арван долоо найман насны гурван бvсгvй оруулж ирлээ. Хонгорын согтож гөлөрсөн нvд чичрэн зогсож байгаа гурван залуу бvсгvй дээр тусав.

- За аль нь дээр байна? гэж сvрхий согтсон Цамба асууснаа гуйван босож очоод захын бvсгvйн эрvвг татаж хараад,

- Дарь эх баймаар хонгор байна гээд Тvгжил рvв харлаа

- Ногоон дарь эх баймаар гэж өргөмжилье гээд Тvгжил мөнгөн аягатай архиийг цvл цvл залгиснаа,

- Эрхэм дарь эхчvвд бидэнтэй сууж хундага хуваалцахыг хичээнгvйлэн гуйя гэлээ.

Бvсгvйчvвд хөдлөлгvй чичрэн, торонд орсон шувуу шиг бvртэлзэнэ.

- Тэр дундах миний дэргэд ирж суу. Ихэрхээд байвал ах чинь дарь эх нэрийг чинь хусаж хаяад шулам болгон бор зvрхээр чинь туг тахиж орхино шvв гэж Тvгжил зандран хэлээд гуйван босоод эмэгтэйн гараас барьж авлаа.

Энэ бvхнийг харсан Хонгорын сэтгэлд хоёр хvчтэй бодол тулалдаж байлаа. Нэг сэтгэл нь Тvгжил Цамба нарыг жигшинэ.

Гэтэл нөгөө сэтгэл нь архинд оволзсон залуугийн тачаалд хөтлөгдөн эр хvний жаргал гэдэг бодолд хvрч байлаа. Эцсийн эцэст хоёр дахь бодол нь давж Цамбаас өрсөн Тvгжилийн ногоон дарь эх гэж нэрлэсэн бvсгvйн гараас хөтлөөд гарч гэр рvвгээ орлоо.

Маргааш нь эсэргvв нар хөдөлсөнгvй. Учир нь гурван бvсгvйтэй самуурч хоносон Тvгжил, Цамба, Хонгор гурав vд өнгөрч байхад арайхийн нэг юм өөдлөв.

Yд өнгөрсөн хойно Цамба босож баригдагсдыг байцааж эхлэв. Байцаалт маш тvргэн явлаа. Учир нь Цамба хэдэн vг асуухад л хариулсан ч хариулаагvй ч <Далд оруул> гэхэд чирч

аваачаад шууд буудаж орхино. Батыг оруулав.

- Цэрэг үү?

- Үгвй багш.

- Нөгөө Тариатын задарсан багш чинь энэ шүү дээ гэж Цамбын хажууд байсан нэг лам хэлэв.

- Тийм бол шөрмөслөж ал.

Цамбыг Бат танив. Тийм ээ. Энэ бол богдоос алтан маниад авч байгаад анги Эрэнчинг цохиж алсан хоёр хvний нэг нь мөн ажээ.

- Чи алахаас өөр юм мэдэх үү? Богдоос алтан маниадын хөлс авч байгаад гандангийн анги Эрэнчинг чи алсан биз дээ. Хар яргачин.

- Үvнийг түргэн гаргаж зүрхээр нь туг тахь.

Хоёр хvн хvлээтэй Батыг чирч гэрүүдийн өмнө босгосон тугуудын дэргэд аваачив.

Арай гэж босоод гэрийн өмнө зогсож байсан Хонгор цус нөж болсон хvн бол Бат гэдгийг танилаа.

- Наадах хvнээ тавь гэж хашгираад Батын дэргэд всрэн очив.

- Хатан зоригт бүргэд баатар минь. Энэ бол Тариатын хүрээн дээр байсан улаантны чононуудын хамгийн сүрхий нь. Одоо бид Цамбын зарлигаар туг тахих гэж байгаа юм гэж Батыг авч явсан хvний нэг нь хэлэв.

- Миний гэрт оруул. Би хувилгаантай өөрөө ярина.

- Туслах жанжны зарлигийг хичээнгvйлэн биелvвлье.

Хонгор хоёр хvнийг явуулаад эзгvй гэрт Баттай vлдэв.

- Чамд өөр юм олдсонгvй юу гэж Бат жигшиж занасан хvнд хоолойгоор асуув.

- Өөр яахав.

- Очиж очиж энэ дээрэмчин нартай нийллээ гэж үү? Даанч дээ.

- Над ондоо зам байгаагvй. Сайхан сэтгэлээр ардын цэрэгт орох гээд очиход минь яасан билээ? Чи мартаагvй биз.

- Энэ чинь төрд тэрсэлсэн зандалчингууд шүү дээ.

- Мэдэж байна. Гэвч намайг хvн гэж vзээд хэрэглэж байна. Би од нарыг вссэглээд хамт явна гэж чи бодож байна уу? Үгвй. Болдогсон бол бүгдий нь зүрхийг суга татаж аваад зэрлэг ноходод хаяад өгмөөр байна. Гэвч би тэгж чадахгvй. Батцэнгэл сумын Хонгор хулгайчийг хаа явсан газар нь барь гэсэн зарыг эд тараагаагvй, танайхан тараасан биз дээ. Одоо танай засаг намайг баривал их өршөөвөл арван жил өгнө. Хэрэв тэр өдөр намайг итгэж цэрэгтээ авсан бол би өнөөдөр Тvгжил, Цамбын толгойг авч өгье гээд гvйж байх байсан биш үү? гэж хэлэхэд Хонгорын нvд нь сүртэйеэ гялалзан амьсгаа нь дээр гарч байлаа.

- Яргачин минь намайг ал. Чи эдэнтэй нийлсэн хойно хол явахгvй гэж Бат хэлэв.

- Угаасаа надад хол явах зам байхгvй болсон. Амьдралаас нэг өдөр булааж авбал аз гэж бодож яваа хvн.

- Ингэж явснаас vxсэн ч дээр дээ.

- Үхнэ гэнээ. Хvн бүхэн амьд явахыг хvсдэг байхад надад тийм эрх байхгvй гэж үү?

- Муу явахаар сайн vx гэж байдаг шүү дээ.

- Надад сайн vxэх боломж байхгvй. Харин чамд бол байна гээд Батын дэргэд ирж явган сууснаа

- Чи бол амьдралд нэг зам шилж олоод тvвнийхээ төлөө зvтгэсэн. Тэгээд одоо vxвэл бас л тvвнийхээ төлөө vxнэ. Би бол замгvй ханан улаан хад мөргөсөөр яваа хvн болохоор юуны төлөө vxэх юм бэ? Би чамайг алуулахгvй. Өнөө шөнө оргуулна. Чи бол над шиг гvн худгийн ёроолд хаягдсан мэлхий шиг амьтан биш гээд санаа алдав.

Эсэргүү нарын гарт орсноос хойш зоригтой үхье гэж Батын сэтгэл шийдээд ухаан орсноос нь эхлэн зодож занчин, халуун зүүгээр төөнөж, үснээс нь туг тугаар зулгааж байхад хараал зүхлээс өөр дуу гарахгүй байж билээ. Гэтэл <Чамайг алуулахгүй. Өнөө шөнө оргуулна> гэсэн Хонгорын үгийг сонсоод шулуудаж эхэлсэн зүрх сэтгэл нь амьдралын шуналаар дэвтэгдэн амьсгаалах болов.

- Үнэн бол хамт оргож манайхантай нийлье.

Хонгор гомдолтой бөгөөд гашуун инээмсэглэсэнээ толгойгоо сэгсэрч <Нэг очсон. Одоо дахиж очихгүй> гэлээ.

- Жаргалыг яасан бол?

- Ямар Жаргалыг?

- Надтай хамт багш байсан. Чи мэднэ шүү дээ.

- Мэднэ. Чамтай хамт баригдсан хэрэг үү?

- Тийм. Бид хамт явсан. Чи аварч өгөөч.

Хонгор дуугүй бодол болон баахан сууснаа Батыг эгц ширтэж <Би өнөөдөр Жаргалыг тавихад Жаргал маргааш намайг буудна шүү дээ. Чадвал ална тийм үү?> гэлээ.

- Магадгүй. Гэвч би чамаас гуйж байна.

Хонгор үг дуугаралгүй гэрээс гарлаа. Жаргалд туслах болов уу аль үгүй болов уу гэсэн таавар бодол Батын сэтгэлд эргэлдэн хүлээхийн шаналалд хурамч гэсэн арай ядан өнгөрөх мэт байв.

Хонгор явснаас хойш их удав. Оройн нар унинд авирч байхад морин төвөргөөн ойртсоор гэрийн дэргэд зогсон удалгүй үүд алгуур нээгдэн Хонгор хөмсгөө зангидан орж ирээд <Хар яргачингууд> гэж тас зуусан шүднийхээ завсраар хэлээд маш хүндээр завилан сууж гаансаа гарган тамхи татлаа.

- Юу болов? Жаргалыг алчихаж уу? гэж асуугаад Бат босов. Хонгор хамар амаараа утаа савсуулан дув дуугүй байснаа Батыг хэсэг ширтээд санаа алдав.

Хонгор гарч Жаргалыг баригдагсдын дунд эрсэн боловч олсонгүй. Гэтэл нэг өвгөн <Хүнийг ч хорхой шиг л хядаж байна даа. Түрүүнд энэ хойшоо арваад сайхан залууг хүлээтэй нь туугаад явлаа. Давааны арын модонд л хороочих байх даа. Бурхан минь яасан ч их нүгэл бэ?> гээд залбирав.

Хонгор мордоод тэдний хойноос довтлов. Үнэхээр ч арваад хүнийг давааны арын модонд дүүжилж алахаар хүлж холбоод Түгжил жанжны баруун гар болсон хоёр яргачин туун явжээ. Модонд аваачаад нэг нэгээр нь том модны мөчрөөс дүүжилж эхлэв. Гурвыг алаад Жаргалын ээлж болов.

- Энэ чинь багш гуай байх аа? гэж нэг яргачин сүрхий доогтой асуугаад Жаргалыг бусдаас нь салгаж авлаа.

- Уг нь туг тахих ёстой золиг байгаа юм. Аваачаад уяж орхи. Нэг тамхи татаж аваад бодийг нь хөтөлж орхиё гээд нөгөө нь хожуул дээр тавтайяа сандайлан суув.

Яг энэ үеэр модон дундаас нарийхан өндөр бор морьтой Хонгор гарч ирлээ.

- Хатан зоригт бүргэд баатар ирлээ гэж Жаргалыг чирч явсан яргачин хэлэв.

- Наад улсаа тавь! гэж Хонгор өндөр дуугаар хэлэв.

- Хэн тэгж байна?

- Би тэгж байна. Дэд жанжин хэлж байна.

- Дэд жанжин гэнээ гээд хожуул дээр сууж байсан яргачин хөгжилтэй инээснээ,

- Түгжил жанжны зарлигийг нэг дэд жанжны битгий хэл, мянган дэд жанжин эвдэж чадахгүй хэрэг.

Аргамжаа мөчир дээгүүр хаяж орхи бушуухан татаж орхиё гээд гаансаа түрийлэн босов.

- Бушуухан сулла гэж байна шүү!

- Залуу минь өөрөө талийгаач болох гээгвй юм бол битгий гуаглаад бай гээд яргачин Жаргал руу явлаа.

Хонгорын морь гэнэт ухасхийн, бүдүүн ташуур хэгжүүн яргачны дагзан дээр буув. Саяхан том үг хэлж байсан яргачин гулдайн унав. Нөгөө нь Жаргалыг орхин, модны бүдүүн мөчир барин дайрсан боловч Хонгор чадамгай зайлан мөн л бүдүүн ташуураар нам цохиж унагаав.

Мориноосоо үсрэн бууж ардаа хавчуулаастай явсан хутгаа суга татан авч хүмүүсийн хүлгийг тайлаад <Дуртай зүгтээ явцгаа> гэж хяхарсан дуугаар хашгирав.

- Хонгор! Чиний ачийг мартагвй гэж Жаргал дэргэд нь ирээд хэлэв.

- Олон үг үгвй зайлцгаа. Тэр хоёр морь, бууг аваарай.

- Чи бидэнтэй яв гэж Жаргал хэлэв.

- Бушуухан зайлаад өгөөч! Аль би та нарыг цохилох уу гэж Хонгор байдаг чадлаараа зандрав.

Тэр хүмүүсийг ор сурагвй алга болтол Хонгор суусаар байлаа. Тэгээд огцом хөдөлгөөнөөр мөрдөн ирсэн замаараа хуй салхи мэт алга болов. Хурдаа саалгвй давхисаар Бат дээр ирлээ.

- Жаргалыг яасан бэ? гэж Бат асуугаад Хонгорын мөрнөөс угзрав.

- Дахиад л баригдагвй бол дуртай зүгтээ явсан.

- Үнэн үү!

- Хонгор толгойгоо эргүүлэн Батыг харснаа <Иш чааваас даа> гээд гашуун мишээв.

Жаргалын амьд гарсанд баярласан Бат олон юм асуумаар байсан боловч <Иш чааваас даа> гэсэн Хонгорын үг, түүний арга нь барагдсан нүд дахиад надаас юм битгий асуугаач гэж байсан тул болив.

Нэгэн хэсэг гэрт ямар ч анир чимээгвй байлаа. Хонгор бодол болон баахан сууснаа гарч хоол авчран Батад өгөв.

- Намайг лав тавих уу?

- Чамайг тавина. Харин ч танайхан ч намайг барьж авбал өршөөхгвй. Шууд ална шүү дээ.

Үнэхээр ч Хонгорыг өршөөхгвй шүү дээ. Түүний урьд хийсэн ял үлэмж. Гэтэл одоо улам нэмэгджээ. Урьд Хонгор шилийн хулгайч байсан бол түүн дээр нь засаг төрийг эсэргүүцсэн зэвсэгт бослогын дэд жанжин нэмэгджээ.

- Үнэхээр ч өршөөхгвй байх даа.

Тариатын танхимын багшийг шөрмөслөхийн оронд найрсаг ярилцан, хооллож байгаа дэд жанжны хачин зангийн тухай сонссон Түгжил юу болж байгааг сонирхон үзэхээр Хонгорын гэрт орж ирлээ.

- Дэд жанжин юу болоод энэ гөлгийг дайлж байдаг билээ? Хонгор босож Түгжилийн дэргэд очоод <Үүнийг баярлуулж байгаад өглөө өөрөө зүрхийг нь сугалж туг тахина. Эцгийн минь хөрөнгийг хураасан энэ бэлтрэгтэй ярих юм надад буй> гэж чихэнд нь шивэгнэв.

Түгжил тааламжтай инээмсэглээд эргэх гэхэд нь

- Дэд жанжинд туг байдагвй юм уу? гэж Хонгор зальжингуй асуув.

- Юу гэж?

- Байдаг юм бол өөрөө тахиx гэсэн юм.

- Жижиг шар тугийг өөрийнхөө туг гэж бодоорой гээд гарлаа. Тэр шөнө Хонгор бор морио Батад өгч явуулахдаа <За сайн яваарай. Бодвол чи нөхөд дээрээ очиж зэвсэгжиж аваад бидэнтэй байлдах гэж ирэх байлгвй дээ. Бид хоёрын зам үүрд салж, уулзах газаргвй болов бололтой гээд гарыг нь чанга атгаснаа, баяртай өвгөн минь. За бушуу морд> гэлээ.

- Намайг тавьсныг мэдвэл чамд бөөн гай болно доо.

- Гайгвй байлгвй дээ. Мэдсэн ч яахав. Тавь шахмыг барьж өгсөн хvн, нэгийг тавих эрхтэй байхгвй яахав. Тvргэн яв.

Улааны гайхлыг оргуулж байгаа Хонгорыг харсан хvн Тvгжилд очиж хэлэх гэсэн боловч залуу бvсгvйтэй самуурч байсан Тvгжил оруулсангвй.

Өглөө нь Тvгжил жанжин Хонгорыг дуудахад очвол гэрийн нь хойморь хөх торгон дээл нөмгөн өмсөөд улаан олбог дээр ханхайн сууж байсан Тvгжилийн нvднээс нь гал бутран

- Муу хулгайч чи улааны нохойг яасан бэ? гэж сvртэй хашгирав.

- Алдчихсан.

- Тийм байх аа. Улааны оргодолд хөл залгуулж өгөөд оргуулсныг чинь мэдээгвй юм гэж бодож байна уу? Үвнийг тvргэн барь гэж Тvгжил хоолойгоо хяхруулан зандрав.

Гэрт байсан дөрвөн хvн Хонгор өөд давшин ирлээ. Хонгор гэрийн дунд сөгнөсөн савтай айргаар цацсанаа эгшин зуур эргэж гараад Тvгжил жанжны салхин зээрд морийг унан өмнө зvгийг барьж бөхийн давхилаа.

Тvгжил гvйн гарч ирээд <Муу хулгайчийн толгойг хага бууд> гэж бахирснаа хэдэн хvн буу хөллөн шагайхыг хараад <Муу сайн гуйлгачингууд минь миний морийг битгий буудаарай> гэлээ.

Буу хэдэн зэрэг нvжигнэн дуугарав. Хонгор морины хажуу руу унах шиг болсон боловч удалгвй дахин эмээл дээрээ гараад давхилаа. Бас хэдэн сайн морьтой хvн хөөв. Гэвч Тvгжилийн салхин хээрийг бараадах морь яахин олон байх билээ.

Ганц морьтой хvн овоо ойртож ирэхэд Хонгор явдал дундаа том чулуу шvврэн авч цохиж унагаав.

## XVI

Хонгорын бор морины нуруун дээр гарсан Бат салхитай уралдан Архангай аймгийн төв рvн нисэв. Эсэргvв нарт эрvвдvвлж шархадсан бие нь өвдөвч vхлийн хар торноос гарсан баярыг нь барж хэрхэн чадах билээ.

Бор морь хөлрөх тусмаа хөнгөрч, даваан дээр бууж бие засахад толгойгоороо тоглож газар цавчлан тогтож ядна.

Батын сэтгэлийг зовоох юм гэвэл Хонгорын тухай бодол байлаа. Буруу замаар явсан сайхан сэтгэлт багын найзынхаа тухай бодох тусам тvвнийг хайрлаж хар мананд орсон хувь заяанд нь харамсан гашуудна.

Үвр цайхын вед Тамирын эрэг дээр хvрч морио услаад мордох гэтэл өмнөөс ирсэн өргөн замаар хэдэн морьтой хvн хатируулж яваа харагдлаа. Ажиглавал ардын цэргийн хvмvвс бололтой.

- Юун хvн бэ? Зугтвал буудна шvв гэж тэдний нэг өндөр дуугаар хашгирав. Бат хөдлөлгвй зогсов. Буугаа бэлхэн барьсан хvмvвс дэргэд нь ирж учир явдлыг асуусанд болсон явдлаа ярилаа. Дарга нь бололтой нэг хvн, хоёр цэрэгт Батыг <Ангид хvргэж өг> гэлээ.

Бат хоёр цэргийн хамт явж байтал төдөлгвй цагаан давааны замаар жагсан ирж явсан ардын цэргийн ангитай золгов.

Төөрч төөрч төрөлдөө гэгчээр энэ ангийн дарга нь Хуяг ажээ.

- Бат чи аймаг орж наадах шархаа эмчлvвл гэж Хуяг хэлэв.

- Үгвй. Би эсэргvв нараас нөхдийнхөө өшөөг авна. Яасан ч буцахгвй гэж Бат шийдэмгий хэлэв.

- Эмч ээ. Үвний шархыг боож өг гэж Хуяг тушаав. Тэндээс Бат Хуягийн ангид газарчлан явлаа. Ганц ч vвлгвй цэлмэг хөх тэнгэр манхайж, зун цагийн гоёлоо өмссөн монгол газар

взэсгэлэнгээ гайхуулавч эзэнгүй орхисон гэrvvд, харах хvнгvй бэлчиж яваа мал энэ газар дээр vймээн болж байгааг гэрчилж байлаа.

Цэргvвдийн царай дvнсийн барайж, vг дуу, баяр, баясгалангvй ажээ. Хvн бvхний царайнд багтаж ядсан уур хилэн, vзvвргvй гомдол холилдон харагдана.

Тэр баруун нуруун дээр гараа, цаад талд нь байгаа урт амыг харуулдаад ир. Яг тэр хадны өмнө талаар шvв. Зун цагт айлууд олон байдаг юмсан гэж Хуяг хоёр цэрэгт тушаагаад дэргэдээ явсан Батыг харснаа < чи газар мэдэх хvн байна хамт яваад ир> гэлээ.

Төрж өссөн нутаг нь vймээний хөлд дайрагдаж зуны сайхан цагт цагаан идээ, нэрмэл архины эхvвн vнэр ханхалж байдаг гэrvvдэд сандран зайлсан эздийн хогшил навсайж байгааг хараад Хуягийн сэтгэл гvн уйтгарт дарагдаж явлаа. Алаглан билчиж байдаг сарлагууд хvртэл алга болоод хааяа энд тэнд нэг хоёр харагдахад нь тvвнийг удтал ажиглан харна.

Бат хоёр цэргийн хамт хатируулан баруун хөтлийн зvг явлаа. Батад энэ нутагтай холбоотой явдал амьдралд нь олон тохиолдож билээ. Солонготойгоо хамт ижилхэн хоёр хар морь унаад Төмөрийнд очих гэж явахдаа тэртээ өмнө харагдах уулын наад талаар гарсан замаар явж байсан. Сургуулийн ажлаар энэ орчмын нутгаар хэд явсныг тоолоход бэрх байлаа. Энэ бvхэн Батын сэтгэлд жирэлзэн өнгөрөв.

Явсаар нурууны орой дээр гарч ирлээ. Үнэхээр ч vргэлжилсэн урт ам өмнө нь тодров. Амны дундуур мурилзан урссан нарийхан гол нарны гэрэлд гялалзан тоглоно. Голын хоёр талаар хэд хэдэн хот айл харагдавч гадна нь амьд амьтан vл vзэгдэнэ. Бас айлуудад доод талд арваад сарлагаас өөр мал эс харагдав.

Гурвуулаа мориноос бууж бvхнийг нарийвчлан ажиглав. Гэтэл тэртээ доорхи айлуудын дундуур ганц бараан морьтой хvн хурдлан ирж явлаа

Морьдоо нуугаад буугаа бэлтгэн тvвнийг харуулдан хvлээв. Бараан морьт зогсолтгvй давхисаар эгц өмнөөс ирлээ. Энэ бол эсэргvв нарийн дундаас Тvгжилийн салхин хээрээр зугтан гарсан Хонгор байлаа. Хонгор тэндээс гараад юуны өмнө эхнэр, хvвхэд хоёртойгоо уулзах гэж гэртээ очвол эзэд нь ор сураггvй дvрвэн алга болж хоосон гэр vлджээ. Эсэргvв бослогын сургаар айлууд дvрвэхэд Сvрэн хvвтэйгээ хамт хадам эцгийн дээ очжээ.

Итгэлт Должин хоёр ач хvвгээ vзэн хязгааргvй баярласан бөгөөд Сvрэнг эсэргvв хөдөлгөөний тухай ярихад <Ардын засгийн хэдэн шалдан банди яаж тэлчлэвч дийлэхгvй. Аминаасаа уйдсан мөн ч тэнэг амьтад юм даа. Гол гарч, их зам бараадан буувал ямар ч аюулгvй. Харин хvв минь яаж яваа бол? Тvвнд л зовох юм> гээд санаа алдан их л юм бодсон билээ.

Маргааш нь эрт ачаалж Тамирыг огтлон өмнө нутгийн аюулгvй газар руу нvвжээ.

Хонгор эзгvй гэртээ ороод тамхи татан хэсэг сууж байх зуур хvвгий нь хоёр бойтог нvдэнд нь харагдахад нийлvвлэн чанга базаж элгэндээ тэвэрснээ хөмсгөө зангидан бодолхийлэв.

<Хаачих вэ? Эхнэр хvвхэд. Эцэг эх минь яаж байдаг бол? Бат минь амьд явдаг болов уу?> гэх зэрэг өдий төдий асуудал сэтгэлд нь оровч өгөх хариу байсангvй. Учир нь сvвлийн хэдэн өдрийн дотор энэ хvний сэтгэлд буй болсон хvнд шарх буглан юм гvн бодох чадваргvй болгожээ.

Бойтгоо өвөртлөөд гарлаа. Дахиад л <Хаачих вэ?> гэдэг асуудал гарч ирлээ. Үнэндээ очих газар байсангvй. Байлдаж байгаа хоёр талын алинд ч очих нvвргvй болжээ. Хvсэж очсон хvв эхнэр нь хаа бvгж байгааг мэдэхгvй учраас хаашаа явах билээ.

<Юу ч гэсэн аавтай уулзъя> гэж бодогдоход морио тайлж аваад мордов. Ингэж давхиж

явахдаа Бат ба түүний нөхөдтэй тулгарчээ. Нэг цэрэг босоод «Юун хvн бэ? Зогс буудна шvv» гэж өндөр дуугаар хашгирахад Хонгор мориныхоо амыг татаж эгшин зуур зогссоноо гэнэт эргэж хурдлав.

Хашгирсан цэрэг буудав. Хонгор мориныхоо зөв тал руу алгуурхан налж унжив.

Оночихож шvv гэж нэг цэрэг хэлтэл <Үгvй. Би амьд байна> гэсэн шиг дахин эмээл дээрээ гарлаа.

Хэрэв бор морь нь байсан бол vхсэн болж хажууд нь чирэгдэн явсаар сум хүрэхгvй газар зайлан гарч болох л байсан. Гэтэл Тvгжилийн морь тийм сургуульгvй болохоор эмээл дээрээ тvргэн гарсан билээ. Яг энэ вeд Бат гохоо мултлав.

Уушгиараа нэвт буудуулсан Хонгор бөхөлзөн найгаснаа тvргэн явсан хурдан морины эрчинд шидэгдэн тэртээ хол харуулдан унаад хөдөлсөнгvй.

Бат нөхдийн хамт хөдлөлгvй хэвтэж байгаа хvнийг ажиглан хэсэг болоод нэг цэргийн хамт мордож очлоо. Урт ургасан сахлаг ногоон дээр тvрvv урагшаа харан унасан Хонгорын цус ойр орчмоо хүрэн улаан өнгөөр буджээ. Үвдэн хоймрын зайтай газар хvvхдийн хоёр бойтог хэвтэнэ.

Бат мориноос бууж, хэвтэж байгаа хvнийг эргvүлсэнд <ээ халаг, Хонгор минь> гээд тэврэн авлаа.

- Хонгор минь . Би Бат байна гэж хашгиравч хариу дуу гарсангvй. Гэтэл Хонгорын гал нь буурч, амьдралын сvүлийн тэмдэг нь орхиж байгаа нvд хагас нээгдэж удтал Батыг ширтсэнээ сулхан инээмсэглэл уруулд нь тодрох мэт болоод амьсгаагаа хураав.

Бат нөхрөө элгэндээ тэврэн, нvднээс нь гашуун нулимс ундран гарлаа. Хонгорын цус болсон нvүрэнд зvүдэлж байгаа хvvхдийн инээмсэглэл тодрон хөхөрсөн уруул нь vл мэдэг ангайжээ.

Бөгчим халуун өдрийн нар бүхнийг хайр найргvй төөнөж Хонгорын хацарт наасан Батын хацар өтгөрсөн цусанд наалдана.

Хонгорын бор морь, Батын мөрөн дээгvүр толгойгоо унжуулан амь нь гарсан эзнээ удтал vнэртсэнээ ижил дасал болсон эзнийхээ цогцсыг булах газар малтах гэж байгаа юм шиг цавчлав.

## XVII

Зуны сvүл сарын нэгэн өдөр хоёр Тэрхийн билчээрээс нилээд доогуур, Дархан уулын өмнөөс өндөр зээрд морьтой, хөх даавуу дээлтэй, ногоон дурдан алчууртай эмэгтэй хvн ирээд голын захад буув.

Энэ бол Дулмаа байлаа. Олон хоног уйлснаас нvд нь хавагнан бөлцийж, vргэлж ягааран туяарч явдаг хацар нь олон жил чийгтэй газар хэвтсэн хөсрий булууны яс мэт өнгөтэй болжээ.

Тvрvv урагшаа харж жирэлзэн урсаж байгаа тунгалаг уснаас баахан залгилснаа явган сууж нvүрээ угаагаад дотоод хормойгоороо арчив. Ус ширтэн хэсэг сууснаа урт бөгөөд гvн санаа алдахад хоёр нvднээс нь сувдан хэлхээ цувран уралдаж байгаа юм шиг хацрыг нь даган урсахад ханцуйгаараа арчив.

- Одоо нэг ч дусал нулимс гаргахгvй гэж тод дуугаар хэлсэнээ босож ийш тийш ширтэн газар орныг ажиглаад мордож шууд гол гатлан баруун хойт зvгийг барин явахад хар булигаар богц нь морины аяар урагш хойш холхилон хаялна.

Төмөр нь алагдсан тухай сонсоод хэд дахин ухаан алдаж унахад Өлзий тэргvүтэй айлын хvмvүс нь сэрээжээ. Төмөр минь байхгvй гэж бодоход ертөнц хоосон, пад харанхуй хонгил агуй шиг болж ээ. Энэ өршөөлгvй хорвоог болдогсон бол хvнд лантуу барьж байгаад

бутартал цохимоор санагдана. Төмөртэй хамт Дулмаагийн хвсэл, эрмэлзэл, аз жаргал, цог жавхаа цөм үгвй болж, бүхнийг жигшин занах битүү хорсол сэтгэлийг нь эзлээд хорвоогоос зайлан зугтах бодлыг нь гагцхүү үргэлж нүдэнд нь тусаж байгаа Төмөрийн хүү чөдөрлөж байлаа.

Төмрийн дүрс нүдэнд нь дахин дахин тодорч, Төмөртэй хамт өнгөрүүлсэн зол жаргал нь байн, байн аль сайн сайхан дүрсээрээ харагдана.

Манарсан, түмэн зэрэглээ болсон элдвийн бодлын тэртээ захад <Өшөө авъя> гэдэг бодлын зурвас гэрэл буй болоод цаг өнгөрөх тутам тодорсоор бүх сэтгэлийг нь эзлэв.

Тэгээд хэд хоног элий балай юм шиг байснаа Дулмаа нэг орой хүүгээ Өлзийтэй хамт үлдээж жороо зээрд морио унан явахдаа <Би ирэхгүй бол хүүг минь Батад өгөөрэй> гэжээ.

Өлзий хаашаа юунд явж байгааг нь янз бүрээр асуун шалж хориглоход <Надад их хэрэг байна. Явахгүй байж тун болохгүй > гэхээс өөр хариу сонссонгүй.

Төмөр алагдсаныг дуулаад Өлзий үлэмж их гашуудаж хэдэн өдөр усан нүдтэй явсан юм. Гэхдээ Төмөрийн өшөө авахаар Дулмаа явлаа гэдгийг мэдсэн бол хориглох л байсан. Учир нь Төмөрийг алсан дайсан, Дулмааг алах нь нүд ирмэхийн хэрэг гэж Өлзий мэднэ.

Дулмаа анх гэрээс гарахдаа <Төмөрийнхөө өшөөг авна> гэдэг ганцхан, үргэлж шатан буцалж байгаа бодолтой байснаас биш хэнээс яаж өшөө авах нь долоон уулын цаана, далан жалганы тэртээ байжээ. Гэвч харанхуйд хүний нүд дасаж юм тод болдгийн адил эхэндээ манан байсан бодол эцэстээ ил болдог болохоор сүүлийн хэдэн өдөр Төмөртэй хамт яваад шарын цэргээс оргож ирсэн хүмүүстэй уулзаж хвсэл жаргалын ширгэшгүй булаг болсон хүнээ яаж алагдсан, хэн алсныг сайн мэдэж авчээ. Гэтэл хамгийн хэцүү нь Түгжил, Цамба хоёрыг олох байлаа. Учир нь энэ вед эсэргүү нар цохигдоод энд тэнд уул хадаар бүгсэн цөөн хүмүүс, ардын цэргээс зугтан, ард түмнийг дээрэмдэж байлаа. <Бас тэгээд эрж олоод яах вэ? Тэд бол төрд тэрсэлсэн зэвсэгтэй дээрэмчид. Би олигтой ташуур байхгүй эмэгтэй хүн> гэж Дулмаад бодогдоно.

Гэвч Төмөрийнхөө өшөөг авахгүй байж огт болохгүй гэдэг бодол бүхнээс хвчтэй байсан болохоор юу ч л гэсэн тэднийг эрж олох хэрэгтэй байлаа.

Дулмаа явсаар Тариатын хүрээний байран дээр ирлээ. Шатсан нэлбэгэр хана үнсний дунд энд тэнд эвдэрхий шавар байшингийн хана дорсойн харагдана. Мориноос буугаад тэр бүхнийг ширтэж хэсэг зогсов. Дулмаа баруун зүг харж сөхрөн сууж <Тайшир хан минь. Тарлан хайрхан минь. Цамба, Түгжил хоёртой ертөнцийн нарыг хамт харахгүй> гэж тангараг өргөжээ. <Намайг хориглосон бол миний Төмөр хэрхэвч явахгүй байсан даа> гэж бодоход нүдэнд нь нулимс өөрийн эрхгүй тунарахад нүдээ гөлийн ширтсээр дусаалгүй шингээж орхив.

Оройн нар жаргахын вед тэндээс мордоод удалгүй нэг айлд очиж хонов. Эсэргүү нарын цохигдсон хэсэг бүгж байгаа газрын бүдэг бадаг баримжаа сонсож аваад маргааш нь Тариатын арын хүрээг дайрч, Тойн амыг уруудан Идэрийн голыг гатлан нилээд яваад их замаас зайлан уулын орой, царам барин нэг өдөр явлаа. Шөнө орой болж хадны нөмөрт унтах болов. Тохмоо дэвсэж эмээлээ дэрлэж хэвтсэн боловч нойр нь хулжаад унтсангүй ээ. Шөнө дундын вед хажууд нь нэг чоно ульж эхлээд удалгүй эргэн тойронд нь нарийн бүдүүн хоолойгоор өдий төдий чоно ульж гарлаа.

- Би хоёр хөлтэй чоноос нөхрийнхөө өшөөг авах гэж яваа хүн.

Та нараас айхгүй. Төмөр минь намайг хамгаалаач гэж хашгиран <Эрдэнэ засгийн унага>-ыг баахан дуулав.

Ийм вед айх сэтгэлийг аялах шиг хэцүү юм байхгүй. Шөнийн турш айхын аюултай



тэмцэлдэн, үүрийн туяатай арай ядан золгов.

Өдөр, гэрэл гэдэг хүнд ямар их хүч, итгэл өгдгийг энэ удаа Дулмаа сайн ойлгосон бөгөөд үүрийн цагаан гэгээгээр мордож цааш явахад эзэнтэйгээ хамт нойрмог хоносон морины нь хамар тачигнаж, чихээ солбин соотолзож хулгана. Үд өнгөрөхийн хирд модны чөлөөнд эмээлтэй хээр морь хантраатай зогсож байхыг хараад цочмог хөдөлгөөнөөр морины амыг татаж зогслоо.

<Яахав? Очих уу? Буцах уу?> гэж эргэлзэн бодохын завсраар <хүнээс зугтаад байвал зорьсноо яаж хийх хүн бэ?> гэж ямар нэгэн дуу зэмлэн хэлэх шиг болов.

Дулмаа морио ташуурдан хөдлөв. Хантраатай морины дэргэд хэвтэж байсан хүн чимээгээр цочин өндийж харснаа босож бүдүүн модны цаана ороод сэлээдий буугаа Дулмаа өөд чиглүүллэв. Түүний мөрөн дээрх цагаан даавуугаар шар цэргийн хүн гэдгийг Дулмаа мэдлээ. Гэвч зогссонгуй явсаар ойртон очиж найланхай бөгөөд эрх дуугаар <сайн байна уу?> гээд инээмсэглэв.

Тэр нуугдаж байсан хүн ямар ч зэвсэггүй гуа эмэгтэйг хараад модныхоо араас гарч ирлээ. Энэ бол гуч гаруй насны лам хүн байлаа. Хүрэн дээл дээр хуучин гяраг бүс бүсэлж жижигхэн шовгор даран өмсчээ.

Өмнөөс нь инээмсэглэн харж байгаа бүсгүйг тачаангуйн гал нь оволзсон хоёр онигор нүдээр ширтэн зогсож байгаа ламыг харахад хоол барьсан хүний гарыг ширтэн маасганан далилзаж байгаа эрх хав шиг байлаа.

- Энэ зэлүүд модонд юу гэж явдаг хүвхэн бэ? Бүр цочоочихлоо гээд марсайн инээмсэглэж буугаа бүсэндээ хавчуулав.

- Тан шиг л тэнэж явахгүй юу гээд Дулмаа хөгжилтэй инээмсэглэхэд лам хамрынхаа угийг атируулан:

- Хи хи хэмээн инээж; - Хүвхэн гуай минь буу л даа. Аль би буулгаж өгөх үү? гэлээ.

- За яршиг алдас болно гээд нэг нь нөгөөгөөсөө ялгагдахаас айсан юм шиг ургасан цагаан шүдээ яралзуулан инээмсэглэхэд ламын царай шуналдаа мансууран эрүү нь сулран хэв нь эвдрэв.

Дулмаа мориноосоо тав хийтэл бууж

- Буу цоор болсон ямар ч сүртэй юм бэ гээд тачигнтал инээсээр урт ургасан ногоон дээр суув. Лам хэсэг зогссоноо хүвхний дэргэд очиж морины нь цулбуурыг авч модноос уяад зэрэгцэж завилан суугаад юу ярих, яахаа мэдэхгүй ногооны үзүүр оролдов.

- Та чинь шар цэргийн хүн үү?

- Тийм санаатай. Би ч дарагдаад уул хадаар л нөхөр хийж явна.

- Муудаа дийлэгдэхгүй юу?

- Тийм биш ээ. Улааны гунан буу, мөлхөө тэрэг, төмөр шувуу гэдэг чинь адтай чөтгөр шүглэсэн эд гэж сүртэй хэлснээ гар нь Дулмаагийн нугалан суусан өвдгөнд хүрмэгц чичрэн татваганаад түүндээ бантаж царай нь чинэрэв. Дулмаа ажиггүй сууж байлаа.

<Ямар сайхан амьтан бэ? Би яах билээ. Шууд дараад авдаг хэрэг үү? Аль буу тулгаж сүрдүүлж байгаад...> гэж бодоход ламын зүрх түргэн түргэн цохилж амьсгаа нь тасалдан гарна.

Дулмаа түүний бодол, сэтгэлийн үймрэлийг мэдэх тутам тайван байдалд орж байлаа.

Хүвхний ер бусын тайван байдал ламын биеийг үл мэдэг шижмээр хүлэх ажээ.

Дулмаа суудлаа засах гэж хөдөлтөл лам эрс бөгөөд эв хавгүй цочмог хөдлөн хүзүүгээр нь тэврэн авлаа. Хэрэв Дулмаа хөдлөлгүй суугаад байвал гуа үзэсгэлэн тайван байдалд дарагдсан лам хөдөлж чадахгүй байсан.

- Байз л даа. Ямар хачин лам бэ? гээд Дулмаа хоёр гараараа гэдэс рvv нь хvчтэй тvлхэв. Лам бөгсөөрөө лаг хийтэл суусан боловч тvргэн босож ноцолдох гэтэл хэдий нь боссон Дулмаагийн гарт орсон сэлээдий буугийн цэвдэг ам цээж рvv нь могойн нvд шиг ширтэж байлаа.

Ламын бvх бие нь сулран салганаж гэдрэгээ ухрах зуур

- Наадах чинь сумтай шvv. Алдвал би өнгөрнө гэлээ.

- Бvв хөдөл, буудаж орхино шvv гэж Дулмаа хяхарсан өндөр дуугаар зандрав. Лам яг зогсов. Тvvний хамрын vзvvр, магнайн арьс нь хvртэл чичирч байлаа. Хатанбаатарын цэрэгтэй хамт явж байхдаа энэ бууг Дулмаа олонтой барьж vзсэн. Гэвч буудаж vзээгvй билээ. Гагцхvv гохыг нь дарвал буудаж болдог байх гэж бодож байв.

<Одоо тайван л байвал хамаг хэрэг бvтнэ> гэж бодоод буутай гараа унжуулан

- Цамба, Тvгжил хоёр хаана байна? гэж сvр vзvvлсэн шахмал дуугаар асуув.

- Жа энvvxэн дээр майхантай байгаа. Өчvvxэн би бол тэдний харуул

- Олуулаа юу?

- Гурвуулаа. Надтай бол дөрөв.

- Би тэднийг барихаар яваа хvн. Манай цэрэг энvvxэнд байгаа.

- Мөлхөө тэрэг бас байгаа юу?

- Хэд хэд буй гээд буутай гараа өргөхөд ламын царай vнс шиг хөх болж сөхрөн суугаад:

- Улаан хувьсгалч дагина гуай минь би ардын засагт буруу санасан удаагvй билээ. Хvчинд автагдсан ядуу хуврагийн амийг өршөөн соёрхоно уу? гэж чичрэн бvвтнав.

Бослогын дунд вeэс оролцсон энэ лам Гоогийн тулалдаанд алагдсан жанжныхаа сэлээдий бууг авч морины сайнаар зугтан амьд гарчээ. Тэгээд уул нутагтаа харья гэж бодсон боловч баригдахаас айн уул хадаар тэнvвчлэн яваад оргож яваа Тvгжил, Цамба нартай нийлжээ.

- Намайг дагуулж тэдэн дээр хvргэ. Мэдэв vv. Май энэ муу зэвээ ав. Бас засагтай тэмцэх санаатай гээд Дулмаа сэлээдий бууг лам руу шидэв. Лам нэгэн хэсэг юу ч ойлгосон шинжгvй тэнэг битvv царай гарган Дулмааг ширтэв. Улааныхан айхтар зэвсэгтэйг лам мэднэ. Бас тэгээд энэ хvvxний байж байгааг харахад цэрэг нь их ойрхон байгаа бололтой. Эдний гараас гардаг ч өнгөрлөө. Энэ хvvxний хэлсэн бvхнийг хийвэл амь өршөөж магад болов уу. Аль энэ бууг авах гэх дээр буудаж орхих гэж байна уу? гэх зэрэг бодсон лам байрнаасаа хөдөлж чадсангvй.

- Наадах буугаа аваад намайг дагуулж яв. Тэгэхгvй бол гээд магнай руугаа долоовор хуруугаараа чичсэнээ vвнд чинь vхэр бууны сум зооно шvv. За явъя. Замдаа яахыг би хэлж өгнө.

- Амь л өршөө.

- Олон таван vггvй наадахаа аваад бушуу морд. Чамтай заваарах цаг алга гээд хvvxэн тайвнаар алхаж морио тайлан авлаа.

- Та намайг буу авах дээр буудаж орхих гэж байгаа юм биш биз.

- Чи бушуу авна уу, vгvй юу

- Лам могой барьж байгаа юм шиг чичрэн очиж буугаа авахдаа хаанаас буу дуугарч насны тоо гvйцэх бол гэж чичрэн дагжиж байлаа. Гэтэл хvvxэн аль хэдий нь мордоод хормойгоо ямар ч ажиггvй засав

Дулмаагийн vнэн байдлыг айн сандарсан лам ажиж хэрхэн чадах билээ. Лам буугаа авах вeд Дулмаагийн сэтгэлд юу бодогдож байсныг бичихэд хэцvv. Хэрэв буу өөр рvv нь чиглэсэн бол морио ташуурдан эгц дайръя гэж бодож байжээ. Энэ ч учраас буунд ламын гар хvрэх вeд өндөс хийсэн бөгөөд сvvлд нь тvvнээ баллах гэж хормойгоо засав.

- Түргэл гэж ширүүн зандарсан Дулмаагийн дуу ламыг бүр мөсөн ялж моринд нь мордуулав.
- Зэрэгцэн яв гэж тушаахад лам хажууд нь ирлээ. Түүний бие тогтож ядан бээвэгнэн чичирч завьжаар нь шүлс савирна.
- Намайг модонд дайралдсан. Юу ч хэлж өгөхгүй юм. Тэгээд авчирлаа. Харин замдаа танай шар цэрэгт байгаа нөхрөө эрж явна гэсэн гэж хэлээрэй. Өөр илүү дутуу юм чалчсан байвал уу? гэж Дулмаагийн хэлэхэд лам хялалзан ийш тийш харах зуур <жа> гэж шивэгнээд эмээл дээрээ намс гэлээ.
- Намайг хэн гэдгийг хэлсэн байвал мөч, мөчөөр чинь хяргаж ална шүү. Харин миний хэлсэн бүхнийг хийвэл нохой амийг чинь аваръя.
- Ээ бурхан минь. Юу боллоо гэж тэгэх вэ. Тэр хоёр зэрэгцэн нилээд явлаа. Дулмаа амандаа ямар нэгэн дуу гиншин аялна. Удсан ч үгүй модны цоорхойд байгаа хуучин хөх майхан харагдлаа. Майхны дэргэд эмээлтэй морьд харагдав. Морины чимээгээр майхнаас Түгжил, Цамба хоёр гарч ирлээ. Тэдний гарт сэлээдий буу байхыг хараад Дулмаагийн дотор зарс гэлээ.
- Лам зааж өгсөн үгийг тоть шиг давтан хэлээд мориноосоо буухад Дулмаа ч буужээ.
- Дулмаа. Чи чинь хаанаас гараад ирэв гэж Цамба инээмсэглэн хэлэв.
- За Дулмаа чамайг хэн явуулав? гэж Түгжил ойртон очиж сэжигтэй нүдээр ширтэн асуув.
- Хэн явуулсан баймаар байна? гэж Дулмаа асуудлыг асуудлаар хариулаад ламын тушсан морины хэвднээс морио ажиггүй уяв.
- Улааныхан явуулсан биш биз дээ? Хатуу тоглоом эм хүнд огт хэрэггүй гээд Түгжил гартаа барьсан сэлээдийгээр тоглож, Дулмаагийн байдлыг ажна.
- Дулмаа тачигнатал инээснээ
- Намайг ч улааныхан л тооно доо. Тийм амьтдад дийлэгдээд энд бүгж байдаг. Ямар заяагүй амьтад вэ? Та нар чинь гэлээ.
- Тэгээд чи юу гэж яваа юм бэ?
- Миний нөхөр та нартай хамт явсан. Нөхрөө эрж явна.
- Нөхрөө эрж явна гэнээ. Тэр чинь бидэнтэй хамт байх ёстой юм уу? гээд Цамба ёжтой инээмсэглэв.
- Шарын цэрэгт л явсан юм даа.
- За тийм бол майханд ор. Тавтай ярь гээд Түгжил Дулмаатай ирсэн ламд хандаж
- Чи урьдах өндөр дээр гарч хүн харж байгаад бүрэнхий болохоор ир гэлээ.
- Дулмаа хэлснээр нь яваад ир гэдэг дохио хулгай нүдээр ламд өгөөд шууд майхан руу явлаа. Гараа үл мэдэг хаялан хоёр сүүжин дээрээ ганхан яваа Дулмаагийн хойноос Түгжил, Цамба хоёр тачаангуйн гал дүрэлзсэн нүдээр ширтэв.
- Сар шахам аглаг ууланд бүгж, эмэгтэй хүний бараа хараагүй энэ хоёрт Дулмаа улам ч гуа үзэсгэлэнтэй болсон юм шиг бодогдож байлаа.
- <Ёстой тэнгэрийн дагина л ийм байдаг байх даа?> гэж Цамба дотроо бодож байсан бол <сайхан хүүхэн гэж хошуу дамжин ярилцдаг нь арга ч үгүй юм даа. Тэр гэзгий нь ...суналзаад, нуруу нь> гэж Түгжил бодож байлаа.
- Дулмаа майханд ороод ийш тийш харвал хамба лам байсангүй. Учир нь зугтаж бүгд явахад бөөн дараа болсон хөгшин ламыг Түгжил өдөр ойрхон модонд дагуулж аваачаад цохиж орхисон юм.
- Түгжил хамбыг хөвдөөр булж орхиод ирэхэд <багш яваад өгөв үү?> гэж Цамба асуужээ.
- Ингэж ууланд баавгай шиг байж чадахгүй гэнээ гээд Түгжил ажиггүй хэвтэж байлаа.
- Түгжил их юм бодож байгаа хүн. Цамбыг барьж өгвөл ардын засаг амь өршөөх болов уу? гэж

бодно. Гэвч хийсэн ял нь нэг Цамба байтугай, хэдэн Цамбаар төлөгдөхгүй учраас тэгж чадахгүй байлаа. Цамба ч баригдвал амьд гарахгүй гэдгээ сайн мэднэ. Улааны мөрдлөгөөс зугтахад ганцаараа бол дээр мэт бодогдовч ингэж явахад хоёулаа бол бие биендээ түшигтэй юм шиг санагдана. Ганцаараа бол дээр гэж бодсон үедээ Түгжилийн хоолойг хяргаж орхимоор байдаг билээ. Дулмааг харснаас хойш <Түгжилийг алж орхиод, энэ хүүхнийг авч хил давъя> гэдэг бодол орж ирлээ.

- За та нар нөхөр минь хаана байгааг хэлээд аль? гэж майханд орж ирсэн. Түгжил, Цамба хоёроос Дулмаа шийдэмгий шаардав.

Түгжил ч гэсэн, Цамба ч гэсэн Төмөрийг алсан гэж шууд хэлж чадсангүй.

- Уулзаж болох байлгвй дээ. Өнөөдөр нэгэнт орой болсон болохоор бидэнтэй хоноод яв л даа гэж Цамба хэлэв.

- Ууланд бүгж сурсан хүн болохоор та хоёр шиг ийм амархан ч олдохгүй л дээ гэж Дулмаа санаа алдан үлэмж гомдолтой хэлэв.

Үдшийн бүрэнхий болоход харуулд гарсан лам эргэж ирлээ. Түгжил, Цамба хоёрын зайг харж байгаад Дулмаа <миний дохиогоор л хөдөлнө шүү> гэж ламд хэлжээ.

Дөрвүүлээ майханд хэвтсэн боловч хэн ч унтсангүй.

Бие биеэс Дулмааг харамлан Түгжил, Цамба, хоёр нэг нь нөгөөгөө хөдлөх бүр дэр доорхи буугаа атган авч байлаа.

Дулмаа унтаж байгаа дүр үзүүлэн жигд амьсгаалан хааяа, хааяа хухиравч нүдний булангаар хоёр тийшээ хялалзан байжээ.

Үүр цайхад Дулмаа босож <эмэгтэй хүн байна. Та нарт цай чанаж өгье> гээд гарлаа.

Нойргүй хоносон Түгжил, Цамба хоёр өөрийн эрхгүй унтав. Харин харуул харж байгаа нэрээр өдөр нь нойроо авсан лам Дулмаагийн дохиог ажин хэвтэв.

Гарч орохын хооронд Дулмаа майхны өмнөх олсыг огтолж амжив. Цай буцлахад Дулмаа жалавчин тогоотой халуун цай бариад майхны баганын хооронд зогссоноо ламд түргэн гарах дохио өгөөд түвнийг гарахад <Цэрэг ирлээ> гэж чанга хашгирав.

Түгжил, Цамба хоёр ухасхийн босоход нүүр рүү халуун цай цацаад эргэхдээ майхны өмнөх баганыг аваад гарлаа. Түлэгдээд бас майханд дарагдсан хоёр юу болж байгааг ухаарч чадаагүй сандран оволзож байхад Дулмаа овойсон газар нь бүдүүн баганаар занчиж гарлаа. Цагаан хар нь ялгаран байдаг Дулмаагийн нүдэнд улаан цус хуралдан эргэлдэж, үс нь босон сэгсийж цохих бүрдээ

“ Төмөрийн минь хариу “ гэж сэтгэлдээ үглэж байлаа. Дотроос хоёр удаа буу дуугарсан боловч майхныг цоолохоос өөр ямар ч гэм хийсэнгүй. Толгой руугаа хүнд баганаар хэд хэд цохиулсны дараа Түгжил, Цамба хоёр ухаангүй гулдайн унажээ. Энэ бүхнээс айж ёстой л сүнс зайлсан лам аль ч учраа олохгүй хий бүлтгэнэн зогсоно. Дулмаа баганаа хаяж майхан руу харвал хөдлөх юмгүй болжээ.

- Чи энэ хоёрыг моринд тэгнэж хойт суман дээр байгаа цэрэгт өг. Аваачиж өгөөгүй байвал уу? Чамайг огтонын нүхэнд орсон ч олно гэж мэдээрэй гээд Дулмаа шууд аргамжаатай байсан морио авч унаад явлаа. Хэсэг явсны дараа бууж мориныхоо хүзүүнээс тэврэн эхэр татан мэгшин уйлав.

## ТӨГСГӨЛ

Мянга есөн зуун гучин хоёр оны намар. Ардын төр засгийг эсэргүүцэн боссон бослого дарагдаж намаас шинэ эргэлтийн бодлогыг явуулав. Улс төр бэхжин, Тунгалаг Тамирын

хөндийд энх амьдрал, хвсэл мөрөөдөл, хайр дурлал улам ч гуа вэсгэлэнтэй, тайван сайхнаар цэцэглэв. Бослого дарагдсаны дараа Эрдэнийг хотод ажил хийлгэхээр Намын Төв Хороо дууджээ. Харин Бат Архангай аймгийн төвийн сургуулийн захиралаар томилогдов. Тэнгэр өчvvхэн ч vvлгvй, налгар сайхан өдөр Булган ууланд байдаг учралт моносон дээр хоёр хvvхэд, нэг эр хvн, гурван эмэгтэй нийт зургаан хvн очив. Энэ хvмvvсийг уншигч та танина. Энэ бол Бат, Солонго, Дулмаа, Сvрэн нар байсан агаад тэдний хамт Төмөр, Хонгор нарын хоёр хvv байв. Солонго долоон сар болсон хvvхэд гэдсэндээ тээжээ. Хонгорын моносны мөчрvvд арвин ургасан мойлоо дааж ядан доош гулзайжээ. Тvрvvлж очсон Бат тэр тодноос нэг мойл чимхэж авахад бяцарч нөжирсөн цус шиг хvрэн хар шvvс хурууг нь дагаж урсан ирлээ. Амандаа хийх гэснээ болив. Хонгорын хvv гvйж ирээд “ Бат ахаа над мойл авч өгөөч “ гэлээ.

-Болоогvй байна. Дvv минь. Энэ модыг хайрлаж хамгаалж яваарай. Энэ бол vlэмж сайхан сэтгэлтэй, төөрч будилсан хvний мод юм шvv гээд Батын нvдэнд тунгалаг бvлээн нулимас тунарав.

**Төгсөв**  
**1967 оны 4 дvгээр сарын 6**

Эх сурвалж:

Формат, фонт зэргийг бага зэрэг янзалж pdf

хэлбэр уруу хөрвүүлсэн:

[www.elibrary.mn](http://www.elibrary.mn)

The Weatherman

<http://weatherman.blog.banjig.net/>